АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ДЭЛХИЙН БАНК

Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага

Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл

Жан–Пьер Бран
Анастасия Сотиропаолу
Ларисса Грей
Клайв Скотт
Кевин М.Стивенсон

Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага

Хулгайлагдсан хөрөнгийг буцаах ажиллагааны талаар (StAR-ын) ном товхимлууд

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга - СтАР /StAR - the Stolen Asset Recovery initiative/ бол авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хамгаалах чиглэлээр олон улсын хүчин чармайлтуудад дэмжлэг үзүүлж ажилладаг Дэлхийн банкны групп болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны /UNODC-United Nations Office on Drugs and Crime/ хамтарсан хөтөлбөр юм. СтАР нь хөгжиж байгаа орнууд болон санхүүгийн төвүүдтэй авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хувиргахаас сэргийлэх талаар хамтран ажиллаж, хууль бус хөрөнгийг илүү системтэйгээр, цаг тухайд нь буцаан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Түүнчлэн СтАР нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн /UNCAC-United Nations Convention against Corruption/ Гишүүн орнуудын чуулган /COSP-Conference of the States Parties/, Их 8 /G-8/, Их 20 /G-20/-ын бүлэг болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /FATF - Financial Action Task Force/, бусад олон улсын байгууллагууд, бодлого тодорхойлогч нартай олон улсын хөрөнгө буцаах ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, хөгжүүлэхэд хамтран ажилладаг.

СтАР /StAR/-ын ном товхимлуудад авлигатай тэмцэх, хөрөнгө буцаан авах чиглэлээр өргөн хүрээний практик, олон улсын сайн туршлагууд болон бодлогын арга хэмжээнүүдийн талаарх салбарын мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн StAR ба UNODC байгууллагуудын хүчин чармайлтуудыг тусгасан байдаг. Илүү их мэдээллийг www.worldbank.org/star сайтнаас үзнэ үү.

Хулгайлагдсан хөрөнгийг буцаах ажиллагааны талаар /СтАР-ын/ ном товхимлууд

Stolen Asset Recovery: A Good Practices Guide for Non-Conviction Based Asset Forfeiture (2009) by Theodore S. Greenberg, Linda M. Samuel, Wingate Grant, and Larissa Gray

*Politically Exposed Persons: Preventive Measures for the Banking Secto*r (2010) by Theodore S. Greenberg, Larissa Gray, Delphine Schantz, Carolin Gardner, and Michael Latham

Asset Recovery Handbook: A Guide for Practitioners (2011) by Jean-Pierre Brun, Larissa Gray, Clive Scott, and Kevin M. Stephenson

Barriers to Asset Recovery: An Analysis of the Key Barriers and Recommendations for Action (2011) by Kevin M. Stephenson, Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabriele Dunker, and Melissa Panjer

The Puppet Masters: How the Corrupt Use Legal Structures to Hide Stolen Assets and What to Do about It (2011) by Emile van der Does de Willebois, Emily M. Halter, Robert A. Harrison, Ji Won Park, and J. C. Sharman

Public Office, Private Interests: Accountability through Income and Asset Disclosure (2012)

On the Take: Criminalizing Illicit Enrichment to Fight Corruption (2012) by Lindy Muzila, Michelle Morales, Marianne Mathias, and Tammar Berger

Few and Far: The Hard Facts on Stolen Asset Recovery (2014) by Larissa Gray, Kjetil Hansen, Pranvera Recica-Kirkbride, and Linnea Mills

Left Out of the Bargain: Settlements in Foreign Bribery Cases and Implications for Asset Recovery (2014) by Jacinta Anyango Oduor, Francisca M. U. Fernando, Agustin Flah, Dorothee Gottwald, Jeanne M. Hauch, Marianne Mathias, Ji Won Park, and Oliver Stolpe

Public Wrongs, Private Actions: Civil Lawsuits to Recover Stolen Assets (2015) by JeanPierre Brun, Pascale Helene Dubois, Emile van der Does de Willebois, Jeanne Hauch, Sarah Jaпs, Yannis Mekki, Anastasia Sotiropoulou, Katherine Rose Sylvester, and Mahesh Uttamchandani

Getting the Full Picture on Public Officials: A How-To Guide for Effective Financial Disclosure (2017) by Ivana M. Rossi, Laura Pop, and Tammar Berger

Going for Broke: Insolvency Tools to Support Cross-Border Asset Recovery in Corruption Cases (2020) by Jean-Pierre Brun and Molly Silver

Asset Recovery Handbook: A Guide for Practitioners, Second edition (2021) by JeanPierre Brun, Anastasia Sotiropoulou, Larissa Gray, Clive Scott, and Kevin M. Stephenson

СтАР-ын бүх цуврал бүтээлүүдийг дараах сайтнаас үнэгүй ашиглах боломжтой: https://openknowledge.worldbank .org/handle/10986/2172.

Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага

Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл

Жан–Пьер Бран
Анастасия Сотиропаолу
Ларисса Грей
Клайв Скотт
Кевин М.Стивенсон

WORLD BANK GROUP

Stolen Asset Recovery Initiative
The World Bank • UNODC

2021 Олон улсын Сэргээн босголт, Хөгжлийн банк/Дэлхийн Банк
1818 H Street NW, Washington, DC 20433
Утас: 202-473-1000 Интернет: www.worldbank.org
Зарим эрхүүдийг хадгална.

1 2 3 4 24 23 22 21

Энэхүү бүтээл нь Дэлхийн банкны ажилтнууд болон бусад хамтран ажилладаг байгууллагуудын нөр их зүтгэлийн үр дүн билээ. Энэхүү бүтээлд тусгагдсан мэдээлэл, тайлбар, дүгнэлтүүд нь Дэлхийн банк, түүний Гүйцэтгэх захирлуудын зөвлөл, эсхүл тэдний төлөөлж буй орнуудын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Дэлхийн банк нь уг бүтээлд дурдагдсан тоон үзүүлэлтийн үнэн зөв, бодитой эсэхэд баталгаа гаргахгүй. Бүтээлд тусгагдсан газар зүйн зураг, дүрслэлүүдийн хил хязгаар, өнгө, нэршлүүд болон бусад мэдээллүүд нь аливаа нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, тэдгээрийг баталгаажуулах, эсхүл хүлээн зөвшөөрөхтэй холбогдох Дэлхийн Банкны байр суурийг илэрхийлэхгүй.

Дэлхийн банкинд тусгайлан хадгалагддаг давуу эрх, халдашгүй байдлыг энэхүү бүтээлээр тогтоох, хязгаарлах, эсхүл татгалзахыг хориглоно.

Эрх ба Зөвшөөрөл/Rights and Permissions

Уг бүтээл нь дараах зөвшөөрлийн дагуу ашиглагдах боломжтой: the Creative Commons Attribution 3.0 IGO license (CC BY 3.0 IGO) http://creativecommons .org/licenses/by/3.0/igo. Уг зөвшөөрлийг авснаар та энэхүү бүтээлийг үнэ төлбөргүйгээр хуулбарлах, тараах, дамжуулах, засварлах, эсхүл арилжааны зорилгоор худалдахдаа дараах нөхцлийг хангасан байх ёстой:

Эх сурвалжийг дурдах (Attribution): - “Brun, Jean-Pierre, Anastasia Sotiropoulou, Larissa Gray, Clive Scott, and Kevin M. Stephenson. 2021. Asset Recovery Handbook: A Guide for Practitioners, second edition. Washington, DC: World Bank. doi:10.1596/978-1-4648-1616-1. License: Creative Commons Attribution CC BY 3.0 IGO” гэж бичнэ.

Орчуулга (Translations) - Хэрэв та энэ бүтээлийн орчуулгыг хийж байгаа бол дараах тайлбарыг эх сурвалжийн хамт дурдана уу: *Энэхүү орчуулгыг Дэлхийн банк хийгээгүй бөгөөд үүнийг Дэлхийн банкны албан ёсны орчуулга гэж үзэхгүй. Орчуулгыг хийхэд гарсан агуулгын болон бусад алдааг Дэлхийн банк хариуцахгүй.*

Засан сайжруулах (Adaptation) - Хэрэв та энэхүү бүтээлийг засан сайжруулсан бол дараах тайлбарыг эх сурвалжийн хамт дурдана уу: *Энэхүү бүтээл нь Дэлхийн банкны эх бүтээлийн засан сайжруулсан хувилбар болно. Засан сайжруулсан хувилбарт тусгагдсан санаа, үзэл бодол нь зөвхөн уг хувилбарын зохиогч, эсхүл зохиогч нарынх ба үүнийг Дэлхийн банкнаас хариуцахгүй.*

Гуравдагч этгээдийн контент (Third-party content) - Тус бүтээлд тусгагдсан агуулгын бүрэлдэхүүн хэсэг нь Дэлхийн банкны оюуны өмч биш юм. Үүнтэй холбогдуулан, тус бүтээлд тусгагдсан аливаа гуравдагч этгээдийн өмчлөлд байгаа бие даасан санаа, түүний бүрэлдэхүүн хэсгийг энэхүү бүтээлд ашигласнаас үүссэн оюуны өмчийн эрхийг зөрчлийг Дэлхийн банк хариуцахгүй. Иймд эрх зөрчигдсөнтэй холбоотойгоор гарах эрсдэлийг зөвхөн та өөрөө хариуцна. Хэрэв та энэ бүтээлийн аль нэг хэсгийг дахин ашиглахыг хүсвэл тийнхүү дахин ашиглахад зохиогчоос зөвшөөрөл авах шаардлагатай эсэхийг тодорхойлох нь таны үүрэг юм. Бүтээлийн хэсгийн жишээг дурдвал, хүснэгт, зураг, дүрслэл зэрэг багтах ба зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.

Оюуны өмчийн эрх, зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар хүсэлтээ World Bank Publications, The World Bank Group, 1818 H, Street NW, Washington, DC 20433, USA; e-mail: pubrights@worldbank.org хаягаар илгээх боломжтой.

ISBN (paper/цаасаар): 978-1-4648-1616-1
ISBN (electronic/элекроноор): 978-1-4648-1617-8
DOI: 10.1596/978-1-4648-1616-1

Хавтасны зураг: дарвуулт онгоц болон хауз: © TerryJ / 2007 / арын хуудасны зураг; модон алх: © DNY59 / Getty зургууд; бэлэн мөнгө: © imagestock / Getty зургууд. Зөвшөөрлийн лдагуу ашигласан. Дахин ашиглах бол зөвшөөрөл шаардлагатай. Хавтас болон дотоод дизайн: Debra Naylor, Naylor Design, Washington, DC

Конгрессын Номын сангийн каталоги дахь мэдээлэл заавал шаардлагатай.

"This work was originally published by the World Bank in English as Asset Recovery Handbook: A Guide for Practitioners, Second Edition in 2020. The Mongolian translation was arranged by Prosecutor General's Office of Mongolia. Prosecutor General's Office of Mongolia is responsible for the quality of the translation. In case of any discrepancies, the original language will govern."

"Энэхүү бүтээлийн эх хувийг Дэлхийн Банк нь 2020 онд "Олон Улсад хөрөнгө буцаах ажиллагааны тухай гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл" нэртэйгээр Англи хэл дээр эрхлэн гаргасан. Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар нь уг бүтээлийн Монгол хэл дээрх орчуулгыг хариуцан эмхтгэсэн юм. Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газар нь энэхүү бүтээлийн Монгол хэл дээрх орчуулгын чанарт хариуцлага хүлээх бөгөөд орчуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хэл дээрх эх хувийг баримтална."

Asset Recovery Handbook: A Guide for Practitioners, Second Edition
Copyright © 2020 by International Bank for Reconstruction and Development / The World Bank

Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл
© 2020 он. Зохиогчийн эрх нь Олон улсын Сэргээн босголт, Хөгжлийн банк/Дэлхийн Банкинд хадгалагдана.

"Дэлхийн Банкинд зориулан хэвлэв"

Гарын авлагыг Монгол хэлнээ орчуулсан ажлын хэсгийн ахлагч:
Ж.Болорпүрэв /LLM/

Орчуулгыг хянан тохиолдуулсан:
Ц.Насанбат /Докторант/
У.Эрдэнэтуяа /LLM-IL/

Орчуулсан ажлын хэсгийн гишүүд:
Г.Гантүвшин/LL.M/, Ж.Төгс-Очир/LL.M-CCL/, Д.Тулга/LL.M/, С.Энхчимэг/MPP&Economics/, Ц.Эрдэнэхишиг/LL.M-IR/, У.Эрдэнэтуяа/LL.M-IL/, Х.Энхмандах/LL.B/, О.Эрхэмжаргал/LL.B/, М.Батсоёмбо/BA-IR/, М.Ганцэцэг /MBA/, [Ч.Молор-Эрдэнэ], Н.Номундарь /BSc/.

Цаасны хэмжээ: 175x250мм
Хэвлэсэн тоо: 1000ш
"2023, Улаанбаатар"
"УРАНГАР ПРЕСС" ХХК-д хэвлэв.

Агуулга

Талархал *xvii*
Зохиогчдын талаар *xix*
Товчилсон үгсийн жагсаалт *xxi*

Оршил **1**
Аргачлал 3
Гарын авлагыг хэрхэн хэрэглэх тухай 3
Ном зүй 6

1. Хөрөнгө буцаах ажиллагааны талаар ерөнхий ойлголт **7**
1.1. Удиртгал 7
1.2. Хөрөнгө буцаах ажиллагааны ерөнхий үйл явц 7
1.3. Хөрөнгө буцаах ажиллагааг хийх эрх зүйн арга замууд. 12
1.4. Хулгайлагдсан хөрөнгийг гадаад улс орны үүсгэсэн эрх зүйн маргааны хүрээнд буцаан авах тухай 21
1.5. Хөрөнгө буцаан авах арга замуудыг практикт хэрэглэсэн нь: Гурван хэргийн жишээ 23
Ном зүй 30

2. Хэргийн менежмент, зохион байгуулалтыг хийхэд анхаарах стратегийн асуудлууд **33**
2.1. Удиртгал 33
2.2. Фактуудыг цуглуулах нь: Мэдээллийн анхан шатны эх сурвалж 33
2.3. Хууль тогтоомжид үнэлгээ хийх болон эрх зүйн шинэчлэлийг бодолцох нь 40
2.4. Хэргийн стратегийг боловсруулах нь 42
2.5. Ажлын хэсэг, нэгж, баг байгуулж, гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь. 43
2.6. Гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай харилцаа тогтоох болон олон улсын хамтын ажиллагааны дэмжлэг авах боломжийг үнэлэх нь 50
2.7. Дэмжлэг үзүүлэх, хангалттай нөөц, бололцоотой байх 52
2.8. Хууль зүйн болон хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлох нь 54
2.9. Хариуцлага хүлээх бүх талуудыг тодорхой болгох 65
2.10. Эрүүгийн хэргийн талаар тусгайлан анхаарах асуудлууд 66
2.11. Хэргийн менежмент 72
Ном зүй 75

3. Нотлох баримтыг хамгаалах болон Хөрөнгийг мөшгих (1): Мөрдөн шалгах ажиллагааны арга замууд **79**
3.1. Удиртгал 79
3.2. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нь 81
3.3. Хувийн хэрэг үүсгэх 87
3.4. Санхүүгийн болон бусад мэдээлэл, нотлох баримтыг олж авах 88
Ном зүй 111

4. Нотлох баримтыг хамгаалах болон Хөрөнгийг мөшгих (2): Холбогдох мэдээлэл болон Санхүүгийн баримт бичгүүд 113
4.1. Удиртгал 113
4.2. Холбогдох мэдээллийг тодорхойлох: Түгээмэл эх сурвалжид тулгуурласан баримт бичгүүдийн жишээнүүд 113
4.3. Мэдээллийг зохион байгуулах: Санхүүгийн хувийн хэрэг нээх 128
4.4. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх: Санхүүгийн урсгалыг санхүүгийн хувийн хэргийн мэдээлэлтэй харьцуулах 132
4.5. Олон Улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх 133
Ном зүй 134

5. Хөрөнгийн хамгаалалт 137
5.1. Удиртгал 137
5.2. Нэр томьёо: Хөрөнгө хураах болон хязгаарлах 138
5.3. Урьдчилсан арга хэмжээний шийдвэрийн шаардлагууд 138
5.4. Хөрөнгө хязгаарлах болон хураах ажиллагааны өмнөх төлөвлөлт 150
5.5. Урьдчилсан арга хэмжээг авах цаг хугацаа 157
5.6. Зардлыг төлүүлэхтэй холбоотойгоор гаргасан хөрөнгө хязгаарлах шийдвэрт хамааралгүй асуудлууд 158
5.7. Нэмэлт шийдвэрүүд 159
5.8. Гуравдагч талын ашиг сонирхол 160
5.9. Урьдчилсан арга хэмжээний бусад хувилбарууд 161
Ном зүй 162

6. Хураан авсан хөрөнгийн менежмент 163
6.1. Удиртгал 163
6.2. Хөрөнгийн удирдлагын гол оролцогчид 164
6.3. Хөрөнгийн менежерийн эрх хэмжээ 168
6.4. Хөрөнгийн бүртгэл, тайлагнал 170
6.5. Хөрөнгийн түгээмэл хэлбэрүүд болон холбогдох бэрхшээлүүд 170
6.6. Одоогийн менежментийн асуудлууд 179
6.7. Зөвшилцөх 180
6.8. Хөрөнгийг худалдан борлуулах 180
6.9. Хөрөнгийн менежерт төлөх төлбөр 181
Ном зүй 181

7. Хураан авах механизм 183
7.1. Удиртгал 183
7.2 . Хураан авах журам 187
7.3. Хураан авах ажиллагаа хэрхэн явагддаг вэ? 194
7.4. Хураан авах ажиллагааг өргөжүүлэх 203
7.5. Гуравдагч талын ашиг сонирхол 210
7.6. Хураан авах ажиллагааны талаар хуульчлахад тулгардаг асуудлууд 211
7.7. Гадаад улсад байршуулсан хөрөнгийг хураах 213
7.8. Хөрөнгө хураах замаар эрүүгийн хэрэгт хохирлыг барагдуулах нь. 214
Ном зүй 215

8. Хөрөнгө буцаан авахтай холбоотой олон улсын хамтын ажиллагааны гол зарчмууд ба Хамтын ажиллагааны албан бус сувгууд 219
8.1. Удиртгал 219
8.2. Албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн талаар харьцуулсан тойм 221
8.3. Олон улсын хамтын ажиллагаанд анхаарах үндсэн асуудлууд 224
8.4. Албан бус болон албан ёсны олон улсын хамтын ажиллагааны ерөнхий процесс 233
8.5. Албан бус хамтын ажиллагааны сувгууд 235
Ном зүй 245

9. Олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх 247
9.1. Удиртгал 247
9.2. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт 247
9.3. Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахад хамтран ажиллах 272
9.4. Иргэний журмаар (хувийн эрх зүйн) хөрөнгийг буцаан авах хамтын ажиллагаа 274
9.5. Хөрөнгө буцаан авахад хамтран ажиллах 275
Ном зүй 277

10. Иргэний процесс ажиллагаа 281
10.1. Удиртгал 281
10.2. Нэхэмжлэл гаргах ба нөхөн төлүүлэх 282
10.3. Хөрөнгө буцаан авах зорилгоор иргэний нэхэмжлэл гаргах 302
10.4. Эцэслэн шийдвэрлэх 310
10.5. Төлбөрийн чадваргүйд тооцох процесс 311
Ном зүй 313

11. Гадаад улсын шүүхийн шийдвэрийн дагуу дотооддоо хураан авах ажиллагаа явуулах процесс 315
11.1. Удиртгал 315
11.2. Харьяалал 316
11.3. Арга хэмжээ авч эхлэх журам 321
11.4. Гадаад улсад мөрдөн шалгах, яллах ажиллагааг явуулахад авлигын гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн талын үүрэг 321
11.5. Гадаад улсад байршуулсан хөрөнгийг буцаах талаар баталгааг гаргуулах нь 325
Ном зүй 332

Нэр томьёоны тайлбар **333**
Хавсралт A. Яллагдагчаар татвал зохих хэргүүдийн жагсаалт **339**
Хавсралт B. Сонгон авсан хуулийн этгээд ба бизнесийн нөхцөлүүдийн талаарх тайлбар **347**
Хавсралт C. Санхүүгийн тагнуулын албаны тайлангийн загвар **353**
Хавсралт D. Үзлэг, нэгжлэг хийх, хураан авах талаар шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг төлөвлөх **355**
Хавсралт E. Санхүүгийн байгууллагаас баримт, мэдээлэл гаргуулан авах тухай шийдвэрийн загвар. **357**
Хавсралт F. Цахим сангаар халхавчилсан бөгөөд цуврал байдлаар төлбөрийг шилжүүлэх аргууд. **363**
Хавсралт G. Санхүүгийн хувийн хэргийн маягтын загвар **369**
Хавсралт H. Харилцах сувгаар дамжуулан хэлэлцэх боломжтой асуудлууд - Албан бус туслалцааны үе шат **389**
Хавсралт I. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн загвар, төслийг боловсруулах талаар зөвлөмж **391**
Хавсралт J. Цахим эх сурвалжууд **397**
Хавсралт K. Лозаннагийн удирдамжийн тойм **409**
Хавсралт L. Цогц мөрдөн шалгах ажиллагааны менежментийг сайжруулах зорилгоор хэргийн электрон менежментийн системийг ашиглах нь **411**

Шигтгээнүүд

1.1 Хөрөнгө буцаах авах эрх зүйн арга хэрэгслүүд 12
1.2 Хөрөнгө буцаан авах бусад арга замууд 20
1.3 Перу: Владимиро Монтесинос ба түүний хамсаатнуудын хэрэг 23
1.4 Замби: Фредерик Чилуба ба түүний хамсаатнуудтай холбоотой гэм хорыг нэхэмжилсэн иргэний хэрэг 25
1.5 Нигер: Диепрье Аламиесейха-ийн хэрэг 27
2.1 Хөрөнгө буцаан авах ажиллагаанд Санхүүгийн тагнуулын албаны гүйцэтгэх үүрэг, оролцоо 34
2.2 Европын улс төрчдийн эсрэг “Caviar Diplomacy” мэдэгдэл 38
2.3 United Kingdom: Register of “People with Significant Control” 39
2.4 Бразил: “Автомашин угаалга” ажиллагааны танилцуулга 41
2.5 Лозанна удирдамж 43
2.6 Тунис: Бен Али болон түүний гэр бүлийнхний холбогдсон хэрэгт Зохион байгуулах, мөрдөн шалгах нэгж байгуулсан тухай 46
2.7 Малайз: 1MDB хэргийн мөрдөн шалгах ажиллагаан дахь дотоодын болон олон улсын хамтын ажиллагаа 47
2.8 Хөрөнгө хураах ажиллагаа дахь олон улсын хамтын ажиллагааны хүндрэл бэрхшээл 52
2.9 Узбекистан: Гулнара Каримовагийн авлигын хэрэгт АНУ-ын харьяалах хэсэг 55
2.10 Экваторын Гвиней: Дэд Ерөнхийлөгч Теодоро Нгуема Обианг Мангуегийн хэрэг дэх халдашгүй байдлын асуудал 59
2.11 Бразил: “Давуу эрхт форум” ба ялаас зайлсхийх үйлдлийн төгсгөл 61
2.12 Замби: Ерөнхийлөгч асан Фредерик Чилубагийн хэрэг дэх хуульчдын хариуцлага 66
2.13 Бразил: Лава Жатогийн хэрэгт хариуцагч талуудыг тодорхойлох нь 67

2.14	Нягтлах бодох, бүртгэл, дотоод хяналтын зохилцуулалтын хэргийг Их Британи, АНУ-д хянан шийдвэрлэх нь	69
3.1	Санхүүгийн урсгал ба холбоосын тухай ойлголт: Бразилийн Лава Жато (автомашин угаалга)-ын хэрэгт халхавч компаниудыг ашигласан тухай	83
3.2	Узбекистан: Гульнара Каримовагийн хэргийн халхавч компаниудын эцсийн өмчлөгч	86
3.3	Сэжигтний хувийн хэрэгт оруулах шаардлагатай үндсэн мэдээллийн хяналтын жагсаалт	87
3.4	Их Британи: Жошуа Дариегийн хэрэгт ашиглагдсан мөрдөн шалгах ажиллагааны арга техник	89
3.5	Экваторын Гвиней Улс: Теодорин Обиангийн мөрдөн шалгах явцад иргэний нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлсэн тухай	93
3.6	Хөрөнгө буцаан авах ажиллагаанд Эгмонт группын гүйцэтгэх үүрэг	95
3.7	Зөвшөөрөл авах үндэслэлүүд болон гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй талаар мэдээллийн эх сурвалжтай холбоотой анхаарах зүйлс	102
3.8	Мөрдөн шалгах ажиллагааны явцад хурааж авах шаардлагатай эд зүйлс	103
3.9	Санхүүгийн байгууллагаас гаргуулан авах баримт бичгүүд	105
3.10	Хадгалах шийдвэр	107
3.11	Их Британи: Тайлбарлагдаагүй хөрөнгө орлогын талаарх шийдвэрийг гаргах, гүйцэтгэхэд тавигдах шаардлага	109
4.1	Мөнгө шилжүүлэх үйл явцтай холбоотой маягт, баримт бичиг	118
4.2	Бразил: Одебректийн “Хахуулийн газар”	123
4.3	Гэрээ, төлбөрийн баримт, төлбөрийн түүх болон төлбөрийн хэрэгслийн талаар анхаарах асуудал	124
4.4	Нигер: OPL 245 газрын тосны блокны маргаан болон анхаарах асуудал	126
4.5	Молдав Улсын банкны залилангийн хэргийн дуулиан	130
5.1	Нигер: Газрын тосны нөөцийн сайд асангийн хэрэгт хөрөнгийг царцаасан болон иргэний журмаар хураан авсан хэрэг	140
5.2	Гэрчийн мэдүүлэг авах	142
5.3	Арабын “Arab Spring’s Fallen Regimes” дэглэмтэй холбоотой хөрөнгийг хойшлуулшгүйгээр царцаах Швейцарийн Холбооны Зөвлөлийн эрх мэдэл	144
5.4	Нигер: OPL 245 хэрэгт царцаасан хөрөнгө	146
5.5	Бразил: Швейцарь дахь Лава Жатогийн хөрөнгийг царцаах үйл ажиллагаа	147
5.6	Украйн: Виктор Януковичийн эд хөрөнгийг царцаах шийдвэр	148
5.7	Хийсвэр жишээ: Хөрөнгө хязгаарлах үйл ажиллагааны өмнө гаргах шийдвэрүүд	153
5.8	Перу: Владимиро Монтесиносын Швейцарь дахь хөрөнгийг царцаах про-актив ажиллагаа	157
6.1	Франц: Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг удирдах, буцаан олгох агентлаг	166
6.2	Хятад: Жоу Юнкан болон түүний хамаарал бүхий этгээдээс 14.5 тэрбум ам.долларын үн бүхий хөрөнгийг хураан авсан тухай	171
6.3	Виртуал хөрөнгийг хураан авахтай холбоотой зарим асуудлууд	173

7.1	Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураах, царцаах тухай ЕХ-ны Удирдамж, 2014 он	184
7.2	Хөрөнгө хураах тухай хууль тогтоомжийн түүхэн хөгжил ба сүүлийн үеийн чиг хандлага	186
7.3	Малайз: 1Малайзын Хөгжлийн сангийн хэрэгт хийсэн иргэний журмаар хөрөнгө хураах ажиллагаа	190
7.4	ИБУИНВУ: Хөрөнгө буцаан авах ажиллагааны үед прокурорын эдлэх бүрэн эрхийн талаар удирдамж	193
7.5	Хууль бус орлоготой холилдсон хөрөнгийг хураахад тулгардаг асуудлууд: Хэргийн жишээ	197
7.6	“Холбоотой үйл ажиллагаанууд” зарчмыг гэмт хэргийн нийт ашиг хонжоог бүрэн тодорхойлох зорилгоор ашиглах нь – Хэргийн жишээ	201
7.7	Гаити: Хууль бус хөрөнгийг хураах тухай Швейцарийн хуулийн дагуу хөрөнгийн үүсэл гарал нь хууль бус болох тухай президент ашигласан Жан Клод “Baby Doc” Дювалиерын хэрэг	207
7.8	Урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах Италийн тогтолцоо	210
8.1	Operação Lava Jato (Автомашин угаалга ажиллагаа): АНУ, Бразил, Швейцар улсуудын хамтын ажиллагаа	224
8.2	ВимпелКомын хэрэг: 20 улсын прокурор, зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа	226
8.3	Хүмүүстэй холбогдох нь: Перу Улсын хэргийн жишээ	228
8.4	Олон улсын хамтын ажиллагааны сувгууд	229
8.5	Мэдэгдэх үүрэг: Эрх зүйн харилцан туслалцаанд саад болох уу?	233
8.6	Албан бус туслалцааг хялбаршуулах нь	236
8.7	Франц, Швейцар, Их Британи, АНУ-ын мөрдөн шалгах эрх бүхий хууль сахиулах байгууллагууд	238
8.8	Авлигын дуулиант хэргүүдийг илрүүлэх олон улсын хамтын ажиллагаа: Панама пэйпэрс	239
8.9	Франц Цлсын банкны төвлөрсөн бүртгэл: ФИКОБА	241
8.10	Швейцарийн ил болсон мэдээлэл	244
9.1	Албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлтийн эрх зүйн үндэслэлийг сонгох	249
9.2	Харилцан гэмт хэрэгт тооцдог байх шаардлагыг давах: Үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон гадаад улсын нийтийн албан тушаалтнуудын авлигын хэрэг	254
9.3	Банкны нууцлал ба санхүүгийн гэмт хэргүүд: Эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг гүйцэтгэхээс татгалзахыг хориглосон үндэслэлүүд	258
9.4	Хэт өргөн хүрээний эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шийдвэр гаргуулахаас урьчдилан сэргийлэх	262
9.5	ИБУИНВУ-ын улс харгалзахгүйгээр урьдчилан сэргийлэх түр арга хэмжээ авах талаарх шийдвэр	268
9.6	ИБУИНВУ, АНУ-д хөрөнгө хураахтай холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг шууд гүйцэтгэхэд тавигдах шаардлага	269
9.7	Франц Улсад эрх зүйн туслалцааны хүсэлтийн дагуу хөрөнгө буцаах	275
9.8	Хөрөнгө буцаах ажиллагааны Авлигын гэмт хэргийн улмаас хураагдсан хөрөнгийг шийдвэрлэх, шилжүүлэх гол зарчмуудын талаарх олон улсын форум	276
10.1	Хөрөнгийн өмчлөх эрхийг шаардсан хэргийн жишээ	283

10.2 АНУ-ын рэкетийн нөлөөнд автсан болон авлигад идэгдсэн байгууллагуудын дүрэм (RICO) 289
10.3 Хөрөнгийг зориулалтын бусаар ашигласнаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх 291
10.4 Файффс Групп ХХК-ны эсрэг Темплман болон бусад хүмүүсийн хэрэг (2000) 293
10.5 Ираны үндэсний газрын тосны компанийн эсрэг Crescent Petroleum Company International ХХК & Gas Corporation ХХК-ийн хэрэг (2016) 294
10.6 Гвиней: Симандоу төмрийн уурхайн олборлолтын эрхийн гэрээг цуцалсан тухай 295
10.7 World Duty Free Company Limited-ийн эсрэг Бүгд Найрамдах Кени Улсын хэрэг (2006) 297
10.8 Хуулийн болон захиргааны арга замаар гэрээг хүчингүй болгохоос өөрөөр хохирлыг төлүүлэх жишээ 298
10.9 Ашгаас суутгах: АНУ-ын туршлага
10.10 Ливийн хөрөнгө оруулалтын газрын эсрэг Société Générale SA болон бусад этгээдийн хэрэг (2016) 303
10.11 Их Британийн Нэгдсэн Вант Улс: Оксфорд хэвлэлийн компанийн хэрэг 303
10.12 Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсын эсрэг Сантолина Инвестмент Корп., Соломон & Петерс, Диепрье Аламиесейха нарын хэрэгт “нөхцөл байдлын нотлох баримт”-ыг авч үзсэн нь (2007) 305
10.13 Франц, Панам, Нэгдсэн Вант Улс дахь таслан сэргийлэх арга хэмжээ авахад тавигдах шаардлага 308
10.14 БНХАУ-ын ЗЗОБ Макао: Ао Ман Лонгийн хэрэг 309
10.15 Яллагдагчийн эзгүйд шүүхийн шийдвэрийг биелүүлэх 310
11.1 Тухайн нутаг дэвсгэрт үйлдэхийг хязгаарласан үйлдэл гарсан тохиолдолд харьяалал тогтоох 317
11.2 Их Британи болон АНУ-ын иргэдийн хувьд харъяалал тогтоох 318
11.3 Бразил, Франц, Швейцарь, Их Британи, АНУ дахь мөнгө угаах гэмт хэргийг яллах ажиллагааны харъялал 320
11.4 Гадаад улсад эхлүүлсэн хөрөнгө буцаах ажиллагааны процессын талаарх мэдээллийн эх сурвалжийн жишээ 322
11.5 Гаити: Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улсын оролцооны ач холбогдол 324
11.6 Хөрөнгийг шууд буцаах талаар практик 326
11.7 Казахстан: БОТА санг байгуулах эрх зүйн үндэс болох харилцан ойлголцлын санамж бичиг 328
11.8 Нигери: Нигерийн диктатор генерал асан Сани Абачагийн хулгайлсан хөрөнгийг буцаан авах тухай АНУ, Нигери, Жерсигийн хооронд байгуулсан хөрөнгө буцаах гэрээ 329
11.9 Швейцар дахь хөрөнгө буцаах сонголтууд: Абачагийн хэрэгт харилцан ойлголцлын санамж бичгийг ашиглах нь 330
A.1 Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой Франц Улсын хуулийн заалтууд 343
F.1 Хэрэглэгчийн эх сурвалжийн мэдээллийг нуусан мөнгөн шилжүүлгийн талаар авах хариу арга хэмжээ 365
F.2 Санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалтын бүртгэл 366

I.1 Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах (ЭЗТХ) болон бусад зөвлөгөө 392

Зураг

1.1 Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах процесс 8
2.1 Хөрөнгө буцаан авах ажиллагаан дахь нотолгооны стандарт 65
3.1 Хөрөнгө буцаан авахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааг хийх үед асуух 5 чухал асуулт 82
3.2 Засгийн газрын агентлагуудаас авч болох урьдчилсан мэдээллийн эх сурвалж 94
4.1 Ердийн хил дамнасан мөнгөн гуйвуулгын гүйлгээний процесс 116
4.2 SWIFT мэссэжний формат болон кодыг тайлбарласан жишээ 121
4.3 Хөрөнгийн урсгал болон сүлжээний жишээ 129
4.4 Мөрдөн шалгах обьектийн хамаарал ба холбогдох эд хөрөнгийн жишээ 130
B4.5.1 Залилангийн хэрэгт ашиглагдсан Карусель зээлийн схем 132
7.1 Гадаад улсад байршуулсан хөрөнгө хураах 213
8.1 Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хөрөнгө буцаах үе шатын интеграц 220
8.2 Хөрөнгө буцаах ажиллагаанд олон улсын түвшинд хамтран ажиллах талаар 235
8.3 Албан бус туслалцаа, албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт: Ямар туслалцааг хүсч болох вэ? 236
9.1 Гэрээ, эсхүл дотоодын хууль тогтоомж байгаа нөхцөлд эрх зүйн туслалцааны хүсэлтийн урсгал 271
A.1 Хөрөнгө буцаах ажиллагааг явуулахад харгалзан үзэх хэргүүд 339
F.1 SWIFT Цуврал/Дараалсан болон халхавчаар төлбөр хийх процесс, арга зам 364
L.1 Мөрдөн байцаалтын хэргийн материалын эксел дэх үндсэн талбарууд 416
L.2 Хэргийн материалын нүүр хуудасны жишээ 416

Фото

6.1 Цагдаагийн байгууллагын хашаанд байрлуулсан өндөр үнэтэй, хурдан элэгддэг тээврийн хэрэгслүүд 175

Хүснэгт

2.1 Хөрөнгө буцаах ажиллагаанд харгалзан үзэх эрүүгийн гэмт хэрэг, бүлгээр 68
2.2 Хөрөнгө буцаах ажиллагаатай холбогдон сонгогдсон эрүүгийн хэргүүдийн элементийг бүрдүүлэхэд тулгарах үндсэн нотлох баримтын сорилтууд 71
5.1 Хөрөнгийн хэсэгчилсэн хяналт буюу хязгаарлагдмал түвшинд хязгаарлах үйл ажиллагааны ач холбогдол—Тухайлбал, Зочид буудал 155
8.1 Албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хоорондын ялгаа 222

L.1	Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэлийн загвар	418
L.2	Хэрэгт холбогдох этгээдийн мэдээллийн стандарт форматын загвар	420
L.3	Сошиал медиа болон бусад НЭСДШ-ний эх сурвалжаас авсан мэдээллийн загвар	421
L.4	Хэрэгт холбогдох этгээдийн мэдээлэлд багтаан оруулах санхүүгийн анхан шатны мэдээлэл	422
L.5	Санхүүгийн мэдээллийн стандарт форматын загвар	424
L.6	Хэрэгт холбогдох этгээдийн санхүүгийн мэдээлэл дэх хөрөнгийн үнэ цэнийг тооцоолох форматын загвар	425
L.7	Хэрэгт холбогдох этгээдийн санхүүгийн мэдээлэлд байгаа өр төлбөрийн тооцооллын форматын загвар	426
L.8	Санхүүгийн мэдээлэл хэсэгт багтах орлогын талаарх мэдээллийн загвар	426
L.9	Санхүүгийн танилцуулга дахь зардлын дата мэдээллийн жишээ	426
L.10	Хэрэгт холбогдох этгээдийн нийт хөрөнгө дэх өөрчлөлтийг тооцоолох жишээ формат	427
L.11	Урьдчилсан нотлох баримтын матрицын жишээ	429
L.12	Нотлох баримтын матрицыг баяжуулсан жишээ, гол нотлох баримтуудыг элемент бүрээр жагсаасан загвар	430
L.13	Эд мөрийн баримтын бүртгэлийн стандарт форматын жишээ	431
L.14	Үйл явдлуудын он цагийн дараалын жишээ формат	431
L.15	Ашиг сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтын жишээ формат	432
L.16	Хэрэг хаахад шалгах хяналтын хуудсанд багтаах хэсгүүдийн жишээ	433
L.17	“Хайлт” талбарт оруулах мэдээлэл	435

Талархал

Энэхүү Гарын авлагын эхний хэвлэлийг Жан-Пьер Бран (Багийн ахлагч, Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга, ил тод байдлын алба); Ларисса Грей (Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга байдлын албанд ажиллаж байсан); Кевин М.Стивенсон (Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга байдлын алба); Клайв Скотт (Нэгдсэн Үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байсан, Олон улсын валютын санд ажиллаж байгаа) болон Нина Гидваней (Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга байдлын албаны зөвлөх) нар хамтран бүтээсэн. Уг бүтээл нь дэлхийн өнцөг булан бүрээс гаргасан хамтын хүчин чармайлтын үр дүн юм. Авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хууль бус хөрөнгийг буцаан авах талаар салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагыг бүтээхэд зохиогчдын туршлага, зарцуулсан цагийг үнэлж баршгүй юм. Эрүүгийн хэрэгт олон улсын хэмжээнд хөрөнгө хураан авах, шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах, иргэний нэхэмжлэл гаргах, мөрдөн шалгах ажиллагаа, хөрөнгийг мөшгих, олон улсын хамтын ажиллагаа болон хөрөнгийн менежментийн талаарх иргэний болон нийтийн эрх зүйн тогтолцоотой, мөн бага, дунд, өндөр орлоготой орнуудын туршлагын талаар салбарын мэргэжилтнүүдэд арвин туршлагаа хуваалцлаа.

Тус шинэчлэгдсэн хоёр дахь хэвлэлийг Жан-Пьер Бран (Багийн ахлагч, Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга байдлын алба) болон Анастасия Сотиропаолу (Грекийн Үндэсний ил тод байдлын албаны захирагчийн тусгай хуулийн зөвлөх бөгөөд Грек дэх Америкийн Дерээ коллежийн I зэргийн туслах багш) нар бэлтгэлээ.

Энэхүү хоёр дахь хэвлэлд маш олон мэргэжилтнүүд олон улсын түвшинд хөрөнгө буцаан авах чиглэлээр өөрсдийн туршлагадаа тулгуурлан үнэт хувь нэмрээ оруулаа: Серефино Рокко Альварес-Родригес (UNODC-ийн зөвлөх шинжээч); Элнур Мусаев (Авлигын эсрэг шинжээч, Азербайжан, Их Британи); Эльза Гопала Кришнан (StAR санаачилга, одоо Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага [OECD]); Дебра ЛаПревотте, хяналтын тусгай агент асан (Холбооны мөрдөх товчоо [FBI]); Жан-Бернард Шмид (өмгөөлөгч бөгөөд зөвлөх, Ochsner & Associés хуулийн фирм, Женев); Жан-Мишель Верелст (прокурор, Бельгийн Хөрөнгө битүүмжлэх, хураан авах ерөнхий газрын захирал [COSC]); Жон Гилкес, FCA (харилцагч, Англи, Уэльсийн Мэргэшсэн нягтлан бодогчдын институт); Фредерик Пиерсон (багийн ахлагч, туршилт ба бодлого хариуцсан, Европын санхүү, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх төв, Европол); Фредерик Раффрей (Барристер, Англи, Уэльс; өмгөөлөгч, Гернси; Дэлхийн Банкны зөвлөх,); Лауре ду Кастильон (төлөөлөгч магистр, Бельгийн Гадаад хэргийн яам, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц [UNCAC] болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц [UNTOC]-ийн олон улсын харилцааны асуудлаар мэргэшсэн шинжээч); Кэвин М.Стефенсон (Дэлхийн банкны зөвлөх); Олаф Мейер (профессор, Франкфуртын Хэрэглээний шинжлэх ухааны их сургууль); Родриго Кайссерлиан (прокурор бөгөөд Бразилийн Хөрөнгө буцаах ажиллагааны институт [IBRA]-ийн үүсгэн байгуулагч, Вена дэх Авлигын эсрэг олон улсын академийн магистрын зэрэгтэй); Стефан Д.Касселла (АНУ-ын Холбооны прокурор асан, одоо "Хөрөнгө хураах тухай хууль" ХХК-ийн гүйцэтгэх захирал); Виталий Каско (прокурор бөгөөд авлигын эсрэг шинжээч, Украин); болон Уолтер Квиринен (COSC-ийн дэд захирал).

Мөн Йира Ж. Маскаро (Дэлхийн банкны Санхүүгийн тогтвортой, шударга байдлын албаны практик менежер) ахалсан, Фрэнк Фариелло (тэргүүлэх зөвлөх, Дэлхийн банкны Хууль зүйн асуудал хариуцсан Дэд ерөнхийлөгч); Дэвид Г.Хокс (Дэлхийн банкны Шударга байдлын асуудал хариуцсан Дэд ерөнхийлөгч, Тусгай нэхэмжлэх албаны дарга); Янник Стефант (эрсдэлийн ахлах ажилтан, Олон улсын санхүүгийн корпорацийн Комплаенс болон Бизнесийн эрсдэлийн хэлтэс); Жейсон Д.Рейхелт (ахлах зөвлөх, UNODC) болон Жеймс Андерсон (Дэлхийн банкны засаглалын ахлах мэргэжилтэн) нар Дэлхийн банкны хяналтын үйл явцын үеэр олон чухал саналуудыг манай багт ирүүлсэн.

Зохиогчдын зүгээс Эмиль ван дер Доес де Виллебойд (зохицуулагч, StAR санаачилга) болон Шервин Мажлесси (Авлига болон Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Бага хурлыг дэмжих хэсгийн ахлагч, UNODC) нарт зааж, зөвлөн дэмжлэг үзүүлж байсанд нь халуун талархал дэвшүүлье.

Мөн багийн зүгээс Бони де Мораес Соарешт (прокурор, Бразилийн Ерөнхий прокурорын газар); Владимир Козин (гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн байцаан шийтгэх албаны ажилтан, UNODC); Лэй Янг (прокурор, төслийн салбарын мэргэжилтнүүд) болон Тайса Толедо Лонго (прокурор, Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга байдлын албанд ажиллаж байсан) нарт редакцийн болон судалгааны чиглэлээр туслалцаа үзүүлж байсанд баярлалаа.

Энэ төслийг хэрэгжүүлэхэд Кисок Вихвег, Викки В.Таака захиргааны чиглэлээр бүх талын дэмжлэг үзүүлсэн билээ.

Энэхүү гарын авлагыг эцэслэн боловсруулахад Хина Гупта (прокурор бөгөөд зөвлөх, Дэлхийн банкны Санхүүгийн зах зээлийн шударга байдлын алба) судалгаа хийж, хэргийн жишээг байнга шинэчлэн, практикийн талаарх саналыг дэвшүүлж, өргөн хүрээнд дэмжлэг туслалцаа үзүүлж байсанд тусгайлан талархал дэвшүүлж байна.

Жан-Пьер Бран
Ажлын багийн ахлагч
Санхүүгийн тогтвортой байдал, шударга байдлын нэгж
Дэлхийн банк

Зохиогчдын талаар

Жан-Пьер Бран. 2008 оны 08 дугаар сараас Дэлхийн банкинд санхүүгийн ахлах шинжээчээр ажиллаж байна.Тэрээр Санхүүгийн болон зах зээлийн глобал практик болон Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга (StAR) хөтөлбөрт техникийн туслалцаа, бодлогын бичиг баримт боловсруулах ажлыг хариуцдаг. StAR хөтөлбөрөөс эрхлэн гаргасан 5 бүтээл дээр хамтран зохиогчоор ажилласан байна: *Asset Recovery Handbook; Barriers to Asset Recovery: An Analysis of the Key Barriers and Recommendations for Action; Identification and Quantification of the Proceeds of Bribery;Public Wrongs, Private Actions: Civil Lawsuits to Recover Stolen Assets*; and *Going for Broke: Insolvency Tools to Support Cross-Border Asset Recovery in Corruption Cases*. Тэрээр өмнө нь Францад (Парис) Deloitte-ийн захирал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн прокурор байсан бөгөөд улсын аудитор болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий шүүгчээр ажиллаж байсан байна.

Анастасия Сотиропаолу. Грекийн Үндэсний ил тод байдлын албаны захирагчийн тусгай хуулийн зөвлөх бөгөөд Грек дэх Америкийн Дерее коллежид Либерал урлаг, шинжлэх ухааны сургууль, Бизнес, эдийн засгийн сургуульд факультетын профессорын туслахаар ажилладаг. Тэрээр өмнө нь StAR хөтөлбөрт зөвлөхөөр ажиллаж байсан. Грекэд өмгөөлөгчөөр ажиллах эрхтэй ба эрх зүйн бакалавр, магистр, докторын зэрэгтэй.

Ларисса Грэй. Канадын Онтариод Нийгмийн ухааны чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн хуульч юм. 2008-2017 онд Дэлхийн банкны санхүүгийн секторын ахлах ажилтны хувьд хөрөнгө буцаан авах болон мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр бага, дунд орлоготой орнуудтай хамтран ажиллаж байсан. StAR хөтөлбөрөөс эрхлэн гаргасан 5 бүтээл дээр хамтран зохиогчоор ажилласан байна: *Asset Recovery Handbook; Barriers to Asset Recovery; Stolen Asset Recovery: A Good Practices Guide for Non-Conviction Based Asset Forfeiture; Politically Exposed Persons: Preventive Measures for the Banking Sector*; and *Few and Far: The Hard Facts on Stolen Asset Recovery*. 2017 оноос хойш тэрээр глобал архитектур болон дизайны фирмүүдэд ёс зүй, хяналт шалгалтын хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлсэн байна.

Клайв Скотт. Австралийн Шинэ өмнөдийн Уэльс болон Викториагийн Дээд шүүхэд хуульч. 1988-1996 онд тэрээр Австралийн Холбооны прокурорын газрын даргын ахлах туслахаар ажиллаж, хөрөнгө хураан авах асуудлыг хариуцаж байсан. Мөн хуульчаар ажиллаж байхдаа хөрөнгө хураан авах болон санхүүгийн гэмт хэргийн талаар мэргэшсэн бөгөөд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд Антигуа, Барбудагийн Засгийн газарт зөвлөгөө, удирдамж өгөх зэргээр ажилласан байна. 2011 оноос хойш Олон улсын Валютын сангийн Хууль зүйн газрын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүсийн асуудал хариуцсан Сингапур дахь суурин зөвлөх байсан. Энэхүү бүтээлд тэрээр ОУВС-ийн бус харин өөрийн үзэл бодлыг тусгасан болно.

Кевин М.Стивенсон. АНУ-д тусгай агент, мөн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, залилах, мансууруулах бодис наймаалах болон бусад эрүүгийн хэргийн мөрдөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Тэрээр НҮБ-д Косово дахь Санхүүгийн тагнуулын албаны дарга, мөн Тимор-Лесте дахь авлигатай тэмцэх асуудал хариуцсан зөвлөх байсан. Тэрээр Вашингтон ДС-д Дэлхийн банкны

санхүүгийн асуудал эрхэлсэн ахлах шинжээч; Торонтод Санхүүгийн тагнуулын Эгмонт группын гүйцэтгэх нарийн бичгийн дарга; болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хот дахь ФАТФ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн анхны захирлаар тус тус ажиллаж байв. Одоо Сейшилд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан суурин зөвлөх бөгөөд Баруун Кэйс Ресерв их сургуулийн хуулийн факультетэд ажиллаж байна.

Товчилсон үгсийн жагсаалт

ARIN	asset recovery interagency network - Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ
BIC	business identifier code (SWIFT) - Бизнесийг таних код
CARIN	Camden Asset Recovery Inter - Agency Network – Камден Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ
CDD	customer due diligence - Хэрэглэгчийн зохих шалгалт
CHIPS	Clearing House Interbank Payments System – Банк хоорондын төлбөрийн систем
CTR	currency transaction report – Валютын гүйлгээний тайлан
DOJ	Department of Justice (US) - Хууль зүйн яам /АНУ/
ECHR	European Court of Human Rights – Европын хүний эрхийн шүүх
EU	European Union – Европын холбоо
EWHC (Ch.)	England and Wales High Court (Chancery Division) - Англи, Уэльсийн Давж заалдах шатны шүүх /Иргэний тэнхим/
FAC	Federal Administrative Court (Switzerland) – Холбооны Захиргааны шүүх /Швейцар/
FATF	Financial Action Task Force – Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
FCPA	Foreign Corrupt Practices Act (US) - Гадаад улсын албан тушаалтныг хахуульдах хэргийн талаар хууль /АНУ/
Fedwire	Fedwire Funds Service – Фэдвайр сангийн үйлчилгээ
FinCEN	Financial Crimes Enforcement Network (US) – Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ
FIU	financial intelligence unit - Санхүүгийн тагнуулын алба
GFAR	Global Forum on Asset Recovery – Хөрөнгө буцаах Глобал форум
ICJ	International Court of Justice – Олон улсын шүүх
ICSID	International Centre for Settlement of Investment Disputes – Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв
IFO	interim freezing order – Түр царцаах захирамж
ISP	internet service provider - Интернет үйлчилгээ үзүүлэгч
KYC	know your customer (due diligence) – Харилцагчийг таньж мэдэх
LLP	limited liability partnership - Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
MOU	memorandum of understanding – Харилцан ойлголцлын санамж бичиг
MLA	mutual legal assistance - Эрх зүйн харилцан туслалцаа
NCB	non-conviction based (confiscation) - Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах
NGO	nongovernmental organization – Төрийн бус байгууллага
OECD	Organisation for Economic Co-operation and Development – Эдийн засгийн хамтын ажиллагаа ба Хөгжлийн байгууллага
1MDB	1Malaysia Development Berhad (case) – 1Малайзын хөгжлийн Берхад /хэрэг/
PEP	politically exposed person – Улс төрд нөлөө бүхий этгээд
PSC	person/people with significant control (UK) – Онцгой хяналтанд байгаа хүн/хүмүүс /Их Британи/

RICO	Racketeer Influenced and Corrupt Organizations Act (US) – Рикет болон авлигын нөлөө бүхий байгууллагуудын тухай хууль /АНУ/
SAR	suspicious activity report – Сэжигтэй үйлдлийн талаарх тайлан
SEC	Securities and Exchange Commission (US) - Үнэт цаас, биржийн хороо /АНУ/
StAR	Stolen Asset Recovery initiative – Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга
STR	suspicious transaction report - Сэжигтэй гүйлгээний тайлан
SWIFT	Society for Worldwide Interbank Financial Telecommunication – Дэлхийн банкууд хоорондын санхүүгийн харилцааны нийгэмлэг
UN	United Nations – Нэгдсэн Үндэстний Байгууллага
UNCAC	United Nations Convention against Corruption –Авлигын эсрэг НҮБ-ын конвенц
UNODC	United Nations Office on Drugs and Crime – НҮБ-ын Мансуурууллах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба
UNTOC	United Nations Convention against Transnational Organized Crime - Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц
UWO	unexplained wealth order – үндэслэлгүй хөрөнгийн талаарх шийдвэр

Оршил

Бага, дунд орлоготой орнуудын хувьд төрийн өмчийг хулгайлах асуудал нь хөгжлийн асар том саад юм. Ийм эдийн засагтай улсууд болон шилжилтийн үедээ байгаа орнуудаас хулгайлан жил бүр гадаад улсад байршуулан нуусан мөнгөний хэмжээ нь олон улсын санхүүгийн урсгалын нэлээд хувийг эзэлдэг гэсэн тооцоо гарсан байна. (Дэлхийн банк ба НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба 2007). Төрийн удирдагчдын хулгайлсан хөрөнгийн үнийн дүнгээс авлигын нийгэмд учруулсан хохирол нь хамаагүй илүү гарсан байна. Авлига болон санхүүгийн гэмт хэрэг нь төрийн байгууллагуудад итгэх итгэлийг сулруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж, ядуурлыг бууруулах хөтөлбөр, эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээг хүртээх механизмд хөнөөл учруулж байдаг.

Олон улсын хамтын нийгэмлэг энэхүү сорилтод хариу арга хэмжээ авсан билээ. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан гол зорилт болох Зорилт 16-д энх тайван, шударга ёс, хүчирхэг байгууллагууд бол “санхүүгийн болон зэвсгийн хууль бус урсгалыг мэдэгдэхүйц бууруулах, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагааг бэхжүүлэх, бүх төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” (онцлон тодотгож нэмсэн) юм.[1] Хууль бус санхүүгийн урсгалаас хамаарсан хөгжлийн нөөцийн алдагдал нь хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах замаар тогтвортой хөгжлийг хангах бодит хэрэгцээг уялдуулан бий болгож байдгийг дээрх зорилтоор тодорхойлсон байна. Тиймээс сүүлийн 10 жилийн хугацаанд хөрөнгө буцаан авах ажиллагаа нь хөгжлийн чухал асуудал болоод байна.[2]

2005 онд хүчин төгөлдөр болсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенц (UNCAC) нь энэ талаарх олон улсын хүчин чармайлтын нэг юм. Хууль бус хөрөнгийг царцаах, битүүмжлэх, хураан авах, болон авлигын гэмт хэргээс олсон орлогыг буцаан авах зэргээр гишүүн орнууд хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах талаар авах арга хэмжээний хүрээ хязгаарыг Конвенцийн V бүлэгт тусгайлан заасан байдаг. Үүний тулд улс орнууд дараах төрөл бүрийн механизмыг ашиглаж болно. Тухайлбал,

- Хөрөнгө царцаах, хураан авах талаар гаргасан гадаад орны шүүхийн шийдвэрийг шууд биелүүлэх;[3]
- Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах, ялангуяа гэмт хэрэгтэн нас барсан, оргон зайлсан, эзгүй байх, эсхүл бусад зохих тохиолдолд;[4]
- Гишүүн орны үүсгэсэн иргэний хэргийн хувьд нөгөө орныг нэхэмжлэгч тал болохыг хүлээн зөвшөөрч, гэмт хэргийн замаар олсон орлогыг буцаан олгох;[5]
- Мөнгө угаах болон бусад гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэх замаар гадаад улсаас гаралтай хөрөнгийг хураан авах;[6]

---

[1] НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 16-ын 16.4, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн мэдлэгийн платформ https://sdgs.un.org/goals/goal16.

[2] Дэлхийн банк болон НҮБМБХТТА (НҮБ-ын Мансууруулах бодис, хар тамхитай тэмцэх алба). 2013. “Арабын орнуудад хөрөнгө хураан авах ажиллагаа явуулах нь: Дараагийн алхмууд.” Шинэ хэвлэл, 2013 оны 6-р сарын 10. Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (StAR) вэбхуудас. https://star.worldbank.org/news/asset-recovery-arab-world-next-steps.

[3] НҮБАЭК, 54-р зүйлийн (1)(a) болон (2)(a).

[4] НҮБАЭК, 54-р зүйлийн (1)(c).

[5] НҮБАЭК, 53-р зүйл.

[6] НҮБАЭК, 54-р зүйлийн (1)(b) болон 54(2)(b).

- Гишүүн өөр улсад нөхөн төлбөр олгох, хохирлыг барагдуулахыг баталгаажуулсан шүүхийн шийдвэр гаргах, авлигын улмаас олж авсан хөрөнгийн хууль ёсны эзэмшигч болох өөр улсаас гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн зөвшөөрөх.[7]

Энэ утгаараа хөрөнгө буцаан авах ажиллагааг явуулахын тулд дараах хоёр үндсэн арга замыг ашиглах нь зүйтэй:

- Урьдчилан хүсэлт шаардахгүйгээр өөр оролцогч улсад мэдээллийг хүргүүлэх.[8]
- Олон улсын хамтын ажиллагаа болон хөрөнгө буцаан авах.[9]

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагааг хэрэгжүүлэх нь нарийн төвөгтэй ажил юм. Энэ нь дотоодын агентлагуудаас гадна хууль эрх зүйн өөр өөр тогтолцоо, журамтай улсуудын яамд хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбооноос хамаарч байдаг. Түүнчлэн "мөнгийг мөшгих"-тэй холбоотойгоор үндэсний хил хязгаараас давж мөрдөн шалгах ажиллагааг явуулах тусгай техник, ур чадвар болон хөрөнгийг үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлж түргэн шуурхай ажиллах чадвартай байхыг шаарддаг. Үр дүнтэй байдлыг хангахын тулд эрх бүхий байгууллага нь дотоод, гадаадын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, явуулах, өөр улсын эрх бүхий байгууллагад мөрдөн шалгах ажиллагаанд нь зориулан нотлох баримт, тагнуулын мэдээллээр хангах, эсхүл аль алиныг нь хийх чадавхитай байх ёстой. Эрүүгийн хэрэгт хөрөнгө хураан авах, шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах, иргэний нэхэмжлэл гаргах зэрэг хууль зүйн бүх боломжийг харгалзан авч үзэх хэрэгтэй. Энэ үйл явц нь хамгийн туршлагатай салбарын мэргэжилтнүүдийн хувьд ч хэцүү байж болно. юм. Ялангуяа улсын санхүү дампуурахад хүрсэн, авлигад идэгдсэн, эсхүл хязгаарлагдмал нөөц боломжтой бол онцгой хэцүү байдаг.

Үйл явцын энэхүү нарийн төвөгтэй байдал нь салбарын мэргэжилтнүүдэд үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж, туслалцаа үзүүлэх гарын авлага шаардлагатай болохыг тодотгон харуулж байгаа юм. Тиймээс хулгайлагдсан хөрөнгийг илүү системтэй, цаг алдалгүй буцаан авах ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилгоор Дэлхийн банк болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны (UNODC) хамтарсан хөтөлбөр, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (StAR) нь "Олон улсад хөрөнгө буцаах ажиллагааны тухай гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж"-ийн анхны хэвлэлийг 2011 онд гаргасан. (Brun et al. 2011).

Авлигын гэмт хэргийн замаар бий болж, гадаад улсад нуусан хөрөнгийг буцаан авах ажиллагааны явцад тулгардаг стратеги, зохион байгуулалт, мөрдөн шалгах ажиллагааны болон хууль зүйн сорилт бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх арга замыг салбарын мэргэжилтнүүдэд чиглүүлж өгөх маягаар энэхүү гарын авлага бичигдлээ. Гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг буцаан авах ажиллагаанд хэрэглэгдэж байгаа нийтлэг арга барил, салбарын мэргэжилтнүүдэд тулгарч болзошгүй бэрхшээлүүд болон сайн туршлагын талаар танилцуулаа. Хөрөнгө буцаан авах ажиллагааны үе шат бүртэй холбоотой бүх мэдээллийг нэгтгэснээр салбарын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлж, нэгэн баг мэт ажиллахад уг гарын авлага дэмжлэг болох юм.

---

[7] НҮБАЭК, 53-р зүйлийн (b) болон (c).
[8] НҮБАЭК, 56-р зүйл.
[9] НҮБ-ын АЭК, 55 болон 57-р зүйл.

Салбарын мэргэжилтнүүд, сургагч багш нарт зориулагдсан энэхүү гарын авлага нь 10 жилийн турш хүлээн зөвшөөрөгдсөн лавлах болсон тул StAR санаачилга энэ хугацаанд хуримтлуулсан туршлага дээрээ тулгуурлан шинэчлэн боловсруулж, энэхүү хоёр дахь хэвлэлийг гаргахаар шийдсэн юм. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд олон үйл явдал өрнөсөн бөгөөд энэхүү шинэчлэгдсэн хэвлэлд хөрөнгө буцаан авах талаар шинээр гарсан хэргийн жишээнүүд, шинэ сорилтууд, олон оронд нутагшуулсан хууль тогтоомжууд, олон улсын хүчин чармайлтын жишээнүүд болон шинээр гарсан онцгой сайн туршлагуудын талаарх мэдээллийг багтаасан болно.

Аргачлал

Хөрөнгө буцаан авах ажиллагаанд тулгарах асуудал, хууль эрх зүйн зохицуулалт, онолын талаар салбарын мэргэжилтнүүдэд ойлголт, чиглэл өгч туслалцаа үзүүлэх зорилгоор гарын авлагын анхны хэвлэлийг StAR хөтөлбөр боловсруулахдаа энэхүү ажиллагааны нэг болон түүнээс дээш үндсэн чиглэлээр мэргэшсэн ажилтнуудын практикт өдөр тутам гарч байсан туршлагад тулгуурласан. Үүнд хууль сахиулах байгууллагын ажилтнууд, санхүүгийн мөрдөгч, мөрдөх эрх бүхий магистрат, прокурорууд, хувийн хэвшлийн хуульчид болон хөрөнгийн менежерүүд багтана. Гарын авлагад эрүүгийн хэрэгт хөрөнгө хураан авах, шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах, иргэний нэхэмжлэл гаргах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хөрөнгийг мөшгих, олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгийн менежментийн талаар өндөр орлоготойгоос бага, дунд орлого бүхий орнууд, мөн иргэний болон нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудын туршлагын талаар авч үзсэн байна. Зарим асуудал, бэрхшээлтэй тулгарч байсны хувьд тэдгээр сорилтыг даван туулах арга замын талаар өөрсдийн гэсэн санааг гарын авлагын зохиогчид дэвшүүлсэн.

2009 оны 5 дугаар сард Вена хотод зохион байгуулагдсан семинарын үеэр салбарын хэсэг мэргэжилтнүүд энэхүү гарын авлагын ерөнхий хэлбэр болон гол гол сэдвүүдийг тохиролцсон байна. Нэг жилийн дараа Францын Марсель хотод болсон салбарын мэргэжилтнүүдийн хоёр дахь уулзалтын үеэр тэдгээр сэдвийг боловсруулсан төслөө зохиогч нар танилцуулж, хэлэлцүүлсэн. Хоёр дахь семинарын дараа төслийн талаарх нэмэлт санал, зөвлөгөөнүүдийг нэгтгэн, гарын авлагын сүүлийн хувилбарыг өргөтгөсөн бүлгээр хэлэлцэж зөвшөөрсөн байна.

Энэхүү хоёр дахь удаагийн хэвлэлд StAR нь янз бүрийн улс орнуудад сүүлийн 10 жилийн хугацаанд боловсруулсан өөр өөр тогтолцооны талаар авч үзэн, олон улсын түвшинд хамгийн сүүлийн үед гарсан хэргүүд, үйл явдлуудын сургамжийн талаар тусгахыг зорьсон. Шинэчлэгдсэн бүлгүүдийг эрдэмтэн судлаач, салбарын мэргэжилтнүүдээс гадна хууль сахиулах байгууллагын ажилтнууд, санхүүгийн мөрдөгч, мөрдөх эрхтэй магистратууд, прокурор, хувийн хэвшлийн хуульч, хөрөнгийн менежерүүд өөр өөр орны талаарх өөрсдийн туршлагад үндэслэн хянан үзэж, хувь нэмрээ оруулсан юм.

Гарын авлагыг хэрхэн хэрэглэх тухай

Хөрөнгө буцаан авах ажиллагааны талаарх энэхүү гарын авлага нь иргэний болон нийтийн эрх зүйн тогтолцоо бүхий аль ч орны хууль сахиулах байгууллагын ажилтнууд, мөрдөх эрхтэй магистратууд, прокурор, хөрөнгийн менежерүүд болон бодлого боловсруулагч зэрэг салбарын мэргэжилтнүүдийн ширээний ном байж, хэрхэн яаж хийх вэ гэдэгт нь туслах гарын авлага байх хэлбэрээр бүтээгдсэн.

Харилцан ялгаатай эрх зүйн тогтолцооны онцлогоос хамааран нэг оронд тохирсон туршлага, эсхүл стратеги нь нөгөөд тохирохгүй байж болохыг уншигч авхай нар санаж байх хэрэгтэй. Түүнчлэн, нэг улсад зөвшөөрөгддөг мөрдөн шалгах ажиллагааны арга техникийг нөгөө улсад зөвшөөрөхгүй, эсхүл арай өөр процессын шаардлага тавьдаг байж болно. Мөн хууль зүйн ижил ойлголтыг (жишээлбэл, зарим нь "хөрөнгө хураан авах/confiscation", зарим нь "хураах/forfeiture" гэсэн үгийг хэрэглэх) эсхүл процедурыг ("хөрөнгө хураах/seizing" гэсэн үгийг зарим оронд "хязгаарлах/restraining", "хориглох/blocking", "царцаах/freezing", эсхүл "хавсаргах/attaching гэх мэтээр) өөр өөр нэр томъёо хэрэглэн тайлбарладаг. Бас хөрөнгө буцаан авах ажиллагааг хэрэгжүүлдэг хүмүүс улс орнуудад өөр өөр үүрэг, хариуцлагатай байж болно: жишээлбэл, зарим улсад мөрдөн шалгах ажиллагааг магистратууд хийх эрхтэй байдаг бол заримд нь хууль сахиулах байгууллага эсхүл прокурор хийдэг.

Гарын авлагаар эдгээр ялгааг хаана нь байгааг зааж өгөхийг хичээсэн бөгөөд өөр өөр үзэл баримтлал эсхүл практиктай байсан ч ижил хүндрэл, бэрхшээлийг ижил төстэй байдлаар шийдэх шийдлүүд байж болохыг онцолсон байна. Гэвч гарын авлага нь хууль тогтоомж, үйл ажиллагааны дэлгэрэнгүй эмхэтгэл биш юм. Тиймээс салбарын мэргэжилтнүүд уг гарын авлагыг судлахдаа хөрөнгө буцаан авах ажиллагаа амжилттай явуулах арга зам, тулгарч буй бэрхшээлийг тайлбарлахад хэрэглэдэг нэр томьёо, үзэл баримтлалд баригдахгүйгээр өөрийн орны эрх зүйн тогтолцоо, хууль сахиулах бүтэц, нөөц боломж, хууль тогтоомж, журамтай холбон унших хэрэгтэй. Мөн хөрөнгө буцаан авах талаар хамтран ажиллах тухайн орны хууль эрх зүйн тогтолцоо, хууль сахиулах бүтэц, нөөц боломж, эрх зүйн орчин, журмыг ч харгалзан үзэх ёстой.

Энэхүү гарын авлагын гол зорилго нь ялангуяа НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн V бүлэгт дурдсанчлан их хэмжээний авлигаас үүдсэн хөрөнгийг буцаан авахад дэмжлэг болох явдал юм. Гэсэн хэдий ч хөрөнгийг хураах, буцаан авах ажлыг илүү өргөн хүрээний гэмт хэргүүдэд, ялангуяа Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн хөрөнгө хураан авахтай холбоотой заалтуудад тусгасны дагуу хэрэглэх нь зүйтэй.

Энэхүү *Гарын авлага* нь 11 бүлэг, нэр томъёоны тайлбар болон нэмэлт мэдээлэл бүхий 12 хавсралттай. Бүлэг тус бүрээр авч үзвэл:

- *1 дүгээр бүлэг,* "Хөрөнгө буцаах ажиллагааны талаар ерөнхий ойлголт," хөрөнгө буцаан авах ажиллагааг явуулах процесс, хууль зүйн арга замыг практикт гарсан тодорхой жишээн дээр тайлбарласан.
- *2 дугаар бүлэг,* "Хэргийн менежмент, зохион байгуулалтыг хийхэд анхаарах стратегийн асуудлууд," факт болон мэдээллийн анхны эх сурвалжийг цуглуулах, багаа бүрдүүлэх, олон улсын хамтын ажиллагааны гадаад түншүүдтэй харилцаа тогтоох зэрэг кейс боловсруулах, хэргийн менежментийн талаар харгалзан үзэх стратегийн олон асуудлыг танилцуулсан.
- *3 дугаар бүлэг,* "Нотлох баримтыг хамгаалах болон Хөрөнгийг мөшгих (1): Мөрдөн шалгах ажиллагааны арга замууд," салбарын мэргэжилтнүүд хөрөнгийг мөшгих, санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, түүнчлэн хөрөнгө хураан авах хэрэгт найдвартай, үнэлэгдэхүйц нотлох баримтыг хамгаалахад ашиглаж болох арга техникийг танилцуулсан.
- *4 дүгээр бүлэг,* "Нотлох баримтыг хамгаалах болон Хөрөнгийг мөшгих (2): Холбогдох мэдээлэл болон Санхүүгийн баримт бичгүүд," хөрөнгийг буцаан

авахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулах төрөл бүрийн мэдээллийн эх сурвалж, баримт бичгүүдийн талаар, мөн нийтлэг эх сурвалжаас авч болох мэдээллийн жишээнүүд болон тухайн мэдээллийг цэгцлэх, шинжлэхийн ач холбогдлын талаар илэрхийлсэн.

- *5 дугаар бүлэг,* "Хөрөнгийн хамгаалалт," хөрөнгө буцаах ажиллагааны эхэн үед голдуу авч болох түр зуурын арга хэмжээг (хөрөнгө царцаах гэх мэт) авч үзсэн.
- *6 дугаар бүлэг,* "Хураан авсан хөрөнгийн менежмент," түр зуурын арга хэмжээ хэрэглэхээс өмнө болон хөрөнгийг хураан авахаас өмнө хамгаалах төлөвлөгөөг гаргахад салбарын мэргэжилтнүүдийн хувьд анхаарах ёстой хөрөнгийн удирдлагын зарим асуудлуудыг танилцуулсан.
- *7 дугаар бүлэг,* "Хураан авах механизм," хөрөнгө хураан авах янз бүрийн тогтолцоонууд, тэдгээр нь хэрхэн ажилладаг, зарим улсын тогтолцоонд сайжруулах боломжтой процедурын талаар авч үзсэн.
- *8 дугаар бүлэг,* "Хөрөнгө буцаан авахтай холбоотой олон улсын хамтын ажиллагааны гол зарчмууд ба Хамтын ажиллагааны албан бус сувгууд," олон улсын хамтын ажиллагааны сувгууд, мөн "албан бус" буюу захиргааны хамтын ажиллагаа, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт зэрэг боломжтой янз бүрийн аргуудын талаар салбарын мэргэжилтнүүдэд үе шат бүрээр нь тайлбарласан.
- *9 дүгээр бүлэг,* "Олон улсын хамтын ажиллагаа ба Эрх зүйн харилцан туслалцаа," олон улсын хамтын ажиллагааны гол зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцсэн. Энэ бүлэгт албан ёсны туслалцааны үйл явцад анхаарлаа хандуулахын зэрэгцээ улс хооронд хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай явуулахад албан бус болон албан ёсны хэрэгслийг хэрхэн үр дүнтэй хослуулах талаар дэлгэрэнгүй тайлбарласан.
- *10 дугаар бүлэг,* "Иргэний процесс ажиллагаа," иргэний процессоор дамжуулан хөрөнгө буцаан авах ажиллагааг хийх талаар авч үзсэн.
- *11 дүгээр бүлэг,* "Гадаад улсын шүүхийн шийдвэрийн дагуу дотооддоо хураан авах ажиллагаа явуулах процесс," хууль бус хөрөнгийг хураан авах талаарх хүсэлтийг хүлээн авагч улсын дотооддоо явуулдаг процессыг хүсэлт гаргаж буй улс нь хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагаандаа хэрхэн хөшүүрэг болгон ашиглах боломжтой болохыг тус тус зааж өгсөн байна.

Салбарын мэргэжилтнүүд та бүхэн энэхүү гарын авлагын бүлэг тус бүрийн төгсгөл хэсэгт дурдагдсан ном зүй, ишлэлийг анхаарна уу. Түүнчлэн, нэр томъёоны тайлбар нь гарын авлагад тусгагдсан нэлээд олон тусгай нэр томъёог тайлбарлаж өгсөн. Улс орнууд хууль зүйн ижил ойлголт, үзэл баримтлал болон үйл явцыг тайлбарлахдаа ихэвчлэн янз бүрийн нэр томъёог ашигладаг тул тус гарын авлагын нэр томъёоны тайлбар хэсэгт ашиглаж болохуйц хувилбараар тайлбарлаж тусгав.

Хавсралтуудаар салбарын мэргэжилтнүүдэд хэрэгтэй байж болох практик эх сурвалж, нэмэлт мэдээллүүдийг дараах байдлаар авч үзлээ:

- *Хавсралт А* Яллагдагчаар татвал зохих хэргүүдийн жагсаалт
- *Хавсралт В* Сонгон авсан хуулийн этгээд ба бизнесийн нөхцөлүүдийн талаарх тайлбар, нарийвчилсан байдлаар
- *Хавсралт С* Санхүүгийн тагнуулын албаны тайлангийн загвар болон сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг авч үзсэн

- *Хавсралт D* Үзлэг, нэгжлэг хийх, хураан авах талаар шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг төлөвлөхөд шалгах хяналтын асуулгуудыг санал болгосон
- *Хавсралт E болон G* Санхүүгийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа гаргуулан авах тухай шийдвэрийн загвар болон санхүүгийн хувийн хэргийн маягтын загварыг авч үзсэн
- *Хавсралт F* Цахим сангаар халхавчилсан бөгөөд цуврал байдлаар төлбөрийг шилжүүлэх аргууд, электрон санд шилжүүлэг хийхэд корреспондент банкинд хэрэглэгддэг аргууд болон халхавчилсан төлбөрийн талаарх 2009 оны 11 дүгээр сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн стандартыг тус тус авч үзсэн
- *Хавсралт H* Салбарын мэргэжилтнүүд гадаад улсын хамтран ажилладаг байгууллагуудтай харилцаагаа хэрхэн эхлүүлэх талаар дурдсан
- *Хавсралт I* Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн загвар, төслийг боловсруулах болон хүсэлтийг гүйцэтгэх талаар зөвлөмжийг санал болгосон
- *Хавсралт J* Олон улсын болон бүс нутгийн вэбхуудас, бусад цахим эх сурвалжийн талаар өргөн хүрээний мэдээллийг өгсөн
- *Хавсралт K* "Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх удирдамж" (Лозаннагийн удирдамжийн тоймын талаар 2 дугаар бүлэгт хэлэлцсэн)-ийг авч үзсэн байна; Эдгээр удирдамжийн бичиг баримтууд нь хөрөнгө буцаан авах ажиллагааг алхам алхмаар хэрэгжүүлэх ажиллагааг зааж өгсөн
- *Хавсралт L* Дэлхийн банк-НҮБ-ын МБХТТА-ны СтАР хөтөлбөрөөс боловсруулсан Хэргийн электрон менежментийн системийг хэрхэн бий болгож, ашиглах талаар удирдамжийн талаар тус тус өгүүлсэн байна.

Ном зүй

Brun, Jean-Pierre, Larissa Gray, Clive Scott, and Kevin M. Stephenson. 2011. Asset *Recovery Handbook: A Guide for Practitioners.* Washington, DC: World Bank.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc.org / pdf/convention_1988_en.pdf.

UNTOC (United Nations Convention against Transnational Organized Crime), UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25.

World Bank and UNODC (United Nations Office on Drugs and Crime). 2007. "Stolen Asset Recovery (StAR) Initiative: Challenges, Opportunities, and Action Plan." Working paper, Report No. 43854, World Bank, Washington, DC.

1. Хөрөнгө буцаах ажиллагааны талаар ерөнхий ойлголт.

1.1. Удиртгал

Хөрөнгө буцаан авах ажиллагаатай холбогдох хэрэгт гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгслийг хураан авах оновчтой стратеги боловсруулах нь нэн тэргүүнд тавигдах асуудал. Энэхүү стратегийг боловсруулахдаа салбарын мэргэжилтнүүд нь хөрөнгө буцаан авахад хэрэглэж болох эрх зүйн арга зам, хэлбэрүүдийг нарийн тооцоолж, оновчтой хувилбарыг сонгохдоо үүсч болзошгүй хүчин зүйлс, хүндрэл бэрхшээлийг харгалзан үзэх нь зүйтэй. Номын эл бүлэгт хөрөнгө буцаан авах ерөнхий үйл явц, эрх зүйн арга хэлбэрүүдийг товч дурдах бөгөөд удаах бүлгүүдэд дийлэнхийг нь нарийвчлан авч үзэх болно.

1.2. Хөрөнгө буцаах ажиллагааны ерөнхий үйл явц

Хөрөнгө хураан авах ажиллагааг эхлүүлэх эсхүл ахиулахад хэрэглэх эрх зүйн арга хэрэгсэл нь стратегийн ач холбогдолтой нөлөө үзүүлж, хэргийн үр дагаварт ч чухал үүрэг гүйцэтгэх хандлагатай байдаг тул мэргэжилтнүүд нь хэргийн стратегийг нэн даруй боловсруулах шаардлагатай. Ингэхдээ, эрүү, иргэн, захиргаа, шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах, эсхүл иргэний хувийн маргаан үүсгэх, гадаадын улс оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх замаар хөрөнгө буцаан авах ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой. Эдгээр бүх арга хэлбэр нь процесс ажиллагааны хэлбэрийн хувьд ялгагдах ч агуулга нь хоорондоо төстэй юм. Зураг № 1.1-д энэ процессыг дүрсэлж, 1.2.1-1.2.6 дэд хэсэгт нарийвчлан тайлбарласан.

1.2.1 Мэдээ сэлт, нотлох баримтууд цуглуулах, хөрөнгө тогтоох ажиллагаа

Мэдээ сэлт цуглуулах, мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэх үе шатад шинжээчид болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид нь мэдээ сэлт, нотлох баримт цуглуулж, хөрөнгө тогтоож, илрүүлдэг. Прокурорууд эсхүл шүүгчид нь энэхүү процессыг хянаж, удирдан чиглүүлдэг. Харин иргэний эрх зүйн арга замыг хэрэглэх бол хувийн мөрдөгчид эсхүл ашиг сонирхол бүхий гуравдагч этгээдийг татан оролцуулах боломжтой. Нээлттэй мэдээллийн эх сурвалжийг цуглуулаад зогисохгүй хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл, Санхүүгийн тагнуулын албаны санхүүгийн мэдээллийн сан, авлигатай тэмцэх болон хөрөнгө буцаан авах ажиллагааг хариуцах нэгжүүд, газрын эрхийн бүртгэл, аж ахуйн нэгж (ААН)-ийн бүртгэл зэрэг Засгийн газрын мэдээллийн санг ашиглаж, мөн хууль сахиулах байгууллагын алба хаагч нар нь мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга техникийг ч ашиглах боломжтой.

Албадлагын арга хэмжээний хэлбэрээс хамаараад прокурор эсхүл шүүгчийн зөвшөөрөл гаргуулах шаардлага үүсч болзошгүй (тухайлбал, цахим ажиглалт, нэгжлэг, битүүмжлэл хийх зөвшөөрөл, бичиг баримт гаргуулах захирамж, эсхүл дансны үйл ажиллагааг хянах захирамж гэх мэт). Бусад хэлбэрийн ажиллагаанд

удирдах албан тушаалтны зөвшөөрөл авахад хангалттай байж болно. Тэр ч байтугай, зарим ажиллагаанд урьдчилан зөвшөөрөл авах шаардлага үүсэхгүй ч байж болно (жишээ нь, биет ажиглалт, нээлттэй мэдээллийн эх сурвалж, гэрчээс мэдүүлэг тайлбар гаргуулах гэх мэт).

ЗУРАГ 1.1 Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах процесс

Эх сурвалж: Дэлхийн Банк.
Тэмдэглэл: ЭЗТХҮ=Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх

1.2.2 Хөрөнгө хамгаалах ажиллагаа

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хураан авахаар төлөвлөж буй эд хөрөнгийг үрэгдүүлэх, шилжүүлэх, эсхүл устгахаас урьдчилан сэргийлэх зорилгоор түр зуурын арга хэрэгслийг ашиглан хамгаалах шаардлагатай. Зарим Эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах улс орнуудад, хөрөнгө царцаах, битүүмжлэх зэрэг хөрөнгө хамгаалах түр зуурын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг прокурорууд, мөрдөгч магистратууд, эсхүл хууль сахиулах агентлагууд гаргах бүрэн эрх эдэлдэг. Жич, энэхүү эрх зүйн бүлд харьяалагдах ч түр зуурын арга хэмжээ хэрэгжүүлэхэд шүүхээс зөвшөөрөл гаргуулах шаардлага ч үүсдэг. Нийтийн эрх зүйн бүлд харьяалагдах улс орнуудад хөрөнгө царцаах эсхүл битүүмжлэхэд шүүхээс зөвшөөрөл гаргуулах шаардлага тавигддаг (хөрөнгө царцаах зарим онцгой тохиолдлыг эс тооцвол).

1.2.3 Олон улсын хамтын ажиллагаа

Хулгайлагдсан хөрөнгийг ихэвчлэн гадаадын улс орон руу шилжүүлэх эсхүл нуун далдлах нь түгээмэл ажиглагддаг тул хөрөнгө буцаан авах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааг үр дүнтэйгээр гүйцэтгэх нь зайлшгүй байдаг. Үүнийг, нотлох баримт цуглуулах, түр зуурын хязгаарлалт хийлгэхээс эхлээд гэмт хэргийн гаралтай эд хөрөнгө, хэрэгслийг хураан авах, хүсэлт уламжилсан хохирогч улс руу хураагдсан хөрөнгийг буцаан олгох хүртэлх бүхий л үе шатад амжилттай хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү номын 8 болон 9 дүгээр бүлэгт олон улсын хамтын ажиллагааг дэлгэрэнгүй авч үзэж, "албан бус"[1] болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх (ЭЗТХҮ) замаар үзүүлэх олон улсын хамтын ажиллагаа гэж ангилсан.

Албан бус хамтын ажиллагаанд төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа эсхүл диагнал харилцаа холбоогоор дамжуулан, холбогдох хууль журмын хүрээнд хууль сахиулах байгууллагууд, Санхүүгийн тагнуулын албад, хууль эрх зүйн болон шүүх тогтолцооны байгууллагуудын хамтын ажиллагаа багтдаг. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны эхний үе шатад мэдээ сэлт цуглуулах анхдагч арга хэрэгсэл болдог. Харин албан журмын хамтын ажиллагаанд нотлох баримт гаргуулахтай холбоотой бичгээр үйлдсэн хүсэлт (албадлагын шинжтэй ажиллагааг оруулаад), түр зуурын арга хэмжээ хүсэмжлэх, гадаад улсын эрх бүхий байгууллагаас дотоодод хүчин төгөлдөр захирамж гаргуулах орно. Эрх зүйн уламжлалын хүрээнд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд дотоодын шүүх хуралд хэрэглэж болохуйц нотлох баримтыг гадаад улс орноос гаргуулах явдал оршиж байв. Орчин үед энэ хэлбэрийн эрх зүйн туслалцааны хэрэглээ өргөжиж, албадлагын арга хэмжээ эсхүл шүүхийн захирамжаар дамжуулан нотлох баримтыг гадаад улс нь хүсэлт шилжүүлсэн улсад мөрдөн шалгах ажиллагааны үе шатад ч гаргаж өгөх болж байна.

Албан бус болон албан журмын хамтын ажиллагааг нэн даруй хэрэгжүүлэх нь хөрөнгө амжилттай буцаан авахад асар их ач холбогдолтой. "Албан бус хамтын ажиллагаа" нь албан журмын хамтын ажиллагаа шаардагдах тохиолдолд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийн үндэс нь болдог. Албан бус хамтын ажиллагааг хэрэгжүүлээгүй үед дийлэнхи хэрэг нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг боловсруулах хэмжээнд хүрэхгүй бөгөөд даалгавар ч цаг хугацаандаа багтаж, амжилттай хэрэгжих боломж бүрдэхгүй (Nainappan 2019). Мөн, албан бус хамтын ажиллагаагаар албан журмын эрх зүйн туслалцаа хүсэмжлэх шаардлагатай эсэх болон хэрэгжүүлэх арга замыг ч тодорхойлох боломж бүрдэнэ. Иймээс олон улсад хөрөнгө амжилттай буцаан авах ажиллагаа нь албан бус болон албан журмын хамтын ажиллагааг хэрхэн үр дүнтэйгээр хавсруулан хэрэглэснээс шууд хамаарна. Шаардлагатай тохиолдол бүрт олон улсын шинжтэй асуудлыг сайтар харгалзан үзсэн эсэхээ баталгаажуулахад 8, 9 дүгээр бүлэг болон 2-7 дугаар бүлгүүд (дотоодод хийгдэх ажиллагаануудыг дурдсан)-ийг судлахыг зөвлөж байна.

---

[1] Энэхүү номонд ***"албан бус эрх зүйн туслалцаа"***-нд ЭЗТХҮ хүсэлт уламжлах шаардлагагүйгээр үзүүлэх бүх төрлийн эрх зүйн туслалцааг оруулсан болно. Энэ төрлийн албан бус, ижил төстэй мэргэжилтнүүдийн хооронд үзүүлдэг эрх зүйн туслалцааг ЭЗТХҮ хууль тогтоомжид тодорхойлж, эрх бүхий байгууллагууд, агентлагууд, эсхүл захиргааны нэгжүүдийг оруулж болно. Номын 8 дугаар бүлэгт, албан бус хамтын ажиллагааны талаар авч үзсэн ба ЭЗТХҮ хүсэлттэй холбоотой процесстой харьцуулсан байна.

1.2.4 Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх

Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн хэргийн яллах шийдвэр/тогтоол гаргуулах, шүүхийн шийдвэргүйгээр улсын орлого болгох, эсхүл иргэний эрх зүйн хувийн маргаан үүсгэх (удаах бүлгүүдэд нэг бүрчлэн тайлбарласан)-ийг хамардаг. Хөрөнгө хураан авахад эд хөрөнгө эсхүл хөрөнгийн үнэлгээнд суурилсан гэсэн хоёр хувилбарыг ашигладаг. Эд хөрөнгөн дээр суурилсан хөрөнгө хураан авах ажиллагааны объект нь гэмт хэргийн улмаас олсон орлого болон үүнийг үйлдэхэд ашигласан хэрэгсэл байдаг тул эд хөрөнгө болон гэмт хэргийн хоорондох шалтгаант холбоог нотлох шаардлага тавигддаг. Харин удаах хувилбар нь гэмт хэргийн гаралтай хөрөнгө орлогыг хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны эд хөрөнгөтэй хольж, хууль бус гарал үүслийг нь нуун далдлах эсхүл будлиантуулах зорилготой байх тул нотлоход төвөгтэй байдаг.

Үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах аргыг гэмт хэргийн “орлого ашиг”-тай холбогдох зохицуулалт гэж нэрийдэх нь түгээмэл бөгөөд үүгээр гэмт хэргийн улмаас олсон ашиг орлогын үнэлгээг тодорхойлж, үүнтэй дүйцэх хөрөнгийг шүүгдэгчийн “гэмт бус хэргийн гаралтай” эд хөрөнгөөс ч гаргуулах боломжтой байдаг онцлогтой. Зарим улс орнууд нь хөрөнгө хураан авах өндөржүүлсэн арга хэрэгслийг ашиглах бөгөөд үүнд хөрөнгө хураан авах нэмэлт зохицуулалтууд эсхүл эрх зүйн презумпци ашиглаж хөрөнгө хураан авахад тавигддаг нотолгооны босгыг хөнгөвчлөх боломж бүрддэг.

1.2.5 Шүүхийн шийдвэр /захирамж гүйцэтгэх

Шүүхээс хөрөнгө царцаах, битүүмжлэх, өмч шилжүүлэх хөдөлгөөнийг хязгаарлаж, эсхүл хөрөнгө хураан авах захирамж/шийдвэр гарсаны дараа шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа хийгдэнэ. Эд хөрөнгө нь гадаад улсад оршиж байгаа тохиолдолд гадаадын эрх бүхий байгууллага нь тухайн улсын шүүхийн шийдвэрийг дахин хянан хэлэлцэлгүйгээр дотоодын шүүх нь хүлээн зөвшөөрч эсхүл бүртгэж, гүйцэтгэх ёстой (шүүхийн шийдвэрийг шууд гүйцэтгэх). Жич, гадаадын шүүх нь дотоодын шүүхдээ хөрөнгө царцаах, битүүмжлэх, эсхүл хураан авах захирамж гаргах тохиолдол ч бий (шүүхийн шийдвэрийг шууд бусаар гүйцэтгэх). Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенци (АЭНҮБК) нь улс орнуудыг хөрөнгө хураан авахтай холбоотой гадаадын шүүхийн шийдвэр/захирамжийг дотооддоо шууд гүйцэтгэхийг зөвлөсөн байдгийг анхаарууштай юм.[2] Энэхүү үйл ажиллагааг ихэвчлэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт уламжлах замаар хэрэгжүүлдэг (олон улсын хамтын ажиллагаа сэдэвт 1.2.3 дугаар хэсэгт дурдсан).

1.2.6 Хөрөнгө буцаан олгох ажиллагаа

Гадаадын улс оронд хөрөнгө хураан авах эцсийн шийдвэрийг хүсэлт гаргагч улс нь Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн 54, 55, 57 дугаар зүйлийг хэрэглэж, холбогдох эд хөрөнгийг буцаан авах боломжтой. Конвенцийн эдгээр зүйлийг бүрэн хэрэглээгүй тохиолдолд хөрөнгө нь хүсэлт гаргагч улсын

[2] АЭНҮБК-ийн 54 болон 55 дугаар зүйл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенцийн 13 дугаар зүйл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн **эсрэг** нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 5 дугаар зүйл, Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенцийн 8 дугаар зүйл, хөрөнгө царцаах, битүүмжлэх асуудлаар АЭНҮБК-ийн 54.2 дугаар зүйлийг харна уу.

төрийн сан эсхүл хураан авсан хөрөнгийн санд төвлөрч болзошгүй. Үүнтэй холбогдуулан, уг конвенцид улс орнууд нь хөрөнгө буцаан авах тодорхой механизмыг бүрдүүлсэн байхыг шаарддаг байна.

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн 57 дугаар зүйлд хүсэлт хүлээн авсан улс нь гадаад улсын шүүхийн хөрөнгө хураан авах эцсийн шийдвэрийг дотооддоо гүйцэтгэж, төсвийн хөрөнгийг шамшигдуулах эсхүл холбогдох хөрөнгийг угаасан хэргүүдэд аливаа нөхцөлт болзол тавилгүйгээр шууд буцаан олгохыг зохицуулсан байдаг. Тус конвенцийн бусад зүйл ангийн гэмт хэргүүдийн хувьд хүсэлт хүлээн авсан улс нь гадаадын шүүхийн хөрөнгө хураан авах шийдвэрийг дотооддоо гүйцэтгэж, хүсэлт уламжилсан улс нь холбогдох эд хөрөнгийн өмчлөлөө урьдчилан хангалттай хэмжээнд тогтоож эсхүл хүсэлт хүлээн авсан улс нь хүсэлт гаргасан улсын хохирлыг хүлээн зөвшөөрсөн үед хөрөнгө буцаан олгох ажиллагаа явагддаг.

Хүсэлт гаргагч улсын шүүхээс гаргасан хөрөнгө хураан авах шийдвэр /захирамж байхгүй зэрэг бусад бүх тохиолдолд, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенци нь хүсэлт хүлээн авагч улс нь хүсэлт гаргагч улс руу хөрөнгө буцаан олгох, хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид буцаан олгох эсхүл авлигын гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулах асуудлыг “нэн тэргүүнд тавих” үүргийг хүлээлгэдэг байна. Энэ тохиолдолд хөрөнгө буцаан олгох зохицуулалт нь тухайн улсын дотоодын хууль тогтоомж, холбогдох олон улсын конвенци, бүс нутгийн гэрээ хэлцэл, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, эсхүл бусад онцгой гэрээ хэлцэл (хөрөнгө хуваах гэрээ хэлцэл зэрэг)-ийн хүрээнд хэрэгждэг. Жич, хүсэлт гаргагч улс руу буцаан олгох хөрөнгөөс хүсэлт хүлээн авагч улсын гаргасан хөрөнгө царцаах, битүүмжлэх, хураан авсан хөрөнгийн хадгалалт хамгаалалт, худалдан борлуулалт, мөрдөн шалгах, яллах, эсхүл шүүхээр хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой үүссэн зардал, мөн Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид дурдсаны дагуу шүүгдэгчийн эрх зүйн болон амьжиргааны зардлыг ч суутгадаг байна.

Авлига, эсхүл нийтийн өмчийг завшсан, шамшигдуулсан хэргүүдтэй холбогдох хөрөнгө хураан авахад хэд хэдэн бодлогын асуудал тулгарах хандлагатай. Хүсэлт хүлээн авагч улс нь хөрөнгө буцаасны дараа хүлээн авагч улсад тухайн хөрөнгийг дахин шамшигдуулах эрсдэл байж болзошгүй гэж болгоомжлох тохиолдол гардаг. Нэн ялангуяа, хүсэлт гаргагч улсад авлигын үзүүлэлт өндөр хэвээрээ байгаа эсхүл шинээр хийгдсэн авлигын үнэлгээ нь дахин өндөр гарсан, хэрэгт холбогдох этгээд нь албан тушаалаа үргэлжлүүлэн хашиж, их хэмжээний нөлөөтэй байсаар байгаа нөхцөл байдлыг харгалзан үздэг ажээ. Мөн түүнчлэн, хүсэлт хүлээн авагч улс нь хураан авсан хөрөнгийг хэрхэн зохицуулахтай холбоотой тусгай гэрээ хэлцэл хийх шаардлага тавих тохиолдол ч бий. Зарим тохиолдолд Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллагууд нь хөрөнгө буцаах ажиллагаа, буцаан олгосон хөрөнгөд хяналт тавьдаг. Номын 11 дүгээр бүлгийн Шигтгээ 11.7-д Казакстанд БОТА Сан (BOTA Foundation) гэх тусгай чиг үүрэгтэй хуулийн этгээдийг үүсгэн байгуулж, авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг тус улс руу буцаан олгох ажиллагааг ил тод, нээлттэй болгож, Казакстаны эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх чиглэлээр энэхүү хөрөнгийг тус улсад захиран зарцуулах асуудлыг баталгаажуулсаныг дурдсан.

Хүсэлт хүлээн авагч улсын дотоодын шүүхийн шийдвэрийн хүрээнд хураасан хөрөнгийг хүсэлт гаргагч улс руу шууд шилжүүлэх (“шууд олгох”) тохиолдол ч

бий.[3] Иргэний шүүхийн хувийн нэхэмжлэл үүсгэх замаар хүсэлт хүлээн авагч улсын шүүх нь хохирогч улсад нөхөн төлбөр эсхүл хохирлыг шууд барагдуулах шийдвэр гаргаж болно. Мөн, хүсэлт хүлээн авагч улсын шүүх нь эрүүгийн эсхүл шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах хэрэгт холбогдох шийдвэрийн дагуу хохирогч улсад нөхөн төлбөр эсхүл нөхөн олговор шууд олгохыг захирамжилж болно. Хөрөнгө хураан авах асуудлыг хянан хэлэлцэх явцад зарим шүүхүүд нь хохирогч улсын нэхэмжлэлийг тухайн хөрөнгийн хууль ёсны эзэмшигч гэж хүлээн зөвшөөрөх эсэх бүрэн эрх эдэлдэг.

Эрүүгийн хэргийн шүүгдэгч нь дампуурлаа зарласан тохиолдолд (эсхүл шүүгдэгчийн ашигласан ААН нь төлбөрийн чадваргүй бол), дампуурлын албан ёсны журам зохицулалтын хүрээнд залилангийн шинжтэй үйл ажиллагаа, гүйлгээтэй холбоотой хөрөнгө хураан авах арга хэрэгслийг ашиглан хөрөнгө хураан авах боломжтой. Эдгээр механизмыг 9, 10, 11 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

1.3 Хөрөнгө буцаах ажиллагааг хийх эрх зүйн арга замууд.

Хөрөнгө хураан авахад олон төрлийн эрх зүйн арга замуудыг хэрэглэх боломжтой. Дотоодын эсхүл олон улсын шинж чанартай хэрэг эсэхээс хамааран дараах механизмууд ордог. Үүнд:

- Эрүүгийн хэргийг дотооддоо яллаж, дотоодын шүүхийн шийдвэр гарсаны дараа шүүхийн шийдвэрийг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээр дамжуулан гадаад улсад гүйцэтгэх.[4]
- Шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах шийдвэр дотооддоо гаргаж, уг шийдвэрийг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээр дамжуулан гадаад улсад гүйцэтгэх.
- Иргэний хувийн нэхэмжлэл үүсгэх (албан ёсоор дампуурлаа зарлаж, төлбөрийн чадваргүй болсонтой холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа).
- Захиргааны журмаар хөрөнгө хураан авах.
- Татвар, торгууль, эрүүгийн хэргийн шүүхээс нөхөн төлбөр гаргаж өгөх шийдвэр зэрэг бусад арга зам.

ШИГТГЭЭ 1.1 Хөрөнгө буцаан авах эрх зүйн арга хэрэгслүүд

Хууль тогтоомж, процессын хуулиуд (дотоодын болон гадаад улсад):

- Эрүүгийн хууль тогтоомжийн авлига, завших үрэгдүүлэх, шамшигдуулах, мөнгө угаах гэмт хэргийн зүйл ангиуд.
- Эрүүгийн процессын хуулиуд (мөрдөн шалгах бүрэн эрх, нэгжлэг хийх, битүүмжлэх гэх мэт).

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[3] АЭНҮБК-ийн 53 дугаар зүйлд гишүүн орнууд нь хөрөнгө шууд хураан авах ажиллагааг харилцан зөвшөөрөхийг шаардсан байдаг.

[4] Шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авахыг бүх улс орнууд хүлээн зөвшөөрөөгүй байгаа.

ШИГТГЭЭ 1.1 Хөрөнгө буцаан авах эрх зүйн арга хэрэгслүүд

- Түр зуурын арга хэмжээ ба хөрөнгө хураан авах зохицуулалтууд (жишээ нь, эрүү, шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах, захиргааны гэх мэт).
- Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зүйл заалтууд (нөхөн олговор гэх мэт).
- Иргэний хуулийн зүйл заалтууд (нөхөн олговор гэх мэт).
- Хөрөнгө хуваалцах тухай хууль тогтоомжууд, журам зохицуулалтууд.
- Бусад холбогдох хууль тогтоомжууд (үүнд, гэмт хэргийн гаралтай хөрөнгө орлогын тухай хууль, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах тухай хууль, татварын хуулиуд зэрэг багтана.)

Олон улсын конвенц, олон талт гэрээ хэлцлүүд[a]

(баталсан огноо, хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн огноо)

Нэгдсэн Үндэстэний Байгууллага (НҮБ)

- Авлигын эсрэг НҮБ-ийн конвенц (АЭНҮБК) (2003/2005).
- Мансуурах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц (1988/1990).
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц (2000/2003) болон нэмэлт протоколууд.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (Organization for Economic Co-operation and Development)

- Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Гадаад улсын нийтийн албан хаагчдын олон улсын бизнес харилцаан дахь авлигын эсрэг конвенци (1997/1999, "Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг конвенц" гэх).

Америкийн улсуудын байгууллага

- Авлигын эсрэг Америк тивийн улс хоорондын конвенц (1996/1997).
- Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Америк тивийн улс хоорондын конвенц (1992/1996).

Европын Холбоо болон Европын Консулын эрх зүйн зарим арга хэрэгслүүд

- Иргэний болон худалдааны маргааны шүүхийн харьяалал тогтоох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Брюсселийн конвенц (1968/1973, "Брюсселийн конвенц").

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.1 Хөрөнгө буцаан авах эрх зүйн арга хэрэгслүүд

- Европын Консулын Гэмт хэргийн ашиг орлогыг угаах, илрүүлэх, царцаах, хураан авах тухай конвенц (1990/1993) болон Европын Зөвлөл (шинэ)-ийн Гэмт хэргийн улмаас олсон ашиг орлогыг угаах, илрүүлэх, царцаах, хураан авах болон Терроризмыг санхүүжүүлэх тухай конвенц (2005/2008).
- Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын конвенц (1959/1962) болон нэмэлт протоколууд (1962).
- Европын холбоонд Хөрөнгө болон баримт нотолгоог битүүмжлэх захирамж хэрэгжүүлэх тухай Европын холбооны зөвлөлийн шийдвэр 2003/577/JHA (2003).
- Европын улс орнууд ба ЕХ-ны гишүүн орнуудын ажилтнууд оролцсон авлигын гэмт хэрэгтэй тэмцэх тухай ЕХ-ны гэрээ хэлцлийн K.3(2)(c) заалтад тулгуурлан гаргасан Конвенц (1997).
- Европын Зөвлөлийн авлигын гэмт хэрэгт холбогдох эрүүгийн хуулийн конвенц (1999/2003).
- Хөрөнгө хураан авах захирамж/шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх журмыг хэрэгжүүлэх тухай Европын Холбооны Зөвлөлийн шийдвэр 2006/783/JHA (2006).
- Иргэний болон худалдааны маргааны шүүхийн харьяалал тогтоох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай ЕХ-ны журам №1215/2012 (Брюсселийн I дүгээр журмыг шинэчлэн найруулсан) (2012).
- ЕХ-нд Гэмт хэргийн гаралтай хөрөнгө, түүний арга хэрэгслийг царцаах, битүүмжлэх тухай Европын Парламент ба Европын Зөвлөлийн шийдвэр №2014/42/EU (2014).
- Хөрөнгө битүүмжлэх, хураан авах тухай шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Европын Парламент ба Европын Зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2018/1805 дугаартай ЕХ-ны журам.

Африкийн Холбоо

- Авлига болон холбогдох бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай Африкийн Холбооны конвенц (2003/2006).

Бүс нутгийн бусад гэрээ хэлцлүүд

- Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Зүүн хойд-Азийн гэрээ хэлэлцээр (2004).
- Авлигын эсрэг Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэгийн протокол (2001).

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.1	Хөрөнгө буцаан авах эрх зүйн арга хэрэгслүүд

- Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэгийн протокол (2002/2007).
- Иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн гэрээ (1993/1994, "Минскийн конвенц"), 1997 онд шинэчлэн найруулсан).

Эрх зүйн харилцан туслалцааны хоёр талт гэрээ хэлцлүүд

Улс орнууд нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт гэрээ хэлцэл байгуулж, үзэглэсэн байж болно.

а. Интернет орчинд нээлттэй вэбсайтын эх сурвалжийн жагсаалтыг Хавсралт J-аас харна уу.

Эрх зүйн эдгээр арга замыг хэрэглэх боломж нь тухайн хэрэг дотоодын төдийгүй гадаадын элементтэй эсэх, улмаар дотоод болон гадаад улсын хууль тогтоомж, журам зохицуулалт болон хоёр талт, олон талт гэрээ хэлцэл, конвенцоос хамаардаг. Хөрөнгө хураах, буцаан авах ажиллагаа нь олон төрлийн эрх зүйн зохицуулалтыг хамрах хандлагатай бөгөөд ялангуяа улс дамнан үйлдэгдсэн хэрэгт нилээд хэдэн хөрөнгө хураан авах тухай хууль тогтоомжийг хамардаг. Шигтгээ 1.1-д салбарын мэргэжилтнүүдийн хэрэглэж болохуйц хууль тогтоомжууд болон олон улсын арга хэрэгслийг дурдсан. Энэхүү мэдээлэлд салбарын хүрээнд хэрэглэж болохуйц улс орнуудын дотоодын бүх хууль тогтоомжууд болон олон улсын бүх гэрээ хэлцлийг агуулаагүй болохыг анхаарна уу.

Хууль тогтоомжийг анхаарахаас гадна эрх зүйн арга замаа сонгохдоо эрх зүйн, практикийн, эсхүл үйл ажиллагааны бодит нөхцөл байдлыг зайлшгүй харгалзан үзэх ёстой. Үйл ажиллагааны чиглэл, төрлийг хэргийн стратеги боловсруулахдаа шийдвэрлэсэн байх шаардлагатай бөгөөд эдгээр давуу болон сул талууд, тухайн улс орны онцлогийг ч тооцоолон төлөвлөх шаардлагатай. Хүндрэл, хэргийн менежментийн асуудал зэрэг стратеги боловсруулахад харгалзах зүйлсийг Номын 2 дугаар бүлэгт дурдсан болно.

1.3.1 Эрүүгийн хэрэгт ял шийтгэл ногдуулах ба шийтгэх тогтоолд үндэслэн хөрөнгө хураан авах тухай

Эрх бүхий байгууллагууд нь эрүүгийн хэрэг үүсгэж хөрөнгө хураан авахаар шийдвэрлэсэн тохиолдолд эрүүгийн хэргийн ял шийтгэлд үндэслэж хөрөнгө хураан авах боломж бүрддэг. Салбарын бүхий л мэргэжилтнүүд нь эд хөрөнгөтэй холбогдох нотлох баримтыг цуглуулж, хөрөнгө тогтоож, хамгаалах ажиллагааг гүйцэтгэж, холбогдогч этгээд (хувь хүн эсхүл хуулийн этгээд)-ийг яллах ажиллагааг эхлүүлж, улмаар хэргээ шүүхээр шийдүүлэх шаардлагатай. Шүүх нь хэрэгт холбогдох ял шийтгэлийг тодорхойлсоны дараа хөрөнгө хураан авах шийдвэр мөн шүүхээс гарна.

Зарим улсад хөрөнгө хураан авах шийдвэр гаргуулахад шаардагдах нотолгооны стандарт нь эрүүгийн хэрэгт ял шийтгэл гаргуулахад тавигддаг нотолгооны босгоос

доогуур байдаг. Тухайлбал, Их Британид, хөрөнгө хураан авах шийдвэр гаргуулахад “магадлалын тэнцвэрт харьцаа” гэх нотолгооны стандарт хангалттай байхад эрүүгийн хэрэгт яллах шийдвэр гаргуулахад “хөдөлбөргүй нотлогдсон” гэх нотолгооны стандарт тавигддаг байх жишээтэй. Жич, бусад улсууд нь хөрөнгө хураан авах болон эрүүгийн хэрэг яллах шийдвэр гаргуулахад хоёуланд нь ижил түвшний өндөр нотолгооны стандарт тавьдаг (“хөдөлбөргүй үнэн нь нотлогдсон”) (Нийтлэг болон эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах улс орнуудын нотлох баримтад тавигдах стандартыг номын 2 дугаар бүлгийн 2.8.5 дугаар хэсгийн Зураг 2.1-д тайлбарлан оруулав). Ерөнхийдөө, өндөржүүлсэн эсхүл өргөтгөсөн хөрөнгө хураан авах зүйл заалтууд[5] хэрэглэгдэхгүй тохиолдолд бусад хууль тогтоомжийн хүрээнд гэмт хэрэгтэй холбон тогтоох боломжтой арга хэрэгсэл, орлого, бусад ашиг хонжоог шууд болон шууд бусаар хураан авах бололцоо бүрддэг.

Олон улсын хамтын ажиллагаа (албан бус болон албан журмын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ороод) нь гадаад улсад орших хөрөнгийг тодорхойлох, тогтоох, хамгаалах болон хөрөнгө хураан авах тухай шүүхийн эцсийн шийдвэрийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагддаг.[6] Ихэнх улс албан журмын эрх зүйн харилцан туслалцааг зөвхөн эрүүгийн гэмт хэрэгт үзүүлдэг байна.

Эрүүгийн хэрэг яллах ба холбогдох эд хөрөнгийг хураан авах ажиллагааны нэгэн давуу тал нь авлигыг гэмт хэргийн шинж чанартай болох, шүүгдэгчид хариуцлага тооцох асуудлыг нийгэм хүлээн зөвшөөрч байгаа явдал юм. Улмаар хорих, торгох, хөрөнгө хураан авах ял шийтгэл нь гэмт хэрэгтнүүдийг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, таслан зогсоох ач холбогдолтой. Мөн эрүүгийн гэмт хэргийн мөрдөгчид нь хууль сахиулах байгууллагууд болон Санхүүгийн тагнуулын алба (СТА)-ын мэдээллийн сан зэрэг мэдээ, тагнуулын мэдээлэл цуглуулах, нэгжлэг хийх, электрон тоног төхөөрөмжид ажиглалт хийх, санхүүгийн бичиг баримтуудыг шалгах, эсхүл гуравдагч этгээдэд агуулагдах бичиг баримтад нэвтрэх зэрэг албадлагын арга хэмжээ болон тангарагтны шүүхээр хэргийг урьдчилан хянуулах, шүүхэд зарлан дуудах бичиг гардуулах, шүүхэд дуудах, гэрчийн мэдүүлэг эсхүл нотлох баримт гаргуулах зэрэг бусад албадлагын шинжтэй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх боломжоор хангагдсан байдаг.

Жич эрүүгийн хэргийг шүүхээр шийдүүлэх эсхүл хөрөнгө хураан авахад нотлох баримт дутуу, хүчин чадал ба улс төрийн хүсэлт зориг дутагдах, цаг хугацаа хомс байх (хөөн хэлэлцэх хугацаа) зэрэг томоохон сорилт тулгарч болзошгүй. Үүн дээр нэмээд, шүүгдэгч нь нас барсан, оргон зугтсан, эсхүл дархан халдашгүй эрх ямба эдэлж байгаа тохиолдолд эрүүгийн ял шийтгэл гаргуулах боломжгүй байдал үүсдэг. Мөн ЭЗТХҮ хүсэлт уламжилсан хүлээн авагч улс нь тухайн гэмт

---

[5] *“Өргөтгөсөн хөрөнгө хураан авах зүйл заалтууд”*-ын шинж чанар, зохицуулалтыг номын 7 дугаар бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн. Өндөржүүлсэн гэх ойлголтод а. Гэмт хэргийн гаралтай хөрөнгө орлогыг гээгдүүлсэн эсхүл үрэн таран хийсэн тохиолдолд уг гэмт хэрэгтэй холбогдолгүй ч “орлох эд хөрөнгийг хураан авах тухай зүйл заалтууд”-ыг хэрэглэдэг, б. Тодорхой нөхцөлд хууль бусаар ашигласан эсхүл үүсэж бий болсон эд хөрөнгийг магадлан тооцоолох, в. Тодорхой гэмт хэргийн улмаас олсон хууль бус ашиг хонжоог магадлан тооцоолох, г. Тодорхой тохиолдолд нотлох үүргийг шилжүүлэх механизмыг хэрэглэх.

[6] АЭНҮБК-ийн 54.1.а, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенцийн 13.1.а дугаар зүйл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 5.4.а дугаар зүйлийн хүрээнд гишүүн орнуудад гадаад улсын шүүхийн захирамж, шийдвэрийг дотооддоо гүйцэтгэх шаардлага оногдуулсан байдаг.

хэргийг дотооддоо гэмт хэрэгт тооцоогүй тохиолдолд даалгавраар эрх зүйн хүсэлт хүсэмжилсэн үйл явдлыг гэмт хэрэгт тооцохгүй байх нөхцөл бүрддэг (хоёр улс хоёулаа тус үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг гэж тооцохыг шаарддаг олон улсын эрх зүйн зарчим-Dual Criminality). Эдгээр болон бусад саад бэрхшээлийн талаар 2 дугаар бүлэгт авч үзсэн байна.

1.3.2 Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах

Дэлхий даяар дэлгэрч байгаа хөрөнгө хураан авах нэгэн арга нь эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах буюу шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах *(non–conviction based (NCB) confiscation or forfeiture)* юм.[7] Энэ төрлийн хөрөнгө хураан авах арга нь гэмт хэргийн улмаас олсон орлого, түүний арга хэрэгслийг хураах ба буцаан авах зорилготой байдгаараа эрүүгийн хэрэгт холбогдох хөрөнгө хураан авах арга замтай төстэй. Шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах арга нь гэмт хэргийг таслан зогсоох, хуулийн өмнө эрх тэгш хандах, хохирсон эрхийг сэргээх ач холбогдол бүхий зорилгыг агуулдаг.

Гэсэн хэдий ч эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолд үндэслэн хөрөнгө хураан авах болон шүүхийн ял шийтгэл ногдуулах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах нь хоорондоо ялгаатай ойлголтууд юм. Эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолд үндэслэж хөрөнгө хураан авахад эхлээд хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж ял шийтгэл оногдуулсан байхыг шаарддаг бөгөөд үүний дараа хөрөнгө хураан авах ажиллагаа явагддаг. Харин шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах нь эсрэгээрээ зөвхөн хөрөнгө хураан авахтай холбоотой хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа явагдаж, эрүүгийн хэрэгт шийтгэх тогтоол гарсан байхыг шаарддаггүй онцлогтой юм. Олон улс орнуудад энэ хэлбэрийн хөрөнгө хураан авах ажиллагаанд тавигдах нотолгооны стандарт нь харьцангуй доогуур байх (“Магадлалын тэнцвэрт байдал” эсхүл “Нотлох баримтууд нь илт давамгай байх”) тул эрх бүхий байгууллагуудад ногдох нотолгооны стандартыг хангахад дөхөм болдог. Бусад орнуудад, үүний дотор ихэнх эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах улс орнуудад эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол гаргахад нотолгооны арай илүү түвшний стандарт шаардагддаг (хөдөлбөргүй үнэн болохыг нотлох).

Шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах арга хэлбэр нь бүх улс орнуудад хэрэглэгддэггүй ажээ. Үүнтэй холбогдуулан, салбарын мэргэжилтнүүд нь энэ хэлбэрийн хөрөнгө хураан авах шийдвэрийг шүүхийн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авахыг хуульчлаагүй гадаадын улсад эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон уг арга замаар хөрөнгө хураан авах шийдвэрийг гүйцэтгэх, холбогдох эрх зүйн туслалцаа хүсэмжлэхэд тухайн улс нь татгалзах хандлагатай байдаг. Гэхдээ, зарим улс орнууд, Европын холбооны нэг адилаар шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах талаар гаргасан гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх боломжтой байдаг. Мөн эрх зүйн туслалцаа хүсэмжилж байгаа улс орнууд нь

[7] Эдгээр улсуудын заримыг нь дурдахад Ангуилла, Антигуа ба Барбуда, Австрали, Канадын зарим мужууд (Алберта, Бритиш Колумбия, Манитоба, Онтарио, Квебек, Саскатчеван), Колумб, Коста Рика, Фижи, Гернзи, Ирланд, Айл оф Мэн, Израил, Жерзи, Лихтенштайн, Шинэ Зеланд, Филиппин, Словен, Өмнөд Африк, Швейцар, Тайланд, Их Британи, АНУ, Замби орж байна. Олон улсын конвенци, олон талт гэрээ хэлцлүүд нь шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авахыг мөн зөвшөөрсөн байдаг. Үүнд, АЭНҮБК-ийн 53.1 дүгээр зүйл, ФАТФ-ын 2019 оны Зөвлөмжүүдийн 4 дүгээр зөвлөмж (“хөрөнгө хураан авах болон түр зуурын арга хэмжээ”)-д тус тус дурдсан байна.

шүүхийн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах эрх зүйн арга замыг мөнгө угаах гэмт хэрэгт түгээмэл хэрэглэдэг Их Британи, АНУ зэрэг улсуудтай хамтран ажиллахад давуу тал үүсэх боломжтой (1.4 дүгээр хэсэг болон 11 дүгээр бүлгийг харна уу). Шүүхийн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах арга хэлбэрийг энэхүү бүтээлийн 7 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

1.3.3 Иргэний хэргийн хувийн маргаан үүсгэх замаар хөрөнгө хураан авах тухай

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой улс орнууд нь дотооддоо эсхүл гадаад улсын иргэний хэргийн шүүхээр дамжуулан хөрөнгө хамгаалах, хураан авах, төсвийн хөрөнгө завшсан, шамшигдуулсан хэргүүд, гэм хор, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргүүдтэй холбоотой үүссэн хохирол барагдуулах боломжтой.[8] Дараах тохиолдолд гадаад улсын шүүхийн харьяалал үүснэ. Үүнд:

a) Хариуцагч нь тус улсын иргэншилтэй, оршин суудаг, байршдаг этгээд, хувь хүн, эсхүл хуулийн этгээд (субъектийн харьяалал).
b) Тус хэрэгтэй холбогдох эд хөрөнгө нь уг улсад оршиж байгаа эсхүл дамжин өнгөрсөн (хэрэгт хамаарах улс орон).
c) Тус улсад авлига эсхүл мөнгө угаах гэмт үйлдэл үйлдэгдсэн.[9]

Иргэний хэргийн хувийн нэхэмжлэл үүсгэхдээ Төр нь тус улсын өмгөөлөгчийг ажиллуулж, үүсгэх боломжтой нэхэмжлэлүүд болон зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга замуудыг судлан шинжлүүлэх боломжтой (завшсан шамшигдуулсан хөрөнгө, гэм хор, хууль бус орлого ашгийг хураан авах, гэрээний үүргийн зөрчил гэх мэт). Иргэний хэргийн хувийн нэхэмжлэл эхлүүлэх нь өндөр өртөгтэй бөгөөд төсвийн хөрөнгө завшиж, шамшигдуулсан, гэрээ зөрчсөн эсхүл гэм хор учруулсан гэх үндэслэлээр хариуцлага тооцох үндэслэлтэй болохыг нотлох баримт цуглуулах шаардлага үүсдэг. Зарим тохиолдолд эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримтыг иргэний хэргийн шүүхэд хэрэглэх боломжтой байдаг. Мөн, иргэний хэргийн нэхэмжлэл гаргахаасаа өмнө шүүхээс нотлох баримт бүрдүүлэхтэй холбоотой туслалцаа хүсэмжлэх боломжтой.

Нийтийн эрх зүйн бүлд харьяалагдах улс орнуудад шүүгдэгч нь шүүхээс олон төрлийн захирамж гаргуулах боломжтой байдаг бол Эх газрын зүйн бүлд харьяалагдах улсуудын хувьд энэ боломж нь хязгаарлагдмал байдаг.[10] Шүүхээс гаргуулах боломжтой захирамжуудад дараах шийдвэр багтдаг. Үүнд:

- Хөрөнгө царцаах, улсын орлого болгох, шүүхийн шийдвэрээр хөрөнгө хураан авах, эсхүл хязгаарлалт тогтоох захирамжууд (боломжтой бол Дэлхийн аль ч улсад хүчин төгөлдөр, Их Британий хуульд “Маревагийн шүүхийн шийдвэр” ч гэдэг)-ыг авлигын орлого байж болзошгүй гэж сэжиглэж байгаа эд хөрөнгийг хамгаалах, хэрэг шийдэгдэх хүртэл тухайн хөрөнгөд

[8] АЭНҮБ-ын конвенцийн 53.с дүгээр хэсэгт гишүүн улс орнууд нь дотоодын иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахыг бусад гишүүн орнуудад зөвшөөрөхийг шаардсан байдаг.

[9] АЭНҮБ-ын конвенцийн 42 дугаар зүйлд уг конвенцийн дагуу тогтоогдсон гэмт хэрэгт харьяалал тогтоох шаардлагуудыг дурдсан байдаг.

[10] Эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах улс орнуудад дор жагсаасан бүх төрлийн захирамж, шийдвэрийг гаргуулах боломжтой ч жагсаалтын нэг дүгээр хувилбар нь харьцангуй хязгаарлагдмал байдаг.

тодорхой өмчлөл тогтоох зорилгоор гаргуулдаг.[11] Зарим улс орнуудад, хэрэг шүүхээр шийдэгдэх хүртэл, тэр ч байтугай шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө урьдчилан мэдэгдэлгүйгээр тухайн улсын шүүхийн харьяаллаас гадуур бусад газар нутагт хүчин төгөлдөр үйлчлэх завсрын эсхүл түр зуурын захирамж гаргадаг. Эдгээр захирамжууд нь ихэвчлэн барьцаа тавих, баталгаа гаргаж өгөх, эсхүл нэхэмжлэгчээс бусад төрлийн үйл ажиллагааг шаарддаг.

- Хариуцагчид өөрийн эл хөрөнгө болон тэдгээрийн оролцоотой хийгдсэн шилжүүлгийн эх үүсвэрийн тухай мэдээлэл гаргаж өгөх үүрэг хүлээлгэх захирамж гаргуулах.
- Банк, санхүүгийн зөвлөхүүд, эсхүл эрх зүйч өмгөөлөгч зэрэг гуравдагч этгээдээс нотлох баримт гаргуулахад шаардагдах бичиг баримтууд гаргаж өгөх үүрэг хүлээлгэх захирамжууд.
- Банкууд болон бусад этгээдүүдэд хариуцагчид хөрөнгө царцаах битүүмжлэх захирамж эсхүл мэдээлэл гаргаж өгөх захирамжийн тухай хариуцагчид “үл мэдэгдэх” үүрэг ногдуулах захирамжууд.
- Өнөөгийн нөхцөл байдал, статусыг хадгалах болон хөрөнгө элэгдэлд орохоос урьдчилан сэргийлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эсхүл эдгээрийг аль алиныг нь хангах ерөнхий хамгаалалт эсхүл хадгалах захирамжууд гаргуулах. Энэ төрлийн захирамж гаргуулахад тухайн хэргийг шүүхээр амжилттайгаар шийдүүлэх өндөр магадлалтай байх болон тус шийдвэрийг гаргахыг хойшлуулах нь гэнэтийн аливаа эрсдэлийг үүсгэж болзошгүй болохыг дурдах шаардлагатай.

Иргэний хэрэгт нэхэмжлэгч тал болж оролцоход үүсэх үндсэн сул талууд (ялангуяа гадаад улсад) нь хөрөнгө тогтооход шаардагдах зардал, холбогдох шүүхийн захирамж гаргуулахад үүсэх эрх зүйн төлбөр тооцоо юм. Жич, нэхэмжлэгч нь иргэний хэрэг хянан шийдвэрлүүлэх ажиллагаанд хяналтыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлж, гуравдагч этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг нэхэмжлэх болон нотлох баримтад тавигдах нотолгооны босго нь ч эрүүгийн эрх зүйн арга замыг ашиглахаас доогуур байдаг давуу тал эдэлдэг.

Мөн олон улсын гэрээ хэлцлийг авлига эсхүл хууль бус давуу тал эдэлж авлигач албан тушаалтанд өгсөнтэй холбогдох хэргийг арбитраар хянан шийдвэрлүүлэхэд гэрээ хэлцлийг хүчин төгөлдөр бус болгох, гэм хор эсхүл хохирол барагдуулах нэхэмжлэл гаргах замаар эрх зүйн өөр нэгэн боломжийг үүсгэдэг. Энэхүү арга замыг номын 10 дугаар бүлэгт нарийвчлан судалсан.

1.3.4 Захиргааны хэргийн хүрээнд хөрөнгө хураан авах

Эрүүгийн эсхүл шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах төрлөөс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх замаар хөрөнгө хураан авах нь эрүүгийн хэргийн шүүхийн ажиллагаа шаардагддаггүй, эрүүгийн бус, зарим тохиолдолд шүүхийн бус аргаар аливаа гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эсхүл оролцуулсан хөрөнгө эсхүл эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох боломжгүй үйлдэлтэй холбоотой хөрөнгө хураан авахад ашигладаг давуу талтай. Хөрөнгө хураан авахдаа холбогдох эсхүл тодорхой хууль журмыг хэрэглэж, ихэвчлэн маргаан үүсээгүй эсхүл захиргааны зөрчил үүссэн тохиолдолд уг аргыг хэрэглэдэг.

[11] АНУ-д хөрөнгө царцаах, битүүмжлэх захирамж гаргуулахын тулд их хэмжээний нотлох баримт эсхүл процессын ажиллагааг хангах шаардлагатай. Үүнийг, номын 5 дугаар бүлэгт авч үзэв.

Захиргааны хэргийн журмаар хөрөнгө хураан авах нь ихэвчлэн эрх бүхий байгууллагаар хэрэгждэг. Үүнд, цагдаагийн тасаг эсхүл эрх бүхий хууль сахиулах агентлаг орох бөгөөд процесс нь ихэвчлэн гаалиар хууль бусаар бараа бүтээгдэхүүн нуун далдалж оруулахыг завдсан хэрэгт ашигладаг ажиллагаатай төстэй байдаг.[12] Жич, зарим тохиолдолд эрүүгийн бус захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүх хэрэгжүүлдэг. Тухайн эд хөрөнгөтэй холбоотой хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдэд мэдэгдэл хүргүүлэх эсхүл нийгэмд хамааралтай бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх процесс ажиллагааг шаарддаг. Эс бөгөөс төрийн нэрийн өмнөөс төлөөлөн оролцох этгээд болон хариуцагчийг оролцохыг шаардсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай төстэй шүүх хурал явагдана.

Ерөнхийдөө захиргааны хэргийн журмаар хөрөнгө хураан авах нь тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилд хэрэглэгдэж, бага үнэлгээтэй хөрөнгө эсхүл тодорхой төрлийн эд хөрөнгөд л хэрэглэгддэг.[13] Жич, зарим улс орнууд нь захиргааны хэргийн процессыг өндөр үнэлгээтэй хэргүүдэд шинэлэг байдлаар хэрэглэсэн байна. Үүнд захиргааны журмаар хөрөнгө хураан авах олон янзын арга хэрэглэж байгаагийн нэг нь “хууль ёсны ашиг сонирхлоосоо татгалзах” бөгөөд үүнд ижил процесс ажиллагааг баримталдаг ажээ.

1.3.5 Бусад арга замууд

Өмнө дурдсан эрх зүйн арга замуудаас гадна, улс орнуудад тодорхой тохиолдолд өөр арга замыг ашигладаг. Хэдийгээр энэхүү арга зам нь ерөнхий эсхүл Дэлхий нийтээр мөрдөгдөх тогтсон загварыг дагахгүй ч өмнө дурдсан эрх зүйн арга замуудаас ялгагдах тодорхой шинж чанарыг агуулах тул энд дурдах нь зүйтэй юм. Практикт хараахан ашиглаагүй байсан хөрөнгө хураан авах ажиллагаанд шинэлэг шийдэл, аргачлалыг гаргаж байгаа тул эдгээр нь хэрэгцээ шаардлагатай зүйл гэж дүгнэж байна. Шүүхийн бус аргаар хөрөнгө хураан авах өөр нэг хувилбар нь хууль бус ашгийг татварын замаар хураан авах явдал юм. Шигтгээ 1.2-т жишээнүүд оруулсныг харна уу.

ШИГТГЭЭ 1.2 Хөрөнгө буцаан авах бусад арга замууд

Татварын арга замаар

Авлига, төсвийн хөрөнгө шамшигдуулсан, хулгайлагдсан хөрөнгө эзэмшиж буй нийтийн албан тушаалтан эсхүл төрийн өмчит ААН-ийн албан тушаалтны хууль бус орлогод орлогын албан татвар ногдуулж болно. Энэ тохиолдолд уг хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг тодорхойлох шаардлагагүй. Харин хөрөнгө орлогын тайландаа тайлагнаж, мэдүүлээгүй орлого гэж нотлоход л хангалттай.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[12] Гаалиар аливаа зүйлийг нууцаар гаргуулахыг оролдсон хэргүүдтэй холбоотой хөрөнгө хураан авах ажиллагаа нь тодорхой хууль журмын хүрээнд зохицуулах цөөн тооны суурь гэмт хэрэгтэй холбогддог.

[13] Гаалиар аливаа зүйлийг нууцаар гаргуулах, эсхүл мансууруулах бодистой холбоотой хэргүүдтэй холбоотой хураан авах эд хөрөнгө нь усан онгоц, эсхүл хувийн нисэх онгоц зэрэг өндөр өртөг бүхий эд хөрөнгө байх магадлалтай. Харин, завших, шамшигдуулах эсхүл авлигын хэрэгт, ААН-д бүртгэлтэй хувьцааг ашиглан мөнгө угаахыг завдаж байгаа тохиолдолд зах зээлийн зохицуулагч байгууллагаар дамжуулан хөрөнгө хураан авах боломжгүй нөхцөл бүрддэг.

ШИГТГЭЭ 1.2 Хөрөнгө буцаан авах бусад арга замууд

Эрх бүхий байгууллага нь татвар төлөгч нь татвар ногдуулахуйц ашиг орлоготой болохыг баталж, тодорхой хэмжээний татвар төлөх үүрэгтэй болохыг нотлоход л хангалттай. Татвар төлөх дүнд хүү, алданги, торгууль зэргийг оруулдаг. Энэ арга замын хувьд нотолгоог бүрдүүлэх, түүнд тавигдах шаардлага нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх замаар хөрөнгө буцаан авахаас хялбар байдаг. Энэ арга зам нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шаарддаггүй учир эрүү, иргэний хэргийн журмаар гэмт хэргийн ашиг орлогыг хураан авахаас хямд бөгөөд илүү түргэн шуурхай шийдэгддэг давуу талтай.

Эрүүгийн хэргийн шүүхээс торгууль, нөхөн төлбөр төлөх захирамж гаргуулах

Эрүүгийн хэргийн шүүхээс шүүгдэгчид торгууль эсхүл нөхөн төлбөр (эсхүл хоёуланг нь)-ийг хохирогчдод төлүүлэх захирамж гаргаж болно. Эдгээрийг хөрөнгө хураан авах захирамжтай хавсарган гаргах боломжтой эсхүл хөрөнгө хураан авах захирамжийн оронд ч гаргах тохиолдол бий. Хувь хүмүүс болон үндэстэн дамнасан корпорациудад ногдуулах нөхөн төлбөрийн дүнг тэдний эдэлсэн эсхүл эдлэх байсан ашиг хонжоо, давуу байдлын үнэлгээг тооцоолон гаргадаг. Тухайн гэмт хэргийн улмаас олсон ашиг хонжоон дээр үндэслэн торгуулийн хэмжээг тооцоолдог улсуудад Австрали, Грек, Унгар, БНСУ (ЕАБХАБ, Дэлхийн Банкны тайлан 2012) ордог:

- Австралид, үндэстэн дамнасан корпорацид ногдуулах торгуулийн дээд хэмжээ нь 11 сая Австрали доллараас их байдаг эсхүл гэмт явдал үйлдсэнтэй холбоотой тухайн ААН-д шууд эсхүл шууд бусаар үүссэн аливаа ашиг хонжоог гурав дахин нэмсэнтэй тэнцэх дүн байдаг (үүнд, тус ААН-тэй холбоотой аливаа компаний үйл ажиллагааг оруулна). Хэрэв шүүх нь тухайн ашиг хонжооны үнэлгээг гаргаж чадахгүйд хүрвэл тухайн ААН-ийн гэмт явдал үйлдэгдэхээс өмнөх 12 сарын хугацаанд олсон жилийн нийт орлогын 10 хувь гэж тооцоолно.
- Грект гадаад улсад авлига үйлдсэн аливаа үндэстэн дамнасан корпорацид ногдуулах захиргааны торгууль нь тухайн ААН-д үүссэн "ашиг хонжоо"-г гурав дахин өсгөсөнтэй тэнцэхээр тооцоолдог.
- Унгарт хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн дээд хэмжээ нь тухайн ААН-д бий болсон эсхүл бий болох байсан санхүүгийн давуу байдлыг гурав дахин өсгөсөнтэй тэнцэнэ эсхүл доод тал нь 500,000Ft-тэй тэнцэнэ.

Бүгд Найрамдах Солонгос Улсад хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн дээд хэмжээ нь 1 тэрбум вон, жич ашиг хонжоо нь 500 сая воноос илүү байвал түүнд олсон ашгийг хоёр дахин өсгөсөнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулдаг.

1.4 Хулгайлагдсан хөрөнгийг гадаад улс орны үүсгэсэн эрх зүйн маргааны хүрээнд буцаан авах тухай

Авлигад өртсөн гадаадын албан тушаалтан, тэдний хамсаатнууд, эсхүл тогтоогдсон эд хөрөнгөтэй холбоотой гадаад улсад үүсгэсэн эрүүгийн эсхүл шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж болно. Хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсний дараа тухайн улс эсхүл Засгийн газар нь үндэсний, олон улсын эрх зүй эсхүл гэрээ хэлцлийг ашиглан гадаадын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх замаар хөрөнгийн тодорхой хувийг авах

боломжтой.[14] Энэхүү арга замыг хэрэглэхийн тулд гадаадын эрх бүхий байгууллага нь а. Хэрэгт харьяалалтай, б. Хэргийг яллах, шүүхээр шийдүүлэх хүчин чадалтай, г. Хамгийн гол нь хураан авсан хөрөнгийг хуваах хүсэл эрмэлзлэлтэй байх ёстой.

Гадаад улсад дараах хоёр хувилбарын аль нэг хувилбараар ажиллагааг эхлүүлэх боложмтой. Үүнд:

- Авлигын гэмт хэрэгт өртсөн улсын эрх бүхий байгууллага нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас дотооддоо хэрэг үүсгэх хүсэлт гаргаж болно. Үүнийг гомдол гаргах эсхүл гэмт хэрэг үйлдсэн болохыг нотлохуйц мэдээлэл солилцох эсхүл хавтаст хэргийг тухайн улсын эрх бүхий байгууллагад шилжүүлэх[15] зэрэг аргыг ашиглаж болно. Энэ тохиолдолд гадаадын эсхүл олон улсын байгууллага нь хэрэг үүсгэх эсхүл хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэрийг бие даан гаргана. Хэрэг үүсгэхээр шийдвэл авлигын гэмт хэрэгт өртсөн улс нь гадаад улс эсхүл олон улсын байгууллагатай нотлох баримтууд, мэдээлэл хуваалцах замаар хамтран ажиллах шаардлагатай.
- Авлигын гэмт хэрэгт өртсөн улс нь хүсэлт гаргаагүй байсан ч гадаад улс эсхүл олон улсын байгууллага нь хэрэг үүсгэхээр шийдвэрлэж болно. Гадаадын эрх бүхий байгууллага нь авлигач нийтийн албан тушаалтан эсхүл авлигач олон улсын албан хаагч[16] тус улстай холбогдож байгааг сонингийн нийтлэл, олон улсын байгууллагын мэдээлэл, сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ), албан бус эсхүл албан эрх зүйн туслалцааны хүсэлтээр дамжуулан тогтоож, уг улсын газар нутагт үйлдэгдсэн мөнгө угаах эсхүл гадаадын авлигын хэргийг мөрдөн шалгахаар шийдвэрлэж болно.

Ихэнх улс орнууд нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд авлигын гэмт хэрэгт өртсөн, хохирсон улсыг татан оролцуулахыг дэмждэг. Эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах зарим улсад хохирогч улс нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцох ч боломжтой байдаг. Эх газрын болон нийтийн эрх зүйн тогтолцоотой улсуудын аль алинд шүүхээс захирамжилсан нөхөн төлбөр, нөхөн олговор олгох, эсхүл хохирол барагдуулах шийдвэрийн хүрээнд хөрөнгө хураан авах боломжтой бөгөөд хохирогч улс нь энэхүү ажиллагаанд авлигын гэмт хэрэгт өртсөн тал эсхүл хураан авсан хөрөнгийн жинхэнэ өмчлөгч байдлаар оролцох боломжтой.

Хэрэв хохирсон улсад эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй эсхүл бие даан олон улсад хөрөнгө хураан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд хангалттай нотлох баримт байхгүй тохиолдолд энэхүү арга замыг сонгох нь үр дүнтэй байдаг. Ялангуяа гадаад улс оронд үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэрэгт шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах ажиллагааг гүйцэтгэх боломжтой улс орнуудад (АНУ болон Их Британи) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх нь маш үр дүнтэй байдаг. Ингэхдээ тухайн улс нь хураан авсан хөрөнгийг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг

[14] АЭНҮБК-ийн 53b, 53c дүгээр хэсгүүдэд гишүүн улс орнуудад хөрөнгө шууд хураан авах ажиллагааг харилцан дэмжих шаардлага тавьсан.

[15] Мэдээллийг тохиолдлын хэлбэрээр солилцох гэдэг нь “Гэрээний нөгөө талд холбогдох аливаа мэдээллийг уг тал нь авах хүсэлт гаргаагүй байхад тохиолдлын байдлаар, сайн дураар мэдээлэл олгох” явдал юм (OECD 2006).

[16] Энэ нь олон улсын нийтийн албан тушаалтан нь гадаад улсад байршилтай /биетээр/ олон улсын байгууллагад ажиллаж байгаа тохиолдолд хамаарна.

хохирогч улсад хөрөнгө хуваах гэрээ хэлцлийн дагуу буцаан олгохыг зөвшөөрөх эсэхийг урьдчилан тодруулах шаардлагатай.[17]

Мөн авлига эсхүл төсвийн хөрөнгө шамшигдуулсан суурь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусантай холбоотой яллах боломжгүй болсон ч уг хэргийг мөнгө угаах эсхүл хулгайлагдсан хөрөнгийг эзэмшсэн гэх гэмт хэргийн зүйл ангиар гадаад улсад мөрдөн шалгах боломжтой.

Жич зарим хэргүүдэд, авлигын гэмт хэрэгт өртсөн улс нь гадаадын шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хэрэгт ямар ч хяналт хэрэгжүүлэх боломжгүй байх тул уг хэргийг амжилттай шийдүүлэх эсэх нь тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагуудын хүчин чадал болон хэрэг шийдвэрлэхтэй холбогдох хүсэл зоригоос ихээхэн хамаардаг. Мөн гадаад улсын шүүх нь хураасан хөрөнгийг буцаан олгох шийдвэрийг гаргаагүй тохиолдолд хохирогч улс нь уг улстай байгуулсан хөрөнгө хуваах гэрээ хэлцэл эсхүл хөрөнгө буцаан олгох асуудлаар тухайн улсын Засгийн газрын шийдвэрээс шууд хамаарах нөхцөл үүсдэг. Энэ асуудлыг номын 11 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн.

1.5 Хөрөнгө буцаан авах арга замуудыг практикт хэрэглэсэн нь: Гурван хэргийн жишээ

Шигтгээ 1.3, 1.4, 1.5-д энэхүү бүлэгт дурдсан хөрөнгө хураан авах арга замуудыг практикт хэрхэн хэрэглэснийг илтгэхийг зорилоо. Тухайн хэргийн онцлог нөхцөл байдал, дотоод болон гадаад улсад хэрэглэх боломжтой байсан эрх зүйн арга замууд, хөрөнгө буцаан олгохтой холбогдох зохицуулалтаас хамаараад кейс бүрт хэд хэдэн улс, олон төрлийн арга зам болон хүчин зүйлсийг харгалзан үзсэн.

ШИГТГЭЭ 1.3 Перу: Владимиро Монтесинос болон түүний хамсаатнуудын хэрэг

Үндсэн мэдээлэл: Ноён Владимиро Монтесинос нь Перугийн Ерөнхийлөгч Альберто Фужимори (1990–2000)-ийн хувийн туслах бөгөөд тус улсын Тагнуулын байгууллагын жинхэнэ дарга байсан гэж үздэг. Тэрбээр 2000 оны 9 дүгээр сард сөрөг хүчний конгрессын гишүүнд авлига өгсөн хэргээр томоохон авлигын гэмт хэрэгт татагдсан. Перугийн телевизийн сувгаар уг конгрессын гишүүнд 15,000 ам долларын авлига өгч, өөрийнхөө намаас гарч, Фужиморигийн эвсэлд нэгдэхийг хүссэн видеог нь цацжээ.[a] Хэдэн сарын дараа 2000 оны 11 дүгээр сард Ерөнхийлөгч Фужимори нь огцорч, 2001 оны 6 дугаар сард Монтесиносыг Венесуэлд баривчилсан (түүнийг зугтсанаас 8 сарын дараа).[b] Нэмэлт мөрдөн шалгах ажиллагаагаар тэрбээр авлига, төсвийн хөрөнгө шамшигдуулсан, галт зэвсэг ба мансууруулах бодис наймаалах, хүний эрхийг ноцтой зөрчсөн зэрэг олон төрлийн гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон.[c] Улмаар, түүнийг хэд хэдэн зүйл ангиар яллаж, шийтгэл оногдуулсан юм.

Хууль бус эд хөрөнгө: 1990 оноос хойш Монтесинос нь галт зэвсэг хууль бусаар наймаалах 32 удаагийн үйлдэл, төлбөр тооцооноос авлига авсан (худалдан авсан дүн бүрээс 18 хувийг тооцож авч байсан), Перугийн нисэхийн компаниудын

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[17] Номын 2 дугаар бүлгийн Шигтгээ 2.7-с 1Malaysia Development Berhad (MDB) хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд Малайз болон АНУ хэрхэн хамтран ажилласан тухай мэдээллийг үзнэ үү.

ШИГТГЭЭ 1.3 Перу: Владимиро Монтесинос болон түүний хамсаатнуудын хэрэг

худалдан авсан гурван нисэх онгоцоос урамшуулал авч байсан (Levi, Dakolias, Greenberg 2007) зэрэг олон гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн. Тэрбээр, хууль бус эд хөрөнгөө Швейцарь, Кеймэн арлууд, Люксембург, Перу, АНУ зэрэг улс орнуудад байршуулсныг тогтоосон.

Швейцарт байршуулсан хууль бус хөрөнгө, стратеги төлөвлөлт: Швейцарт царцааж, битүүмжилсэн 49.5 сая ам.доллар (номын 5 дугаар бүлгийн Шигтгээ 5.8 дугаар хэсгээс Монтесиносын хөрөнгийг царцаан битүүмжилсэн мэлээллийг харна уу)[d]-тай холбоотой тус улсын мөрдөн шалгах Магистраттай хоёр хувилбарыг хэлэлцсэн. Үүнд, Нэгдүгээрт, Монтесиносын авлигын хэргийг Перуд шүүхээр хянан шийдвэрлэж, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх аргыг ашиглан хөрөнгийг буцаан авах болон Хоёрдугаарт, Швейцарт мансууруулах бодис хууль бусаар хилээр нэвтрүүлсэн болон холбогдох мөнгө угаасан хэрэг (хавсарч үйлдсэн хэрэг)-ийг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх байв. Жич, хоёр дугаар хувилбарыг сонговол Перу нь хураан авсан хөрөнгийн тодорхой хэсгийг Швейцартай хуваалцах шаардлага үүсэх байв.

Иймээс, Перу нь эхний хувилбарыг сонгож, ял тохиролцох арга замыг хуульдаа нэмэлт байдлаар оруулсан бөгөөд энэ арга замыг номын 2 дугаар бүлгийн 2.3 дугаар хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн.[E] Эрүүгийн хэргийн хөнгөрүүлсэн ял шийтгэл эсхүл шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэний хариуд шүүгдэгч нар нь одоо мэдэгдэж байгаа эсхүл тогтоогдоогүй байгаа гэмт хэрэг, нотлох баримт, гэмт хэргийн улмаас олсон орлого, үндсэн субъектүүдтэй холбоотой гэрчийн мэдүүлэг гаргаж өгөхийг зөвшөөрөх шаардлагатай байсан. Мөн шүүгдэгч нарт гадаадын банкуудад эзэмшиж байгаа эд хөрөнгийг Перугийн төрийн сангийн данс руу шилжүүлэхийг зөвшөөрч, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурж баталгаажуулах шаардлага тавьсан. Улмаар энэхүү бичиг баримтыг ашиглаж, олон сая ам.долларыг хураан авав. Улмаар, Швейцар болон Перугийн үр дүнтэй хамтын ажиллагааны үндсэн дээр нийт 77 сая ам.долларыг Перу руу шилжүүлж чадсан юм.[f]

Кеймен арлуудад орших хууль бус хөрөнгө: Тус улсад байршуулсан хөрөнгийн хувьд Перу нь тус улсын өмгөөлөгчийг ажиллуулж, 33 сая ам.долларыг Перугийн банк руу шилжүүлэхэд дэмжлэг авчээ. Мөн тэд Кеймен арлуудын Санхүүгийн тагнуулын албатай уулзаж, туслалцаа эрэлхийлсэн. Улмаар санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хэдэн сар гүйцэтгэсний дараа уг хөрөнгийг Кеймен арлууд руу огт шилжүүлээгүй, харин Перугийн банкинд байсаар байгааг тогтоосон. Зээл өгөх авах схемийг ашиглан Кеймен арлууд руу мөнгө шилжүүлсэн мэт халхавч үүсгэсэн ч үнэн хэрэгтээ Перугийн банкны дансанд байсаар байгааг тогтоосон. Улмаар уг хөрөнгийг царцааж, хураан авсан байна.

АНУ-д байршуулсан хууль бус хөрөнгө: Перугийн эрх бүхий байгууллагууд нь Холбооны мөрдөх товчоо (ХМТ)-той хамтран Монтесинос болон түүний хамсаатан ноён Виктор Венеро Гарридогийн залилан, авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгаж, 20.2 сая ам.долларыг царцааж, Гарридог түүний орон сууцнаас нь баривчилсан (INL 2005). Мөн Монтесиносын 30 сая ам.долларыг өөрийнхөө нэр дээр эзэмшиж байсан этгээдээс уг хөрөнгийг хураан авсан. АНУ-ын Флорида болон Калифорни мужид болсон шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах ажиллагааны үндсэн дээр хөрөнгө хураан авч, уг хөрөнгийг бүхэлд нь Перу руу буцаасан. АНУ болон Перугийн хооронд байгуулсан Хөрөнгө буцаан олгох гэрээний дагуу уг хөрөнгийг хохирогчдын

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.3 Перу: Владимиро Монтесинос болон түүний хамсаатнуудын хэрэг

хохирлыг барагдуулах, тус улсад авлигатай тэмцэх хүчин чармайлтад зарцуулахаар тохиролцсон бөгөөд уг ажиллагааг ил тод нээлттэй байдлаар хэрэгжүүлэхээр тохиролцсон (INL 2005).

Перуд байршуулсан хууль бус хөрөнгө: Перуд нийт 60 гаран сая ам.доллартай тэнцэх үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, усан онгоц, бусад төрлийн эд хөрөнгийг битүүмжилж, хураан авсан. Энэхүү ажиллагаагаар нийт 180 орчим эрүүгийн хэргийн 1,200 шүүгдэгчийг шүүхээр хянан шийдвэрлэсэн юм.

Нийт хураан авсан хөрөнгийн дүн: Эцсийн дүндээ нийт 250 сая ам.долларыг Швейцар, АНУ, Перугийн дотоодын банкуудаас хураан авсан.

a. "Montesinos Timeline," BBC News Online, June 25, 2001, http://news.bbc.co.uk/2/hi/americas/1406486.stm.
b. "Montesinos Timeline," June 25, 2001.
c. Collyns, Dan. 2016. "Former Peru Spy Chief Given Another Jail Sentence for 1993 Forced Disappearances." The Guardian, September 28, 2016. https://www.theguardian.com/world/2016/sep/28/peru-spy-vladimiro-montesinos-sentenced-forced-disappearances.
d. Swiss Federal Council. 2002. "Montesinos Case: Switzerland Transfers 77 Million US Dollars to Peru." Press Release, August 20, 2002. https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-23237.html.
e. Referred to as the "Efficient Collaboration Act" (Law 27.378).
f. Swiss Federal Council, "Montesinos Case," August 20, 2002.

ШИГТГЭЭ 1.4 Замби: Фредерик Чилуба болон түүний хамсаатнуудтай холбоотой гэм хорыг нэхэмжилсэн иргэний хэрэг

Хэргийн үндсэн мэдээлэл: Фредерик Чилуба нь 1991-2000 оны хооронд Замби Улсын Ерөнхийлөгч байсан. 2002 онд тус улсын Ерөнхийлөгч асан болон түүний хамсаатнуудтай холбоотой 1991-2000 онд үйлдэгдсэн авлигын хэргийг мөрдөн шалгах ажлын хэсгийг байгуулж, түүний эсрэг эрүүгийн хэрэг шийдүүлэх боломж болон хөрөнгө хураан авах хамгийн оновчтой хувилбарыг тодорхойлохоор ажилласан.

2003 оны 2 дугаар сард түүний халдашгүй дархан эрх дуусгавар болсоны дараа ерөнхийлөгч асан Чилуба, Тагнуулын ерөнхий газрын дарга Хавиер Чунгу, хэд хэдэн сайдууд (албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байсан), өндөр албан тушаалтнуудын хэргийг Замбийн шүүхээр хянан хэлэлцэж, 168 удаагийн давтан үйлдлээр төсвийн хөрөнгийг хувьдаа завшсан гэсэн зүйл ангиар ял шийтгэл оногдуулжээ.[a] Үүнд тус улсын Сангийн яамны данснаас Замбийн үндэсний худалдааны банк (Zanaco)-ны Лондонгийн салбарын данс руу мөнгө зувчуулж шилжүүлсэн хууль бус үйлдэл орж байв. Замбийн Засгийн газар нь уг дансыг Чилуба ба Чунгугийн хувийн хэрэгцээнд ашигладаг байсан гэж тогтоосон ч шүүгдэгч нар нь тус улсын гадаад дахь тагнуулын ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглаж байсан гэж маргажээ (Ryder 2011, 1).

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэд хэдэн удаа хойшлуулсан үйл явдал болсон: хэргийн хамсаатан болох шүүгдэгч нь тус улсаас оргон зайлсан, гурван шүүх хурлын хоёр нь бүтэлгүйтэж, уг ажиллагаанд улс төрийн сөрөг нөлөө орж байв. Замбийн шинэ Ерөнхийлөгч Леви Муанатаса нь хэрэв Чилуба угаасан

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.4 Замби: Фредерик Чилуба болон түүний хамсаатнуудтай холбоотой гэм хорыг нэхэмжилсэн иргэний хэрэг

мөнгөнийхөө 75 хувийг буцаан өгвөл өршөөл үзүүлнэ гэж хүртэл амлалт өгөв. Улмаар Замбийн эрх бүхий байгууллагууд нь Их Британид иргэний хэрэг үүсгэхээр шийдэж, түүний угаасан хөрөнгийн тодорхой хэсгийг ч болов хураан авах найдлага тээж байв. Улмаар, 2004 онд, Замби улсын ерөнхий прокурор нь тус улсын нэрийн өмнөөс Чилуба болон түүний 19 хамсаатан (номын 2 дугаар бүлэгт Шигтгээ 2.12-оос Чилубагийн өмгөөлөгчдөд ногдуулсан ял шийтгэлийг харна уу)-тай холбоотой иргэний хэргийг Их Британид эхлүүлж, Чилубагийн жилийн цалингийн орлогоос 40 дахин их үнэтэй байшин зэрэг түүний өндөр өртөг бүхий амьдралын хэв маягийг санхүүжүүлэхэд ашиглаж байсан хөрөнгийг 1995-2001 оны хооронд Лондон болон Европ даяар шилжүүлсэн хөрөнгийг хураан авахаар шийдвэрлэсэн.[b] Энэхүү ажиллагааг Замбид гүйцэтгэж байсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралтай зэрэгцүүлэн явуулж байв.[c]

Хэрэглэсэн эрх зүйн арга зам: Замбид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай зэрэгцэн Лондонд иргэний маргаан үүсгэх стратегийн шийдвэрийг гаргахад хүргэсэн гурван зүйл нь:

- Дийлэнх шүүгдэгчид нь Европт, ялангуяа Лондонд байсан тул зарим тохиолдолд дотооддоо эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон хөрөнгө хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон.[d]
- Хэрэгт холбогдох ихэнх нотлох баримтууд, эд хөрөнгө нь Европт байрлаж байсан нь хэргийг Европт хянан шийдвэрлэхэд хамгийн тохиромжтой гэж дүгнэхэд хүргэсэн. Замбигаас гарсан ихэнхи хөрөнгийг Их Британид байрлах хоёр хуулийн фирм болон банкны дансуудаар дамжуулан угаадаг байсан нь тогтоогдсон. Улмаар Замби улсын ерөнхий прокурор нь Иргэний болон Худалдааны хэрэгт шүүхийн харьяалал тогтоох, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай Брюсселийн конвенцийг ашиглан шүүгдэгч нарт харьяалал тогтоох боломжтой болсон.[e]
- Дотоодын шүүхээр эрүүгийн хэрэг яллаж, хөрөнгө хураан авах шийдвэрийг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээр дамжуулан амжилттай хэрэгжүүлэх нь Замби улсын хувьд боломжгүйд тооцогдож байв. Учир нь Замби улсад хоёр талт болон олон талт гэрээ хэлцэл, процессын түвшний аюулгүй байдал хамгаалалт, хүчин чадал, Европ даяар нотлох баримтууд цуглуулах, шүүхийн хөрөнгө хураан авах шийдвэрийг хэрэгжүүлэх туршлага дутагдаж байсан.

Улмаар Брюселлийн конвенци зэрэг хэрэглэж болох эрх зүйн арга хэрэгсэлд нэгдэн орсон, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх боломжтой Европын улсыг сонгохоор шийдвэрлэв. Ингэснээр холбогдох шүүхийн шийдвэр нь Европын бүх оронд хэрэглэх боломжтой болсон. Их Британи нь шүүхийн шийдвэрийг дотоодын шүүхдээ бүртгэснээр уг шийдвэрийг Замбид хүчин төгөлдөр авч үзэх болно гэж төлөвлөсөн.

Их Британий иргэний хэргийн шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлсэн нь: Эхний хэрэг нь Замбигаас 52 сая ам.долларыг "Замтроп данс" гэх Засгийн газрын хэвийн үйл ажиллагааны гадуур зохицуулагддаг банкны данснаас Занако банкны Лондонгийн салбарт орших данс руу шилжүүлсэн үйл явдлаас эхтэй юм ("Zamtrop Conspiracy" буюу "Замтроп хуйвалдаан" гэх). Мөн 20 сая ам.долларыг Замби болон Болгар улсын хооронд хийсэн зэвсгийн худалдааны төлбөр гэж Болгар, Швейцарь луу шилжүүлсэн ч уг шилжүүлэг нь үнэндээ Лондон руу хийгдсэн болохыг тогтоосон ("BK Conspiracy" буюу "BK хуйвалдаан" гэх).[f]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.4 Замби: Фредерик Чилуба болон түүний хамсаатнуудтай холбоотой гэм хорыг нэхэмжилсэн иргэний хэрэг

Шүүхийн шийдвэр: Шүүх нь бүх нотлох баримтыг харгалзан үзсэний дараа Чилуба болон түүний хамсаатнуудыг гэм хор учруулсан гэж дүгнэсэн. Ялангуяа Замтроп хуйвалдаанаар 25,754,316 ам.долларыг, ВК хуйвалдаанаар 21,200,719 ам.долларыг шамшигдуулах зорилгоор үгсэн хуйвалдсан гэж үзжээ.[g] Улмаар шүүгдэгч нараас шамшигдуулсан хөрөнгийн дүн дээр нэмээд хохирол нөхөн төлүүлэх үүрэг оногдуулсан. Шүүхийн шийдвэрт "Засгийн газрын нийтийн албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын үүднээс төсвийн хөрөнгийг зүй бус, шударга бусаар шамшигдуулсан" гэж дурджээ.[h]

Нийт хураан авсан хөрөнгө: Энэхүү хэрэгтэй холбогдох шүүхийн шийдвэрийн онцлог нь Их Британид байршуулсан хөрөнгө, тус улсын шүүхийн шийдвэрийг дотоодын шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр болгож үздэг бусад улс орнуудад байршуулсан хөрөнгийг мөн адил царцааж, битүүмжилсэн явдал юм. Жич, Лондонгийн шүүхийн шийдвэрийг Замбид хүчин төгөлдөр гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээлүүд байсаар байв (Ryder 2011, 7). Чилуба нь Замбигийн дотоодын хууль тогтоомж нь гадаадын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхийг бүрэн зөвгөөрөөгүй гэж маргаж байв. Улмаар Лондонгийн шүүхийн шийдвэрийг Замбид гүйцэтгэх боломжгүй болсонтой холбоотой авсан сургамж нь хөрөнгө шууд хураан авахаас илүү уг ажиллагааг гүйцэтгэхэд сонгосон эрх зүйн процессыг сайтар анхаарах явдал байв (Ryder 2011, 8).

a. Эдгээр давтан үйлдлүүд нь Чилубатай холбоотой үүсгэсэн эрүүгийн үйл явдалтай холбогдож байгаа (Ryder 2011, 9).
b. Attorney General of Zambia v. Meer Care & Desai & Others, [2007] EWHC 952 (Ch.) (United Kingdom).
c. Лусакад 2003 онд эрүүгийн хэрэг үүсгэж, 2009 онд шүүх хурал болсоноор дууссан ч үүнд Чилубаг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан. Уг шүүхийн шийдвэрийг давж заалдсан ч Улсын ерөнхий прокурор хэдхэн хоногийн дараа үүнийг хүчин төгөлдөр бус болгосон (Ryder 2011, 6).
d. Тухайн үед Замбид шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах тухай хууль тогтоомж байгаагүй ч тун удалгүй хуулиндаа оруулсан юм.
e. Брюсселийн конвенцийн дагуу иргэний болон худалдааны шүүхийн шийдвэрийг ЕХ-ны аль ч улсад хүчин төгөлдөр гэж үздэг байна.
f. Meer Care, [2007] EWHC 952, at § 2.
g. Meer Care, [2007] EWHC 952, at §§ 1120, 1132.
h. Meer Care, [2007] EWHC 952, at § 57.

ШИГТГЭЭ 1.5 Нигер: Диепрье Аламиесейха-ийн хэрэг

Хэргийн үндсэн мэдээлэл: 1999 онд Диепрье Аламиесейха нь Нигерийн Байэлса мужийн Амбан захирагчаар сонгогдож, 2003 онд дахин сонгогдов. 2005 онд тэрбээр авлигын гэмт хэрэг үйлдсэнтэй холбоотой албан тушаалаасаа огцорсон. 1999-2005 оны хооронд, Alamieyeseigha нь гадаадад үл хөдлөх эд хөрөнгө, банкны данснууд, хөрөнгө оруулалтууд, бэлэн мөнгө зэрэг нийт 10 сая фунт стерлингээс илүү үнэлгээтэй эд хөрөнгийг эзэмших болжээ. Гадаад улсад байршуулсан эд хөрөнгө нь ихэвчлэн түүний болон түүний эхнэрийн нэр дээр байсан бөгөөд бусад эд хөрөнгийг Бахама, Сейшел, Өмнөд Африк, Британий Виржинийн арлуудад үүсгэн байгуулсан компаниуд, трастуудад бүртгүүлсэн байв. Нигери, Их Британид болсон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгө царцаах битүүмжлэх захирамжууд, Нигерээс Их Британи руу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт уламжилсан

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.5 Нигер: Диепрье Аламиесейха-ийн хэрэг

явдал орж байв. Улмаар, Нигерийн дотоодын шүүх нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон тул холбогдох эд хөрөнгийг хураан авсан байна. Их Британид үүсгэсэн иргэний хувийн маргаан шийдвэрлэх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд Дэлхий даяар хүчин төгөлдөр хэрэгжих хөрөнгө царцаах битүүмжлэх захирамжийг Кипр, Дани улсуудад гүйцэтгэсэн. Иргэний хэргийн хөрөнгө хураан авах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мөн Өмнөд Африк, АНУ-д зохион байгуулсан. Ялангуяа эдгээр ажиллагаа нь дараах байдлаар өрнөсөн.

- *Мөнгө угаах гэмт хэрэгт сэжиглэж, цагдан хорьсон нь.* 2005 оны 9 дүгээр сард, Лондон хотын цагдаагийн газар нь ноён Диепрье Аламиесейха-г Хитроу нисэх онгоцны буудлаас мөнгө угаах гэмт хэрэгт сэжиглэсний үндсэн дээр анх баривчилсан. Мөрдөн шалгах ажиллагаагаар тэрбээр 2.7 сая ам.долларыг банкны данснуудад болон Лондонгийн гэртээ нуун далдалж, Лондонд 15 сая ам.долларын үнэлгээтэй үл хөдлөх эд хөрөнгө эзэмшдэг болохыг

  тогтоосон. Тэрбээр 2005 оны 11 дүгээр сард тэнсэнгээр суллагдаж, Их Британиас Нигери руу зугтсан.
- *Нигерид хөрөнгө хураан авсан нь.* Нигерид Аламиесейха нь эхэндээ эрүүгийн хэрэгт яллагдахаас сэргийлэх дархан халдашгүй эрхтэй гэж маргаж байв. Жич Байэлса мужийн хууль тогтоогч нарын шийдвэрээр албан тушаалаасаа огцорч дархан халдашгүй эрхээ алдсан юм. Нигери улсын Эдийн засаг, Санхүүгийн гэмт хэргийн хороо[18] нь түүнийг мөнгө угаах, авлигын 40 удаагийн давтан үйлдлээр яллаж, Нигери улсад орших эд хөрөнгийг нь царцаах битүүмжлэх шүүхийн шийдвэрийг гаргуулсан.
- *Их Британид бэлэн мөнгө хураан авсан нь.* Их Британид орших хөрөнгийн хувьд Нигери улсын Эдийн засаг, Санхүүгийн гэмт хэргийн хороо ба Лондон хотын Цагдаагийн газрын Авлигын гэмт хэргийн гаралтай хөрөнгө орлогын тасагтай үр дүнтэй хамтран ажиллаж чадсан нь үлэмж ач холбогдолтой байв. Аламиесейхагийн Лондонгийн гэрээс 1.5 сая ам. долларыг Гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогын тухай хууль 2002-ын хүрээнд гэмт хэргийн улмаас олсон орлого гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дагуу хураан авсан. Улмаар, 2006 оны 5 дугаар сард хураан авсан хөрөнгийг Нигери улс руу буцаан олгох шийдвэр гаргаж, шилжүүлгийг хэдэн долоо хоногийн дараа хийв.
- *Их Британи ба Нигерид хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг.* Эд хөрөнгө болон нотлох баримтууд нь Бахама, Сейшел, Өмнөд Африк, Их Британи, Британий Виржиний арлууд зэрэг олон улс орнуудад байршиж байсан тул банкинд байршуулсан хөрөнгийг хураан авах ажиллагаа нь илүү төвөгтэй байсан. Тус улсын удирдлагууд нь нэг талаас эдгээр улсуудад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт эрэлхийлэх нь ихээхэн хугацаа шаардах бөгөөд нөгөө талаас Нигерийн дотоодын шүүхийн шийдвэрийг гадаад улсад гүйцэтгэхгүй байх хандлагатайг ойлгож байв. Мөн Аламиесейхаг эд хөрөнгө ба авлигын гэмт үйлдэлтэй холбож байгаа нотлох баримт хангалттай байгаагүй тул эдгээр улсуудад хэрэг үүсгэж, шүүхээр шийдвэрлүүлэх нь бараг бүтэхгүй зүйл байв. Улмаар Нигери улсын эрх бүхий байгууллагууд нь Их Британид иргэний хэрэг шүүхээр шийдвэрлүүлэхээр шийдэж, Нигерид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.5 Нигер: Диепрье Аламиесейха-ийн хэрэг

ажиллагааг зэрэг эхлүүлэхээр шийджээ. Нотлох баримт цуглуулахтай холбоотой Нигерийн эрх бүхий байгууллага нь Лондон хотын Цагдаагийн газрын мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцдаа цуглуулсан нотлох баримтуудыг ил болгох захирамжийг гаргуулж авсан.[b] Улмаар Нигери нь эрүүгийн журмаар олж авсан болон иргэний хэргийг нь хянан шийдвэрлэхэд ашигласан түүний хөрөнгө орлогын мэдүүлгийг ч нотлох баримтаар ашиглаж, Аламиесейхагийн шууд ба шууд бусаар эзэмшдэг Дэлхий даяар орших эд хөрөнгийг битүүмжлэх болон түүний болон хамсаатнуудтай холбоотой банкуудад хадгалагдаж байгаа бүх бичиг баримтыг гаргуулах захирамж гаргуулжээ.[d]

- *Шүүхийн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах ажиллагааг Өмнөд Африкт гүйцэтгэсэн нь.* Дээрх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай зэрэгцэн, Өмнөд Африкийн Хөрөнгө хураан авах нэгж нь Аламиесейхагийн Кэйптаунд орших далайн эргийн тансаг зэрэглэлийн пэнтхаустай холбоотой шүүхийн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах ажиллагааг эхлүүлсэн. 2007 оны 1 дүгээр сард уг хөрөнгийг худалдан борлуулсны дараа хөрөнгийг Нигери улсад буцаан олгосон.
- *Гэм буруугийн тохиролцоо.* 2007 оны 7 дугаар сард Нигерийн Дээд шүүх нь Аламиесейхаг зургаан удаа хөрөнгө орлогын мэдүүлгээ худал гаргаж өгсөнтэй холбоотой гэм буруутайд тооцсон. Мөн түүний эзэмшдэг компаниудад 23 удаа мөнгө угаасан хэрэгт гэм буруутайд тооцсон. Түүнд хоёр жил хорих ял оноож, Нигери дэх эд хөрөнгийг нь хураан авах шийдвэр гаргав. Улмаар Лондонгийн Дээд шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийг эсэргүүцсэн эсэргүүцлийг нь хүчин төгөлдөр бусад тооцов. 2007 оны 12 дугаар сард Их Британийн банкны дансанд орших хөрөнгийг хураан авах шийдвэрийг шүүхээс гаргав. Улмаар, 2008 оны 7 дугаар сард болсон шүүхийн удаах шийдвэрээр Их Британи, Кипр, Данид байрлах түүний үлдсэн эд хөрөнгийг хураан авах шүүхийн шийдвэр гарав.
- *АНУ-д хөрөнгө хураан авсан шийдвэр.* 2012 оны 6 дугаар сард АНУ-ын дүүргийн шүүх нь Аламиесейхад холбогдох 401,931 ам.доллартай тэнцэх хөрөнгийг Нигери руу буцаан олгох шийдвэр гаргав.[e] Мөн түүний АНУ-ын Мэриланд мужийн Роквилл хотод худалдан авсан нийт 700,000 ам.долларын үнэтэй хувийн орон сууцыг хураан авах шийдвэр гарав.[f]

Нийт хураан авсан хөрөнгө: Өмнөд Африк, Их Британи, АНУ-тай үр дүнтэйгээр хамтран ажиллаж, олон төрлийн хөрөнгө хураан авах механизмыг сонгож, хавсруулан хэрэглэсний үндсэн дээр Нигери нь нийт 17.7 сая ам.долларыг дотоод, гадаадад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хураан авч чадсан.

a. Номын 10 дугаар бүлгийн 10.1 дэх хэсэгт Нигерийн Бүгд Найрамдах улсын гаргасан өмчийн нэхэмжлэлийн тухай мэдээллийг харна уу.
b. Лондон хотын Цагдаагийн газар нь Нигери улсын гаргасан бичиг баримт гаргаж өгөх захирамжид эсэргүүцэл илэрхийлээгүй. Ихэвчлэн цагдаагийн байгууллага нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримтыг иргэний маргаанд зохигч этгээдэд гаргаж өгдөггүй ч уг тохиолдолд түгээмэл бус шийдвэр гаргасан юм.
c. Аламиесейха нь 1999 онд анх мужийн амбан захирагчаар сонгогдохдоо Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгсөн бөгөөд үүндээ түүний эзэмшиж байгаа хөрөнгө нь 0.5 сая ам. доллартай тэнцэж, жилийн орлогоо 12,000 ам.доллар гэж тайлагнаж байв.
d. Номын 10 дугаар бүлгийн Шигтгээ 10.2-д нөхцөл байдлаас урган гарах нотлох баримтын тухай унших боломжтой.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 1.5 Нигер: Диепрье Аламиесейха-ийн хэрэг

e. Энэ нь АНУ-ын Хууль зүйн яамны Kleptocracy хөрөнгө хураан авах санаачлага (Kleptocracy Asset Recovery Initiative)-ын хүрээнд хураан авсан анхны хөрөнгө байсан юм. ("Хууль зүйн яам нь Нигерийн амбан захирагч асантай холбогдох авлигын гаралтай 400,000 ам. долларыг хураан авав". Хэвлэлийн мэдээ. 2012 оны 6 сарын 28 өдөр. https://www.justice.gov/opa/pr/department-justice-forfeits -more-400000-corruption-proceeds-linked-former-nigerian-governor)
f. АНУ-ын Цагаачлал, Гаалийн байгууллага. 2013. "Нигерийн авлигын гаралтай эд хөрөнгөөр худалдан авсан Мэрилэнд дахь үл хөдлөх эд хөрөнгийг Дотоодын аюулгүй байдлыг хамгаалах албаны МША болон Kleptocracy хөрөнгө хураан авах санаачлагын хүрээнд хураан авав". Хэвлэлийн мэдээ. 2013 оны 5-р сарын 31-ний өдөр. https://www.ice.gov/news/releases/maryland -property-purchased-nigerian-corruption-proceeds-forfeited-through-hsi.

Ном зүй

Brussels Convention on Jurisdiction and the Enforcement of Judgments in Civil and Commercial Matters, European Economic Community, Official Journal L 299, 31/12/1972, 32–42 (September 27, 1968). https://eur-lex.europa.eu/legal-content/GA/TXT/?uri=CELEX:41968A0927(01).

FATF (Financial Action Task Force). 2019. "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation." The FATF Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

INL (Bureau for International Narcotics and Law Enforcement Affairs, US Department of State). 2005. "Law Enforcement Cases." In International Narcotics Control Strategy Report, Volume II: Money Laundering and Financial Crimes, March 2005, 12–19. Washington, DC: INL. https://www.hsdl.org/?view&did=457663.

International Convention for the Suppression of Financing of Terrorism, UN General Assembly Resolution 54/109 (December 9, 1999), United Nations, New York. https://undocs.org/en/A/RES/54/109.

Levi, Michael, Maria Dakolias, and Theodore S. Greenberg. 2007. "Money Laundering and Corruption." In The Many Faces of Corruption: Tracking Vulnerabilities at the Sector Level, edited by J. Edgardo Campos and Sanjay Pradhan, 389–426. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/6848/399850REPLACEM101OFFICIAL0USE0ONLY1.pdf.

Nainappan, Shane. 2019. "Shane Nainappan's Quick Guide to International Cooperation in Asset Recovery." Basel Institute on Governance (blog), August 5, 2019. https://www.baselgovernance.org/blog/shane-nainappans-quick-guide-international-cooperation-asset-recovery.

OECD (Organisation for Economic Co-operation and Development). 2006. "Spontaneous Exchange of Information." In Manual on the Implementation of Exchange of Information Provisions for Tax Purposes, Module 2. Paris: OECD. https://www.oecd.org/ctp/exchange-of-tax-information/36647823.pdf.

[18] Нигерийн Эдийн засаг, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо (EFCC).

OECD and World Bank. 2012. Identification and Quantification of the Proceeds of Bribery: A Joint OECD–StAR Analysis. Rev. ed. Paris: OECD. https://www.oecd-ilibrary.org/governance/identification-and-quantification-of-the-proceeds-of-bribery_9789264174801-en;jsessionid=dENX4fZTUE_DhV7QWhb4jEfp.ip-10-240-5-58.

Ryder, Katherine E. 2011. "'Making Hay While the Sun Shines': Experiences with the Zambian Task Force on Corruption." U4 Practice Insight, Chr. Michelsen Institute, Bergen, Norway. https://www.cmi.no/publications/file/4071-making-hay-while-the-sun-shines.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc.org/pdf/convention_1988_en.pdf.

UNTOC (United Nations Convention against Transnational Organized Crime), UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25

2. Хэргийн менежмент, зохион байгуулалтыг хийхэд анхаарах стратегийн асуудлууд

2.1 Удиртгал

Хөрөнгө буцаан авах ажиллагааг амжилттай явуулахын тулд олон тооны чухал алхмууд, анхаарах асуудлуудыг багтаасан маш дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөөтэй байх шаардлагатай.

Салбарын мэргэжилтнүүдийн зүгээс хэргийг бүрэн ойлгох зорилгоор факт, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, шаардлагатай эх сурвалжийг тодорхойлох (ажиллах хүмүүс, мэдээллийн технологи, болон мэргэшсэн ажилтнууд), хэргийн харьяаллын дагуу албан болон албан бус хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор түргэн шуурхай гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах[1], хандах, олон улсын хөрөнгө буцаах ажиллагаанд тулгамдах эрх зүй, практик, гүйцэтгэх ажиллагааны асуудлыг ойлгож шийдвэрлэх[2], үр дүнтэй хэргийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэхүү бүлгийн хэсэг бүр нь эрх бүхий албан хаагчийг хөрөнгө буцаах ажиллагаанд ашиглах хамгийн тохиромжтой эрх зүйн арга хэмжээг сонгоход туслалцаа үзүүлнэ. Тус бүлэг нь эрх бүхий албан хаагч хөрөнгө хураах ажиллагаанд ашиглах аргыг сонгоход тулгамдах зарим асуудал болон эхэн үед хэрэгжүүлэх зарим арга хэмжээг авч үзнэ.

2.2 Фактуудыг цуглуулах нь: Мэдээллийн анхан шатны эх сурвалж

Хөрөнгө буцаахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхийн өмнө албан тушаалтан өргөн цар хүрээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Мөн зарим төрлийн урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж болно (гуравдугаар бүлэгт дурдав). Боломжит мэдээллийн эх сурвалж нь дор дурдсан байж болно.

Эрүүгийн хэргийн гомдол (харилцаа) ба процесс. Залилан, авлига, хулгай болон бусад хэргийн мэдээлэл нь хохирогч (хувь хүн, компани болон авлигын хохирогч тал зэрэг) эсхүл төрийн байгууллага (зохицуулах газар, авлигатай тэмцэх газар, гаалийн газар, татварын газар болон санхүүгийн тагнуулын алба зэрэг) гаргаснаас үл хамааран мэдээллийн чухал эх сурвалж болно. Түүнчлэн бусад эрүүгийн үйлдлийг мөрдөн шалгах явцад авлигын үйлдлийг илрүүлэх боломжтой. Тухайлбал

[1] Албан болон албан бус олон улсын хамтын ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг 8 болон 9 дүгээр бүлгээс авна уу.

[2] Тулгарсан тодорхой хүндрэл бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Стефенсон(2011)-оос авна уу: https://star.worldbank.org/sites/star/files/Barriers%20to%20Asset%20Recovery.pdf. Мөн ФАТФ(2012)-тай танилцана уу:https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Best%20Practices%20on%20%20Confiscation%20and%20a%20Framework%20for%20Ongoing%20Work%20on%20Asset%20Recovery.pdf

мансууруулах бодисын хэргийг хайх эсхүл харилцаа холбоог чагнах нь хахуулийн үйлдлийн нотлох баримтыг илрүүлэх боломжтой.

Санхүүгийн тагнуулын албаны тайлан. Мөнгө угаахтай тэмцэх хууль, тогтоомж нь санхүүгийн институт, зохицуулах байгууллага болон зарим санхүүгийн бус бизнес, мэргэжлийн хүнийг сэжигтэй гүйлгээний тайлан эсхүл сэжигтэй үйлдлийн тайланг Санхүүгийн тагнуулын албанд мэдэгдэж, төрийн өндөр албан тушаалтан, тэдний гэр бүлийн гишүүн, ойрын хамаарал бүхий этгээд зэрэг улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбогдолтой үйл ажиллагаанд сайтар анхаарал хандуулахыг шаарддаг. Зарим харьялалд валютын гүйлгээний тайланг тодорхой заасан хязгаараас их хэмжээний гүйлгээнд гаргаж өгөхийг зохицуулсан байдаг.[3] Цаашлаад, СТА нь хил дамнасан тодорхой хэмжээний гүйлгээний талаарх тайлан мэдээг холбогдох хилийн байгууллагаас хүлээн авна. СТА нь холбогдох тайлан мэдээг хүлээн авсны дараагаар мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх эсхүл бүс нутгийн хууль сахиулах албан хаагчид мэдээллийг шилжүүлэх эсхүл прокурорт мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгүүлэх зорилгоор шилжүүлдэг (Шигтгээ 2.1).

ШИГТГЭЭ 2.1 Хөрөнгө буцаан авах ажиллагаанд Санхүүгийн тагнуулын албаны гүйцэтгэх үүрэг, оролцоо

Санхүүгийн тагнуулын алба(СТА) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэлтэй тэмцэх зорилгоор санхүүгийн институт болон бусад тайлан гаргах этгээдээс сэжигтэй гүйлгээний тайланг цуглуулах үүрэг бүхий Засгийн газрын байгууллага бөгөөд тайланд дүн шинжилгээ хийж олсон мэдээллийг бүс нутгийн холбогдох байгууллагад(хууль сахиулах байгууллага, прокурор болон гадаад улсын СТА зэрэг) түгээх үүрэг бүхий засгийн газрын байгууллага юм. Энэхүү нэгж нь хөрөнгө хураах албан хаагчдын хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд дараах хэд хэдэн замаар дэмжлэг үзүүлж болно:

- *Тагнуулын шугамаар олж авсан мэдээллийг хууль сахиулах байгууллага болон прокурорт хуваалцах.* СТА-ны дүн шинжилгээ нь мөнгө угаах эсхүл бусад эрүүгийн үйлдэл байгааг илрүүлсэн тохиолдолд тэд өөрсдийн санаачлагаар мэдээллийг бүс нутгийн холбогдох байгууллага болон прокурорт дамжуулдаг. Шаардлагатай тохиолдолд, СТА нь Эгмонт группын Аюулгүй веб системийг ашиглан гадаад улсын СТА-д мэдээллийг уламжилна. Энэхүү мэдээллийг дахин нягтлан шалгасны дараагаар гадаад улсын хууль сахиулах байгууллага, прокурорт мэдээллийн загвараар шилжүүлж болно.
- *Туслах тагнуулын зохицуулалт.* Ихэнх СТА нь сэжигтэй гүйлгээний тайлан, валютын гүйлгээний тайлан, хил дамнасан валютын тайлан, тагнуулын тайлан болон хууль сахиулах байгууллага, гадаад улсын СТА-ны хүсэлтийг цуглуулсан үндсэн дата төвтэй байдаг. Сэжигтэй гүйлгээний тайланд холбогдох хувь хүн болон хуулийн этгээдийг СТА нь нарийвчлан хянан шалгадаг. Хүлээн авч хадгалсан мэдээлэл нь шууд хууль сахиулах байгууллагад хүргүүлэх тодорхой шаардлагыг хангахгүй байж болно. Гэвч

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[3] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 52-р зүйлийг харна уу. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг илрүүлэх ба урьдчилан сэргийлэх талаарх санхүүгийн байгууллагын үүргийг 1 болон 2 дугаар догол мөрнөөс харах боломжтой. Мөн ФАТФ-ын 12, 20 болон 23-р зөвлөмжтэй танилцах(2019): https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2009-title18/html/USCODE -2009-title18.htm.

ШИГТГЭЭ 2.1 Хөрөнгө буцаан авах ажиллагаанд Санхүүгийн тагнуулын албаны гүйцэтгэх үүрэг, оролцоо

хамтад нь хянан шалгаснаар хууль сахиулах албан хаагч нь мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэж буй этгээдийн үйл ажиллагааг ойлгох, хамтран оролцогчдыг илрүүлэх, бусад байгууллагын мөрдөгч нарын мэдээлэлтэй холбоход тустай юм.

- *Санхүүгийн үйл ажиллагаанд мэргэшсэн байдал.* Санхүүгийн тагнуулын шинжээчид нь санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн болон мөнгө угаах арга барилын талаар сайтар мэдээлэлтэй байдаг. Тэд санхүүгийн тайлан мэдээ, гүйлгээнд шинжилгээ хийх болон хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн үнэлгээ гүйцэтгэхэд мэргэшсэн болно. Энэхүү ур чадвар нь мөрдөн шалгах болон яллах ажиллагаанд нэн чухал үүрэгтэй бөгөөд СТА нь энэ хүрээнд нэн тустай эх сурвалж болдог.
- *Хувийн харилцаа болон сүлжээ.* СТА нь санхүүгийн институт, бусад дотоодын төрийн байгууллага болон гадаад улсын СТА (Эгмонт группээр дамжуулан)-тай харилцаатай байдаг бөгөөд холбогдох албан хаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх эх сурвалж болох боломжтой.
- *Хөрөнгийг захиргааны журмаар царцаах боломж.* Зарим СТА нь тодорхой хугацааны турш хөрөнгийг царцаах бүрэн эрхтэй байдаг бөгөөд энэ нь холбогдох албан хаагч шүүхийн албан ёсны шийдвэр гарахаас өмнө хөрөнгийг шуурхай хадгалах ажиллагаанд дэмжлэг болдог.
- *Шинэ хэрэгсэл, Газарзүйн зорилтот тушаал* (GTO). АНУ-д Санхүүгийн гэмт хэрэтэй тэмцэх сүлжээ (FinCEN)[a] нь Газарзүйн зорилтот тушаалыг гаргаж санхүгийн институт эсхүл бусад “хаалгач”-ийг тухайн газарзүйн бүс нутгийн эцсийн өмчлөгч, холбогдох мэдээллийг илрүүлэх эсхүл зарлахыг үүрэг болгодог. Тухайлбал, АНУ-ын нэр бүхий даатгалын компани нь тодорхой бүс нутагт зээлийн санхүүжилт авалгүй тодорхой хязгаараас дээш үнийн дүнтэй орон сууц худалдан авсан хуулийн этгээдийн ард буй этгээдийг зарлахыг үүрэг болгоно.

СТА нь эрх бүхий албан тушаалтны хамгийн үр дүнтэй хамтрагч юм. Энэхүү харилцаа хоёр тал харилцан мэдээлэлээ солилцох буюу хууль сахиулах байгууллага болон СТА-ны хооронд мэдээллийн урсгал хоёр талдаа байх шаардлагатай. Хууль сахиулах албан хаагчид ийнхүү мэдээллийг солилцсоноор СТА-ны мэдээллийг нэмэгдүүлж, цаашлаад тус албаны дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг сайжруулдаг байна.

a. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (FinCEN) нь АНУ-ын Сангийн яамны товчоо бөгөөд санхүүгийн системийг хууль бусаар ашиглахаас хамгаалах, дотоодын болон олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэх мэт холбогдох гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор санхүүгийн гүйлгээний талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийдэг бөгөөд санхүүгийн байгууллагуудыг болон санхүүгийн тагнуулыг стратегийн түвшинд хэрэглэх замаар үндэсний аюулгүй байдлыг хамгаалдаг. (“Эрхэм зорилго”, FinCEN-ийн цахим хуудас: https://www.fincen.gov/)

Иргэний, эсхүл захиргааны процесс. Иргэний эсхүл захиргааны процесс, санхүүгийн институтэд ногдуулж буй зохицуулах санкц эсхүл олон улсын болон бүс нутгийн хөгжлийн банкнаас компанид оногдуулж буй санкц нь авлигын

үйлдлийг ил болгох боломжтой.[4] Энэхүү процесс эсхүл санкц нь залилан болон авлигыг тухайлан илэрхийлдэггүй боловч мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд хууль бус үйл ажиллагааг илрүүлэхэд хүргэдэг ба нотлох баримтын чухал эх сурвалж болно. Тухайлбал, алдаатай эсхүл дутуу барааны тухай гомдол нь худалдан авах ажиллагааны албан хаагч алдаатай бараа бүтээгдэхүүнийг хахууль авсны хариуд хүлээн авсан байж болзошгүй юм. Үүнтэй адил гэрээ байгуулсан этгээдээс сонгон шалгаруулалтын шударга бус үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдолд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт. Гадаад улсаас ирүүлсэн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд (8 болон 9 дүгээр бүлэгт тусгагдсан) байгаа хувь хүн болон банкны дансны талаарх нэлээдгүй дэлгэрэнгүй мэдээлэлд тулгуурлан дотооддоо мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг тогтоох боломжтой.

Татварын албаны мэдээлэл. Татварын аудит гүйцэтгэх явцад татварын алба нь ихэвчлэн цагаан захтны гэмт хэрэгт хамаарал бүхий хуурамч нягтлан бүртгэл, зохиомол тооцоо зэрэг ердийн бус гүйлгээний талаар илрүүлдэг. Энэхүү мэдээллийг гадаад улсын татварын албанаас татвар харилцан хуваалцах гэрээний дагуу цуглуулах боломжтой бөгөөд ингэснээр адил нөхцөл байдалд эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа эсхүл процессыг гүйцэтгэхэд тус мэдээллийг ашиглах боломжоор хангагдана.

Аудитор. Хувь хүмүүс татварын албанд аудит хийлгэдэг бол компаниуд жил бүр санхүүгийн аудит хийлгэдэг. Засгийн газраас ихэвчлэн аудит хийх эсхүл зохицуулах байгууллага (жишээ нь, АНУ-ын холбооны агентлагт Ерөнхий байцаагчийн алба болон тусгайлсан нягтлан бүртгэх алба байгуулсан байдаг)-ыг Засгийн газрын байгууллага эсхүл төрийн өмчит хуулийн этгээдийг хянах зорилгоор байгуулдаг. Энэхүү аудитын дүгнэлтээр хөрөнгийн шилжилт ба бодит бизнесийн гүйлгээний хоорондын зөрүүг илрүүлж боломжит авлигын үйлдлийн дохиог өгдөг. Тухайлбал, орлого, зарлагын санхүүгийн баримтад хяналт шинжилгээ хийснээр ердийн авлига болон хахуулийн хэрэгт гардаг зохиомол төлбөр тооцоог илрүүлэх боломжтой.

Мэдээллийг илчлэх. Гадаад улсын эрх бүхий байгууллага болон Санхүүгийн тагнуулын алба нь өөрийн улсын иргэн холбогдсон эсхүл бусад харьяаллын улсад үйлдэгдсэн авлигын үйлдлийн талаарх мэдээллийг өгч болно. Энэхүү мэдээлэл нь албан болон албан хаагчдын мэдээллийн сүлжээг ашиглан албан бус байдлаар дамжуулагдах боломжтой. Албан бус хамтын ажиллагааны олон улсын мөрдөн шалгах ажиллагаанд үзүүлэх нөлөөг наймдугаар бүлгээс харна уу.

Шүгэл үлээгч. Мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх мэдээлэл нь ажилчдаас гарч болно. Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль нь тэдний ажиллаж буй байгууллагаас

[4] Олон улсын хөгжлийн банкууд болон бусад хөгжлийн агентлагууд хөгжлийн сангаас ашиг хүртэж буй албан тушаалтан, компани, хувь хүмүүсийн авлигын үйл ажиллагааг шийдвэрлэхийн тулд дотоод мөрдөн шалгах болон захиргааны шийтгэл, шилжүүлэх механизмыг боловсруулсан. Дотоод мөрдөн шалгалтаар авлигын үйл ажиллагаа илэрсэн тохиолдолд эдгээр байгууллага эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой харьяалагдах үндэсний эрх бүхий байгууллагад дүгнэлтээ шилжүүлж болно. Судалгааны үр дүнг дурдаагүй байсан ч үндэсний эрх баригчид хориг арга хэмжээ нийтлэгдсэний дараа мэдээлэл хүлээн авч болно.

шүүхэд нэхэмжлэх гаргах, дарамтлах үйлдлээс хамгаалах гол зэмсэг болдог. Түүнчлэн нэрээ нууцалж мэдээлэл өгөх системийг бий болгох шаардлагатай.[5]

Гэмт хэрэгтэнтэй хамтран ажиллах. Зарим тохиолдолд хөнгөн ял сонсох зорилгоор гэмт хэрэгтэн мэдээлэл өгөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд хууль сахиулах байгууллага нь тухайн этгээд далд зорилготой эсэхийг нарийвчлан шалгах шаардлагатай.

Хэвлэл мэдээлэл ба иргэний нийгмийн тайлан. Сэжигтэй үйл ажиллагаа эсхүл гадаадын иргэн авлигын хэрэгт холбогдон баривчлагдсэн талаарх мэдээллийг ихэвчлэн мэдээллийн хэрэгсэл эсхүл иргэний нийгэм болон ашгийн төлөө бус байгууллагын тайлангаас авна.6 Энэхүү тайланд үндэслэн мөрдөн шалгах ажиллагааг шууд эхлүүлэх эсхүл тус ажиллагааг гүйцэтгэхэд яваандаа хүргэх сэжигтэй гүйлгээний тайланг гаргахад хүргэдэг.7 Шигтгээ 2.2-т Европын судалгааны байгууллагыг тайланд үндэслэн ил болсон Лука Волонтегийн хэргийг харуулав.

Төрийн албан хаагчийн хөрөнгийн мэдүүлэг. Олон улс оронд төрийн албан хаагчийг өөрийн хөрөнгө орлогыг мэдүүлэхийг шаарддлаг. Энэхүү мэдүүлэг нь албан хаагчийн мэдүүлсэн орлоготой үл нийцэх их хэмжээний хөрөнгийн нэмэгдэл эсхүл хуурамч орлогын мэдүүлгийг ил гаргах боломжтой.8 Хөрөнгө орлогын мэдүүлгийг тэдний хөрөнгөтэй тулгаж шалгаснаар үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг илрүүлж болно.

Тагнуулын алба. Тагнуулын байгууллага эсхүл бусад улсын Засгийн газрын байгууллагын тагнуулын үйл ажиллагааны дагуу хүлээн авсан мэдээлэл (тухайлбал, хууль сахиулах байгууллага).9

Мөрдөн шалгах нууц ажиллагаа. Хууль сахиулах албан хаагчид мөн боломжит эх сурвалжаас мэдээллийг идэвхтэй хайж болно. Тэд мөнгө угаах, авлигын гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлтэй салбарууд эсхүл байгалийн баялгийн олборлолт, зэвсгийн наймаа зэрэгт ажиглалт, шинжилгээ хийж болно. Албан хаагчид мөн компанийн өмчлөгч, удирдлагын талаарх мэдээллийг нийтэд нээлттэй эх сурвалжаас авах замаар компанийн гэрээ, гүйлгээг хянаж болно. ИБУИНВУ-ын “чухал ач холбогдолтой өмчлөгч этгээд”-ийн талаарх нийтэд нээлттэй бүртгэлийн талаарх танилцуулгыг Шигтгээ 2.3-т харуулав.

---

[5] Ихэнх улс орнууд шүгэл үлээгчийн хамгаалалт болон түүний процессыг хуульчилсан байдаг. Тухайлбал, Хайти Улс нь үүнийг “нийтийн дуу хоолой” хэмжээн 1987 оны Үндсэн хуулинд тусгасан байдаг. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 33 дугаар зүйлийг харна уу.

[6] Бусад байгууллагын хүрээнд харна уу, Дэлхийн гэрч (https://www.globalwitness.org/en/) болон Нийтийн мэлмий (https://www.publiceye.ch/en/).

[7] Тухайлбал, Францад эрүүгийн хэрэг үүсгэхэд хүргэсэн Францын төрийн бус байгууллага (ТББ), Өлсгөлөнгийн эсрэг, хөгжлийн төлөөх Католик хорооноос (CCFD 2007) нийтэлсэн “Biens mal acquis” тайланг харна уу. Уг тайланд барууны орнуудын 23 дарангуйлагч болон тэдний гэр бүлийнхний хөрөнгийн талаарх мэдээллийг илчилсэн байна

[8] АЭНҮБК, 8 (5), 52 (5) ба (6) дугаар зүйл нь улс орнуудаас энэ төрлийн тогтолцоог бий болгох талаар бодолцохыг шаарддаг. Дэлхийн банкны судалгаагаар ойролцоогоор 143 улсаас төрийн албан тушаалтнуудын хөрөнгө эсхүл ашиг сонирхлын мэдээллийг ил тод болгох системийг нэвтрүүлсэн болохыг тогтоожээ. (Rossi, Pop, and Berger 2017).

[9] Тухайлбал, АНУ-д Холбооны Мөрдөх Товчоо нь тагнуулын байгууллаг ба хууль сахиулах байгууллагын эрх хэмжээг давхар гүйцэтгэдэг.

ШИГТГЭЭ 2.2 Европын улс төрчдийн эсрэг “Caviar Diplomacy” мэдэгдэл

2012 онд Европын тогтвортой байдлын санаачилга (ESI) буюу Берлин хотод төвтэй судалгааны төв нь “Түрс дипломат ажиллагаа” гэх нэртэй тайланг нийтэд дэлгэж Европын улс төрчид хахууль авч Азербайжан улсад улс төрийн дэмжлэг үзүүлж байсан талаар дурджээ. 2016 онд ESI нь Европын зөвлөлийн парламентын ассамблей(PACE)-н зарим гишүүд хэрхэн авлигад идэгдсэн талаар нийтэлж байжээ.

2017 онд Европын зөвлөл(COE) нь PACE-ийн гишүүд болон гишүүн асан хүмүүсийн талаарх гэмт хэргийн мэдээллийг мөрдөн шалгах бие даасан, хараат бус байгууллага байгуулсан. 10 гаруй сар үргэлжилсэн гэрчийн сайн дурын үндсэн дээр хамтран ажилласан мөрдөн шалгах ажиллагааны дүнд, бүлэг гишүүд парламентын ёс зүйн дүрмийг зөрчиж Азербайжан улсад давуу байдал олгож байсан нь тогтоогджээ. Үүнтэй холбогдуулан Европын зөвлөл болон Европын зөвлөлийн Парламентын ассамблейн 14 гишүүнийг огцруулсан байна.[a]

Энэхүү схемтэй холбогдох хамгийн цуутай нь Италийн улс төрч Лука Волонтед холбогдох хэрэг юм. Италийн прокуророос PACE-ийн гишүүн асан Лука Волонтег Азербайжан улсын хүний эрхийн эсрэг үйлдлийн талаарх Европын байгууллагын шүүмжлэлийг дарсны хариуд төлбөр авсан гэж буруушаасан. 2013 онд Волонте нь Азербайжан улсын улс төрийн хоригдлуудын талаарх PACE-н шүүмжлэлтэй тайланг (Strasser Report) батлагдахаас сэргийлж, нөлөөлсөн үйлдэлд буруутгагдсан байна.[b]

Схемийн дагуу Италийн прокуророос Волонтег Азербайжан улсын компаниас төлбөрийг[c] ИБУИНВУ-д бүртгэлтэй дөрвөн хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлөөр дамжуулан хоёр бизнесийн этгээдээр авсан гэж буруутгасан.[d] Энэхүү бизнесийн этгээдүүд нь “Danske Bank”-ны[e] Эстони улсын салбарт данстай байсан бөгөөд Дани, Эстони, Итали, ИБУИНВУ, АНУ-д шалгагдаж байна. Тус банкны Эстони улс дахь салбарын захирал асан нь энэхүү схемтэй холбогдсон шалтгаанаар яллагджээ.[f]

2014 онд, Милан хотын прокуророос Италийн банкны сэжигтэй гүйлгээний сэрэмжлүүлгийн дагуу Волонтед холбогдуулан мөнгө угаах болон авлигын хэргийг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн. Шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны явцад шүүгч нь тус хоёр хэргийг салгаж процессын үйл ажиллагааг гүйцэтгэсэн ба Волонте нь 2018 оны 02 дугаар сард мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон үйлдэлдээ цагаатгагдсан бөгөөд тус шийдвэрийг прокуророос давж заалджээ.[g]

a. Гэмт хэрэг ба аюулгүй байдлын Европын ажиглалтын төв (EX-OCS). 2018. “Европын зөвлөл Азербайжаны авлигын хэрэгт буруутгагдсан 14 гишүүнийг хөөв.” EU-OCS Political Watch, 2018 оны 7-р сарын 14. https://eu-ocs.com/council-of-europe-expels-14-members-accused -of-corruption-in-azerbaijan-case/.
b. Лука Волонтегийн яллах дүгнэлт, 2016 оны 7-р сарын 21, Миланы Прокурорын газар. Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигыг мэдээлэх төсөл /OCCRP/-өөс энэ хэрэгтэй холбоотой мэдээлэл, баримт бичгүүдийг гаргасан. Жишээлбэл, Пол Раду, Хадижа Исмаилова, Мадина Маммадова нарыг харна уу. 2017. “Азербайжан угаалгын газар: Нөлөөллийн машин.” OCCRP вэбсайт, 2017 оны 9-р сарын 4. https://www .occrp.org/en/azerbaijanilaundromat/the-influence-machine. Strдsser тайлангийн талаар мөн COE (2018, xiii) -ийг үзнэ үү.
c. Эдгээр машинууд нь Италийн сан болох Новае Террае сан байсан бөгөөд 2 сая гаруй еврог хэд хэдэн хэсэгчлэн хүлээн авсан; L.G.V. Волонтегийн эхнэрийн эзэмшдэг Италийн хязгаарлагдмал компани S.r.l. (Лука Волонтегийн яллах дүгнэлт, 2016 оны 7-р сарын 21).
d. Их Британийн дөрвөн түншлэл нь Шотландын Глазго хотод бүртгэлтэй Hilux Services LLP болон Polux Management LLP; Их Британи, Бирмингем хотын үйлчилгээний хаягаар бүртгэлтэй Metastar Invest LLP; болон LCM Alliance LLP, Hertfordshire, UK. Эдгээр 4 хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (XXK) нь эцсийн дүндээ Белиз, Сейшелийн арлууд, Британийн Виржиний арлуудын компаниудынээмшилд байсан

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 2.2 Европын улс төрчдийн эсрэг “Caviar Diplomacy” мэдэгдэл

бөгөөд тэдгээр нь мөн корпорацийн түншээр ажилладаг байв. Эдгээр түншлэлүүд нь эргээд Азербайжаны “Бакталеком ММС” компаниас мөнгө авсан. Италийн прокуророууд Волонтег мөн Маршаллын арлуудад бүртгэлтэй Jetfield Network Ltd компаниас Латви улсын Балтикумс банк дахь байгууллагын дансаар дамжуулан төлбөр хүлээн авсан гэж мэдэгджээ.
e. Лука Волонтегийн яллах дүгнэлт, 2016 оны 7-р сарын 21.
f. Андре Деликата. 2013. “Азербайжан дахь Авлигын схемд оролцсон банкийг шалгаж байгаа орнуудтай Итали нэгдэв.” The Shift News, 2019 оны 1-р сарын 3. https://theshiftnews.com/2019/01/03/investigations-into-danske-bank-scandal-continue-to-widen/.
g. “Азербайжан Европын зөвлөлийн экс гишүүдэд хэрхэн авлига өгсөн бэ?” Европын сонирхол, 2018 оны 4-р сарын 24. https://www.europeaninterest.eu /article/azerbaijan-bribed-ex-council-europe-members/; COE (2018, 66).

ШИГТГЭЭ 2.3 ИБУИНВУ: “Хяналттай хүмүүс”-ийн бүртгэл

Оршил: Олон улсын санхүүгийн хямрал болон ил тод бус корпорациар дамжуулан өргөн хүрээнд татвараас зайлсхийсэн талаарх олон нийтийн бухимдлын хариуд тухайн үеийн Ерөнхий сайд Давид Камерон өндөр хөгжилтэй орнууд болох “Их найм”-ын хуулийн этгээдийн ил тод байдлыг баталгаажуулах зорилгоор 2013 онд санаачилга гаргаж, эцсийн өмчлөгчийн ил тод бүртгэлийг бий болгохоор ажиллаж эхэлсэн. 2016 онд энэхүү санаачилгын хүрээнд, нийтэд ил тод бүхий “Ач холбогдол бүхий удирдлагатай хүмүүсийн бүртгэл”(PSC)-г байгуулжээ.

Зорилго: ИБУИНВУ-ын компани, Европын компани, Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, холбогдох Шотланд нөхөрлөлд удирдлага хэрэгжүүлж буй хувь хүн болон хуулийн этгээдийн мэдээллийг PSC-д холбогдох этгээдийн нэр дээр зарлана.[a] Үүний зорилго нь мэдээллийн ил тод байдлыг баталгаажуулж, ИБУИНВУ-ын компанийн өмчлөгч, удирдлагын талаарх мэдээллийг дэлгэх замаар компанийн итгэлийг нэмэгдүүлэх юм.

Үүрэг: 2017 оны 06 дугаар сарын 26-наас эхлэн, компани болон ХХН-ууд PSC бүртгэлд бүртгүүлэх шаардлагад нийцэж буй этгээдийн мэдээллийг олж мэдсэнээс хойш 14 хоногийн дотор бүртгүүлэхийг үүрэг болгосон. Бүхий л компани болон ХХН нь дараагийн 14 хоногийн дотор PSC-ийн төв бүртгэлийг шинэчлэх шаардлагатай юм.[b]

PSC-д хэн бүртгүүлэх этгээд: Дор дурдсан аль нэг нөхцөл эсхүл хэд хэдэн нөхцөлийг хангасан этгээд нь PSC-д бүртгүүлнэ:

- Хувьцааны 25 хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг
- Саналын эрхийн 25 хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг
- Захирлуудын зөвлөлийн олонхийг томилох эсхүл огцруулах эрхийг шууд болон шууд бусаар эзэмшдэг
- Их хэмжээний нөлөөлөл эсхүл удирдлагыг хэрэгжүүлэх эрхтэй
- Чухал ач холбогдол бүхий нөлөө үзүүлэх эсхүл бодитоор хэрэгжүүлэх эрхтэй хувь хүн буюу хуулийн этгээдийн шинжгүй боловч эхний дөрвөн нөхцлийн аль нэгийг нь хангасан итгэмжлэгч, эсхүл фирм.

PSC-д бүртгүүлэх мэдээлэл: Тус бүртгэл нь дээр дурдсан таван нөхцөлийн аль нь хангагдсан талаарх мөн холбогдох тохиолдолд хангагдсан нөхцөлийн тоог мэдүүлдэг. Бүртгүүлэх этгээд нь PSC-д өөрийн сайн дурын үндсэн дээр мэдээлэл гаргаж өгөх эсхүл компанийн мэдээлэл хүссэн хүсэлтэд хариулах шаардлагатай бөгөөд биелүүлээгүй тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг гэж үзнэ.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 2.3 ИБУИНВУ: “Хяналттай хүмүүс”-ийн бүртгэл

Мэдээлэлд нэвтрэх: Өөрсдийн PSC бүртгэлийг хөтлөх компаниуд мэдээллийг нийтэд нээлттэй байлгана. Төв бүртгэлээс бүртгэгдсэн этгээдийн гэрийн хаяг болон төрсөн огнооноос бусад ихэнх мэдээллийг нийтэлнэ. Төв бүртгэлд байгаа бүх мэдээлэл нь хууль сахиулах байгууллагад нээлттэй байна.

a. Мөн “Компани болон хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлд тавигдах PSC-ын шаардлага” (хамгийн сүүлд 2018 оны 2-р сарын 15-нд шинэчлэгдсэн)-д тусгагдсан удирдамжийн баримт бичгүүдийг үзнэ үү. https://www.gov.uk/government/publications/guidance-to-the-people-with- компани болон хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлд тавигдах чухал -хяналтын шаардлага.
b. Companies House нь Их Британийн Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн яамнаас ивээн тэтгэдэг гүйцэтгэх агентлаг бөгөөд хязгаарлагдмал компаниудыг нэгтгэх, татан буулгах, компанийн мэдээллийг шалгаж, хадгалах, олон нийтэд нээлттэй болгох ажлыг хариуцдаг. PSC-ын бүртгэлийг бүрдүүлдэг өгөгдлийн файлуудыг Companies House-ийн http://download.companieshouse.gov.uk/en_psc-data.html цахим хуудаснаас авах боломжтой.

2.3. Хууль тогтоомжид үнэлгээ хийх болон эрх зүйн шинэчлэлийг бодолцох нь

Эрх бүхий байгууллагаас дотоодод болон гадаадын холбогдох харьяалалд үр дүнтэй бөгөөд нөхцөл байдалд нийцсэн эрх зүйн орчин байгаа эсэхийг тогтоох нь нэн чухал ач холбогдолтой.[10] Энэ нь хөрөнгийн менежмент болон олон улсын хамтын ажиллаанд холбогдох зөв эрх зүйн хэрэгсэл болон зохицуулалт байгаа эсэх хамаарна. (6-р бүлэг, хөрөнгийн менежмент болон 9-р бүлэг, олон улсын хамтын ажиллагаанаас илүү мэдээллийг авна уу.) Тухайлбал хөрөнгө хураах ажиллагааг гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах ерөнхий хуулиар зохицуулсан байж болно эсхүл тодорхой гэмт хэрэгт холбогдох зохицуулалтаар гүйцэтгэнэ. Дээрх хоёр тохиолдолд мөрдөн шалгаж буй хэрэгт холбогдуулан хөрөнгө хураах ажиллагааг гүйцэтгэхэд хуулиар зөвшөөрсөн эсэхийг урьдчилан тодорхойлох хэрэгтэй.

Тодорхой эрх зүйн хэрэгсэл нь хангалтгүй тохиолдолд бусад хэрэгслийг ашиглахаар бодолцох нь зөв. Зарим улсад, хууль батлагдахаас өмнө үйлдэгдсэн гэмт үйлдлийг зохицуулахад шинэ процесс ашиглах боломж байдаг. Тухайлбал, эрх бүхий

[10] Цахим судалгаа, гадаадын албан тушаалтнуудтай холбоо тогтоох нь гадаадын хууль тогтоомжийг судлах тустай эх сурвалж болно. Зарим улс орнууд өөрсдийн төрийн байгууллагын цахим хуудсанд хууль тогтоомжийг байршуулсан байдаг. Эдгээр эх сурвалжийг хавсралт J-ээс үзнэ үү. Хууль тогтоомжийн бусад эх сурвалжийг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны (UNODC) TRACK платформод авлигын эсрэг мэдээлэл байршуулсан байдаг (http://www.track. unodc.org/Pages/ home.aspx) болон Олон улсын мөнгө угаах мэдээллийн сүлжээ (IMOLIN) (2018 оны 8-р сарын 12-нд хандсан) (https://www.imolin.org/). Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах(StAR) санаачилга нь холбогдох 30 гаруй улсын хөрөнгө буцаан авах арга үйл ажиллагааны заавар, журам, мөн үндэсний агентлагуудын холбоо барих мэдээллийг агуулдаг. https://star.worldbank .org/ArabForum/asset-recovery-guides.

байгууллагаас яллагдагчтай хэрэг наймаалцаж хөнгөн ял[11] өгөх талаар бодолцох, эсхүл дээд хэмжээний ялаас хөнгөн ял өгөх саналыг гаргах байдлаар илүү чухал сэжигтэнд хамаарах нотлох баримт гаргуулахад хамтран ажиллахыг хүсэж болно. Энэ төрлийн процессыг Перу улс Монтесиносын хэрэг (1-р бүлэг, шигтгээ 1.3) болон Бразил улс "Автомашин угаалга ажиллагаа" мөрдөн шалгах ажиллагаанд (шигтгээ 2.4) ашигласан. Өмнө нь үйлдэгдэж байсан үйлдлийг гэмт хэрэгт тооцсон хууль эсхүл процесс нь хуулийн болоод үндсэн хуулийн маргаан дагуулдаг тул ихээхэн асуудал дагуулж болзошгүй гэдгийг улс орнууд анхаарах хэрэгтэй.[12]

ШИГТГЭЭ 2.4 Бразил: "Автомашин угаалга" ажиллагааны танилцуулга

Бразил улсын Автомашин угаалга хэрэгт эрх зүйн шинэчлэл хийж ял наймаалцах боломжийг бий болгож, мөрдөгч болон прокурорууд хөнгөн ял оноох хөшүүргийг ашиглан шаардлагатай мэдээллийг гаргуулах нөхцөлийг бүрдүүлснээр амжилт олсон. 2013 онд авлигатай хийсэн тэмцлийн давалгаанд Ерөнхийлөгч Дилма Роуссефф системийн залиланг ил болгох зорилгоор хууль батлах ажиллагааг эрчимжүүлсэн.[a]

Нарийвчлахад. 2013 оны №. 12,850 "Гэмт бүлэглэлийн тухай" холбооны хууль нь Бразилийн прокурорууд ял наймаалцах боломжийг олгосон. Энэхүү хэрэгсэл нь хэдийгээр өмнөх хуульд тусгагдсан боловч, хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалт цөөн байснаас төдийлөн хэрэглэдггүй байжээ (Ribeiro 2017). Хуульд заасан "Шагналт хамтын ажиллагаа"[b] гэх зохицуулалт нь АНУ-д тогтмол хэрэглэгддэг ял наймаалцах ажиллагаатай төстэй боловч гэм буруутайд тооцоход ашигладаггүй байдлаар ялгарч байв. Цаашлаад зөвхөн хувь этгээдэд[c] хамаарах бөгөөд хуулийн этгээдийг харьялалд оруулдаггүй байна. Тус хэрэгслийг ашиглан бусад гэмт этгээдийг илрүүлэх, гэмт бүлэглэлийн зохион байгуулалтыг илчлэх, гэмт бүлэглэлийн бусад гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө хураах эсхүл хохирогчийг тогтоох зэрэг зөвхөн нотлох баримт гаргуулна (Ribeiro 2017).

2014 оны 03 дугаар сард хууль батлагдсанаас хэдэн сарын дараагаар Бразил улсын Холбооны Цагдаагийн газар болон Холбооны Прокурорын албанаас нэгэн хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж эхэлсэн нь хожим Автомашин угаалгын хэрэг гэх нэртэй болсон. Мөрдөн шалгах ажиллагааны дүнд "Доллар хүн" гэх хар захын мөнгөний дилер, Бразил улсын өмчит газрын тосны компани "Петробас"-ын захирал асан тус хэрэгт холбогдож байсныг илрүүлжээ. (хариуцах талуудыг тогтоох ажиллагаа чухал болох талаар Шигтгээ 2.13-аас харна уу.)

Тус хоёр этгээдийг баривчилсны дараагаар тэд хамтран ажиллаж эрх бүхий байгууллагад мэдээлэл гаргаж өгсний дагуу олон зуун ял наймаалцах гэрээг холбогдогч талуудтай байгуулсан. Энэхүү хэрэгслийг Автомашины угаалга хэрэгт холбогдуулан өргөн хүрээнд ашиглаж Бразил улсын төрийн байгууллага болон хувь этгээдийн хооронд олон тооны гэрээг байгуулжээ.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[11] Тухайлбал, Аргентин улс 2016 онд гэмт хэрэгт хамтран зүтгэгчдийг эрх баригчидтай хамтран ажиллах урамшуулал (ялыг хөнгөлөх гэх мэт) олгох зорилгоор Лей дель Аррепентидо-г нэвтрүүлсэн. Гэвч энэ хуулиар мөрдөгчдөд өргөн хүрээний эрх мэдэл өгөөгүй, хамтран ажиллах боломж хязгаарлагдмал байна гэж шүүмжилдэг. (Бенжамин Н. Гедан ба Кристофер Фален. 2018. "Аргентинд яагаад Одебрехт фронтод бүгд чимээгүй байна?" Americas Quarterly, 2018 оны 4-р сарын 9. https://www.americasquarterly.org.

[12] Жишээ нь, Лихтенштейн, Тайланд, АНУ-д (Greenberg et al. 2009, 45–46), эд хөрөнгө хураах тухай хуулиудыг буцаан хэрэглэх тухай асуудал хөндөгдөж байна.

ШИГТГЭЭ 2.4 Бразил: “Автомашин угаалга” ажиллагааны танилцуулга

a. Жонатан Уоттс. 2017. “Авто угаалгын газар: Энэ хэрэг түүхэн дэх хамгийн том авлигын дуулиан мөн үү?” The Guardian, 2017 оны 6-р сарын 1 (2019 оны 1-р сарын 27-нд шинэчлэгдсэн). https://www.theguardian.com/world/2017/jun/01/brazil-operation-car-wash-is-this-the-biggest -corruption-scandal-in-history.
b. “Шагналтай хамтын ажиллагаа” гэж орчуулагдсан; Бразилд үүнийг delação premiada (шагналтай үгүйсгэл) гэж нэрлэдэг (Рибейро 2017, 7).
c. Бразилд байгаль орчны эсрэг гэмт хэргээс бусад тохиолдолд аж ахуйн нэгжид эрүүгийн хариуцлага тооцдоггүй. Бразилийн цэвэр компанийн тухай хуулийн (2013 оны 12,846-р Холбооны хууль) үндсэн дээр хуулийн этгээдэд иргэний болон захиргааны хариуцлага хүлээлгэж болно. г. Холбооны прокурорын алба. “Үр дүн,” Машин угаалгын хэрэг [Португали хэлээр] (2020 оны 8-р сарын 10-нд шинэчлэгдсэн). http://www.mpf.mp.br /grandes-casos/lava-jato/resultados

Тухайлбал, Перу улсын Засгийн газраас тухайн үеийн Тагнуулын албаны дарга Владимиро Монтесиносын мөрдөн шалгах ажиллагааны эхэн үед стратегийн алхам хийж №27.738 хуулийг батлсны дагуу зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн мөрдөн шалгах ажиллагаанд ял наймаалцах механизмыг нэвтрүүлсэн. Үүний хүрээнд Англо-Саксоний эрх зүйн тогтолцоонд Ром-Германы эрх зүйн тогтолцоотой харьцуулбал төдийлөн их байдаггүй “гэм буруугаа хүлээх” болон ял наймаалцах гэрээг Перу улсад шинээр нэвтрүүлжээ. Тус хууль нь яллагдаж буй зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүд (толгойлогч болон зарим төрийн албан хаагчидаас бусад)-ийг прокурортой хамтран ажиллаж ял наймаалцах гэрээ байгуулан мэдээлэл өгч хөнгөн ял сонсох боломжийг бүрдүүлсэн.

Хуулийн хүрээнд гэм бурууг тогтоож, олон жил үргэлжлэх байсан шүүн таслах ажиллагааг өндөрлүүлсэн. Хамгийн чухал нь энэ хууль нь Перу улсын эрх бүхий байгууллагуудыг Монтесиносын хөрөнгийн урсгалын талаарх мэдээллийг түргэн шуурхай авч гадаад улсын харьялаллаас 175 сая ам.долларын хөрөнгийг хураах боломжийг бүрдүүлсэн.

2.4. Хэргийн стратегийг боловсруулах нь

Албан хаагчид хэргийн стратеги боловсруулж, хэрэгжүүлэхэд бүтээлчээр сэтгэх нь чухал. Хамтарсан ажлын хэсэг эсхүл гадаад улсын байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах баг байгуулах зэргээр шинэлэг аргаар асуудлыг шийдвэрлэхээр хэлэлцэх нь стратеги боловсруулах явцын нэг хэсэг байх хэрэгтэй. Үндэстэн дамнасан, өргөн, ээдрэй төвөгтэй хэргийн хувьд мэргэшсэн баг, нэгж эсхүл ажлын хэсэг байгуулах эсхүл гадаад улсын байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэх талаар шийдвэр гаргах үед бодолцох нь чухал.

Хэргийн харьялал болон нөхцөл байдлаас шалтгаалж мөрдөн шалгах болон прокурорын баг шаардагдах ба холбогдох төрийн байгууллага эсхүл гадаад улсын байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэхийг шаардана.[13] Мэргэшсэн нэгж эсхүл гадаад улсын байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулахад сонгох албан хаагчид болон байгууллагын талаар 2.6 дугаар хэсэгт дэлгэрэнгүй дурдав. Энэ хүрээнд үр дүнтэй албан бус хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой.

[13] Мөрдөн шалгах ажиллагааны багууд ихэвчлэн шүүгдэгчийн эсрэг хэрэг үүсгэхээс өмнө болон дараа нь мөрдөн шалгал ажиллагаа, тагнуулын мэдээлэл цуглуулдаг. Гэсэн хэдий ч зарим улс оронд “мөрдөн шалгах” гэсэн нэр томъёог зөвхөн албан ёсны хэрэг үүсгэсний дараа ашигладаг.

Албан хаагчид мөн шинэ мэдээлэл, боломж, шийдвэр гарсантай холбогдуулан гүйцэтгэж буй хэргийн стратегийг дахин үнэлэх ажиллагааг баталгаажуулах нь зөв. Прагматик байдал чухал бөгөөд эхний сонголтыг дахин хянаж (дотоодын болон олон улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагыг шаардлагатай тохиолдолд оролцуулж), мөрдөн шалгах явцад хамгийн зөв гэдгийг ямагт баталгаажуулж байх хэрэгтэй. Тухайлбал эрх зүйн нэг хэрэгслийг ашиглан хөрөнгө хураах ажиллагааг гүйцэтгэх нь өөр хэргийг мөрдөн шалгах холбогдох баримт мэдээллийг өөр нэгэн хэрэгслийг ашиглан олох боломжийг олгодог.

ШИГТГЭЭ 2.5 Лозанна удирдамж

Хулгайлагдсан хөрөнгийг үр дүнтэй хураах Лозанна удирдамж нь 2014 онд "Лозанна процесс" буюу 2001 оноос 30 гаруй улс, олон улсын байгууллагын шинжээчдийг хамруулсан олон улсын шинжээчдийн семинард холбогдуулан гарчээ. Лозанна процесс нь холбогдох улсын албан хаагчид Засаглалын Базел Институтын Хөрөнгө хураах олон улсын төв болон Дэлхийн банк болон НҮБ-ын МБГХТА-ны хамтарсан Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилгатай нягт хамтран ажиллаж хөрөнгө хураах чиглэлд тулгарч буй асуудал болон шийдлийн талаар хэлэлцэх боломжийг бүрдүүлсэн.[a]

НҮБ-ын Ерөнхий Ассемблей болон Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн гишүүн орнуудын конференцээс олгосон бүрэн эрхийн дагуу 2014 оны Лозанна VIII семинарын оролцогчид өөрсдийн мэдлэгийг нэгтгэж Хулгайлагдсан хөрөнгө үр дүнтэй хураах удирдамжийг боловсруулсан.

Лозаннагийн 10 удирдамж нь хөрөнгө хураах хэргийг зохион байгуулах, менежмент хийхэд гүйцэтгэх шат дараалал, үйл ажиллагааг нарийвчлан зааж өгсөн. Тус үйл ажиллагаа нь харилцаа тогтоож ашиглах, эрх зүйн шаардлагын талаар харилцах мэдээллийг стратеги боловсруулах, эрх зүйн харилцан туслалцааны шаардлага, цаг хугацаа болон хэргийн стратеги боловсруулахад хөрөнгө царцаах, мөрдөн шалгах болон давхар мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх талаар оруулахыг заажээ.

а. Лозаннийн удирдамж нь бодлого боловсруулагчид, хууль тогтоогчид зэрэг салбарын мэргэжилтнүүдээс бусад олон хэрэглэгчдэд хамааралтай. Зааврыг бүрэн эхээр нь https://guidelines.assetrecovery.org/guidelines хаягаар орж, Базелийн хүрээлэнгийн Засаглалын цахим хуудаснаас "Хулгайлагдсан хөрөнгийг үр ашигтай нөхөн сэргээх заавар"-аас үзнэ үү. Түүнчлэн Хавсралт К-д Удирдамжийн тоймыг оруулсан болно.

Хэргийн стратеги нь мөрдөн шалгах ажиллагааны явцад шинэ мэдээлэл, холбогдох илэрсэн тохиолдолд захин залруулах, өөрчлөх боломжтой баримт бичиг байх шаардлагатай. Албан хаагчид Хулгайлагдсан хөрөнгийг үр дүнтэй хураах удирдамжийн хэргийн стратеги боловсруулах, менежмент хийх талаар шигтгээ 2.5-аас харж болно.

2.5 Ажлын хэсэг, нэгж, баг байгуулж, гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь.

Олон талт салбарын ажлын хэсэг эсхүл нэгж байгуулах нь санхүүгийн мөрдөгч, шинжээч, нягтлан бодогч, хууль сахиулах албан хаагч, прокурор болон хөрөнгийн менежер зэрэг төрөл бүрийн салбарын хүмүүсийг оролцуулах боломжоор хангадаг. Шинжээчдийг хувийн салбараас томилох эсхүл зохицуулах байгууллага, санхүүгийн тагнуулын алба, татварын алба, аудитын алба эсхүл хяналтын байгууллагын албан

хаагчдийг түр хугацаагаар ажилуулах замаар бүрдүүлж болно. Гадаад улсын байгууллагатай хамтарсан мөдөн шалгах ажиллагаа гүйцэтгэх шийдвэр гарсан тохиолдолд мөрдөгч нар нь өөрийн улсын эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт болон олон улсын хамтын ажиллагааны орчны талаар сайтар мэдлэгтэй байх шаардлагатай. Боломжтой тохиолдолд албан хаагчид гадаад улсын хамтрагчидтай үр дүнтэй харилцах үүднээс холбогдох хэлээр ярих чадвартай байх нь чухал.

2.5.1 Мөрдөн шалгах, яллах ажлын хэсэг болон мэргэшсэн хөрөнгө хураах нэгж

Түүнчлэн прокурор нь хэргийг шүүхэд үр дүнтэй танилцуулах санхүүгийн хангалттай мэдлэг, туршлагатай байх шаардлагатай. Тусгай прокурорыг төрийн өндөр албан тушаалтан холбогдсон хэрэгт ашиг сонирхлын зөрчил үүсэхээх сэргийлж, хараат бус мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэн хэргийн процессын шударга байдлыг хангах зорилгоор томилж болно.

Ихэвчлэн өндөр түвшний прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг удирдах эсхүл хууль сахиулах албан хаагчийн гүйцэтгэж буй үйл ажиллаагаатай тухай бүр танилцаж байх шаардлагатай юм. Учир нь прокурор өөрөө шүүхэд хэргийг танилцуулах бүрэн эрхтэй. Удирдах прокурор нь хууль сахиулах байгууллагаас хэргийн гэм бурууг тогтооход шаардлагатай холбогдох нотлох баримтыг бүрэн цуглуулсан эсэх, хойшлуулашгүй ажиллагаа гүйцэтгэх болон хөрөнгө хураах шийдвэр гаргуулсан эсэхийг хянах шаардлагатай.[14] Цаашлаад албан хаагч нь чагнах, нэгжлэг хийх, баривчлах, ял наймаалцах зэрэг мөрдөн шалгах тусгай хэрэгсэл ашиглах зөвшөөрөл авах шаардлагатай тохиолдолд прокурор нь шүүгч ба хууль сахиулах албан хаагчийн хооронд гүүр болон ажиллах шаардлагатай.

Хууль сахиулах эсхүл прокурорын байгууллага нь тодорхой хэргийн хүрээнд хөрөнгө хураах зорилгоор нотлох баримтыг цуглуулж, үнэлэх бүрэн эрхтэй байдаг. Боломжтой тохиолдолд үндсэн мөрдөн шалгах ажиллагааны ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө хураах, яллах, мөрдөн шалгах тусгай ажлын хэсгийг байгуулах нь үр дүнтэй. Туршлагаас харахад, мөрдөн шалгах болон хөрөнгө хураах ажиллагааг албан хаагч прокурор нь зэрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг байна. Зарим улсад тухайлбал, яллах ажиллагааг мөрдөн шалгах ажиллагааны ихэнх хэсэг гүйцэтгэгдсэн тохиолдолд эхлүүлдэг бөгөөд энэ нь хөрөнгө хураах ажилллагааг гүйцэтгэхэд хэтэрхий оройтсон байдаг. Түүнчлэн мөрдөгч болон прокурор нь ихэвчлэн олон тооны хэргийг зэрэг шалгадаг тул хөрөнгө хураах ажиллагаанаас илүүтэйгээр гэм бурууг тогтооход анхаарал хандуулдаг. Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үед хөрөнгийг царцаах, хураах нь нэн чухал юм.

Хөрөнгө хураах тусгай нэгжийг байгуулснаар мөрдөгч болон прокурор нь хэргийг үр дүнтэй шүүхэд танилцуулах тусгайлсан ур чадварыг эзэмшдэг. Хөрөнгө хураах эсхүл царцаах ажиллагаа нь гэм бурууг тогтоохоос илүүтэйгээр нарийн төвөгтэй мөрдөн шалгах ажиллагааг шаарддаг бөгөөд энэ чиглэлд хараат бус, бие даасан, объектив байдлаар хандах ёстой. Хөрөнгө хураах мөрдөгчид нь өөрсдийн ур чадварын хүрээнд энгийн мөрдөгчдөөс илүүтэйгээр хэргийн хөрөнгийг илрүүлж, гадаад улсад байршсан хөрөнгийг олох зорилгоор олон улсын шугамыг ашигладаг. Энэ төрлийн аргыг ашигласан тохиолдолд хөрөнгө хураах албан хаагчид

[14] Зарим Ром-Саксоны эрх зүйн тогтолцоонд мөрдөгч шүүгчид хэргийн эхэн үеэс эхлэн эцсийн шийдвэр гартал мөрдөн шалгах ажиллагааг удирдаж болдог.

хамтрагчидтайгаа нягт хамтран ажиллаж гэм бурууг тогтооход анхаарал хандуулах ёстой. Үр дүнтэй хамтран ажиллахгүй байх нь мөрдөгч, прокуроруд хангалттай санхүүгийн мэдээлэл эсхүл нотлох баримт олох боломжгүй байдалд хүргэж хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлж, цаашлаад хөрөнгө хураах ажиллагаанд нөлөөлдөг.

Ажлын хэсэг нь а. Мөрдөн шалгах, яллах эсхүл аль аль бүрэн эрхийг нь хэрэгжүүлдэг авлигатай тэмцэх байгууллагад эсхүл б. Энгийн хууль сахиулах болон прокурорын байгууллагад байгуулагдсан байж болно. Ямар байгууллагад байгуулагдсанаас үл хамаарч мөрдөгч болон прокуроруудын мөрдөн шалгах, яллах бүрэн эрхээс гадна хэргийн хөрөнгийг хураан авахтай холбоотой эрх мэдэл нь хуулиар баталгаажсан байх нь чухал байдаг.[15]

2.5.2 Хамтарсан ажлын хэсэг

Хөрөнгө хураах тусгайлсан ажлын хэсгийг хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан олон төрлийн байгууллагаас бүрдсэн хамтарсан ажлын хэсэг болгон өргөжүүлэх боломжтой. Хамтарсан ажлын хэсэг нь хуулиар зөвшөөрөгдсөний дагуу төрийн болон хувийн салбарын хөрөнгө хураах, яллах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сонирхолтой төлөөлөгчдөөс бүрдэж болно. Энэхүү ажлын хэсэг нь мэдээлэл солилцох болон мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор харилцах, шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар дүгнэх боломжийг олгодог.

Ингэхдээ ажлын хэсэгт байгаа байгууллага болон албан хаагчдын үүргийг нарийвчлан тодорхойлж аливаа төөрөгдөл, өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх хэрэгтэй. Түүнчлэн ажлын хэсгийн гишүүн байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг хүлээн зөвшөөрч үнэлэх шаардлагатай. Ихэвчлэн энэ зорилгоор хамтарсан хэвлэлийн мэдээ хийх эсхүл төсвийн хуваарилалт хийдэг.

Хамтарсан ажлын хэсэг нь хууль сахиулах болон прокурорын байгууллагаас гадна дараах салбарын байгууллагаас бүрдэж болно.[16] Үүнд:

- Татвар
- Гааль
- Хууль зүй
- Гадаад харилцаа
- Улсын төсөв
- Иргэн харьяатын
- Санхүүгийн тагнуулын алба
- Зохицуулах байгууллага
- Төв байгууллага[17]
- Хөрөнгийн менежмент хийх байгууллага

Тунис улсын Ерөнхийлөгч асан Бен Алигийн дэглэмийн гишүүдийн хөрөнгийг мөшгих комисс байгуулсан талаарх жишээг Шигтгээ 2.6-д харуулав.

---

[15] Ерөнхийдөө гадаадын харьяалал нь хууль тогтоомжоор эрх олгогдоогүй агентлагаар удирдуулсан мөрдөн шалгах ажиллагаанд эрх зүйн харилцан туслалцаа олгохоос татгалздаг.

[16] Эдгээр агентлагуудын тодорхой чиг үүргийн талаар 3-р бүлгээс харна уу. Холбогдох байгууллагуудаас авах боломжтой мэдээллийг 3-р бүлгийн 3.4.2-т дэлгэрэнгүй харуулав.

[17] Төвийн байгууллагын тухай ойлголтыг 8-р бүлгийн 8.4-р хэсэгт тайлбарласан болно.

ШИГТГЭЭ 2.6	Тунис: Бен Али болон түүний гэр бүлийнхний холбогдсон хэрэгт Зохион байгуулах, мөрдөн шалгах нэгж байгуулсан тухай

2011 онд Тунис улсын Ерөнхийлөгч Бен Али огцорч, зугтсаны дараагаар шинэ эрх бүхий албан тушаалтнууд түүний болон хамтрагчдыг авлигын хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах шаардлагатай гэж үзжээ. Түр Засгийн газраас төсвийн хөрөнгийг шамшигдуулсан, мөнгө угаасан, эрх мэдлээ урвуулан ашигласан болон хахууль авсан хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн.

Мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэх зорилгоор дотоодын мэдээллийн солилцоо, эрх зүйн арга хэмжээг үр дүнтэй авахаар Засгийн газраас гадаад улсын хэргүүдийг зохион байгуулах үндэсний хороог байгуулсан. Хороо нь Сангийн сайд, Хууль зүйн сайд, Гадаад харилцааны сайд, Төв банк, Санхүүгийн тагнуулын нэгж, Санхүүгийн шинжилгээний комисс болон Гаалийн албанаас бүрджээ.[a] Түүнчлэн Хууль зүйн сайдаас тодорхой прокурорын нэгжийг Санхүүгийн гэмт хэрэгт мэргэшсэн шүүхийн дор байгуулсан.

Үндэсний хороо нь Франц, Итали, Ливан, Испани болон Швейцар улсуудад байгаа холбогчдын хэргийг зохион байгуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн. Холбогдох байгууллагын оролцоог хангаж, Санхүүгийн тагнуулын нэгж болон прокурорын байгууллага хоорондын мэдээллийн солилцоог эрчимжүүлсэн. Мөн комисс нь мөрдөн шалгах ажиллагааны хамтын ажиллагааг баталгаажуулж, Франц болон Швейцар улсад гүйцэтгэгдсэн хэргийн орлогын шүүх хуралд Тунис улс иргэний нэхэмжлэгчээр оролцох боломжийг бий болгосон.

a. "Гадаад улсад байршуулсан хууль бус хөрөнгийг буцаан авах үндэсний хороо байгуулах тухай 2011 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 2011-15 дугаар тогтоол"-ыг үзнэ үү, https://legislation-securite.tn/fr/node/43750

Дотоодын ажлын хэсэг байгуулах үр дүнг харуулсан мөн нэгэн жишээ бол олон тооны улсад хамаарах мөрдөн шалгах, хөрөнгө хураах ажиллагааны Малайзийн Хөгжлийн Берхад хэрэг юм(1MDB). Шигтгээ 2.7-д харуулав.

Эцэст нь хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал үүсч болзошгүй үед хувийн салбарын туслалцаа ихээхэн үр дүнтэй байх боломжтой. Хувийн байгууллага нь ээдрэй төвөгтэй хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, эх сурвалжтай байдаг. Цаашлаад хувийн байгууллага болон төрийн байгууллагын хамтын ажиллагаа нь гэмт хэргийн хөрөнгийг үр дүнтэй хураан авахад нөлөөлөх боломжтой.[18] ИБУИНВУ-ын Дотоод хэргийн сонгон шалгаруулах комиссоос бүрэн биелэгдээгүй хөрөнгө хураах даалгаврыг биелүүлэх хувийн салбарын зах зээлийг бий болгож амжилттай гүйцэтгэсэн тохиолдолд хувь өгдөг байхаар зохицуулахыг санал болгожээ.

[18] Виртуал валютын хувьд хувийн хэвшилтэй хамтран ажиллахын давуу талуудын талаар мөн 4-р бүлгийн 4.2.5-ыг үзнэ үү.

2.5.3 Гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтран мөрдөн шалгах нь

Ээдрээ төвөгтэй мөрдөн шалгах ажиллагаанд өөр улсын байгууллагатай хамтран арга хэмжээ авах, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэх эсхүл гадаад улсын байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулахыг шаарддаг.[19]

ШИГТГЭЭ 2.7 Малайз: 1MDB хэргийн мөрдөн шалгах ажиллагаан дахь дотоодын болон олон улсын хамтын ажиллагаа

Оршил: "1MDB" нэрээр алдартай хэрэг нь Малайзийн Хөгжлийн Берхадаас шамшигдуулсан хөрөнгийг олон улсын түвшинд мөнгө угаах хуйвалдаантай холбогдох бөгөөд Малайз улсын Засгийн газрын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилготой улсын хөрөнгө оруулалтын санд холбогдох хэрэг юм.[a] Гэвч 1MDB-ны албан хаагчид, хамтрагчид нь 4.5 тэрбум ам.долларыг Сингапур, Люксембург, АНУ-ын компаниудаар дамжуулан гүйлгээ хийж шамшигдүүлжээ.[b]

Дотоодын ажлын хэсэг: Малайз Улсад өндөр түвшний ажлын хэсгийг байгуулж тус хэрэгт холбогдуулан дотоодын үйл ажиллагаа болон олон улсын хамтын ажиллагааг зохион байгуулж эхэлжээ. Ажлын хэсэг нь ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Авлигатай тэмцэх комиссын ерөнхий комиссар болон Төв банкны захирагчаас бүрдсэн.

Олон Улсын зохион байгуулалт: Малайз улсын эрх бүхий байгууллагаас Сингапур, Швейцар, АНУ болон бусад мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж буй холбогдох улстай (Франц, Индонез, Люксембург) хамтарсан зохион байгуулалтын механизмыг байгуулсан. Эдгээр улсууд нь хөрөнгийг илрүүлэх, зохион байгуулах, мэдээлэл солилцох, хөрөнгө буцаах ажиллагаанд хамтран ажиллсан.

Энэхүү хэрэгт хэрэглэгдсэн механизмын нэн чухал элемент нь:

- Олон улсын зохион байгуулалтын механизм. Мэдээллийг цуглуулах, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт эсхүл Эгмонт группын Санхүүгийн тагнуулын нэгжээр дамжуулан мэдээлэл авах
- Эрх зүйн саад тотгороос зайлсхийх. Үр дүнтэй, хурдан шуурхай хамтын ажиллагаа нь улс орнууд гадаад улсын эрх зүйн шаардлагыг ойлгох боломжийг олгосон.
- Эх сурвалжийг бүрэн дүүрэн ашиглах. Үр дүнтэй менежмент хийснээр мөрдөн шалгах ажиллагааг давхардуулж гүйцэтгэхээс сэргийлсэн.

Хэргийн үр дүн ба хөрөнгө хураах нь: Хэргийн үр дүнд Куала Лумпур хотын Дээд шүүхээс Ерөнхий сайд асан Нажиб Разакад 12 жилийн хорих ял оноож 49.4 сая ам.долларын торгууль ногдуулсан.[c] Оногдуулсан ялыг давж заалдсан байна.

Олон улсын ажлын хэсгийн онцлох үр дүнг дурдвал:

- Сингапурын холбогдох байгууллагаас 15.3 сая ам.долларыг Малайз улсад мөрдөн шалгах ажиллагаа эхэлснээс 1 жилийн дотор буцаасан.
- Экуанимити дарвуулт онгоц буюу Индонез улсын холбогдох байгууллагаас Бали аралд царцаасан хөрөнгийн Малайз улсад буцаан олгосон. Малайз улс нь тус дарвуулт онгоцыг 126 сая ам.доллараар худалдсан.[d] АНУ-ын шүүхээс мөн Сингапур улсад байрлах хувийн нисдэг тэргийг худалдах эрхийг олгосон.[e]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[19] АЭНК, 49-р зүйл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц (UNTOC), 19-р зүйл, хоёр болон олон талт гэрээ, хэлцлийн үндсэн дээр хэрэг тус бүрээр хамтран мөрдөн шалгах баг байгуулах тухай.

ШИГТГЭЭ 2.7 Малайз: 1MDB хэргийн мөрдөн шалгах ажиллагаан дахь дотоодын болон олон улсын хамтын ажиллагаа

- АНУ-ын Засгийн газраас Малайз улсад 57.04 сая ам.долларыг тус улсын Хууль зүйн яамнаас Холливуудын кино компани "Ред Гранит Пикчерс"-тэй ял наймаалцах гэрээ хийсний дагуу буцаасан. Малайз улсаас тус компанийн хамтран үүсгэн байгуулагч Волл Стрийтийн Чоно киноны продюсерын 250 сая ам.доллар хүлээн авсан үйлдэлд ногдуулсан ялыг цуцалсан. Гэвч шүүхийн шийдвэрээр 107 сая ам.долларыг буцаан олгохыг шийдвэрлэсэн.[f]
- АНУ-д Хууль зүйн яам нь 49 сая ам.долларын хохирол бүхий иргэний хэргийг шийдвэрлэсэн. Үүнд Беверли Хиллс болон Нью-Йорк хотод байрлах 49 сая ам.долларын өртөг бүхий өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийг тус хэрэгт холбогдуулан олж авсан хөрөнгөөр худалдан авсан байжээ.[g] Үүнээс өмнө АНУ-аас 1 тэрбум ам.долларын хөрөнгийг буцаан олгоод байсан.
- 2020 оны 03 дугаар сард АНУ-ын мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд 1 тэрбум гаруй ам.долларын хөрөнгийг Малайз Улсад буцаан олгосон байна.[h]
- 2020 оны 07 дугаар сард Голдман Сакс байгууллагаас 3.9 тэрбум ам.долларыг Малайз Улсын Засгийн газартай тохиролцож олгохоор болсон.[i] 2020 оны 10 дугаар сард 2.9 тэрбум гаруй ам.долларыг Хонконг, Хятад, Малайз, Сингапур, ИБУИНВУ, АНУ болон бусад холбогдох улсын эрх бүхий иргэний болон эрүүгийн байгууллагыын хамтарсан тогтоолын дагуу төлөхөөр хүлээн зөвшөөрч, Малайз Улс дахь салбар нь ял наймаалцах гэрээ хийжээ.[j]

Өөрсдийн мэдэгдэлд АНУ-ын Хууль зүйн яамнаас дэлхийн олон байгууллагын туслалцаанд талархснаа илэрхийлсэн. Үүнд: ИБУИНВУ-ын Санхүүгийн ёс зүйн байгууллага, Сингапур улсын Ерөнхий Прокурорын газар, Швейцар үлсын Хууль зүйн яам, Люксембург улсын Шүүхийн мөрдөн шалгах байгууллага, Малайз Улсын Ерөнхий прокурорын газар, тус улсын Цагдаагийн газар, Авлигатай тэмцэх комисс болон Франц, Гурнси улсын эрх бүхий байгууллагыг нэрлэжээ.[k]

a. АНУ-ын Хууль зүйн яам (DOJ). 2016. "Малайзын үндэсний баялгийн сантай холбоотой авлигын улмаас олдсон 1 тэрбум гаруй долларыг АНУ буцаан авахаар зорьж байна." Хэвлэлийн мэдээ, 2016 оны 7-р сарын 20. https://www.justice.gov/opa/pr/united-states-seeks -recover-more-1-billion-obtained-corruption-involving-malaysian-sovereign; болон DOJ. 2017. "Малайзын үндэсний баялгийн сантай холбоотой авлигын улмаас олсон 540 сая долларыг АНУ эргүүлэн авах гэж байна." Хэвлэлийн мэдээ, 2017 оны 6-р сарын 15. https://www .justice.gov/opa/pr/us-seeks-recover-approximately-540-million-obtained-corruption-involving-malaysian-sovereign.
b. ХЗЯ, "Малайзын үндэсний баялгийн сантай холбоотой авлигын улмаас олсон 540 сая долларыг АНУ эргүүлэн авах гэж байна".
c. Шиванжали Шукла. 2020. "Малайзын Ерөнхий сайд асан 1MDB-ийн дуулианы хэргээр 12 жилийн хорих ял авлаа." HURIST, 2020 оны 7-р сарын 30. https:// www.jurist.org/news/2020/07/former-malaysia-pm-sentenced-to-12-years-in-prison-for-1mdb-scandal/.
d. Руперт Нейт. 2019. "Малайз 1MDB дуулиант хэрэгт хураан авсан тансаг зэрэглэлийн супер дарвуулт онгоцыг 95 сая фунтээр зарав." The Guardian, 2019 оны 4-р сарын 3 (2020 оны 7-р сарын 23-нд шинэчлэгдсэн). https://www.theguardian.com/world/2019/apr/03/malaysia-sell-luxury-superyacht-seized-in-1mdb-scandal-for-95m.
e. Ройтерс. 2018. "Малайзын санхүүчний хувийн онгоц 1MDB-ийн скандалтай холбоотой зарагдах гэж байна." Ройтерс, 2018 оны 11-р сарын 1 (2020 оны 7-р сарын 23-нд шинэчлэгдсэн). https://www.reuters.com/article/us-malaysia-politics-1mdb-jet/malaysian-financiers-private-jet-linked -to-1mdb-scandal-to-be-sold-idUSKCN1N63LS.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 2.7 Малайз: 1MDB хэргийн мөрдөн шалгах ажиллагаан дахь дотоодын болон олон улсын хамтын ажиллагаа

f. Кристофер Коппер-Инд. 2020. "Малайз улс 1MDB-ийн мөнгө угаасан хэргийг хэрэгсэхгүй болгож, 107 сая долларын нөхөн төлбөр авчээ." Олон улсын хөрөнгө оруулалт, 2020 оны 5-р сарын 15 (2020 оны 6-р сарын 25-нд шинэчлэгдсэн). https://www.internationalinvestment.net/news/4015242/malaysia-drops-1mdb-money -laundering-case-recovers-usd107m.
g. ХЗЯ. 2020. "АНУ Малайзын үндэсний баялгийн сантай холбоотой 49 сая долларыг эргүүлэн авахаар тохиролцов." Хэвлэлийн мэдээ, 2020 оны 5-р сарын 6 (2020 оны 7-р сарын 10-нд шинэчлэгдсэн). https://www.justice.gov/opa/pr/united-states-reaches-settlement-recover -more-49-million-involving-malaysian-sovereign-wealth#:~:text=The%20Department%20of%20Justice%20has,financial%20 institutions%20in%20several%20jurisdictions%2C.
h. ХЗЯ, "АНУ 2020 оны 5-р сарын 6-ны өдөр тохиролцоонд хүрч байна."
i. Розанна Латифф, Жозеф Сипалан, Элизабет Дилтс Маршалл нар. 2020. " 1MBD-ийн дуулианы хэрэгт Голдман Малайзад 3.9 тэрбум доллар төлнө, АНУ тохиролцоо." Ройтерс, 2020 оны 7-р сарын 24. https://www.reuters.com/article/us-malaysia-politics-1mdb-goldmansachs /goldman-to-pay-malaysia-3-9-billion-over-1mbd-scandal-u-s-settlement-seen-close-idUSKCN24P14L.
j. ХЗЯ. 2020. "Голдман Сакс гадаадын хээл хахуулийн хэрэг шийдэгдэж, 2.9 тэрбум гаруй доллар төлөхөөр боллоо." 2020 оны 10-р сарын 22. https://www .justice.gov/usao-edny/pr/goldman-sachs-resolves-foreign-brribery-case-and-agrees-pay-over-29-billion.
к. ХЗЯ, "Голдман хээл хахуулийн хэрэг шийдэгдэв", 2020 оны 10-р сарын 22

Зөвшөөрөгдсөн тохиолдолд хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа нь арга хэмжээ давхардахаас сэргийлж хамтын ажиллагаа, мэдээллийн харилцан солилцоо болон нэгдсэн стратеги боловсруулах боломжийг бий болгоно (нэг улсаас гадна олон улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэхэд мөн хамаарна). Түүнчлэн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн сөрөг талаас зайлсхийх боломжтой юм (мөрдөн шалгах ажиллгааны обектыг нөгөө талд мэдэгдэж хугацаа алдах зэрэг). Учир нь хууль сахиулагчид нэг зорилгын төлөө ажиллаж байгаа билээ.

Хянан шийдвэрлэж буй хэрэгт холбогдох олон асуудал байгаа тохиолдолд хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа нь гадаад улсуудад байгаа хэргийн холбогдогч нарт мэдээллийг хүргэх баталгаа болдог. Хөрөнгө хураах болон хойшлуулшгүй ажиллагаа гүйцэтгэх сул нөөц бололцоо болон эрх зүйн орчинтой улс орнуудад хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа нь мэргэжлийн ур чадвар солилцох эсхүл илүү үр дүнтэй улс орны хуулийн дагуу зөвшөөрөл авч гүйцэтгэх боломжийг бий болгоно. Европ тивд, ЕвроЖаст нь хамтарсан мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулах боломжийг бүрдүүлсэн.[20]

Нөгөөтэйгүүр хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулах нь хүндрэлтэй тул албан хаагчид амжилтай мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэх нөхцөл бололцоо байгаа эсэхийг судлах шаардлагатай. Энэ хүрээнд эрх бүхий байгууллага нь эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт ашиглалгүйгээр хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж гадаад улсын албан хаагчид үндсэн улсын газар нутагт нотлох баримт цуглуулах, мэдээллийг шууд дамжуулах эрх зүйн бололцоо байгааг шалгах хэрэгтэй юм. Учир нь ажиллагаанд оролцож буй байгууллага бүр нь хуулийн хүрээнд холбогдох хэргийг харьяалан шийдвэрлэх

[20] Eurojust нь Европын Холбооны хоёр буюу түүнээс дээш гишүүн орнуудыг хамарсан ноцтой гэмт хэрэгтэй холбоотой үндэсний мөрдөн шалгах болон прокурорын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой Европын Холбооны (ЕХ) байгууллага юм. Энэ нь Нидерландын Гааг хотод байрладаг. Хамтарсан мөрдөн шалгах багуудын (JITs) талаар дэлгэрэнгүй мэдээллийг Eurojust вэб сайтын JIT хэсгээс үзнэ үү: http://www.eurojust.europa.eu / Practitioners/JITs/Pages/JITs-sitemap.aspx

эрхтэй байх ёстой бөгөөд гадаад улсын газар нутагт үйлдэгдсэн хэргийг харьяалан шийдвэрлэх боломжтой байх нь давуу талтай.

Түүнчлэн Санхүүгийн тагнуулын алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг, Эгмонт группээр дамжуулан Санхүүгийн тагнуулын алба хооронд мэдээлэл солилцох механизм зэрэг албан бус хамтын ажиллагааны хэрэгсэл байгаа эсэхийг шалгах хэрэгтэй юм. Учир нь эдгээр хэрэгсэл нь мөрдөн шалгах ажиллагааг илүү үр дүнтэй, түргэн шуурхай гүйцэтгэх боломжоор хангадаг. Албан хаагчид мөн хэргийн нөхцөл байдлыг шийдвэрлэх зохих сургалтанд хамрагдсан, гүйцэтгэх ажиллагааны мэдээлэл авах аюулгүй байдал хангагдсан, орчин тойрон нь итгэл, хичээл зүтгэлтэй албан хаагчидтай байх зэрэг хангалттай нөөц бололцоотой эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Эцэст нь талууд нэгдсэн зорилго, хугацаа, зардлын хуваарьлалт, процесс болон цуглуулсан мэдээллийг хэрхэн ашиглах асуудлыг тохирох хэрэгтэй юм. Энэ төрлийн асуудлыг харилцан ойлголцлын санамж бичигт тусгаж болно.

2.6 Гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай харилцаа тогтоох болон олон улсын хамтын ажиллагааны дэмжлэг авах боломжийг үнэлэх нь

2.6.1 Олон улсын сүлжээ ба дэмжлэг авах суваг

Хэргийн эхний шатнаас гадаад улсын мөрдөгч, прокурор эсхүл мөрдөн шалгах эрх бүхий магистратуудтай албан бус харилцаа тогтоосноор салбарын мэргэжилтнүүд учирч болох хүндрэл бэрхшээлийг үнэлж, стратеги боловсруулах, урьдчилсан мэдээлэл болон албан бус дэмжлэг хүлээн авах,[21] эрх зүйн харилцан туслалцаа авахад тавигдах шаардлагыг судлах болон олон улсын хамтын ажиллагаанд эерэг үр дүн гаргахад ихээхэн тустай байна. Санхүүгийн тагнуулын алба, татвар болон гаалийн байгууллагын хоорондын захиргааны дэмжлэгийн сувгийг мөн судлах хэрэгтэй. Элчин сайдын яамдад томилогдсон хууль сахиулах атташе, эсхүл гадаад хамтын ажиллагааны албан хаагч нар нь гадаад улсын байгууллагатай харилцах сайн гүүр болдог. Томоохон хэргүүдийн хувьд, ижил түвшний эрх бүхий байгууллагатай биечилсэн уулзалт хийх нь олон улсын амжилттай хамтын ажиллагаанд амжилт гаргахад нэн чухал зүйл болох нь батлагдсан. Шууд харилцаа нь улс төрийн хүсэл зоригийг харуулахад тусалж хүндрэл бэрхшээл, стратеги, шаардлагатай тусламжийн талаар зөвшилцөхөд эерэг нөлөөтэй.

Зарим байгууллагууд холбогдох хэрэгт сонирхол илэрхийлэх боломжтой улс орны эрх бүхий байгууллагын төлөөлөгчдийг оролцуулсан ажлын хурал эсхүл чуулган зохион байгуулах тохиолдол байдаг. Хөрөнгө буцаах дэлхийн форумыг 2007 онд ИБУИНВУ болон АНУ-ын дэмжлэгтэйгээр Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга зохион байгуулж Нигер, Шри Ланка, Тунис болон Украйн улсад холбогдох хэргийн талаар санал солилцох боломжийг олгосон. Тус форум нь

[21] Албан бус тусламж гэдэг нь ихэвчлэн албан ёсны хүсэлтээс гадуур үзүүлсэн албан ёсны тусламжаас бүрддэг. Зарим харяаллын хүрээнд албан бус тусламжийг “албан ёсны” гэж үздэг, учир нь уг ойлголтыг хууль тогтоомжоор зөвшөөрсөн бөгөөд албан ёсны байгууллагыг хамардаг. Дэлгэрэнгүй мэдээллийг 8-р бүлгээс үзнэ үү.

мөрдөгч болон прокурорууд санхүүгийн төвийн мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлж хөрөнгийг илрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлсэн.[22]

Энэхүү арга зам нь хэд хэдэн гадаад улсын хамарсан эсхүл нөөц бололцооны улмаас гадаад улсад зорчих боломжгүй нөхцөлд хэрэглэхэд ихээхэн тохиромжтой. Мөн Интерпол нь энэ хүрээн дэх олон улсын чухал байгууллага. Хэдийгээр Интерпол нь цагдаа-цагдаа гэсэн харилцааг бүрдүүлдэг боловч прокурор, мөрдөн шалгах шүүгчдийг хэрэгт оролцуулан зөвшилцөх боломжоор хангах боломжтой. Наймдугаар бүлгийн, 8.3 дэх хэсэгт олон улсын хамтын ажиллагааны процесс болон боломжит харилцааны хэрэгслийн талаар дэлгэрэнгүй танилцуулсан болно. Олон улсын ижил чиг үүрэг бүхий байгууллага хоорондын зохион байгуулалтын механизмын талаар 1MDB хэрэгт холбогдуулан шигтгээ 2.7-д тайлбарласан болно.

2.6.2 Хүндрэл бэрхшээлтэй тулгарах болон хамтын ажиллагааны нөхцөлийг үнэлэх

Эрх зүйн тогтолцоо (эх газрын болон нийтийн эрх зүйн тогтолцоо) болон хөрөнгө хураах систем (үнэлгээнд суурилсан болон хөрөнгөд суурилсан)-ийн зөрүүтэй байдал нь гадаад улсын байгууллагатай хамтран ажиллахад хүндрэл бэрхшээл учруулдаг. Албан хаагчид нэр томъёо, процесс, нотлох баримт, дэмжлэг авах хугацаанд харилцан адилгүй байх боложмтой. Тухайлбал зарим эх газрын эрх зүйн тогтолцоонд прокурор болон мөрдөн шалгах шүүгч нар нь бүрэн эрхийн хүрээнд хөрөнгийг илүү хялбар царцааж шуурхай ажиллах боломжтой байдаг. Эсрэгээрээ нийтийн эрх зүйн тогтолцоонд тус хүсэлтийг заавал шүүхэд танилцуулдаг. Үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах систем нь хэргийн ялтан эсхүл шүүгдэгчид хөрөнгө хамааралтайг харуулсан нотлох баримт байхыг шаарддаг бол хөрөнгөд суурилсан системд хөрөнгө болон гэмт хэрэг хоёрын харилцан хамаарлыг баталсан нотлох баримт шаарддаг.

Буруу нэр томъёо ашиглах эсхүл нотлох баримтын шаардлагад үл нийцэх нь төөрөгдөл, удаашрал эсхүл туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл болдог. Хэдийгээр энэхүү гарын авлага, ном нь дээрх зарим ялгамжтай байдлыг харуулыг зорьсон боловч бусад системтэй танилцах зорилгоор шууд харилцааг тогтмол гүйцэтгэж шаардлагатай үйл ажиллагааг тухай бүр үйлдэх нөхцөл бололцоог бүрдүүлэх нь чухал.

Олон улсын түвшинд хөрөнгө хураахаар ажиллаж буй эрх бүхий байгууллагууд нь албан бус туслалцаа (санхүүгийн тагнуулын алба, татвар, гаалийн байгууллага) болон албан эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээх нөхцөл бүрдсэн эсэхийг нягтлах шаардлагатай. Түүнчлэн уг туслалцааг авахад гарах практик болон эрх зүйн саад тотгор бий эсэхийг судлах нь зөв.

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд өргөнөөр тулгардаг эрх зүйн асуудал нь хоёр улсад гэмт хэрэгт тооцогдох байдал юм. Дурдвал, хүсэлтэд дурдсан үйлдэл нь хоёр улсад адил гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай. Учир нь гэмт хэргийг нэр томъёогоор нь бус үйлдлээр нь ерөнхийд нь дүгнэж, хүлээн зөвшөөрдөг. Иймд үүнийг тус улсад гэмт хэрэгт тооцогдоно гэдгийг нотлох зорилгоор мэдээлэл, нотлох баримт гаргаж өгөх шаардлагатай. Тухайлбал, хүсэлт хүлээн авч буй улсад үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдэл[23] нь гэмт хэрэгт тооцогддоггүй тохиолдолд

[22] Дэлгэрэнгүй мэдээллийг Star.worldbank.org/about-us хэсгээс үзнэ үү.
[23] АЭНҮБК, 20-р зүйл

тус үйлдлийг мөнгө угаах зэрэг бусад гэмт хэрэгтэй холбон тайлбарлах шаардлагатай.

Шигтгээ 2.8-д олон улсын хамтын ажиллагаа хүлээн авах тулгарах асуудал, найм болон есдүгээр бүлэгт энэ талаар мөн дэлгэрэнгүй тайлбарласан болно. Дотоодын эрх зүйн дагуу хойшлуулашгүй ажиллагаа болон хөрөнгө хураах ажиллагааг эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн дагуу гүйцэтгэх боломжгүй нь мэдэгдсэн тохиолдолд эрх зүйн бусад хэрэгслийг нэн түрүүнд яаралтай судлах нь зөв. Гэм буруутайд тооцолгүйгээр хөрөнгө хураах эсхүл иргэний эрх зүйн дагуу арга хэмжээ авч хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах эсхүл гадаад улсад яллах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хэргийн материалыг гарган өгөх үйл ажиллагааг гүйцэтгэж болно.

2.7 Дэмжлэг үзүүлэх, хангалттай нөөц, бололцоотой байх

Улс төрийн хүсэл сонирхол буюу авлигатай тэмцэж хөрөнгө буцаан авчрах үйл ажиллагааг дэмжих улс төрийн тоглогч, төрийн албан хаагч болон механизмын хүсэл сонирхол нь хөрөнгө буцаан авчрахад шаардагдах нэн тэргүүнийн нөхцөл юм. Улс төрийн хүсэл сонирхол болон Засгийн газрын удирдагчдын дэмжлэг, улс төрийн нөлөөлөл ба нөөц бололцооны дутагдалтай байдал нь хэргийг шалгахад хүндрэл бэрхшээл учруулдаг.[24]

ШИГТГЭЭ 2.8 Хөрөнгө хураах ажиллагаа дахь олон улсын хамтын ажиллагааны хүндрэл бэрхшээл

Дараах хүндрэл бэрхшээл нь олон улсын хамтын ажиллагаанд учирч болзошгүй (найм болон есдүгээр бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлав):

- Эрх зүйн бэрхшээл
  - Олон улсын хамтын ажиллагаа, гадаад улсын шийдвэрийг биелүүлэх болон хөрөнгө хураах ажиллагаа дахь үр дүнгүй хууль болон процесс
  - Албан бусаар хамтран ажиллах эрх бүхий байгууллагагүй
  - Ял оноохоос өмнө эрх зүйн туслалцаа үзүүлэх хязгаарлагдмал чадвар
  - Хүсэлт тавьж буй байгууллагын хэрэг хөөн хэлэлцэх хугацааны богино байдлаас шалтгаалж эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх хангалттай хугацаа олгодоггүй байдал.
  - Гадаад улсын хөрөнгийн эзэмшигчийн мэдээллийг ил болгохыг шаардсан хууль
- Хоёр улсад адил гэмт хэрэгт тооцогддог байх, шаардлагатай арга хэмжээг гүйцэтгэх (харилцан адилгүй байх, мэдээллийн ашиглалтын хязгаарлалт, зардал эсхүл хохирлыг төлөх)
- Чухал ашиг сонирхол, ялын шинж чанар, хүсэлт гаргасан улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа, хүсэлт гаргасан улсад хуулийн дагуу зохих ажиллагааг гүйцэтгээгүй болон тодорхой гэмт хэргээс шалтгаалан татгалзах

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[24] Улс төрийн хүсэл зориг байхгүй байгаа нь хөрөнгө хураан авах ажиллагаанд хэрхэн саад болж болох талаар ярилцлагыг үзнэ үү. (2011), https://star.worldbank.org/sites/star/files/Barriers%20to%20Asset%20Recovery.pdf

ШИГТГЭЭ 2.8	Хөрөнгө хураах ажиллагаа дахь олон улсын хамтын ажиллагааны хүндрэл бэрхшээл

- Албан шаардлага, процесс хийх хугацаа болон давж заалдах боломжоос шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах
- Нотлох баримтын шаардлага хэт өндөр байх (тухайлбал, "загасчлах аян" буюу гадаад улсад буй шалгах банкны дансны мэдээлэл дутмаг байдал)
- Хөрөнгө хураах системийн ялгавартай байдал (үнэлгээнд суурилсан болон хөрөнгө суурилсан) нь хууль сахиулах ажиллагаанд хүндрэл учруулах боломжтой.

Үүний үр дүнд албан хаагчид улс төрийн болон төрийн байгууллагын хооронд хамтрагчидтай болж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туслалцаа хүсэх сүлжээ бий болгох шаардлагатай.[25] Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллагын тусламжтайгаар нийтийн хүчирхэг дэмжлэг авах нь улс төрийн хүсэл сонирхлыг өндөр түвшинд байлгадаг. Энгийн явцын тайланг удирдах улс төрийн албан тушаалтнуудад өгч нөөц бололцоо, шаардлагын талаар зөвлөлдсөнөөр тэдний хүсэл сонирхлыг нэг түвшинд байлгаж болно. Хөрөнгө буцаах дэлхийн форум нь албан хаагчид дундын харилцаа болон бодлого төлөвлөгчдийн дэмжлэгийг авах сайн жишээ юм. Үүнтэй адилаар, албан хаагчид нь хэрэгт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлаас зайлсхийх хэрэгтэй, нэн ялангуяа боломжит шүүгдэгч нь улс төрийн хамтрагч эсхүл төрийн албан хаагчийн хувийн найз байх тохиолдолд анхаарал хандуулах хэрэгтэй.

Улс төрийн болон нийтийн дэмжлэгийг баталгаажуулахаас гадна, хөрөнгө хураах ажиллагааны шат бүрт хангалттай төсөв батлуулах хэрэгтэй. Ялангуяа хуулийн хүрээнд. Хөрөнгө хураах мөрдөн шалгах ажиллагаа нь дунд болон буурай эдийн засагтай улс оронд хүндрэлтэй байдаг, учир нь тус ажиллагаа нь банкны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, гадаад улсад байгаа хөрөнгийг илрүүлэх, хамгаалах, шаардлагад нийцсэн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт боловсруулж, хөрөнгө хураах эцсийн шийдвэр гаргах ур чадвартай албан хаагчдыг шаарддаг юм.

Хэрэв эрх бүхий байгууллага нь дотооддоо мөрдөн шалгах, яллах ажиллагаа гүйцэтгэхээр төлөвлөж байгаа тохиолдолд гадаад улсаас хүн хүчний (тухайлбал, ментор), санхүүгийн, эсхүл мөрдөгч, прокурорт зориулсан сургалтын дэмжлэг авах боломжтой байдаг. Зарим орнууд буурай хөгжилтэй орны төсвийн хөрөнгийг шамшигдуулсан авлигач албан тушаалтны эсрэг иргэний нэхэмжлэл гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн жишээ байгаа бол, хувийн хуулийн фирмүүд хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх, эсхүл гэнэтийн зардлыг хариуцах зэргээр туслалцаа үзүүлсэн байна.

[25] Конго улсын Ерөнхийлөгч асан Мобуту Сесе Секогийн эсрэг авлига, хөрөнгө шамшигдуулсан хэрэгт улс төрийн хүсэл зориг дутмаг байсан нь илт байв. Хэдийгээр Швейцарийн эрх баригчид түүний 5.5 сая ам.долларын хөрөнгийг битүүмжилсэн ч (тус улсад 4 тэрбум ба түүнээс дээш ам.доллар гэж тооцогдож байгаагийн зөвхөн багахан хэсэг) уг асуудлыг хариуцагчаар томилж, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын Засгийн газрыг төлөөлөх өмгөөлөгчийг санал болгосон боловч Мобутугийн үйлдсэн аливаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хангалтгүй арга хэмжээ авсан. Үүний үр дүнд уг хөрөнгийг 2009 онд өв залгамжлагчид нь олгожээ. (FDFA 2016, 16–17)

Дотоодын мөрдөн шалгах ажиллагаа болон хөрөнгө хураах байдлаар буцаан авах эсхүл иргэний арга хэмжээнд улс төрийн дэмжлэг болон нөөц бололцоо хангалтгүй байгаа тохиолдолд эрх бүхий байгууллагууд хэргийн материал, нотлох баримтын харьяаллын дагуу гадаад улсын төрийн байгууллагад илгээж дэмжлэг хүсэж болно.

Улс орнууд хөрөнгө хураах ажиллагаанд оролцсон төрийн байгууллагуудад урамшууллын загварын дагуу нөөц бололцоог хуваарилж болно. Тухайлбал, хураан авсан хөрөнгийг Засгийн газрын байгууллага болон холбогдох мөрдөн шалгах эсхүл прокурорын байгууллага эсхүл шүүхэд хуваан өгч болно. ИБУИНВУ-д 2002 оны Гэмт хэргийн орлогын тухай хуулийн дагуу буцаан авчирсан хөрөнгийг 2006 онд байгуулагдсан Хөрөнгө хураах ажиллагааны урамшууллын схемийн дагуу гүйцэтгэх ажиллагааны агентлагуудад хуваан олгодог. Хууль сахиулах байгууллагууд хүлээн авсан хөрөнгийг дараагийн хөрөнгө хураах ажиллагаанд хуваарилж зарцуулдаг.[26] 2011/12 оны санхүүгийн жилээс хойш 307 сая фунт стерлинг хөрөнгийг тус урамшууллын схемийн дагуу гүйцэтгэх ажиллагааны агентлагуудад дараагийн хэрэгт ашиглуулахаар олгосон нь тус схемийн нийт зарцуулалтын 88 хувь юм.[27] Хэдийгээр энэхүү практик нь "ашгийн төлөөх бодлого" гэх нэр авч шүүмжлэл дагуулсан, учир нь урамшууллын схемийн дагуу хөрөнгө хураах ажиллагаанд оролцоогүй этгээдүүдэд мөн урамшуулал олгодог болно.[28]

Нөгөөтэйгүүр гэмт хэргийн орлого нь нийгмийн санаачилга, үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх эх сурвалж болох боломжтой. Тухайлбал "Нийгэм өөрсдийн хөрөнгийг буцаан авах" гэх Шотландын хөтөлбөрийн дагуу гэмт хэргийн орлогыг хураан авч залуучуудад чиглэгдсэн санаачилгыг хэрэгжүүлэхэд санхүүжүүлдэг байна. 2008 оноос хойш тус хөтөлбөр нь 2 сая үйл ажиллагаа, боломжийг залуучуудын төлөө, нэн ялангуяа нийгмийн бололцоо тааруу хүмүүст зориулан санхүүжүүлжээ.

2.8 Хууль зүйн болон хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлох нь

Хөрөнгө хураах хэргийн эхэн үед, албан хаагчид боломжит эрх зүйн бэрхшээл болон асуудлыг судлаж шийдвэрлэх арга замыг олох шаардлагатай. Энэхүү боломжит бэрхшээл нь шүүхийн харьяалал, сэжиглэгдэж буй албан хаагчийн халдашгүй бүрэн эрх, хэрэг хөөн хэлэлцэх хугацаа, буцаах зохицуулалт болон нотлох баримтын шаардлагыг хамруулна.

Албан хаагчид нь эх газрын болон нийтийн эрх тогтолцооноос гадна бусад тогтолцоо байдгыг санаж байх хэрэгтэй, үүнд, заншлын, холимог, шашны эрх зүйн тогтолцоо хамаарна. Иймд эрх зүйн орчин, практик, байгууллагын механизм нь улс бүрээс шалтгаалан олон төрөлтэй байх бөгөөд нөхцөл байдалд зохицуулан ажиллах хэрэгтэй. Энд тусгасан концепт буюу эрх зүйн тогтолцоог ялгаж хандах нь албан хаагчдад өргөн хүрээтэй хялбаршуулсан танилцуулгыг санал болгох юм. Үүнийг хүлээн зөвшөөрсний дагуу албан хаагчид нь гадаад улсын хамтрагчидтай албан бус харилцааг тогтмол байгуулж энэхүү бэрхшээлийг тодорхойлж шийдвэрлэх арга замыг таних шаардлагатай.

---

[26] "Хөрөнгө буцаан авах статистикийн товхимол, 2011/12–2016/17." Статистикийн эмхэтгэл 15/17 (2017 оны 9-р сар)

[27] "Хөрөнгийн буцаан авах статистикийн товхимол"

[28] Иймээс Дотоод хэргийн хороо гэмт хэргийн шинжтэй эд хөрөнгийн 10-аас доошгүй хувийг хохирогчдод буцаан өгөх, хандивлахыг зөвлөсөн (Дотоод хэргийн хороо 2016, 18–19).

2.8.1 Хэргийн харьяалал

Хэргийн харьяалал нь хуулийн байгууллагуудад хэргийг мөрдөн шалгах, яллах, шүүх болон эрх зүйн ажиллагаа гүйцэтгэх бүрэн эрхийг олгодог.[29] Үйл ажиллагааг гүйцэтгэхээс өмнө, байгууллагууд шүүхээс тус хэргийг шийдвэрлэх харъяалалтай эсэхийг шалгах ёстой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус улсын газар нутагт гадаадын болон дотоодын иргэний үйлдсэн хэрэгт харьяалалтай байх боломжтой. Мөн өөрийн улсын иргэн, хуулийн этгээд гадаад улсад үйлдсэн хэрэгт харьяалал тогтоож болно. Зарим улсад гэмт хэргийн нэг элемент нь тус улсын газар нутагт үйлдэгдсэн бол бусад элементээс үл хамаарч харьяалал тогтоодог, тухайлбал, гадаад улсад үйлдэгдсэн хахуулийн хэрэгт дотоодын банк, байгууллагыг ашиглан мөнгө угаасан үйлдэл хамаарна. Зарим байгууллагууд гэмт хэргийн холбогдолтой энгийн нэгэн үйлдэл тус улсын газар нутагт ямар нэгэн байдлаар үйлдэгдсэн тохиолдолд харьяалан шийдвэрлэдэг.

Газар нутгийн болон этгээдийн харьяалал аль аль нь хэрэгжихгүй тохиолдолд хэргийг зөвхөн гадаад улсын байгууллагаас яллаж болно.[30] Шигтгээ 2.9-д АНУ-ын төрийн байгууллага хэрхэн Гульнара Каримова болон түүний хамтрагчдын хэргийн харьялаллыг тогтоож Узбекистан улсад бизнес хийхээр хахуульч компаниудын хэргийг шийдвэрлэсэн талаар танилцуулав.

ШИГТГЭЭ 2.9 Узбекистан: Гульнара Каримовагийн авлигын хэрэгт АНУ-ын харьяалах хэсэг

Оршил: Узбекистаны Ерөнхийлөгч асан Ислам Каримовын охин Гульнара Каримова нь тус улсын албан тушаалтнуудад нөлөөлж, бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсний хариуд харилцаа холбооны компаниудаас хахууль авсан авлигын хэд хэдэн схемд холбогдсон байна.[a] Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигын тухай мэдээлэх төслийн (OCCRP) дагуу, Каримова нь 1 тэрбум гаруй ам.долларын хахууль болон харилцаа холбооны компанийн хувацаа хүлээн авсан байна. (Каримовагийн ашиглаж байсан компанийн талаарх мэдээллийг гуравдугаар бүлгийн, Шигтгээ 3.2-оос харна уу.)

АНУ-ын санхүүгийн системийг хууль бус олон гүйлгээнд ашигласан тул Каримова, түүний хамсаатнууд болон хахууль өгсөн компанийн холбогдох хэргийн харьяаллыг АНУ тогтоох боломжтой болсон.[b] АНУ-ын төрийн байгууллагаас олон улсын томоохон харилцаа холбооны гурван компанид холбогдуулан хэд хэдэн тогтоол гаргажээ.

Харилцаа холбооны компаниудын хэргийн үр дүн: Дэлхийн томоохон харилцаа холбооны компанийн нэг бөгөөд АНУ-ын олон нийтэд арилжаалагддаг үнэс цаас гаргагч VimpelCom нь Узбекистан улсын охин компани Unitel-ээр дамжуулан 114 сая гаруй ам.долларыг 2006-2012 оны хооронд тус улсад нэвтрэх, үйл ажиллагаа явуулах зорилгоор Каримовад өгсөн гэдгээ хүлээн зөвшөөрсөн

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[29] АЭНҮБК, 42-р зүйлийг үзнэ үү. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, 15-р зүйл. Оролцогч улс орнуудад холбогдох конвенцийн дагуу гэмт хэргийн харьяаллыг тогтооход шаардлагатай арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

[30] Тухайлбал, гадаадын иргэн төрийн өмчит компанийн гадаад дахь охин компанийн хөрөнгийг завшсан, мөнгө угаах үйл ажиллагаа нь гадаадын харьяаллын дагуу явагддаг бол энэ нь үнэн юм.

ШИГТГЭЭ 2.9 Узбекистан: Гульнара Каримовагийн авлигын хэрэгт АНУ-ын харьяалах хэсэг

юм.[c] АНУ-ын Хууль зүйн яамны мэдээлснээр тус төлбөрийг дэлхийн өнцөг булан бүрт буй банкны данс, хөрөнгийг ашиглан угаасан ба үүнд Нью Йорк хотод байрлагдсан хөрөнгө мөн хамаарна. 2016 онд Unitel нь буруугаа хүлээн зөвшөөрч, VimpelCom нь Хууль зүйн яамтай яллах хугацааг хойшлуулах гэрээ байгуулж Үнэт цаас, биржийн хороо болон Нидерландын Нийтийн Прокурорын албатай тохиролцож, нийт 795 ам.долларыг АНУ болон Нидерландад эрүүгийн болон зохицуулалтын торгууль болгож өгөхөөр зөвшөөрчээ.[d] (Энэ хэрэгт 20 улсын прокурор, зохицуулагч нарын хооронд амжилттайгаар хамтран ажилласан талаар 8 дугаар бүлгийн Шигтгээ 8.2-оос үзнэ үү.)

Олон улсын харилцаа холбооны компани бөгөөд АНУ-д олон нийтэд арилжаалагддаг үнэт цаас гаргагч асан Telia компани нь Узбекистан улсын охин компани Coscom-ын хамт 2017 онд Нью-Йорк дахь дансаар дамжуулан 331 сая гаруй ам.долларыг Каримовад хахууль болгон өгснийг хүлээн зөвшөөрсөн.[e] 2017 онд Coscom нь буруугаа хүлээн зөвшөөрч, Telia нь Хууль зүйн яамтай яллах хугацааг хойшлуулах гэрээ байгуулж Үнэт цаас, биржийн хороо болон Нидерландын Нийтийн Прокурорын албатай тохиролцож, нийт 965 сая гаруй ам.долларыг АНУ болон Нидерландад эрүүгийн болон зохицуулалтын торгууль болгож өгөхөөр зөвшөөрчээ.[f]

ОХУ-ын хамгийн том харилцаа холбооны компани бөгөөд АНУ-д олон нийтэд арилжаалагддаг үнэт цаас гаргагч Mobile Telesystems нь Узбекистан улсын охин компани Kolorit-ын хамт 2004-2012 оны хооронд 420 сая гаруй ам.долларыг Каримовад хахууль болгон өгч үүний хариуд үнэтэй харилцаа холбооны хөрөнгө хүлээн авч тус улсад бизнес үргэлжлүүлэн эрхлэх болсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн.[g] 2019 онд Kolorit нь буруугаа хүлээн зөвшөөрч, Mobile Telesystems нь Хууль зүйн яамтай яллах хугацааг хойшлуулах гэрээ байгуулж Үнэт цаас, биржийн хороо болон Нидерландын Нийтийн Прокурорын албатай тохиролцож, нийт 850 сая ам.долларыг АНУ болон Нидерландад эрүүгийн болон зохицуулалтын торгууль болгож өгөхөөр зөвшөөрчээ.[h]

Каримовагийн эрүүгийн яллах ажиллагаа: 2019 онд Каримовад Нью-Йорк мужийн Өмнөд дүүргээс мөнгө угаахаар хуйвалдсан хэрэгт яллах дүгнэлт үйлдсэн. Цаашилбал, тэрээр 864 сая ам.долларын хахуулийг харилцаа холбооны гурван компаниас авч, АНУ-ын санхүүгийн системээр дамжуулан мөнгө угаасан хэрэгт буруутгагдсан.[i] 2015 онд Каримова Узбекистан улсад төсвийн хөрөнгө шамшигдуулсан, мөнгө завшсан хэргээр буруутгагдаж 5 жилийн тэнсэн авах ял авч, гэрийн хорионд оржээ.[j] 2017 онд түүнийг авлигын хэрэгт гэм буруутайд тооцож 5 жил "хязгаарлагдмал эрх чөлөө" ял оноосон байна.[k] 2019 онд шүүхээс Каримоваг журам зөрчсөн хэргээр буцаан хорих шийдвэр гаргасан.

Хөрөнгө буцаан авах ажиллагааны үр дүн: Одоогоор АНУ-д явагдсан мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд дэлхийн хэмжээнд 2.6 тэрбум гаруй ам.долларын торгууль, хураамж оногдуулжээ.[l] 2016 онд Хууль зүйн яамнаас Каримовагийн хэрэгт холбогдсон харилцаа холбооны компаниудын 850 сая ам.долларын Белги, Ирланд, Люксембург, Швейцар улсуудын банкад хадгалагдаж байсан хөрөнгийг мөнгө угаасан эсхүл хахуулийн хэрэгт холбогдуулан хураан авах хоёр иргэний нэхэмжлэл гаргажээ.[m] Тус улсуудын банканд мөнгө байрлагдахаас өмнө АНУ-ын санхүүгийн байгууллагуудаар дамжсан явдал нь тус хэрэгт харьялал тогтоох нөхцөл болсон байна. 2020 оны есдүгээр сард Швейцар, Узбекистан Улсын хооронд 131 сая ам.долларыг Узбекистан улсад буцаан олгох хэлэлцээр байгуулжээ. Тус хөрөнгө нь Узбекистан улсын иргэдийн тусын тулд зарцуулагдах юм.[n]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 2.9 Узбекистан: Гульнара Каримовагийн авлигын хэрэгт АНУ-ын харьяалах хэсэг

Хэвлэгдсэн материалууд:
a.Миранда Патрусик. 2015. "Ерөнхийлөгчийн охин Телеком үйлдвэрийг хэрхэн хянаж байсан бэ." OCCRP, 2015 оны 3 сарын 22. https://www .occrp.org/en/corruptistan/uzbekistan/gulnarakarimova/presidents-daughter-controlled-telecom-industry; DOJ. 2019. "Mobile Telesystems Pjsc and Its Uzbek Subsidiary Enter into Resolutions of $850 Million with the Department of Justice for Paying Bribes in Uzbekistan." Press Release, 2019 оны 3 сарын 07. https://www.justice.gov/opa/pr/mobile-telesystems-pjsc-and-its-uzbek -subsidiary-enter-resolutions-850-million-department.
b. DOJ, "Mobile Telesystems Pjsc," 2019 оны 3 сарын 07.
c. DOJ. 2016. "VimpelCom Limited and Unitel LLC Enter Into Global Foreign Bribery Resolution of More Than $795 Million; United States Seeks $850 Million Forfeiture in Corrupt Proceeds of Bribery Scheme." Press Release, 2016 оны 2 сарын 18. https:// www.justice.gov/opa/pr/vimpelcom-limited-and-unitel-llc-enter-global-foreign-bribery-resolution-more-795-million.
d. The amount includes criminal penalties, disgorgement of profits, and prejudgment interest (DOJ, "VimpelCom Limited and Unitel LLC," 2016 оны 2 сарын 18).
e. DOJ. 2017. "Telia Company AB and Its Uzbek Subsidiary Enter into a Global Foreign Bribery Resolution of More than $965 Million for Corrupt Payments in Uzbekistan." Press Release, September 21, 2017. https:// www.justice.gov/opa/pr/telia -company-ab-and-its-uzbek-subsidiary-enter-global-foreign-bribery-resolution-more-965.
f. The amount includes criminal penalties, disgorgement of profits, and prejudgment interest (DOJ, "Telia Company AB," 2017 оны 9 сарын 21).
g. DOJ, "Mobile Telesystems Pjsc," 2019 оны 3 сарын 07.
h. The amount includes criminal and civil penalties. MTS has also agreed to the imposition of an independent compliance monitor (DOJ, "Mobile Telesystems Pjsc," 2019 оны 3 сарын 07). i. DOJ, "Mobile Telesystems Pjsc," March 7, 2019. MTS and Kolorit admitted to paying US$420 million in bribes to Karimova.
j. Lisa Lambert and Chris Sanders. 2019. "U.S. Indicts Gulnara Karimova in Uzbek Corruption Scheme." Reuters, March 7, 2019. https:// www.reuters.com/article/us-mob-telesystems-usa/u-s-indicts-gulnara-karimova-in-uzbek-corruption-scheme-idUSKCN1QO2GL.
k. Eurasianet. 2019. "Karimova Back to Prison in Uzbekistan, Indicted in US." Eurasianet.org 2019 оны 3 сарын 07. https://eurasianet .org/karimova-back-to-prison-in-uzbekistan-indicted-in-us.
l. DOJ, "Mobile Telesystems Pjsc,"2019 оны 3 сарын 07. m. DOJ, "VimpelCom Limited and Unitel LLC," 2016 оны 2 сарын 18.
n. Federal Department of Foreign Affairs (Switzerland). 2020. "Switzerland and Uzbekistan Sign an Agreement with a View to the Restitution of Confiscated Assets." https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-80393.html.

Дэлхийн дахинаа ам.долларыг ашиглан хийгдэж буй бүх гүйлгээ нь АНУ-ын санхүүгийн системийн зөвшөөрлийг авдаг болохыг албан хаагчид мэдэх нь зөв. Корреспондент буюу зуучлагч банк нь дотоодын санхүүгийн институц болон АНУ-ын санхүүгийн байгууллага хооронд гүүр болон ажиллаж санхүүгийн үйлчилгээ хийх боломжоор хангаж хил дамнасан төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг. (дөрөвдүгээр бүлгийн 4.2.4 дэх хэсэгт гүйлгээний талаар дурдав.) Үүний үр дүнд АНУ-ын хуулийн систем нь ам.долларыг ашиглан зуучлагч банкны сувгаар хийгдсэн бүх мөнгө угаах үйлдлийг харьяалан шийдвэрлэх боломжтой.

Олон талт харьяалалтай хэргүүдийн хувьд хэргийг харьяалан шийдвэрлэх эрхтэй гадаад улсын байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхээр шийдвэрлэж болно. Ингэхдээ хохирогч улсын албан бус харилцааны дагуу өгсөн мэдээлэл болон захиргааны туслалцаа хүссэн мөн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн дагуу шийдвэрлэдэг. Учир нь хэргийн холбогдчид мэдэгдэх эсхүл эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг татгалзах зэргээр дотоодын мөрдөн шалгах ажиллагаанд бэрхшээл учруулж болзошгүй тул албан хаагчид тус бэрхшээлийг урьдаас тооцоолж боломжит шаардлагатай урьдчилан сэргийлэх, зохион байгуулах арга хэмжээг авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа саадгүй гүйцэтгэх нөхцлийг хангах хэрэгтэй. Арваннэгдүгээр бүлэгт харьяаллын асуудал болон гадаад улсын байгууллагын процессын талаар тайлбарлав.

2.8.2 Албан тушаалтны халдашгүй дархан эрх

Албан тушаалтны халдашгүй дархан эрх нь тэднийг эрүүгийн хэрэгт холбогдон яллагдахаас зайлсхийх боломжийг бий болгодог. Ихэнх улсад дотоодын хууль тогтоомж эсхүл Үндсэн хуульд тусгагдсан дархан эрх нь "үндэсний дархан эрх" гэж ойлгогддог. Түүнчлэн "олон улсын дархан эрх" гэж байх бөгөөд энэ нь олон улсын заншлын эрх зүй болон олон улсын гэрээний дагуу хувийн болон албан ажлын дархан эрх олгодог. "Албан ажлын дархан эрх" нь төрийн өмнөөс ажиллаж буй гадаад улсын албан тушаалтанд олгогдоно (засгийн газрын тэргүүн, сайд г.м). "Хувийн дархан эрх" нь зарим төрийн албан тушаалтныг баривчилгаа болон эрүү, иргэн, захиргааны процессаас хамгаалдаг (ихэнхдээ албан ажлын өрөөнд). Хувийн дархан эрх нь ажлын өрөөнөөс гарсан даруй алдагддаг бол албан ажлын дархан эрх нь үйлчилсэн хэвээр байдаг.

Хөрөнгө хураах ажиллагаа нь төрийн тэргүүн, парламентын гишүүн, шүүгч эсхүл төрийн өндөр албан тушаалтанд холбогдосон тохиолдолд албан хаагчид тэдгээр албан тушаалтны дархан эрхийг харгалзан үзэх хэрэгтэй.[31] Тухайлбал, албан хаагчид а. Дархан эрхийн төрөл болон хязгаар (тухайлбал, хувийн эсхүл албан ажлых гэдгийг тодорхойлж эрүү, иргэн, захиргааны хариуцлагаас чөлөөлөх эсэхийг нягтлах) б. Дархан эрхийг түтгэлзүүлэх боломжтой эсэх в. Боломжтой тохиолдолд хэрэгт холбогдох бусад этгээдэд ял оноох боломжтой эсэх, тухайлбал, гэр бүлийн гишүүн, танил мөн мөнгө угаах ажиллагаанд оролцсон этгээдүүд болно.

Зарим улс орнууд дархан эрх олгосон хуулийг өөрчилж албан хаагчдыг яллах боломжийг бүрдүүлсэн боловч хорих зэрэг зарим төрлийн ял оноохийг хориглодог.[32] Түүнчлэн, улс орнууд гадаад улсын дотоодын дархан эрхийг хүлээн зөвшөөрөлгүй мөнгө угаах болон гадаад хахуулийн хэрэгт холбогдуулан яллах тохиолдол байдаг. Тухайлбал, ИБУИНВУ-аас Нигер улсын албан тушаалтан Диепрье Аламиесейхад холбогдох хэрэг Нигер улсад үйлдэгдсэн атал авлигын хөрөнгийн мөнгө угаах үйлдэл ИБУИНВУ-д болсон гэх шалтгаанаар яллаж байсан.[33] Цаашлаад олон улсын дархан эрх хүртэл гадаад улсын санхүүгийн байгууллагаас хөрөнгийг царцаах, хамгаалах ажиллагаанд нөлөөлөөгүй тохиолдол байдаг.[34] Хэрэв эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн хангалтгүй байх эрсдэл үүсвэл иргэний хариуцлага хүлээлгэх боломжтой юм. Үүнд ял оноолгүй хөрөнгө хураах иргэний процессыг судлах шаардлагатай.

Шигтгээ 2.10, 2.11-т Эквадорын Гвиней, Бразил улсуудад тус тус төрийн албан хаагчийн дархан эрхийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг харж болно.

---

[31] АЭНҮБК, 30-р зүйл. Оролцогч улсуудаас халдашгүй дархан эрх болон гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, яллах, шүүх боломжийн хоорондын зохистой тэнцвэрийг хадгалахыг шаарддаг.

[32] Энэхүү кэйс нь Аргентин Улсад хамаарна.

[33] Их Британи Улс үндэсний дархан эрх нь хүчинтэй байсан нөхцөл байдалд Нигерийн захирагчдыг авлига, мөнгө угаах гэмт хэрэгт буруутган шүүсэн (Чайкин ба Шарман 2009).

[34] Америкийн бизнесмэн Казахстаны албан тушаалтнуудад хахууль өгсөн хэрэгт холбогдуулан Швейцарийн Холбооны шүүх Швейцарийн банкинд хадгалагдаж байсан 84 сая ам.долларыг бүрэн эрхт халдашгүй дархан байдлын улмаас хамгаалсан гэж Казахстан Улсад мэдэгдээд байсан ч гаргахаас татгалзав (Чайкин 2010, 2-3). Эцэст нь уг хөрөнгийг АНУ ашиглан хураан авсан. Дэлгэрэнгүй мэдээллийг 11-р бүлгийн 11.7-р бүлгийн сангийн тухай хэлэлцүүлгээс үзнэ үү.

2.8.3 Хөөн хэлэлцэх хугацаа

Ихэнх улс орнуудад хэрэг үйлдэгдсэнээс тодорхой хугацааны дараагаар түүнд холбогдуулан эрүү болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гүйцэтгэх боломжгүй болдог ба үүнийг "хөөн хэлэлцэх хугацаа" гэнэ. Энэхүү хугацаа нь улс орноос шалтгаалан төрөл бүр байх ба ихэнхдээ хэргийн хүнд, хөнгөн нөхцөл байдлаас шалтгаалдаг (хүнд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа ерөнхийдөө урт байна).[35]

Ерөнхийдөө хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт үйлдлийг хийснээр эхэлнэ. Гэвч үргэлжилсэн гэмт хэрэгт тус гэмт үйлдэл зогссоноор хөөн хэлэлцэх хугацаа тоологдож эхэлдэг. Тухайлбал мөнгө угаах гэмт хэрэг нь үргэлжилсэн гэмт хэрэг бөгөөд ихэнх улсад тус хөрөнгө нь шүүгдэгчийн өмчлөлд байгаа тохиолдолд гэмт хэрэг үргэлжлэн үйлдэгдэж байна гэж үздэг. Цаашлаад банкны дансанд хүү бодогдож буй үйлдлийг зарим улс орнууд гэмт хэрэг үргэлжилж байна гэж үздэг бол бусад улсад илүү идэвхтэй үйл ажиллагаа гүйцэтгэсэн байхыг шаарддаг.[36]

ШИГТГЭЭ 2.10 Эквадорын Гвиней: Дэд ерөнхийлөгч Теодоро Нгуема Обианг Мангуегийн хэрэг дэх халдашгүй байдлын асуудал

Оршил: Эквадорын Гвинейн Дэд Ерөнхийлөгч Теодоро Обианг нь 2017 оны 10 дугаар сард Францын эрүүгийн шүүхээс авлигаас олсон хөрөнгийг Франц улсад оруулж 110 сая еврогийн байшин Парис хотод худалдсан авсан, мөн өндөр үнэтэй спорт автомашин, 76 метр урт дээд зэрэглэлийн дарвуулт завь худалдан авсан хэрэгт буруутгагджээ.[a]

Яллах ажиллагаа: Теодоро Обиангд холбогдох хэргийг Франц улсын прокуророос танилцуулаагүй бөгөөд авлигын эсрэг төрийн бус байгууллага болох Франц хуульчдаас бүрдсэн Шерпа нийгэмлэг болон Трансперенси интернэшнл Франц байгууллагаас эрүүгийн хэргийн гомдлыг Конго, Габон, Эквадорын Гвинейн Ерөнхийлөгчид, тэдний гэр бүл, ойр түншүүдийн эсрэг иргэний нэхэмжлэлийн хамт гаргасан. (Гуравдугаар бүлгийн Шигтгээ 3.5-д мөрдөн шалгах ажиллагаанд иргэний нийгэмлэгийн байгууллагын оруулсан дэмжлэгийн талаар танилцуулав.)[b]

Дархан эрхийн асуудал: Энэхүү хэрэг нь хэд хэдэн бэрхшээлтэй нүүр тулсан юм.[c] Францын прокурорын байгууллагаас шүүхийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулахаас татгалзсан, Эквадорын Гвинейн Засгийн газраас Обианг, түүний хөрөнгийг хамгаалахыг оролдож 2011 оны 10 дугаар сард НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын төлөөлөгчөөр нэр дэвшүүлсэн юм. Тус албан тушаал нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрх эдэлдэг билээ. Гэвч Обианг нь тус албан тушаалд томилогдож чадаагүй боловч улсынхаа хоёр дахь дэд ерөнхийлөгчөөр томилогдсон. Өндөр үнэтэй хөрөнгийг хураалгахаас сэргийлэх зорилгоор тус улсын Засгийн газраас Парис хотын 42 Фоч өргөн чөлөөнд байрлалтай 101 өрөөтэй харш нь Засгийн газрын дипломат албаны хөрөнгө гэж тайлбарласан болно.[d]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[35] Тухайлбал, зарим улсад хүн амины хэргээр яллах хугацаа хөөн хэлэлцэх хугацаагүй байдаг бол хулгайн гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жилээр хязгаарлагддаг.

[36] Тусси АНУ-ын эсрэг(1970). АНУ-д "тасралтгүй үйлдсэн гэмт хэргийн үйлдэл"-ын дагуу хэрэв гэмт хэрэг үргэлжилсэн бол түүний үргэлжлэх мөн чанарын практик үр нөлөө нь хуулийг "заасан хугацаанаас нь хэтрүүлэн" сунгах явдал юм. АНУ Жейнсийн эсрэг, 75 F.3d 1493, 1505 (10th Cir. 1996). "Хуйвалдаан. . . Энэ бол үргэлжилсэн гэмт хэрэг юм."

ШИГТГЭЭ 2.10 Эквадорын Гвиней: Дэд ерөнхийлөгч Теодоро Нгуема Обианг Мангуегийн хэрэг дэх халдашгүй байдлын асуудал

2016 оны 06 дугаар сард Эквадорын Гвинейн улс Олон улсын шүүхэд Обионгын дархан эрхтэй холбогдуулан Францын эсрэг нэхэмжлэл гаргасан. Олон улсын шүүхээс тус нэхэмжлэлийг шийдвэрлэх харьяалал байхгүй гэх шалтгаанаар хүлээн авахаас татгалзжээ.[e] Гэвч Франц Улсыг тус харш дахь Эквадорын Гвинейн дипломат албаны бүрэн эрхийг зөрчихгүй байх шаардлагатай арга хэмжээг авахыг даалгасан байна.

Шийтгэх тогтоол ба хөрөнгө хураах ажиллагаа: 2017 оны 10 дугаар сард Парис хотын Эрүүгийн шүүхээс Обианг нь мөнгө угаах, хөрөнгө шамшигдуулах, итгэл алдах, авлигын хэрэгт гэм буруутайд тооцож 3 жил хорих, 30 сая еврогийн торгууль ногдуулсан. Гэвч Обианг нь шинэ гэмт хэрэг үйлдээгүй тул 5 жилийн хугацаатай ялыг тэнссэн байна.

Транспэрэнси Интернэшнл Франц байгууллага нь 10 мянган еврогийн сэтгэл зүйн хохирол, 41,081 мянган еврог хөрөнгийн хохирол болгон олгожээ.

Шүүхээс мөн 150 сая еврогийн Обиангийн Франц улсад байрлагдсан хөрөнгийг царцаажээ. Гэвч Олон улсын шүүхийн шийдвэрийг хүлээснээр Франц улсын шүүхээс харш доторх хөрөнгийг царцаахыг шийдвэрлээгүй байна.[f] Шүүхээс Обиангийн бүхий л дархан эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж үүнийгээ яллах дүгнэлт гарсны дараагаар дэд ерөнхийлөгчөөр томилогдсон учир хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж тайлбарласан. Обаингаас шүүхийн шийдвэрийг давж заалдсаны дараагаар давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Олон улсын шүүхийн шийдвэр ба хүлээгдэж буй нэхэмжлэл: Эквадорын Гвиней улсаас Франц улс олон улсын дархан эрхийг зөрчсөн гэж үзэж Олон улсын шүүхэд нэхэмжлэл гаргасан. Олон улсын шүүхээс Обианг дархан эрх эдэлж байсан гэх нэхэмжлэлийг хангахад НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн дагуу харьяалан шийдвэрлэх боломжгүй талаар тайлбарлажээ. Цаашлаад шүүхээс Дипломат харилцааны тухай Венийн конвенцийн нэмэлт протоколын дагуу Парис хотод байрлах дипломат хэсгийн талаарх нэхэмжлэхийг, тус хэсгийн байран дахь тавилга болон бусад эд хөрөнгийг хураан авах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хүлээн авч шийдвэлэх харьяалалтай талаар мэдэгдсэн. Сүүлийн хэсэгт дурдсан асуудлын шийдвэр хүлээгдэж байна.[g]

a. Ширли Поужет. 2017. "Парис хотод болсон шүүх хурал яагаад авлигын эсрэг тэмцэгчдийн хувьд чухал үйл явдал болсон бэ?" Нээлттэй нийгэм сангийн вэбсайт, 2017 оны 6-р сарын 16 (2018 оны 8-р сарын 13). https://www.opensocietyfoundations.org/voices/why-trial-paris-marks-milestone -anticorruption-activists.
b. Поужет, "Парис дахь шүүх хурал," 2017 оны 6-р сарын 16.
c. Perdriel-Vaissiire (2017) нь CCFD (2007) тайланг нийтлэхээс эхлээд 2016 оны 12-р сар хүртэл хугацааны баримт фактууд, асуудал бэрхшээлийн талаар бүрэн тоймлон харуулсан бөгөөд Францын Транспэрэнси Интернешнл (TI) хэрэгт нэг тал болж нэгдэхийг хүссэн хүсэлт байгаагүй, түүнийг нь Давж заалдах шатны шүүх хүлээн зөвшөөрөөгүй байсан бол уг хэргийг хэрэгсэхгүй болгосон байх байсан. Эхний шатан дахь хэргийн талаарх тоймыг мөн TI-аас үзнэ үү. (2010). "Biens Mal Acquis-ийн хэрэг: Францын Дээд шүүх Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон." Хэвлэлийн мэдээ, 2010 оны 11-р сарын 9 (2018 оны 8-р сарын 13). https://www.transparency.org/news/pressrelease/20101109_biens_mal_acquis_case_french_supreme_court_overrules_court_of_appe.
d. Рик Мессик. 2017. "Обиангийн шүүх хурал: Арван жилийн турш үргэлжилсэн хууль зүйн тулалааны сургамж." GAB | Дэлхийн Авлигын эсрэг блог, 2017 оны 6-р сарын 26 (2018 оны 8-р сарын 13). https://globalanticorruptionblog.com/2017/07/26/the-obiang-trial-lessons-from-a -decade-long-legal-battle/.
e. Олон улсын шүүх (ICJ). 2016. "Дархан эрх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Экваторын Гвиней Францын эсрэг)." Хэвлэлийн мэдээний дугаар. 2016/38, 2016 оны 12-р сарын 7. https://www.icj-cij.org/files/case-related/163/19286.pdf.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 2.10 Эквадорын Гвиней: Дэд ерөнхийлөгч Теодоро Нгуема Обианг Мангуегийн хэрэг дэх халдашгүй байдлын асуудал

f. Ширли Поужет, Кен Хурвиц нар. 2017. "Францын шүүх Экваторын Гвинейн дэд ерөнхийлөгч Теодорин Обианг авлигын их хэмжээний орлогыг угаасан хэргээр шийтгэв." GAB | Дэлхийн Авлигын эсрэг блог, 2017 оны 10-р сарын 30 (2018 оны 8-р сарын 13-нд хандсан). https://globalanticorruptionblog.com/2017/10/30/french-court-convicts-equatorial-guinean-vice-president-teodorin -obiang-for-laundering-grand-corruption-proceeds/.
g. ICJ. 2018. "Дархан эрх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Экваторын Гвиней Францын эсрэг), хураангуй 2018/3." 2018 оны 6-р сарын 6. https://www .icj-cij.org/files/case-related/163/163-20180606-SUM-01-00-EN.pdf; ICJ. 2020. "Дархан эрх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (Экваторын Гвиней Францын эсрэг)." Хэвлэлийн мэдээний дугаар. 2020/16, 2020 оны 2-р сарын 21 (2020 оны 8-р сарын 9-нд хандсан). https://www.icj-cij.org/files/case -related/163/163-20200221-PRE-01-00-EN.pdf.

ШИГТГЭЭ 2.11 Бразил: "Давуу эрхт форум" ба ялаас зайлсхийх үйлдлийн төгсгөл

Оршил: Бразил улсын Үндсэн хуулийн дагуу бүх салбарын тодорхой албан тушаалтнууд (гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх) болон бүх түвшинд (холбооны, мужийн, бүс нутгийн), Ерөнхийлөгч, Конгрессын гишүүн, засаг дарга зэрэг нь холбогдох харьяаллын дагуу тусгай эрх зүйн статус эдэлдэг. Тус статусын дагуу албан тушаалтнуудын холбогдох хэргийг зөвхөн Дээд шүүхээс шийдвэрлэдэг.

Давуу эрхт форум буюу foro privilegiado гэж нэрлэгддэг энэхүү давуу статус нь албан тушаалтан бус албан тушаалтай холбогдолтой байсан.[a] Энэхүү онцгой эрхийн үндсэн зорилго нь албан тушаалтныг улс төрийн зорилготой мөрдөн шалгах ажиллагаанаас хамгаалж, илүү өндөр туршлагатай шүүгчээр хэргийг шийдвэрлүүлэх байв.[b] Гэвч энэхүү ажиллагаа нь албан тушаалтнуудад ял завших боломж олгосон байж болзошгүй юм. Учир нь Холбооны дээд шүүх нь хэргийг шийдвэрлэхэд олон жил зарцуулдаг аж.[c]

Албан тушаалтны эрх ямбын эсрэг шийдвэр: 2018 оны 05 дугаар сард Холбооны дээд шүүхээс Конгрессын гишүүдэд дээрх давуу эрх олгохыг хязгаарлах шийдвэр гаргасан. Иймд Конгрессын гишүүд (сенатор, танхимын төлөөлөгч) нар нь өөрсдийн бүрэн эрхийн хугацаанд албан тушаалтай нь холбогдолтой хэргийг тус шүүхээс шийдвэрлэх бөгөөд бусад хэргийг доод шатны шүүх шийдвэрлэх болжээ.[d] Тус шийдвэр нь хууль тогтоогчдын дархан эрхийг хязгаарлаж, доод шатны шүүхэд олон тооны хэрэг шийдвэрлүүлэх боломжийг нээсэн.[e]

Ял шийтгэлийн үр дүн: "Автомашины угаалга" хэрэгт холбогдсон хэд хэдэн улс төрчдийг шийтгэсэн ажиллагааг тэдгээрийг огцорсны дараагаар гүйцэтгэх боломж бүрдсэн. Дээр дурдсан хязгаарлалтын дагуу бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй улс төрчдийг хууль сахиулагчид шалгах боломж бүрдэж байна.[f]

Бразил Улсын гэм буруутай нь тогтоогдсон улс төрч, албан тушаалтны дунд Луйз Игнасио Лула Да Силва (Ерөнхийлөгч асан), Жосе Дирсеу (Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга асан), Педро Корреа (Конгрессын гишүүн асан), Эдуардо Сунха (Танхимын илтгэгч асан) нар байв. (Шигтгээ 2.13-аас хариуцлага хүлээх талуудыг тодорхойлох нь чухал болох талаар харна уу.)[g]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 2.11	Бразил: “Давуу эрхт форум” ба ялаас зайлсхийх үйлдлийн төгсгөл

Тодорхойлбол, Ерөнхийлөгч асан Луйз Игнасио Лула Да Силвад 2019 оны 04 дүгээр сард Дээд шүүхээс 8 жилийн хорих ял (2017 оны 7 дугаар сард анхны ял шийтгэл шинэчлэгдсэнээс хойш), Бүс нутгийн холбооны шүүхээс 2019 оны 11 дүгээр сард 17 жилийн хорих ял, авлига болон мөнгө угаасан хөрөнгөд дүйцэх торгууль ногдуулсан.[h]

a. Бразилийн Сенатын хууль тогтоох зөвлөх, 2017 оны 5-р сарын 5 (2019 оны 4-р сарын 3-нд шинэчлэгдсэн). https://www12.senado.leg.br/noticias/audios/2017/05/mais-de-54-mil-autoridades-tem-foro-privilegiado-revela-estudo-da-consultoria.
b. Сара ДиЛоренцо. 2018. “Бразилийн ахмад улс төрчид удахгүй шударга ёстой нүүр тулна.” Associated Press, 2018 оны 5-р сарын 1 (2019 оны 1-р сарын 27-нд шинэчлэгдсэн). https://www.apnews.com/55ac3382f4f54ac8b9fcad48ad02451e.
c. Жо Лихи. 2018. “Хууль зүйн хамгаалалтаа алдсан Бразилийн улс төрчид.” Financial Times, 2018 оны 5 сарын 4.
d. Андре Рихтер. 2018. “Бразилийн Дээд шүүх улстөрчдийн халдашгүй дархан байдлыг хязгаарлах санал өгсөн.” Agkncia Brasil, 2018 оны 5-р сарын 3 (2019 оны 1-р сарын 27-нд шинэчлэгдсэн). http://agenciabrasil.ebc.com.br/en/politica/noticia/2018-05/brazils-supreme-court-votes -restrict-near-inmmunity.
e. Лихи, “Бразилийн улс төрчид,” 2018 оны 5-р сарын 4. Нэмж дурдахад, Нью-Йорк Таймс сонинд иш татсанчлан шүүгч Сержио Моро хэлэхдээ, “Миний харж байгаагаар Лава Жато [Машин угаалга] гэж нэрлэгддэг хэрэг нь ийм төрлийн гэмт хэрэгт зориулсан Бразилийн дүрэм төгсгөл болж байгааг харуулж байна” гэжээ. (Ernesto Londono. 2017. “A Judge’s Bid to Clean Up Brazil from the Bench.” New York Times, 2017 оны 8-р сарын 25 (2019 оны 1-р сарын 27-нд шинэчлэгдсэн). https://www. .nytimes.com/2017/08/25/world/americas/judge-sergio-moro-brazil-anti-corruption.html.)
f. Лихи, “Бразилийн улс төрчид,” 2018 оны 5 сарын 4. Бразилийн мэдээллийн G1 цахим хуудсанд (https://g1.globo.com/) Дээд шүүхэд үргэлжилж буй 500 гаруй эрүүгийн хэргийн шийдвэр гарсны дараа анхан шатны шүүхүүдэд шилжүүлнэ гэж мэдээлсэн. .
g. Пауло Роберто Костагийн (Петробрас компанийн захирал асан) хэрэгт гаргасан шүүхийн эцсийн шийдвэрийг эс тооцвол тэдгээр шүүхийн шийдвэрийн ихэнхийг давж заалдаж болно.
h. Ерөнхийлөгч асан Лулатай холбоотой бүх ажиллагааны харьцангуй шинэчлэгдсэн явц, байдлын талаар BBC News Brasil-аас үзнэ үү. 2019. “Entenda em que pé estão os processos e acusaçxes contra o ex-presidente Lula” [Ерөнхийлөгч асан Лулагийн эсрэг мэдүүлсэн зарга, буруутгаж байгаа үндэслэлүүдийг ойлгох]. 2019 оны 11-р сарын 27 (2020 оны 8-р сарын 10-нд шинэчлэгдсэн). https://www.bbc.com/portuguese / brasil-49647499.

Ихэнх улс орнууд “үнэмлэхүй” болон “харьцангуй” хөөн хэлэлцэх хугацааг ашигладаг. “Үнэмлэхүй” хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн хэрэг түр зогсох, тасалдахаас үл шалтгаалан хугацааг заасан бөгөөд сунгах боломжгүй. Эсрэгээрээ “харьцангуй” хөөн хэлэлцэх хугацаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хамгийн эцсийн хугацааг тодорхойлж, ажиллагаа түр зогсох, тасалдаг тодорхой хугацааг зөвшөөрдөг.

Хөөн хэлэлцэх хугацааг түтгэлзүүлж эсхүл хэд хэдэн шалтгааны улмаас дахин тоолж болдог, үүнд, эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн, албан ёсны процесс эхэлсэн (шүүн таслах ажиллагаа эхэлсэн), хэргийн нарийн төвөгтэй байдал, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт, дархан эрх эсхүл шүүгдэгч нь оргон зайлсан тохиолдол хамаарна. Цаашлаад, зарим улсад хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийг илрүүлсэн эсхүл төрийн албан тушаалтан огцорсноор тоологдож эхэлдэг.[37] Тухайлбал, зохиомол нэхэмжлэх, хуурамч нягтлан бодох бүртгэл нь хахуулийг нуун дарагдуулах зорилгоор үйлдэгдсэн бол тус үйлдлийг илрүүлэх хүртэл хөөн хэлэлцэх

[37] Аргентин Улсын Эрүүгийн хууль, Тухайлбал, 67 дугаар зүйлд зааснаар төрийн албан тушаалтан албан тушаалаас чөлөөлөгдсөний дараагаар бүх хөөн хэлэлцэх хугацаа эхэлдэг. Хураан авсан хэрэгт Франц, Их Британи, АНУ-д нээлтийн зарчмыг баримталдаг (жишээлбэл, U.S.C. § 1621-ийг үзнэ үү).

хугацаа тоологдохгүй. “Илрүүлэх” гэдэг нь хууль тогтоомжийн дагуу эсхүл шүүхээр шийдвэрлэгддэг бол илрүүлсэн огноог шүүхээс тогтоодог.

Хөөн хэлэлцэх хугацаа дуусах нь албан хаагчдад сорилт болж байна, учир нь авлигын хэргийн нотлох баримт эсхүл төсвийн хөрөнгийг шамшигдуулсан үйлдэл нь авлигач албан тушаалтан чөлөөлөгдсөнөөс урт хугацааны дараа илэрдэг билээ. Хөөн хэлэлцэх хугацаа богино байх, гэмт хэргийг илрүүлэх зохицуулалт хангалтгүй байх нь мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тодорхойлбол, зарим улсад үргэлжилсэн гэмт хэргийн суурь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны дотор үйлдэгдсэн байхыг шаарддаг. Цаашлаад мөнгө угаах гэмт хэргийн үндсэн элемент (тухайлбал, гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг хадгалах) нь үргэлжилсэн бөгөөд суурь гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх шалтгаанаар ял оногдуулах болсноор тус мөнгө угаах гэмт хэрэгт мөн ял оноох боломжгүй болж байгаа юм.

Хулгайлагдсан хөрөнгө хураахаар ажиллаж буй албан хаагчид нь харьяаллын улсын хөөн хэлэлцэх хугацааг сайтар судалж[38], дараах арга хэмжээг авах шаардлагатай:

- Хэрэг шалгахад илүү давуу байдал олгох хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэргийг тодорхойлох (тухайлбал, хөрөнгө шамшигдуулах, мөнгө угаах, хулгайлагдсан хөрөнгө эзэмших)
- Хулгайлагдсан хөрөнгө гадаад улсад байрлагдсан гэмт хэрэг илрэх хүртэл хөөн хэлэлцэх хугацааг хойшлуулсан, эсхүл түдгэлзүүлсэн хууль эсхүл шүүхийн шийдвэрийг судлах
- Прокурор эсхүл хууль сахиулах байгууллагын тодорхой үйл ажиллагаа нь хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлсэн эсхүл шинээр эхлүүлсэн эсэхийг нягтлах
- Албан тушаалын байдлаас шалтгаалан тусгай давуу байдал эдэлж буй албан хаагчдад анхаарал хандуулах, тухайлбал, төрийн тэргүүн эсхүл сайд, учир нь энэхүү давуу байдал нь дархан эрх эсхүл Үндсэн хууль, захиргаа, шүүхийн тусгай үйл ажиллагаа гүйцэтгэхийг шаардах боломжтой бөгөөд цаашлаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах боломжтой. Мөн нэг улсад олгож буй дархан эрх нь нөгөө улсад хүлээн зөвшөөрөгдөхгүй байх боломжтой.
- Боломжит эрх зүйн бүх хэрэгслийг судлах, үүнд, эрүүгийн болон гэм буруутайд тооцолгүй хөрөнгө хураах, иргэний арга хэмжээ ба гадаад улсаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхийг хүсэх зэргээр хамгийн их давуу байдал олгох хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох[39]

[38] Грекийн Иргэний болон Эрүүгийн Дээд шүүхийн шийдвэр, 2011 оны 1-р шийдвэр. Грекийн Засгийн газарт 30 гаруй жил (ялангуяа Батлан хамгаалахын сайдаар) сайдаар ажиллаж байсан Акис Цохатзопулостой холбоотойгоор хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой хэд хэдэн асуудал гарч байв. Цохатзопулосыг хүндрүүлэх нөхцөл байдалд (төрийн өмчөөс ашиг олох) хахууль авсан хэргээр буруутгаж, Грекийн үндсэн хуулийн дагуу Засгийн газрын одоогийн болон хуучин гишүүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх тусгай хугацаа үйлчилж байсан тул шийтгэл нь аль хэдийн хүчингүй болсон. Иймд хахууль авах хэргээр яллах ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй гэж мэдэгдэв. Гэсэн хэдий ч түүнийг мөнгө угаасан хэргээр буруутгаж, шүүхээр шийтгэсэн нь Үндсэн хуульд заасан хязгаарлалтад хамаарахгүй байв. Хахууль авах үндсэн гэмт хэргийн заалтыг мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгахад хамааралгүй гэж үзсэн.

[39] 19 U.S.C. § 1621, АНУ-ын хураан авах хөөн хэлэлцэх хугацаа (эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаанаас ялгаатай нь) хураан авах ажиллагаа явуулахад хүргэсэн гэмт хэрэг илэрсэн үеэс эхлэн хэрэгжиж эхэлдэг бөгөөд хэрэв эд хөрөнгө АНУ-ын хилээс гадуур байрладаг бол түдгэлзүүлж болно.

- Хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргийн нотлох баримтыг ашиглахыг бодолцон үзэх, учир нь энэ төрлийн баримт нь бусад хугацаа дуусаагүй гэмт хэрэгт хөтөлдөг.

2.8.4 Хөрөнгө буцаах ажиллагаа дахь хуулийн зохицуулалт, шүүхийн шийдвэр, гэрээ

Гадаад эсхүл дотоодын мөрдөн шалгах ажиллагаанаас сонгох, эсхүл бусад эрх зүйн хэрэгслийг ашиглах сонголт хийхээс өмнө албан хаагч хэд хэдэн параметрыг хөрөнгө хураах ажиллагаа болон хөрөнгийн хэмжээнд хамааруулан бодолцох хэрэгтэй. Хөрөнгө шамшигдуулах эсхүл төсвийн хөрөнгийн мөнгө угаасан хэрэгт НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн дагуу хөрөнгө хураасан тохиолдолд тус хөрөнгийг хүсэлт гаргасан улсад буцаан олгох шаардлагатай[40] Нөгөөтэйгүүр, тус үйл ажиллагаа нь хүсэлт гаргагч талаас хөрөнгө нь өөрийх мөн гэснийг бүрэн нотлох эсхүл хүсэлт хүлээн авсан тал нь хүсэлт гаргагч талд тулгарсан хохирлыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд конвенцийн бусад гэмт хэрэгт хамаарна.[41]

Гэсэн хэдий ч, энэхүү нөхцөл байдлаас гадуур хураасан хөрөнгө, тухайлбал, гадаад улсан байгууллагаас дотоодын мөнгө угаасан хэргийг шийдвэрлэж хураан авсан хөрөнгийг буцаах эсэх нь хураан авсан талын хууль, бусад холбогдох олон улсын гэрээ, эсхүл хэрэгжиж буй түр зохицуулалтын дагуу шийдвэрлэнэ.[42] Хөрөнгө буцаах хэлэлцээр нь зарим тохиолдолд үр дүнтэй тус хөрөнгийг буцаах ажиллагааг зохицуулдаг(ес болон арваннэгдүгээр бүлгийг харна уу). Түүнчлэн гадаад улсын процесс ажиллагаа нь зөвхөн мөнгө угаах хэргээр хязгаарлагдаж бусад гэмт хэрэг болон суурь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг хураан авахад сөргөөр нөлөөлөх боломжтой юм.

2.8.5 Нотлох баримтын шаардлага

Албан хаагчид мөн нотлох баримт нь дотоодын болон зарим тохиолдолд гадаад улсад хэргийг илрүүлэх, арга хэмжээ авах, хөрөнгө хураах, иргэний арга хэмжээ, гэм буруутайд тооцох шаардлагад нийцсэн эсэхийг нягтлах хэрэгтэй. Хэдийгээр улс орон бүрээс шалтгаалан холбогдох шаардлага нь өөр боловч ерөнхийдөө мөрдөн шалгах ажиллагааны техник эсхүл арга хэмжээ нь нарийвчлагдсан байвал нотлох баримтын стандарт мөн нэмэгддэг байна. (2.1 дэх зургийг харна уу)

Олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай хэрэг шийдвэрлэж буй албан хаагчид эрх зүйн тогтолцооны талаар мэдлэгтэй байж хуулийн нэр томъёо, нотлох баримтын

---

[40] АЭНҮБК, 57(3)-р зүйлд заасны дагуу мөнгө завшсан, угаасан тохиолдолд хөрөнгийг хүсэлт гаргасан оролцогч улсад буцаан олгоно гэж заасан.

[41] Бусад бүх тохиолдолд хүсэлт гаргагч тал нь хүсэлт гаргагчийн харьяалалд байгаа хөрөнгийг буцаан авах, хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгох, авлигын хохирогчдод нөхөн төлбөр олгох асуудлыг “нэн тэргүүнд анхаарч үзэх” үүрэгтэй.

[42] Ийм нөхцөл байдал нь Перугийн Швейцарь дахь Владимиро Монтесиносын хөрөнгийн эсрэг дотоодын хэрэг үүсгэх шийдвэрт нөлөөлсөн. Хэдийгээр Швейцарь улс хар тамхитай тэмцэх хууль тогтоомжийнхоо дагуу хэргийн зарим хэсгийг яллах боломжтой байсан ч тухайн үеийн хөрөнгө хуваах хуулиуд нь хөрөнгийн тодорхой хэсгийг Перу руу буцаахыг зөвшөөрч байв. Швейцарьтай стратегийн хэлэлцээ хийсний дараа Перу улс дотоодын хэргүүдийг шилжүүлж, хөрөнгийн ихээхэн хэсгийг эргүүлэн авахын тулд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт болон хууль тогтоомжийн зохицуулалтыг ашиглахаар шийджээ. Нэмэлт мэдээллийг 1-р бүлгийн 1.3-р хайрцагт байгаа хэргийн хэлэлцүүлгийг үзнэ үү

стандарт үүнээс шалтгаалан өөрчлөгдөж байдгийг анхаарах хэрэгтэй юм. Ихэнх нийтийн эрх зүйн тогтолцоонд тухайлбал, ял оногдуулахад “эргэлзээгүй нотлогдсон байх” шаардлагатай байдаг бол хөрөнгө хураах (шийтгэх тогтоолгүйгээр болон эрүүгийн журмаар) ажиллагаанд “магадлалын тэнцэл” эсхүл “нотлох баримтын давамгайлал” стандарт хангаж байхыг эх газрын эрх зүйд (иргэний эрх зүйн тогтолцоо) шаарддаг. Харин эх газрын эрх зүйн тогтолцооны хувьд ял оногдуулах стандарт нь ижил боловч эрүүгийн болон ял ногдуулахгүй хөрөнгө хураах ажиллагаа эсхүл иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхэд “хангалттай итгэл үнэмшил” шаарддаг.

Нийтийн эрх зүйн тогтолцоо нь нотлох баримтын үнэлэхэд боломжит үзлийг ашигладаг, тухайлбал хэрэг үйлдэгдсэн гэх боломж, магадлалын хувийг тооцно.

ЗУРАГ 2.1 Хөрөнгө буцаан авах ажиллагаан дахь нотолгооны стандарт

	Илрүүлэх арга хэмжээ	Зохицуулах арга хэмжээ, зарим мөрдөн шалгах техник (царцаах болон хураах даалгавар)	Хөрөнгө хураах даалгавар эсхүл иргэний арга хэмжээ	Гэм буруутайд тооцох
Нийтийн эрх зүйн тогтолцоо	Сэжиглэх боломжит үндэслэл	Итгэх боломжит үндэслэл	Магадлалын тэнцвэр эсхүл нотлох баримтын давамгайлал	Үндэслэлд эргэлзэх зүйлгүй байх
Эх газрын эрх зүйн тогтолцоо	Үнэнийг тогтоох нотлох баримт	Үнэнийг тогтоох нотлох баримт	Хангалттай итгэл үнэмшил байх	Хангалттай итгэл үнэмшил байх

Эх сурвалж. Дэлхийн банк

Эх газрын эрх зүйн тогтолцооны улсууд нь шүүгчийн субъектив байдалд ихээхэн анхаарал хандуулдаг. Цаашлаад холимог эсхүл бусад тогтолцоонд тусгай шаардлага байж болно.

Албан хаагчид мөн дээрх ялгааг сайтар ойлгож нотлох баримт холбогдох шаардлагад нийцэж буй эсэхийг нягтлах шаардлагатай. Хэрэв нэг стратегийг ашиглан гүйцэтгэхэд нотлох баримт нь шаардлага хангахгүй тохиолдол, эрх зүйн бусад хэрэгслийг ашиглахыг албан хаагч тооцох ёстой. Тухайлбал “үндэслэлд эргэлзэх зүйлгүй байх” шаардлагыг хангаж яллах нь эрүүгийн хөрөнгө хураах ажиллагаанд хүндрэл учруулдаг. Нөгөөтэйгүүр нотлох баримтын холбогдох ерөнхий шаардлагыг хангасан тохиолдолд авлигын орлого болон хөрөнгийг хувийн иргэний арга хэмжээ эсхүл гэм буруутайд тооцолгүй хөрөнгө хураах ажиллагаа гүйцэтгэж буцаан авчрах боломжтой юм.

2.9 Хариуцлага хүлээх бүх талуудыг тодорхой болгох

Ихэнх улс орнуудад гэмт хэргийн хөрөнгийг мэдсэн атал шилжүүлсэн эсхүл үндэслэлгүйгээр олсон хөрөнгийг хүлээн авах нь иргэний эсхүл эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээхээр заагдсан бөгөөд үүнд хамтран оролцох, хуйвалдаан, санаатайгаар үл тоомсорлох, хайхрамжгүй байдал, хуурамчаар түдгэлзэх эсхүл

орхигдуулсан залилангийн үйлдэл хамаарна. Үүнд хуулийн этгээд болон тэдний удирдах албан хаагч, банкир, санхүүгийн менежер, үл хөдлөх хөрөнгө зуучлагч, нотариат, эсхүл санаатайгаар үндэслэл бүхий мэдээлэл гаргаж өгөөгүй хуульчид хамаарна.[43] Зарим улс оронд зөвлөх үйлчилгээний төлбөр нь үйл ажиллагааны үнэлгээнээс хэтэрсэн эсхүл техникийн ур чадваргүй талд төлөгдсөн тохиолдолд энэ тухай мэдээгүй гэх шалтгааныг шүүх хүлээн авдаггүй. Бусад улс оронд охин компанийн хууль бус үйл ажиллагаанд үндсэн хуулийн этгээдийн ажилтан шууд нөлөөлсөн гэж үзвэл тус хуулийн этгээдийг мөн хариуцлагад татдаг.

Хөрөнгө хүлээн авагч талыг онилох нь хоёр үндсэн давуу талтай: нэгдүгээрт, авлигач албан тушаалтан бус хуулийн этгээд эсхүл хувь хүнээс хөрөнгийг нөхөн төлүүлэх боломжийг нэмэгдүүлдэг, учир нь тус этгээдүүдэд нь санхүүгийн өндөр чадамжтай байх нь элбэг, хоёрдугаарт, авлигач албан тушаалтны эсрэг гуравдагч этгээд хамтран ажиллах болон дэмжлэг, мэдээлэл авах боломжтой юм. Түүнчлэн, албан хаагчид ийнхүү ажилласанаар нөөц бололцоог хэргийн олон үйл ажиллагаанд хуваан зарцуулж стратегид сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэйг тооцох хэрэгтэй. Шигтгээ 2.12 болон 2.13-д харуулсан хэрэг нь хариуцлагатай бүх талуудыг тодорхойлох ач холбогдлыг харуулах болно.

2.10 Эрүүгийн хэргийн талаар тусгайлан анхаарах асуудлууд

2.10.1-т тусгагдсаны дагуу албан хаагчид хөрөнгө буцаах эрүүгийн хэрэгт хэд хэдэн зүйлийг онцгой анхаарах хэрэгтэй.

ШИГТГЭЭ 2.12 Замби: Ерөнхийлөгч асан Фредерик Чилубагийн хэрэг дэх хуульчдын хариуцлага

Оршил: 2004 онд Замби улсын Ерөнхий прокуророос Ерөнхийлөгч асан Фредерик Чилуба болон бусад шүүгдэгчдийн эсрэг иргэний нэхэмжлэл гаргаж, 1995-2001 оны хооронд Сангийн яамнаас шилжүүлсэн хөрөнгийг буцаан авахыг шаардсан. Шүүгдэгчдийн дунд өмгөөлөгч Икбад Меер, түүний хуулийн фирм Meer Care & Desai, мөн өмгөөлөгч Бимал Такер, Бхупендра Бхайлал Такер байжээ. Иргэний нэхэмжлэлийн үндэслэлийг 10 дугаар бүлгийн шигтгээ 10.3-аас харна уу.

Икбад Меерийг онилсон нь(мөн түүний хуулийн фирм Meer Care & Desai): Их Британийн Дээд шүүхээс Меерийн зан араншинг "сонгодог сохор худал"[a] гэж тайлбарласан буюу Меер нь өөрт ирсэн зааварчилгааг үг дуугүй үйлчлүүлэгчийн өмнөөс гүйцэтгэсэн, энэ нь а. Хэрэгжүүлж буй арга хэмжээг ойлгож байсан боловч, санаатайгаар залилан хийх хуйвалдаанд оролцсон эсхүл б. Хариултыг мэдэхийг хүсээгүй байна. Шүүхээс Меерийг хуйвалдаан зохион байгуулсан, шударга бус дэмжлэг үзүүлсэн, үйлчлүүлэгчийн дансаар хийгдсэн хөрөнгийг хулгайлсан, хулгайн гэмт хэргийг хийхээс татгалзалгүй гүйцэтгэсэн хэрэгт хариуцагчаар тогтоогдсон.[b]

Гэвч давж заалдах шатны шүүхээс Меерийг шударга бус дэмжлэг үзүүлж хуйвалдаан хийсэн боловч тэрээр шударга боловч мөнгө угаах гэмт хэрэг гэдгийг мэдэх хангалттай мэдлэг, ур чадвар, туршлага байхгүй байх боломжтой гэдгийг

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[43] "ФАТФ-ын зөвлөмж"-ийн 22 дугаар зөвлөмж нь казино, үл хөдлөх хөрөнгийн агент, үнэт метал, чулууны дилер, хуульч, нотариатч, нягтлан бодогч зэрэг тусгайлсан санхүүгийн бус бизнес, мэргэжлээр (DNFBPs) үйлчлүүлэгчийг сайтар нягтлан шалгах, бүртгэл хөтлөх шаардлагыг хангадаг. (FATF 2019).

ШИГТГЭЭ 2.12 Замби: Ерөнхийлөгч асан Фредерик Чилубагийн хэрэг дэх хуульчдын хариуцлага

дээд шүүхээс харгалзан үзээгүй шийдвэрлэж алдаа гаргасныг тогтоожээ.[c] Үнэн хэрэгтээ шүүхээс түүний үйлдлийг "үнэнч бөгөөд тэнэг" гэж тайлбарласан.[d] Цаашлаад шүүхээс өмгөөлөгчийг илүү болгоомжтой ажиллах ёстой байсан гэж үзсэн боловч үнэнч эсэх тал дээр нь маргажээ. Гэсэн хэдий ч Меер нь хуулийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ 3 жилээр түдгэлзүүлсэн байна.

Бимал Такер, Бхупендра Бхайлал Такер нарын хэрэг (тэдний хуулийн фирм Cave Malik & Co): Дээд шүүхийн мэдээлснээр Бимал Такерын үйлдэл нь мөн шударга бус байсан юм, учир нь тэрээр Засгийн газрын хөрөнгийн эх үүсвэрийг нуун дарагдуулж, банкуудыг төөрөгдүүлж хууль бусаар хөрөнгө худалдан авч буйг мэдэж байсан.[e] Иймд шүүхээс түүнийг үйлчлүүлэгчийнхээ дансаар дамжуулан мөнгө хулгайлсан хуйвалдаан хийсэн, шударга бус туслалцаа үзүүлсэн хэрэгт хариуцлага ногдуулсан байна.[f]

Шүүхийн шийдвэрүүд:
a. High Court of Justice, Chancery Division [2007] EWHC 952 (Ch.) 04.05.2007, § 587.
b. High Court of Justice [2007], § 589.
c. Court of Appeal, Civil Division [2008] EWCA Civ 1007 31.07.2008, § 267.
d. Court of Appeal [2008], § 294.
e. High Court of Justice [2007], § 851.
f. High Court of Justice [2007], § 875

ШИГТГЭЭ 2.13 Бразил: Лава Жатогийн хэрэгт хариуцагч талуудыг тодорхойлох нь

2014 оны 03 дугаар сард Бразил улсын Холбооны цагдаагийн газраас тус улсын төрийн өмчит газрын тосны компани болох Петробас болон Одебрехт зэрэг томоохон барилгын компаниудыг олон улсын хахуулийн схемд холбогдуулан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн. Автомашин угаалгын хэрэг нь мөнгө угаах үйлдлийг нуун дарагдуулж автомашин угаалгын газар ажиллуулж байсан учраас ийнхүү нэр авсан бөгөөд ээдрээ төвөгтэй хахуулийн схемийн боломжит холбогдоч талуудыг илрүүлэх, ангилах үйлдлийг чухлыг харж болно.

Тухайлбал, Бразилийн Холбооны Прокурорын албанаас тус хахуулийн хэрэгт холбогдсон этгээдийн дөрөв ангилсан байдаг:[a]

- "Бизнес бүлэг" буюу хахуулийн схемд холбогдсон Бразилийн барилгын компанийн ажилтан, агентаас бүрдсэн хэсэг бөгөөд Петробас компанийн удирдлага, улс төрчдөд хахууль өгөх үйлдлийг гүйцэтгэж байсан этгээдүүд
- "Захиргааны бүлэг" буюу Петробас компанийн удирдах албан тушаалтнууд
- "Улс төрийн бүлэг" буюу Үндэсний конгрессын гишүүн болон гишүүн асан, улс төрийн намын төлөөлөгчид бөгөөд барилгын компанийн хүсэл зорилгыг биелүүлэх этгээдүүд
- "Санхүүгийн бүлэг" хар захын мөнгөний дилер этгээдүүд буюу мөнгө угаах, тараах үйлдлийг гүйцэтгэгчид

a. Холбооны прокурорын газар нь "Entenda o Caso" (хэргийн талаарх дэлгэрэнгүйг [Португал хэл дээр] дөрвөн хэсэгтэйгээр гаргасан. Caso Lava Jato, Бразилийн Холбооны Цагдаагийн газрын цахим хуудас: http://www.mpf.mp.br/grandes-casos/lava-jato/entenda-o -caso. Энэ нь мөн Adir Assad, Agenor Medeiros болон бусад хүмүүстэй холбогдуулан 2016 оны 8 сарын 09-ний өдөр гаргасан гомдлын талаарх мэдээллийг багтаасан.

2.10.1 Холбогдох эрүүгийн гэмт хэргийг тодорхойлох

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагаанд зөвхөн хахуулийг стратеги болгон ашиглах нь зохимжгүй. Хүснэгт 2.1-т тусгасны дагуу албан хаагчид харгалзан үзэх үйлдлийг харуулав.

Авлига нь ихэнхдээ хэд хэдэн эрүүгийн хэргийг давхар үүсгэдэг. Иймээс мөрдөн шалгах хэргийг сонгохдоо дараах нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй: а. Хэргийн мэдээлэл, б. Нотлох баримтын бэлэн байдал, шууд болон нөхцөл байдалд тулгуурласан нотлох баримт нь гэмт хэргийн элементийг хангах эсэх, в. Няцаах боломжгүй таамаглал зэрэг процессын дэмжлэг[44], г. Ял оноох магадлал, д. Боломжит санкци, з. Нийтийн хүсэл сонирхол, ж. Шаардлагатай тохиолдолд гадаад улсаас туслалцаа авах, хэрэгжүүлэх чадвар хамаарна.

Хүснэгт 2.1 Хөрөнгө буцаах ажиллагаанд харгалзан үзэх эрүүгийн гэмт хэрэг, бүлгээр

Хөрөнгө шамшигдуулах	Боломжит хэрэг
Хахууль, эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг үйлдэл	• Хулгай эсхүл дээрэм • Шамшигдуулах • Хууль бус хуваарилалт • Залилан, худал мэдээлэл
Гэмт хэргийн орлогыг угаах, нуун дарагдуулах, олж авах, эзэмших эсхүл ашиглах	• Хахууль (үндэсний болон гадаад төрийн албан хаагч) • Хувийн салбарын хахууль • Үүргээ зөрчих • Нөлөөллөө наймаалцах • Бүрэн эрхээ урвуулах • Ашиг сонирхлын зөрчил • Улс төрийн нам эсхүл сонгуулийн сурталчилгааны хууль бус санхүүжилт • Сүрдүүлэх • Монополийн эсрэг эсхүл өрсөлдөөний тухай хуультай холбогдох зөрчил
Бусад холбогдох гэмт хэрэг	• Хөрөнгө шилжүүлэх эсхүл өөрчлөх • Нуун дарагдуулах • Гэмт хэргээс олсон орлогын олж авах, эзэмших эсхүл ашиглах • Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

[44] Олон тооны харьялалын хүрээнд “няцаах боломжтой таамаглал”-ыг ашигладаг бөгөөд энэ нь прокурор эсвэл гомдол гаргагчийг нотлох үүргээ биелүүлэхэд үр дүнтэй тусалдаг. Жишээлбэл, прокурор зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдсон нь тогтоогдвол шүүгдэгчийн эд хөрөнгийг гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон орлого гэж үзнэ (хэрэв шүүгдэгч таамаглалыг баталж чадахгүй бол). Илүү олон жишээг 7-р бүлгийн 7.4.1-ээс үзнэ үү.

Facilitating and other relevant offenses	• Хөрөнгө мэдүүлээгүй эсхүл худал мэдүүлэх • Зохицуулалтын гэмт хэрэг • Төрийн худалдан авах ажиллагааны журам зөрчих • Баримт бичиг хуурамчаар үйлдэх • Нягтлан бүртгэлийн гэмт хэрэг • Татварын зөрчил • Гаалийн залилан эсхүл хууль бусаар бараа нэвтрүүлэх • Шуудан болон утасны залилан • Хуйвалдаан, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлд оролцох • Гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх • Хууль сахиулах үйл ажиллагаанд саад учруулах

Түүнчлэн илэрхий энгийн авлигын гэмт хэргээс илүүтэйгээр прокурорууд гэм буруутайг тогтоох боломжийг нэмэгдүүлэх бусад гэмт хэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд, хуйвалдаан, гэмт хэрэгт дэмжлэг үзүүлэх, гэмт хэргээс олсон орлогыг хүлээн авах, эзэмжих эсхүл мөнгө угаах гэмт хэрэг хамаарна.[45] Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэнх тохиолдолд мөрдөн шалгах хамгийн үр дүнтэй сонголт болдог, ялангуяа бие даан мөнгө угаах үйлдлийг гэмт буруутайд тооцдог болон суурь гэмт хэргийн бүх элементийг хангахыг шаардаггүй улс орнуудад үр дүнтэй юм.[46] Энэхүү прокурорын шийдвэр нь гадаад улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх боломжтойг харгалзан үзэж гадаад улсын хамтрагчидтай нягт хамтран ажиллахыг хичээх хэрэгтэй. Шигтгээ 2.14-т хахуулийн хүрээнд дүн, бүртгэлийн журмыг зөрчсөн, зохицуулалтын мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн зэрэг гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн жишээг харуулав.

ШИГТГЭЭ 2.14 Нягтлах бодох, бүртгэл, дотоод хяналтын зохилцуулалтын хэргийг Их Британи, АНУ-д хянан шийдвэрлэх нь

АНУ-ын эсрэг Сименсийн хэрэг:[a] Төрийн байгууллагаас засгийн газрын гэрээг авах зорилгоор төрийн албан хаагчдад хахууль өгсөн талаар мэдсэн. Хахуулийг зөвлөхөд өгсөн төлбөр мэтээр тооцож цаашид төрийн албан хаагчдад шилжүүлсэн байна. Сименс болон Аргентин, Бангладеш, Венесуэл дахь охин компаниуд нь хуйвалдаан болон Гадаад авлигын эсрэг хуульд[b] заасан бүртгэлийн зохицуулалт, дотоод хяналтын зохицуулалтыг зөрчсөн гэдгийг хүлээн зөвшөөрч, ял наймаалцах гэрээ байгуулан 450 сая ам.долларын торгууль төлөхөөр болжээ.

АНУ-ын эсрэг BAE systems хэрэг:[c] Тус компани нь хэд хэдэн улсад зэвсэг нийлүүлэхээр төрийн албан хаагчдийг хахуульдсан байх бөгөөд АНУ, Их Британитай олон улсын түвшинд тохиролцоонд хүрсэн байна. АНУ-д тус компани нь зохицуулалтын мэдүүлэг холбогдуулан худал мэдүүлэг өгөх хуйвалдаан хийсэн хэргийг хүлээн зөвшөөрч 400 сая ам.долларын торгууль төлөхийг болон дагаж

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[45] Францад татварын болон хуурамч нягтлан бодох бүртгэлийн гэмт хэрэг, хөрөнгө шамшигдуулах, итгэлийг эвдэх гэмт хэрэг буюу авлигын үйл ажиллагаатай байнга холбоотой гэмт хэрэг нь хахууль өгөх гэмт хэргээс илүү хялбар нотлогддог.

[46] Бельги Улсад санхүүгийн гүйлгээнд оролцсон яллагдагчдыг хөрөнгө нь хууль бусаар гарал үүсэлтэй гэдгийг мэдэх хангалттай нотолгоо байгаа тохиолдолд мөнгө угаасан хэрэгт буруутгаж болно. Прокурор урьдчилсан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох шаардлагагүй.

ШИГТГЭЭ 2.14 Нягтлах бодох, бүртгэл, дотоод хяналтын зохилцуулалтын хэргийг Их Британи, АНУ-д хянан шийдвэрлэх нь

мөрдөн журмын талаар нэмэлт үүрэг хүлээхээр тохиржээ. Их Британид тус компани нь нягтлан бодох бүртгэлийн журам зөрчсөн гэх хэрэгт гэм буруугаа хүлээж 30 сая фунт стерлингийн торгууль төлөхийг зөвшөөрсөн байна.

a. Хэрэг: US District Court for the District of Columbia, United States of America v. Siemens Aktiengesellshaft, Siemens S.A. (Argentina), Siemens Bangladesh Ltd., and Siemens S.A. (Venezuela), Sentencing Memorandum, December 12, 2008 (accessed August 12, 2018), https://www.justice.gov/sites/default/files/criminal-fraud/legacy/2013/05/02/12-12-08siemensvenez-sent.pdf. See also 18 U.S.C. § 371; 15 U.S.C. §§. 78(b)(2)(B), 78m(b)(5), and 78ff(a).
b. АНУ-ын Хууль зүйн яам (DOJ) болон АНУ-ын Үнэт цаас, биржийн комисс (SEC) нь Гадаадын авлигын үйл ажиллагааны тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй. DOJ нь нийтийн компаниудын эсрэг эрүүгийн хэрэг болон дотоодын асуудалтай холбоотой эрүүгийн ба иргэний асуудлыг хариуцсан агентлагуудтай. SEC нь нийтийн компаниудад холбогдох иргэний асуудлуудыг хариуцан ажилладаг. (DOJ and SEC 2012).
c. Хэрэг: US District Court for the District of Columbia, United States of America v. BAE Systems PLC, No. 1:10-cr-035(JDB), Sentencing Memorandum, February 22, 2010 (accessed August 12, 2018), https://www.justice.gov/sites/default/files/criminal-fraud /legacy/2011/02/16/02-22-10baesystems-memo.pdf.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь Аргентин, Бразил, Колумб зэрэг улс орнуудад авлигач албан тушаалтныг яллах үр дүнтэй хэрэгсэл болдог.[47]

Энэ нь төрийн албан хаагч мэдүүлсэн хөрөнгө нь хууль ёсны орлогоор нотлогдоогүйгээр их хэмжээгээр нэмэгдсэн үйлдэл хариуцлага ногдуулдаг. Цаашлаад авлигын гэмт хэргийн элементийг тогтооход шаардагдах яллах байгууллагын ачааллыг ихээхэн бууруулдаг (авлигын үйлдэл, ашиг зэрэг). Энэ төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй улс орнууд өөрийн иргэний болон захиргааны хуульд тусгасан байдаг.[48]

Их Британид Тайлбарлагдаагүй хөрөнгийн даалгаврын тухай хуульд зааснаар үүнтэй төстэй үр дүнтэй байж болзошгүй юм, учир нь энэхүү даалгавар нь яллах байгууллагад хөрөнгийг царцаах, цаашлаад шүүгдэгч хөрөнгийн эх үүсвэрийг хууль ёсных гэдгийг нотолж чадахгүй бол хураах хүртэл арга хэмжээ авах боломжийг бүрдүүлдэг. Албан хаагчид үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэрэгт ял оноох нь энэ төрлийн хэргийг дотоодын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэгт тооцдоггүй улс орнуудтай олон улсын хамтын ажиллагаа гүйцэтгэхэд хүндрэл учруулж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

2.10.2 Нотлох баримтын сорилтыг урьдчилан тооцоолох

Албан хаагчид нь хэргийг эргэлзээгүйгээр батлах тодорхой элементийг тогтооход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тооцоолох хэрэгтэй (Хүснэгт 2.2). Зарим улс орнуудад эдгээр элементийг тогтооход прокурорт дэмжлэг үзүүлэх зорилго бүхий няцаах боломжтой таамаглал байдаг.

---

[47] АЭНҮБК, 20-р зүйлийг үзнэ үү. Авлигын эсрэг Америк хоорондын конвенц (IACAC), 9-р зүйл. Хоёр конвенцид оролцогч улсууд холбогдох заалтуудыг батлах талаар харгалзан үзэхийг шаарддаг. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг гэж үзэх нь хөрөнгийг эргүүлэн авах үйл явцад хэрхэн эерэгээр нөлөөлөх талаар илүү дэлгэрэнгүй ярилцахыг Muzila(2012)-аас үзнэ үү. https://star.worldbank.org/sites/star/files/on_the_take-_criminalizing_illicit_enrichment_to_fight_corruption.pdf.

[48] Үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг гэж тооцдог зарим харьяалал ч хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан авах зорилгоор иргэний арга хэмжээг ашигладаг.

Төрөл бүрийн хэрэгтэй холбоотой сорилтуудыг тухай бүрд авч үзэх хэрэгтэй. Тухайлбал, урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааны явцад тодорхой бичмэл баримт бичиг байхгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг батлах нь хахуулийн хэргийг нотлохоос хялбар юм.[49] Гэвч мөрдөгчид энэхүү нотлох баримтын илрүүлсэн тохиололд хахуулийн үйлдлийг нотлох нь илүү хялбар болно. Учир нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг тогтооход прокурор нь шүүгдэгчийн хөрөнгө болон амьдралын хэв маягийн талаар мэдээлэл цуглуулах шаардлагатай болдог.

2.10.3 Ял шийтгэх боломжгүй байдал

Ихэнх улс орнуудад шүүгчдэгч нь оргон зайлсан эсхүл нас барсан тохиодолд эрүүгийн хэргийг шүүн тогтоох боломжгүй байдаг. Цөөн тооны эх газрын эрх зүйн тогтолцоонд шүүгдэгч нь оргон зайлсан тохиолдолд эрүүгийн хэргийн шүүх хурлыг хийх боломжтой юм. Гэвч эдгээр хэргийн шүүхийн шийдвэр нь эцсийн биш байх боломжтой юм, учир нь шүүгдэгч баригдсан тохиолдолд шүүхийн шийдвэрийг давж заалдах бүрэн эрхтэй байдаг. Түүнчлэн зарим хөрөнгө хураах хуулинд шүүгдэгч оргон зайлсан эсхүл нас барсан тохиолдолд хөрөнгө хураах ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэхийг зөвшөөрсөн байдаг.

Хүснэгт 2.2 Хөрөнгө буцаах ажиллагаатай холбогдон сонгогдсон эрүүгийн хэргүүдийн элементийг бүрдүүлэхэд тулгарах үндсэн нотлох баримтын сорилтууд

Гэмт хэрэг	Сорилт
Хахууль	Гэмт хэрэг үйлдсэнийг тогтооход хахууль өгөхийг санал болгосон, амласан эсхүл "авлигын амлалт"-ын нэг хэсэг болгож төлсөн гэх шаардлагыг хангах хэрэгтэй бөгөөд тус хахуулийн нөхцөлийг тодорхойлж хахууль өгөгч болон төрийн албан хаагч эсхүл хувийн байгууллагын ажилтан харилцан ашигтай байгаа байдлыг батлах ёстой. Ихэнх тохиолдолд авлигын тохиролцоог нотлох баримт олох хүндрэлтэй байдаг, учир нь тус тохиролцоог нууцаар гүйцэтгэдэг билээ, нэн ялангуяа, мөрдөн шалгах ажиллагаа нь хэрэг үйлдэгдсэний дараа гүйцэтгэсэн тохиолдолд. Охин компани болон зуучлагчдаар дамжуулан гадаад улсын газар нутагт хахууль өгснөөр прокуроруд үндэсний байгууллагын удирдах ажилтнууд тус үйлдлийг зохион байгуулсан, мэдэж байсан гэдгийг нотлох үүрэг хүлээдэг. Шүүгдэгч нар нь хахууль өгсөн албан хаагчид компанийн дүрмийг зөрчиж өөрсдийн шийдвэрээр хахууль өгсөн хэмээн мэдэгдэж болдог.
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үйлдлийг нотлохын тулд тухайн этгээдийн нуун дарагдуулсан хөрөнгө эсхүл орлогыг үнэлэх шаардлагатай.
Хулгай эсхүл шамшигдуулалт	Тус гэмт хэрэг нь үл хөдлөх хөрөнгө эсхүл үйлчилгээнд хамаарахгүй байх боломжтой.
Мөнгө угаах	Энэ нь ихэвчлэн үндсэн гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн хөрөнгийн хууль бус гарал үүсэл, ээмшил, хяналтыг нуун дарагдуулах, далдлах зорилгоор зохион байгуулсан үйлгээ, схемийг нотлох баримт шаарддаг.

[49] Үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэргийг яллах нь зарим улсын хууль эрх зүйн зохицуулалтын давхар гэмт хэргийн шаардлагыг хангахад хүндрэл учруулж болзошгүйг анхаарна уу. Дэлгэрэнгүй мэдээллийг 9-р бүлгийн 9.2.2-оос үзнэ үү.

Баримт бичиг хуурамчаар үйлдэх	Энэ нь хуурамч баримт бичиг нь хууль зүйн ач холбогдол, үр дагавартай болохыг нотлох баримт шаардаж болно. Бусад төрлийн баримт бичгийг ихэвчлэн хуурамчаар үйлдэх боломжгүй гэж үздэг. Зарим улс орнуудад нягтлан бодох бүртгэлийн зөрчил нь зөвхөн нийтлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн тайланд хамаардаг.
Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага	Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага бүх улс оронд байдаггүй эсхүл бүх төрлийн гэмт хэрэгт хамаарахгүй байж болно. Үндэстэн дамнасан томоохон компаниуд зэрэг хуулийн этгээдийн эсрэг ял тулгах үед удирдлагын гинжин хэлхээнд нэг шийдвэр гаргагчийг тодорхойлоход хэцүү байх магадлалтай.
Залилан	Удаан хугацааны туршид залилангийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд олон зуун, бүр хэдэн мянган хувь этгээдийн гэмт хэрэг үйлдэгдсан байж болзошгүй тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь төвөгтэй эсхүл хэцүү байдаг. Түүвэр эсхүл төлөөлөх хураамжийг ашиглах нь хураан авах ажиллагааны явцад сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй

Хэрэв шүүгдэгч оргон зайлсан бол төрийн байгууллагаас хоёр талт эсхүл олон талт хэлэлцээр болон хоёр улсын хууль тогтоомжийн дагуу гадаад улсаас шилжүүлэн авахыг бодолцон үзэх хэрэгтэй. Энэхүү ажиллагаа нь урт удаан бөгөөд хүндрэлтэй байдаг, нэн ялангуяа, шүүгдэгчийн шилжүүлэх гадаад улсын хуульд зааснаар тус ажиллагааг шүүхийн шийдвэрийг дагуу гүйцэтгэх шаардлагатай үед шүүхийн шийдвэрийг давж заалдах зэргээр сунжруулдаг байна.

Түүнчлэн шүүгдэгч шилжүүлэн өгөх улсаас гэмт хэргийн хүсэлтийн үндэслэлийг татгалзсан тохиолдолд, онцгой зарчим нь хүсэлт гаргасан улс орон тус мөрдөн шалгах эсхүл яллах ажиллагааг зогсоох хүргэж болзошгүй.[50] Албан хаагчид гадаад улсын байгууллагад гомдол гаргах (эрүүгийн эсхүл гэм буруутайд тооцолгүй гадаад улсаас хөрөнгө хураах зорилгоор) эсхүл дотоодын хууль тогтоомжийн хүрээнд гэм буруутайд тооцолгүй хөрөнгө хураах зэрэг өөр хувилбарыг хайж болно. Хэрэв шүүгдэгч нас барсан тохиолдолд, төрийн байгууллагаас өв залгамжлагчаас хувийн иргэний арга хэмжээ авах эсхүл дотоодын болон гадаадын гэм буруутайд тооцолгүй хөрөнгө хураах ажиллагааг гүйцэтгэж болно.

Хэрэв албан хаагч нь гэм буруутайд тооцох нотлох баримтын стандартад нийцсэн нотлох баримт дутмаг тохиолдолд хувийн иргэний арга хэмжээ авах эсхүл гэм буруутайд тооцолгүй хөрөнгө хураах ажиллагаа гүйцэтгэхэд хангалттай нотлох баримт байгаа эсэхийг судлах шаардлагатай.(нотлох баримтын стандартыг 2.8.5 дахь хэсгээс харна уу)

2.11 Хэргийн менежмент

Үр ашиг, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд гэмт хэрэгтнүүдэд зохих ёсоор хариуцлага хүлээлгэх, нотлох баримтыг зохих ёсоор цуглуулж, хууль сахиулах байгууллагаас прокурор, прокуророос шүүхэд шилжүүлэх, мөн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхийг хангахад чиглэсэн бодлого, журмыг гэмт хэрэгтний эрхийг хохироолгүй хэрэгжүүлэх нь чухал юм. Нууцлал, зохих журмын шаардлагыг дагаж мөрдөхгүй байх нь дотоодын хэргийг хүчингүй болгох, итгэл үнэмшил алдагдах, гадаад улстай олон улсын хамтын ажиллагаа гүйцэтгэх боломжгүй байдал үүсгэж болзошгүй юм. Томоохон нарийн төвөгтэй мөрдөн шалгах ажиллагааны

[50] Мэргэшлийн зарчмын талаар дэлгэрэнгүйг Эрх зүйн харилцан туслалцааны шаардлагын тухай 9-р бүлгийн 9.2.2-оос үзнэ үү.

явцад нотлох баримт цуглуулах, нэгтгэх, аюулгүй байдлын менежментийг хариуцах тусгай албан хаагчдыг томилохыг зөвлөдаг. Чухал бодлого, журмын зарим жишээг доор авч үзэв.

2.11.1 Стратегийн төлөвлөлт ба манлайлал

Хэдий хэргийн эхэнд стратегийг боловсруулдаг боловч эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргах үйл явц нь байнгын бөгөөд урсгалтай байх ёстой. Хөрөнгө хураан авах үйл явцын аль ч мөчид урьдчилан тооцоолоогүй хүндрэл, сорилтууд гарч болзошгүй бөгөөд мөрдөн шалгах шинэ арга эсхүл өөр эрх зүйн хэрэгсэл хайхыг шаардаж болно.

Уян хатан байдлыг хангахын тулд хэргийг байнга хянаж бодлого тодорхойлогчид, прокуророууд, эцэст нь мөрдөн шалгах шүүгчид болон бусад оролцогч байгууллагуудыг нэгтгэх ёстой. Эдгээр уулзалтууд нь сүүлийн үеийн шийдвэр, тэдгээрийн үндэслэлийг нарийвчлан харуулсан нарийн, шинэчлэгдсэн, үнэн зөв тайлан, эсхүл бүртгэлд үндэслэсэн байх ёстой бөгөөд болзошгүй сорилт, боломжуудыг урьдчилан таамаглахад цаг зарцуулах шаардлагатай. Олон орнууд хурал зохион байгуулах, эцсийн шийдвэр гаргах, нөөц бололцоог хангах зэрэг үйл ажиллагааг хариуцах нэг хэргийн менежерийг томилох нь ашигтай гэж үздэг.

2.11.2 Хугацаа ба зохицуулалт

Мөрдөн шалгах ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг эд хөрөнгө тарах эсхүл хөдлөх, холбогдогч зугтахаас зайлсхийхийн тулд хойшлуулашгүй арга хэмжээ, баривчлах ажиллагаатай уялдуулан хэргийг төлөвлөх хэрэгтэй. Тийм ч учраас албан бус хамтын ажиллагаа (8-р бүлэгт онцолсон) үргэлж олон улсын мөрдөн шалгах ажиллагааг амжилттай явуулах түлхүүр болдог.

Хөрөнгө хураах ажиллагаанд хөрөнгийн менежментийн асуудлыг төлөвлөлтийн нэг хэсэг болгон үнэлэх ёстой. Мөн томоохон гэрч, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, өмгөөлөгч, шүүгчид олны анхаарлын төвд байгаа хэргүүдийн аюулгүй байдлыг хангах механизмтай байх ёстой. Энэхүү зохицуулалт нь мөрдөн шалгах ажиллагааны эхний үе шатанд онцгой чухал, учир нь үндсэн мэдээлэл цуглуулах, бичиг баримт хүсэх, гэрчүүдээс мэдүүлэг авах, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээх зэрэг олон хүчин чармайлт нь боломжит зорилтуудыг сэрэмжлүүлж, баримтат нотлох баримтыг устгах, нуун дарагдуулах, нөлөөлөх, улс төрийн дэмжлэг авах, гадаад улс руу зугтах боломжийг олгодог.

Мөрдөн байцаалтын эхний үе шатанд, тухайлбал, биет болон цахим тандалт хийх, цахим харилцаа холбоо, олон нийтийн сүлжээг хянах, шуудан, хогийн савыг шалгах, мэдээлэгчийг ашиглах зэрэгт мөрдөн шалгах далд аргуудыг болгоомжтой сонгох замаар энэ эрсдлийг байнга үнэлж, багасгах хэрэгтэй. Илүү илэрхий арга техник шаардлагатай үед (байшин, аж ахуйн нэгжид нэгжлэг хийх, бичиг баримт хураан авах, гэрчүүдээс мэдүүлэг авах зэрэг) эдгээр үйл ажиллагааг баривчлах, таслан зогсоох, хөрөнгө хураах хугацаатай уялдуулах талаар бодох нь чухал.

Нэмж дурдахад, туршлагатай мөрдөгчид мэдүүлэг авах нь санхүүгийн нарийн төвөгтэй мөрдөн шалгах ажиллагаанд давуу тал болно.

2.11.3 Хэргийн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх нь

Хөрөнгийн буцаах мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сан нь ашиг тустай байж болох юм. Тухайлбал, Их Британийн Хөрөнгийн нөхөн сэргээх нэгдсэн мэдээллийн сан (JARD) нь гэмт хэргийн үндэсний агентлагийн удирддаг, эрүүгийн эрх зүйн тогтолцооны эд хөрөнгийг буцаах мэдээллийг агуулсан мэдээллийн сан юм. JARD-ийн бүртгэлийг цагдаа, прокурорын алба, онц ноцтой залилангийн алба, орон нутгийн засаг захиргаа зэрэг хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл бүрдүүлдэг. Тохиолдол гарах тусам өгөгдөл байнга өөрчлөгддөг; зарим шинэ хэрэг нэмэгдэж байхад зарим нь шийдэгдэж байна.[51]

Хэрэгт хамаарах хугацаа, тухайлбал, ял оноох эсэх шийдвэрийг хөөн хэлэлцэх хугацаанд гаргаж, түр хугацаагаар хорих, сэжигтнийг цагдан хорих болон бусад хойшлуулашгүй ажиллагаа гүйцэтгэх зэрэг баримтуудыг бүрдүүлэх ёстой. Мөн хэрэгт авагдсан эд хөрөнгө, санхүүгийн гүйлгээний урсгалыг харуулсан график, гэмт хэргийн орлогын тооцооны тайлбар (дотоодын хууль тогтоомжийн дагуу хийгдсэн), мэдүүлэг болон баримт бичгийн хураангуйг хавтаст хэрэгт хавсаргасан байна.

Нотлох баримтыг дугаарлаж, бүртгэж, битүүмжлэх, хадгалах хооронд цагдан хорих гинжин хэлхээний тэмдэглэлийн хамт хамгаалалттай газар хадгална. Хэдийгээр эдгээр бэлтгэл ажил нь цаг хугацаа их шаардаг бөгөөд хэргийг боловсруулахад саад болж байгаа мэт боловч нотлох баримтын бүрэн бүтэн байдал эсхүл бүртгэлийг хангахад зайлшгүй шаардлагатай. Хавсралт L нь үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хэргийн баримт бичгийг зохион байгуулах талаар Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрах санаачлагын удирдамжийг харуулав.

Тайлан бичих нь эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны чухал хэсэг боловч ихэнхдээ үл тоомсорлодог эсхүл бага ач холбогдолтой байдаг. Гэсэн хэдий ч хөрөнгө буцаах мөрдөн шалгах ажиллагааны явцад ажиллагаа урт, нарийн төвөгтэй, олон орныг хамарсан байж болох тул энэ нь илүү чухал ач холбогдолтой юм. Нарийвчлалтай, цаг тухайд нь, товч тайлан бичих нь жишээлбэл, нотлох баримт авах хүсэлтэд нотлох баримтын шаардлагыг хангахад шаардлагатай суурь мэдээллийг боловсруулахад тусална. Албан хаагчид мөрдөн шалгах ажиллагааны явцад болон чухал үйл явдлуудын дараа олж мэдсэнээ үе үе баримтжуулж байх нь зайлшгүй чухал юм. Тайлангууд нь тодорхой бөгөөд товч бичигдсэн байх ёстой (тайлбарласан үйл явдалтай нэг өдөр байвал зохимжтой) бөгөөд холбогдох бүх мэдээлэл, үйл явдлыг багтаасан байх ёстой. Тэдгээрийг хянагч нь аль болох хурдан хянаж, батлах ёстой.

2.11.4 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр илэрсэн мэдээллийг шийдвэрлэх нь

Авлигын хэрэг, тэр дундаа өндөр албан тушаалтнуудтай холбоотой хэргүүд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн анхаарлыг ихээхэн татах магадлалтай. Албан хаагчид эдгээр асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байх ёстой, эс тэгвээс нууц мэдээллийг санамсаргүйгээр задруулах нь хэргийн хувьд гамшигт үр дагаварт хүргэж болзошгүй юм.

[51] "Хөрөнгийн буцаан авах ажиллагааны статистикийн товхимол, 2011/12–2016/17." Статистикийн эмхэтгэл 15/17 (2017 оны 9-р сар)

Ихэнх улс орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах хариуцлага нь ерөнхий прокурор эсхүл холбогдох төрийн байгууллагын удирдлага (жишээлбэл, олон нийттэй харилцах, боловсон хүчин, хууль зүйн газар) хариуцдаг. Ихэвчлэн орон нутгийн оффисын ахлах албан тушаалтан, эсхүл томоохон тохиолдолд багийн ахлах гишүүнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбоо барих цэгээр томилдог. Эдгээр хүмүүс зохих ёсоор бэлтгэгдсэн байх ёстой бөгөөд хэвлэлийн мэдээ, бага хурлаар дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр хандах арга зам, мөрдөн байцаалтын явцад илчлэгдэж болох мэдээллийн төрлүүд, үндэсний түншүүдтэйгээ хамтран ажиллах зэрэг холбогдох заавар, журмуудыг (хэрэв байгаа бол) мэддэг байх ёстой. Зарим тохиолдолд албан хаагчид шүүхийн тогтолцоо хэрхэн ажилладагийг тайлбарлаж чадах процессын (бодит бус) мэдээлэл авах холбоо барих цэгийг томилох нь тустай гэж үзсэн.

Эцэст нь зорилтот этгээдийн эсрэг хууль ёсны арга хэмжээ авахыг хориглох аливаа мэдэгдлээс зайлсхийх хэрэгтэй. Зарим тохиолдолд албан хаагчид хэвлэл мэдээллийн хэрэгслийг олон нийтийн дэмжлэгийг авах арга хэрэгсэл гэж үзэж болох ч энэ төрлийн харилцаа холбоог холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын хүрээнд зөвшөөрч, явуулахыг баталгаажуулах ёстой.[52]

Ном зүй

BEIS (Department for Business, Energy & Industrial Strategy, Government of the United Kingdom). 2017. “Register of People with Significant Control: Guidance for People with Significant Control over Companies, Societates Europaeae, Limited Liability Partnerships and Eligible Scottish Partnerships.” London: The Stationery Office. https:// assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment _data/file/753028/170623_NON-STAT_Guidance_for_PSCs_4MLD.pdf.

CCFD (Catholic Committee against Hunger and for Development). 2007. Biens mal acquis … profitent trop souvent: La fortune des dictateurs et les complaisances occidentales [Ill-Gotten Goods . . . Too Often Do Benefit: Western Complacency and the Wealth of Dictators]. [In French] Report, Studies and Advocacy Department, CCFD, Paris. https://web.archive.org/web/20081123194925/http://www.ccfd.asso.fr/e_upload /pdf/biens-mal-acquis.pdf.

Chaikin, David. 2010. “International Anti-Money Laundering Laws: Improving External Accountability of Political Leaders.” U4 Brief 2010:4, Chr. Michelsen Institute, Bergen, Norway. https://www.cmi.no/publications/file/3775-international -anti-money-laundering-laws-improving.pdf.

Chaikin, David, and Jason C. Sharman. 2009. Corruption and Money Laundering: A Symbiotic Relationship. New York: Palgrave Macmillan. https://www.palgrave.com / gp/book/9780230613607.

COE (Council of Europe). 2018. “Report of the Independent Investigation Body on the Allegations of Corruption with the Parliamentary Assembly.” Report, COE, Strasbourg, France. http://assembly.coe.int/Communication/IBAC/IBAC-GIAC-Report -EN.pdf.

[52] Тухайлбал, Бразилийн Лава Жатогийн (машин угаалга) дагалдагч нар олон нийтийн дэмжлэг авах зорилгоор хэвлэлийг ашигласан. Хэдийгээр хэвлэлд мэдээлэл задруулах нь зарим нэг ноцтой санаа зовоосон асуудал үүсгэж болох ч “Илчлэлтүүдийн байнгын урсгал нь олон нийтийг сонирхож, намын удирдагчдыг хамгаалалтанд байлгадаг” (Гилберт 1995, 134–35)

DOJ and SEC (US Department of Justice and US Securities and Exchange Commission). 2012. "FCPA: A Resource Guide to the U.S. Foreign Corrupt Practices Act." Guide produced by the DOJ Criminal Division and the SEC Enforcement Division, Washington, DC. https://www.sec.gov/spotlight/fcpa/fcpa-resource-guide.pdf.

ESI (European Stability Initiative). 2012. "Caviar Diplomacy: How Azerbaijan Silenced the Council of Europe, Part 1." Report,

ESI, Berlin. https://www.esiweb.org/pdf/esi _document_id_131.pdf. ESI (European Stability Initiative.) 2016. "The European Swamp (Caviar Diplomacy, Part 2): Prosecutors, Corruption and the Council of Europe." Report, ESI, Berlin. https://www.esiweb.org/pdf/ESI%20-%20The%20Swamp%20-%20Caviar%20Diplomacy%20Part%20two%20-%2017%20December%202016.pdf.

FATF (Financial Action Task Force). 2012. "Best Practices on Confiscation (Recommendations 4 and 38) and a Framework for Ongoing Work on Asset Recovery." Best Practices Paper, FATF and Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents /reports/Best%20Practices%20on%20%20Confiscation%20and%20a%20 Framework%20for%20Ongoing%20Work%20on%20Asset%20Recovery.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations." Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents /recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

FDFA (Swiss Federal Department of Foreign Affairs). 2016. "No Dirty Money: The Swiss Experience in Returning Illicit Assets." Booklet, FDFA, Bern. https://www.eda.admin.ch/dam/eda/en/documents/aussenpolitik/voelkerrecht/edas-broschuere-no-dirty-money_EN.pdf.

Gilbert, Mark. 1995. The Italian Revolution: The End of Politics, Italian Style? Boulder, CO: Westview Press.

Greenberg, Theodore S., Linda M. Samuel, Wingate Grant, and Larissa Gray. 2009. Stolen Asset Recovery: A Good Practices Guide for Non-Conviction Based Asset Forfeiture. Washington, DC: World Bank. http://siteresources.worldbank.org / FINANCIALSECTOR/Resources/Stolen_Assest_Recovery.pdf.

Home Affairs Committee. 2016. "Proceeds of Crime, Fifth Report of Session 2016–2017." Report of the Home Affairs Committee printed June 29, 2016, by authority of the House of Commons, UK Parliament, London. https://publications .parliament.uk/pa/cm201617/cmselect/cmhaff/25/25.pdf.

IACAC (Inter-American Convention against Corruption) (B-58), adopted at the Organization of American States (OAS) Specialized Inter-American Conference, Third Plenary Session, March 29, 1996, Caracas, Venezuela, RB. http://www.oas.org / en/sla/dil/docs/inter_american_treaties_B-58_against_Corruption.pdf.

Muzila, Lindy, Michelle Morales, Marianne Mathias, and Tammar Berger. 2012. On the Take: Criminalizing Illicit Enrichment to Fight Corruption. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star / files/on_the_take_criminalizing_illicit_enrichment_to_fight_corruption.pdf.

OECD (Organisation for Economic Co-operation and Development). 2016. “Typologies on the Role of Intermediaries in International Business Transactions: Final Report.” Report of the Working Group on Bribery in International Business Transactions, Directorate for Financial and Enterprise Affairs (DAF) Anti-Corruption Division, OECD, Paris. https://www.oecd.org/daf/anti-bribery/43879503.pdf.

Perdriel-Vaissиre, Maud. 2017. “France’s Biens Mal Acquis Affair: Lessons from a Decade of Legal Struggle.” Paper, Legal Remedies for Grand Corruption series, Open Society Foundations, New York. https://www.justiceinitiative.org/uploads/8e7d1268-b5fb-44cf-b549-bc0ed6500667/legal-remedies-11-perdriel-20170612.pdf.

Ribeiro, Fausto de Assis. 2017. “The Accidental Trojan Horse: Plea Bargaining as an Anticorruption Tool in Brazil.” Working Paper No. 627, International Institute of Social Studies of Erasmus University Rotterdam (ISS), The Hague, Netherlands. https://repub.eur.nl/pub/97967.

Rossi, Ivana M., Laura Pop, and Tammar Berger. 2017. Getting the Full Picture on Public Officials: A How-To Guide for Effective Financial Disclosure. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star / files/getting-the-full-picture-on-public-officials-how-to-guide.pdf.

Scottish Government. 2017. “CashBack for Communities: Annual Report 2017.” Program report, Scottish Government, Edinburgh. https://cashbackforcommunities .org/wp-content/uploads/2017/11/CashBack-Annual-Report-2016-17-Final.pdf. Stephenson, Kevin M., Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabrielle Dunker, and Melissa Panjer. 2011. Barriers to Asset Recovery: An Analysis of the Key Barriers and Recommendations for Action. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star/files/Barriers%20to%20Asset%20Recovery.pdf.

TI Italia (Transparency International Italia). 2016. “Impact of Statutes of Limitation in Corruption Cases Affecting EU Financial Interests: A Comparative Report.” Report, TI Italia, Milan. https://www.transparency.it/wp-content/uploads/2017/01 /TI_Report_Prescrizione.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc.org / pdf/convention_1988_en.pdf.

UNTOC (United Nations Convention against Transnational Organized Crime), UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25.

UNODC (United Nations Office on Drugs and Crime). 2015. “Digest of Asset Recovery Cases.” Digest by the UNODC Corruption and Economic Crime Branch, United Nations, New York. https://www.unodc.org/documents/corruption/Publications /2015/15-05350_Ebook.pdf.

Wilson Center. 2017. “Dr. Rodrigo Janot on the Role of Plea Bargains in the Fight Against Corruption in Brazil.” Event Summary, July 2017, The Brazil Institute, Wilson Center, Washington, DC. https://www.wilsoncenter.org/sites/default/files /janot_summary_0.pdf.

3.Нотлох баримтыг хамгаалах болон Хөрөнгийг мөшгих (1): Мөрдөн шалгах ажиллагааны арга замууд

3.1 Удиртгал

Хөрөнгө буцаан авах ажиллагааны өмнө тулгамдаж байгаа асуудлуудын нэг нь хууль бус хөрөнгийг гэмт хэрэг үйлдэн олж авсан болохыг нотлох баримттай холбох (өмч-суурьтай хураан авах ажиллагаа), эсхүл гэмт хэрэг үйлдэн олж авсан хөрөнгийн хэмжээг тодорхойлох (үнэлгээнд суурилсан хураан авах ажиллагаа) асуудал юм.[1] Энэхүү холбоосыг ("холбоо" эсхүл "цаасан мөр" гэж нэрлэдэг) тогтоохын тулд салбарын мэргэжилтнүүд гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгийг олж тогтоох, тодорхойлох, байршлыг тогтоох хүртэл “мөнгийг дагах” аргаар ажиллах ёстой.

Гэсэн хэдий ч хууль бус аргаар олж авсан хөрөнгийг оффшор төвүүд, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, зуучлагчид, "сүрлэн хүмүүс" болон санхүүгийн төрөл бүрийн гүйлгээг ашиглан мөнгө угаах, энэ холбоосыг бүдгэрүүлэх схемийг ашиглан хөрөнгийг дэлхий даяар шилжүүлсэн байдаг. Мөн хөрөнгө нөхөн төлүүлэх ажиллагааны явцад үйлдэх баримт бичиг их гардаг тул цаг хугацаа их шаардагддаг, төвөгтэй, олон төрлийн техникийн ур чадвар шаарддаг. Иймд салбарын мэргэжилтнүүд дараах чадвартай байх ёстой:

- Уламжлалт мөрдөн байцаалтын аргаар холбогдох мэдээллийг олж авах
- Дотоодын болон гадаадын нээлттэй эх сурвалжаас авч болох мэдээллийг бүрэн ашиглах
- Гэрч эсхүл зорилтот бүлгийн этгээдийн ярилцлагаар дамжуулан нотлох баримтыг олж авах;
- Агуулгын болон нөхцөл байдлын нотлох баримт цуглуулах;
- Санхүүгийн байгууллагаас ямар мэдээлэл авч болдогийг ойлгох;
- Банкны хуулга, бизнесийн бүртгэл, санхүүгийн баримт бичиг, гэрээнд дүн шинжилгээ хийх;
- Эцсийн ашиг хүртэгч эздийг тодорхойлох;
- Гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай харилцан ажиллах;
- Мэдээллийг цаг алдалгүй, иж бүрэн, уялдаатай цэгцлэх

Үүнээс гадна салбарын мэргэжилтнүүд нотлох баримтыг олж авах эсхүл хэргийг шийдвэрлэхэд хууль эрх зүйн ямар арга хэрэгсэл хэрэглэхээ эхнээсээ ойлгож ажиллах хэрэгтэй, тухайлбал гэм буруугийн хэлэлцээр хийх, мөрдөн байцаалтын

[1] Өмч, үнэлгээнд суурилсан хураан авах тогтолцооны талаар 7-р бүлгийн 7.3-аас үзнэ үү.

ажиллагаа явуулах өргөн хүрээний талуудыг тодорхойлох (санаатайгаар мэдээгүй мэт дүр эсгэсэн байдлыг мөрдөн шалгах гэх мэт).[2]

Энэхүү гарын авлагын 3 болон 4-р бүлгүүдэд салбарын мэргэжилтнүүд хөрөнгө олж илрүүлэх, санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, түүнчлэн хөрөнгийг нөхөн төлүүлэх тохиолдолд найдвартай, зөвшөөрөгдөх нотлох баримтыг баталгаажуулахад ашиглаж болох зарим арга техникийг танилцуулна. Энэхүү аргуудыг мөрдөн байцаалтын шатанд байгаа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, нотлох баримт цуглуулахад ашиглаж болно.

Олон улсад хэрэглэгддэг төрөл бүрийн мөрдөн байцаалтын арга техникүүдийн талаар дараачийн хэсгүүдэд тайлбарлана.[3] Гэхдээ хэргийн харьяалал нь эдгээр аргуудын заримыг ашиглахыг хязгаарлаж эсхүл заримыг нь зөвшөөрөхгүй байж болно. Үүнээс гадна шүүхээс урьдчилан зөвшөөрөл авах эсхүл тусгай журам хэрэглэх зэргээс хамаарч харьяалал өөр өөр байх болно.

Ихэвчлэн албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд (жишээлбэл, нэгжлэг хийх, банкны дансны мэдээлэлд нэвтрэх, цахим хяналт тавих гэх мэт) зарим төрлийн урьдчилсан зөвшөөрөл авах шаардлагатай байдаг бол албадлагын бус арга хэмжээ авах тохиолдолд, жишээ нь олон нийтэд нээлттэй мэдээлэл ашиглах, тагнуул болон бусад төрийн байгууллагуудаас мэдээлэл гаргуулан авахад урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй юм. Салбарын мэргэжилтнүүд нь хуулиар зөвшөөрсөн арга техникийг тодорхойлж, хууль эрх зүйн үүднээс тавигдсан шаардлага, бодлого, журмыг дагаж мөрдөхийг баталгаажуулах зайлшгүй шаардлагатай. Мөрдөн байцаалтын явцад хэргийн тулгуур болох эх нотлох баримтыг хадгалах гинжин хэлхээг хадгалж үлдэхийн тулд зохих протоколуудыг дагах ёстой. Ингэснээр хууль ёсны дагуу олж авсан нотлох баримтыг шүүхийн ажиллагааны явцад хүлээн зөвшөөрүүлэх боломжтой гэдгийг эрх бүхий байгууллагад нотлох боломжтой юм.

Олон улсад эрх зүйн харилцан туслалцаа хүссэн тохиолдолд яллагдагчийн эрх, эрх зүйт төрийн үндсэн зарчим зэргийг хангаж ажиллах нь чухал. Хуулиар тавьсан шаардлага, бодлого, журмаас хазайх эсхүл яллагдагчийн эрхийг зөрчих нь олж илрүүлсэн нотлох баримтыг, магадгүй бүхэл бүтэн мөрдөн байцаалтын ажиллагааг ч хүчингүй болгож, хүлээн зөвшөөрөх боломжгүй болоход хүргэж болзошгүй тул заавал хэрэгжүүлэх шинж чанартай байна. Яллагдагчийн олон улсын баримт бичгүүдээр баталгаажсан дараах эрхүүдийг хангах ёстой: шүүхэд хандах эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх, гэм буруугүйг таамаглах, хувийн нууцыг хамгаалах эрх, өмчлөх эрхийг хамгаалах (Attisso 2010, 11).

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гаднын хуулийн байгууллагууд яллагдагчийн эрхийг зөрчсөн хэмээн үзвэл албан бус хамтын ажиллагаа, эрх зүйн

---

[2] Зарим харьяалалд хөрөнгө мөрдөх чиг үүрэг бүхий мөрдөгч нарын мэргэшсэн нэгжүүдийг бий болгодог харин бусад мөрдөгчид эрүүгийн гэмт хэрэг, хууль бус үйлдэлтэй холбоотой нотлох баримт цуглуулахад анхаарлаа хандуулдаг. Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа эсвэл хөрөнгийг мөшгөх мөрдөн шалгах явцад хохирол учруулахгүйн тулд мөрдөгчид нягт хамтран ажиллах ёстой.

[3] Эдгээр бүлгүүд нь техник тус бүрийг хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй заавар өгөх зорилго агуулаагүй. Илүү нарийвчилсан зааварчилгааг онлайнаар болон номын сан, номын дэлгүүр зэрэг олон нийтэд нээлттэй эх сурвалжаас авах боломжтой. Үүнээс гадна, дотоод, гадаадын байгууллагууд хэрэгцээ шаардлагад тохирсон заавартай байдаг бөгөөд эдгээрийг эх сурвалж болгох боломжтой.

туслалцаа харилцан (MLA) үзүүлэх зэргээс татгалздаг.[4] (Мөн зохих журмын дагуу татгалзах үндэслэлүүдийн талаар 9 дүгээр бүлгийн 9.2.5-ыг үзнэ үү)

3.2 Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нь

Хулгайлагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх нарийн төвөгтэй хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны үед хэргийн бодит байдлыг тогтоохын тулд уламжлалт таван асуултад (Зураг 3.1) хариулах шаардлагатай. Хэн, юу, хаана, хэзээ, яаж? Мөрдөн байцаалтын төлөвлөгөө нь эдгээр асуултад хариулт өгөх замаар, мэдээлэл, нотлох баримтыг үр ашигтай, иж бүрэн цуглуулах хүрээг тодорхойлдог. Хөрөнгийг үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд авлига, мөнгө угаах зэрэг гэмт хэргийн мөрдөн байцаалтын явцад хөрөнгийг мөшгөх нь хамгийн чухал. Мөрдөн байцаалтын төлөвлөгөөг боловсруулах нь эхний чухал алхам бөгөөд ихэвчлэн авлига, түүнтэй холбоотой мөнгө угаах, эсхүл хоёуланг нь шалгах чиглэлийг боловсруулах эсэхээ шийдвэрлэх шаардлагатай болдог. Эхний ээлжид салбарын мэргэжилтнүүд авлигын гэмт хэргийг шалгаж, дараа нь гэмт хэргийн орлого, хэрэгслийг олж илрүүлэхийн тулд мөнгөний мөрөөр мөшгөнө. Дараагийн ээлжид мөрдөгчид санхүүгийн гүйлгээнд дүн шинжилгээ хийж, авлига, эсхүл бусад гэмт хэрэгтэй холбоотой эсэхийг тогтооно.

Суурь баримтууд нь байнга өөрчлөгдөж байдаг тул мөрдөн байцаалтын төлөвлөгөө ч үүнтэй адил байнга өөрчлөгддөг. Хууль эрх зүйн арга замууд; мөн мөрдөгчид байгаа нөөц, цаг хугацаа, хэргийн урьдчилсан мэдээлэл зэргээс шалтгаалан тохирсон хандлагыг сонгох нь зүйтэй. Мөн хамтран ажилладаг олон улсын байгууллагуудтай албан бус сувгаар эртнээс харилцаж эхлэх нь зүйтэй.

Нарийн төвөгтэй хэргийг шалгах “Мөрдөн байцаалтын төлөвлөгөө” нь мөрдөн байцаалтын болон хууль эрх зүйн үйл ажиллагааны үе шат бүрийн стратегийг ерөнхийд нь тодорхойлох бөгөөд үүнд дараах зүйлсийг багтаана.

- Чухал үе шатуудын дараалал, цаг хугацаа (жишээлбэл, түр захирамж гаргах хүсэлт, албадлагын эрх мэдлийг хэрэгжүүлэх, гол түншүүд эсхүл зорилтот этгээдээс мэдүүлэг авах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт илгээх, шүүн таслах ажиллагааг эхлүүлэх)
- Дээрх чухал арга хэмжээнүүдийг дуусгах хугацаа, тодорхой үйлдлүүдийн дараалал
- Хэрэгжүүлэх хугацаа
- Байгууллагууд болон тодорхой мөрдөгчийн үүрэг
- Албан болон албан бусаар хамтран ажиллах төлөвлөгөө, хэргийн харьяалал
- Мөрдөн байцаах ажилд шаардагдах төсөв, эх үүсвэр
- Юуг, ямар үнээр, хир хугацаанд олж авч болох талаарх үнэлгээ

[4] Эдгээр үндсэн эрхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966, 1976 онд хүчин төгөлдөр болсон) болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), түүнчлэн Хүний эрхийг хамгаалах конвенц зэрэг бүс нутгийн олон талт хэлэлцээрүүдийг үзнэ үү. (1950, 1953 онд хүчин төгөлдөр болсон).

ЗУРАГ 3.1 Хөрөнгө буцаан авахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааг хийх үед асуух 5 чухал асуулт

Хэн
- Хэн мөнгө хулгайлсан бэ?
- Хамтран оролцсон байсан бэ?

Юу
- Юу хулгайлсан бэ?
- Хэнээс хулгайлсан бэ?

Хаана
- Хөрөнгийг хаанаас хулгайлсан бэ?
- Хөрөнгийг хааш нь аваачсан бэ?
- Хөрөнгө одоо хаана байгаа

Хэзээ
- Хэргийг хэзээ үйлдсэн бэ эсвэл хэзээ мөнгө угаасан бэ?

Хэзээ
- Хөрөнгийг хэрхэн хулгайлсан бэ?
- Хөрөнгийг хэрхэн хөдөлгөсөн бэ?
- Хэрхэн буцааж авах ёстой вэ?

Эх сурвалж: Дэлхийн банк

Хэрэгт холбогдсон этгээд, компани, хөрөнгө, тэдгээрийн хоорондын холбоог тодорхойлох, үүний дараа хөрөнгө, санхүүгийн урсгалд дүн шинжилгээ хийх зэрэг тодорхой алхмуудыг төлөвлөгөөнд тусгана. (Жишээ нь: олон тооны компанийг дамжуулан үйлдсэн авлигын схем дэх санхүүгийн урсгалыг ойлгох ач холбогдлыг Бразилийн Лава Жатогийн хэргийн жишээгээр Шигтгээ 3.1-д харуулсан болно). Үүнээс гадна гэмт хэрэгт холбогдсон этгээд, тэдгээрийн гол хамтрагчид, хуулийн этгээд, (жишээлбэл: өмчлөлийн түүх, ашиг сонирхол шилжсэн байдал, үндсэн үйл ажиллагаа) хөрөнгө (эзэмшил, ашиг сонирхол шилжсэн байдал) зэргийн талаарх мэдээллийг хэргийг мөрдөн шалгах явцад байнга шинэчилж байх хэрэгтэй.

Салбарын мэргэжилтнүүд хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах явцад их хэмжээний бичиг баримт үйлддэг тул тухайн хэргийн шинж чанараас хамааран тодорхой төрлийн баримт, данс, цаг хугацаа зэргийг эрэмбэлэх шаардлагатай байдаг. Жишээлбэл, мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн байцаалтын явцад банкны данстай холбоотой бичиг баримтыг хамгаалах, олж авах, дүн шинжилгээ хийх аргаар мэдээллийг тайлбарлах, зураглах нь гэмт хэрэгтэн этгээд болон компаниудын хоорондын холбоог олж тогтоох, мөнгөний урсгалыг илрүүлэхэд тустай. Харин бэлэн мөнгөөр хээл хахууль өгсөн иргэний хэргийг мөрдөн байцаах үед хамгийн чухал нотлох баримт нь гэрчийн мэдүүлэг байж болно (бизнесийн хамтрагч, ажилтан, хөрш) эсхүл нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл байж болно. (эд хөрөнгийн эрхийн мэдээлэл, шүүхийн бүртгэл, татварын бүртгэл болон олон нийтийн сүлжээ г.м).

Салбарын мэргэжилтнүүд цаасан суурьтай хэргийн материал бүрдүүлэх нь хэргийн менежментэд хүндрэл учруулах, нэг хэрэг дээр ажиллаж буй олон тооны мөрдөгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байдаг зэрэг сул талтай. Хэргийн цахим удирдлагын систем (CMS) нь энэхүү асуудлыг шийдвэрлэх боломжтой. Ийм системийг мөрдөн байцаалтын үйл ажиллагаа, үндсэн өгөгдлийг хянах, бүртгэх төдийгүй баримт бичгийн цахим бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх, мэдээлэл гаргах үйл явцыг хөнгөвчлөх, илрүүлэх, задлах үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор өргөжүүлж болно. Энэхүү CMS систем нь дундын драйв дээр хайпер холбоос бүхий цахим баримт үүсгэх боломжтой ба энэ нь хэргийн материалыг бүхэлд нь нэг аюулгүй газар хадгалах боломжоор хангадаг. Дэлхийн Банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын (UNODC) Хулгайлагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх (StAR) санаачилга хамтран хэргийн удирдлагын тогтолцоог бий болгох, ашиглах зааварчилгааг боловсруулсан (Хавсралт L-ийг үзнэ үү).

Дараах дэд хэсгүүдэд хөрөнгө нөхөн төлүүлэх мөрдөн байцаалтын явцад анхаарах бусад чухал асуудлуудыг тусгасан.

ШИГТГЭЭ 3.1	Санхүүгийн урсгал ба холбоосын тухай ойлголт: Бразилийн Лава Жато (автомашин угаалга)-ын хэрэгт халхавч компаниудыг ашигласан тухай

Нөхцөл байдал: Бразил улсад гарсан Лава Жатогийн машин угаалгатай холбоотой хэргийн мөрдөн байцаалтын явцад авлигын дуулиантай хэрэгт холбогдсон тал, компани, хөрөнгийг олж тогтооход шаардлагатай арга хэмжээг авах, тэдний холбоосыг ойлгож, санхүүгийн урсгалд дүн шинжилгээ хийх нь чухал болохыг харуулсан. Энэ хэрэг нь Бразил улсад авлигын гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг угаах, эсхүл гадаад дахь хувь хүмүүс болон компанид мөнгө шилжүүлэхийн тулд зөвхөн Бразилд төдийгүй татварын диваажингийн харьяанд байдаг халхавч компаниудын цогц сүлжээг ашигласан авлигын томоохон схемтэй холбоотой юм. (Хэргийн талаар нэмэлт мэдээллийг 2-р бүлэг, 2.4, 2.11-ийг; 4-р бүлэг, 4.2-ыг; 5-р бүлэг, 5.5-ыг, 8-р бүлгийн 8.1-ийг үзнэ үү.)

Бразилийн халхавч компаниудыг ашигласан тухай: Бразилийн халхавчийн компаниуд хоёр төрлийн үүрэг гүйцэтгэсэн. Үүнд: Бразилийн дотоодын авлигын орлогыг угаах, гадаад дахь хувь хүн, компаниудад мөнгийг шилжүүлэх багтана. Үйлдлийн арга нь халхавч компаниуд болон Бразилийн барилгын компаниудын хооронд хуурамч гэрээ байгуулж зохиомол нэхэмжлэхээр мөнгө шилжүүлсэн нь тогтоогдсон. Угаасан орлогыг ихэвчлэн мөнгө угаах гэмт хэрэг үйлддэг хар захын дилерүүд болох ашиг хүртэгч валютын ченжид бэлнээр хүргэдэг байсан.[a] Сүүлдээ Бразилийн валютын хяналтыг тойрч гарахын тулд Бразилийн халхавч компаниудыг ашиглан валютын ченжтэй холбоотой оффшор компаниудтай хуурамч импортын гэрээ байгуулжээ.[b]

Оффшор дахь халхавчийн компанийг ашиглах: Гүйлгээ нь олон давхаргатай оффшор компаниуд болон банкны дансаар дамждаг тул авлигын схем улам боловсронгуй болсон. Эдгээр оффшор давхаргууд нь нэгдүгээрт Бразилийн барилгын компаниуд, хоёрдугаарт валютын ченжийн эзэмшдэг оффшор давхарга, гуравдугаар ашиг хүртэгч давхарга нь төрийн албан тушаалтан, улс төрчид байсан.

Оффшор бүсүүдийн үйл ажиллагааг энэ төрлийн хэрэгт холбогдсон Бразилд төвтэй дэлхийн хэмжээний хэд хэдэн оффшор компанийг өөртөө нэгтгэсэн барилгын компани болох Одебрехт компанийн жишээнээс харж болно. Тухайлбал: Смит ба Наш Инженеринг (Британийн Виржинийн арлууд[c], Аркадекс (Белиз); Голак төсөл ба барилга (Британийн Виржинийн арлууд); болон Хавинсур (Уругвай) - бүгд Швейцар дахь PKB Privatbank-д данстай байсан. Эдгээр оффшор бүсэд хамаарах Швейцарийн данснуудыг ашиглан Одебрехт дараа нь Constructora Internacional del Sur (Панама) Сагар Холдинг (Панам); Инновацийн судалгааны инженерчлэл ба хөгжил (Антигуа ба Барбуда); болон Клиенфельд үйлчилгээ (Антигуа ба Барбуда) гэх мэт валютын ченжийн нэгтгэсэн оффшоруудын хоёрдугаар давхаргад хамаарах банкны данс руу мөнгө шилжүүлсэн. Хариуд нь валютын ченж хоёр дахь давхаргын оффшор компаниудаас Quinus Services, Milzart Overseas Holdings, Pexo (бүгд Панамд бүртгэлтэй) зэрэг гуравдугаар давхаргын компаниудад мөнгө шилжүүлсэн. Оффшор компаниудын эцсийн ашиг хүртэгчид нь Petrobras-ын ажилтнууд байсан.[d]

Одебрехт компани дэлхий даяарх бизнесийн үйл ажиллагаандаа Лава Жатогийн авлигын арга барилыг хуулбарлан хэрэгжүүлсэн. Өөртөө давуу талыг бий болгохын тулд Одебрехт гадаад улсын төрийн албан тушаалтнуудад олон

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 3.1 Санхүүгийн урсгал ба холбоосын тухай ойлголт: Бразилийн Лава Жато (автомашин угаалга)-ын хэрэгт халхавч компаниудыг ашигласан тухай

давхар оффшор байгууллага, банкны дансны схемийг ашиглан мөнгө төлсөн. АНУ-ын Хууль зүйн яамны мэдээлснээр Одебрехт Ангол, Аргентин, Колумб, Доминикан, Эквадор, Гватемал, Мексик, Мозамбик, Панам, Перу, Боливарын Бүгд Найрамдах Венесуэл зэрэг 11 улсад авлигын гэмт хэрэг үйлдсэн. Зөвхөн Панамд л гэхэд Одебрехт төрийн албан тушаалтнууд болон тэдний өмнөөс ажилладаг зуучлагчдад 59 сая гаруй ам.долларын хахууль өгсөн гэж үздэг.[e]

Яллах болон хураан авах ажиллагаа: Панамын прокурорын байгууллагаас Лава Жатогийн хээл хахуулийн хэрэгт хийсэн мөрдөн байцаах ажиллагааны хүрээнд Рикардо Альберто Мартинелли, Луис Энрике Мартинелли (Панамын ерөнхийлөгч асан Рикардо Мартинелли Беррокалын хоёр хүү) нарыг Одебрехт компаниас 22 сая ам.долларын авлига авсан хэргээр ялласан байна. Швейцар улсын эрх баригчид ч энэ хэргийг шалгаж Мартинеллигийн хөвгүүдийн Швейцарийн банкны дансанд дахь 22 сая ам.долларыг хураан авчээ.

Одебрехт компани нь ах дүү Мартинеллигийн эзэмшдэг Кадайр Инвестментс (Британийн Виржиний арлуудад бүртгэлтэй) оффшор компаниудад төлбөр хийхдээ дээрх системтэй ижил оффшор компаниуд болон оффшор дансуудыг ашигласан байна. Кадайр Инвестментс нь Одебрехт -ээс Швейцар дахь "Banque Pictet" дахь дансандаа 1.8 сая ам. доллар, 2.26 сая ам. доллар, 3.2 сая ам доллар, 1.5 сая ам.доллар гэсэн дөрвөн удаагийн шилжүүлэг хүлээн авсан нь тогтоогдсон. Эдгээр шилжүүлгүүдийг Панам, Антигуа/Барбуда мужид бүртгэлтэй Трайдент Интер Трэйдинг, Инновац Судалгаа инженер хөгжил, Конструктора Интернэйшнл дел Сур, Клайнфилд Сервис гэсэн дөрвөн оффшор компаниар дамжуулан шилжүүлсэн нь тогтоогдсон.[f]

a. Тухайлбал, Бразилийн Холбооны Прокурорын албаны мэдээлснээр энэ үйл явал нь Сенпес хотод (Петробрас дахь Америко Мигес де Мелло судалгаа, хөгжлийн төв) барилга барихад тохиолдсон байна. Ажлыг гүйцэтгэх үүрэгтэй Ново Сенпес консорциум (OAS, Carioca Engenharia, Construbase Engenharia, Construcap CCPS Engenharia, Schahi Engenharia гэсэн таван барилгын компани) MRT Gestão Empresarial-тай гэрээ байгуулсан бөгөөд ямар ч үйлчилгээ үзүүлээгүй ч тус бүр нь 492,533.88 R$-ын дүн бүхий дөрвөн төлбөр нэхэмжлэхийн дагуу гаргасан байна. (Адир Асад, Агенор Медейрос нарт холбогдуулан 2016 оны 8-р сарын 9-нд гаргасан гомдлыг үзнэ үү, http://www.mpf.mp.br/pr/sala-de-imprensa/docs/denunciaabismo.pdf). Дараа нь Петробрас компанийн ажилтнууд болох Ренато Дуке, Педро Баруско, Пауло Адалберто Альбес Феррейра нарын цалинг бэлнээр олгоход дээрх хэмжээний мөнгийг зарцуулсан байна.

b. Бразилийн Холбооны Прокурорын албаны мэдээлснээр, Альберто Юсеф Леонардо Мейреллес, Педро Аргесе, Эсдра де Арантес, Рафаэл Флорес, Карлос Альберто нартай хамт дараах компаниудыг халхавчаар ашиглан валют солих хэлцлээр дамжуулан 444,659,188.75 ам.долларыг гадаадад шилжүүлсэн байна (ME гэдэг нь "бичил аж ахуйн нэгж" буюу EPP, "бичил бизнесийн байгууллага"-ыг илэрхийлж байна): Bosred Serviços de Informática - ME; Hmar Consultoria em Informática - ME; Labogem S/A Química Fina болон Biotecnologia; Indústria e Comércio de Medicamentos Labogem; Piroquímica Comercial - EPP; RMV & CVV Consultoria em Informática - ME; болон оффшор халхавч компаниуд нь DGX Imp. ба Exp. болон RFY Imp. Exp. (Fausto Macedo. 2014. "Justiça abre ação contra doleiro da lava jato" [Лава Жато Долейрод холбогдох иргэний хэргийг шүүхээс үүсгэсэн байна]. exame.com, 2014 оны 4-р сарын 23. https://exame.com/brasil/justica-abr e- acao-contra-doleiro-da-lava-jato/).

c. Хэргийн харьяаллыг аж ахуйн нэгжийн нэрийн ард хаалтад дурдсан болно.

d. Сезар Роча, Марсело Одебрехт нарт холбогдох гомдол, 2015 оны 10-р сарын 16.

e. Америкийн Нэгдсэн Улсаас Odebrecht S.A-ийн эсрэг, Гэм буруугийн тохиролцооны гэрээ, Cr. No16-643 (RJD) (F.#2016R00709), 2016 оны 12-р сарын 12, https://www.justice.gov/opa/press-release/file/919916/download.

f. Роландо Б.Родригес. 2017. "Ricardo y Luis Enrique Martinelli Linares Recibieron Millones de Odebrecht" [Рикардо, Луис Энрике Мартинелли Линарес нар Одебрехтээс сая саяыг хүлээн авсан]. La Prensa, 2017 оны 1-р сарын 23. http://impresa.prensa.com /panorama/Ricardo-Enrique-Martinelli-Linares-Odebrecht_0_4672782785.html

3.2.1 Ашиг хүртэгч эзэмшигчийн тухай

Ихэнх авлигын хэрэгт авлигачид өөрсдийн нэр дээр хөрөнгө, банкны дансыг бүртгүүлдэггүй. Үүний оронд тухайн албан тушаалтны ашиг хүртэгч өмчлөгчийн нэрийг далдлахын тулд хөрөнгөө бусад хувь хүн, компаниудын эзэмшилд өгдөг бөгөөд тэднийг тухайн хөрөнгө болон банкны дансыг эзэмшдэг, эсхүл хянадаг "натурал эзэмшигч" хэмээн нэрлэдэг. (Шигтгээ 3.2) Ийм учраас тэдний хамсаатнууд болон сэжигтэй арилжааны үйл ажиллагаа (ердийн бус хөрөнгө оруулалт, зээл, зөвлөхийн гэрээ, ашиг) -нд профайл үүсгэж дүн шинжилгээ хийх шаардлагатай байдаг. Мэргэжилтнүүд гэмт хэрэгт оролцож болзошгүй этгээдүүд болон банкны дансанд явцын шалгалтыг хийж байх нь чухал юм. Үүнд:

- Хамаатан садан, эхнэр, нөхөр, романтик хамтрагчид; бизнесийн түншүүд; найз нөхөд болон бусад ойр дотнын хүмүүс; гэрийн үйлчилгээний ажилчид хүртэл;
- Хувь эзэмшигч, зуучлагч, эсхүл “сүрлэн хүмүүс” – авлигачийн ятгалгаар эсхүл багахан хөлсөөр данс нээлгэн, хөрөнгө эзэмшиж авлигачийг нуун далдахаар ажиллаж буй этгээд;
- Хуулийн этгээд, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, сангууд зэрэг аж ахуйн нэгж. Зарим хуулийн этгээдийн жагсаалт, тайлбарыг Хавсралт B-ээс үзнэ үү.[5]

Хөрөнгийг санхүүгийн байгууллага эзэмшиж байгаа тохиолдолд тухайн дансыг ашиг олох зорилгоор эзэмшдэг "натурал эзэмшигч"-ийн нэрийг гаргаж өгсөн удаа байдаг.[6] Гэхдээ хуулийн этгээдээр дамжуулан эцсийн ашиг хүртэгч этгээдийг нуун далдалсан үед бүх банкнаас энэ төрлийн мэдээллийг олж авах боломжгүй. Банкны бүртгэлд хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудыг тусгах боловч эцсийн ашиг хүртэгч эзэмшигчийг тэр бүр илчилдэггүй. Данс нээсэн ажилтан ашиг хүртэгч эзэмшигчийг зааж өгсөн ч худал мэдүүлгээр авлигачийг нуун дарагдуулах боломжтой.

Эдгээр хязгаарлалтууд болон ихэнх хөрөнгөөс ашиг хүртэгч этгээдийн мэдээллийг оруулаагүй байдаг зэргийг харгалзан мэргэжилтнүүд тухайн хөрөнгийн бодит эзэмшигчид болох этгээд болон компаниудыг тодорхойлж, баримтаар нотлох арга хэмжээ авах шаардлагатай. Иймд мөрдөгч нь санхүүгийн байгууллагаас өгсөн баримт мэдээллийг шалгахдаа уламжлалт мөрдөн байцаалтын арга техникийг ашиглах эсхүл нээлттэй эх сурвалжийн мэдээллийг боловсруулах шаардлагатай юм.

---

[5] Авлигын томоохон хэргүүдэд (авлигын хэрэг болон орлого угаах тохиолдолд) хуулийн этгээдийг зүй бусаар ашиглах талаар ван дер Доес де Виллебоис тайлбарласан байдаг. (2011) at https://star.worldbank.org/sites/star/files/puppetmastersv1.pdf.

[6] Олон улсын хамтын нийгэмлэг нь санхүүгийн байгууллагуудаас харилцагч болон бодит өмчлөгчийг тодорхойлох, бизнесийн харилцааны мөн чанарын талаар мэдээлэл авах, улс төрийн нөлөөнд автсан хүмүүстэй харилцахдаа зохих шалгалтын арга хэмжээг сайжруулах шаардлагатай стандартуудыг баталсан байдаг. төрийн өндөр албан тушаалтнууд, тэдний гэр бүл, ойр дотнын хүмүүс.

ШИГТГЭЭ 3.2 Узбекистан: Гульнара Каримовагийн хэргийн халхавч компаниудын эцсийн өмчлөгч

АНУ-ын иргэний хөрөнгийн нэхэмжлэлд, Узбекистаны албан тушаалтан (Узбекистаны ерөнхийлөгч асны охин) Гульнара Каримова харилцаа холбооны компаниудын хувьцаанаас ашиг олохын тулд өөрийн мэдэлд байсан халхавч компанийг ашигласан ба хэсэг хугацааны дараа харилцаа холбооны компаниудад өндөр өртгөөр эргүүлэн худалдсан тухай дурдсан байдаг.[a]

Үүнээс гадна Каримовагийн эзэмшилд байдаг халхавч компаниуд харилцаа холбооны компаниуд болон тэдний охин компаниудтай хуурамч гэрээ байгуулж олон сая долларын авлига авах боломжийг бүрдүүлсэн. Эдгээр авлигын хариуд түүний халхавчийн компани өөрийн охин компанийг тодорхой хөрөнгийг эзэмших эрхээсээ татгалзахаар тохиролцож, эдгээр хөрөнгийг Узбекистан Улсад шилжүүлэх хүртэл халхавч компани харилцаа холбооны компаниудаас бүрэн төлбөр авахгүй байхаар тохиролцсон. Цаашилбал, халхавч компани нь харилцаа холбооны хоёр компанитай (VimpelCom болон TeliaSonera) олон сая долларын зөвлөхийн гэрээ байгуулж, Каримова засгийн газарт нөлөөгөө ашиглан тэдний үйл ажиллагаанд туслах замаар Узбекистан улсад томоохон авлигын ажиллагааг зохион байгуулжээ. (2-р бүлэг, Шигтгээ 2.9-д дэлгэрэнгүй авч үзсэн хэргийн нэг хэсэг).

a. Гомдол, United States v. All Funds Held in Account Number Ch1408760000050335300 (S.D.N.Y. 2016), https://www.justice .gov/opa/file/826636/download.

3.2.2 Холимог хөрөнгийн талаар анхаарах зүйлс

Санхүүгийн салбарт хөрөнгийг мөшгөхдөө авлигын орлогыг төрөл бүрээр шилжүүлэх боломжтой гэдгийг санах нь чухал: орлого нь гэмт хэрэгтэй холбоогүй бусад хөрөнгөтэй холилдож, хэлбэр нь өөрчлөгдөж, янз бүрийн сувгаар дамжиж урсгал нь өөрчлөгдөх боломжтой юм. Ийм орлого хэлбэрээ өөрчилсөн ч (жишээлбэл, нэг сая ам.долларыг нэг дансанд байршуулж, зарим хэсгийг нь дараа нь өөр банкны данс руу шилжүүлж эсхүл үл хөдлөх хөрөнгө худалдаж авахад ашигладаг) орлогын эцсийн хэлбэр буюу түүнтэй адилтгах үнийн дүнг хурааж болно.[7]

3.2.3 Түр авах арга хэмжээ

Мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн хөрөнгийг хураах, хязгаарлах түр зуурын арга хэмжээ авах боломжтой, бодитой эсэхийг мөрдөгчид байнга үнэлж байх ёстой. Зарим тохиолдолд тэд дансаа нээлттэй байлгаж шинээр сэжүүр илрүүлэхийн тулд хөдөлгөөнийг хянаж болно. Гэхдээ энэ арга хэмжээ нь сэжиг төрүүлэх эд хөрөнгийг тараах эсхүл шилжүүлэх эрсдэлтэй тохиолдолд түр зуурын арга хэмжээг авах талаар бодолцох хэрэгтэй.

7 Үүнтэй холбоотойгоор, улс орнууд хууль тогтоомждоо “хөрөнгө” буюу “өмч”, “гэмт хэргээс олсон орлого” гэсэн ойлголтыг өргөн хүрээнд тусгах нь чухал юм. НҮБ-ын АЭК-ийн UNCAC, 2(d) зүйлийг үзнэ үү. Мөн 7-р бүлгийн 7.3.1 хэсгээс (“Өмчид суурилсан хураан авах ажиллагаа”) холилдсон хөрөнгөний талаар дэлгэрүүлэн харна уу.

3.3 Хувийн хэрэг үүсгэх

Мөрдөн байцаалтын явцад хамгийн эхний чухал алхам бол сэжигтний хувийн хэргийг үүсгэх явдал юм. Салбарын мэргэжилтнүүд нэн тэргүүнд сэжигтэнтэй холбоотой бүхий л үндсэн мэдээллийг цуглуулж бүртгэдэг. Тухайлбал сэжигтнийг бүрэн тодорхойлсон мэдээлэл, түүний хэрэглэдэг нэр хоч мэдээллийг багтаана. Эдгээр мэдээллийг хэргийн материалд эмх цэгцтэй хадгалах ёстой. Олон харьяалалтай хэрэгт сэжигтний хувийн мэдээллийг гадаад орны холбогдох байгууллагатай хуваалцах шаардлага үүсдэг. Шигтгээ 3.3-т мөрдөн байцаалтын эхний үе шатанд салбарын мэргэжилтнүүдийн цуглуулах шаардлагатай мэдээллийн хяналтын хуудсыг оруулсан болно.

ШИГТГЭЭ 3.3	Сэжигтний хувийн хэрэгт оруулах шаардлагатай үндсэн мэдээллийн хяналтын жагсаалт

Хөрөнгө буцаах мөрдөн шалгах ажиллагааны эхний үе шатанд дараах мэдээллийг цуглуулж, хадгалах ёстой.

- Нэр (өөр хэрэглэдэг нэр хоч), сэжигтний төрсөн он сар өдөр, газар; төрсний гэрчилгээ болон паспорт, иргэний үнэмлэхийн хуулбар;
- Эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг эх, хамтран амьдрагч, (салсан эсхүл тусдаа гарсан), ах, эгч, дүү, ах, эгч, дүү нарын эхнэр нөхөр, ойрын хамаатан садан (авга эгч, нагац эгч, үеэл, өвөө, эмээ, ач зээ) тэдгээрийн эхнэр, нөхөр зэргийн төрсөн он, сар, өдөр, газар;
- Холбогдох утасны дугаар (бизнес, гэр, гар утас), и-мэйл хаяг болон бусад холбоо барих мэдээллийг - зарим улс орнуудад интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад (ISP) өгсөн захиалагчийн мэдээллээс авч болдог.
- Сэжигтэн болон хамсаатнуудын сүүлийн үеийн гэрэл зургууд (Засгийн газраас олгосон үнэмлэхийг оруулаад)
- Хурууны хээний карт
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэх лавлагаа
- Боловсролын гэрчилгээ, ажил эрхлэлтийн түүх, холбооны гишүүнчлэл
- Интернэт хайлтын систем, олон нийтийн мэдээллийн сайтууд, орон нутгийн болон олон улсын хэвлэл мэдээллийн мэдээллүүд, номын сангууд ашиглан сэжигтэн, түншүүд болон хамаарал бүхий компаниудын олон нийтийн сүлжээний эх сурвалжийн хайлтын үр дүн
- Төрийн байгууллагуудын мэдээлэл (3.4.2 дахь хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ)
- Тухайн сэжигтний холбогдох төрийн байгууллагаас олгосон цалингийн тодорхойлолт
- Худалдан авах гэрээ, ипотек, зээлийн өргөдөл, үнэлгээ зэрэг үл хөдлөх хөрөнгийн бүртгэл
- Бизнесийн бүртгэлтэй байж болох банк, банкны данс болон бусад байгууллагуудын тодорхойлсон мэдээлэл. Хадгалах тушаалыг мөн авч үзэж болно (Шигтгээ 3.10-д дэлгэрэнгүй үзнэ үү).

3.4 Санхүүгийн болон бусад мэдээлэл, нотлох баримтыг олж авах

Сэжигтнийг тодорхойлохын хирээр шүүхэд найдвартай, зөвшөөрөгдөх нотлох баримтыг гаргаж авахын тулд салбарын мэргэжилтнүүд эдгээр сэжигтнүүдийн талаарх нэмэлт мэдээлэл, санхүүгийн мэдээллийг олж авах шаардлагатай болно. Мөрдөн байцаалтын төлөвлөгөөнөөс хамааран санхүүгийн мэдээлэлд сэжигтний бизнесийн бүх хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг багтааж болно. Баримт бичгийн сэжүүрийг интернэт болон бусад олон нийтэд нээлттэй эх сурвалж зэрэг олон эх сурвалжаас цуглуулах боломжтой; төрийн байгууллагууд; санхүүгийн байгууллага, түүний дотор цахим банкны хэрэгсэл; мөнгөний үйлчилгээ үзүүлэгч; хуулийн болон нягтлан бодох бүртгэлийн компаниуд; итгэлцэл, компанийн үйлчилгээ үзүүлэгч; үл хөдлөх хөрөнгийн агентууд; урлагийн бүтээлийн худалдаачид; даатгалын компаниуд; бизнесийн өрсөлдөгчид; аялал болон бусад урамшууллын хөтөлбөрүүд; бизнес эрхлэгчид, хамаатан садан, ажилчид, зорилтот түншүүд; болон зорилтууд өөрсдөө (жишээ нь эх сурвалж нь тодорхойгүй хөрөнгийн тухай Шигтгээ 3.11-т үзнэ). Мөрдөн байцаалтын тодорхой аргыг сонгохдоо мөрдөн байцаалтын ерөнхий төлөвлөгөө эсхүл хамрах хүрээний нэг хэсэг (3.2-р хэсгийг үзнэ үү) хэмээн үнэлж, шаардлагатай бол дотоодын болон гадаадын хуулийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулна.

Салбарын мэргэжилтнүүд илүү төвөгтэй аргуудыг (утас чагнах гэх мэт) хэрэгжүүлэхээс өмнө хамгийн энгийн мөрдөн байцаалтын болон хөндлөнгийн бус аргуудыг (сэжигтний танилцуулгыг бэлтгэхийн тулд интернэт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр хайх, үндсэн мэдээлэл цуглуулах гэх мэт) ашиглах ёстой. Үүнээс гадна ил арга техник (хувь хүний нууцад халдан орон байранд нэгжлэг үзлэг хийх, нэгжлэг хийх зөвшөөрөл авах)-ийг хэрэгжүүлэхээс өмнө далд арга техникийг (биечилсэн хяналт, олон нийтэд нээлттэй мэдээлэл, олон нийтийн сүлжээний мэдээлэл хэрэгслээс хайлт хийх, бусад төрийн байгууллагуудаас мэдээлэл авах, хогийн сав шалгах) ашиглах талаар төлөвлөх хэрэгтэй. Онлайн болон олон нийтийн сүлжээний хэрэгслээр хайлт хийхдээ салбарын мэргэжилтэн өөрийн хувийн мэдээллээ хамгаалахын тулд нууцлалтай программ хангамж ашиглах шаардлагатайгаас гадна мөрдөн байцаалтын бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нууцлалыг хадгалж, анхаарал болгоомжтой байх, сэжиг авахуулахаас зайлсхийн ажиллах ёстой.

Салбарын мэргэжилтнүүд нэг төрлийн техникийг ашиглан сэжүүр гаргасны үндсэн дээр нэмэлт арга техник хэрэглэх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бизнесийн үйл ажиллагаа явуулдаг газар, эсхүл оршин суудаг газарт нэгжлэг хийснээр сэжигтний ашигладаг банктай холбоотой нотлох баримтыг илрүүлж болох бөгөөд ингэснээр банкны дансны мэдээллийг гаргуулан авах дараагийн шатны зөвшөөрөл хүсэх нөхцөл бүрдэх юм. Сэжигтний хөдөлгөөнд биечилсэн хяналт тавьж дундын зуучлагч этгээдүүдийг илрүүлэх боломжтой. Мөн “банкнаас мэдээлэл авах тухай шийдвэр”-ийг гаргуулан авснаар гүйлгээг хийхэд оролцсон банкны албан тушаалтан, хувь хүний талаарх мэдээлэл ил болох ба тэднээс мэдүүлэг авах замаар нэмэлт мэдээлэлтэй болох боломжтой юм. Мөрдөн байцаалтын арга техникийг практикт хэрхэн ашиглаж болох тухай жишээг Нигери улсын Мужийн захирагч Жошуа Дариегийн хэрэгт Их Британи Улсын мөрдөгчдийн ашигласан мөрдөн байцаалтын арга техникийг Шигтгээ 3.4-с үзнэ үү.

ШИГТГЭЭ 3.4 Их Британи: Жошуа Дариегийн хэрэгт ашиглагдсан мөрдөн шалгах ажиллагааны арга техник

Их Британи улсын хууль сахиулах байгууллагын ажилтнууд Нигери улсын Плато мужийн захирагч асан Жошуа Дариегийн авлига, эд хөрөнгө завшсан гэх хэргийн талаар мэдээлэл цуглуулж байх явцад хөрөнгөө Их Британид байршуулсан байж магадгүй гэж сэжиглэжээ. Дараах мөрдөн байцаалтын аргуудыг хэрэглэснээр эцэст нь эд хөрөнгийг илрүүлж, гэмт хэрэгтэнтэй холбоотой болохыг тогтоосон байна.

1. ***Техник.*** мөрдөгчид Дариегийн талаарх мэдээллийг Их Британийн улсын бүртгэлээс хайсан (хөрөнгө, тээврийн хэрэгсэл, аж ахуйн нэгжийн бүртгэлээр дамжуулан). Тэд мөн Их Британийн Санхүүгийн тагнуулын алба (FIU) зэрэг Засгийн газрын бусад агентлагуудаас мэдээлэл авах хүсэлтийг хүргүүлсэн. Санхүүгийн тагнуулын албаны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 3.4.2-оос үзнэ үү.
   Үр дүн. Дариед холбогдох мэдээлэл олдоогүй.
2. ***Техник.*** Мөрдөгчид Дариегийн гэр бүл, хамтрагчдыг илрүүлж, Их Британитай холбоотой эсэхийг шалгажээ.
   Үр дүн. Мөрдөгчид хүүхдүүд нь Их Британид хувийн сургуульд сурдаг болохыг тогтоосон.
3. ***Техник.*** Мөрдөгчид сургуулийн төлбөрийг төлсөн банканд шалгалт хийсэн. /Эдийн засгийн мөрдөгчид ийм эрхтэй./
   Үр дүн. Дарие нь "Баркли" банкны кредит картаар төлбөрөө хийдэг байсан ба энэхүү кредит картын төлбөрийг сар бүр Жоис Оеэбанжо гэгч этгээд барагдуулж байсныг мөрдөгчид тогтоосон.[a]
4. ***Техник.*** Дариегийн хүүхдүүдийн сургууль дээрх хувийн хэрэгтэй танилцахын тулд "Мэдээлэл, лавлагаа гаргуулан авах тухай" зөвшөөрөл авсан.
   Үр дүн. Сургуулийн төлбөрийг Жоис Оеэбанжо төлсөн болохыг баталгаажуулсан.
5. ***Техник.*** Оеэбанжо гэгч этгээдийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болон төрийн бусад агентлагуудын мэдээллийн сангаас хайсан. Мөн түүнчлэн Оеэбанжо-ийн банкин дахь дансны мэдээллийг авахаар зөвшөөрөл авсан.
   Үр дүн. Оебанжо, Их Британид үл хөдлөх хөрөнгийн менежмент хариуцсан ажилтнаар ажилладаг бөгөөд ойролцоогоор 1.5 сая фунт стерлинг (ойролцоогоор 2.3 сая ам. доллар) бүхий 15 банкны данс, мөн 2 сая фунт стерлинг ойролцоогоор 3.1 сая доллар) үл хөдлөх хөрөнгөтэй болох нь тогтоогдсон. Цаашилбал, Оебанжо нь "Жозеф Дагван"-ын нэрээр худалдаж авсан, Нигери улсын Экологийн сангаас янз бүрийн компаниудаар дамжуулан төлбөр төлсөн Режентс Парк Плаза дахь Дариегийн өмчийн нэгний менежментийг удирдаж байгаа нь тогтоогдсон.
6. ***Техник.*** мөрдөгчид зээлийн лавлагааны шалгалт хийж, сэжигтнүүдийн үйл ажиллагаандаа ашиглаж буй банкны дансыг илрүүлсэн. Дараа нь эдгээр банкны данснаас бусад банкны данс, эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл зэрэг хөрөнгийг илрүүлсэн. Нэмэлт мэдээлэл олж авах, хөрөнгийг мөшгихийн тулд нэгжлэг хийх болон мэдээлэл гаргуулан авах зөвшөөрлийг ашигласан.
   Үр дүн. Дарие Лондонд тодорхой хаягаар бүртгэлтэй банкны данстай болохыг тогтоосон. Дарие, Ойебанжо нарын банкны дансыг шалгахад Нигерийн янз бүрийн банкнаас их хэмжээний цахим шилжүүлэг орж ирсэн байсан.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 3.4 Их Британи: Жошуа Дариегийн хэрэгт ашиглагдсан мөрдөн шалгах ажиллагааны арга техник

7. ***Техник.*** Дээр дурдсан Лондоны хаягтай холбоотой мэдээллийг гаргуулан авах зөвшөөрөл авсан.
   Үр дүн. Хаягтай холбоотой мэдээлэлд тухайн үл хөдлөх хөрөнгийг хуурамч нэр дээр Лондон хотод үйл ажиллагаа явуулдаг Нигери Улсын компанийн дансаар худалдан авсан нь тогтоогдсон.
8. ***Техник.*** Нигери Улсын холбогдох байгууллагад эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу тухайн хөрөнгийн эх үүсвэр хэрхэн бий болсон талаар мэдээ авахаар хүсэлт хүргүүлсэн. Энэ тохиолдолд албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хамгийн сүүлийн шатанд ашигласан бөгөөд албан бус хамтын ажиллагаа өмнөх үе шатуудад гол үүрэг гүйцэтгэсэн гэдгийг анхаарна уу. (8, 9-р бүлгээс олон улсын хамтын ажиллагааны талаар үзнэ үү)
   Үр дүн. Дарие банкны ажилтнуудын тусламжтайгаар өөрийн компанийн данс руу экологийн буцалтгүй тусламжийн хөрөнгийг шилжүүлж, нуун дарагдуулсан байсан нь тогтоогдсон. Хөрөнгийг нэгэн компани руу шилжүүлж, холбогдох банкны дансыг Дарие Нигерид нээж, улмаар Лондон руу шилжүүлэн ашиглаж байсан. Лондоны үл хөдлөх хөрөнгийг худалдаж авсан Нигерийн компани мөн экологийн буцалтгүй тусламжийн хулгайтай холбоотой байсан, учир нь хулгайлсан хөрөнгөөс 100 сая фунт стерлинг (ойролцоогоор 157 сая ам. доллар) авсан байна. Плато мужид 37 сая фунт стерлингийн (ойролцоогоор 58 сая ам. доллар) телевизийн тоног төхөөрөмж суурилуулахыг зөвшөөрсний дараа тус компани Лондоны үл хөдлөх хөрөнгөд 400,000 фунт стерлинг (ойролцоогоор 626,800 ам. доллар) төлсөн байна.

Энэ хэрэг нь сэжигтнүүдийн ойр дотнын хамаатан садан, бизнесийн хамтрагчид болон бусад этгээдэд мөнгө хулгайлж, гадаадын харьяалал руу шилжүүлэхэд тусалж чадах бүх хүмүүсийг тогтоох "субъектээ мэдэх", олж тогтоох зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Мэргэжилтнүүд дараагийн сэжүүр, мэдээлэл хааш нь ч хөтөлж болохыг мэдэхгүй тул боломжтой бүх арга техникийг (жишээлбэл, төрийн байгууллагууд, олон нийтийн эх сурвалж, албадлагын арга хэмжээ) ашиглах ёстой.

а. Дариегийн Их Британи дахь банкир Оебанжо нь Дариегийн хоёр хүүхдийн хувийн сургуулийн төлбөр болон бусад үйлчилгээний төлбөрийг Дариегийн нэрийн өмнөөс төлсөн.

3.4.1. Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл

Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл гэдэг нь ерөнхийдөө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл эсвэл интернэтээр үнэ төлбөргүй, төлбөртэй эсвэл захиалгаар авах боломжтой, хууль эрх зүйн ямар ч аргаар цуглуулж болох олон нийтэд нээлттэй мэдээлэл гэж тодорхойлогддог. Нээлттэй эх сурвалж болон төрийн бусад байгууллагуудын мэдээлэл нь сэжигтэй этгээд, тэдний гэр бүл, хамтран ажиллагсад болон холбогдох бизнесүүдийн эзэмшиж буй хөрөнгийг илчлэх боломжтой. Нээлттэй эх сурвалжийн мэдээллийг мөрдөн байцаалтын бүхий л шатанд хэрэглэгдэх байгаа бөгөөд мэдүүлгийн найдвартай эсэхийг үнэлэхээс эхлээд шүүх хуралдааны үед нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх үе шатанд хүртэл ашигладаг. Эхний үе шатанд нээлттэй эх сурвалжийн мэдээллийг мөрдөн байцаалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэг үүсгэх, сэжигтний профайлыг үүсгэх зэрэгт

ашиглахаас гадна сэжигтэн этгээд, тэдний гэр бүл, хамтран ажиллагсад болон холбогдох бизнесүүдийн эзэмшиж буй дотоод, гадаадын хөрөнгийг тодорхойлох эсвэл холбоотойг тогтооход ашиглаж болно. Сэжигтэн этгээдийн хамтрагчид болон гэрчүүдийг олж тогтоох, сэжигтний хувийн хэрэг, танилцуулга (3.3-р хэсэг) болон санхүүгийн танилцуулга (4-р бүлэг, 4.3-р хэсэг)-ыг бүрдүүлэх, түүнчлэн нэгжлэг, хураан авах тогтоолын үндсэн мэдээллийг бэлтгэхэд (3.4.8-р хэсэг) нээлттэй эх сурвалжийн мэдээллийг ашиглаж болно.

Нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд интернэт болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан нийтэд нээлттэй мэдээлэл (архивлагдсан мэдээлэл) орно. Дижитал мэдээллийн хэрэгслээс мэдээлэл олж авах; цахим шуудангийн мэдээллийг шалгах; мөн олон нийтийн сүлжээний хэрэгсэл (Facebook, Instagram гэх мэт) болон мэргэжлийн сүлжээний данс (LinkedIn гэх мэт) дээрх мэдээллийг шалгах нь хөрөнгө олж илрүүлэх ажиллагааны бүхий л үе шатанд төрөл бүрийн мэдээлэл олж авахад ашиглана. Жишээлбэл, олон нийтийн сүлжээн дээрх постод итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө байнга гарч байсан нь сэжигтэн болон тэдгээрийн хоорондын холбоо сүлбээг тодорхойлоход ашигласан тохиолдол бий. Мэргэжилтнүүд сэжигтний дижитал ул мөрийг мөрдөн шалгах ажиллагааны эхэнд тодорхойлох, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ISP) болон олон нийтийн сүлжээний компаниудтай газарзүйн байршил болон бусад Интернэт протокол (IP) хаягийн мэдээллийг тодорхойлох чиглэлээр эртнээс хамтран ажиллаж эхлэх хэрэгтэй.

Гэхдээ олон нийтийн сүлжээ болон интернэтээс олж авсан мэдээлэл нь үргэлж үнэн зөв байдаггүй бөгөөд чухал баримтуудын хангалттай нотлох баримт биш тул уламжлалт мөрдөн байцаалтын аргуудаар нотлох шаардлагатай.

Нээлттэй эх сурвалжийн мэдээллийн ангилалд дараах зүйлс орно. Үүнд:

- Төрийн албан ёсны бүртгэл (дотоодын болон гадаад)
  - Төрсөн, нас барсан, гэрлэлт, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл
- Хувийн, арилжааны эсвэл хууль сахиулах байгууллагын мэдээллийн сан
  - Эд хөрөнгийн болон зээлийн тайлан
  - Үйлчлүүлэгчийн (KYC) мэдээллийн бааз
- Иргэний хэрэг шүүхэд мэдүүлсэн мэдээлэл, гэрлэлт цуцлуулах, гэрээслэл (хэрэв байгаа бол)
- Аж ахуйн нэгжийн бүртгэл ба байгууллагын мэдүүлэг (санхүүгийн тайланг оруулаад)
- Патент, барааны тэмдгийн бүртгэлийн мэдүүлэг
- Төрийн бус байгууллагын бүртгэлийн мэдээлэл
- Татварын мэдүүлэг эсвэл тэтгэврийн төлөвлөгөөний мэдээлэл (хэрэв байгаа бол)
- Онгоц, усан онгоц,[8] моторт тээврийн хэрэгсэл гэх мэт хөдлөх хөрөнгийг хянадаг сайтууд
- Олон нийтийн сүлжээн дэх постууд

[8] Жишээлбэл, Нигерийн OPL 245 тосны блоктой холбоотой тансаг зэрэглэлийн хувийн тийрэлтэт онгоцтой холбоотой хэргийг (5-р бүлэг, хайрцаг 5.4-т авч үзсэн) FlightAware вэбсайт (https://uk.flightaware.com) ашиглан илрүүлсэн. Лионел Фаулл болон Маргот Гиббс. 2020. “Нигери улсад OPL245 мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой тансаг зэрэглэлийн хувийн онгоцыг хураан авчээ. Монреаль." Ил болсон эдийн засаг, 2020 оны 6-р сарын 6. https://www.financeuncovered.org/investigations/nigeria -Монреаль дахь тансаг зэрэглэлийн-хувийн тийрэлтэт онгоцыг-opl245-мөнгө угаахтай холбогдсон нь/-с үзнэ үү.

- Мэдээллийн хэрэгсэл (сонин, сэтгүүл, нийгэм эсвэл хов живийн шар хэвлэл, эсвэл вэбсайтыг оруулаад)
- Боловсролын бүртгэл, төгсөгчдийн байгууллагын хэвлэл
- Хөрөнгө хураах эрх зүйн байгууллагуудаас гаргасан мэдээлэл болон бусад орны холбогдох мэдээлэл
  - Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF) reports: https://www.fatf-gafi.org/
  - Улс орнуудын тайлан: Жишээлбэл, АНУ-ын Хууль зүйн яамны www.state.gov вэбсайтаас авах боломжтой тайлангууд
  - Хөрөнгө нөхөн төлүүлэх болон ашиг хүртэх өмчлөх гарын авлага: Жишээлбэл: https://star.worldbank.org/ArabForum/asset-recovery-guides andhttps://star.worldbank.org/content/beneficial-ownership-guides гарын авлагаас харах боломжтой.
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба төрийн бус байгууллага (ТББ)-ын тайлангууд: Жишээлбэл, Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн консорциум (ICIJ), Global Witness, Global Financial Integrity, Public Eye зэрэг байгууллагаас гаргасан тайлан.[9]

Салбарын мэргэжилтнүүд холбогдох мэдээллийг агуулсан мэдээллийн арилжааны санд бүртгүүлж болно. Нээлттэй эх сурвалжтай зарим вэбсайтуудын жагсаалтыг Хавсралт J-ээс үзнэ үү.

Нэмж дурдахад нотлох баримт бүхий мэдээлэл цуглуулдаг иргэний нийгмийн байгууллагуудаас мэдээлэл авч, улмаар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн байгууллагад шилжүүлж болно. Эдгээр байгууллагууд хууль эрх зүйн орчноос хамааран мөрдөн байцаах ажиллагаанд оролцож болно. Тухайлбал, хууль эрх зүйн орчны хувьд нь авлига, авлигатай тэмцэх чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх боломжийг олгодог улс орнуудад хэргийн илрүүлэлт болон явц ахицтай байдаг. Шигтгээ 3.5-д Эквадорын Гвиней улсын Теодорин Обиангын гэгчийн үйлдсэн хэргийг мөрдөн байцаах явцад дээр дурдсан байгууллага хэрхэн дэмжлэг үзүүлсэн талаар авч үзнэ. Үүнээс гадна сэтгүүлчид нотлох баримт цуглуулан холбогдох байгууллагад шилжүүлснээр авлигын схемийн нарийн ширийнийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.[10]

---

[9] Эдгээр ТББ-уудын тайланг ICIJ-ийн вэб сайтаас үзнэ үү (https://www.icij.org/); Global Witness (https://www.globalwitness.org/); Дэлхийн санхүүгийн нэгдмэл байдал (https://gfintegrity.org/); болон нийтийн хяналт (https://www.publiceye.ch/en/).

[10] Даниел Полити. 2018. “Аргентин дахь ууттай бэлэн мөнгө: Жолоочийн гар дээрх мөнгөн тэмдэгтүүд авлигын хэргийн шалгалтыг эхлүүлэв. Нью Иорк Таймс. 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдөр. https://www.nytimes.com/2018/08/03/world/americas/argentina-corruption -investigation.html Аргентины "La Naciyn" сонины эрэн сурвалжлах сэтгүүлч 2018 онд Холбооны төлөвлөлтийн яамны өндөр албан тушаалтны жолоочоос 2005-2015 оны хооронд 50 сая гаруй ам.доллар бэлэн мөнгө хээл хахуулийн зорилгоор хүргэсэн тухай бичсэн тэмдэглэлийн дэвтэр бүхий хайрцаг хүлээн авчээ. Нотлох баримтыг холбогдох албан тушаалтнуудад шилжүүлсэн. мөрдөгчид энэхүү авлигын хэргийн мөнгөн дүн 160 сая ам. Долларт хүрсэн хэмээсэн бөгөөд Аргентины прокурорууд ерөнхийлөгч асан Нестор Киршнер, Кристина Фернандес де Киршнер нар энэхүү авлигын схемийн удирдагчид байсан гэдгийг тогтоосон юм.

ШИГТГЭЭ 3.5	Эквадорын Гвиней улс: Теодорин Обиангийг мөрдөн шалгах явцад иргэний нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлсэн тухай

Энэ хэргийн гол асуудал нь Transparency International France (TI France) нь "хохирогч иргэний тал"-ын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрх зүйн чадамжтай эсэхийг тодорхойлох байв.

Францын хуульчдын бүлэг болох Шерпа нийгэмлэг нь Biens mal acquis хэрэгт авлигын хэргээр эрүүгийн хэрэг үүсгэсэн (2-р бүлгийн тэмдэглэл 8-д тайлбарласан) байдаг. Цагдаагийн байгууллагаас хийсэн мөрдөн байцаах ажиллагааны явцад маш их хөрөнгө илэрсэн ч улсын прокурор Эквадорын Гвинейн Дэд ерөнхийлөгч асан Теодоро Нгуэма Обианг (ихэвчлэн Теодорин гэж нэрлэдэг)-ийн хэргийг хэрэгсэхгүй болгов. Түүний халдашгүй эрхтэй холбоотой мэдээллийг 2-р бүлгийн Шигтгээ 2.10-аас үзнэ үү.

Францын TI байгууллага нь Шерпагийн үүсгэсэн энэхүү эрүүгийн хэрэгт "хохирогч иргэний тал"[a] болж оролцсон нь шүүхээс мөрдөн байцаах ажиллагаа явуулна гэж найдсаных аж. (Perdriel-Vaissiire 2017). Мөрдөн байцаах ажиллагааг явуулах эсэх шийдвэр гаргахын өмнө шүүх эхлээд TI France байгууллага нь хуулийн хувьд эрх зүйн чадамжтай оролцогч мөн эсэхийг тогтоох шаардлагатай байсан бөгөөд улмаар TI France байгууллагыг чадамжтай хэмээн үзсэн.

Энэхүү хэрэгтэй холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийг давж заалдаж, Францын Эрүүгийн хэргийн дээд шүүх (Кассацийн шүүх) хүртэл хандсан бөгөөд тэр үеийн түүхэн шийдвэрээр доод шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

TI France байгууллага болон Шерпа нар мөрдөн байцаах ажиллагаанд дараах дэмжлэгийг үзүүлсэн. (Perdriel-Vaissiire 2017)

- Төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл, нотлох баримт цуглуулах;
- Цуглуулсан материалыг мөрдөн байцаалтыг хариуцаж буй магистрын шүүгч нарт шилжүүлэх
- Амжилтад хүрэхэд саад болох хуулийн заалтуудын талаар судалгаа хийх
- Теодорин Обиангийн ашиг олох хөрөнгийг илрүүлэх (Парисын 42 Avenue Foch дахь үл хөдлөх хөрөнгийг оруулаад).

а. Францын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (85-р зүйл) шинэ зүйлд гэм хэргийн улмаас хохирсон иргэний талууд нь хүнд болон хүндэвтэр гэмт хэргийн улмаас хохирсон талаарх өргөдөл гарган нэгдэж болно гэж заасан байна.

3.4.2 Төрийн бусад байгууллагаас гаргаж болох мэдээлэл

Доор тайлбарласан агентлагууд болон бусад төрийн байгууллагаас гаргаж болдог мэдээллийн талаар судлах шаардлагатай (Зураг 3.2).

Санхүүгийн тагнуулын алба: (СТА) ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхийн стандартыг тогтоодог Засгийн газар хоорондын байгууллага юм. ФАТФ-ын 29-р зөвлөмжийн дагуу улс орнууд сэжигтэй гүйлгээний тайлан (STR) болон бусад мэдээллийг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, мөнгө угаах, гэмт хэрэг үйлдэхээс өмнөх мэдээлэл, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг түгээх зорилготой (үйл ажиллагааны болон стратегийн) үндэсний төв болох СТА байгуулах ёстой.[11]

[11] ФАТФ-ын 29 дүгээр зөвлөмж "Санхүүгийн тагнуулын алба" (ФАТФ 2019, 22)-ны тайлбар тэмдэглэл, зөвлөмж 29-ийг ийг үзнэ үү. (97-99)

ЗУРАГ 3.2 Засгийн газрын агентлагуудаас авч болох урьдчилсан мэдээллийн эх сурвалж



Эх сурвалж: Дэлхийн банк

Тэмдэглэл: FIU=Санхүүгийн тагнуулын алба

СТА нь мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрхтэй байж болох бөгөөд шүүхийн салбарт дотор, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эсвэл бие даасан захиргааны эрх бүхий байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулбал зохистой.[12] Санхүүгийн мэдээллийн чухал эх сурвалжийн хувьд мөнгөний ул мөрийг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. СТА-ны чиг үүрэг, оруулдаг хувь нэмрийн тухай дэлгэрэнгүй тайлбарыг 2-р бүлгийн 2.1-р хэсгээс үзнэ үү.

Улс орнууд өөрсдийн Санхүүгийн тагнуулын албыг олон улсын Эгмонт группт гишүүнээр элссэн эсэхийг шалгаж байх хэрэгтэй. Шигтгээ 3.6-д Эгмонт Группийн

[12] "Санхүүгийн тагнуулын алба (СТА)" "Эгмонтын тухай" Эгмонт группын вэбсайт (2019 оны 11-р сарын 13-ны өдөр), https://egmontgroup.org/en/content/financial-intelligence-units-fius. Мөн хууль сахиулах болон шүүхийн байгууллагуудын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг хосолмол загварууд, СТА -ны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ОУВС ба Дэлхийн банкнаас (2004) үзнэ үү.

үйл ажиллагааны зорилт, болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой "Санхүүгийн тагнуулын нэгж хоорондын мэдээлэл солилцох зарчим"-д үндэслэн гүйцэтгэх үүргийг тайлбарласан болно (Эгмонт Групп 2013).

Хэрэв зөвшөөрөгдсөн бол,[13] хууль сахиулах байгууллагаас санхүүгийн тагнуулын албанд хүсэлт гаргахдаа дараах мэдээллийг тусгасан байх ёстой. Үүнд:

- Мөрдөн байцаах ажиллагааны сэжигтний аливаа сэжигтэй гүйлгээний тайлан (STR), сэжигтэй үйл ажиллагааны тайлан (SAR) эсвэл валютын гүйлгээний тайлан (CTR)
- Сэжигтэн этгээдтэй холбоотой бизнесийн STR, SAR эсвэл CTR тайлангууд
- Сэжигтний хамтрагч эсвэл хамаатан садантай холбоотой аливаа STR, SAR эсвэл CTR
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаарх гүйцэтгэх ажлын аливаа мэдээлэл (Зарим СТА-д STR байхгүй тохиолдолд мэдээлэл өгөхийг зөвшөөрдөггүй)

ШИГТГЭЭ 3.6 Хөрөнгө буцаан авах ажиллагаанд Эгмонт группын гүйцэтгэх үүрэг

Эгмонт групп нь олон улсын 165 Санхүүгийн тагнуулын алба (СТА)-аас бүрдсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн туршлага, санхүүгийн мэдээллээ аюулгүй солилцох платформ бүхий байгууллага юм.[a] Эгмонт групп нь Санхүүгийн тагнуулын олон улсын форумын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд өөрийн гишүүн СТА-уудын хооронд санхүүгийн мэдээлэл солилцоход хамтран ажиллаж "хил дамнасан мэдээлэл солилцоход тулгарч буй саад бэрхшээлийг даван туулахад" дэмжлэг үзүүлдэг. (Эгмонт групп 2013, 2-р догол).[b]

Эгмонт группт гишүүнээр элссэнээр ФАТФ-ын (Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага) 29, 40-р зөвлөмжид (Эгмонт групп 2013, 3-р догол) заасан стандартад нэгдэхийг баталгаажуулдаг. СТА-уудын олон улсын хамтын ажиллагаа нь "харилцан итгэлцэл дээр суурилдаг" (Эгмонт групп 2013, 7-р догол); мэдээллийг "чөлөөтэй, хүсэлтийн дагуу харилцан үйлчлэх үндсэн дээр" солилцож болно (Эгмонт групп 2013, 11-р догол). Хоёр эсхүл олон талт гэрээ, хэлэлцээрээр мөн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно (Эгмонт групп 2013, 15-р догол).

Үүнээс гадна, "СТА-нд хүсэлт гаргаснаар хүлээн авсан, боловсруулсан, хадгалсан эсхүл тараасан мэдээлэл нь найдвартай хамгаалагдсан, нууц байх ёстой бөгөөд " мэдээллийг зөвхөн гаргасан хүсэлтийн дагуу эсвэл гаргаж өгсөн зорилгын дагуу ашиглах ёстой" (Эгмонт Групп 2013, 28-29, 32-р зүйл) Мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд "СТА нь аюулгүй байдал, найдвартай байдлыг хангадаг Egmont Secure Web эсвэл бусад хүлээн зөвшөөрөгдсөн сүлжээг л ашиглах ёстой" (Egmont Group 2013, 35-р зүйл).

a. "Эгмонтын тухай" Эгмонт группын вэбсайт (2020 оны 5-р сарын 11-нд шинэчилсэн), https://egmont-group.org/en/content/about.
b. Мөн "Эгмонтын тухай" Эгмонт группын вэбсайтаас үзнэ үү.

[13] Зарим улс орнуудад СТА нь сэжигтэй гүйлгээний тайлан, валютын гүйлгээний тайлангийн хуулбарыг хууль сахиулах байгууллагад дамжуулахыг зөвшөөрдөггүй. Ийм нөхцөлд тагнуулын тайланг (хэрэв боловсруулсан бол) ихэвчлэн хүсэлт гаргасан тохиолдолд өгөх боломжтой бөгөөд ижил мэдээллийг агуулсан байдаг.

Цагаачлалын алба, хилийн боомтын холбогдох байгууллага. Сэжигтний хилийн боомтоор нэвтэрсэн мэдээлэл болон цагаачлалын түүхийг харуулсан маягтын хуулбар эсвэл бусад холбогдох баримт бичгийг гаргуулан авах боломжтой.

Гаалийн байгууллага. Гаалийн мэдүүлэгд сэжигтний хилээр нэвтэрсэн тухай мэдээлэл багтаж болох юм. Хилээр нэвтрэхэд биед авч яваа бэлэн мөнгөө мэдүүлэх шаардлага гарсан тохиолдолд сэжигтний авч явсан валютын төрлийг олж мэдэх боломжтой.

Татварын байгууллага. Сэжигтний татвартай холбоотой мэдээллийг цуглуулах шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд хувь хүний орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, аж ахуйн нэгжийн албан татварын мэдүүлэг, татварын маргаантай холбоотой материалуудыг гаргуулан авч болно. Татвар төлөгчийн алба эсвэл кадастрын алба нь эд хөрөнгийн өмчлөлийн болон худалдан авалтын түүх, эд хөрөнгийн эрх зүйн байдал, түүний үнэ цэний үнэлгээний талаар мэдээлэл өгөх боломжтой.

Ёс зүй, шударга байдлын алба. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ёс зүйн өндөр соёлыг төлөвшүүлэх, дэмжих үүрэг хүлээсэн энэхүү алба нь авлигатай холбоотой гомдол, хариуцлагын талаарх бүртгэгдсэн асуудлын талаар мэргэжилтнүүдэд мэдээлж болно. Ийм алба нь төрийн албан тушаалтнуудын хөрөнгө, санхүүгийн нээлттэй мэдүүлгийг мөрдөгчийн хүсэлтийн дагуу гаргаж өгч болно. (Rossi, Pop, and Berger 2017; World Bank 2012).

Аудитын байгууллага. Ерөнхий аудиторын алба. Төрийн аудитын агентлагууд (зарим улсад Ерөнхий аудиторын алба гэж нэрлэдэг) ихэвчлэн харьяалагдаж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хараат бус, бодитой хяналт тавих үүрэгтэй. Залилах гэмт хэрэг, зүй бус үйлдэл гаргасан эсэхийг илрүүлэх, хэлтсийн үйл ажиллагааны шударга байдал, үр ашиг, үр дүнтэй байдалд үнэлгээ хийж мөрдөн байцаалт, аудит, тусгай төслүүдийг хэрэгжүүлдэг. Хэрэв төрийн байгууллага авлигын хэрэгт холбогдсон бол эдгээр агентлагууд мөрдөн байцаах ажиллагаанд шаардагдах мэдээллийг гарган өгч дэмжлэг үзүүлнэ. Жишээлбэл, аудитын байгууллагууд тодорхой хугацаанд мөрдөн байцаах ажиллагаанд татагдан ажиллах шүүх шинжилгээний нягтлан бодогчтой байж болно.

Газрын бүртгэлийн байгууллага. Харьяаллаас хамааран хот, дүүрэг, мужийн бүртгэлийн алба нь эд хөрөнгийн акт (худалдан авагч ба худалдагч), үл хөдлөх хөрөнгийн барьцаа, ипотекийн зээл, хөрөнгийн татвар, хөрөнгийн татварын үнэлгээ, худалдах, худалдан авах бүртгэлийн мэдээлэл, болон барилгын зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг гарган өгөх боломжтой.

Тээврийн хэрэгсэл, усан онгоц болон агаарын хөлгийн бүртгэл. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн алба нь шилжүүлэх, худалдаж авсан хугацаа, тухайн тээврийн хэрэгслийн нэрийн мэдээлэл болон хураангуй мэдээллийг өгч болно. Хувийн нисэх онгоц болон усан завь, хөлөг онгоцны бүртгэлийг тус тусын бүртгэлээс авах боломжтой. Нислэгийн төлөвлөгөө болон аяллын манифестийг шаардлагатай тохиолдолд гаргуулан авч болно.

Аж ахуйн нэгж, бизнесийн бүртгэл, лицензийн зөвлөл. Сэжигтэн болон түүний хамаарал бүхий этгээдийн хөрөнгийг тодорхойлоход аж ахуйн нэгж, бизнесийн бүртгэл хариуцдаг төрийн байгууллагын бүртгэлээс шаардлагатай мэдээлэл авч болно. Энэхүү бүртгэлээс бусад хамтран зүтгэгч, хамааралтай этгээдүүдийг илрүүлэх ч боломж гарч магадгүй. Зарим бүртгэлд хөрөнгийн өмчлөлийн мэдээлэл,

бүртгэлийн агентын нэр (ихэвчлэн хуульч эсвэл нягтлан бодогч), хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн зөвлөл, эцсийн ашиг хүртэх өмчлөгчид, компанийн санхүүгийн тайлан болон бусад бизнесийн мэдээллийг багтаасан байдаг. Бүртгэлийн системд хийх хайлтыг хувиараа эрхлэх аж ахуй, түншлэл, хязгаарлагдмал хариуцлагатай компани, төрийн болон хувийн компани гэх мэт бүх төрлийн бизнест хийх ёстой. Лицензийн бүтгэлд хуульч, нягтлан бодогч, нотариатч, эмнэлгийн мэргэжилтэн гэх мэт мэргэжлийн лиценз авахад бүрдүүлсэн мэдээлэл хадгалагдаж байж болно.

Иргэний бүртгэл. Иргэний бүртгэлийн газраас одоогийн болон өмнөх эхнэр, нөхөр (гэрлэлт, салалтын бүртгэл), хүүхэд, ах эгч, аав, ээж, өвөө эмээ болон бусад хамаатан садан зэрэг өв залгамжлал, гэр бүлийн байдлын талаарх мэдээллийг авах боломжтой.

Шүүхийн бүртгэл мэдээллийн сан. Мэргэжилтнүүд шүүхийн бүртгэлээс сэжигтний өмнө нь иргэний шүүхээр орж байсан эсэх, эсвэл иргэний маргаанд оролцож байсан эсэхийг тодорхойлох боломжтой. Хэрэв тухайн сэжигтэн иргэний шүүхээр орж байсан бол эд хөрөнгө болон бусад холбогдох баримтын талаарх мэдээллийг түүний мэдүүлэг, шийдвэр, шийтгэлийн сонсголын мэдүүлэг, хуулбараас үзэх боломжтой. Зарим шүүхүүд хууль сахиулах байгууллагын мэдээллийн сантай холбогдоогүй байдаг тул холбогдох мэдээллийг авахын тулд сэжигтний гэр бүлийн, иргэний, дампуурлын асуудал хариуцсан шүүхийн бүртгэлээс хайх шаардлагатай болдог.

Хэрэглээ. Сэжигтний хэрэглээний төлбөрөөс түүний оршин суугаа хаяг, эрхэлдэг бизнес, (цахилгаан, ус, утас, кабель эсвэл интернэт, бохир ус, хог хаягдлын төлбөр гэх мэт) төлбөр хүлээн авагч, төлбөрийн хэлбэр, төлбөрийг гүйцэтгэгч этгээдийг тодорхойлох боломжтой. Мөн түүний хэрэглээний төлбөрийн бүртгэлээс өөр хаягт бүртгэлтэй эсэхийг тодорхойлохын тулд сэжигтэн болон түүний хамсаатнуудын талаар ерөнхий хайлт хийж болно.

Хөрөнгө, хүү, орлогын мэдүүлэг. Сэжигтний хөрөнгө, орлого, орлогын эх үүсвэр, бэлэг дурсгалын зүйл, хөрөнгийн өөрчлөлт, албан тушаалаас гадуур эрхэлж буй албан тушаал, ТУЗ-ийн гишүүнчлэл, хувьцаа эзэмшилт, санхүүгийн бусад ашиг сонирхол, харьяалагдах төрийн байгууллага гэх мэт мэдээллийг хөрөнгө, орлого мэдүүлэх системээс авах боломжтой. (Rossi, Pop, and Berger 2017; World Bank 2012).

3.4.3. Биечилсэн хяналт

Биечилсэн хяналт гэдэг нь мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй сэжигтэн этгээдийн талаар мэдээлэл цуглуулахын тулд хийж буй нууц далд ажиглалт юм. Тодруулбал, биечилсэн хяналтын үед авлигын гэмт хэргийг үйлдэхэд оролцож буй гэрч, хуйвалдаанд оролцогчид, үл хөдлөх болон бусад хөрөнгө, хуульч, банкны ажилтан, нягтлан бодогч, эрхэлж буй бизнес, зан үйлийн хэв маяг, бусад гүйцэтгэх ажлын мэдээллийг цуглуулах боломжтой. Энэхүү нууц ажиллагааг зохион байгуулахад нарийвчилсан сайн төлөвлөлтийг урьдчилж хийхийг шаарддагаас гадна урт хугацаанд нууц хэвээр үлдэж чаддаггүй. Үүнээс гадна биечилсэн хяналтыг зохион байгуулах нь тодорхой эрсдэлүүдийг дагуулдаг: сэжигтэн этгээд хяналт тавьж байгаа ажлын багийн чанар, туршлагаас үл хамааран тэднийг илрүүлэх эрсдэлтэй. Ахлах мөрдөгч биечилсэн хяналтын эцсийн үр дүн нь дагуулах эрсдэлээс илүү эсэхийг багийнхантайгаа зөвшилцсөний үндсэн дээр тодорхойлох ёстой.

Хяналтын ажиллагааг амжилттай явуулахад туршлагатай боловсон хүчин, тоног төхөөрөмж зэрэг хангалттай нөөц шаардлагатай болдог. Жишээлбэл, радио эсвэл гар утсаар багийн гишүүдэд сэжигтний байршил, үйл ажиллагааны талаар мэдэгдэхэд чухал ач холбогдолтой бол бичлэг хийх төхөөрөмжөөр болж буй үйл явдлыг баримтжуулах, хөдөлгөөний тэмдэглэл хөтлөх эсвэл бусад хүмүүстэй холбоо барих боломж олгодог. Түүнчлэн, биечилсэн хяналтаар олж авсан мэдээллийг цуглуулах, зохицуулах, хянах үүрэг бүхий туршлагатай ахлах мөрдөгчийг томилох ёстой.

Багийн ахлагч нар багийн хэмжээ, хяналтын хэлбэр, байршлыг тодорхойлно. Тэд багийн гишүүдэд даалгаврыг тайлбарлах, ээлжийн тасралтгүй байдлыг хангах, хувийн аюулгүй байдал хангах асуудлаар зөвлөгөө өгөх зорилгоор биечилсэн хяналтыг эхлүүлэхийн өмнө товч заавар бэлтгэх шаардлагатай. Багийн ахлагч хяналтын төрлийг сонгох (жишээлбэл, суурин, хөдөлгөөнт машин, явганаар); хяналтын явцад тааралдсан өөр сэжигтнийг дагах эсэхийг шийдэх; мөн хяналтын явцад тохиолдсон чухал үйл явдлын тайлангийн илтгэх хуудсыг боловсруулах зэрэг стратегийн шийдвэр гаргах үүрэгтэй. Хэдий биечилсэн хяналт тавих нь үр дүнтэй арга боловч 7 хоногийн 24 цагт хэрэгжүүлэхэд зардал хэт өндөр гардгийг харгалзан үзэж завсарлагатай хяналт хэрэгжүүлэх аргыг санал болгодог.

3.4.4. Сэжигтний хог хаягдалд үзлэг хийх тухай

Сэжигтний хог хаягдалд үзлэг хийх нь түүний хаясан банкны хуулга, бизнесийн түншүүдийн нэр, захидал харилцаа, төлбөрийн баримт, аяллын баримт гэх мэт холбогдох мэдээллийг хайж олох зорилготой юм. Ингэснээр сэжигтэн болон бусад хамсаатан эсвэл хөрөнгө хоорондын уялдаа холбоог харуулах замаар нэгжлэг хийхэд шаардагдах мэдээлэл бүхий нотлох баримтыг олох боломжтой хэмээн үздэг.

Мөрдөн байцаалтын бусад аргуудын нэгэн адил сэжигтний хог хаягдалд үзлэг хийхийг мөрдөгчид хуулиар зөвшөөрдөг эсэх, аливаа хязгаарлалт тавигддаг эсэхийг урьдчилан тодорхойлох шаардлагатай, учир нь зарим эрх зүйн тогтолцоонд хогийн савыг "хувийн нуцаар хамгаалах" стандарт байдаг.[14] Хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд сэжигтний оршин суугаа газар болон бизнесийн үйл ажиллагаа явуулдаг газар зэрэг бүхий л байрлалын хог хаягдалд үзлэг хийх хэрэгтэй. Мэргэжилтнүүд банкны мэдээлэл, төлбөрийн баримт, санхүүгийн хөрөнгө, аж ахуйн нэгжтэй холбоотой баримт бичиг; хамаарал бүхий бусад хүн, компани, хуульч, нягтлан бодогчдын нэрийг агуулсан баримт бичиг; зээлийн картын хуулга; эсвэл аяллын бүртгэл (жишээлбэл, онгоцонд суух тасалбар эсвэл хамрагдсан аяллын хөтөлбөрийн мэдэгдэл) зэрэг баримтуудад анхаарал хандуулах хэрэгтэй. Цуглуулсан нотлох баримтын огноо, цаг, хариуцсан ажилтан, баримт бичгийн дугаар гэх мэт мэдээллийг нэгтгэн бүртгэл хөтлөх шаардлагатай. Хогийн саванд хийх үзлэгт сэжигтэн этгээдийн эхнэр, нөхөр, хуучин эхнэр, нөхөр, хуульч, нягтлан бодогчид болон түүнтэй холбоотой бусад бизнес эрхлэгчид гэх мэт бусад гэр бүлийн гишүүд эсвэл хамсаатнуудыг хамааруулж болно.

---

[14] Жишээлбэл, АНУ-д байшингийн гаднах замын хашлага дээр байрлуулсан хогийн савнаас хувийн нуцыг хамгаална гэсэн хүлээлт байдаггүй; тиймээс мөрдөгчид нэгжлэг хийх зөвшөөрөлгүйгээр шалгаж болно (Калифорниа эсрэг Гринвуд, 486 АНУ 35 [1988]). Гэсэн хэдий ч, хэрэв хогийн сав байшингийн зэргэлдээ хогийн саванд байгаа бол хувийн нуцыг хамгаалах хүлээлт байдаг бөгөөд энэ тохиолдолд хууль сахиулагчид нэгжлэг хийх зөвшөөрөл авах ёстой. Үүний эсрэгээр, зарим улс оронд (жишээлбэл, Украин) хог хаягдалд үзлэг хийхийг зөвшөөрдөггүй.

3.4.5 Захидлын дугтуй, байгууллагад нэвтэрсэн бүртгэл

Битүүмжилсэн эсвэл битүүмжлээгүй шуудангийн захидлын дугтуйны гадна талд харагдаж байгаа аливаа мэдээллийг (жишээлбэл, буцах хаяг, шуудангийн марк хүчингүй болгосон огноо, илгээсэн улс гэх мэт) тодорхой хугацаанд бүртгэж болно. Харин битүүмжлэлгүй шуудан байвал агуулгыг бүртгэж болно. Дугтуй дээрх хаяг хөрөнгийн байршлыг маш сайн тодорхойлдог. Жишээлбэл, банк, хуулийн фирм, компани эсвэл нягтлан бодох бүртгэлийн фирмээс ирүүлсэн захидал нь тэдний эзэмшиж буй хөрөнгийн талаарх мэдээллийг агуулсан байдаг. Эрх зүйн хувьд зөвшөөрөгдсөн улсад дугтуйн гадна талыг хувийн нууцад хамаарахгүй хэмээн үздэг тул захидлын дугтуйн бүртгэл хөтлөх ажиллагааг эхлүүлэхийн өмнө холбогдох зөвшөөрөл авах шаардлагагүй байдаг. Ихэнх улс орнууд битүүмжилсэн захидал, илгээмжийг нээх, уншихын тулд нэгжлэг эсвэл өөр хэлбэрийн хууль ёсны зөвшөөрөл шаарддаг. Энэхүү ажиллагааны үед мөрдөгчид сэжигтэн болон захидал илгээгч нарын хоорондын харилцаа хамаарлыг тодорхойлохыг хичээж дугтуй, боодлын гадна талд байгаа бүх өгөгдлийг үнэн зөв бүртгэх, өөрийн захидлын дугтуйг бүртгэх ажиллагаа хийсэн огноо, цагийг тэмдэглэж, дугтуйны хуулбарыг хавтаст хэрэгт хадгалах нь чухал юм.

Нэмж дурдахад, төрийн байгууллага болон хувийн компаниуд байгууллагадаа нэвтэрсэн зочдын бүртгэлийг хөтөлдөг. Эдгээр бүртгэлийг сэжигтэн этгээдүүдийн уулзалтын цаг, огноог тогтоох эсвэл бусад тохиолдолд харилцах бүртгэлийг үүсгэхэд ашиглаж болно. Эдгээр бүртгэлийг ихэвчлэн зөвшөөрөлгүйгээр авах боломжтой.

Сүүлийн үед энэ төрлийн бүртгэлийг карт уншигчийн системээр дамжуулан цахимаар бүртгэх болсон. Цахим бүртгэлийг мөрдөгчид бэрхшээлгүйгээр олж авах боломжтой байдаг.

3.4.6. Ярилцлага

Аливаа мөрдөн байцаах ажиллагааны чухал хэсэг болох ярилцлага хийх нь хөрөнгө буцаах ажиллагааны ч чухал хэсэг юм.[15] Ярилцлагаар олж авсан мэдээлэл нь өмнө цуглуулсан байсан мэдээллийг баталгаажуулах, шинэ сэжүүр гаргах, эсвэл санхүүгийн шинэ баримтыг тодорхойлох зэрэг ач холбогдолтой. Ярилцлагын чухал эх сурвалжид сэжигтний эсрэг гомдол гаргагч, бизнесийн хамтрагч, хамаатан садан, хөршүүд, ажилчид болон сэжигтэн этгээдийн бусад хамаарал бүхий этгээд, бизнесийн өрсөлдөгчид; санхүүгийн байгууллагын ажилтнууд болон сэжигтэнтэй харилцаж байсан этгээд болон сэжигтэн өөрөө ч байж болно. Мөн тухайн хэрэгт холбогдсон “Сүрлэн хүмүүс”-ийг олж тогтоох, ярилцлага хийх нь чухал гэдгийг анхаарах хэрэгтэй. “Сүрлэн хүмүүс” урамшуулал багатай боловч хэрэгт маш их эрсдэлийг үүрэн оролцож байгаа тохиолдолд өөр хүний өмнөөс хэрэгт холбогдсоноос хуулийн байгууллагад мэдэгдэх нь дээр хэмээн үзэх тохиолдол гардаг.

[15] Зарим улс орнууд ярилцлага болон байцаалтыг хооронд нь ялгаж, "ярилцлага" -ыг мөрдөн байцаалтын зорилгогүй хүмүүсийг байцаах, "байцаалт"-ыг зорилтот хүмүүсийг байцаах гэж тодорхойлдог. Энэ хэсэгт "ярилцлага" гэсэн нэр томъёо нь асуулгын хоёр хэлбэрийг хэлнэ. Мэргэжилтнүүд гэрч, шинжээч, хохирогч, шүгэл үлээгч, хамтран ажиллаж буй объектуудыг зохих хамгаалалтаар хангах ёстой. Жишээлбэл, UNCAC 32, 33, 37 бүлгийг үзнэ үү.

Гаднын улс оронд сэжигтэн болон түүнтэй холбоотой этгээдтэй ярилцлага хийх үед тухайн орныхоо хууль эрх зүйд хэрхэн заасныг баримтлах шаардлагатай.[16] Жишээлбэл, зарим эрх зүйд бүх мэдүүлгийг албан ёсны сонсголоор авах шаардлага тавьдаг. Зарим улс орнуудад тухайн орны хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг байлцуулан гэрчээс мэдүүлэг авах (албан ёсны болон зөвшөөрөлгүйгээр), мэдүүлгийг бичгээр өгөх, ярилцлагад оролцогчдод урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр видео эсвэл аудио бичлэг хийх, эсвэл тангараг өргөн мэдүүлэг өгөх зэрэг төрөл бүрийн ярилцлагын хувилбаруудыг хууль тогтоомжоороо зөвшөөрсөн байдаг.

Ярилцлагыг амжилттай хийхийн тулд сайтар бэлтгэх, мөрдөн байцаалтын явцад цуглуулсан нотлох баримт, сэжигтэн, түүнтэй холбогдох этгээд, үйл явдлын цаг хугацаа, мэдээллийн талаар бүрэн ойлголттой байх нь чухал юм. Бэлтгэл ажлын хүрээнд өмгөөлөгчийг тодорхойлох, ярилцлагын асуултуудыг тус бүрээр нь төлөвлөх, тухайлбал, гэрчийн ярилцлагаар дамжуулан хамсаатны үйлдлийг урьдчилан таамаглах эсвэл өмгөөлөгчийн хүсэл сонирхлыг урьдчилан тодорхойлох зэргийг багтаана. Мэргэжилтнүүд хариулт авахыг хүссэн асуултуудаа бэлтгэн асуух боловч явцын дунд уян хатан байж, төлөвлөсөн асуултаас гадна өөр хариулт өгсөн тохиолдолд соргог байж анхаарал хандуулах хэрэгтэй.[17]

Сэжигтний зүгээс гэрчийн мэдүүлэгт нөлөөлөх, хамсаатнуудтайгаа үгсэх, урьдчилан тохиролцох зэргээр холбоо тогтоохыг оролдож болзошгүй тул мэргэжилтнүүд ярилцлага хийхээс өмнө тэднийг хоорондоо харилцахыг хориглох / эсвэл эрх бүхий шүүхийн байгууллагад хүсэлт гаргах/ эсвэл тохирох арга хэмжээг хэрэгжүүлэх зэргээр урьдчилан сэргийлж болно. Үүнээс гадна, ярилцлага авах газар нь анхаарал сарниулах зүйл багатай, үзэмж сайтай, нээлттэй хариулт өгөх боломжтой орчин бүрдүүлсэн байх ёстой (жишээ нь, оршин суугаа газар, цагдаагийн газар эсвэл бизнесийн газар). Ярилцлага авах ажилтны тоо хоёроос илүүгүй байх хэрэгтэй.

3.4.7. Дансны хяналтын захиалга

Дансны хяналтын захиалга гэдэг нь хяналт хэрэгжүүлэх зорилгоор шүүхээс /зарим эрх зүйн тогтолцоонд магистрын шүүгч/ захиалгад дурдсан дансны заасан хугацаан дахь мэдээллийг гаргаж өгөхийг санхүүгийн байгууллагад даалгахыг хэлнэ. Мэдээллийг захиалгад заасан журмаар заасан хугацаанд холбогдох албан тушаалтанд гаргаж өгнө.[18] Энэхүү захиалга нь тухайн дансаар хийгдэж буй гүйлгээнд бодит цаг хугацаанд санхүүгийн хяналт тавих боломжийг олгож, үйл ажиллагааны төрлийг тогтоох, холбоотой шинэ данснуудыг тодорхойлох боломжийг олгодог. Ингэснээр хөрөнгийг илрүүлэх, царцаах, нэгжлэг хийх, хураах тушаал гаргах үндэслэлд оруулах мэдээллийг цуглуулах боломжтой болно.[19] Их хэмжээний

[16] Мэргэжилтнүүд ярилцлагад тавигдах шаардлагуудыг (Жишээ нь, ярилцлага авагчид шаардлагатай анхааруулга) гадаадын хамтран ажилладаг байгууллагад хүргүүлэх ёстой бөгөөд тэдгээрийн ярилцлагад оролцох боломжтой эсэхийг асуух ёстой. Гадаадын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах эсвэл хүсэлтийг биелүүлэхэд оролцох талаар ярилцахыг 9-р бүлгийн 9.2.6-аас үзнэ үү.

[17] Үүнтэй холбогдуулан мэргэжилтнүүдэд ярилцлагыг чиглүүлэх тусгай асуултаас илүү сэдвийг бэлтгэх нь илүү тустай байж болох юм.

[18] Их Британид захиалга нэг удаад 90 хүртэл хүчинтэй байж болно.

[19] Дансны хяналтын тушаал нь нотлох баримтын стандарт эсвэл бусад шаардлагууд нь мэдээллийг ил болгох, царцаах, хураах тушаалаас арай бага шаардлага тавигдсан байдаг.

бэлэн мөнгө гаргаж авсан тохиолдолд тухайн байршлыг зааж өгөх тул бэлэн мөнгийг хураан авч болно.

3.4.8. Нэгжлэг хийх, хураах зөвшөөрөл

Оршин суух хаяг болон бизнесийн байранд нэгжлэг хийх нь гэмт хэргийн шинжтэй нотлох баримт цуглуулах, хөрөнгийн талаарх мэдээллийг олох, илрүүлэх, хамтран оролцогчдыг илрүүлэх, мөрдөн байцаалтад хэрэгтэй бусад сэжүүрийг олж тогтоох асар том боломж юм.[20] Зарим тохиолдол эсвэл эрх зүйн системд энэхүү ажиллагаа нь банкнаас мэдээлэл гаргуулахад хэрэглэгддэг үндсэн арга юм. (мөн 3.4.9, "Баримт бичгийг задруулах, гаргаж өгөх" хэсгийг үзнэ үү). Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд, мөрдөгчид гадаад улсад нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг зохион байгуулах шаардлагатай гэж үзвэл төвлөрсөн, уялдаатай байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай тул холбогдох байгууллагуудтай эртнээс харилцах, албан бусаар хамтран ажиллаж эхлэх нь үр дүнтэй байдаг.

Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд хүний хувийн орон зайд хүчээр нэвтрэн орж нэгжлэг хийх нь албадлагын шинж чанартай байдаг тул эрх бүхий албан тушаалтан (ихэвчлэн хууль сахиулах байгууллагын ажилтан эсвэл прокурорын ажилтан) хүсэлт гаргаж, шүүгчээс зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Гэхдээ эх газрын болон нийтийн эрх зүйд нэгжлэг хийх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага өөрийн онцлогтой байдгийг анхаарах хэрэгтэй. Тодруулбал, нэгжлэг хийх, хураах зөвшөөрөл гаргахад шаардагдах нотлох баримтын стандарт, хураан авах нотлох баримтад шаардагдах тодорхой байдал, нотлох баримтын байршлыг тодорхойлох хэрэгцээ (онцгой шаардлага) зэрэг нь эрх зүйн системээс шалтгаалан янз бүр байна. Ерөнхийдөө нийтийн эрх зүйн системд илүү тодорхой байхыг шаарддаг.

Нэгжлэг хийх зөвшөөрөл авахаар бэлтгэх, зөвшөөрөл авах

Нийтийн эрх зүйд бичгээр хүсэлт гаргах шаардлага тавьдаг. /зөвхөн онцгой тохиолдолд утсаар болон амаар/ Хүсэлтэд сэжигтэй үйлдлүүдийг дурдсан гэрчийн мэдүүлгийг тусгана. (гэрчийн мэдүүлгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 5-р бүлгийн 5.3.2-оос үзнэ үү.)

Үүний дараа (а) гэмт хэрэг үйлдэгдсэн, (б) эрэн сурвалжлагдаж буй эд зүйл нэгжлэг хийх байранд байгаа, (в) эрэн сурвалжлагдаж буй эд зүйл гэмт хэрэгтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй, эсвэл магадлалыг тодорхой хэмжээнд тайлбарлах ёстой. (Үндэслэлтэй гэж үзэх эсвэл магадлалтай шалтгааны талаар Шигтгээ 3.7-г үзнэ үү.) Хэрэв магистрын шүүгч үндэслэлтэй гэж үзвэл зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөлд нэгжлэг хийх албан тушаалтныг оролцуулан нэгжлэгийн дэлгэрэнгүй мэдээлэл; байршил; нэгжлэг хийх хугацаа, цаг, (жишээлбэл, өдөр, шөнө); үргэлжлэх хугацаа; юу хайх ёстой; хураан авсан зүйлсийн тооллого; мөн шүүхэд дараа нь тайлан гаргах шаардлага зэрэг мэдээллийг багтаана.

[20] Байшин, аж ахуйн нэгжүүдээс гадна нэгжлэг хийх зүйлд банк, хүмүүс, машин, онгоц, хөлөг онгоц, компьютер, боодол, хайрцаг болон бусад цахим хэрэгсэл (компакт диск, шифрлэлтийн түлхүүр гэх мэт) багтаж болно.

ШИГТГЭЭ 3.7	Зөвшөөрөл авах үндэслэлүүд болон гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй талаар мэдээллийн эх сурвалжтай холбоотой анхаарах зүйлс

Нэгжлэг хийх зөвшөөрөл авахад шаардлагатай үндэслэлийг олон өөр төрлийн эх сурвалжаас авах ба зөвшөөрөл авахад үүнийг анхаарч ажиллавал зохино. Мэдээллийн эх сурвалж дараах төрлөөс бүрдэнэ:

- Шууд ажиглалт (шууд эх сурвалжаас авсан мэдээлэл)
- Биет болон цахим ажиглалтаас олж авсан мэдээлэл
- Нийтэд нээлттэй мэдээлэл
- Бусад хэргийн материал дахь мэдээлэл
- Гэрчээс гаргаж өгсөн мэдээлэл
- Мэдээлэгчээс авсан мэдээлэл
- Нэрээ нууцалсан мэдээлэл

Анхаарах зүйлс:

- Гэрч, мэдээлэгчид нь өөрсдийн эрх ашгийн төлөө ажиллаж байж болзошгүй
- Нэрээ нууцалсан мэдээлэл, цуурхал нь үндэслэлгүй байх магадлалтай
- Сэжигтэн нотлох баримтыг устгаж болзошгүй гэж үзэх үндэслэл байгаа эсэх
- Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулахыг завдсан эсэх
- Нотлон баримт бэхжүүлэх бусад аргууд үр дүнд хүрээгүй, явуулах боломжгүй гэж үзэх үндэслэлтэй эсэх, мөрдөн шалгах ажиллагааг эрсдэлд оруулах, мэдээлэгч, нууц ажилтныг ил болгох аюултай нөхцөл байдал байгаа эсэх. Дээрх нөхцөлд тухайн асуудлын шуурхай шийдвэрлэх шаардлагатай.

Зарим тохиолдолд дээрх нотлох баримтуудыг бататгах шаардлагатай.

Эх газрын эрх зүйн системтэй улс орнуудад зөвшөөрөл авахад шаардлагатай мэдээлэл нь “гэмт хэрэг үйлдэгдсэн гэх хангалттай үндэслэл” эсхүл “гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй гэх үндэслэл”-ээс ялгаатай байдаг. Зарим тохиолдолд гэрчийн мэдүүлэг шаардлагагүй ба алба хаагчид прокурор, эсхүл шүүхээс “хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай бүхий л нэгжлэг явуулах зөвшөөрөл” урьдчилж авсан байж болно.[21]

Зөвшөөрөл хүсэж буй алба хаагч хайх объект болон хайлт явуулах газрын талаар мэдээлэл өгөх шаардлагатай. Эх газрын эрх зүйн тогтолцоот улсад зарим тохиолдолд хуульд заасан үндэслэлийг дурдахад хангалттай байдаг. Нийтийн эрх зүйн систем бүхий улсад зөвшөөрөл авахад илүү тодорхой мэдээлэл шаардлагатай бөгөөд мөрдөгч эд зүйлийг хурааж авах бодит шаардлагыг тайлбарлаж чаддаг байх ёстой. Хурааж авч болох эд зүйлсийн төрлийг Шигтгээ 3.8-с харна уу.

Нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг төлөвлөх, явуулах

Хойшлуулшгүй тохиолдлоос бусад үед нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг төлөвлөх боломжтой байдаг. Эд мөрийн баримт устах, үгүй болохоос урьдчилан сэргийлж хэд хэдэн газар эсхүл улсад зэрэг нэгжлэг хийх боломжтой эсэхийг

[21] Франц болон бусад улс орнуудын иргэний эрх зүйн энэхүү зөвшөөрөл нь ихэвчлэн шүүгчийн тушаалаар “commission rogatoire” хэмээн нэрлэгддэг. Швейцарь улсад "нарийн нэгжлэг" гэж нэрлэгддэг нэгжлэгийг прокурорын гарын үсэг бүхий энгийн бичгээр өгсөн тушаалаар (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 241-р зүйл) хийж болно.

харгалзаж үзэх шаардлагатай. Хэдийгээр урьдчилж төлөвлөх, чиглүүлэх нь төвөгтэй ч үр дүн нь бахдам байж болно.

Нэгжлэг хийх, хураан авах ажиллагаанд шаардлагатай шинжилгээг төлөвлөх шаардлагатай. Жишээ нь, цахим хэрэгслээс мэдээллийг бүрэн бүтэн, ямар нэг эвдрэл гэмтэлгүйгээр хуулбарлан авч хадгалах, тус мэдээллийг шаардлагатай хэлбэрээр гаргаж өгөх, шүүхэд нотлох баримтыг шаардлага хангахуйцаар бэхжүүлэх (хэргийн газрыг гэрэл зургаар бэхжүүлэх, авч хэрэгжүүлсэн ажиллагаа, алба хаагчийн нэрийг тусгах)-д компьютерын шинжээч оролцуулах шаардлага гарч болно.[22] Түүнчлэн цахим мөнгө хадгалж байж болзошгүй мэдээлэл авсан тохиолдолд төсөөтэй эд зүйлсийг хадгалж болох төхөөрөмж, тэдгээрт нэвтрэх мэдээллийн талаар урьдчилж зөвлөгөө авах шаардлагатай.

Дансан дахь мөнгө зэрэг нэгжлэг хийх үед байхгүй болох эрсдэлтэй эд хөрөнгийг урьдчилж эсхүл нэгжлэг хийх үед бэхжүүлэх (мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах) арга хэмжээ авна. Учир нь сэжигтэн нэгжлэгийн талаар урьдчилж мэдэх боломжтой. (5.3 дугаар хэсгээс урьдчилж зөвшөөрөл авах нөхцөлийг харна уу). Нэгжлэг хийх, хурааж авах ажиллагааг төлөвлөхөд анхаарах зарим зүйлсийг Хавсралт D-д тусгасан болно.

Эд мөрийн баримтыг хадгалах, ажиллагаа явуулсны дараах шаардлагыг хангах

Эд мөрийн баримтыг хураан авсны дараагаар аюулгүй газар хадгалах, бүртгэх, үзлэг хийх ажиллагаа явуулах ба тэдгээрийг хэргийн материалд тусгана. Хэрэв үзлэгийн явцад сэжигтэн, түүний хамсаатнуудаас мэдүүлэг авсан бол мэдүүлгийн тэмдэглэлийг нэн даруй хавтаст хэрэгт хавсаргана.[23] Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгч эд мөрийн баримтын бүрэн бүтэн байдал, хурааж авсан эд мөрийн баримтын бүртгэл, мөн мөрдөн шалгах ажиллагаа хууль ёсны байх зэрийг тус тус хариуцна. Түүнчлэн зарим тохиолдолд мөрдөгч хийж гүйцэтгэсэн ажиллагааг прокурор, шүүхэд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

ШИГТГЭЭ 3.8 Мөрдөн шалгах ажиллагааны явцад хурааж авах шаардлагатай эд зүйлс

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хурааж авбал зохих эд зүйлсийг жагсаалтаар харуулав. Нийтийн эрх зүйн тогтолцоо нь нэгжлэг хийх, хурааж авах эд зүйлсийн талаар тодорхой зааж өгөхийг шаарддаг учир эдгээр эд зүйлсийн төрлийг мөн харуулсан болно.

Санхүүгийн баримт бичиг. Энэ бүлэгт ном, тэмдэглэл, гүйлгээ, бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн баримт, эд хөрөнгө, хамтрагч байгууллага, бизнесийн үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө, электрон гүйлгээ, ипотекийн зээл, зээлийн болон төлбөрийн карт, хадгаламжийн хайрцгийн түлхүүрийн талаарх мэдээлэл, банкны

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[22] Компьютерийн хэрэглэгчид өгөгдлийг хамгаалах, нуух эсвэл зөвшөөрөлгүй хэрэглэгч нэвтрэхийг оролдох үед системийг нэвтрэх боломжгүй болгох янз бүрийн механизмуудыг хэрэгжүүлж болохыг анхаарна уу. Компьютерийн шүүх шинжилгээний мэргэжилтнүүд системийг хадгалах, устгасан эсвэл алдагдсан мэдээллийг сэргээх, үүлэн тооцооллын хэрэглээг хянах гэх мэт хэрэгслүүдтэй байдаг. Мэдээллийг зөв цуглуулах нь мэдээллийн менежментийг баталгаажуулдаг.

[23] Зарим улсууд нотлох баримтын хүчинтэй байх шаардлагыг биелүүлэхийн тулд эд зүйл бүрийн байршил дээр ажиллагаа явуулах шаардлага тавьдаг.

ШИГТГЭЭ 3.8 Мөрдөн шалгах ажиллагааны явцад хурааж авах шаардлагатай эд зүйлс

баталгаа, мөнгөн гүйлгээ, чек, тооцооны хуудас, банкны захидал харилцаа, кассын баримт, банкны баримт зэрэг багтана.

Компьютер, компьютерын санах ой, электрон төхөөрөмж. Энэхүү бүлэгт компьютер, планшет, электрон төхөөрөмж, гар утас (ухаалаг утас), автомат хариулагч, хувийн төлөвлөгч, компакт диск, флаш, USB ороллттой санах ой бүхий төхөөрөмж, факс, принтер зэрэг хамаарна. Компьютер болон электрон төхөөрөмжийг хураан авах ажиллагаа нь хатуу диск дэх мэдээллийн хуулбар бус бодит төхөөрөмжийг нөөц төхөөрөмжийн хамт хураан авахад оршино.

Унтраасан төхөөрөмжийг асаахгүй, асаалттай төхөөрөмжийг унтраахгүй байхыг зөвлөдөг бөгөөд учир нь эдгээр үйлдэл төхөөрөмжид өөрчлөлт оруулах, мэдээлэл алдагдах эрсдэлд хүргэнэ. Компьютерын шинжээчийг бүрэлдэхүүнд багтаах нь эдгээр төхөөрөмжийг эрсдэлгүй хурааж авах боломж олгоно. Cloud буюу интернэт орчинд хадгалсан мэдээллийг боломжтой бол нэн даруй татаж авна.

Хамсаатнуудыг болон бусад ул мөр тогтоох боломжтой эд зүйлс. Эдгээр зүйлсэд гэрэл зураг, бичлэг, олон нийтийн сүлжээн дэх харилцааны талаарх мэдээлэл, тэмдэглэлийн дэвтэр, нэрийн хуудас, календарь, хог хаягдал зэрэг хамаарна.

Орлого эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйл. Эдгээр зүйлсэд мөнгөн дэвсгэрт, үнэт металл, үнэт эдлэл, санхүүгийн хэрэглүүр буюу хувьцаа, урлагийн бүтээл, цуглуулга зэрэг багтана. Боломжтой бол криптовалютыг аюулгүй, мөрдөгчийн хяналт бүхий данс (Wallet)-нд байршуулна.[a]

Урж жижиглэсэн цаас. Хэрэв боломжтой бол, урж жижиглэсэн материалыг сэргээх ёстой.

а. Найман Гибсон Миралис (NGM). "Сэжигтний биткойныг хураан авах: Алхам тутмын зааварчилгаа." NGM вэбсайт (2020 оны 5-р сарын 11-нд шинэчилсэн мэдээлэл).https://ngm.com.au/seizing-bitcoin-guide/

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй алба хаагч хураан авсан баримт бичигт үзлэг хийж эд хөрөнгө, хамсаатнуудын байж болзошгүй газрын талаарх мэдээлэл байгаа эсэхийг шалгаж шаардлагатай тохиолдолд эд хөрөнгийг үрэгдүүлэх, шилжүүлэхээс урьдчилан сэргийлж шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хойшлуулшгүй ажиллагаа явуулна. Хэрэв мөрдөн шалгах ажиллагааны тухай бусад улсын эрх бүхий байгууллагад хандсан бол нэгжлэг хийх мөрдөн шалгах ажиллагаа явуулсан талаар нэн даруй мэдэгдэх нь эерэг үр дүнд хүргэдэг.

3.4.9 Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах

Энэ төрлийн гэмт хэрэгт мэдээлэл баримт бичиг гаргуулан авах нь чухал үр нөлөөтэй. Ихэнх тохиолдолд шүүхийн зөвшөөрөл шаардагдах баримт бичигт банк, хууль, санхүү, даатгал, шуудан, хүргэлт, цахим шуудан, олон нийтийн сүлжээний платформ, онлайн дэлгүүр, нийтийн аж ахуйн үйлчилгээ, интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хадгалагдаж буй мэдээллүүд хамаарна. Мэдээлэл баримт бичиг гаргуулан авах процесс нь нэгжлэг хийх, хураан авах ажиллагаа явуулах зөвшөөрөл авахтай ижил юм. (3.4.8 дугаар хэсгээс нэгжлэг хийх, хураан авах ажиллагаа явуулах зөвшөөрөл авах тухай нэмэлт мэдээлэл авна уу).

Нэгжлэг хийх зөвшөөрөл авах процесстой адилаар мэдээлэл баримт бичиг гаргуулан авах зөвшөөрөл авахад улс орон тус бүр өөрсдийн онцлогоос шалтгаалж ялгаатай

байж болно. Нийтийн эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад дэлгэрэнгүй жагсаалт шаардлагатай бол эх газрын эрх зүйн тогтолцоот орнуудад хуульд заасан "гэмт хэрэгтэй холбоотой бүхий л баримт бичиг" гэх мэт заалтыг үндэслэл болгоход хангалттай байдаг. Байгууллагууд гаргаж өгч буй мэдээлэл, баримт бичгийн хэмжээг хязгаарлахыг шаардаг тул мэргэжилтнүүд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг тусгасан тодорхой жагсаалтыг хуульд заасан үндэслэлийн хамт гаргах буюу эдгээд хоёр аргыг хослуулах нь илүү үр дүнтэй гэж үздэг. Хэрэв алба хаагчийн зөвшөөрөл авахаар гаргаж өгсөн албан бичиг хангалттай мэдээлэл агуулаагүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу авах эрсдэлтэй. Шигтгээ 3.9-с санхүүгийн байгууллагаас мэдээлэл баримт бичиг гаргуулж авахад тусгах мэдээллийг харна уу.

Шаардлагатай баримт бичгийг цуглуулахын тулд албан бичигт дэлгэрэнгүй мэдээлэл заах хэрэгтэй ч алба хаагч хэрэгт ач холбогдолгүй мэдээлэл гаргуулж авахаас зайлсхийхийг эрмэлзэнэ учир нь мөрдөгч, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй ажлын хэсэг их хэмжээний санхүүгийн баримтад зохих хугацаанд үзлэг хийх боломжгүй юм. Их хэмжээний мэдээлэл шаардах нь баримт бичгийг гаргаж өгөх хугацааг удаашруулах эрсдэлтэй, түүнчлэн мэдээлэл гаргаж өгч буй байгууллага баримт бичгийг бэлтгэхэд нэмэлт хугацаа шаардагдаж болно. Үүнээс гадна мэдээлэл гаргаж буй байгууллага мэдээлэл, баримт бичиг гаргуулж авах зөвшөөрлийг хэрэгт ач холбогдолгүй гэх үндэслэлээр маргаан үүсгэх, эсхүл мэдээллийг гаргаж өгөх нь хэт хүндрэлтэй, эсхүл зарлагатай гэх шалтгаанаар гаргаж өгөхөөс татгалзаж болно.[24]

ШИГТГЭЭ 3.9 Санхүүгийн байгууллагаас гаргуулан авах баримт бичгүүд

Мөрдөгч ихэнх тохиолдолд санхүүгийн байгууллагаас мэдээлэл, баримт бичиг гаргуулж авахдаа данс, хувь хүн, тэдний хамаарал бүхий этгээд, ойрын хамтрагч, хамааралтай бусад байгууллагын талаарх шаардлагатай мэдээллийг жагсаалтаар гаргаж өгдөг. Энэ тохиолдолд Санхүүгийн тагнуулын алба эсхүл Төв банкны мэргэжилтнүүдээс хэрэгт хамаарал бүхий баримт бичгийг тодорхойлоход туслалцаа авч болно. Гаргуулж авч болох зарим баримт бичгийг доор харуулав. Үүнд:

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[24] Мэдээллийг задруулж буй этгээдийн маргааны өөр нэг нийтлэг үндэслэл бол давуу эрх (хуульч болон үйлчлүүлэгчийн хоорондох давуу эрх гэх мэт) юм. Дотоодын өмгөөлөгчийн тухайд хуульчийн мэргэжлийн давуу эрх хамаарах эсэх, хэр хэмжээгээр харьяаллын хувьд ялгаатай байдаг. Жишээлбэл, АНУ-д тодорхой нөхцөл байдалд дотооддоо өмгөөлөгч авах хүсэлт гаргаж болно. Kevin C. Baltz-г үзнэ үү. 2018. "АНУ: Арваннэгдүгээр бүлэг: Байшин доторх өмгөөлөгчийг чөлөөлөх—Нотлох эрхийг хадгалах, хамгаалах." Mondaq.com, 2018 оны 9-р сарын 18 (2020 оны 5-р сарын 11-нд шинэчилсэн мэдээлэл). https://www.mondaq.com/united-states/Litigation-Mediation-Arbitration/66334/Chapter-Eleven-Depositions-Of-In-House-Зөвлөгөө9472Эрх ямбаа хадгалах, хамгаалах. Гэсэн хэдий ч Европын холбооны хүрээнд (ЕХ) дүрэм, дотоод хуульчдын бэлтгэсэн баримт бичигт давуу эрх олгохгүй. Америкийн хуульчдын холбоог үзнэ үү. (ABA). 2010. "Өнөөгийн хэвээр байх нь: ЕХ-ны шүүх хуульчийн мэргэжлийн давуу эрхийн хамрах хүрээг хязгаарлаж байна." Бизнес Өнөөдөр хууль, 2010 оны 9-р сарын 20. https://www.americanbar.org/groups/business_law/publications/blt /2010/09/keeping_current_balfour/

ШИГТГЭЭ 3.9 Санхүүгийн байгууллагаас гаргуулан авах баримт бичгүүд

- Данс нээлгэхэд шаардлагатай бүх төрлийн бичиг баримт буюу хамтран эзэмшигчийн талаарх мэдээлэл (Швейцар улсын "Маягт А"), итгэмжлэл, гарын үсгийн баталгаа, байгууллага нэгтгэх болон хамтран ажиллах гэрээ, түүнчлэн сэжигтний өөрийн нэр дээр болон итгэмжлэлийн дагуу нээсэн, гарын үсэг зурсан, бусад энэ төрлийн хамааралтай данс нээлгэхэд гаргаж өгсөн хувийн бичиг баримтын хуулбар.
- Харилцагчийн хувийн хэрэг, үйлчлүүлэгчээ мэдэх систем (know your customer) дахь мэдээлэл, үйлчилгээ хариуцсан менежерийн тэмдэглэл, үйлчлүүлэгчийн санхүүгийн байдал, арилжаа, гүйлгээтэй холбоотой бүх төрлийн баримт бичиг (гэрээний хуулбар, дансны хуулга, банкны баталгаа, хамтрагч байгууллага, охин компаниудын жагсаалт)
- Зээлийн баримт, ипотекийн зээлийн талаарх мэдээлэл, зээл хүссэн өргөдөл, барьцаа хөрөнгө, орлого, эд хөрөнгө, хувийн болон үйл ажиллагааны талаарх мэдээлэл
- Үнэт цаас, брокерын данс, тэдгээр дансны хуулга
- Эд хөрөнгөө захиран зарцуулсан талаарх баримт бичиг, мэдээлэл, эсхүл энэ талаар банкны өгсөн зөвлөгөө
- Тодорхой хугацаанд хийсэн бүх гүйлгээ
- Санхүүгийн байгууллагын ажилтны гаргаж өгсөн сэжигтэй гүйлгээний талаарх мэдээлэл, түүнчлэн Санхүүгийн тангуулын албанд хүргүүлээгүй байж болзошгүй мэдээлэл
- Дансны гүйлгээтэй холбоотой баримт бичиг буюу үйлчлүүлэгчдийн захиалга, орлого, зарлагын баримт, банкны мэдэгдэл, чек
- Электрон шилжүүлгийн талаарх баримт бичиг буюу хүсэлт, зөвлөгөө, баталгааны хуудас, бусад холбогдох бичиг баримт (4 дүгээр бүлгийн Шигтгээ 4.1-ээс электрон гүйлгээтэй холбоотой мэдээллийг харна уу)
- Санхүүгийн байгууллагад хадгалж буй захидал харилцааны мэдээлэл, банкны дотоод мэдэгдлүүд, үйлчлүүлэгчдийн ирсэн, явсан бүртгэл, утсаар өгсөн захиалга, и-мэйл, факс, үйлчилгээ хариуцсан менежерийн тэмдэглэл, зөвлөгөө, гүйлгээний бүртгэл
- Зээлийн болон төлбөрийн картын мэдээлэл, аппликейшн, дансны хуулга, зээлийн болон гүйлгээний картын ажилтантай хийсэн гүйлгээ, сэжигтний ашигладаг бусад хүний нэр дээрх дансны мэдээлэл
- Хадгаламжийн хайрцгийн талаарх мэдээлэл буюу гэрээ, ирсэн, явсан бүртгэл, хяналтын камерын бичлэг (хадгаламжийн хайрцагт байгаа зүйлсийг харуулснаас бусад)
- Хэрэгт ач холбогдол бүхий бусад баримт бичиг

Санхүүгийн байгууллагаас мэдээлэл, баримт бичиг гаргуулж авах зөвшөөрлийн жишээг Хавсралт Е-аас харна уу.

Мэдээлэл хадгалах тухай хууль, хадгалах тушаал, мөн "устгахыг хориглоно" гэсэн тушаалууд мөрдөгдөж байгаа тохиолдолд - тодруулагч байгууллага мөрдөн байцаалтын явцад хамааралтай байж болох бүртгэлийг хөтөлнө (Шигтгээ 3.10-ыг харна уу) – мэргэжилтнүүд баримт нотолгоо бүрийг ашиглаж, хэргийг үе шаттайгаар мөрдөх ёстой (тусгайлан нарийн төвөгтэй хэргүүдийг). Тиймээс юуны түрүүнд зайлшгүй гэж үзсэн зүйлсийг тодруулан, хэргийн хамрах хүрээ томрох үед дараагийн арга хэмжээг авна. Боломжит санамсаргүй байдлаар мэдээлэл устахаас урьдчилан сэргийлэх үүднээс бусад давхар хадгалалт, бүртгэлийг үүсгэх ёстой. Боломжтой нөхцөлд баримт бичгүүдийг газар дээр нь ангилах нь холбогдох

хүмүүсийг ангилахад илүү хялбар болгоно. Энэ арга барилаар ажилласнаар хамааралгүй байж болох бичиг баримтыг ялгаж цаг хэмнэх боломжтой юм.

Хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд хүсэлт гаргагч байгууллага зорилтоос гажихгүйн тулд өргөдлийг мэдэгдэлгүйгээр авч үзэж болно. Мэргэжилтнүүд иргэдэд мэдээлэл өгөхдөө эрсдэлийг үнэлж, шаардлагатай бол хөрөнгийг хязгаарлах эсвэл хураах арга хэмжээг авах ёстой.[25]

3.4.10 Тодорхой бус хөрөнгийн мэдүүлэг

Зарим хууль эрх зүйн хүрээнд хөрөнгө орлогын хэмжээ нь тэдний үндсэн орлогоос давсан байвал тухайн этгээд тус орлогыг тайлбарлах шаардлагатай болно. Ийм тохиолдолд тухайн этгээдээс хөрөнгийг хэрхэн эзэмшсэн тухай мэдүүлэг авах, шаардлагатай бичиг баримтыг шаардаж болно.

ШИГТГЭЭ 3.10 Хадгалах шийдвэр

Ихэнх улс орнуудад бизнес эрхлэгчид (банк, нягтлан бодогч, хуульч, интернэт үйлчилгээ үзүүлэгч (ISP), утасны компаниуд гэх мэт) харилцагчийн мэдээлэл, бүртгэлийг тогтсон хугацаанд хадгалан хамгаалах хуультай байдаг. Энэ тогтсон хугацаа нь бизнесийн төрлүүдээс хамаарч хэдэн сараас хэдэн жил хүртэл өөр өөр байж болно. Мөрдөн байцаалтын явцад мэргэжилтнүүдэд харилцагчдын хувийн мэдээллийг ил болгох эсхүл хүсэлтийн дагуу гаргаж өгөх хангалттай нотлох баримт болохгүй байх магадлалтай. Гэхдээ олон улсад шүүх эрх мэдлийн хүрээнд энэ асуудлыг хадгалах тухай тушаал болон "устгахыг хориглоно" тушаалаар шийдвэрлэдэг.

Энэхүү тушаалууд нь баримт бичиг эзэмшигч нь хуульд заасан хугацаанаас өмнө хэрэгтэй холбоотой баримт бичгийг хадгалах зохицуулалт болдог бөгөөд ингэснээр холбогдох мэдээлэл, нотлох баримтыг алдахаас сэргийлдэг. Тус тушаалыг хэрэгжүүлэх нь мэдээллийг ил болгох тушаалтай харьцуулахад бага ач холбогдолтой тул мөрдөн байцаалтын эхний үе шатанд хэрэгжүүлэхэд тохиромжтой. Мэргэжилтнүүд бичиг баримтыг хаана хадгалахаа тогтоох ёстой; мөн зөвшөөрөгдсөн болон шаардлагатай тохиолдолд хадгалах тухай тушаалыг гаргуулна. Энэхүү арга хэмжээнүүд нь холбогдох мэдээллийн нууцлалыг хадгалахад тусалдаг.

Эдгээр тодорхой бус хөрөнгө орлогын эх үүсвэрийг авлигын орлогын хөрөнгөөр олж авсан гэж сэжиглэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд мэргэжилтнүүдэд хөрөнгө орлогын эх үүсвэрийн талаар чухал мэдээллийг олж авах хэрэгтэй.[26]

Тодорхой бус хөрөнгө орлогын эх үүсвэр болон тэдгээртэй холбоотой хууль тогтоомж нь хөрөнгө орлогыг хууль ёсны эсэхийг нотлох үүргийг хөрөнгө өмчлөгчид шилжүүлдэг. Хэрэв хөрөнгө өмчлөгч нь тус хөрөнгийг хууль ёсны эсэхийг нотолж чадаагүй гэж үзвэл хөрөнгө өмчлөгчийг ямар нэгэн урьдчилсан

[25] Эрх зүйн харилцан туслалцаа шаардагдах тохиолдолд мэргэжилтнүүд хүсэлт гаргасан улсын мэдээлэл ил болгох хууль эрх зүйн талаар мэдэж байх ёстой. Ийм тохиолдолд тэд хүсэлтийг илгээхээсээ өмнө энэ асуудлыг анхааруулах ёстой. Нэмэлт мэдээллийг 8-р бүлгийн 8.3.4-с үзнэ үү.

[26] Рэйчел Дэвис Тека. 2017. "Тодорхойгүй баялгийн захиалга: Товч гарын авлага." Transparency International Их Британи, 2017 оны тавдугаар сарын 30. https://www.transparency.org.uk/unexplained-wealth-orders-brief-guide

гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нотлох шаардлагагүйгээр хууль бус гэж үзэж болно. Их Британийн эх сурвалж нь тодорхой бус хөрөнгө орлогыг шийдвэрлэж байгаа сүүлийн үеийн жишээг Шигтгээ 3.11-ээс харна уу.

3.4.11 Цахим тандалт

Сэжигтний ашиглаж буй гар утас, харилцаа холбоо, компьютер эсвэл бусад цахим харилцаа холбоог нууцаар хянах талаар энэхүү гарын авлагад "цахим ажиглалт" гэх – хууль сахиулах байгууллагын ажилтнуудын биеэр тандахтай төстэй болон нэмэлтээр хэрэгжүүлэх ажиллагааг хэлнэ. (3.4.3 хэсэг). Мөн цахим тандалт нь хүн хүч их шаарддаг, зардал өндөртэй, ажиллагаа ихтэй техник ажиллагаа юм. Тиймээс, яллагдагчийн хувийн нууц, процессын явцад эдлэх эрхийг хамгаалахын тулд шүүх, эсхүл бусад тусгай эрх бүхий байгууллага хянан үздэг байхыг олон улсууд шаарддаг. Зарим оронд шүүхийн зөвшөөрөл авах шаардлагагүй тохиолдолд талуудын аль нэгтэй нь (жишээлбэл, хамтран ажиллаж байгаа гэрч, мэдээлэгч эсхүл нууц ажилтан) урьдчилан зөвшилцсөний дагуу хяналт тавихыг зөвшөөрдөг.[27] Ямарч тохиолдолд, цахим ажиглалтыг дотоодын хууль тогтоомж болон дүрэм, журамд заасан хэлбэрээр явуулсан байх ёстой. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс өөрсдийн харилцаа холбоогоо хамгаалах хамгийн дэвшилтэт арга техникийг ашиглахад бэлэн байдгийг, ялангуяа өөрсдийн хамтран ажиллаж байгаа хүмүүс, сүлжээгээ тусгай төхөөрөмжөөр хангаж, шифрлэгдсэн мэдээлэл солилцож байдгийг цахим ажиглалт, тандалт хариуцан ажиллаж буй практик ажилтнууд анхаарч үзэх хэрэгтэй. Зарим нөхцөлд, хууль сахиулах байгууллагууд шифрлэхээс өмнө эдгээр харилцаанаас мэдээлэл, өгөгдлийг авахын тулд тусгай программ хангамжийг ашиглаж болно.[28]

Тэд мөн тасалдсан харилцаа бүрийн сэдэв, цаг, огноо, ярианы үргэлжлэх хугацаа болон бусад холбогдох мэдээллийг бүртгэхдээ маш чамбай байх ёстой. Мөн түүнчлэн, эх бичлэгийг нотлох баримт болгон хадгалахын тулд аюулгүй байдлыг ханган, зохих ёсоор битүүмжилж, найдвартай нөхцөлд хадгалах ба хуулбарыг нь авах боломжтой байх ёстой. Гадаад хэл дээр яриа явагдаж байгаа нөхцөлд мөн орчуулгын үйлчилгээ шаардагдах болно. Цаг хугацаанаас хамааран өгөгдөх боломжтой мэдээллийг хурдан шуурхай шийдвэрлэх, дараагийн үйлдлүүдийг зөв уялдуулахын тулд өдрийн 24 цагаар, 7 хоногийн бүх өдрүүдэд хяналтыг үргэлжлүүлж байх ёстой. Харах боломжтой болон дуут нотлох баримтыг бүрдүүлэхийн тулд салбарын мэргэжилтнүүд нь цахим хяналтын багтай нягт уялдаатай ажиллах биет хяналтын багийг ажиллуулах талаар давхар бодолцох хэрэгтэй байдаг.

---

[27] АНУ-д тодорхой зөвшилцлийн дагуу хяналт тавихыг зөвшөөрдөг. Дэлгэрэнгүй мэдээллийг АНУ-ын Хууль зүйн яамны Хууль зүйн гарын авлагын 9-р бүлгээс үзнэ үү. 7.301, https://www.justice.gov/jm/jm-9-7000-electronic-surveillance#9-7.301. Холбооны цахим тандалтын дүрмийг (ихэвчлэн "Гарчиг III" гэж нэрлэдэг) 18 U.S.C.-д кодлогдсон байдаг. Зөвшилцлийн дагуу хяналт тавихыг зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхийн шийдвэр шаардлагатай (жишээлбэл, Украинд)

[28] Martin Untersinger and Jacques Follorou. 2020. "EncroChat, cette mystérieuse société technologique prisée par le crime organisé" [EncroChat, this mysterious technological company prized by organized crime]. Le Monde, 2020.07.03 (accessed 2020.07.09-нд шинэчлэгдсэн.). https://www.lemonde.fr/pixels/article/2020/07/03/encrochat -une-societe-technologique-mysterieuse-prisee-par-le-crime-organise_6045126_4408996.html.

ШИГТГЭЭ 3.11 Их Британи: Тайлбарлагдаагүй хөрөнгө орлогын талаарх шийдвэрийг гаргах, гүйцэтгэхэд тавигдах шаардлага

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль: 2016 оны 04 дүгээр сард батлагдсан Их Британи улсын "Үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай, 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Их Британи улсын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хуулийг Хатан хаан соёрхон баталсан. Уг хуулийн 1-р хэсгийн 1-р бүлэгт "Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоол"-ыг иргэний эрх болон мөрдөн байцаах ажиллагааны хэрэгсэл болгон танилцуулсан. Хөрөнгө эзэмшигч нь тодорхой шалгуурыг хангасны дараа хөрөнгө орлогын эх үүсвэр нь хууль ёсны гэдгийг нотлох шаардлагатай болсон.[a] Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоол нь эд хөрөнгийг хураан авах тухай бус, харин гэмт хэргийн шинжтэй олсон орлогыг мөрдөн шалгах хэрэгсэл юм.

Дээд шатны шүүхийн эрх мэдэл: Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх газар, Их Британийн Гаалийн газар, Санхүүгийн хяналтын газар, Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга эсвэл Улсын прокурорын газрын дарга зэрэг хэрэгжүүлэх эрх бүхий[b] байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу шүүхээс тодорхой хөрөнгийн эх үүсвэрийг тайлбарлах шаардлагатай гэж үзвэл Дээд шүүх тухайн хөрөнгийн талаар "Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоол" гаргаж болно.

Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоолын шаардлага: Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоолыг Дээд шүүхээс гаргахдаа тухайн хөрөнгөө эзэмшигч нь 50,000 фунт стерлингээс дээш үнэтэй хөрөнгийг олж авсан эх сурвалж, орлогоо нотлох шаардлага тавьдаг.[c] Мөн Дээд шүүх нь хариуцагч этгээд нь улс төрийн нөлөө бүхий эсхүл онц хүнд гэмт хэрэгт холбогдоогүй гэдгийг батлахыг шаарддаг.[d]

Улс төрд нөлөө бүхий этгээд: Дээрх хуульд улс төрд нөлөө бүхий этгээд гэдэгт Олон улсын байгууллага болон Их Британи улсаас өөр улсад томоохон албан тушаал хашдаг этгээд; Европын эдийн засгийн бүсээс гадна (ЕЕА); эсхүл улс төрийн нөлөө бүхий этгээдийн гэр бүл, ойрын хамаатан; эсхүл уг этгээдтэй ойр харилцаатай албан тушаалтныг багтаасан.[e] Үндэслэлгүй хөрөнгийн талаарх шийдвэр нь Европын эдийн засгийн бүсэд хамаарахгүй орны улс төрд нөлөө бүхий этгээдийг хүнд гэмт хэрэгт холбоотой байхыг шаарддаггүй.[f]

Хариуцагчийн үүрэг: Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоол нь хариуцагчийг тухайн хөрөнгөө хууль ёсны дагуу эзэмшиж, олж авсан талаар тайлбарлахыг шаарддаг. Тодруулбал, хариуцагч тухайн хөрөнгийн ашиг сонирхлын шинж чанар, цар хүрээний талаар мэдүүлэг өгөх, эд хөрөнгөө хэрхэн олж авсан тухайгаа тайлбарлах,[g] эд хөрөнгө итгэмжлэгдсэн хүмүүсийн эзэмшилд байгаа бол төлбөр тооцооны нарийвчилсан мэдээллийг тусгах, холбогдох мэдээлэл, баримт бичгийг бүрдүүлэх шаардлага тавьдаг.[h]

Арга хэмжээ: Хариуцагч нь хариу өгөх тогтоосон хугацаа дуусахаас өмнө ямар нэгэн үндэслэлгүйгээр тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоолын шаардлагыг биелүүлээгүй бол дараагийн арга хэмжээ болох хөрөнгийг нөхөн төлүүлэх үндэслэлтэй хэмээн үзнэ.[i]

Үр дагавар: Хариуцагч төөрөгдүүлэх зорилгоор худал мэдүүлэг өгсөн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хэмээн тооцож 2 жил хүртэл хорих ял оноох, торгох, эсвэл аль алийг нь оноох, яллагдагчаар татсан тохиолдолд 12 сар хүртэл баривчлах, торгох, эсвэл аль алийг оноож болно.[j]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 3.11 Их Британи: Тайлбарлагдаагүй хөрөнгө орлогын талаарх шийдвэрийг гаргах, гүйцэтгэхэд тавигдах шаардлага

Хөрөнгийг хугацаатайгаар царцаах (IFOs): Хууль сахиулах байгууллагаас Дээд шүүхийн шийдвэрийг харгалзан хөрөнгийг шууд хураах нь эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд хугацаатайгаар хөрөнгийг царцаах аргыг хэрэгжүүлж болдог.[k] Энэхүү шийдвэр гарсан тохиолдолд хариуцагч болон ашиг сонирхлын холбоотой этгээд нь царцаасан хөрөнгийг ашиглах боломжгүй болдог.[l] Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоол болон хугацаатайгаар хөрөнгийг царцаах арга хэмжээг нэг баримт бичигт нэгтгэж болно.[m]

a. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль 2017, 22-р бүлэг, 1-р хэсэг: Гэмт хэргийн орлого, 1-р бүлэг: Мөрдөн байцаалт (2017) https://www.legislation.gov.uk/ukpga/2017/22/contents/enacted;
b. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362A бүлэг, 7-р хэсэг.
c. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362B бүлэг, 2(a), 2(b), 3-р хэсэг.
d. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362A бүлэг, 4-р хэсэг.
e. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362B бүлэг, 7-р хэсэг.
f. "Мэдэгдэл 003/2018" 2-р хэсэг.
g. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362A бүлэг, 3-р хэсэг.
h. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362A бүлэг, 5-р хэсэг.
i. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362C бүлэг, 1,2-р хэсэг.
j. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362E бүлэг, 1,2-р хэсэг.
k. Анхны тодорхой бус хөрөнгө орлогын тухай тушаалыг Их Британи Улсын Гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний агентлаг 2018 оны 2-р сард нийт 22 сая фунт стерлингийн үнэ бүхий хоёр үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулсан бөгөөд энэ нь улс төрийн нөлөө бүхий этгээдийн эзэмшилд байдаг гэж үзсэн. Тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоолоос гадна хөрөнгийг худалдах, шилжүүлэх, тараахаас урьдчилан сэргийлэхийн тулд хугацаатайгаар хөрөнгийг царцаах арга хэмжээг авсан. https://www.riskscreen.com/kyc360/news /uk-secures-first-unexplained-wealth-orders-property-owned-pep/. Замира Хажиевагийн хэргийг Дээд шүүх хэрэгсэхгүй болгож, давж заалдах шатны шүүхээс дараагийн давж заалдах гомдлыг мөн хэрэгсэхгүй болгожээ. www.nationalcrimeagency.gov.uk/news/court-dismisses-uwo-appeal-by-zamira-hajiyeva. Лидсийн бизнесмен ноён Мансур Хуссейн тухайд тодорхой бус хөрөнгө орлогын тухай тогтоол нь зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдсон гэх үндэслэлээр олж авсан анхныхаас гадна тодорхой бус хөрөнгө орлогын тухай хэрэгт 10 сая фунт стерлингийн төлбөр төлж барагдуулсан анхны буцаалт юм. https://www.nationalcrimeagency.gov.uk/news/businessman-with-links-to-serious criminals-loses-property-empire-after-settling-10m-unexplained-wealth-order-case.
l. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362J бүлэг, 3-р хэсэг.
m. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн хууль, 362J бүлэг, 4(c)-р хэсэг.

Цахим тандалтын хэрэгжүүлж байгаа мэргэжилтнүүд гэмт хэрэгт холбогдсон этгээдүүд харилцаа холбооны нууцлалаа хамгаалах хамгийн дэвшилтэт арга техник, тэр дундаа үйлчлүүлэгчдэдээ тусгай үйлчилгээ үзүүлдэг сүлжээг ашиглахад бэлэн байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

Нэмж дурдахад тэд эх бичлэгийг зохих журмын дагуу битүүмжилж, найдвартай, аюулгүй орчинд хуулбартай хамт хадгалж нотлох баримт болгон хамгаалах ёстой. Гадаад хэл дээрх харилцан яриаг орчуулах шаардлага гарч болзошгүй. Цагийн нарийвчлалтай мэдээллийг хурдан шуурхай шийдвэрлэх, дараагийн үйлдлүүдийг зөв уялдуулан хэрэгжүүлэхийн тулд харилцаа холбооны хяналтыг 7 хоногийн 7 өдөр, 24 цагийн турш хэрэгжүүлэх шаардлага тавигддаг. Мэргэжилтнүүд цахим тандалтын багтай нягт уялдаатай ажиллах ба биечилсэн хяналтаар дүрс болон дуут нотлох баримтыг баримтжуулж авна.

3.4.12 Гүйцэтгэх ажил

Сэжигтний орон зайд нэвтэрч, хөрөнгийн талаарх нотлох баримт, мэдээллийг илрүүлэх өөр нэг мөрдөн шалгах арга нь гүйцэтгэх ажил юм. Хөрөнгө буцаах хэрэгт нууц ажилтнаар дамжуулан хяналттай хүргэлт хийх аргыг хэрэглэж болно. Гэхдээ

энэ ажиллагаа нь хууль эрх зүйн болон процедурын хувьд зардал өндөр, төвөгтэйгөөс гадна эрсдэл дагуулдаг. Бусад аргын нэгэн хангалттай нотлох баримт цуглуулахын тулд хуулийн хатуу шаардлага, журмыг чанд мөрдөх ёстой болдог. Энэхүү ажиллагааг хэрэгжүүлэх мөрдөгчид нарийн ур чадвартай, бэлтгэгдсэн, тухайн ажиллагаанд тохирсон байх ёстой. Гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэх мэргэжилтнүүд мэдээлэгч болон сэжигтнүүдийн уулзалтыг бүртгэх, хянах хүчин чадал бүхий тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой бөгөөд тэдний аюулгүй байдлыг давхар хангах шаардлагатай.[29]

Мэдээлэгчийн гаргаж өгсөн мэдээлэл найдвартай эсэх тал дээр асуудал гардаг тул гүйцэтгэх ажилтныг ашиглахыг илүүд үзэх тал бий. Мэдээлэгч ашиглах нь цорын ганц сонголт бол хууль сахиулах байгууллагын нууц мэдээллийн санд албан ёсоор бүртгэлжүүлэх, тодорхой, товч бичгээр зааварчилгаа өгөх, зааварчилгааг ойлгосон тухай бичгэн хэлбэрээр гарын үсэг зуруулж санд хадгалах нь зүйтэй. Мөн мэдээлэгчийн тээврийн хэрэгсэл болон бусад холбогдох эд зүйлсийг аливаа ажиллагаанд явуулахын өмнө шалгах хэрэгтэй. Эцэст нь мэргэжилтэн болон мэдээлэгчийн аюулгүй байдал нэн тэргүүнд тавигддаг тул уулзалт хаана болж байгааг хянах, үйл ажиллагааны явц, аюулгүй байдлыг хангахад хамгийн таатай орчныг сонгох нь чухал юм.

Ном зүй

References Attisso, Kodjo. 2010. “The Recovery of Stolen Assets: Seeking to Balance Fundamental Human Rights at Stake.” Working Paper No. 08, International Center for Asset Recovery (ICAR), Basel Institute on Governance, Basel, Switzerland. https://www.baselgovernance.org/sites/default/files/2019-06/biog_working_paper_08_EN.pdf.

Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms and Protocol (European Convention on Human Rights), Council of Europe (1950, in force 1953). https://www.echr.coe.int/Documents/Collection_Convention_1950 _ENG.pdf.

Egmont Group (Egmont Group of Financial Intelligence Units). 2013. “Principles for Information Exchange Between Financial Intelligence Units.” Document approved by the Egmont Group Heads of Financial Intelligence Units, Egmont Group, Toronto. https://egmontgroup.org/en/document-library/8.

FATF (Financial Action Task Force). 2019. “International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations.” Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf /documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

Greenberg, Theodore S., Larissa Gray, Delphine Schantz, Carolin Gardner, and Michael Latham. 2010. Politically Exposed Persons: Preventive Measures for the Banking Sector. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank.

[29] Жишээлбэл, мэдээлэгч, албан тушаалтан эсвэл зөвшөөрөл гаргасан талууд биедээ утас эсвэл бусад далд дамжуулагч төхөөрөмж (магадгүй үзэг, гар утас, тамхины хайрцаг, цүнх, зөөврийн компьютерт нуугдсан төхөөрөмж) мөн тусдаа бичлэг хийх төхөөрөмж зэргийг зүүж чанартай бичлэг хийх хэрэгтэй. (учир нь дамжуулагчийн дохио салж, дуу хоолойны чанар муу байж болно) Туршлагаас харахад мэргэжилтнүүд нэр, огноо, цаг, үйл явдлын товч тайлбарыг соронзон хальсны бичлэгийн оршил хэсэгт бичиж үлдээх нь тустай.

IMF (International Monetary Fund) and World Bank. 2004. Financial Intelligence Units: An Overview. Washington, DC: IMF. https://www.imf.org/external/pubs/ft/fiu/fiu.pdf.

Perdriel-Vaissиre, Maud. 2017. “France’s Biens Mal Acquis Affair: Lessons from a Decade of Legal Struggle.” Paper, Legal Remedies for Grand Corruption series, Open Society Foundations, New York. https://www.justiceinitiative.org/uploads/8e7d1268-b5fb-44cf-b549-bc0ed6500667/legal-remedies-11-perdriel-20170612.pdf.

Rossi, Ivana M., Laura Pop, and Tammar Berger. 2017. Getting the Full Picture on Public Officials: A How-To Guide for Effective Financial Disclosure. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star / files/getting-the-full-picture-on-public-officials-how-to-guide.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations International Covenant on Civil and Political Rights, UN General Assembly Resolution 2200A (adopted December 16, 1966, effective March 23, 1976), United Nations, New York. https://treaties.un.org/doc /Treaties/1976/03/19760323%2006-17%20AM/Ch_IV_04.pdf.

Universal Declaration of Human Rights, UN General Assembly Resolution 217A (December 10, 1948), United Nations, New York. https://www.ohchr.org/EN/UDHR / Documents/UDHR_Translations/eng.pdf. Securing Evidence and Tracing Assets (1): Investigative Measures I 109

van der Does de Willebois, Emile, Emily M. Halter, Robert A. Harrison, Ji Won Park, and J.C. Sharman. 2011. The Puppet Masters: How the Corrupt Use Legal Structures to Hide Stolen Assets and What to Do about It. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star/files /puppetmastersv1.pdf.

World Bank. 2012. Public Office, Private Interests: Accountability through Income and Asset Disclosure. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https:// star.worldbank.org/sites/star/files/Public%20Office%20Private%20Interests.pdf.

4. Нотлох баримтыг хамгаалах болон Хөрөнгийг мөшгих (2): Холбогдох мэдээлэл болон Санхүүгийн баримт бичгүүд

4.1 Удиртгал

Мөрдөн шалгах ажиллагааны явцад баримт бичгийн цаасан болон электрон хувилбарын аль аль нь давхар цуглардаг. Эдгээрт арилжааны банкны данс нээхтэй холбоотой мэдээлэл болон өдрийн тэмдэглэлийн тэмдэглэл; хэрэглэгчийг таньж мэдэх (KYC) болон магадлан шалгалтын баримт бичиг; банк болон санхүүгийн тайлан, мэдээ; болон компанийн гэрээ, хэлэлцээрийг агуулсан хувийн хэрэг; нэхэмжлэх, төлбөр болон цахим шуудангийн захидалыг агуулсан үүсгэн байгуулах дүрэм, журам. Цуглуулсан баримт бичгүүдэд бүх төрлийн харилцаа, холбооны мэдээлэл багтах бөгөөд энэ нь мөрдөгч нарыг бүх төрлийн хэлийг ашиглан цахим шуудангаар дамжуулан мэдүүлэг болон захидлыг цуглуулсан болохыг баталгаажуулна.

Эдгээр баримт, бичиг дээр хийгдэх дүн шинжилгээгээр хөрөнгийн талаарх мэдээллийг илчлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, хуулийн этгээд болон хувь хүн хоорондын холбоо хамаарал болон цаашид хийгдэх мөрдөн шалгах ажиллаганы чиглэлийг тодорхойлно. Энэ бүлэг нь салбарын мэргэжилтнүүд нарт туслалцаа үзүүлэх зорилгоор нийтлэг баримт бичигтэй холбоотой мэдээлэлд холбогдох жишээгээр хангаж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон төлөвлөхийн чухалыг харуулах болно.

4.2 Холбогдох мэдээллийг тодорхойлох: Түгээмэл эх сурвалжид тулгуурласан баримт бичгүүдийн жишээнүүд

4.2.1 Сэжигтэй гүйлгээний тайлан

Сэжигтэй гүйлгээний тайлан (STRs)[1] болон холбогдох баримт бичгүүд нь хуулийн байгууллагын салбарын мэргэжилтнүүдэд сайн эх сурвалжийн мэдээлэл болдог учир нь тэд ихэвчлэн гүйлгээний мэдээлэл, гүйлгээг сэжигтэй гүйлгээнд авах болсон танилцуулга болон санхүүгийн шинжээч[2]-ийн дүгнэлтийг агуулж байдаг. Агуулагдаж байгаа мэдээллийн хэмжээ болон чанар нь сэжигтэй гүйлгээний тайланг бэлтгэсэн хүн эсхүл хуулийн шаардлагаас хамаарч байдаг. Ерөнхий байдлаар сэжигтэй гүйлгээний тайлан (STR) нь дараах үндсэн гол мэдээллүүдийг агуулж байдаг:

- Хөрөнгийн эх үүсвэр болон хүлээн авагчийн мэдээлэл

[1] STR-г зарим улс оронд сэжигтэй үйл ажиллагааны тайлан (SAR) гэж нэрлэдэг.

[2] Зарим улс оронд санхүүгийн тагнуулын алба (CTA) нь STR эсвэл валютын гүйлгээний тайлангийн (CTR) хуулбарыг хууль сахиулах ажилтнуудад өгөхийг зөвшөөрдөггүй. Ийм нөхцөлд тагнуулын тайланг (хэрэв боловсруулсан бол) ихэвчлэн хүсэлтийн дагуу авах боломжтой бөгөөд ижил мэдээллийн ихэнх хэсгийг агуулна.

- Банкны тайлан бэлтгэгч нь сэжиглэх болсон үндэслэлийн тайлбар, сэжиглэх болсонтой холбоотой баримт бичиг болох харилцагчийг таньж мэдэх (KYC) ажиллагааны хүрээнд цугларсан мэдээллийг хавсаргадаг
- Бэлэн мөнгөний давтамжтай хэрэглээ, мөнгөн шилжүүлэг, чек болон цахим төлбөр тооцооны сүүлийн хугацааны мэдээлэл
- Обьектын банканд эзэмшдэг бусад хөрөнгө эсхүл бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээлэл

Зарим улсын хуульд (Тухайлбал Америкийн Нэгдсэн Улсад) мөрдөгч нар нь Санхүүгийн тагнуулын албаны сэжигтэй гүйлгээний тайлан бичихэд ашигласан бүх төрлийн баримт бичигтэй ямар нэгэн албан бичиг шаардахгүйгээр танилцах боломжтой байдаг.

Дээрх мэдээллүүдийг ашиглан салбарын мэргэжилтнүүд мөнгөний ул мөрийг мөшгих зорилгоор санхүүгийн урсгалыг дахин бүтээж, хөрөнгийн эх үүсвэрийг шалгах (хууль бус хөрөнгө эсэх) зорилгоор эсхүл хөрөнгө хаашаа шилжсэн болохыг тогтоох зорилгоор цааш нь хөөж шалгадаг. Эдгээр мэдээллүүд нь цааш банкны дансны хуулгыг мөрдөгчийн тогтоолоор гаргуулан авах, хувь хүнээс мэдүүлэг авах, хуулийн этгээдийг шалгах эсхүл сэжигтний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах ажиллагаа руу хөтөлдөг. Сэжигтэй гүйлгээний тайлантай холбоотой мэдээлэл тодруулахад банкны комплаенсын ажилтантай шууд холбогдох нь ашигтай байдаг бөгөөд, зарим тохиолдолд тэдгээрт обьекттой холбоотой нэмэлт мэдээлэл байх боломжтой байдаг. Санхүүгийн тагнуулын албаны тайлангаас авах боломжтой мэдээллийн жишээг хавсралт С-ээс харна уу.

4.2.2 Харилцах данс нээх баримт бичиг болон харилцагчийг таньж мэдэх эсхүл магадлан шалгалтын баримт бичиг

Салбарын мэргэжилтнүүд нь санхүүгийн байгууллагаас ирүүлсэн харилцах данс нээх баримт бичиг, харилцагчийг таньж мэдэх (KYC) болон магадлан шалгалтын баримт бичиг (CDD) бүртэй няхуур танилцах шаардлагатай.[3] Мөн улс төрд нөлөө бүхий этгээд (PEPs)-эд санхүүгийн байгууллагууд нь тэдний гүйлгээ болон санхүүгийн эх үүсвэрт нэмэлтээр магадлан шалгалтын баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай. Эдгээр баримтууд нь хэрэгцээт мэдээлэл болон боломжит хувилбаруудаар хангах боломжтой. Тухайлбал:

- Банкны өөрийн харилцагч нараар бичүүлсэн дансны гүйлгээ хийх эрх бүхий этгээд болон дансны хуулганы гарын үсэг зэргийг шалгах,
- Банкны харилцагчийн хөрөнгийн эх үүсвэрээ баталгаажуулахаар гарган өгсөн баримт, материалыг шалгах. Жишээ нь гэрээ, захидал, үл хөдлөх хөрөнгийн худалдах гэрээ зэрэг.

---

[3] Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж 10 (Магадлан шалгалтын баримт бичиг [CDD]), “Санхүүгийн байгууллагууд нь эзэмшигчгүй данс эсхүл илт хуурамч нэрээр үүсгэсэн данс байлгахыг хориглоно” (ФАТФ 2019, 12-13). Тэд “холбогдох магадлан шалгалтын баримт бичгийг (i) бизнесийн холбоо тогтоох, (ii) зөвшөөрөгдөх хэмжээнээс дээш хэмжээний гүйлгээ хийх (15,000 ам.доллар/евро) эсхүл мөнгөн гуйвуулга хийх; … (iii) мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлж байгаа талаар сэжиг байгаа; эсхүл (iv) санхүүгийн байгууллагад дансны өмнөх эзэмшигчийн мэдээлэлд эргэлзээ байгаа”. CDD нь “харилцагчийг таних болон харилцагчийн мэдээллийг тогтоох” хэмжээнд; “эцсийн өмчлөгчийг тогтоох болон эцсийн өмчлөгчийг тогтооход шалтгаалах арга хэмжээг авах”; “зорилго болон бизнесийн холбоог ойлгох”; болон “үргэлжилж байгаа магадлан шалгах ажиллагааг гүйцэтгэх”.

- Эцсийн өмчлөгчийг тогтооход туслалцаа үзүүлнэ (Шалгагч нар хаяг, хуулийн этгээд болон хувь хүнийг шалгах)
- Холбогдох хөрөнгийн эх үүсвэрийн мэдээллийг ойлгоход тусална,
- Бэхжүүлсэн нотлох баримтын мэдээлэл, уг үүсвэрийг тодорхойлох,
- Хэрэгцээт гэрч болон мөрдөн шалгах ажиллагааны чиглэлийг тогтоох,
- Объектуудтай уулзалт зохион байгуулахад туслана,
- Данс эзэмших эсхүл дансны гүйлгээ хийх эрх бүхий этгээдээс мэдүүлэг авах,
- Банкны дансны эрх бүхий хуулийн этгээдийг бүртгэлийн гэрчилгээний хүрээнд нягтлах, холбогдох ТУЗ-ын гишүүд болон хувь хүний нэрсийн жагсаалтаас мэдүүлэг авахад тохиромжтой этгээдийг тодорхойлох боломжтой.[4]

4.2.3 Банкны дансны хуулга

Хамгийн эхний алхам бол салбарын мэргэжилтнүүд нь дансанд орсон хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох мөн шилжүүлэгдсэн ямар ч хөрөнгийн эцсийн авсан газрыг тодорхойлох ёстой. Үүнд дансаар хийгдсэн орлого, зарлагын гүйлгээнээс гадна бэлэн мөнгөний орлого, зарлага, мөнгөн гуйвуулга, бонд, чек, зээл болон бусад төлбөрийн хэрэгслүүд багтана. Эдгээр гүйлгээний урсгалуудыг шалгахад төрөл бүрийн төлбөрийн хэрэгслүүдэд өөр өөр төрлийн дараах техникүүд ашиглагдана.

Бэлэн мөнгө. Бэлэн мөнгөний гүйлгээг шалгахад хөрөнгийн эх үүсвэрийн мэдээлэл болон шилжүүлэг хийсэн гүйлгээний мэдээлэл хомс байдгаас шалтгаалан бэрхшээлтэй байдаг. Салбарын мэргэжилтнүүд нь бэлэн мөнгөний орлого болон зарлагын баримтыг банкнаас гаргуулан авснаар гүйлгээ хийж байгаа этгээдийн мэдээллийг тодруулах боломжтой. Бэлэн мөнгөний машин (ATM)-ы байршлаар бэлэн мөнгөний орлого болон зарлагын гүйлгээ хийгчийн мэдээллийг тодорхойлох боломжтой. Мөн салбарын мэргэжилтнүүд нь уламжлалт мөрдөн шалгах ажиллагааны аргачлал болох текст, цахим шуудан, мөнгөн гуйвуулга болон захидлыг ашиглан бэлэн мөнгөтэй холбоотой холбоосыг тогтоох боломжтой (4.2.4 дэх хэсэгт дурьдсанчилан). Тэд нар мөн бусад дансны үйл ажиллагааг хянан аюулгүй орлогын хайрцагны нэвтэрсэн түүхийг харах боломжтой.

Бонд. Бондын орлого нь банкнаас банкны хооронд хийгдэх боломжтой учир салбарын мэргэжилтнүүд нь банкнаас бондтой холбоотой мэдээлэл шалгахад тухайн данс руу хэрхэн орлогодсон зэргийг багтаан бүх төрлийн мэдээллийг асуух хэрэгтэй.

Чек. Чекээр мөнгө орлогодсон тохиолдолд салбарын мэргэжилтнүүдэд холбогдох дансны холбогдох банканд очиж чекийг гаргуулан авсан этгээдийг тодруулах эсхүл цахим бүртгэлийн мэдээллийг шаардах боломжтой. Чекийг баталгаажуулсан тохиолдлуудыг (өөрөөр хэлбэл, бэлнээр мөнгө оруулах, хадгалуулах эсвэл өөр хэн нэгэнд гарын үсэг зурж өгсөн) бэлэн мөнгөний орлогын нэгэн адил авч үзэх ёстой. Тиймээс салбарын мэргэжилтнүүд чекийг баталгаажуулсан хүнийг тодорхойлох ёстой. Мөн "санамж" гэсэн мөрийг хянаж үзэх хэрэгтэй, учир нь энэ нь сэжигтэй үйл ажиллагааг илтгэж магадгүй юм. Жишээлбэл, "менежмент", "зөвлөгөө" болон бусад үйлчилгээтэй холбоотой (охин компани гэх мэт) мэдээлэл нь тус компани

[4] Зарим тохиолдолд , ТУЗ-ийн гишүүд болон халхавч компаниудыг бий болгох үүрэгтэй мэргэжлийн зуучлагч эсвэл үйлчилгээ үзүүлэгчийн ажилтнууд мөрдөн байцаалтад туслах зарим мэдээлэлтэй байж болно.

өөрийн эзэмшдэг хэд хэдэн компаниар дамжуулан гэмт хэргийн орлогыг угааж байгааг харуулж болно.

4.2.4 Мөнгөн гуйвуулга

Өмнө дурдагдсан авлигын хэргүүдээс харахад, санхүүгийн байгууллагад байршуулсан гэмт хэргийн замаар олдсон их хэмжээний мөнгийг аудитын шалгалтаас зугтах, банкны нууцлалын диваажинд байршуулах зорилгоор мөнгөн гуйвуулга (электрон хөрөнгийн шилжүүлэг) ашиглан дэлхийгээр дамжуулан шилжүүлсэн. Мөнгөн гуйвуулга нь харилцагчийн хүсэлтээр (санхүүгийн байгууллага, хуулийн этгээд эсхүл хувь хүн) хаашаа ч хамаагүй буюу дотоод эсхүл олон улсын гүйлгээний шууд шилжүүлэг хийгддэг.[5]

ЗУРАГ 4.1 Ердийн хил дамнасан мөнгөн гуйвуулгын гүйлгээний процесс



Мэдээллийн эх сурвалж. Дэлхийн банк

Хүсэлтийн мэдээллийн гар утасны мессежний систем, цахим шуудан, факс болон гар утасны аппликейшн-ээр хангагддаг. (Зураг 4.1 Ердийн хил дамнасан мөнгөн гуйвуулгын гүйлгээний процесс.)[6]

Зарим тохиолдолд мэргэжлийн зуучлагч, халхавчийн компани үүсгэн байгуулах үйлчилгээ үзүүлэгч компанийн ажилтан болон ТУЗ-ын гишүүн нь мөрдөн шалгах ажиллагаанд хэрэг болохуйц мэдээллийг агуулж байж болно.

Орлогыг эцсийн хүрэх газартаа хүрэхээс өмнө хэд хэдэн санхүүгийн байгууллага, дамжин өнгөрөх эрх бүхий улс орнуудаар дамжуулан корреспондент банкны данс, цуврал шилжүүлэг, халхавч төлбөр, халхавчийн компаниуд болон оффшор бүс нутгуудыг ашиглан мөнгөн шилжүүлгийг давхар хэрэглэж болно. Зарим санхүүгийн байгууллага, өмгөөлөгч, нягтлан бодогчид авлигад идэгдсэн улстөрчид, тэдний төрөл төрөгсөд болон ойр дотны хүмүүст мөнгө угаахад тусгайлан бэлдсэн хуулийн

[5] Энэ нь дор хаяж нэг улсын хил дамнасан мөнгөн гуйвуулга байх боломжтой (Жишээ нь өөр улсад байгаа хүлээн авагч банк). Та бүхэн ФАТФ-ын 15 дугаар зөвлөмж (Мөнгөн гуйвуулга) болон холбогдох тэмдэглэлийг харна уу. (ФАТФ 2019, 15-16, 72-73).

[6] ФАТФ-ын 16 дугаар зөвлөмж нь хил дамнасан мөнгөн гуйвуулга болон дотоодын мөнгөн гуйвуулга, түүний дотор дараалсан төлбөр болон даатгалын төлбөр зэрэгт хамаарна. Зөвлөмж 16-ын “Хамрах хүрээ” хэсгийг харна уу. (ФАТФ 2019, 72)

этгээдийг ашиглан нарийн төвөгтэй гүйлгээ хийх замаар мөнгө угаахад тусалж, хувийн баялгийн дансны тусгай эрх олгосон.[7]

Суурин шилжүүлэг нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй: (а) үүсгэн байгуулагч болон ашиг хүртэгч байгууллагуудын талаарх мэдээллийг агуулсан заавар; ба (б) хөрөнгийн бодит хөдөлгөөн буюу шилжүүлэг. Санхүүгийн байгууллагууд янз бүрийн банк хоорондын төлбөрийн систем, цахим шуудан, факс, утас, телексээр дамжуулан ашиглах боломжтой цахим сүлжээ зэрэг хэд хэдэн аргаар заавар илгээж болно. Банкнуудын хооронд шилжүүлгийн зааварчилгааг дамжуулах хамгийн түгээмэл арга бол Дэлхийн банк хоорондын санхүүгийн цахилгаан холбооны нийгэмлэг (SWIFT) гэгддэг санхүүгийн тусгай холбооны системд хандах явдал юм. Мөнгөний бодит хөдөлгөөний тухайд банк хоорондын төлбөрийн хоёр том бөөний төлбөрийн систем байдаг: Клирингийн төв банк хоорондын төлбөрийн систем (CHIPS) болон Fedwire Funds Service (Fedwire). Нэмж дурдахад банкууд харилцагчийн мөнгийг байгууллагуудын хооронд шилжүүлэхийн тулд банк хоорондын шууд болон бусад зуучлагч төлбөрийн системийг байнга ашигладаг.

CHIPS болон Fedwire-ийг ам.долларын шилжүүлэг хийх эсвэл олон улсын гүйлгээний ам.долларын бүрэлдэхүүн хэсэг болгон ашиглаж болно. Гэсэн хэдий ч CHIPS-ийг доллараар илэрхийлсэн олон улсын шилжүүлгийг хөнгөвчлөх зорилгоор голчлон ашигласан. Эдгээр төлбөрийн системээс ялгаатай нь SWIFT нь зөвхөн мессежийн систем юм; энэ нь хөрөнгө хадгалдаггүй, шилжүүлдэггүй, мөн харилцагч нарынхаа нэрийн өмнөөс данс удирддаггүй. Мэргэжилтнүүд АНУ-ын банкууд, CHIPS эсвэл Fedwire-ээр дамжуулан клирингийн гүйлгээ нь мөнгө хураах тохиолдолд АНУ-ын эрх баригчдад харьяалагддаг гэдгийг мэдэж байх ёстой.

Бодит мөнгөн гуйвуулга нь "номын шилжүүлэг"-ээр хийгддэг бөгөөд корреспондент банк оролцуулж болно. Номын шилжүүлэг нь үндсэндээ нэг данснаас нөгөө данс руу мөнгө шилжүүлэх нягтлан бодох бүртгэлийн үйл явц юм. Хэрэв анхдагч үйлчлүүлэгч болон ашиг хүртэгч аль аль нь нэг санхүүгийн байгууллагад данстай бол дотоод данс шилжүүлэг. хоёр хэрэглэгчийн дансны хооронд явагдаж болно. хооронд мөнгө шилжүүлэх үед Харилцаа холбоогүй хоёр санхүүгийн байгууллагатай харилцах харилцааг гүүр болгохын тулд ажилладаг корреспондент эсвэл зуучлагч банкаар дамжуулан ном шилжүүлэг хийдэг.[8]

Олон банкууд үндсэндээ CHIPS эсвэл Fedwire-ийн гишүүн, нэвтрэх эрхтэй байгууллагуудтай мөнгөн гуйвуулгын гүйлгээг боловсруулах, клирингийн зорилгоор корреспондент данс хөтөлдөг; Ингэснээр тэд гишүүн байгууллага биш ч гэсэн харилцагчдынхаа нэрийн өмнөөс мөнгөн гуйвуулга хийх боломжийг олгодог. Корреспондент банкны харилцаа нь дотоодын болон гадаадын банкуудын хооронд нийтлэг байдаг, учир нь тэд гадаадад байгаа харилцагчийн бизнесийг хөнгөвчлөх,

---

[7] АНУ-ын Сенат (2004)-ийг харна уу, https://www.hsdl.org/?abstract&did=451010. Цаашилбал, Олон Улсын томоохон банк өөрийн ажилтнуудаа зориулсан сургалтын гарын авлагатай бөгөөл ингэснээр тэд хориг арга хэмжээ авагдсан газар луу халхавчийн дор хийгдэж байгаа мөнгөн гуйвуулгаас хэрхэн мэдээллийг "тайлах" (авах) аргыг мэддэг байсан. АНУ-ын Шударга ёсны тэнхим (DOJ)-ийг харна уу. "Нью Ёорк хотын хууль болон Олон Улсын Онцгой байдлын эдийн засгийн хуулийг зөрчсөнтэй холбоотой 536 сая ам.долларыг хураан авсан тухай" 2009.12.16-ны өдрийн нийтлэл http://www.justice.gov/opa/pr/2009/December/09-ag-1358.html.

[8] Энэ тохиолдолд, үүсгэн байгуулагч банк нь хүлээн авагч банкинд корреспондент данс хөтөлж байгаа бол хүлээн авагч банкнаас хүлээн авагч банкны харилцах данснаас хүлээн авагчийн данс руу мөнгө шилжүүлэхийг даалгаж болно (FinCEN 1992).

гадаад дахь төлөөлөгчийн газар байгуулах зардал, дарамтгүйгээр үйлчилгээ үзүүлэх боломжтой.[9]

Цахим шилжүүлгэнд дүн шинжилгээ хийхэд холбогдох баримт бичиг, мэдээлэл цуглуулах

Мэргэжилтнүүд нь хөрөнгийн мөшгих үйл ажиллагаанд шаардагдах мөнгөн гуйвуулгатай холбогдох мэдээллийг санхүүгийн байгууллагуудаас хүсэх ёстой. Ийм баримт бичигт мөнгөн шилжүүлгийн мессежийн хуулбар, түүнчлэн санхүүгийн байгууллагуудаас мөнгө шилжүүлэх, хүлээн авах явцад бүрдүүлдэг бусад баримт бичгийг багтаасан байх ёстой. Шигтгээ 4.1-д мөнгө шилжүүлэхтэй холбогдуулан гаргаж болох зарим маягт, баримт бичгийг жагсаав. Эдгээр баримт бичиг, маягтыг хянан үзэхэд үүсгэн байгуулагч болон ашиг хүртэгч санхүүгийн байгууллага, харилцагч талууд, дүн, огноо, харилцагчаас үйлчлүүлэгчид эсвэл санхүүгийн байгууллагаас институц руу шилжих мэдээлэл зэрэг гол мэдээллийг олж авна.

Мэдээлэл хайж буй мэргэжилтнүүд нь цахим шилжүүлгийн мэдээллийг хүснэгтийн формат болон хэрэв боломжтой бол зөвлөгөөний мэдэгдлийн маягт хэлбэрээр гаргуулах боломжтой. Банкууд нэгдсэн стандартчилагдаагүй форматыг ашиглаж болох тул хүснэгт нь гүйлгээг ойлгоход хялбар болгох мэдээллийг агуулж, зөвлөгөөний мэдэгдлийн формат нь илүү дэлгэрэнгүй мэдээллийг агуулж болно.

ШИГТГЭЭ 4.1 Мөнгө шилжүүлэх үйл явцтай холбоотой маягт, баримт бичиг

Шилжүүлэгч байгууллага

- Мөнгө шилжүүлэх хүсэлтийн форм
- Мөнгөн шилжүүлгийн хуулбар
- Мөнгө шилжүүлэхтэй холбоотой зөвлөгөө болон баталгаажуулалт
- Шилжүүлэгчид илгээсэн зарлагын мэдээлэл
- Харилцагчийн сар тутмын дансны хуулга
- Гадаад мөнгөн шилжүүлгийн дотоод бүртгэл (Хоблогдох банкны бүртгэл, төлбөр тооцооны шилжүүлгийн бүртгэл)
- Журналын бичилт

Хүлээн авагч (эсхүл дамжуулагч) байгууллага

- Мөнгө шилжүүлэх хүсэлтийн форм
- Мөнгөн шилжүүлгийн хуулбар
- Хүлээн авагчид илгээсэн орлогын мэдээлэл (хэрэв орлого авсан бол)
- Харилцагчийн сар тутмын дансны хуулга
- Журналын бичилт
- Кассын мэдээлэл
- Банкуудын клирингийн гүйлгээ хийх зорилгоор хадгалдаг банк хоорондын дансны шилжүүлгийн мэдээлэл

[9] Корреспондент банкны харилцаа холбоо, SWIFT-ийн боловсруулсан төлбөрийн төлбөрийн практикийг багтаасан цуваа болон төлбөрийн аргыг ашиглах талаар нэмэлт мэдээллийг хавсралт F-ээс үзнэ үү.

Мөрдөн байцаалтын нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлт баримт бичиг олж авах эсвэл өөр газруудаас мэдээлэл нь чухал юм. Тухайлбал:

- *Төлбөрийн үндсэн баримт бичиг.* Эдгээрт нэхэмжлэх, тээвэрлэлтийн баримт бичиг, төлбөрийн баримт, зөвлөхийн гэрээ болон шилжүүлэгтэй холбоотой бусад баримт бичиг багтдаг бөгөөд энэ нь тухайн хөрөнгийн талаарх гол мэдээллийг илчилж болох юм.
- *Харилцагчийг таньж мэдэх /KYC/ шугамаар цуглуулсан мэдээлэл болон комплайнсын мэдээлэл.* Гүйлгээний түвшинд данснаас мөнгө гарах үед банк эцсийн хүлээн авагчийг тодорхойлоогүй байж болно. Энэ тохиолдолд KYC мэдээлэл тус болж магадгүй.
- *Улс төрд нөлөө бүхий этгээд үйлчлүүлэгч.* Улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой тохиолдолд мөнгөн шилжүүлгийг санхүүгийн байгууллагын хувийн банкны бизнесийн үйл ажиллагаанаас олж болно. Улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой лавлагаанд итгэмжлэл хавсаргасан бүх данс, хуулийн фирмүүдийн хадгалдаг, ихэвчлэн мөнгө шилжүүлэхийн тулд Улс төрд нөлөө бүхий этгээдийн ашигладаг бүх дансыг шалгах шаардлагатай.
- *Хувийн болон байгууллагын данс хооронд шилжүүлэг.* Ийм гүйлгээнүүд нь олон шатлалт схемийг илрүүлэхэд ашигтай байж болно.
- *Санхүүгийн байгууллагын ашигладаг SWIFT хувийн гарц болон нэрийн хувилбарууд.* Банк болон түүний янз бүрийн салбар нэгжид зөвхөн хувийн банкны үйлчлүүлэгчдэд зориулагдсан тусдаа SWIFT гарцуудыг хянаж үзэхэд тэдгээрээр дамжуулан үүсэлтэй тусдаа, тусгай зөвшөөрөлтэй гүйлгээг илрүүлж болно. Санхүүгийн байгууллагын ашигладаг SWIFT нэрийн хувилбарууд нь өөр өөр замаар шилжүүлгийг илрүүлж болно. Банк өөр өөр мөнгө шилжүүлэх хэлтэс, хаяг эсвэл өөрийгөө таних дотоод аргатай байж болно.[10] Банкны бүртгэл хөтлөх захиалгад гарцын жагсаалт болон нэрийн хувилбаруудыг багтаасан байх тулд мэргэжилтнүүд банкны ажилтнуудтай (жишээлбэл, дагаж мөрдөх албаны хүмүүс) ярилцлага хийх замаар эдгээр мэдээллийг цуглуулах боломжтой.
- *Сэжигтэй гүйлгээний мэдээлэл.* Хэрэв боломжтой бол, сэжигтэй гүйлгээний мэдээлэл болон гүйцэтгэх ажлын мэдээлэл нь мөнгөн шилжүүлгийн мэдээлэл болон мөнгө шилжүүлэгчийн талаарх үнэтэй мэдээллийг гаргаж өгөх боломжтой.
- *Холбооны нөөцийн банкны лавлагаа.* Fedwire-ээр дамжуулан илгээсэн мөнгөн гуйвуулгын хувьд АНУ-ын Холбооны нөөцийн системийн холбогдох дүүргийн банк нь мөнгөн шилжүүлгийн бүртгэлийг 180 хоногийн турш хадгалдаг тул ашигтай эх сурвалж байж болох юм. Мэдээлэл хүсэхдээ аль болох олон дэлгэрэнгүй мэдээллийг (жишээ нь: огноо, гүйлгээний дүн, шилжүүлэгч тал, хүлээн авсан харилцагч, хүлээн авагч байгууллага, дансны дугаар, мэдэгдэж байгаа бол гүйлгээний зорилго гэх мэт)
- *Тодорхой байгууллагуудын гүйлгээний хэв маяг.* Жижиг банкнуудаас олж авсан мэдээллийг шалгахдаа мэргэжилтнүүд банкны хэмжээтэй харьцуулахад маш их хэмжээний шилжүүлгийн хэлбэрийг хайж болно (жишээлбэл, нэг сарын хугацаанд тухайн банканд шилжүүлсэн нийт мөнгөний нэлээд хувийг эзэлдэг номын шилжүүлэг).
- *Засварласан, буцаасан, дахин илгээсэн гүйлгээнүүд.* Хяналтын систем дээр алдаа агуулсан мессежнүүд (тухайлбал, шилжүүлэгчийн мэдээлэл бүрэн бус)

[10] Нэг банк өөрийн нэр, хаяг дээр нийт 43 тусдаа танигчтай болох нь тогтоогдсон.

"засварлах" үүсгэж болно. Эдгээр мессежнүүд нь гараар хянуулахаар анхааруулдаг. Ийм баримт бичгүүдийг ихэвчлэн шилжүүлэгч болон хүлээн авагч банкнууд хөтлөх бөгөөд зорилтот байгууллага эсвэл банкны үйл ажиллагааны хэв маягийг илрүүлж болно.[11]

- *Зээлийн мэдээлэл.* Шүүгдэгчид шаардлагад нийцүүлэхийн тулд зээлийн бүртгэлийн талаар төөрөгдүүлсэн мэдээлэл өгдөг бөгөөд энэ нь зарим улс оронд эрүүгийн гэмт хэрэг байж болзошгүй.

Мөнгөн шилжүүлгийн баримт бичгийг тайлбарлах

Ихэнх тохиолдолд банкны шилжүүлгийг баталгаажуулсан зөвлөмжийн мэдэгдэл, түүнчлэн банкнаас эх эсвэл хүлээн авагч харилцагчдадаа илгээсэн дебит болон зээлийн санамжууд нь уншихад хялбар баримт бичиг байх болно. Эдгээр баримт бичиг нь дансны дугаар, эх үүсвэр болон хүлээн авагч харилцагчийн хувийн мэдээллийг багтаасан хөрөнгийн хөдөлгөөнийг хянахад шаардлагатай мэдээллийг агуулдаг. Ийм баримт бичиг байхгүй тохиолдолд мөнгөн хөрөнгийг тодорхойлох, мөшгөх үйл явц нь мөнгөн шилжүүлэг хийхэд ашигладаг янз бүрийн мессежний системийг хэрхэн уншиж, тайлбарлах талаар ойлголттой байх шаардлагатай.[12]

CHIPS болон Fedwire зэрэг төлбөрийн системүүд нь гишүүн байгууллагуудын хооронд мөнгөн шилжүүлгийн харилцаанд зориулж тусдаа мессежний форматыг ашигладаг; Гэвч SWIFT нь дэлхийн хамгийн олон тооны санхүүгийн байгууллагуудад стандартчилсан мессежний платформыг санал болгодог. SWIFT мессежний тухайд, мэдээлэл дамжуулах явцад аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мессежний формат, мэдээлэл, чиглэлийг ялгах тусгай код, шифрлэлт зэрэг салбарын хэмжээнд өргөн хэрэглэгддэг протоколууд байдаг.

Янз бүрийн төрлийн SWIFT мессежийг тодорхойлохын тулд тус бүрд нь дугаар өгдөг. Жишээлбэл, "MT 103" гэж тодорхойлсон мессежний хувьд "MT" угтвар нь "мессежний төрөл" гэсэн утгыг илэрхийлдэг бол дараах гурван оронтой тоо нь тодорхой SWIFT мессежний төрлийг илэрхийлнэ (энэ тохиолдолд "103" нэг үйлчлүүлэгч эсвэл зээлийн шилжүүлэг). Мессежний төрөлд тусгай талбарын кодууд нь чухал мэдээллийг заадаг. Жишээлбэл, 50-р талбар (захиалга өгөх үйлчлүүлэгч) нь зөвхөн харилцагчийн нэр, хаягаас илүү их зүйлийг агуулж болох тул угаасан мөнгийг мөшгөхөд анхаарах гол талбар юм.[13] Зураг 4.2-т мөрдөгчид холбогдох SWIFT мессежний талбаруудын жишээг үзүүлэв.

SWIFT бизнес таних код (BIC) нь санхүүгийн байгууллага, улс, байршил ба /эсвэл салбарын нэрийг өгдөг. BIC нь ерөнхийдөө найман тэмдэгтээс бүрддэг: дөрвөн тэмдэгттэй банкны код (санхүүгийн байгууллагад өвөрмөц), хоёр тэмдэгттэй улсын

[11] Эдгээр бүртгэлүүд нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хэв маягийг хайж олоход тустай байж болох бөгөөд энэ нь гэмт хэргээс олсон орлогыг санаатайгаар угаасан болохыг нотлох болно. Нэмж дурдахад, мэргэжилтнүүд сүүлийн 30 хоногийн түдгэлзсэн гүйлгээний мэдээллийг холбогдох банкнаас асуух боломжтой; Тэд дахин илгээсэн шилжүүлгийн нэмэлт эсхүл өөрчлөгдсөн мэдээлэлд онцгой анхаарал хандуулах ёстой.

[12] Жишээлбэл, Молдавын банкны луйврын дуулианд (хайрцаг 4.5) Молдавын Үндэсний банкны Банкны хяналтын хэлтэс нь мөрдөн байцаалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор Кролл хэмээх хувийн мөрдөн байцаах агентлагийг хөлсөлжээ (Kroll 2015). Устгасан баримт бичгийг сэргээхийн тулд SWIFT өгөгдлийг ашигласан

[13] 50-р талбарт (захиалга өгөх үйлчлүүлэгч) мэдээллийг харуулах гурван сонголт нь эмчийн хувьд ашигтай байж болно: (а) данс нэмэх танигч, (б) танигч дээр нэр, хаяг, (в) данс нэмэх нэр, хаяг.

ЗУРАГ 4.2	SWIFT мэссэжний формат болон кодыг тайлбарласан жишээ

:20: PAYREF-XT78305
:32A: 091010EUR#1010000#
:50: [CUSTOMER NAME AND ADDRESS]
:59: [BENEFICIARY NAME AND ADDRESS]

Кодны тайлбар

20	Гүйлгээний бүртгэлийн дугаар (Шилжүүлэг хийсэн байгууллагын гүйлгээг таних зорилгоор гаргасан дугаар)
32A	Гүйлгээний хугацаа, валютын код, гүйлгээний хэмжээ
50	Шилжүүлэгчийн мэдээлэл (SWIFT гүйлгээг захиалагч тал)
59	Хүлээн авагч (Хөрөнгийг хүлээн авах эцсийн этгээд)
Дээр дурдсан кодоос гадна дараах кодуудад агуулагдаж болзошгүй:	
52D	Шилжүүлэгч банк (SWIFT гүйлгээ хийсэн санхүүгийн байгууллага)
53D	Шилжүүлэгчийн корреспондент банк
54D	Хүлээн авагчийн корреспондент банк
57D	Шилжүүлэгчийн мэдэгдсэн төлбөр төлөх хүлээн авагчийн санхүүгийн байгууллага
70	Гүйлгээний мэдээлэл
71A	Гүйлгээний шимтгэлийн мэдээлэл
72	Шилжүүлэгч банкнаас хүлээн авагч банканд хүргүүлсэн зөвлөмж

Эх сурвалж: Дэлхийн банк.
Тэмдэглэл: SWIFT = Society for Worldwide Interbank Financial Telecommunication.

код (санхүүгийн байгууллага байрладаг улсыг тодорхойлдог), хоёр тэмдэгтээс бүрдэх байршлын код (энэ нь харьяаллын хүрээнд газарзүйн ялгаа). Заримдаа салбар кодын хувьд гурван нэмэлт тэмдэгт ашигладаг (санхүүгийн байгууллагын бодит салбарыг тодорхойлох).[14]

4.2.5 Виртуал хөрөнгө

Виртуал хөрөнгийг тайлбарлахдаа “Төв банк эсвэл төрийн байгууллагаас гаргаагүй, баталгаажуулаагүй, хууль ёсоор тогтоосон мөнгөн тэмдэгттэй заавал холбоогүй, мөнгөн тэмдэгт, мөнгөний эрх зүйн статусгүй боловч үнэ цэний дижитал дүрслэл” гэж тодорхойлсон. Хувь хүн, хуулийн этгээд солилцооны хэрэгсэл болгон хүлээн

[14] BIC-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг https://www.swift.com/ сайтаас авна уу. Вэбсайт нь байгууллагын нэрээр эсвэл BIC-ээр хайлт хийхийг зөвшөөрдөг бол хайлтын параметрүүдийг улс, хот эсвэл хоёуланг нь нарийсгаж болно.

зөвшөөрсөн бөгөөд цахим хэлбэрээр шилжүүлэх, хадгалах, арилжаалах боломжтой.[15]

Виртуал хөрөнгийн нууцлал нь хууль бус орлогыг буруугаар ашиглах боломжийг бий болгодог.[16] Мөн зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд мөнгө угаах зорилгоор ашиглаж байгаа нотлох баримтууд тогтоогдсон байна (Keatinge, Carlisle, and Keen 2018, 17). Виртуал хөрөнгөтэй холбоотой хууль бус үйл ажиллагааг илрүүлэхийн тулд мэргэжилтэн нар техникийн ур чадвар, нөөцийг эзэмшиж, ахисан түвшний сургалтад хамрагдсанаар тухайн салбарын талаар холбогдох мэдээлэлтэй байх шаардлагатай (Keatinge, Carlisle, and Keen 2018, 57). Гүйлгээг нууцлах, сэжигтэй шинж тэмдгийг илрүүлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд эсвэл хувийн пүүсүүдтэй хамтран ажиллах нь тустай байж болно (Keatinge, Carlisle, and Keen 2018, 31). Агентлаг болон хамтран ажиллагсдын хооронд мэдээлэл, сайн туршлагыг хуваалцах нь бас чухал юм.[17]

4.2.6 Нягтлан бодох бүртгэлийн мэдээллүүд

Бизнесийн нягтлан бодох бүртгэлд санхүүгийн гүйлгээг баримт бичгээр баталгаажуулж, дансны нэр, дүнг тодорхойлсон журналын бичилтээр бүртгэдэг. Эдгээрийг бизнесийн санхүүгийн тайланд орлогын тайлан, балансыг багтаасан нэгтгэдэг.[18]

Авлига авсан албан тушаалтнууд болон залилах схемд холбогдсон хүмүүс хууль бус үйлдлээ нуун дарагдуулахын тулд эдгээр бүртгэлийг ихэвчлэн ашигладаг. (Шигтгээ 4.2-т Odebrecht S.A.-ийн хахуулийн төлбөрийг хөнгөвчлөх нууц санхүүгийн бүтцийг тайлбарласан болно.) Мэргэжилтнүүд нягтлан бодох бүртгэлийн бичилт, бодит төлбөр, тэдгээрийг зөвтгөхөд ашигласан баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, харьцуулах замаар хууль бус гүйлгээг олж болно.

---

[15] Санхүүгийн системийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх тухай Европын парламент болон Зөвлөлийн 2018 оны 5-р сарын 30-ны өдрийн 2015/849 тоот Захирамж (ЕХ)-ын 2018/843 тоот удирдамжаас "виртуал хөрөнгө"-ийн тодорхойлолт, 2009/138/ЕС болон 2013/36/ЕХ-ны тоот тушаалууд. Нэмэлт өөрчлөлт оруулсан 1. 3(d) "виртуал хөрөнгө"-ийг тодорхойлсон (18) элементийг нэмэх. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32018L0843.

[16] 2019 оны 6-р сараас хойш ФАТФ-ын 15-р зөвлөмжийн тайлбарын тэмдэглэл ("Шинэ технологи") нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг (VASPs) "тусгай зөвшөөрөл авч, бүртгүүлэх" шаардлагатай; "Виртуал хөрөнгийн шилжүүлгийн талаар шилжүүлэгчийн шаардлагатай, үнэн зөв мэдээлэл, хүлээн авагчийн шаардлагатай мэдээллийг олж авах, хадгалах"; мөн "хүсэлтээр зохих байгууллагуудад өгөх" (ФАТФ 2019, 70 [3-р зүйл], 71 [7(b)-ийн догол мөр]).

[17] Жишээлбэл, Данийн цагдаа нар биткойны гүйлгээг хянах программ хангамжийг боловсруулсан бөгөөд энэ нь тэдэнд хар тамхины хэрэгт амжилттай ял оноох боломжийг олгосон юм (Гарретт Кейрнс. 2017. "Данийн цагдаа нар Bitcoin Tracking-д амжилтад хүрсэн." CoinDesk.com, 2017 оны 2-р сарын 22. https://www. .coindesk.com/danish-police-claim-break through-bitcoin-tracking).

[18] Журнал гэдэг нь нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг он цагийн дараалаар хөтлөх бүртгэл юм. Ихэнхдээ бэлэн мөнгөний орлого, зарцуулалт, борлуулалт, худалдан авалт, ерөнхий журналууд ашиглагддаг. Бүртгэлийн дэвтэр нь дансны төрлөөр гүйлгээг бүртгэдэг. Орлогын тайланд орлого, зарлагыг жагсаасан байдаг. Баланс нь хөрөнгө, өр төлбөрийг жагсаадаг.

ШИГТГЭЭ 4.2 Бразил: Одебрехтийн “Хахуулийн газар”

Бразилд олон жил үргэлжилсэн Lava Jato (Машин угаалга) нэртэй авлигын хэрэгт олон компаниуд нэр холбогдсон бөгөөд эдгээрийн нэг нь Odebrecht S.A. XXK болон Бразил улсад бүртгэлтэй, олон улсад барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг Braskem компани юм. Бразилийн Одербрехт нефть химийн компанийн хувьцааны тодорхой хэсгийг Petrobras (Бразилийн төрийн өмчит газрын тосны компани) компани эзэмшдэг. Бразил, Швейцар болон Америкийн нэгдсэн улсын холбогдох шалгалтаар тус компаниуд нь хамгийн багадаа 3.5 тэрбум ам.долларын төлбөр төлөх шийтгэл хүлээсэн.[a]

Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн яам (DOJ)-аас мэдэгдэхдээ, Одербрехт болон Браскен компаниуд нь 2001 оны эхэн үеэс эхлэн нарийвчлалтай, нууц санхүүгийн бүтэц байгуулж түүгээр дамжуулан Бразил болон бусад улсын авлигажсан Засгийн газрын эрх мэдэлтнүүдэд авлига өгдөг байсан. Энэхүү бүтэц нь боловсронгуй болсноор сүүлд “Бүтэцлэгдсэн үйл ажиллагааны хэлтэс” буюу Одербрехт болон түүний холбогдох компаниудын хахуулын хэлтэс болж дарга нь Одербрехтийн удирдлагаас ирсэн хүсэлтийн дагуу авлига авдаг байсан байна.

Энэ зорилгоор Одебрехтийн хээл хахуулийн хэлтэс нь гишүүддээ авлигын төлбөрийн талаарх аюулгүй цахим шуудан, мессежээр дамжуулан бие биетэйгээ болон хамтран зүтгэгчидтэй харилцах боломжийг олгосон гадуур харилцааны системийг ашигласан. Мөн тус компанийн “сүүдрийн” төсвийг удирдаж, авлига авах хүсэлт гаргаж, боловсруулдаг тусдаа компьютерын системээр дамжуулан хахуулийг санхүүжүүлдэг байв. Нэмж дурдахад энэ хэлтэс нь оффшор компаниудаас авлига авагчдад мөнгө шилжүүлэх, Бразилийн дотоод болон гадаадад бэлэн мөнгөний төлбөр хийх замаар авлига авах үүрэгтэй байв.

Бракхем мөн Одербрехт системийг ашиглан Бразилийн улс төрчид болон Петробрасын албан тушаалтанд давуу эрх олгох (худалдан авах ажиллагааг оролцуулан) болон компанид таатай хууль тогтоомжоор хээл хахууль өгөхийг зөвшөөрсөн.

а. Лава Жатогийн хэргийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл мөрдөн байцаалтын явцыг ахиулсан Бразилийн хуулийн өөрчлөлтийн тухай 2-р бүлэг (хайрцаг 2.4, 2.11) болон Одебрехт болон бусад талууд авлигын орлого угаахын тулд халхавч компаниудыг ашигласан тухай 3-р бүлгийг (хайрцаг 3.1) үзнэ үү.

Эх сурвалж: DOJ. 2016. “Одебрехт, Браскем нар буруутай гэдгээ хүлээн зөвшөөрч, түүхэн дэх хамгийн том гадаад хээл хахуулийн хэргийг шийдвэрлэхийн тулд дэлхийн хэмжээнд дор хаяж 3.5 тэрбум долларын торгууль төлөхийг зөвшөөрч байна.” Хэвлэлийн мэдээний дугаар. 16-1515, 2016 оны 12-р сарын 21. https://www.justice.gov/opa/pr/odebrecht-and-braskem-гэм буруугаа хүлээн зөвшөөрч-хамгийн багадаа-35 тэрбум-дэлхийн торгууль төлөх-шийдвэрлэх.

Хахууль авсан эсвэл гуравдагч этгээдэд их хэмжээний төлбөр төлсөн гэж сэжиглэгдсэн тохиолдолд авлига авагч (агент, зуучлагч эсвэл гуравдагч этгээд) ихэвчлэн төлбөр төлөгч талуудад (ихэвчлэн гэрээ байгуулахыг эрмэлздэг компани) хуурамч нэхэмжлэх гаргадаг. Хуурамч нэхэмжлэх ашиглах нэг шалтгаан нь авлига өгсөн компанийн бүртгэлд хуурамч "аудитын мөр" гаргаж, улмаар төлбөрийн үндсэн зорилгыг нуун дарагдуулах явдал юм. Хуурамч нэхэмжлэх нь үнэмшилтэй, хууль ёсны баримт бичиг мэт харагддаг тул тодорхойлоход хэцүү байдаг.

Хэрэв хуурамч нэхэмжлэх ашигласан гэж сэжиглэж байгаа бол салбарын мэргэжилтнүүд үндсэндээ нэхэмжлэхийн дүн болон худалдан авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнэ (эсвэл байхгүй) хоорондын зөрүүг тодорхойлоход анхаарлаа хандуулах хэрэгтэй. Мөн падааныг гаргасан компани нь хуурамч эсэхийг шалгах ёстой. Гүйлгээг бүртгэх янз бүрийн баримт бичиг-гэрээ; төлбөрийн агент руу илгээсэн баримт бичиг (жишээлбэл, нэхэмжлэх эсвэл имэйл); төлбөрийн

бүртгэл; коносамент; мөн төлбөрийн үйл явц нь өөрөө улаан тугийн үзүүлэлтүүдийг илрүүлж болно. (Шигтгээ 4.3-т гэрээ болон бусад бүртгэл дэх улаан тугуудыг авч үзэх ба 4.4-т Нигерийн OPL 245 газрын тосны блоктой холбоотой гэрээний шагналын улаан тугийг тусгайлан авч үзнэ.) Ийм зөрүү илэрсэн үед сэжигтэй гүйлгээний тоог шүүж, шалгах боломжтой болно. Хуурамч нэхэмжлэх гаргагч (хахууль авсан сэжигтэй этгээд) дээр мөрдөн байцаалтыг чиглүүлэх хэрэгтэй.

ШИГТГЭЭ 4.3 Гэрээ, төлбөрийн баримт, төлбөрийн түүх болон төлбөрийн хэрэгслийн талаар анхаарах асуудал

- Гэрээнүүд
- Гуравдагч этгээдэд их хэмжээний төлбөр төлөхөд нэхэмжлэхийг дэмжих албан ёсны гэрээ байхгүй
- Гүйцэтгэх үйлчилгээний талаар гэрээ, хэлэлцээрт тодорхой зүйл байхгүй
- Хэлэлцэн тохирогч талын хэн болох, хууль ёсны эсэхийг баталгаажуулахын тулд зохих шалгалт хийсэн тухай бичгээр нотлох баримт байхгүй
- Татварын диваажин эсхүл хамтын ажиллагаагүй нутаг дэвсгэрт бүртгэлтэй хуурамч компанид төлбөр төлсөн
- Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө үйлчилгээ үзүүлж, төлбөр төлсөн хугацаа нь дуусан гэрээ эсвэл гэрээнүүд
- Нэг байршилд ижил үйлчилгээг гүйцэтгэхийн тулд өөр өөр талуудтай олон гэрээ байгуулах (өөрөөр хэлбэл, нэг үйлчилгээний төлбөрийг олон гүйцэтгэгчид төлөх гэрээ)
- Анхны гэрээний хамрах хүрээг үндэслэлгүйгээр өргөжүүлсэн эсвэл өөрчилсөн хавсралт эсвэл дагалдах гэрээ (амаар хийсэн хэлцлийг оролцуулан) байгаа эсэх
- Төлбөр төлөгч тал гол гэрээ байгуулсан тохиолдолд, ялангуяа төлөөлөгчийн үйл ажиллагааг тодорхой заагаагүй тохиолдолд амжилтын шимтгэлийг "агент"-д төлөх ёстой.
- Харьяаллын хувьд хүлээгдэж буй зах зээлийн ханшаас давсан шимтгэлийн хувь хэмжээ.

Төлбөрийн баримт бичиг болон үйлчилгээний баталгаа

- Үйлчилгээ үзүүлсэн гэдгийг батлах нэмэлт мэдээлэл өгөөгүй
- Гуравдагч этгээдээс гаргасан бусадтай ижил эсвэл ижил төстэй, эсвэл төлж буй шимтгэлтэй тохирохгүй тайлангууд (жишээ нь, тайлангийн хэсгүүдийг интернэтээр хайхад тайланг хуулбарласан эсвэл хуурамчаар үйлдсэн болохыг олж мэдэх боломжтой))
- Ерөнхий нэмэлт хураамж эсвэл нэмэлт хураамж агуулсан нэхэмжлэх
- Хүлээгдэж буй мэдээлэл дутуу нэхэмжлэх (татварын тодорхойлолт эсвэл байгууллагын бүртгэлийн дугаар гэх мэт)
- Үнэт цаас гаргагч нь өөр харилцагчгүй болохыг харуулж болох дараалсан нэхэмжлэх дугаарлалт
- Үйлчилгээний үнэ цэнэ нь төлсөн дүнтэй үл тохирно
- Үйлчилгээ үзүүлсэн харьяалал эсвэл байршлаас ялгаатай хүлээн авагчийн банкны дэлгэрэнгүй мэдээлэл
- Гуравдагч этгээдийн нэр хуурамч компани юм уу эсхүл хуурамч компаний удирдлага бол байх

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 4.3	Гэрээ, төлбөрийн баримт, төлбөрийн түүх болон төлбөрийн хэрэгслийн талаар анхаарах асуудал

- Гэрээнд заасан гуравдагч этгээдийн нэрээс ялгаатай хүлээн авагчийн нэр
- Нэг бизнесийн хаягтай олон гуравдагч этгээд
- Нэг төрлийн нэхэмжлэхийн хэлбэр эсвэл хаягтай олон зөвлөхүүд.

Нягтлан бодох бүртгэлд байх бичилт болон төлбөрийн түүх

- "Төрөл бүрийн зардал" эсвэл "зөвлөх" гэх мэт ерөнхий дэвтрийн дансанд бүртгэгдсэн их хэмжээний нэхэмжлэх эсвэл нэхэмжлэхийн дүн
- Эцсийн дүндээ буцаагдсан эсвэл найдваргүй өрийн данснаас хасагдсан түр болон түр данснуудыг ашиглах
- Ердийн өглөгийн процессоос гадуур хийгдсэн төлбөрүүд (жишээ нь, нэг удаагийн гарын авлага эсвэл бэлэн мөнгөний төлбөр)
- Төлбөрийн журмыг дагаж мөрдөөгүй (жишээлбэл, хоёр шаардлагатай үед нэг гарын үсэг авах)
- Компанийн ажилтнууд ердийн сувгаар (онлайн эсвэл шууд нэхэмжлэх гэх мэт) төлбөрийн нэхэмжлэхийг батлах дургүй байх.
- Гуравдагч этгээд эсвэл компанийн ажилтнуудаас төлбөрийг яаралтай шийдвэрлэхийг шаардах дарамт
- Компанийн ажилтнууд тодорхой гуравдагч этгээдэд төлөх төлбөрийг боловсруулахад ер бусын сонирхолтой байх
- Нэмэлт баримт бичгийн хүсэлтийн хариуд компанийн ажилтнууд эсвэл гуравдагч этгээдийн ердийн бус хариу үйлдэл эсвэл дайсагнал.
- Эрсдэлийн удирдлагын үйл явцыг дагаж мөрдөөгүй гуравдагч этгээдийн төлбөр.

Төлбөрийн шимтгэлд ашигласан төлбөрийн механизмууд

- Татварын диваажингийн орнуудаар дамжуулан төлбөрийг шилжүүлэхийг хүссэн
- Төлбөрийг гараас нь хүргэхийг ажилчдын хүсэлт
- Компанийн олон банкны данс эсвэл улсын оффис дээр төлбөрийг хуваах хүсэлт
- Төлбөрийг бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах мөнгөөр хийх тухай ажилчдын хүсэлт
- Ажилчдын өндөр үнэтэй "бэлэг" (цаг, үнэт эдлэл гэх мэт) худалдан авах хүсэлт.

Илүү тодорхой удирдамж байхгүй тохиолдолд зардлын дансанд бүртгэгдсэн том, ер бусын эсвэл нэг удаагийн зүйлд (жишээлбэл, зөвлөх үйлчилгээ, шимтгэл, зугаа цэнгэл, аялал, төрөл бүрийн зардал) анхаарлаа хандуулах хэрэгтэй. Түүнчлэн, мэргэжилтэн нар эргэн төлөгдөөгүй, найдваргүй өр гэж хасагдсан дансны авлага, хувийн зээл зэрэг хөрөнгийг авч үзэх хэрэгтэй.

ШИГТГЭЭ 4.4 Нигери: OPL 245 газрын тосны блокны маргаан болон анхаарах асуудал

Ерөнхий мэдээлэл: Энэхүү үргэлжилж буй хэрэг нь 9 тэрбум баррель түүхий нефтийн нөөцтэй Африкийн хамгийн том нефтийн ордуудын нэг дэх хээл хахуулийн схемийг шалгахад улаан дарцагт заасан хэсгүүд хэрхэн нөлөөлснийг харуулж байна.[a] Хэрэв газрын тосны хайгуулын лиценз (OPL) 245 батлагдсан бол газрын тосны нөөц нь Нигерийн нийт батлагдсан газрын тосны нөөцийн бараг дөрөвний нэгтэй тэнцэх болно (Global Witness 2015, 5). Чухал ач холбогдолтой учраас OPL 245 нь дэлхийн хамгийн том газрын тос, байгалийн хийн хоёр том компани болох Royal Dutch Shell ("Shell") болон Италийн Agip-Eni ("Eni") нартай холбоотой маргаантай борлуулалтын хэлцлийн сэдэв байсаар ирсэн. Авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэхийн тулд ийм хэлцлийг цаашид нягтлан шалгахыг эрх баригчдад анхааруулах таван улаан тугийг доор харуулав.[b]

Улаан дарцаг 1: Засгийн газар илтэд шаардлага хангаагүй компанид ашигтай гэрээ байгуулах. 1998 онд Malabu Oil and Gas ("Малабу") нь үйл ажиллагаагаа эхлээд тавхан хонож байсан бөгөөд урьд өмнө ямар ч туршлага, хөрөнгө, боловсон хүчингүй байсан компанийг Дан Этете OPL 245 газрын тосны блокыг 100 хувь хянах эрхийг олгосон. Сани Абачагийн 1993-98 оны цэргийн дарангуйллын үед Нигерийн Газрын тосны сайд (Global Witness 2018, 5; Sayne, Gillies, and Watkins 2017, 12).

Улаан дарцаг 2: Улс төрийн нөлөө бүхий этгээд (УТНБЭ) нь компанийн хувь эзэмшигч. Хожим нь Малабуг Этете нууцаар эзэмшдэг байсан бөгөөд тэрээр 20 сая ам.долларын "гарын үсэг зурах урамшуулал"-аар өөртөө газрын тосны концесс олгосон бөгөөд үүнээс ердөө 2 саядолларыг Нигерийн Засгийн газарт төлсөн байна.[c] 2001 онд Shell олгосон лицензийн 40 хувийг Malabu.d-аас худалдаж авахаар тохиролцсон.[d]

Улаан дарцаг 3: Эрх баригчид маргаантай шийдвэр гаргаж байсан түүхтэй. 2002 онд Нигерийн шинэ Засгийн газар Этете, Абача нар эрх мэдлээ урвуулан ашиглаж, газрын тосны блокыг маш бага үнээр (Global Witness 2015, 5) эзэмшиж, өрсөлдөөнт тендерт оруулсан гэсэн үндэслэлээр Малабугийн лицензийг цуцалжээ. Шелл тендерт ялж, 2003 онд Нигерийн үндэсний нефтийн компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, 210 сая ам.долларын урамшуулал авсан. Малабугийн эхлүүлсэн шүүхийн үйл ажиллагааны дараа 2006 онд Нигерийн Засгийн газар Малабуг газрын тосны блокийн эзэмшигчээр сэргээв. Shell энэ асуудлыг Дэлхийн банкны группын Хөрөнгө оруулалтын маргааныг зохицуулах олон улсын төвд (ICSID) арбитрын шүүхэд өгсөн.[e]

Улаан дарцаг 4: Ялагч компанийн төлбөрийг Засгийн газрын данснаас шилжүүлсэн гэх. 2011 онд Shell болон Eni нар OPL 245-ыг бүрэн хянахын тулд 1.3 тэрбум ам.доллар төлөхөөр Малабутай гэрээ байгуулсан. Энэ мөнгийг Нигерийн Засгийн газраас байгуулсан Лондон дахь JPMorgan Chase & Co.-ийн эскроу дансанд төлсөн. OPL 245-ын мөрдөн байцаалтын явцад Нигери зөвхөн 210 сая ам.долларын[f] гарын үсгийн урамшуулал авсан бол үлдсэн 1.1 тэрбум ам.долларыг Дан Этете, Ерөнхийлөгч Гудлак Жонатан болон бусад[g] Нигерийн тав ба түүнээс дээш компаниудад "улс төрийн хандив"-д зарцуулсан болохыг харуулсан. Абубакер Алиюу-тай холбоотой гэж үздэг.[h] 2018 оны арванхоёрдугаар сард Милан хотын шүүхийн шийдвэрээр газрын тосны хоёр компани болох Shell болон Eni нар 1.1 тэрбум ам.долларын ихээхэн хувь нь "хувийн халаасанд" орох болно гэдгийг мэдэж байсан нь тогтоогдсон. Гэрч 2018, 7).

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 4.4 Нигери: OPL 245 газрын тосны блокны маргаан болон анхаарах асуудал

Улаан туг 5: Шагналын нөхцөл нь салбар эсвэл зах зээлийн хэм хэмжээнээс ихээхэн зөрүүтэй байсан. Shell болон Eni-д зөвхөн OPL 245-д өрөмдлөг хийх тусгай зөвшөөрөл төдийгүй Нигерийн Засгийн газар нэгдээгүй бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу маш таатай нөхцөлүүдийг олгосон.[i] Сүүлийнх нь мөн үйлдвэрлэсэн газрын тосны тодорхой хувийг хуваарилах эрхээ хасуулсан.[j] 2011 оны гэрээ нь Нигерийн Эрүүл мэнд, боловсролын нэгдсэн төсвийг хоёр жил гаруй хугацаанд санхүүжүүлэхэд хүрэлцэхгүйц 6 тэрбум ам. (Global Witness 2018, 21).

a. Нигерийн Төлөөлөгчдийн танхим. 2013. "Холбооны Засгийн газар болон Shell/AGIP компаниуд болон Malabu Oil and Gas Limited компаниудын оролцоотой OPL 245 нефтийн блокийн борлуулалттай холбоотой гүйлгээний тухай түр хорооны тайлан," 64 дэх (2013 оны 7-р сарын 9) иш татав. Global Witness-д (2015, 5 [n. 17]).
b. Нефть, байгалийн хий, уул уурхайн салбарт гэрээ байгуулах тухай 100 гаруй тохиолдлыг судалж үзээд Sayne, Gillies, and Watkins (2017, 2—3) нар эрх баригчид болон хяналтын байгуллагуудыг анхааруулж болох 12 улаан тугийн жагсаалтыг гаргажээ. илүү нарийн шалгах шаардлагатай байна.
c. Хэдийгээр дараагийн жилүүдэд Малабугийн хувьцааны бүртгэл өөрчлөгдсөн боловч 2013 онд Сани Абачагийн хүүг хувьцааны бүртгэлээс хассанаас хойш Дан Этете нь "Малабугийн үндсэн ашиг хүртэгч" байсан нь батлагдсан (Energy Venture Partners Ltd. v. Malabu Oil. and Gas Ltd. Queens Bench Division [Comm.] before Lady Justice Gloster, [2013] EWHC 2118 [Comm.], 2013.07.17).
d. Shell-ийн удирдлагууд Этете Малабуг эзэмшдэг гэдгийг мэддэг байсан (Global Witness 2015, 6).
e. Shell Nigeria Ultra Deep Ltd.-ийн эсрэг ХНС-ыг үзнэ үү. Нигерийн Бүгд Найрамдах Улс (ICSID Case No. ARB/07/18), https://icsid.worldbank.org
/en/Pages/cases/casedetail.aspx?CaseNo=ARB/07/18. Энэ хэргийг 2011 онд зогсоосон.
f. 2012 оны 3-р сард N.Y. Sup. Ct. Шүүхийн шийдвэрээр Ж.Бернард Ж.Фрид Нигерийн засгийн газрын гүйцэтгэх үүргийг "Малабугийн эцсийн төлбөрийг төлөхийн тулд 1.1 тэрбум доллар эзэмшиж буй "сүрэл хүн" гэсэн зүйр цэцэн үг" гэж тайлбарлав. Int'l Legal Consulting Ltd. v. Malabu Oil & Gas Ltd., No 83 (N.Y. Sup. Ct. 2012 оны 3-р сарын 22), https://iapps.courts.state.ny.us/fbem/DocumentDisplayServlet? documentId=llMh qMX_PLUS_/fJrxxubSXRkww==&систем=прод.
g. Хамгийн багадаа 520 сая ам.долларыг Нигерийн төрийн албан хаагчдад төлөхийн тулд бэлэн мөнгө болгон хөрвүүлсэн (Global Witness 2018, 3, 15).
h. Алиюг Байелса муж улсын ял шийтгүүлсэн захирагч асан Диепрье Аламиесейхатай ойр дотно харилцаатай гэж үздэг байсан; Алиюугийн компаниуд Нигерийн Ерөнхийлөгч Гудлак Жонатаны фронт байсан гэж үздэг. Malabu Oil & Gas Ltd.-ийн Төрийн яллах газрын захирлын эсрэг, Лондонгийн Southwark Crown шүүх, 74/14, Шүүхийн Эдистийн шийдвэр (2015 оны 12-р сарын 15), https:// shellandenitrial.org/wp-content/-г үзнэ үү. uploads/2018/07/ШҮҮХ-МАЛАБУ-финал.pdf.
i. Энэ нь гэрээлэгч болон төрийн хооронд гэрээ байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний стандарт журмаас ялгаатай (Global Witness 2018, 2, 3).
j. Олон улсын валютын сангаас газрын тосны орлогын 65-85 хувийг төлөвшсөн газрын тос олборлогч орнууд авахыг зөвлөж байна. Одоогийн OPL 245 гэрээ нь Нигерид ердөө 41 хувь буюу түүхэн ядуу хувь байх төлөвтэй байна (Global Witness 2018, 2, 3).

4.2.7 Даатгалын бодлого

Амь насны даатгалын зарим бодлого нь маш их үнэ цэнэтэй байж болох ба нэг удаагийн урьдчилгаа төлбөрөөр худалдаж авах боломжтой тул мөнгө угаагч, ялангуяа "даатгал боогч" гэж нэрлэгддэг хүмүүсийн сонирхлыг татахуйц болгодог.[19] Мэргэжилтнүүд ялангуяа нас барсны тэтгэмжийг түргэсгэх, эрт төлөх эсвэл цуцлах бусад нөхцөлүүдийг шалгах шаардлагатай. Нэмж дурдахад, даатгалын бодлого нь зорилтот хүмүүсийн эзэмшдэг хөрөнгийг (үнэт эдлэл, машин, урлаг гэх мэт) илрүүлж болно.

[19] Тусдаа данс эсвэл үнэт цаасны данстай амь насны даатгалын бодлогын талаар " Швейцарийн банкнуудын ёс зүйн дүрэм"-ийг үзнэ үү. 42 (SBA 2018), https://www.swissbanking.org/library/richtlinien/vereinbarung-ueber-die-standesregeln-zur-sorgfaltspflicht-der-banken-vsb-20/vsb_2020_einzelseiten_print_en.pdf/.

Бодлого нь бодлогыг бий болгоход тусалсан брокер, өмгөөлөгч гэх мэт бусад мэргэжлийн зуучлагч, түүнчлэн ашиг хүртэгчдийн жагсаалтад багтах зорилтот хүний гэр бүлийн бусад гишүүд эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тодорхойлоход тусална. Ерөнхийдөө ийм мэдээллийг янз бүрийн мөрдөн байцаалтын арга техникээр цуглуулж болно.

4.2.8 Худалдах болоод худалдан авалтын баримт бичиг

Үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, тээврийн хэрэгсэл, үнэт эдлэл, урлагийн бүтээл гэх мэт хөрөнгө худалдах, худалдан авахтай холбоотой баримт бичигт газрын бүртгэлийн баримт бичиг, худалдах, худалдан авах гэрээ, зээл, ипотекийн зээл,[20] худалдагчаас олгосон баримт, санхүүгийн тайлан, татварын тайлан, зээлийн картын хуулга зэрэг орно. Салбарын мэргэжилтнүүд худалдан авалт, борлуулалтын огноог баримтжуулахад анхаарлаа хандуулах ёстой; худалдан авагч ба худалдагчийн нэрс; төлбөрийн арга (бэлэн мөнгө, чек, валют); болон хөрөнгийн эх үүсвэр. Хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдаж авсан тохиолдолд, ялангуяа олон боломжит худалдагч эсвэл дилерүүд байгаа үед (уран бүтээл, үнэт эдлэл, тээврийн хэрэгслийн хувьд) худалдан авсан огноо, үнэ цэнийг хянахад хэцүү байж болно. Аяллын мэдээлэл (хилийн боомтын мэдээлэл, зээлийн картын мэдээлэл эсвэл аяллын урамшууллын хөтөлбөрөөс цуглуулсан); даатгалын бодлого; үнэт эдлэлийн засварын төлбөр; тээврийн хэрэгслийн таних дугаар; тээврийн хэрэгслийн дилерийн наалт эсвэл наалт; мөн урлагийн дилерүүд эдгээр зүйлсийг худалдагч болон худалдан авсан огноог тодорхойлоход тусалж болно.

Мэргэжилтнүүд сэжигтэй этгээдийн гэр бүлийн гишүүд эсвэл ойр дотны хүмүүсийн эзэмшдэг боловч бэлэглэх зарчмаар өгсөн, түүнийг захиран зарцуулах боломжтой хөрөнгөд анхаарал хандуулах хэрэгтэй. (5-р бүлгийн 5.3-ыг үзнэ үү.)

4.3 Мэдээллийг зохион байгуулах: Санхүүгийн хувийн хэрэг нээх

Банкны данс бүрийн дансны профайлд цуглуулсан мэдээллийг цэгцлэх нь чухал юм. Энэ мэдээллийг эргээд цуглуулсан санхүүгийн бусад мэдээлэлтэй (бусад хөрөнгийн эзэмшил, компанийн ашиг сонирхол, өр төлбөр, орлого, зардал гэх мэт) нэгтгэж, зорилтот хүний санхүүгийн дүр төрхийг бий болгож болно. Энэ зорилгоор стандарт компьютерын хүснэгтийн программыг ашиглаж болно (Хавсралт G дахь санхүүгийн профайл маягтын жишээг үзнэ үү). Хайлт хийх боломжтой хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх программ хангамжийг ашиглах нь бас ашигтай.

Жишээлбэл, дансны мэдээлэл нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- Банкны нэр эсхүл болон салбарын байршил
- Банкны дансны дугаар болон төрөл
- Банкны данс эзэмшигчдийн нэр, эцсийн өмчлөгч, захиран зарцуулах эрх бүхий этгээд
- Данс нээсэн болон хаасан огноо (хэрэв боломжтой бол)
- Валют
- Дансны хуулга авах үеийн үлдэгдэл

[20] Ипотекийн зээлийн зөвшөөрөлтэй холбоотой баримт бичигт ипотекийн барьцаанд өгсөн бусад хөрөнгийн талаарх мэдээллийг агуулсан байж болно. Үүнд үл хөдлөх хөрөнгө, хадгаламж, үнэт цаасны банкны данс, урлагийн бүтээл, үнэт металл, үнэт эдлэл гэх мэт мэдээлэл багтаж болно.

- Жилийн орлого
- Жилийн зарлага
- Хөрөнгийн шилжилт хөдөлгөөний хязгаарласан эсэх

Дараа нь салбарын мэргэжилтнүүд мөрдөн шалгах ажиллагааны явцад банкны дансанд гарсан кредит, дебит үйл ажиллагаа гэх мэт нэмэлт холбогдох өгөгдлийг хүснэгтэд оруулах, огноо, хэмжээ, (боломжтой бол) хөрөнгийн эх үүсвэр эсвэл хаана байгаа эсхүл мөнгө илгээсэн талаар шалгаж болно. (банк болон банкны данс эзэмшигчийн нэр).

Мэдээллийг зохион байгуулах, эцэст нь танилцуулах, тайлбарлахад туслахын тулд салбарын мэргэжилтнүүд хөрөнгийн урсгалыг урсгал диаграммд (зураг 4.3) дүрсэлж, холбогдох харилцааг дүрслэн харуулах ёстой (Зураг 4.4). Эдгээр урсгал диаграммууд нь зорилтот хүмүүс, хамтран ажиллагсад, хаалгач, хөрөнгө, банкны данс, компанийн тээврийн хэрэгслийн мэдээллийг өгдөг.

Энэхүү дүрслэл зураг буюу "том зураг" нь бусад мэргэжилтнүүдэд холбоо хамаарлыг ойлгож, тайлбарлахад тусална.

Нэмж дурдахад ийм дүрслэл нь мөрдөн байцаалтын явцад үүссэн мөнгөний урсгал, хань холбоог прокурор, шүүгчид тайлбарлахад тустай. Арилжааны програм хангамж (IBM i2 Analyst's Notebook гэх мэт) эсвэл хүснэгтийн програмуудад зориулсан үнэгүй нээлттэй эх сурвалжийн сүлжээний холбоосууд (жишээ нь NodeXL) ийм дүрслэлд тустай байж болно.

ЗУРАГ 4.3 Хөрөнгийн урсгал болон сүлжээний жишээ



Эх сурвалж. Дэлхийн банк
Товчилсон үг: МШ=мөнгөн шилжүүлэг бэлэн бус, ББТ=бэлэн бус төлбөр, МГ=мөнгөн гуйвуулга

ЗУРАГ 4.4 Мөрдөн шалгах обьектын хамаарал ба холбогдох эд хөрөнгийн жишээ



Эх сурвалж. Дэлхийн банк
Товчилсон үг: УТНБЭ=улс төрд нөлөө бүхий этгээд

Эцэст нь салбарын мэргэжилтнүүд баримт бичгийн удирдлагын системийг ашиглах, ялангуяа нарийн төвөгтэй тохиолдолд, удирдах, дүн шинжилгээ хийх их хэмжээний өгөгдөл байгаа тохиолдолд ашиглах талаар бодож үзэх хэрэгтэй. Шигтгээ 4.5-д цуврал гүйлгээ бүхий нарийн төвөгтэй хэргийн жишээг үзүүлэв.

ШИГТГЭЭ 4.5 Молдав Улсын банкны залилангийн хэргийн дуулиан

Ерөнхий мэдээлэл: 2014 онд томоохон хэмжээний луйврын зээлийн улмаас Молдав Улсын гурван томоохон банк нэг тэрбум гаруй ам.долларын алдагдал хүлээсэн нь эцэстээ дампуурахад хүргэсэн.[a] Тус улсын Төв банк болох Молдавын Үндэсний банк (BNM) үлдсэн хадгаламж эзэмшигчдэд Молдавын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 12 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөр олгох ёстой байв.

Мөрдөн шалгах ажиллагаа болон тогтоогдсон нөхцөл байдал: BNM-ийн захиалгаар Кролл (дэлхийн эрсдлийн шийдлүүдийг нийлүүлэгч) явуулсан мөрдөн байцаалтын дагуу зээлийг янз бүрийн харьяалалд бүртгэлтэй компаниудын бүлэгт шилжүүлсэн байна (Kroll 2017, 55). Луйврын болон авлигын схемд бусад зүйлсийн дотор дараах зүйлс багтсан (Kroll 2015):

- “Эдийн засгийн үндэслэлгүй” хэд хэдэн сэжигтэй гүйлгээ
- Нэг банкны зээлийг нөгөө банкнаас авсан зээлээр төлж, эцэст нь банкнуудыг хоосолдог “тойруулга /карусель/” зээлийн схем (Зураг B4.5.1)

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 4.5 Молдав Улсын банкны залилангийн хэргийн дуулиан

- Боломжтой хөрвөх чадварыг дээд зэргээр нэмэгдүүлэх, "Молдавын аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хэмжээг их хэмжээгээр нэмэгдүүлэхэд" туслах нэгдсэн хүчин чармайлт
- Дансаар дамжуулан мөнгөн хөрөнгийг хуваж, үе давхаргад хуваах, түүнчлэн холбогдсон данснуудын хооронд валютыг байнга, дур зоргоороо солих.
- Зээл хүлээн авагч компаниудын хоорондын хамаарал бүхий этгээдийн харилцааг далдлах
- Гүйлгээний жинхэнэ зорилго болон тэдний эцсийн хүлээн авагчийг нуун дарагдуулах, банкнууд дахь одоо байгаа зээлийн өрийг төлөхийн тулд Латвийн банкны данстай Их Британийн хязгаарлагдмал түншлэлийг ашиглах.
- Шинээр байгуулагдсан Молдавын аж ахуйн нэгжүүдийн нийтлэг бүлгийг харилцагчаар бүртгэж их хэмжээний зээл авах үйл ажиллагаа явуулсан.

Ял шийтгэл болон эд хөрөнгийг эргүүлэн авах: Кролл (2015)-ын мөрдөн байцаалтын явцад бизнесмен Илан Шор нь цогц гүйлгээний гол зохицуулагч, ашиг хүртэгч байсан гэж үздэг. Шор 2017 онд Молдавын шүүхээс долоон жил хагас хорих ял оноож, давж заалдсан юм.[b] Энэ дуулианд нэр бүхий улстөрч, тэр дундаа Ерөнхий сайд асан Влад Филат 2016 онд албан тушаалаа урвуулан ашигласан, авлига авсан хэргээр буруутгагдаж, есөн жилийн хорих ял авсан юм.[c]

2017 онд Европын Холбоо, Молдав, BNM-тай байгуулсан санамж бичигт уг хөрөнгийг эргүүлэн авах, Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн хөрөнгийг олж авах шинэ агентлаг байгуулах үүрэг хүлээсэн (ЕС 2017). Гэхдээ үүнийг бичиж байх үед (одоогоор) хөрөнгийг нөхөн сэргээх үйл явц эцэслэгдээгүй байна.

ШИГТГЭЭ 4.5 Молдав Улсын банкны залилангийн хэргийн дуулиан

ЗУРАГ B4.5.1 Залилангийн хэрэгт ашиглагдсан тойруулсан зээлийн схем

Эх сурвалж: Дэлхийн банк

a. Эндрю Вробел. 2019. "Restoring Trust in Moldova's Banking Sector" (interview with Sergiu Cioclea, head of the National Bank of Moldova). Emerging Europe, 2019 оны 2-р сарын 04. https://emerging-europe.com/interviews/restoring-trust-in-moldovas-banking-sector/.
b. ММатей Роска ба Силвиа Скиорилли Боррелли. 2019. "MEPs Help Campaign of Moldovan Convicted in $1B Fraud." Politico, 2019 оны 2-р сарын 20. https://www.politico.eu/article/ilan-shor-fulvio-martusciello-barbara-kappel-richard-milsom-meps-help-campaign-of -moldovan-convicted-in-1-billion-fraud/.
c. Александр Танас. 2016. "Moldovan Court Jails Ex-PM for Nine Years for Abuse of Power." Reuters, 2016 оны 6-р сарын 27. https://www .reuters.com/article/us-moldova-filat-court/moldovan-court-jails-ex-pm-for-nine-years-for-abuse-of-power-idUSKCN0ZD1XM.

4.4 Мэдээлэлд дүн шинжилгээ хийх: Санхүүгийн урсгалыг санхүүгийн хувийн хэргийн мэдээлэлтэй харьцуулах

Энэхүү эгзэгтэй үе шатанд шинжээчид огноо, гарал үүсэл, очих газар, банкны данс эзэмшигчид, банкнууд, мэдээллийн эх сурвалжийг харьцуулж, гүйлгээг бүлэглэх, нэгтгэх, мэдээллийн цоорхойг илрүүлэх болно. Жишээлбэл, нэг данснаас их хэмжээний бэлэн мөнгө гарч шинжээчийг цааш мөшгөх мэдээлэлгүй үлдээж болно; харин өөр нэг дансанд ойролцоо хэмжээний орлогын гүйлгээ хийсэн байх. Эсвэл ажиглалтын бүртгэлээс үзэхэд сэжигтэй этгээд зарлагын гүйлгээний дараах хэдэн өдрийн дотор гадаадын улс руу аялсан болохыг харуулж байна. Гүйцэтгэгчид төлөх төлбөр нь дараагийн хадгаламжтай холбоотой байж болно. Авлига авсан албан тушаалтны дансны хэд хэдэн орлогын гүйлгээ нь гүйцэтгэгчид төлсөн төлбөртэй

ижил хувьтай тэнцэх хэмжээний мөнгө байсан нь нэг жишээн дээр гарч ирсэн. Ийм дүн шинжилгээ нь хөрөнгийн урсгалыг илүү сайн ойлгож, шинээр нөхцөл байдал тогтооход тусална.

Мэргэжилтнүүдийн ашигладаг өөр нэг арга бол хөрөнгө орлогын шинжилгээ юм. Энэ процессыг зорилтот этгээдийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг мэдээлсэн эсвэл мэдэгдэж буй орлоготой нь харьцуулахад ашигладаг. Тайлагдаагүй аливаа орлого нь хууль бус гарал үүсэлтэй байх магадлалтай бөгөөд салбарын мэргэжилтнүүд дараа нь хөрөнгө болон гэмт хэргийн хоорондын уялдаа холбоог харуулахын тулд хүчин чармайлт гаргах шаардлагатай болно. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь гэмт хэрэгт тооцогддог хууль зүйн үндэслэлтэй орнуудад хөрөнгө орлогын дүн шинжилгээ нь мөрдөн байцаалтын явцад зайлшгүй шаардлагатай алхам болдог.

Авлига, мөнгө угаах схемийг илрүүлэхэд туслахын тулд гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэх янз бүрийн төрлүүд болон улаан тугуудын талаарх мэдээлэл, судалгааг хянаж үзэх нь тустай. Олон агентлаг, олон улсын байгууллагууд ийм тайланг нийтэлдэг бөгөөд үүнийг дараах байдлаар онлайнаар авах боломжтой:

- Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тайлан, судалгаа, типилоги судалгаа (APG 2012; FATF 2006, 2008a, 2008b).
- Санхүүгийн тагнуулын алба (FIU) болон Эгмонт групп (Egmont Group)-ээс сэжигтэй гүйлгээний тайлан, дүн шинжилгээний талаарх жилийн тайлан мэдээ,[21]

Санхүүгийн байгууллага болон банкны холбооноос гэмт хэргийн шинжтэй үйлдэл болон мөнгө угаалтыг илрүүлэх талаарх судалгаа тайлан (HKAB 2016, 18)

4.5 Олон Улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Авлигын хэргээр эд хөрөнгийг эргүүлэн авах нь ихэвчлэн хил давж, олон улсын хамтын хамардаг. Тиймээс гадаадад байгаа хөрөнгө, банкны дансны мэдээллийг авах заавал зайлшгүй шаардлага тулгардаг. Газар, тээврийн хэрэгсэл, компанийн мэдээлэл, санхүүгийн мэдээлэл зэрэг зарим мэдээллийг эрх зүйн харилцан туслалцаа (MLA)-ны хүсэлтээр бус, нээлттэй эх сурвалжийн хайлт, албан бус сувгаар олж авч болно. Жишээ нь: Хөрөнгө буцаан авах оффис дахь хамтран ажилладаг мэргэжилтнүүдийг авч үзье; харилцааны шүүгчид; бүс нутгийн атташе; Эгмонт групп гэх мэт мэргэжилтнүүдийн сүлжээ; Camden Asset Recovery Inter-Agency Network (CARIN) зэрэг агентлаг хоорондын хөрөнгө буцаах сүлжээнүүд; эсвэл Дэлхийн Гаалийн байгууллага.

Мөрдөн байцаалтын эхний шатанд мэдээлэл, тагнуулын мэдээлэл олж авах нь мөрдөн байцаалтын явцыг ахиулах боломжийг олгодог учраас ашигтай байдаг.

Гэсэн хэдий ч хэрэв хүсэлт гаргасан харьяалалд дотоодын шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглаж болох бичиг баримт шаардлагатай бол баталгаажуулсан хуулбар эсвэл эх хувь шаардлагатай бөгөөд энэ нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт гаргах шаардлагатай болно. Бүх тохиолдолд салбарын мэргэжилнүүд

[21] Жишээлбэл, Эгмонт группын жилийн тайлан (https://egmontgroup.org/en/document-library/10) болон Италийн СТА -ны жилийн тайланг (UIF 2016) үзнэ үү.

гадаадын харьяалал дахь үйл ажиллагаанд оролцох боломжтой. Энэ хүрээнд салбарын мэргэжилнүүд албан бус болон албан ёсны үйл явцын талаар цаашдын зааварчилгааг агуулсан 8, 9-р бүлэгт онцлон тэмдэглэсэнчлэн олон улсын албан бус болон албан ёсны хамтын ажиллагааг хослуулах хэрэгцээг бүрэн ойлгосон байх хэрэгтэй.

Ном зүй

APG (Asia/Pacific Group on Money Laundering). 2012. "APG Typology Report on Trade Based Money Laundering Typologies." Report adopted by APG members at the 15th Annual Meeting, July 20, 2012. Sydney. http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Trade_Based_ML_APGReport.pdf.

EC (European Commission). 2017. "Macro-Financial Assistance to the Republic of Moldova Grant and Loan from the European Union of up to EUR 100 million." Memorandum of Understanding between the European Union and the Republic of Moldova and the National Bank of Moldova as the Beneficiary's Financial Agent, November 23, 2017. https://ec.europa.eu/info/sites/info/files/economy-finance/20171123_-_mou_eu_-_moldova_-_signed_eu_version.pdf.

FATF (Financial Action Task Force). 2006. "Trade-Based Money Laundering." Study, FATF Secretariat and the Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Trade%20Based%20Money%20Laundering.pdf.

FATF (Financial Action Task Force). 2008a. "Proliferation Financing Report." Report of the Proliferation Financing Typology Project, FATF Secretariat and the Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Typologies%20Report%20on%20Proliferation%20Financing.pdf.

FATF (Financial Action Task Force). 2008b. "Terrorist Financing." Study, FATF Secretariat and the Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/FATF%20Terrorist%20Financing%20Typologies%20Report.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations." Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

FinCEN (Financial Crimes Enforcement Network). 1992. "Key Electronic Funds Transfer Systems: Fedwire, CHIPS, SWIFT." Report OSA92ICB0012, FinCEN Reference Series, US Department of the Treasury, Vienna, VA.

Global Witness. 2015. Shell and Eni's Misadventures in Nigeria: Shell and Eni at Risk of Losing Enormous Oil Block Acquired in Corrupt Deal. London: Global Witness. https://humanrightscommission.house.gov/sites/humanrightscommission.house.gov/files/documents/Shells_misadventures_in_Nigeria_0.pdf.

Global Witness. 2018. "Take the Future: Shell's Scandalous Deal for Nigeria's Oil." Analysis commissioned by Global Witness, London. https://www.globalwitness.org/

en/campaigns/oil-gas-and-mining/take-the-future/#:~:text=A%20deal%20 Shell%20 and%20Eni,we%20commissioned%20from%20leading%20experts.

KAB (Hong Kong Association of Banks). 2016. "Guidance Paper on Combating Trade-Based Money Laundering." Paper, HKAB, Hong Kong SAR, China. www.hkab.org.hk/DisplayArticleAction.do?sid=5&ss=16.

Keatinge, Tom, David Carlisle, and Florence Keen. 2018. "Virtual Currencies and Terrorist Financing: Assessing the Risks and Evaluating Responses Study." Study for the European Parliament's Special Committee on Terrorism (TERR Committee), PE 604.970, com- missioned by the Policy Department for Citizens' Rights and Constitutional Affairs, Directorate-General for Internal Policies, European Union, Brussels. http://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2018/604970/IPOL_STU(2018) 604970_EN.pdf.

Kroll. 2015. "Project Tenor: Scoping Phase, Final Report." Report for the National Bank of Moldova, April 2, 2015. Kroll, London. https://kupdf.net/download/kroll-project-tenor-candu-020415_5a794336e2b6f50a0b563666_pdf.

Kroll. 2017. "Project Tenor II: Summary Report." Report for the National Bank of Moldova, December 20, 2017. Kroll, London. https://www.bnm.md/files/Kroll_%20Summary%20Report.pdf.

Sayne, Aaron, Alexandra Gillies, and Andrew Watkins. 2017. "Twelve Red Flags: Corruption Risks in the Award of Extractive Sector Licenses and Contracts." Report, Natural Resource Governance Institute, New York. https://resourcegovernance.org/sites/default/files/documents/corruption-risks-in-the-award-of-extractive-sector-licenses-and-contracts.pdf.

SBA (Swiss Banking Association). 2018. "Agreement on the Swiss Banks' Code of Conduct with Regard to the Exercise of Due Diligence (CDB 20)." Agreement between the SBA and signatory banks, June 13, 2018. Basel, Switzerland. www.swissbanking.org/library/richtlinien/vereinbarung-ueber-die-standesregeln-zur-sorgfaltspflicht-der-banken-vsb-20/vsb_2020_einzelseiten_print_en.pdf/.

UIF (Financial Information Unit of Italy). 2016. "Unita di Informazione Finanziaria Annual Report 2015." UIF, Bank of Italy, Rome. https://uif.bancaditalia.it/pubblicazioni/rapporto-annuale/2016/Annual_Report_2015_8.pdf?language_id=1.

US Senate. 2004. "Money Laundering and Foreign Corruption: Enforcement and Effectiveness of the Patriot Act; Case Study Involving Riggs Bank." Report released by the minority staff of the Permanent Subcommittee on Investigations, July 15, 2004. Washington, DC. https://www.hsdl.org/?abstract&did=451010.

5. Хөрөнгийн хамгаалалт

5.1 Удиртгал

Гэмт хэргийн шинжтэй хөрөнгийг улсын орлого болгох ажиллагаа нь ач холбогдол багатай байвал улсын орлого болгох хөрөнгө байхгүй болно. Хулгайлсан эд хөрөнгийг богино хугацаанд нуун дарагдуулж, гараас нь холдуулж болох бол мөрдөн байцаалтын ажиллагаа, хураах ажиллагаа нь олон жил шаардагдах бөгөөд энэ нь ихэвчлэн хөрөнгийг шилжүүлэх, тараахад хангалттай хугацаа өгдөг. Түүнчлэн хөрөнгө хамгаалах хүрээнд авсан арга хэмжээ нь улсын орлого болох шийдвэрийн нөхцөлийг бүрдүүлж болдог байна. Эдгээр арга хэмжээ нь "урьдчилсан арга хэмжээ"-нд хамаарах ба хөрөнгө хураах болон хязгаарлах багтдаг бөгөөд эд хөрөнгийн битүүмжлэх үйл ажиллагааг эхнээс нь дуусах хүртэл хөрөнгийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай[1].

Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 54 (2) – т зааснаар талууд улсын шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, хүсэлтийн дагуу эд хөрөнгийг царцаах, битүүмжлэхийг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна, ингэхдээ "хүсэлт гаргагч этгээд тухайн арга хэмжээг авах хангалттай үндэслэл байгаа гэж үзсэн тохиолдолд хөрөнгө хураах шийдвэр гарна". Мөн тухайн эд хөрөнгийг олж авсантай холбогдуулан битүүмжлэх буюу эрүүгийн ял сонсох талаар гадаадад шийдвэр гарсан зэрэг үндэслэлээр эд хөрөнгийг хураах зорилгоор хадгалахыг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөх нэмэлт арга хэмжээ авах асуудлыг авч үзэх шаардлагатай.

Ихэнх улсын хөрөнгө хадгалах, хураах урьдчилсан арга хэмжээг зохицуулдаг хуулиудад өөр хоорондоо эсрэг байгаа хоёр зарчмыг тэнцвэржүүлсэн байдаг: Нэг талаас нийтийн ашиг сонирхол нь гэмт хэргийн сэжигтэй орлого болон хэрэгслийг улсын орлого болгох үйл ажиллагаа дуустал хадгалахыг шаарддаг (Шигтгээ 5.3 – т дурдсанаар Швейцарь улсын үндэсний эрх ашгийг хамгаалах зорилгоор үндсэн хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд хөрөнгө царцаах үйл ажиллагааг явуулах)[2]. Нөгөөтэзгүүр хувь хүн өөрийн эд хөрөнгөө өмчлөх, ашиглах эрхийг аливаа тохиолдлын хохирлоос хамгаалах шаардлагатай.

---

[1] Хэдийгээр зарим орнууд хөрөнгө хадгалах, хураах урьдчилсан арга хэмжээний шийдвэрийг хязгаарладаг боловч үүнийг сунгаж болдог. Тухайлбал, Линтенштейн улсад шийдвэр гаргах хугацааг хязгаарлах ёстой боловч өргөдөл дээр үндэслэн тухайн хугацааг сунгаж болдог байна. (Code of Criminal Procedure, sec. 97a[4], https://www.legislationline.org/download/id/8270/file/Liechtenstein_Criminal_Procedure_Code_1987_am2017_en.pdf). Швейцарь улсад цаг хугацааны хувьд хязгаарлалт байхгүй боловч шүүх нь пропорциональ зарчмыг харгалздаг төдийгүй мөрдөн байцаалтын явцад жинхэнэ гэмт хэргийг нотлохгүй бол цаг хугацаа өнгөрөх тусам чангарах хандлагатай байдаг.

[2] Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах нь АНУ-д Ерөнхийлөгчийн тушаал гаргах замаар, Швейцарь улсад Холбооны Зөвлөлийн захирамж болон тогтоол гаргах замаар гадаадын хөрөнгийг царцаах үндэслэлийг зөвтгөхөд ашигласан (UNODC 2015, 40 [para. 101]).

5.2 Нэр томьёо: Хөрөнгө хураах болон хязгаарлах

Эх газрын болон нийтийн эрх зүйн тогтолцооны аль алинд нь хөрөнгийг улсын орлого болгох хүрээнд тухайн эд хөрөнгийг хянах болон хадгалах гэсэн хоёр ялгаатай механизм бий болсон, үүнд: хөрөнгө хураах болон хязгаарлах.

Хөрөнгө хураах гэдэг нь зорилтот хөрөнгийг бодитойгоор хураан авч эзэмшилдээ авахыг хэлнэ. Хэдийгээр хөрөнгө хураах үйл ажиллагаа нь прокурор болон хяналтын шатны шүүгчийн шүүхийн өмнөх шийдвэр эсвэл зөвшөөрөл шаардагддаг боловч зарим улсад хууль сахиулагчид эд хөрөнгө хураах эрхтэй байдаг. Тухайлбал, шаардлагатай нөхцөлд их хэмжээний бэлэн мөнгө болон бусад хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого буюу гэмт хэргийн хэрэгсэл гэж "үндэслэлтэйгээр сэжиглэгдэж эсвэл итгэж байгаа" тохиолдолд шүүхийн урьдчилсан шийдвэргүйгээр хураан авч болдог байна. Энэ эрх нь бэлэн мөнгөний импорт, экспортын тайлагналын хууль тогтоомжийг зөрчин олон улсын хилээр дамжиж буй сэжигтэй бэлэн мөнгийг хураахад онцгой ач холбогдолтой юм.

Хязгаарлах шийдвэр нь шүүгч болон шүүхээс заавал биелүүлэх шийдвэрийн нэг хэлбэр бөгөөд уг шийдвэрт заасны дагуу эд хөрөнгийг улсын орлого болгох үйл ажиллагаа шийдэгдэх хүртэл аливаа этгээдийн тухайн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлах явдал юм[3]. Хөрөнгө хураах шийдвэрээс ялгаатай, хязгаарлах шийдвэр нь эд хөрөнгийг биечлэн эзэмшихэд хүргэдэггүй. Зарим улсад прокурор болон бусад эрх бүхий байгууллагаас хязгаарлах зөвшөөрлийг олгодог ч ихэвчлэн тухайн үйл ажиллагааг явуулахад шүүхийн зөвшөөрөл шаардлагатай байдаг[4].

Хөрөнгө хураах, хязгаарлах гэсэн нэр томьёонууд нь улс орон бүрт өөрөөр хэрэгжих магадлалтай. Тухайлбал, нэг улсад банкны дансыг "хураах" үйл ажиллагаа явуулж байхад өөр улс "хязгаарлах" боломжтой. Түүнчлэн бусад улс орнууд "царцаах" болон "хаах" гэсэн өөр томьёоллудыг шинээр нэвтрүүлсэн[5]. Өөр улстай холбоотой шийдвэрийг хүргүүлэх эсвэл хүлээн авахдаа нэр томьёоны ялгааг мэдэх болон шийдвэрт ойлгомжтой нэр томьёо ашиглахыг хүссэн эсэхийг нягтлах шаардлагатай. Иймд хүлээн авагч талаа эргэлзээнд оруулахгүй байх үүднээс тушаалд заасан нэр томьёог ашиглахын оронд тушаалын зорилгыг тайлбарлах нь илүү үр дүнтэй байж болох юм. (Нэмэлт мэдээллийг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг боловсруулах талаар [MLA] 9 бүлгийн 9.2 – оос харна уу.)

5.3 Урьдчилсан арга хэмжээний шийдвэрийн шаардлагууд

Ихэнх улс оронд хөрөнгө хадгалах, хураах урьдчилсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шүүгч болон хяналтын шатны шүүгчийн зөвшөөрөл шаардагддаг. Түүнчлэн олон

---

[3] Хязгаарлах шийдвэр нь "Маревагийн тушаал" нийтлэг хуультай төстэй (ижилхэн бус) (10 бүлгийн 10.3.2 хэсгийн тэмдэглэл 45 дэлгэрэнгүй авч үзнэ)

[4] Колумб болон Мексик улсуудад прокурор хөрөнгө хураах, хязгаарлах эрхтэй байдаг (Тухайлбал, Law 793.02 Colombia хуулийг харна уу). Үүнтэй адилаар Швейцарь улсад прокуророос гаргасан хязгаарлах шийдвэрийг давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэгддэг (Criminal Code 311.0, art. 71, para. 3; Criminal Code 312.0, art. 263 [Switz.]).

[5] Эд хөрөнгийг улсын өмч болгох зарим хуулиудад хязгаарлах болон царцаах шийдвэрүүдийг тусгасан байдаг. Хязгаарлах шийдвэр нь (шүүгчийн шийдвэр) аливаа өмч хөрөнгийг хязгаарлах боломжтой өндөр түвшний тушаал бол царцаах шийдвэр нь (хууль сахиулах байгууллага болон төрийн албан хаагчдын удирдлагад хамаарах) үнийн дүн бага эд хөрөнгийг хязгаарлах боломжтой хязгаарлагдмал тушаалууд юм.

улсад онцгой тохиолдолд эсвэл богино хугацааны урьдчилсан арга хэмжээг Санхүүгийн тагнуулын алба, хууль сахиулах байгууллага эсвэл хуулийн дагуу бусад эрх бүхий байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг байна. (Онцгой байдлын урьдчилсан арга хэмжээгний талаар 8-р бүлгийн, 8.5.4-р хэсэг болон 9-р бүлгийн 9.2.6-р хэсгээс харна уу). Улс орнууд урьдчилсан арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргуулахад нотлох баримт болон үйл ажиллагааны шаардлагуудыг тавьж болдог байна.

5.3.1 Нотлох баримтад тавигдах шаардлага

Хөрөнгө хураах эсвэл хязгаарлах шийдвэрт тавигдах шаардлагууд нь ихэвчлэн дараах зүйлүүдийг агуулдаг (хөрөнгө хураах шийдвэрийн талаар 3-р бүлгийн 3.4.8-р хэсгийг харна уу):

- (a) зорилтот этгээд нь гэмт хэргээс орлого олсон гэж сэжиглэгдэж байгаа(хохирлын хэмжээнд үндэслэж улсын орлого болгох), эсвэл (b) хайж буй хөрөнгө гэмт хэргийн үйл ажиллагаатай холбоотой (хөрөнгөд үндэслэж улсын орлого болгох). (хөрөнгөд үндэслэж болон хохирлын хэмжээнд үндэслэж улсын орлого болгох талаар 7-р бүлгээс харна уу).
- Хэрэг үүсгэсэн эсвэл шинээр үүсгэж байх шаардлагатай[6]. Зарим улсад өмнө нь гэмт хэргээс олсон орлогын хэргийг хаасан орлуулах орлогыг хураах эсвэл царцаах боломжтой тохиолдолд хураах зөвшөөрөл олгодог байна. Шүүхийн шийдвэргүйгээр улсын орлого болгох үйл ажиллагааны явцад эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдсэнтэй шууд холбоотой гэж үзэх шаардлага ихэвчлэн тавигддаг байна.

Нийтийн эрх зүйн тогтолцоонд эдгээр шаардлагууд нь ерөнхийдөө “итгэх үндэслэлтэй шалтгаан” буюу “боломжтой шалтгаан” гэсэн нотлох баримтуудыг стандартаар тогтоодог[7]. Үүнтэй адилаар эх газрын эрх зүйн тогтолцоонд мөрдөн байцаалтын явцад эд хөрөнгийг хувиргах болон алдагдуулахгүйн тулд хөрөнгө хураах шийдвэр зайлшгүй шаардлагатай гэсэн прокурор эсвэл шүүгчийн итгэл үнэмшилд тулгуурлаж шийдвэр гаргаж байгаа юм. Нэмэлт шаардлагад алдагдах болон үрэгдэх эрсдэлтэй эд хөрөнгийг хурааж, хохирлыг барагдуулах үүрэг хүлээсэн үндэслэлийг багтаасан байх боломжтой[8]. Их Британид үндэслэлгүй мөнгөн хөрөнгийг тогтоох зорилгоор шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу түр царцаах шийдвэр гаргаж болдог байна (3-р бүлэг, шигтгээ 3.11-т дэлгэрэнгүй авч үзнэ). Үндэслэлгүй мөнгөн хөрөнгийг тогтоох зорилгоор шүүхээс гаргасан

---

[6] Зарим хязгаарлах арга хэмжээ нь мөрдөн байцаалтын ажиллагаа (эрүүгийн хэрэг)явагдаж байгаа тохиолдолд хүссэн үедээ өргөдөл гаргахыг зөвшөөрдөг. Энэ уян хатан байдал нь хязгаарлах шийдвэрийг эрт гаргах нөхцөлийг бий болгодог бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийг дэмжих шаардлагатай байдаг байна.

[7] Эдгээр нотлох баримтуудын стандартын томьёолол нь улс орон бүрт өөрөөр тодорхойлогдсон байдаг. Тухайлбал, Австралийн дээд шүүх “үндэслэлтэй итгэл үнэмшил”-ийг гэдэг нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалж, сэжиглэх эсвэл таамаглах оюун санааны хандлагыг үндэслэлтэй өдөөж болох санал, үндэслэлийг үгүйсгэхийн оронд түүнийг зөвшөөрөх хандлага гэж тодорхойлсон байдаг." George v. Rockett (1990) 170 CLR 104, High Court of Australia.

[8] Гэмт хэргээс үссэн болон тухайн үйл ажиллагааг шалгах явцад үүссэн хохирлыг барагдуулах ёстой улс орнуудад гэмт хэрэгтэнд учирсан хохирлыг прокурорын газраас барагдуулах нөхцөл хязгаарлагдмал байдаг. Прокурор ажил үүргээ биелүүлж байхдаа алдаа гаргасан эсвэл санаатайгаар албан тушаалаа урвуулан ашигласан зэрэг нь нотлогдоогүй тохиолдолд хохирлыг автоматаар барагдуулах тогтоол хэрэгсэхгүй болно.

шийдвэрт тодорхойлсон эд хөрөнгийг царцаах шийдвэр нь тухайн хөрөнгийг алдагдахаас сэргийлдэг (Home Office 2017, 16). Шигтгээ 5.1-д Нигер улсын сайд асан Диезани Алисон-Мадуекегийн хөрөнгийг царцаах оролдлогыг тайлбарласан болно.

ШИГТГЭЭ 5.1 Нигер: Газрын тосны нөөцийн сайд асангийн хэрэгт хөрөнгийг царцаасан болон иргэний журмаар хураан авсан хэрэг

Үндэслэл: Нигерийн газрын тосны нөөцийн сайд асан Диезани Алисон-Мадуекегийн өөрийн хамтран ажиллагсад болох Колаволе Аканни Алуко, Оладиже Омороке нартай ашигтай газрын тосны гэрээ байгуулахын тулд эрх мэдлээ ашигласан гэсэн таамаглал дэвшүүлж байгаа[a]. Тухайн албан тушаалд байх хугацаандаа Алисон-Мадуеке улсын төрийн өмчит Нигерийн үндэсний нефтийн корпорацийг удирддаг байжээ.

Мөрдлөг болон иргэний гомдол: Алисон-Мадуеке нь Нигер улсын хоёр халхавч компани болох Atlantic Energy Drilling Concepts Nigeria болон Atlantic Energy Brass Development гэх компаниудтай гэрээ байгуулсан бөгөөд уг компаниуд нь Британийн Виржиний арлын хувьцаат компаниудын эзэмшилд байдаг ба эцсийн өмчлөгчид нь Алуко болон Омокоре юм.

Эдгээр компаниуд найман хуурай газрын тосны хийн блокийн хайгуул болон олборлолтыг санхүүжүүлэх шаардлагатай байсан ч хөрөнгө болон техникийн мэдлэг дутуу байсан улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй[b]. Гэсэн хэдий ч тухайн компаниудад 1.5 тэрбум ам.доллараас илүү үнэ бүхий түүхий нефтийг босгож, борлуулах зөвшөөрөл олгосон байна. Алуко, Омокоре нар сайд асан болон түүний гэр бүлийн тансаг амьдралын хэв маягийг мөнгө угаасан орлого, Сейшелийн арлууд болон АНУ-д бүртгэлтэй компаниудыг ашиглан Их Британи, АНУ-д үл хөдлөх хөрөнгө ба бусад хөрөнгө, тэр дундаа 50 сая ам.доллар Манхэттэний хамгийн үнэтэй барилгуудын нэг болон 82 сая ам.долларын үнэтэй Галактика Од дарвуулт онгоцоор дамжуулан санхүүжүүлсэн[c].

Хөрөнгө царцаах болон улсын орлого болгох: Тус хэргийг Нигери, Швейцарь, Их Британи болон АНУ-д мөрдөн шалгасан. 2016 оны есдүгээр сард Их Британийн Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг (UK National Crime Agency) Омороке болон Алуко нарын сайдад ашиг гаргах үүднээс худалдаж авсан 10 сая фунт стерлингийн үнэ бүхий гурван үл хөдлөх хөрөнгийг битүүмжилсэн[d]. Гэвч Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг Лондонд 8 сая фунт стерлингийн үнэ бүхий хоёр үл хөдлөх хөрөнгийг зарахаас урьдчилан сэргийлж чадаагүй байна.

Нигери улсын Лагос хотын Холбооны Дээд Шүүх 2017 оны 8 дугаар сард 11.75 тэрбум (37.5 сая ам.доллар) үнэ бүхий Банана арал буюу Лагос хотын чинээлэгт тооцогдох Икойи орчмын эргээс хол байрлах хиймэл арал дээрх үл хөдлөх хөрөнгийг улсын орлого болгох шийдвэр гаргасан[e]. Мөрдөн байцаалтын явцад Эдийн засаг, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо өмнөх сайдтай холбоотой нэмэлт эд хөрөнгийг илрүүлсэн бөгөөд сайдтай холбоотой хэдэн тэрбум үнэ бүхий хөрөнгүүдийг улсын орлого болгох шийдвэр гаргасан[f].

АНУ-ын Хууль зүйн яам 2017 оны 7 дугаар сард Алисон-Мадуеке, Алуко болон Оморе нартай холбоотой 144 сая ам.долларын хөрөнгийг нөхөн төлүүлэхийг хүссэн иргэний гомдлыг гаргасан. Тухайн эд хөрөнгүүд нь улсын орлого болгох үйл ажилагаанд орох бөгөөд 50 сая долларын кондоминиум, 82 сая долларын дарвуулт онгоц багтана.[g]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 5.1	Нигер: Газрын тосны нөөцийн сайд асангийн хэрэгт хөрөнгийг царцаасан болон иргэний журмаар хураан авсан хэрэг

Одоогийн нөхцөл байдал: АНУ 2018 онд Хууль зүйн яамны мэдээллсний дагуу Алукогийн 2013 онд 82 сая ам.долларaар худалдаж авсан хөлөг онгоцыг хурааж авсан бөгөөд шүүхийн шийдвэрийн дагуу 2019 онд 37 сая ам.долларaар дуудлага худалдаанд оруулж, сарын 170,000 ам.долларын засвар үйлчилгээний зардлаас зайлсхийх зорилгоор эргүүлэн авахаар хүлээгдэж буй мөнгийг алдагдуулсан[h].

Алукогийн олж авсан 144 сая долларын эд хөрөнгийг хураах тухай нэхэмжлэлийг АНУ-ын Хууль зүйн яам мэдэгдсэнээр холбогдох нэхэмжлэлийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж дуустал түр зогсоосон байна.

a. АНУ-ын Хууль зүйн яам (DOJ). 2017. "Хууль зүйн яам Нигерийн нефтийн салбар дахь авлигын улмаас олсон 100 сая долларыг эргүүлэн авахаар зорьж байна." Хэвлэлийн мэдэгдэл № 77-777, 2017 оны 7 дугаар сарын 14-ны өдөр. https://www.justice.gov/opa/pr/department-justice -seeks-recover-over-100-million-obtained-corruption-nigerian-oil-industry.
b. DOJ, "100 сая долларыг эргүүлэн авахаар зорьж байна," 2017 оны 7 дугаар сарын 14-ны өдөр.
c. DOJ, "100 сая долларыг эргүүлэн авахаар зорьж байна," 2017 оны 7 дугаар сарын 14-ны өдөр.
d. Маргот Гиббс. 2017 он. "Онцгой: "Их Британид Алисон-Мадуекегийн хэрэг чангарч, 18 сая фунт стерлингийн үл хөдлөх хөрөнгийг илрүүлжээ". Premium Times, 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр. https://www.premiumtimesng.com/news/headlines/241676-exclusive-noose-tightens-around-alison -mad-ueke-uk-18-million-property-uncovered.html.
e. Эдийн засаг, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо. 2017 он. "Шүүхээс Диезанигийн 37.5 сая долларын Банана арлын өмчийг хураах шийдвэр гаргажээ." Хэвлэлийн мэдэгдэл, 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдөр. https://efccnigeria.org/efcc/news/2703-court-orders-final-forfeiture-of-diezani -s-37-5m-banana-island-property.
f. Тони Ориладе болон Айша Гамбари, "Диезани Алисон-Мадуеке: Ямар их сонирхол вэ!" Эдийн засаг, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо.https://efccnigeria.org/efcc/news/2706-diezani-alison-ma-dueke-what-an-appetite.
g. DOJ, "100 сая долларыг эргүүлэн авахаар зорьж байна," 2017 оны 7 дугаар сарын 14-ны өдөр.
h. Уильямс Клоуз. 2020 он. Энроны хуучин алба АНУ болон Нигерийн засгийн газруудыг 80 сая долларын үнэтэй дарвуулт онгоцны төлөө сөргөлдүүдж байна. Bloomberg, 2020 оны 7-р сарын 3-ны өдөр. https://www.latimes.com/business/story/2020-07-03/enron-legacy-returns-in-battle-over-80-million-yacht.

Олон улсад улс төр нөлөө бүхий этгээд (УТНБЭ)-ийн эд хөрөнгийг царцаах шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд Швейцарь (Шигтгээ 5.3) болон Канадын хууль тогтоомжийн дагуу дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Гадаадын Засгийн газар эрх мэдлээ алдсан
- Улсын авлигын түвшин өндөр
- Авлига, гэмт хэргийн удирдлага сул болон бусад хүнд гэмт хэргийн улмаас олж авсан байж болзошгүй хөрөнгө
- Шүүхийн тогтолцоо сул
- Улс орон эрх зүйн харилцан туслалцаа (ЭЗХТ) үзүүлэх шаардлагыг хангах чадваргүй
- Үндэсний эрх ашгийг хамгаалах (Швейцарь улсын хувьд)[9]

[9] Гадаад улсын улс төрд нөлөө бүхий этгээдийн хууль бус хөрөнгийг битүүмжлэх, буцаан авах тухай Холбооны Акт ("Foreign Illicit Assets Act" [FIAA] 2015 оны 12-р сарын 18, CC 196.1, 3 дугаар зүйлийн 2 дахь догол; 4 дүгээр зүйлийн 2–3 дахь догол [Switz.]), https://www.admin.ch/opc/en/classified-compilation/20131214/index.html

- Гадаад улсын дотоод эдийн засгийн хямрал болон улс төрийн тодорхойгүй нөхцөл байдал; мөн олон улсын харилцааны ашиг сонирхол (Канад улсын хувьд)[10]

5.3.2 Хөрөнгө хураах ажиллагаанд тавигдах шаардлага

Хөрөнгө хураах буюу хязгаарлах шийдвэрийг холбогдох дүрэм журмыг эд хөрөнгийг улсын орлого болгох тухай хууль эсвэл эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх хуулийг ишлэлээр тусгаж болно. Тухайлбал, Нийтийн эрх зүйд өргөдлийг бичгээр өгөхийг шаарддаг бөгөөд ихэвчлэн хоёр баримт бичгээс бүрддэг байна. Үүнд: (a) эд хөрөнгө хураах эрх олгох буюу хязгаарлах тушаал болон (b) дэмжлэг үзүүлэх гэрчийн мэдүүлэг. Шигтгээ 5.2 -т гэрчийн мэдүүлэг болон чухал нотлох баримтуудын талаар тайлбарласан болно.

Үүний эсрэгээр эх газрын эрх зүйд хавтаст хэрэгт багтсан холбогдох баримт бичиг буюу нотлох баримтаар нотлогдсон баримтуудыг шүүхийн байгууллагад танилцуулахыг шаардаж болдог байна. Харин иргэний хуулийн зарим эрх мэдлийн хүрээнд прокурор буюу хяналтын шатны шүүчид зөвхөн нотлох баримтыг хадгалах буюу улсын хөрөнгө орлого болгох хөрөнгийг үрэгдүүлэхээс зайлсхийх шаардлагатай гэсэн үндэслэлээр эд хөрөнгийг хураах буюу хязгаарлаж болно.

ШИГТГЭЭ 5.2 Гэрчийн мэдүүлэг авах (Аффидавит)

Гэрчийн мэдүүлэг (Аффидавит) гэдэг нь тухайн гэрчийн мэдлэг буюу итгэл үнэмшилд үндэслэсэн үнэн зөв гэдгийг тангарагласан мэдүүлэг юм. Энэ нь ихэвчлэн нийтийн эрх зүйн хүрээнд ашиглагддаг бөгөөд хөндлөнгийн байцаалтад хамаарахгүй бичгэн хэлбэрийн мэдүүлгээр дамжуулан нотлох баримтыг хүлээн авах чухал үйл ажиллагаа юм. Прокурор нь мэдүүлэг авалгүйгээр хөндлөнгийн байцаалтад орох гэрчүүдийг дуудах ёстой (аман нотолгоо); Эх газрын эрх зүйн тогтолцоонд нотлох баримтыг прокурор гаргаж өгөх боломжгүй байдаг.

АНУ-д шүүхийн шийдвэргүйгээр улсын орлого болгох хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэхэд аффидавит шаардлагагүй байдаг байна. Эрүүгийн хэрэг үүсгэхэд эд хөрөнгийг улсын орлого болгоход шаардлагатай болсон баримтуудыг товч дурдахад хангалттай. Аффидавит нь хөрөнгө буцаах хэрэгтэй холбоотой шүүхэд хандсан бүх хэрэгтэй хамааралтай байдаг бөгөөд үүнд нэгжлэг хийх, хөрөнгө хураах зөвшөөрөл, хязгаарлах шийдвэр, илрүүлэх буюу бичиг баримтаа үзүүлэх шүүхийн шийдвэр болон шүүх ажиллагааны явцад тодорхой төрлийн нотлох баримтын ашиглахыг зөвшөөрөх зэрэг багтдаг.

Хөрөнгө хураах, хязгаарлах болон мөрдөн байцаалтын бусад арга хэрэгсэлд аффидавит нь хэрэгт хамааралтай эх сурвалжуудаас авсан дамжсан яриан дээр үндэслэсэн нотлох баримт зэрэг холбогдох бүх материалыг ихэвчлэн хууль сахиулах байгууллагын ажилтануд танилцуулах үүрэгтэй байдаг. Салбарын мэргэжилтнүүд шүүхийн дүрэмд заасан арга барилын дагуу аффидавитын боловсруулсан эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Улс орнуудад салбарын мэргэжилтнүүд зориулсан чиглүүлэх маягт байдаг. Үүнээс гадна салбарын

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[10] Гадаад улсын албан тушаалтны авлигын гэмт хэргийн хөрөнгийг битүүмжлэх тухай Акт, S.C. 2011, c. 10 (Can.), Orders & Regulations 4(2) (2018 оны 8 сарын 18), http://laws.justice.gc.ca/eng/acts/F-31.6/page-1.html#h-4.

ШИГТГЭЭ 5.2	Гэрчийн мэдүүлэг авах (Аффидавит)

мэргэжилтнүүд дараах зүйлүүдийг анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:

- Нотлох баримт агуулсан аффидавит нь хязгаарлах шийдвэр гаргах нотлох баримтын шаардлагыг тухайн хэрэг хэрхэн хангаж байгааг тодорхойлох ёстой.
- Шүүхийн шийдвэрт аффидавит болон өргөдөлд дамжсан яриан дээр үндэслэсэн нотлох баримтыг хүлээн зөвшөөрдөг. Гэрчлэгч хөндлөнгийн этгээдээс авсан мэдээлэлд тулгуурлаж гэрчийн мэдүүлэг өгч байгаа тохиолдолд түүний эх сурвалж болон гэрч яагаад тухайн мэдээллийг үнэн зөв гэж үзэж буйг зааж өгөх ёстой.
- Хэрэгт холбогдох аливаа дагалдах баримт бичиг аффидавитад хавсаргасан байх шаарлагатай.
- Аффидавитад дурдагдсан баримтуудыг үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай.
- Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтэд нууцын гэрээ байгуулах хүсэлт гаргасан улс ороны хувьд шүүхэд /аливаа аффидавитийг/ өгөхөөс өмнө зөвшөөрөл авах ёстой.

Урьдчилсан арга хэмжээг зорилтот этгээд, тэдний гэр бүл, хамтрагчид[11], ялангуяа их хэмжээний эд хөрөнгийн ашиг сонирхлыг зөрчлийг хязгаарлах болон хуурах тохиолдолд эсэргүүцэх болон давж заалдах боломжтой. Үүний үр дүнд урьдчилсан арга хэмжээ авах өргөдлийн үйл явц нь тухайн өргөдлийг дэмжсэн мэдэгдлийг эсэргүүцэх жижиг хэмжээний шүүх хуралдаан болох боломжтой юм.

Зарим улс оронд санхүүгийн тогтолцооны хэмжээнээс хамааран (АНУ-г оруулан) хөрөнгө буцаах үйл ажиллагаа нь гол үүрэг гүйцэтгэдэг бол салбарын мэргэжилтнүүд тухайн үйл явц нь үйл ажиллагаанд учирсан хүндрэлийг давах боломжтой. Урьдчилсан арга хэмжээ нь тодорхой баримтын үндэслэлийг шаарддаг бөгөөд прокуроруд шүүх хуралдаанаар тогтоогдох хэргийн эцсийн шийдвэрийг хэлэцэхээс зайлсхийх шаардлагатай. Уг шийдвэр нь мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, улсын орлого болгох хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх нь хамгийн тохиромжтой байдаг.

Олон улсад холбогдох этгээдэд урьдчилсан арга хэмжээ авах эрхийг прокурорт олгодог буюу хөрөнгө шилжүүлэх, нуун дарагдуулах боломжтой гэсэн үндэслэлээр хөрөнгө эзэмшигчдэд мэдэгдэлгүйгээр арга хэмжээ авахыг зөвшөөрдөг байна. Зарим улс оронд прокурор болон хяналтын шатны шүүгч шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдэд хэрэг үүсгэх үнэмлэхүй эрхтэй байдаг бол бусад нь эд хөрөнгө алга болох, тараах эрсдэлтэй зэрэг тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд арга хэмжээ авах зөвшөөрөл олгодог байна.

Хязгаарлах шийдвэр авах хүсэлт гаргасан тухай мэдэгдэл нь тухайн эд хөрөнгийг устгах, үрэгдүүлэхэд хүргэх эрсдэлтэй эсвэл хязгаарлалтанд хамаарах эд хөрөнгө нь хөрвөх чадвар сайтай бол (банкны дансанд дахь мөнгөн хөрөнгө, үнэт эдлэл, бэлэн мөнгө гэх мэт) сайн туршлагад заасны дагуу хүсэлтийг нөгөө талд мэдэгдэлгүйгээр гаргах зарчмаар үйл ажиллагааг явуулхыг шаарддаг байна.

[11] Швейцарь улсад банкан дахь харилцах дансыг царцаах шийдвэрийг тухайн хөрөнгийн эцсийн өмчлөгч бус зөвхөн албан ёсны эзэмшигч (тухайбал халхавч компанийн захирал эсвэл трастын итгэмжлэгдсэн төлөөлөгч) эсэргүүцэж болдог байна.

Холбогдох этгээдэд мэдэгдэхгүйгээр хөрөнгө хураах, хязгаарлах шийдвэр гаргах нь хязгаарлагдмал хугацаанд хүчинтэй байдаг бөгөөд энэ хугацаанд өргөдөл гаргагч нь (a) хөрөнгө эзэмшигчид мэдэгдэл хүргүүлж, шүүх хуралдаанд оролцох боломжийг олгох, эсвэл (b) хугацаа сунгах талаар шүүхэд хүсэлт гаргахын аль нэгийг заавал биелүүлэх ёстой байдаг. Зарим улсад хөрөнгө эзэмшигчид протокол зэрэг үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллээр хангахыг шаарддаг.

5.3.3 Гадаадад байгаа хөрөнгийг түр хугацаагаар хязгаарлах буюу хураах

Гадаад улсад байгаа эд хөрөнгийг хураах, хязгаарлах олон арга замууд байдаг[12]. Улс орны урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах хүсэлтийн дагуу гадаад улсын эрх бүхий байгууллага хүсэлт гаргасан улсын хязгаарлах, хураах шийдвэрийг албадан хэрэгжүүлж болдог байна[13]. Түүнчлэн хүсэлт хүлээн авсан улсын эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан улсаас хангасан, тогтоосон баримтад үндэслэн дотооддоо хөрөнгө хязгаарлах, хураах шийдвэрийг гаргаж болдог. Хөрөнгө хураах, хязгаарлах албан бус буюу захиргааны аргын талаар Бүлэг 8-аас дэлгэрэнгүй харж болно. Шигтгээ 5.3, 5.4, 5.5 болон 5.6-д хөрөнгө хязгаарлах урьдчилсан арга хэмжээний туршлагыг харуулсан.

ШИГТГЭЭ 5.3	Арабын хавар үйл явдалтай холбоотой хөрөнгийг хойшлуулшгүйгээр царцаах Швейцарийн Холбооны Зөвлөлийн эрх мэдэл

Швейцарийн Холбооны Зөвлөл Үндсэн хуулиар олгогдсон эрх мэдлийнхээ дагуу ажиллаж, Хосни Мубарак (Арабын Бүгд Найрамдах Египет Улс) болон Зин эль Абидин Бен Али (Тунис) зэрэг бусад хүмүүстэй холбоотой хөрөнгийг түргэн, шуурхай царцаах боломжтой болсон (Cissé et al. 2013). Швейцарийн Холбооны Үндсэн хууль нь Холбооны Зөвлөлд улс орны эрх ашгийг хамгаалахын тулд захирамж, шийдвэр гаргах эрхийг олгодог боловч эдгээр тогтоолууд нь зөвхөн хязгаарлагдмал хугацаанд хүчинтэй байна[a].

Египетийн Ерөнхийлөгч асан Хосни Мубаракийн Швейцарьт эзэмшиж байсан хөрөнгө

Эд хөрөнгө царцаах шийдвэр: Мубарак 2011 онд огцорсны дараагаар болон хэдэн долоо хоног үргэлжилсэн олон нийтийн эсэргүүцсэн цуглааны дараа Холбооны зөвлөл Египетийн ерөнхийлөгч асан болон түүний ойрын намуудын Швейцарь дахь бүх хөрөнгийг царцаах шийдвэр гаргасан. Царцаах тухай шийдвэр шууд хүчин төгөлдөр болсон бөгөөд үл хөдлөх хөрөнгө зэргийг худалдах, захиран зарцуулахыг хамарсан[b]. Уг шийдвэр нь анх гурван жилийн хугацаанд хүчинтэй байхаар гарсан бөгөөд 2017 он хүртэл сунгасан.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[12] НҮБ-ын АЭК-ийн бүлэг 54(2)(a) and 54(2)(b)-ээс механизмуудын жагсаалтыг үзнэ үү.

[13] Энэ нь хүсэлт гаргасан улс орон нь гадаад улсад байрлаж буй эд хөрөнгийг газар нутаг дэвсгэрээс гадуур байхыг шаарддаг бөгөөд хязгаарлах шийдвэрийг жагсаалтад орсон байх ёстой байдаг. Хүсэлт гаргасан улс орны дагуу тухайн үйл ажиллагааг шууд хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн эд хөрөнгө улсын орлого болгох ажиллагаа явуулж буй зорилтот этгээд болон түүний гэр бүл, хамтрагчдад тулгарч буй асуудал, хүндрэлийг авч үзэхийн тухайн улс орны шүүхээс хориглосон заалтууд байдаг. Эдгээр заалтууд нь хоёр өөощр улсын дагуу ижил төстэй асуудлыг шийдвэрлэхээс сэргийлдэг байна.

ШИГТГЭЭ 5.3 Арабын хавар үйл явдалтай холбоотой хөрөнгийг хойшлуулшгүйгээр царцаах Швейцарийн Холбооны Зөвлөлийн эрх мэдэл

Одоогийн нөхцөл байдал: Анх царцаасан хөрөнгийн нийт хэмжээ ойролцоогоор 700 сая ам.доллар байсан. Гэвч Египетийн эрх баригчид олон тооны эвлэрлийн гэрээ, цагаатгах шийдвэр, цуутай хэргүүдийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зогсоох шийдвэр гаргасны дараа энэ дүн эцэст нь Sw F 430 сая болгож бууруулжээ. 2017 оны 12 дугаар сард буюу анхны шийдвэр гарснаас хойш бараг долоон жилийн дараа Холбооны Зөвлөл Египетийн эрх баригчидтай хамтран ажилласнаар хүлээгдэж буй үр дүнд хүрээгүй гэдгийг ойлгоод царцаах шийдвэрийг цуцалсан[c]. Гэсэн хэдий ч энэхүү шийдвэр нь хөрөнгийг чөлөөлөхөд хүргээгүй бөгөөд Швейцарийн эрх баригчид эд хөрөнгийн гарал үүслийг хууль бус эсэхийг тогтоох болон шаардлагатай эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилгоор Швейцарьт тусгаарлагдсан хэвээр байна.

Тунисын Ерөнхийлөгч асан Бен Алигийн Швейцарьт эзэмшиж байсан хөрөнгө

Эд хөрөнгө царцаах шийдвэр: Бен Алиг Тунисаас дүрвэсний дараа Холбооны Зөвлөл 2011 оны 01 дүгээр сард улсын хөрөнгийг шамшигдуулах, гадаад улсад шилжүүлэх эрсдэлээс зайлсхийхийн тулд шаардлагатай арга хэмжээг авах шийдвэр гаргасан. Энэ нь Бен Али болон хамтрагчдын Швейцарьт эзэмшиж байсан бүх хөрөнгийг нэн даруй хэрэгжүүлэх гурван жилийн хугацаатай царцаах шийдвэр гаргасан. Мөн тус зөвлөлөөс эдгээр иргэдийн үл хөдлөх хөрөнгийг худалдах болон захиран зарцуулахыг хориглосон[d].

Одоогийн нөхцөл байдал: Нийлбэр дүнгээр 60 сая Швейцарийн франктай дүйцэхүйц хөрөнгө царцаах шийдвэрийн дагуу царцаасан хэвээр байгаа бөгөөд үүнийг 2021 он хүртэл сунгасан[e]. Холбооны зөвлөлийн мэдээлснээр, 2011 оноос хойш Тунисын эрх баригчид хамтран ажиллах хүсэлтэй байгаа илэрхийлсэн боловч тухайн эд хөрөнгийг улсын орлого болгох үйл ажиллагаа болон төлбөр тооцоо хийгдэхгүй байгаа юм. Холбооны Зөвлөл Тунисын хөрөнгийг буцаах үйл ажиллагаанд нь туслах зорилгоор царцаах хугацааг сунгалаа.

Гадаадын хууль бус хөрөнгийг царцаах, буцаан олгох тухай Холбооны хуулийг батлах талаар

Швейцарь улс Арабын хавартай холбоотой учирч буй хүндрэлд хариу арга хэмжээ авч, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Хууль бус хөрөнгийг царцаах, буцаан олгох тухай Холбооны хуулийг ("Гадаадын хууль бус хөрөнгийн тухай хууль" (ГХБХТХ) буюу FIAA) баталсан[f]. Гадаадынхууль бус хөрөнгийн тухай хууль нь улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ) болон тухайн этгээдүүдийн ойр дотны хүмүүсийн авлига, гэмт хэргийн болон бусад хүнд гэмт хэргийн замаар олж авсан гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд хөрөнгийг царцаах, улсын орлого болгох, нөхөн төлүүлэх зэрэг асуудлыг зохицуулдаг байна[g].

Холбооны Зөвлөл Швейцарь улс дахь улс төрд нөлөө бүхий этгээдийн хөрөнгийг эрх зүйн харилцан туслалцаа (ЭЗХТ) үзүүлэх зорилгоор (ГХБХТХ, 3-р зүйл) царцаах, эсхүл эрх зүйн харилцан туслалцааны ажиллагаа амжилтгүй болвол улсын орлого болгох (ГХБХТХ, 4-р зүйл) зэрэг шийдвэрүүдийг хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд гаргаж болно. (Нотлох баримтын шаардлагын талаар 5-р бүлгийн 5.3.1-ээс үзнэ үү.)

Гадаадын хууль бус хөрөнгийн тухай хууль (6-р зүйл) нь хөрөнгө царцаах шийдвэрийн хугацаа болон тус хугацааг сунгах хүрээнд зохицуулалт хийдэг.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 5.3 Арабын хавар үйл явдалтай холбоотой хөрөнгийг хойшлуулшгүйгээр царцаах Швейцарийн Холбооны Зөвлөлийн эрх мэдэл

Улс орон эрх зүйн харилцан туслалцааны хүрээнд хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн тохиолдолд эд хөрөнгийг царцаах хугацааг нэг жилээр сунгах боломжтой. Үүний үндсэн дээр жил бүр сунгах замаар эд хөрөнгө царцаах хугацааг дээд тал нь 10 жилээр сунгаж болно. Тухайлбал, саяхан Бен Алигийн хэргийн сунгалтыг энэ заалтыг үндэслэн олгосон байна[h].

a. 1999 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Швейцарийн Холбооны Үндсэн хууль, SR 101, art. 184 (on "Foreign Relations"), para. 3 (2020 оны 6-р сарын 18-нд хандсан), https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19995395/index.html.
b. Швейцарийн Холбооны Зөвлөл. 2011 он. "Холбооны Зөвлөл Египетийн Ерөнхийлөгч асан Хосни Мубаракийн Швейцарь дахь бүх хөрөнгийг битүүмжлэх тушаал гаргажээ.." 2011 оны 2 дугаар сарын 11-ний өдөр (2020 оны 4-р сарын 18-нд хандсан). https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases. msg-id-37632.html.
c. Швейцарийн Холбооны Зөвлөл. 2017 он. "Холбооны Зөвлөл Тунис, Украины хөрөнгийг битүүмжлэх хугацааг сунгаж, Египетийн хөрөнгийг битүүмжлэлийг цуцаллаа." 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр (accessed April 18, 2020). https://www.admin.ch/gov/en/start/documentation /media-releases.msg-id-69322.html.
d. Швейцарийн Холбооны Зөвлөл. 2011 он. "Холбооны Зөвлөл Тунисын Ерөнхийлөгч асан Бен Алигийн Швейцарьт эзэмшиж байсан бүх хөрөнгийг битүүмжлэх тушаал гаргажээ." 2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр. (2020 оны 4-р сарын 18-нд хандсан). https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases. msg-id-37285.html.
e. Швейцарийн Холбооны Зөвлөл. 2019 он. "Холбооны зөвлөл Тунис, Украинтай холбоотой хөрөнгийг царцаах хугацааг сунгалаа." 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр (2020 оны 6-р сарын 18-нд хандсан). https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-77509.html.
f. Гадаадын хууль бус хөрөнгийн тухай хууль (FIAA) Dec. 18, 2015, CC 196.1, art. 3, para. 2; art. 4, paras. 2–3 (Switz.), https://www.admin.ch /opc/en/classified-compilation/20131214/index.html. Pursuant to similar legislation adopted by Canada-the Freezing Assets of Corrupt Foreign Officials Act , S.C. 2011, c. 10 (Can.), Orders & Regulations 4(2), http://laws.justice.gc.ca/eng/acts/F-31.6 /page-1.html#h-4)-the Canadian government issued regulations regarding the freezing of assets in Tunisia and Ukraine.
g. FIAA (Switz.), art. 1, "Зорилго."
h. Швейцарийн Холбооны Зөвлөл, "Тунисын ерөнхийлөгч асангийн эзэмшиж байсан бүх хөрөнгийг битүүмжлэх," 2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

ШИГТГЭЭ 5.4 Нигер улс: OPL 245 хэрэгт царцаасан хөрөнгө

Үндэслэл: Royal Dutch Shell болон Eni S.p.A.-г Нигерийн газрын тосны хайгуулын лиценз (OPL) 245 газрын тосны блокыг авахын тулд хээл хахуулийн схемд оролцсон гэж сэжиглэж байсан. Ойролцоогоор 1.1 тэрбум ам.долларыг газрын тосны компаниуд Нигерийн газрын тосны сайд асан Дан Этетегийн эзэмшдэг Malabu Oil and Gas компанид төлсөн гэж мэдэгджээ. (Энэ тохиолдолд сэжигтэй дохионы талаарх дэлгэрэнгүйг 4-р бүлгийн 4.4-ийг үзнэ үү.)

Эд хөрөнгө царцаах шийдвэр: Ромд төвтэй Eni-тэй холбоотой мөрдөн байцаалтын хүрээнд Италийн прокуророууд 2014 оны 5 дугаар сард Их Британий Прокурорын байгууллагад Malabu Oil and Gas компанийн 85 сая долларын хөрөнгийг царцаах хүсэлт гаргасан. Үүнтэй холбоотойгоор Лондонгийн Southwark Crown шүүх тухайн хөрөнгийг царцаах шийдвэрийг гаргажээ. Мөн 2015 оны 12 дугаар сард Southwark Crown шүүхийн шүүгч Эдис Малабугийн царцаах шийдвэрийг хүчингүй болгох хүсэлтийг хүлээн аваагүй байна[a]. Түүнчлэн Италийн

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 5.4 Нигер улс: OPL 245 хэрэгт царцаасан хөрөнгө

прокурорын хүсэлтийн дагуу зуучлагч Эмека Обид төлсөн 110.5 сая ам.долларыг 2013 онд Их Британийн Арилжааны шүүхээс царцаасан байна[b]. Тухайн хөрөнгийн дийлэнх хэсэг нь Швейцарь улсад байсан бөгөөд Малабугийн хэлэлцээрийн дараа Eni-ийн удирдлагуудад өгсөн хахууль байсан гэж үздэг.

Үр дүн ба одоогийн нөхцөл байдал: 2018 оны 9 дүгээр сард Миланы шүүх шуурхай шүүх хурлын үеэр Эмека Оби болон Италийн зуучлагч нарт дөрвөн жилийн хорих ял оноож, тэднээс 120 сая гаруй ам.доллар хураан авсан байна[c]. Eni болон Shell-ийн эсрэг явагдаж буй шүүх хурал одоог хүртэл Миланд үргэлжилсээр байна. 2017 оны 1 дүгээр сард Абужа дахь Нигерийн Холбооны дээд шүүхийн шүүгч Жон Цохо газрын тосны блокийн хяналтыг Нигерийн холбооны засгийн газарт шилжүүлж, мөрдөн байцаалтын ажиллагаа болон сэжигтнүүдийг яллах хүртэл шийдвэр гаргажээ[d]. Энэхүү түр хугацааны битүүмжлэх үйл ажиллагааг Нигерийн шүүх цуцалж, газрын тосны блокийн эзэмшлийг Shell болон Eni-ийн Нигерийн охин компаниудад буцааж өгсөн.

a. Global Witness. 2015 он. "Шүүх Нигерийн нефтийн блок руу хийсэн 'Smash and Grab' Raid-ийн хөрөнгийг хяналтаас гаргахаас татгалзав." Хэвлэлийн мэдээ, 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр. https://www.globalwitness.org/en/press-releases/court-refuses-unfreeze-funds-smash-and-grab-raid -nigerian-oil-block/.
b. Energy Venture Partners Ltd. v. Malabu Oil & Gas Ltd., Queens Bench Division before Lady Justice Gloster (2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр) EWHC 2118 (Comm).
c. Бен Чапман. 2018 он. "Нигерийн нефтийн ордын халхавч болон Энигийн гэрээтэй холбоотой авлигын хэргээр хоёр зуучлагч яллагдана." 2018 оны 9 дугаар сарын 21-ний өдөр (2020 оны 5-р сарын 7-нд хандсан). https://www.independent.co.uk/news/business/news/shell-eni-corruption-trial -two-men-convicted-emeka-obi-di-nardo-a8551436.html.
d. Эдийн засаг, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо, "Шүүхээс Малабу газрын тосны блокыг хураах шийдвэр гаргасан." https://efccnigeria.org/efcc/news /2287-court-orders-forfeiture-of-malabu-oil-block.

ШИГТГЭЭ 5.5 Бразил: Швейцарь дахь Лава Жатогийн хөрөнгийг царцаах үйл ажиллагаа

Бразилийн Лава Жатогийн (машин угаалгын газар) авлигын томоохон дуулиан болж, Бразилийн эрх баригчид хөрөнгөө буцаан авахын тулд хэд хэдэн улстай олон улсын хэмжээнд хамтран ажилласан[a]. Үүнтэй холбоотойгоор Швейцарь улс 2015 оны 3 дугаар сард 120 сая ам.долларын хөрөнгийг Бразил улсад буцааж олгосон. Тухайн оны дараагийн гуравдугаар сард Швейцарийн эрх баригчид дахин 70 сая ам.долларын хөрөнгийг буцаан авахаар төлөвлөж байгаагаа зарлав. Уг хэрэгт холбогдсон нийт 800 сая ам.долларыг Швейцарьт царцаасан болно[b].

Швейцарьт байршиж буй дансны эцсийн өмчлөгчид (ихэнх хэсэг нь дотоодын компаниудын эзэмшилд байдаг)[c] нь Бразилийн Холбооны Засгийн газрын хяналтан дор байдаг холимог капиталын компани болох Petroleo Brasileiro (Petrobras)-ын удирдлагууд болон тэдгээрийн хамтран ажиллагсад, түүний дотор санхүүгийн зуучлагч, Бразилийн улс төрчид багтана[d].

a. Хэргийн таларх дэлгэрэнгүйг 2-р бүлгийн 2.4 ба 2.11-р бүлгээс үзнэ үү; 3-р бүлэг, хайрцаг 3.1; ба 4-р бүлэг, хайрцаг 4.2.
b. Бразилийн Холбооны Прокурорын алба, "A Lava Jato em números no Paraná" [Car Wash, by the Numbers, in Paraná State], last updated March 19, 2020, http://www.mpf.mp.br/grandes-casos/lava-jato/resultados.
c. Оршин суугаа хаягийн дагуу үйл ажиллагаа явуулдаг компани гэдэг нь бүртгүүлсэн газраа арилжааны болон үйлдвэрлэлийн бизнес эрхэлдэггүй корпораци, итгэлцэл, сан юм.
d. Швейцарийн Холбооны Зөвлөл. 2016 он. "Петробрас хэрэг: Цаашид царцаагдсан 70 сая ам.долларын хөрөнгийг блокоос гаргаж, Бразил руу буцаана." 2016 оны 3 дугаар сарын 17-ны өдөр. https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-61034.html.

ШИГТГЭЭ 5.6 Украйн: Виктор Януковичийн эд хөрөнгийг царцаах шийдвэр

Үндэслэл: 2019 оны 1 дүгээр сард Украины ерөнхийлөгч асан Виктор Янукович эх орноосоо урвасан хэргээр 13 жилийн хорих ялыг оногдуулсан байна[a]. Янукович болон түүний хамтрагчдыг Украин, Швейцарьт авлига болон албан тушаалаа урвуулан ашигласан, мөнгө угаасан хэргээр мөрдөн шалгаж байгаа юм[b]. Украины ерөнхий прокурорын мэдээллэснээр, Янукович улсын 100 тэрбум ам.долларын хөрөнгийг хулгайлсан байна[c]. Түүнийг албан тушаалаас нь буулгасны дараагаар[d] олж илрүүлсэн баримт бичгүүдээс үзэхэд Янукович болон түүний хамтрагчид эд хөрөнгө болон хуулийн этгээдийг эцсийн өмчлөгчийг нуун дарагдуулахын тулд халхавч компани, траст болон сангаас бүрдсэн цогц корпорацийн өмчлөлийн сүлжээг ашигласан болох нь тогтоогдсон.

Украйны хямралын хариуд Канад, Европын холбоо, Швейцарь, АНУ зэрэг хэд хэдэн улс Янукович болон түүний хамтрагчдын хөрөнгийг царцаах шийдвэр гаргасан. Гэхдээ царцаасан хөрөнгийн хэмжээг ямар ч тохиолдолд нийтэд мэдээлээгүй байна.

Европын холбооноос гаргасан хөрөнгө царцаах шийдвэр: Европын холбоо 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Януковичийг Украинд төрийн өмч шамшигдуулсан болон тухайн хөрөнгийг хууль бусаар Украйны газар нутгаас хууль бусаар шилжүүлсэн хэргээр шүүхийн өмнөх мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байсан гэх үндэслэлээр нэг жилийн хугацаанд түүний хөрөнгө, эдийн засгийн нөөцийг царцаасан[e]. Эд хөрөнгийг шийдвэр нь түүний ойрын 17 холбоотнуудыг хамруулсан бөгөөд хоёр хүү нь багтсан байна. Нийт 22 албан тушаалтныг хамруулсан царцаах шийдвэр нь 2014 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр сунгагдсан[f]. Мөн 2015 оны 3 дугаар сарын 05-ны өдөр царцаах шийдвэрийг нэг жилээр сунгаж, Янукович болон түүний хамтран зүтгэгчдийг төсвийн хөрөнгө, хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан хэргээр Украиныэрх баригчид эрүүгийн хэрэг үүсгэсэн хэвээр байна гэсэн үндэслэлээр жагсаалтад оруулсан[g].

Янукович болон түүний хүү Олександр нар 2015 оны 3 дугаар сараас 2016 оны 3 дугаар сар хүртэл хөрөнгийг царцаах шийдвэрийг Европын Ерөнхий шүүхэд гаргахаас өмнө хөрөнгүүдийг нь царцаасан бөгөөд үүний дараагаар Европын холбооны шүүхээс (ЕХШ) тухайн үйл ажиллагааг баталсан болно[h]. Уг шийдвэрт багтсан бусад этгээдүүд Европын холбооны шүүхийн өмнөх эд хөрөнгө царцаах шийдвэрийг эсэргүүцсэн бөгөөд үүний үр дүнд тэдний заримд тавьсан хоригийг цуцалсан[i]. Хориг арга хэмжээг цуцлах болсон гол шалтгаануудын нэг нь Украинд мөрдөн байцаалтын ажиллагаа үр дүнтэй хийгээгүй, Украины мөрдөгчид гадаадын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүд байв.

Түүнээс хойш Янукович болон түүний хамсаатнуудын хөрөнгийг царцаах арга хэмжээнээс удаа дараа гарснаар жагсаалтад оруулах шалгуурт өөрчлөлт оруулсан. 2019 онд хөрөнгө царцаах шийдвэр 2020 оны 3 дугаар сарын 06-ны өдөр хүртэл сунгаж, Януковичийг оролцуулаад ердөө 12 этгээдийг оролцуулан сунгасан байна[j]. 2020 оны 3 дугаар сард тухайн шийдвэр дахин нэг жилээр сунгагдсан бөгөөд одоо зөвхөн 10 хүний жагсаалтад хамааруулсан байна[k].

Швейцарь улсын царцаах шийдвэрийн тухай: Украины хөрөнгийг буцаах хэргийн хүрээнд Швейцарийн Холбооны зөвлөл Украины Ерөнхий прокурорын газраас гаргасан эрх зүйн харилцан туслалцааны (ЭЗХТ) хүсэлтийг хэрэгжүүлж, 2014 оны 2 дугаар сард Януковичийн хөрөнгийг 70 сая Швейцарийн франк хүртэл хөрөнгийг царцаах болсныг зарласан. Царцаах шийдвэрийг гурван удаа сунгасан

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 5.6 Украйн: Виктор Януковичийн эд хөрөнгийг царцаах шийдвэр

бөгөөд хамгийн сүүлд 2019 оны 12 дугаар сард нэг жилээр сунгасан№. Ерөнхий прокурорын газраас 2014 онд Базелийн Засгийн газрын хөрөнгө сэргээх олон улсын төвд (ICAR) Янукович болон түүний хамтрагчдын хулгайлсан хөрөнгийг олж илрүүлэх, олж авахад туслах үүрэг өгсөн[m].

АНУ-д хориг тавих шийдвэрийн талаар: 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдөр АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама Украины төрийн өмчийг хууль бусаар шамшигдуулсан үндэслэлээр тухайн хэрэгт холбогдох Украйны нутаг дэвсгэрт байгаа хүмүүсийн АНУ дахь өмчид хориг тавьсан тухай 13660 тоот Гүйцэтгэх тушаалыг гаргасан[n].

Канад улсын хөрөнгө царцаах журам: Украины хүсэлтээр Канад улс мөн авлигад идэгдсэн гадаадын албан тушаалтнуудын хөрөнгийг царцаах тухай хуулийн (2011) үндсэн дээр төрийн мөнгийг завшсан, албан тушаал, бизнес, эсвэл хувийн харилцаа холбоотой болон гэр бүлийнх нь үйл ажиллагааны үр дүнд зүй бусаар өмч хөрөнгө олж авсан хүмүүсийн эд хөрөнгийг царцаах журмыг баталсан[o].

a. Эндрю Рот. 2019 он. "Украины Ерөнхийлөгч асан Виктор Янукович эх орноосоо урвасан хэрэгт буруутгагдлаа." Guardian, 2019 оны 1-р сарын 25-ны өдөр. https://www.theguardian.com/world/2019/jan/25/ukraine-ex-president-viktor-yanukovych-found-guilty-of-treason.

b. Эндрю Э. Крамер. 2019 он. "Украины Ерөнхийлөгч асан Виктор Янукович эх орноосоо урвасан хэрэгт буруутгагдлаа," New York Times, 2019 оны нэгдүгээр сарын 24-ний өдөр. https://www .nytimes.com/2019/01/24/world/europe/viktor-yanukovych-russia-ukraine-treason.html.

c. Гай Фолконбридж, Анна Дабровский, Стивен Грей нар. 2014 он. "Мафийн" Ерөнхийлөгчийг унагасан нь Украинд 100 тэрбум долларын хохирол учруулсан гэж прокурор хэлэв." Reuters, 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр. https://www.reuters.com/article/us-ukraine-crisis-yanukovich/toppled-mafia -president-cost-ukraine-up-to-100-billion-prosecutor-says-idUSBREA3T0K820140430.

d. Сэргээсэн баримт бичгүүдийг "YanukovychLeaks National Project" компанийн https://yanukovychleaks.org/en/ цахим хуудсанд байршуулсан байна.

e. Европын холбооны зөвлөлийн журам 2014 оны 3-р сарын 5-ны өдрийн 208/2014 тоот - Украин дахь нөхцөл байдлыг харгалзан тодорхой хүн, аж ахуйн нэгж, байгууллагуудын эсрэг чиглэсэн хязгаарлалтын арга хэмжээний тухай (OJ L 66, 06.03.2014), https://eur-lex.europa.eu/legal-content/EN /TXT/?uri=celex-:32014R0208.

f. Зөвлөлийн хэрэгжүүлэх журам (ЕХ) 2014 оны 4-р сарын 14-ны өдрийн 381/2014 тоот - Украйн дахь нөхцөл байдлын үүднээс зарим хүмүүс, аж ахуйн нэгж, байгууллагуудын эсрэг чиглэсэн хязгаарлалтын арга хэмжээний тухай (OJ L 111, 15.04.2014), https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX-%3A32014R0381.

g. Зөвлөлийн хэрэгжүүлэх журам (ЕХ) 2014 оны 3-р сарын 15-ны өдрийн 2015/357 тоот Украйн дахь нөхцөл байдлын үүднээс тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн эсрэг чиглэсэн хязгаарлалтын арга хэмжээний тухай (OJ L 62, 06.03.2015), https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex-:32015R0357.

h. Европын Холбооны Шүүх. 2017 он. "Украины Ерөнхийлөгч асан ноён Виктор Янукович болон түүний хүү Александр нарын хөрөнгийг 2015 оны 3-р сарын 6-наас 2016 оны 3-р сарын 6 хүртэл хугацаанд царцаахыг Шүүхийн шүүх баталжээ.." Хэвлэлийн мэдэгдэл № 108/17, 2017 оны 10-р сарын 19-ний өдөр. https://curia.europa.eu/jcms/upload/docs/application/pdf/2017-10/cp170108en.pdf.

i. AntAC (Авлигын эсрэг үйл ажиллагааны төв). 2019 он. "Украины клептократуудын эсрэг ЕХ-ны таван жилийн хориг арга хэмжээ: Хоёр хүн хэрэгтэй танго." 2019 оны 4-р сарын 3-ны өдөр. https://antac.org.ua/en/publications/five-years-of-eu-sanctions-against-ukrainian-kleptocrats-tango-that-needs-two/.

j. Европын холбооны зөвлөл. 2019 он. "Украины улсын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан нь: Зөвлөл ЕХ-ны хориг арга хэмжээг нэг жилээр сунгалаа." Хэвлэлийн мэдээ, 2019 оны 3 дугаар сарын 4-ны өдөр .https://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2019/03/04/ misappropriation-of-ukrainian-state-funds-council-prolongs-eu-sanctions-for-one-year/.

k. Европын холбооны зөвлөл. 2019 он. "Украины улсын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан нь: Зөвлөл хөрөнгийн царцаах хугацааг сунгав." Хэвлэлийн мэдээ, 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдөр. https://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2020/03/05/ misappropriation-of-ukrainian-state-funds-council-extends-asset-freezes/.

l. Швейцарийн Холбооны Зөвлөл. 2019 он. "Холбооны Зөвлөл Тунис, Украинтай холбоотой хөрөнгийг царцаах хугацааг сунгав." Хэвлэлийн мэдээ, 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр. https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-77509.html.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 5.6	Украйн: Виктор Януковичийн эд хөрөнгийг царцаах шийдвэр

m. Базелийн институт. 2014 он. "ICAR Януковичийн хөрөнгийг эргүүлэн авахад Украинд туслах үүрэгтэй." Мэдээ, 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдөр. https://www.baselgovernance.org/news/icar-mandated-assist-ukraine-recovering-yanukovych-assets.
n. Exec. Order No. 13660, 79 Fed. Reg. 13491 (2014 оны 3 дугаар сарын 6), sec. 1(i)(C). https://www.federalregister.gov/ documents/2014/03/10/2014-05323/blocking-property-of-certain-persons-contributing-to-the-situation-in-ukraine.
o. Авлигад автсан гадаадын албан тушаалтнуудын хөрөнгийг царцаах тухай (Украйн) журам, SOR/2014-44 (March 26, 2014), http://canadagazette. gc.ca/rp-pr/p2/2014/2014-03-26/html/sor-dors44-eng.html.

5.4 Хөрөнгө хязгаарлах болон хураах ажиллагааны өмнөх төлөвлөлт

Үр дүнтэй эд хөрөнгийн хязгаарлах болон хураан авах үйл ажиллагааг явуулахын тулд зөв зохистой төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай байдаг. Салбарын мэргэжилтнүүдэд үйл ажиллагаандаа анхаарах шаардлагатай хэд хэдэн хүчин зүйлийг доор дурдав.

5.4.1 Урьдчилсан хөрөнгө хураах арга хэмжээгээр авах хөрөнгийг тодоройлох

Урьдчилсан хураах арга хэмжээ авж буй хөрөнгө нь улсын орлого болгох шийдвэрийг биелүүлэх боломжтой үйл ажиллагаа юм. Урьдчилсан арга хэмжээ авах өргөдлийг улсын орлого болгох арга хэмжээ, хязгаарлагдсан болон хураагдсан эд хөрөнгийн эсрэг үйлчилж болзошгүй хориг арга хэмжээнд (нэгээс олон арга хэмжээ авах боломжтой) нийцүүлэн сайтар боловсруулсан байх ёстой.

Зохих хөрөнгийг урьдчилсан байдлаар хураах арга хэмжээ авах эсэх нь улсын орлого болгох тогтолцооноос (өөрөөр хэлбэл, уг тогтолцоо нь өмчид суурилсан эсвэл хохирлын хэмжээнд үндэслэсэн эсэх) хамаарна. Тухайлбал, өмчит суурилсан хураах үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын улсын орлого болгох шийдвэр нь зорилтот этгээдийн эсрэг авах боломжтой цорын ганц арга хэмжээ байдаг бөгөөд авлигаас олсон орлого, хэрэгсэл гэж тодорхойлох боломжгүй байшинг хураах нь ямар ч үр дүнд хүрдэггүй байна. Үүний эсрэгээр, хохирлын хэмжээнд үндэслэсэн улсын орлого болгох шийдвэр эсвэл хөрвөх боломжтой эд хөрөнгөтэй холбоотой заалтууд байдаг улс орнуудад зорилтот этгээд гэмт хэргээс ашиг хүртэж байсан гэсэн нотлох баримттай тохиолдолд тухайн хөрөнгийг хураах хангалттай үндэслэл болдог.

Няцаах таамаглал дэвшүүлэх эсвэл нотлох баримтыг өөрчлөх тохиолдолд уг шийдвэрийн хамрах хүрээг өргөжүүлж, таамаглалын үндсэн дээр хөрөнгийг улсын орлого болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, хэрэв гэмт хэргийн мөрдөн шалгах явцад зарим буюу бүх хөрөнгийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэж таамаглаж байгаа бол тухайн хөрөнгийг урьдчилсан арга хэмжээгээр хураах боломжтой. (Харин няцаах таамаглалын талаарх дэлгэрэнгүйг 7-р бүлгийн 7.4.1-ээс үзнэ үү.)

Зорилтот этгээдийн хяналтад байгаа, эзэмшиж байгаа эсвэл бэлэглэсэн хөрөнгө

Хэдийгээр зарим улсууд өмчлөгч эсвэл эзэмшигчийг харгалзаж үзэхгүйгээр эд хөрөнгийг хураахыг зөвшөөрдөг ч бусад эрх мэдэл, ялангуяа хохирлын хэмжээнд үндэслэсэн хөрөнгийн улсын орлого болгох тогтолцоо нь тухайн этгээдийн "эзэмшсэн" хөрөнгийг хураахыг хязгаарладаг. Өмчлөлийн талаар нарийвчлан тайлбарлах нь авлига авсан албан тушаалтнууд өмч хөрөнгийг эзэмшлийг далдалсан байх магадлалтай тул хүндрэлтэй байдаг. Тухайлбал, дараах хөрөнгүүд багтдаг байна:

- Зорилтот этгээдийн гэр бүлийн гишүүн болон хамтрагчдын эзэмшиж буй хөрөнгө болон зорилтот этгээдэд ашиг өгөх үүднээс тухайн хөрөнгийг эзэмшдэг;
- Шууд бусаар зорилтот этгээдээр удирдуулдаг байгууллага болон траст компани;
- Зорилтот этгээдээс гэр бүлийн гишүүн, хамтрагч болон хамааралтай компанид өгсөн өндөр үнэ бүхий бэлэг, дурсгал

Урьдчилсан арга хэмжээний шийдвэр нь үр дүнтэй байхын тулд зорилтот этгээдийн хяналтад байгаа корпорацийн хөрөнгөд болон гуравдагч этгээдийн гарт байгаа хөрөнгийг хурааж авах нөөц бололцоотой байх нь онцгой чухал юм. Үүнтэй холбоотойгоор ихэнх улс орнууд "өмчлөх" гэсэн нэр томъёог өргөн хүрээнд тодорхойлдог бөгөөд хөрөнгийг үр дүнтэй удирдах, эзэмших эсвэл зорилтот этгээдээс бэлэглэсэн зэргийг багтаасан ойлголтыг. Ийм хуулиуд нь тухайн хүний эзэмшиж болох хэмжээнээс давсан хөрөнгийг, траст компани, корпораци эсвэл хувь хүний эзэмшиж буй хөрөнгө зоритот этгээдийн хяналтад байдаг тохиолдлуудыг багтаадаг.

Зарим улс орнууд таамаглал гэх мэт процедурын бусад хэрэгслийг ашигладаг бөгөөд өмчлөлийг нотолгоог үгүйсгэж гуравдагч этгээдэд шилжүүлэх үйл ажиллагааг багтаадаг[14]. Эдгээр арга хэмжээ нь гуравдагч этгээдэд зах зээлийн үнээс доогуур үнээр худалдсан хөрөнгийг хязгаарлах буюу хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тусалдаг бөгөөд хуурамчаар хууль ёсны гүйлгээг хийсэн тохиолдолд (тухайлбал, мэргэжлийн байгууллагын төлбөр эсвэл огт байхгүй өр төлбөр төлөх). Бусад улс орнууд зөвхөн зорилтот этгээдийн эзэмшиж буй хөрөнгийг хязгаарлахыг зөвшөөрдөг бөгөөд энэ нь "хяналтад байгаа" гэдгийг өргөн хүрээнд тодорхойлж, эзэмшил болон бусдын эзэмшиж буй хөрөнгийг зорилтот этгээд ашиг сонирхлын хүрээнд эзэмшдэг зэргийг багтаадаг.

Бэлэглэсэн хөрөнгийн хувьд зарим улс орнууд үндэслэлтэй хугацаанд, тухайлбал тав, зургаан жилийн дотор бэлэглэсэн хөрөнгийг хязгаарлах, хураахыг зөвшөөрдөг[15]. Эдгээр арга хэмжээ нь дампуурал зарлах хүртэлх хугацаанд хувь хүн, аж ахуйн нэгжийн захиран зарцуулсан хөрөнгийг нөхөн сэргээхэд ашигладаг "улсын тэтгэлгийг нэмэгдүүлэхэд гарсан зардлын татварыг нэмэгдүүлэх замаар нөхөх" арга хэмжээтэй төстэй юм.

---

[14] Колумби улсад, хэрэв гэмт этгээд хөрөнгөө гуравдагч этгээдэд шилжүүлсэн эсвэл худалдсан бол түүнийг хязгаарлаж болдог; Гуравдагч этгээд гэмт хэрэгт холбогдоогүй гэдгээ нотлох үүрэгтэй

[15] Колумб улс ямар ч үед бэлэглэсэн эд хөрөнгийг улсын орлого болгохыг зөвшөөрдөг (Хууль 793.02). Их Британид хууль тогтоомж нь хэрвээ гэмт хэрэгтэй холбоотой тохиолдолд бол зургаан жилээс их хугацаанд улсын орлого болгохыг зөвшөөрдөг.

Хамтрагч, ойр дотны хамаатан садан эсвэл компанийн нэр дээр эзэмшиж буй хөрөнгө, данстай зорилтот этгээдийг холбохдоо дансны гүйлгээний хүрээнд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай:

- Хөрөнгийн төлсөн дүн (зах зээлийн үнэ), тухайлбал, ипотекийн хариуцлагыг өмчлөх эрхийн хамт шилжүүлсэн эсэх.
- Тухайн хөрөнгийг худалдан авахад зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр
- Хөрөнгөтэй холбоотой зардал, гаралтын үр шимийг хүртэгчид
- Хөрөнгийг худалдан авах, хадгалахад тухайн хөрөнгийг эзэмшигчийн чадавх буюу нөөц
- Тухайн хөрөнгийг эзэмшиж, эзэмшиж, хянаж байгаа хүн

Эдгээр хүчин зүйлүүд нь шүүхээр тухайн хөрөнгийг дүгнэх боломжийг олгохуйц нөхцөл байдлын болон бусад нотлох баримтуудыг цуглуулахад хүргэдэг бөгөөд хэдийгээр гуравдагч этгээдийн нэр дээр эзэмшил байгаа боловч зорилтот этгээд нь эцсийн өмчлөлөөр, хяналтдаа байлгадаг тул (хууль зөвшөөрвөл) хязгаарлах, хураах арга хэмжээ авах шаардлагатай.

Хөрөнгийн хэсэгчилсэн ашиг сонирхол

Зорилтот этгээд ихэвчлэн хөрөнгө, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын хэсэгчилсэн хувь эсвэл хувийг эзэмшдэг. Үлдсэн хувийг зорилтот этгээд эцсийн өмчлөгчөөр эзэмшиж, хяналтдаа байлгадаг гэж нотлохоос бусад тохиолдолд хязгаарлах үйл ажиллагаа нь зорилтот этгээдийн хөрөнгө эзэмшиж буй хувиар хязгаарлагдаж буйг баталгаажуулах нь чухал юм (гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тухай 5-р бүлгийн 5.8-д харна уу).

5.4.2 Хөрөнгийн удирдлагын ач холбогдол

Аливаа хөрөнгөд урьдчилсан арга хэмжээ авч болох эсэхийг тодорхойлохыг зэрэгцээ хураах, хязгаарлах арга хэмжээнээс үүдэн бий болох хөрөнгийн удирдлагын шаардлагыг харгалзаж үзэх нь чухал юм (хөрөнгийн удирдлагын талаар бүлэг 6-аас харна уу). Эдгээр шаардлагад мөрдөн байцаалтын баг (хөрөнгө мөшгих үүрэгтэй мөрдөгчийг оролцуулан) болон прокурорын багийг (шийдвэр гаргах үүрэгтэй прокурорыг оролцуулан) оролцуулна.

Хязгаарлах эсвэл хураах шийдвэр гарсан тохиолдолд хөрөнгийн удирдлагыг хариуцсан газрыг тухайн үйл ажиллаганд оролцуулах талаар харгалзан үзэх шаардлагатай (хэрвээ байдаг бол). Хөрөнгө удирдах албан хаагч нь хөрөнгийг хязгаарлах эсвэл хураах эсэх, мөн уг шийдвэрт хөрөнгийн удирдлагыг хөнгөвчлөхийн тулд тусгах ёстой тодорхой эрх мэдэл, нөхцөлийн талаар үнэтэй зөвлөгөө өгөх боломжтой. Хөрөнгө удирдах газар нь үнэлшгүй ойлголтыг өгч чадна. Хөрөнгө удирдах албан хаагчийг эрт оролцуулах нь хөрөнгийн биет хяналтыг бий болгоход шаардлагатай логистикийн зохицуулалтыг авч үзэх боломжийг олгоно.

Хөрөнгө хураах, хязгаарлах арга хэмжээнд банкны данс, хувьцааны гэрчилгээ, бэлэн мөнгө болон үнэ бүхий биет бус хөрөнгө багтдаг. Иймд хөрөнгийн удирдлага шаарддаг хөрөнгийн хувьд зардал үр дүнгийн шинжилгээ хийх нь чухал байдаг. Хөрөнгийн удирдлага нь удирдаж буй хөрөнгийн үнэ цэнээс илүү үнэтэй байж болох үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, хөрөнгийг хязгаарлаж, хурааж болно гэдэг нь заавал тухайн үйл ажиллагааг хийх ёстой гэсэн үг биш юм.

Ерөнхий дүрмийн дагуу хураах гэж буй эд хөрөнгийн үнэ цэнэ тухайн хөрөнгийг хадгалах, удирдахад гарах зардалаас бага тохиолдолд хураах болон хязгаарлах шийдвэрийг гаргадгүй байна. Зарим улс орнууд үнэ цэнэ багатай хөрөнгийг хязгаарлах, хураахаас зайлсхийхийн тулд босго тогтоосон; зарим төрлийн эд хөрөнгийг (мал гэх мэт) хязгаарлах, хураахаас ч татгалзаж болно. Удирдахад хэтэрхий эрсдэлтэй эсвэл үнэтэй хөрөнгийн хувьд хадгалах газар, эскроу агент эсвэл кастодианыг томилж болдог бөгөөд зарим хөрөнгийг хураан авч, худалдахыг зөвшөөрдөг.

Уг ерөнхий дүрэмд уян хатан байдлаар ашиглаж болдоггүй. Хаясан байшинг хууль бус үйл ажиллагаанд ашиглах гэх мэт нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн хураан авах, таслан зогсоох шалтгаан байж болно. Үүний нэгэн адил, хөрөнгө үнэ цэнэтэй болон хязгаарлах шалтгаан байж болох ч үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрөх – тухайлбал, энэ нь гэр бүлийн байшин болон түүний эд хогшил эсвэд машин[16]. Эдгээртэй холбоотой тодорхой бодлого боловсруулж, салбарын мэргэжилтнүүдэд болон хөрөнгийн удирдлагад мэдэгдэх ёстой[17].

Төлөвлөлтийн үе шатанд харгалзаж үзэх ёстой зүйлүүдийн нэг бол үл хөдлөх хөрөнгийн барьцааг улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг хөрөнгийн удирдлагын үйлчилгээ шаардахгүйгээр хөрөнгийг хадлагах боломжтой эсэх. Шигтгээ 5.7 нь төлөвлөлтийн үр дүнд хөрөнгийн менежерийг томилох шаардлагагүйгээр хөрөнгө хураах шийдвэрт бага зэрэг өөрчлөлт оруулах замаар зардал, нарийн төвөгтэй байдал, захиргааны ажлыг хэмнэж, хөрөнгийн үнэ цэнийг их хэмжээгээр алдагдуулахгүйгээр ажиллаж болохыг харуулж байна.

ШИГТГЭЭ 5.7 Хийсвэр жишээ: Хөрөнгө хязгаарлах үйл ажиллагааны өмнө гаргах шийдвэрүүд

Төрийн албан хаагчийн авлигын гэмт хэргийг мөрдөн байцаах явцад тухайн албан тушаалтныг баривчлах үеэр буюу өмнөхөн нь хөрөнгө хураах үйл ажиллагаа явуулахаар тогтоогдсон. Хэрэгт холбогдсон албан тушаалтны хөрөнгийн жагсаалт, тухайн хөрөнгийг хураах болон хязгаарлах удирдлагын шийдвэр зэргийг дараах байдлаар харуулав. Үүнд:

Төрийн албан хаагч болон түүний гэр бүлийн эзэмшилд байдаг том хэмжээний байр. Тухайн үл хөдлөх хөрөнгийг хязгаарлах арга хэмжээнд багтаасан. Уг хязгаарлах шийдвэр нь ирээдүйн худалдан авагч эсвэл баталгаатай

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[16] Жишээлбэл, 5-р бүлгийн 5.6-д зардлын төлбөрийг хязгаарлах шийдвэрийн гадуур заалтуудыг харгалзан үзнэ үү; 6-р бүлгийн 6.5.3-т хөрөнгийн удирлагад ихээхэн бэрхшээл учруулж болзошгүй моторт тээврийн хэрэгсэл, завь, онгоцны тухай.

[17] АНУ-д засгийн газар хаягдсан хөрөнгө эсвэл хөрөнгийн үнэ цэнэ нь буурч байгааг нотлоогүй бол улсын орлого болгох үйл ажиллагааны явцад үл хөдлөх хөрөнгө хураахыг хориглодог. Гэсэн хэдий ч прокурорууд хүлээгдэж буй үйл ажиллагааны талаар мэдэгдэх хүрээнд улсын газрын бүртгэлд lis pendens (барицаа) байрлуулна. Хөрөнгө хадгалах эрх нь ирээдүйн худалдан авагчдыг үнэ цэнийн хувьд шударгаар худалдан авалт хийхээс сэргийлдэг. Швейцарь улсад хурдан элэгдэлд орох эсвэл үнэтэй засвар үйлчилгээ шаарддаг эд хөрөнгө болон хөрөнгийн бирж эсвэл зах зээлийн үнэ бүхий үнэт цаас болон бусад хөрөнгийг SR 281.1 Холбооны Өрийн хэрэгжилт ба дампуурлын тухай хуулийн (Federal Act on Debt Enforcement and Bankruptcy) дагуу нэн даруй зарж болно (1889 оны 4-р сарын 11 [Швейцарь]). Гэмт хэргээс олсон орлогыг хураана (Эрүүгийн хуулийн 312.0, 2007 оны 10-р сарын 5, 266-р зүйлийн 5 [Швейцарь]).

зээлдүүлэгч нарт анхааруулах зорилгоор тэмдэглэл хийсэн болно. Хөрөнгийн удирдах ажилтан томилогдоогүй. Эд хөрөнгөө хэвээр хадгалах, зохих төлбөр, татвар, байрны зээлийн төлбөрийг төлсөн тохиолдолд (шийдвэрт дурдсанчлан) тухайн албан тушаалтан болон түүний гэр бүлийнхэнд гэртээ үлдэхийг зөвшөөрсөн.

Далайн эргийн дагуу байрлах хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (зуучлагчаар дамжуулж түрээслэгдсэн). Хэдийгээр уг байшинг анхнаасаа удирдах шаардлагатай хөрөнгө гэж үзэж байсан ч үл хөдлөх хөрөнгийн зуучлагч эд хөрөнгө болон түүнээс олсон ашгийг удирдаж байсныг мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн. Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаас хуримтлагдсан түрээсийн төлбөрийг хязгаарлагдсан банкны дансанд төлөхийг шаардсан зохих шийдвэрийн дагуу хөрөнгө удирдах ажилтангүйгээр уг хөрөнгийг хязгаарлах шийдвэр гарсан. Тухайн шийдвэрээр үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид тухайн байшингийн зардал болон түрээс төлөхийг зөвшөөрсөн. Шийдвэрийн хүчин төгөлдөртэй байдлыг гарчигт тэмдэглэв.

Тухайн төрийн албан хаагчийн эзэмшдэг компаниийн үйл ажиллагаа явуулдаг хуванцар эдлэлийн жижиг үйлдвэр (тухайн албан тушаалтны эзэмшилд байдаг аж үйлдвэрийн нэгж). Тус үйлдвэр нь үнэ цэнэ багатай гэж тогтоогдсон: дансны үлдэгдэл бага байсан бөгөөд мөрдөгчид үүнийг зүгээр л авлигаас олсон орлогоо угаах хэрэгсэл болгон ашигласан гэж сэжиглэж байсан. Үүний үр дүнд уг бизнест хязгаарлах арга хэмжээ аваагүй бөгөөд өөрт нь үлдээсэн байна. Түүнийг баривчлагдсанаас хойш зургаан сарын дотор хуванцар эдлэлийн үйлдвэрийн бизнес уналтад орсон.

Аж үйлдвэрийн нэгж. Тус нэгжийн цорын ганц "түрээслэгч" нь тухайн албан тушаалтанд түрээсээ төлөөгүй үйлдвэр болох нь тогтоогдсон. Гарчигт дурдсанчилан уг хөрөнгө хязгаарлах шийдвэрт багтсан. Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, зохих төлбөр, татварыг төлж байгаа нөхцөлд тус үйлдвэр түрээсийн төлбөргүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой гэдгийг тогтоосон. Хуванцар эдлэлийн үйлдвэрийн бизнес уналтанд орсоны дараа энэ үл хөдлөх хөрөнгийг удирдах хөрөнгийн менежерийг томилохоор хязгаарлалтын шийдвэрийг шинэчилсэн. Сүүлд нь үл хөдлөх хөрөнгө түрээслүүлэхээр тохиролцож, түрээсийн төлбөрөөс газар, барилга байгууламжийн төлбөрийг төлж, ашгаа хөрөнгө оруулалт хийсэн.

Хувийн банкны данс, хувьцааны багц. Тухайн албан тушаалтны бүх банкны дансыг хязгаарласан боловч цалин хүлээж авдаг бага дүнтэй дансыг (албан тушаалтан өөрийнхөө болон гэр бүлийнхээ амьжиргааны зардлыг төлөхөд ашигладаг) хязгаарлах арга хэмжээнээс гадуур үлдээсэн. Хувьцааны багц нь том биш, "цэнхэр чип"-тэй компаниудад тогтвортой үнэлгээтэй байсан учраас анхнаасаа хөрөнгийн менежер томилогдоогүй. Аж үйлдвэрийн нэгжийг удирдахаар хөрөнгийн менежер томилогдсоны дараа хувьцааны багцыг мөн түүний мэдэлд оруулсан.

Өндөр үнэтэй гурван машин. Тээврийн хэрэгслийн удирдлагын журам, тоног төхөөрөмж нь өндөр үнэ цэнэтэй автомашиныг зохих ёсоор арчлах боломжийг олгодог хууль сахиулах байгууллагуудад (хууль тогтоомжийн дагуу) авто машинуудыг хязгаарлах арга хэмжээнд оруулсан.

5.4.3 Хэсэгчилсэн хяналт буюу хязгаарлагдмал хязгаарлах үйл ажиллагаа

Зарим хөрөнгийг хянах түвшин өөр байж болох тул тухайн хөрөнгийг улсын орлого болгох зорилгоор хадгалахад шаардагдах хяналтын түвшинг урьдчилан анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал, хэрэв зорилтот этгээд газар болон тухайн газар дээр үйл ажиллагаа явуулдаг бизнесийг хоёуланг нь эзэмшдэг бол газар, бизнес явуулж буй байр эсвэл бизнесийг аль алиныг нь хязгаарлах боломжтой. Иймэрхүү шийдвэр нь тодорхой хүчин зүйлүүдийг харгалзаж үзэхийг шаарддаг. Хэдийгээр хөрөнгийн менежер томилохгүйгээр газрыг хязгаарлаж болох ч барилга байгууламж, бизнесийг хэвээр авч үлдэх нь өндөр өртөгтэй байх магадлалтай бөгөөд менежментийг шаарддаг.

Бизнесүүд менежментийн мэргэжлийн чадварыг шаарддаг бөгөөд ялангуяа маркетинг, борлуулалт, харилцагчийн үйлчилгээ, ложистик ба ханган нийлүүлэлт, хөрөнгийн менежмент, хүний нөөцийн менежмент зэргийг хамардаг. Эдгээрийн аль нэг нь алдагдвал ашигтай бизнесийг ашиггүй үйл ажиллагаа руу чиглүүлдэг. Гэсэн хэдий ч барилга байгууламж, бизнесээс олсон ашгийг хязгаарлах шийдвэрт тусгаагүй бол улсын орлого болгох боломжгүй. Хүснэгт 5.1-д хэсэгчилсэн хяналт хязгаарлагдмал буюу хязгаарлах үйл ажиллагааны хувилбаруудын зарим давуу болон сул талуудыг харуулсан болно.

5.4.4 Биечлэн хураах/эзэмших үйл ажиллагааны бэлтгэл ажил

Ихэнхдээ эд хөрөнгийг хадгалах цорын ганц бодит арга бол тэдгээрийг биечлэн эзэмших явдал юм. Хөрөнгийн менежер биечлэн эзэмшихээс өмнө тухайн хөрөнгийг аюулгүйгээр хураах, аюулгүй хадгалах байгууламж, хадгалах байгууламж руу аюулгүй шилжүүлэх зохицуулалтуудыг хийх ёстой. Зарим тохиолдолд хадгалах үйл ажиллагааг харьцангуй амарханаар зохицуулалт хийж болдог; тухайлбал, үнэт эдлэл эсвэл гулдмайг банкны сейфэнд найдвартай хадгалах боломжтой. Үнэ цэнэтэй урлагийн бүтээл, моторт тээврийн хэрэгсэл, дарвуулт онгоц зэрэг бусад төрлийн эд хөрөнгө нь тусгай зориулалтын хадгалах байгууламж шаарддаг бөгөөд хадгалах нөхцөлийн бүрдүүлэхэд цаг хугацаа, их хэмжээний зардал шаардагдана. Бельги зэрэг зарим улс оронд хураагдсан боловч худалдах шийдвэр нь хүлээгдэж буй виртуал валютуудыг гадны хувийн компани ашиглан хадгалдаг байна.

Хүснэгт 5.1 Хөрөнгийн хэсэгчилсэн хяналт буюу хязгаарлагдмал түвшинд хязгаарлах үйл ажиллагааны ач холбогдол. Тухайлбал, Зочид буудал

Хувилбар	Давуу тал	Сул тал
1. Зөвхөн газрыг хязгаарлах (зочид буудлын менежмент болон барилгыг зорилтот этгээдэд болох холбогдолтой зардлыг төлөх хүнд хэвээр үлдээх)	Уг хувилбар нь хөрөнгийн менежерийг томилох шаардлагагүй байж магадгүй, учир нь зорилтот этгээд бизнесийн үйл ажиллагаанаас гарах зардал, татварыг хариуцах болно.	Газар болон бизнесээс олсон ашгийг улсын орлого болгох үйл ажиллагааг явуулахгүй байх. Хэрэв бизнесийг мөнгө угаахад ашиглаж байгаа бол энэ хувилбар нь гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжийг олгоно. Ийм тохиолдолд 3-р хувилбарыг авч үзэх нь зүйтэй.

2. Газар болон барилгыг хязгаарлах (зочид буудлын бизнест газрыг түрээслэх)	Улсын орлого болгох үйл ажиллагаа амжилтгүй болбол эрх бүхий байгууллагын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хохирлыг хариуцах эрсдэл бага байна.	Хөрөнгийн менежерийг томилох шаардлагатай хэвээр байж магадгүй. Бизнесээс олсон ашгийг улсын орлого болгох үйл ажиллагааг явуулахгүй байх.
3. Бүх хөрөнгийг хязгаарлах (газар, барилга болон зочид буудлын бизнесийн хамруулаад)	Газраас олсон ашгийг түрээсийн хэлбэрээр улсын орлого болгох Менежментийн үүрэг нь газар болон барилга байгууламжаар хязгаарлагддаг тул хүндрэлтэй байх нь бага.	Энэхүү томоохон хөндлөнгийн оролцоо нь бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавих, бизнесийн ашгийг зохих ёсоор хязгаарлахын тулд шинжээч менежерүүдийн оролцоо шаарддаг. Улсын орлого болгох үйл ажиллагаа амжилтгүй болбол Улсын орлого болгох үйл ажиллагаа амжилтгүй болбол эрх бүхий байгууллагын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хохирлыг хариуцаж болно.

Тэмдэглэл: "Хөрөнгө" гэдэгт сэжигтний эзэмшил газар дээрх зочид буудалтай холбоотой бизнесийг хамааруулж байна.

Хөрөнгийг хэрхэн хураах талаар хөрөнгийн менежер (эсвэл хөрөнгийн удирдлагын эрх бүхий байгууллага) тухайн эрүүгийн хэргийг шалгаж буй салбарын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах ёстой. Эд хөрөнгийг хураах байранд нэгжлэх хийх зөршөөрөл олгогдсон тохиолдолд, хураах үйл ажиллагааг нэгжлэг хийх явцад гүйцэтгэх нь хамгийн тохиромжтой. Албан хаагчид нэгжлэг хийх байрыг хамгаалалтанд авч, нотлох баримт хайх урьдчилсан нэгжлэгээ хийсний дараагаар хөрөнгийн менежер хураах зөвшөөрөлтэй эд хөрөнгө байгаа эсэхийг хялбархан шалгаж болно[18]. Хөрөнгө хураах шийдвэрийг гаргах хүсэлт гаргасан этгээд хөрөнгийн менежерт шийдвэр гаргасан газарт нэвтрэх зөвшөөрлийг тусгаагүй тохиолдолд хууль сахиулах байгууллагад олгосон эрх мэдлийн хүрээнд хамрагдахгүй байж болзошгүй.

Хөрөнгийг эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагаанаас хамааралгүйгээр хураах шаардлагатай үед (жишээ нь, NCB-ны улсын орлого болгох ажиллагааны явцад хөрөнгө хураах шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд) тодорхой хөрөнгийг хөрөнгийн менежер эзэмшихийн тулд үйл ажиллагаа явуулж буй байранд нэвтрэх зөвшөөрөл авах шаардлагатай байж болно. Хөрөнгийн менежерүүд аюулгүй байдлын асуудлаар хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах ёстой бөгөөд хууль сахиулах байгууллагын ажилтнууд тухайн чиглэлд төлөөлөгчөөр хангах ёстой.

[18] Зарим тохиолдолд салбарын мэргэжилтнүүд салбарын мэргэжилтнүүд хөрөнгийг улсын орлого болгох тухай хууль эрх зүйн зохицуулалтаар хязгаарлах шийдвэрт орсон хөрөнгө эсвэл гэмт хэргээс олсон орлого, хэрэгсэл гэж үзэж байгаа хөрөнгийг битүүмжлэх эрхийг олгодог.

5.5 Урьдчилсан арга хэмжээг авах цаг хугацаа

Урьдчилсан арга хэмжээг зөв цагт хийх нь хөрөнгийг улсын орлого болгох ажиллагааны хамгийн хүнд хэсгүүдийн нэг юм[19]. Хэрэв тухайн арга хэмжээг эрт авсан тохиолдолд зорилтот этгээд мэдээлэл авч, үйл ажиллагаагаа зогсоох боломжтой (нотлох баримт цуглуулах, бусад бүртгэл, зорилтот этгээд, типологийг тодорхойлоход хүндрэл учруулдаг). Гэсэн хэдий ч, хэрэв зорилтот этгээд мөрдөн байцаалтын талаар мэдсэний дараа арга хэмжээ авах юм бол хөрөнгийг тараах эсвэл нуух магадлалтай (Шигтгээ 5.8-д хөрөнгийг нэн даруй царцаасан жишээг харуулав). Урьдчилсан арга хэмжээ нь гадаад улсыг хамарсан тохиолдолд албан бус болон албан ёсны хамтын ажиллагааны харилцан үйлчлэл чухал ач холбогдолтой.

Үүний үр дүнд гэмт хэргийг шалгаж буй салбарын мэргэжилтнүүд хөрөнгө буцаахаар ажиллаж буй салбарын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах ёстой. Тэд зорилтот этгээд мөрдөн хийж буй талаар мэдэх эрсдлийг харгалзаж байх ёстой бөгөөд шаардлагатай үед урьдчисан арга хэмжээг авахын тулд хангалттай хурдтай байх ёстой. Дараах үе шатуудын аль нэгэнд зорилтот этгээд мөрдлөг хийж буй талаар мэдэх боломжтой:

ШИГТГЭЭ 5.8 Перу: Владимиро Монтесиносын Швейцарь дахь хөрөнгийг царцаах про-актив ажиллагаа

Перугийн ерөнхийлөгчийн зөвлөх асан, Тагнуулын газрын дарга Владимиро Монтесиносын (цаашид 1-р бүлгийн 1.3-р хэсэгт авч үзнэ) Швейцарийн дансанд байсан хөрөнгийг буцаан олгох арга хэмжээ нь Швейцарийн мөнгө угаах гэмт хэргийн хууль эрх зүйн зохицуулалтын ачаар боломжтой болсон. Швейцарь улсын Мөнгө угаах тухай хуулийн дагуу Мөнгө угаахтай тэмцэх албанд мэдээлэх үүргээ банкууд биелүүлж, Монтесинос болон Перугийн генерал асан Николас де Бари Хермоза Риос нарын хөрөнгийн талаарх мэдээллийг дамжуулсан[a]. Тухайн хөрөнгөд хориг тавьж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. Үүний дараа Перугийн шүүх эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэж, Швейцарь улсад хууль зүйн туслалцаа авах хүсэлтээ илгээсэн байна.

Швейцарийн эрх бүхий байгууллагуудын идэвхтэй хариу арга хэмжээний ачаар Монтесинос болон Хермозагийн Швейцарийн дансанд байршуулсан хууль бус хөрөнгийг цаг алдалгүй царцаасан байна.

а. Швейцарийн Холбооны Зөвлөл. "Монтесиносын хэрэг: Швейцарь Перу руу 77 сая ам.доллар шилжүүлэв." Хэвлэлийн мэдээ, 2002 оны 8 дугаар сарын 20-ны өдөр. https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-23237.html.

- Мөрдөн байцаалтын явцад орон сууц эсвэл бизнест нэгжлэг хийх, гэрчээр ярилцлага авах, баримт сэлт гаргуулах тогтоол, эрх зүйн харилцан туслалцаа авахаар хүсэлт гаргах зэрэг мөрдлөгийн тодорхой арга техникийг ашиглах үед - эдгээр техникийг ашиглахаас өмнө (эсвэл нэгэн зэрэг) хөрөнгийг баталгаажуулах нь чухал юм

[19] Тунисын ерөнхийлөгч асан Зин эль Абидин Бен Алигийн эзэмшиж байсан Швейцарийн банкны дансыг түүнийг албан тушаалаасаа бууснаас хойш ердөө тав хоногийн дараа, Египетийн ерөнхийлөгч асан Хосни Мубаракийг түлхэн унагаснаас хойш ердөө хагас цагийн дараа дансыг царцаасан байна (FDFA 2016, 22), https:/ /www.eda.admin.ch/dam/eda/en/documents/aus senpolitik/voelkerrecht/edas-broschuere-no-dirty-money_EN.p

- Зорилтот этгээд эрүүгийн гэмт хэрэгт буруутгагдаж байгаа үед
- Хөрөнгө улсын орлого болгох өргөдөл гаргах үед

Буруу цаг хугацааг сонгох нь хөрөнгө болон нэмэлт нотлох баримтыг алдахад хүргэдэг. Салбарын мэргэжилтнүүд мөрдөн байцаалтын эхэн үед, зорилтот этгээдийн эсрэг ямар нэгэн илэрхий арга хэмжээ авахаас өмнө зөвлөлдөх шаардлагатай. Гэмт хэргийн мөрдөн байцаалтын зорилгод хүрэхийн тулд зорилтот этгээдийн хөрөнгийг оновчтой цагт нь хязгаарлах буюу хураан авах боломжийг олгох стратеги боловсруулах ёстой.

Зорилтот этгээдэд авах арга хэмжээг тогтоосны дараа л тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг улс орнуудад урьдчилсан арга хэмжээ үр дүн багатай байдаг. Ихэнх мөрдөн байцаалтын ажиллагаа, ул мөр тогтоох ажиллагаа жил биш юм аа гэхэд хэдэн сар шаардагдах бөгөөд ингэснээр зорилтот этгээд хөрөнгөө нуун дарагдуулах, тараах эсвэл тухайн улс орноос зугтах боломжийг нэмэгдүүлдэг. Зарим улс оронд гэмт хэргийн мөрдөн байцаалтын явцад ямар ч үед урьдчилсан арга хэмжээ авахыг зөвшөөрч тухайн асуудлыг шийдвэрлэсэн нь гайхалтай. Мөн NCB-ны эд хөрөнгийг хураах тухай хууль нь эд хөрөнгийг илүү эрт хязгаарлах, хураах боломжийг олгодог, учир нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс шалтгаалахгүй.

Товчхондоо, салбарын мэргэжилтнүүд сонгосон механизм нь тухайн хөрөнгийг эзэмшиж буй улс орны нутаг дэвсгэрт байгаа арга хэмжээнээс шалтгаална. Энэ нь ихэвчлэн хүсэлт гаргасан болон хүсэлт гаргаж буй улс орны хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл солилцохын тулд холбогдох албан бус сувгуудыг ашигласны үр дүн юм.

5.6 Зардлыг төлүүлэхтэй холбоотойгоор гаргасан хөрөнгө хязгаарлах шийдвэрт хамааралгүй асуудлууд

Зарим улс оронд тодорхой ангиллын зардлыг, тухайлбал зорилтот этгээд болон түүнээс хамааралтай байдаг хүмүүсийн амьжиргааны зардал, хөрөнгийг улсын орлого болгох ажиллагаа ба холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн зардал, мөн тухайн этгээдийн бодит өр болон бизнесийн зардлуудыг хязгаарлах шийдвэрээс гадуур байхыг зөвшөөрдөг байна.

Эдгээр шийдвэрт үл хамаарах хэсгүүд нь маргаантай байдаг (Greenberg et al. 2009, 74). Хязгаарлах шийдвэрт гадуур үйлчлэх зүйлүүдийн талаар хүсэлт гаргах нь тухайн шийдвэрийн үнэ цэнийг бүхэлд нь алдах боломжтой. Нэг талаас хөрөнгө нь хязагаарлах шийдвэрт орсон хүмүүс тухайн арга хэмжээнээс гаргах гэж бус, харин уг шийдвэрт орсон хөрөнгөө улсын орлого болгохоос сэргийлэн ашиглахыг оролдох сэдэлтэй байдаг. Нөгөөтэйгүүр хэргийн үйл явцын болон эрхийн хүрээнд хуулийн зөвлөгөө авах эрхийн талаар харгалзаж үзэх ёстой[20].

Хязгаарлагдсан шийдвэрт багтсан хөрөнгийг бууруулахыг зөвшөөрдөг улс орнуудад салбарын мэргэжилтнүүд зардлаа төлөх ёстой бусад хязгаарлагдсан хөрөнгө байгаа эсэхийг нягтлах шаардлагатай[21]. Мөрдөн байцаалтын арга техникийг (баримт сэлт

[20] Ийм хязгаарлах шийдвэрт үл хамаарах хэсгүүдийг зөвшөөрдөггүй улс орнууд ихэвчлэн хууль зүйн туслалцааны системд тулгуурладаг эсвэл зарга мэдүүлэх кураторыг томилдог.

[21] Зарим улсад хөрөнгө хязгаарлах шийдвэр авах талаар хүсэлт гаргагч (зорилтот этгээд) зардал төлөх шаардлагатай бохир хөрөнгөгүй гэдгээ тангараг өргөх замаар шүүхэд мэдүүлэх үүрэгтэй.

гаргуулах тогтоол болон мэдээллийг ил болгох шийдвэр) ашиглан салбарын мэргэжилтнүүд тухайн нутаг дэвсгэрт эсвэл нутаг дэвсгэрээс гадна хязгаарлах арга хэмжээнд ороогүй үл хөдлөх хөрөнгийн нотлох баримтыг олж, дараа нь энэ мэдээллийг ашиглан хязгаарлагдаагүй бусад эд хөрөнгө байгаа тул тухайн шийдвэрийн үл хамаарах зүйлд багтах ёсгүй талаар шүүхээр маргах боломжтой. Үүнтэй холбогдуулан мэдүүлэг гаргагчийн итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлж, тангараг өргөсөн мэдүүлэгт эсвэл шалгалтын үеэр худал хуурмаг, зөрчил илэрсэн тохиолдолд прокурорт ашигтай байдаг. (Эдгээр тодруулга өгөх нэмэлт шийдвэрийн талаар 5.7 хэсгээс харна уу.)

Хязгаарлагдаагүй хөрөнгө байхгүй болох нь тогтоогдсон тохиолдолд өргөдөл гаргагч нь тухайн зардлын тооцоог шүүхэд гаргаж өгөх ёстой. Зарим улс орнууд хуульчдаас авах хураамжийн дээд хэмжээг хуулиар тогтоосон байдаг бөгөөд энэ нь ихэвчлэн хууль зүйн туслалцааны төлбөртэй дүйцэхүйц хэмжээтэй байдаг[22].

5.7 Нэмэлт шийдвэрүүд

Тодруулга өгөх нэмэлт шийдвэр нь хөрөнгө хязгаарлах, хураах тухай шийдвэрүүдийн нэмэлт шийдвэр юм. Энэ нь хөрөнгө хязгаарлах, хураах шийдвэрийн үр нөлөөг нэмэгдүүлдэг, тухайлбал,

- Зорилтот этгээд эсвэл түүнтэй холбоотой хүмүүсээс зорилтот этгээдийн эзэмшиж буй өмчийн шинж чанар, байршлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг шаардах;
- Хязгаарлагдмал буюу хураагдсан эд хөрөнгийг хөрөнгийн менежерийн хяналтад байлгах (6-р бүлгийг үзнэ үү);
- Шүүх болон бусад эрх бүхий байгууллагын албан тушаалтны өмнө эд хөрөнгийн талаар тангараг өргүүлэн шалгуулахыг шаардах; эсвэл
- Зорилтот этгээдийн хөрөнгөтэй холбоотой баримт бичгийг бүрдүүлэхийг гуравдагч этгээдээс шаардах.

Мэдээллийг задруулах, шалгах эрх мэдэл нь ээдрээтэй хөрөнгийн сан байгаа эсэхийг шалгах, хязгаарласан сангаас зардлыг санхүүжүүлэх хүсэлтийг хамгаалахад хэрэгтэй нотлох баримтыг олж авах үр дүнтэй арга байж болно. Прокурорууд эд хөрөнгийн талаарх бүх мэдээлэлтэй болон шалгуулж буй этгээдээс өгсөн нотлох баримттай танилцаагүй, эсэргүүцэх чадваргүй байгаа тохиолдолд шалгалт хийх ёсгүй. Тухайлбал, санхүүгийн байгууллагын мэдээлэл нь зорилтот этгээд эзэмшиж буй хөрөнгийнхөө талаар үнэн зөв мэдээллээр хангахгүй, мэдээлэх үүргээ дагаж мөрдөхгүй байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгэж, шийтгэл ноогдуулах боломжтой юм.

Зорилтот этгээдийн эрхийн хүрээнд өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс хамгаалахын тулд тодруулга өгөх нэмэлт шийдвэрийн дагуу олж авсан нотлох баримтыг

[22] Канад улсын Онтарио мужид хууль тогтоомж нь нэхэмжлэгчийг NCB-ны хөрөнгийг улсын орлого болгосон хэргүүдтэй холбоотой хууль зүйн үндэслэлтэй зардлаас чөлөөлөхөөр шүүхэд хандахыг зөвшөөрдөг. Тухайн төлбөр нь Иргэний эрх зүйн зохицуулалтын тухай хуульд заасан хязгаарлалттай байдаг (S.O. 2001, c. 28 [Can.]). Хуулийн зардлын хамгийн дээд хэмжээг нийт хөрөнгийн хувиар тооцдог бөгөөд хуулийн зардлын тарифт хязгаарлалт тавьдаг.

холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж болно[23]. Тухайн хэргийг шалгаж буй этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны боломжит зорилтуудыг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн нотлох баримтыг олж авах аргуудыг мэдэж байх ёстой. Энэ хүрээнд прокурортой зөвлөлдөх шаардлагатай байдаг.

5.8 Гуравдагч талын ашиг сонирхол

Хөрөнгө хязгаарлах, хураах арга хэмжээг авах тохиолдолд гуравдагч талын шаардлага зайлшгүй гарах болно. Зорилтот этгээд нь ихэнхдээ хөрөнгийг эзэмшлийг тогтооход төвөгтэй байдлаар эзэмшдэг бөгөөд бизнесийн түншүүд, хөрөнгө оруулагчид гэх мэт хууль ёсны ашиг сонирхол бүхий гуравдагч этгээдийн оролцоотой байх нь олонтаа. Гуравдагч тал нь тухайн хөрөнгийг хууль бусаар ашиглагдаж байгааг мэдээгүйгээр гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгслийн хувьд ашиг сонирхол, өмчлөх эрхтэй байж болно. Зарим тохиолдолд гуравдагч талын ашиг сонирхлын хувьд хууль ёсны эсэх дээр асуудал үүсэж болно. Тухайлбал, гуравдагч тал нь цаасан дээр зорилтот этгээдийн хянадаг гэх хөрөнгийг эзэмшиж болно, эсвэл гуравдагч этгээд нь жинхэнэ худалдан авагч биш байж болно.

Гуравдагч тал зорилтот этгээдтэй хамт бизнес эсвэл компанид хувь эзэмшдэг бол, салбарын мэргэжилтнүүд тухайн хувь эзэмшил нь жинхэнэ бөгөөд зорилтот этгээд эцсийн өмчлөгч нь биш болон түүний хяналтанд байдаггүйг баталгаажуулах шаардлагатай байдаг. Хэрэв зорилтот этгээдийн оролцоо байхгүй тохиолдолд гуравдагч талын эрх ашгийг хязгаарлахгүй, хураахгүй байхаар шийдвэрийг боловсруулах нь чухал. Ийм тохиолдолд, хөрөнгө хязгаарлах шийдвэр нь шүүхэд тайлагнах хатуу шаардлага, үл хөдлөх хөрөнгийн менежерийн хяналтын дагуу бизнесийн хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг шаардаж болдог бөгөөд тухайн бизнест оролцож, ашиг тусыг нь хүртэх боломжийг олгодог байна. Зорилтот этгээдэд ирэх аливаа ашиг гурван талын гэрээгээр зохицуулагдаж, мөн тухайн зорилтот этгээдийг бизнес эрхэлж, оролцохоос сэргийлнэ.

Зорилтот этгээд болон хууль бус үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцоогүй хууль ёсны хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн гэм зэмгүй гуравдагч этгээдийн хооронд дундын өмч байгаа тохиолдолд хязгаарлах шийдвэрийг бүх эд хөрөнгөд авах нь тохиромжгүй байж болно. Үүний оронд зорилтот этгээдийн тодорхой хөрөнгийг хязгаарлахад хангалттай байж болох юм. Практикт ийм шийдвэр нь гуравдагч этгээд өөрийн ашиг сонирхлын төлөө бие даан ажиллахад хэцүү байх тул бүх өмчид хориг тавьдаг. Харин шийдвэрийг хэсэгчилсэн байдлаар гаргаснаар гуравдагч этгээдэд түүний ашиг сонирхлыг хураах зорилгогүй гэдгийг ойлгуулж, шаардлагагүй маргаан үүсгэхээс зайлхийх боломжтой.

Улсын орлого болох шийдвэрт орсон эд хөрөнгө нь тухайн хөрөнгийг хууль бусаар ашиглахад ямар ч оролцоогүй, эсхүл энэ талаар огт мэдээгүй (жишээлбэл, зээл олгосон банк) барьцаа болон бусад үнэт цаас эзэмшиж буй хувь хүн, аж ахуйн нэгж дарамтад ордог. Зээлдүүлэгч нь хууль бус үйл ажиллагаанд оролцоогүй гэдгийг тогтоосон тохиолдолд зарим улс орнууд ийм зээлдүүлэгчийг гэм буруугүй өмчлөгч гэж хүлээн зөвшөөрөх үйл явцыг оновчтой болгосон. Зарим улс орнууд хөрөнгө

[23] Эдгээр хамгаалалтын арга хэмжээг ихэвчлэн хууль тогтоомжид тусгасан эсвэл үндсэн хуулиар заасан байдаг. Зарим улс оронд прокуророос олж авсан нотлох баримтыг холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглахгүй гэсэн амлалт өгөхийг шаарддаг.

хадгалах эрхтэй этгээд нь бусад талуудын ашиг сонирхлын нэгэн адил улсын орлого болгох ажиллагаанд цаг тухайд нь нэхэмжлэл гаргах шаардлагатай, хэрэв ийм нэхэмжлэл гаргаагүй бол эд хөрөнгийг улсын орлого болгох журмаар хадгалах эрхийг хүчингүй болгоно. Улсын орлого болгох ажиллагаа дуусаж, эд хөрөнгийг хурааж, худалдсан тохиолдолд олсон орлогоос нь жинхэнэ зээлдүүлэгчид төлдөг.

Салбарын мэргэжилтнүүд аливаа тохиолдолд гуравдагч этгээдийн мэдүүлэгт нээлттэй байх ёстой бөгөөд хэрэв зөвшөөрөгдсөн бол хязгаарлах арга хэмжээг өөрчлөх, хууль ёсны дагуу эзэмшиж буй хөрөнгө, хэрэгслийг буцаан олгох ёстой[24]. Гэсэн хэдий ч хангалттай, баталгаатай тайлбар өгөх боломжгүй, эсхүл эд хөрөнгийг хураах олон нийтийн ашиг сонирхол байгаа бол (жишээлбэл, хар тамхины наймааны үйл ажиллагаа явуулсан байшин), гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах, тухайн хөрөнгийг хязгаарлах болон улсын орлого болгох арга хэмжээнээс хасах тухай хууль тогтоомжид заасан шалгуурын дагуу гуравдагч этгээдийн нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд үлдээх нь зүйтэй. (Улсын орлого болгох үе шатанд гуравдагч талын ашиг сонирхлын талаарх дэлгэрэнгүйг 7-р бүлгийн 7.5-аас харна уу.)[25]

Корпорацийн эзэмшилд байгаа хөрөнгө нь төлбөрийн чадваргүй байдалд орсон тохиолдолд салбарын мэргэжилтнүүд гуравдагч этгээдийн нэхэмжлэл болон хөрөнгө буцаах үйл ажиллагааны талаар гуравдагч этгээдэд мэдэгдэхэд шаардагдах хууль эрх зүйн алхмуудыг анхаарч үзэх хэрэгтэй. (Мөн төлбөрийн чадваргүй байдал болон зээлдүүлэгчийн эрхийн тухай 10-р бүлгийн 10.5-ыг харна уу.)

5.9 Урьдчилсан арга хэмжээний бусад хувилбарууд

Хэдийгээр урьдчилсан арга хэмжээ нь хөрөнгө хамгаалахад тохиромжтой механизм боловч холбогдох шийдвэр гаргахад зарим тохиолдолд хангалттай нотлох баримт болдоггүй байна. Ийм тохиолдолд салбарын мэргэжилтнүүд ижил үр дүнд хүрэх алтернатив хувилбарыг авч үзэх хэрэгтэй.

Олон улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалт нь - тухайлбал сэжигтэй үйл ажиллагаа болон гүйлгээний талаар мэдээлэх шаардлагууд нь хөрөнгө хамгаалах алтернатив хэрэгсэл болж өгдөг. СТА нь санхүүгийн байгууллагаас сэжигтэй гүйлгээний тайлан эсвэл сэжигтэй үйл ажиллагааны тайлан үндэслэн тухайн гүйлгээг хязгаарлах эсвэл гаргахаас татгалзах захиргааны эрх мэдэлтэй байж болно. Ерөнхийдөө СТА-ны энэхүү эрх мэдэл нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал бөгөөд мөнгө угаасан сэжигтэй байдлын ноцтой байдлыг шалгахад ашиглах ёстой.

Мөнгө угаах гэмт хэрэгт ороцолдохгүйн тулд санхүүгийн байгууллагууд бие даан дансаа хязгаарлах шийдвэр гаргаж болно. Үүний үр дүнд салбарын мэргэжилтнүүд авлига авсан албан тушаалтныг яллагдагчаар татсан эсвэл сэжигтэй үйл ажиллагаа явуулсан гэж санхүүгийн байгууллагад мэдэгдсэн тохиолдолд банк сэжигтэй

[24] Салбарын мэргэжилтнүүд хөрөнгө буцаахдаа гуравдагч этгээдээс хөрөнгө буцаах баримт бичгийг гүйцэтгүүлж, хязгаарлах буюу хураах үйл ажиллагаанд оролцсон төрийн албан тушаалтнууд болон тэдгээрийн гүйцэтгэх ажилтнуудын эсрэг цаашид нэхэмжлэл гаргахаас татгалзаж, асуудалгүй байлгах ёстой.

[25] Улс орны хууль тогтоомж болон хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан эд хөрөнгө хураах шийдвэр амжилтгүй болж, хохирол учирсан нь тогтоогдвол (хөрөнгийн үнэ эсвэл орлого) төрөөс хохирлыг барагдуулах эрсдэлтэй) болон үл хөдлөх хөрөнгийн менежер нь гуравдагч этгээдэд хөрөнгийг буцаан олгосон байх ёстой.

гүйлгээний тайлан эсвэл сэжигтэй үйл ажиллагааны тайлан гаргах хангалттай үндэслэлтэй болж, СТА тухайн хөрөнгийг хамгаалах хүрээнд дээрх хоёр алтернатив хувилбараас аль нэгийг нь хэрэгжүүлэхийг шаарддаг. Салбарын мэргэжилтнүүд тухайн хувилбарыг ашиглахдаа хууль эрх зүйн журмыг зөрчихгүй байх ёстой.

Бусад боломжууд нь эрх бүхий байгууллагууд "Mareva by Letter" (цаашид 10-р бүлгийн 10.3.2-т тайлбарласан) дансанд байгаа мөнгөний гарал үүсэл нь гэмт хэргийн шинжтэй холбоотой болохыг банкинд бичгээр сануулсан үед тухайн хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд банкны харилцагчийг таньж мэдэх ажиллагаа, мэдээлэх үүрэг болон холбогдох хариуцлагыг талаар яригдаж болно. Эцэст нь салбарын мэргэжилтнүүд заримдаа шүүхээс зөвшөөрөгдсөн эд хөрөнгийн нэмэлт гэрээг үргэлжлүүлэх боломжийг авч үзэж болно.

Ном зүй

Cissé, Hassane, Sam Muller, Chantal Thomas, and Chenguang Wang, eds. 2013. The World Bank Legal Review, Volume 4: Legal Innovation and Empowerment for Development. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank .org/handle/10986/12229.

FDFA (Swiss Federal Department of Foreign Affairs). 2016. "No Dirty Money: The Swiss Experience in Returning Illicit Assets." Booklet, FDFA, Bern.

Greenberg, Theodore S., Linda M. Samuel, Wingate Grant, and Larissa Gray. 2009. Stolen Asset Recovery: A Good Practices Guide for Non-Conviction Based Asset Forfeiture. Washington, DC: World Bank. http://siteresources.worldbank.org/FINANCIALSECTOR/Resources/Stolen_Assest_Recovery.pdf.

Home Office (Government of the United Kingdom). 2017. Explanatory Notes: Criminal Finances Act 2017, Chapter 22. Norwich, UK: The Stationery Office (TSO). https://www.legislation.gov.uk/ukpga/2017/22/pdfs/ukpgaen_20170022_ en.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

UNODC (United Nations Office on Drugs and Crime). 2015. "Digest of Asset Recovery Cases." Study, UNODC Corruption and Economic Crime Branch, United Nations, New York. https://www.unodc.org/documents/corruption/Publications/2015/15-05350_Ebook.pdf

6. Хураан авсан хөрөнгийн менежмент

6.1 Удиртгал

Түр арга хэмжээ авах замаар хөрөнгийг хамгаалах тохиолдолд эрх бүхий байгууллагууд тухайн хөрөнгийн аюулгүй байдлыг хангахаас гадна хөрөнгийг хурааж авах (эсвэл чөлөөлөх) хүртэл үнэ цэнийг нь хадгалах хэрэгтэй бөгөөд энэхүү процесс нь ихэвчлэн олон жил шаарддаг. Зарим тохиолдолд хөрөнгийг хураах эсвэл хязгаарлах ажиллагааг байнга хяналт шалгалт хийж, удирдах шаардлагагүйгээр хэрэгжүүлж болно. Тухайлбал, банкны дансыг хязгаарлах эсвэл царцаах шийдвэрийг банканд хүргүүлснээр тухайн банк дансыг үр дүнтэй блоколж хаах үүрэг хүлээнэ. Учир нь данснаас хөрөнгө шилжсэн тохиолдолд тухайн банкийг хохирлыг барагдуулахыг шаардаж шүүхэд хандах эсвэл хянан шалгагчдын зүгээс хариуцлагын арга хэмжээ авч болзошгүй юм. Гэхдээ зарим улс орнуудын хувьд мэргэжилтнүүд тухайн хөрөнгийг улсын дансанд шилжүүлэх нь илүү аюулгүй гэж үздэг.

Харин нарийн төвөгтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл, байгалийн зэрлэг эсвэл ашиг шим өгөх мал сүрэг, тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, машин, усан онгоц, өндөр үнэтэй дарс зэрэг бусад төрлийн хөрөнгийг тогтмол хадгалж, хянаж удирдахад илүү зорилтот арга хандлагыг ашиглах шаардлагатай болдог. Тиймээс аливаа хөрөнгө хураах тогтолцоо нь хураан авахаар хүлээгдэж байгаа хөрөнгийг хянаж удирдахад уян хатан байх, мөн тухайн хөрөнгийг хураан авсны дараа[1] хүлээн зөвшөөрч, олсон орлогыг улсад, засгийн газарт эсвэл бусад эрх бүхий хүлээн авагчид төлөх боломжтой байх нь нэн чухал юм.

Хөрөнгийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгох хамгийн эхний алхам бол хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үр ашигтай, ил тод, уян хатан байх хэмжээнд хадгалах, хамгаалах боломжийг бүрдүүлсэн холбогдох зохицуулалт бүхий зохистой хууль эрх зүйн орчин юм. Уг тогтолцоог бий болгохын тулд бусад анхаарах зүйлсээс гадна нөөц бололцоог хангалттай хэмжээнд зохистой хуваарилах шаардлагатай. Энэ нь ихэнхдээ хөрөнгийг удирдах, хянах төвлөрсөн эрх бүхий байгууллагыг бий болгохоос гадна тухайн хөтөлбөрт хяналт тавих удирдлага, зохион байгуулалтын ур чадвар бүхий ахлах түвшний боловсон хүчнийг томилж ажиллуулахыг шаардаг. Учир нь одоогийн байгаа хууль сахиулах байгууллагуудад шаардлагатай ур чадвартай боловсон хүчин, нөөц бололцоо бүхий бүтэц зохион байгуулалт байхгүй байж болох юм.

Зарим улс орнуудын хувьд энэ чиглэлээр тодорхой хэмжээний нөөц бололцоотой байж болно. Тухайлбал, гэмт хэргийн нотлох баримт болсон эд хөрөнгийг хураан авч, хадгалах үүрэг хүлээсэн хууль сахиулах байгууллага байгаа боловч олон

[1] Хураан авсан хөрөнгийг удирдахын ач холбогдлыг олон улсын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн бөгөөд Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц (UNCAC)-ийн 31(3) дугаар заалтыг харна уу. Мөн G8 Лион/Рома групп (2005) (https://docplayer.net/16960901-G8-best-practices-for- the-administration-of-seized-assets.html) сэдвийн хүрээнд болон Вашингтон, ДиСид байрлах АНУ-ын мужуудын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн албанаас 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдөр гаргасан “Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой мөнгө угаах гэмт хэрэг болон бусад төрлийн гэмт хэрэгтэй холбоотой загвар журам”-ын 7 дугаар заалтын хүрээнд холбогдох зөвлөмж, зааварчилгааг гаргасан байдаг.

төрлийн хөрөнгийг хязгаарлах, хураан авах ажиллагааг явуулахад ихэвчлэн зарим хүндрэлтэй тулгардаг. Хууль тогтоомж, журам болон хөрөнгийн удирдлагын санхүүжилтийг анхааралтай боловсруулж хэрэгжүүлэхгүй л бол хамгийн амжилттай хураан авах тогтолцоо хүртэл хураан авсан хөрөнгийг удирдах чадваргүй болсны улмаас үр дүнгүйд тооцогдож болзошгүй юм. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-аас 2017 онд хураан авсан хөрөнгийг өдөр тутам удирдах чиглэлээр хууль эрх зүй, бодлогын орчинг бий болгох зөвлөмж болон туршлагыг багтаасан тайланг нийтэлсэн (UNODC 2017).

Эцэст нь хөрөнгийн ул мөрийг тогтоох, хязгаарлах, удирдах, барагдуулах зэрэг хөрөнгийг хураан авахтай холботой бүх үе шатанд нөөц бололцоо шаардлагатай. Хөрөнгийг удирдахад өндөр үнэтэй байж болно. Иймээс урьдчилан таамаглах боломжтой, тогтмол зохих санхүүжилтээр хангах механизм шаардлагатай. Зарим тохиолдолд хөрөнгийн удирдлагыг үндсэн төсвөөс, бусад тохиолдолд хураан авсан хөрөнгийн сангаар дамжуулан санхүүжүүлж болно. Энэ талаар Дэлхийн Банкны Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачлага (StAR)-ын хүрээнд гаргасан цуврал (2009 онд гарсан Грийнберг зэрэг зохиолчдын бүтээлийн 90 дүгээр хуудас, Дэлхийн банк 2009)-д багтсан бусад нийтлэлүүдэд тусгасан байдаг. Мөн олон улсын хамтын нийгэмлэгээс олон улсын болон бүс нутгийн төрөл бүрийн байгууллагуудаар дамжуулан хөрөнгийг удирдах ажиллагаанд техник туслалцаа, санхүүжилт олгох санаачлагыг дэмжсээр ирсэн.[2]

6.2 Хөрөнгийн удирдлагын гол оролцогчид

Дээр дурдсанчлан хөрөнгийг хураан авахад хууль сахиулах албан хаагчид, прокурор, шүүгч, санхүүгийн шинжээч, хөрөнгийн менежер эсвэл хөрөнгийн удирдлагын агентлаг зэрэг төрөл бүрийн ур чадвартай хувь хүн, байгууллагууд харилцан уялдаа холбоотой, хамтран хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай. Тухайн нөхцөл байдлаас хамааран нэг нь нөгөөгөөсөө илүү оролцоотой байж болох хэдий ч бүх байгууллага, хувь хүмүүс тухайн тохиолдлын хувьд ямар ажиллагаа явагдаж байгааг эхлэхээс дуусах хүртэл мэдэж байх нь чухал юм.

Хөрөнгийн менежерүүд дараах ур чадвар, нөөц бололцоо, хууль ёсны эрх мэдэлтэй байх ёстой. Үүнд:

- Хөрөнгийг хураан авснаар гарах хадгалалт, хамгаалалтын зардал, хөрөнгийн үнэ цэнэ болон эвдрэл гэмтэл, гарзтай холбоотой болзошгүй өр төлбөр зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн хөрөнгийг хураан авах нь эдийн засгийн ач холбогдолтой эсэх талаар хөрөнгийг хураан авахаас өмнө зөвлөгөө өгөх,
- Хураан авахаар хүлээгдэж буй хөрөнгийн аюулгүй байдал, үнэ цэнийг хадгалах (хурдан элэгдэлд ордог хөрөнгийг борлуулах мөн хамаарна),
- Шаардлагатай тохиолдолд хөрөнгийн удирдлагыг амжилттай гүйцэтгэх тусгай ур чадвар бүхий этгээдийг гэрээгээр ажиллуулах,

[2] Тухайлбал, Европын Холбооны дэмжсэн санаачилгын үр дүнд НҮБ-ын Бүс нутаг хоорондын гэмт хэрэг, шударга ёсны судалгааны хүрээлэн (UNICRI) хэрэгжүүлэгч байгууллагаар хамтран ажиллаж, Европын Холбооны улс орнуудын шилдэг туршлага дээр үндэслэн Ливи Улсад хөрөнгийг хураан авч удирдах нэгжийг байгуулсан. Энэхүү санаачлагын хүрээнд UNICRI-аас хулгайлагдсан хөрөнгийн ул мөрийг тогтоох, буцаах чиглэлээр улс орнуудад тусламж үзүүлсэн (EC 2018, 8 дугаар хуудас).

- Үнэ цэнийн хэлбэлзэл ихтэй хөрөнгийг эзэмших эсвэл худалдан борлуулах эсэхийг тодорхойлох,
- Хөрөнгийг хураан авсны дараа бодит үнэ цэнээр худалдан борлуулах,
- Шаардлагатай бүх зардлыг төлж барагдуулсны дараагаар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олсон орлогыг хуваарилах.

  Хууль сахиулах албан хаагчид, прокурор, шүүгчдэд энэ төрлийн ур чадвар, нөөц бололцоо, хууль ёсны эрх мэдэл дутмаг байж болох юм. Тиймээс эрх баригчдын зүгээс дараах сонголтуудын аль нэгээр дамжуулан шаардлагатай ур чадвар, туршлагыг эзэмших эсвэл бий болгохыг зорих хэрэгтэй. Үүнд:
- Хөрөнгийн удирдлагаар мэргэшсэн тусгай агентлаг эсвэл албыг байгуулах. Энэхүү тусгайлсан агентлаг нь хураан авсан эсвэл хязгаарласан хөрөнгийг удирдах, хөрөнгийн удирдлагын чадварлаг менежрүүдийг авч ажиллуулах, хязгаарлалт хийхээс өмнө төлөвлөлт, дүн шинжилгээг хийх, хөрөнгийг хураан авсны дараагаар хүлээн зөвшөөрч барагдуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй байна (Энэ тохиолдлын хувьд жишээ болгож Франц улсын Хураан авсан хөрөнгийг буцаах, удирдах агентлаг [ХАХБУА]-ийн талаар шигтгээ 6.1-д тайлбарласан).[3]
- Одоо үйл ажиллагаа явуулж байгаа агентлагийн харъяанд хөрөнгийн удирдлагын нэгжийг бий болгох. Засгийн газрын агентлагийн нэгж нь хураан

[3] Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас хөрөнгийн удирдлагын нэгж байгуулж ажиллахыг зөвлөсөн байдаг (ФАТФ 2012, 9–10 [26–27 дугаар заалт]). Гааг хотод төвтэй Камден Хөрөнгө Буцаах Агентлаг Хоорондын Сүлжээ (CARIN)-ний 2008 онд болсон Жилийн Уулзалтаар ийм төрлийн нэгж байгуулахыг зөвлөсөн байдаг. Хөрөнгийн удирлагаар мэргэшсэн нэгжүүдийн жишээг дурдвал: (а) Канад Улсын Хураан Авсан Эд Хөрөнгийн Удирдлагын Газар; (б) Румын Улсын Хураан Авсан Хөрөнгийг Удирдах Үндэсний Агентлаг (Agenția Națională de Administrare a Bunurilor Indisponibilizate, ANABI), https://anabi.just.ro/en/The+mission+and+the+tasks+of+the+Agency; (в) Украйн Улсын Хөрөнгийг Буцаах, Удирдах Агентлаг (ARMA), https://arma.gov.ua/en/; (г) Бельгийн Хаант Улсын Хураан Авах Төв Газар (COSC), https://ec.europa.eu /avservices/photo/photoByReportage.cfm?sitelang=en&ref=020472; (д) Нидерланд Улсын Эрүүгийн Хэргийн Гаралтай Хөрөнгийг Хураах Товчооны Хөрөнгийн Удирдлагын Нэгж (Bureau Ontnemingswetgeving Openbaar Ministerie, BOOM), https://www.prosecutionservice.nl/; (е) Итали Улсын Хураан Авсан Хөрөнгийн Үндэсний Агентлаг (Agenzia Nazionale per l'Amministrazione e la Destinazione del Beni Sequestrati e Confiscati alla Criminalita Organizzata, ANSBC), https://www.benisequestraticonfiscati.it/; (ж) Испани Улсын Хөрөнгө Буцаах, Удирдах Алба (Oficina de Recuperacion y Gestiyn de Activos, ORGA), https://www.mjusticia.gob.es/cs/Satellite/Portal/es/areas-tematicas/oficina-recuperacion-gestion; (з) Бүгд Найрамдах Португал Улсын Хөрөнгийн Удирдлагын Алба (Gabinete de Administraçao de Bens, GAB), https://igfej.justica.gov.pt/Gabinete-de-Administracao-Bens; (и) Бүгд Найрамдах Францын Улсын Хураан Авсан Хөрөнгийг Буцаах, Удирдах Агентлаг (AGRASC) (шигтгээ 6.1-д тайлбарласан); (к) Төрөл бүрийн хөрөнгийг удирддаг АНУ-ын Маршалын Алба, https://www.usmarshals.gov/; (л) Тайланд Улсын Мөнгө Угаахтай Тэмцэх Алба (AMLO), http://www.amlo.go.th/index.php/en /about-amlo/vision-and-mission; (м) Перу Улсын Хураан Авсан Эд Хөрөнгийн Үндэсний Хороо (Comisiyn Nacional de Bienes Incautados, CONABI), http://www.pcm .gob.pe/etiqueta/comision-nacional-de-bienes-incautados-conabi/; (н) Гондурасын Хураан Авсан Эд Хөрөнгийн Удирдлагын Алба (Oficina Administradora de Bienes Incautados, OABI), https://oabi.gob.hn/.

авсан хөрөнгийг удирдах чиг үүргийг тусгайлан хариуцах боломжтой.[4] Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байсан туршлагатай агентлагийн зүгээс ийм нэгжийг байгуулах талаар судалж үзэж болох юм.[5]

ШИГТГЭЭ 6.1 Франц Улс: Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг удирдах, буцаан олгох агентлаг

Танилцуулга: Франц улсаас Хураан авсан хөрөнгийг буцаах, удирдах агентлаг (ХАХБУА)-ийг байгуулсан нь хөрөнгийг буцаах чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтыг нь илтгэх бөгөөд бусад улс орнууд энэ талаар харгалзан үзэх боломжтой.а ХАХБУА нь Хууль зүйн болон Төсвийн яамдын давхар хяналтад хамаардаг гүйцэтгэгч агентлаг бөгөөд 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 768/2010 дугаар хууль тогтоомжийн хүрээнд гэмт хэрэгтэй холбоотой хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр байгуулагдсан. Тус хуулиар хураан авах боломжтой эд хөрөнгийн цар хүрээг өргөжүүлсэн бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хөрөнгийг хураан авах тусгайлсан процедурыг нэвтрүүлсэн.

Тус агентлагийг шүүгч тэргүүлдэг бөгөөд удирдах зөвлөл нь (мөн адил шүүгч тэргүүлдэг) Хууль зүй, Дотоод хэрэг болон Төсвийн яам зэрэг холбогдох яамдуудын төлөөлөөс бүрддэг. Европын Холбооны 2007 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 2007/845/JHA дугаартай шийдвэрийн дагуу Франц улс тус агентлагийг хөрөнгө буцаан авах ажиллагааг хариуцагч албаар тодорхойлсон.[b]

Эрхэм зорилго: ХАХБУА-ийн эрхэм зорилго бол хураан авах ажиллагааны чиглэлээр шүүгчдэд туслалцаа үзүүлж, чиглүүлэх явдал юм. Бүр тодруулбал, уг агентлаг нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- Caisse des Dépôts et Consignations (Хадгаламж, Илгээмжийн сан) нэртэй улсын банканд нээсэн дансаараа дамжуулан (эцсийн шийдвэр нь хүлээгдэж байгаа) хураан авсан хөрөнгийн төвлөрсөн удирдлагыг хэрэгжүүлэх,
- Хураан авсан хөдлөх эд хөрөнгө нь цаашид үнэнийг нотлоход шаардлагагүй болсон бөгөөд элэгдэлд орох магадлалтай гэж үзсэн тохиолдолд шүүх хурлаас өмнө тухайн эд хөрөнгийг бүгдийг нь худалдан борлуулах. Ингэхдээ эдгээр борлуулалтаас олсон орлогыг Хадгаламж, Илгээмжийн сангийн дансанд нэмж хийнэ.
- Хэргийг хэрэгсэхгүй болгосон эсвэл эд хөрөнгийг хурааж авахааргүй болсон тохиолдолд тухайн хөрөнгийн эзэмшигчид (шүүх хурлаас өмнө хийсэн борлуулалтын дагуу) Хадгаламж, Илгээмжийн сангийн дансанд хадгалуулсан дүнг буцаан олгох,

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[4] Бүгд Найрамдах Колумби Улсын Үндэсний Хар Тамхитай Тэмцэх Алба (DNE) нь Колумбийн хар тамхины наймааны эсрэг хууль тогтоомжийн дагуу хураан авсан, хязгаарласан хөрөнгийг удирдах чиг үүрэг бүхий хөрөнгийн удирдлагаар мэргэшсэн тусгай албатай байдаг. АНУ-ын ерөнхий хууль сахиулах байгууллага болох Маршалын Алба нь 1984 оноос хойш АНУ-ын Хөрөнгө Хураах Хөтөлбөрийн хүрээнд хөрөнгийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. https://www.usmarshals.gov/assets/ (2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хандаж авсан).

[5] Жишээ нь, Австрали Улсын Дампуурал, Итгэлцлийн Үйлчилгээ Үзүүлэх Алба (ITSA) нь дампуурал болон төлбөрийн чадваргүй болсонтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй Засгийн газрын нэгж юм. Мөн энэхүү алба нь дампуурлын үл хөдлөх хөрөнгийг зохицуулах болон дампуурал зарласан хувь хүмүүс, төлбөрийн чадваргүй болсон компаниудын хөрөнгийг удирдах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна Австралийн холбооны хөрөнгө хураах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд хөрөнгийн удирдлагын мэргэшсэн үйлчилгээг үзүүлдэг.

ШИГТГЭЭ 6.1 Франц Улс: Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг удирдах, буцаан олгох агентлаг

- Үл хөдлөх хөрөнгийг хураан авах талаар олон нийтэд мэдээлэх,
- Хөрөнгийг хураан авсны дараагаар захиран зарцуулах, худалдан борлуулах, устгалд оруулах зэргээр шаардлагатай бүх хөрөнгийг удирдах,
- Олон улсын харилцан туслалцааны хүсэлтийг биелүүлэх зорилгоор эсвэл гадаадын шүүхийн эрх байгууллагуудтай хамтран хураан авсан хөрөнгөөс бий болсон бүтээгдэхүүнийг худалдах, түгээх зэргээр хураан авсан хөрөнгийг удирдах,
- Хураан авсан эд хөрөнгөөс иргэний хэргийн оролцогч талуудад нөхөн төлбөр олгохтой холбоотой аливаа шийдвэрийг гүйцэтгэхийн өмнө зээлдүүлэгч, хохирогчдод мэдэгдэх.

Санхүүжилт: ХАХБУА нь шүүхийн шийдвэрээр хураан авсан хөрөнгийн орлого болон нийт хураан авсан хөрөнгөд тооцсон хүүгийн орлогоос голлон санхүүждэг.[c] Тус агентлаг нь 2012 оноос хойш Хадгаламж, Илгээмжийн сан дахь нийт хураан авсан хөрөнгө оруулалтын хүүгийн орлогоор өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж байна.

a. ХАХБУА-ийн цахим хуудсыг үзнэ үү: http://www.justice.gouv.fr/justice-penale-11330/agrasc-12207/.
b. "Гэмт хэрэгтэй холбоотой орлого, бусад эд хөрөнгийн ул мөрийг тогтоох, илрүүлэх чиглэлээр гишүүн улс орнуудын Хөрөнгө Буцаах Ажиллагааг Хариуцсан Байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны талаарх Европын Консулын 2007 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 2007/845/JHA дугаартай шийдвэр"-ийг үзнэ үү. (OJ L 332, 18.12.2007), https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX-%3A32007D0845.
c. Францын сенат. 2017. "Pour que le 'Crime ne Paie Pas': Consolider L'Action de l'AGRASC (Agence de Gestion et de Recouvrement des Avoirs Saisis et Confisqués) "[Гэмт хэрэг төлбөрөө төлдөггүй": Хураан Авсан Хөрөнгийг Буцаах, Удирдах Агентлаг (ХАХБУА)-ийн авсан арга хэмжээний нэгтгэл]. 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 421 дугаартай мэдээллийн тайлан (2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хандаж авсан). https://www.senat.fr/rap/r16-421/r16-4210.html.

- Хөрөнгийн удирдлагыг аутсорсинг хийх. Хөрөнгийн удирлагын албыг байгуулах эсвэл одоо үйл ажиллагаа явуулж байгаа агентлагийн харъяанд нэгж бий болгох боломжгүй улс орнуудын хувьд дотоодын хөрөнгийн итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй хамтран ажиллах нь тохиромжтой байж болох юм.[6]

[6] Өмнөд Африк нь 1998 оны Зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд хөрөнгийн удирдлагын үйлчилгээ үзүүлэх хувийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл шүүхээс томилогдсон төлөөлөгчийг ашигладаг улс орны жишээ юм. Энэхүү хууль тогтоомжийн хүрээнд хураан авсан, хязгаарласан хөрөнгийг удирдах, хураан авах шийдвэрийн дагуу эд хөрөнгийг худалдан борлуулах эрхтэй хүмүүсийг шүүхээс томилохыг зөвшөөрдөг. Өмнөд Африкийн Үндэсний Прокурорын Газрын Хөрөнгө Хураан Авах Нэгжээс хуулийн дагуу шүүхээс томилогдсон төлөөлөгчдөд зориулан зааварчилгаа бүхий гарын авлагыг боловсруулсан. Бельги болон Франц Улсад нарийн төвөгтэй хөрөнгийн удирдлагыг шүүхээс томилогдсон хөрөнгийн менежерүүдэд хариуцуулж болдог. Үүнтэй адилаар, Итали Улсад шүүхээс томилогдсон хөрөнгийн менежерүүдэд тухайн улсын мафийн эсрэг хууль тогтоомжийн дагуу нийтийн хэрэгцээнд дахин ашиглах хөрөнгийн удирдлагыг хариуцуулах боломжтой байдаг. Мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, үнэлгээ хийх үйлчилгээг үзүүлж болно. (Хөрөнгө Буцаах Ажиллагааг Хариуцсан Ажлын Хэсэг 2017, 57–59, https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/WorkingGroups/workinggroup2/2017-August-24-25/V1705952e.pdf). Эдгээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн нөхөн төлбөр, зардлын асуудлыг ихэвчлэн урьдчилан шийдвэрлэх шаардлагатай байдаг бөгөөд энэ талаар Бүлэг 6.9-д дэлгэрүүлж авч үзсэн.

6.3 Хөрөнгийн менежерийн эрх хэмжээ

Хөрөнгийн менежерүүд одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, шүүхийн дүрэм, журам эсвэл шүүхийн шийдвэрт үндэслэн эрх мэдлээ хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр баримт бичигт тэднийг үүргээ гүйцэтгэхэд нь туслах чухал мэдээлэл цуглуулах эрх мэдлийг тусгасан байдаг.

6.3.1 Хуулиар олгогдсон бүрэн эрх

Шүүхээс хөрөнгийн удирдлагын албанд хязгаарлах, хураан авах шийдвэрийн дагуу хөрөнгөд хяналт тавих эрх үүрэг олгох тохиолдолд тухайн алба (эсвэл менежер) шаардлагатай чиг үүргийг хэрэгжүүлэх хууль ёсны эрх мэдэлтэй байх ёстой. Ерөнхийдөө, эдгээр эрх мэдлийг хөрөнгийг хураан авах тухай хууль тогтоомж[7], хөрөнгийн удирдлагын тухай хууль тогтоомж, мөнгө угаахтай тэмцэх тухай хууль тогтоомж болон шүүхийн шийдвэрээр олгодог. Эдгээр эрх мэдэл нь дараах эрх хэмжээтэй байна. Үүнд:

- Хөрөнгийн удирдлагыг эрх бүхий хувь хүн, аж ахуйн нэгжид шилжүүлэх, даалгах,
- Хөрөнгийг удирдахтай холбоотой өдөр тутмын шийдвэрийг гаргахаас гадна хөрөнгийг хязгаарлах, хураан авах, удирдахтай холбоотой гарсан шаардлагатай бүх зардлыг төлөх, зарцуулах,
- Хувьцаа, үнэт цаас, бусад хөрөнгө оруулалтын хэлбэртэй байгаа хураан авсан эсвэл хязгаарласан хөрөнгийг худалдах,
- Хяналтад байгаа хөрөнгийг даатгуулах,
- Бизнесийн үйл ажиллагааны хүрээнд хүмүүсийг ажилд авах (ажлаас чөлөөлөх), шаардлагатай тохиолдолд бизнесийн менежер хөлсөлж ажиллуулах, бизнесийн үйл ажиллагааг зохистой удирдаж явуулахад шаардлагатай шийдвэрүүдийг гаргах зэргээр үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
- Компанийн хувьцаанаас бүрдсэн хөрөнгийн хувьд хөрөнгийн менежер нь хувьцааны бүртгэлтэй эзэмшигчийн хувиар тухайн хувьцаатай холбоотой саналын болон бусад эрхийг хэрэгжүүлэх,
- Тодорхой журам, хуваарь эсвэл шүүхийн шийдвэрийн дагуу дэлгэрэнгүй тодруулга хийх, заавал аудитад хамруулах шаардлагын хүрээнд хөрөнгийн менежер болон хөрөнгийг удирдахад оролцсон хүмүүст нөхөн төлбөр олгох

[7] Тухайлбал, Тунисын хувьсгалын дараа огцруулсан Ерөнхийлөгч Зин эль Абидин Бен Алигийн хөрөнгийг шинэ Засгийн Газрын тогтоол (2011-13 хуулийн тогтоол)-ын дагуу хураан авах шийдвэр гаргасан. Уг тогтоолд Бен Али болон түүний төрөл төрөгсөд зэрэг 114 хүнийг хамруулсан байна. Хураан авсан эд хөрөнгөд нийтдээ ойролцоогоор 13 тэрбум ам.долларын үнэлгээтэй үл хөдлөх хөрөнгө, усан онгоц, дарвуулт онгоц, хувьцааны багц, банкны данс, 662 гаруй аж ахуйн нэгжүүд багтсан (Райкерс, Фрейнд, Нусифора 2014). (Бен Али болон түүний гэр бүлийн эсрэг хэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 2-ийн Шигтгээ 2.6 болон Бүлэг 5-ийн Шигтгээ 5.3-аас үзнэ үү.) Гэсэн хэдий ч Бен Алигийн гэр бүл давж заалдсаны дараагаар 2015 онд 2011 оны тогтоолыг хүчингүй болгосон. 2015 оны Тарек Амарааг үзнэ үү. “Тунисын шүүхээс хөөн зайлуулсан Ерөнхийлөгчийнхөө хөрөнгийг хураан авах шийдвэрийг хүчингүй болгов” Ройтерс, 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдөр. https://www.reuters.com/article/us-tunisia-corruption/tunisian-court-annuls-confiscation-of-ousted-presidents-assets-idUSKBN0OQ19A20150610.

(Хөрөнгийн менежерүүдэд төлөх төлбөрийн талаар Бүлэг 6.9-т мөн авч үзсэн).[8]

Хөрөнгийн менежерүүдэд заримдаа элэгдэл хорогдолд ордог эвсэл хурдан мууддаг хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байдаг. Ялангуяа, хөрөнгийг хураан авах эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө шүүх ажиллагааны явцад хөрөнгийг худалдан борлуулах эрхийг олгодог (Хурдан мууддаг, элэгдэлд ордог хөрөнгийн талаар Бүлэг 6.5.7-д илүү дэлгэрүүлж авч үзсэн). Хэрэв хөрөнгийн менежерүүдэд хурдан мууддаг хөрөнгийг захиран зарцуулах эрхийг олгоогүй, эсвэл тэдэнд хуулийн дагуу тусгайлсан заарчилгаа, эрх хэмжээг олгоогүйн улмаас хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудал тулгарсан тохиолдолд тухайн хязгаарлах шийдвэрийг гаргасан шүүхэд хандаж зааварчилгаа, эрх хэмжээг олгохыг хүсч болно. Гэхдээ энэ процесс нь цаг хугацаа шаардахаас гадна зардал ихтэй байж болно.

6.3.2 Мэдээлэл цуглуулах эрх мэдэл

Хөрөнгө хураан авахтай холбоотой хууль тогтоомжид ихэвчлэн мэдээлэл цуглуулах эрх мэдлийг тусгасан байдаг. Ихэнх тохиолдолд, зөвхөн хууль сахиулах албан хаагчид, прокурор, шүүгчид уг эрх мэдлийг ашиглах боломжтой байж болно. Гэхдээ тухайлсан байршил, мөн чанар нь тодорхойгүй байгаа хөрөнгийг хяналтандаа авах эсвэл үнэ цэнэд суурилсан мөнгөн төлбөр буюу үр ашигтай холбоотой шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн хөрөнгийн менежерүүдэд заримдаа энэ төрлийн эрх мэдлийг олгодог. Мэдээлэл цуглуулах эрх мэдэлд тайлан мэдээлэлтэй танилцах, хөрөнгийн ул мөрийг тогтоох зорилгоор холбогдох баримт бичигт нэгжлэг хийх, хөрөнгийг илрүүлэхийн тулд сэжигтэнээс албан ёсны мэдүүлэг авах, шалгалт хийх зэрэг хамаарч болно. Сэжигтэнийг тангараг өргүүлэн мэдүүлэг авах замаар хөрөнгийн байршил болон мөн чанарын талаар хөрөнгийн менежерт мэдээлэл өгөхийг шаардах эрх мэдлийг иргэний болон нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжтой улс орнуудад[9] өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс хамгаалах нөхцөл, хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх нь үр ашигтай тактик юм. Хэрвээ сэжигтэн өмнө нь тодорхойгүй байсан хөрөнгө оршин байгаа эсэх болон түүний байршлын талаар мэдээлэл өгөөгүй эсвэл бүр мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд хуулийн үйлчилгээний төлбөр эсвэл амьжиргааны зардлаа төлөх зорилгоор хязгаарласан хөрөнгийг ашиглах гэсэн сэжигтэний дараа дараачийн хүсэлтийг хүлээж авахгүй байхад тустай байж болох юм.[10] Мөн түүнчлэн, худал мэдүүлэг өгөх эсвэл аливаа мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд ихэвчлэн мэдээлэл авахтай холбоотой шийдвэрийг биелүүлээгүй эсвэл үл хүндэтгэсэн гэж үзэн яллах

---

[8] Зарим улс оронд хөрөнгийн менежерүүдийн цалин хөлсийг хураан авсан хөрөнгөөс олгодог. Хөрөнгийг хураан авахтай холбоотой мөрдөн шалгах, маргаан таслах шийдвэр гаргах үүрэгтэй мэргэжилтний цалин хөлсийг ийм төрлийн сангаас шууд олгохыг зөвлөдөггүй бөгөөд учир нь ингэснээр мөнгөн урамшуулал авахын тулд хөрөнгийг хураан авсан мэт харагдана. (Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Хөрөнгийг Буцаах Ажиллагааг Урамшуулах Схем [ХБАУС]-г зохих нөөц бололцоо, дэмжлэгээр хангах болон түүний талаарх шүүмжлэлийн тухай Бүлэг 2-ын 2.7-оос мөн үзнэ үү).

[9] Бразил Улс болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эрх баригчид ийм төрлийн мэдүүлэг авах хүсэлт гаргах боломжтой байдаг.

[10] Эдгээр шалгалт хийх эрх мэдэл нь заримдаа сэжигтэй этгээдийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөрчдөг. Ийм тохиолдолд эрх баригчид ихэвчлэн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шалгалтын явцад олж авсан аливаа нотлох баримтыг ашиглахаас сэргийлдэг.

үндэслэл болдог. Цаашилбал, сэжигтэн, түүний хамаарал бүхий этгээд эсвэл мэргэжлийн зөвлөхүүд (нягтлан бодогч, төлөөлөгч, хөрөнгөөр мэргэшсэн хуульчид гэх мэт)-ийг тангараг өргүүлэн шалгах эрх мэдэлтэй байх нь тухайн хөрөнгийн ул мөрийг тогтооход хэрэгтэй байж болно.

6.4 Хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Хөрөнгийн менежер хязгаарласан хөрөнгийг хяналтандаа авах үед тухайн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл болон түүнтэй холбоотой гарсан аливаа гүйлгээний талаарх мэдээллийг хадгалах нь чухал байдаг. Менежер хөрөнгийн нарийвчилсан тооллого, тайлбар болон тэдгээрийн шинж байдлын талаарх мэдээллийг цуглуулж, түүнийгээ тогтмол шинэчилэх хэрэгтэй.[11] Эдгээр мэдээлэл дээр нэмж, хөрөнгийг хураан авах эсвэл хязгаарлах үед тухайн хөрөнгийн шинж байдлыг харуулсан зураг, видео бичлэгийг хадгалах хэрэгтэй. Мөн хөрөнгийн үнэлгээний мэдээллийг олж авч оруулах хэрэгтэй. Эдгээр мэдээлэл нь хөрөнгийн менежер болон хязгаарлах арга хэмжээ авах хүсэлт гаргагчийг хөрөнгийн менежерийн ажилтан эсвэл төлөөлөгчид нь хөрөнгийг гэмтээсэн гэсэн гомдол маргаан гаргахаас хамгаалж чадна.

Менежерүүд мөн хөрөнгийг хураан авах эсвэл хязгаарлах үед илэрсэн эвдрэл гэмтэл болон удирдлагатай холбоотой аливаа асуудлуудын талаар нарийвчилсан тэмдэглэл үйлдэх хэрэгтэй (жишээ нь, барааг хадгалж буй агуулах нь ус гоождог дээвэртэй байх). Менежерүүд шаардлагатай арга хэмжээг авах, мөн өмнө үүссэн нөхцөл байдлын улмаас хариуцлага хүлээхээс зайлсхийх зорилгоор энэхүү мэдээллийг шүүх эсвэл прокурорт эсвэл хоёуланд нь өгөх хэрэгтэй.

Тайлагналын асуудал нь хөрөнгийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд мөн чухал ач холбогдолтой. Энэ нь хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэхээс гадна тухайн албаны зорилго, ололт амжилтын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх боломжтой. Тухайн кейс хэргийн талаарх тайланг хязгаарлах арга хэмжээ авах хүсэлт гаргагчид хүргүүлэх хэрэгтэй бөгөөд хууль тогтоомжоор шаардсан тохиолдолд шүүхэд илгээнэ. Хөрөнгийн тооллого, үнэлгээний талаарх мэдээллийг уг тайланд хавсаргах хэрэгтэй. Мөн түүнчлэн, тухайн албаны ерөнхий үйл ажиллагааны талаарх жилийн тайлан болон нэгдсэн статистик мэдээлэл шаардлагатай болж болно.

6.5 Хөрөнгийн түгээмэл хэлбэрүүд болон холбогдох бэрхшээлүүд

Хураан авсан хөрөнгөд хураан авсан бэлэн мөнгө, банкны данс, санхүүгийн хэрэгсэл; үл хөдлөх хөрөнгө; тээврийн хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц; бизнесийн үйл ажиллагаа; мал аж ахуй, фермерийн аж ахуй; үнэт металл, үнэт эдлэл, урлагийн бүтээл; болон хурдан мууддаг болон элэгдэлд ордог хөрөнгүүд хамаарч болно. Ийм төрлийн олон янзын хөрөнгийг зөвхөн нэг кейс хэргийн хувьд ч хураан авах боломжтой (Тэтгэвэрт гарсан БНХАУ-ын албан тушаалтан Жоу Юнканд хамаарах хөрөнгийг хураан авсан талаар Шигтгээ 6.2-т оруулсан). Эдгээр төрлийн хөрөнгийг хураан авахад тулгарч болох хүндрэл бэрхшээлүүдийн талаар дараагийн хэсгүүдэд авч үзсэн.

[11] Шинэчилсэн хөрөнгийн жагсаалтыг хөтлөхөд технологийн дэвшлийг ашиглах нь чухал үр дүнтэй. Зарим улс орнуудад энэ зорилгоор тусгайлан бүтээсэн компьютерийн хяналтын системийг нэвтрүүлсэн байдаг.

ШИГТГЭЭ 6.2	Хятад: Жоу Юнкан болон түүний хамаарал бүхий этгээдээс 14.5 тэрбум ам.долларын үнэ бүхий хөрөнгийг хураан авсан тухай

Ерөнхий мэдээлэл: Авлигын эсрэг аяны хүрээнд БНХАУ-ын эрх баригчид тэтгэвэрт гарсан Дотоодын аюулгүй байдлын сайд асан Жоу Юнканыг тус улсад болсон хамгийн том авлигын дуулиант хэргүүдийн нэгт оролцсон гэж мэдэгдсэн. Сайд асанг эрх мэдлээ урвуулан ашигласан, хээл хахууль авсан, улсын нууц задруулсан хэрэгт буруутгаж, 2015 оны 6 дугаар сард бүх насаар нь хорих ял оноосон.a

Хураан авсан хөрөнгө: 2014 оны 3 дугаар сарын байдлаар БНХАУ-ын эрх баригчид түүний гэр бүлийн гишүүд болон ойрын хамаарал бүхий этгээдээс хамгийн багадаа 90 тэрбум юань (14.5 тэрбум ам.доллар)-ийн үнэ бүхий хөрөнгийг хураан авсан. Тодруулбал, нийтдээ 37 тэрбум юанийн хадгаламжтай банкны дансуудыг царцаасан бөгөөд 51 тэрбум юанийн нийлбэр дүн бүхий дотоод, гадаадын бондыг мөн хураан авсан.[b]

Үүнээс гадна БНХАУ-ын эрх баригчид 300 орчим үл хөдлөх хөрөнгийг хураан авсан бөгөөд үүнд 1.7 тэрбум гаруй юанийн үнэ бүхий зуслангийн харш болон орон сууц, 1 тэрбум юанийн үнэ бүхий эртний эдлэл, уран зураг, мөн 60 гаруй тээврийн хэрэгсэл багтсан. Мөн үнэтэй архи, алт, мөнгө, дотоод болон гадаад валютаарх бэлэн мөнгийг хураан авсан. Хураан авсан хөрөнгийн ихэнх нь Жоу Юнкангийн нэр дээр байгаагүй бөгөөд түүний төрөл төрөгсөд, улс төрийн хамтрагчид болон ажилтнуудын нэр дээр байсан гэж үздэг.[c]

a. Майкл Форсит. 2015. "БНХАУ-ын Аюулгүй байдал хариуцсан дарга асан Жоу Юнкан залилангийн хэргээр бүх насаараа хоригдох ял авлаа." Нью Йорк Таймс, 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдөр. https://www.nytimes.com/2015/06/12/world/asia/zhou-yongkang-former-security-chief-in-china-gets-life-sentence-for-corruption.html.
b. Бенжамин Кан Лим, Бен Бланчард. 2014. "Эх сурвалж: БНХАУ Аюулгүй байдал хариуцсан дарга асны гэр бүл, хамаарал бүхий этгээдээс 14.5 тэрбум ам.долларын үнэ бүхий хөрөнгийг хураан авчээ." Ройтерс, 2014 оны 3 дугаар сарын 30-ны өдөр. https://www.reuters.com/article/us-china-corruption-zhou/exclusive-china-seizes-14-5-billion-assets-from-family-associates-of-ex-security-chief-sources-dUSBREA2T02S20140330. Нийт хөрөнгөөс хэдэн хувийг гэмт хэргээс олсон орлого эзэлж байгаа нь тодорхойгүй байна.
c. Лим, Бланчард, "БНХАУ 14.5 тэрбум ам.долларыг хураан авлаа", 2014 оны 3 дугаар сарын 30-ны өдөр.

6.5.1 Хураан авсан бэлэн мөнгө, банкны данс, санхүүгийн хэрэгсэл

Мөнгөний ул мөрийг олж тогтооход ихэвчлэн хүндрэлтэй байдаг боловч түүнийг удирдахад илүү хялбар байдаг. Нотлох баримт болгож ашиглах бэлэн мөнгөнөөс бусад хураан авсан мөнгийг голдуу хүү тооцож олгодог дансанд байршуулан хадгалдаг.[12] Банкны дансыг хязгаарладаг эсвэл хураан авдаг улс орнуудад үүнтэй ижил төстэй бодлогыг баримталдаг байж болно.[13]

[12] Мөнгийг банканд хадгалуулах шийдвэр гаргахаасаа өмнө хураан авсан бэлэн мөнгөний нотлох баримт болох үнэ цэнийг авч үзэх ёстой. Ашиг сонирхол бүхий этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр ийм үйлдэл хийх нь нотлох баримтыг санаатайгаар булаан авсан гэсэн маргаан гарахад хүргэж болзошгүй юм. Хураан авсан бэлэн мөнгийг хадгаламжид байршуулахыг шаарддаг АНУ-ын Хууль зүйн яамны бодлогын талаар илүү дэлгэрүүлж, United States v. $209,815 in U.S. Currency, 2015 WL 5970186, *7–8 N.D. Cal. (2015) баримт бичгийг үзнэ үү.

[13] Швейцар Улсын хувьд Швейцарийн Банкны холбоо болон хууль сахиулах байгууллагууд хамтран хураан авсан банкны дансуудыг удирдах тогтолцоог бий болгох чиглэлээр ажилласан.

Санхүүгийн хэрэгсэл (кассын чек, мөнгөн гуйвуулга, хадгаламжийн гэрчилгээ, хувьцаа, бонд, брокерийн данс гэх мэт)-ийг мөн хураан авах шаардлагатай бөгөөд ингэхдээ түүний үнэ цэнийг хадгалж үлдэх, нөхөн төлөх процедурыг ашиглана. (Виртуал хөрөнгийг хураан авахтай холбоотой нарийвчилсан асуудлын талаар Шигтгээ 6.3-ыг үзнэ үү.)

Хувьцаа, бонд, брокерийн дансны хувьд мэргэшсэн мэргэжилтэн (жишээ нь, хувьцааны брокер)-ийг хөрөнгийн үнэлгээг хийх, түүний үнэ цэнийг хэрхэн хамгийн сайн хадгалахыг тодорхойлох зорилгоор томилж ажиллуулах ёстой. Зарим тохиолдолд, тухайн мэргэжилтэнд (а) зах зээлийн нөхцөл байдлаас хамааран үнэ цэнэ нь хэлбэлзэж болзошгүй хөрөнгийг үргэлжлүүлэн эзэмших эсвэл худалдан борлуулахтай холбоотой шийдвэр гаргах, (б) тухайн гаргасан шийдвэрийн улмаас учирсан санхүүгийн алдагдлыг хариуцахаас чөлөөлөгдөх зэрэг эрх мэдлийг олгох шаардлагатай.

6.5.2 Үл хөдлөх хөрөнгө (газар)

Эхний ээлжинд, шүүх болон хууль сахиулах байгууллагуудаас (а) үл хөдлөх хөрөнгийг хураан авах шаардлагатай эсэх (өөрөөр хэлбэл, улсын мэдэлд авах); (б) шүүхийн хязгаарлах шийдвэрийн дагуу газрын бүртгэлд тэмдэглэл хийж түүнийг эзэмшигчийн мэдэлд нь үлдээх эсэх; эсвэл (в) эдгээрийг хоёуланг нь хэрэгжүүлэх эсэхийг тодорхой болгохыг хүснэ. Зарим улс орнуудад, тухайн хөрөнгийг эзэмшигч нь эсвэл хөндлөнгийн этгээд хадгалж удирдах шаардлагатай эсэх талаар хөрөнгийг хураан авах эрх бүхий байгууллагаас шийдвэрлэнэ. Ерөнхийдөө гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа явагдаагүй тохиолдолд эд хөрөнгийг биетээр хураан авах шаардлагагүй байдаг.

Үр дүнтэй газрын эзэмшлийн системтэй улс орнуудад газрын төвлөрсөн бүртгэл эсвэл газар эзэмшлийн алба нь газрын эзэмшил болон түүнтэй холбоотой барьцаа, нэхэмжлэлийн мэдээллийг бүртгэж авдаг.[14] Эдгээр улс орнуудад нийтийн газрын бүртгэлд барьцаа эсвэл бусад нэхэмжлэлийн талаарх мэдээллийг бүртгэх нь маш хялбар байдаг бөгөөд сэжигтэн газрыг худалдахыг оролдож болзошгүй аливаа холбогдох этгээдэд тухайн газрыг хураан авах ажиллагаа явагдаж байгаа талаар мэдэгдэл хүргүүлдэг. Ихэнх тохиолдолд, уг барьцаа буюу мэдэгдлийн тусламжтайгаар сэжигтэнийг худалдан авагчид хөрөнгийг тодорхой үнэ цэнээр шилжүүлэх, тухайн худалдан авагч дараа нь хөрөнгийн жинхэнэ эзэмшигч гэсэн маргаан үүсгэхээс урьдчилан сэргийлэхэд хангалттай. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, сэжигтэн хураан авахаар хүлээгдэж байгаа хөрөнгийг худалдах, нэхэмжлэхийг эсвэл түүний үнэ цэнийг бууруулахыг оролдсоны улмаас шүүхээс хариуцлага тооцож болох хэдий ч шүүхээс хязгаарлах шийдвэр гаргах шаардлага үүсч болох юм.

[14] Хуучин бүртгэлийн системийг ерөнхийдөө олон нийтэд зориулсан ном, сурах бичигт индексжүүлэн оруулсан байдаг. Харин шинээр гарсан бүртгэлийн системийг электрон байдлаар индексжүүлсэн байдаг бөгөөд ихэвчлэн цахим мэдээллийн сангаар дамжуулан ашиглах боломжтой байдаг.

ШИГТГЭЭ 6.3 Виртуал хөрөнгийг хураан авахтай холбоотой зарим асуудлууд

ФАТФ (Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага)-ын Зөвлөмж 15 ("Шинэ Технологи")-ын дагуу улс орнууд виртуал хөрөнгийг "эд хөрөнгө", "орлого", "сан", "сан эсвэл бусад хөрөнгө" эсвэл бусад "харгалзах үнэ цэнэ" гэж үзэх хэрэгтэй (ФАТФ 2019, 70 дугаар хуудас [1 дэх хэсэг]). Виртуал хөрөнгийг хураан авах нь техникийн хувьд хүндрэл бэрхшээлтэй байдаг. Учир нь эдгээр хөрөнгийн талаар бодолцож үзэхгүйгээр боловсруулсан хууль эрх зүйн арга хэрэгслүүд болон нөөц бололцоог хууль сахиулах байгууллагууд ашиглах шаардлагатай болдог (Китинг, Карлайл, Кин 2018, 57).

Биткойн зэрэг криптовалютыг хураан авч, найдвартай хадгалахын тулд хууль сахиулах байгууллагууд криптовалютын хэтэвчийг бэлэн байлгахад анхаарах хэрэгтэй бөгөөд ингэснээр мөрдөн байцаалтын явцад хураан авсан виртуал хөрөнгийг тухайн хэтэвчид шилжүүлэх боломж бүрдэхээс гадна хураан авсан виртуал хөрөнгийг алдсан тохиолдолд даатгалд хамруулах бодлогыг хэрэгжүүлэх эсэх талаар судалж болно (Китинг, Карлайл, Кин 2018, 60).а Криптовалютын үнийн тогтворгүй байдлын улмаас шүүх ажиллагааны явцад арилжаа хийхэд хүндрэлтэй байдгийг мэргэжилтнүүд анхаарах хэрэгтэй.

Виртуал хөрөнгийн бирж тухайн улсаас өөр улсад үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд хөрөнгийг блоколж хаах эсвэл хэтэвчид шилжүүлэх хүсэлтийг үл тоомсорлож болзошгүй бөгөөд хууль сахиулах байгууллагууд ийм төрлийн хүсэлтийн хэрэгжилтийг албан ёсоор хангах зорилгоор бусад улс орнуудтай харилцаа тогтоох шаардлагатай болж болох юм.[b] Тухайн хөрөнгө гэмт хэрэгтний анхны хэтэвчид байгаа тохиолдолд гэмт хэрэгтэн тухайн хэтэвчний нууц үг, хувийн түлхүүрийг сэргээх үгсийг олж авах боломжтой учраас хөрөнгийг шилжүүлэх эрсдэл хэвээр байгаа гэж үзнэ.[c]

a. Мөн Бүлэг 4-ийн 4.2.5 дахь хэсгээс виртуал валютын талаарх мэдээлэлтэй танилцана уу.
b. РБК (РосБизнесКонсалтинг). 2019. "Дотоод Хэргийн Яамнаас криптовалютыг саатуулах, хураан авах механизмыг боловсруулна." Санхүүгийн мэдээ, 2019 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр (2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хандаж авсан). https://www.rbc.ru/finances/07/11/2019/5dc160019a7947c61a5119a3.
c. Любомир Тасев. 2020. "Татварын албан хаагчид биткойныг гэмт хэрэгтнээс "хураан авсан" боловч койнуудыг түүний хэтэвчид үлдээжээ." Bitcoin.com, Мэдээ, 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдөр (2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хандаж авсан). https://news.bitcoin.com/tax-agents-confiscate-bitcoin/.

Хүндрэл бэрхшээл гараагүй тохиолдолд газрыг ихэвчлэн хөрөнгийн менежер томилохгүйгээр үр дүнтэйгээр хязгаарлалтад оруулах боломжтой. Гэхдээ дор ангилсан хэд хэдэн асуудлууд үүсдэг.

Төлбөр хураамж, татвар, баталгаат зээл. Газарт ихэвчлэн засгийн газраас төлбөр хураамж, татвар ногдуулдаг бөгөөд газрыг орон сууцны зээл эсвэл бусад төрлийн зээлийн барьцаанд банканд тавьсан байж болно. Аливаа хязгаарлах шийдвэрийг гаргахаас өмнө үл хөдлөх хөрөнгийн менежер нь газартай холбоотой одоо байгаа бүх барьцаа, нэхэмжлэлийг харгалзан үзсэний дараагаар тухайн хөрөнгийн үнэ цэнэ нь хязгаарлалтад оруулж, улмаар хураан авахад хангалттай үндэслэл болох эсэхийг тогтоох хэрэгтэй.

Газрыг хязгаарлалтад оруулсан тохиолдолд уг шийдвэрийн дагуу сэжигтэн болон тухайн газрын бусад оршин суугчдыг барьцаанд байгаа газрын нэхэмжлэлтэй холбоотой одоо байгаа татварын төлбөр болон бусад өр төлбөрийг барагдуулахыг шаарддаг. Хэрэв газар эзэмшигч төлбөр хураамж, татвар, зээлээ төлөхөө зогсоосон тохиолдолд энэ талаар шүүхэд мэдэгдэхээс гадна шүүх ажиллагааны явцад тухайн

газрыг худалдан борлуулах шийдвэр гаргах хүсэлтийг Засгийн газраас шүүхэд гаргаж болно.[15]

Өөр хувилбар гэвэл менежер нь сэжигтэн болон бусад оршин суугчидтай тохиролцсоны үндсэн дээр эдгээр төлбөрийг төлж барагдуулах нөхцөлтэйгээр тэднийг үргэлжлүүлэн тухайн газар дээр орших суухыг зөвшөөрч болох бөгөөд ингэхдээ тухайн нөхцөлийг хангаагүй тохиолдолд оршин суугчдыг албадан нүүлгэж, газар эзэмших эрхийг шууд менежерт олгохоор тохиролцож болно. Хэрэв оршин суугчдыг албадан нүүлгэх шаардлага үүссэн тохиолдолд хөрөнгийн менежер холбогдох зардлыг төлж барагдуулахад хүрэлцэхүйц хувь хэмжээгээр тухайн хөрөнгийг түрээслүүлж эсвэл тухайн хөрөнгийг худалдан борлуулж, олсон орлогоор үлдэгдэл өр төлбөрийг барагдуулах арга замыг эрэлхийлж болно. Эцсийн дүнд, татвар болон барьцаа төлбөрийг барагдуулахыг ихэвчлэн хөрөнгийг хураан авах шийдвэрийг хэрэгжүүлэхээс илүүд авч үздэг.

Эцэст нь хөрөнгийн менежер нь жинхэнэ барьцаалан зээлдүүлэгчтэй аливаа шаардлагагүй шүүхийн маргаан үүсэхээс зайлсхийх зорилгоор урьдчилан харилцан тохиролцох боломжтой бөгөөд ингэхдээ тухайн хөрөнгийг худалдан борлуулсан орлогоос барьцаа төлбөрийг барагдуулах учраас энэхүү хэрэг шүүхээр шийдэгдэх хүртэл барьцаа хөрөнгийг барагдуулах талаар аливаа шүүхийн маргаан үүсгэхээс татгалзахыг хүсч болно.

Зардал, төлбөр, хөрөнгийн сайжруулалтууд. Газрыг хязгаарлалтад оруулах нь тухайн хөрөнгөтэй холбоотой өндөр дүнтэй зардал болон ашиглалтын төлбөрөөс шалтгаалан хүндрэлтэй байж болох бөгөөд эдгээр төлбөрийн заримыг яаралтай барагдуулах шаардлага үүсч болно. Зарим төрлийн газрын хувьд үнэ цэнийг нь хадгалахад ихээхэн хэмжээний, өндөр үнэтэй завсар үйлчилгээ шаардлагатай болдог (жишээ нь, гольфын талбай, фермер).

Тухайн хөрөнгийн нийт үнэ цэнийг хадгалахын тулд сэжигтний хөрөнгийн сан, хөрөнгө хураан авах зориулалтын сан, эсвэл бусад эрсдэлийн санг ашиглан санхүүжүүлж болно. Хэрэв сангийн хөрөнгө байхгүй эсвэл үнэ цэнийг нь хадгалах боломжгүй бол (эзэмшигчийн зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөлгүйгээр холбогдох шийдвэрийн дагуу) газрыг түрээслүүлэх эсвэл худалдах нь илүү тохиромжтой байж болно.

6.5.3 Моторт тээврийн хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц

Тээврийн хэрэгслийг удирдахад нэлээд их хүндрэл бэрхшээл тулгардаг. Тэднийг хураан авснаас хойш улсын орлого болгох хүртэл олон жил шаарддаг бөгөөд энэ хугацаанд тээврийн хэрэгслийг хадгалах, арчлахад зардал ихтэйгээс гадна хүндрэлтэй байдаг. Хураан авсан хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ эргэлзээтэй байж болох бөгөөд үнэ цэнэ нь ихэвчлэн хурдан унадаг.

Мэргэжилтнүүдийн хураан авсан тээврийн хэрэгслийг ихэнхдээ зүгээр л хашаандаа орхисон байдаг (зураг 6.1). Энэ нь хөрөнгийн удирдлагын зохистой стратеги биш бөгөөд хөрөнгийг хураан авсан байгууллагыг нөхөн төлбөрийн нэхэмжлэлд

[15] Нэмэлт Дүрэм Г(6) буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Холбооны дүрмийг үзнэ үү (Газар эзэмшигч нь татвар эсвэл орон сууцны зээлийн төлбөрөө төлөхөө больсон тохиолдолд тухайн хөрөнгийг шүүх ажиллагааны явцад худалдан борлуулах шийдвэр гаргах эрхийг АНУ-ын Холбооны шүүхэд олгодог).

оруулахаас гадна эцэст нь тээврийн хэрэгслийг хураан авснаар аливаа борлуулалтын орлогоос төлбөр барагдуулах боломжийг эрс бууруулдаг.

ФОТО 6.1 Цагдаагийн байгууллагын хашаанд байрлуулсан өндөр үнэтэй, хурдан элэгддэг тээврийн хэрэгслүүд

Эх сурвалж: © Клайв Скотт / Дэлхийн банк.

Моторт тээврийн хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоцыг зохих ёсоор хадгалахын тулд аюулгүй байдлыг хангасан тохиромжтой хадгалах байгууламжаас гадна хураан авсан тухайн төрлийн тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг хангаж ажиллах туршлагатай боловсон хүчин хэрэгтэй. Эдгээр хөрөнгийг хадгалах болон туршлагатай боловсон хүчнийг ажиллуулахад өндөр өртөгтэй байж болохоос гадна (хураан авах шийдвэрийн дагуу) эсвэл бусад эх сурвалж (сэжигтэн эсвэл хураан авах сан) зэрэг хураан авах ажиллагааг хариуцаж буй байгууллагаас мөн холбогдох санхүүжилтийг олгох шаардлага үүсч болно.

Эдгээр зардал болон тээврийн хэрэгслийн элэгдэх шинж чанарыг харгалзан үзсэний үндсэн дээр хуучирсан эсвэл элэгдэж муудсан тээврийн хэрэгслийг хураан авах нь ач холбогдолгүй байж болох юм. Учир нь тэдгээр тээврийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь засвар үйлчилгээний зардлаа нөхөхгүй байж магадгүй. Хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд, (өмчлөгчийн зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөлгүйгээр) ийм тээврийн хэрэгслийг харьцангуй шинэ, сайн нөхцөлтэй байхад нь худалдан борлуулахад анхаарах хэрэгтэй. Учир нь элэгдэж мууддаг тээврийн хэрэгслийг үнэ цэнээ хадгалдаг эсвэл нэмэгдүүлдэг хөрөнгө болгон хувиргах нь ихэвчлэн бүх талуудын ашиг сонирхолд нийцэх бөгөөд энэ төрлийн хэлцлийг сэжигтэн болон бусад бүх талуудын зөвшилцлийн үндсэн дээр хийх боломжтой. Зарим улс орнуудад, шүүгдэгч этгээд зөвхөн тодорхой нөхцөлд л ингэж худалдан борлуулахаас татгалзаж болдог.

Эцсийн нэг хувилбар гэвэл сэжигтэнийг хэрэг үүсгэсэн үеийн хөрөнгийн үнэ цэнэтэй дүйцэхүйц хэмжээний дүнг төлөхөө баталгаажуулан бонд байршуулах замаар хураан авах ажиллагааны явцад тээврийн болон бусад хэрэгслийг ашиглахыг зөвшөөрөх явдал юм.

6.5.4 Бизнесийн үйл ажиллагаа

Ерөнхийдөө бизнесийн үйл ажиллагааг хөрөнгийн менежерийн хяналтанд оруулахгүйгээр үр дүнтэй хязгаарлах, эсвэл хураан авах боломжгүй юм. Учир нь ийм үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ихээхэн эрсдэлтэй бөгөөд зардалтай байж болно. Тухайн бизнес бага үнэлгээтэй байж болох учраас (жишээ нь, хэрэв өөрийн бараа материал эсвэл үйл ажиллагаа явуулж байгаа байраа эзэмшдэггүй бол) нийт өр төлбөрийн дарамт болон эзэмшигчдийн өмчийг үнэн зөв тодорхойлохын тулд аливаа хязгаарлах, хураан авах хүсэлт гаргахаас өмнө бизнесийн хөрөнгийн үнэлгээг хийх ёстой. Хэрэв хязгаарлах эсвэл хураан авах хүсэлт гаргахаас өмнө ийм үнэлгээг хийх боломжгүй бол түр арга хэмжээг авсны дараа удалгүй хийх ёстой.

Үнэлгээ багатай эсвэл хууль бус зорилгоор эрхэлдэг бизнесийн хувьд түүний үйл ажиллагааг үргэлжлүүлэхтэй холбоотой санхүүгийн эрсдэлийг тооцохгүйгээр хураан авах ажиллагаанд хамруулах нь зүйтэй. Үүний оронд, тухайн бизнесийг зарах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох нь илүү тохиромжтой байж болно. Мөн тухайн бизнесийг хураан авах ажиллагаанд хамруулахаар тодорхойлох нь түүний гүдвилл үнэ цэнийг бууруулах магадлалтай. Үүнээс урьдчилан сэргийлэх боломжит арга зам гэвэл хөрөнгийн менежертэй гэрээ байгуулсан эсвэл шүүхээс томилогдсон бизнесийн менежерийн хяналтан дор одоогийн менежерийг үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахыг зөвшөөрөх явдал юм.

Хязгаарлалтад оруулахаас өмнө төлөвлөх нь аливаа бизнесийг хязгаарлах эсвэл хураан авахад чухал ач холбогдолтой. Тухайн бизнесийн бэлэн мөнгө болон хөрөнгө алдагдахаас зайлсхийх зорилгоор хязгаарлах шийдвэрийг аливаа этгээдийн нэрийн өмнөөс гаргах хэрэгтэй. Бизнесийг удирдахад шаардлагатай ур чадвар бүхий хүмүүсийг томилж, хязгаарлалт хийх үед нэн даруй хяналтыг хэрэгжүүлэх боломжтой байх ёстой.

Хөрөнгийн менежер, томилогдсон менежер эсвэл гэрээлэгч нь банкны данс, нягтлан бодох бүртгэлийн систем болон мэдээ баримт, бизнесийн чухал дата мэдээлэл (хэрэглэгчийн бүртгэл гэх мэт), үнэ цэнэ бүхий бараа материал, хөрөнгө, тоног төхөөрөмжийг нэн даруй хяналтандаа авах хэрэгтэй. Хэрэв бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахаар бол бүх нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн мэдээ баримт болон дэвтэрийг бэлэн байлгах шаардлагатай бөгөөд менежер эдгээр баримт мэдээллийг үнэлэх ёстой. Мөн түүнчлэн, менежерүүд нь ажилтнууд болон голлох мэргэжилтнүүдийн хэр найдвартай эсэх талаар эцсийн шийдвэрийг гаргахад өөрсдийгөө бэлтгэхийн тулд эдгээр ажилтнуудтай харилцах шаардлагатай болно. Ажилтныг халах нь зардал ихтэй байж болохоос гадна компанийн мэдлэгээ алдах, үйлчлүүлэгчид сэтгэл ханамжгүй болох, ажлаас үндэслэлгүй халсан гэсэн маргаан үүсэх, мөн бизнесээ алдахад хүргэж болзошгүй юм. Гэхдээ нөгөө талаас, зорилгодоо үнэнч ажилтнуудыг авч үлдэх нь бизнест аюул учруулж болно. Бизнесийн гүйцэтгэлийн талаарх тайланг хязгаарлах шийдвэрийг хариуцсан прокурорын байгууллагад тогтмол хүргүүлэх шаардлагатай. Бизнестэй холбоотой аливаа асуудлыг нэн даруй тодорхойлж хэлэлцэх хэрэгтэй.

Эцэст нь, бизнесийн орлогын урсгал хууль ёсны болон хууль бус үйл ажиллагаатай хоёулантай нь холбоотой бөгөөд хууль бус үйл ажиллагааг явуулахгүйгээр тухайн бизнес оршин тогтнох боломжгүй гэдэг нь тодорхой болсон үед үүсэх асуудлуудаас үл хөдлөх хөрөнгийн менежер сэрэмжтэй байх ёстой. Ийм тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн менежер нь тухайн бизнесийг хаах талаар шүүхийн шийдвэр гаргуулах арга замыг эрэлхийлж болно.

6.5.5 Мал аж ахуй болон фермерийн аж ахуй

Энэ ангилалд хамаарах хөрөнгө нь ихэвчлэн бизнесийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм: үхэр, хонь, агнуурын амьтад нь ихэвчлэн хөдөө аж ахуйн бизнесийн нэг хэсэг байдаг бол адууг үржүүлгийн эсвэл уралдааны зорилгоор ашигладаг. Мөн тухайн бизнес нь жижиг хэмжээний хобби фермерүүд байж болно. Бизнесийн хэлбэр ямар ч байсан гэсэн амьтдыг удирдах нь хөрөнгийн менежерүүдэд нэлээд хүндрэл бэрхшээлтэй байдаг.

Эдгээр хөрөнгө нь тодорхой зах зээл дээр маш өндөр үнэлгээтэй үед (жишээ нь, уралдааны морьд хэдэн зуун мянга, бүр хэдэн сая долларын үнэтэй байж болно) мэргэжилтнүүд тэднийг хязгаарлах шийдвэрт хамруулж оруулахыг илүүд үздэг. Гэхдээ нөгөө талаас амьтдыг асарч тэжээхэд хүнсний нөөц тэжээл, мал эмнэлгийн зардал, хашаа, бэлчээрийн арчилгаа, амьтан асрагч ажиллуулах зардал гээд маш өндөр зардал гарах боломжтой. Эдгээр зардлууд болон тэдгээрийг санхүүжүүлэх хангалттай орлогын эх үүсвэр байхгүй байх магадлалтай учраас зарим улс орнууд мал аж ахуй болон фермерийг хураан авахаас татгалздаг. Бусад улс орнуудад фермерийг хязгаарлалтад оруулж, дараа нь мал амьтдыг хураан авч зарах эрхтэй байдаг (эзний зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөлгүйгээр). Дахин хэлэхэд, сэжигтэн эсвэл түүний хамаарал бүхий этгээд хураан авах ажиллагааны явцад бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахыг хүсвэл бонд байршуулж болно.

6.5.6 Үнэт металл, үнэт эдлэл, урлагийн бүтээл

Хөрөнгийн менежерүүд эдгээр эд хөрөнгийг хадгалж хамгаалах журам процедурыг дагаж мөрдөхөөс гадна хяналт шалгалт, баталгаажуулалт, үнэлгээ хийх ур чадвар, туршлагатай байх эсвэл эдгээр эд хөрөнгийг хүлээн зөвшөөрөгдсөн төвүүдэд шалгаж үздэг байх шаардлагатай. Аюулгүй байдлыг хангасан тохиромжтой хадгалах байгууламжийг бэлтгэх эсвэл энэ асуудлыг хууль тогтоомж, журмаар зохицуулсан байх шаардлагатай.[16]

6.5.7 Хурдан мууддаг болон элэгдэлд ордог хөрөнгө

Энэ ангилалд ерөнхийдөө дараах төрлийн хөрөнгө багтана. Үүнд:

- *Маш хурдан мууддаг хөрөнгө*, тухайлбал, хэдхэн хоногийн дотор зарж борлуулахгүй бол бүх үнэ цэнээ алдах завь дүүрэн шинэ загас эсвэл тайрч ачсан цэцэгс гэх мэт;
- *Дунд зэргийн мууддаг хөрөнгө*, тухайлбал, тохиромжтой хугацаанд, магадгүй хэдэн долоо хоног, сарын дотор хурааж авахгүй бол үнэ цэнээ алдах тариалангийн ургац эсвэл фермерийн мал амьтад гэх мэт;

[16] Жишээ нь, Азербайжан Улсад хураан авсан алмазыг санхүүгийн байгууллагад хадгалж хамгаалах ёстой.

- *Элэгдэлд ордог хөрөнгө*, тухайлбал, жил бүр үнэ цэнээ 15-30 хувиар алддаг автомашин, усан онгоц, цахилгаан тоног төхөөрөмж гэх мэт.

Хөрөнгийн менежерт түргэн мууддаг эсвэл хурдан элэгддэг хөрөнгийг худалдан борлуулж, олсон орлогыг хөрөнгийн менежер эсвэл шүүхийн хяналтан дор хүү тооцож олгодог дансанд байршуулах эрх олгосон заалтуудыг хөрөнгийг хураан авах тухай хууль тогтоомжид тусгаж болно. Ийм эрх мэдэл олгоогүй эсвэл хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд хязгаарласан хөрөнгөтэй холбоотой зохих шийдвэрийг гаргах ерөнхий эрх мэдлээ хэрэгжүүлэхийг шүүхээс шаардаж болно. Бүх талууд зөвшилцөлд хүрэх нь илүү зохистой боловч маргаан гарсан ч гэсэн шүүхээс ийм шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх ёстой.

6.5.8 Гадаад улсад байгаа хөрөнгө

Хөрөнгийг албан бус тусламжаар (жишээ нь, захиргааны журмаар) эсвэл эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн дагуу гадаад улсад хязгаарлаж, хураан авч болно (Бүлэг 5-ын 5.3.3 дугаар хэсэг болон Бүлэг 8-д мөн авч үзсэн).[17] Хязгаарлах шийдвэрийг бүртгэж авсан тохиолдолд түүний хэрэгжилтийг гадаад улсын эрх бүхий байгууллага хариуцна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хөрөнгийн менежерийг гадаад улсын шүүхээс томилж болно.

Ерөнхийдөө, хоёр улсын харьяаллын хөрөнгийн менежерүүд тухайн хөрөнгийг хадгалж хамгаалах чиглэлээр хамтран ажиллана. Үүний зэрэгцээ, хүсэлт гаргасан улсын хөрөнгийн менежер нь гадаад улсын гаргасан хязгаарлах шийдвэр болон хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд туслах нэмэлт эрх мэдэлтэй байх нь илүү ухаалаг хэрэг юм. Ийм эрх мэдлийн хүрээнд хүсэлтийг хүлээн авсан улсад байгаа хөрөнгийг биетээр хяналтандаа авах эрхийг хөрөнгийн менежерт олгохгүй. Гэхдээ хүсэлтийг хүлээн авсан улсын шүүхийн шийдвэрийг олж авахын тулд тухайн улсад гэрээлэгч, хуульч болон бусад төлөөлөгчдийг хөлсөлж ажиллуулахыг хөрөнгийн менежерт зөвшөөрч болно.

Гадаад улстай харилцахад нэмэлт бэрхшээл асуудлууд үүсч болзошгүй байдаг. Хүсэлтийг хүлээн авсан улс нь тодорхой төрлийн хөрөнгийг хязгаарлах эсвэл хураан авах чиглэлээр дотооддоо эрх мэдэлгүй эсвэл үйл ажиллагааны чадамжгүй байж болно. Жишээ нь, зарим улс орнууд амьд амьтдыг хураан авахаас татгалздаг. Мөн түүнчлэн, хүсэлтийг хүлээн авсан улсад хөрөнгийн менежер эсвэл хөрөнгийг удирдахад зориулсан сан байхгүй байж болно. Эдгээр асуудлыг хүсэлтийг хүлээн авсан улстай хэлэлцээр хийх замаар шийдвэрлэх боломжтой хэдий ч эцсийн дүндээ

[17] Швейцар Улсын эрх баригчид 2016 онд Бүгд Найрамдах Франц Улсын эрх баригчдын хүсэлтийн дагуу Теодорин Обианг (Экваторын Гвиней Улсын дэд ерөнхийлөгч асан)-ийн мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд Женевт 25 тансаг зэрэглэлийн автомашиныг хураан авч байсныг энд дурдах нь зүйтэй. (энэ кейс жишээг Бүлэг 2-ын Шигтгээ 2.10 ба Бүлэг 3-ын Шигтгээ 3.5-т мөн авч үзсэн). Швейцар Улсын прокурорын байгууллагын мэдээлснээр хураан авсан бүх автомашиныг худалдан борлуулж, олсон орлогыг нь Обиангийн эх оронд хэрэгжсэн нийгмийн хөтөлбөрт зарцуулсан байна. Лорент Гиллиерон. 2019. "Женевийн прокурор Обиангийн хэргийг хааж, 25 тансаг зэрэглэлийн автомашиныг зарав." Швейцарийн мэдээ (swissinfo.ch)-г үзнэ үү, 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр. https://www.swissinfo.ch/eng/equatorial-guinea_geneva-prosecutor-closes-obiang-case--sells-off-luxury-cars-/44740962. Ричард Этьенний онцолж хэлснээр ийм зохицуулалт хийхэд төвөгтэй бөгөөд маргаантай байж болно. 2020. "Teodorin Obiang retrouve un de ses bolides confisqués a Genive, Economie" [Теодорин Обианг Женевт хураагдсан автомашиныхаа нэгийг олжээ]. Ле Темпс, 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр. https://www.letemps.ch/economie/teodorin-obiang-retrouve-un-bolides-confisques-geneve.

тухайн улсад хөрөнгийн менежер хөлсөлж ажиллуулах санхүүжилтийг хүсэлт гаргасан улсаас гаргах шаардлагатай болж болно.

6.6 Одоогийн менежментийн асуудлууд

6.6.1 Зардал

Тохиромжтой нөхцөлд хөрөнгийн менежер нь боломжит хөрөнгө (орлого бүрдүүлдэг, бэлэн мөнгө, капитал, элэгдэлд ордог хөрөнгө)-ийн багцад хяналт тавих бөгөөд улмаар олсон орлогоороо зардлаа төлөх замаар тухайн багцын нийт үнэлгээг хэвээр хадгалах, мөн хураан авах ажиллагааны үр дүн гарах хүртэл түүнийг хадгалж үлдэх хэрэгтэй. Гэхдээ заримдаа хөрөнгийг хадгалах эсвэл засвар үйлчилгээ хийх ажлыг санхүүжүүлэх бэлэн мөнгө эсвэл орлого байхгүй байж болно. Эдгээр тохиолдолд, хөрөнгийн менежер нь хөрөнгийг худалдан борлуулах эсвэл засвар үйлчилгээний төлбөрийг төлөхөд хангалттай санхүүжилтийг магадгүй сэжигтэн, эсвэл хураан авах ажиллагаа, хураан авах сангаас бүрдүүлэх аль нэг арга хэмжээг авах шаардлагатай. Эцэст нь, хөрөнгийн удирдлагын улсын албанаас ашигт ажиллагааг хангахыг шаардахаас илүүтэйгээр хураан авсан хөрөнгийн үнэ цэнийг хадгалахыг шаардах хэрэгтэй.

6.6.2 Их хэмжээний өр төлбөр

Зарим тохиолдолд хөрөнгийн менежер нь их хэмжээний өр төлбөртэй байгаа сэжигтэний хөрөнгөд хяналт тавьдаг. Хөрөнгийн менежер эдгээр өр төлбөрийг төлж барагдуулахын тулд бусад хязгаарласан хөрөнгийг чөлөөлөх эсвэл худалдан борлуулах хүсэлтийг шүүхэд гаргаж болно. Зээлдүүлэгчид ихэвчлэн шүүхийн шийдвэрээр барьцааг авахыг оролдох эсвэл дампуурлын хэрэг үүсгэх замаар хөрөнгө хураан авах эрх бүхий байгууллагын кейс хэрэгтэй өрсөлддөг.

Эдгээр нөхцөлд, хөрөнгийн менежер нь хураан авахтай холбоотой хууль тогтоомжийн заалтууд дампуурлын эсвэл компанийг татан буулгах тухай хууль тогтоомжтой хэрхэн холбогдож байгааг сайн ойлгох хэрэгтэй. Зарим улс оронд хувь хүн эсвэл компани дампуурал зарласан тохиолдолд дампуурлын эсвэл татан буулгах тухай хууль тогтоомжийг нэн түрүүнд хэрэгжүүлдэг бөгөөд хөрөнгийг хураан авах байгууллага нь бусад баталгаагүй зээлдүүлэгчидтэй хамт дараалалд ордог. Бусад улс орнуудад хөрөнгө хураан авахтай холбоотой хууль тогтоомж нь дампуурлын болон компанийг татан буулгах тухай хуулиудын үйлчлэлд хамаардаггүй бөгөөд ингэснээр хураан авах эрх бүхий байгууллага болон түүний шийдвэрийг бусад бүх зээлдүүлэгчийн нэхэмжлэлээс илүү давуу авч үздэг.

6.6.3 Амьжиргааны, хууль эрх зүйн болон бизнесийн зардал

Шүүхээс ихэвчлэн сэжигтэн болон түүний хамаарал бүхий этгээдийн амьжиргааны, хууль эрх зүйн болон бизнесийн зардалд зориулан хязгаарласан хөрөнгөөс санхүүжилт зарцуулах үүргийг хөрөнгийн менежерт өгдөг (энэ асуудлын талаар Бүлэг 7-ын “Гуравдагч этгээдийн ашиг сонирхол” гэсэн 7.5 дугаар хэсэгт мөн дурдсан). Ихэнх тохиолдолд, зардлыг хуулиар эсвэл шүүхээр тогтоодог хэдий ч тодорхой зорилгын хүрээнд буюу сэжигтэн шүүхэд гомдол гаргаж маргаан үүсгэх боломжтой үнэлгээний хувьд зардлын дүнг “үндэслэлтэй” тодорхойлоход заримдаа хөрөнгийн менежер оролцож болдог.

Эдгээр зардлыг төлөхтэй холбоотой маргаан шүүхийн өмнө байнга гардаг тул хөрөнгийн менежерүүд шийдвэрээ болгоомжтой гаргаж, эдгээр шийдвэр болон түүнтэй холбоотой аливаа гүйлгээг бүртгэж, баримтжуулах нь чухал юм.

6.6.4 Хураан авсан хөрөнгийг ашиглах

Хураан авсан боловч улсын орлого болгоогүй байгаа хөрөнгийг ашиглах нь ёс зүйн болон эдийн засгийн томоохон асуудлуудыг дагуулдаг. Ёс зүйн гол асуудал бол мэдээж ашиг сонирхлын зөрчил юм. Жишээ нь, прокурор, шүүгчид, хууль сахиулах албан хаагчид эсвэл цэргийн албан хаагчдыг хэргийн урьдчилсан шатанд хураан авсан аливаа тээврийн болон бусад хэрэгслийг тэр даруй ашиглахыг зөвшөөрсөн тохиолдолд тэдний хөрөнгө хураан авах ажиллагааг дуустал нь үргэлжлүүлж хөөцөлдөх сонирхол нь буурч болно. Улмаар шүүхийн шийдвэргүйгээр эд хөрөнгийн эзэмшигчийг үр дүнтэйгээр үүрд хохиролд оруулж болзошгүй юм. Мөн түүнчлэн, ийм түр арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хууль сахиулах байгууллагуудад шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэхгүйгээр хөрөнгийг хураан авах хүсэгүй хөшүүргийг бий болгодог.

Санхүүгийн хувьд мөн зардлын асуудал гардаг бөгөөд ялангуяа шүүхийн шийдвэрээр хөрөнгийг буцаан олгохыг шаардсан тохиолдолд үүсдэг. Хөрөнгийг ашиглах нь түүний үнэ цэнийг бууруулдаг тул тухайн улсын төрийн сангаас нөхөн төлбөр олгох шаардлагатай болдог.

6.7 Зөвшилцөх

Өмнө дурьдсанчлан хөрөнгийн менежерүүд санал болгож буй хязгаарлалт болон хөрөнгийн удирдлагын шийдвэрийн талаар бусад мэргэжилтнүүдтэй зөвшилцөх ёстой. Удирдлагын санал эсвэл шийдвэр нь хязгаарлалтад оруулсан хөрөнгийн үнэлгээнд нөлөөлж болзошгүй тохиолдолд зөвшилцөх нь үр ашигтай байж болно. Ингэж зөвшилцөх нь хөрөнгийг муу удирдсаны улмаас учирсан хохирлыг нэхэмжлэхээс хамгаалж болох бөгөөд ялангуяа эдгээр зөвшилцөлд сэжигтэн, хязгаарлах шийдвэрийг гаргуулсан мэргэжилтэн, болон ашиг сонирхол бүхий гуравдагч этгээд оролцсон тохиолдолд ач холбогдолтой. Зөвшилцөлд оролцсон бүх талуудын зөвлөгөөг бичгээр тэмдэглэн авч, нухацтай авч үзэх хэрэгтэй. Гэхдээ эцсийн дүндээ, хөрөнгийн менежерүүд шүүхийн удирдамжийн хүрээнд эцсийн шийдвэрийг гаргадаг.

6.8 Хөрөнгийг худалдан борлуулах

Хөрөнгийн менежерийг хязгаарлах шийдвэрийн дагуу хөрөнгөд хяналт тавихаар томилсон тохиолдолд энэ үүрэг нь ихэвчлэн хөрөнгийг хадгалах, засвар үйлчилгээ хийх, удирдлагаар хангах байдаг. Ихэнх тохиолдолд, хязгаарлалтад оруулсан хөрөнгийг худалдан борлуулах асуудлыг зөвхөн хурдан мууддаг болон элэгдэлд ордог хөрөнгөтэй холбоотойгоор эсвэл хураан авах шийдвэр гарсны дараа л авч үздэг. Мөн түүнчлэн, хөрөнгийг зарж борлуулах эрх мэдэл харилцан адилгүй байдаг. Зарим улс оронд хөрөнгийн менежерүүдэд хуулийн дагуу эрх олгосон байдаг бол бусад улс оронд шүүхээс тэдгээр хөрөнгийн менежерүүдэд хэрэгжүүлэх эрх мэдлийг олгосон тушаал гаргах ёстой.

Хэрэгжүүлэх эрх мэдлийн хүрээнд хөрөнгийг худалдан борлуулах тохиолдолд хөрөнгийн менежер ихэвчлэн процессын талаар шийдвэр гаргахдаа нэлээд өөрийн

үзэмжээр хандах боломжтой. Хөрөнгийн удирдлагыг муу хэрэгжүүлсэн гэх маргааныг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс хамгийн ил тод журам процедурыг ашиглах хэрэгтэй. Энэ шалтгаанд үндэслэн ерөнхийдөө зар сурталчилгаа сайтай, мэргэжлийн түвшинд зохион байгуулагддаг олон нийтийн дуудлага худалдаагаар хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулах нь хамгийн сайн арга юм. Заримдаа тусгайлсан эсвэл чамин төрлийн хөрөнгийг хориглодог. Эдгээр хөрөнгийг хамгийн өндөр үнэд хүргэхийн тулд төрөлжсөн зах зээлд борлуулах зэрэг аргуудыг ашиглах боломжтой. Энэ аргаар хөрөнгийг худалдан борлуулах шийдвэрийг гаргахдаа мэргэжилтний зөвлөгөөнд үндэслэх бөгөөд сайтар баримтжуулсан байх ёстой. Олон улс орнууд цахим дуудлага худалдаагаар эсвэл урьдчилан тогтоосон хамгийн бага үнийн саналаар борлуулдаг бусад цахим хуудсанд хөрөнгийн жагсаалтыг байршуулах замаар эдгээр зорилгыг хэрэгжүүлдэг.

6.9 Хөрөнгийн менежерт төлөх төлбөр

Зарим улс орнуудад хөрөнгийн менежерт төлөх төлбөрийн хэмжээг хураан авахтай холбоотой хууль тогтоомж эсвэл бусад хуулиуд (жишээ нь, хөрөнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл компанийг татан буулгах тухай хууль тогтоомж)-д иш татах байдлаар тодорхой заасан байдаг. Заримдаа эдгээр төлбөрийг шүүхийн шийдвэрээр хойшлуулдаг бөгөөд төлбөрийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тодруулгад тусгаж, заавал аудит хийлгэх шаардлагатай байдаг.

Хөрөнгийг хураан авахтай холбоотой хууль тогтоомжид ихэвчлэн хөрөнгийн менежерүүдийн төлбөрийг хураан авсан орлогоос тогтмол хувиар эсвэл үйлчилгээний хураамжид үндэслэн магадгүй цагийн хөлсөөр эсвэл төлбөрийн хуваарийн дагуу суутган тооцохоор заасан байдаг. Хөрөнгийн менежерүүд удаан хугацааны туршид хөрөнгийг удирдах шаардлагатай болдог тул менежерүүд өөрсдийн томилогдсон хугацаанд гарсан төлбөрийг тогтмол шинэчлэн бэлтгэж, хариуцсан прокурорт хүргүүлэх нь сайн туршлагад тооцогддог. Хэрэв тухайн шийдвэр эдийн засгийн үр ашиггүй байгаа тохиолдолд хуримтлагдсан төлбөр нь прокурорт сэрэмжлүүлэг болох бөгөөд засгийн газрын эрх бүхий байгууллагаар шууд удирдуулах зэргээр хөрөнгийн удирдлагын бусад аргуудын талаар авч үзэхийг санал болгодог.

Хөрөнгийн менежер маш их ажлыг хийж гүйцэтгэдэг боловч төлбөрийг суутгах боломжгүй нөхцөлд (жишээ нь, хураан авах ажиллагаа зогссон эсвэл амжилтгүй болсон тохиолдолд) хураан авах эрх бүхий байгууллагаас менежерийн төлбөрийг төлөх ёстой. Хураан авах сан нь хөрөнгийн удирдлагын зардлыг төлөх ашигтай хэрэгсэл байж болно. Сайн туршлагаас харахад хожим нь үл ойлголцол болон өндөр зардалтай маргаан үүсэхээс зайлсхийхийн тулд эдгээр асуудлыг прокурор, хөрөнгийн менежер, шүүхээр аль болох эрт авч хэлэлцэн, бичгээр тохиролцох хэрэгтэй.

Ном зүй

EC (European Commission). 2018. “Commission Implementing Decision of 10.8.2018 on the Preparatory Action for Support to EU Neighbours to Implement Asset Recovery to be Financed from the General Budget of the Union.” Document C(2018) 5142 final, EC, Brussels. https://ec.europa.eu/neighbourhood-enlargement/sites /near/files/c_2018_5142_preparatory_action_asset_recovery_merged.pdf.

FATF (Financial Action Task Force). 2012. "Best Practices on Confiscation (Recommendations 4 and 38) and a Framework for Ongoing Work on Asset Recovery." Best Practices Paper, FATF and Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Best%20Practices%20on%20%20Confiscation%20and%20a%20 Framework%20for%20Ongoing%20Work%20on%20Asset%20Recovery.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations." Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf /documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

G8 Lyon/Roma Group. 2005. "G8 Best Practices for the Administration of Seized Assets." Guidance document, Criminal Legal Affairs Subgroup, G8 Lyon/Roma Group. https://docplayer.net/16960901-G8-best-practices-for-the-administration-of -seized-assets.html.

Greenberg, Theodore S., Linda M. Samuel, Wingate Grant, and Larissa Gray. 2009. Stolen Asset Recovery: A Good Practices Guide for Non-Conviction Based Asset Forfeiture. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star/files / Non%20Conviction%20Based%20Asset%20Forfeiture.pdf).

Keatinge, Tom, David Carlisle, and Florence Keen. 2018. "Virtual Currencies and Terrorist Financing: Assessing the Risks and Evaluating Responses Study." Study for the European Parliament's Special Committee on Terrorism (TERR Committee), PE 604.970, commissioned by the Policy Department for Citizens' Rights and Constitutional Affairs, Directorate-General for Internal Policies, European Union, Managing Assets Subject to Confiscation I 179 Brussels. http://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2018/604970/IPOL _STU(2018)604970_EN.pdf.

Rijkers, Bob, Caroline Freund, and Antonio Nucifora. 2014. "All in the Family: State Capture in Tunisia." Policy Research Working Paper 6810, World Bank, Washington, DC. http://documents1.worldbank.org/curated/en/440461468173649 062/pdf/WPS6810.pdf.

UNODC (United Nations Office on Drugs and Crime). 2017. "Effective Management and Disposal of Seized and Confiscated Assets." Study, UNODC, Vienna. https://www.unodc.org/documents/corruption/Publications/2017/17-07000_ebook_sr.pdf.

Working Group on Asset Recovery (Open-Ended Intergovernmental Working Group on Asset Recovery). 2017. "Study Prepared by the Secretariat on Effective Management and Disposal of Seized and Confiscated Assets." Document CAC /COSP/WG.2/2017/CRP.1, Conference of the States Parties to the United Nations Convention against Corruption, Vienna. https://www.unodc.org/documents /treaties/UNCAC/WorkingGroups/workinggroup2/2017-August-24-25 /V1705952e.pdf.

World Bank. 2009. "Stolen Asset Recovery; Management of Returned Assets: Policy Considerations." Stolen Asset Recovery (StAR) initiative working paper, Report No. 55007, World Bank, Washington DC. https://documents.worldbank.org/en /publication/documents-reports/documentdetail/895271468332443748/stolen-asset-recovery-management-of-returned-assets-policy-considerations

7. Хураан авах механизм

7.1 Удиртгал

Авлига болон мөнгө угаасны улмаас бий болсон хууль бус орлогыг буцаан авах цогц арга хэрэгслийг нэвтрүүлэх хүсэлтэй аливаа улс орон эхлээд хөрөнгө хураан авах талаар ажиллагааг журамлаж зохицуулсан байх ёстой. “Хөрөнгө хураан авах” гэдэг нь шүүх болон эрх бүхий бусад байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авахыг хэлнэ гэж тодорхойлсон[1]. Хөрөнгийн эрх, гэрчилгээг улс өөрийн нэр дээр шилжүүлэн авах бөгөөд тэдгээрийг эзэмшиж байсан этгээдэд ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй.

Хөрөнгө хураан авах тогтолцоо нэн чухал болохыг олон улсын стандарт, удирдамжуудад онцгойлон зааж өгдөг бөгөөд авлига, мөнгө угаах, бусад ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэхийн тулд хамгийн багадаа эрүүгийн журмаар хөрөнгө хураан авах тогтолцоог нэвтрүүлсэн байх шаардлагатай гэж үздэг[2]. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц ба ФАТФ-ын Зөвлөмжүүд (ФАТФ 2019) шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахыг дэмждэг бөгөөд хөрөнгө хураан авах талаар зохицуулалтыг өргөжүүлж, уг зарчмыг хүлээн зөвшөөрөн шинээр нэвтрүүлж буй улс орны тоо өсөн нэмэгдсээр байна.[3] (Европын Холбоо [ЕХ]-ны гишүүн орнуудад хөрөнгө хураан авах зохицуулалтуудыг өргөжүүлэх зорилго бүхий ЕХ-ны 2014/42/EU тоот Тогтоолын талаар Шигтгээ 7.1.-ээс үзнэ үү).

Хөрөнгө хураан авах үндэслэл нь тодорхой юм: Нэгдүгээрт, хууль бус орлого бий болгож буй авлига, бусад гэмт хэрэг нь төр, Засгийн газар, эсхүл хувь этгээдэд хохирол учруулдаг тул тэдгээрт нөхөн төлбөр олгогдох ёстой. Хоёрдугаарт, эдгээр гэмт хэргийг үйлдэх үндсэн зорилго нь хууль бус орлого олох явдал байдаг тул хөрөнгийг хурааснаар ашиг шимийг нь хүртэх боломжгүй болгож улмаар урьдчилан сэргийлэх үр нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө хураан авах нь “гэмт хэрэг үйлдэж орлого олох боломжгүй” гэсэн ойлголтыг түгээдэг[4]. (Хөрөнгө хураан авах ажиллагааны түүхэн хөгжлийн талаарх нэмэлт мэдээллийг Шигтгээ 7.2-оос үзнэ үү).

---

[1] Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, 2-р зүйл, Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенц, 2-р зүйл, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц, 1-р зүйл.

[2] Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 2, 31, 54, 55; Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенц, 2, 6, 12, 13-р зүйл; Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц, 1, 5-р зүйл; ФАТФ (2019) -ын Зөвлөмж 4, 38

[3] Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, 54-р зүйл (1) (с); ФАТФ (2019) -ын Зөвлөмж 4

[4] Калей АНУ-ын эсрэг, 571 U.S. 320, 323 (2014), хөрөнгө хураах нь буруутныг шийтгэх, ирээдүйн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн байгууллагуудын эдийн засгийн хүчин чадлыг бууруулах, хохирогчдод нөхөн олговор олгох, гэмт хэрэгт өртсөн иргэдийн нөхцөл байдлыг сайжруулах, хууль сахиулах үйл ажиллагаа, үүний дотор цагдаа нарын сургалтыг дэмжих зэрэг үүрэг гүйцэтгэдэг гэж АНУ-ын Дээд шүүх тэмдэглэсэн.

ШИГТГЭЭ 7.1 Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураах, царцаах тухай ЕХ-ны Удирдамж, 2014 он

Европын холбоонд Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураах, царцаах тухай Европын холбооны 2014/42 тоот тогтоол нь авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг олон хэргийн тухайд хөрөнгө хураах энгийн болон үнэлгээнд суурилсан дэглэмийг хэрэгжүүлэх замаар гишүүн орнууд дахь хөрөнгө хураах дэглэмийг нь өөрчлөн шинэчлэх, өргөжүүлэх зорилготой.[a] Уг тогтоолд багтсан зарим чухал зүйлийг дурдъя:

- *Гэмт хэргийн улмаас олсон орлогын тодорхойлолтыг өргөжүүлсэн.* Гэмт хэргийн улмаас олсон орлого гэдэгт гэмт хэргийн шууд орлогоос гадна шууд бус орлогыг хамруулах болсон бөгөөд шууд орлогыг хожим дахин хөрөнгө оруулсан эсхүл өөрчлөн хувиргасан зэргийг багтаасан илүү өргөн тодорхойлолтыг баталсан. Тогтоолд зааснаар өөр өмч болгон өөрчилсөн, хувиргасан, мөн хууль ёсны хөрөнгөтэй хольсон өмч, хөрөнгийг гэмт хэргийг орлогод тооцож болно.[b]
- *Хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагаа.* Яллагдсан этгээд нь хууль ёсны орлогоос хэт давсан үнэлгээ бүхий өмчтэй, мөн шүүхээс уг өмчийг гэмт хэргийн үйл ажиллагаагаар олж авсан гэж дүгнэсэн тохиолдолд хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагааг ашиглана гэж уг Тогтоолд заасан.[c]
- *Яллах боломжгүй тохиолдол.* Сэжигтэн, буруутгагдсан этгээд өвчтэй эсхүл оргон зайлсан учир хөрөнгө хураах боломжгүй байгаа тохиолдолд "яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааны хязгаарлагдмал хувилбар" гэдэг ойлголтыг Тогтоолд шинээр нэвтрүүлсэн (Fazekas and Nanopoulos 2016). Хэрэг үүсгэгдсэн, мөн сэжигтэн, буруутгагдсан этгээд хэрэв зугтаагаагүй бол шүүхээс яллагдах байсан тохиолдлуудад гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураахад шаардлагатай нөхцөлийг гишүүн орнууд бүрдүүлэх ёстой гэж заасан.[d]
- *Гуравдагч талын эзэмшилд буй хөрөнгө хураах.* Шууд эсхүл зуучлагчаар дамжуулан шууд бусаар гуравдагч талд шилжүүлсэн, эсхүл гуравдагч талын худалдан авсан хөрөнгийг хураах заалтууд Тогтоолд тусгагдсан.[e] Тогтоолын дагуу хөрөнгө хураагдахаас зайлсхийх зорилгоор шилжүүлсэн, эсхүл худалдан авсан гэдгийг гуравдагч тал нь мэдэж байсан эсхүл мэдэх ёстой байсан тохиолдлуудад хөрөнгө хураах боломжтой байна.[f] Чин үнэнч гуравдагч талуудын эрхийг хэлбийж хөндөхгүй.[g]
- *Яаралтай арга хэмжээ.* Долдугаар зүйлд заасны дагуу, гишүүн орнуудын эрх бүхий байгууллагууд хураагдах магадлалтай хөрөнгийг хадгалан хамгаалах арга хэмжээ авах ёстой, үүнд "яаралтай арга хэмжээ" мөн хамаарна.[h] Хөрөнгө царцаах арга хэмжээ нь хөрөнгийг хадгалан хамгаалахад шаардлагатай бүхий л хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.[i]
- *Процедурын журам, хамгаалалт.* Хөрөнгө царцаах шүүхийн шийдвэрийг холбогдох этгээдэд зохих ёсоор хүргэх[j], мөн эрхээ хамгаалах боломжийг тухайн этгээдэд бүрдүүлж өгөхийн тулд шаардлагатай арга хэмжээг гишүүн орнууд авсан байх ёстой[k].

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 7.1	Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураах, царцаах тухай ЕХ-ны Удирдамж, 2014 он

- Статистик тоо баримт. Гэмт хэргийн орлогыг царцаах, хураахтай холбоотой баримт, мэдээлэл ховор байдаг. Хөрөнгө царцаах, хураах, өмч мөшгөн бүртгэх, шүүхийн үйл ажиллагаа явуулах болон хөрөнгө худалдах, борлуулах зэрэгтэй холбоотой статистик баримт мэдээллийг төвлөрсөн байдлаар цуглуулах хэрэгтэй.[l] Арваннэгдүгээр зүйлийн дагуу холбогдох байгууллагуудаас дэлгэрэнгүй статистикийг тогтмол цуглуулж хадгална. Үүнд дараах төрлийн мэдээлэл орно:
    - Царцаах шийдвэрийг хэрэгжүүлсэн тоо
    - Хураах шийдвэрийг хэрэгжүүлсэн тоо
    - Царцаасан хөрөнгийн баримжаалсан үнэ
    - Хураасан хөрөнгийн баримжаалсан үнэ
    - Бусад гишүүн орнуудад хэрэгжүүлэх хөрөнгө хураах хүсэлтийн тоо
    - Бусад гишүүн оронд гаргасан шийдвэрийн дагуу хураасан өмчийн үнэ эсхүл баримжаалсан үнэ

a. Европын Парламент ба Зөвлөлөөс 2014 оны 4-р сарын 3-ны өдөр гаргасан ЕХ-нд Гэмт хэргийн орлого, хэрэгслийг царцаах тухай Тогтоол
(OJ L 127, 29.04.2014), art. 3. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014L0042&from=EN.
b. Тогтоол 2014/42/EU, оршил, рага. 11; "орлого"-ын тодорхойлолт Зүйл. 1, догол мөр. 1.
c. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 5, догол мөр. 1.
d. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 4, догол мөр. 2.
e. Тогтоол 2014/42/EU, оршил, догол мөр. 24.
f. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 6, догол мөр. 1.
g. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 6, догол мөр. 2.
h. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 7, догол мөр. 1.
i. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 8, догол мөр. 3.
j. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 8, догол мөр. 2.
k. Тогтоол 2014/42/EU, Зүйл. 8, догол мөр. 1.
l. Тогтоол 2014/42/EU, оршил, догол мөр. 36–37.

Хөрөнгө хураахтай холбоотой хууль тогтоомж, практикт ажиглагдаж буй томоохон ач холбогдол бүхий чиг хандлагын нэг бол няцаагдах боломжтой презумпци буюу үндэслэл бүхий таамаг, дүгнэлтийг илүү өргөнөөр ашиглах болсон явдал юм (Шигтгээ 7.2.). Презумпци гэж бодит баталгаа үгүй нөхцөлд учир шалтгааныг магадлах, тунгаан бодох замаар тодорхой нөхцөл байдалд тулгуурлан баримт, таамаглалын үнэн болохыг тогтоосон гаргалгаа, дүгнэлт юм.

Төрийн албан хаагчдын авлигын хэргүүдэд гэмт үйлдэл болон шүүгдэгчийн өмчилж, эзэмшиж буй хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох бараг боломжгүй байдаг, эдгээр тохиолдолд презумпци нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх хугацаанд олсон баялаг, хөрөнгийн гарал үүслийг өөрөө тайлбарлаж чадахгүй нөхцөлд прокурорын байгууллагаас уг хөрөнгийн эх үүсвэр хууль бус болохыг нотлох шаардлагагүй болсон нь яллах ба хөрөнгө хураах шийдвэр гарах магадлалыг ихээхэн нэмэгдүүлж өгсөн.

Энэ салбарт ашигладаг бас нэг чухал хэрэгсэл бол хөрөнгийн үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах хэлбэр юм, үүнд гэмт хэргийн улмаас олсон ашиг хонжооны дүнг шүүх болон эрх бүхий байгууллагууд тооцоолж тухайн дүнд дүйцэх хөрөнгийг шүүгдэгчээс хураах шийдвэр гаргадаг.

Дотоод хууль тогтоомжийн хүрээнд прокурорууд хөрөнгө хураах олон арга хэрэгслийг хэрэгжүүлэх боломжтой байдаг, гэхдээ хөрөнгө хураахад хүндрэл учрах магадлал өндөр, мөн тодорхой нөхцөл байдлаас улбаалан аль нэг хэрэгслийг ашиглах боломжгүй болох эрсдэлтэй учир аль болох олон хувилбартай байвал зохистой. Жишээлбэл, нотлох баримтыг хүлээж авах боломжгүй болсон, эсхүл шүүгдэгч нас барсан тохиолдолд шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах хүсэлтийг давхар мэдүүлсэн байх нь хөрөнгө хураах боломжийг нээлттэй үлдээдэг. Олон арга хэрэгсэл, хувилбартай дэглэмд эрх бүхий байгууллагууд нуугдмал хөрөнгийн олох, битүүмжлэхэд нэг аргыг, хөрөнгө хураахад өөр аргыг ашиглах боломжтой байдаг.[5]

Энэ бүлэгт улс орнууд хөрөнгө хураах шийдвэр гаргахдаа авдаг тодорхой алхмууд, процедурын арга хэрэгслийг авч үзэв. Хөрөнгө хураахтай холбоотой бусад асуудлын талаарх мэдээллийг Бүлэг 3-6 болон 8-9-өөс үзнэ үү.

ШИГТГЭЭ 7.2 Хөрөнгө хураах тухай хууль тогтоомжийн түүхэн хөгжил ба сүүлийн үеийн чиг хандлага

Хөрөнгө хураах концепци олон жилийн түүхтэй. Олон мянган жилийн өмнөх хуулийн баримт бичгүүдэд хөрөнгө хураах жишээнүүдийг дурдсан байдаг. Эдгээр эртний хуулиудаас өвлөгдөн ирсэн хөрөнгө хураах хуулиуд Английн хуулийн тогтолцоо, Эх газрын эрх зүйн тогтолцооны аль алинд нь шингэн тусгагдсан.[a] 1980-аад онд мансууруулах бодисын наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлт нэмэгдэх хэрээр зарим улс орнууд эрүүгийн журмаар хөрөнгө битүүмжлэх, мөн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

Сүүлийн жилүүдэд хууль бус ашиг орлогыг хураах хүчин чармайлтыг нэмэгдүүлэх болсон, учир нь гэмт хэргийн үйл ажиллагааны хүрээнд олдог ашиг, орлого маш өндөр байхад хураасан хөрөнгийн хэмжээ төдийлөн их биш байгаа юм. Үүнээс улбаалан хөрөнгө хураах хууль тогтоомжид шинээр дараах чиг хандлага ажиглагдах болсон. Үүнд:

- Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах заалтыг нэвтрүүлсэн
- Хөрөнгө хураах үнэлгээнд суурилсан аргачлалыг хөгжүүлсэн
- Нотлох баримтын стандартыг бууруулсан
- Зарим нөхцөлд нотлох шаардлагаас чөлөөлсөн (амьдралын хэв маягтай холбоотой зөрчил, тайлбарлаж чадахгүй баялаг гэх мэт тохиолдол хамаарна, энэ талаар бүлэг 3, шигтгээ 3.11-т авч үзсэн)[b]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[5] АНУ-д хууль тогтоомжийн хүрээнд шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахдаа яллах дүгнэлт гарахаас өмнө хөрөнгийг “түр хураах”, “битүүмжлэх” арга хэмжээ авдаг бөгөөд хэрэв шүүхийн шийтгэх тогтоол гарсан бол эрүүгийн журмаар хөрөнгө хураах ажиллагаа руу шилждэг. United States v. Candelaria-Silva 166 F.3d 19, 43 (1st Cir. 1999) хэргийг харна уу. Энэ нь салбарын мэргэжилтнүүд нотлох баримтын үндсэн дээр албан ёсны яллах дүгнэлт гарахаас өмнө хөрөнгийг түр хураах, битүүмжлэх хүсэлтэй байдагтай холбоотой. Гэсэн хэдий ч, ерөнхийдөө яллах дүгнэлт гарсны дараа эрүүгийн хэргээр оноох ял шийтгэлийн нэг хэсэг болгон хөрөнгө хураах шийдвэр гаргуулах нь илүү хялбар байдаг. Үүний нэгэн адил Колумбид хөрөнгө хураах тогтолцооны дагуу шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах ажиллагаа эрүүгийн хэргээс тусдаа, бие даасан байдлаар явагдах боломжтой. Гэхдээ хэрэгтэн шийтгэгдсэн тохиолдолд эрүүгийн журмаар хөрөнгө хураах ажиллагаагаа хийх нь шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах ажиллагааг дуусгахаасаа илүү хялбар байдаг.

ШИГТГЭЭ 7.2	Хөрөнгө хураах тухай хууль тогтоомжийн түүхэн хөгжил ба сүүлийн үеийн чиг хандлага

- Презумпцийг илүү өргөнөөр ашиглах болсон (шигтгээ 7.7)
- Гэмт хэргийн бэлэн мөнгө, бусад хэрэгслийг шүүхийн бус буюу захиргааны аргаар хураах тохиолдол нэмэгдсэн.

a. Италийн гэмт хэрэг судлаач Цезаре Бекариа (Cesare Beccaria, 1738–94) 1764 оны "Dei delitti e delle pene" (Гэмт хэрэг, ял шийтгэл) хэмээх алдартай бүтээлдээ хөрөнгө хураах талаар бичиж байсан: "Цөлөөд, дээр нь хөрөнгө хураах нь дан цөллөгт явуулахаас илүү их ял шийтгэл болдог, тиймээс үйлдсэн гэмт хэргээс хамааран баялгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хураах тохиолдлууд байж болно, эсхүл огт хураахгүй ч байж болно" (Panzavolta 2017, 27).
b. Нигерийн дарангуйлагч Сани Абача ба түүний гэр бүлийн эсрэг үүсгэгдсэн хэргийн хүрээнд Швейцар нотлох үүргийг эсрэгээр ногдуулсан, улмаар царцаасан байсан хөрөнгийг хууль ёсны замаар олсон гэдгээ Сани Абача ба түүний гэр бүлийн гишүүд нотлох хэрэгтэй болсон бөгөөд хожим нь ийнхүү нотолж чадаагүй (FDFA 2016, 20), https://www.eda.admin.ch/dam/eda/en/documents/aussenpolitik/voelkerrecht/edas-broschuere-no-dirty-money_EN.pdf.

7.2 Хураан авах журам

Авлигын орлого, хэрэгслийг хураан авах гурван төрөл байдаг, үүнд эрүүгийн журмаар, яллах шийдвэргүйгээр, мөн зарим улс орнуудын хувьд захиргааны журмаар хөрөнгө хураах зэрэг хамаарна. Зарим оронд холимог тогтолцоо ашиглаж болдог, үүнд шүүхэд нэхэмжлэл гаргах, тусгаарлах зэрэг иргэний хуулийн арга хэмжээг эрүүгийн ажиллагаанд авч ашиглан хөрөнгө хураадаг.

7.2.1. Эрүүгийн журмаар хөрөнгө хураах

Эрүүгийн журмаар яллаж хөрөнгө хураахын тулд шүүхээр хэлэлцэж яллах шийдвэр гаргуулсан эсхүл шүүгдэгч гэм буруугаа хүлээж зөвшөөрсөн байх ёстой байдаг. Яллах дүгнэлт нэгэнт гарсан хойно шүүхээс хөрөнгө хураах эцсийн шийдвэр гаргадаг, ихэнх тохиолдолд энэ нь шүүгдэгчид ногдуулсан ялын нэг хэсэг байдаг. Зарим улс орнуудад хөрөнгө хураах нь шүүхийн шийдвэрт заавал ордог бол зарим улсад шүүх эсхүл тангарагтны шүүх уг асуудлыг өөрийн үзэмжээр шийддэг.[6] Эрүүгийн журмаар хөрөнгө хураах нь өмчид суурилсан, үнэлгээнд суурилсан, эсхүл хослуулсан байж болдог (эдгээрийн талаарх дэлгэрэнгүйг дэд бүлэг 7.3-т оруулсан).

Зарим улс оронд (тухайлбал, яллах үйл явц, хөрөнгө хураах үйл явц гэх мэт) хэргийн хоёр үе шатанд эд мөрийн баримтын тухайд өөр өөр стандартууд ашиглаж болдог. Яллах ажиллагааны тухайд эрүүгийн стандартын дагуу тавигддаг нотолгоо, эд мөрийн баримтыг бүрдүүлж шүүгдэгчид яллах дүгнэлт гаргуулах нь прокурорын хувьд хамгийн чухал асуудал байдаг, үүнд нийтийн эрх зүйн тогтолцоотой улс оронд "үндэслэл бүхий сэжиг", харин эх газрын эрх зүйн тогтолцоонд "**бодит үнэнийг тогтоох**" зарчмыг ашиглаж болно. Гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг нотлохын тулд эд мөрийн баримт, нотолгооны энэ стандартыг эхний ээлжид хангасан байх ёстой, үүний дараа хөрөнгө хураах асуудал яригдана.

[6] Камерунд, жишээлбэл, зарим авлигын хэргүүдийн тухайд заавал хөрөнгө хураах арга хэмжээ авдаг: Камеруны Эрүүгийн хууль, 184 (4), төрийн мөнгө, хөрөнгө завших тухай заалтад "бүх тохиолдолд" хөрөнгө хураах арга хэмжээ авна гэж заасан байдаг.

Хөрөнгө хураах ажиллагааны тухайд эд мөрийн баримт, нотолгооны өөр стандарт мөрдөгдөж болох хэдий ч хөрөнгө хураах асуудлыг хэлэлцэх явцад үйлдсэн хэрэг, хураах хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох зэрэг нэмэлт шаардлагыг шүүхээс тавьж болно. Зарим улс оронд ийм хоёрдогч шаардлагыг хангахад нотлох баримтын стандартын "магадлалын тэнцвэр" доогуур байхыг зөвшөөрдөг бол зарим улс орнуудад эрүүгийн яллах ажиллагаа, хөрөнгө хураах ажиллагаанд яг ижил түвшний нотлох баримт шаарддаг.[7]

Яллах шийдвэр гарсан байх шаардлага үйлчилж байгаа нөхцөлд хэрэгтэн нас барсан, өөр орон руу зугтсан, эсхүл өөр ямар нэг шалтгаанаар шүүхээр орох боломжгүй болсон тохиолдлуудад хөрөнгө хураахад бэрхшээлтэй болдог. Хэрэгтэн оргон зайлсан гэдэг нь тогтоогдсон бол зарим улс орнуудад холбогдогчийн эзгүйд шүүх хурлыг явуулдаг, эсхүл хөрөнгө хураах зорилгоор хэрэгтэнг "яллагдсанд" тооцдог болсон.[8]

7.2.2. Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах (заримдаа "иргэний журмаар" хөрөнгө хураах гэгддэг) нь яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах эрх олгодог.[9] Ихэнх тохиолдолд энэ нь хөрөнгийг эзэмшиж, өмчилж буй этгээдийн эсрэг бус өмчид суурилсан тухайн хөрөнгийн эсрэг ажиллагаа байдаг тул яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагаанд тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан

---

[7] Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад ихэнх тохиолдолд "үнэн зөвд итгэх итгэл" стандарт байдаг.

[8] Жишээлбэл, Их Британийн Гэмт хэргийн улмаас олсон орлогын тухай 2002 оны хуулийн 28-р хэсэгт яллагдахаас өмнө оргон зайлсан этгээдийн талаар тусгасан байдаг. Оргон зайлснаас хойш 2 жил өнгөрсөн бол хөрөнгө хураах шийдвэр гаргаж болдог. (Гэмт хэргийн улмаас олсон орлогын тухай 2002 оны хуулийн тайлбар [2018 оны 9-р сарын 22-нд хандсан http://www.legislation.gov.uk/ukpga/2002/29/notes/division/5/2/4?view=plain).

[9] Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг зөвшөөрдөг улс орнуудыг жишээг Бүлэг 1, тайлбар 7-с үзнэ үү. Эдгээрт Ирландын Гэмт хэргийн улмаас олсон орлогын тухай 1996 оны хууль, Словенийн 2011 онд батлагдаж 2012 онд хүчин төгөлдөр мөрдөгдөх болсон Хууль бус үүсэл гарал бүхий хөрөнгийг хураах тухай хуулийг дурдаж болно. Иргэний журмаар яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааны тодорхой хэлбэрүүдийг Болгар, Словак, Грек, Латви, Литва, Нидерланд, Румын, Испани зэрэг орнуудад "баялгийг тайлбарлаж чадахгүй" байгаа хязгаарлагдмал хүрээний хэргүүдийн тухайд хэрэглэж байна (ЕС 2016, 13–14).

гэдгийг нотлоход л хангалттай байдаг;[10] үүнд холбогдогч этгээдийн эсрэг яллах шийдвэр гарсан, үгүй нь хамаагүй.[11]

Ийм төрлийн хөрөнгө хураалт хоёр арга замаар явагддаг. Эхнийх нь эрүүгийн ажиллагааны хүрээнд явагддаг, гэхдээ яллах шийдвэр гарах, гэм буруутайг нотолсон байх шаардлага тавигддаггүй.[12] Энэ тохиолдолд яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хуулийг одоогоор үйлчилж буй Эрүүгийн хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, эсхүл өөр бусад эрүүгийн хууль тогтоомжид нэгтгэн оруулдаг бөгөөд "эрүүгийн" ажиллагааны нэг хэсэг гэж үзэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хамааруулдаг. Эрүүгийн ажиллагаанаас тусдаа, бие даасан байдлаар эсхүл зэрэгцээ ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлсэн бие даасан хууль гаргаж хөрөнгө хураах нь яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хоёрдох арга зам юм. Энэ нь эрүүгийн гэхээсээ илүүтэйгээр иргэний бөгөөд захиргааны журмаар явагдах нь элбэг байдаг.[13]

Иргэний журмаар хөрөнгө хураах зарчим ашигладаг улс орнуудад нотлох баримтын стандартын "магадлалын тэнцвэр" эсхүл "нотлох баримтын давамгай байдал" доогуур байхыг зөвшөөрдөг тул өмч, хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг прокурор нотлох үүрэг, шаардлагыг бууруулж өгдөг. Гэхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн, мөн өмчийг гэмт хэргийн улмаас олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан гэдгийг нотлох шаардлага тавигдсан хэвээр байдаг. Нотлох баримт нь эрүүгийн журмаар яллах дүгнэлт гаргахад хангалтгүй нөхцөлд улс хөрөнгө хураах шийдвэр гаргаж болдог. (Бранн ба бусад

2015, xi). Хөрөнгө хураах ийм төрөл бүх улс оронд байдаггүй. Байдаг улс орнуудад, төр иргэний журмаар шүүх ажиллагаа явуулдаг (Brun ба бусад. 2015, 4; Cassella 2015). Малайзын Хөгжлийн сан (1Malaysia Development Berhad)-аас шамшигдуулсан

---

[10] Бразил, Филиппинд харин хөрөнгө хураах тогтолцоо нь цэвэр өмчид суурилсан биш, учир нь эрх бүхий байгууллагууд хөрөнгийн эсрэг бус харин холбогдогч этгээдийн эсрэг шийдвэр гаргуулж болдог. Мөн Антигуа, Барбуда, Австрали зэрэг орнууд үнэлгээнд суурилсан яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг өмчид суурилсан хөрөнгө хураах ажиллагааны хажуугаар нэмэлтээр ашигладаг.

[11] Жишээлбэл, Германд Эрүүгийн хуульд (76 а) хэрэв холбогдогч этгээдийн яллаж, яллах шийдвэр гаргуулж чадаагүй нөхцөлд хөрөнгө хураах шийдвэрийг тусад нь гаргаж болдог. Энэ заалтыг зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэлдэхтэй холбоотой янз бүрийг гэмт хэргүүдийн тухайд хэрэглэж болно. Гэмт хэргээс олсон орлогын тухай Эрүүгийн хуулийг шинэчлэх тогтоолыг шинээр батлснаар Европын холбооны Тогтоол 2014/42/EU Германы хуулийн тогтолцооны нэг хэсэг болж, 2017 оны 7-р сард хүчин төгөлдөр болсон. Хөрөнгө хураах шийдвэр гаргахад шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн тухай бүрийн нотлох баримт шаардах шаардлагагүй, харин тодорхой хөрөнгийн үүсэл гарал нь гэмт хэргийн шинж чанартай гэж дүгнэх юм бол хөрөнгө хураах шийдвэр гаргах эрхтэй болсон. (CMS Law-Now. 2017. "Герман: Шинэ хууль батлагдсанаар гэмт хэргийн орлогыг хураахад илүү хялбар боллоо." eAlert, July 11, 2017 [хандсан огноо 8-р сарын 5, 2018]. https://www.cms-lawnow.com/ealerts/2017/07/germany-new-law-makes-confiscating-proceeds-of-crimes-easier). Энэхүү заалтыг анх 2018 оны 7-р сард хэрэглэж зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотой 10.8 сая ам.долларын үнэлгээ бүхий 77 үл хөдлөх хөрөнгийг Германы эрх баригчид хураасан. (Ben Knight. 2018. "Берлины прокурорууд Ливаны мафийн хөрөнгийг хураав." DW.com, July 19, 2018 [хандсан оноо 9-р сарын 13, 2018]. https://www.dw.com/en/berlin-prosecutors-confiscate-lebanese-mafias-properties/a-44742961).

[12] Жишээлбэл, Лихтенштейн, Словени, Швейцар, Тайланд

[13] Жишээлбэл, Колумб, Өмнөд Африк, Их Британи, АНУ. "Иргэний журмаар хөрөнгө хураах" нь энэ тогтолцоонд хамаарна.

хөрөнгөтэй холбоотойгоор АНУ-аас үүсгэсэн иргэний журмаар хөрөнгө хураах хэргийн талаар Шигтгээ 7.3-т оруулав.

ШИГТГЭЭ 7.3 Малайз: 1Малайзын Хөгжлийн сангийн хэрэгт хийсэн иргэний журмаар хөрөнгө хураах ажиллагаа

Ерөнхий мэдээлэл: 100 хувь Малайзын төрийн эзэмшилд байдаг үндэсний хөрөнгө оруулалтын сан болох Малайзын Хөгжлийн сангаас завшсан хөрөнгийг угаах олон улсын зохион байгуулалттай хэрэгтэй холбоотой 1 тэрбум ам. долларын хөрөнгийг эргүүлэн олж авах зорилгоор АНУ 2016, 2017 онуудад иргэний журмаар хөрөнгө хураах хэд хэдэн нэхэмжлэл гаргасан (энэ талаар Бүлэг 2, Шигтгээ 2.7-д мөн дурдсан).[a] Уг хөрөнгө оруулалтын санг олон улсын түншлэл бүрдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах замаар эдийн засгийн хөгжлийг дэмжиж, Малайзын ард түмний амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор Малайзын Засгийн газар үүсгэн байгуулсан. Уг зорилгын төлөө ажиллахын оронд сангийн албан тушаалтан, албан хаагчид, мөн тэдгээрийн садан төрлийн холбоотой этгээдүүд сангийн 4.5 тэрбум орчим ам. доллартой тэнцэх хөрөнгийг Сингапур, Швейцар, Люксембург, АНУ зэрэг улс орнуудад банкны данстай хуурамч халхавч компаниудаар дамжуулан шат дараалал бүхий ярвигтай олон хэлцэл хийх замаар завшсан.[b]

Хөрөнгө хураах ажиллагаа: Хөрөнгийг АНУ-аар дамжуулан угаасан гэж үзсэн. АНУ-ын Хууль зүйн яам уг ажиллагаа "Эрх мэдлээ урвуулан ашиглах замаар хулгайлсан хөрөнгийг буцаах, хураах тухай санаачилгын хүрээнд хийгдсэн түүхэн дэх хамгийн том арга хэмжээ болсон" гэж мэдэгдсэн.[c]

2017 оны 8-р сард Хууль зүйн яамнаас холбооны улсын эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааны шийдвэр гарах хүртэл иргэний журмаар хөрөнгө хураах ажиллагааг түр зогсоох хүсэлт гаргасан.[d]

Малайзын Хөрөнгө оруулалтын сангаас завшсан мөнгөөр худалдан авсан гэгдэх АНУ дахь хөрөнгөд Нью Йорк, Лос Анжелес, Лондон дахь өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, зочид буудал, 35 сая америк долларын үнэлгээ бүхий тийрэлтэт онгоц, 300 фунтын тансаг зэрэглэлийн усан онгоц, Винсент ван Гог, Пабло Пикассо, Клод Моне зэрэг зураачдын уран зураг, EMI Music компанийн дуу хөгжим нийтлэх эрхийн ихээхэн хэмжээний хувь, 2013 оны Уолл Стритийн чоно киноны продакшн эрх, Палантир технологийн компани, Флайуилл фитнес компаниудын хувьцаа, Лас Вегас дахь казинод мөрийтэй тоглосон зардал, нийт 27.3 сая гаруй америк долларын очир эрдэнийн гоёл чимэглэл зэрэг багтсан.[e]

Хөрөнгө хураах тохиролцоо: 2019 онд Хууль зүйн яам буруутгагдаж буй этгээдүүдийн нэг болох Лоу Таек Жо (болон түүний гэр бүлийн гишүүд)-гийн авсан 700 сая гаруй ам. долларын үнэлгээ бүхий хөрөнгийн тухайд тохиролцоонд хүрсэн.[f]

2020 онд Хууль зүйн департамент бас нэг шүүгдэгч болох Кадем ал-Кубайси-гийн эсрэг үүсгэгдсэн иргэний журмаар хөрөнгө хураах хэргийн тухайд тохиролцоонд хүрсэн. Тохиролцооны нөхцөлийн дагуу хөрөнгийг удирдах эрхтэй байсан Atlantic Property Trust компани хураах шийдвэр гаргуулахаар хүлээгдэж байсан 49 сая ам. долларын үнэлгээ бүхий хөрөнгийг хураалгахыг зөвшөөрсөн. Дээрх хөрөнгөд Беверли Хиллз дэх өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, Нью Йорк хот дахь тансаг зэрэглэлийн пентхаус зэргийг худалдсан орлого багтсан, эдгээр хөрөнгийг Малайзын Хөрөнгө оруулалтын сангаас завшсан мөнгөөр худалдаж авсан гэж үзсэн.[g]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 7.3 Малайз: 1Малайзын Хөгжлийн сангийн хэрэгт хийсэн иргэний журмаар хөрөнгө хураах ажиллагаа

Өмнөх хөрөнгө хураах ажиллагаатай нийлээд нийт 1 тэрбум гаруй ам. долларын үнэлгээ бүхий хөрөнгийг хураасан, улмаар уг хөрөнгө оруулалтын сангийн хэрэгтэй холбоотой хөрөнгө хураах ажиллагаа нь АНУ-ын Хууль зүйн яамнаас хийгдэж байсан, мөн "Эрх мэдлээ урвуулан ашиглах замаар хулгайлсан хөрөнгийг буцаах, хураах тухай санаачилга"-ын хүрээнд хийгдсэн томоохон арга хэмжээнүүдийн нэг болсон.[h] 2020 оны 10-р сард Голдман Сакс АНУ-ын Хууль зүйн яамтай хойшлуулан яллах гэрээ байгуулж, уг гэрээний хүрээнд Голдман Сакс 2.9 тэрбум гаруй ам. доллар төлөх үүрэг хүлээсэн, үүнийг АНУ болон бусад улсуудад эрүүгийн болон иргэний эрх бүхий байгууллагууд хамтран гаргасан шийдвэрийн хүрээнд хийсэн.[i]

a. Хууль зүйн яам, 2016. "United States Seeks to Recover More than $1 Billion Obtained from Corruption Involving Malaysian Sovereign Wealth Fund." Press Release no. 16-839, July 20, 2016. https://www.justice.gov/opa/pr/united-states-seeks-recover-more-1-billion-obtained-corruption-involving-malaysian-sovereign. Гэхдээ Wall Street Journal ба Sarawak Report (энэ хэргийг илчлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн Лондонд төвтэй эрэн сурвалжлах вэбсайт) гэх мэт хэвлэлийнхний олж авсан Малайзын Ерөнхий Аудиторааас гаргасан нууц тайлангаас үзвэл Малайзын Хөгжлийн сангаас алдагдсан хөрөнгийн хэмжээ 7 тэрбум ам.доллар ч байж болзошгүй тухай мэдээлсэн байдаг. (SarawakReport. 2016. "1MDB Auditor General's Report." SarawakReport.org, 7-р сарын 14, 2016. http://www.sarawakreport.org/1mdb-report-summary-eng/.) Хууль зүйн яам. 2017. "U.S. Seeks to Recover Approximately $540 Million Obtained from Corruption Involving Malaysian Sovereign Wealth Fund." Press Release no. 17-655, June 15, 2017. https://www.justice.gov/opa/pr/us-seeks-recover-approximately-540-million-obtained -corruption-involving-malaysian-sovereign.
b. Хууль зүйн яам, "U.S. Seeks to Recover Approximately $540 Million," 6-р сарын 15, 2017.
c. Хууль зүйн яам, "United States Seeks to Recover More than $1 Billion," 7-р сарын 20, 2016.
d. Edvard Pettersson. 2017. "Stolen 1MDB Funds Are Focus of U.S. Criminal Investigation." Bloomberg, August 10, 2017. https://www.bloomberg.com/news/articles/2017-08-10/stolen-imdb-funds-are-focus-of-u-s-criminal-investigation.
e. Хууль зүйн яам, "Documents and Resources from the July 20, 2016 Press Conference Announcing Significant Kleptocracy Enforcement Action to Recover More than $1 Billion Obtained from Corruption Involving Malaysian Sovereign Wealth Fund" (archived documents regarding the 1MDB civil forfeiture complaints). https://www.justice.gov/archives/kleptocracy-enforcement-action.
f. Хууль зүйн яам. 2019. "United States Reaches Settlement to Recover More than $700 Million in Assets Allegedly Traceable to Corruption Involving Malaysian Sovereign Wealth Fund." Press Release no. 19-1,176, 10-р сарын 30, 2019. https://www.justice.gov/opa/pr/united-states-reaches-settlement-recover-more-700-million-assets-allegedly-traceable.
g. Хууль зүйн яам. 2020. "United States Reaches Settlement to Recover More than $49 Million Involving Malaysian Sovereign Wealth Fund."Press Release no. 20-431, 5-р сарын 6, 2020. https://www.justice.gov/opa/pr/united-states-reaches-settlement-recover-more-49-million-involving -malaysian-sovereign-wealth.
h. Хууль зүйн яам, "United States Reaches Settlement," 5-р сарын 6, 2020.
i. https://www.justice.gov/opa/pr/goldman-sachs-charged-foreign-bribery-case-and-agrees-pay-over-29-billion

Зарим улс орнууд эрүүгийн журмаар хөрөнгө хураах ажиллагааны арга хэрэгслийг бүрэн ашиглаж шавхсан эсхүл амжилтгүй болсон нөхцөлд л яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах журмыг ашигладаг. Бусад орнуудад, эрүүгийн ажиллагаа хийгдэж дуустал яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг түр зогсоодог.[14]

Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах журам олон нөхцөл байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг, тухайлбал а) хэрэгтэн нас барсан, өөр орон руу зугтсан, эсхүл

[14] Иргэний ажиллагааны хүрээнд шүүн хэлэлцэх боломж олгох (гэрчээс мэдүүлэг авах, байцаалт авах, нийтэд дэлгэх шийдвэрээр баримт бичиг олж авах гэх мэт) нь эрүүгийн ажиллагааны үйл явцад сөргөөр нөлөөлөх боломжтой.

яллагдахгүй байх дархан эрхтэй,[15] b) хөрөнгийг олсон ба өмчлөгч нь тодорхойгүй, c) эрүүгийн журмаар шийтгэхэд нотлох баримт хангалтгүй эсхүл эрүүгийн хэрэг үүсгэгдээд гэм буруугүй гэж үзсэн зэрэг байж болно.

Өмч гуравдагч талын өмчлөлд байгаа, мөн эрүүгийн томоохон ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд эрүүгийн хэргээр албан ёсны шийдвэр гарах хүртэл хөрөнгийг царцах, хураах шаардлагатай тохиолдлуудад ийм төрлийн хөрөнгө хураах журам их хэрэг болдог. Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудад ийм тохиолдолд хязгаарлах шийдвэр гаргахын зөвшөөрдөг, харин нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудад хязгаарлах шийдвэр гарснаас хойш тодорхой хугацааны дотор албан ёсоор яллахыг шаарддаг.[16]

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах тогтолцоо нь эрүүгийн журмаар хөрөнгө хураах журмыг орлох зорилгыг агуулдаггүй.[17] Яллаад, яллах шийдвэр гаргах боломжтой тохиолдлуудад яллах нь зөв зохистой бөгөөд эрүүгийн журмаар хөрөнгө хураах үр дүнтэй, мөн эдийн засгийн хувьд үр ашигтай механизм прокуроруудад байх ёстой. Гэхдээ хөрөнгө хураах эрүүгийн ажиллагааны хажуугаар яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах тогтолцоог улс орнууд мөн давхар нэвтрүүлэх нь зүйтэй, ингэснээр өөрийн эрх зүйн тогтолцоонд нийцсэн хөрөнгө хураах нэмэлт хэрэгсэлтэй болж хөрөнгө хураах ажиллагааг амжилттай явуулах үндэс бүрдэнэ. Шигтгээ 7.4-т яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах механизм илүү оновчтой байх тохиолдлуудыг авч үзсэн.

7.2.3. Захиргааны журмаар хөрөнгө хураах

Захиргааны журмаар хөрөнгө хураахад шүүхийн шийдвэр шаардлагагүй байж болдог, гэхдээ улс орноос хамааран зарим тохиолдолд шүүхээр орох шаардлагатай байдаг. Аль нэг тал хөрөнгө хураахыг эсэргүүцээгүй, мөн тодорхой (жишээлбэл, талуудад мэдэгдэл хүргүүлсэн, хэвлэн нийтэлсэн, мөн сөрөг нэхэмжлэл ирээгүй гэх мэт) шаардлагууд хангагдсан нөхцөлд түгээмэл ашигладаг. Үүнээс гадна, захиргааны журмаар хураах хөрөнгийн үнийн дүнд дээд хэмжээ заах, эсхүл төрөл зүйлийн жагсаалт гаргах гэх мэтээр захиргааны журмын үйлчлэх цар хүрээг

[15] АНУ First Merit банкнаас хураасан 506069.09 ам.долларын эсрэг 664 F. App'x 422 (6th Cir.2016) хэргийн материалаас үзвэл, жишээлбэл, Саид Жавед Ахтар-Заиди (Syed Jawed Akhtar-Zaidi) эмч, түүний эхнэр ба Охайо өвчин намдаах эмнэлгийн эсрэг төр иргэний журмаар хөрөнгө хураах хэрэг үүсгэсэн. Эмч өөрийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хамаарахгүй эм бодисын жорыг зохих хууль ёсны үндэслэлгүйгээр олгодог байсан гэж үзсэн. Эм, бодис борлуулснаас олсон бохир орлогыг тэр бээр өөрийн, эхнэрийн мөн эмнэлгийн нэр дээрх янз бүрийн дансанд холин байршуулж, дараа нь янз бүрийн хөрөнгө оруулалтын болон тэтгэврийн данснууд руу шилжүүлсэн. Төр Заиди, түүний эхнэр болон эмнэлгийн нэр дээрх 13 дансанд дахь 4.8 сая ам.долларын хөрөнгө, 90 мянган ам.долларын үнэлгээ бүхий 139 ширхэг гоёл чимэглэлийн эд зүйлсийг хураах ажиллагаа мэдүүлсэн. Мөрдөн шалгах үйл ажиллагаа эхлүүлснийг мэдэнгүүт Заидигийн гэр бүл АНУ-аас гарсан. Давж заалдах шатны шүүх Дүүргийн шүүхийн шийдвэрийн хэвээр үлдээсэн.

[16] Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах зайлшгүй шаардлагатай тохиолдлуудын жагсаалтыг Rui and Seiber (2015)-аас үзнэ үү.

[17] Тунис ял шийтгэлийн бус хөрөнгө хураах тухай хуулийг эцэслэн гаргасан. Авлига болон бусад ноцтой гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгийг битүүмжлэх, хураахтай холбоотой төрийн хүчин чармайлтыг хурдасгана гэж үзсэн (EC 2018, 8).

хязгаарлах заалтуудыг хуульд суулгадаг.[18] Захиргааны журмаар хөрөнгө хураах дэглэмийн хуулиудад зохих шийдвэрийг шүүхээс гаргах заалт оруулах нь түгээмэл байдаг.

ШИГТГЭЭ 7.4 ИБУИНВУ: Хөрөнгө хураах ажиллагааны үед прокурорын эдлэх бүрэн эрхийн талаар удирдамж

Эрүүгийн ажиллагаа, мөрдөн байцаах ажиллагаа нь гэмт хэрэг бууруулах хамгийн үр дүнтэй арга гэж ИБУИНВУ-ын Ерөнхий прокурорын газраас гаргасан "Хөрөнгө хураах тухайд прокуроруудад олгогдсон эрх мэдэл" удирдамжид дурдсан байна.[a] Үүний хажуугаар 2002 оны ИБУИНВУ-ын Гэмт хэргийн улмаас олсон орлогын тухай хуулиар яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах эрх мэдлийг прокуроруудад давхар олгосон ба уг эрх мэдлийг дараах нөхцөлд ашиглахад оновчтой байдаг, үүнд:[b]

- Яллах шийдвэр гаргуулах боломжгүй
- Яллах шийдвэр гарсан ч, хөрөнгө хураах шийдвэр гараагүй эсхүл
- Зохих эрх бүхий байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэснээс яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах нь олон нийтийн эрх ашигт илүү нийцнэ гэж үзсэн.

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах нь илүү тохиромжтой тохиолдлууд: Яллах шийдвэр гаргуулах боломжгүй учир яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хууль тогтоомжийг ашиглах боломжтой дараах тохиолдлуудыг уг удирдамжид онцолсон байна, гэхдээ зөвхөн эдгээр тохиолдлоор хязгаарлагдахгүй гэдгийг дурдах нь зүйтэй.[c] Үүнд:

- Гэмт хэрэг өөр улс оронд үйлдэгдсэн
- Тухайн хэрэгт холбогдох амьд сэжигтэн байхгүй
- Гэмт хэргийн орлогыг хэргийн сэжигтэнтэй холбох боломжгүй
- Нотлох баримт нь яллах шийдвэр гаргуулахад хангалтгүй
- Яллах ажиллагааны эцэст яллах шийдвэр гаргуулж чадаагүй

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах нь олон нийтийн эрх ашигт илүү нийцэх тохиолдлууд: Яллах шийдвэр гаргуулах боломжтой хэдий ч яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хууль тогтоомжийг ашиглах нь олон нийтийн эрх ашигт илүү нийцэх дараах тохиолуудыг уг удирдамжид оруулсан, гэхдээ зөвхөн эдгээр тохиолдлоор хязгаарлагдахгүй гэдгийг дурдах нь зүйтэй. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг зогсоохын тулд яаралтай арга хэмжээ авах шаардлагатай
- Гэмт хэрэгт дам холбогдсон бүх этгээдийг мөрдөн шалгах нь зохимжгүй
- Ихээхэн хэмжээний өмч хөрөнгөтэй хүний тухайд иргэний журмаар хөрөнгө хураах ажиллагаа нь илүү тохиромжтой
- Хэрэгтэн өөр улсад яллагдсан бөгөөд гэмт хэргийг бүхэлд нь хамрах хэмжээний ял шийтгэл хүртсэн

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[18] АНУ-д 500,000 ам.долларoос доош үнэ бүхий хөрөнгийг үнийн дүнгээс үл хамааран заавал шүүхийн замаар хураах ёстой. Унгарт, хууль бус аргаар олсон аливаа хөрөнгийг татварын хэргийг хэлэлцэх шүүхээр дамжуулан хураах боломжтой (EC 2016, 14).

ШИГТГЭЭ 7.4	ИБУИНВУ: Хөрөнгө хураах ажиллагааны үед прокурорын эдлэх бүрэн эрхийн талаар удирдамж

a. Ерөнхий Прокурорын газар - Attorney General's Office, "Прокурорын хөрөнгө хураах эрх мэдэл: Удирдамж 2009" (guidance for prosecutorsand investigators on their asset recovery powers under Section 2A of the Proceeds of Crime Act 2002) (Introduction, para. 1),11-р сарын 29, 2012 (хандсан огноо - 9-р сарын 22, 2018), https://www.gov.uk/guidance/asset-recovery-powers-for-prosecutors-guidance-and-background-note-2009.
b. Ерөнхий Прокурорын газар, "Asset Recovery Powers" (Удиртгал, 5 дахь догол).
c. Ерөнхий Прокурорын газар, "Asset Recovery Powers" (Удиртгал, 5 дахь догол).

Захиргааны журмаар шүүхийн бус замаар хөрөнгө хураах нь Гаалийн тухай хууль, Мансууруулах бодис тээвэрлэх, валют хил дамжуулан тээвэрлэхтэй холбоотой хуулиудыг хэрэгжүүлэхэд хамаатай, мөн эдгээр хуулиудаас үүдэлтэй байдаг. Тухайлбал, хориотой бараа бүтээгдэхүүн тээвэрлэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, тээвэрлэгчийн биед байсан бэлэн мөнгийг хураахад уг заалтыг ашигладаг. Эдгээр тохиолдлуудад хуулийг хэрэгжүүлэх эрх мэдлийг цагдаагийн ажилтан, гаалийн ажилтнуудад олгодог. Ийм үйл явц ашиглах нь хурдан бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай.

7.3 Хураан авах ажиллагаа хэрхэн явагддаг вэ?

Хөрөнгө хураахад а/ хөрөнгөд суурилсан (тодорхой хөрөнгийг зааж өгдөг), эсхүл б/ үнэлгээнд суурилсан (тодорхой этгээдийн төлөх ёстой үнийн дүнг зааж өгдөг) хоёр аргачлалыг ашигладаг. Зарим улс орнууд энэ хоёр аргачлалыг аль алийг нь ашигладаг бөгөөд олж тогтоосон хөрөнгийг нь хураах, мөн холбогдогч этгээдийн хууль ёсны өмч хөрөнгөөс хохирлыг барагдуулах шийдвэр гаргуулдаг.

Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд нийтлэг зүйлс их бий. Гэхдээ ашиглаж буй журам, үйл явц, мөн орлогыг хураахад тавигддаг нотлох баримт, эд мөрийн баримтын шаардлага, стандартууд нь ялгаатай. Энэ хэсэгт эдгээр ялгааг авч үзье.

7.3.1. Өмч, хөрөнгөд суурилсан хөрөнгө хураах явц

Өмч, хөрөнгөд суурилсан тогтолцоо ("in rem" хөрөнгө хураалт буюу "бохир өмч"-ийг хураах гэдэг) нь гэмт хэргийн аргаар олсон орлого, хэрэгсэлтэй холбоотой хөрөнгөд чиглэсэн. Үүнд тухайн өмч хөрөнгө, гэмт хэрэг хоорондын хэлхээ холбоог олж тогтоосон байх ёстой.

Өмч хөрөнгөд суурилсан хөрөнгө хураах ажиллагааг хөрөнгө нь гэмт хэргийн нотолгоо, эд мөрийн баримт болж холбогдсон нөхцөлд ашиглахад хамгийн тохиромжтой байдаг, тухайлбал, авлига авсан этгээдээс хураасан мөнгө (гэмт хэргийн орлого), эсхүл авлига өгөх зорилгоор их хэмжээний бэлэн мөнгө тээвэрлэхэд ашигласан тээврийн хэрэгсэл (гэмт хэргийн хэрэгсэл) байж болох юм.

Харин сэжигтэн этгээд нь гэмт хэргийн үйл ажиллагаанд шууд оролцоогүй, эсхүл гэмт хэргээс мөнгө угаах замаар холдсон гэх мэт өмч хөрөнгө болон гэмт хэрэг хоорондын шууд холбоог тогтоох боломжгүй тохиолдлуудад хөрөнгө хураах ийм төрлийн аргачлалыг ашиглахад хүндрэлтэй. Авлигад автсан дэглэм өнө удаан жил эрх барьсан, мөн удаан хугацаанд ямар ч хариуцлага хүлээгээгүй, төр хувийн

хэвшил өөр хоорондоо сүлбэлдсэн орчинд үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой өмч хөрөнгө хоорондох хэлхээ холбоог тогтооход нэн хүндрэлтэй байдаг, энэ нь 2011 онд Египет болон Тунис улсуудад явуулсан хөрөнгө хураах ажиллагааны явцад тодорхой ажиглагдсан. Зарим улс орнуудад ийм саад бэрхшээлийг даван туулах зорилгоор эрх зүйн нэмэлт заалтууд баталж өгсөн, тухайлбал үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах, өмч хөрөнгийг орлуулах, хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагаа ашиглах зэрэг зохицуулалтуудыг дурдаж болно ("Хөрөнгө хураах ажиллагааны нэмэлтүүд" дэд бүлгийн үзнэ үү). Өөрөөр нотолж чадаагүй нөхцөлд гэмт бүлэглэл, байгууллагын гишүүдийн өмчилж буй хөрөнгө нь уг байгууллагатай шууд холбоотой гэж бусад улс орнуудад үздэг. Ийм төрлийн хууль тогтоомж нь хулгайн хөрөнгийг буцаахад их хэрэг болдог.

Хураагдах ёстой хөрөнгө, хэрэгслийг хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсон, мөн тэдгээрийг шүүх хэрхэн тайлбарлаж байгаа нь хөрөнгө хураах жагсаалтад чухамхүү ямар хөрөнгийг оруулах шийдвэрт чухал нөлөө үзүүлдэг. Хуульд орсон тодорхойлолтыг хэрхэн тайлбарласан нь гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураахад ямар нөлөө үзүүлдэг жишээ, үүнтэй холбоотой үүсдэг асуудлуудыг дараагийн хэсэгт оруулав.[19]

Шууд ба шууд бусаар олсон орлого

Ерөнхийдөө, "гэмт хэргээс олсон орлого" гэдэг нь гэмт хэрэг үйлдэх замаар шууд ба шууд бусаар олсон эсхүл авсан аливаа эд хөрөнгийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг[20]. Үүнд, гэмт хэргээс өөр замаар олох боломжгүй байсан өмч хөрөнгийг гэмт хэргийн орлого гэж үздэг, өөрөөр хэлбэл "өөрөөр боломжгүй" гэдэг шалгуурыг өргөн хэрэглэдэг.

"Шууд орлого" гэдэгт албан тушаалтан авлигаар авсан мөнгө, эсхүл төрийн хөтөлбөр, төсвөөс хулгайлсан мөнгийг хамруулан ойлгоно. Гэмт хэрэгтэй шууд холбоогүй "шууд бус орлого" гэдэгт авлигаар авсан мөнгийг банканд хадгалуулсан дансанд тооцогдох хүү, хөрөнгийн үнэлгээний өссөн дүн, хулгайлсан хөрөнгөөр худалдан авсан хувьцааны багц зэргийг багтаана. Шууд бус орлого гэдэгт мөн гэмт хэрэг үйлдэгдээгүй байсан бол олохгүй байсан бусад дайвар ашиг хонжоог мөн хамааруулна.

Холилдсон орлого

Гэмт хэргийн орлогыг угаахад тухайн орлого нь гэмт хэргийн бус бусад хөрөнгөтэй холилдох, мөн өөр төрлийн хөрөнгө болон хувирах боломжтой (Шигтгээ 7.5.). Ингэснээр эдгээр өмч хөрөнгө нь шууд утгаар гэмт хэргийн орлого биш харин гэмт

[19] 1993-98 онуудад Нигерийн Сани Абачагийн дэглэмийн хугацаанд хулгайлсан хөрөнгийг буцаахад Швейцарийн ийм төрлийн хууль тогтоомж их хэрэг болсон. (4 дүгээр бүлгийн [Шигтгээ 4.4] болон 5 дугаар бүлгийн [Шигтгээ 5.4]).-ийг харна уу.

[20] Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 2, Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенц, зүйл 2, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 1 гэх мэт НҮБ-ын Конвенцуудад заасан "гэмт хэргээс олсон орлого"-ын тодорхойлолтыг дийлэнх улс орнууд авч ашигладаг. Эдгээр Конвенцуудад "гэмт хэргээс олсон орлого" гэж гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон эсхүл авсан аливаа эд хөрөнгийг хэлнэ гэж заасан.

хэргийн орлоготой холилдсон өмч хөрөнгө болно[21]. Хууль тогтоомжид ийнхүү холилдсон тохиолдлуудад хураах хөрөнгийг, жишээлбэл, дараах байдлаар тодорхойлсон байдаг, үүнд:

- *"Аливаа хөрөнгө эсхүл хөрөнгийн хэсэг"* эсхүл *"хууль бус орлогыг хувирган өөрчилсөн[22] аливаа хөрөнгө эсхүл хөрөнгийн хэсэг"* гэсэн нь өөр хөрөнгөтэй холилдсон гэмт хэргийн орлогыг ялган тусгаарлахад шүүхэд тус болдог.
- *"Гэмт хэргийн улмаас үүдсэн, олсон, биежсэн"* хөрөнгө эсхүл *"дийлэнхдээ гэмт хэргийн улмаас үүдсэн, биежсэн"* хөрөнгө гэж тодорхойлсноор гэмт хэргийн орлого нь гэмт хэргийн бус орлоготой холилдсон ч орлого гэдэгт хамааруулж тооцох үндэс бүрддэг. "Дийлэнхдээ үүдсэн" гэж тодорхойлох нь гэмт хэргийн улмаас олсон зарим орлогыг хураах боломжгүй нөхцөл үүсгэх боломжтой. Жишээ нь, үл хөдлөх хөрөнгө, эсхүл урлагийн үнэтэй бүтээл худалдаж авахад үнийн зөвхөн 10 хувийг хууль бус орлогоос бүрдүүлсэн байвал шүүхээс тухайн хөрөнгө нь "дийлэнхдээ авлигын гэмт хэргээс үүдсэн" гэж шийдвэрлэж чадахгүй.
- *"Орлого нь холилдсон аливаа хөрөнгө"* гэсэн томьёолол нь хамгийн өргөн цар хүрээтэй, үүнд холилдсон бүх хөрөнгийг хамааруулна.[23] Ийнхүү тодорхойлсон тохиолдолд, онолын хувьд 999 ам.долларын үлдэгдэлтэй дансанд гэмт хэргийн улмаас олсон 1 ам.доллар хийхэд тухайн данс бүхэлдээ бохир хөрөнгөд тооцогдож нийт дүнг тэр чигээр нь хураах эрх үүснэ.
- *"Гэмт хэргийн орлоготой холилдсон бүхий л хэрэгсэл"*. Зарим улс орнуудад мөнгө угаахад оролцсон банкны дансыг гэмт хэргийн хэрэгсэл гэж үзэн бүхэлд нь хураахыг зөвшөөрдөг.
- Жишээ нь, сэжигтэн нь гэмт хэргийн орлогыг өөр бусад хөрөнгөтэй холиод *мөнгө угаасан бол мөнгө угаах гэмт хэрэгт "холбогдсон" өмч, хөрөнгийг* хурааж болдог, учир нь холилдсон хөрөнгийг мөнгө угаах гэмт хэрэгт "холбогдсон" гэж үзэх үндэслэлтэй.[24]

---

[21] Хувиргасан, холилдсон хөрөнгийг хураах боломжийг төр бүрдүүлэх ёстой гэж олон улсын гэрээнүүдэд заасан. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 31 (4)-(5); Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенц, зүйл 12 (3)-(4); Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 5 (6) (a)-(b).

[22] Жишээлбэл, БН Азербайжан Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, бүлэг 99-1.1.3-ыг үзнэ үү, уг хуулийг 2017 оны Эрүүгийн хуулийн хүрээнд баталсан.

[23] Ийм төрлийн заалтыг нэг жишээ бол Өмнөд Африкийн Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай 1998 оны хуульд "хууль бус үйл ажиллагааны орлого" гэдгийг тодорхойлохдоо "хууль бус үйл ажиллагаанаас олсон орлоготой холилдсон" өмч хөрөнгийг батгаан ойлгоно гэж заасан.

[24] United States v. Bikundi, 926 F.3d 761 (D.C. Cir. 2019) хэргийн материалаас үзнэ үү, үүнд орлогыг гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон гэдгийг нуун дарагдуулах зорилгоор цэвэр ба бохир хөрөнгийг хольж хутгасан бол хөрөнгийг мөнгө угаах зөрчилд оролцсонд тооцож банкны дансанд байршиж буй цэвэр мөнгийг хураах боломжтой гэж дүгнэсэн. Мөн Энэтхэгийн Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх тухай 2002 оны хуулийн бүлэг 23-д "мөнгө угаах явцад нэг ба түүнээс дээш холбоотой хэлцлүүд хийгдсэн, мөн эдгээр хэлцлүүдийн нэг ба түүнээс дээшхийг нь мөнгө угаахад оролцсон гэдгийг эд мөрийн баримтаар нотолсон" бол өөрөөр нотлох хүртэл "хэлцлүүдийн бусад хэсгийг холбоотой хэлцлүүдийн нэг хэсэг гэж дүгнэнэ" гэж заасан. (https://enforcementdirectorate.gov.in/PreventionOfMoneyLaunderingAct2002.pdf?p1=1208271601217172513).

ШИГТГЭЭ 7.5	Хууль бус орлоготой холилдсон хөрөнгийг хураахад тулгардаг асуудлууд: Хэргийн жишээ

Ноён Х нь төрийн санхүүжилттэй гэрээ олгох явцад нөлөө үзүүлж 100,000 ам.долларын авлига бэлэн мөнгөөр авсан төрийн албан хаагч. Уг хөрөнгийг угаах зорилгоор хэд хэдэн шилжүүлэг, хэлцлүүд хийгдсэн:

- Ноён Х авлигын мөнгийг эхнэрийнхээ нэр дээрх банкны дансанд байршуулсан.
- Өөр улсад байдаг хуульчийн траст данс руу мөнгийг шилжүүлэх зааврыг Ноён Х эхнэртээ өгсөн. Ноён Х-гийн итгэмжлэлээр уг хуульчийн эзэмшдэг трастын дансанд 900,000 ам.доллар байсан, үүсэл гарал нь тодорхойгүй.
- Ноён Х хуульчид заавар өгч ноён Х-гийн хяналтад байдаг хөрөнгө оруулалтын компанийн нэр дээр 1 сая ам.долларын үнэтэй үл хөдлөх хөрөнгө худалдан авах заавар өгсөн.
- Гурван жилийн дараа ноён Х худалдаж авсан хөрөнгөө 2 сая ам.долларoор борлуулж орлогыг нь өөрийн улсад байгаа өөрийн хяналтад байдаг данс руу шилжүүлсэн.

Эдгээр авлигын хэргийг ил болгоход прокурорууд хөрөнгөд суурилсан хөрөнгө хурааан авах ажиллагаа явуулахдаа 2 сая ам.доллартой банкны данснаас гэмт хэргийн орлогод хамаарах 200,000 ам.долларыг хураах шийдвэрийг гаргуулсан. Хураан авах дүнг дараах байдлаар тооцоолсон:

100,000 ам.доллар - авлигаас шууд олсон орлого. Хөрөнгө нь өөр хөрөнгөтэй холилдож өөр хэлбэртэй болсон нь гэмт хэргийн шууд орлого гэдэг мөн чанарт нөлөө үзүүлэхгүй

+100,000 ам.доллар – байшин борлуулснаас үүдсэн авлигын орлогод ногдох ашиг (хоёр дахин өссөн) – авлигын хэргийн шууд бус орлого= 200,000 ам.доллар – гэмт хэргийн орлого

Хэрэв хуульд "гэмт хэргийн орлоготой холилдсон аливаа өмч хөрөнгө" гэж заасан байсан бол банкны дансанд байсан нийт дүн буюу 2 сая ам.долларыг хураах нөхцөл бүрдэх байсан. Түүнчлэн мөнгө угаахад ашигласан хэрэгсэл гэдэг үндэслэлээр банкны дансанд байсан бүх үлдэгдлийг хураах аргачлал байж болно.

Гадаад улсад үйлдэгдсэн гэмт хэргийн орлого

Авлига, бусад гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлогыг нэг улсад олоод өөр улсад хөрөнгө оруулах тохиолдол түгээмэл байдаг. Гадаадад үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон орлогоор худалдан авсан хөрөнгийг хураахыг дийлэнх улс орны хөрөнгө хураах хуулиуд зөвшөөрдөг, үүнд авлига авсан төрийн албан хаагч, эсхүл төрийн өмчийг завшсан этгээдүүд хамаарна.

Зарим улс орны хуулиар гадаадад үйлдэгдсэн гэмт хэрэг нь аль аль улсынх нь хуулиар хууль бусд тооцогддог байхад хангалттай байдаг.[25] Зарим орнуудад ноцтой гэмт хэргийн жагсаалтыг тодорхой гаргаж баталсан байдаг нь хөрөнгө хураах үндэслэл болдог, тухайлбал гадаадаас авлига авах, мансууруулах бодис тээвэрлэх, хүчирхийллийн гэмт хэрэг гэх мэт.

[25] Жишээлбэл, ИБУИНВУ-ын 2002 оны Гэмт хэргийн орлогын тухай хуулийн бүлэг 241; мөн Лихтенштейны Эрүүгийн хуулийн бүлэг 20.b(2) -ээс үзнэ үү.

Гэмт хэргийн хэрэгсэл

“Хэрэгсэл” гэж гэмт хэрэг үйлдэх, үйлдэхэд туслахад ямар нэг хэлбэрээр ашигласан, ашиглахаар завдсан хөрөнгийг хэлдэг, жишээлбэл, өгөх зорилгоор их хэмжээний бэлэн мөнгө тээвэрлэж явсан тээврийн хэрэгсэл байж болно. Хууль ёсны эх үүсвэрээр хууль дүрмийн дагуу худалдан авсан байсан ч тухайн хөрөнгө гэмт хэргийн хэрэгсэлд тооцогдож болно. Тухайн хөрөнгийг хууль бус зорилгоор ашигласан учир гэмт хэргийн хэрэгсэл гэж үзэх үндэслэл бүрдэж байгаа юм.[26]

Салбарын мэргэжилтнүүдийн тухайд анхаарч үзэх асуудал бол “ашигласан” гэдгийг тодорхойлолт юм – үүнийг хуулийн заалтад суулгаж тодорхойлсон байх уу, эсхүл тухайн хэрэгтэй холбоотой шийдвэрлэх үү гэдэг асуудал. Жишээлбэл, авлигачин авлига авахаар нэг байранд байсан утас ашиглан мөнгөө хэрхэн дамжуулж авах талаар тохирсон бол тухайн байр нь гэмт хэрэг үйлдэхэд “ашигласан” гэж үзэхэд хангалттай үндэслэл болж чадах эсэх нь эргэлзээтэй байж болох. Өөр нэг жишээ дурдвал, авлигачин албан тушаалтныг зугаацуулахад ашигласан дарвуулт онгоц байж болох юм.

Гэмт хэрэг болон хөрөнгө хооронд санамсаргүй, тохиолдлын чанартайгаас илүү хүчтэй хэлхээ холбоо байхыг зарим орны шүүхээс шаарддаг: гэмт хэрэг нь тухайн хөрөнгөтэй холбоотой, хамааралтай, тухайн хөрөнгөгүйгээр үйлдэгдэх боломжгүй, эсхүл тухайн хөрөнгийг ашигласнаас шууд үүдсэн байх ёстой.[27] Бусад улс орнуудын шүүх хөрөнгийг ямар байдлаар гэдэг нь хамаагүй “гэмт хэрэгтэй холбоотойгоор” “ашигласан” л бол хөрөнгө хураах үндэслэл болно гэж үздэг.

Дийлэнх улс орнуудад хэрэгслийг хураахад Үндсэн хууль, хуулийн заалтуудын хязгаарлалтууд үйлчилдэг, үүнд үйлдэгдсэн гэмт хэргийн хүнд болон хураах хөрөнгийн хэмжээ хэт ялгаатай байж болохгүй.[28]

7.3.2. Үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах явц

Тодорхой хөрөнгөд чиглэсэн өмчид суурилсан хөрөнгө хураах ажиллагаанаас ялгаатай нь үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах ажиллагаа нь гэмт хэргийн улмаас олсон ашиг, орлогын үнийн дүнд анхаардаг ба тухайн дүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн хариуцлага ногдуулдаг. Ийм тогтолцоонд гэмт хэргийн сэжигтэн нь үйлдсэн гэмт хэргээс олсон ашиг хонжоо (шууд ашиг хонжоо) болон хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэнээс үүдсэн ашиг хонжоо (шууд бус ашиг хонжоо)-г тоогоор илэрхийлдэг. Ял шийтгэл ногдуулах үед яллагдагчийн хүртсэн ашиг хонжоотой дүйцэхүйц хэмжээний төлбөр барагдуулах шийдвэрийг шүүхээс гаргадаг. Уг шийдвэрийг хэрэгжүүлэх явцад яллагдагчийн эзэмшдэг ямар ч хөрөнгийг өр барагдуулах, торгууль ногдуулахад ашиглаж болдог, үүнд тухайн хөрөнгө нь гэмт хэрэгтэй холбоотой эсэх нь хамаагүй. Холбогдох хөрөнгийг дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээд, хувь хүн эзэмшиж байгаа нөхцөлд шүүхийн шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар салбарын мэргэжилтнүүд бодолцож үзэх

[26] Гадаадад үйлдэгдсэн гэмт хэргийн орлогыг хураах шийдвэр гаргах зөвхөн зургаан ангиллыг АНУ-ын хууль оруулсан байдаг. 18 U.S.C. § 1956(c)(7)(B)-аас үзнэ үү.

[27] 1986 оны Эмийн бодис буруугаар ашиглах тухай хууль [1988] 2 Qd. R. 506 (Австрали)-ийг хэрэглэх тухай

[28] АНУ-д хэрэгсэл нь гэмт хэрэгт “ихээхэн хэмжээгээр холбоотой” байсан, мөн хэрэгслийг хураах арга хэмжээ болон зөрчлийн хүнд өөр хоорондоо хэт ялгаатай биш гэдгийг аль алиныг нь төр нотлох ёстой. 18 U.S.C. §§ 983(c)(3) ба (g)-с үзнэ үү.

хэрэгтэй (Бүлэг 10, дэд бүлэг 10.5-д төлбөрийн чадваргүй болсон талаар хэлэлцсэн байгаа).

Тодорхой хөрөнгийг гэмт хэрэгтэй холбох шаардлагагүй болсноор хөрөнгө хураах шийдвэр гаргуулахад салбарын мэргэжилтнүүдэд илүү хялбар болдог. Гэхдээ сэжигтэнд яллах дүгнэлт гаргуулахын тулд ашиг хонжоо нь гэмт хэргээс үүдэлтэй гэдгийг тогтоосон байх ёстой. Үүнээс гадна хөрөнгө нь гагцхүү яллагдагчийн өмчлөлд буй хөрөнгөөр хязгаарлагддаг, гэхдээ "өмчлөл" гэдэгт яллагдагчийн өмчилж, эзэмшиж, хяналтдаа байлгаж буй, бэлэглэсэн зэрэг бүх хөрөнгийг хамааруулан ойлгох замаар үүнийг шийдэж болдог (Бүлэг 5, дэд бүлэг 5.4.1-ээс хөрөнгийг тодорхойлох асуудлыг үзнэ үү).

Өмчид суурилсан хөрөнгө хураах ажиллагаатай нэгэн адил гол нэр томьёоны тодорхойлолт, тайлбарууд нэн чухал. Шүүх хурлын явцад гардаг зарим асуудлыг дор авч үзэв.

Ашиг, хонжоог үнэлэх

"Ашиг хонжоо" гэдэгт гэмт хэргийн улмаас яллагдагчийн (эсхүл яллагдагчийн удирдамжийн дагуу гуравдагч этгээдийн) шууд болон шууд бусаар хүлээн авсан бэлэн мөнгөний эсхүл бэлэн бүс мөнгөн ашиг хонжооны бүтэн дүнг хамааруулан ойлгохоор ерөнхийлөн томьёолдог (шууд ба шууд бус орлогын тодорхойлолтыг дэд бүлэг 7.3.1-ээс үзнэ үү). Ашиг хонжоо гэдэгт санхүүгийн шан харамжаас гадна дараах зүйлсийг хамааруулан ойлгодог, үүнд:[29]

- Гэмт хэргийн улмаас бодитоор хүлээн авсан хөрөнгийн үнийн дүн болон мөнгөний хэмжээ (үүнд "хууль бус" хөрөнгийг ч хамааруулна)[30]
- Гэмт хэргийн улмаас шууд болон шууд бусаар (яллагдагч эсхүл яллагдагчийн зааврaар гуравдагч талын) олсон, борлуулсан хөрөнгийн үнэ
- Гэмт хэргийн улмаас шууд болон шууд бусаар (яллагдагч эсхүл яллагдагчийн зааврaар гуравдагч тал) хүртсэн ашиг хонжоо, үйлчилгээ, давуу тал (тухайлбал авлигын хэргийн тухайд тансаг зугаа цэнгэл[31] эсхүл хүний наймаа эсхүл хууль бус худалдааны хэргийн тухайд албадан гүйцэтгүүлсэн биеийн, гэрийн болон бусад төрлийн хөдөлмөр)
- Холбоотой эсхүл өмнө үйлдэгдсэн гэмт үйл ажиллагаанаас шууд ба шууд бусаар хүртсэн ашиг хонжооны дүн

[29] Зарим улс орнууд хууль тогтоомжид удирдамж оруулсан байдаг. Жишээлбэл, Австралийн 2002 оны Гэмт хэргийн орлогын тухай хуулийн зүйл 122-ыг үзнэ үү.

[30] Ашиг хонжоо гэдэгт хууль ёсны хөрөнгө болон хууль бус хөрөнгийг багтааж болно – жишээлбэл, гэмт хэргийн бүлэглэлийн үйл ажиллагаанаас олсон орлого. Хууль бус ашиг хонжооны үнийн дүнг тогтооход хүндрэлтэй бөгөөд олдсон нотлох баримт дээр үндэслэн тогтоох ёстой байдаг. Салбарын ажилтнуудад үнэд суурилсан хөрөнгө хураах тогтолцоо их хэрэг болдог, энэ тогтолцоонд ашиг хонжооны үнэлгээний үйл явц илүү уян хатан байдаг, улмаар хар захын үнэлгээ дээр үндэслэн үнэ тогтоох, мөн тодорхой хугацаанд үргэлжилсэн гэмт хэргийн цаг үед хамаарах үнэлгээ гаргах боломж олгодог.

[31] Өндөр үнэтэй зугаа цэнгээний хэлбэрээр авлига өгөх тохиолдол сүүлийн үед гарсан хэргүүдэд олон илэрсэн – жишээлбэл, 90 мянган ам.долларын 6 хүний оройн зоог, аяллын зардал, сэдэвчилсэн тоглоомын парк, хөрөнгө ашиглалт гэх мэт.

Зарим улс орнуудад тухайн этгээдийн эзэмшиж буй хөрөнгийн үнэлгээ гэмт хэрэг үйлдэхээс өмнө ба хойно хэрхэн нэмэгдсэн байдлаас ашиг хонжоо олсон эсэхийг мөн тодорхойлдог. [32]

Гэмт хэрэгтэй холбоотой ашиг хонжоо нь яллагдагчийг яллан шийтгэх үндсийг бүрдүүлдэг. Яллагдагчийн гэмт үйлдлийг төлөөлсөн, мөн янз бүрийн яллах шийдвэрүүдээс прокуророууд зохих ял шийтгэл сонгох явцад[33] хууль бус ашиг хонжооны үнэлгээтэй холбоотой үүсдэг зарим хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн аргачлал бий болсон, үүнд:

- *Тодорхой хугацаанд үргэлжилсэн удаан хугацааны гэмт хэргийн онцлогийг төлөөлж чадахуйц ял шийтгэл.* Тодорхой хоёр огноо хооронд үйлдэгдсэн авлигын хэргийн тухайд тухайн хугацааг бүхэлд нь хамарсан "хэрэг үйлдэгдсэн хугацааны" ашиг хонжоог бүгдийг нь хураах шийдвэр гаргуулах боломж бүрдүүлдэг.
- *Презумпци, хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагаа.* Презумпци нь нэг зөрчлөөр яллах дүгнэлт гарсан бол тухайн үеийн хугацаанд олсон ашиг хонжоо бүхэлдээ тухайн зөрчлийн улмаас олсон ашиг хонжоо гэж үзэх боломж олгодог. Ийнхүү презумпци дэвшүүлэх нь ял шийтгэл хүлээгээгүй өөр зөрчлөөс яллагдагчийн олсон хөрөнгийг хураах боломж олгодог. Үүнтэй адил, "холбоотой гэмт хэрэг"-ийн хөрөнгийг хураах боломжийг шүүхэд олгодог зүйл заалтуудыг холбоотой эсхүл ижил төрлийн гэмт хэргүүдээс олсон ашиг хонжоог тооцоолоход ашиглаж болох юм. (дараагийн дэд бүлэг 7.4. ба 7.4.3-аас илүү дэлгэрэнгүй мэдээлэл авна уу). Шигтгээ 7.6.-д "холбоотой үйл ажиллагаа"-г хэрхэн бүрэн дүүрэн ашиглаж болох талаар тайлбарласан.
- *Сэжигтэнг хуйвалдааны зарчмаар яллах.* Хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагаа явуулах эрх зүйн үндэс байдаггүй, улмаар яллах шийдвэрт хамааруулах өмч хөрөнгийг хязгаарладаг улс орнуудад прокуророууд хуйвалдааны агуулгын хүрээнд бүх орлого, хэрэгслийг хураахыг зорьж болно.

Хэрэв эрх зүйн системд үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах шийдвэрийг зөвхөн сэжигтэн яллагдсан нөхцөлд зөвшөөрдөг бол салбарын мэргэжилтнүүд ямар ялаар шийтгэл ногдуулахаа сонгох хэрэгтэй болдог (өөрөөр хэлбэл хөрөнгө хураах хүссэн хэлбэрээ сонгохын тулд ямар ял ногдуулахаа сонгоно гэсэн үг). Үүнээс гадна, ямар нэг яллах дүгнэлтээс татгалзах шийдвэр нь ашиг хонжооны тооцоололд ихээхэн нөлөө үзүүлнэ гэдгийг бодолцох хэрэгтэй.

[32] Ашиг хонжоог ийнхүү тодорхойлох боломжийг хууль бусаар хөрөнгөжих, үндэслэлгүйгээр хөрөнгөжих заалтуудыг агуулсан хуулиудтай улс орнууд олгодог, тухайлбал Аргентин, Колумб. "Үндэслэлгүй хөрөнгө эзэмших" хэсэг шинэ гэмт хэргийг Францад томьёолсон гэдгийг энд дурдах нь зүйтэй (зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдсон нь нотлогдсон тохиолдолд), Европын холбооны бусад гишүүн орнуудад ийм заалт байдаггүй (ЕС 2016).

[33] Хууль бусаар хөрөнгөжих, үндэслэлгүйгээр хөрөнгөжих зөрчлийн хэрэг бол энэ нь хүндрэлтэй асуудал биш, учир нь бүх ашиг хонжоо нэг гэмт хэрэгт холбогдоно.

ШИГТГЭЭ 7.6	“Холбоотой үйл ажиллагаанууд” зарчмыг гэмт хэргийн нийт ашиг хонжоог бүрэн тодорхойлох зорилгоор ашиглах нь – Хэргийн жишээ

Гаалийн ажилтан болох хатагтай Х нь нууц ажиллагааны хүрээнд хоёр сарын туршид гурван удаа авлига авсан. Нийт авлигын хэмжээ 20,000 ам.доллар болсон. Нотлох баримтаас үзэхэд тэр бээр нэмж авлига авахаар төлөвлөж байсан бөгөөд сүүлийн хоёр жилийн хугацаанд төрийн албан хаагчийн цалингаар хуримтлуулж болох байсан дүнгээс 500,000 ам.долларoор илүү их баялагтай байсан. Мөн тайлбарлаж чадахгүй ихээхэн хэмжээний бэлэн мөнгөний хэлцэл хатагтай Х хийснийг Сэжигтэй гүйлгээний тайлангаас мөрдөгч нар олж илрүүлсэн.

Нууц ажилтнуудаас авсан гурван удаагийн авлигын хэргээр хатагтай Х-г ялласан. Прокурор нь тухайн гурван зөрчил болон “тухайн зөрчилтэй холбоотой бусад аливаа гэмт хэрэг”-ээс олсон ашиг хонжоо дээр суурилсан хөрөнгө хураах шийдвэр гаргуулсан – тухайн улсын хөрөнгө хураах хуулиар ийм боломж олгогдсон байдаг. Импортлогч нараас авлига авдаг байсан, мөн өөрийнх нь баялаг 500,000 ам.долларoор нэмэгдсэнийг тайлбарлаж чадахгүй байгааг нотлох баримтаар тогтоосон. Шүүхээс 520,000 ам.долларыг хураах шийдвэр гаргасан – авлигаар авсан 20,000 ам.доллар дээр нэмээд холбоотой зөрчлөөс олсон баялгийн үнийг нэмсэн.

“Холбоотой үйл ажиллагаа”-ны зүйл заалтыг хууль тогтоомжид нэмж оруулаагүй байсан бол прокуророос зөвхөн 3 удаагийн авлигын мөнгө болох 20,000 ам.долларыг хураах шийдвэр гаргах байсан.

Бохир ба цэвэр ашиг хонжоо

Дийлэнх улс орнуудад[34], “ашиг хонжоо” гэдгийг “бохир ашиг хонжоо” гэж тодорхойлдог, “цэвэр ашиг хонжоо” эсхүл “ашиг” гэж тодорхойлдоггүй. “Цэвэр ашиг хонжоо”-д суурилсан тооцооллыг ашиглавал авлига авсан албан тушааалтнууд мөнгө угаах үйл явцад төлсөн хуулийн, банкны, тээврийн болон бусад зардлыг хасаж орлогын зарим хэсгийг авч үлдэх боломжтой болно. Үүнээс гадна, төрийн албан хаагчид авлига өгөх замаар улсаас ашиг хонжоо олж буй этгээдийн авлига өгөх зардлыг хасах үндэслэл төрийн бодлогод байх ёсгүй.

Ямар ч нөхцөлд, бохир ашиг хонжоог тооцоолохдоо хөрөнгийн үнийн бууралт, хорогдлыг хасах ёсгүй, учир нь гэмт хэргийн улмаас ашиг хонжоо үүссэн цаг мөчид тухайн ашиг хонжооны үнэлгээгээр тогтоогддог.

Хамтарсан ба бүлгээр үүрэх өр төлбөр

Зарим улс орнуудад үнэлгээнд суурилсан шийдвэрт яллагдагч нарыг хамтаар эсхүл бүлгээр нь өр төлбөр үүрүүлэх тохиолдол байдаг. Ингэснээр яллагдсан бүх иргэдээс ашиг хонжооны дүнг бүрэн гаргуулдаг. Жишээ нь, 5 хүн гэмт хэрэгт оролцоод нийт 500,000 ам.долларын нийт ашиг хонжоо олсон бол хүн тус бүрээс 100,000 ам.долларoос гэхээсээ илүүтэйгээр нийт хураах хөрөнгийн хэмжээг 500,000 ам.доллар гэж шийдвэрлэдэг. Холбогдогч 4 этгээд нь мөнгөгүй, харин 5 дахь оролцогч 1 сая ам.доллартой бол ийм шийдвэр тус болдог.

Хамтын болон бүлгээр үүрэг хариуцлага үүрүүлэхийг зөвшөөрдөг улс орнуудад хөрөнгө хураах ийм шийдвэр гаргахдаа гэмт хэргийн орлогыг хэрхэн хэнд

[34] Нидерланд үүнд хамаарахгүй, энд тооцооллыг цэвэр ашиг дээр суурилан гаргадаг.

хуваарилахыг шийддэг гэмт бүлэглэлийн ахлагч эсхүл хамтран үгсэн ажилласан (гэмт хэргийн орлогыг хамтран олсон гэр бүлийн гишүүд гэх мэт) хүмүүст гол хариуцлагыг ногдуулдаг, мөн шууд хүртээгүй орлогыг доод шатны оролцогчдод ногдуулж хураахыг хориглодог.

7.3.3 Хөрөнгө хураах үзэмж

Зарим улс орнуудад эрүүгийн зөрчлөөр ялласны дараа хөрөнгө хураах шийдвэр заавал гардаг. Бусад улс орнуудад хөрөнгө хураах шийдвэрийг шүүх өөрийн үзэмжээр гаргадаг.[35] Хөрөнгө хураах зарим хуулиудад ийнхүү өөрийн үзэмжээр хөрөнгө хураах эсхүл эс хураах тухай шийдвэр гаргахдаа шүүх тодорхой хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой байдаг. Эдгээр хүчин зүйлсийг дурдвал:

- Шийдвэр гарсан нөхцөлд тухайн этгээдэд тулгарах хүндрэл
- Хураах тухай шийдвэр гаргуулж буй хөрөнгийн ердийн хэрэглээ, мөн
- Гаргасан зөрчил болон хураах гэж буй хөрөнгийн хэмжээний дүйцэхүйц байдал.[36]

7.3.4 Орлогыг үнэлэхэд гардаг хүндрэл бэрхшээл

Гэмт хэргээс олсон орлогыг (эсхүл үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах ажиллагааны тухайд "ашиг хонжоог") үнэлэхэд хэцүү. Жишээлбэл, цэргийн гэрээ олгох тендерт ялах зорилгоор нэг компани авлига өгсөн гэж үзье, энэ тохиолдолд орлого эсхүл ашиг хонжоог тодорхойлох хэд хэдэн хувилбар бий. Салбарын мэргэжилтнүүд тухайн гэрээг авснаар компанид үүсэх санхүүгийн үр дагаврыг (магадгүй нягтлан бодогч эсхүл санхүүгийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар) тооцож үзнэ. Тухайн гэрээний хүрээнд олж авсан төлбөр нь орлого бүрдүүлнэ (гэрээний бохир дүн), мөн зардал гарна (үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэхтэй холбоотой гарах зардал). Өрсөлдөх чадвар нь сайжирч өөр гэрээ авах, тендерт ялах давуу тал үүсэх, бусад өрсөлдөгч нарыг зайлуулах зэрэг байдлаар удаан хугацааны ашиг хонжоо үүсэж болно. Иймээс, ашиг хонжоо гэдгийг тодорхойлох дараах хувилбарууд байж болно, үүнд:[37]

- *Гэрээний бохир дүн.* Тус бүр 50 сая ам.долларoор эргүүлийн хоёр завь нийлүүлэх гэрээ байсан бол ашиг хонжооны нийт дүн 100 сая ам.доллар болно. Энэ аргачлалын дагуу хэрэв авлига өгөөгүй байсан бол уг гэрээг авч чадахгүй байсан гэж үзэж байгаа – энэ нь үнэн ч ч байж болох, худал ч байж болох юм.
- *Гэрээнээс олсон цэвэр ашиг.* Дээр дурдсан жишээнээс үзвэл тухайн компани завинуудыг нийлүүлэхэд 60 сая ам.долларын зардал гаргасан (үүнд бараа

[35] Ийм төрлийн хууль тогтоомжид шүүх нь шаардлага хангагдсан бол хөрөнгө хураах шийдвэр "гаргаж болно" гэж заасан байдаг.

[36] Хүндрэл, ердийн хэрэглээ, дүйцэхүйц байдал зэрэг заалтыг тухайн хэрэгсэл нь хууль ёсоор худалдан авсан гэр бүлийн оршин сууж буй орон байрыг хууль бус үйл ажиллагааны төв болгон (хууль ёсны болон хууль бус аль аль зориулалтаар) ашигласан гэх мэт тохиолдлуудад илүүтэйгээр хэрэглэгддэг. Жишээлбэл, Профет Улсын прокурорын үндэсний захирлын эсрэг хэргийн (CCT56/05) [2006] ZACC 17 материалаас үзнэ үү. Уг хэрэгт хориотой бодистой холбоотой үйл ажиллагаанд оршин суугаа орон байрыг "хэрэгсэл" болгон ашигласныг хураах тухай шийдвэрийг Өмнөд Африкийн Үндсэн хуулийн цэцээс хэвээр үлдээхэд харгалзан үзсэн хүчин зүйлсийг дурдсан.

[37] ЭЗХАХБ ба Дэлхийн банк (2012)-наас дэлгэрэнгүй дүн шинжилгээг үзнэ үү.

үйлчилгээ худалдан авах, цалин хөлс гэх мэт) байхад цэвэр ашиг нь 40 сая ам.доллар болно. Ихэнх улс орнуудад авлигын зардлыг хасдаггүй.

- *Гэрээгээр өрсөлдөгчийг зайлуулснаар өсөн нэмэгдсэн ашгийн хэмжээ.* Үүнийг хэмжихэд хүндрэлтэй байдаг ба эдийн засгийн нарийн тооцоолол хийх шаардлагатай болдог. Гэхдээ авлига бүхий эхний гэрээ авснаас хойш авсан бусад гэрээнүүдийн үнийн дүнг үнэлж нэмэгдсэн ашгийн хэмжээг тогтоодог.

7.3.5. Шүүхэд хөрөнгө хураах нотлох баримт танилцуулахад шинжээч, хураангуй дүгнэлт ашиглах нь

Хөрөнгө болон олсон ашиг хонжоо хоорондын хэлхээ холбоог тогтоосон нотлох баримтыг ойлгоход шүүгчид хүндрэлтэй байж болно. Ийм нотлох баримт, санхүүгийн материалыг ойлгоход илүү хялбар болгох үүднээс урсгалын диаграмм, хүснэгт ашиглах нь тохиромжтой. (Бүлэг 4, зураг 4.3, 4.4 -аас ийм урсгал диаграммын жишээ үзнэ үү).

Нотлох баримт танилцуулах туршлагатай, ул мөр хөөх нарийн мэргэшлийн нягтлан бодогч эсхүл санхүүгийн мөрдөгчид энэ явцад тус болно. Хэрэв зөвшөөрдөг бол орлогыг хэрхэн олсон, мөн ямар схем ашигласан гэдгийг хүснэгт, диаграммаар тодорхой харуулсан сайтар бэлдсэн дүгнэлтийг гэрч танилцуулж болно. Эх сурвалж баримт бичиг дэх нотлох эд мөрийн баримтыг дүгнэлт, танилцуулгад үнэн зөв, алдаагүй тусгахад онцгой анхаарах ёстой, баримтын бөгөөд аргачлалын алдаа гарвал нотлох баримтын үнэмшилтэй байдалд сөргөөр нөлөөлж улмаар яллах хэрэгт том цоорхой үүсгэх болно.

7.3.6 Хураасан хөрөнгийг борлуулах

Эцэст нь, хураасан хөрөнгийг борлуулж, борлуулсан орлогыг төрийн тусгай данс эсхүл төрийн санд байршуулахыг хөрөнгө хураах хуулиар шаарддаг. Олон улс оронд хураасан хөрөнгийн сан үүсгэсэн байдаг бөгөөд тухайн сан руу борлуулалтыг орлогыг шилжүүлдэг[38]. Санд хуримтлагдсан хөрөнгийг хууль хэрэгжүүлэх, хөрөнгө хураах хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор ашигладаг, тухайлбал, тоног төхөөрөмж худалдаж авах, сургалт хийх, мөрдөн байцаах зардалд зарцуулах, прокурорын активын удирдлага хэрэгжүүлэх, хөрөнгө борлуулах зардал гэх мэт байж болно (*Greenberg ба бусад.2009, 90–94; Дэлхийн банк 2009*). Хураагдсан хөрөнгийн удирдлагатай холбоотой асуудлыг Бүлэг 6-аас үзнэ үү.

7.4 Хураан авах ажиллагааг өргөжүүлэх

Хөрөнгө хураах хуулийн үр дүнтэй байдлыг сайжруулах, мөн хураах хөрөнгийн цар хүрээг тэлэх зорилгоор улс орнууд хөрөнгө хураах ажиллагааны нэмэлт арга

[38] Эдгээрт Австрали, Канад, Итали, Люксембург, Намиби, Испани, Өмнөд Африк, ба АНУ зэрэг улс орнууд багтана. Хөрөнгө хураах сантай улс орнуудын жагсаалтыг Грийнберг ба бусад (2009, 91)-аас үзнэ үү.

хэрэгслүүдийг ашигладаг.[39] Жишээлбэл, дэд бүлэг 7.4.2-т дурдсанчлан гэмт хэрэг үйлдэх замаар, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тухайлсан өмч хөрөнгийг хураах боломжгүй бол "орлуулах хөрөнгийг" хураах боломжийг хууль тогтоомжид тусгаж өгсөн байдаг.

7.4.1 Няцаагдах боломжтой презумпци

Оршил хэсэгт тайлбарласанчлан презумпци гэдэг нь бодит баталгаа үгүй нөхцөлд учир шалтгааныг магадлах, тунгаан бодох замаар тодорхой нөхцөл байдалд тулгуурлан баримт, таамаглалын үнэн болохыг тогтоосон гаргалгаа, дүгнэлт юм. Тиймээс, таамаг дэвшүүлэхэд нөхцөл байдал хангалттай байгааг мэргэжилтэн тогтоосон бол ийнхүү презумпци дүгнэлтээр буруутгагдаж буй этгээд энэ дүгнэлт буруу гэдгийг нотлох үүрэг хүлээдэг. Хэрэв дүгнэлт буруу гарсан гэдгийг няцааж чадахгүй бол тухайн дүгнэлтийг бодит үнэнд тооцдог.

Эрүүгийн хуулиар эн тэргүүнд гэмт буруугүй гэж үздэг – гэм буруутайг нь нотлох хүртэл сэжигтэнг гэм буруугүй гэж үздэг эрх зүйн болон үндсэн хуулиар олгогдсон эрхийг иргэн бүр эдэлдэг. Зохих стандартын дагуу гэмт бурууг нь нотлох үүргийг прокурор хүлээдэг, ингэж чадаагүй тохиолдолд сэжигтэн цагааддаг. Няцаагдах презумпцийг эрүүгийн ажиллагааны хүрээнд ашиглах нь ховор байдаг, учир нь дээрх зарчим яг эсрэгээр тавигддаг. [40] Гэхдээ эрүүгийн хариуцлага яригдаагүй мөн иргэний хүний эрх, эрх чөлөө хөндөгдөөгүй, өөрөөр хэлбэл эн тэргүүнд гэм буруугүйд тооцох зарчим хамаарахгүй хөрөнгө хураах болон иргэний хэргүүдэд няцаагдах боломжтой презумпцийг илүү түгээмэл ашигладаг.[41]

Няцаагдах боломжтой презумпци нь авлигачин төрийн албан хаагч нартай холбоотой хэргүүдэд ихэд тус болдог – нэн ялангуяа төрийн албанд өн удаан жил зүтгэсэн албан тушаалтнуудын тухайд – учир нь хөрөнгө завшиж өнгөлөн далдлах боломж тэдгээрт асар их байдаг, мөн гэрчид нөлөөлөх, өөрсөд нь хамааралтай хөрөнгийн тухайд явагдах мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах боломжтой. Үүсэл гарал нь тодорхойгүй баялгийг хууль бус үйлдэлтэй холбох, үүнийг нотлох үүргээс прокуроруудыг чөлөөлснөөр яллах дүгнэлт гаргуулах магадлал, мөн хөрөнгө хураах шийдвэр гаргуулах магадлал ихээхэн нэмэгддэг. Эрүүгийн гэмт бүлэглэлийн гишүүдийн эзэмшиж буй хөрөнгө нь авлигын үйл ажиллагаатай холбоотой гэсэн презумпци, дүгнэлт гаргах боломжийг хуульчилж өгөх нь авлигын дэглэм нуран унахад хулгайлсан хөрөнгийг олж илрүүлэх хүчин чармайлтад ихээхэн тус болдог.[42]

---

[39] Олон улсын гэрээ, конвенцуудад нэмэлт арга хэмжээ ашиглахыг дэмждэг (Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 48, 59; Европын Парламентын болон Зөвлөлийн 2014 оны 4-р сарын 3-ны өдрийн Европын Холбоонд үйлдэгдсэн гэмт хэргийн орлого, хэрэгслийг царцаах, хураах тухай Тогтоол 2014/42/EU, зүйл 5 [OJ L 127, 29.04.2014], https://eur-lex.europa.eu/legalcontent/EN/TXT/PDF/?uri=CELEX:32014L0042&from=EN).

[40] Жишээлбэл, жороор олгогдсон эмийн хэмжээнээс давсан хэмжээний эм биедээ авч явсан этгээдийг өөрөөр нотлох баримт үгүй тохиолдолд хориотой эмийн бодис тээвэрлэсэн гэж үзэж болно.

[41] Эрүүгийн журмаар хөрөнгө хураах нь яллах шийдвэр гарсны дараа хэрэгждэг гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Татвар, гаалийн хууль тогтоомжийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдгээрийг мөн ашиглаж болно.

[42] Жишээлбэл, Швейцарийн Швейцарийн Эрүүгийн хууль (CC 311.0), зүйл. 72: https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19370083/index.html.

Няцаагдах боломжтой презумпци нь хүчтэй хэрэгсэл юм, тиймээс салбарын мэргэжилтнүүд үүнийг зүй зохистойгоор ашиглах ёстой. Хөрөнгө хураах тогтолцооны хүрээнд уг хэрэгслийг урвуулан ашиглах практик тогтвол тогтолцоог тэр чигээр нь үнэмшилгүй, нэр хүндгүй болгох эрсдэлтэй.[43] Жишээлбэл, няцаагдах боломжтой презумпцийг ашиглан харьцангуй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн бүх хөрөнгийг хураах шийдвэр гаргуулбал хөрөнгө хураах тогтолцоо өөрөө шударга эсэх тухай асуудал сөхөгдөнө. Няцаагдах боломжтой презумпцийг ашиглах дараах суурь нөхцөл, үндэслэл байж болно, үүнд:

- *Биедээ авч явсан.* Гэмт хэрэг үйлдэх явцад эсхүл үйлдээд удаагүй байхад тухайн этгээдийн биедээ авч явсан хөрөнгийг гэмт хэргийн орлого эсхүл хэрэгсэл гэж үздэг.
- *Хамаарал.* Зохион байгуулалттай гэмт хэргүүдийн тухайд зохион байгуулалттай гэмт бүлэглэлд оролцдог эсхүл дэмждэг этгээдийн эзэмшилд буй хөрөнгийг тухайн бүлэглэлийнх гэж үзээд хураах үндэслэл бүрддэг.[44] Ийнхүү нэмэлт хэрэгсэл ашиглах нь эрүүгийн бүлэглэлүүдийн эдийн засгийн суурийг онилоход хэрэг болдог.
- *Амьдралын хэв маяг.*[45] Тодорхой хугацаанд хуримтлуулсан хөрөнгийн үнэлгээ нь хууль ёсны орлогын эх үүсвэртэй дүйцэхгүй байх нөхцөлд прокурор энэ үндэслэлийг ашиглаж болдог.[46] Хууль ёсны дагуу худалдан авсан гэдгээ харуулж нотолж чадах хөрөнгийг хураах хөрөнгийг жагсаалтаас хасаж болно. Тодорхой хэрэгтэй холбоотой бус илүү өргөн хүрээний хөрөнгийн эх үүсвэрийг яллагдагч нотлох хэрэгтэй болдог.
- *Хөрөнгө шилжүүлэх.* Зах зээлийн үнээс хэт доогуур үнээр эсхүл гэр бүлийн гишүүд болон ойрын хамсаатнуудаа шилжүүлсэн хөрөнгийг хууль бус гэж

---

[43] Зарим улс орнуудад зарим презумпцийг зөвхөн ноцтой гэмт хэргийн тухайд ашиглахыг зөвшөөрдөг, тухайлбал Австралийн Викториа муж улсын (1987 оны Хөрөнгө хураах тухай хууль) болон 2002 оны Австралийн Гэмт хэргийн орлогын тухай хууль. Их Британид үнэд суурилсан хөрөнгө хураах хэргүүдэд презумпцийг ашиглах явдлыг зөвхөн "гэмт хэргийн амьдралын хэв маягийн" ангилалд хамаарах хэргийн тухайд ашиглахыг зөвшөөрдөг: 2002 оны ИБУИНВУ-ын гэмт хэргийн улмаас олсон орлогын тухай хууль, хэсэг 6. АНУ-д презумпцийг зөвхөн хориотой бодистой холбоотой хэргүүдэд ашиглахыг зөвшөөрдөг: 21 U.S.C. § 853(d).

[44] 2005 онд Швейцарийн Холбооны Дээд шүүх Нигерийн дарангуйлагч асан Сани Абача, түүний гэр бүл болон хамсаатнууд хамтдаа гэмт хэргийн бүлэглэл мөн болохыг тогтоож, Абача-тай холбоотой 458 сая ам.долларын үнэлгээ бүхий хөрөнгийг хураах шийдвэрийг эдгээр заалтыг ашиглан гаргасан. (FDFA 2016, 18–20; мөн Бүлэг 4, шигтгээ 4.4-т энэ талаар оруулсан). Мөн Швейцарийн Эрүүгийн хуулийн (CC 311.0), зүйл. 72-ыг үзнэ үү: "Гэмт хэргийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын захиран зарцуулах эрх мэдэл бүхий бүх хөрөнгийг хураах шийдвэрийг шүүх гаргана. Гэмт хэргийн байгууллагад оролцдог, түүнийг дэмждэг (зүйл 260ter) аливаа этгээдийн хөрөнгийг тухайн байгууллага захиран зарцуулах эрхтэй гэж тогтоовол тэдгээр хөрөнгийг эсрэгээр нотлох хүртэл хураах ёстой" (9-р сарын 21, 1937[9-р сарын. 1-ний байдлаар, 2017],https://www.admin.ch/opc/en /classified-compilation/19370083/201709010000/311.0.pdf).

[45] Амьдралын хэв маягт үндэслэсэн презумпци нь хууль бусаар хөрөнгөжих, үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой хэргүүдээс ялгаатай бөгөөд тусдаа. Хэдийгээр тодорхойлолтууд адил байдаг ч, ашиглах ажиллагаа, журам нь өөр.

[46] Өмнөд Африкт презумпци нь хянан шүүх ажиллагаа эхэлснээс өмнө 7 жилийг хамардаг (Зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хоёрдох нэмэлт өөрчлөлт, дугаар 38, 1999, хэсэг 22). ИХУИНВУ-д гэмт хэргийн шинж чанартай амьдралын хэв маягтай гэж тогтоогдсон этгээдийн тухайд презумпци нь 6 жилийн хугацааг хамардаг. (ИБУИНВУ-ын Гэмт хэргийн улмаас олсон орлогын тухай хууль, хэсэг 10[8]). Мөн Францын Эрүүгийн хуулийг үзнэ үү, зүйл 131-21.

дүгнэх боломжийг энэ презумпци олгодог.[47] Зах зээлийн ханшаар зах зээлийн зарчмаар хийгдсэн хэлцлийн үндсэн дээр эзэмшиж буйг нотлох үүргийг хөрөнгийг эзэмшигч/өмчлөгч хүлээдэг.[48] Презумпцийг няцааж чадаагүй нөхцөлд тухайн хэлцлийг хүчингүйд тооцдог.

- *Гэмт хэргийн мөн чанар.* Ийм үндэслэлийг их хэмжээний мансууруулах бодис, авлигын ноцтой хэрэг, залилан, дээрэм, зохион байгуулалттай гэмт хэрэг гэх мэт онцгой хүнд хэрэг, бүлгээр үйлдсэн эрүүгийн хэрэгт хамааруулж хэрэглэдэг. Ийм хэргээр ял явсан хүн тухайн гэмт хэрэг үйлдэгдэх хугацаанд, мөн үйлдэгдэхээс тодорхой хугацааны өмнө, хойно хуримтлуулсан хөрөнгийг гэмт хэргийн орлого гэж үзэж хураах шийдвэр гаргадаг.[49]
- *Үүсэл гарал нь хууль бус, тодорхойгүй баялаг.* Улс төрийн албан тушаалтны баялаг нь их хэмжээгээр нэмэгдсэн, мөн ийнхүү нэмэгдсэн нь (нэн ялангуяа авлигын тохиолдол өндөр байдаг улсад) авлигын үр дүн гэж үзэх үндэслэл бүхий тохиолдлуудад энэ нэмэлтийг ашигладаг. (Швейцарийн холбогдох хууль тогтоомж болон Дювалиерийн хөрөнгийн талаарх дэлгэрэнгүйг Шигтгээ 7.7-оос үзнэ үү). Их Британид үүсэл гарал тодорхойгүй хөрөнгийн шийдвэрийг шүүхээс гаргаж тогтоосон хугацаанаас өмнө үүсэл гарлыг тайлбарлах шаардлагыг холбогдогч этгээд биелүүлж чадаагүй бол тухайн хөрөнгийг иргэний ажиллагааны хүрээнд хураах боломжтой гэж үздэг (үүнийг Бүлэг 3, дэд бүлэг 3.4.10, Шигтгээ 3.11-д тайлбарласан).

Презумпцийг няцаах үүргийг яллагдагч хүлээдэг хэдий ч прокурор нь яллагдагчийн танилцуулж болзошгүй бүх нотлох баримтыг үгүйсгэх мэдээллийг давхар танилцуулж хөрөнгийг хууль бусаар олсон эсхүл хөрөнгө нь гэмт хэргийн хэрэгсэл байсан гэдгийг тогтооход туслалцаа үзүүлдэг. Ийм нөхцөлд яллагдагч нь хөрөнгийг хууль ёсны аргаар авсан, хууль ёсны хүрээнд ашигласан гэдгээ илэрхийлснээр үндэслэл презумпцийг няцаахад илүү хүндрэлтэй болгодог.

7.4.2 Хөрөнгийг орлуулах заалтууд

Гэмт хэрэгтэй холбоогүй хөрөнгийг хураах боломж олгодог учир хөрөнгөд суурилсан хөрөнгө хураах дэглэмд тулгардаг – гэмт хэргийг хөрөнгөтэй холбох, үл мөрийн хэлхээг тогтоох гэх мэт –хүндрэлүүдийг хөрөнгө орлуулах заалтууд даван туулахад тус болдог. Ийм заалтуудыг ашиглахын тулд а) гэмт хэрэг, зөрчлийн улмаас олсон ашиг хонжооны бодит хөрөнгө, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан бодит хэрэгслийн б) байршлыг олж тогтоох боломжгүй эсхүл олдохгүй байгаа гэдгийг нотлох шаардлага тавигдах боломжтой.

Гэмт хэрэгтэн хууль бус үйл ажиллагааны шууд орлогыг сарниулахыг оролдсон гэдгийг тогтоосон нөхцөлд ижил үнэлгээ бүхий хөрөнгийг түүний хууль ёсны хөрөнгөөс хураан авах хүсэлтийг прокурор дэвшүүлж болно.

---

[47] Тайландад гэр бүлийн гишүүдэд хөрөнгө шилжүүлэхийг шударга бус гэж дүгнэдэг (Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, B.E. 2542 [1999], хэсэг. 51–52).

[48] Колумбид, презумпцийг няцаахаар оролдож буй тал мөн тухайн хэлцэл бодитоор хийгдсэн гэдгийг нотлох ёстой (өөрөөр хэлбэл, хөрөнгийг худалдан авах эх үүсвэр хангалттай байсан, мөн борлуулагч тал төлбөрийг хүлээн авсан гэдгийг нотолно.)

[49] 21 U.S.C. § 853(d) заалтыг жишээлбэл үзнэ үү, уг заалтад хориотой бодистой холбоотой зөрчлийн хүрээнд худалдан авсан хөрөнгийг гэмт хэргийн орлого гэж үзнэ.

ШИГТГЭЭ 7.7

Гаити: Хууль бус хөрөнгийг хураах тухай Швейцарийн хуулийн дагуу хөрөнгийн үүсэл гарал нь хууль бус болох тухай презумпци ашигласан Жан Клод “Baby Doc” Дювалиерын хэрэг

Швейцарийн хууль ба хууль бус үүсэл гарлын талаарх презумпци: хөрөнгө хураах арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор улс төрийн өндөр албан тушаалтнуудын олсон хууль бус хөрөнгийг хураах тухай хуулийг Швейцар 2011 онд баталсан. Эрх зүйн тогтолцоо нь сул хөгжсөн улс орнуудад үйлчилж болох тухай уг хуульд тусгасан байдаг.

Тодруулбал, хөрөнгийг хууль бус үүсэл гаралтай гэж үзэхэд хоёр нөхцөл хангагдсан байх ёстой, үүнд, а) хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээдийн баялаг нь улс төрийн зүтгэлтэн албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор үлэмж их хэмжээгээр нэмэгдсэн, мөн (б) “тухайн улсын авлигын түвшин өндөрт тооцогддог”.[a] “Үлэмж их хэмжээгээр” нэмэгдэнэ гэж төрийн албан хаагчийн орлого болон үүсэл гарлыг нь тайлбарлаж чадахгүй хөрөнгийн хооронд хэт их зөрүүтэй байхыг хэлнэ (Adam 2013, 253, 259). Тухайн улсад авлигын түвшин “өндөр” болохыг Дэлхийн банк, Транспэрэнси Интернэшнл зэрэг нэр хүнд бүхий байгууллага, хүрээлэнгүүдийн хийсэн судалгааны үндсэн дээр тодорхойлдог (Adam 2013, 260).

Дювалиерын хөрөнгөд тухайн зарчмыг ашигласан нь: Франсуа Дювалиер гэх эцэг нь нас барсны дараа Жан Клод Дювалиер Гаитигийн ерөнхийлөгчийн албан тушаалыг өвлөн авсан бөгөөд 1971-1986 онуудад уг албыг хашиж байгаад эх орноосоо оргон зайлсан. Төрийн эрх барих хугацаандаа Жан Клод болон түүний хамсаатнууд олон сая ам.долларын үнэлгээ бүхий хөрөнгийг завшсан бөгөөд тэдгээрийг гадаад улсуудад, үүний дотор Швейцар улсад нуусан. 2010 оны эцсийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 5 сая швейцар франк давсан.[b]

Гаитигийн эрх баригчид олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг анх 1986 онд Швейцарт хандан ирүүлж Дювалиерын хөрөнгийг царцаахыг хүссэн. 2002 онд тус улсын Холбооны Зөвлөлөөс хөрөнгийг царцаах шийдвэр гаргасныг Холбооны Захиргааны шүүхээс 2013 онд дэмжиж баталгаажуулсан[c]. Тэр цагаас хойш эрүүгийн хэргээр олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд эсвэл Холбооны захиргааны шүүхийн шийдвэрийн хүрээнд Швейцарийн Холбооны Үндсэн хуулийн дагуу хөрөнгийг царцаасан хэвээр байлгасан.[d] 2009 он хүртэл Гаититай харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хэлэлцээ амжилтад хүрээгүй. *(Adam 2013, 258; Ivory 2014, 43).*

2009 оны 2-р сард Швейцарийн Холбооны Хууль зүйн яамнаас хөрөнгийг Гаитид буцаах өгч хүмүүнлэгийн зорилгоор ашиглах ёстой гэж шийдсэн бөгөөд давж заалдах хүсэлтийг хүлээн аваагүй. Гэвч Дювалиерын багийнхан Холбооны Дээд шүүхэд дахин давж заалдаж Дээд шүүхээсХууль зүйн яамны шийдвэрийг хүчингүй болгосон, уг шийдвэрийн гол үндэслэл нь хуулийн үйлчлэх хүрээ хангалтгүй гэж үзсэн. (Ivory 2014, 44).[e] Ийм шийдвэр гарсан хэдий ч Ерөнхий зөвлөлөөс Дювалиерын хөрөнгийг Холбооны үндсэн хуулийн хүрээнд царцаасан хэвээр үлдээсэн, тэр хооронд Швейцарийн парламентаас улс төрийн зүтгэлтнүүдийн хууль бус баялгийг буцаан хураах тухай хуулийг авч хэлэлцсэн. Уг хууль 2011 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд уг хуулийн хүрээнд хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус гэж үзэх үндэслэл бүрдсэн.[f]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 7.7

Гаити: Хууль бус хөрөнгийг хураах тухай Швейцарийн хуулийн дагуу хөрөнгийн үүсэл гарал нь хууль бус болох тухай президент ашигласан Жан Клод “Baby Doc” Дювалиерын хэрэг

2011 оны 2-р сард уг хуулийн дагуу Холбооны Зөвлөлөөс Дювалиерын хөрөнгийн царцаах захиргааны шийдвэр гаргасан, Сангийн яам уг хөрөнгийг хураах ажиллагааг 2014 оны 4-р сард эхлүүлсэн (Ivory 2014, 45). Дювалиерын багийнхан Холбооны Зөвлөлийн шийдвэрийг давж заалдан Захиргааны шүүхэд хандсан.[g]

2013 оны 9-р сард Захиргааны шүүх Холбооны Зөвлөлийн хөрөнгө царцаах тухай 2002 оны шийдвэр, мөн 2011 оны Сангийн яамнаас эхлүүлсэн хөрөнгө хураах ажиллагааг хэвээр үлдээсэн, уг шийдвэрийн үндэслэлд Швейцарийн ашиг сонирхлыг хадгалахын тулд Холбооны зөвлөлийн шийдвэр зайлшгүй шаардлагатай байсан гэж үзсэн.[h] Тодруулбал, Захиргааны шүүх нь холбогдох хөрөнгийг нь хууль бус аргаар олж авсан, мөн Дювалиерын ба түүний хамсаатнуудын баялаг нэмэгдсэн нь төрийн албан хаагчийн хувьд гүйцэтгэж байсан үүрэгтэй нь хамаагүй үйл ажиллагаанаас үүдэлтэй болохыг тэд нотолж чадаагүй. Мөн Дювалиер албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд Гаитид авлигын түвшин маш өндөр байсан гэдгийг Захиргааны шүүхээс тогтоож, “хэрэгт хамаарах хөрөнгийн гарал үүсэл хууль ёсны бус гэж тодорхойлох нөхцөл хангагдсан” гэж үзсэн.[i]

Эцэст нь, хөрөнгө хураах ажиллагааг дуусгаж чадаагүй. 2014 онд хөөн хэлэлцэх хугацаа дуусан үндэслэлээр эрүүгийн ажиллагааг Гаитид хүчингүй болгосон бөгөөд 2014 оны 10-р сард Дювалиер нас барсан.

a. Хууль бус хөрөнгийг буцаах тухай хууль,зүйл. 6, догол мөр. 1. https://www.admin.ch/opc/en/classified-compilation/20100418/201102010000/196.1.pdf.
b. Холбооны Захиргааны шүүх. 2013. “FAC Confirms Freezing and Forfeiture of Duvalier Assets.” Press Release (decisionsC-1371/2010 and C-2528/2011), September 25, 2013. https://www.bvger.ch/dam/bvger/de/dokumente/juricom/pressemitteilungen/c-1371_2010_c-25282011facconfirmsfreezingandforfeitureofduvalier.pdf.download.pdf/c-1371_2010_c-25282011facconfirmsfreezingandforfeitureofduvalier.pdf.
c. Холбооны Захиргааны шүүх, “FAC Confirms Freezing,” 9-р сарын 25, 2013.
d. Швецарийн Холбооны Зөвлөл. 2010. “The Duvalier Accounts Remain Blocked While a Draft Law Will Be Reviewed that Could Permit Illicit Assets to Be Confiscated.” Press Release, 2010 оны 2- сарын 03. (accessed September 20, 2018). https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-31463.html.
e. Мөн Швейцарийн Холбооны Зөвлөлөөс үзнэ үү, “The Duvalier Accounts,” 2-р сарын 3, 2010.
f. Хууль бус хөрөнгийг буцаах тухай хууль, зүйл. 6, догол мөр. 1.
g. Холбооны Захиргааны шүүх, “FAC Confirms Freezing,” 9-р сарын 25, 2013.
h. Холбооны Захиргааны шүүх, “FAC Confirms Freezing,” 9-р сарын 25, 2013; Stolen Asset Recovery (StAR) Initiative. 2017. “Jean Claude “Baby Doc” Duvalier (Switzerland).” Asset Recovery Watch, 7-р сарын 20, 2017. https://star.worldbank.org/corruption-cases/node/18515.
i. Холбооны Захиргааны шүүх, “FAC Confirms Freezing,” 9-р сарын 25, 2013.

Үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах хуультай улс орнуудад хөрөнгө орлуулах зүйл заалтууд шаардлагагүй (учир нь ашиг хонжоо олсон этгээдэд мөнгөн өр төлбөр үүрүүлдэг учир тухайн этгээдийн аливаа хөрөнгийг хурааж болдог) ч хөрөнгөд суурилсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга зам болгон хөрөнгийг орлуулан хураах механизмыг ашиглах эрх олгодог хуулиуд зарим улс орнууд давхар үйлчилдэг. [50]

[50] АНУ-д орлуулсан хөрөнгийг бүх эрүүгийн хэргийн тухайд хурааж болох хэдий ч яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хүрээнд зөвшөөрдөггүй.

7.4.3. Хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагаа

Хөрөнгө хураах өргөтгөсөн ажиллагаа гэдэг нь яллах шийдвэрт тулгуурласан хөрөнгө хураах хэлбэр юм, үйлдсэн гэмт хэрэг ба хөрөнгө хоорондын хэлхээ холбоо сул, баттай нотолж чадаагүй хэдий ч тухайн хөрөнгийг хууль бус үүсэл гаралтай гэж үзэж буй тохиолдлуудад ашиглагддаг (Boucht 2017, 117, 119). Ижил төстэй эсхүл холбоотой гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон хөрөнгийг хураах (эсхүл ашиг хонжооны үнэлгээнд оруулах)-ыг зарим улс орны шүүхээс зөвшөөрдөг.[51] Холбоотой гэмт хэрэг, зөрчлөөр тухайн этгээдэд ял шийтгэл ногдуулсан байх шаардлагагүй, гэхдээ "холбоотой үйл ажиллагаа"-нд холбогдох хэлхээ холбоо нь хангалттай байгааг шүүхээс тогтоосон ёстой (тухайлбал, энэ талаар Шигтгээ 7.6-д үзүүлсэн).

Бусад улс орнуудад холбогдсон эсхүл яллагдсан этгээдийн хөрөнгийг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн хураах эрхийг шүүхэд олгосон байдаг, ингэхдээ тухайн хөрөнгийг зөрчил гаргахаас өмнө эсхүл дараа худалдан авсан гэдгийг харгалздаггүй.[52] Ийм заалтыг ихэвчлэн (терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах, авлига, мансууруулах бодис тээвэрлэх гэх мэт) онц ноцтой, хүнд гэмт хэргүүдийн тухайд ашигладаг ба зөвхөн яллагдагчийн эзэмшил, хяналтад буй хөрөнгөд хамаардаг. Урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах Италийн тогтолцооны талаар Шигтгээ 7.8-д оруулав.

7.4.4 Хөрөнгийн шилжүүлгийг хүчингүй болгох

Тодорхой шилжүүлгийг хүчингүй болгох (дэд бүлэг 7.4.1-ийг үзнэ үү) арга хэрэгслээс гадна хураагдаж буй хөрөнгийг олох хууль бус үйл ажиллагаа үйлдэгдсэн цагаас эхлэн хөрөнгийн эзэмших, өмчлөх эрх, эрхийн гэрчилгээг төр эсхүл төрийн байгууллагад шилжүүлэх заалтыг зарим орны хуульд тусгасан байдаг.[53] Хэрэв хөрөнгийг дараа нь өөр этгээдэд шилжүүлсэн бол тухайн хөрөнгийг хураах эрхтэй – хөрөнгө нь хураагдах ёстой гэдгийг мэдээгүй чин үнэнч худалдан авагч нарт энэ заалт хамаарахгүй.

7.4.5 Яллах дүгнэлт гармагц автоматаар хөрөнгө хураах

Ийм төрлийн заалтууд нь презумпци руу хөтлөхгүй, харин хуулийн заалт автоматаар үйлчлэх учир хөрөнгө хураах шууд үндэслэл бүрддэг. Тодорхой нөхцөл, шаардлага хангагдсан бол шүүхийн ямар нэг шийдвэргүйгээр хөрөнгө хураах боломжтой.[54] Автоматаар хураагдах хөрөнгийг эзэмших эрхтэй гэж үзэж байгаа этгээд – яллагдагч, гэм буруугүй эзэмшигч, эсхүл гуравдагч тал – тухайн хөрөнгийг хууль ёсны аргаар олж авсан гэдгээ нотлоод хураагдах заалтаас уг хөрөнгийг хасуулах боломжтой. Энэ тохиолдолд нэхэмжлэл гаргаж байгаа тал нотлох үүргийг хүлээдэг.

---

[51] Хөрөнгө хураах ийм нэмэлт эрх мэдэл ЕХ-ны бүх улс орнуудад нэвтрүүлсэн байхыг шаардаг, Гэмт хэргийн орлого, хэрэгслийг хураах, царцаах тухай ЕХ-ны Тогтоол 2014/42/EU, 2014 оны 4-р сарын 3, зүйл 5.

[52] Францын Эрүүгийн хууль, зүйл 131-21

[53] 53. Энэ концепцийг АНУ-д ашигладаг, 21 U.S.C. §§853(c), 881(h)-аа үзнэ үү.

[54] Австралид автоматаар хөрөнгө хураах заалтыг ашигладаг.

ШИГТГЭЭ 7.8	Урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах Италийн тогтолцоо

Италид хөрөнгө хураах заалтуудыг зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 1982 оноос эхлэн мафийн эсрэг хуулиудад суулгаж өгсөн байдаг, тэр цагаас хойш олон нэмэлт өөрчлөлт орсон (Маззакува 2017, 117, 119). Хөрөнгө хураах ийм төрөлд эрүүгийн ял ногдуулсан байх шаардлагагүй.[a] Тухайн этгээд нь гэмт хэргийн бүлэглэл, байгууллагын гишүүн мөн болох тухай презумпци байх нь ийм төрлийн хөрөнгө хураах заалтыг ашиглах гол шалгуур болдог.[b] Үүнээс гадна, хувь хүний "нийгэмд үзүүлэх аюул занал" (тухайн этгээд нэмэлт гэмт хэрэг үйлдэх магадлал)-ыг үнэлэх, мөн хөрөнгө нь тухайн этгээдийн орлогоос хэт давсан гэдгийг харуулахыг хуулиар шаарддаг (Маззакува 2017).

2008 оноос эхлэн урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах ажиллагааг мафитай холбоотой хэргүүдээс гадна өөр хэд хэдэн төрлийн гэмт хэргүүдийн тухайд ашиглах болсон. Хууль бус хөрөнгийн ул мөрийг тогтоож чадахгүй байгаа нөхцөлд адил үнэлгээ бүхий өөр хөрөнгийг мөн хураах боломжтой (Маззакува 2017, 104). Холбогдогч этгээд нас барсан ч хөрөнгө хураах ажиллагаа үргэлжилж болно (TI Italia 2013, 11).

Италийн эрх зүйн тогтолцооны хүрээнд эрүүгийн болон урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах нь хэд хэдэн асуудлаар ижил төстэй байдаг, үүнд: холбогдогч этгээдийн орлого ба хөрөнгө хооронд хэт их ялгаатай, мөн тухайн хөрөнгийг үүсэл гарлыг нотолж чадахгүй байгаад аль аль ач холбогдол өгдөг (TI Italia 2013, 12). Гэхдээ, эрүүгийн журмаар хөрөнгө хураах тохиолдолд, тухайн этгээдэд яллах шийдвэр гаргуулсан байх шаардлагатай байдаг бол урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах тохиолдолд холбогдогч этгээдийн "нийгэмд үзүүлэх аюул занал"-ыг харуулсан байх шаардлагатай байдаг. Үүнээс гадна, эрүүгийн журмаар хөрөнгө хураах ажиллагаанд зөвхөн гэмт хэрэгт холбогдсон хөрөнгийг хураадаг бол урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах тохиолдолд гэмт хэрэгтэй холбоогүй хөрөнгийг хурааж болдог.

a. Европын Холбооны Хүний эрхийн шүүх ийм төрлийн хөрөнгө хураах ажиллагааг эрүүгийн мөн чанартай гэж үздэггүй, эрүүгийн ажиллагаанд ашигладаггүй. Синамото (2017, 365, 373) ба M. v. Italy (no. 12386/86, Commission Decision of April 15, 1991), уг хэрэгт хууль ёсны үүсэл гарлыг нь тогтоож чадаагүй өмчийг хууль бусаар, зарим тохиолдолд нийгэмд аюултай, хор уршигтай байдлаар ашиглахаас, урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө хураах арга хэмжээ авна гэж заасан.
b. 2008 оноос хойш, тухайн этгээдийн үйлдсэн хэрэг нь заавал зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хамааралтай байх шаардлагагүй гэж үзсэн (Мазукава 2017, 103).

7.5 Гуравдагч талын ашиг сонирхол

Хураагдах хөрөнгөд ашиг сонирхолтой гуравдагч талууд хэрэг хэлэлцэх талаар мэдээлэл авах, мөн өөрийн байр суурийг тайлбарлах эрхтэй. [55] Ихэнх тохиолдолд хуулиар ашиг сонирхлыг нь бүртгэсэн гэж үзсэн бүх иргэдэд зохих зарыг эрх бүхий байгууллагууд хүргүүлдэг. Энэ шалгуурыг аль болох чөлөөтэй ашиглах ёстой. Хэрэв талууд ашиг сонирхолтой болохоо илэрхийлсэн бол зарыг албан ёсоор хүргүүлэх ёстой. Хөрөнгийг хурааснаар тухайн хөрөнгөтэй холбоотой бүх эрхийг үгүй хийдэг тул сонин, эрх зүйн хэвлэл, интернэт зэрэг олон нийтийн хэрэгслээр дамжуулан нийт ард иргэдэд мэдээлэл хүргэх нэмэлт аргуудыг ашигладаг. Хөрөнгө

[55] Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 31 (9), 35, 55 (3) (c), 57; Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенц, зүйл 12 (8), 13 (8); Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц, зүйл 5 (8).

битүүмжлэх шийдвэрт гуравдагч талуудын хууль ёсны ашиг сонирхол, эрхийг хэрхэн зохицуулах тухай заалтуудыг оруулсан байх ёстой (энэ асуудлын талаарх хэлэлцүүлгийг Бүлэг 5, дэд бүлэг 5.6-аас үзнэ үү).

Зарим улс орнуудад шүүхээс шийдвэр гарахаас өмнө хязгаарлагдмал хүрээнд өөрийн эрх ашгаа хамгаалах боломжийг гуравдагч талуудад олгодог – тухайлбал, хөрөнгийг битүүмжлэх нь ихээхэн хүндрэл бэрхшээл учруулна, эсхүл хөрөнгө нь хууль ёсны үүсэл гаралтай, мөн амьжиргаагаа залгуулахад зайлшгүй шаардлагатай гэх мэт үндэслэлүүд гаргаж болно.

Гуравдагч талуудын ашиг сонирхлыг баталгаажуулах процедурын алхмууд эрүүгийн журмаар хөрөнгө хураах эсхүл яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах эсэхээс хамааран янз бүр байж болно. Ерөнхийдөө эрүүгийн журмаар хөрөнгө хураахад үйлдсэн гэмт хэргийнх нь яллах шийдвэр, мөн яллагдагчийн хөрөнгийг хураах шийдвэр эцэслэн гарсан байх ёстой байдаг, яллах дүгнэлт гарсны дараа гуравдагч талын ашиг сонирхлыг нэмэлт шүүх хурлаар хэлэлцдэг. Ийм нөхцөлд гэмт хэрэг үйлдэгдэх цаг мөчид тухайн өмч хөрөнгө нь гуравдагч талын өмчлөлд байсан гэдгийг эсхүл дараа нь үнэ төлбөрийг нь шударгаар төлж худалдаж авсан гэдгээ гуравдагч тал нотолж чадвал тэр бээр ялах боломжтой.[56]

Гуравдагч тал нь гэмт хэрэгт оролцсон байсан ч ийм тохиолдлуудад ялах боломжтой байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Эрүүгийн хэрэгт гуравдагч талыг татаж шүүхээр оруулаагүй бол хөрөнгө хураах үндэслэлийг няцаах боломж олголгүйгээр тухайн талын хөрөнгийг хураах нь зохих хуулийн үйл явцыг зөрчсөнд тооцогдоно. Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах тогтолцоо нь гэмт хэрэгт оролцсон гуравдагч талуудын хөрөнгийг хураах боломжийг төрд олгодог, үүнд гэмт хэрэг үйлдэгдсэн, мөн гуравдагч талыг оролцуулсан нэмэлт хурлаар тухайн хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашигласан гэдгийг тогтоосон байхад хангалттай.

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах тогтолцоонд, гуравдагч талууд (а) хөрөнгийн тухайд хууль ёсны эрхтэй, мөн (б) гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө тухайн хөрөнгийг худалдан авсан, эсхүл гэмт хэрэгтэй холбоотой гэж үзэх ямар нэг үндэслэл тухайн үед байгаагүй эсхүл (в) гэмт хэрэг үйлдэгдсэний дараа хөрөнгийг худалдаж авсан бөгөөд хөрөнгийг шударгаар зах зээлийн үнэ ханш төлж авсан гэдгээ гуравдагч тал нотлох ёстой. Үүнийг заримдаа “гэм буруугүй өмчлөгч”-ийн өмгөөлөл гэж нэрлэдэг.[57]

7.6 Хураан авах ажиллагааны талаар хуульчлахад тулгардаг асуудлууд

Бусад бүх хууль тогтоомжтой нэгэн адил хөрөнгө хураах хуулиуд үндэсний болон олон улсын шүүхийн өмнө тодорхой хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Эдгээрт өмчийн эрхтэй холбоотой асуудал багтдаг ба хөрөнгийг нь хурааж буй этгээдийн эрхийг хамгаалах талаар эрүүгийн журмаар хөрөнгө хураах ажиллагаанд мөрдөгддөг зарчмууд яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах тохиолдолд ижил түвшинд үйлчилдэг эсэх асуудлаар мэтгэлцээн маргаан өрнөдөг, үүнд тухайлбал, гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрх, эрүүгийн шүүхээр хэргээ шүүлгүүлэх эрх, өөрийгөө буруутгахгүй байх эрх, нэг хэргээр давхар

[56] АНУ-д энэ ажиллагааг хуулиар заасан байдаг 21 U.S.C. § 853(n).

[57] АНУ-д 18 U.S.C. § 983(d) заалтад иргэний журмаар хөрөнгө хураах хэргүүдийн тухайд гэм буруугүй өмчлөгчийн өмгөөллийн зарчмыг ашиглах талаар тусгасан.

хариуцлага хүлээхгүй байх, ял шийтгэлийг ухраан оноохоос хамгаалагдах гэх мэт асуудлууд байж болно.

Эдгээр маргааны дийлэнх нь хөрөнгө хураахыг ял шийтгэл гэж үзэх үү эсхүл засаж залруулах арга хэмжээ гэж үзэх үү гэдгээс үүдэлтэй. Хэрэв хөрөнгө хураахыг ял шийтгэл гэж үзвэл эрүүгийн хуулийн дагуу олгогддог хамгаалалтын заалтууд хамаарах ёстой болно.

Эсрэгээр хэрэв хөрөнгө хураахыг засаж залруулах арга хэмжээ гэж үзвэл хэрэглэх цар хүрээ нь нэмэгдэх ёстой. Захиргааны байгууллагууд болон иргэний шүүхээр хэлэлцэх, мөн баримт нотолгооны өөр стандарт, няцаагдах боломжтой презумпци (эрүүгийн зөвхөн тодорхой зөрчлүүдийн тухайд ашиглахыг зарим улс орнуудад зөвшөөрдөг), ухраан хэрэглэх зэргийг ашиглаж болно гэсэн үг. Ийнхүү илүү өргөн цар хүрээгээр ашиглах арга барилыг олон улс орны шүүх дэмжиж, зөвшөөрөх болсон. [58]

Зарим улс орнуудад хөрөнгө хураах ажиллагааны мөн чанарын талаарх маргаан арай өөр байдлаар өрнөдөг: хөрөнгө хураахыг ял шийтгэл гэж үздэг улс оронд хэрэглээ нь хуульд заасан зөвхөн явцуу хүрээний тохиолдлуудаар хязгаарлагддаг. Засаж залруулах арга хэмжээ гэж үздэг улс орнуудад хэрэглээ нь арай өргөн цар хүрээг хамардаг ба тодорхойгоор зааж хасаагүй л бол хууль бус орлого олсон бүх л гэмт хэргүүдэд нийтлэг ашигладаг. [59]

Хөрөнгө хураах дэглэм нь орлого болон хэрэгслийг тодорхойлох, битүүмжлэх, удирдах, хураах, борлуулах, хуваах, буцаах зэргийг бүхэлд нь хамрах ёстой. Няцаагдах боломжтой презумпцийг тодорхойлох замаар хөрөнгө хураах эрх зүйн тогтолцооны цар хүрээг эрх бүхий байгууллагууд тэлж өгч болдог. Цаашилбал, их хэмжээний ашиг олдог гэмт хэргүүд (үүнд авлига, мөнгө угаах хэргүүд ч мөн хамаарна) хил дамнан хэрэгжих нь түгээмэл байдаг тул хөрөнгө хураах дэглэм нь дотоодод гаргасан хөрөнгө хураах шийдвэрийг гадаадад хэрхэн хэрэгжүүлэх заалтуудыг агуулсан байх ёстой.

---

[58] Европын Хүний эрхийн шүүх дараахыг тогтоосон, үүнд: хэрэв дүн нь олсон ашиг хонжоогоор хязгаарлагдаж байгаа бөгөөд хорих ялаар орлуулах боломжгүй, харин эдийн засгийн бусад арга хэмжээгээр орлуулах боломжтой бол гэмт хэргийн орлогыг хураах нь засаж залруулах арга хэмжээнд тооцогдоно: Уэлш ИБУИНВУ-ын эсрэг (no.17440/90, 2-р сарын 9, 1995); Филипс ИБУИНЬУ-ын эсрэг (no. 41087/98, 7-р сарын 5, 2001); ба Батлер Их Британийн эсрэг (no. 41661/98, 6-р сар 27, 2002) зэргээс үзнэ үү. Сүүлийн үеийн нэг жишээ авч үзвэл, Гогитидзе Гүржийн эсрэг (no. 36862/05, 5-р сарын 12, 2015) хэрэгт уг шүүхээс эрүүгийн яллах дүгнэлтгүйгээр иргэний журмаар хөрөнгө хураах шийдвэр гаргасан нь яллан шийтгэх бус харин урьдчилан сэргийлэх бөгөөд нөхөн төлбөр олгох зорилготой гэж тогтоосон. Өөр бусад орнуудын тодорхой жишээнүүдийг Грийнберг ба бусад (2009, 19–21)-аас үзнэ үү. АНУ-ын хөрөнгө хураах тогтолцоо нь хамгийн өндөр хөгжсөн дэглэмд тооцогддог. Хуулийн болон шийдвэр гаргах байгууллагуудын түүхэн хөгжил ба одоогийн нөхцөл байдлын талаар Касселла (2013)-аас үзнэ үү.

[59] 2012 онд Азербайжан хөрөнгө хураах тогтолцоогоо шинэчилсэн, ингэхдээ хөрөнгө хураах арга хэмжээг явцуу хүрээний гэмт хэрэг, зөрчлийн тухайд үндсэн болон нэмэлт ял шийтгэл байдлаар оногдуулдаг байсныг өөрчилж хууль бус ашиг олох эх үүсвэр болсон бүх гэмт хэргийн тухайд ашиглаж болох эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг хэрэгсэл болгосон.

7.7 Гадаад улсад байршуулсан хөрөнгийг хураах

Авлига, мөнгө угаах хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагаа хил давж гадаад улс орнуудаас хамтын ажиллагаа, тусламж авах байдлаар явагдах нь түгээмэл байдаг.[60] Гадаад улс орон оролцох нь тухайн хэргийг хүндрүүлдэг, үүний хажуугаар олон шинэ боломжуудыг нээж өгдөг. Жишээлбэл, авлига, мөнгө угаах дотоодын хэрэгт гадаадад мөнгө угаах хэрэг хавсарсан бол шинээр хэд хэдэн хувилбар гарч ирдэг (зураг 7.1), тухайлбал:

- Хөрөнгө хураах дотоодын хэргийг авч хэлэлцээд гадаадад байрлалтай өмчийг хураах шийдвэр гарсан бол тухайн шийдвэрийг олон улсын гэрээ, хэлэлцээр, эсхүл бусад гэрээний дагуу харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн хүрээнд хэрэгжүүлж болдог.[61] (Бүлэг 1, 9-өөс харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний талаар, мөн хөрөнгө хураах шийдвэрийг гадаадад хэрхэн хэрэгжүүлэх тухай тайлбарласан.)
- Өмч хөрөнгө нь байршиж буй улс орны хууль хэрэгжүүлэх байгууллагууд гадаад дахь авлигын гэмт хэрэг ба тухайн гэмт хэрэг болон өмч, хөрөнгө хоорондын хэлхээ

ЗУРАГ 7.1 Гадаад улсад байршуулсан хөрөнгө хураах



[60] Жишээлбэл, Крисафулли-гийн хэргийг үзнэ үү, уг хэргийн хүрээнд Францад яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хууль байдаггүй хэдий ч Францын эрх бүхий байгууллагууд Италийн яллах шийдвэргүйгээр (урьдчилан сэргийлэх зорилго бүхий) хөрөнгө хураах тогтоолыг хүлээн авч гүйцэтгэсэн. Крисафулли-д Италийн шүүхээс хориотой бодис, мансууруулах бодис тээвэрлэхтэй холбогдсон эрүүгийн хэргээр ял шийтгэл ногдуулсан. Тэр бээр Францад ээмшдэг байсан виллаг мансууруулах бодисын худалдаанаас олсон орлогоор худалдан авсан гэж үзсэн. Италийн эрх бүхий байгууллагуудын хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэх хүсэлтийн дагуу – Европын Зөвлөлийн Гэмт хэргийн орлогыг угаах, нэгжих, битүүмжлэх, хураах Конвенцод үндэслэн (1990 онд батлагдсан, 1993 онд хүчин төгөлдөр болсон) - хэдийгээр Францын үндэсний хуулиар эрүүгийн журмаар яллах дүгнэлт гарсны дараа л хөрөнгө хураах ажиллагааг эхлүүлэх боломжтой байдаг ч Францын Дээд шүүхээс Италийн хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэхээр тогтоосон. (Кассацийн шүүх, no. 03-80371,11-р сар 13, 2003).

[61] Жишээлбэл, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн буцаах заалтуудыг үзнэ үү, зүйл 54, 55, 57. АНУ-д 28 U.S.C. § 2467-д гадаадын хөрөнгө хураах шийдвэрийг хэрэгжүүлэх тухай заалтууд орсон.

- Гадаадад мөнгө угаах хэрэг нээж уг ажиллагааны хүрээнд хөрөнгийг хурааж болно. (Бүлэг 11 ба дэд бүлэг 7.8-аас хүсэлт гаргаж буй улс орнуудад ямар хувилбарууд байгааг үзнэ үү, үүнд зарим орнууд "иргэний этгээд" статусаар хэрэгт нэгдэх боломж мөн хамаарна.)
- Гадаад дахь болон дотоодын ажиллагааг нэгтгэн хэрэгжүүлж болно. Салбарын мэргэжилтнүүд өмч нь байршиж буй улс орнууд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцоор шаардаг (зүйл 54-55) гадаадын хөрөнгө хураах шийдвэрийг хэрэгжүүлэх механизм байгаа эсэхийг анхнаас нь судалж үзэх хэрэгтэй, ингэхдээ гэмт хэргийг дүгнэлтийг өөрчилж болохгүй. (Бүлэг 1, 9-өөс хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэх, хөрөнгийг буцаах асуудлаар олон улсын хамтын ажиллагаа хэрхэн хэрэгжүүлэх талаар үзнэ үү.)

7.8 Хөрөнгө хураах замаар эрүүгийн хэрэгт хохирлыг барагдуулах нь.

Хөрөнгө хураах механизмыг гэмт хэргийн хохирогч нарт зориулан хэрэгжүүлэх явдал улам бүр түгээмэл болсон.[62] Төрийн сан, эсхүл төсөв рүү хөрөнгө төвлөрүүлэх зорилгоос илүүтэйгээр гэмт хэргийн хохирогчдод голлох ач холбогдол өгөх байдлаар хууль тогтоомж, журмуудыг сүүлийн үед баталж байна. Нөхөн олговор олгох шийдвэр болон хөрөнгө хураах шийдвэрийг аль алиныг гүйцэтгэхэд хангалттай хөрөнгө байгаа бол хохирогчдод нөхөн олговор олгосны дараа хураасан хөрөнгөөс үлдсэн хэсгийг төрийн сан, төсөвт шилжүүлэх боломжтой.

Гэмт хэргийн улмаас нөхөн төлбөр авах эрхтэй хохирогчдын хохирлыг барагдуулалгүйгээр хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэх ёсгүй гэсэн зарчмыг эдгээр механизмуудад баталгаажуулж өгдөг. Мөн бас нэг давуу тал байдаг, тухайлбал, албан ёсоор ял шийтгэл ногдуулсан тохиолдолд хөрөнгө хураах зорилгоор хөрөнгийг битүүмжлэх заалтууд иргэний журмаар хохирол барагдуулах, нөхөн төлбөр гаргуулах шийдвэрийг хэрэгжүүлэхэд ашиглаж болдог арга хэмжээнүүдээс илүү чанга байдаг. Эцэст нь хэлэхэд иргэний шүүхийн журмаар хэрэг үүсгэхэд ихээхэн хэмжээний (буцаах боломжтой хөрөнгийн үнийн дүнгийн хувиар тооцдог) хуулийн зардал гардаг, хөрөнгө хураах шийдвэр гаргуулах замаар гэмт хэргийн хохирогч нарт нөхөн төлбөр олгох явцыг ашиглавал дээрх хуулийн зардлыг хэмнэх боломжийг хохирогчдод олгодог.

Ийм практикийг олон улсын конвенцуудаар дэмждэг – тодруулбал Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн зүйл 53 (с)-д "энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч гэдгээ тогтоолгох тухай оролцогч өөр улсын шаардлагыг эд хөрөнгө хураах шийдвэр гаргах үедээ хүлээн зөвшөөрөхийг өөрийн шүүх буюу эрх бүхий байгууллагад зөвшөөрөхөд шаардлагатай бүхий арга хэмжээг авна" гэж заасан. Үүнээс гадна, тус конвенцийн 57.3 (с) -д "бусад бүх тохиолдолд, хураасан эд хөрөнгийг хүсэлт гаргагч оролцогч улсад буцаан өгөх, уг эд хөрөнгийг өмнөх хууль ёсны өмчлөгчид буцаан өгөх буюу гэмт хэргийн хохирогчид хохирлыг нөхөн төлөх асуудлыг эн тэргүүнд авч үзнэ" гэж заасан байдаг.

Эх газрын эрх зүйн тогтолцоотой олон улс оронд төр, эрүүгийн журмаар хөрөнгө хураахаас өмнө төрийн холбогдох байгууллагууд иргэний этгээд статусаар өөрийн

[62] Хохирогчийн нэрийн өмнөөс хөрөнгө хураах, царцаах практикийг Финлянд, Францад хэрэгжүүлдэг. (ЕС 2016, 23).

эрхээ нэхэмжилж болдог. Иргэний этгээдийн статус байхгүй байсан ч тэд прокурор, мөрдөн байцаах шүүгч, эсхүл шүүхэд хандан өөрийн өмчийг сэргээж өгөх хүсэлтийг гаргаж болно. Үүний нэгэн адил, хөрөнгө хураах шийдвэр гарахад өмнө нь өмчлөлд нь байсан боловч хулгайд алдаж, завшуулсан өмч хөрөнгийн нөхөн төлбөрийг буцаан олгох боломжийг хохирогч нарт олгосон зүйл заалтууд нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хууль тогтоомжид багтсан байдаг.

Хураах хөрөнгийг тодорхойлж эсхүл битүүмжилсэн нөхцөлд өмчлөх эрхтэй байж болзошгүй талуудад уг ажиллагааны талаар мэдэгдэх ёстой тухай заалтыг хуулийн тогтолцоонуудад суулгаж өгсөн байдаг (Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, зүйл 56). Энэ үүргийг хэрэгжүүлээгүй нөхцөлд прокуророууд болон холбогдох байгууллагууд гадаадын төрийн байгууллагуудын ашиг сонирхол авлигын хэргийн улмаас хохирох боломжтойг харгалзан үзэхгүйгээр хэрэг шийдэх нөхцөл үүснэ, ингэснээр гадаадын төрийн байгууллага өөрийн эрхээ хамгаалан нэхэмжлэх боломжийг үгүйсгэж байна гэсэн үг.

Ном зүй

Adam, Rita. 2013. “Innovation in Asset Recovery, The Swiss Perspective.” In The World Bank Legal Review, Volume 4: Legal Innovation and Empowerment for Development, edited by Hassane Cissé, Sam Muller, Chantal Thomas, and Chenguang Wang, 253–64. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank.org / handle/10986/12229.

Boucht, Johan. 2017. “Extended Confiscation: Criminal Assets or Criminal Owners.” In Chasing Criminal Money: Challenges and Perspectives on Asset Recovery in the EU, edited by Katalin Ligeti and Michele Simonato, 117–38. Oxford, UK, and Portland, OR: Hart Publishing.

Brun, Jean-Pierre, Pascale Helene Dubois, Emile van der Does de Willebois, Jeanne Hauch, Sarah Jaпs, Yannis Mekki, Anastasia Sotiropoulou, Katherine Rose Sylvester, and Mahesh Uttamchandani. 2015. Public Wrongs, Private Actions: Civil Lawsuits to Recover Stolen Assets. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank and United Nations Office on Drugs and Crime. https://star.worldbank. org/sites/ star/files/9781464803703_0.pdf

Cassella, Stefan D. 2013. Asset Forfeiture Law in the United States, 2nd ed. Huntington, NY: Juris Publishing.

Cassella, Stefan D. 2015. “Civil Asset Recovery: The American Experience.” In Non-Conviction-Based Confiscation in Europe: Possibilities and Limitations on Rules Enabling Confiscation without a Criminal Conviction, edited by Jon Petter Rui and Ulrich Seiber, 13–30. Berlin: Duncker & Humblot. https://pure.mpg.de/rest/items / item_2499325_6/component/file_3081806/content.

Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime, Council of Europe Treaty No. 141 (November 8, 1990, entered into force January 9, 1993), Strasbourg, France. https://www.coe.int/en/web/conventions/full -list/-/conventions/rms/090000168007bd23.

EC (European Commission). 2016. “Impact Assessment Accompanying the Document ‘Proposal for a Regulation of the European Parliament and of the Council on the Mutual Recognition of Freezing and Confiscation Orders.’” Commission Staff

Working Document, EC, Brussels. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT / PDF/?uri=CELEX:52016SC0468&from=EN.

EC (European Commission). 2018. "Commission Implementing Decision of 10.8.2018 on the Preparatory Action for Support to EU Neighbours to Implement Asset Recovery to be Financed from the General Budget of the Union." Document C(2018) 5142 final, EC, Brussels. https://ec.europa.eu/neighbourhood -enlargement/sites/near/ files/c_2018_5142_preparatory_action_asset_recovery _merged.pdf.

EC (European Commission). 2020. "Asset Recovery and Confiscation: Ensuring that Crime Doesn't Pay." Report from the Commission to the European Parliament and the Council, COM(2020) 217 final, February 6, Brussels. https://ec.europa.eu /home-affairs/sites/homeaffairs/files/what-we-do/policies/european-agenda -security/20200602_com-2020-217-commission-report_en.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations." Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf /documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

Fazekas, Mihaly, and Eva Nanopoulos. 2016. "The Effectiveness of EU Law: Insights from the EU Legal Framework on Asset Confiscation." European Journal of Crime, Criminal Law and Criminal Justice 24 (1): 39–64. https://www.repository.cam.ac.uk/ bitstream/handle/1810/253705/Fazekas%20and%20Nanopoulos%20European%20 Journal%20of%20Crime%2C%20Criminal%20Law%20and%20Criminal%20 Justice.pdf?sequence=1&isAllowed=y.

FDFA (Swiss Federal Department of Foreign Affairs). 2016. "No Dirty Money: The Swiss Experience in Returning Illicit Assets." Booklet, FDFA, Bern. https://www.eda. admin.ch/dam/eda/en/documents/aussenpolitik/voelkerrecht / edas-broschuere-no-dirty-money_EN.pdf.

Greenberg, Theodore S., Linda M. Samuel, Wingate Grant, and Larissa Gray. 2009. Stolen Asset Recovery: A Good Practices Guide for Non-Conviction Based Asset Forfeiture. Washington, DC: World Bank. http://siteresources.worldbank.org / FINANCIALSECTOR/Resources/Stolen_Assest_Recovery.pdf.

Ivory, Radha. 2014. Corruption, Asset Recovery, and the Protection of Property in Public International Law: The Human Rights of Bad Guys. Cambridge: Cambridge University Press.

Mazzacuva, Francesco. 2017. "The Problematic Nature of Asset Recovery Measures: Recent Developments of the Italian Preventive Confiscation." In Chasing Criminal Money: Challenges and Perspectives on Asset Recovery in the EU, edited by Katalin Ligeti and Michele Simonato, 101–16. Oxford, UK, and Portland, OR: Hart Publishing. OECD (Organisation for Economic Co-operation and Development) and World Bank. 2012. Identification and Quantification of the Proceeds of Bribery: A Joint

OECD– StAR Analysis. Rev. ed. Paris: OECD. https://www.oecd-ilibrary.org/docserver /9789264174801-en.pdf?expires=1600641659&id=id&accname=guest&checksum= 337609114C09DBA4A84487B212880DF3.

Panzavolta, Michele. 2017. "Confiscation and the Concept of Punishment: Can There Be a Confiscation without a Conviction?" In Chasing Criminal Money: Challenges and

Perspectives on Asset Recovery in the EU, edited by Katalin Ligeti and Michele Simonato, 25–52. Oxford, UK, and Portland, OR: Hart Publishing.

Rui, Jon Petter, and Ulrich Seiber, eds. 2015. Non-Conviction-Based Confiscation in Europe: Possibilities and Limitations on Rules Enabling Confiscation without a Criminal Conviction. Berlin: Duncker & Humblot. https://pure.mpg.de/rest/items / item_2499325_6/component/file_3081806/content.

Simonato, Michele. 2017. "Confiscation and Fundamental Rights across Criminal and Non-Criminal Domains." ERA Forum 18 (3): 365–79. https://link.springer.com /article/10.1007/s12027-017-0485-0.

TI Italia (Transparency International Italia). 2013. "Illicit Assets Recovery in Italy: Enhancing Integrity and Effectiveness of Illegal Asset Confiscation." Report, TI Italia, Milan. https://docplayer.net/25502355-Illicit-assets-recovery-in-italy.html.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc.org / pdf/convention_1988_en.pdf.

UNTOC (United Nations Convention against Transnational Organized Crime), UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25.

World Bank. 2009. "Stolen Asset Recovery; Management of Returned Assets: Policy Considerations." Stolen Asset Recovery (StAR) initiative working paper, Report No. 55007, World Bank, Washington DC. https://documents.worldbank.org/en /publication/documents-reports/documentdetail/895271468332443748 / stolen-asset-recovery-management-of-returned-assets-policy-considerations.

8. Хөрөнгө буцаан авахтай холбоотой олон улсын хамтын ажиллагааны гол зарчмууд ба Хамтын ажиллагааны албан бус сувгууд

8.1 Удиртгал

Авлигын хэргүүд болон нарийн төвөгтэй мөнгө угаах хэргүүд ерөнхийдөө нэг улсын хилээр хязгаарлагдахгүй хөрөнгө буцаах арга хэмжээ авахыг шаарддаг. Зарим гэмт хэрэг болон гэмт хэргийн хэсгүүд өөр улсад үйлдэгдэж болно. Жишээ нь: Гэрээ байгуулахын төлөө авлига өгч буй компанийн төв байр эсхүл төлөөлөгчийн газар нь авлига өгч, авах үйл явц өрнөж буй улсаас өөр улсад байрлалтай байж болох ба авлига авч буй албан хаагч хууль бус орлогоо өөр улсад угааж болох юм. Түүнчлэн олон улсын санхүүгийн сектор нь хөрөнгөө угаахыг болон эд хөрөнгө мөшгөх ажиллагаанд саад болохыг эрмэлзэж буй этгээдүүдийн ихээхэн анхаарлыг татаж байдаг. Нягтлан бодогчид, хуульчид, итгэмжлэх болон компанийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг дундын зуучлагч нар санхүүгийн секторт нэвтрэх боломжийг олгодог ба авлига авсан албан хаагчийн хөрөнгийн шилжүүлэг болон эзэмшихэд оролцох оролцоог нуун далдлах үүрэгтэй ажилладаг. Эдгээр “хаалгач”-ууд хөрөнгийн араас явах өөр сэжмийг бий болгож болох ба ингэснээр хамрах улсуудын тоо нэмэгдэх боломжтой.

Авлига авсан албан хаагчид төвөгтэй санхүүгийн схемийг ашиглаж авлигаас олсон орлогоо угаахдаа ихэвчлэн оффшор, оншор санхүүгийн төвүүд, халхавч компани, хууль бус хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлахад ашиглаж байгаа хуулийн этгээдүүд зэрэг зохион байгуулахад хялбар аргыг ашигладаг. Түүнчлэн, компьютер, гар утасны ганц товчлуур дарснаар электрон шилжүүлэг, аккредитив, кредит болон дебит карт, АТМ, криптовалют, утасны төхөөрөмж зэргийг ашиглан мөнгийг гүйлгээнд оруулж болно.

Мөнгийг гүйлгээнд оруулж, далд бүтцийг болгоход богино хугацаа шаарддаг бол эсрэгээрээ хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурорууд хөрөнгийг мөшгөх, буцаахад хэдэн сар, жилийг ч зарцуулах тохиолдол байна. Учир нь тусгаар улсын бүрэн эрхт зарчмаас үүдэн гадаад улсад мөрдөн шалгах, хууль сахиулах үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагддаг. Эрх зүйн уламжлал, хууль, журам, хэл, цагийн бүс, нөөц, чадавхын ялгаатай байдлаас үүдэлтэй удааширсан, төвөгтэй процесс байдаг учир хөрөнгө мөшгөх, буцаах ажиллагааг амжилттай гүйцэтгэх эсэх нь ихэвчлэн гадаад улсын туслалцаа, дэмжлэгтэй хамааралтай байдаг.

Энэ утгаараа олон улсын хамтын ажиллагаа нь гадаад улсад нуусан, хадгалсан хөрөнгийг амжилттай буцаахад чухал ач холбогдолтой.[1]

[1] Украин Улсын Ерөнхийлөгч асан Виктор Януковичийн хөрөнгийг царцаасан явдал нь эхлэлээсээ олон улсын түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны жишээ юм.

ЗУРАГ 8.1 Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хийх хөрөнгө буцаах үе шатын интеграц

Эх сурвалж: Дэлхийн банк

Олон улсын хамтын нийгэмлэг үүнийг хүлээн зөвшөөрч (Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 46 болон 51 дүгээр зүйлийг харна уу) улсууд хоорондоо мөрдөн шалгах, нотлох баримтаар хангах, түр зуурын арга хэмжээ авах, хөрөнгө хураах, буцаах зэргээр улсууд хамтран ажиллах шаардлагатайг олон талт гэрээ, эрх зүйн баримт бичгүүдэд тусгажээ. Тодруулбал тус конвенцийн 51 дүгээр зүйлд "улс орнууд өргөн хэлбэрээр хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ" гэж тодорхой заасан байдаг. Диаграм 8.1-д хөрөнгө буцаах хэд хэдэн үе шаттай олон улсын хамтын ажиллагааны интеграцийг дүрслэн харуулав.

Салбарын мэргэжилтнүүдийн хувьд олон улсын хамтын ажиллагаа нь харилцан уялдаатай байдгийг анхааралдаа авч үзэх хэрэгтэй: хөрөнгөө алдсан улс гадаад улсаас эсхүл улсуудаас зөвхөн тусламж хүсэхээс гадна мэдээлэл, нотлох баримтаар эдгээр орнуудыг хангаснаар хөрөнгө буцаах ажиллагаа амжилтад хүрдэг. Түүнчлэн салбарын мэргэжилтнүүд олон улсын хамтын ажиллагаа хүсэх, гадаад улсууд дахь түнш байгууллагуудад болзошгүй авлигын гэмт хэргийн талаар сэрэмжлүүлэг өгөх талаар харилцан идэвхтэй байх ёстой.

Хамтын ажиллагааны төрлийг сонгох шийдвэр, үйл явц тухайн хэргээсээ шалтгаалан өөр өөр байх ба хамтын ажиллагааны бүхий л үе шатанд оролцож буй улсууд харилцан хэлэлцсэн байх хэрэгтэй. Энэхүү бүлэгт стратегийн асуудлууд, сорилт бэрхшээл, олон улсын хамтын ажиллагаанд оролцох салбарын мэргэжилтнүүдэд тулгарах олон төрлийн сонголтуудыг тодорхойлох зэрэг асуудлуудыг онцолно.

8.2 Албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн талаар харьцуулсан тойм

Уг гарын авлага нь нэг улсаас нөгөө улсад албан ёсны хүсэлт тавихыг шаарддаг эрх зүйн харилцан туслалцаа болон албан бус туслалцааны талаарх ялгааг тодорхойлно.

Тодруулбал, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг бичгээр илэрхийлж олон талт, хоёр талт болон дотоодын хууль эрх зүйн дагуу тодорхой журам, протокол, шаардлагад нийцүүлсэн байх ёстой. Мөрдөн шалгах ажиллагааны шатанд эдгээр хүсэлтүүд ерөнхийдөө нотлох баримт, түр зуурын арга хэмжээ авах, эсхүл мөрдөн шалгах ажиллагааны тодорхой арга техник ашиглах /банкны дансны бичиг баримт гаргуулах, нэгжих, битүүмжлэх шийдвэр гаргуулах, шаардлагатай бичиг баримтуудаар хангах/ талаар байдаг. Эрх зүйн харилцан туслалцаа нь ихэнхдээ хөрөнгө хураах шийдвэрийг хэрэгжүүлэхийг шаарддаг.

Албан бус туслалцаа нь ерөнхийдөө албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтээс бусад албан ажлын хүрээнд хийгдэх туслалцааг гэж ойлгоно. Зарим улсуудад албан бус туслалцаа нь эрх зүйн харилцан туслалцаатай холбоотой хууль тогтоомжоор баталгаажиж, албан ёсны эрх бүхий байгууллага, агентлаг, удирдлагууд оролцдог учир албан бус туслалцааг “албан ёсны эрх зүйн харилцан туслалцаа” гэж үздэг. Ийм хамтын ажиллагааны ач холбогдлыг олон улсын хэлэлцээр, стандартуудад чухалчилж тэмдэглэсэн байдаг.[2]

Албан бус туслалцааны хүрээнд цуглуулсан мэдээллийг шүүх хуралд нотлох баримтаар ашиглах боломжгүй байж болно. Харин уг мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагааг явуулахад хувь нэмэр оруулж болохуйц гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, суурь мэдээлэлтэй илүү төстэй ба эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргахад хүргэж болно.[3] Ийм “албан бус” процесс утсаар холбогдож харилцаж болохоос /Хууль сахиулах байгууллагууд, мөрдөн шалгах ажиллагааны магистрантууд, прокурорууд/ гадна захиргааны хамтын ажиллагааны эсхүл түншүүд хоорондын биечлэн уулзалт хэлбэрээр байж болно.[4] Ихэвчлэн эрх бүхий байгууллага хоорондын мэдээлэл солилцоо албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулахыг шаарддаггүй.

Албан бус туслалцаанд өөр улсад байх түнш байгууллагууд хоорондын ойлголцлын санамж бичгээр тогтсон захиргааны хамтын ажиллагааг оруулдаг /татвар, гаалийн байгууллага, санхүүгийн тагнуулын алба гэх мэт/. Ийм санамж бичгийг байгуулснаар шүүх, цагдаагийн байгууллагууд мэдээлэл солилцох боломж бүрдэж,

---

[2] Авлигын эсрэг конвенцийн 48, 50 дугаар зүйл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 26, 27 дугаар зүйл, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцийн 9 дүгээр зүйл, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагаас гаргасан зөвлөмж 40 /Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд/ 2019 он.

[3] Ерөнхийдөө, нийтийн эрх зүйт улсын хувьд албан бус туслалцааны үр дүнд авсан мэдээллийг шүүхэд нотлох баримтаар тооцдоггүй. Нөгөө талаас Эх газрын эрх зүйн тогтолцоот улсууд шүүхийг албан бус туслалцааны хүрээнд авагдсан мэдээллийг харгалзаж үзэхийг зөвшөөрдөг. Чили, Швейцар зэрэг улсууд ийм нотлох баримтыг хүлээн зөвшөөрдөг.

[4] Авлигын эсрэг конвенцийн 46 дугаарын зүйлийн 9-д улсуудыг давхар гэмт хэргийг шаардахгүйгээр туслалцаа үзүүлэх ёстойг дурдсан /9 дүгээр бүлгийн 9.2.2-т үүний талаар бичсэн/. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын зөвлөмж 37-д /Эрх зүйн харилцан туслалцаа/ ч улсууд давхар гэмт хэрэггүй хэдий ч бага халдсан, албадлагын бус арга хэмжээний үед эрх зүйн харилцан туслалцааг үзүүлнэ гэжээ.

банкны данс, мөнгөн шилжүүлэг, хил дамнасан мөнгөн гүйлгээний талаарх мэдээлэл олж авахад нэмэр болно. Зарим гааль, татварын захиргааны байгууллагууд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх мэдэлтэй байдаг. Мэдээлэл хүлээн авах эрх бүхий байгууллагуудын хувьд эдгээр механизмын хүрээнд солилцож буй мэдээлэл нь ихэвчлэн хязгаарлагдмал байдаг.

Эрх зүйн орчны хувьд албан бус туслалцаанд албадлагын бус мөрдөн шалгах арга хэмжээ буюу олон нийтэд ил мэдээлэл цуглуулах, ажиглалт хийх, санхүүгийн тагнуулын албанаас мэдээлэл авах гэх мэт орж болохын сацуу мэдээллийг шууд мэдээлэх, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эрх бүхий байгууллагыг өөр улсад хэрэг нээхийг хүсэх зэргээр өргөн хүрээнд байж болно. Зарим улсад яаралтай түр зуурын арга хэмжээ нь /тухайлбал хүлээгдэж буй мөнгөн шилжүүлэгт саад хийх/ албан бус сувгаар дамжиж ирдэг ч дараа нь эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтээр ирэх ёстой.

Нөгөө талаас албан ёсны туслалцаанд гэмт хэргээс олсон орлогыг өөр улс руу шилжүүлэх; шууд хөрөнгө буцаахыг зөвшөөрдөг дотоодын хуулийн хэрэгжилт; урьдчилан сэргийлэх хязгаарлалтын болон хөрөнгө царцаах өөр улсын шийдвэрийг хэрэгжүүлэх, бүртгэх; шилжүүлэн өгөх тухай хэлэлцээр зэрэг ордог.[5] Хүснэгт 8.1-т албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хоорондын ялгааг харуулав.

Хүснэгт 8.1 Албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хоорондын ялгаа

Хүчин зүйл	Албан бус туслалцаа	Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт
Зорилго	• Мөрдөн шалгах ажиллагаанд нэмэр болох гүйцэтгэх ажлын мэдээ болон мэдээллийг цуглуулах[a] • Яаралтай түр зуурын арга хэмжээг зарим улсад авах	• Эрүүгийн хэргийн шүүх хуралд болон улсын орлого болгоход нотлох баримт цуглуулах • Хязгаарлалт тогтоох, хөрөнгийг улсын орлого болгох шийдвэр гаргах
Туслалцааны төрөл	• Ил мэдээлэлд хандах эрх • Албадлагын бус мөрдөн шалгах ажиллагааны арга хэмжээ • Эрх зүйн үндэслэлийн дагуу хаалттай мэдээллийг ил болгох ажлыг үр дүнтэй хийх • Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа • Гадаад улсад хэрэг нээх	• Албадлагын мөрдөн шалгах ажиллагааны арга хэмжээ /нэгжлэг хийх шийдвэр гэх мэт/ • Шүүхийн туслалцааны бусад хэлбэрүүд /урьдчилсан арга хэмжээ авах шийдвэр, улсын орлого болгох шүүхийн шийдвэр гэх мэт/

[5] Шилжүүлэн өгөх гэдэг нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эсхүл шийтгэгдсэн хэрэгтнийг шилжүүлэх үйл явц юм. Хэрэгтнийг шилжүүлэн өгөхтэй холбоотой процессын зарим хэсэг болон тавигдах шаардлагууд нь эрх зүйн туслалцаанд тавигдах шаардлагуудтай төстэй боловч иргэншил, тусгай баталгаа болон эрхийн /the doctrine of non-inquiry/ талаарх тусгайлсан шаардлагууд мөн тавигддаг. Энэ асуудлуудыг дэлгэрэнгүй авч үзнэ гэвэл энэхүү Гарын авлагын агуулга, хүрээнээс халин гарах юм.

Хүснэгт 8.1 Албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хоорондын ялгаа

Харилцах үйл явц	Шууд:	Ихэвчлэн, шууд бус:
	• Хууль сахиулах байгууллага, прокурор, мөрдөн шалгах ажиллагааны магистрантаас түнш рүү • Санхүүгийн тагнуулын албад, банк, үнэт цаасны салбарын зохицуулагч нар эсхүл татвар, гаалийн байгууллагуудын хоорондb	• Тухайн улсын эрх бүхий төв байгууллагаар дамжина.c • Гадаад харилцааны яамаар дамжих шүүхийн захидал
Шаардлага	• Голчлон агентлаг хоорондын харилцаа байх ба зарим тохиолдолд ойлголцлын санамж бичиг байгуулах • Хоёр талд хуулийн дагуу цуглуулсан байх	• Давхар гэмт хэрэгт тооцогдсон байх ёстой ба харилцан ажиллах, үргэлжилж буй эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, хөрөнгө болон гэмт хэргийн хоорондын холбоос шаардлагатай.
Давуу тал	• Мэдээллийг түргэн шуурхай олж авах боломжтой. Эрх зүйн харилцан туслалцааны албан хүсэлт шаардлагагүй. /жишээ нь давхар гэмт хэрэгт тооцогдсон байх гэх мэт/ • Авагдсан баримт, мэдээллийг нягталж эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргахад нэмэртэй.	• Шүүхэд зөвшөөрөгдөхүйц нотлох баримт • Албадан хэрэгжүүлэх шийдвэр гаргах боломжтой
Сул тал	• Мэдээлэл нь хязгаарлалтгүйгээр ил болгоход хүндрэлтэй ба нотлох баримтад тооцогдохгүй • Холбоо барих талуудыг тодорхойлоход төвөгтэй • Сүлжээ үүсгэхэд хуваарилагдсан эх сурвалж цөөхөн • Мэдээлэл алдагдах эрсдэлтэй	• Цаг хугацаа их зарцуулдаг • Ажиллагаа ихтэй • Өндөр шаардлага тавигддаг • Мэдээлэл алдагдах эрсдэлтэй

Эх сурвалж: Дэлхийн банк

a. Зарим тохиолдолд албан бус туслалцааны явцад эрүүгийн хэргийн шүүх хуралд ашиглаж болохуйц нотлох баримтыг эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулах шаардлагагүйгээр авч болдог. Тухайлбал, гадаад улсын хууль сахиулах байгууллагын дарсан фото зураг, олон нийтэд нээлттэй баримт сэлт, эсхүл дотоодын хууль сахиулах байгууллагын баталгаат баримт сэлтээр хангах.

b. Татвараас зайлсхийх, татвар төлөхөөс зугтах асуудлын хүрээнд татварын хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай олон талт конвенцод улс орнууд нэгдэн орсон. Тус конвенцийн 6 дугаар зүйлд эрх бүхий байгууллагууд автоматаар мэдээлэл солилцохыг зөвшөөрөхийг шаардсан байдаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай олон талт конвенцыг харах /2020 оны 9 дүгээр сард шинэчлэгдсэн/ https://www.oecd.org/ctp/exchange-of-tax-information/convention-on-mutual-administrative-assistance-in-tax-matters.htm. https://www.oecd.org/tax/automatic-exchange/.

c. Оролцогч талуудын хоорондш шууд харилцахыг зөвшөөрсөн хоёр талт болон олон талт хэлэлцээрүүд байж болно.

8.3 Олон улсын хамтын ажиллагаанд анхаарах үндсэн асуудлууд

Хөрөнгө буцаах стратегид олон улсын хамтын ажиллагааны асуудлыг эхнээс нь[6] анхаарах шаардлагатай. Иймд салбарын мэргэжилтнүүд дараах дөрвөн зарчмыг анхааран авч үзэх нь зүйтэй.

8.3.1 Хэргийн бүх үе шатан дахь олон улсын хамтын ажиллагаа

Тухайн хэрэгт нэгээс илүү улс оролцсон тохиолдолд салбарын мэргэжилтнүүд хэргийн хугацааг хэвийн байлгах үүднээс олон улсын хамтын ажиллагааны идэвхжүүлэхэд нэн даруй анхаарах нь чухал. Зарим байгууллагууд хөрөнгө мөшгөх, гадаад дахь хөрөнгийг баталгаажуулах үйл явц эхлэхээс өмнө яллах болон хөрөнгө хураах дотоодын шийдвэр гарахыг хүлээдэг ба ингэж хугацаа алдсанаар авлига авсан албан хаагч хөрөнгөө өөр хамтын ажиллагаагүй улс руу шилжүүлэх боломжтой болох зэрэг сөрөг үр дагавар ихэвчлэн гардаг. Иймд бусад улсаас эрх бүхий байгууллагыг оролцуулах нь зайлшгүй шаардлагатай бөгөөд эхний ээлжид албан бус байдлаар ч оролцуулж болно.

Эхнээс нь идэвхтэй харилцааг бий болгох нь салбарын мэргэжилтнүүдэд гадаад улсын хууль эрх зүйн тогтолцоо, тулгарч болзошгүй сорилтуудыг ойлгох, нэмэлт сэжүүр олох, стратеги боловсруулахад ач холбогдолтой юм. Түүнчлэн тухайн гадаад улсад хамтын ажиллагааны үүрэг оролцоогоо ойлгож, бэлтгэх боломж олгоно. Шигтгээ 8.1 болон 8.2-т хөрөнгө буцаах үйл ажиллагаанд хамтран ажилласан хэд хэдэн улсын салбарын мэргэжилтнүүдийн хоёр кэйсийг оруулжээ.

ШИГТГЭЭ 8.1 Operação Lava Jato (Автомашин угаалга ажиллагаа): АНУ, Бразил, Швейцар улсуудын хамтын ажиллагаа

"Автомашин угаалга" арга хэмжээ нь эхэндээ зөвхөн мөнгө угаах[a] хэргийг мөрдөн шалгах ажиллагаа байсан ч удалгүй газрын тос, байгалийн хийн томоохон компаниудын нэг Бразил Улсын төрийн өмчит Петролео Бразилэйро /Петробрас/ компанийг оролцуулсан авлигын эсрэг том арга хэмжээ болж өргөжсөн. Мөрдөн шалгах ажиллагааг Петробрас болон барилгын том компани болох Одебрехт зэрэг түүний ханган нийлүүлэгчид хоорондын хэвийн бус санхүүгийн гүйлгээний дараа анх 2014 оны 3 дугаар сард Бразилийн холбооны цагдаагийн байгууллага болон Бразилийн прокурорын албанаас томилогдсон ажлын хэсэг эхлүүлэв. Хожим эдгээр гүйлгээнүүд нь Петробрас компани удирдлагуудын хууль бус үйл ажиллагаа болон улс төрчдийн сонгуулийн кампанит ажлыг санхүүжүүлэхэд ашиглаж байсан хахууль байсан нь тогтоогдсон.

Уг кэйсийг анхдагч бөгөөд Бразил Улсын түүхэн дэх хамгийн өргөн хүрээтэй авлигын хэргийг мөрдөн шалгах ажиллагаа гэж тайлбарладаг.[b] 2018 оноос хойш 340 орчим хариуцагчийн эсрэг 80 гаруй эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[6] Тодорхой улс орнуудтай холбоотой асуудлыг ойлгохын тулд салбарын мэргэжилтнүүд Хөрөнгө буцаах заавар (https://star.worldbank.org/ArabForum/asset-recovery-guides) болон Дэлхийн банкны Хулгайлагдсан хөрөнгө буцаах тухай санаачилгын хүрээнд боловсруулсан Эцсийн өмчлөлийн тухай заавар (https://star.worldbank.org/content/beneficial-ownership-guides)-ыг харж болно. Түүнчлэн Хулгайлагдсан хөрөнгийг үр дүнтэй буцаах тухай Лозаннагийн гарын авлагыг харах (тус номын 2 дугаар бүлгийн Шигтгээ 2.5-д тайлбарласан) о https://guidelines.assetrecovery.org/guidelines.

ШИГТГЭЭ 8.1 Operação Lava Jato (Автомашин угаалга ажиллагаа): АНУ, Бразил, Швейцар улсуудын хамтын ажиллагаа

Эдгээр хэргүүдийн дийлэнх нь аль хэдийн шүүхээр шийдэгдсэн ба 140 орчим хариуцагчийг авлига, хээл хахууль, мөнгө угаах болон бусад гэмт хэрэгт буруутган 200 гаруй ял, шийтгэл оноожээ.[c]

Эхэн үедээ энэ дуулиант хэргийн талаар олон улсын хэмжээнд яригдаж хэд хэдэн улс болон компаниуд оролцсон болох нь тодорхой болсон. Иймээс Бразил Улс энэхүү авлигын нарийн ээдрээтэй авлигын торыг илрүүлэхээр эдгээр улсуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай болжээ. 2014-2018 оны хооронд Бразил Улсын холбогдох байгууллагууд 269 удаагийн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг 45 оронд тавьж, гадаад улсын 36 байгууллагаас 248 удаагийн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хүлээн авчээ.[d] Үүнийг бичиж байх үед Бразил Улс мэдээлэл солилцох хэлэлцээрийг Аргентин, Швейцар, Норвег, Нидерланд болон бусад улстай байгуулсан байв.[e]

Тухайлбал, АНУ-тай[f] өрнүүлж буй тэдний хамтын ажиллагаа нь дотоодын улс төрийн авлигын асуудлыг шийдвэрлэхийг хүсэж буй улсад бодит жишээ болж өгсөн.[g] Бразил Улс болон АНУ-ын холбогдох байгууллагууд Одербрехт барилгын компани болон түүний харьяа нефть химийн алба Браскемыг /Петробрас компани бага хэмжээний хувьцааг нь эзэмшдэг/ мөрдөн шалгах ажиллагаа зэрэг энэхүү дуулиант хэргийн зарим хэсгүүд дээр хамтран ажиллажээ.[h] Одербрехт болон Браскем компани дэлхий даяар ахлах албан тушаалтнуудад их хэмжээний хахуулийг системтэйгээр өгч байсан нь илэрсэн байна.[i]

Бразил Улс болон АНУ-ын прокурорууд нотлох баримт цуглуулан хэргийг илрүүлэхэд нягт хамтран ажилласны үр дүнд Бразил Улс, АНУ, Швейцар Улсын талаас Одербрехт болон Браскем компанийг яллагдагчаар татсан ба тэд буруугаа хүлээн зөвшөөрч 3.5 тэрбум ам.долларын торгууль төлөхөөр зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч энэ хоёр компани тус тусдаа хууль сахиулах байгууллагуудтай ял наймаалцах тохиролцоог хийсэн.[j] Тохиролцооны дагуу Бразил Улс нийт торгуулийн 80 хувийг авч, АНУ, Швейцар Улс тус бүр 10 хувь авахаар байжээ. Эдгээр дэлхийн хэмжээний тохиролцооны үр дүнд давхар торгууль, шийтгэл оноох асуудал цэгцлэгдэхийн зэрэгцээ торгууль, шийтгэлийн шударга байдлыг хангаж, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллахад түлхэц болсон.

АНУ-ын Хууль зүйн яамны мэдээлснээр, нарийн төвөгтэй уг хэргийг мөрдөн шалгах, яллахад олон улсын хамтын хүчин чармайлт онцгой нэмэр оруулсны үр дүнд дээрх тохиролцоонд хүрсэн ба гадаад улс дахь хамгийн том авлигын хэргийг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн.[l]

a. Арга хэмжээний нэрийг гэмт хэргээс олсон орлогоо угаахад ашиглаж байсан шатахуун түгээх станц, авто угаалгаас санаа авчээ. Жонатан Уаттс, 2017. "Автомашин угаалга арга хэмжээ: Түүхэн дэх хамгийн дуулиант авлигын хэрэг үү?" Гардиан сэтгүүл, 2017.06.01 https://www.theguardian.com/world/2017/jun/01/brazil-operation-car-wash-is-this-the-biggest-corruption-scandal-in-history.
b. Энэхүү гарын авлагын 2 дугаар бүлгийн 2.4, 3.1, 3 дугаар бүлгийн 3., 4 бүлгийн 4.2, 5 дугаар бүлгийн 5.5 дугаар Шиттгээт Лава Жатогийн хэргийн талаар дурдсан.
c. Бразил Улсын прокурорын алба, "A Lava Jato em números no Paraná" [Car Wash, by the Numbers, in Paraná State], 2020.03.19-нд шинэчлэгдсэн. http://www.mpf.mp.br/grandes-casos/lava-jato/resultados.
d. Бразил Улсын прокурорын алба, "A Lava Jato em números no Paraná."
e. Нэтэн Дэвис. 2018. "Автомашин угаалга арга хэмжээтэй холбоотой Аргентин болон Бразил Улсуудын мэдээлэл солилцоо" Эл Хэмисферио, 2018.07.20 https://elhem.co/2018/07/20/argentina-brazil-to-share-some-information-related-to-operation-car-wash/.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.1 Operação Lava Jato (Автомашин угаалга ажиллагаа): АНУ, Бразил, Швейцар улсуудын хамтын ажиллагаа

f. АНУ-ын Хууль зүйн яам. 2016. "Одербрехт, Браскем компаниуд гэм буруутайгаа хүлээ зөвшөөрч, хамгийн том авлигын хэргийг шийдвэрлүүлэхээр 3.5 тэрбум ам.доллар төлөхөөр тохиролцлоо" Хэвлэлийн мэдээ №16-1515, 2016.12.21 https://www.justice.gov/opa/pr/odebrecht-and-braskem-plead-guilty-and-agree-pay-least-35-billion-global-penalties-resolve.
g. Кийс Томпсон. 2018. "Бразил Улс: Авлигын хэргийг яллахад олон улсын хамтын ажиллагааны жишиг болов." Дэлхийн авлигын эсрэг блог, 2018.06.21 https://globalanticorruptionblog.com/2018/06/21/brazil-a-model-for-international-cooperation-in-foreign-bribery-prosecutions/.
h. АНУ-ын ХЗЯ, "Одербрехт, Браскем компани гэм буруугаа хүлээв" 2016.12.21 https://www.justice.gov/opa/press-release/file/919901/download.
i. АНУ-ын ХЗЯ, "Ерөнхий прокурорын орлогчийн үүрэг гүйцэтгэгч Кенет А.Бланко Атлантын зөвлөлийн арга хэмжээний үеэр "Бразил Улсаас үлдсэн сургамж: хямрал, авлига, дэлхийн нийтийн хамтын ажиллагаа" гэх илтгэл тавьжээ. 2017.07.19 https://www.justice.gov/opa/speech/acting-assistant-attorney-general-kenneth-blanco-speaks-atlantic-council-inter-american-1. Мөн АНУ-ын ХЗЯ-ны "Одербрехт, Браскем компани гэм буруугаа хүлээв" мэдээг харах. 2016.12.21.
j. Одербрехт компанид тавьсан торгууль хамгийн багадаа 2.6 тэрбум ам.доллар ба тус компанийн төлөх чадвараас хамааран цаашлаад 4.5 тэрбум ам.доллар хүртэл байжээ. Браскем компанийн хувьд нийт торгууль 957 сая ам.доллар байв. (АНУ-ын ХЗЯ, "Одербрехт, Браскем компани гэм буруугаа хүлээв" 2016.12.21).
k. АНУ-ын ХЗЯ, "Одербрехт, Браскем компани гэм буруугаа хүлээв" 2016.12.21
l. АНУ-ын ХЗЯ, "Одербрехт, Браскем компани гэм буруугаа хүлээв" 2016.12.21. 2020 оны 2 дугаар сарын "Эйрбас"-ийн тохиролцоо нь Франц, Их Британи, АНУ-ыг хамруулсан бас нэгэн гадаад улс дахь авлигын хэргийн жишээ билээ. АНУ-ын ХЗЯ 2020 оны "Эйрбас компани 3.9 тэрбум ам.долларыг төлөхөөр тохиролцов" Хэвлэлийн мэдээ №20-114, 2020.01.31. https://www.justice.gov/opa/pr/airbus-agrees-pay-over-39-billion-global-penalties-resolve-foreign-bribery-and-itar-case.

ШИГТГЭЭ 8.2 ВимпелКомын хэрэг: 20 улсын прокурор, зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа

ВимпелКомын кэйс нь 20 улсын прокурор, зохицуулагч байгууллагууд түүхэн дэх гадаад улс дахь авлигын томоохон хэргүүдийн нэгийг мөрдөн шалгахад хэрхэн хамтран ажилласан тухай нэгэн жишээ юм.a (2 дугаар бүлгийн 2.9 дүгээр шиг тгээг харна уу)

Уг кэйс нь ВимпелКом (Дэлхийн зургаа дахь том цахилгаан холбооны компани) болон Узбекистан дахь түүний охин компани Юнител зэрэг компаниуд 2006-2012 оны хооронд Узбекистаны Засгийн газрын албан хаагчдад авлига өгдөг байсан (цахилгаан холбооны зөвшөөрөл, давтамж, суваг болон бусад давуу байдал олж авахын тулд) болон мөнгө угаасан талаар юм.[b]

ВимпелКом компани эрүүгийн болон зохицуулалтын шийтгэлийг шийдвэрлэхийн тулд АНУ, Нидерландын талд 800 сая ам.доллар төлөхөөр тохиролцсон[c] нь АНУ-ын Хууль зүйн яам болон АНУ-ын Үнэт цаас, биржийн комисс, Нидерланд Улсын Прокурорын газар, Бельги, Франц, Латви, Люксембург, Швед, Швейцар, Их Британи зэрэг орнуудын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүн юм.[d]

Мөн АНУ-ын Хууль зүйн яам 850 сая ам.долларыг буцаахаар оролдож байна. Уг шалтгааны улмаас хоёр иргэний гомдол гарсан: Нэг нь Швейцарийн банкны дансанд байгаа хууль бус авлигаас олсон 550 сая ам.доллар, угаахад оролцуулсан эд хөрөнгө нэхэмжилж байна. Нөгөө нь Бельги, Ирланд, Люксембургт зарцуулах эрхийг хязгаарласан 300 сая ам.доллар нэхэмжилжээ. Мөрдөн шалгах

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.2	ВимпелКомын хэрэг: 20 улсын прокурор, зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагаа

ажиллагааны үр дүнд АНУ-д 1.3 тэрбум ам.долларын торгууль төлсөн ба 2.6 тэрбум гаруй ам.долларыг холбогдох улсуудад торгууль болон буцаан олгох хэлбэрээр төлжээ.

a. АНУ-ын ХЗЯ. 2016. Хэвлэлийн мэдээ №16-194, 2016.02.18 https://www.justice.gov/opa/pr/vimpelcom-limited-and-unitel-llc-enter-global-foreign-bribery-resolution-more-795-million.
b. АНУ-ын ХЗЯ, "ВимпелКом, Юнител ХХК" 2016.02.18; АНУ-ын Үнэт цаас, биржийн комисс 2016. "ВимпелКом компани гадаад дахь авлигын хэргийн хуулийг зөрчсөн тул 795 сая ам.долларыг төлөх болов" хэвлэлийн мэдээ №2016-34, 2016.02.18. https://www.sec.gov/news/pressrelease/2016-34.html.
c. АНУ-ын ХЗЯ, "ВимпелКом, Юнител ХХК" 2016.02.18
d. АНУ-ын ХЗЯ, "ВимпелКом, Юнител ХХК" 2016.02.18. "ВимпелКом компани 795 сая ам.долларыг төлөхөөр болж, Узбекистан дахь их хэмжээний авлигын хэргийг хүлээн зөвшөөрлөө" Райн Ролфсен, Жошуа Ашер 2016.02.19. https://www.lexology.com/library/detail.aspx?g=6d9fae12-f209-47a0-9be4-e6134e386698.
e. АНУ-ын ХЗЯ, "ВимпелКом, Юнител ХХК" 2016.02.18
f. АНУ-ын ХЗЯ, 2019. "Узбекистаны Засгийн газрын холбогдох албан тушаалтан асан, цахилгаан холбооны удирдлага 1 тэрбум ам.долларын авлига, мөнгө угаах гэмт хэрэгт буруутгагдав" Хэвлэлийн мэдээ №19-067, 2019.03.07.https://www.justice.gov/usao-sdny/pr/former-uzbek-government-official-and-uzbek-telecommunications-executive-charged-bribery.

8.3.2 Хувийн харилцаа, холбоо тогтоох, түүнийг хадгалах

Гадаадын түнш байгууллагуудтай хувийн харилцаа тогтоох нь амжилттай хөрөнгө буцаасан кэйсүүдийн нийтлэг шинж юм. Утас, цахим шуудан, видео хурлаар холбогдох, биечлэн уулзалтыг гадаадын түншүүдтэй хийх нь хэргийг илрүүлэхэд нэн чухал шаардлагатай. Харилцаа, холбоо нь мэдээлэл, гүйцэтгэх ажлын мэдээ олох, стратегийн шийдвэр гаргах, гадаад улсын шаардлагыг ойлгох, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн төслийг бэлтгэх, хүсэлтийн мөрөөр дахин холбогдох зэрэг бүхий л шатанд чухал нөлөөтэй. Ингэснээр нэр томьёо, хууль эрх зүйн ялгаатай байдлаас гарах үл ойлголцол, хоцрогдлыг багасгах үр дүнтэй. Түүнчлэн, захиргаа удирдлагын зүгээс хэрэгт ач холбогдол өгч байгааг харуулах боломжтой ба үүний үр дүнд талуудын итгэлцлийг бэхжүүлж, анхаарал хандуулан ач холбогдол өгөх болно.

Том кэйсүүдийн хувьд, мөрдөн шалгах ажиллагаанд оролцож буй хэд хэдэн улсын салбарын мэргэжилтнүүд биечлэн уулзалт хийх нь мэдээлэл солилцоог хөнгөвчилдөг. Үүнээс гадна түншүүд хоорондын итгэлцэл нэмэгдэж, стратегийг үнэлэх, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт тавихтай холбоотой шаардлагуудыг ойлгоход нэмэртэй. (Шигтгээ 8.3-т мэргэжлийн харилцаа, холбоог ашиглах, хадгалах ач холбогдлыг харуулсан кэйсийг онцлов.)

ШИГТГЭЭ 8.3 Хүмүүстэй холбогдох нь: Перу Улсын хэргийн жишээ

2000 оны 9 дүгээр сард телевизээр Перу Улсын Тагнуулын албаны дарга Владимиро Монтесинос конгрессын гишүүнд авлигал өгч байгаа бичлэг цацагджээ.[a] Үүний дараа Швейцар Улсаас өөрийн санаачилгаар Перу Улсын талд Швейцар дахь хөрөнгийг царцаах талаар анхааруулга өгөн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулахыг уламжилжээ.

Перу Улсын Прокурор Швейцар Улсын хэргийг удирдаж буй мөрдөн шалгах ажиллагааны магистраттай хувийн шугамаар утсаар холбогдож, дараа нь Цюрих хотод биечлэн уулзсан. Ингэснээр дараах үр дүнд хүрсэн ба тодруулбал:

- *Стратегийн чухал шийдвэрүүдийг гаргах боломжтой болсон.* хөрөнгө буцаах сонголтуудын талаар хэлэлцсэнээр Перу Улс Швейцар дахь хөрөнгийг буцаахын тулд хэргийг дотооддоо мөрдөх, эрх зүйн харилцаа туслалцаа авах, хуулийн хариуцлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан.
- *Эрх зүйн харилцан туслалцааны шаардлагуудыг тодорхой болов.* Уг уулзалтын үр дүнд Перу Улсын эрх бүхий байгууллагууд Швейцарийн тогтолцооны талаар болон тавьсан хүсэлтийг амжилттай болгохын тулд юуг баталж, юугаар хангах шаардлагатайг ойлгосон.
- *Итгэлцэл нэмэгдэв.* Хувийн харилцаа, холбоо тогтоосноор хоёр талын улс төрийн эрмэлзэл, хүчин чармайлт харуулж, талуудын итгэлцлийг нэмэгдүүлэхэд нэмэр болжээ.

Швейцар болон Перу Улсын хамтын ажиллагааны үр дүнд 77 сая ам.долларыг Швейцар Улсаас эх орондоо буцаан авчирсан явдалд хувийн харилцаа, холбооны тогтоосон нь чухал нөлөө үзүүлжээ.[b]

a. Уг кэйсийн талаар дэлгэрэнгүйг нэгдүгээр бүлгийн 1.3, тавдугаар бүлгийн 5.8 дугаар шигтгээд үзнэ үү,
b. Швейцар Улсын Холбооны зөвлөл, 2002. "Монтесиносийн кэйс: Швейцар Улс 77 сая ам.долларыг Перу Улсад шилжүүлэв." Хэвлэлийн мэдээ, 2002.08.20 https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-23237.html

Хувийн харилцаа, холбоо тогтооход хүндрэлтэй байдаг. Олон салбарын мэргэжилтнүүд интернэтээр хэнтэй харилцахаа тодорхойлох боломж бага, утсаар шууд холбогдох эрхгүй, танилын хүрээгээ өргөжүүлэхэд нэмэр болохуйц олон улсын болон бүс нутгийн уулзалтад анхаарал хандуулах боломж бололцоо хомс байдаг.

Мөн холбогдох шаардлагатай нэр, утасны дугаар зэргийг хаанаас олох, гадаад хэлний бэрхшээл зэрэг асуудлууд хувийн харилцаа, холбоог тогтоож, өргөжүүлэхэд тодорхой хэмжээнд саад болдог.

Хувийн харилцаа, холбоотой байх нь хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд нэн чухал ба холбогдох байгууллагууд энэ нөхцөл боломжийг бий болгох бүхий л оролдлогыг хийх хэрэгтэй. Ийм харилцаа, холбоог тогтооход цаг хугацаа, хүчин чармайлт зарцуулсны үр дүнд салбарын мэргэжилтнүүд хэргийг хэрхэн үр дүнтэй шалгах, хэрэгт холбоотой мэдээлэл олж авах талаар зааварчилга авах, эсвэл эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн төслийг бэлдэх туслалцаа авах боломжтой. Шигтгээ 8.4-т танилын хүрээг өргөжүүлэх аргуудыг тусгажээ.

ШИГТГЭЭ 8.4 Олон улсын хамтын ажиллагааны сувгууд

Албан ажлын явцад тогтоох холбоо: Өмнөх хэргүүд болон уулзалт, хурлын үеэр тогтоосон харилцаа, холбоо.

Холбож өгөх: Түншүүд, хувийн шугамаар холбогдсон танилууд, олон улсын байгууллагууд (жишээ нь Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба) өөрсдийн танилын хүрээнд үндэслэн шаардлагатай этгээдтэй холбож өгөх.

Гадаад улс дахь түнш байгууллагууд:

- Хууль сахиулах байгууллагууд (цагдаа, авлигатай тэмцэх, гааль, мансууруулах бодистой тэмцэх, татварын байгууллагууд)
- Санхүүгийн тагнуулын албаны үүрэг, оролцооны талаар 2 дугаар бүлгийн Шигтгээ 2.1-д дурдав.
- Зохицуулагч байгууллагууд (банк, үнэт цаас)
- Прокурор
- Мөрдөн шалгах ажиллагааны магистрат
- Гадаадын зөвлөхүүд (зарим улсад өөр улсын дүрэм журам, шаардлагын талаар мэдлэгтэй зөвлөхүүдтэй байдаг)

Холбогч магистратууд болон бүс нутгийн хууль сахиулах байгууллагын атташе нар: Ихэнх улс орнууд гадаад улсад суугаа Элчин сайдын яам, консулын газрууддаа суугаа оронтойгоо хамтын ажиллагааны асуудлыг хөнгөвчлөх ажлыг хийх хүний нөөцийг бүрдүүлсэн байдаг. Үүнд ЭСЯ-ны дипломат ажилтнууд, дипломат төлөөлөгчөөр томилогдсон хууль, цагдаа, гааль, шүүх байгууллагын албан хаагчид байдаг. Эдгээр албан хаагчид өөрийн болон суугаа орныхоо хууль, дүрэм, журмын талаар мэдлэгтэй байх тул салбарын мэргэжилтнүүдэд эрх зүйн тогтолцооны ялгаатай байдлаас үүдэн гарах төөрөгдлийг арилгахад тус болно. Тэдний үүрэг өөр өөр хэдий ч ерөнхийдөө түншүүдтэй харилцах харилцаа хялбаршуулж, албан бус туслалцаа үзүүлж, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлттэй холбоотой бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн мөрөөр хийгдэх ажилд туслах зэрэг байна. Салбарын мэргэжилтнүүд гадаад улсаас суугаа ЭСЯ, Консулын газар, гадаад харилцааны яамнаас ийм нөөц бололцоотой хүний нөөц байгаа эсэхийг мэдэх зорилгоор холбогдохыг хүсэж болно.

Аргентин, Чили, Колумби, Франц, Их Британи, АНУ (тухайлбал, Холбооны мөрдөн шалгах товчоо, Цагаачлал, гаалийн байгууллага) зэрэг өөрийн элчин сайдын яамандаа уг чиглэлээр ажиллаж боломжтой хүний нөөцийг томилдог жишээ бий. Зарим улсууд авлигын хэргийн асуудалд дипломат төлөөлөгчдийнхөө үүрэг, оролцоог нэмэгдүүлсэн байдаг. Жишээ нь Бельги Улсын хувьд Элчин сайдын яамдаас Гадаад харилцааны яамны холбогч магистратад Бельгийн бизнес эрхлэгчид гадаад улсын албан хаагчдад авлига өгч буй талаар сэжигтэй үйлдлийг мэдээлэх механизмтай байдаг.

Төв байгууллагууд: НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 46 дугаар зүйлд "улс орнууд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүлээн авах эрх, үүрэгтэй, хэрэгжүүлэх эсвэл хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад уламжлах төв байгууллагыг тодорхойлсон байх" шаардлагыг тавьжээ. Төв байгууллагууд ихэвчлэн Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Ерөнхий прокурорын газар байх ба тодорхой тохиолдлуудад Авлигатай тэмцэх байгууллагууд байдаг. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргагч болон хүлээн авагч улсууд төв байгууллагыг тодорхойлсноор харилцах суваг тодорхой болсон байх тул олон улсын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой. Тухайлбал:[a]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.4 Олон улсын хамтын ажиллагааны сувгууд

- ***Дотоодын:*** Дотоодын төв байгууллага салбарын мэргэжилтнүүд гадагшаа холбох, олон талт болон хоёр талт хэлэлцээртэй улс орны талаар мэдээллээр хангаж болно.
- ***Хүсэлт хүлээн авагч улсад:*** Хүсэлт хүлээн авагч улсын төв байгууллага нь хүсэлт гаргагч улсын хэрэгцээ, шаардлагыг харгалзан хэрхэн үр дүнтэй арга хэмжээ авах, хүсэлт хүлээн авагч улсын хууль, эрх зүйн талаар зааварчилга өгөх чадамжтай байх хэрэгтэй.

Салбарын мэргэжилтнүүдийн сүлжээ: Хөрөнгө буцаах үйл явцыг хялбаршуулах зорилгоор дэлхий даяар хэд хэдэн Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARIN) бий болсон.

Тэдэн дундаас Камдены хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ нь (CARIN) гишүүдийнхээ "гэмт хэрэгтнүүд хууль бус орлогоос нь салгах" хүчин чармайлтыг дэмжих салбарын мэргэжилтнүүдийн албан бус сүлжээ бөгөөд 2004 онд байгуулагджээ. Энэхүү Сүлжээ (CARIN) нь гэмт хэргийн замаар бий болсон орлогыг таслахад анхаарал хандуулж, харилцаа холбооны сүлжээг бий болгохыг зорьдог ба хөрөнгө буцаах салбарын мэргэжлийн төвийн үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ мэдээлэл, сайн практик солилцоог дэмжих, холбогдох байгууллагуудад зөвлөгөө өгөх, улс орнуудын хамтын ажиллагааг дэмжиж ажилладаг.

Одоогийн байдлаар тус Сүлжээ (CARIN) нь 54 гишүүн улстай ба Европын Холбооны 28 гишүүн орон, олон улсын 9 байгууллага багтаж байна. Ажиглагч болон түншийн статустай оролцож болдог. Гишүүд, ажиглагч нар өөрсдийн холбогч нарын мэдээлэл болон хөрөнгө буцаахтай холбоотой хууль, эрх зүйн орчны талаар тус Сүлжээнд мэдээлэх шаардлагатай. Мөн гишүүд, ажиглагч нар мэдээлэл солилцоо, эрх зүйн харилцан туслалцааг хялбаршуулж хөрөнгө буцаахад оролцох эрх бүхий байгууллагуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Хамтын ажиллагааг хөнгөвчилж, аюулгүй байдлыг хангахын тулд мөрдөгч болон шүүх байгууллагынханд зориулсан хаалттай цахим хуудас болох Европолын Санхүүгийн гэмт хэргийн мэдээллийн төвөөс (FCIC) зөвхөн тус Сүлжээний (CARIN) гишүүд, ажиглагчдад зориулсан мэдээллийн хэсэгт нэвтрэх эрх өгдөг бөгөөд ингэснээр гэмт хэргийн хөрөнгө буцаахтай холбоотой хууль, эрх зүй, кэйсүүдийг харах боломжтой болдог.

Бусад ийм төрлийн байгууллага хоорондын сүлжээнд олон улс орнууд харьяалагддаг. Камдены хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээтэй адилаар тэдний гол зорилго нь хөрөнгө буцаах салбарын мэргэжлийн төвийн үүргийг гүйцэтгэж, мэдээлэл, сайн практик солилцоо, сургалт, зөвлөгөө өгөх, эрх бүхий байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих юм.[b]

- ***Бүс нутгийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARINs):***
  - (ARIN-SA) Өмнөд Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээнд Зүүн болон Өмнөд Африкийн улсууд багтдаг.
  - (ARIN-WA) Баруун Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2014 оноос хойш)
  - (ARIN-EA) Зүүн Африкийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2013 оноос хойш)
  - (ARIN-AP) Ази, Номхон далайн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2013 оноос хойш)

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.4 Олон улсын хамтын ажиллагааны сувгууд

- (ARIN-CARIB) Карибын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2016 оноос хойш)
- (ARIN-WCA) Баруун болон Төв Азийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (2018 оноос хойш)
- RRAG (GAFILAT) Өмнөд Америкийн хөрөнгө буцаах сүлжээ: Өмнөд Америкийн орнуудын мэдээлэл солилцоо, холбоо тогтоох виртуал платформ

• ***Салбарын мэргэжилтнүүдийн бусад сүлжээ:***

- ЭГМОНТ групп (EGMONT group): Санхүүгийн тагнуулын албадын олон улсын сүлжээ (2 дугаар бүлгийн 2.1, 3 дугаар бүлгийн 3.6 дугаар шигтгээг харна уу)
- Интерпол, Европол, Асеанпол, Америпол: Олон улсын (бүс нутгийн) цагдаагийн байгууллагууд нь хил дамнасан цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагаа хөнгөвчилдөг.
- Дэлхийн гаалийн байгууллага (WCO-World customs organization), түүний бүс нутгийн холбогч мэдээллийн албад
- Арабын авлигын эсрэг нэгдсэн сүлжээ (ACINET)
- Иберо Америкийн прокурорын сүлжээ(AIAMP)
- Европын шүүхийн сүлжээ
- Еврожаст нь Европын Холбооны гишүүн орнуудын шүүгч, прокуроруудаас бүрдэж хил дамнасан онц ноцтой эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, яллаж ажиллагаанд оролцож буй байгууллагуудад дэмжлэг үзүүлдэг агентлаг юм.
- Олон улсын прокурорын холбоо(IAP)
- Олон улсын төлбөр тооцооны банк, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо зэрэг банк, үнэт цаас, компанийн зохицуулалтын байгууллагуудын[c] салбарын мэргэжилтнүүдийн сүлжээ

a. Эрх зүйн харилцан туслалцаатай холбоотой гэрээ болон олон талт конвенцуудын дагуу улс орнууд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хүлээн авах эрх бүхий төв байгууллагыг тодорхойлсон байх шаардлагатай. Зарим улс эрх бүхий хоёр төв байгууллага, хэд хэдэн холбоо барих этгээдийг тодорхойлсон байдаг.
b. Ази, Номхон далайн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээний зорилгыг харна уу http://www.arin-ap.org/main.do and ARIN-SA https://new.arinsa.org/.
c. Энэхүү хамтын ажиллагаа нь зарим тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг шаарддаг учир хязгаарлагдмал байдаг ба хууль сахиулах ажиллагааны зорилгоор мэдээлэл солилцоо хязгаарлагдах тохиолдол гарч болно.

Хулгайлагдсан хөрөнгө буцаах (StAR) санаачилгын (Дэлхийн банк, НҮБ-ын МБГХТА 2019 он) цахим хуудсанд хөрөнгө буцаах сүлжээдийн бүтэц, үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан тойм, лавлах нийтлэгдсэн.[7]

[7] "Хөрөнгө буцаах олон улсын түншлэл: Байгууллага хоорондын сүлжээдийн тойм, лавлах" нийтлэлийг цахимаар харна уу https://star.worldbank.org/publication/international-partnerships-asset-recovery.

8.3.3 Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн өмнө, явцад, дараа албан бус туслалцааны сувгийг ашиглах нь

Салбарын мэргэжилтнүүд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй болсон гэж үзсэн үедээ эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт яаралтай боловсруулахаас өөр аргагүйд хүрдэг. Гэсэн хэдий ч түншийн харилцаат хууль сахиулах байгууллагууд, санхүүгийн тагнуулын албад, эсвэл холбогч магистрат, тухайн улсад эсхүл бүс нутагт томилогдсон хууль сахиулах асуудал эрхэлсэн атташе нартай шууд холбогдон зарим чухал мэдээллийг шуурхай авдаг.

Ийм төрлийн туслалцаа нь хөрөнгийг тодорхойлох явцыг хурдасгаж, шаардлагатай туслалцааг бататгахаас гадна хамгийн чухал нь эрх зүйн харилцан туслалцааны албан ёсны хүсэлт гаргах үндэслэл болдог. Албан бус туслалцааны хүрээнд тухайн улсад ямар мэдээллийг илүү хялбар авч болох талаар зөвлөгөө өгч болно. Учир нь эдгээр мэдээлэл нь нийтийн хүртээл болсон, хайж болохуйц мэдээлэл байдаг. Түүнчлэн, гадаад улсын дүрэм журам, системийн талаар ойлголттой болох, стратегийн сонголтыг үнэлэх боломж олгодог.

Бусад улсуудтай протокол зөрчигдөөгүй байх, гадаад улсаас туслалцаа авахтай холбоотой хууль, тогтоомжид нийцсэн болохыг бататгах зорилгоор салбарын мэргэжилтнүүдийн харьяалагдах дотоодын төв байгууллагаас албан бус холбоо тогтоох контактыг зөвшөөрсөн байх ёстой. Хэрэв боломжтой бол хүсэлт хүлээн авагч улсад суугаа хүсэлт гаргагч улсын дипломат төлөөлөгчийн газартай албан бус контактын талаар хэлэлцэх нь сайн практик билээ.

8.3.4 Тулгарч болзошгүй бэрхшээлийн талаар ойлголттой байх

Салбарын мэргэжилтнүүд олон улсын хамтын ажиллагааны явцад олон саад, бэрхшээлтэй тулгарч магадгүй, тиймээс болзошгүй саад, бэрхшээл гарахыг хүлээн зөвшөөрч, түүнийг даван гарахад шаардлагатай арга хэмжээг авах нь маш чухал. Эрх зүйн уламжлал, хөрөнгө хураах тогтолцооны ялгаатай байдал, тухайн улсын асуудал, үйл ажиллагааны хувилбарууд, хууль, эрх зүйн бэрхшээл, хоцрогдол зэрэг саад тотгоруудыг салбарын мэргэжилтнүүд анхааран үзэж, шаардлагатай алхмуудыг авах хэрэгтэй. (2 дугаар бүлгийн 2.8 дахь шигтгээг харна уу)

Салбарын мэргэжилтнүүд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн дагуу болон албан бусаар гадаад улс руу явуулсан мэдээлэл нь тухайн гадаад улсыг дотоодын мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх, улмаар дотооддоо хэрэг шалгах ажиллагааны явцад туслалцаа үзүүлэхээс татгалзахад хүргэж болно. Түүнчлэн, мэдээлэх үүрэг туслалцааны процессыг тодорхой хэмжээнд хойшлуулж болзошгүй байдаг (Шигтгээ 8.5). Тиймээс эрх зүйн харилцан туслалцааны гэрээн дэх нууцлалын үүргийг үл харгалзан мэдээлэл алдагдах тохиолдол олон гардаг.

Ийм эрсдэлийг таамаглаж шийдвэрлэхийн тулд салбарын мэргэжилтнүүд хувийн харилцаа холбоо, Камдены хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ, эсвэл бүс нутгийн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээг ашиглан бусад тогтолцоог судлах, стратегиа батлах, мэдээллээр хангахад гарах үр дагаврын талаар хэлэлцэх хэрэгтэй. Нууцлалтай холбоотой хууль, тогтоомжийг зөрчихгүйгээр ахиц гаргахын тулд салбарын мэргэжилтнүүд ихэвчлэн стратеги төлөвлөх, хэргийн эхэн үеийн явцад төсөөлсөн байдлаар нэр томьёо ашиглаж ярина. Жишээ нь “Иргэн “X” “Y” үйлдэл хийсэн байна. Би гадаад улсын нутаг дэвсгэрт яаж хүссэн үр дүндээ

хүрэх вэ?”. Шигтгээ 8.5-д мэдэгдэх үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй бэрхшээлийг шийдвэрлэх зарим санааг харуулжээ.

ШИГТГЭЭ 8.5 Мэдэгдэх үүрэг: Эрх зүйн харилцан туслалцаанд саад болох уу?

Лихтенштайн, Люксембург, Швейцар зэрэг орнуудад эрх бүхий байгууллага эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулахад хүргэж буй этгээдэд мэдэгдэл өгөх, туслалцаа үзүүлэх шийдвэрийг давж заалдах эрх олгохыг шаарддаг ил тод байх үүрэгтэй байдаг. Энэ нь банкны дансны мэдээлэл, түр зуурын арга хэмжээ авах тухай хүсэлтийг ярвигтай болгодог. Мэдэгдэх үүрэг, хариуцлагын дагуу мэдэгдэл өгсний дараагаар хөрөнгө замхарч алга болох эрсдэлээс гадна хугацааг хойшлуулж уртасгах эрсдэлд хүргэж болно. Тухайн этгээд эрх зүйн харилцан туслалцаад саад болох бүхий л аргыг ашиглах ба хэдэн сар, жилийн хугацаа авахаар давж заалдсаар байх болно.

Эдгээр саад бэрхшээлээс зайлсхийх дараах санааг өгч байна:

- Нэн түрүүнд гадаад түншүүдтэй тухайн асуудлууд, стратегийг хэлэлцэж, мөрдөн шалгах алхмуудыг эрт ил тод байлгахад хүргэж болзошгүй цагаа олоогүй үйл ажиллагаа явуулахгүй байх талаар хүсэх.
- Мэдээлэл гаргаж өгөх банк болон санхүүгийн зуучлагч нарт чиглэсэн мэдээлэл задруулахгүй байх тухай захирамж гарган мэдээлэл солилцооны талаар задруулахгүй байх талаар хэлэлцэх.
- Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эсвэл гадаад улсыг мэдээллээр хангаснаар тухайн улс дотооддоо мөрдөн шалгах ажиллагаа болон түр зуурын арга хэмжээг авах боломжтой болно. Тухайн этгээдэд мэдээлэл өгснөөр дотоодын мөрдөн шалгах ажиллагаа, түр зуурын арга хэмжээг хойшлогдох тул хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа, айлын талыг мэдээллээр хангах аль ч сонголт нь хугацаа алдах асуудлыг цэгцлэх боломж өгнө.
- Гаргаж буй хүсэлт нь хувийн нууцад халдсан гэх маргаан гаргахуйц хэтэрхий өргөн хүрээнд байж болохгүй.
- Хүсэлт гаргах үндэслэл бүхий баримт, учир шалтгаан нь давхар гэмт хэргийн шаардлагыг хангаагүй гэх гарч болзошгүй маргааныг шийдвэрлэхийн тулд маш тодорхой байх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл тухайн этгээд давхар гэмт хэргийн зарчмаас зайлсхийхийн тулд уг хүсэлтийг авлигын хэргийн мөрдөн шалгах ажиллагаагаар халхалсан татварын мөрдөн шалгах ажиллагаа гэж маргаан гаргаж болзошгүй. (9-р бүлгийн 9.2.2-т дэлгэрэнгүй авч үзнэ).

8.4 Албан бус болон албан ёсны олон улсын хамтын ажиллагааны ерөнхий процесс

Өмнө дурдсанчлан хөрөнгө буцаан авах үйл явц нь мэдээлэл, гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээлэл, нотлох баримт олж авах, түр зуурын арга хэмжээ авах, хөрөнгө хураах, төгсгөлд нь хөрөнгө буцаан авах зорилгоор албан бус хүсэлт, албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг хослуулан хэрэглэдэг. Хэрэв улс орнуудын хооронд болон өмнө нь үр дүнтэй албан бус хамтын ажиллагаатай байсан хамтран ажиллагч талуудын хооронд зохих журмын дагуу эрх зүйн харилцан туслалцааны үйл явц явагдвал тун хялбар байх болно. Учир нь ямар хугацаанд юунд хүрсэн байхыг тодорхойлоход ихээхэн нэмэр болдог.

Тухайн хүсэлт өргөн цар хүрээтэй байх тохиолдолд мөрдөн байцаалтын ажиллагаа, яллах ажиллагааг цаг тухайд нь явуулах боломжтой байх үүднээс нотлох баримтыг баталгаажуулахад нухацтай хандаж, хэлэлцэх шаардлагатай.

Хэдийгээр нэг хүсэлтэд хүсэж буй бүх зүйлийг багтаах нь илүү хялбар мэт санагдаж болох ч, хэт өргөн хүрээтэй хүсэлт нь хүссэн бүх мэдээллээр хангах эсвэл хүссэн арга хэмжээг авах, ялангуяа түр зуурын арга хэмжээ авах, хураах зэрэг дараачийн үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нотлох баримтын үндэслэлээр хангалтгүй байж болно. Түүнчлэн нэг хүсэлтэд бүгдийг багтаасан байх нь хэд хэдэн байгууллагуудыг ажиллуулж, хариу илгээх хугацааг уртасгадаг учир хүсэлт хүлээн авагч улсад тун хүндрэлтэй байдаг.

Хэцүү, төвөгтэй хэргүүдийн хувьд хамгийн үр дүнтэй арга бол ихэвчлэн үйл явцыг алхам алхмаар хийж нэг хүсэлтээр дараа дараагийн хүсэлт гаргах нөхцөлийг бүрдүүлэх юм. Жишээлбэл, тухайн хэргийн эхэн үед банкны дансны мэдээллийг албан бус туслалцааны хүрээнд авч болох ба (санхүүгийн тагнуулын албадын сувгаар) ингэснээр банкны бичиг баримтыг битүүмжлэх зорилгоор эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулахад шаардлагатай үндэслэл, суурийг бий болгоно. Эдгээр бичиг баримтуудыг шалгах явцад илэрсэн үйлдлүүд нь мөрдөгч нарт хөрөнгийг мөшгөж, нэмэлтээр банкны данс ашиглах эрхийг хязгаарлах, битүүмжлэн уг асуудлыг олон улсын хэмжээнд анхаарахад нэмэр болох юм. Энэ мэдээллийг яаралтай түр зуурын арга хэмжээ (боломжтой бол албан бус туслалцаагаар) авах эсвэл эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулан хязгаарлах, хураан авах эсэхээс үл хамааран түр зуурын арга хэмжээнд шаардлагатай нотлох баримтыг олж авахад дараа нь ашиглаж болно. Эцэст нь эрх зүйн харилцан туслалцаагаар баталгаажсан мэдээлэл нь дотооддоо хураах, албадан хэрэгжүүлэх үндэслэл болно.

Үйл явцыг алхам алхмаар хэрэгжүүлэх нь салбарын мэргэжилтнүүдэд үе шат (8.2 диаграм) бүрд стратегийн чухал шийдвэр гаргах боломж олгоно. Ингэснээр түншүүд хоорондын харилцаа, холбоо сайжирч, улмаар улс орнууд хоорондын итгэлцэл, харилцааг хөгжүүлснээр ил болон хаалттай форматаар холбогдох материал солилцдог.

Үүний зэрэгцээ, юуг хүсэж болох, сайн үр дүнд хүрэх үйл явцын талаар хэлэлцэж, тохиролцоонд хүрч болно. Зураг 8.3-д ихэвчлэн албан бус болон албан ёсны сувгуудаар дамжуулан хүсэлт гаргаж авах мэдээллийг тайлбарласан болно.

ЗУРАГ 8.2 Хөрөнгө буцаах ажиллагаанд олон улсын түвшинд хамтран ажиллах талаар



Эх сурвалж: Дэлхийн банк
Анхаарна уу: Цайвар саарал хүснэгтэд хүсэлт гаргагч улс, бараан саарал хүснэгтэд хүсэлт хүлээн авагч улсыг төлөөлөв. Зарим улсад нотлох баримт, түр зуурын арга хэмжээтэй холбоотой хүсэлтийг зэрэг гаргаж болдог. ЭЗХТ-эрх зүйн харилцан туслалцаа.

8.5 Албан бус хамтын ажиллагааны сувгууд

Энэ хэсэгт хүсэлт хүлээн авагч улсын хөрөнгө буцаах, ялангуяа хөрөнгө мөшгөх, яаралтай түр зуурын арга хэмжээ авах, сайн дураар мэдээлэх, өөр улсаас хэрэг нээх хүсэлт тавих албан бус туслалцааны сувгууд, холбогч нарын талаар хэлэлцэж, жишээ оруулав. Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа нь албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн дагуу хийгдэх хамтын ажиллагааны нэг төрөл юм. Энэ талаар 2 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлав (2.5.3 дугаар хэсэг, “Гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах”). Бусад сувгуудыг иргэний нийгмийн байгууллагууд санаачилж, удирддаг.

“H” хавсралтад байгаа “A” хяналтын жагсаалтад салбарын мэргэжилтнүүд түншүүдтэй яриа, хэлэлцээрийг эхлүүлэх сэдэв, асуудлуудыг жагсаасан.

ЗУРАГ 8.3 Албан бус туслалцаа, албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт: Ямар туслалцааг хүсч болох вэ?

Мөрдөн шалгах (албадлагын бус)	Бусад	Мөрдөн шалгах (албадлага) болон шүүх хурлын нотлох баримт	Түр зуурын арга хэмжээ	Хөрөнгө хураах
• СҮТ, СГТ • Ил мэдээлэл, бүртгэлийн мэдээлэл (тээврийн хэрэгсэл, аж ахуй нэгж, газар) • Хувь хүн, хуулийн этгээдийн банкны дансны жагсаалт • Зөвшөөрөлтэй нэгжлэг • Дүрсний ажиглалт • Гэрчээс тайлбар авах[a]	• Гадаадад хэрэг нээх хүсэлт • Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа • Зөвшөөрөлтэй нэгжлэг • Дүрсний ажиглалт • Шууд мэдэгдэх • Түр зуурын арга хэмжээ[b]	• Баталгаат бичиг баримт • Мэдээлэл гаргуулах захирамж • Нэгжлэг хийх болон хураах зөвшөөрөл • Данс хянах захирамж • Мэдүүлэг, гэрчийн тайлбар[a] • Хамтарсан мөрдөн шалах ажиллагаа[b]	• Гадаад улсын хязгаарлах, хураах шийдвэрийг шууд хэрэгжүүлэх • Дотооддоо хязгаарлах, хураах шийдвэр гаргаж шууд бусаар хэрэгжүүлэх	• Гадаад улсаас хөрөнгө хураах шийдвэрийг шууд хэрэгжүүлэх • Дотооддоо хязгаарлах, хураах шийдвэр гаргаж шууд бусаар хэрэгжүүлэх

Албан бус туслалцааны шугамаар авах боломжтой

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргахыг шаарддаг

Эх сурвалж: Дэлхийн банк.
Анхаарна уу: СҮТ=сэжигтэй үйлдлийн тайлан; СГТ=Сэжигтэй гүйлгээний тайлан.
a. Тухайн улсаас хамааран албан туслалцаа, эвсэл албан ёсны эрх зүйн харилцан туслалцаа шаарддаг.
b. Анхан шатны захирамж гаргахад албан ёсны эрх зүйн харилцан туслалцаа шаардахгүй байж болно. Гэхдээ тухайн захирамжийг хадгалж үлдэхийг шаардах болно.

ШИГТГЭЭ 8.6 Албан бус туслалцааг хялбаршуулах нь

Албан бус туслалцаа нь ерөнхийдөө түншээс түншийн хооронд явагддаг бөгөөд хууль сахиулах байгууллагууд гадаад улсын Санхүүгийн тагнуулын албанаас мэдээлэл авахдаа дотоодын Санхүүгийн тагнуулын албаар дамжих ёстой тул дундын зуучлагч оролцуулдаг процесс юм.

Зарим улсад албан бус солилцоог хөнгөвчлөхийн тулд тухайн байгууллага нь түншийн харилцаатай эсэхээс үл хамааран шууд хамтран ажиллахыг зөвшөөрдөг. Тухайлбал, АНУ-ын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ болон Европын Холбооны хууль сахиулах байгууллагууд шууд хамтран ажилладаг.

Эдгээрээр гадна, хөрөнгө буцаах байгууллагууд өөрийн улс дахь үүрэг, оролцооноос хамааран тухайн үйл явцын талаар болон холбоо тогтоох холбогдох байгууллагуудын талаар мэдээлэл солилцох ач холбогдолтой суваг байж болдог.

8.5.1 Ерөнхий анхаарах асуудлууд

Хэдийгээр албан бус туслалцаа нь эрх зүйн харилцан туслалцааны хүсэлттэй харьцуулахад хориглох зүйлс бага ч салбарын мэргэжилтнүүд анхаарах шаардлагатай хэд хэдэн хориглох зүйлс байдаг. Хоёр талд солилцож буй мэдээллийг хуулийн дагуу цуглуулж, солилцсон байх шаардлагатай ба түншүүдтэй харилцах харилцаа холбоог албан ёсоор зөвшөөрч эрх олгосон байх ёстой. Хамтын ажиллагаа нь ихэвчлэн түншээс түншийн хооронд байдаг тул зохих салбарын мэргэжилтнүүд дотоодын холбогдох байгууллагаар дамжин гадаад түншүүдтэй харилцах ёстой. (Зарим улсууд энэ шаардлагыг хасаж байгаа талаар жишээг Шигтгээ 8.6-аас харна уу)

Жишээ нь хууль сахиулах байгууллага гадаад улсын СТА -тай харилцахаас гадна, дотоодын СТА Эгмонтын сувгийг ашиглан гадаад улсын СТА -аас мэдээлэл авч хууль сахиулах байгууллага руу өгөх боломжтой. Зарим тохиолдолд Эгмонтийн гишүүнчлэлээс гадна түнш байгууллагууд харилцан ойлголцлын санамж бичиг, нууцын баталгаа байгуулах шаардлагатай болдог.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын 40 дүгээр зөвлөмжид (Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд) санхүүгийн тагнуулын албад, санхүүгийн хянан шалгах байгууллага, хууль сахиулах байгууллагууд хооронд мэдээлэл солилцоход тавигдах шаардлагыг тусгасан. Мөн тодорхой нөхцөлийн дагуу улс орнууд өөрсдийн эрх бүхий байгууллагуудад түншийн харилцаагүй талтай шууд бусаар мэдээлэл солилцохыг зөвшөөрөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тухайн хүсэлт гаргагч байгууллагаас нэг буюу түүнээс дээш хэд хэдэн дотоодын болон гадаадын байгууллагаар дамжуулан гаргах боломжийг бүрдүүлэх юм.[8]

Салбарын мэргэжилтнүүд албан бус туслалцааны эрсдэл, давуу талыг харьцуулан үзэх шаардлагатай. Тухайлбал, сайн дурын гэрчийн тайлбар эсвэл гадаадын түнш нууцлал задруулснаар тухайн этгээдэд дохио өгч нотлох баримтаа устгах, хөрөнгөө шилжүүлэх, өөр улс руу зугтах эрсдэлтэй байдаг.

8.5.2 Гадаад улс дахь албан бус туслалцааны түншүүд болон төрийн бус байгууллагаар дамжих сувгууд

Албан бус туслалцааны гадаадын түнш байгууллагуудын салбарын мэргэжилтнүүдэд хууль сахиулах байгууллага, прокурор, мөрдөн шалгах ажиллагааны магистрат зэрэг багтдаг. Хууль сахиулах асуудал эрхэлсэн атташе болон холбогч магистрат нар ч хамааралтай байдаг. Элчин сайд эсвэл консулын газарт байрладаг эдгээр албан хаагчид нь албан бус туслалцаа үзүүлэх, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн бэлтгэл ажил, хүсэлтийн мөрөөр хийгдэх ажлын талаар түншүүдтэй холбогдоход амар хялбар нөхцөлийг бүрдүүлдэг. Түншүүдтэй харилцахыг хүсэж буй салбарын мэргэжилтнүүдэд тулгардаг нэг асуудал нь зарим улс орнууд хэд хэдэн хууль сахиулах байгууллагатай байх тул холбоо тогтоох байгууллагаа тодорхойлоход хүндрэлтэй байдаг. (Дөрвөн улсын хууль сахиулах байгууллагуудын талаар шигтгээ 8.7-д харна уу) Эдгээр байгууллагуудыг дурдвал холбооны, мужийн, тойргийн, хотын цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, гаалийн байгууллага, мансууруулах бодистой тэмцэх алба, татварын байгууллага зэрэг орно. Иймд салбарын мэргэжилтнүүд хэд хэдэн байгууллагатай холбогдож, бусад

[8] Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын 40 дүгээр зөвлөмж “Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр” (СХАХАБ 2019 он), 40 дүгээр зөвлөмжийн тайлбарыг харна уу.

байгууллагад хамааралтай эсэх, эсвэл эрх бүхий төв байгууллагуудтай зөвлөлдөх эсэхийг асуух хэрэгтэй.

Үүнээс гадна салбарын мэргэжилтнүүд “Панама пэпэрс” гэх мэт иргэний нийгмийн байгууллагын санаачлан удирдан явуулж буй сувгууд албан бус хил дамнасан хамтын ажиллагааг учир шалтгаан болдог гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. (Шигтгээ 8.8)

8.5.3 Хөрөнгө мөшгөх болон мөрдөн шалгах бусад ажиллагаа

Ихэвчлэн тодорхой банк, салбар, байршлыг нарийвчлан хайхад хангалттай мэдээлэл байдаггүйн улмаас хөрөнгө мөшгөх үйл явцад саад болдог. Санхүүгийн байгууллага, түүний салбар (мэдээлэл хуваалцдаггүй) ихтэй улс орнуудад ийм төрлийн мэдээлэл шаардагддаг.

ШИГТГЭЭ 8.7	Франц, Швейцар, Их Британи, АНУ-ын мөрдөн шалгах эрх бүхий хууль сахиулах байгууллагууд

Ихэнх улс оронд авлига, мөнгө угаах хэргийг мөрдөн шалгах, яллах чиг эрх үүрэгтэй олон хууль сахиулах байгууллага байдаг. Тухайлбал:

Франц

- Гааль
- Үндэсний жандармер (Үндэсний цагдаагийн хүчний бүрэлдэхүүн)
- Зохион байгуулалттай, санхүүгийн гэмт хэргийн бүс нутаг хоорондын мэргэжлийн шүүх
- Мөрдөн шалгах ажиллагааны шүүх
- Эрүүгийн цагдаагийн алба
- Прокурорын газар
- Авлигын эсрэг газар
- Санхүүгийн тагнуулын алба

Швейцар

- Холбооны хууль зүйн алба (эрх зүйн харилцан туслалцааны төв алба)
- Холбооны болон мужийн цагдаагийн алба
- Холбооны төрийн яам
- Мужийн төрийн яам (Цюрих, Женев, Тикино дахь)
- Санхүүгийн тагнуулын алба

Муж тус бүр өөрийн харьяа прокурор, хууль сахиулах байгууллагуудтай болохыг анхаарна уу.

Их Британи (Англи, Уэльс)

- Прокурорын газар болон Гааль, орлогын прокурорын газар
- Их Британийн орлого, гаалийн алба
- Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх газар
- Онц ноцтой залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.7 Франц, Швейцар, Их Британи, АНУ-ын мөрдөн шалгах эрх бүхий хууль сахиулах байгууллагууд

Түүнчлэн, Англи, Уэльс Улсад бүсийн 43 цагдаагийн хүчин байдгаас заримд нь авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй нэгж байдаг. Үүнд мөн Нийслэлийн цагдаагийн газар болон Лондон хотын цагдаагийн газар багтаж байна.

Америкийн Нэгдсэн Улс

- Гааль, хил хамгаалах алба
- Дотоодын аюулгүй байдлын яам
- Хууль зүйн яам (АНУ-ын эрх бүхий төв байгууллага)
- Сангийн яам
- Мансууруулах бодистой тэмцэх газар
- Холбооны мөрдөх товчоо
- Цагаачлал, гаалийн газар
- Дотоод орлогын алба, Эрүүгийн мөрдөн шалгах газар
- Нэгдсэн Улсын Шуудангийн алба
- Санхүүгийн тагнуулын алба

Эдгээрээс гадна, мужийн болон орон нутгийн цагдаагийн байгууллага байна.

ШИГТГЭЭ 8.8 Авлигын дуулиант хэргийг илрүүлэх олон улсын хамтын ажиллагаа: Панама пэйпэрс

Хил дамнасан авлигын хэргийг илрүүлэхэд зөвхөн хууль сахиулах байгууллагууд хамтран ажилладаггүй. Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн салбар дуулиант авлигын хэргийг илчлэхэд олон улсын хамтын ажиллагаа шаардлагатайг харуулсан. Панама пэпэрсийн асуудлаар татвараас зайлсхийхээс эхлээд авлига өгөх зэрэг хууль бус зорилгоор ашигладаг байж болзошгүй хэдэн мянган оффшор аж ахуй нэгжийн мэдээллийг ил болгосон. 2014 оны сүүлээр нууц эх сурвалж Баварийн өдөр тутмын хэвлэлийн компани болох "Süddeutsche Zeitung"-тэй (СЗ) нууцалсан сувгаар холбогдож дэлхийн өнцөг булан бүрээс оффшор компани байгуулахад шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг Панамийн хуулийн фирм "Моссак Фонсека"-ын дотоод үйл ажиллагааны бичиг баримтуудыг явуулж эхэлсэн.[a]

Ийм их хэмжээний өгөгдлийг хэрхэн шилжүүлсэн талаар олон нийтэд мэдэгдээгүй ч нууцалсан хатуу дискээр зөөвөрлөсөн гэж таамагладаг.[b] 1970-2016 оны хугацаанд цугласан 2.6 терабайт мэдээлэл алдагдсан нь өнөөг хүртэл хамгийн томд тооцогдож байна. "Süddeutsche Zeitung" компани дэлхийн 80 гаруй орны 100 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага, 370 сэтгүүлчтэй хамтран ажиллаж, эх сурвалж, бичлэг, ярилцлагын видеог хуваалцдаг Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциумтай хамтран мэдээлэлд дүн шинжилгээ хийхээр шийджээ.[c]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.8 Авлигын дуулиант хэргийг илрүүлэх олон улсын хамтын ажиллагаа: Панама пэйпэрс

Байгууллагууд дангаараа ажлыг хийхээс илүүтэйгээр хамтран хийх нь үр дүнтэй гэдгийг ойлгов.[d] Сэтгүүлчид орчуулгын асуудлыг хэлэлцэх бодит цагийн чатын систем зэрэг нууц үгээр хамгаалагдсан, хамтын форумд хамтран ажилласан. Ирсэн өгөгдлүүдийг (сканердсан зургууд гэх мэт) өндөр үзүүлэлттэй компьютерт хийж, машин унших боломжтой үсэг таних технологи руу хөрвүүлж текст хэлбэрт шилжүүлснээр алдартай компаниудын нэрсийн жагсаалтыг алгоритм ашиглан гаргасан.[e]

Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн олон улсын консорциум хоёр хүчин зүйлт баталгаажуулалтаар хамгаалсан бичиг баримт хайх системийг зохиож BBC, Гардиан, Фюжин зэрэг гадаад хэл дээрх хэвлэл мэдээллийн хэрэгслүүд рүү нууцалсан цахим шуудан явуулж байсан. 100 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага нэгэн зэрэг нийтэлснээр олон улсын анхаарлыг татаж чадсан.[f] Зарим гэм буруугүй аж ахуй нэгжүүдийн хувийн нууцыг хамгаалах үүднээс өгөгдлийг бүхлээр нь олон нийтэд ил болгоогүй. Мэдээллийг задалснаар улс орнууд хоорондоо албан ёсны хүсэлт илгээх, шууд мэдээлэх тайланг солилцож байв.[g] Дэлхий даяар мөрдөж буй хэд хэдэн хэргүүдээс гадна 16 улс эсвэл олон улсын байгууллагууд Панама Пэпэрстэй холбоотойгоор томоохон шинэчлэл хийсэн гэсэн тооцоо байдаг. (Грэйвс ба Шаббир, 2019 он)

a. Фредерик Обермайер, Бастиан Обермайер, Ванесса Вормер, Вольфганг Жасченски нар. "Панамын баримт бичгийн тухай." Sددeutsche Zeitung (2020.06.23). https://panamapapers.sueddeutsche.de/articles/56febff0a1bb8d3c3495adf4/.
b. Энди Гринберг. 2016. "Сэтгүүлчид Панамын баримт бичгүүдийг хэрхэн задалсан бэ?: Шүгэл үлээгчдийн түүхэн дэх хамгийн том хэрэг". WIRED, 2016.04.04 https://www.wired.com/2016/04/reporters-pulled-off-panama-papers-biggest-leak-whistleblower-history/.
c. Кристен Харе. 2016. "ЭССОУК хэрхэн олон зуун сэтгүүлчдийг Панамын баримт бичигт хамтран ажиллуулсан бэ" Пойнтер, 2016.04.04. https://www.poynter.org/news/how-icij-got-hundreds-journalists-collaborate-panama-papers.
d. Харе, 2016.04.04 " ЭССОУК хэрхэн олон зуун сэтгүүлчтэй нэгтгэсэн бэ"
e. Гринберг, "Сэтгүүлчид Панамын баримт бичгүүдийг ил болгов" 2016.04.04
f. Гринберг, "Сэтгүүлчид Панамын баримт бичгүүдийг ил болгов" 2016.04.04
g. Европын парламент. 2017. Панамын баримт бичгээс илэрсэн схемүүдийн гишүүн орнуудын эдийн засаг, санхүүд үзүүлэх нөлөө https://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2017/572717/IPOL_STU(2017)572717_EN.pdf

Эсхүл хүсэлт нь хэтэрхий өргөн хүрээтэй байх болно. Зарим улс орнуудад энэ асуудлыг шийдвэрлэх тусгай арга хэрэгсэл байдаг.

Уг асуудлыг шийдвэрлэхэд туслах энэ арга хэрэгсэл нь банкны дансны төвлөрсөн бүртгэл[9] юм. Жишээ нь Бразил, Чили, Франц (хүснэгт 8.9), Итали, Герман[10] улсуудад хэрэгжсэн ба хязгаарлагдмал мэдээллийг (жишээ нь дансны дугаар, нэр, салбарын байршил) бүртгэж, нууцлал аюулгүй байдлыг хангаж, тодорхой байгууллагууд тодорхой нөхцөлийн дор хандах эрхтэй байдаг.

[9] Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагаас төвлөрсөн бүртгэлийг бий болгох нь хамгийн сайн практик гэдгийг хүлээн зөвшөөрсөн. (FATF 2012), http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Best%20Practices%20on%20%20Confiscation%20and%20a%20Framework%20for%20Ongoing%20Work%20on%20Asset%20Recovery.pdf.

[10] Шинэчлэгдсэн мэдээллийг харна уу (Майнзер 2012 он) https://www.taxjustice.net/cms/upload/pdf/ BAR2012-TJN-Report.pdf.

Зарим улсад СТА мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлж байж болзошгүй сэжигтэй тохиолдлын үел өгөгдлийн баазаас хайлт хийж болдог. Гадаад улсын салбарын мэргэжилтнүүд эдгээр мэдээллийг авахад шаардлагатай мэдээллийг хангалттай гаргаж өгөх хэрэгтэй ба эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргах шаардлага гарч болзошгүй.

ШИГТГЭЭ 8.9 Франц Улсын банкны дансны төвлөрсөн бүртгэл: ФИКОБА

Франц Улсын татварын удирдах газар болох Төрийн сангийн ерөнхий газар банкны дансны төвлөрсөн бүртгэлийг хариуцах чиг үүрэгтэй.[a] Энэ байгууллага нь Франц Улсын ерөнхий татварын хуулийн хүрээнд 1992 оноос хойш ажиллаж байна.

Тус байгууллага нь банк, шуудан, хадгаламж гэх мэт олон төрлийн дансыг тодорхойлдог ба Франц дахь хувь хүн болон компанийн эзэмшиж буй дансны талаарх мэдээллийг эрх бүхий этгээдэд гаргаж өгдөг. Данс нээх, хаах, өөрчлөх мэдүүлэгт дараах мэдээллийг агуулдаг:

- Дансыг удирдаж буй байгууллагын нэр, хаяг
- Дансны дугаар, мөн чанар, төрөл, шинж чанар
- Зарлагдсан гүйлгээний огноо, мөн чанар (нээх, хаах, өөрчлөх)
- Данс эзэмшигчийн овог, нэр, төрсөн он сар өдөр, газар, хаяг, бизнес эрхлэгчийн СИРЭТ дугаар.[b]

Хуулийн этгээдийн хувьд овог нэр, хуулийн хэлбэр, SIRET дугаар, хаяг зэргийг бичнэ. Данс нээх, өөрчлөх, хаах тухай мэдүүлгийг түүнээс хойш нэг сарын дотор гаргана.[c]

Зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн этгээд уг бүртгэлд хандана[d]. Тухайлбал,

- Санхүүгийн удирдах байгууллагын ажилтнууд (татвар, гааль гэх зэрэг)
- Санхүүгийн зах зээлийн газар
- Нийгмийн хамгааллын байгууллагууд
- Шүүх, эрүүгийн цагдаагийн ажилтнууд
- Аудиторын шүүхийн магистрат, бүс нутгийн танхимууд
- Францын шүүхийн шийдвэр гүйцэтгэгч-Бальи
- Үл хөдлөх хөрөнгийн нотариатууд

Банк, санхүүгийн байгууллагууд, шуудангийн хяналтын төв, брокерын фирмүүд гэх мэт данс удирдаж буй байгууллагуудаас мэдээллийн санд холбогдох мэдээллийг ирүүлдэг[e]. ФИКОБА-ийн уг мэдээллийн санд шүүхийн шийдвэр дагуу хандаж болдог.

Үүнээс гадна, Францын ерөнхий татварын хуулийн 1649А дугаар зүйлд Франц Улсад оршин суугаа болон үүсгэн байгуулагдсан арилжааны хэлбэргүй хувь хүн, нийгэмлэг, компаниуд орлого, эсвэл данс нээх, хаах, эзэмших, ашиглах, эсвэл гадаад хаалгасан дансны тухай тайланг мэдүүлэх ёстой гэж заасан байдаг. Түүнчлэн тус хуульд зааснаар хэмжээ, үнэт цаас, эсвэл гадаад улс руу шилжүүлсэн болон тодорхой нөхцөлөөр мэдүүлээгүй гадаад улс дахь дансаар дамжсан үнэт цаас нь өөрөөр нотлогдоогүй бол татвар ногдох орлого гэж үздэг.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 8.9	Франц Улсын банкны дансны төвлөрсөн бүртгэл: ФИКОБА

a. CNIL (Тооцоолол ба эрх чөлөөний комисс). 2018. "ФИКОБА: Fichier national des comptes bancaires and assimilés, Les grands fichiers en fiches" [FICOBA: Банк, ижил төстэй данснуудын үндэсний файл]. CNIL.fr, 2018.03.08 https://www.cnil.fr/fr/ficoba-fichier-national-des-comptes-bancaires-et-assimiles.
b.SIRET (Systime d'identification du répertoire des établissements) дугаар нь бизнесийн бүртгэлийн давтагдашгүй дугаар эсвэл бизнесийн таних дугаар
c. 1982 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн "Банкны дансны файлыг удирдах автоматжуулсан системийг өргөтгөхтэй холбоотой" нэмэлт өөрчлөлт оруулсан зарлиг.
https://www.legifrance.gouv.fr/affichTexte.do;jsessionid=E3E54137E9BC710C7E977B6FFD4AF7A0.tpdjo-09v_3?cidTexte=JORFTEXT000000864438&dateTexte=20131119.
d. CNIL, "ФИКОБА" 2018.03.08
e. CNIL, "ФИКОБА" 2018.03.08

8.5.4 Хойшлуулшгүй түр зуурын арга хэмжээ

Зарим улс орнууд албан ёсны шийдвэр гаргахаас өмнө тухайн этгээд хөрөнгөө шилжүүлэх, тараахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хойшлуулшгүйгээр хөрөнгийг шуурхай битүүмжлэх, эсхүл хязгаарлах арга хэмжээг авдаг.[11] Ийм төрлийн шуурхай арга хэмжээг авхуулахын тулд дараа нь тодорхой хугацааны дотор эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргасан байх нөхцөл тавьдаг. (Өргөдөл гаргах хугацааг зарим улсад сунгах тохиолдол байдаг). Хэрэв эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтээ хугацаанд нь гаргаагүй бол хурааж, царцаасан мөнгийг чөлөөлдөг.

Захиргааны шийдвэрүүд албан бус туслалцааны нэг хэсэг нь юм. Заавал албан ёсны туслалцааны хүрээнд авах яаралтай түр зуурын арга хэмжээний талаарх жишээг 9 дүгээр бүлгийн 9.2.6 дахь хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлав. Санхүүгийн тагнуулын албатай холбоотой удирдах албан тушаалтан (2 дугаар бүлгийн 2.1 дэх хүснэгт, "Хөрөнгө буцаах хэрэгт Санхүүгийн тагнуулын албаны үүрэг, оролцоо") санхүүгийн байгууллагад богино хугацаанд хөрөнгийг хязгаарлах тухай хадгалах шийдвэр

[11] Жишээ нь Тунис Улсын Ерөнхийлөгч асан Зинэ Эл Абибине Бэн Алигийн хөрөнгөтэй холбоотой кэйсийн хувьд ЕХ-ноос өөрийн гишүүн орнуудад тухайн хөрөнгө байгаа эсэхийг нарийвчлан харуулалгүйгээр урьдчилан сэргийлэх царцаах арга хэмжээ авах талаар баталсан. "Зөвлөлийн шийдвэр 2011/72/CFSP, 2011 оны 1 дүгээр сарын 31, Тунис дахь нөхцөл байдлаас үүдэн тодорхой хувь хүн, аж ахуй нэгжид чиглэсэн хязгаарлах арга хэмжээний талаар, https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2011:028:0062:0064:EN:PDF, 2018 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр 2018/141 дугаартай Зөвлөлийн шийдвэрээр өөрчлөлт орсон. Тунис дахь нөхцөл байдлаас үүдэн тодорхой хувь хүн, аж ахуй нэгжид чиглэсэн хязгаарлах арга хэмжээг 2019 оны 1 дүгээр сарын 31 хүртэл сунгав. https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELE X:32018D0141&from=EN. Зөвлөлийн шийдвэрээр өөрчлөлт орсон. Тунис дахь нөхцөл байдлаас үүдэн тодорхой хувь хүн, аж ахуй нэгжид чиглэсэн хязгаарлах арга хэмжээг 2021 оны 1 дүгээр сарын 31 хүртэл сунгах тухай 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 2020/117 дугаартай Зөвлөлийн шийдвэр гарав, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32020D0117.

гаргаж болно. Эдгээр захиргааны шийдвэрүүд зарим тохиолдолд суурь гэмт хэргүүдэд хязгаарлагддаг.[12]

Зарим улсад санхүүгийн байгууллагуудаас сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэхтэй холбоотойгоор Санхүүгийн тагнуулын албанаас тухайн хөрөнгийг чөлөөлөх зөвшөөрөл гаргах хүртэл хөрөнгийг барьж байх эсвэл тодорхой хугацаанд хөрөнгийг барьж байхыг шаарддаг. (Ингэснээр СТА болон хууль сахиулах байгууллагуудад түр зуурын арга хэмжээ авах боломжийг олгодог) Бусад улсад санхүүгийн байгууллага гүйлгээ хийхээс өмнө эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахыг шаарддаг. Хэрэв зөвшөөрөл олгоогүй тохиолдолд санхүүгийн байгууллага гүйлгээг хийхээс татгалзана.

8.5.5 Шууд мэдээлэх

Авлигын хэргээс олсон орлогыг буцаахад туслалцаа үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх албан бус туслалцааны өөр нэг хэлбэр бол "шууд мэдээлэх" юм.[13] НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод энэ талаар анхаарч үзсэн байдаг. Зарим улсад шууд мэдээлэх эрх мэдлийг албан ёсоор дотоодын хууль, эрх зүйгээр зохицуулсан (жишээ нь Швейцар дахь банкны нууцлалын асуудлыг шийдвэрлэх). Гэсэн хэдий ч эдгээр мэдээлэл задруулах үйл явц нь үндсэндээ мэдээлэл дамжуулах идэвхтэй хэлбэр бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа, гадаад улс руу эрх зүйн харилцан туслалцааны албан ёсны хүсэлтийг боловсруулахад нэмэр болдог. Шууд мэдээлэх нь одоо байгаа нотлох баримт (авлига авсан улс төрчийн банкны данс гэх мэт) болон хоёр талд явагдаж байгаа мөнгө угаах хэргийг мөрдөн шалгах ажиллагааны талаар гадаад улсад анхааруулахад тун хэрэгтэй.

Шигтгээ 8.10-т Швейцарийн эрх бүхий байгууллагаас шууд мэдээлэх хэлбэрээр шилжүүлсэн мэдээлэл болон хэрэв тухайн мэдээлэл нь гадаад улсыг эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргахад хүрвэл банкны нууцлалыг цуцлах тухай тайлбарлажээ.[14] Европын Холбооны хувьд гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ЕХ-ны Хөрөнгө буцаах алба эсвэл бусад эрх бүхий байгууллагуудын хооронд шууд мэдээлэл солилцох боломжийг хууль тогтоомжийн хүрээнд бий болгосон байдаг.[15] Үндэсний эрх зүйн орчны хүрээнд

---

[12] Тайланд Улсын Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийн 48 дугаар хэсэгт зааснаар Гүйлгээний хороо нь хэрэв аливаа хөрөнгийг нуун далдлах зорилгоор гүйлгээ хийх, түгээх, байршуулах үйлдэл хийсэн гэж үзвэл 90 хоногийн хугацаанд хязгаарлах, битүүмжлэх эрхтэй байдаг. Яаралтай үед Мөнгө угаахтай тэмцэх зөвлөлийн нарийн бичгийн дарга шийдвэр гаргаж болдог. Саатуулах, хадгалах, дуудлага худалдаа гэх зэрэг процесстой холбоотой зохицуулах байгууллагууд хандаж болно.

[13] НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 46, 56 дугаар зүйлд улсууд хоорондоо мэдээллийг ил болгох тухай заасан байдаг.

[14] Шууд мэдээлэх хууль эрх зүйн үндэслэл нь Швейцар Улсын Эрүүгийн хэргийн олон улсын харилцан туслалцааны тухай хууль юм. Мэдээлэл дамжуулснаар Швейцар Улс дахь эрүүгийн хэрэг шалгах явцад нөлөө үзүүлэхгүй.

[15] "Гэмт хэргээс олсон орлого болон бусад эд хөрөнгийг илрүүлэх, илрүүлэх чиглэлээр гишүүн орнуудын Хөрөнгө буцаах албад хоорондын хамтын ажиллагааны тухай 2007 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 2007/845/JHA дугаартай Зөвлөлийн шийдвэр" https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32007D0845&from=EN.

(захиргааны, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага)[16] Хөрөнгө буцаах албадын статус нь энэхүү хамтын ажиллагаанд саад болохгүй.

ШИГТГЭЭ 8.10 Швейцарийн ил болсон мэдээлэл

Эрүүгийн хэргийн олон улсын харилцан туслалцааны тухай, 67а дугаар зүйл:

Гэмт хэргийг яллахаар ажиллаж буй эрх бүхий байгууллага гадаад улсын ижил чиг үүрэгтэй байгууллага руу мөрдөн шалгах ажиллагааны явцад цугласан мэдээлэл, нотлох баримтыг айлын талаас хүсэлт гаргаагүй байсан ч дамжуулж болно. Тухайн мэдээлэл, нотлох баримтыг шилжүүлснээр дараах үр дүнд хүрнэ гэж үзсэн тохиолдолд шилжүүлж болно:

А. Эрүүгийн хэрэг үүсгэхийг зөвшөөрөх

Б. Үргэлжилж буй эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хөнгөвчлөх

Хэрэв гадаад улсаас харилцан туслалцааны хүсэлт явуулах нөхцөл бүрдэх тохиолдолд нууцлалын дүрэм журамд хамаарах мэдээллийг дамжуулж болно.

Нууцлалын тухай дүрэм журамд хамаарах мэдээлэлд хөрөнгө эзэмшиж буй банкны нэр, данс эзэмшигч болон эцсийн өмчлөгч, данс эзэмшигчийн нэр, дансны дугаар, царцаасан хөрөнгийн хэмжээ, холбогдох гүйлгээ зэрэг багтана.

Хүлээн авагч улс нотлох баримтын албан ёсны элементүүдийн талаар мэдээлэл авах сонирхолтой тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт гаргах боломжтой.

Эх сурвалж: Эрүүгийн хэргийн олон улсын харилцан туслалцааны тухай 1981.03.20 (2019 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар) https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19810037/index.html.

2019 онд Баталгаат мэдээлэл солилцооны сүлжээний аппликэйшн (SIENA)[17] дахь Хөрөнгө буцаах албадын хооронд 7659 гаруй мэдээлэл солилцсон нь 2012 оноос хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.[18]

Түүнээс гадна олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр эдгээр авлигын хэргүүдийг сурвалжилж байгаа нь банкнуудыг дотоодын эрх бүхий байгууллагад сэжигтэй гүйлгээний тайланг мэдүүлэхэд хүргэж, дараа нь авлигын хэргийг мөрдөн шалгаж буй улс руу (Эгмонтоор дамжуулан эсвэл тухайн улсын хуулиар зөвшөөрөгдсөний дагуу) шууд мэдээлэх боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр тухайн улсын мөрдөн шалгах ажиллагаанд болон албан ёсны эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт гаргах явцад ахиц гарах болно. Дотоддоо мэдээлэл түгээх нь мөнгө угаах гэмт

[16] ЕХ-ны Хөрөнгө буцаах албадын нээлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Европын Комиссын "Хөрөнгө хураах ба хөрөнгө буцаах" цахим хуудасны "Хөрөнгө мөшгөх, тодорхойлох" хэсгээс үзнэ үү https://ec.europa.eu/home-affairs/what-we-do/policies/organized-crime-and-human-trafficking/confiscation-and-asset-recovery_en.

[17] SIENA нь ЕХ-ны хууль сахиулах байгууллагууд (мөн түүний хамтран ажилладаг түншүүд болон ЕХ-той хэлэлцээр байгуулсан гуравдагч талууд) хооронд гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл солилцох платформ юм. https://www.europol.europa.eu/activities-services/services-support/information-exchange/secure-information-exchange-network-application-siena.

[18] Европын Комисс, "Хөрөнгө хураах ба хөрөнгө буцаах", "Бид юу хийдэг вэ, Цагаачлал, Дотоод хэрэг" https://ec.europa.eu/home-affairs/what-we-do/policies/organized-crime-and-human-trafficking/confiscation-and-asset-recovery_en.

хэргийн талаар дотоодын мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хүргэж болох ба мөн адил чухал ач холбогдолтой.[19]

Сайн туршлагын хувьд шууд мэдээллийг хүлээн авагч талууд шууд мэдээлж байгаа талтай холбогдож мэдээллийг тодруулах хэрэгтэй ба гадаад улс дахь хэргийн талаар мэдэж, хөрөнгийг битүүмжлэгдэх эсвэл битүүмжлэх эсэхийг баталгаажуулж, дараагийн арга хэмжээний талаар ярилцах хэрэгтэй.

8.5.6 Гадаад улсад хэрэг нээх хүсэлт гаргах нь

Зарим нөхцөл байдалд эрх бүхий байгууллагууд эрүүгийн эсвэл шийтгэх тогтоол үндэслээгүй хураах, эсвэл иргэний хянан шийдвэрлэх ажиллагааны талаар дотооддоо хэрэг мөрдөх боломжгүй болдог. Энэ нь чадавх болон улс төрийн хүсэл эрмэлзэл хангалтгүй байдгаас болдог эсвэл үр дүнгүй эрх зүйн орчноос ч шалтгаалж байж болзошгүй. Ийм нөхцөлд тухайн улс хэргийн материалаар гадаад улс дахь түншээ хангаж, эрх бүхий байгууллагуудаас дотоодын хэрэг шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт тавьж болно. Үүний үр дүнд гадаад улсын эрх бүхий байгууллага хэрэг шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх эсэх, хэрхэн явуулахыг тодорхойлох болно (энэ талаар дэлгэрэнгүйг 11 дүгээр бүлгээс бүлгээс үзнэ үү).

Зарим тохиолдолд уг хүсэлтийг албан ёсны харилцааны хүрээнд тавихыг шаарддаг. Бусад тохиолдолд хэргийн холбогдох материалуудыг захиргааны сувгууд буюу санхүүгийн тагнуулын албад хооронд, татварын байгууллагуудын хооронд мэдээлэл солилцдог.

Ном зүй

CARIN (Camden Asset Recovery Inter-Agency Network). 2012. “The History, Statement of Intent, Membership and Functioning of CARIN.” CARIN manual, European Police Office, The Hague, Netherlands. http://www.carin.network/.

FATF (Financial Action Task Force). 2012. “Best Practices on Confiscation (Recommendations 4 and 38) and a Framework for Ongoing Work on Asset Recovery.” Best Practices Paper, FATF and Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Best%20Practices%20on%20%20Confiscation%20and%20a%20Framework%20for%20Ongoing%20Work%20on%20Asset%20Recovery.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. “International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations.” Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf /documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

Graves, Lucas, and Nabeelah Shabbir. 2019. “Gauging the Global Impacts of the ‘Panama Papers’ Three Years Later.” Factsheet, March 2019, Reuters Institute for the Study of Journalism, University of Oxford. http://www.digitalnewsreport.org/publications/2019/gauging-global-impacts-panama-papers-three-years-later/#:~:text=In%20our%20

[19] Шууд мэдээлэх нь Владимиро Монтесиносын хэргийн талаар Перу, Швейцар улсууд хоорондын олон улсын хамтын ажиллагааны хурдасгуур болсон байдаг. (Шигтгээ 8.3, 1 дүгээр бүлгийн [Шигтгээ 1.3] ба 5 дугаар бүлгийн [Шигтгээ 5.8).

data%2C%2016%20countries,ICIJ%20investigations%20%E2%80%93%20an%20impressive%20result.

Meinzer, Markus. 2012. “Bank Account Registries in Selected Countries: Lessons for Registries of Trusts and Foundations for Improving Automatic Tax Information Exchange.” Report, Tax Justice Network, Chesham, UK. https://www.taxjustice.net / cms/upload/pdf/BAR2012-TJN-Report.pdf.

Moro, Sérgio Fernando. 2018. “Preventing Systemic Corruption in Brazil.” Dædalus 147 (3): 157–68. https://www.mitpressjournals.org/doi/full/10.1162/daed_a_00508. Multilateral Convention on Mutual Administrative Assistance in Tax Matters (1988, amended by Protocol in 2010), Organisation for Economic Co-operation and Development and Council of Europe. https://read.oecd-ilibrary.org/taxation/the -multilateral-convention-on-mutual-administrative-assistance-in-tax-matters _9789264115606-en.

Stephenson, Kevin M., Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabrielle Dunker, and Melissa Panjer. 2011. Barriers to Asset Recovery: An Analysis of the Key Barriers and Recommendations for Action. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star/files/Barriers%20to%20Asset%20Recovery.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc.org / pdf/convention_1988_en.pdf.

United Nations Convention against Transnational Organized Crime (UNTOC), UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25.

World Bank and UNODC (United Nations Office on Drugs and Crime). 2019. “International Partnerships on Asset Recovery: Overview and Global Directory of Networks.” Reference publication and directory, Stolen Asset Recovery (StAR) initiative, World Bank, Washington, DC. https://star.worldbank.org/publication/international-partnerships-asset-recovery.

9.Олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх

9.1 Удиртгал

8 дугаар бүлэгт дурдагдсан олон улсын хамтын ажиллагааны гол зарчмууд нь үр дүнтэйгээр олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд салбарын мэргэжилтнүүдэд сайн үндэслэл болж өгөх юм. Үр дүнтэй олон улсад хөрөнгө буцаах ажиллагаа нь ерөнхийдөө албан бус болон албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлтийн процессуудаас бүрдэнэ. Энэхүү бүлэгт албан ёсны туслалцааны процесст түлхүү анхаарч, эдгээр хэрэгслүүдийг хэрхэн ашиглах болон хооронд нь үр дүнтэйгээр нэгтгэх талаар тайлбарлана.

9.2 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт

8 дугаар бүлэгт дурдсанаар, салбарын мэргэжилтнүүд нь ерөнхийдөө олон улсын хамтын ажиллагааг эрх зүйн туслалцааны хүсэлт илгээснээр эхлүүлэх ёсгүй. Боломжтой тохиолдолд, эхлээд албан бус туслалцааны сувгийг хайж, холбогдох албан тушаалтантай нь харилцаад хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай зүйлс, тулгарч болох бэрхшээлүүдийн талаар ярилцах нь зүйтэй. Салбарын мэргэжилтнүүд нь санхүүгийн баримтуудыг гаргуулан авах, мэдүүлэг авах, нэгжлэг хийх болон битүүмжлэх, эсхүл хөрөнгө хамгаалах түр зуурын арга хэмжээний талаарх шийдвэрийг хэрэгжүүлэх зэрэг эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээж тодорхой ажиллагаанууд явуулах шаардлагатай гэж үзвэл тодорхой шалгуур, процессын шаардлагуудыг хангасан байх шаардлагатай бөгөөд зарим шаардлага, шалгуурын талаар энэ бүлэгт дурдагдах болно.

Улс орон бүрийн шаардлагууд нь харилцан адилгүй байдаг тул салбарын мэргэжилтнүүд нь гадаад улсын эрх бүхий төв байгууллагатай урьдчилан харилцаж, ажиллагааг гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг тодруулах шаардлагатай. Гадаад улсын хамтран ажилладаг болон бусад албан тушаалтантай зөвлөлдөх нь чухал боловч зарим улс орнууд салбарын мэргэжилтнүүдийг эрх зүйн туслалцааны хүсэлт бэлтгэх, илгээхэд эрх бүхий төв байгууллагаараа дамжуулан харилцахыг шаарддаг.

Түүнчлэн, олон улс орнууд эрх бүхий төв байгууллагуудын албан ёсны цахим хуудсандаа эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах шаардлага болон тухайн шаардлагыг хангасан эрх зүйн туслалцааны хүсэлтийн загваруудыг байрлуулсан байдаг[1] (J хавсралтаас зарим улс орнуудын албан ёсны цахим хуудаснуудыг, хавсралт 1-ээс эрх зүйн туслалцааны загвар хүсэлтийг харах). Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба нь эрх бүхий төв

[1] Тухайлбал, ИБУИНВУ болон БНХАУ-ын ЗЗОБ Хонконг, БНХАУ зэрэг улс орнууд салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагатай байна.

байгууллагуудын лавлагаа болон эрх зүйн туслалцааны хүсэлт бичих хэрэгслийг[2] хөгжүүлж, салбарын мэргэжилтнүүдэд[3] дэмжлэг болгож ажиллуулдаг. Мөн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын хэвлэлүүд мөн дэмжлэг болдог.[4]

9.2.1 Олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндэслэл

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хэрэгжүүлэхэд, хамтын ажиллагааны талаар тодорхой эрх зүйн үндэслэлийг дурдах шаардлагатай. Тухайлбал,

- Олон талт гэрээ, конвенц, эсхүл эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай агуулгатай хэлэлцээрүүд,
- Хоёр талт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, хэлэлцээрүүд,
- Эрүүгийн хэрэг дэх олон улсын хамтын ажиллагааг зөвшөөрсөн дотоодын хууль тогтоомж,
- Дипломат шугамаар илэрхийлсэн адил эрх зүйн туслалцааг заавал үзүүлэх талаарх амлалт (зарим улсад "хүсэлт бүхий захидал" (letters rogatory), "дипломат буулт" (comity)).

Эдгээр эрх зүйн сувгууд нь харилцан үгүйсгэсэн бус бөгөөд тухайн хэргийн асуудал, хүлээж буй үр дүнгээс шалтгаалан нэг эрх зүйн туслалцааны хүсэлтэд нэг болон хэд хэдэн сувгийг хэрэглэж болно (Шигтгээ 9.1). Бүхий л сувгуудын талаар тайлбарласан байгаа. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, холбогдох хууль тогтоомж байхгүй тохиолдолд процессыг нэн төвөгтэй болгох магадлалтайгаас гадна тухайн хэрэгт сайн үр дүн гарахад саад учруулна.[5]

---

[2] НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх алба (UNODC) Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг боловсруулах хэрэгсэл санал болгосон (дараах хуудаснаас татах боломжтой https://www.unodc.org/mla.) Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн төсөл боловсруулахад шаардлагатай мэдээлэл бүхий программ хангамж. Энэхүү программ хангамжийн сайжруулсан хувилбар нь бүхий л техник хэрэгсэлд тохирно. Энэ нь салбарын мэргэжилтнүүдийг эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулахад чиглүүлэх бөгөөд НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх албанд бүртгэлтэй Эрх бүхий байгууллагуудын цахим лавлахтай холбогдсон байдаг (https://www .unodc.org/unodc /en/legal-tools/directories-of-competent-national-authorities.html) Холбоо барих мэдээллийг олж авах боломж бүрдүүлсэн.

[3] Бусад олон улсын байгууллагаас эрх бүхий байгууллагуудын жагсаалтыг гаргасан байдаг. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Америк тив дэх улс орнуудын байгууллага (OAS), Иберо-Америкийн төрийн яамдын холбоо (AIAMP).

[4] Stephenson et al. (2011, 114–79), Канад, Кайманы арлууд, Франц, Герман, Хонконг ЗЗОБ, БНХАУ, Япон, Жерси, Сингапур, Лихтенстэйн, Испани, Швейцар, ИБУИНВУ, АНУ зэрэг улс орнуудын эрх зүйн туслалцааны хүсэлттэй холбоотой мэдээлэл (Эрх зүйн туслалцааны эрх зүйн орчин болон урьдчилан бүрдүүлэх нөхцөл байдал, Эрх зүйн туслалцааны ерөнхий процесс, хөрөнгө буцаах асуудал, Мэдээллийн туслалцаа үзүүлэх төрлүүд гэх мэт);
Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тайлан (2017)
"Ази номхон далайн эрх зүйн харилцан туслалцаа: 31 улс орны туршлага" at https://www.oecd.org /corruption/ADB-OECD-Mutual-Legal-Assistance-Corruption-2017.pdf.-аас хараx

[5] The Ferdinand and Imelda Marcos-ын хэрэг нь Швейцар улс дахь анхны бусад улс орны засгийн газраас гаргасан хүсэлтийн дагуу төрийн тэргүүний хөрөнгийг царцаасан тохиолдол (Филиппин улсын тухай). Гэвч 1986 онд Филиппин, Швейцар улсуудын хооронд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгаагүй тул процессын илүү ажиллагаа хийгдэж байсан. (FDFA 2016, 12),
https://www.eda.admin.ch/dam/eda/en/documents/aussenpolitik/voelkerrecht/edas-broschuere-no-dirty-money_EN.pdf.

ШИГТГЭЭ 9.1	Албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлтийн эрх зүйн үндэслэлийг сонгох

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн эрх зүйн үндэслэлийг сонгоход салбарын олон мэргэжилтнүүд бүхий л холбогдох гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн жагсаалт гаргаж ашигладаг. Энэ нь хүсэлтийг хүлээн авах магадлалыг нэмэгдүүлж өгдөг.[a] Учир нь эрх зүйн туслалцааны төрөл болон хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шалтгаан нь улс орнууд хооронд адилгүй байдаг. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг нэг улсад эрх зүйн үндэслэлтэй гэж үзэх боловч өөр улсад татгалзах боломжтой.

Хоёр талт гэрээ нь хэрэв НҮБ-ын Авлигын эсрэг конвенц зэрэг олон талт гэрээний үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж байвал үндсэндээ сайн сонголт болно. Хоёр талт гэрээнүүд нь талуудын эрх зүйн уламжлал болон бололцоонд уялдсан байдаг бөгөөд "нэг стандартыг бүхий л зүйлд тааруулах" олон талт гэрээнээс ялгаатай. Аливаа дотоодын хууль тогтоомжийн дагуу холбогдох гэрээг үндэслэл болговол, ижил төрлийн туслалцаа үзүүлэх амлалт бүхий хүсэлтээс илүү шуурхай хамтран ажиллах боломж олгодог.

а. Дэлгэрэнгүй (бүрэн биш) жагсаалтыг 1 дүгээр бүлгийн Шигтгээ 1.1 "Хөрөнгө буцаах эрх зүйн орчин", холбогдох цахим хуудаснаас харах.

Олон талт конвенц, гэрээ, хэлэлцээрүүд

Олон талт конвенц, гэрээ, хэлэлцээрүүд нь олон улсын эрх зүйн дагуу талууд заавал дагаж мөрдөх буюу эрх зүйн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээлгэсэн заалтууд агуулдаг. Дээрх заалтууд нь хамтын ажиллагааны цар хүрээ болон хэрэглэх процессуудыг тодорхойлж, урьдчилан тооцоолох боломж болон тодорхой байдал бий болгодог. Эдгээр хэлэлцээрүүд нь ихэвчлэн уламжлалт ижил төрлийн туслалцаа үзүүлэх амлалт болон хүсэлт бүхий захидлаас илүү өргөн хүрээний буюу эрх бүхий байгууллагуудын хооронд харилцах зэрэг хамтын ажиллагааны боломж олгодог (албан ёсны дипломат шугамаар харилцахаас илүүтэйгээр).[6]

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод 187 улс орон нэгдэн орсон[7] бөгөөд хамгийн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн авлигын улмаас олсон орлогыг буцаах гэрээ болох энэхүү хэрэгслийг амжилттай ашиглаж, олон улсад хөрөнгө буцаахад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх шаардлагатай. НҮБ-ын Авлигын эсрэг конвенц нь гишүүн орнуудыг авлигын хэрэг дээр мөрдөн шалгах, яллах ажиллагаа, шүүхээр хэрэг хянан хэлэлцэх явцад хамгийн өргөн хүрээнд харилцан туслалцаа үзүүлэх үүрэг оногдуулсан. НҮБ-ын авлигын эсрэг болон бусад НҮБ-ын гэрээнүүдээс гадна бүс нутгийн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, хэлэлцээрүүд нь үндэслэл болж өгнө. Тухайлбал, Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа

[6] Молдов улсад гарсан банкны залилангийн хэрэг дээр (4 дүгээр бүлэг, Шигтгээ 4.5-д дурдсан), Молдов Улсын үндэсний банк нь данс, харилцагчийн талаарх мэдээлэл болон газар дээрх хяналт шалгалт хийсэн тайлан зэрэг чухал мэдээллийг олж авахын тулд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг Кипр, Эстони, Латви, ОХУ-тай байгуулж ажилласан.

[7] НҮБ-ын МБГХТА, "Гарын үсэг зурсан, соёрхон баталсан байдал" (2020 оны 2 сарын 06-ны байдлаар), https://www.unodc.org/unodc/en/corruption/ratification-status.html.

үзүүлэх гэрээ (Зүүн-Өмнөд Азийн бүс нутгийн байгууллагын гишүүн орнууд[8] [ASEAN] байгуулсан), Америкийн бүс нутгийн байгууллагын гишүүн орнуудын (Organization of American States [OAS]) Авлигын эсрэг конвенц.

Салбарын мэргэжилтнүүд олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээрийн талаар нэг асуудлыг анхаарах шаардлагатай. Энэ нь тухайн олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээрт заасан үүргийг дотоодын хууль тогтоомжид тусгасан эсэх буюу "нутагшуулсан" (domestication) эсэхийг анхаарах шаардлагатай. Онолын хувьд, олон талт гэрээг (АЭК г.м) соёрхон батлсан улс орнууд нь тухайн гэрээний дагуу илгээсэн эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг хүлээн авах нь зүйтэй.[9] Гэвч, эдгээр гэрээний заавал биелэгдэх заалтууд нь ихэнх тохиолдолд ерөнхий байдлаар зохицуулагдаж, орчуулгатай холбоотой болон тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлсэн байдаг. Тухайлбал, харилцах суваг, шүүхээс зөвшөөрөл авдаг тодорхой төрлийн нотлох баримт цуглуулах болон хянан шийдвэрлэх ажиллагаа, баримт бичгийг хураан авах хүсэлтийг хэрэгжүүлэх процесс зэргийн талаар тодорхой зохицуулалт байдаггүй.

Зарим улс орнуудад дотоодын хууль тогтоомжоор тодорхой зохицуулалтууд хийж өгдөг бол зарим нь бүрэн бус зохицуулалттай, эсхүл олон улсын гэрээг нутагшуулсан ямарч зохицуулалт хийхгүйгээр, харин хэрэгжиж буй эрүүгийн хууль болон процессын хуулийн дутууг гэрээний заалтад тулгуурлан нөхөж хэрэглэх нь бий. Учир нь зарим хүсэлт илгээж байгаа эрх бүхий байгууллага нь гэрээг нутагшуулсан байхыг илүүд үздэг бөгөөд салбарын мэргэжилтнүүд нь энэхүү асуудлыг харгалзан, олон талт гэрээний хэрэгжилттэй холбогдуулан дотоодын хууль тогтоомжийг хянан үзэх нь чухал билээ.

Мөн түүнчлэн, бусад улс орнуудтай сайн дурын болон бүс нутгийн хэмжээнд сайн дурын механизм (arrangements) бий болгох боломжтой, тухайлбал Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх Хамтын нөхөрлөлийн нарийн бичгийн схем (Commonwealth Secretariat's Scheme on Mutual Legal Assistance in Criminal Matters (Harare схем)) буюу хамтын нөхөрлөлийн орнуудын хууль зүйн асуудал эрхэлсэн байгууллагуудын хоорондын амлалт юм. Хэдийгээр энэ нь заавал биелэгдэх эрх

[8] Хэдийгээр Зүүн өмнөд азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн орнуудын хэмжээнд Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байхгүй, байгуулахаар төлөвлөж байгаа хэдий ч албан ёсоор хязгаарласан зүйл байхгүй. ASEAN 2025: Ирээдүйгээ өөрсдөө бий болгох, B3.1. дэх арга хэмжээ "Улс төрийн аюулгүй байдлын нийгэмлэгийн 2025 он хүртэлх төлөвлөгөө"-нд "2004 оны олон улсын гэрээг шинэчлэх"-ээр тусгасан байдаг. (ASEAN 2015, 33). Индонезийн Жогжакартад 2019 онд зохион байгуулагдсан ASEAN-ы орнуудын Ерөнхий прокуроруд болон Хууль зүйн сайд нарын уулзалтын үеэр "Ази номхон далайн бүс нутгийн эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байгуулахаар тохиролцсон" (ASEAN 2019). "Зүүн өмнөд азийн бүс нутгийн хамтын ажиллагааны улс орнуудын ерөнхий прокурор, сайд нар нягт хамтран ажиллах амлалт өгсөн." ASEAN Нарийн бичгийн мэдээ, 2019 оны 4 дүгээр сарын 25. http://asean.org/asean-attorneys-generalministers-pledged-stronger-mutual-legal-assistance-ciminal-matters.

[9] Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 46, 55 дугаар зүйлүүд; НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (UNTOC)-ийн 18 дугаар зүйл; Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 7 дугаар зүйл.

зүйн хэрэгсэл, гэрээ биш боловч, талууд дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн схемийн заалтуудыг хэрэгжүүлж, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлнэ.[10]

Хоёр талт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, хэлэлцээрүүд

Олон талт гэрээтэй төстэйгөөр, хоёр талт гэрээнүүд нь заавал биелэгдэх заалтууд агуулсан байдаг ба талуудад харилцан туслалцаа үзүүлэх үүрэг оногдуулж, салбарын мэргэжилтнүүд даган мөрдөх процессыг тодорхойлсон байдаг. Түүнчлэн, дээрх гэрээнүүд нь өөр төрлийн зохион байгуулалт (arrangements)–ын замаар хэрэгжүүлэх боломжгүй хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломж олгодог, тухайлбал салбарын мэргэжилтнүүд, эрх бүхий байгууллагууд, шүүх эрх мэдлийн байгууллагууд хооронд шууд харилцах гэх мэт (Тодорхой эрх бүхий төв байгууллагуудыг хамруулсан).[11]

Дотоодын хууль тогтоомж

Зарим улс орнууд нь хоёр талт гэрээгүй[12] улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль тогтоомж баталсан байдаг ба ихэвчлэн харилцан адил байх зарчмыг үндсэн шалгуур болгодог (Хүсэлт илгээсэн тал нь адил төрлийн эрх зүйн туслалцаа үзүүлэх амлалт өгдөг). Гэрээний зохион байгуулалтуудтай (arrangements) адилгүйгээр, ийм төрлийн хууль тогтоомжууд нь олон улсад хүсэлтийг заавал биелүүлэх талаар үүрэг оногдуулдаггүй бөгөөд ийм төрлийн уян хатан байдал нь хүсэлтийг хүлээн авч гүйцэтгэх эсэх талаар тодорхойгүй байдал бий болгодог.[13]

Дипломат шугамаар харилцан адил байх амлалт өгөх (Хүсэлт бүхий захидал (Letters of rogatory))

Энэхүү эрх зүйн туслалцаа хүсэх уламжлалт төрлийг талуудын хооронд гэрээгүй, хүсэлт илгээж байгаа талын дотоодын хууль тогтоомжид зохицуулалт байхгүй тохиолдолд хэрэглэж болох юм (Зарим улс орнуудад олон талт болон хоёр талт гэрээг үндэслэл болгон хүсэлт илгээсэн хэдий ч харилцан адил байх амлалт зайлшгүй шаарддаг).

Хүсэлт бүхий захидал нь улс орнуудын хооронд буюу нэг улсын шүүх, прокурор, эсхүл хууль сахиулах байгууллагын ажилтан болон өөр улсын адил түвшний албан

---

[10] Дараах холбоосоор дэлгэрэнгүй үзнэ үү. Commonwealth Secretariat (2017), "Model Legislation on Mutual Legal Assistance in Criminal Matters," https://thecommonwealth.org/sites/default/files/key_reform_pdfs/P15370_14_ROL_Model_Leg_Mutual_Legal_Asstnce.pdf

[11] Тухайлбал, Щвейцарь, Ангола хооронд 2005, 2012 онуудад тус тус байгуулсан хөрөнгийг буцаах, захиран зарцуулах талаарх хоёр талт гэрээнүүд (21 сая ам.доллар) (FDFA 2016, 12), https://www.eda.admin.ch/dam/eda/en/documents/aussenpolitik/voelkerrecht/edas -broschuere-no-dirty-money_EN.pdf, хуудас 26.

[12] Тухайлбал, Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай Холбооны хууль ("Харилцан туслалцааны хууль," Щвейцарийн Эрүүгийн хууль [CC 351.1]) зэрэг нь 1981 онд батлагдсан бөгөөд гэрээгүй улс орнууд хооронд харилцан туслалцаа үзүүлэх боломжийг бүрдүүлсэн

[13] Зарим улс орнуудын хууль тогтоомжууд, тухайлбал Сингапур Улсын Эрүүгийн хэрэгт зүйн туслалцаа үзүүлэх хууль, https://sso.agc.gov.sg/Act/MACMA2000; Лихтенштайны Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль ("Эрх зүйн туслалцааны хууль"), https://www.regierung.li /international-mutual-legal-assistance-in-criminal-matters; БНХАУ-ын ЗЗОБ Хонконгийн Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх журам (Cap. 525), https://www.elegislation.gov.hk/hk/cap525; Щвейцарийн Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль ("Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хууль," CC 351.1), https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19810037/2019030 10000/351.1.pdf.

тушаалтнуудын хооронд албан ёсны шугамаар харилцах боломж олгодог. Энэхүү үйл явц нь гадаад харилцааны яам болон дипломат албыг заавал хамруулдаг.

9.2.2 Ерөнхий шаардлагууд

Аливаа улс орнуудад эрх зүйн туслалцааны хүсэлтүүдэд тавигдах хууль зүйн шаардлагуудтай байдгийг хүсэлт илгээж буй орнууд анхаарах хэрэгтэй. Тэдгээрээс зарим шаардлагууд болон харгалзан үзэх асуудлуудын талаар салбарын мэргэжилтнүүдэд зориулан хуваалцъя.

Хэргийн шинж чанар

Ерөнхийд нь авч үзвэл, хүсэлт нь эрүүгийн хэрэгтэй холбоотой байх зайлшгүй шаардлагатай, харин зарим улс орнуудад эрүүгийн хариуцлага оногдуулахааргүй тохиолдолд (non conviction based NCB) буюу иргэний болон захиргааны хэрэгт (эдгээр нь эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад үүссэн нөхцөл байдал) холбогдуулан хөрөнгө хураах хүсэлт илгээдэг.[14] Хүсэж буй туслалцааг хангуулах боломж бололцооны талаар тухайн процессын эхэн үед судлах нь зүйтэй.

Улс орнууд нь мөрдөн шалгах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль шатанд ямар туслалцаа үзүүлж чадах эсэхээрээ хоорондоо ялгаатай байдаг. Ихэнх улс орнуудад мөрдөн шалгах ажиллагааны явцад эрх зүйн туслалцааны хүсэлт авах боломжтой байдаг бол бусад улс орнуудад шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахын тулд хураах, эсхүл хөрөнгийн захиран зарцуулах эрхийг хязгаарлах зэрэгт (Тухайлбал гэмт хэрэгт хатган оролцуулсан эсэх (instigation of charges) болон хураах эцсийн шийдвэр зэрэг) төвөгтэй шалгуурууд тавьдаг. Олон улс орнуудад хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлдэггүй. Эдгээр илүү хатуу шалгууртай тохиолдлуудад салбарын мэргэжилтнүүд цаг хугацааны хувьд урьдчилан тооцоолж, хамгаалах арга хэмжээ (provisional measure) авах болон баривчлах тухай хүсэлт илгээж, хөрөнгийг сарниулахаас сэргийлэх шаардлагатай.

Харилцан гэмт хэрэгт тооцох

Олон улс орнуудад харилцан гэмт хэрэгт тооцдог байхыг шаарддаг (хураах хүсэлт нь илгээсэн бол), өөрөөр хэлбэл тухайн туслалцаа авахаар хүсэлт илгээгдэж буй үйлдэл нь талуудад гэмт хэрэгт тооцогдсон байх шаардлагатай.[15] Зарим улс орнуудад тодорхой нөхцөл байдлуудад энэхүү шалгуураас чөлөөлдөг. Харин бусад

[14] 7 дугаар бүлгийг харах, 7.2 болон 7.4 дэх хэсэг, шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах олон улсын хамтын ажиллагаа. Мөн, Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 43 дугаар зүйлийн 1, 54 дүгээр зүйлийн 1-ийн С, гишүүн улс орнуудын иргэний болон захиргааны хэргүүд дээр хамтран ажиллах буюу шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах талаар зохицуулсан.

[15] Жерсид харилцан гэмт хэрэгт тооцох шалгуур байдаггүй.

улс орнууд энэхүү шалгуурыг илүү хатуу хэрэгжүүлдэг (нэр томьёоны[16] хувьд тохирсон байх, эсхүл тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн нь элемент нь адил байх). Гэвч улс орнууд сүүлийн үед үйлдэлд тулгуурласан арга барилыг хэрэгжүүлж байгаа (энэ нь тухайн нэр томьёогоор тодорхойлогдож байгаа үйлдэл нь талуудын дотоодын хууль тогтоомжоор гэмт хэрэгт тооцдог байх тухай ойлголт юм). [17] Ямар ч тохиолдолд, албан бус туслалцаа авах явцад, урьдчилан зөвшилцөж харилцан гэмт хэрэгт тооцох шалгууртай холбоотой аливаа хаалт (barrier)-ыг илрүүлэх, даван гарах нь чухал юм.

Зарим улс орнуудад илүү нарийн гэмт хэргийг хуульчлаагүй байдаг бөгөөд үйлдэлд тулгуурласан арга барил нь авлигын гэмт хэргүүдэд илүү хэрэгтэй байдаг. Тухайлбал, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, гадаад улсын нийтийн албан тушаалтанд хахууль өгөх, татвараас зайлсхийх, өргөтгөсөн хөрөнгө хураах (extended confiscation) гэх мэт. Гэмт хэргийн талаарх жагсаалт гаргаснаас тухайн үйлдлийн талаар тайлбарлах нь чухал бөгөөд хүсэлт хүлээн авагч улсад хүсэлт илгээж буй талын дотоодын хууль тогтоомжийг ойлгох мэргэжилтэн байхгүй байх боломжтой бөгөөд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн нэршлээр нь гэмт хэрэгт тооцох эсэхийг дүгнэх магадлалтай. (Шигтгээ 9.2-т үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон гадаадын нийтийн албан тушаалтны авлигын хэрэгт хэрхэн харилцан гэмт хэрэгт тооцох шалгуурыг давах талаар дурдсан байгаа.)

Тухайн гэмт хэргийг контекст (context) –нд оруулах буюу гэмт үйлдэлтэй уялдуулан холбож, эрх зүйн туслалцааны хүсэлтийг тайлбарлах нь чухал. Түүнчлэн, салбарын мэргэжилтнүүд нэр томьёоны хувьд төөрөгдөлд оруулах тодорхой үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Тухайлбал, түгээмэл нэр томьёо болох "хууль бус гүйлгээ" (Illegal flows) нь зарим улс орнуудад татвараас зайлсхийх, хөрөнгийг гадагшаа гаргах зэрэг нэр томьёоллоор хэрэглэдэг тул асуудалтай. Энэ тохиолдолд түгээмэл хэрэглэгддэг "хууль бус гүйлгээ" нэр томьёог хэрэглэх нь зүйтэй.

Олон улсын конвенц, стандартууд нь эрх зүйн туслалцаа үзүүлэх талуудад харилцан гэмт хэрэгт тооцогдохгүй байгаа нөхцөл байдалд туйлширсан бус арга хэмжээ авахыг шаарддаг байх боломжтой.[18]

Баталгаа болон амлалт: Харилцан адил байх зарчим, Нууцлалыг хангах, Хэрэглэх хязгаар (тусгайлсан), хохирол, төлбөрийг төлөх амлалт

---

[16] Зарим улс орнуудын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид тухайн үйлдлийг дурдсан тохиолдолд тухайн улсын дотоодын хуулийн нэгэн адилаар гэмт хэрэгт тооцож, хүсэлтийг хүлээн авахаар зохицуулсан байдаг (Williams 1991, 600), https://digitalcommons.osgoode.yorku.ca/cgi/viewcontent.cgi?referer=https://www.google.com/&httpsredir=1&article=1454&context=scholarly _works. "Тухайлбал, 1933 онд Албани, АНУ хооронд байгуулсан гэрээнд хүн алах, хүчиндэх, хулайлах гэх мэт 20 гаруй гэмт хэргийг зохицуулсан байдаг" (Jonathan Masters, "Гэмт этгээдийг шилжүүлэх ажиллагаа гэж юу вэ?" [2020 оны 1 дүгээр сарын 8], Гадаад харилцааны зөвлөл, https://www.cfr.org/backgrounder/what-extradition). Албаний Хаант Улс, АНУ хооронд 1993 оны 3 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан Гэмт этгээд шилжүүлэх гэрээг харах, 49 Stat. 3313, https://www.loc.gov/law/help/us-treaties/bevans/b-al-ust000005-0022.pdf.

[17] Олон улсын гэрээ, конвенциуд нь гишүүн улс орнуудыг үйлдэлд суурилсан аргыг хэрэгжүүлэхийг дэмжсэн байдаг. Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 43 дугаар зүйлийн 2, ФАТФ-ын зөвлөмж 37 ("Эрх зүйн харилцан туслалцаа") (ФАТФ [2019]).

[18] Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 46 дугаар зүйлийн 9, ФАТФ-ын Зөвлөмж 37 (2019) ("Эрх зүйн харилцан туслалцаа").

Олон улс оронд харилцан адил байх баталгаа шаарддаг: Хүсэлт илгээж буй улс нь хүсэлт хүлээн авагч улсад төстэй хэрэгт ижил төрлийн туслалцаа үзүүлэх талаар бичгээр мэдэгдэх. Олон улс орнуудад хүсэлт илгээж буй улсаас тухайн эрх зүйн туслалцааны хүсэлт нь нууцлалтай эсэхийг тодорхой дурдахыг шаарддаг. Түүнчлэн, улс орнууд нь хүсэлт илгээж буй улсад гаргаж өгсөн мэдээллийг зөвхөн эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсан хэрэгт ашиглах талаар баталгаа шаарддаг бөгөөд өөр хэрэгт ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд шилжүүлэн өгөхийг хориглодог.[19] Мөн, зарим улс орнууд тухайн хүсэлтийг нь гүйцэтгэх явцад учирч болох аливаа хохирол, төлбөрийг барагдуулах талаарх амлалт авахыг шаарддаг. [20]

Эдгээр баталгаануудыг зарим хэрэгт шаардахгүй байж болох боловч тухайн улс хооронд энэ талаар зөвшилцөх шаардлагатай. Зарим салбарын мэргэжилтнүүд нь эдгээр баталгаануудыг гаргаж өгөхөөс татгалзах, эсхүл эдгээр шаардлагууд нь тухайн улсын хууль тогтоомжид зохицуулагдаагүй (ихэнх эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад байдаггүй) байдаг тул төөрөгдөлд ордог. Улмаар эрх бүхий байгууллагаар тухайн баталгаануудыг гаргуулах эсэх талаар тодорхой ойлголтгүй байдаг. Гэвч, эдгээр баталгаанууд нь ихэнх тохиолдолд заавал шаардагддаг бөгөөд баталгааг гаргаагүй тохиолдолд тухайн эрх зүйн туслалцааны хүсэлтийг нь гүйцэтгэхээс татгалзах магадлалтай.

ШИГТГЭЭ 9.2 Харилцан гэмт хэрэгт тооцдог байх шаардлагыг давах: Үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон гадаад улсын нийтийн албан тушаалтнуудын авлигын хэрэг

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих (нийтийн албан тушаалтан нь тухайн хөрөнгийг хэрхэн олж авсан талаарх үндэслэлтэй тайлбарыг өгч чадахгүй тохиолдолд хууль бусаар олсон гэж үздэг), гадаад улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэрэг хэд хэдэн улс орнуудад хуульчлагдаагүй байдаг. Шууд нэр томьёог нь орчуулбал, харилцан гэмт хэрэгт тооцогдохгүй нөхцөл байдал үүснэ. Мөн тухайн улсаас эрх зүйн туслалцааны хүсэлт хүсэх боломжгүй болно.

Энэхүү шалгуурыг тухайн гэмт хэргийг үйлдлээр нь үнэлсэн тохиолдолд даван туулах боломжтой. Учир нь хүсэлт илгээж буй улсад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа гэмт хэрэг нь хүсэлт хүлээн авагч улсад өөр нэршилтэй гэмт хэрэгт тооцдог байх боломжтой. Тухайлбал, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдэл нь хүсэлт хүлээн авагч улсад өөр нэр томьёогоор гэмт хэрэгт (хахууль авах гэх мэт) тооцдог байх боломжтой. Гадаад улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч улс оронд тухай улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэрэг нэр томьёотойгоор хэрэглэгдэн байх боломжтой.

Тухайн үйлдэл нь аль аль талд нь гэмт хэрэгт тооцогдсон тохиолдолд харилцан гэмт хэрэгт тооцох шаардлага хангагдана. Энэхүү арга барил нь Швейцар улсын Холбооны дээд шүүхийн 2003 оны шийдвэр (ATF 129 II 462)-ээр баталгаажсан.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[19] Үүнийг хязгаарлалтын зарчим гэнэ (НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба 2012), https://www.unodc.org/ documents/organized-crime/Publications/Mutual_Legal_Assistance_Ebook_E.pdf

[20] Хүсэлтийг хүлээн авагч улс нь өөрийн буруугүй үйлдлээс шалтгаалан аливаа төлбөрийг барагдуулах үүрэг хүлээх магадлалтай.

ШИГТГЭЭ 9.2	Харилцан гэмт хэрэгт тооцдог байх шаардлагыг давах: Үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон гадаад улсын нийтийн албан тушаалтнуудын авлигын хэрэг

Тухайн шийдвэрт гадаад улсын нийтийн албан тушаалтны хахуулийн гэмт хэргийн талаар нэр томьёо байгаагүй ч авлигын хэрэгт тооцсон байдаг. Энэхүү шийдвэрийг гаргахдаа, шүүх нь тухайн гэмт хэргийг үйлдэл, нөхцөл байдлыг авч үзсэн, хүсэлт илгээж буй улс нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дурдахдаа өөр гэмт хэргийн бүрэлдэхүүний шаардлагыг хангасан. Швейцарийн дотоодын хууль тогтоомжоор нийтийн албан тушаалтны идэвхтэй авлигын гэмт хэрэгт тооцсон.

Салбарын мэргэжилтнүүд нь энэхүү арга барилыг хэрэглэхдээ тухайн эрх зүйн туслалцааны хүсэлтдээ хэргийн нөхцөл байдал, үйлдлийг тодорхой дурдах шаардлагатай. Тухайлбал, дараах байдлаар илгээх нь энэхүү шаардлагыг хангахгүй.

"Ноён Х нь сар бүр 3000 ам.долларын орлоготой Зам, тээврийн яамны нийтийн албан тушаалтан. Тэрээр 5 жилийн өмнө энэхүү албан тушаалд томилогдохдоо хадгаламжгүй байсан. Одоо тэрээ 5 сая ам.доллартой бөгөөд энэхүү орлогын эх үүсвэрийг тайлбарлаж чадаагүй буруутай."

Үүний оронд, *"Ноён Х нь барилгын худалдан авах гэрээ байгуулсан, өнгөрсөн 3 жилийн хугацаанд тэрээр 3 үндсэн гэрээг шинэ компаниудтай байгуулсан. Түүний банкны мэдээллээр гэрээ байгуулахаас өмнөхөн 400.000.000 ам.долларыг 2 удаа шилжүүлэн авсан нь тогтоогдсон бөгөөд саяхан танай газар нутагт байдаг ноён Х-ын данс руу 1 сая ам.долларыг шилжүүлсэн байна."* гэж дэлгэрэнгүй дурдах.

Хүсэлт хүлээн авагч улсад эрх зүйн туслалцааны хүсэлтийг албан ёсоор илгээхээс өмнө төсөл хэлбэрээр илгээж асуух нь процессыг хурдлуулна. Хүсэлт хүлээн авагч улс нь төслийн талаар санал гаргаж биелэгдэх магадлалыг нэмэгдүүлэх боломжтой.

9.2.3 Нотолгооны шаардлагууд

Салбарын мэргэжилтнүүд нь ихэвчлэн хүсэлт хүлээн авагч улсын албан тушаалтанд дотоодынх нь хууль тогтоомжийн дагуу эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай нотлох баримтаар үнэлэгдэх хангалттай баримт, мэдээллээр хангах шаардлагатай байдаг. Улс орнуудын нотлох баримтаар үнэлэх шалгуур нь адилгүй байдаг тул энэхүү шаардлага нь зарим тохиолдолд хүндрэлтэй байдаг. Хүсэлт хүлээн авагч улс нь хүсэлт илгээж буй улсаас илүү өндөр стандарт шаардах боломжтой. Аль нэг улсад зохистой хэмжээнд эрх зүйн туслалцааны хүсэлт гэж тооцогдож байхад нөгөөд нь хэтэрхий өргөн цар хүрээтэй хүсэлтэд тооцогддог.

Энэхүү шаардлага нь эх газрын эрх зүйн болон нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хоорондын харилцаанд, эсхүл өөр төрлийн эд зүйл хураах эрх зүйн зохицуулалттай улс орнуудын хоорондын харилцаанд илүү бэрхшээлтэй байдаг (үнэ цэнд тулгуурласан болон эд зүйлд тулгуурласан, эсхүл эрүүгийн хэрэгт эд зүйл хураах болон эрүүгийн бус хэрэгт эд зүйл хураах гэх мэт). Түүнчлэн, нотлох баримтын стандарт, нотлох баримтыг шинжлэн судлах болон нотлох баримтын нотолгооны чадварын талаарх шалгуур нь хоорондоо адилгүй байдаг. Тухайлбал, тухайн хэргийн тогтоогдсон нөхцөл байдлууд нь нотлох баримтаар үнэлэгдэхдээ, нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад ихэвчлэн тухайн нотлох баримт нь үнэн болох талаарх баталгаа (affidavit), эсхүл гэрчилгээг хавсаргадаг, харин эх

газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад ихэвчлэн дээрх төрлийн шаардлага байдаггүй. (нотлох баримт нь үнэн болох талаарх баталгааны төслийг боловсруулах талаарх мэдээллийг 5 дугаар бүлэг, Шигтгээ 5.2-оос харах)

Хангалттай хэмжээнд нотлох баримтаар үнэлэгдэхүйц баримт, мэдээллээр хангах босгыг даваагүй, эсхүл нотлох баримтыг цуглуулах бусдад хамгийн бага хохирол учруулах гэх мэт наад захын шаардлагыг хангаагүй нь тухайн хүсэлтийг буцаах, гүйцэтгэхээс татгалзах үндэслэл болно. Иймд, салбарын мэргэжилтнүүд нотлох баримтын шаардлага, стандарт болон нотлох баримтаар үнэлэгдэхүйц баримт, мэдээллийн жишээ зэрэг асуудлын талаар эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө зөвшилцөх хэрэгтэй. Албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлт шаардлагатай гэж үзвэл, дараах 3-н алхмыг эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхээс өмнө бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

- *Нэгдүгээр алхам:* Яг ямар зүйл шаардлагатай байгааг тодорхойлох (тухайлбал, худалдаа, гүйлгээний баримт гаргуулах, хураах, нэгжлэг хийх, эд хөрөнгийг хураах, битүүмжлэх, эсхүл түр хураах гэх мэт). Эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхдээ нэг дор бүгдийг гүйцэтгүүлэх бус алхам, алхмаар нь хэрэгжүүлэх шаардлагатай.
- *Хоёрдугаар алхам:* Бусдын эрхийг хамгийн бага зөрчихүйц, хэлбэрээр шаардлагатай баримт, мэдээллийг олж авах арга, нотлох баримтын стандарт болон хүсэлт хүлээн авагч улсаас хүсэж буй нотлох баримтыг тодорхойлох (Тухайлбал, тодорхой тогтоогдсон нөхцөл байдал, хөрөнгийн байршил, тухайн гэмт хэрэг болон хөрөнгө хоорондын холбоо хамаарал болон шүүхийн шийдвэр гэх мэт).
- *Гуравдугаар алхам:* Хүсэлт хүлээн авагч улсаас хүсэж буй нотлох баримт болон бусад баримтуудыг чухам ямар хэлбэр дээр гаргавал нотлох баримтаар үнэлэгдэхийг тодорхойлох (9.2.4 дэх хэсгээс нэмэлт мэдээлэл болон хэлбэр, агуулгын талаар харах).

Ерөнхийд нь авч үзвэл, тухайн арга хэмжээ нь бусдын эрхийг зөрчих магадлал өндөр байх тусам, нотлох баримтын өндөр стандарт шаардлагатай болно. Тухайлбал, (а) тухайн гэмт хэрэг нь үйлдэгдсэн байх, (б) хүсэлт хүлээн авагч улсад байгаа хөрөнгө нь гэмт хэрэг, гэмт этгээдтэй, эсхүл бусад байдлаар холбоотой байх, (в) битүүмжлэх болон буцаах хөрөнгийн тодорхой байршил нь тогтоогдсон байх талаарх нотлох баримт шаардагдана.

Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад мөрдөн шалгах ажиллагаа явуулах, урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авах зөвшөөрлийг “итгэл үнэмшил төрүүлэхүйц үндэслэл”, эсхүл “байж болзошгүй шалтгаан” зэрэгт үндэслэн олгодог. Хөрөнгө хураахад “магадлалын тэнцвэрт байдал”, эсхүл “хангалттай нотлох баримт” зэрэг нотолгооны өндөр шалгуурыг шаарддаг. Зарим онцгой тохиолдлуудад, ихэнх эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнууд нь хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай бол мөрдөн шалгах ажиллагаа явуулах, эсхүл урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авдаг. Харин, хөрөнгийг хураахад илүү өндөр шалгуур (“хангалттай итгэл үнэмшил төрүүлэхүйц” байх) тавьдаг.

Хоёрдугаар бүлгийн 2.1 дахь хэсэгт нотлох баримтын талаар өөр өөр шалгуурыг дурдсан. 9.2.6 дахь хэсэгт хөрөнгийг мөрдөх, хамгаалах арга хэмжээ авах, хураахад шаардагдах нотлох баримтын шалгуурууд, наад захын нотлох баримтын шалгуур болон бусад мэдээллийн талаар дурдсан.

9.2.4 Эрх зүйн туслалцааны хүсэлтийн хэлбэр, агуулгад тавигдах шалгуур

Эрх зүйн туслалцааны хүсэлтүүд нь заавал бичгээр байж, хүсэлт хүлээн авагч улс, хэрэглэж буй олон улсын гэрээ, талуудын эрх бүхий төв байгууллагаас тавьсан хэл, агуулга, хэлбэрийн талаарх шалгуурыг хангасан байна. Өмнө нь дурдсанчлан, салбарын мэргэжилтнүүд нь эдгээр шалгууруудын талаар албан ёсны хүсэлт илгээхээс өмнө олж мэдэх, хүсэлтийн төслийг илгээх шаардлагатай юм. Зөвшөөрөгдсөн, боломжтой нөхцөлд, салбарын мэргэжилтнүүд нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага, эсхүл хүсэлтийг гүйцэтгэх байгууллагад илгээж биелэгдэх магадлалыг өндөрсгөх нь зүйтэй. Энэхүү төслийг боловсруулах үе шат нь эрх зүйн туслалцааг үр дүнд хүргэхэд шалгуурыг хангах, хэргийн тогтоогдсон нөхцөл байдлуудыг тодорхой болгож, нэр томьёог зөв хэрэглэх зорилготой. Энэ нь мөн хүсэлт илгээж буй салбарын мэргэжилтнүүдэд шаардлагагүй хугацаа алдах, хүсэлт гүйцэтгэхээс татгалзахаас сэргийлэх, хүсэлт хүлээн авагч улсад урьдчилж бэлтгэх зэрэг боломж олгодог.

Эрх зүйн туслалцааны хүсэлт нь хүсэлт хүлээн авагч улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр үйлдэгдсэн байх шаардлагатай. Орчуулга хийх үүргийг хүсэлт илгээж буй улс хүлээнэ. Зарим онцгой тохиолдолд хүсэлт илгээж буй улс төлбөрийг нь хариуцахыг зөвшөөрвөл хүсэлт хүлээн авч буй улсад орчуулгыг гүйцэтгүүлж болдог. Тодорхой хэргүүдэд, зарим улс орнууд нь орчуулгын зардлыг өөрсдөө хариуцах тохиолдол байдаг.

Хэрэв орчуулгын үйлчилгээ авч байгаа бол хуулийн нэр томьёоны талаар мэдлэгтэй мэргэжлийн орчуулгын үйлчилгээ авах нь чухал. Учир нь орчуулгын алдаа нь үл ойлголцол төрүүлж, түүнийг тодруулахад хугацаа алдах эрсдэлтэй. Энэ нь зарим тохиолдолд хүсэлт гүйцэтгэх процессын хамгийн том саад нь болдог. Мөн, эх хэлээрээ эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг үйлдэж байгаа албан тушаалтан нь орчуулга хийлгэнэ гэж тооцоолон, ойлгомжтой, обьектив талаас нь, хялбар хэллэг ашиглаж орчуулгын ажлыг хялбарчлах, буруу орчуулахаас сэргийлэх шаардлагатай. Товчхондоо, өгүүлбэрийг он цагийн дараалаар нь байрлуулж орчуулна. Хариуцаж буй прокурор, мөрдөгчтэй холбоо барих мэдээллийг хүсэлтэд оруулах шаардлагатай.

Салбарын мэргэжилтнүүд нь хүсэлтийн биелэгдвэл зохих хэлбэр, нэмэлт мэдээллийг тодорхойлох нь зүйтэй. Зарим улс орнууд тодорхой гарчгууд өгч, хүсэлтийг илүү ойлгомжтой болгодог (Хавсралт I-с эрх зүйн туслалцааны хүсэлтийн загварыг харах). Хүсэлтэд баталгаа, баримт бичиг гаргуулах, битүүмжлэх, урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ, эд хөрөнгө хураах шүүхийн шийдвэрийн эх болон хуулбар хувь, гэх мэт шаардлагатай бусад материалыг хавсаргана. Эдгээр баримтуудыг шүүхээс баталгаажуулсан, эсхүл эрх бүхий байгууллага, гэрчээр гарын үсэг зуруулсан байх шаардлагатай.[21]

Эцэст нь, хүсэлт илгээж буй улсаас хүсэлт хүлээн авч буй улсад хүсэлтийг гүйцэтгэхэд тавих тусгайлсан хууль тогтоомжийн шаардлага байвал (тухайлбал, мэдүүлэг авч байгаа албан тушаалтанд тавигдах тусгайлсан шаардлага гэх мэт)

[21] Тухайн этгээд нь үнэн зөв мэдүүлэг өгөхийг илэрхийлсэн, хөндлөнгийн гэрчүүд, тухайлбал нотариат байлцуулсан байхыг шаарддаг. Гэрчилгээг шүүх, магистрат, алба хаагчийн аль аль нь гаргаж өгч болно.

хүсэлтдээ тусгана. Салбарын мэргэжилтнүүд тухайн эрх зүйн туслалцааны хүсэлт нь яаралтай биелэгдэх шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх сүүлийн хугацаа болон шалтгааныг баримтаар баталгаажуулах (тухайлбал, шүүх хурлын товын талаарх мэдээлэл). Мөн хүсэлтэд өөрсдийн холбоо барих мэдээллийг тусгана.

9.2.5 Хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шалтгаанууд

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах ерөнхий болон нотлох баримтын талаарх шаардлагаас гадна, ихэнх тохиолдолд тухайн хэрэг тус бүрийн онцлогоос хамааран тодорхой нөхцөл байдалд хүсэлт хүлээн авагч улс хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах эрх эдлэхийг зөвшөөрсөн байдаг.[22] Зарим олон улсын гэрээнүүдэд (НҮБ-ын гэрээ, конвенциуд гэх мэт) хүсэлт гүйцэтгэхээс татгалзахыг хориглосон үндэслэлүүдийг заасан байдаг. Тухайлбал, улсын санхүүгийн асуудал, банкны нууцлалтай холбоотой хэргүүд (Шигтгээ 9.3-ыг харах).

ШИГТГЭЭ 9.3 Банкны нууцлал ба санхүүгийн гэмт хэргүүд: Эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг гүйцэтгэхээс татгалзахыг хориглосон үндэслэлүүд

Банкны нууцлал болон санхүүгийн гэмт хэргүүдэд холбогдуулан илгээж буй эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзахыг НҮБ-ын конвенциудаар хориглосон байдаг. Хэрэв тухайн олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орсон бол салбарын мэргэжилтнүүд нь дараах гэрээ, конвенцийн заалтуудыг хэрэглэх нь зүйтэй.

Санхүүгийн гэмт хэргүүд

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг ганцхан санхүүгийн асуудалтай холбоотой гэж үзэж гүйцэтгэхээс татгалзахыг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 46 дугаар зүйлийн 22 дахь хэсэг, НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 18 дугаар зүйлийн 22 дахь хэсэг, НҮБ-ын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт тус тус зааснаар хориглодог.

Банкны нууцлал

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг банкны нууцлалын асуудалтай холбогдуулан гүйцэтгэхээс татгалзахыг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Олон улсын бизнесийн хэлцэлд гадаад улсын нийтийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх конвенцийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 46 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[22] Тухайлбал, Авлигын эсрэг НҮб-ын Конвенцид дараах тохиолдлуудад татгалзахаар зохицуулсан, (a) хүсэлт болгосон туслалцааны мөнгөн дүн хэт бага; (b) процессийн шаардлагыг хангаагүй (харилцан гэмт хэрэгт тооцох гэх мэт); (c) хүсэлт хүлээн авагч улсын бүрэн эрх, аюулгүй байдал, нийтийн хэв журам, болон бусад ашиг сонирхлыг зөрчих тохиолдолд; (d) дотоодын хууль тогтоомжийг зөрчих тохиолдолд. Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 46 дугаар зүйлийн (9)(b), 46 дугаар зүйлтийн (21),(23)-ийг тус тус харах.

ШИГТГЭЭ 9.3	Банкны нууцлал ба санхүүгийн гэмт хэргүүд: Эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг гүйцэтгэхээс татгалзахыг хориглосон үндэслэлүүд

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт гишүүн улс орнуудын шүүх болон бусад эрх бүхий байгууллагад дотоодын хэрэгт банк, санхүү, худалдааны байгууллагыг битүүмжлэхэд олон улсад хамтран ажиллах эрх олгох талаар заасан байдаг.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 40 дүгээр зүйлд гишүүн улс орнуудад мөрдөн шалгах ажиллагаанд банкны нууцлалтай холбоотой үүсэж болох саад бэрхшээлийг давах тохиромжтой механизм бий болгохыг шаардсан байдаг. Хэдийгээр энэхүү заалт нь дотоодын мөрдөн шалгах ажиллагаанд хэрэглэгдэх боловч мөн л адил банкны нууцлалын эсрэг үйлчилгээтэй бөгөөд хүсэлт хүлээн авч буй улсад мөнгө угаах зүйл ангиар хэрэг үүсгэх шаардлага үүсэхэд хэрэглэгдэх юм.

Салбарын мэргэжилтнүүд нь эдгээр боломжит саадыг эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхээс өмнө урьдчилж тодруулах шаардлагатай (хэрэв боломжтой бол) бөгөөд нэгэнт эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шийдвэр гарсан тохиолдолд дахин илгээх боломж бага байдаг. Гадаад улсын хамтран ажиллаж байгаа албан тушаалтантай харилцан зөвлөлдөх нь энэ утгаараа чухал юм. Зарим улс орнуудад эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах дараах зарим шалтгаануудыг хуваалцъя. Үүнд:

Үндсэн ашиг сонирхол. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүсэлт хүлээн авч буй улсын үндсэн ашиг сонирхолд халдаж байна гэж үзвэл гүйцэтгэхээс татгалздаг. Үндсэн ашиг сонирхлыг аливаа конвенцод дурдаагүй боловч бүрэн эрх, нийтийн хэв журам, аюулгүй байдал, дотоодын нөөцөд илт ачаалал өгөх зэрэг ойлголтыг агуулна. Харамсалтай нь, үндсэн ашиг сонирхлын талаар өргөн хүрээний тайлбар нь олон улсын хамтын ажиллагааг сулруулдаг. Тухайлбал, хүсэлт хүлээн авч буй улс байгалийн баялгийн талаарх мэдээлэл ил болох магадлалтай гэх үндэслэлээр хахуулийн гэмт хэрэгт хамтран ажиллахаас татгалзах боломжтой.

Мөнгөн дүн нь хэт бага (Assets of de minimis value). Дээр дурдсанчлан, олон улсын хамтын ажиллагааг олж авах процесс нь урт хугацааг хамарч, хүсэлт илгээж буй улс болон хүсэлт хүлээн авч буй улс аль алинаас нь их хэмжээний нөөц шаардаг. Мөн хүсэлт хүлээн авч буй улсад мөнгөн дүнгийн доод хэмжээ болон бусад шалгуурт нийцсэн байхыг (тухайлбал, гэмт хэрэг нь ноцтой эсэх) шаардаг.[23] Салбарын мэргэжилтнүүд нь урьдчилан эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийн мөнгөн дүн, яллах магадлал хангалттай эсэхийг хянана. Улс орнуудын хувьд хэт бага мөнгөн дүнд ямар хэмжээг тооцдог нь хоорондоо адилгүй байдаг. Гэвч, нийтийн эрх ашиг хөндөгдсөн, авлигын, эсхүл ахмад улс төрч холбогдсон хэргүүдэд улс орнууд ихэвчлэн энэхүү мөнгөн дүнгийн босгыг харгалзан үздэггүй.

Нэг гэмт хэрэгт давтан ял оногдуулахгүй зарчим болон хүсэлт хүлээн авч буй улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явж байгаа тохиолдолд. Хэргийн

[23] Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 46 дугаар зүйлийн (9)(b), 55 дугаар зүйлийн (7)-д хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах үндэслэлүүдийг зохицуулсан. Түүнчлэн, нэмэлтээр 46 дугаар зүйл, 55 дугаар зүйлийн (7), (8)-д тус тус татгалзах үндэслэлүүдийг тусгасан байдаг.

холбогдогч нь аль хэдийн эрүүгийн хариуцлага хүлээсэн, эсхүл тухайн гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан, хүсэлт хүлээн авч буй улсад тухайн үйлдэлд нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа зэрэг тохиолдолд эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах магадлалтай. Энэхүү зарчим нь эрх зүйн туслалцааны хүсэлтэд илүү хамааралтай, учир нь эрх зүйн туслалцааны хүсэлтээр өгч буй мэдээллээр хүсэлт хүлээн авч буй улсад дотоодод эрүүгийн хэрэг үүсгэхэд хангалттай их байдаг. Хүсэлтийг хүлээн авч "Та бүхний мэдээлэлд талархал илэрхийлье, бидний зүгээс танай мэдээлэлд үндэслэн мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлсэн тул эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй" гэсэн хариу өгөх боломжтой. Энэхүү асуудлыг урьдчилан тооцоолж, эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх нь эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй (тухайлбал, хувийн сүлжээгээр дамжуулан холбогдох).

Эрүүгийн хариуцлагын шинж чанар болон хүнд хөнгөн. Зарим улсад хэрэв тухайн гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага нь хэт хүнд, тухайлбал цаазын ял оногдуулахаар байвал хамтран ажиллахаас татгалздаг. Хөрөнгө хураах тохиолдлыг тусгайлан авч үзвэл, эрүүгийн хариуцлагын үндэс суурь нь, тухайлбал хөрөнгө хураах ялын тухай зохицуулалт (тухайлбал, сунгасан хураах ял (extended confiscation)) тухайн улсад байдаггүй тохиолдолд хамтын ажиллагааг сулруулах магадлалтай. Энэхүү асуудлыг тодорхой төрлийн ялыг оногдуулахгүй байх баталгаа, эсхүл амлалт гаргаж өгөх хэлбэрээр шийдвэрлэх боломжтой.

Халдашгүй байдал. Хэрэв тухайн этгээд нь халдашгүй эрхтэй байвал улс орнууд ерөнхийдөө эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалздаг. Энэхүү асуудал нь хүсэлт илгээж буй улсаас халдашгүй байдлыг цуцлах байдлаар шийдвэрлэгдэнэ. Тухайлбал, Фердинанд Маркосын жишээг авч үзэхэд, Филиппин улсын засгийн газар нь өргөн хүрээнд халдашгүй байдлыг нь цуцалж, гадаад улсаас ажиллагаа явуулах боломжоор хангаж өгсөн.[24] Илүү их мэдээлэл авахыг хүсвэл халдашгүй байдлын талаар хоёрдугаар бүлгийн 2.8.2 дахь хэсгийг үзнэ үү.

Хянан шийдвэрлэх ажиллагааны дутагдал (Lack of due process). Салбарын мэргэжилтнүүд нь хүсэлт хүлээн авч буй улсад хэрэгт холбогдогчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь эрх нь хангагдаж байгаа талаар мэдэгдэх шаардлагатай. Урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ болон хөрөнгө хураахад, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гуравдагч этгээдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь эрх нь мөн хангагдсан байх хэрэгтэй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь эрх нь ерөнхийдөө шударгаар шүүлгэх, хэрэгт урьдчилан бэлтгэх хугацаагаар хангуулах, гуравдагч этгээдийн хамгаалалт, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гарал үүсэл, үндэс, хүйс, шашин, шүтлэгээр ялгаварлагдахгүй байх зэрэг юм. [25]

Салбарын мэргэжилтнүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхийг хангах нь чухал асуудал бөгөөд бусад үндэслэлүүдийн адилаар хүсэлтийг гүйцэтгэхээс

[24] Филиппин Улсын Засгийн газрын дипломат ноот бичигт (1988 оны 8 дугаар сарын 9), "АНУ, Филиппин Улсын хооронд байгуулсан Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, бусад хамтын ажиллагаануудад үндэслэн Өмнөд Нью-Йоркод мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэрэгт холбогдуулан Филиппин Улсын Засгийн газраас тус улсын өмнөх ерөнхийлөгч, түүний гэргийгийн дипломат эрх ямбыг цуцлав." In re Doe, 860 F.2d 40, 43 (2d Cir. 1988).

[25] Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал.

татгалзах үндэслэл болдог. Мөн ерөнхийд нь эрх зүйн стандарт тогтоосноос илүү хэрэг болгонд тохируулж хэрэглэх шаардлагатай. Үр дүнд нь, эрх зүйн туслалцааны хүсэлтэд тухайн этгээдэд эдлүүлэх шаардлагатай эрх болон процессын бусад шийдвэрүүдийн талаар гэх мэт дотоодын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын талаар хангалттай мэдээлэл тусгах нь зүйтэй. Харин, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, авах ажиллагаанд дээр дурдсан дээр зарим үндэслэлүүд нэмэгдэнэ. [26]

9.2.6 Тусгайлан анхаарах зүйлс: Мөшгөх, Түр зуурын арга хэмжээ авах, болон Хураан авах

Мөрдөн шалгах ажиллагаа болон хөрөнгө мөрдөх

Гурав болон дөрөвдүгээр бүлэгт дурдсанчлан, хөрөнгийг мөрдөх болон мөрдөн шалгаж мэдээлэл, нотлох баримт цуглуулах хэд хэдэн арга бий. Эдгээрийн ихэнхэд нь эрх зүйн туслалцааны хүсэлт шаардлагатай. Тухайлбал, а. Санхүүгийн байгууллагаас холбогдох баримт бичгийг гаргуулах, хураах, б. Банкны дансанд ажиглалт хийх шийдвэр гаргаж, санхүүгийн байгууллагаас дансны хөдөлгөөн, гүйлгээний мэдээллийг тухай бүрд нь авах, в. Нэгжлэг хийх, хураах зөвшөөрөл гаргаж, байгууллага, хувь хүнээс биет баримтыг олж авах, г. Гэрчүүдээс мэдүүлэг авах. Дээрх эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай нөхцөлүүдийн талаарх дараах жишээг дурдвал:

- Эрх зүйн туслалцааны ерөнхий шалгууруудыг хангасан бөгөөд татгалзах үндэслэл байхгүй.
- Мөрдөн шалгах ажиллагааны хүсэлт болгосон мэдээлэл нь тухайн банкны данс, эсхүл нэгжлэг хийх газарт байгаа гэж таамаглах хангалттай үндэслэл байгаа.
- Ажиглалт хийх хөрөнгийн байршил, гаргуулан авах банкны дансны гүйлгээний мэдээ, тухайн мэдээллийн талаарх хугацаа зэргийн талаар шаардлагатай мэдээллээр хангасан байх (Хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шийдвэр гаргуулахаас сэргийлэх талаар Шигтгээ 9.4-ийг харах).

Зарим эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад зарим шийдвэрүүдийг прокурор, мөрдөгч гүйцэтгэх боломжтой. Харин нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад, эдгээр шийдвэрүүдийг зөвхөн шүүх гаргадаг. Аль эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргах эсэхээс нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа, хүсэлтэд тавигдах эрх зүйн болон хэлбэрийн шалгуурыг тодорхойлно (Тухайлбал, шүүхээс шийдвэр гаргуулах шаардлагатай хүсэлт илгээхэд илүү өндөр шалгуур, хугацаа шаардагдана).

Өргөн цар хүрээ хамарсан, эсхүл ээдрээ төвөгтэй буюу өргөн хүрээний банкны болон санхүүгийн баримт, мэдээлэл шаардлагатай хэргүүдэд салбарын мэргэжилтнүүд нь хүсэлтийг гүйцэтгэхэд оролцох эсэх талаар анхаарах шаардлагатай. Хэрэв зөвшөөрвөл, хүсэлт илгээж буй улсын салбарын мэргэжилтнүүд нь мөрдөн шалгах ажиллагаанд нэгжлэг хийх, хураан авах, хураан авч баримт,

[26] Гэмт хэрэг нь Хүсэлтийг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, эсхүл улс төрийн гэмт хэрэг байвал Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзаж болно. Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 44 дүгээр зүйлийн (4)-ийг харах.

мэдээллийг нь ангилах болон гэрч, мэргэжилтнүүдээс асуулт асуух зэрэг байдлаар оролцох нь хүсэлтийг гүйцэтгэх хурдыг нэмэгдүүлнэ. [27]

ШИГТГЭЭ 9.4	Хэт өргөн хүрээний эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шийдвэр гаргуулахаас урьдчилан сэргийлэх

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шийдвэр гаргах, эсхүл нэмэлт мэдээлэл хүсэх гол шалтгаануудын нэг нь тухайн хүсэлт нь хэтэрхий өргөн цар хүрээ хамарч, тухайн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргээс давсан байдагтай холбоотой. Хэд хэдэн асуудлууд үүсэх боломжтой боловч тодорхой техник, сайн туршлага нь хүсэлтийг гүйцэтгэхээ татгалзах шийдвэр гаргахаас нь сэргийлдэг.

Цар хүрээ нь хэт өргөн эрх зүйн туслалцааны хүсэлт

Тухайлбал, дараах эрх зүйн туслалцааны хүсэлт нь мөрдөн шалгах ажиллагаанаас гадуурх бөгөөд хэт өргөн цар хүрээг хамарсан байна. Үүнд:

"Ноён Х нь авлигын гэмт хэрэгт холбогдсон. Танай улсад бүртгэлтэй түүний бүхий л дансны мэдээллийг гаргаж, захиран зарцуулах эрхийг нь нэн даруй хязгаарлаж өгнө үү" гэх.

Үүнээс илүүтэйгээр, мянга, мянган санхүүгийн байгууллага болон хэдэн арван мянган зуучлагч үйл ажиллагаа явуулдаг улс оронд дээрх мэдээллийг олж авах нь хэт ахадсан даалгавар. Хэдхэн том санхүүгийн байгууллагатай бөгөөд тэдгээр нь зуу, зуун салбартай улс оронд хүртэл дээрх мэдээллийг олж авахад тухайн банк нь нэгдсэн мэдээллийн сангүй тохиолдолд хэт их ачаалал болдог.

Тодорхойгүй, эсхүл өргөн хүрээний хүсэлтүүд

Хэт өргөн цар хүрээний эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээ татгалзах, эсхүл гацаах зэргээс сэргийлэхийн тулд тухайн хүсэлт нь маш тодорхой байх шаардлагатай. Тухайлбал, тухайн хөрөнгийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн байршлын талаарх мэдээлэл нь тодорхой байх. Үнийн дүнд суурилсан хүсэлтээс бусад тохиолдолд ихэвчлэн тэдгээр хөрөнгө болон мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй гэмт хэргийн хооронд холбоо хамаарал байхыг шаарддаг.

Тухайн хүсэлтэд хөрөнгө байж болох банк болон санхүүгийн зуучлагч байгууллага, холбогдогчийн хамсаатнуудын нэрс (Эхнэр, нөхөр, хүүхэд, халхавч хуулийн этгээдүүд, итгэмжлэгдсэн этгээд, ойрын хамтран ажиллагч, хуульч болон бусад этгээд) байх. Эдгээр мэдээллийг гаргаж авахад хүндрэлтэй байж болох ч эрх зүйн туслалцааны хүсэлтэд зайлшгүй байх шаардлагатай.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[27] Энэ нь Щвейцарь, ИБУИНВУ болон бусад улс орнуудад хэрэгждэг. Щвейцарьт, гадаад улсын мөрдөгчид "нууцад хамаарах мэдээлэл"-д нэвтрэхийг хориглодог (Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх Холбооны хууль ["Эрх зүйн туслалцааны хууль," CC 351.1], 65[3] дугаар зүйл). "Нууцлал" гэж хуулиар хамгаалсан, тухайлбал банкны мэдээлэл болон худалдааны нууцлалд хамаарах мэдээлэл. "Нэвтрэх" гэж мэдээллийг хуулбарлах, тэмдэглэл хөтлөх, бичлэг хийх, эсхүл бусад хэлбэрээр шүүхэд хүлээн зөвшөөрөгдөх баримт олж авахыг хэлнэ. Түүнчлэн, эдгээр хязгаарлалтуудыг хамгаалах хүрээнд, гадаад улсын эрх бүхий байгууллагыг ердийн журмын дагуу тухайн нууцлалд хамаарах мэдээллийг задруулахгүй гэх гол нөхцөлтэйгээр ажиллагаанд оролцуулдаг.

ШИГТГЭЭ 9.4	Хэт өргөн хүрээний эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шийдвэр гаргуулахаас урьдчилан сэргийлэх

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхийг татгалзахаас сэргийлэх арга замууд

Эрх зүйн туслалцааны хүсэлттэй холбоотой хангалттай мэдээлэл цуглуулж болох хэд хэдэн саналыг танилцуулъя.

- Дотоодын мөрдөн шалгах ажиллагаа болон албан бус туслалцааны сувгийг ашиглах – Дотоодын Санхүүгийн тагнуулын албаар дамжуулан ЭГМОНТ группт хүсэлт тавьж, аль болох их мэдээлэл цуглуулах (3 дугаар бүлэг, 3.4.2 дахь хэсэгт дурдсан). Энэ төрлийн сувгуудын талаар 8 дугаар бүлэгт мөн тодорхой дурдсан байгаа.
- Банкны дансны дугаар болон салбарын байршлыг олж авах боломжгүй бол, хүсэлтийг хүлээн авч буй улсын эрх бүхий байгууллагаас дансны байршлыг тогтооход шаардлагатай бусад мэдээллээр хангаж өгөх. Тухайлбал, банкны утас болон факсын дугаар, дансны менежерийн нэр, эсхүл нэрийн хуудас, зорчсон байршлууд, зочид буудлын төлбөрийн баримтууд, зээлийн картын мэдээлэл, чекийн хуулбарууд болон банкны гүйлгээний мэдээлэл болон бусад мэдээллүүд.
- Бага хэмжээний баримт, мэдээллээр хангасан тохиолдолд ч цөөн тооны улс орнууд нь туслалцаа үзүүлэх боломжтой байдаг. Тухайлбал, харьцангуй жижиг улс орнууд болон төрөөс банкны дансыг бүртгэдэг улс орнууд (Бразил, Чил, Франц, Герман, Итали, Спайн гэх мэт). Тодорхой нөхцөлүүдэд, тухайн гэмт хэрэг болон хөрөнгө хоорондын холбоо хамаарлын хувьд, эдгээр улс орнуудад ч гэсэн адил шаардлага тавигддаг (Төвийн бүртгэлийн талаар илүү их мэдээллийг 8 дугаар бүлгийн 8.5.3 дахь хэсгээс харах).

Хүсэлтийг илгээж буй улс нь тухайн гэмт хэргийн болон нотлох баримтын шалгууруудын талаар илүү их мэдээлэлтэй байдаг тул холбогдох баримт, мэдээллийг олж тогтоох болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шаардлагуудыг (Тухайлбал, гэрчид анхааруулга уншиж танилцуулах гэх мэт) хангуулахад илүү тохиромжтой. Шууд оролцоход мөн эрх зүйн туслалцааны хүсэлтийн явц байдлын талаар мэдээлэл хүсэх шаардлагагүй болдог.

Оролцогч тал гэдэгт тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий шүүгч, эрх бүхий байгууллагын (яам эсхүл прокурор) төлөөлөл, хууль сахиулах байгууллагын алба хаагч (шинжээч болон техникийн ажилтан), аливаа холбогдогч, тэдгээрийн өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, тэдгээрийн өмгөөлөгч зэргийг хамруулж болно. Холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шаардлагыг хангаж эрх зүйн туслалцааны хүсэлтийг хууль, журмын дагуу явуулах: Хэдийгээр гадаад улсын салбарын мэргэжилтнүүд нь баримт, мэдээллийг хүлээн авсан боловч, эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авч баталгаажуулаагүй тохиолдолд тухайн баримт, мэдээллийг илгээдэггүй. Албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авахаас өмнө тухайн олж авсан мэдээллийг ашиглахгүй байх талаар амлалт авдаг.

Мөн, томоохон хэргүүдэд, салбарын мэргэжилтнүүд нь эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийн цар хүрээг нь багасгах арга хэмжээ авах хэрэгтэй. Ихэнх олон жил,

зарим тохиолдолд хэдэн арван жил зарцуулсан, хэд хэдэн банкны данс, данс эзэмшигч, бараа бүтээгдэхүүн, хуулийн этгээд болон халхавч компаниуд хамарсан авлигын хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд тухайн улсын банкны болон бусад баримт, мэдээллийг гаргуулах хүсэлт илгээвэл, хэдэн сар, жил зарцуулж, тэдгээр баримт, мэдээллийг цуглуулах боломжтой. Баримт, мэдээллийг хүлээн аваад салбарын мэргэжилтнүүд нь олон хайрцаг хамааралтай болон хамааралгүй баримт бичгүүдийг шалгах шаардлагатай болно. Түүнчлэн, эрх зүйн туслалцааг ач холбогдлоор нь ангилж, өргөн цар хүрээ хамарсан их хэмжээний баримт, мэдээлэл шаардлагатай хүсэлт илгээхээс зайлсхийх хэрэгтэй (тухайлбал, хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээдийн 10 жилийн хугацааны дансны материал гэх мэт). Эхний шатанд зөвхөн банкны тодорхойлолт, ач холбогдох бүхий гүйлгээний мэдээллийг авч, дараа нь эдгээр баримт, мэдээлэлд үндэслэн нэмэлт мэдээлэл хүсэх нь зүйтэй.

Ийнхүү цар хүрээг хумих нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх хугацааг хурдасгахаас гадна шаардлагагүй хүсэлт тавигдахаас зайлсхийх, ач холбогдолгүй баримт, мэдээллүүд дээр хүчин чармайлт гаргахаас сэргийлнэ. Тухайн хөрөнгийг өмчлөгчид нь эрх зүйн туслалцааны талаар зайлшгүй мэдэгдэх шаардлагатай улс орнуудад хөрөнгийн өмчлөгч хэт өргөн цар хүрээг хамарсан гэх үндэслэлээр тухайн хүсэлтийн талаар маргаан үүсгэхээс мөн сэргийлнэ.

Хөрөнгийг мөшгөх туслалцаа авахад хүсэлтэд шаардлагатай баримт бичгийг олж авах аргачлалын талаар Дөрөвдүгээр бүлэг, 4.2 дахь хэсгийг харна уу.

Түр зуурын арга хэмжээ

Хөрөнгийг олж тогтоосны дараа эрх бүхий албан тушаалтнууд нь хөрөнгийг хураах шийдвэр гарахаас өмнө алга болохоос нь сэргийлээд түр хураах, эсхүл шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авна. Салбарын мэргэжилтнүүд нь эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө хэрэв боломжтой тохиолдолд гадаад улсын эрх бүхий албан тушаалтнуудаар (Санхүүгийн тагнуулын алба, хууль сахиулах албан тушаалтнууд болон бусад дотоодын байгууллагаар дамжуулан) захиргааны болон хойшлуулшгүй тохиолдолд авах урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авхуулах талаар бодолцон үзэх хэрэгтэй (Наймдугаар бүлгийн 8.5.4 дэх хэсэгт дурдсан албан бус туслалцааны арга хэлбэр).[28] Эцэст нь, урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авахуулахаар эрх зүйн туслалцааны хүсэлт илгээж тухайн арга хэмжээг үргэлжлүүлнэ (түр хураах, эсхүл захиран зарцуулах эрхийг хязгаарлах). Дараах урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээнүүдэд эрх зүйн туслалцааны хүсэлт шаардлагатай. Үүнд:

- *Түр зуурын арга хэмжээ авах тухай шүүхийн албан тушаалтны (Investigating magistrate) шийдвэр.* Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад, шүүхийн албан тушаалтнууд нь шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагаа явуулж,

[28] Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн 54 дүгээр зүйлийн (2)-т, хүсэлт гаргагч оролцогч улсын шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураах шийдвэрийн дагуу өөрийн эрх бүхий байгууллагад эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураахыг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авах тухай зохицуулсан.

хөрөнгө хураах шийдвэр гарах, эсхүл тухайн хөрөнгө нь алга болох магадлалтай гэж үзвэл албан ёсны шийдвэрүүд гаргах боломжтой байдаг.[29]

- *Ял сонсгох, эсхүл баривчлах үед авах түр арга хэмжээ (Instigation of charges or arrest).* Зарим улсад баривчилгааны дараа хөрөнгө хураахад чиглэсэн захиран зарцуулах эрхийг хязгаарлах, түр хураах түр зуурын шийдвэр гаргах боломжтой байдаг.[30] Хүсэлт илгээж буй улсаас баривчилгааны талаарх баримт болон хэргийн тогтоогдсон нөхцөл байдлын талаар товч мэдээллээр хангах шаардлагатай. Хөрөнгийг нэмэлт мэдээлэл иртэл царцаах арга хэмжээ авах бөгөөд хүсэлт илгээж царцаах арга хэмжээний хугацааг сунгах боломжтой. Ерөнхийдөө, олон улсын гэрээ байх шаардлагагүй бөгөөд энэхүү арга хэмжээг хөрөнгийн өмчлөгчид мэдэгдэлгүйгээр авдаг (ex parte).
- *Прокурорт шууд илгээх (Direct referral to prosecutors).* Зарим улсад, дотоодын хэрэгт хамтын ажиллагааг хэрэгжүүлэхтэй адилаар хөрөнгийн захиран зарцуулах эрхийг хязгаарлах, хураах хүсэлтийг прокурорт шууд гаргаж арга хэмжээ авахуулдаг.[31] Гэмт хэргийн талаарх болон гэмт хэргийн улмаас олж авсан хөрөнгө, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн арга хэрэгслийн талаарх нотлох баримт шаардлагатай байх болно.

Зарим улсад урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авахад эрх зүйн туслалцааны хүсэлт шаардагддаг ба хойшлуулшгүй тохиолдолд, хөрөнгийн өмчлөгчид мэдэгдэлгүйгээр хэлэлцүүлэг зохион байгуулдаг.[32] Бусад улсад хүсэлт илгээж буй улсад баривчилгаа хийсэн, эсхүл яллагчдаар татагдсан зэрэг хатуу шалгуур тавьдаг. Энэ тохиолдолд, салбарын мэргэжилтнүүд нь бусад арга замыг сонгох хэрэгтэй – хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон албан бус сувгаар гадаад улсын эрх бүхий байгууллагыг хангалттай баримт, мэдээллээр хангаж дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авах боломжоор хангаж өгөх. Энэхүү арга зам нь тухайн гэмт хэргийн зарим хэсэг нь гадаад улсын эрх бүхий байгууллагын харьяалалд нь багтаж байгаа тохиолдолд л боломжтой (мөнгө угаах).

Улс орнуудын хэрэглэж буй өөр хоорондоо адилгүй арга барилууд нь талуудын хооронд эхэн үеийн нягт хамтын ажиллагааны ач холбогдлыг илтгэнэ. Улс орнуудаас хамааралд, урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээний талаарх эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд хүсэлт хүлээн авч буй улсад хүсэлт илгээж буй улсын шийдвэрийг шууд хэрэгжүүлнэ гэсэн үг бөгөөд нотлох баримтууд нь

[29] Щвейцарьт 2011 оноос хойш мөрдөн шалгах магистрат болон прокуроруудын чиг үүргийг нэгтгэсэн бөгөөд прокуроруд нь шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах ажиллагаануудыг явуулж түр хураан авах зөвшөөрөл олгодог болсон. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах төв байгууллага—Холбооны Хууль зүйн газар—Эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг хариуцдаг бөгөөд мужийн болон холбооны яамуудад илгээдэг.

[30] АНУ-д 18 U.S.C. 984(b)(4)-д заасан үндэслэлээр баривчлахаас өмнө 30 хүртэл хоногийн хугацаанд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр гаргаж болдог.

[31] Тухайлбал, ИБУИНВУ-ын 2002 оны Гэмт хэргийн процессийн хууль (Гадаад улсаас ирүүлсэн хүсэлтүүд болон шийдвэрүүд), 2005 оны шийдвэр, 6 дахь хэсэг, https://www.legislation.gov.uk/uksi/2005/3181/contents/made.

[32] БНХАУ-ын ЗЗОБ Хонконгт хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн хэлэлцүүлэг явуулдаг.

дотоодын хөрөнгийн захиран зарцуулах эрхийг хязгаарлах, эсхүл түр хураах шийдвэр гаргахад шаардлагатай.[33]

Шийдвэрийг шууд бусаар гүйцэтгэх (хүсэлт хүлээн авч буй улс нь хөрөнгө хураах ажиллагааг "дотоодын болгож" (Domesticate) шүүхэд өөрсдөө хэрэг үүсгэнэ) нь ерөнхийдөө хүсэлт илгээж буй улс нь хүсэлт хүлээн авч буй улсад салбарын мэргэжилтнүүд нь дотооддоо тухайн хэргийг нотлоход шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгнө. Нотолгооны үүрэг болон шаардлагатай нотлох баримтын талаар хүсэлт хүлээн авч буй улсын дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд энэ нь хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэхэд ч адил хамааралтай. Хүсэлт хүлээн авч буй улсад эрүүгийн хариуцлага оногдуулахгүйгээр хөрөнгө хураах (NCB) –д нотлох баримтын шалгуур харьцангуй бага байвал энэхүү арга нь ач тусаа өгнө.

Шийдвэрийг шууд гүйцэтгэх. Гадаад улсын хөрөнгийн захиран зарцуулах эрхийг хязгаарлах, түр хураах шийдвэрийг шууд гүйцэтгэхэд хүсэлт хүлээн авч буй улс нь гадаад улсын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, эсхүл бүртгэж дотоодын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэхтэй нэгэн адил зарчмаар хэрэгжүүлнэ. Хүсэлт илгээж буй улс нь хөрөнгийн захиран зарцуулах болон түр хураах шийдвэр, хөрөнгө хураах шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангана (нийтийн эрх зүйн улс орнуудад баталгаа (affidavit) болон гэрчилгээний хэлбэртэй байна). Зарим улсад шийдвэрийн факсаар ирүүлсэн хувийг бүртгэж авдаг; Харин шийдвэрийн албан ёсны хуулбар нь тухайн хөрөнгийн захиран зарцуулах болон түр хураах шийдвэр, хөрөнгө хураах шийдвэрийг үргэлжлүүлэн авахад хэрэг болдог. Хүсэлт илгээж буй улс нь үүний дараа гадаад улсын шүүхийн шийдвэрийг өөрийн шүүхэд бүртгэх боломжтой болно.

Шийдвэрийг шууд гүйцэтгэх процесс нь шууд бусаар гүйцэтгэх процесстой харьцуулахад хэд дахин хүчин чармайлт гаргахгүй, шийдвэр гаргуулахын тулд дахин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй зэргээр хурдан бөгөөд хялбар байдаг. Харин, энэ нь бүхий л хэрэгт биелэгдэх боломж байдаггүй. Хууль тогтоомж болон олон улсын гэрээнд шууд хэрэгжүүлэхэд үндэслэл болгох зохицуулалт байхгүй байх боломжтой, эсхүл хүсэлт хүлээн авч буй улс нь тухайн шийдвэрийг гаргасан процесс нь дотоодын хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн эсэхэд анхаарал хандуулдаг.[34]

Ийм эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүчинтэйд тооцуулахад шаардлагатай түгээмэл нөхцөл байдлуудын талаарх дараах жишээнүүдийг авч үзье. Үүнд:

- Эрх зүйн туслалцааны ерөнхий шалгууруудыг хангасан бөгөөд татгалзах үндэслэл байхгүй.
- Тухайн хайж буй хөрөнгө нь гэмт хэрэгтэй холбоотой, эсхүл холбогдогч нь гэмт хэрэг үйлдэх замаар ашиг олсон гэх үндэслэл байгаа.
- Тухайн хөрөнгө нь хураагдана гэх үндэслэл байгаа.
- Царцаах хөрөнгийн байршлын талаарх мэдээллээр хангасан.

---

[33] Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн 54 дүгээр зүйлийн (2)(a), (b), 55 дугаар зүйлийн (2), Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн 5 дугаар зүйл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 13 дугаар зүйл, Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенцийн 8 дугаар зүйлийг тус тус харах.

[34] Авлигын эсрэг НҮб-ын Конвенцийн чухал давуу тал нь гишүүн улс орнуудыг хөрөнгө хураах, царцаах, битүүмжлэх хууль зүйн үндэслэл болгох боломж олгодог (Авлигын эсрэг конвенцийн 55 дугаар зүйлийн (6)).

- Хүсэлт хүлээн авч буй улсад тухайн арга хэмжээг авсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчигдсөн эрхийг сэргээх боломжоор хангах (эсхүл тухайн хураахыг хүсэлт болгосон хөрөнгө нь хүсэлт хүлээн авч буй улсад мөн хураах шаардлагатай хөрөнгө).[35]
- Холбогдох шүүхийн шийдвэрүүдийн хуулбаруудыг (шаардлагатай тохиолдолд баталгаажуулсан) хавсаргасан бөгөөд хүсэлт хүлээн авч буй улсад гүйцэтгэх боломжтой байх.

Мөрдөн шалгах ажиллагааны шийдвэрүүдтэй адилаар, урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээг эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад прокурор болон шүүхийн эрх бүхий ажилтнуудын шийдвэрээр авагдах боломжтой; Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад үндсэндээ шүүхийн шийдвэр шаардлагатай. Өмнө дурдсанчлан, энэхүү улс орнуудын өөр хоорондоо адилгүй байдал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн хэлбэр, шалгуур, гүйцэтгэх хугацаанд нөлөөлдөг. Салбарын мэргэжилтнүүд нь дараах нэмэлт ойлголтуудыг харгалзан үзэх шаардлагатай.

Хөрөнгийн өмчлөгчид мэдэгдэх. Ихэнх улс орнуудад урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээг өмчлөгчид нь мэдэгдэлгүйгээр гүйцэтгэдэг бол бусад улс орнуудад шууд өмчлөгч болон хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдэд хууль тогтоомжийн дагуу заавал мэдэгддэг байна. Гадаад улсад мэдэгдэх хуудас нь заавал орчуулагдаж бичгээр гаргах шаардлагатай – салбарын мэргэжилтнүүдийн хувьд үүсэж болох нэмэлт зардал. Зарим улс орнуудад цахим орчинд мэдэгдэх зарыг байршуулдаг, зардал хэмнэсэн арга хэлбэр. Зарим улс орнууд гадаад улсын эрх бүхий байгууллагыг өөрсдийн улсад мэдэгдэх хуудас болон зарлал гаргуулдаггүй, мэдэгдэх хуудас өгөх эрх зүйн туслалцааны хүсэлт нь зөвхөн эрх бүхий төв байгууллагаар дамжуулан ирүүлэх боломжтой байдаг. Зарим улсад мөн эрх зүйн туслалцааны хүсэлт, шийдвэр, бусад хүсэлтийг хөрөнгийн өмчлөгчид заавал мэдэгддэг (8 дугаар бүлэг, Шигтгээ 8.5, эрх зүйн туслалцааны хүсэлтэд саад болох буюу нууцлал задруулах зарчим).

Хөрөнгө тарах нэмэлт эрсдэл. Зарим улсад тухайн царцаасан хөрөнгийн хууль ёсны бусад зардлуудыг төлүүлэх боломжтой байдаг (хадгалах, түрээс, барьцаалсан зээл). Энэ нь удах тусам тухайн хөрөнгийг хураан авах бололцоог бууруулж байдаг.

Хүсэлт хүлээн авч буй улсад эдгээр төлбөрийг төлөхийг шаарддаг байх магадлалтай бөгөөд хүсэлт илгээж буй улсын дотоодын хууль тогтоомжоор ийм төрлийн төлбөрийг төлөх талаар зохицуулалт байхгүй ч нэгэн адил төлөхийг шаардах болно.[36]

Хөрөнгө хураах загваруудын онцлогууд. Хамтран ажиллаж байгаа улс орнууд өөр загварын хөрөнгө хураах зохицуулалттай тохиолдолд салбарын мэргэжилтнүүд нь нотлох баримтын шалгуур болон нотолгооны стандартыг анхаарах шаардлагатай. Тухайлбал, нэг улсаас холбогдогч гэмт хэргийн улмаас санхүүгийн ашиг олсныг

[35] Улс орнуудын хууль тогтоомжоор зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээх зохицуулалтууд нь өөр хоорондоо адилгүй тул энэхүү нөхцлийг хангахад амаргүй байдаг. Зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой асуудал нь ихэвчлэн хязгаарлах, битүүмжлэх, хураах, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан үнэ бүхий эд зүйлийг шууд хураан авсан тохиолдолд үүсдэг. Түүнчлэн, торгох, хөрөнгийг орлуулах, нэмэлтээр хураах зэрэгт мөн зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой асуудал үүсэх боломжтой.

[36] Зарим улс орнуудад, хүсэлт хүлээн авагч улс нь хүсэлт гаргагч улсын хүсэлтийг "гүйцэтгэх" – тэй холбогдуулан тодорхой маргаан үүсдэг. Энэ тохиолдолд хүсэлт гаргагч улсын дотоодын хууль тогтоомжийг хэрэглэдэг.

нотолж, үнэд суурилсан хөрөнгө хураах хүсэлт гаргах; Өөр улсаас тухайн гэмт хэрэг болон хөрөнгө хоорондын холбоо хамаарлыг нотолж, өмч хөрөнгөд суурилсан хөрөнгө хураах хүсэлт гаргах. Түүнчлэн, зарим улсад урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээг өргөн хүрээнд авах боломжтой байдаг (Шигтгээ 9.5-ыг харах).

ШИГТГЭЭ 9.5 ИБУИНВУ-ын улс харгалзахгүйгээр урьдчилан сэргийлэх түр арга хэмжээ авах талаарх шийдвэр

Европын холбооны гишүүн бус улсын улс төрд нөлөө бүхий этгээдийн (PEPs) ИБУИНВУ-д байрлах хөрөнгөтэй холбоотой хэрэгт, хил харгалзахгүйгээр царцаах, мэдээллийг ил болгох шийдвэр гаргуулах асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй (10 дугаар бүлэг, 10.3.2-ыг харах).[a] Ийм шийдвэр нь гадаад улсаас буцаан авах тодорхой хөрөнгө, эсхүл (банкны мэдээлэл зэрэг) баримт мэдээллийг ил болгохыг шаарддаг бөгөөд ингэснээр тэдгээр нь тухайн нэг улсын харьяалалд багтах бүлэг хөрөнгө болж өгөх юм.

Зарим тохиолдолд түр арга хэмжээ авах, эсхүл хөрөнгийг битүүмжлэх шатанд хүлээн авагч тал нь тухайлбал, прокурорын эрх мэдлээр дамжуулан тодорхой хүнийг томилж, царцаасан хөрөнгийг буцаан авах ажлыг хариуцуулан ажилладаг.

Эдгээр шийдвэрүүд нь хязгаарлагдмал байдаг, учир нь хэргийн холбогдогч, шийдвэрт тусгагдсан бусад этгээдийн хамтын ажиллагаанд илүү тулгуурладаг. Түүнчлэн, тэдгээр шийдвэрийг үл хүндэтгэх, эсхүл биелүүлээгүй тохиолдолд нэмэлтээр торгох, төлбөр төлөх магадлалтай байдаг.

а.Энэтхэг Улсад царцаах шийдвэр гаргуулах хүсэлтэд, Лондоны Дээд шүүхээс хөрөнгийн тарах эрсдэл, хүчин зүйлийн талаар тайлбарласан. Эдгээр хүчин зүйлүүд нь хөрөнгийн шинж чанар, холбогдогчийн бизнесийн төрөл болон байр суурь, холбогдогч нь хэр удаан тухайн бизнесийг эрхэлсэн, холбогдогчийн оршин суугаа хаяг, холбогдогчийн бизнес эрхэлж буй улсад шийдвэрийг гүйцэтгэх механизм, холбогдогчийн зээлийн түүх, холбогдогчийн тухайн хөрөнгийг хэрхэх талаарх төлөвлөгөө, арбитрын шийдвэрээр дампуурсан холбогдогчийн хуулийн этгээд, холбогдогчийн тухайн шийдвэрийн талаарх байр суурь. Энэтхэгийн Төрийн банк, Орс. ба Малия болон Орс (2018) –ыг харах. (State bank of India & Ors. V. Mallya ^ Ors, [2018] EWHC (Comm) 1084 at para. 105.)

Хөрөнгө хураах

Эцэст нь, салбарын мэргэжилтнүүд нь эрх зүйн туслалцааны хүсэлт илгээж хөрөнгө хураахыг хүсэх шаардлагатай. Салбарын мэргэжилтнүүд тухайн хөрөнгө байрлаж буй улс орны хууль тогтоомжийг судалж, хөрөнгө хураах шийдвэрийг шууд гүйцэтгэх, эсхүл шууд бусаар гүйцэтгэх боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 55 дугаар зүйлийн 1-ийн б-д хүсэлт хүлээн авч буй улс нь “.....эд хөрөнгө хураах тухай шийдвэрийг хүсэлтэд дурдсан хэмжээнд хэрэгжүүлэх үүднээс хүсэлт хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэлтэй холбоотой хэмжээнд өөрийн эрх бүхий байгууллагад өгнө” гэж заасан.

Энэхүү шаардлага нь гадаад улсын хөрөнгө хураах шийдвэрийг “шууд гүйцэтгэх” тухай ойлголт юм. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 54 дүгээр зүйлийн 1-ийн а-д оролцогч талууд “оролцогч өөр улсын шүүхээс эд хөрөнгийг хураах талаар гаргасан шийдвэрийг биелүүлэхийг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авч” гэж заасан бөгөөд 55 дугаар зүйлийн 1-ийн Б-г гүйцэтгэх боломжийг олгосон. Шигтгээ 9.6-д ИБУИНВУ, АНУ-д хөрөнгө хураах шийдвэрийг шууд гүйцэтгэхэд шаардагдах зүйлсийн талаар дурдсан.

ШИГТГЭЭ 9.6	ИБУИНВУ, АНУ-д хөрөнгө хураахтай холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг шууд гүйцэтгэхэд тавигдах шаардлага

АНУ-д илгээх хүсэлтийн хувьд

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг АНУ-д гүйцэтгүүлэх эрх зүйн туслалцаа хүсэхэд зайлшгүй гэрээ, хэлэлцээр болон хэргийн товч мэдээлэл шаардлагатай. Хөрөнгө хураах ажиллагааны процессын талаарх товч мэдээлэл, баталгаажуулсан хөрөнгө хураах шийдвэр, түүнийг мэдэгдсэн талаарх баталгаа, тухайн шийдвэр нь эцсийнх бөгөөд давж заалдах хугацаа өнгөрсөн талаарх баталгаа зэрэг шаардлагатай.

АНУ-ын эрх бүхий байгууллагаас хэрэг нээж, шийдвэрийг дотоодын шийдвэрийн адилаар гүйцэтгүүлнэ. АНУ-ын дүүргийн шүүхээс гадаад улсын шүүхийн шийдвэр нь дотоодын процессын шаардлагад нийцээгүй, залилангийн аргаар олж авсан, гадаад улсын шүүхэд субъектийн талаар тодорхой тусгагдаагүй, харьяалалд нь хамааралгүй зэрэг асуудал байхгүй гэж үзвэл түүний өмнөөс шийдвэр гаргана.

ИБУИНВУ-д илгээх хүсэлтийн хувьд

ИБУИНВУ-д Англи, Вэйлс-д байрлах хөрөнгийн хувьд хөрөнгө хураах шийдвэр бүхий эрх зүйн туслалцааны хүсэлтийг ИБУИНВУ-ын эрх бүхий байгууллагад илгээх шаардлагатай (Нийтийн прокурорын газрын Ноцтой залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, эсхүл Хөрөнгө, орлого, гаалийн прокурорын газарт). Титэм шүүх нь гадаадын шийдвэрийг бүртгэх, хүчинтэйд тооцох эсэхийг шийднэ. Ингэхдээ хэрэгт холбогдсон хүний талаарх зөвхөн эцсийн шийдвэрийг бүртгэх бөгөөд 1998 оны Хүний эрхийн хуульд нийцсэн эсэхийг хянана. Тухайн шийдвэрт нь Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй.

Шотланд, Хойд Ирланд, хамаарал бүхий газруудад (Guernsey, Jersey, Isle of Man) өөр эрх бүхий байгууллагууд болон дүрэм, журам үйлчилдэг.Түүнчлэн, Англи улс нь ЕХ-ноос гарах хүртэл ЕХ-ны гишүүн улс орнуудын хүсэлттэй холбогдуулан тусгайлсан журам үйлчилдэг байсан.

Салбарын мэргэжилтнүүд нь Английн албан ёсны цахим хуудсанд байрлах эрх зүйн туслалцаа хүсэх заавар (2013.03.26-ны өдрийн сүүлд 2020.06.17-нд шинэчилсэн)-ыг харах боломжтой. https://www.gov.uk/guidance/mutual-legal-assistance-mla-requests.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод заасан өөр нэг арга хэлбэр нь конвенцийн 54 дүгээр зүйлийн 1-ийн Б, 55 дугаар зүйлийн 1-ийн А-д үндэслэсэн “шууд бусаар гүйцэтгэх” арга буюу хүсэлт хүлээн авч буй улс нь дотоодын хөрөнгө хураах шийдвэр гаргуулж, гадаад улсын хүсэлтийг гүйцэтгэх явдал юм. Практикт, хүсэлт илгээж буй улсаас ирүүлсэн нотлох баримтууд дотоодын хөрөнгө хураах шийдвэр гаргуулахад дэмжлэг болдог. Иймд, хүсэлт илгээж буй улс нь хүсэлт хүлээн авч буй улсын дотоодын нотолгооны стандартыг хангахуйц хэмжээнд нотлох баримтууд гаргаж өгөх шаардлагатай болдог.

Хөрөнгө хураах шийдвэр[37] гаргуулахад шаардлагатай нөхцөл байдлын талаар дурдвал:

- Өмнө дурдсан урьдчилан сэргийлэх түр зуурын арга хэмжээ авахад шаардлагатай нөхцөл байдлууд.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байхад хөрөнгө сарнихаас сэргийлж, царцаах арга хэмжээ авах.
- Давж заалдах боломжгүй эцсийн байдлаар хөрөнгө хураах шийдвэр гаргуулах.
- Бүхий л хариуцагч нарт мэдэгдэж, хуульд заасан бэлтгэл хангах боломж олгосон байх.

Зарим улсад нэмэлт мэдээлэл шаардлагатай болдог, тухайлбал хүсэлт илгээж буй улсад тухайн төлбөрийг төлж барагдуулаагүй талаар болон тухайн этгээд нь тодорхой гэмт хэрэг үйлдсэн талаарх мэдээлэл. Удаах шаардлага нь холбогдогч нас барснаас, өөр улс руу оргон зайлснаас, болон халдашгүй байдлаас болон эрүүгийн хариуцлага оногдуулаагүй бол биелэгдэх боломжгүй. Ихэнх улсад тухайн этгээдийг байхгүйд нь, эсхүл оргон зайлсан тохиолдолд ял оногдуулах боломжгүй байдаг боловч хөрөнгө хураах талаар эрүүгийн хуулийн заалтыг хэрэглэх замаар, эсхүл шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах боломжтой байдаг.

9.2.7 Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх, явц байдлын талаар мэдээлэл авах, татгалзах тохиолдлууд

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг эцэст нь хүсэлт илгээж буй улсын холбогдох эрх бүхий байгууллагаас гарын үсэг зурж, гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллагаар дамжуулан илгээдэг. Зарим хоёр талт болон олон талт олон улсын гэрээнд хүсэлтийг шууд хууль сахиулах байгууллагад илгээж, хувийг төв байгууллагад нь илгээхийг зөвшөөрдөг (ЕХ-ны конвенц). Бусад улс оронд уламжлалт аргаар буюу дипломат шугамаар илгээдэг. Зураг 9.1 хүсэлтийн талаар.

[37] Гадаад улсын холбогдох шийдвэрийг хүлээн зөвшөөрөх асуудлыг зохицуулсан хууль нь ихэвчлэн хүсэлт хүлээн авагч улсын шүүхэд маргаан үүсгэхийг хориглосон байдаг. Зарим тохиолдолд хуульд шууд ийм төрлийн хязгаарлалтыг зохицуулаагүй боловч практикийн ажилтнууд нь хүсэлт гаргагч улсын шүүхэд эрхийг нь хөндөж буй этгээдэд шүүх хуралдаанд оролцох боломжоор нь бүрэн хангаж, аль хэдийнээ шийдвэрлэсэн маргааныг дахин хүсэлт хүлээн авагч улсын шүүхэд шийдвэрлэхийг эсэргүүцдэг.

ЗУРАГ 9.1 Гэрээ, эсхүл дотоодын хууль тогтоомж байгаа нөхцөлд эрх зүйн туслалцааны хүсэлтийн урсгал

Зарим гэрээнд салбарын мэргэжилтнүүд хооронд шууд харилцахыг зөвшөөрдөг

Эх сурвалж: Дэлхийн банк
Тэмдэглэл: Хэрэв хүсэлт бүхий шүүхийн захидал шаардлагатай бол энэ талаар талуудын гадаад харилцааны асуудал эрхэлсэн яамд нь процесстоо тусгаж өгөх хэрэгтэй. ЭЗХТХ=эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт
а.Салбарын мэргэжилтнүүд гэдэгт прокуророууд, мөрдөх эрх бүхий магистратууд болон хууль сахиулах байгууллагын ажилтнууд багтана.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээсний дараа салбарын мэргэжилтнүүд нь хүсэлтийн явц байдлын талаар мэдээлэл авна. Боломжтой тохиолдолд хүсэлтийг гүйцэтгүүлэхээр хуваарилсан этгээдтэй шууд харилцана. Энэ нь орчуулгын болон нэр томьёоны асуудлаар тодруулга хийхэд ач холбогдолтой бөгөөд шалгууруудад нийцсэн эсэхийг тодруулж, нэмэлт мэдээллээр хангаж болно. Хүсэлт илгээж буй улсаас хүсэлт гүйцэтгэхтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл хүсэж болно. Ийм хүсэлт нь түүнийг гүйцэтгэхээс татгалзсаныг илэрхийлэхгүй бөгөөд хэт ерөнхий, төөрөгдөл үүсгэхүйц хүсэлт нь нэг болон хэд хэдэн нэмэлт мэдээлэл хүсэх үндэслэл болдог. Тухайн мэдээллүүдийг тодруулж, цаашид хугацаа алдахаас сэргийлэн шаардлагатай тохиолдолд шууд холбоо барих мэдээллийг дурдах нь зүйтэй.

Хариу өгөхгүй, эсхүл татгалзах үндэслэлийг тусгаж хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд өөр арга замыг олох шаардлагатай. Гуравдагч улс, олон улсын байгууллагад хүсэлт тавьж шахалт үзүүлэх нь заримдаа тус болдог, ялангуяа хэд хэдэн улс дамнасан гэмт хэрэгт НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар болон Дэлхийн банкны хамтарсан СтАР санаачилга улс хоорондын хөрөнгө буцаахад чиглэсэн хамтын ажиллагааг дэмжиж, тодорхой хэргүүдэд яриа хэлэлцээний платформоор хангаж өгдөг.[38]

Хүсэлт хүлээн авч буй улс нь өөр бусад хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзсан улстай харилцах нь хүсэлт илгээж буй улсаас илүү их үр дүнд хүрэх магадлалтай. Ялангуяа, харилцаа сайтай улс орнуудын хооронд туслалцаа үзүүлэх нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, Х улс хоёр том санхүүгийн төв улсаас туслалцаа хүссэн: У болон З нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн гишүүн улсууд. У улс туслах санал

[38] Илүү дэлгэрэнгүй мэдээллийг СТАР-ын “Бидний тухай: Чиг үүрэг” https://star.worldbank.org/about-us/our-work линкээс харах.

тавьсан, З улс нь татгалзсан. У улс нь З улстай бусад хэргүүд дээр амжилттай ажилласан туршлагатай бөгөөд З улсад хандаж Х улсад туслалцаа үзүүлж байгаа бөгөөд түүний хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзсан үндэслэл нь Авлигын эсрэг конвенцыг зөрчиж байгаа тухай мэдэгдэв. З улс нь туслалцаа үзүүлэх асуудлыг талаар дахин хөндөв.

Өөр нэг хэлбэр нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг боловсруулах, уламжлах, явц байдлын талаар тодруулахад хүсэлт хүлээн авч буй улсын дотоодын өмгөөлөгчийг хөлслөх юм. Энэхүү арга хэлбэрийн давуу тал нь тухайн өмгөөлөгч нь хүсэлт хүлээн авагч улсад байрладаг, сүлжээтэй бөгөөд хэлийг нь мэддэгт байдаг. Харин сул тал нь зардлын асуудал юм.

9.3 Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахад хамтран ажиллах

Олон талт гэрээ, олон улсын стандартад[39] нийцүүлэн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах ажиллагааг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалттай орнуудын тоо нэмэгдэж байгаа хэдий боловч тийнхүү хөрөнгө хураах чиглэлээрх олон улсын хамтын ажиллагаа нь хэд хэдэн шалтгааны улмаас хүндрэлтэй хэвээр байна.

Нэгдүгээрт, хэдийгээр шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах ажиллагаа нь хөгжиж буй хууль зүйн ойлголт боловч, энэ нь дэлхийн хэмжээнд тархаагүй байна. Өөрөөр хэлбэл, бүх улс оронд шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахыг болон гадаад улсын энэ талаарх шийдвэрийг гүйцэтгэхийг зөвшөөрсөн хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Хоёрдугаарт, дээрх тогтолцоо байсан ч гэлээ, өөр хоорондоо адилгүй байдаг. Зарим улс орнуудад шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах ажиллагааг тусад нь иргэний хэргийн шүүхэд шийдвэрлүүлдэг (“иргэний журмаар хөрөнгө хураах”) бөгөөд энэ нь эрүүгийн хэрэгтэй харьцуулахад харьцангуй нотолгооны стандарт бага байдаг (“магадлалын баланс”, эсхүл “аль нэг талын нотлох баримтын давамгайлал”). Бусад улсад дээрх хөрөнгө хураах ажиллагааг эрүүгийн хэргийн шүүхэд буюу илүү өндөр нотолгоо шаардлагатай нөхцөлд шийдвэрлүүлдэг. Зарим улс орнуудад эрүүгийн хэрэгт яллах ажиллагаа нь бүтэлгүйтсэн тохиолдолд дээрх хөрөнгө хураах ажиллагааг явуулдаг, харин бусад нь эрүүгийн хэрэгтэй зэрэгцүүлэн хөрөнгө хураах ажиллагаа явуулдаг.[40]

Эдгээр бэрхшээлүүдийг давсан сайн туршлагууд байдаг. Зарим улсад хоёр талт гэрээ, хэлэлцээрт шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах зохицуулалтууд оруулж өгсөн байдаг. Бусад улс орнууд хэргийн талаарх мэдээллийг гадаад улсад өгч, гадаад улсын эрх бүхий байгууллагаас өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн

[39] НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 54 дүгээр зүйлийн С-д улс орнууд хоорондоо тухайн этгээд нас барсан, сураггүй алга болсон болон бусад хэргүүд дээр хамтран ажиллах талаар дурдсан байдаг. ФАТФ-ын Зөвлөмж 4-т (“Хураан авах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ”) улс орнууд шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авахыг шаардсан байдаг (FATF 2019). ФАТФ нь мөн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авсан шилдэг туршлагуудыг хуваалцсан, тухайлбал гадаад улсын шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах шийдвэрийг хүлээн зөвшөөрөх гэх мэт. Үүнийг ФАТФ-ын 2012 оны 10 дугаар сард хийсэн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн (FATF 2012).

[40] ИБУИНВУ нь шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах ажиллагааг зөвхөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоосон, эсхүл бүтэлгүйтсэн тохиолдолд хүлээн зөвшөөрдөг. АНУ нь шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах ажиллагааг ихэвчлэн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай зэрэгцээ хэрэгжүүлдэг.

дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг. Эцэст нь, зарим улсад гадаад улсын шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах шийдвэрийг тогтолцооны зөрүүтэй ч гэсэн гүйцэтгэдэг,[41] эсхүл гадаад улсад эрүүгийн хариуцлага оногдуулахгүйгээр хөрөнгө хураах тогтолцоо байхгүй ч гэсэн гүйцэтгэх боломжтой байдаг.[42]

Бүс нутгийн хэмжээнд, Европын холбооны журмууд нь гишүүн улс орнуудын хооронд царцаах болон хураах шийдвэрийг баталгаажуулж, гүйцэтгэх талаар зохицуулсан байдаг.[43] Ингэхдээ, дээд тал нь 45 хоногийн дотор хөрөнгө хураах шийдвэрийг гүйцэтгэхээр заасан байдаг. Зарим яаралтай тохиолдолд царцаах шийдвэр гаргах 48 цагийн хугацаа олгогдох бөгөөд гүйцэтгэхэд мөн 48 цагийн хугацаа олгодог. Мөн түүнчлэн, европын улс орнууд дотоодын хууль тогтоомжид зохицуулалт байхгүй ч гэсэн гишүүн улс орнуудын шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах шийдвэрийг энгийн хөрөнгө хураах шийдвэрийн адил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Хүсэлт илгээж буй улсад дээрх хөрөнгө хураах талаар хууль тогтоомжийн зохицуулалт байхгүй ч гэсэн бусад дотооддоо дээрх зохицуулалттай улс оронд

---

[41] АНУ-аас Швейцар Улсад илгээсэн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах хүсэлтэд (Эрүүгийн хэргийн шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хориглосон шийдвэр гарсан), Швейцар Улсын Дээд шүүхээс хөрөнгө хураах шийдвэрийг хэргийн онцлогт тохируулан шийдвэрлэх нь зүйтэй, тухайлбал гадаад улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаагүй байгаа тохиолдолд гүйцэтгэж болох талаар дурдаж хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн. А компанийн эсрэг Холбооны хууль зүйн газар гэх хэргээс харах (1A.32612005, ATF 132 II 178). Тухайн улс нь эрүүгийн хариуцлага оногдуулах харьяалал бүхий байх ба зайлшгүй эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан байх шаардлагагүй. Энэхүү шалгуур нь АНУ-д биелэгдэх боломжтой боловч (шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай зэрэгцээ, эсхүл хэргийг эцэслэн шийдвэрлэхээс өмнө хийдэг), бусад улс оронд тухайн хэрэг нь бүтэлгүйтсэн, эсхүл шийдэгдэх боломжгүй тохиолдолд шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авдаг.

[42] Хонконгийн ЗЗОБ, БНХАУ болон Жерсид гадаад улсаас ирүүлсэн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах шийдвэрийг хүлээн зөвшөөрөх хуулийн зохицуулалттай бөгөөд дотооддоо шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах зохицуулалтыг сүүлд баталсан. Жерси дэх эрх зүйн зохицуулалт (Хөрөнгийг буцаан авах [Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа] 2018); Хонконгийн ЗЗОБ, БНХАУ (Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх журам [“ЭЗТ журам”], Хонконгийн хууль тогтоомжийн 525 дугаар бүлэг); (БНХАУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйл) шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авахыг зөвшөөрдөг, бөгөөд БНХАУ-ын хувьд хэт хязгаарлагдмал нөхцөл байдлыг дурдсан байдаг. Зарим Латин Америкийн улс орнууд нь шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгийг хураан авах шийдвэрийг хүлээн аваад иргэний хэргийн шүүхэд хэрэг үүсгэх замаар гүйцэтгэдэг. Франц Улсад энэ талаар эрх зүйн зохицуулалт байхгүй боловч Итали Улсаас илгээсэн шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах шийдвэрийг Европын Холбооны 1990 оны Гэмт хэрэг үйлдэж мөнгө угаасан хэргийн эсрэг нэгжлэг хийх, царцаах, хураан авах конвенц (Convention on laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds of Crime) –д үндэслэн гүйцэтгэсэн. [Кассатионы Шүүхийн, 2003 оны 11 сарын 13-ны өдрийн 03-80371 дугаартай шийдвэр]). Шүүхээс хоёр үндэслэлээр дээрх шийдвэрийг гүйцэтгэсэн байдаг. Нэгдүгээрт, нотлох баримтаар тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олсон болохыг хангалттай нотолсон, эрүүгийн хэрэгт холбогдуулан шийдвэр гаргах хэмжээний шаардлага хангасан, иймд эрүүгийн хэрэгтэй дүйцүүлж шийдвэрлэсэн. Хоёрдугаарт, тухайн этгээдийн хөрөнгийг хураасан нь эрүүгийн хариуцлага оногдуулсантай дүйцэхүйц байсан. (Crisafulli хэрэг 7 дугаар бүлэг, 60 дахь тэмдэглэлийг харах.)

[43] Европын Холбооны (EU) 2018 оны 11 сарын 14-ний 2018/1805 дугаартай царцаах болон хураах шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх шийдвэрийг харах, (OJ L 303, 28.11.2018), https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:32018R1805.

хүсэлт гаргах боломжтой. Хүсэлт илгээж буй улс нь хүсэлт хүлээн авагч улсад дотооддоо хэрэг нээх хүсэлт тавьж болно. Энэ нь зарим тохиолдолд буюу холбогдогч нь нас барсан, оргон зайлсан, халдашгүй эрхтэй тохиолдолд хөрөнгө буцаах цорын ганц арга байдаг (11 дүгээр бүлгээс энэ талаарх мэдээлэл харах).[44]

9.4 Иргэний журмаар (хувийн эрх зүйн) хөрөнгийг буцаан авах хамтын ажиллагаа

Иргэний журмаар хөрөнгө хураах хэрэгт олон улсын хамтын ажиллагаа нь хэдийгээр хувийн эрх зүйн хэрэг ч гэсэн ихээхэн хүндрэлтэй байдаг.[45] Хэдийгээр албан бус сувгаар олж авсан мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагааг хөгжүүлэх боловч эрх зүйн туслалцааны хүсэлтийн гэрээнүүд нь олж авсан мэдээллийг иргэний хэрэг маргаанд ашиглахыг хориглосон байдаг. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг улс орнуудад "харилцан адил байх зарчим" болон хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэдэг.

Мөн түүнчлэн, олон улсад иргэний журмаар хөрөнгө буцаах ажиллагаа нь авлигын хэрэгт цорын ганц арга зам нь байдаг бөгөөд иргэний болон захиргааны хэрэг дээр хамтран ажиллахыг уриалсан.[46] Үр дүнд нь, улс орнууд энэхүү арга хэлбэрийг олон улсын гэрээ, эсхүл хэрэг болгон дээр ялгавартай байдлаар хэрэглэх амлалтууд өгсөн. Иргэний хэрэг дээр хамтран ажиллах нь мөн олон улсын эрх зүйн баримт бичиг дээр үндэслэж болно. Тухайлбал, Иргэний болон худалдааны хэргийн талаарх нотлох баримтыг гадаад улсад цуглуулах тухай 1970 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Гаагын конвенц.[47]

---

[44] Энэхүү арга барил нь хэд хэдэн хэрэгт ашиглагдсан: АНУ-аас Пэрү-д Владимир Монтесиносийн орлогч, Өмнөх ерөнхийлөгч Алберто Фүжиморигийн зөвлөх Виктор Венерогийн хэрэгт холбогдуулан 20 сая ам-долларыг буцаасан (1 дүгээр бүлэг, Шигтгээ 1.3). АНУ-аас 2.7 сая ам. долларыг Никарагуад өмнөх Татварын албаны дарга Байрон Жерезийн хэрэгт холбогдуулан буцаасан. Мөн АНУ-аас Украйн Улсад өмнөх ерөнхий сайд Павло Лазаренкогийн хэрэгт холбогдуулан хөрөнгийг буцаасан.

[45] Тухайлбал, 2001 оны 9 сард, Нигерийн засгийн газраас Лондоны Дээд шүүхэд банкны дансны мэдээлэл гаргуулах, ингэхдээ холбогдох этгээдүүдэд мэдэгдэхгүй байх хүсэлт гаргасан. Шүүхээс банкны итгэлцлийн захирамж гаргасан (Банкны итгэлцэл Шапирагийн эсрэг [1980] 1274) бөгөөд энэ нь банкин дахь мэдээллийн хуулбарыг гаргуулах зорилготой. Тухайлбал, данс эзэмшигчид мэдэгдэлгүйгээр дансны мэдээлэл, харилцагчийг таних форм (KYC), төлбөрийн лавлагаа болон холбогдох бусад банкны мэдээллүүд зэргийг гаргаж өгөхөөр тусгагдсан. (Азийн Хөгжлийн Банк, ЭЗХАХБ, and Засаглалын Басель Институт 2007, 183–84), https://star.worldbank.org/corruption-cases/sites/corruption-cases/files/documents/arw/Abacha_Daniel_Case_Study_ADB_2007.pdf.

[46] НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 43 дугаар зүйл, Зөвлөмж 37 "Хөрөнгө буцаах асуудлаарх хамтын нөхөрлөлийн ажлын хэсгийн тайлан" (Хамтын нөхөрлөлийн нарийн бичгийн 2006, 350) зэрэгт "Хамтын нөхөрлөлийн орнуудын эрх зүйн харилцан туслалцааны дэглэмд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цуглуулсан нотлох баримтыг дараа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглахыг зөвшөөрөхөөр тусгагдсан бөгөөд авлигын хэрэгт холбогдуулан энэ төрлийн хүсэлтийн гүйцэтгэлийг хангахаар тусгасан."

[47] Иргэний хэрэгт холбогдуулан эрх зүйн туслалцаа үзүүлэх олон улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх процесс болон эрх зүйн баримт бичгүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий дараах өгүүллийг санал болгож байна https://star.worldbank.org/sites/star/files/9781464803703_0.pdf.

9.5 Хөрөнгө буцаан авахад хамтран ажиллах

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн дагуу хөрөнгө хураах ажиллагааг хийж гүйцэтгэмэгц, хүсэлт илгээж буй улсад тухайн хөрөнгийг буцаан өгөх боломжтой (Шигтгээ 9.7). Авлигын эсрэг конвенцийн 57 дугаар зүйлийн дагуу хүсэлт хүлээн авч буй улс нь төсвийн мөнгийг хувьдаа завших замаар олсон, эсхүл мөнгө угааж олсон хөрөнгийг хураах шийдвэр гарсны дараа хүсэлт илгээсэн улсад буцаан олгох талаар заасан байдаг. Бусад Авлигын эсрэг конвенцод заасан гэмт хэргүүдэд, хүсэлт хүлээн авсан улс нь хүсэлт илгээсэн улс тухайн хураасан хөрөнгийн өмчлөлийн талаар үндэслэлтэй тайлбарласан, эсхүл гэмт хэргийн улмаас хохирсныг тогтоосон тохиолдолд буцаан олгоно. Авлигын эсрэг конвенцийн бусад хэргүүдэд хүсэлт хүлээн авсан улс нь хөрөнгө буцаахад давуу байдал олгоно.

ШИГТГЭЭ 9.7	Франц Улсад эрх зүйн туслалцааны хүсэлтийн дагуу хөрөнгө буцаах

Франц улсад, гадаад улсын шүүхийн шийдвэрт үндэслэсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг Хууль зүйн яамнаас прокурорын газарт уламжилна. Улмаар шүүхэд хүсэлт гаргаж, хөрөнгийг хураадаг. Шүүхээс шийдвэр гаргавал, хураасан хөрөнгө нь Франц улсын хөрөнгө болдог. Холбогдох эрх бүхий байгууллагууд нь улмаар Франц улс нь олон улсын гэрээгээр хөрөнгө буцаан олгох үүрэг хүлээсэн эсэхийг тодорхойлно. Ийм үүрэг байхгүй ч, хүсэлт илгээсэн улстай тусад нь гэрээ байгуулж хөрөнгийг буцаан олгох боломжтой.

Хоёр талт болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр, хөрөнгө буцаах гэрээний хуульд заасан эрх бүхий байгууллага нь хураасан хөрөнгийг буцаан олгох (Гэрээ, эсхүл ялгавартай байдлаар), хэсэгчлэн олгоно.

11 дүгээр бүлэгт хүсэлт хүлээн авч буй улсын нутаг дэвсгэрт хураасан хөрөнгийг хүсэлт илгээсэн улс нь авлига болон мөнгө угаах гэмт хэргийн улмаас хохирсон гэх үндэслэлээр нэхэмжлэх талаар тайлбарласан. 11 дүгээр бүлэгт мөн Нигерийн өмнөх диктатор Генерал Сани Абачагийн хулгайлсан хөрөнгийг буцаан олгох талаар АНУ болон Нигерь, Жерси нарын хооронд байгуулсан хөрөнгө буцаах гэрээг дурдсан (Шигтгээ 11.8).

Салбарын мэргэжилтнүүд нь хүсэлт илгээсэн улсаас хөрөнгийн ил тод, үр дүнтэй менежментийн механизмын баталгаа гаргаж өгвөл ийм төрлийн гэрээнүүд хэрэгждэг талаар анхаарах нь зүйтэй. Энэ нь тодорхой аудит болон мониторингийн үр дүнд бий болох боломжтой. Төрийн бус байгууллагад мэдэгдэх, буцаасан хөрөнгийг хөгжлийн төслүүдэд ашиглах талаар төлөвлөх. Хөрөнгө буцаах олон улсын форумыг (GFAR) 2017 онд АНУ, ИБУИНВУ-аас Дэлхийн банканд зохион байгуулсан бөгөөд тус форумаар амжилттай хөрөнгө буцаах гол зарчмуудыг зарласан (Шигтгээ 9.8).

ШИГТГЭЭ 9.8	Хөрөнгө буцаах ажиллагааны Авлигын гэмт хэргийн улмаас хураагдсан хөрөнгийг шийдвэрлэх, шилжүүлэх гол зарчмуудын талаарх олон улсын форум

Зарчим 1: Түншлэл

Амжилттай хөрөнгө буцаах ажиллагаа нь хөрөнгийг шилжүүлж байгаа болон хүлээн авч байгаа улс орнууд хоорондын хүчтэй түншлэлд суурилсан байдаг.

Ийм түншлэл нь итгэлцэл болон итгэл үнэмшил төрүүлдэг.

Зарчим 2: Талуудын ашиг сонирхол

Хөрөнгийг шилжүүлж буй болон хүлээн авч байгаа улс орнууд үр дүнд хүргэх сонирхолтой байдаг. Иймд, харилцан зөвшөөрсөн хөрөнгийг шилжүүлэх ажиллагааг хамтран гүйцэтгэх.

Зарчим 3: Эрт зөвшилцөх

Хөрөнгийг шилжүүлж буй болон хүлээн авч байгаа улс орнууд хооронд тухайн ажиллагааны аль боломжит эрт үед зөвшилцөж эхлэх, мөн ажиллагааны туршид зөвшилцөх.

Зарчим 4: Ил тод байдал болон хариуцлагын тогтолцоо

Хөрөнгийг шилжүүлж буй болон хүлээн авч байгаа улс орнууд хөрөнгийг хүлээн авсны дараах шийдвэрлэлтэд ил тод болон хариуцлагын тогтолцооны талаар баталгаа гаргах. Хөрөнгийн шилжүүлэлт болон захиргааны талаарх мэдээлэл нь талуудын олон нийт, иргэдэд нээлттэй байх. Тодорхойгүй болон гэнэтийн зардлууд гаргахгүй байх.

Зарчим 5: Ашиг хүртэгч

Бололцоотой бол тогтоогдсон хохирогчид туйлшрахгүйгээр авлигын гэмт хэргийн улмаас хохирсон төр, иргэдэд ашиг хүртээх.

Зарчим 6: Хөгжил болон авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлж

Бололцоотой бол буцаагдсан хөрөнгийг зарцуулахдаа Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн авлигатай тэмцэх зарчмуудыг дэмжих, авлигын улмаас үүссэн хор уршгийг арилгаж, хөгжлийн зорилгод хүрэх.

Зарчим 7: Тохиолдолд суурилсан шийдвэрлэлт

Хураасан хөрөнгийг шийдвэрлэхдээ тохиолдол бүрд тохируулах.

Зарчим 8: Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 57 дугаар зүйлийн 5-д заасны дагуу гэрээ байгуулахыг харгалзах

Талууд нь тухайн гэрээнд буцаасан хөрөнгийн ил тод, үр дүнтэй зарцуулах, захиргаа, мониторингийн талаар зохицуулалт оруулах. Шилжүүлэх механизмыг одоо байгаа улс төрийн болон байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлж, улсын хөгжлийн төлөвлөгөөнд уялдаа холбоотой байх, давхардлаас сэргийлэх, үр дүнд төвлөрөх гэх зэргээр нийцүүлэх.

Зарчим 9: Гэмт хэрэгтнүүдэд ашиг хүртээхээс сэргийлэх

Хураасан хөрөнгийг шийдвэрлэхэд дагаж мөрдөх эдгээр алхмууд нь тухайн гэмт хэргийг үйлдэхэд хамтран оролцсон этгээдүүдэд аливаа байдлаар ашиг хүртээхгүй байх.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 9.8	Хөрөнгө буцаах ажиллагааны Авлигын гэмт хэргийн улмаас хураагдсан хөрөнгийг шийдвэрлэх, шилжүүлэх гол зарчмуудын талаарх олон улсын форум

Зарчим 10: Төрийн бус байгууллагуудыг оролцуулах

Тохирох болон зөвшөөрөгдсөн хуулийн хүрээнд нийтийн салбараас гадуурх, нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага болон бусад байгууллагуудын хувь хүн болон бүлэг этгээдийг хөрөнгө буцаах ажиллагаанд оролцуулах. Ингэхдээ, буцаан авсан хөрөнгийн шилжүүлэлт, шийдвэрлэлт, захиргаатай холбоотойгоор гэмт хэргийн улмаас учруулсан хор уршгийг хэрхэн арилгах, хөрөнгийг шийдвэрлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх зэргээр оролцуулах.

Эх сурвалж: GFAR (2017), https://star.worldbank.org/sites/star/files/the-gfar-principles.pdf.

Ном зүй

ADB (Asian Development Bank), OECD (Organisation for Economic Co-operation and Development), and Basel Institute on Governance. 2008. "General Sani Abacha—A Nation's Thief." In Asset Recovery and Mutual Legal Assistance in Asia and the Pacific: Proceedings of the 6th Regional Seminar on Making International AntiCorruption Standards Operational, 173–85. Manila: ADB; Paris: OECD. https://star .worldbank.org/corruption-cases/sites/corruption-cases/files/documents/arw / Abacha_Daniel_Case_Study_ADB_2007.pdf.

ADB (Asian Development Bank) and OECD (Organisation for Economic Co-operation and Development). 2017. "Mutual Legal Assistance in Asia and the Pacific: Experiences in 31 Jurisdictions." Report of the ADB/OECD Anti-Corruption Initiative for Asia and the Pacific, ADB, Manila; OECD, Paris. https://www.oecd.org/corruption/ADB-OECD-Mutual-Legal-Assistance-Corruption-2017.pdf.

ASEAN (Association of Southeast Asian Nations). 2015. ASEAN 2025: Forging Ahead Together. Jakarta: ASEAN.

Brun, Jean-Pierre, Pascale Helene Dubois, Emile van der Does de Willebois, Jeanne Hauch, Sarah Jaпs, Yannis Mekki, Anastasia Sotiropoulou, Katherine Rose Sylvester, and Mahesh Uttamchandani. 2015. Public Wrongs, Private Actions: Civil Lawsuits to Recover Stolen Assets. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank and United Nations Office on Drugs and Crime. http://documents1.worldbank.org/curated/en/964411468127796449/pdf/Public-wrongs-privateactions-civil-lawsuits-to-recover-stolen-assets.pdf.

Commonwealth Secretariat. 2006. "Report of the Commonwealth Working Group on Asset Repatriation." In Meeting of Commonwealth Law Ministers and Senior Officials, Accra, Ghana, 17–20 October 2005, 324–96. London: Commonwealth Secretariat. https://read.thecommonwealth-ilibrary.org/commonwealth/governance/2005-meeting-of-commonwealth-law-ministers-and-senior-officials_9781848598843-en#page3.

Commonwealth Secretariat. 2017. "Model Legislation on Mutual Legal Assistance in Criminal Matters." Legislative template, Office of Civil and Criminal Justice Reform,

Commonwealth Secretariat, London. https://thecommonwealth.org/sites/default/files/key_reform_pdfs/P15370_14_ROL_Model_Leg_Mutual_Legal_Asstnce.pdf.

Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime, Council of Europe Treaty No. 141 (November 8, 1990; entered into force January 9, 1993), Strasbourg, France. https://www.coe.int/en/web/conventions /full-list/-/conventions/rms/090000168007bd23.

Convention on the Taking of Evidence Abroad in Civil or Commercial Matters (Hague Evidence Convention), drafted under auspices of the Hague Conference on Private International Law (concluded March 18, 1970; entered into force 1972). https://assets.hcch.net/docs/dfed98c0-6749-42d2-a9be-3d41597734f1.pdf.

FATF (Financial Action Task Force). 2012. "Best Practices on Confiscation (Recommendations 4 and 38) and a Framework for Ongoing Work on Asset Recovery." Best Practices Paper, FATF and Organisation for Economic Co-operation and Development (OECD), Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Best%20Practices%20on%20%20Confiscation%20and%20a%20Framework%20for%20Ongoing%20Work%20on%20Asset%20Recovery.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations." Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents /recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

FDFA (Swiss Federal Department of Foreign Affairs). 2016. "No Dirty Money: The Swiss Experience in Returning Illicit Assets." Booklet, FDFA, Bern. https://www.eda.admin.ch/dam/eda/en/documents/aussenpolitik/voelkerrecht/edas-broschuere-no-dirty-money_EN.pdf.

GFAR (Global Forum on Asset Recovery). 2017. "GFAR Principles for Disposition and Transfer of Confiscated Stolen Assets in Corruption Cases." Statement of principles adopted at inaugural GFAR meeting, December 4–6, Washington, DC. https://star.worldbank.org/sites/star/files/the-gfar-principles.pdf.

Inter-American Convention against Corruption. Adopted at third plenary session of the Organization of American States (OAS) on March 29, 1996; entered into force March 6, 1997. http://www.oas.org/en/sla/dil/docs/inter_american_treaties_B-58 _against_Corruption.pdf.

International Convention for the Suppression of Financing of Terrorism (Terrorist Financing Convention), UN General Assembly Resolution 54/109 (December 9, 1999), United Nations, New York. https://undocs.org/en/A/RES/54/109.

OECD Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions (OECD Anti-Bribery Convention) (adopted 1997; entered into force 1999), Organisation for Economic Co-operation and Development, Paris. http://www.oecd.org/daf/anti-bribery/ConvCombatBribery_ENG.pdf.

Stephenson, Kevin M., Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabrielle Dunker, and Melissa Panjer. 2011. Barriers to Asset Recovery: An Analysis of the Key Barriers and Recommendations for Action. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/sites/star/files/Barriers%20to%20 Asset%20 Recovery.pdf.

Treaty on Mutual Legal Assistance in Criminal Matters. 2004. Signed in Kuala Lumpur, Malaysia, on November 29, 2004, by member states of the Association of Southeast Asian Nations (ASEAN). https://asean.org/storage/2020/02/20160901074559.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc.org / pdf/convention_1988_en.pdf.

UNTOC (United Nations Convention against Transnational Organized Crime), UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25.

United Nations International Covenant on Civil and Political Rights, UN General Assembly Resolution 2200A (adopted December 16, 1966; entered into force March 23, 1976), United Nations, New York. https://treaties.un.org/doc/Treaties/1976 /03/19760323%2006-17%20AM/Ch_IV_04.pdf.

Universal Declaration of Human Rights, UN General Assembly Resolution 217A (December 10, 1948), United Nations, New York. https://www.ohchr.org/EN/UDHR / Documents/UDHR_Translations/eng.pdf.

UNODC (United Nations Office on Drugs and Crime). 2012. "Manual on Mutual Legal Assistance and Extradition." Reference manual, UNODC, Vienna. https://www.unodc.org/documents/organized-crime/Publications/Mutual_Legal_Assistance _Ebook_E.pdf.

Williams, Sharon A. 1991. "The Double Criminality Rule and Extradition: A Comparative Analysis." Nova Law Review 15 (2): 581–624. https://digitalcommons.osgoode.yorku.ca/cgi/viewcontent.cgi?referer=https://www.google.com/&httpsredir=1&article=1454&context=scholarly_works.

10.Иргэний процесс ажиллагаа

10.1 Удиртгал

Гишүүн нэг улс нь нөгөө улсын шүүхэд хөрөнгийн өмчлөх эрх, эсхүл хохирлыг нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргахыг зөвшөөрдөг байх талаар арга хэмжээ авах тухай Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 53 дугаар зүйл ("хөрөнгийг шууд буцаан олгох")-д тусгасан байна. Авлигын гэмт хэргийн улмаас олсон орлогыг буцаан авахыг хүсэж буй эрх бүхий байгууллага нь яг л хувь иргэдийн нэг адилаар өөрийн болон гадаадын орны иргэний хэргийн шүүхэд хандах эрх нь ихэнх орнуудад нээлттэй байдаг.[1] Зарим тохиолдолд, эрх бүхий байгууллага авлигын гэмт хэргийг эрүүгийн шүүхээр шийдвэрлүүлж, уг гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг буцаан авахад иргэний процессыг хэрэглэх арга замыг сонгон авах боломжтой.[2]

Иргэний журмаар хөрөнгө буцаах ажиллагааг янз бүрийн шалтгаанаар сонгон хэрэглэж болох бөгөөд дараах тохиолдлууд байж болно. Үүнд: (а) эрүүгийн хэрэгт шийтгэх тогтоол гаргуулах боломжгүй, (б) шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах, эсхүл (в) эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх замаар хөрөнгө буцаан авах ажиллагаатай холбоотой шийдвэрийг биелүүлэх зэрэг юм. (Эдгээртэй холбоотой болон хөрөнгө буцаан авах арга замыг сонгоход тулгардаг асуудлуудын талаар 1-р бүлгийг үзнэ үү.)

Үүнээс гадна процессын хувьд зарим давуу талуудтай байдаг. Иргэний хэрэгт хариуцагчаар татагдаж буйг хуулийн дагуу түүнд мэдэгдэж чадсан бол хариуцагчийг байлцуулахгүйгээр хэргийг шийдвэрлэх боломжтой. Түүнчлэн нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудын хувьд нотолгооны доод стандартад тулгуурлан (ихэвчлэн "магадлалын тэнцэл") иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэж болно. Сэжиг бүхий хөрөнгийг хүлээн авах, шилжүүлэх, эсхүл удирдахад тусалсан, оролцсон, мөн дэмжлэг туслалцаа үзүүлсэн гуравдагч этгээд, зуучлагч, мэргэжлийн хүмүүсийн эсрэг эрүүгийн процессыг эхлүүлэхээсээ иргэний хэрэг үүсгэх нь зарим улсад илүү хялбар байдаг.[3]

Хилийн чандад хөрөнгө буцаах ажиллагааг эхлүүлж буй эрх бүхий этгээдийн хувьд хүсэлтээ эрүүгийн журмаар явуулснаас илүү иргэний журмаар нэхэмжлэх нь тухайн хэрэгт хяналтаа хэрэгжүүлэх олон боломжууд нээгдэг. Түүнчлэн иргэний журмаар гадаадын шүүхэд хандах нь эрүүгийн журмаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулахаар гадаадын эрх бүхий байгууллагыг хүлээж цаг алдах эрсдэлийг

---

[1] "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа"-г "иргэний журмаар хөрөнгө буцаах", "иргэний журмаар эд хөрөнгө хураах" гэх мэт ойлголтуудаас ялган салгаж ойлгох нь зүйтэй.

[2] Иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа парлелны явагдаж болно. Бас зарим улс оронд эрүүгийн хэрэг эцэслэн дуустал иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг. Түүнчлэн иргэний журмаар хөрөнгө буцаах шүүхийн шийдвэр гаргахдаа гэм хорын хохирлыг давхар шийддэг бол бусад оронд гэм хорын хохирол учирсныг тогтоосон шүүхийн шийдвэртээ хөрөнгө буцаах ажиллагааг багтаан тусгадаг.

[3] Эрүүгийн журмаар гэмт хэрэгт оролцсон оролцоог тогтооход хүндрэлтэй тохиолдолд иргэний журмаар хариуцлага тооцох /гэм хорыг арилгах/ нь илүү хялбар байж болно.

багасгаж хөрөнгө буцаах ажиллагааг шийдвэрлэх өргөн, ашигтай гарцууд нээгддэг.[4] Иргэний журмаар гадаад улсаас нотлох баримт цуглуулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхэд хоёр талын иргэний харилцан туслалцаа үзүүлэх болоод олон улсын гэрээ /Гаагийн конвенц/-нүүдийг үндэслэн үр дүнтэй ажиллах боломжтой.[5]

Иргэний журмаар хийгдэх ажиллагааны сул тал нь эд хөрөнгийг мөшгихтэй холбоотой өртөг болон холбогдох шүүхийн шийдвэрийг гаргуулахад хуулийн дагуу шаардагдах төлбөр, хураамж зэрэг зардлууд юм. Мөн иргэний хэрэг нь зарим эрүүгийн хэрэг шиг олон жил үргэлжлэх, өмгөөлөгч болон хувийн мөрдөгч нар нь хууль сахиулах байгууллагын ажилтны нэгэн адил гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхгүй зэрэг сул талуудыг дурдаж болно.

Дотоодын болон гадаадын иргэний шүүхэд нэхэмжлэл гаргахаар шийдвэр гаргасан бол салбарын ажилтнуудын анхаарах зүйл бол нэхэмжлэл болон нэхэмжлэлийн (хууль бус өмчлөгч, хууль бусаар олсон ашиг, хохирол нөхөн төлүүлэх, гэрээ хүчин төгөлдөр бус байх гэх мэт) шаардлагуудаа маш сайн бүрдүүлэх, эсхүл бусад хувилбаруудыг (гэмт хэрэг болохыг тогтоож чадахгүй боловч хууль бусаар олж авсан орлого гэдгийг нотлох баримтуудыг цуглуулах) сайтар судалсан байх шаардлагатай. Мөн түүнчлэн хэрхэн нэхэмжлэлийг гаргах, нотлох баримтаа цуглуулах, хөрөнгийг хамгаалах, гадаад улсын шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх зэрэг ажиллагааг зохион байгуулахаа тодорхойлсон байх хэрэгтэй. Энэ бүлгээр иргэний процесс ажиллагаа ашигласан төрөл бүрийн арга техник, сонголтуудын талаар авч үзэх болно.[6]

10.2 Нэхэмжлэл гаргах ба нөхөн төлүүлэх

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд олон төрлийн нэхэмжлэл, нөхөн төлбөрийн хэлбэрүүд байдаг ба дурдвал хөрөнгө өмчлөх маргаан, хувь хүний эрхийг сэргээх маргаан зэргийг дурдаж болно. Ерөнхийдөө *хөрөнгө өмчлөх маргаан* нь аливаа өмч, хөрөнгийн тодорхой хэсгийн талаар жинхэнэ өмчлөгчөөс шууд гаргадаг бол *хувь хүний эрхийг сэргээх маргаан* нь төрөл бүрийн өмчийн талаар нэг этгээдээс нөгөө этгээдэд холбогдуулан гаргасан байдаг. Хувийн нэхэмжлэлийг ихэвчлэн гэрээний үүргээ зөрчсөн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол төлүүлэх талаар, гэрээ хүчин төгөлдөр эсэх болон хуулв бусаар, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх үндэслэлээр гаргадаг.

---

[4] Иргэний журмаар нэхэмжлэл гаргахаас өмнө харгалзан үзсэн хүчин зүйлсийн талаар Замби улсын иргэн Фредерик Чилуба болон Нигерийн иргэн Диепрее Аламиесейха нарын кейсээс харна уу. 1-р бүлгийн 1.4, 1.5-р тус тус тусгасан болно.

[5] Иргэний хэргийн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх процесс, арга хэрэгслийн талаар дэлгэрэнгүйг Stolen Asset Recovery (StAR) initiative publication Public Wrongs, Private Actions: Civil Lawsuits to Recover Stolen Assets (Brun et al. 2015) https://star.worldbank.org/sites/star/files/9781464803703_0.pdf

[6] Дэлгэрэнгүйг *Going for Broke: Insolvency Tools to Support Cross-Border Asset Recovery in Corruption Cases* (Brun and Silver 2019), https://star.worldbank .org/sites/star/files/going-for-broke.pdf.

10.2.1.Өмчлөлийн (өмчлөгчийн) нэхэмжлэл, нөхөн төлбөр

Үйлдлийн шалтгаан

Хууль бусаар хөрөнгө болон төрийн албан тушаалтнуудад өгсөн хахууль зэрэгтэй холбоотойгоор хууль ёсны бөгөөд жинхэнэ өмчлөгч нь нэхэмжлэх боломжийг олон улс орны хувьд зөвшөөрсөн байдаг. Шигтгээ 10.1-д үндэстэн дамнасан авлигын хэрэгт хөрөнгийн өмчлөлийг тогтоолгох тухай иргэний нэхэмжлэлийн дөрвөн жишээг үзүүлэв.

ШИГТГЭЭ 10.1 Хөрөнгийн өмчлөх эрхийг шаардсан хэргийн жишээ

Кэйс 1: Kartika Ratna Thahir v. Pertamina (1992–1994)

Факт: Газрын тос, байгалийн хийн хайгуул, боловсруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг Индонезийн төрийн өмчит Пертамина компанийн захирал Хажи Ахмад Тахирд тус салбарт үйл ажиллагаа эрхэлдэг зарим компаниуд гэрээний нөхцөлүүдийг сайжруулж, давуу эрх олж авна хэмээн найдаж их хэмжээний хахууль өгсөн байдаг.[a] Гүйцэтгэх захирал Хажи Ахмад Тахир авлигаар авсан мөнгөө Сингапурын банканд байршуулжээ. Сингапур дахь Хажи Ахмад Тахиригийн дансны талаар (түүний эхнэр Картика Ратна Тахир нарын хамтран эзэмшдэг) түүнийг нас барсны дараа Пертамина компани мэдэж, Сингапурын талд тус дансанд дахь хөрөнгийг компанийн нэр дээр шилжүүлэх нэхэмжлэл гаргасан байна.[b]

Шүүхийн шийдвэр: Анхан шатны шүүх гүйцэтгэх захирал асны мэдэл дэх хээл хахуулиар олж авсан хөрөнгийг тэрээр констрактив трастын хувьд эзэмшиж байсан болохыг тогтоосон. Давж заалдах шатны шүүхээс шийдэхдээ, одоо бий болсон хөрөнгө бол Пертамина компани болон түүний захирал асан Тахиригийн хоорондох фидуцийн харилцааны үр дүнд үүссэн хөрөнгө гэдгийг баталгаажуулсан байна. Өөрөөр хэлбэл, Тахир болон Пертамина компанийн хооронд үүссэн фидуцийн гэрээгээ зөрчиж, тус компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж байсан Тахир хахууль авсан байна гэж дүгнэсэн.[c] Иймд Сингапурт мөнгө угаах замаар байршиж буй хөрөнгийн жинхэнэ өмчлөгч нь Пертамина компани бөгөөд хөрөнгийн өмчийн эрхийг түүнд шилжүүлж буцаан олгожээ.

Үр дүн: Маргаан бүхий хөрөнгийг төрийн өмчит Пертамина компанид шилжүүлсэн. (Brun et al. 2015, 18 [Шигтгээ 1.5]).

Кэйс 2: Attorney General for Hong Kong v. Reid ((1994)

Факт: Прокурор асан Чарльз Уорвик Рэйдийн Шинэ Зеландад худалдаж авсан эд хөрөнгийг эргүүлэн авах ажиллагааг Хонгконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо (ICAC) хийсэн байна.[d] Зарим этгээдийг яллахгүй байсныхаа шанд авсан хахуулийн мөнгөөрөө худалдан авалт хийсэн хэрэгт түүнийг буруутгасан байна. Рэйдийн авсан авлигын нийт хэмжээ 2.5 сая гаруй Шинэ зеланд доллар давжээ. Тэрээр Шинэ Зеландад авлигын мөнгөөрөө 3 үл хөдлөх хөрөнгө худалдан авсан ба өөрийн болон эхнэр, түүнчлэн өмгөөлөгчийнхөө нэр дээр бүртгүүлсэн байв.

Шүүхийн шийдвэр: Шүүхээс Рэйдийг авлигад авсан мөнгөөр тэдгээр үл хөдлөх хөрөнгүүдийг худалдан авсан гэж үзэж шийдвэрлэсэн. Мөн шүүх авлига авсан этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь авлига авсан гэдгийг мэдсээр байж тэр мөнгөөр аливаа үйлдэл хийсэн бол гарах үр дагаврыг итгэмжлэл олгосон этгээдийн нэгэн адил хүлээнэ гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, хэрэв авлигын мөнгөөр худалдан авсан эд хөрөнгийн үнэлгээ унасан тохиолдолд итгэмжлэгдсэн этгээд

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

анх худалдан авсан үнийн дүнгийн зөрүүг хариуцах ёстой, учир нь тэрээр анхнаасаа авлига аваагүй боловч итгэмжлэгдсэн этгээдийн хувьд итгэмжлэл олгосон этгээдийн өмнө хариуцлага хүлээх үүрэгтэй байдаг. Авлигын мөнгөөр худалдан авсан хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэн тохиолдолд итгэмжлэгдсэн этгээд уг нэмэгдсэн үнэлгээнээс ашиг хүртэх эрхгүй ба итгэмжлэл олгосон этгээд уг хөрөнгийг анхнаасаа хууль бусаар аргаар олсон тул ямар ч аргаар ашиг олохыг зөвшөөрөх боломжгүй юм гэж дүгнэсэн байна.[e] Энэ жишээ нь найдваргүй фидуцийн харилцаагаар дамжуулан авлига авах замаар бий болсон хууль бус орлогыг буцаан авахад итгэлцлийг /констрактив траст/ ашигласан нийтлэг эрх зүйн системтэй орнуудын сайн жишээ хэмээн тооцогддог.

Үр дүн: Шинэ Зеланд дахь гурван үл хөдлөх хөрөнгийг эзэн хааны нэрийн өмнөөс хураан авсан ба ойролцоогоор Шинэ Зеландын 500,000 долларoор худалдагдсан байна. БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонгконгийн Засгийн газар эдгээр үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны эзэмшигчээр тогтоогдсон байна.

Кэйс 3: State of Libya v. Capitana Seas Ltd. (2012, 2015)

Үйл баримт: Ливи Улсад өрнөсөн иргэний дайны дүнд Муаммар Эль-Каддафиг огцруулсны дараахан 2011 онд Ливи Улс, Лондоны нэр хүндтэй Хэмпстэд цэцэрлэгт хүрээлэнд байрлах найман унтлагын өрөө, усан сан, хувийн кино театр бүхий 10 сая фунт стерлингийн үнэтэй үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг хүлээн авах нэхэмжлэлийг Их Британийн Виржиний арлуудад бүртгэлтэй Капитана Сэйс компаниад холбогдуулан Лондоны дээд шүүхэд гаргажээ.[f] Ливи Улс нэхэмжлэлдээ Их Британийн Виржиний арлуудад бүртгэлтэй Капитана Сэйс компанийг ашиглан тус үл хөдлөх хөрөнгийг 2009 онд Муаммар Эль-Каддафийн хүү Саади Каддафи худалдаж авсан хэмээн дурджээ.

Мөн нэхэмжлэлдээ Саади Куаддафи нь цэргийн албан хаагчийн цалингаараа ийм үнэтэй үл хөдлөх хөрөнгө худалдаж авах боломжгүй ба Ливи Улсын хөрөнгийг хууль бусаар ашиглан худалдаж авсан гэж мэдэгдэв. Ливийн мөрдөн байцаагчид Британийн Виржиний арлуудын бүртгэлтэй компанийн өмчлөгчтэй холбоотой мэдээллийн нууцлалаас шалтгаалан Саади Куаддафиг Хэмпстэд дахь харшийн өмчлөгч болохыг өөрсдөө тогтоох боломжгүй байгаа тул Их Британийн Сангийн яамаар уламжлуулан, Британийн Виржин арлын эрх баригчидтай шууд холбогдсон талаар мэдээлсэн байна.

Шийдвэр: Шүүх Саади Куаддафи нь үл хөдлөх хөрөнгийг худалдан авахад ашигласан Капитана Сэйс компанийн цорын ганц эзэмшигч болох нь тогтоогдсон.[g] Капитана Сэйс компанийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг Ливийн Улсын нэхэмжлэлээр түр царцаасан.[h] Түүнчлэн шүүх хуралд Капитана Сэйс Лимитед компаниас итгэмжлэгдсэн төлөөлөгч болон Саади Куаддафи нар ирээгүй тул Ливи Улсын талд ашигтайгаар шийдвэр гаргасан.[i] Иймд үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийг Ливи Улс хэмээн тогтоов.

Шүүхийн шийдвэрийн дагуу Их Британийн Сангийн яам үл хөдлөх эд хөрөнгийг Ливид шилжүүлэв. 2012 онд гарсан уг шийдвэрийг Капитана Сэйс компани эсэргүүцэн 2015 шүүхэд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох тухай нэхэмжлэл гаргасан боловч нотлох баримт дутуу гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож 2012 оны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.[j]

Үр дүн: Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг Ливи улсад олгосон нь Арабын хаврын хувьсгал хийсэн улсууд дундаас хөрөнгөө эргүүлэн авсан анхны амжилттай жишээ болсон юм.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 10.1 Хөрөнгийн өмчлөх эрхийг шаардсан хэргийн жишээ

Кэйс 4: Federal Republic of Nigeria v. Santolina Investment Corp., Solomon & Peters, and Diepreye Alamieyeseigha (2007)

Нэхэмжлэл: Холбооны Бүгд Найрамдах Нигери улс 1999 оны 5-р сараас 2005 оны 12-р сар хүртэл Нигерийн Байелса мужийн захирагчаар ажиллаж байгаад авлигын гэмт хэрэг холбогдон албан тушаалаас нь огцруулсан Диепрье Аламиесейха эсрэг Лондоны шүүхэд нэхэмжлэл гаргасан.[k] Тодруулбал, Нигерийн засгийн газар Аламиесейхагийн хяналтад байдаг компаниуд болох Santolina Investment Corp, Solomon & Peters Ltd (S&P)-ын Лондонд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, банкны дансыг царцаах, өмчлөх эрхийг Нигерийн засгийн газарт шилжүүлэх нэхэмжлэл гаргасан.[l] Нигерийн засгийн газар нэхэмжлэлдээ дээрх хөрөнгө нь Аламиесейха төрийн албан хаагч байхдаа эрх мэдлээ урвуулан ашиглаж, хээл хахууль авах замаар бүрдүүлсэн мөнгөөр худалдан авсан хэмээн дурджээ. (Энэ хэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 10.12-р, 1-р бүлгийн 1.5-аас үзнэ үү.)

Шийдвэр: 2007 оны 12-р сард Лондон хотын Давж заалдах шүүхээс Нигерийн Засгийн газар нь Лондон дахь орон сууцнууд болон хэд хэдэн дансанд байршуулсан мөнгөний жинхэнэ өмчлөгч нь гэж дүгнэжээ.[m] Тэдгээр өмч нь Сейшелийн арлууд болон Британийн Виржиний арлуудад бүртгүүлсэн Сантолина ба S&P гэх хоёр компаниудын нэр дээр бүртгэгдсэн ба Аламиесейхагийн хяналтад байдаг байжээ. Түүнчлэн Нигерийн шүүх Аламиесейхагийн удирдаж буй хоёр компанийг хахууль өгөх замаар Засгийн газартай гэрээ байгуулан ажил гүйцэтгэх давуу эрх олж авсан, мөнгө угаасан гэмт хэрэгт буруутай хэмээн үзсэн.[n]

Нигерийн энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон нөхцөл байдлыг тогтоосон бусад нотлох баримтад үндэслэн, Лондоны Давж заалдах шүүхээс Аламиесейхагийн хяналтад байдаг хоёр компанийн эзэмшиж байсан банкны дансан дахь үлдэгдэл болон үл хөдлөх хөрөнгийг хахууль, нууц ашиг орлогын үндсэн дээр худалдан авсан хэмээн үзэж Нигерийн засгийн газрыг хууль ёсны өмчлөгчөөр тогтоож, хөрөнгийг буцаан өгөхөөр болсон байна. Түүнчлэн шүүгдэгчийн хууль ёсны орлого нь дээрх нэр бүхий хөрөнгийг худалдан авч бүрдүүлэхэд хүрэлцэхгүй буюу хууль ёсны аргаар худалдан авснаа тайлбарлахад хангалтгүй гэж үзсэн нь бусад ижил төстэй хэргүүдийг шийдвэрлэхэд баримталдаг суурь үндэслэлүүдийн нэг юм.

Үр дүн: Шүүх Нигери улсыг банкны дансанд хадгалагдсан 2.7 сая ам. долларын (үүний 1.8 сая £-ийг Santolina Investment Corp. дансанд эзэмшиж байсан) болон Лондон дахь 15 сая долларын үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийн (S&P-д компанийн нэр дээр бүртгүүлсэн дөрвөн үл хөдлөх хөрөнгөтэй) хууль ёсны өмчлөгч гэж дүгнэв.[o]

Хэргүүд:
a. Kartika Ratna Thahir v. PT Pertambangan Minyak dan Gas Bumi Negara (Pertamina) [1994] 3 SLR 257; [1994] SGCA 105 (Сингапур).
b. Kartika Ratna Thahir v. Pertamina, 2–3 дахь догол.
c. Kartika Ratna Thahir v. Pertamina, 53, 57 дахь догол. State of Libya v. Capitana Seas Ltd. (2012) EWHC 602 (Comm) хэрэгт маргаж байгаа хөрөнгийг Saadi Quaddafi нь өөрийгөө траст /constructive trust/ гэж үзэн Ливийн төрийн сангийн хөрөнгөөр худалдан авсан нь хууль бусаар байна гэж Лондонгийн Давж заалдах шүүхээс дүгнэжээ. (3 дахь догол). Саяхан, in FHR European Ventures LLP & Ors v. Cedar Capital Partners LLC [2014] UKSC 45 хэрэг дээр Их Британийн Дээд шүүх дүгнэхдээ трастын үйлчилгээний үед хахууль болон нууц урамшуулыг өөрийн агентаараа дамжуулан авсан байна гэсэн байна.
d. Att'y Gen. for Hong Kong v. Reid [1994] 1 AC 324 PC (UK).
e. Att'y Gen. for Hong Kong v. Reid [1993] UKPC 2 (November 1, 1993).
f. State of Libya v. Capitana Seas Ltd. [2012] EWHC 602 (Comm).

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 10.1 Хөрөнгийн өмчлөх эрхийг шаардсан хэргийн жишээ

g. High Court of Justice, Commercial Court [2012] EWHC 602 (Comm), 5 дахь догол.
h. High Court of Justice 3 дахь догол.
i. High Court of Justice 4 дэх догол.
j. Libya v. Capitana Seas Ltd., QBD (Comm) (Knowles J) 05/08/2015.
k. Fed. Republic of Nigeria v. Santolina Inv. Corp., Solomon & Peters, болон Diepreye Alamieyeseigha [2007] EWHC 437 (Ch) (UK).
Сонирхолтой нь, энэ хэрэгт хялбаршуулсан журмаар шийдвэр гаргуулах тухай хүсэлт нь Холбооны Бүгд Найрамдах Нигери улсын хоёр дахь оролдлого байсан юм. Эхний хүсэлтийг авлигын хэрэг нь шүүхэд шилжүүлсэн байх тул хэрэгсэхгүй болгосон. Гэвч эхний өргөдлийг хэрэгсэхгүй болгосноос хойш Нигерийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд Alamieeseigha мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн буруутай гэдгээ хүлээн зөвшөөрсөн тул нөхцөл байдал өөрчлөгдсөн.Fed. Republic of Nigeria and (1) Santolina Inv. Corp.,(2) Solomon & Peters Ltd., (3) Diepreye Alamieyeseigha [2007] EWHC 3053 (QB), 2 дахь доголыг харна уу.
l. Nigeria v. Santolina, 1 дэх догол.
m. Nigeria v. Santolina, 54 дэх догол.
n. Nigeria v. Santolina, 4–5 дэх догол.
o. Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (StAR)-ын хэргийн талаарх судалгаа, "Diepreye Alamieyeseigha,"
https://star.worldbank.org/corruption-cases/sites/corruption-cases/files/Alamieyeseigha_StAR_Case_Study_2.pdf.

Зөрчигдсөн эрхийг сэргээх

Шүүхээс хууль ёсны өмчлөгчид нь эд хөрөнгийг буцаан олгох, дахин тогтоохдоо олон төрлийн хуулийн гаргалгаар шийдвэрлэх боломжтой.[7] Зөрчигдсөн эрхийг сэргээх буюу хаяуулийн замаар олсон орлогыг буцаах тухай нэхэмжлэл нь хариуцагчид хамаарал бүхий бусад этгээдийн өмнө гэрээгээр болон бусад шүүхээс хүлээлгэсэн үүргээс давуу эрхтэй шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хаяуулийн замаар олсон орлогыг буцаах тухай нэхэмжлэлийг бусад хариуцагчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах нэхэмжлэлээс өмнө буюу давуу эрхтэй шийдвэрлэх нь зүйтэй. Мөн шүүх нэхэмжлэгч хөрөнгө царцаах, нэхэмжлэл гаргаагүй, түүнчлэн хөрөнгийг хөдөлгөх эрсдэл байхгүй байсан ч хөрөнгө царцаах шийдвэр гаргаж болно. Хэрэв хариуцагч авлигын замаар хөрөнгө бий болгосон нь тогтоогдсон ба уг орлогоо хариуцагч өөр зүйлд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд түүнээс ашиг олсон бол Шигтгээ 10.1-д үзүүлсэн *Kartika Ratna Thahir v. Pertamina and Attorney General for Hong Kong v. Reid* хэргийг шийдвэрлэсэнтэй адилаар тэр ашгийг хөрөнгө буцаах нэхэмжлэл гарсан этгээдэд буцаан олгоно.

Гэсэн хэдий ч хууль бус орлогоо үндэстэн дамнуулан угаасан тохиолдолд авлигын гэмт хэрэг үйлдсэн болохыг олж тогтооход хүндрэлтэй болж зүй ёсны өмчлөгчөөр

[7] Дэлгэрэнгүйг Sinclair Investments (UK) Ltd. v. Versailles Trade Finance Ltd. (2011), (Shantanu Majumdar. 2013. "Agents, Bribes and Remedies: Where Are We Now?" Radcliffe Chambers, нийтлэлээс харна уу Lexology, 2013 оны 12 сарын 03. https://www.lexology.com/library/detail.aspx?g=18d25953-827a-4971-8a70-9e370f0f433b.). Энэ хэрэгт Давж заалдах шатны шүүхээс, фидуцийн гэрээний дагуу ашиг хүртэгч нь өмчийг нэхэмжлэх боломжгүй байсан бөгөөд эд хөрөнгө нь түүний эзэмшилд ороогүй, эсхүл ашиг хүртэгчийн боломж, эрхээс үүсэгүй тохиолдолд зөвхөн "шударга данс" авах эрхтэй байсан гэдгийг тогтоосон. Гэсэн хэдий ч, FHR European Ventures LLP-ийн эсрэг Манкариус (2013)-д фидуцын итгэмжлэлд тулгуурлан үйлдсэн авлигын гэмт хэргээс олсон ашиг байсан гэж дүгнэн, Давж заалдах шатны шүүхээс өмчлөх эрхийг олгосон байна.

тогтоолгох, нөхөн төлбөр авах боломжгүй болох эрсдэлтэй.[8] Төрийн албан тушаалтнуудын авлига эсхүл залилангийн гэрээнээс олсон ашгийг нийтлэг эрх зүйн баримжаа бүхий зарим улс орнуудын зарим эрх мэдэл нь итгэлцлийн зарчмыг баримталдаг. Өөрөөр хэлбэл, үүргээ зөрчиж хууль бусаар мөнгө авсан төрийн албан хаагчийн олсон мөнгө эцсийн дүндээ төр тухайн хүнд итгэмжлэл хүлээлгэсэн учир төр өөрөө жинхэнэ өмчлөгч учир шаардах эрх үүсэж байгаа юм. харин бусад ялангуяа хувийн эрх зүйн баримжаа бүхий орнуудад хууль бус хөрөнгийг улсын өмч хэмээн үздэг.

10.2.2 Гэм хорыг арилгах

Үйлдлийн шалтгаан

НҮБАЭК-ийн дагуу оролцогч улсууд авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хүсэлтийг эрх бүхий байгууллагад гарах зөвшөөрсөн[9]. Гэм хороос үүдэлтэй үүргийг нөхөн төлүүлэх хэлбэрүүд нь нэхэмжлэгчийн алдагдал, хохирол, үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлууд буюу хууль бус болон гэмт хэргийн улмаас түүнчлэн гэрээний үүргээ биелүүлээгүйгээс гарах хохирол зэргийг хамруулж болно. Авлигын үүднээс гэм хор учирсан гэж үзвэл нэхэмжлэгч ерөнхийдөө хариуцагч үүргээ зөрчсөн буюу авлига хээл хахуулийн улмаас нэхэмжлэгчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх буюу хохирол учирснаа нотлох өөрөөр хэлбэл авилгийн улмаас хохирол учирсан байх тэр нөхцөл байдлыг ойлгоно.

Авлигын гэмт хэрэгт шууд болон мэдсээр байж оролцсон хуулийн этгээд, хувь хүмүүс учирсан хохирлыг үндсэндээ хариуцна. Түүнчлэн авлигын үйлдлийг өдөөсөн, авлигаас урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ аваагүй хүмүүс буюу авлигын хэрэгт тусалсан хуульч, зуучлагч, охин компани, ажилчдаа зохих хяналт тавьж чадаагүй толгой компани, ажил олгогчдод шүүх хариуцлага тооцож болно.

---

[8] ([2015] UKPC 35, Privy Council Appeal No. 0069 of 2013, https://www.jcpc.uk/cases/docs/jcpc-2013-0069-judgment.pdf) шүүхийн шийдвэр. Пауло Малуфын хэрэг дээр гарсантай адилаар, Их Британийн Хувийн зөвлөлөөс мөнгийг өөр газар зарцуулсан байсан ч банкны данс руу мөнгө оруулсны дараа хууль бус төлбөрийг нөхөн сэргээх арга болох "буцаан мөшгих" нь хууль ёсны болохыг баталсан ([2015]] UKPC 35, Хувийн зөвлөлийн 2013 оны 0069 дугаар давж заалдах гомдол, https://www.jcpc.uk/cases/docs/jcpc-2013-0069-judgment.pdf). Энэ хэрэг нь 2005 онд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс болон Сан Паоло хотын захиргаанаас Дурант ба Килдаре (Британийн Виржиний арлуудад бүртгэлтэй, тус хотын ахлах дарга Паоло Малуф болон түүний хүү Флавио нарын удирдлаган дор байдаг) хоёр компанийн эсрэг нийтийн ажлын гэрээтэй холбогдуулан өгсөн авлигатай холбогдуулан үүсгэсэн иргэний хэрэгтэй холбоотой юм. 2012 онд Жерсигийн Хатан хааны шүүх шүүгдэгчдийг гэрээтэй холбоотой 10 сая орчим ам.долларын хээл хахуулийн хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгч хотын захиргааны өмнө хариуцлага хүлээх ёстой гэж үзжээ. Компаниуд авлига авсан нийт дүнг долоон сая ам.доллараас хэтрэхгүй гэж Жерсигийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан байна. Давж заалдах шатны шүүх 2013 онд Хатан хааны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. Эцэст нь компаниуд Хувийн зөвлөл, Их Британийн хараат байдал болон Хамтын нөхөрлөлийн бусад орнуудад хандах эцсийн шатны шүүхэд хандсан. Уг шүүхийн шийдвэр нь гомдлыг няцааж "энэ асуудлыг буцаан мөшгих боломжгүй ба орлого нь давсан дансанд төлөгдсөн хөрөнгийн үнэ цэнийг шүүх хэзээ ч мөшгиж чадахгүй" гэж дүгнэжээ. ([2015] UKPC 35, Privy Council Appeal No. 0069, 2013, 40 дэх догол).

[9] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 53 дугаар зүйл, Европын холбооны Авлигын эсрэг Иргэний эрх зүйн конвенц, 5 дугаар зүйл.

Иргэний эрх зүйн тогтолцоо бүхий зарим улс орнуудад гэмт хэргийн улмаас шууд хохирол амссан аливаа этгээд гэм буруутайн тогтоогдсон этгээдээс иргэний болон эрүүгийн журмаар гэм хорын нөхөн төлбөрийг нэхэмжлэх боломж нь нээгддэг.[10] Хариуцагчаас хохирлоо барагдуулахын тулд материаллаг хуульд хариуцагчийн хийсэн үйлдэл, эс үйлдэхүй нь нэхэмжлэгчид хохирол учирсан гэдгийг нотлохыг шаарддаг. Зарим улсын шүүх авлига өгсөн болон авсан этгээдийг аль алиныг нь гэм хор учруулсан гэж үзэж хамтран хариуцагчаар татдаг.[11] Авлига нэгэнт өгсөн нь тогтоогдсон бол авлига авсан этгээд авлига өгсөн этгээдийн тусын тулд үндсэн зорилго чиглэгдэх ба нийгмийн нийтлэг зарчмын эсрэг үйлдэл хийсэн гэж үзэх бөгөөд энэ талаар маргах нь хэрэггүй ба хахууль өгсөн гэдгийг нотлоход л болно.[12] Зарим орнуудад компанийн захирал болон ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр заасан үүргээ хууль бусаар ашиглан хээл хахууль авсан хэмээн ажилтныхаа эсрэг нэхэмжлэл гаргах боломжийг олгосон. Практикт хээл хахуулийн үйлдлээс шалтгаалан материаллаг хохирол учруулсан хэмээн нотлоход төвөгтэй байдаг.[13] Шигтгээ 10.2-т АНУ-д гэм хорийн жишээ, үндэслэлийг тайлбарласан болно.

Зөрчигдсөн эрхийг сэргээх

Авлигын улмаас олгоогүй, үндэслэлтэй хүлээгдэж буй ашиг, түүнчлэн нэн даруй тооцох боломжгүй эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг шүүхээр шийдвэрлэж болно.[14] Түүнчлэн шүүхээс нэхэмжлэгч хайхрамжгүй хандсан эсхүл ямар нэгэн ашиг хонжоо хайсан бол нэхэмжлэлийн нөхөн төлбөрийн хэмжээг бууруулж эсхүл бүр хэрэгсэхгүй болгож болдог.

---

[10] Жишээлбэл, Панам улсад гэмт хэрэг эсхүл хууль бус үйлдлээс үүдэлтэй гэм хорыг эрүүгийн болон иргэний журмаар нэхэмжлэх боломжтой. Франц мөн эрүүгийн шүүхээр гэм хорын хохирлоо нэхэмжлэхийг зөвшөөрдөг; Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Франц), 2 бүлэг. Швейцар улс гэмт хэргийн улмаас үүдсэн хохирлоо эрүүгийн журмаар нөхөн төлүүлэх боломж олгодог.

[11] Их Британи хариуцагч гэм хорын учруулахад оролцсон хэлбэрээ буюу хамтран хариуцагч оролцоогоо тайлбарлах шаардлага тавигддаг Act of 1978.

[12] Industries & General Mortgage Co. Ltd. v. Lewis [1949] 2 All ER 573 (UK).

[13] Жишээлбэл, Канн (Франц) хотын захиргаа авлигын хэргээр ял сонссон хотын захирагчаа шүүхэд өгсөн хэрэгт шүүх хотын захирагчийн тус албан тушаалд байхдаа өгсөн болон өгөөгүй тусгай зөвшөөрлөөс үүдэлтэй хохирлыг нийт хохирлын хэмжээ хэмээн үзсэн ба Хотын нэр хүндийг алдсаны улмаас учирсан хохирлыг 100,000 евро (ойролцоогоор 128,300 ам.доллар) гэж тооцсон.

[14] Жишээлбэл, авлигын хэргийн дуулианы улмаас хотын нэр хүндийг унагаасных нь төлөө Францын Канн хотын авлигыг хүлээн авсан дарга болон авлига өгсөн хүмүүсийг 100,000 евро төлөх талаар шүүхийн шийдвэр гарсан ((Brun et al. 2015, 92 [Шигтгээ 7.2]).

ШИГТГЭЭ 10.2 АНУ-ын рэкетийн нөлөөнд автсан болон авлигад идэгдсэн байгууллагуудын дүрэм (RICO)

Гадаад улсуудын Засгийн газар, эсхүл гадаадын иргэд авлигын болон бусад хууль бус үйлдлийн улмаас өөрт хохирол учирсан гэж үзвэл АНУ-д иргэний журмаар нэхэмжлэл гаргах боломжтой. АНУ-ын Гадаадын иргэн, улс гэм хороос үүдэх хохирлоо нэхэмжлэх тухай хууль (1789 онд батлагдсан)-ийн дагуу дотоодын хууль тогтоомж эсхүл АНУ-ын олон улсын гэрээг зөрчсөний улмаас хохирсон хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах боломжтой тул энэ хүрээнд авлига, залилан мэхлэх үйл ажиллагааны улмаас хохирсон хохирлоо нэхэмжилж болно.[a] Гадаад авлигын гэмт хэргийн тухай хуулийн[b] дагуу АНУ-ын төрийн аливаа байгууллага агентлагууд нь гадаадын албан тушаалтнуудад авлига өгөхийг хориглож эрүүгийн болон иргэний журмаар хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг учир захим тохиолдолд шүүхээс иргэний журмаар гэм хор нөхөн төлүүлэх эрхийг нь хааж болдог. Харин нэхэмжлэгч авлигын улмаас учирсан хохирлоо Далайлган сүрдүүлэгч ба авлигад автсан байгууллагын тухай (RICO-Racketeer Influenced and Corrupt Organizations) хуулийн дагуу нөхөн төлүүлэх боломжтой.[c]

RICO-ийн дүрмэнд рэкетлэх ажиллагаа явуулах, эсхүл хууль бус өрийг цуглуулах замаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохыг хууль бус гэж заасан байдаг. Уг дүрмэнд заахдаа рикетлэх ажиллагаа "суурь гэмт хэрэг"-т оруулан тооцсон бөгөөд үүнд хахууль, хулгай, хөрөнгө завших, албан тушаалаа ашиглан хясан боогдуулж мөнгө авах, залилах, шүүн таслах ажиллагаанд саад учруулах, мөнгө угаах зэрэг хэргүүд мөн орно. Суурь гэмт хэргүүд нь "ижил эсхүл төстэй зорилготой, үр дүнтэй, оролцогчидтой, хохирогчидтой эсхүл үйлдлийн арга барилтай" бол хэв маягийг бүрдүүлсэн гэж үздэг. 10 жилийн дотор хоёр удаа суурь гэмт хэрэг үйлдсэн хэрэгтэнд уг хууль хамаарна. Практикт, шүүхүүд RICO-д заасан хэргүүдтэй холбоотойгоор иргэний журмаар хариуцлага хүлээлгэх суурь нь FCPA-д заасныг зөрчих явдал гэж шүүхүүд үздэг. Гадаадын зарим улсад эдгээрийг шийтгэл хүлээлгэх боломжтой бөгөөд албадан хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үздэг боловч хохирлыг гурав дахин нугалж барагдуулах боломжтой байдаг. FCPA-ийн зөрчлийг иргэний RICO-ийн үйл ажиллагааны урьдчилсан үйлдэл болгон ашигласан амжилттай хэрэг бол Dooley v. United Technologies Corp.,[d] бөгөөд Саудын Арабын засгийн газрын төлөөлөгчид болон Дулигийн ажил олгогч, шүүгдэгч Сикорский болон Сикорскийн эцэг эх, United Technologies Corp, мөн Британийн хоёр яллагдагч, Саудын Арабын гурван шүүгдэгч зэрэг янз бүрийн хамтран хуйвалдсан хүмүүсийн хооронд хээл хахуулийн схем үүссэн байсан. Шүүх дүгнэхдээ "Дули FCPA болон Аялал жуулчлалын актуудыг зөрчсөн... гэх үндэслэлээр өөрийн RICO нэхэмжлэлийг гаргаж болно" гэж үзсэн бөгөөд "Саудын хариуцагчийн эсрэг ... Аялал жуулчлалын тухай хууль/FCPA-ийн зөрчлийг ... үйлдсэн гэх гомдол нь нэхэмжлэгчийг тогтооход хангалттай" гэжээ. Тиймээс, RICO-ийн хуулийн дагуу FCPA-г иргэний процессыгэхлүүлэх суурь гэмт хэрэг болгон ашиглах нь FCPA-ийн дагуу хувийн журмаар иргэний хэрэг үүсгэх шууд эрхгүй байдлыг шийдэж, нэхэмжлэгч хохирлоо гурав дахин ихээр нэхэмжлэх эрхээ эдлэх боломжийг олгож байна.[e]

Хэдий тийм боловч саяхан АНУ-ын Дээд шүүх RJR Nabisco, Inc. v. European Community (579 U.S. [2016]), хэрэг дээр RICO хуульд заасан нутаг дэвсгэрээс гадуурх хамрах хүрээтэй холбоотой зарим асуудлыг шийдвэрлэсэн. "Гадаад улсад суурь гэмт хэрэг нь үйлдэгдсэн бөгөөд рэкетийн хэв маяг бүхий байх ба эдгээр гэмт хэрэг тус бүр нь өөрөө нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн бол" RICO-д заасан

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

гадаад улсад үйлдэгдсэн рэкет үйл ажиллагаа гэж үзэж болно гэж дүгнэсэн. Гэхдээ энэхүү рэкет үйл ажиллагааны тухай хуульд "нутаг дэвсгэрээс гадуурх байдлын эсрэг таамаглалыг даван туулж чадахгүй" гэж заасан ч энэ нь иргэний нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлаж чадахгүй , учир нь "ямарч зүйл... Конгрессын зорилго бол АНУ-ын нутаг дэвсгэрийн гадна хохирсон амссаны улмаас иргэний журмаар арга хэмжээ авах эрхийг бий болгох" гэдгийг тодорхой харуулж байгаа юм".[f]

a. Гадаадын иргэн хохирол нэхэмжлэх тухай хууль (ATCA) буюу Гадаадын иргэний хохирол төлүүлэх тухай хууль (ATS) гэж нэрлэгддэг хуулийн дагуу дүүргийн шүүх нь зөвхөн гадаад иргэдээс АНУ-ын хууль тогтоомжийг зөрчсөн хэрэгт гаргасан хохирол төлүүлэх тухай нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх харьяалалтай байна. Хүний эрхийн зөрчил, гэмт хэрэг үйлдэгдсэн болон терроризмын гэмт хэрэгтэй холбоотойгоор гадаад улсын иргэн АНУ-ын шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд энэхүү хуулийг хэрэглэдэг байсан. (CRS 2018). Гэвч уг хуулийн хамрах хүрээг АНУ-ын Дээд шүүх хумьж, АНУ-ын нутаг дэвсгэрээс гадна (Kiobel v. Royal Dutch Petroleum Co., 569 U.S. 108, 120 [2013]). үйлдэгдсэн хэргүүдэд хамааралгүй болгож, зөвхөн олон улсын эрх зүйн зөрчлийн (Sosa v. Alvarez-Machain, 542 U.S. 692, 725 [2004]).Саяхан АНУ-ын дүүргийн шүүхээс (S.D.N.Y.) шийдэхдээ гадаад улсын корпорацийн эсрэг (Jesner v. Arab Bank PLC, 584 U.S. ¯ [2018]) нэхэмжлэл гаргахад дээрх хуулийг хэрэглэх боломжгүй талаар дүгнэлт гаргасан байна. RSM Production Corp. v. Fridman,-ий хэрэг дээр, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагыг Олон улсын бизнесийн хэлцэл хийхдээ гадаад улсын нийтийн албан хаагчийг хахуульдахтай тэмцэх тухай Конвенцийн заалтыг зөрчсөн эсэх талаар нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэгч нь хариуцагчийг "үндэсний хууль тогтоомж"-ийг зөрчсөн гэдгийг харуулж чадаагүй, учир нь хариуцагч бол авлига өгөгч нь биш авсан этгээд нь байсан гэж шүүх шийдвэртээ дүгнэсэн байна.ЭЗХАХБ-ын дээрх конвенцид үнэндээ идэвхтэй авлигын талаар (авлига амлаж байгаа, эсхүл өгч байгаа хүний үйлдсэн хэрэг) авч үздэг ба идэвхгүй авлигын (хээл хахууль авах замаар албан тушаалтнаас үйлдсэн хэрэг) талаар ярьдаггүй RSM Production Corp. v. Fridman, 643 F. Supp 2d 382 [S.D.N.Y 2009]). (Мэтт А.Вегагийн хэлснээр, "Ингэхдээ магадгүй [гадаадын] албан тушаалтнуудад учир битүүлэг төлбөр төлж буй хувь хүмүүс болон хариуцагч аж ахуйн нэгжүүд нь үндэсний хууль тогтоомжийг зөрчсөн байх боломжтой болохыг шүүх нээлттэй орхисон" (Vega 2010, 433). "Гадаадын албан тушаалтныг хээл хахуульдах хэргийг ойрын ирээдүйд дээрх Гадаадын иргэний хохирол төлүүлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах боломжтой гэж холбооны шүүхүүд дүгнэхийг тэдгээр хэргүүд санал болгож байна" гэж тэр мөн бичжээ (389). Эсрэгээрээ, FCPA нь нутаг дэвсгэрийн гадна үйлдэгдсэн хэргийн талаар өргөдөл гаргах боломжийг олгодог бөгөөд үндэстэн дамнасан корпорациуд холбогдсон гэмт хэргийн талаар үндэслэл болгон ашиглаж болно. (Spalding 2014). Гэхдээ, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Кондолиза Райсын НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн (UNCAC) талаар АНУ-ын Сенатад илгээсэн захидалдаа дараах зүйлийг дурдсан (Деминг 2010, 346 [тэмдэглэл 60]): "Энэ зүйлд заасан аль ч эрх [АЭК-ийн 35-р зүйл]-ийг АНУ-аас FCPA-д заасны дагуу нэхэмжлэл гаргах хувийн эрхийг бий болгохыг шаардаж байгаа, эсхүл Гадаадын иргэн хохирол нэхэмжлэх тухай хуулийн хүрээ хязгаарыг өргөтгөн гадаад улсын иргэд АНУ-ын шүүхэд хандаж, авлигын хэрэгтэй холбогдуулан нэхэмжлэл гаргахыг зөвшөөрөх шаардлагатай байна гэж тайлбарлах ёстой" гэжээ. Мөн АНУ Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон баталсан нь "Конвенцийн аль ч заалт нь хувийн арга хэмжээ авах талаарх эрхийг бий болгохгүй" гэдгийг тунхагласан хэрэг болсон.

b. Lamb v. Philip Morris, Inc., 915 F. 2d 1024 (6th Cir. 1990) хэрэгт АНУ-ын 6-р тойргийн Давж заалдах шатны шүүх шийдэхдээ, FCPA-д заасны дагуу хувийн арга хэмжээ авах боломжгүй байна гэж үзсэн.

c. Жишээлбэл, хотын захиргаанаас ойролцоогоор 24 сая ам.доллар гаргасан "сонгуулийн төлөөх зам" схемийн дагуу үйлдэгдсэн санал хураалтын дуулиантай холбоотой State of Indiana & the City of East Chicago v. Robert A. Pastrick, No. 3:04-CV-506, Mar. 11, 2010, хэргийг харна уу.

Шүүхийн зүгээс шүүгдэгч нарыг (а) хулгайлсан, хөрвүүлсэн, эсхүл залилан мэхэлж, хуйвалдаанаар олж авсан мөнгийг мэдсээр байж улс хоорондын арилжаанд шилжүүлэх, дамжуулах зэрэг олон удаагийн, үргэлжилсэн үйлдлээр RICO-г зөрчсөн; (б) Индианагийн "жижиг RICO" дүрмийг зөрчсөн; (в) хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнэн Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн дагуу иргэний хариуцлага хүлээлгэсэн. АНУ-ын дүүргийн шүүгч Жеймс Мүүди 108,007,584.33 ам.долларын хохирлыг нөхөн төлүүлсэн бөгөөд үүнд RICO-гийн зөрчлийн улмаас хохирлыг гурав дахин ихээр төлүүлэх болон муж улсын хуулийн дагуу нэхэмжлэлтэй холбоотой шүүхийн урьдчилсан хураамж багтсан байна.

d. 803 F. Supp. 428, 440, 441 (1992)-ийг харах.

e. Дуглас Р.Янг, "Гадаадын авлигын үйл ажиллагааны талаарх хууль ба иргэний хувийн нэхэмжлэл гаргах талаар" 2002 оны нийтлэлийг Farella Braun + Martel вэбсайтанд гарсан байсныг устгасан байна.

f. RICO-ийн журмаар иргэний нэхэмжлэл гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор гадаад улсад учирсан хохирлыг нөхөн сэргээх боломжийг олгох нь олон улсын түвшинд маргаан дагуулах магадлалтай болох талаар шүүх онцгойлон дурдсан байна.

Нийтийн эрх зүйн систем бүхий орнуудын хувьд, авлигын хэргээс үүдсэн (Шигтгээ 10.3-т үзүүлсэн шиг) хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр тогтоож нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.[15]

Хээл хахуулийн гэмт хэргийн хохирлыг тооцоход тодорхой бэрхшээл гарч болзошгүй. Зарим улс оронд учирсан хохирлын хэмжээг хээл хахуулийн үнийн дүнтэй дүйцүүлэн тооцдог боловч хээл хахуулийн журмаар гаргуулсан Засгийн газрын шийдвэр эсхүл гэрээний хувьд энэ энэ дүн хангалтгүй байх боломжтой. Өөрөөр хэлбэл бараа, үйлчилгээг зах зээлийн үнээс хэтрүүлсэн, эсхүл төрийн баялгийг зах зээлийн үнээс доогуур үнээр ашиглах, борлуулахыг зөвшөөрсөн байж болно. Түүнчлэн тийм гэрээ, шийдвэрийн дүнд нийгэм, байгаль орчинд хохирол учирсан байж болзошгүй.

Дээрх нөхцөл байдалд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо төрийн байгууллагууд авлига аваагүй бол хүрэх байсан үр дүн болон хууль бус гэрээг байгуулсны үр дүнд бий болсон алдагдлын зөрүүг тогтоох шаардлагатай. Зөвхөн Бараа, үйлчилгээний үнэ зах зээлийн үнээс өндөр байсан хэмээн учир хохирол учирсан хэмээн тооцоолох нь учир дутагдалтай. Шүүх давуу эрх олж авсан этгээд барааг зах зээлийн үнээр, үйлчилгээг чанартай хийсэн хэмээн үзэх боломжтой учир хохирлын тооцоог нарийвчлан гаргах шаардлагатай. Зарим нөхцөл байдал, зах зээлийн тодорхой лавлагаа мэдээлэл байхгүй тохиолдолд хохирлын хэмжээг тодорхойлох нь ялангуяа барилга байгууламж барих, тоног төхөөрөмж нийлүүлэх угсрах эсхүл оюуны хөдөлмөр шаардсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнүүдийн хувьд төвөгтэй.

ШИГТГЭЭ 10.3 Хөрөнгийг зориулалтын бусаар ашигласнаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх

Замбийн Ерөнхий прокурорын нэхэмжлэлтэй Meer Care, Desai нарт холбогдох (2007) маргаан[a] /энэ маргааныг 1-р бүлэг (Шигтгээ 1.4) ба 2-р бүлэгт (Шигтгээ 2.12) дэлгэрэнгүй тайлбарласан/ Лондоны Дээд шүүх 25 сая ам.долларыг зориулалтын бусаар зарцуулсан, буруугаар ашигласан гэх хангалттай нотлох баримтыг олж, Болгартай хийсэн зэвсгийн наймааны гэрээний дагуу Замби улс ойролцоогоор 21 сая ам. долларын төлбөр төлөх хууль ёсны үндэслэлгүй гэж үзжээ.

Эдгээр үйлдлийнхээ төлөө хариуцагчдыг гэм буруутайд тооцсон. Мөн тэд Бүгд Найрамдах Замби улсаас олгосон итгэмжлэлийн үүргээ зөрчсөн эсхүл ийм зөрчил гаргахад шударга бусаар тусалсан нь тогтоогдсон. Улмаар эд хөрөнгө завшсаны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хариуцлага тооцжээ. Дээд шүүх мөн гүйлгээнд оролцсон өмгөөлөгчдөд хариуцлага тооцсон ч давж заалдах журмаар тэдэнд холбогдох нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Хэрэг:
a. Att'y Gen. of Zambia v. Meer Care & Desai, [2007] EWHC 952 (Ch) (UK).

Ийм нөхцөлд санхүүгийн хохирлыг тогтоохын тулд (а) авлигал өгөгч ба авагч хоёрын хооронд байгуулсан нууц гэрээ байгуулсан гэх нотлох баримт, (б) техникийн болон нягтлан бодох бүртгэлийн тусламж, (в) эсхүл дээрх хоёул байгаа эсэхийг нь

[15] *Cameroon Airlines v. Transnet Ltd.,* хэрэг дээр арбитрын шүүх шийдвэрлэхдээ Камерун Эйрлайнс хээл хахууль авах замаар байгуулагдсан гэрээг хүчингүй болгож, нөхөн төлбөр авах эрхтэй гэж үзсэн боловч үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой "шударга үнэ цэнэ" нөхөн төлбөрт хамаарахгүй гэж дүгнэсэн. (Brun et al. 2015, 93 [Шигтгээ 7.4]).

шаардана.[16] 7 дугаар бүлгийн 7.3-т хохирлыг тооцох аргуудыг танилцуулсан бөгөөд үүний 7.3.4-т орлогыг үнэлэхэд тулгарч буй бэрхшээлүүдийг тусгасан болно.

Зарим улс оронд авлигын хэрэг үйлдэгдсэнээс хойш олон жилийн дараа илчлэгдэх үед шүүхээс авлигын гэрээний зүйлийг одоо үеийн үнээр тооцдог. Хохирлын хэмжээ нэхэмжлэгчийн нотлох баримтаар үндэслэн тоон үзүүлэлтээр гаргах ёстой (Мейер 2009).

Зарим улс орнуудад таагүй нөхцөлтэй гэрээ байгуулсан бөгөөд авлига өгсөн этгээд хохирогчийн хохирлыг хариуцаж болдог.[17] Зарим шүүх нь Захиалагчийн хуурамч гэрээний дагуу худалдаж авсан аливаа барааны бодит үнэ нь ядаж хээл хахуулийн дүнгээс доошгүй хэмжээгээр нэмэгдүүлсэн[18] байх энэ хэмжээнээс хэтэрсэн хохирол учирсан болох нь нотлогдсон байх ёстой гэж үздэг байна.[19]

Ажилтан-ажил олгогчийн харилцааны хүрээнд авлига авсан ажилтан, авлига өгсөн хүн аль аль нь ажил олгогчийн өмнө хариуцлага хүлээх ёстой[20] ба компани эргээд өөрийн ажилтан болон итгэмжлэгчийн төлөөлөгчийн буруутай үйлдлээс үүдэн гарсан хохирлыг бусад этгээдийн өмнө хариуцна.[21] Хохирлыг хэмжих нарийн хэмжигдэхүүн байхгүй тохиолдолд хээл хахууль хэмжээ,[22] дансны бүртгэл[23] эсхүл хууль бус хэв маягийг бүрдүүлсэн урьдчилсан үйлдлээс үүдэлтэй хохирол байж болно.[24] (Шигтгээ 10.4).

---

[16] Жишээлбэл, эдгээр нотлох баримт нь (а) хахууль өгөгч болон авч байгаа талууд ердийн үнэ цэнийг тодорхой хэмжээгээр эсхүл хувиар нэмэгдүүлэх талаар нууцаар тохиролцсон, (б) ижил төрлийн тендерийн үйл явц дахь өрсөлдөгчдийг харьцуулах, эсхүл (в) авлигажсан гэрээг байгуулах талаар ярьсан ярилцлагын тэмдэглэл, эсхүл уулзалтын талаарх тайлан хаана хэлэлцсэн зэргийг харуулсан байж болно.

[17] *Хэрэг: Salford Corporation v. Lever* (No. 2) (1891) 1 QB 168 (UK).

[18] Хэрэг: *Salford Corp. v. Lever (1891).*

[19] Хэрэг: Solland Int'l Ltd. v. Daraydan Holdings Ltd. [2002] EWHC 220 (TCC) (UK).

[20] Хэрэг: Williams Electronic Games, Inc. v. Garrity, 479 F.3d 904 (7th Cir. 2007) (АНУ-ын Давж заалдах шатны шүүх).

[21] Жишээлбэл, Германд компаниуд тэдний төлөөлөгч нарын үйлдсэн үйлдлийн төлөө захиргааны хариуцлага хүлээх боломжтой (Зохицуулалтын зөрчлийн тухай хууль, 30 дугаар хэсэг).

[22] Хэрэг: Continental Management, Inc. v. U.S., 527 F.2d 613, 620, 208 Ct. Cl. 501 (1975) (АНУ-ын Иргэний хэргийн шүүх).

[23] Нэхэмжлэгчид нөхөн олговор олгох, хариуцагчийг үндэслэлгүйгээр хөрөнгөжихөөс болон хууль тогтоомжийг санаатайгаар зөрчихөөс сэргийлдэг учир гэмт хэргийн замаар олсон ашгийг тодорхойлох нь учруулсан хохирлыг үндэслэлтэйгээр тодорхойлох хэмжүүр болно гэж АНУ-ын шүүхүүд дүгнэжээ.

[24] *County of Oakland v. Vista Disposal, Inc.,* 900 F. Supp. 879 (E.D. Mich. 1995) хэрэгт АНУ-ын дүүргийн шүүх шийдэхдээ, RICO-ийн хэргүүдэд учруулсан иргэний хохирлын хэмжээг тогтоохын тулд суурь гэмт хэргүүдийн улмаас учруулсан хохирлыг тогтоох шаардлагатай гэж дүгнэсэн. Тойргийн хэсгийн хог хаягдлыг боловсруулах тухай гэрээ байгуулсан хэрэгт хохирлын хэмжээг авлига оролцож тогтоосон үнэ болон авлигагүйгээр тогтоосон үнэ хоёрын зөрүүгээр тогтоогдсон.

ШИГТГЭЭ 10.4	Файффс Групп ХХК-ийн эсрэг Темплман болон бусад хүмүүсийн хэрэг (2000)

Дублинд төвтэй, гадил жимсний худалдаа эрхэлдэг Fyffes компаний ажилтан 1992-1996 оны хооронд тээврийн үйлчилгээний гэрээ хэлэлцээрээс 1.4 сая гаруй ам.долларын хахууль авсан нь мэдэгджээ.[a] АНУ-ын Дотоод орлогын албанаас хийсэн шалгалтаар дээрх ажилтан Кипрт бүртгэлтэй компаниараа дамжуулан АНУ-д мэдүүлэггүй төлбөр хийснээр хахууль илэрсэн байна.

Fyffes өөрийн ажилтан, тээврийн жууч болон түүний төлөөлөгчдөөс хохирлоо барагдуулахыг хүссэн ба авлигын нийт үнийн дүнг энэ этгээдүүд хамтран хариуцах ёстой гэж үзжээ.

Шүүхийн шийдвэрт "Файффсийн хувьд харьцангуй бага гэж үзэх байсан ачааны хэмжээг жил бүр тохиролцохдоо тэдний хүлээн авахад бэлэн байсан цэвэр дүнг [хээл хахуулийг] төлөх шаардлагатай байсан тохиолдлыг гүйцэтгэгч талын хувьд харгалзан үзэх тухай ямарч маргаан байж болшгүй юм" гэж дүгнэжээ.

Тээвэрлэлтийн компани болон түүний төлөөлөгч нар таагүй нөхцөлөөр гэрээ байгуулснаас болж Файффс хохирсон хохирлын нэмэлт төлбөрийг төлөх үүрэгтэй байсан. Хэрвээ ухаалаг, шударга хэлэлцэгчээр төлөөлүүлсэн байсан бол Файффс жил бүр ямар төлбөр төлөхөө зөвшөөрөх боломжтой

байх байсныг шүүх тогтоосон. 1992, 1994, 1995 онуудад бодит төлбөр өөр өөр байх байсан гэх нотлох ямарч баримт байхгүй байсан. Гэвч тэд 1993 онд 830,022 ам.доллар, 1996 онд 1,1 сая ам.долларaар инфляцид өртсөн талаар шүүхийн шийдвэрт тусгагдсан байна.

Гүйцэтгэгчээс олсон бүх ашиг нь "Хэрэв ажилтан шударга бус хандаагүй бол Файффс гэрээлэгчтэй үйлчилгээний гэрээ байгуулах магадлал өндөр байсан." учир бүтэлгүйтсэн.

Үүний үр дүнд гэрээний "ердийн" ашиг нь хээл хахуульд автсанаас бус "ямар ч тохиолдолд гэрээ байгуулах байсан үйлчилгээ үзүүлснээс" үүссэн байна.

Хэрэг:
a.: Fyffes Group Ltd. v. Templeman [2000] 2 Lloyd's Rep 643 (UK).

10.2.3. Гэрээг хүчин төгөлдөр бус, хэрэгжих боломжгүй, зөрчсөн хэмээн тооцсоноор үүдэн гарах үр дагавар

Үйлдлийн шалтгаан

Шүүх эсхүл арбитраас төрийн албан тушаалтнуудад хээл хахууль өгөх замаар аливаа гэрээ байгуулсан учир хууль бус хэмээн үзэж улмаар гэрээний үүргийг хууль бус эсхүл хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж болно.[25] Гэрээг авлигын өгч зөвшөөрүүлж, хууран мэхлэх замаар байгуулсан нь тогтоогдсон факт дээр үндэслэж хууль бус хэмээн үзнэ. (Шигтгээ 10.5).

[25] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 34 дугаар зүйлд тэдгээр арга хэмжээг гишүүн орнууд авахыг зөвшөөрсөн байдаг. Att'y Gen. of Turks and Caicos Islands v.Star Platinum Island Ltd. (Brun et al. 2015, 58 [box 4.8]) хэргийг мөн харна уу.

ШИГТГЭЭ 10.5	Файффс Групп ХХК-ийн эсрэг Темплман болон бусад хүмүүсийн хэрэг (2000)

Ираны үндэсний газрын тосны компани (NIOC) болон Crescent Petroleum Co. компаниуд Ираны хуулийн дагуу газрын хий худалдан авах, нийлүүлэх урт хугацааны гэрээ байгуулжээ. 2009 онд Crescent Petroleum болон түүний охин компани болох Crescent Gas Corp нь Ираны үндэсний газрын тосны компани ямар ч хий нийлүүлээгүй гэж мэдэгдэн арбитрын шүүхэд хандсан. Арбитрын шүүх Ираны үндэсний газрын тосны компанийн гэрээг хээл хахуулиар худалдаж авсан тул хэрэгжүүлэх боломжгүй гэсэн үндэслэлийг няцааж, Ираны үндэсний газрын тосны компани нь хий нийлүүлээгүйгээс гэрээг зөрчсөн гэж үзсэн байна.

Ираны үндэсний газрын тосны компани Английн Арбитрын хуулийн дагуу (1996) шийдвэрийг хүчингүй болгохоор шүүхэд давж заалдсан. 67 (бодит харьяаллыг эсэргүүцсэн) болон 68 (ноцтой зөрчил). Түүнчлэн гэрээг Crescent-ийн авлигын улмаас байгуулсан бөгөөд төрийн бодлогын үндэслэлээр түүнийг хэрэгжүүлэхээс татгалзаж байгуулсан гэрээг хүчингүй гэж мэдэгдэв.

Шүүх "Авлигын төлбөрийн талаар ярилцаж байсан ч хэзээ ч хүчин төгөлдөр болоогүй" гэж дүгнэсэн арбитрын дүгнэлтийг хүлээн авч нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгов. Түүнчлэн гэрээг хээл хахуулийн аргаар авсан гэх "шинэ нотлох баримт" байхгүй, "хээл хахууль авсан гэрээг биелүүлэхээс шүүхээс татгалзахыг шаарддаг англи улсын төрийн бодлого байхгүй" гэж үзсэн.

Мөн шүүгч "Худал, хууран мэхлэлт, заналхийлэл, түүнээс ч дор аль аль талдаа хүсээгүй үйлдэл хийсэн олон гэрээ байж болох ч шүүх эдгээр талуудын байгуулсан гэрээнд хөндлөнгөөс оролцохгүй" гэж дүгнэжээ.

Хэргүүд:
a. National Iranian Oil Co. v. Crescent Petroleum Co. Int'l Ltd. & Gas Corp. Ltd. (2016) EWHC 510 (Comm), para. 3, https://www.
uncitral.org/docs/clout/GBR/GBR_040316_FT.pdf#.
b. National Iranian Oil v. Crescent, 4 дэх догол.
c. National Iranian Oil v. Crescent, 39 дэх догол .
d. National Iranian Oil v. Crescent, 37 дахь догол.
e. National Iranian Oil v. Crescent, 48, 49(2), 49(3) дахь доголууд.
f. National Iranian Oil v. Crescent, 49(3) дахь догол.

Зарим улс оронд гэрээг зөрчиж байгуулсан гэж үздэг ба ялангуяа гэрээний заалтад илт байгуулах эрх олгох, гүйцэтгэхтэй холбогдуулан төрийн албан тушаалтныг өдөөн хатгах арга хэмжээ авахгүй гэж гэрээнд заасан заалтуудыг оруулсан бол гэрээг зөрчих өөр нэг шалтгаан болдог.

Гэрээг хүчингүй болгох, зөрчсөн тохиолдолд хохирлыг нөхөн сэргээх

Гэрээг хүчингүй болгох, зөрчихөд учирсан хохирлыг арилгах аргад гэрээг цуцлах, нөхөн төлбөр, санамсаргүй хохирол болон хохирол зэрэг мөнгөн хохирол орно.

Зарим тохиолдолд шүүх өмнө нь төлсөн гэрээний төлбөрт учирсан хохирлыг хязгаарлаж, төлөөгүй төлбөрийг хассан байдаг.[26]

Гэрээг цуцлах нь зарим улс оронд, ялангуяа хээл хахууль, тендерийн тохиролцооны үед боломжтой байдаг (Шигтгээ 10.6)[27].

Гэрээг цуцлах тухай нэхэмжлэлийн шаардлагад төрийн байгууллага ямар нэгэн залилан мэхлэхгүйгээр гэрээнээс татгалзах байсан гэдгийг нотлох баримт шаардлагатай. Хэрэв гэрээг цуцлах нь хүссэн арга хэмжээ биш бол төрийн байгууллага зөрчлийг үүсгэсэн үйлдэл байхгүй тохиолдолд тохиролцсоноос бага таатай нөхцөлөөр гэрээ байгуулсны улмаас хохирлыг барагдуулах эрхтэй болно.

Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээнээс үүдэн гарсан маргаанд "төрийн хариуцлага" гэсэн зарчмыг харгалзан үзэж болно (Raeschke-Kessler and Gottwald 2008). Үүний үр дүнд авлигын улмаас үүссэн хууль бус байдал, зөвшөөрлийн доголдлыг үл харгалзан гэрээ хүчинтэй хэвээр байх боломжтой бөгөөд хохирлыг арилгах, гэрээг өөрчлөх, үнийг бууруулах замаар нөхөн сэргээх арга хэмжээ авах ёстой. (Davis 2009). Нөгөөтэйгүүр, "олон улсын төрийн бодлого" (мөн олон улсын төрийн бодлого гэж нэрлэдэг) нь гэрээ байгуулахаас зайлсхийхэд дэмжлэг үзүүлэхэд ашиглагдаж байсан - жишээлбэл, Хөрөнгө оруулалтын маргааныг зохицуулах олон улсын төвд (ICSID) өмнө нь Кени Улсын хэрэг дээр. Арбитрын зөвлөл (Шигтгээ 10.7)[28].

ШИГТГЭЭ 10.6 Гвиней: Симандоу төмрийн уурхайн олборлолтын эрхийн гэрээг цуцалсан тухай

2008 онд Гвинейн Засгийн газар дэлхийн хамгийн том төмрийн хүдрийн ордуудын нэг болох Симандоугийн төмрийн хүдрийн уурхайн хоёр блокийг Израилын уул уурхайн магнат Бени Штайнметзийн мэдэлд байдаг BSG Resources (BSGR) компанид олгосон.[a] BSG Resources (BSGR) компани өөрийн Симанду дахь уурхайн ашиглах эрхийг хамгаалахын тулд тухайн үеийн Гвинейн ерөнхийлөгч Лансана Контегийн дөрвөн эхнэрийн нэг Мамадие Туред хэд хэдэн авлига өгсөн. Гвинейн засгийн газраас нийтэлж, гарын үсэг зурж баталгаажуулсан тунхаг бичиг Мамадие Туре тус компанид Гвинейд төмрийн хүдэр олборлох эрхийг авахад нь тусалж, Ерөнхийлөгч Контэд нөлөөлөх зорилгоор 5.3 сая ам.долларын авлига авсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.[b]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[26] *S.T. Grand, Inc. v. City of New York,* 32 N.Y.2d 300, 344 N.Y.S.2d 938 (US) хэрэг дээр шүүх шийдвэрлэхдээ,. Нью-Йорк хотын усан санг цэвэрлэх гэрээг байгуулах эрхийг олж авахын тулд хахууль өгсөн гэрээлэгчийг төлөөгүй төлбөрөө буцаан олж авахгүй гэж шийдвэрлэсэн боловч худалдагч талд аль хэдийн төлсөн бүх төлбөрөө хот буцааж авах боломжтой байсан. Бусад шүүхүүд хотын захиргаа зөвхөн хууль бусаар байгуулсан гэрээний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй гэж үзсэн. Гэрээ зөвхөн хууль бусаар байгуулагдсан нөхцөлд түүний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх хотын захиргаанд үүснэ гэж бусад шүүхүүд үзсэн байна.

[27] *Ross River Ltd. v. Cambridge City Football Club Ltd.* [2007] EWHC 2115 (Ch) (UK) хэргийг харна уу. Нэмж хэлэхэд, тендерийн үйл явц дахь өрсөлдөөнийг бууруулах зорилгоор зуучлах ажиллагааг хийх тухай гэрээг байгуулсан төрийн байгууллагууд нь гэрээг цуцлах, эсхүл хохирлын талаар тодорхой эрх эдэлнэ гэж Францын шүүхүүд гэж дүгнэсэн байна.

[28] Хүчингүйд тооцох талаар үндэсний хууль тогтоомжоор зохицуулаагүй нөхцөлд олон улсын арилжааны арбитр нь энэ үр дүнг баталгаажуулах эсэх нь тодорхойгүй байна.

ШИГТГЭЭ 10.6 Гвиней: Симандоу төмрийн уурхайн олборлолтын эрхийн гэрээг цуцалсан тухай

2010 онд сонгогдсон Ерөнхийлөгч Альфа Кондегийн удирдлага дор Гвиней уул уурхайн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2011 оноос өмнө тус улсын байгуулсан уул уурхайн гэрээнүүдийг хянан шалгаж эхэлсэн.[c] Шалгалтын ажиллагааг хийх үүргийг хээл хахуулийн хэргийг шалгах тусгай хороонд (Comité Technique de Revue des Titres et Conventions Miniers [CTRTCM]) өгсөн.[d] 2014 оны 4-р сард тус хороо BSG Resources (BSGR) болон VBG компаниудад олгосон Симандоу дахь орд газрын лиценз нь авлигатай холбоотой хэмээн дүгнээд тэдэнтэй байгуулсан гэрээг цуцлахыг зөвлөжээ.[e] Хорооны зөвлөмжийн дагуу Гвинейн засгийн газар Симандоу дахь олборлолтын эрхийг цуцалсан.[f]

Үүний хариуд BSGR өөрийн буруутай үйлдлийг үгүйсгэж, Бүгд Найрамдах Гвиней улсын эсрэг Хөрөнгө оруулалтын маргааныг зохицуулах олон улсын төвд (ICSID) арбитрын ажиллагаа эхлүүлсэн.[g] 2019 оны 2-р сард Гвинейн засгийн газар, Бени Штайнметц нар Симандоугийн талаар маргаан дээр эвлэрч, BSGR нэхэмжлэлээсээ татгалзан, хоёр тал цаашид үргэлжлэх маргаан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзсан байна.[h]

a. Global Witness. 2014. "Гвинейн 'Зууны гэрээ'" тайлан, 2014 оны 5-р сарын 13. https://www.globalwitness.org/en-gb/reports/guineas-deal-century/. 2010 онд BSGR Симандоугийн уурхайн хувьцааны 51 хувиа Бразилийн уул уурхайн Vale компанид 2.5 сая ам.долларааp худалдсан.
b. 2014 онд Флоридагийн Жексонвилл дахь гурван үл хөдлөх хөрөнгө болон ресторан тоног төхөөрөмжийг хураан авах ажиллагааг АНУ эхлүүлсэн. U.S. v. 4866 Yacht Basin Drive (Case No. 3:14-cv-1428-TJC-PDB) хэргийг болон Rem дахь хураан авах ажиллагаа хийлгэх талаар өөрчлөлт оруулж баталгаажуулсан гомдлыг үзнэ үү. (АНУ-ын дүүргийн шүүх, Флоридагийн Төвийн дүүрэг, Жексонвилл хэлтэс). 2016 оны 2-р сард Туре болон АНУ-ын эрх баригчид эд хөрөнгө нь гэмт хэргийн, тодруулбал хахуулийн хэргийн улмаас бий болсон орлого гэдгийг мэдсээр байж гэрээ байгуулахаар тохиролцсон. Үл хөдлөх хөрөнгийн хоёрыг нь болон ресторан тоног төхөөрөмжийг хураан авсан бөгөөд гурав дахь өмчийн талаар гаргасан нэхэмжлэлийг АНУ хэрэгсэхгүй болгосон байна. U.S. v. 4866 Yacht Basin Drive (Case No. 3:14-cv-01428) (M.D. Fla) хэргийг болон Төлбөрийн гэрээ (2016 оны 2-р сарын 01), Хураан авахыг зөвшөөрсөн шүүхийн шийдвэр (2016 оны 4-р сарын 04)-ийг тус тус харна уу.
c. Барбара Льюис. 2019. "Steinmetz' s BSGR Settles Guinea Row, Looks to Zogota Iron Ore." бүтээл, Ройтерс, 2019 оны 2-р сарын 25. https://www .reuters.com/article/guinea-bsgr/update-3-steinmetzs-bsgr-settles-guinea-row-looks-to-zogota-iron-ore-idUSL5N20K1QG.
d. Guinee Diversité, "Le Comité de Revue Recommande la Retrait de la Convention de BSGR pour ''Corruption" [Хяналтын Хороо "Авлигын тухай" BSGR конвенцийг эгүүлэн татахыг зөвлөж байна], Уул уурхайн нэр, конвенцийн хяналтын техникийн хорооны мэдэгдэл, 2014 оны 4-р сарын 4,https://guineediversite.com/index.php/2014/04/09/090414le-comite-de-revue-recommande-la-retrait-de-la-convention-de-bsgr-pour-corruption-declaration-2/.
e. Guinée Diversité, "Le Comité de Revue," 2014 оны 4-р сарын 4. Мөн Jeune Afrique, "La Guinée Retire Les Permis de BSGR" [Гвиней BSGR зөвшөөрлийг цуцалсан], 2014 оны 4-р сарын 21, https://www.jeuneafrique.com/164220/economie/la-guin-e-retire-les-permis-de-bsgr/.
f. Барбара Льюис, "Steinmetz's BSGR Settles", 2019 оны 2-р сарын 25.
g. BSG Resources Ltd. (захиргааны хувьд), BSG Resources (Гвиней) Ltd., болон BSG Resources (Гвиней) SARL v. Бүгд Найрамдах Гвиней (ICSID Хэргийн дугаар. ARB/14/22), http://icsidfiles.worldbank.org/icsid/ICSIDBLOBS/OnlineAwards/C3765/DS11530_En.pdf.
h. Саймон Гудли. 2019. "Бени Штайнметз Төмрийн хүдрийн төслийн талаарх Гвинейтэй үүссэн маргаанаа шийдвэрлэв." Guardian, 2019 оны 2-р сарын 25.
https://www.theguardian.com/business/2019/feb/25/beny-steinmetz-settles-dispute-guinea-iron-ore-simandou.

ШИГТГЭЭ 10.7	World Duty Free Company Limited-ийн эсрэг Бүгд Найрамдах Кени Улсын хэрэг (2006)

1989 онд Кени Улс World Duty Free Company компанитай Найроби болон Момбаса хотуудын олон улсын нисэх онгоцны буудлын цогцолборуудын барилга угсралт, засвар үйлчилгээ, ашиглах, татваргүй бараа худалдах эрх олгох гэрээ байгуулжээ. Гэрээ байгуулах эрхийг авахдаа World Duty Free компани тухайн үеийн Кенийн ерөнхийлөгч Даниел Арап Моид хахууль өгсөн нь тогтоогдсон байдаг.

Дараа нь 1998 онд World Duty Free-ийг Кени улсын Дээд шүүхээс маргаан бүхий өмчийн эрх хүлээн авагчаар тогтоож, улмаар тус шийдвэрийг 2001 онд албажуулан, хууль ёсны шийдвэр, тогтоол гарч, өмчлөх эрх тус компанид шилжүүлсэн.

Дээрх шийдвэр гарахаас өмнө World Duty Free Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ICSID)-д Кени улс хууль бус эрх шилжүүлэх захирамж гаргах замаар гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлээгүй гэж мэдэгджээ. Харин Кени Улсын Засгийн газар World Duty Free-тэй хийсэн гэрээ хахууль өгөх замаар байгуулсан гэрээ ба гэрээний маргаан гарсан тохиолдолд хэрэглэх Англи болон Кени улсын хууль тогтоомж, олон улсын нийтлэг үзэл баримтлалд харш тул бид гэрээний үүргийг биелүүлэхээс зайлсхийх хууль ёсны эрхтэй гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв Кени улсыг гэрээний үүргээс хууль ёсны дагуу татгалзах эрхтэй ба зайлсхийсэн үйлдэл нь хууль ёсны байна хэмээн үзжээ.[a]

Хэрэг:
a. World Duty Free Co. Ltd. v. Republic of Kenya (ICSID Case No. ARB/00/7, Award of October 4, 2006).

Транспэрэнси Интернэшнл зэрэг төрийн бус байгууллагуудаас (ТББ) засгийн газар төрийн байгууллагаас зарласан тендерт оролцогчид төрийн албан тушаалтнуудад авлига өгөхгүй байх амлалтыг зөрчсөн тохиолдолд оногдуулах шийтгэлийг хүлээн зөвшөөрсөн талаар нийтэд урьдчилан мэдэгдэх буюу тийм гэрээ /хариуцлагын/ байгуулахыг зөвлөдөг мөн уриалдаг[29]. Дээрх байгуулсан гэрээнээс хамааран шүүх болон арбитр гэрээг цуцлах, хүчин төгөлдөр бусад тооцох, үүрэг гүйцэтгүүлэгч болон өрсөлдөж буй тендерт оролцогчдод учирсан хохирлыг хариуцах, зөрчигчийг зохих хугацаанд хариуцлага тооцох зэрэг багтана. Гэрээнд хохирлын хэмжээг тогтоох хэт ээдрээтэй маргаан үүсэхээс зайлсхийж гэрээний орлого, ашгийн тодорхой хувийг эсхүл хахуульд зарцуулсан мөнгийг 200-300 дахин үржүүлэх замаар "нөхөн төлбөр"-ийг урьдчилан тооцох заалтуудыг оруулж болно.

Хэдийгээр энэ жишиг шинэлэг арга хэмжээ болоод хэрэглээ нь хязгаарлагдмал боловч Аргентин, Хятад, Колумб, Эквадор, Герман, Энэтхэг, Мексик, Пакистан зэрэг орнуудад дээрх гэрээг ашиглаж байна. Гэрээг байгуулснаар Засгийн газарт төрийн албан тушаалтнуудын авлигын замаар олж авсан хууль бус төлбөр эсхүл тийм байдлаар олж авсан давуу байдлаас үүдэн гарсан хохирлыг нөхөн сэргээхэд тусалдаг. Нэмж дурдахад, авлигын эсрэг заалтуудыг гэрээнд тусгах талаар хуулийн мэргэжилтнүүд нухацтай хандах нь зүйтэй бөгөөд энэ нь авлигын эсрэг арга хэмжээ авах, түүний дотор гэрээг хүчингүй болгох эсхүл гэрээний хохирлыг арилгах үр дүнтэй арга замыг бий болгож чадна.

[29] Трансперинси Интернэшнл, “Integrity Pacts,” https://www.transparency.org/en /tool-integrity-pacts.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ хүчингүй болсны үр дагавар

Хээл хахуулийн замаар байгуулсан гэрээг хүчингүй болгохтой холбоотой хууль эрх зүйн ойлголт нь улс орон бүрт харилцан адилгүй байж болно. Гэсэн хэдий ч ихэнх улсын хуульд гэрээний хүчин төгөлдөр байх нөхцөлийг заасан байдаг. Тэдгээр хуульд заасан нөхцөлийг дагаж мөрдөөгүйгээс гэрээг хүчин төгөлдөр бусд тооцох боломжтой. Харин гэрээг авлигын замаар байгуулсан нь тогтоогдвол бүхэлд нь эсхүл авлигын замаар байгуулсан буюу авлига өгсөн хэмээн тогтоосон тэр өдрөөс хүчин төгөлдөр бус хэмээн тооцно[30].

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хувьд эдийн засгийн томоохон үр дагаварт хүргэж болзошгүй учир үндсэн буюу цорын ганц хууль эрх зүйн гарц бол гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах юм. Өөрөөр хэлбэл, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцсоноор зөвхөн төр ба гүйцэтгэгч хоёрын хооронд байгуулсан үндсэн гэрээг хөндөөд зогсохгүй гэрээтэй холбоотой бусад бүх гэрээний харилцааг хүчингүй болгож болзошгүй юм. (De Michele, Prats, and Revol 2018) Зарим улс оронд шалгарсан гэрээг хүчингүй болгосноор дэд бүтцийн томоохон ажлуудыг саатуулж, туслан гүйцэтгэгч нарын төлбөрийг саатуулж, улмаар дампуурах, олон мянган ажилчдыг ажлаас халах шалтгаан болж байна.[31]

ШИГТГЭЭ 10.8 Хуулийн болон захиргааны арга замаар гэрээг хүчингүй болгохоос өөрөөр хохирлыг төлүүлэх жишээ

Колумб: 2018 оны 1-р сарын 15-ны өдрийн 1882 тоот хууль, 20 дугаар зүйл, захиргааны болон шүүхийн журмаар гэрээг хүчингүй болсон тохиолдолд,

- Гүйцэтгэгчид зардал, хөрөнгө оруулалт, гарсан зардал, түүний дотор хүүгийн[a] шинэчилсэн үнэ цэнийг нөхөн төлөх ёстой;
- Хууль бус үйлдэл гаргасан концесс эзэмшигч нь тохиролцсон торгуулийн зүйлд заасан хэмжээг, хэрэв харилцан тохиролцоогүй бол гэрээний үнийн дүнгийн 5 хувийг төлөх ёстой.

Панам: Одебрехт компанийн авлигын дуулианы[b] дараа Панамын засгийн газар хэд хэдэн арга хэмжээг багтаасан үйл явцыг эхлүүлсэн

- Одебрехт компанийг цаашид буюу ирээдүйд засгийн газрын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нээлттэй тендерт оролцохыг хориглох, шалгарсан тохиолдолд гэрээ байгуулахгүй байх.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[30] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 34 дугаар зүйлд "Оролцогч улсууд авлигын гэрээг хүчингүй цуцлах буюу хүчингүй болгох, концесс болон бусад адилтгах баримт бичгээс татгалзах, эсхүл эрх зүйн хамгаалалтын аливаа бусад арга хэмжээ авахад эрх зүйн ажиллагааны холбогдох хүчин зүйл мөн гэж үзэж болно" гэж заасан. Үүнтэй нэгэн адилаар, Европын Зөвлөлийн (COE) Авлигатай тэмцэх иргэний эрх зүйн конвенцийн 8-р зүйлд "Авлигын гэмт хэрэг үйлдэх замаар байгуулагдсан гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар гэрээний бүх талууд шүүхэд хандах боломжийг гишүүн орнууд нь өөрийн дотоодын хууль тогтоомждоо тусгана" гэж заасан.

[31] Кристиан Лучеси, Фелипе Маркес, Алин Оямада, 2018. "Зээлийн хэлцэл боломжгүй болох нь нотлогдож байгаа тул Одебрехт өр төлбөрөөс чөлөөлөгдөнө." Блүмберг, 2018 оны 4-р сарын 24, https://www.bloomberg.com/news/articles /2018-04-23/odebrecht-is-said-likely-to-miss -payment-on-debt-due-this-week; болон Мак Марголис. 2018. "Латин Америкийн авлигын эсрэг тэмцэл үнэгүй зүйл биш". Блүмберг, 2018 оны 3-р сарын 26. https://www.bloomberg.com/opinion/articles/2018-03-26/latin-america -s-anti-corruption -fight-can -hurt-economic-growth. –ийг үзнэ үү.

ШИГТГЭЭ 10.8 Хуулийн болон захиргааны арга замаар гэрээг хүчингүй болгохоос өөрөөр хохирлыг төлүүлэх жишээ

- Одебрехт уг станцыг эхлүүлэхэд дорвитой материаллаг алхам хийгээгүй байгаа учир нэг тэрбум орчим ам.долларын үнэ бүхий УЦС-ыг барьж байгуулах тухай Засгийн газар болон Одебрехт хоорондын хамтын ажиллагааны гэрээг цуцлах.[c]
- Хийгдсэн болон хийж буй ажлуудын үнэ цэнийг хадгалах, бий болсон ажлын байрыг хадгалах, ажил дуусахаас шалтгаалж эдийн засаг, нийгмийн хөгжлийг баталгааг хангах арга хэмжжээ авах.
- Odebrecht гэм буруугаа хүлээсэн гэрээнд гарын үсэг зурж, 22 сая ам.долларын торгууль төлүүлэх шийдвэр гарсан.[d]

Перу: 30737 дугаар хуулийн дагуу "авлига, түүнтэй холбоотой гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохирлыг /иргэний эрх зүйн/ Перу улсын талд нэн даруй төлж барагдуулах" үүрэгтэй бөгөөд авлигын гэмт хэргийн гэм буруутайн тогтоогдсон болон эсхүл мөрдөн байцаалтад байгаа компаниудын хэрэгжүүлж буй төслүүдийг шилжүүлэх механизмыг бий болгосон. Үүнээс гадна дөрвөн тусгай арга хэмжээг тусгасан болно. Үүнд

- Тухайн улсад оруулсан хөрөнгө оруулалтаар олсон хөрөнгө, эсхүл хөрөнгө оруулалтаас олсон ашиг, ногдол ашгийг гадаад руу шилжүүлэхийг түр зогсоох.
- Компанийн хөрөнгө, эрх, хувьцаа, эрхийг төлөөлсөн бусад үнэт цаасыг захиран зарцуулахын тулд урьдчилан зөвшөөрөл авах, түүнчлэн тухайн компанийг худалдан авах бол компанийн нийт үнэлгээний 50 хувийг худалдан авагч иргэний журмаар бусад төлөх нөхөн төлбөр болон татварын өр төлбөрийг төлж дуустал тухайн улсад байршуулах, түүнчлэн компанийн хөрөнгөтэй холбоотой улсын бүртгэлд урьдчилан сэргийлэх бүртгэл хийх буюу зөвшөөрлийн дагуу шилжүүлэх.[e] (мөн тэдгээр хөрөнгийг улсын бүртгэлд урьдчилан сэргийлэх бүртгэлийг хийх процессыг бий болгох)
- Нөлөөлөлд өртсөн субъектүүд болон тэдний оролцож буй компаниуд эсхүл консорциумуудын ашиг тусын тулд Перугийн мужаас төлөх төлбөрийн 10 хүртэлх хувийг цэвэр ашгийн хэмжээг суутган авах тухай заалт [f]
- Гэмт хэргийн улмаас үүсэх эрх зүйн үр дагаврыг бууруулах, түдгэлзүүлэх, багасгах, иргэний хохирлыг барагдуулах зорилгоор ял наймаалах гэрээ байгуулах.

Цаашилбал, хуульд шаардлагатай бичиг баримттай танилцах, арга хэмжээ авах эрх бүхий этгээдийг томилох, түүний эрх үүргийг хуульчилж өгсөн. Эцэст нь уг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хуулийн этгээдийг Перу улстай гэрээ байгуулахыг хориглоно гэж заасан.

a. Гэхдээ энэ үнэлгээнд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн талын цалин хөлс, түүний гүйцэтгэлийн төлбөр болон гэрээг хугацааны өмнө цуцалсны улмаас гуравдагч этгээд гүйцэтгэгчид оногдуулсан торгуулийг багтаан оруулаагүй.
b.Одебрехт гэрээ байгуулахын тулд авлига өгсөн гэдгээ АНУ-ын эрх баригчдын өмнө хүлээн зөвшөөрчээ (АНУ-ын Хууль зүйн яам Шударга ёс. 2016. "Одебрехт, Браскем нар түүхэн дэх хамгийн том гадаад хээл хахуулийн хэргийг шийдвэрлэхийн тулд дэлхийн хэмжээнд дор хаяж 3.5 тэрбум долларын торгууль төлөхийг зөвшөөрч, гэм буруугаа хүлээн зөвшөөрч, байна." Хэвлэлийн мэдээний дугаар. 16-1515, 2016 оны 12-р сарын 21. https://www.justice.gov/opa/pr/odebrecht-and-braskem-plead-guilty-and-agree-pay-least-35-billion-global-penalties-resolve

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 10.8	Хуулийн болон захиргааны арга замаар гэрээг хүчингүй болгохоос өөрөөр хохирлыг төлүүлэх жишээ

c. Ройтерс. 2016. "Авлигын дуулианы улмаас Одебрехтийн гэрээг Панам Улс цуцална." Ройтерс Дэлхийн мэдээ, 2016 оны 12-р сарын 27. https://www.reuters.com/article/us-panama-corruption-idUSKBN14H072.
d. Прокурорын газрын мэдээлснээр, "Ял наймаалцах хэлэлцээр" болон Бүгд Найрамдах Панам Улсын Ерөнхий хяналтын газраас гаргасан техникийн тайлантай холбогдуулан тус компани шилжүүлбэл зохих төлбөрийг хийх, түүний ажилтан, албан тушаалтан эсхүл аутсорсинг авсан гуравдагч этгээдийн аль нэг нь мэдсэн байж болох, түүнчлэн АНУ-ын Хууль зүйн яам болон Бразилийн Прокурорын газарт аль хэдийн мэдэгдсэн байж болох харьяалалтай холбоотой аливаа факт зэрэг Панамтай холбоотой бүх мэдээллийг өгөх үүрэг хүлээсэн байна.
e. Хуулинд зарим онцгой тохиолдлуудыг, тухайлбал, 2017 онд хүчин төгөлдөр болсон 003 дугаартай онцгой байдлын тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнө хийсэн мөнгөн шилжүүлэг, гэмт санаа зорилготой болох талаар нотлох баримттайгаас бусад тохиолдлуудыг тодорхойлж өгсөн байна. Mena болон Bravo-г үзнэ үү (2019), https://thelawreviews.co.uk/edition/
the-anti-bribery-and-anti-corruption-review-edition-8/1210835/peru.
f. 30737 дугаар хууль, 6-р зүйл. https://busquedas.elperuano.pe/normaslegales/ley-que-asegura-el-pago-inmediato-de-la-reparacion-civil-a-f-ley-n-30737-1624757-1/.

Түүнчлэн Бразил улсын Лава Жато (Машин угаах) кэйсд ТХХТ-ийн гэрээг хүчингүй болгосноор 90 тэрбум риал буюу 27 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний ажил үйлчилгээ зогсоход хүргэсэн гэж мэдээлж байна.[32] Үүнтэй адилаар Перу улсад Odebrecht-ийн дуулианаас шалтгаалан 562 туслан гүйцэтгэгч компани өртсөнөөс 175 нь 2017 онд машин техник, барилга байгууламж, тээврийн хэрэгслээ алдан дампуурлаа зарласан бол бусад нь 2018 оны эхний улиралд ижил төстэй нөхцөл байдалд орсон байна. Цаашилбал, 2017 оны хоёрдугаар сарын байдлаар Одебрехтийн туслан гүйцэтгэгч нарт төлөх ёстой 260 сая ам.доллар төлбөр хийгдээгүй улмаас төсөлд ажилладаг 60,000 орчим ажилчдыг ажлаас нь халжээ.[33] Эдгээр үр дагавар нь хөрөнгө оруулалтыг бууруулж, салбарын үйл ажиллагаа доголдоход хүргэж болзошгүй юм.

10.2.4 Хууль бусаар буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн асуудалд авах арга хэмжээ

Хууль бус, ёс зүйгүй үйлдлээр олсон ашгийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл нь хууль бус үйлдэл хийж үндэслэлгүйгээр баяжсан нь хэн ч ашиг хүртэх эрхгүй гэсэн хууль болон ёс суртахууны зарчимд суурилдаг (Шигтгээ 10.9). Хохирогч хохирол амсаагүй эсхүл өөр ямар нэгэн байдлаар эрх зүйн байдал нь дордоогүй байсан ч шүүхээс хууль бус аргаар олсон ашгийг буцааж өгөхийг даалгаж болно.[34]

Зарим орны шүүхүүд аливаа хохирол учирсан эсэхээс үл хамааран авлига авсан нь шударга бус үйлдэл бөгөөд эрүүгийн хариуцлага болон иргэний журмаар[35] хохирол нөхөн төлүүлэх, нэхэмжлэх үндэслэл болдог. Түүнчлэн авлига өгсөн хүн авлигын

[32] Рене Перейра. 2017. "Operação Lava Jato deixa mais de R$ 90 bi em paradas" [Зогсоосон ажилд 90 тэрбум гаруй R$-ийг Lava Jato ажиллагаанд зарцуулсан.]. Estadao, 2017 оны 6-р сарын 18. https://economia.estadao.com.br /noticias/geral,operacao-lava -jato-deixa -mais-de-r-90-bi-em-obras-paradas,70001846435.

[33] La República. 2018. "Hay 60 mil trabajadores despedidos por causa Odebrecht" [Odebrecht-ооc болж 60 мянга ажилтан ажлаасаа халагдсан байна]. 2018 оны гуравдугаар сарын 3. https://larepublica.pe/politica/1206155-hay-60-mil-trabajadores -despedidos -por-causa-odebrecht/.

[34] Зарчмын хувьд, Германы иргэний хуулийн үзэл баримтлал нь агент эсхүл буруутай этгээд нь хахуулийн улмаас олсон орлогыг өөртөө үлдээх эрхгүй гэсэн үзэл юм.

[35] Хэрэг: Dubai Aluminum Company Ltd. v. Salaam [2002] All ER (D) 60 (Dec) (UK).

хэмжээг тогтоох үүрэгтэй буюу хээл хахуулийн хэмжээг хохирол хэмээн үзэж нөхөн төлүүлнэ.

Гэрээ гүйцэтгэгч нь албан тушаалтанд авлига өгсний дараа олсон хууль бус ашгийг тус гэрээ хийсэн улсын шүүхийн шийдвэрээр, гэрээ гүйцэтгэгчийн бүртгэлтэй улс болон өөр бусад улсын нутаг дэвсгэрт хийсэн төлбөр тооцоог царцаах, хурааж авах боломжтой. (OECD and World Bank 2012). Энэ тохиолдолд авлигын замаар байгуулсан гэрээний улмаас олсон орлого, хөрөнгийг буцаах, нөхөн төлүүлэхийг нэг орноос нөгөө оронд шаардах асуудал маргаан дагуулдаг (Oduor et al. 2014). Хууль бус гэрээ цуцлуулах ажиллагаа нь заавал хохирол учирсан байхыг шаарддаггүй ба хууль бус гэрээгээр олсон ашиг хэмээн өөр улсын шүүхээр тогтоолгоход л хүндрэлтэй байдаг.

ШИГТГЭЭ 10.9 Ашгаас суутгах: АНУ-ын туршлага

АНУ-д Гадаадын авлигын гэмт хэргийн тухай хууль (FCPA)-ийн дагуу Үнэт цаас, биржийн хороо болон Хууль зүйн яам хууль бус ашиг орлогыг нөхөн төлүүлэх асуудлаар иргэний болон эрүүгийн хэрэг үйлчилгээ үзүүлдэг байнга эрэлхийлдэг.[a] Эдгээр байгууллага хууль бус үйлдэл эсхүл хууль бусаар хөрөнгөжсөн хөрөнгийг буцаах ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Хээл хахуулийн замаар засгийн газрын гэрээ байгуулснаас олсон болон хууль бусаар хөрөнгөжсөн тохиолдолд тухайн этгээдийн нийт орлогоос хууль ёсны зардлыг хасаж, гэрээтэй холбоотой шууд орлогыг тооцон олгодог. Хахууль болон татварт төлсөн хөнгөнийг ерөнхийдөө хасагдах зардалд тооцдоггүй.

АНУ-ын шүүх хэдийгээр хууль бус гэрээ байгуулсан ба гэрээгээр нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн гэрээний шаардлагад нийцсэн, үнэ хямд байсан ч авлигаараа ажил үйлчилгээ эрхэлснийг хууль бус хэмээн үзэж, тэр авлигаар олсон орлогыг буцаах ажиллагаа хийх шийдвэр гаргадаг.[b]

a. Хохирогч, гэрчийг хамгаалах тухай хууль (1982), Хохирол нөхөн төлүүлэх тухай хууль (1996), болон Гэмт хэргийн хохирогчийн эрхийн тухай хууль (2004) нь FCPA-ийн зөрчлийн талаар авч үзээгүй боловч тэдгээр хуулиудад бараг бүх тохиолдолд яллах ажиллагаа явагддаг FCPA-г зөрчих зорилгоор хуйвалдах гэмт хэргийг хуульчилсан байдаг ба энэ нь хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болж өгдөг. АНУ-ын шүүхүүд FCPA-тай холбоотой нэхэмжлэл гаргаж, нөхөн төлбөр төлүүлэх талаарх гадаад орнуудын байр суурийг хүлээн зөвшөөрсөн (Мессик 2016). Тухайлбал, Францын харилцаа холбооны тоног төхөөрөмжийн Alcatel-Lucent SA (Алкател) компанийг холбогдуулан гаргасан FCPA-ийн нэхэмжлэлийг харна уу. Мөн энэ үеэр Коста Рикагийн төрийн өмчит Эрчим хүчний институт (ICE) -ийн албан тушаалтнуудад авлига өгөхөөр Alcatel-ийн зүгээс хуйвалдсаны улмаас ICE "гэмт хэргийн хохирогч" болсныг тогтоож өгөх тухай хүсэлтийг АНУ-ын Флоридагийн Өмнөд дүүргийн шүүхэд гаргасан байна. Хэдийгээр шүүхүүд ICE нь хохирогч биш, харин хэргийн хамтран үйлдэгч гэж үзсэн боловч гадаад улс орнууд хохирлоо нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхтэй болохыг үгүйсгээгүй (Аснер ба Томсон 2013).
Хэрэг:
b. Sears, Roebuck & Co. v. American Plumbing & Supply Co., 19 F.R.D. 334, 339 (E.D.Wis.1956) (US).

Ерөнхийдөө үр дүнд авлигын гэрээгээр хохирсон улс авлигын эсрэг үйл ажиллагаа эхэлсэн тухай мэдээллээ нөгөө улсад нэн даруй мэдээлэх нь чухал юм. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын 51-р зүйлд хөрөнгө буцаах ажиллагаа нь "энэхүү конвенцын тулгуур зарчим мөн" хэмээн тодорхойлсон ба 56-р зүйлд Дотоодын хууль тогтоомжоо үл хөндөн, оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогын талаарх мэдээллийг өөр оролцогч улсад задруулах нь мэдээллийг хүлээн авагч оролцогч улсад мөрдөн байцаах, яллах буюу шүүх ажиллагааг эхлүүлэх буюу явуулахад нь тус дөхөм болж болох буюу Конвенцын энэ бүлгийн дагуу хүсэлт гаргахад нь хүргэж болно гэж үзэж байгаа тохиолдолд ийм мэдээллийг өөрийн мөрдөн байцаах, яллах буюу шүүх ажиллагааг үл хөндөн

өөр оролцогч улсад түүнээс урьдчилж хүсэлт авалгүйгээр шилжүүлэн өгөхийг зөвшөөрөх арга хэмжээ авахыг чармайна хэмээн заасан. Дээрх хоёр зүйл хоёулаа ийм идэвхтэй харилцаа холбоо тогтоох эрх зүйн бат бөх үндэслэлийг бүрдүүлж өгсөн ба нөхөн олговор олгох эсхүл эд хөрөнгийн өмчлөх эрхийг гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусахаас өмнө авч үзэх боломжийг олгодог. Мөн 11 дүгээр бүлгийн 11.1-ийг харна уу.

10.3 Хөрөнгө буцаан авах зорилгоор иргэний нэхэмжлэл гаргах

10.3.1.Иргэний хэрэг үүсгэх

Хөрөнгийг буцаах иргэний нэхэмжлэлийг шүүхийн эсхүл арбитрын журмаар гаргаж болно. Гадаад улсын шүүхэд энэ талаар дараах нөхцөл байдлыг энэ улмаас талын гаргаж

- Хариуцагч нь өөр улсад оршин суугаа, эсхүл тухайн улсад бүртгэлтэй, бизнес эрхэлдэг;
- Хөрөнгө нь өөр улсад байгаа эсхүл дамжин өнгөрсөн;
- Өөр улсад авлига, мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн (жишээлбэл, Шигтгээ 10.10-т тайлбарласан Английн шүүхэд өгсөн иргэний хэрэг).

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримтыг ашиглах боломжтой байдаг.

Иргэний журмаар хөрөнгө буцаах ажиллагаа хийж буй явцад хууль сахиулах байгууллага тухайн эд хөрөнгийг хууль бусаар олж авсан гэх үндэслэлээр хөрөнгө буцаах шийдвэр гаргаж болно. Их Британийн Нэгдсэн Вант Улсад 2017 онд батлагдсан Эрүүгийн санхүүгийн тухай хуулиар эд хөрөнгийг буцаах, мөрдөн шалгах ажиллагааны шинэ эрх хэмжээг нэвтрүүлж 2002 оны Эрүүгийн процессын хуульдаа энэ талын нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Эрүүгийн процессын хуулийн дагуу эд хөрөнгө буцаах болон бусад эрхийг тусгахдаа тухайлбал гэмт хэргээс олсон орлого байж болох эд хөрөнгийг Дээд шүүхээс иргэний журмаар хөрөнгө буцаах тухай шийдвэр, захирамж гаргаж болно хэмээн тусгажээ.[36] (Шигтгээ 10.11-т тайлбарласан).

Олон улсын гэрээгээр арбитрын шүүхээр шийдвэрлэх тухай заалт орсон тохиолдолд арбитрын шүүхийг ашиглаж болно. Эсхүл хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээнд маргаан үүсвэл маргаанаа арбитрын шүүхээр харьяалан шийдвэрлүүлэх талаар тусгаж болно. Ихэнх хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээгээр маргааныг заавал арбитрын шүүхээр эсхүл Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв /ICSID/-ийн дэргэдэх олон улсын арбитрын шүүхээр шийдвэрлэх механизмыг тусгасан байна.

[36] "Гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгийн талаар хууль 2002 (POCA): Guidance under Section 2A хэсэгт тусгасан удирдамж, 2018 оны 1-р сар," https://www.gov.uk/government/publications/the-proceeds-of-crime-act-section-2a.

ШИГТГЭЭ 10.10 Ливийн хөрөнгө оруулалтын газрын эсрэг Société Générale SA болон бусад этгээдийн хэрэг (2016)

Société Générale SA (SocGen) компани Ливийн бие даасан баялгийн санд учруулсан 1.5 тэрбум ам.долларын хохирлыг нөхөн төлүүлэхээр Ливийн Хөрөнгө оруулалтын газар 2014 онд Лондонгийн Дээд шүүхэд нэхэмжлэл гаргасан. Ливийн Хөрөнгө оруулалтын газар нэхэмжлэлдээ 2007-2009 оны хооронд Муаммар Эль-Каддафиг түлхэн унагахаас өмнө SocGen нь нийт 2,1 тэрбум ам.долларын үнэлгээ бүхий таван удаагийн худалдаа хийснийхээ хариуд Ливийн Хөрөнгө оруулалтын газрын албан тушаалтнуудад 58,5 сая ам.долларын хахууль өгсөн гэж Ливийн Хөрөнгө оруулалтын газар мэдэгджээ.[a] Мөн хамтран хариуцагчаар төлбөрийг гүйцэтгэсэн Панамд бүртгэлтэй Leinada Inc компани болон тус компанийг удирдаж байсан Ливийн бизнесмен Валид Аль Гиахми нарыг татсан байна.

Түүнчлэн 50 гаруй Ливийн иргэдийг уг хэрэгтэй холбогдуулан хээл хахууль авсан хэмээн татсан ба тэдний гэр бүлийг Ливи дэх хүчирхийллийн өшөө авалтаас хамгаалахын тулд хэн болохыг нь зарлаагүй байна.[b] 2017 онд Ливийн Хөрөнгө оруулалтын газарт SocGen 963 сая доллар төлөхөөр тохиролцоонд хүрсэн ба бусад тохиролцооны нөхцөл нууц хэвээр байна.[c]

Энэ нь Ливийн Хөрөнгө оруулалтын газрын барууны банкны эсрэг гаргасан хоёр дахь нэхэмжлэл байсан бөгөөд эхнийх нь Goldman Sachs-ийн эсрэг нэхэмжлэл байсан.[d] Тус хэргийг 2016 онд Лондоны Дээд шүүх хэрэгсэхгүй болгосон.

Хэрэг:
a. The Libyan Investment Authority v. Société Générale SA [2016] EWHC 375 (Comm) 1 дэх догол.
b. Ливи улсыг "аюултай газар" гэж тодорхойлдог тул авлига авсан болох нь мэдэгдсэн хүмүүсийг хамгаалахын тулд нууцлагдсан клуб байх шаардлагатай гэж үзжээ. LIA энэ зохицуулалтыг хүчингүй болгох хүсэлт гаргасан боловч хэргийн талаарх бэлтгэл ажилд хөндлөнгөөс оролцсон гэж гомдол гаргасан байна. (LIA v. SocGen [2016] 4 ба 67 дахь догол мөр).
c. SocGen нь "ажилчдынхаа болгоомжгүй байдалд" харамсаж буйгаа илэрхийлээд, LIA-аас уучлалт гуйсан байна (Société Générale. 2017. "Société Générale SA and the Libyan Investment Authority (LIA)." Хэвлэлийн мэдээ, 2017 оны 5-р сарын 4. Мөн Майкл Стотард, Жэйн Крофт. 2007-г үзнэ үү. "SocGen Ливийн Хөрөнгө оруулалтын газартай 963 сая еврогийн төлбөр тооцоог тохиролцов." Financial Times, 2017 оны 5-р сарын 4. https://www.ft.com/content/7dc88450-3094-11e7-9555-23ef563ecf9a.
d. Хөрөнгө оруулалтын банк нь LIA-г хэд хэдэн дериватив гүйлгээ хийхэд хүргэж, хууль бус нөлөө үзүүлсэн гэж үзэж LIA Голдман Саксаас 1.2 тэрбум ам.доллар нэхэмжилсэн байна. Хэрэг Libya Investment Authority v. Goldman Sachs Int'l [2016]EWHC 2530 (Ch)]-г үзнэ үү.

ШИГТГЭЭ 10.11 Их Британийн Нэгдсэн Вант Улс: Оксфорд хэвлэлийн компанийн хэрэг.

Ерөнхий мэдээлэл: Энэ хэрэг нь 2007-2010 оны хооронд Оксфорд хэвлэлийн компани 100 хувь эзэмшдэг түүний салбар Зүүн Африк дахь Оксфорд хэвлэлийн компани (OUPEA) болон Оксфордын Их сургуулийн Танзани дахь хэвлэлийн компани (OUPT)-ын шууд буюу агентуудаар дамжуулан хийсэн хууль бус төлбөртэй холбоотой буюу Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Олон Улсын хэлтэс (OUP) -ээс зарласан сурах бичиг хэвлүүлэх тендер байв.

2011 онд Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Олон Улсын хэлтэс хууль бус үйлдлүүдийг олж мэдээд, хоёр тендерийг Дэлхийн банк санхүүжүүлсэн тул Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны удирдамжийг зөрчиж болзошгүй учир нэн даруй нь мөрдөн байцаалт явуулах тушаал өгсөн.[a]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 10.11	Их Британийн Нэгдсэн Вант Улс: Оксфорд хэвлэлийн компанийн хэрэг.

Иргэний журмаар хөрөнгө буцаах үндэслэл: Онц их хэмжээний залилан мэхлэх гэмт хэрэгтэй тэмцэх газар эрүүгийн хэрэг үүсгэхийн оронд иргэний журмаар хөрөнгө буцаах шийдвэр гаргахдаа дараах үндэслэлүүдийг авч үзсэн.[b]

- Олж авсан нотлох баримт нь эрүүгийн хэрэг үүсгэхэд хангалтгүй.
- Нотлох баримтыг баталгаажуулах нь хэд хэдэн хүндрэлтэй байсан (жишээлбэл, гэрчүүд гадаадад оршин суудаг байсан).
- Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Олон Улсын хэлтэс энэ талаар өөрөө мэдээлж, онц их хэмжээний залилан мэхлэх гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран ажилласан.
- Удирдах зөвлөлийн хүрээнд хууль бус үйлдлийг зөвшөөрсөн нотлох баримт байхгүй.
- Нийлүүлсэн бүтээгдэхүүн нь чанар стандартын шаардлага хангасан байсан бөгөөд хэт их мөнгө төлсөн эсхүл тохиромжгүй эсхүл шаардлагагүй зүйл биш байсан.
- Зүүн Африк дахь Оксфорд хэвлэлийн компани болон Оксфордын Их сургуулийн Танзани дахь хэвлэлийн компанийг Дэлхийн банк давхар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

Оксфорд хэвлэлийн компанийн эсрэг хөрөнгө буцаах шийдвэр: Иргэний шүүх Оксфорд хэвлэлийн компанийг хууль бус үйлдлээс үүдэлтэй 1,895,435 фунт стерлинг нөхөн төлөх, мөн уг тушаалыг биелүүлэх зардалд 12,500 фунт стерлинг төлөхийг тушаасан. Түүнчлэн, Оксфорд хэвлэлийн компанийг Африкийн Сахарын цөлд буй сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн боловсролд зориулж ашгийн бус байгууллагуудад 2 сая фунт стерлинг хандивлах шаардлагатай хэмээн дурджээ.

a. Ноцтой залилах гэмт хэрэгтэй тэмцэх газар. 2012. "Оксфордын хэвлэлийн компани Зүүн Африк дахь үйл ажиллагаандаа хууль бус үйл ажиллагаа явуулснаа хүлээн зөвшөөрсний дараа бараг 1.9 сая фунт стерлинг төлөхөөр болжээ." Мэдээ, 2012 оны 7-р сарын 3. https://www.sfo.gov.uk/2012/07/03/oxford-publishing -ltd-pay –almost -1-9-million-settlement-admitting-unlawful-conduct-east-african-operations/.
b. Ноцтой залилах гэмт хэрэгтэй тэмцэх газар. "Оксфордын хэвлэлийн төлбөр төлнө," 2012 оны 7-р сарын 3.

10.3.2. Нотлох баримт цуглуулах, эд хөрөнгийг хамгаалах

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил иргэний процессын ажиллагааны үед нэхэмжлэгч шүүхэд хууль бус үйл ажиллагааны шалтгааныг тогтоохын тулд шууд болон шууд нотлох баримтыг гаргаж өгөх ёстой. 10.12-р талбарт иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэмэлт нотлох баримтыг ашиглах талаар тайлбарласан болно.

ШИГТГЭЭ 10.12	Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсын эсрэг Сантолина Инвестмент Корп., Соломон & Петерс, Диепрье Аламиесейха нарын хэрэгт “нөхцөл байдлын нотлох баримт”-ыг авч үзсэн нь (2007)

Уг хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдэгдсэн шүүгдэгчд мэдэгдсэн ба түүний эзгүйд хэргийг хянан шийдвэрлэсэн.[a] (Fed. Republic of Nigeria v. Santolina Inv. Corp., Solomon & Peters, and Diepreye Alamieyeseigha [2007] EWHC 437 (Ch) (UK). Мөн Шигтгээ 10.1-д дурдсан хэрэг болон 1-р бүлгийн 1.5-аас үзнэ үү). Шүүх Лондоны банкны дансанд байршуулсан мөнгө болон Аламиеесиагийн хяналтад байдаг хоёр компанийн эзэмшиж байсан эд хөрөнгө нь хээл хахууль замаар олж байсан нууц ашиг гэж үзсэн дүгнэлтэд үндэслэн Нигерийн Засгийн газарт хөрөнгийг буцаан олгох ёстой хэмээн үзсэн.

Ийм дүгнэлтэд хүрэхийн тулд шүүх нөхцөл байдлын нотлох баримт болсон хэд хэдэн зүйлийг дурджээ.

- Аламиеесейхагийн албан ёсоор мэдүүлсэн хөрөнгө, орлого болон түүний гадаадын банкны дансанд байршуулсан хөрөнгийн хооронд асар их зөрүү гарсан.
- Хариуцагч нь үндсэн хуульд заасан хоригийг зөрчиж эдгээр гадаадын банканд данс эзэмшиж байсан.
- Хариуцагч Нигер улсаас гадуур ийм хэмжээний хөрөнгө олж авах чадварынхаа талаар ямар ч үнэмшилтэй, хууль ёсны тайлбар өгч чадаагүй.
- Санхүүжилтийг гүйцэтгэгчид тусдаа гүйлгээгээр шилжүүлж, оффшор компанид хадгалсан.
- Үл хөдлөх хөрөнгийг оффшор компаниас шилжүүлэг эсхүл зээл хэлбэрээр худалдаж авсан.

Хэрэг:
a. Fed. Republic of Nigeria v. Santolina Inv. Corp., Solomon & Peters, and Diepreye Alamieyeseigha [2007] EWHC 437 (Ch) (UK).

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цуглуулсан нотлох баримтыг ашиглах

Хэдийгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримтыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах боломжтой ч эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасан нууц, нууцлалыг хадгалах заалттай тул зарим улс оронд үүнийг ашиглахыг зөвшөөрдөггүй[37].

Үүний нэгэн адил, гадаадын эрүүгийн мөрдөн байцаалт, яллах ажиллагааг дэмжих зорилгоор анх цуглуулсан нотлох баримтыг зарим нийтлэг эрх зүйн системтэй

[37] Францад жишээлбэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх үед түүний элементүүдийг гуравдагч этгээдэд задруулах нь гэмт хэрэг юм. Харин эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусмагц уг ажиллагааны оролцогч иргэний нэхэмжлэгч нь холбогдох баримт бичгийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх жиллагаанд ашиглах, ил болгохыг зөвшөөрдөг.

орнуудад эхлүүлсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж болно[38].

Зарим улсад энэ ажиллагаа илүү нарийн мэдрэмж шаарддаг[39].

Зарим тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэх замаар хөрөнгөө эргүүлэн авах ажлыг эхлүүлсэн бол эрүүгийн журмаар цуглуулсан нотлох баримтыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад ашиглахыг зөвшөөрдөггүй. Зарим улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас давуу эрхтэй байх бөгөөд эрүүгийн хэрэг эцэслэх хүртэл иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлдэг. Тиймээс мөрдөгч болон эрх бүхий этгээд эрүүгийн болон иргэний журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэгцүүлэн явуулахдаа эрүүгийн хэрэгт хамааралгүй баримтыг иргэний журмаар хэрхэн хэлэлцүүлэхээ сайтар бодолцон үзэх нь зүйтэй.

Мэдээллийг ил тод болгох

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмын дагуу зохигч болон гуравдагч этгээдийн мэдэлд буй баримт бичгүүдийг ил тод болгож болно. Хөрөнгийг буцаах ажиллагааны явцад гуравдагч этгээдийн эзэмшиж буй хувь хүний болон компани эзэмшигчийн хувийн мэдээлэл, банк санхүүгийн баримт бичгүүдийг, тухайлбал данс нээх хүсэлтийн маягт, данс, банкны хуулга, мөн тэдгээрийн харилцагчийн мэдээллийг мэдэж авах, буюу ил тод болгох задруулах хүсэлт гаргаж болно. Мөн гуравдагч этгээдэд буруутай этгээдийн хувийн мэдээллийг задруулах үүрэг өгч болно.[40]

Иргэний эрх зүйн системтийн орнуудын шүүгч мэдээллийг задруулах шийдвэр гаргаж болох ба заавал зохиогч талаас албан ёсны хүсэлт өгсөн байхыг шаардахгүй.[41] Зарим иргэний эрх зүйн системтэй оронд аливаа сонирхогч этгээд иргэний хэрэг үүсгэхээс өмнө нотлох баримт цуглуулах захирамж гаргуулах хүсэлтийг иргэний шүүхэд гаргаж болно. Нийтлэг эрх зүйн системтэй оронд талууд ихэвчлэн өөрсдийн

---

[38] *Federal Republic of Nigeria v. Santolina Investment Corp., Solomon & Peters, and Diepreye Alamieyeseigha,*-ийн хэрэгт Нигерийн холбооны засгийн газраас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлттэй холбогдуулан Нийслэлийн цагдаагийн газрын Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх албанаас явуулсан эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны дүнд Аламиеэсига-гийн авлигын замаар бий болсон хөрөнгө, хууль бус үйл ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулсан. Аламиеэсига Нигерид албан тушаал хашиж байхдаа дархан эрх эдэлж байсан ба яллах ажиллагаа эхлэхээс өмнө Их Британи руу оргон зайлсан. Нигери улс хөрөнгөө эргүүлэн авахын тулд Англид иргэний хэрэг үүсгүүлсэн. эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг Нигерт ил болгох нь түүний мөрдөн шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг нотлохыг үүргийг Английн Давж заалдах шүүх Нийслэлийн цагдаагийн газарт өгсөн байна.

[39] Зарим улс орнууд гадаадаас авсан (иргэний) нотлох баримтыг эрүүгийн шүүх хуралдаанд ашиглахад хязгаарлалт тавьдаг. Их Британийн нэг хэрэг дээр Гэмт хэргийн тухай 2003 оны (Олон улсын хамтын ажиллагааны) хуулийн дагуу олж авсан материалыг эрүүгийн хэргийн нээлттэй шүүх хуралдаанд ашигласан нь хүсэлт (MLA)-д дурдагдаагүй байсан тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж Давж заалдах шатны шүүх дүгнэсэн байна. (Family Law Week, Хэрэг: “Crown Prosecution Service & Anor v Gohil [2012] EWCA Civ 1550,” Judgments, 2012 Archives, https://www .familylawweek.co.uk/site.aspx-?i=ed105368).

[40] Хэрэг: Norwich Pharmacal Co. v. Customs & Excise Commissioners [1974] AC 133 (UK).

[41] Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Франц), 139-р зүйл.

мэдэлд буй холбогдох бүх баримт бичгийг нөгөө талдаа өгөх үүрэгтэй бөгөөд гуравдагч этгээдэд буй баримт бичгийг задруулах хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

Зарим орны шүүхүүд хөрөнгөө мэдээллийг ил болгох бусад улсад захирамжлахыг зөвшөөрдөг (9-р бүлгийн 9.5-д дурдсанчлан). Энэ шийдвэрийг гадаадын улсад биелүүлэхийн тулд тухайн улсын шүүхээр шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай.

Гуравдагч этгээдүүд, тэр дундаа банкнууд хариуцагчид тэдний талаар мэдээллийг ил болгох шийдвэр ирсэн талаар мэдэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд шүүхээс энэ талаар хариуцагчид мэдээлэхийг Гуравдагч этгээдүүд хориглох шийдвэр гаргаж болно.[42] Нууцлалыг зөрчсөн аливаа үйлдлийг шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэж болно. Шүүгдэгчдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахаас өмнө шүүхээс банкны дансыг задруулах, хязгаарлах шийдвэр гаргаж болно.[43]

Хөрөнгө царцаах, таслан сэргийлэх шийдвэрүүд

Гэмт хэрэг үйлдэж олсон байж болзошгүй гэж сэжиглэгдэж буй хөрөнгийг цаашид хөдөлгөхөөс сэргийлж түр хугацаагаар царцаах таслан сэргийлэх арга хэмжээг ашигладаг.[44] Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад (хариуцагч нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх хангалттай хөрөнгөтэй бөгөөд түүнийг хөдөлгөхөөс сэргийлж баталгаажуулах) эсхүл шүүхийн шийдвэр гарсны дараа ч авч болдог дараа (шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүднээс).

Таслан сэргийлэх арга хэмжээ гаргуулах хүсэл тодорхой шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд эдгээр шаардлага нь улс орон бүр харилцан адилгүй. Ерөнхийдөө таслан сэргийлэх арга хэмжээ гаргуулах хүсэлт гаргагч нь хариуцагч тухайн хөрөнгийг хөдөлгөх эрсдэлтэй гэдгийг үндэслэл бүхий баримтаар нотлох ёстой. Түүнчлэн хүсэлт гаргагч этгээд шүүхэд хариуцагчийн буруутай үйлдэл тогтоогдохгүй бол гарсан үр дагавар болон хохирлыг нөхөн төлөх үүрэг, амлалт өгөх, барьцаа хөрөнгө байршуулах шаардлага үүсэж болно. (Ийм шаардлагын жишээг Шигтгээ 10.13-аас үзнэ үү.)

Эх газрын болон нийтийн эрх зүйн систем бүхий аль ч орнууд хариуцагч хөрөнгийг хөдөлгөх эрсдэлээс урьдчилан сэргийлж түүнд шүүхэд нэхэмжлэгч хөрөнгө царцаах хүсэлт гаргасан талаар мэдэгдэхгүй байж болно. Зарим оронд нэхэмжлэгч шүүхэд хөрөнгө царцаах хүсэлт гаргахдаа өөрт байгаа бүх бодит нотлох баримтыг бүрэн, тодорхой гарахыг шаарддаг.[45] Харин бусад орны шүүх зөвхөн хөрөнгө хөдөлгөх үндэслэл бүхий баримт буюу үйлдэл илэрсэн тохиолдолд царцаах боломжтой байдаг.

Яллагдагч этгээд тухайн улсад оршин суудаггүй байсан ч хөрөнгө хураах талаар хүсэлтийг гаргасан болон хүсэлтийг хүлээн авсан гадаад улсын аль нэгэнд, эсхүл бүр дэлхийн аль ч оронд хэрэгжих боломжтой эрх хязгаарлах талаарх шүүхийн

---

[42] Энэхүү механизм нь голдуу нийтийн эрх зүйн тогтолцоо бүхий орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн.

[43] Эдгээр шийдвэрүүдийг зарим улсууд "Итгэлцлийн банкирууд"-ын шийдвэр гэж нэрлэдэг (Bankers Trust v. Shapira [1980] 1 WLR 1274 хэргийг шийдвэрлэсний дараа).

[44] *Mareva Compania Naviera SA v. Int'l Bulk Carriers SA* [1980] 1 All ER 213, [1975] 2 Lloyd's Rep. 509 (CA) (UK) хэргийг шийдвэрлэсний дараа эдгээрийг ихэвчлэн "Маревагийн захирамжууд" гэж нэрлэх болсон.

[45] Эдгээр шаардлагууд нь Нэгдсэн Вант Улсад хэрэгждэг (Их Британийн Хууль зүйн яам, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журам, Практикийн заавар, Битүүмжлэх захирамж https://www.justice.gov .uk/courts/procedure-rules/civil/rules/part25/pd_part25a).

шийдвэр гаргах бүрэн эрхийг зарим улсын шүүх эдэлдэг байна. (Нэгдсэн Вант улсын талаар ярьж байсанчлан 9-р бүлгийн Шигтгээ 9.5). Дэлхийн аль ч оронд хэрэгжих боломжтой дээрх эрх хязгаарлах тухай шийдвэрийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд уг шийдвэрийг хүлээн авсан гадаад орны шүүхээс албадан биелүүлэх шинж чанартай байна. Яллагдагч, эсхүл гуравдагч этгээд (банк, өмгөөлөгчийг оролцуулан) тэдгээр шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд тэдэнд анхааруулга өгч болно; мөн хорих, торгох, эд хөрөнгийг хураах зэрэг хариуцлага оногдуулах боломжтой.[46]

ШИГТГЭЭ 10.13 Франц, Панам, Нэгдсэн Вант Улс дахь таслан сэргийлэх арга хэмжээ авахад тавигдах шаардлага

Франц: Шүүхэд (juges de l'execution буюу шүүхийн процесс ажиллагааны хүрээнд хүний аливаа эрхийг хязгаарлах шаардлагатай бол тэр зөвшөөрлийг өгдөг дагнасан шүүгч байдаг) нэхэмжлэгч хариуцагч нь хөрөнгөө (хөдлөх, үл хөдлөх, биет болон биет бус) хөдөлгөх эрсдэлтэй гэдгийг нотолсон тохиолдолд хэргийг хянан шийдвэрлэж дуусах хүртэл царцаах шийдвэр гаргаж болно. Банкны дансанд байгаа хөрөнгийн хувьд нэхэмжлэгч нь "зарчмын хувьд үндэслэлтэй" бөгөөд "хөрөнгө эргүүлэн авахад эрсдэл үүсэх боломжтой" гэдгийг нотлох ёстой.

Панамд нэхэмжлэгч нь хөрөнгө царцаах хүсэлтдээ шүүхэд нэхэмжлэлд тавигдах үндсэн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд шүүхээс тогтоосон дэнчин байршуулах ёстой. Цаашилбал, нэхэмжлэгч нь хөрөнгө царцаах шийдвэр гарсны дараа хариуцагчийн эсрэг хуулийн дагуу нэхэмжлэлээ гаргах ёстой. Шүүхээс нэхэмжлэгчийн талд шийдвэр гарсан тохиолдолд хариуцагч нэхэмжлэгчийн тавьсан дэнчинг төлөх ба төлөөгүй тохиолдолд хариуцагчийн битүүмжилсэн эд хөрөнгөөс давамгай эрхтэй нөхөн төлүүлэх эрхтэй. Харин шүүхийн шийдвэр хариуцагчийн талд гарвал царцаасан хөрөнгийн эрхийг сэргээж, нэхэмжлэгчийн шүүхэд тавьсан дэнчингээс хөрөнгө царцаасанаас үүдэлтэй хохирлыг нөхөн төлүүлнэ.

Их Британид хүсэлт гаргагч нь хүсэлтдээ нотлох баримтыг чамбай хавсаргах шаардлагатай. Үүнд: хөрөнгийн эх үүсвэр, байршил, эзэмшигчийг тодорхойлсон хангалттай нотлох баримт мөн хөрөнгө үрэгдэх бодит эрсдэл учирсан зэрэг болно. Түүнчлэн хүсэлт гаргагч нь хэрэв шүүх таслан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагагүй буюу хариуцагч буруугүй байсан нь нотлогдвол хариуцагчид учирсан хохирлыг нөхөн төлнө гэж амлалт өгөх ёстой.

Авлигын хохирогч нь мөн "Марева мэдэгдэл хүргүүлэх" буюу гуравдагч этгээдийн мэдэлд буй хөрөнгийг хууль бусаар олсон орлого байж болзошгүй хэмээх мэдэгдэл хүргүүлэх аргыг ашиглаж болно[47]. Ийм мэдэгдэл нь хөрөнгийг нэн даруй, бодитойгоор хязгаарлалт тогтоох боломжтой бөгөөд хөрөнгийг царцаахын тулд шүүхэд хүсэлт гаргах зардал ихтэй, урт процессоос зайлсхийх алхам болдог. Гэмт хэргийн улмаас олсон орлогыг эзэмшиж байгаа тухай мэдэгдлийн хүлээн хүлээн авсан этгээд (ихэнхдээ санхүүгийн байгууллага болон бизнесийн үйл ажиллагаа

[46] *Mareva Compania Naviera SA v. Int'l Bulk Carriers SA,* 1 All ER at 213 and 2 Lloyd's Rep.509 хэрэг дээр шүүх Англид болон гадаад улсад байгаа хөрөнгүүдийг хамруулан шийдвэр гаргасан байна.

[47] Мөн Мартин С.Кенниг үзнэ үү. 2006. "'Mareva by Letter'—Preserving Assets Extra-Judicially—Destroyinga Bank's Defense of Good Faith by Exposing It to Actual Knowledge of a Fraud." Martindale LegalLibrary, 2006 оны 11-р сарын 27. http://www.martindale .com/international-law/article_Martin-Kenney-Co._258798.htm.

эрхлэгч буюу хууль бус орлог гэдгийг мэдэлгүй тухайн үед эзэмшиж буй этгээд байдаг) сэжигтэй үйл ажиллагааны талаар мэдээлэх, хөрөнгийг царцаах хангалттай арга хэмжээ авах шаардлага үүсдэг. эс бөгөөс уг этгээд гэмт хэрэгт хамтран оролцогч болох бөгөөд хариуцлага хүлээх үндэслэл болж өгдөг. Мэдэгдэл хүргүүлэхдээ хүлээн авч буй этгээд буюу гуравдагч этгээд хөрөнгө царцаах хангалттай үндэслэл хэрэгтэй тул гэмт хэргийн улсаас олсон орлого гэдгийг нотлох нотолгоог хавсаргасан байх ёстой.

Үзлэг нэгжлэг хийх болон битүүмжлэх шийдвэр

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шүүхээс нотлох баримтыг устгаж болзошгүй учир нэхэмжлэгчийн өмгөөлөгчид баримтжуулан авах шаардлагын үүднээс тодорхой байр, байршилд нэвтрэх зөвшөөрөл өгч болно (нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудад "Антон Пиллерийн шийдвэр" гэдгээр нь мэддэг). Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэнийг нотлох баримт бичгүүд хариуцагчийн мэдэлд байгаа гэх хангалттай нотлох баримт байгаа бөгөөд тэр баримтуудыг устгах бодит боломж байгаа тохиолдолд шүүх ийм шийдвэрийг гаргаж болно. Түүнчлэн, хариуцагчийн үйл ажиллагаа нь нэхэмжлэгчийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулж болзошгүй тохиолдолд шүүхээс ийм шийдвэр гаргаж болно[48].

ШИГТГЭЭ 10.14 БНХАУ-ын ЗЗОБ Макао: Ао Ман Лонгийн хэрэг

2008 онд Макаогийн Тээвэр, нийтийн аж ахуйн яамны сайд асан Ао Ман Лонг 800 сая Хонгконг долларын (ойролцоогоор 103 сая ам. доллар) авлигын хэрэгт холбогдон ял сонсжээ. Шүүхээс түүнд 27 жилийн хорих ял оноож, ойролцоогоор 250 сая Хонгконг долларын (ойролцоогоор 32 сая ам. доллар) хураан авах шийдвэр гарсан. Түүний хээл хахуулийн олсон орлогын багагүй хэсгийг Хонг Конг дахь дансанд байршуулжээ. Макао болон Хонгконгийн хооронд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх (MLA) гэрээгүй боловч Макао талаас хөрөнгийг царцаах, эрэн сурвалжлах зөвшөөрөл авах зорилгоор албан бус сувгаар Хонгконгийн Авлигын эсрэг бие даасан хороонд хандсан байна.

Дээр хэлсэнчлэн хөрөнгө буцаах, царцаах ажиллагааг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх сувгаар авах боломжгүй байсан тул Макао эрх бүхий байгууллага Хонгконгийн шүүхэд 230 сая хонконг доллар (ойролцоогоор 30 сая ам. доллар) гаргуулахаар иргэний нэхэмжлэл гаргажээ.

Эх сурвалж: Young 2009.

[48] Үзлэг, нэгжлэг хийх (түүнчлэн битүүмжлэх захирамж) талаар шүүхийн зөвшөөрөл гаргуулах тухай хүсэлтийг эрх бүхий шүүгчид гаргах ба үүнийг аффидавит нотлох баримтаар баталгаажуулсан байх ёстой. Яаралтай тохиолдолд хүслэтийг урьдчилан мэдэгдэлгүйгээр, тэр ч байтугай нэхэмжлэлийн маягтыг бөглөж өгөхөөс өмнө гаргаж болно. Шүүх хуралдааныг зохион байгуулах боломжгүй тохиолдолд, хүсэлтийг жижүүрийн шүүгчид утсаар эсхүл факсаар гаргаж болно. Их Британийн Хууль зүйн яам, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журам, Битүүмжлэх болон үзлэг хийх тухай шийдвэр ба практик хэрэглээний заавар 25A (Нэмэлт), 4.5 дахь догол мөр. Нэмэлт мэдээллийг "Practice Direction 25A – Interim Injunctions" (2018 оны 12-р сард шинэчлэгдсэн),https://www.justice.gov.uk/courts/procedure-rules/civil/rules/part25/pd_part25a.

10.4 Эцэслэн шийдвэрлэх

Ихэнх тохиолдолд маргаалдагч талууд шүүхийн процесс ажиллагаа эхлүүлэхээс өмнө болон эхлүүлсэн даруй асуудлыг эвлэрлийн замаар шийдвэрлэвэл зохиолтой. Шүүх хуралтай холбоотой зардал (өмгөөлөгч, шинжээчийн гэрчийн хураамж гэх мэт), цаг хугацаа, стрессээс зайлсхийх, мөн төлөх эцсийн дүнг хянахын тулд аль аль талдаа эвлэрлийн гэрээ байгуулах хүчтэй сонирхол байдаг. Иймд нэхэмжлэгч тал эвлэрлийн гэрээ байгуулахдаа ирээдүйд гарч ирж болзошгүй нэхэмжлэх зүйл байгаа эсэх талаар нягтлан эцэслэж, буцаан авах хөрөнгийн хэмжээг эцэслэн тооцож хэрэв эвлэрлийн гэрээ байгуулах үед бүрэн ил болгоогүй хөрөнгөтэй холбоотой ирээдүйн нэхэмжлэл гарч ирвэл одоо байгуулах эвлэрлийн гэрээгээр халхавчлан мултрахаас зайлсхийх боломжгүй байдлаар харах нь зүйтэй.

Эсхүл талууд шүүхийн эцсийн шийдвэрийг хүлээх хэрэгтэй болно.Хөрөнгө буцаах талаар нэхэмжлэгч шүүхэд хангалттай нотлох баримт гаргасан энэ талаар Хариуцагч шүүх хуралдаанд хариу тайлбар өгөхгүй байгаа тохиолдолд шүүх хураангуй шийдвэр гаргаж болно. Түүнчлэн хариуцагч факт, баримт бичгийн дэлгэрэнгүй тайлбарыг шаардсан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд нэхэмжлэгчийн талд ашигтайгаар түргэвчлэн шийдвэр гаргаж болно. Хураангуй болон түргэвчилсэн шүүхийн шийдвэрүүд нь шүүх үйл явцыг богиносгож, бүрэн шүүх хуралгүйгээр шийдвэр гаргах боломжийг олгодог. Гэм буруутай этгээдийн эзгүйд хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж шалгах нь бага бөгөөд иргэний хэрэг үүсгэн илүү түгээмэл байдаг харин гадаад улсад хариуцагчийн эзгүйд иргэний хэрэг үүсгүүлэх ярвигтай байж болно (Шигтгээ 10.15).

ШИГТГЭЭ 10.15 Яллагдагчийн эзгүйд шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Attorney General of Zambia v. Meer Care & Desai & Others (2007)[a] хэрэг бол Замби Улсын ерөнхийлөгч асан Фредерик Чилуба болон түүний Их Британи дахь хамтрагчдын эсрэг Их Британид гаргасан иргэний нэхэмжлэл юм. (Энэ хэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Шигтгээ 10.3 болон 1-р бүлгийн Шигтгээ 1.4-ийг үзнэ үү.) Баталгаа гаргах нөхцлийн дагуу шүүгдэгч нар Замби Улсад үлдэх шаардлага тавигдсан тул шүүх нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд тусгай зохицуулалт хийсэн. Үүнд, Замби дахь тусгай шалгагч нотлох баримтын талаар сонсох ба Лондонд ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд Лондон, Замби хоёрын хооронд шууд видео холболт үүсгэж, өдөр тутмын бичлэгийг бүртгэж авах зэрэг ажил багтсан байна.

Лондонгийн Давж заалдах шүүх Замби Улсын ерөнхий прокурорын талд шийдвэр гаргаж, Замби дахь Лусакагийн Давж заалдах шатны шүүхэд уг шийдвэрийг бүртгүүлжээ. Ерөнхийлөгч асан Лондонд болсон хуралдаанд оролцох боломжгүй байсан, мөн Замбигийн Үндэсний Ассемблейд мэдэгдэх боломжоор хангаагүй гэсэн үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлт гаргасан (эрүүгийн хэрэгт яллах зорилгоор Замбид түүний дархан эрхийг хасуулсан). 2010 онд хангалттай арга хэмжээ авсан үндэслэлээр Замби Улсын Дээд шүүх түүний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхээс татгалзжээ.

Хэрэг:
Att'y Gen. of Zambia v. Meer Care & Desai & Others, [2007] EWHC 952 (Ch) (UK).

10.5 Төлбөрийн чадваргүйд тооцох процесс

Төлбөрийн чадваргүйд тооцох ажиллагаа нь нэмэлт арга хэмжээ юм. Тиймээс нөхөн төлбөрийг зөвхөн нэг нэхэмжлэгч (эсхүл хохирогч)-д олгохгүй. Гэвч албан ёсоор төлбөрийн чадваргүйд тооцох ажиллагааны явцад хөрөнгийг мөрдөн шалгах, хадгалах, нөхөн сэргээх ажиллагаанд анхаарал хандуулах нь зүйтэй. (Бран ба Силвер 2019).

Шүүгч хариуцагчийг төлбөрийн чадваргүй гэж зарласан тохиолдолд хариуцагч болон хариуцагчийн эд хөрөнгөд хяналт тавих төлөөлөгчийг томилдог. Авлигын тохиолдолд авлигад автсан албан тушаалтан, гэмт хэрэгтэн эсхүл авлигын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд ашигласан аж ахуй нэгж төлбөр төлөгч болно. Төлбөрийн чадваргүйг тогтоож, төлөөлөгч томилсон тохиолдолд хариуцагчийн хөрөнгийн хөдөлгөөнийг автоматаар зогсоодог. Иймд гэмт хэрэг үйлдсэн этгээд дампуурлаа зарлаж тухайн оронд байгаа хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарладаг. Иймд хөрөнгө буцаах ажиллагаа хариуцаж буй эрх бүхий этгээд шаардлагатай арга хэмжээг авахгүй бол дампуурлаа зарласан этгээдийн хөрөнгөнөөс өр төлбөртэй бусад этгээдэд адил тэнцүү хуваарилах нөхцөл үүсдэг.

Олон улсын түвшинд үзүүлэх мораториумын нөлөө нь нэлээд нарийн төвөгтэй боловч Европын Холбооны Зөвлөлийн төлбөрийн чадваргүй байдлын тухай журам, НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын (UNCITRAL 2014) Хил дамнасан төлбөрийн чадваргүй байдлын тухай загвар хууль зэрэг олон улсын эрх зүйн зохицуулалт байдаг тул нутаг дэвсгэрийн гадна явуулах процессыг боломжтой болгож байгаа юм. Салбарын мэргэжилтнүүд үүнийг анхаарч, түр зуурын арга хэмжээ авах тохиолдолд "Гуравдагч этгээдийн ашиг сонирхол" гэсэн 5-р бүлгийн 5.8 дахь хэсгийг судлан үзэх нь зүйтэй.[49]

Төлбөрийн чадваргүй гэж зарласны дараа томилогдсон төлөөлөгч хариуцагчийн банкны данс, баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бүртгэлд хандах боломжтой болдог ба төлөөлөгч хариуцагчийн хууль бусаар олсон хөрөнгө хаана байгааг тодорхойлох, зохих хууль ёсны нэхэмжлэл гаргах, гадаад байгаа хөрөнгийг буцаах эрх мэдэл нь төвлөрүүлдэг. Төлөөлөгч хөрөнгө буцаах ажлыг прокурорын ажилтай уялдуулах шаардлагатай болно.

Мөрдөн шалгах эрх хэмжээнд голдуу дампуурсан тал болон төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийн захирлууд харилцан шалгалт хийх, түүнчлэн тухайн хүн, аж ахуйн нэгжтэй холбоотой мэдээлэл бүхий аливаа хүн (нягтлан бодогч, хуульч гэх мэт) хөндлөнгийн шалгалт хийх чадвартай байх явдлыг багтаадаг. Ийм эрх мэдэл нь өргөн хүрээтэй бөгөөд ихэнхдээ шүүхийн шийдвэрээр хэрэгждэг. Ихэнх тохиолдолд хариуцагч өөр этгээдэд хөрөнгийг шилжүүлсэн байдаг ба тэр этгээдийг баривчлах, шоронд хорих шаардлага үүсэх учир тийм эрхийг бас олгож болно. Түүнчлэн мөрдөн шалгах явцад ихэвчлэн хариуцагчийн хуульч болон харилцагч банкнаас хариуцагчийн мэдээллийг албадан гаргах эрх олгогддог. Дампуурсан хүн эсхүл төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгж өөрт ашигтай эрх зүйн боломжийг хүчингүй болгож, хуулийн зөвлөхийнхөө ард нуугдах боломжийг хаах хэрэгтэй.

[49] Төлбөрийн чадваргүй байдлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Зөвлөлийн 2000 оны 5-р сарын 29-ний өдрийн 1346/2000 дугаартай журам (ЕС) (энэ нь 2017 оны 6-р сарын 26-наас өмнө эхлүүлсэн ажиллагаа байсан); болон энэ ажиллагааны талаарх Европын парламент ба Зөвлөлийн 2015/848 дугаартай журам (ЕХ).

Ер нь дампуурсан этгээд болон төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийн өмчлөлийн эд хөрөнгийн тодорхойлолтыг зөвхөн биет эд хөрөнгө төдийгүй биет бус хөрөнгө, түүнчлэн тухайн эд хөрөнгийн ул мөр болохуйц үр дүн болох аливаа хөрөнгийг багтаасан гэж өргөнөөр тайлбарладаг.

Төлбөрийн чадваргүй байдлын асуудал хариуцсан албан тушаалтнууд, зээлдүүлэгч эсхүл бизнесийн түншүүд ч мөн адил хөрөнгөө эргүүлэн авах тусгай нэхэмжлэлүүд гаргаж болох бөгөөд тэдгээрийн заримыг нь бусад ямар нэгэн тал ашиглах боломжгүй байдаг. Ийм төрлийн нэхэмжлэлийн жишээг дурдвал, давуу эрхийн нэхэмжлэл, үнэлгээнд хүрээгүй дутуу гүйлгээ болон хууль бус, хууран мэхэлсэн арилжаа зэрэг байж болно. Тухайлбал, зээлдэгч төлбөрийн чадваргүй болох гэж байгаагаа мэдсээр байж зарим зээлдүүлэгчид төлбөр төлөх маягаар давуу эрх олгосон, эсхүл бизнесийн түншүүдийнхээ ашиг тусын тулд зарим зээлдүүлэгчийг хохироож дутуу үнээр гүйлгээ хийх зэрэг байж болно. Ийм нэхэмжлэлийг хангахдаа ихэвчлэн гүйлгээг буцаах, өмч хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх болон аюулгүй байдлын эрхийг хүчингүй болгох зэрэг арга замыг хэрэглэдэг. [50]

2015 онд Бразилд албан ёсны авлигын схемээр хулгайлагдсан хөрөнгийг хөөцөлдөхөд төлбөрийн чадваргүй байдлын ажиллагааг амжилттай ашигласан. Сан Пауло хотын захирагч асан түүнийг хотын эргэн тойронд хурдны зам барихад зориулагдсан хөрөнгийн 20 орчим хувийг завшсан болохыг эрх баригчид олж тогтоосны дараа татвар төлөгчдийг залилсан хэргээр буруутгагджээ. Бэлэн мөнгөний ихэнх хэсгийг зөвшөөрөлгүй мөнгө зуучлагчаар дамжуулан угааж, АНУ-ын хэд хэдэн муж дахь банкны дансанд байршуулж, Британийн Виржиний арлуудад бүртгэлтэй хоёр хувийн компанийн мэдэлд шилжүүлсэн байна. Уг схемийг илрүүлсний дараа Бразил, Сан Паулогийн засгийн газар хоёр компанийг амжилттай шүүхэд өгчээ. Дараа нь тэд төлбөрийн чадваргүй тогтоолгохын тулд Британийн Виржиний арлуудын шүүхэд хүсэлт гаргасан. Британийн Виржиний арлуудын шүүх хүсэлтийг баталж, компаниудын хяналтыг томилогдсон төлөөлөгч нарт олгосон байна. Тэд нэн даруй компаниудын үйл ажиллагаа, гэрчтэй танилцаж, хулгайлагдсан эд хөрөнгийн үлдэгдэл хөрөнгийг нэгтгэж, Бразил дахь татвар төлөгчдөд буцааж өгөх боломжийг олгосон.

Бразилд гарсан Банко Сантосын төлбөрийн чадвартай холбоотой хэрэг дээр хийгдсэн хураан авах ажиллагааны үед зээлдүүлэгчийн эрх болон төрийн эрх ашиг сонирхлын дунд бий болсон зөрчлийг шийдвэрлэхэд Бразилын хуулийг хэрэглэсэн чухал жишиг тохиолдол гарсан.

Зарим тохиолдолд (а) дампуурсан байгууллагын менежменттэй холбоотойгоор үйлдэгдсэн эрүүгийн хэргийн хохирогч болон (б) тухайн байгууллагад зээл олгосон зээлдүүлэгч хооронд ашиг сонирхлын зөрчилтэй байдаг. Бразилийн хуулинд зааснаар бол гэмт хэргийн замаар бий болсон орлого буюу хөрөнгөнөөс юуны өмнө хохирогчдын эрхийг нөхөн сэргээх байх ёстой бөгөөд бусад хэсгийг зээлдүүлэгчид зориулах боломжтой байна. Эрүүгийн хэргийн шүүх болон дампуурлын шүүх эрүүгийн хэргийн улмаас хохирсон хохирлыг эн тэргүүнд нөхөн төлүүлэхтэй холбоотой хоёр шүүхийн үйл ажиллагааг хэрхэн уялдуулах талаар харилцан тохиролцсон гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн байна.

[50] Ийм төрлийн нэхэмжлэлийг итгэмжлэгдсэн төлөөлөгч, захирагч, татан буулгах эрх бүхий этгээд, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх төлөөлөгч, эсхүл төлбөрийн чадвартай холбогдох хэрэг дээр ажилладаг ижил төстэй албан тушаалтнууд гаргах боломжтой байдаг.

Ном зүй

Asner, Marcus A., and Gillian L. Thompson. 2013. “Restitution from the Victim’s Perspective: Recent Developments and Future Trends.” Federal Sentencing Reporter 26 (1): 59–66. https://www.arnoldporter.com/en/perspectives/publications/2013/10 / restitution-from-the-victims-perspectiverecent-d__.

Brun, Jean-Pierre, Pascale Helene Dubois, Emile van der Does de Willebois, Jeanne Hauch, Sarah Jaпs, Yannis Mekki, Anastasia Sotiropoulou, Katherine Rose Sylvester, and Mahesh Uttamchandani. 2015. Public Wrongs, Private Actions: Civil Lawsuits to Recover Stolen Assets. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank and United Nations Office on Drugs and Crime. http://documents1.worldbank .org/curated/en/964411468127796449/pdf/Public-wrongs-private-actions-civil -law-suits-to-recover-stolen-assets.pdf.

Brun, Jean-Pierre, and Molly Silver. 2019. Going for Broke: Insolvency Tools to Support Cross-Border Asset Recovery in Corruption Cases. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://star.worldbank.org/publication/going -for-broke.

Civil Law Convention on Corruption. Council of Europe Treaty No. 174 (opened April 11, 1999; entered into force January 11, 2003), Strasbourg, France. https://www.coe .int/en/web/conventions/full-list/-/conventions/rms/090000168007f3f6.

CRS (Congressional Research Service). 2018. “The Alien Tort Statute (ATS): A Primer.” Report No. R44947, CRS, Washington, DC. https://crsreports.congress.gov/product / pdf/R/R44947/4.

Davis, Kevin E. 2009. “Civil Remedies for Corruption in Government Contracting: Zero Tolerance versus Proportional Liability.” International Law and Justice Working Paper 2009/4, New York University of Law. https://papers.ssrn.com/sol3/papers .cfm?abstract_id=1393326.

De Michele, Roberto, Joan Prats, and Isaías Losada Revol. 2018. “Effects of Corruption on Public-Private Partnership Contracts: Consequence of a Zero-Tolerance Approach.” Discussion Paper No. IDB DP 625, Inter-American Development Bank, Washington, DC. https://publications.iadb.org/en/ effects-corruption-public-private-partnership-contracts-consequences-zero-toler-ance-approach.

Deming, Stuart H. 2010. The Foreign Corrupt Practices Act and the New International Norms. 2nd ed. Chicago: American Bar Association.

Mena, Teresa Tovar, and Viviana Chávez Bravo. 2019. “Peru.” In The Anti-Bribery and Anti-Corruption Review, 8th ed., edited by Mark F. Mendelsohn, 245–57. London: Law Business Research Ltd. https://thelawreviews.co.uk/edition/the-anti-bribery -and-anti-corruption-review-edition-8/1210835/peru.

Messick, Richard E. 2016. “Legal Remedies for Victims of Bribery under U.S. Law.” Paper, Legal Remedies for Grand Corruption series, Open Society Foundations, New York. https://www.justiceinitiative.org/uploads/58dc15ea-f2c9-4bfa-894f -0d007145b230/legal-remedies-5-messick-20160601_1.pdf.

Meyer, Olaf, ed. 2009. The Civil Law Consequences of Corruption. Baden-Baden, Germany: Nomos Verlag.

Ministry of Justice (UK). 2011. “The Bribery Act of 2010: Guidance about Procedures which Relevant Commercial Organisations Can Put into Place to Prevent Persons Associated with Them from Bribing.” Guidance document, UK Ministry of Justice, London. http:// www.justice.gov.uk/downloads/legislation/bribery-act-2010-guidance.pdf.

Oduor, Jacinta Anyango, Francisca M. U. Fernando, Agustin Flah, Dorothee Gottwald, Jeanne M. Hauch, Marianne Mathias, Ji Won Park, and Oliver Stolpe. 2014. Left Out of the Bargain: Settlements in Foreign Bribery Cases and Implications for Asset Recovery. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https:// star.worldbank.org/sites/star/files/9781464800863.pdf.

OECD (Organisation for Economic Co-operation and Development) and World Bank. 2012. Identification and Quantification of the Proceeds of Bribery: A Joint OECD–StAR Analysis. Rev. ed. Paris: OECD. https://www.oecd-ilibrary.org/docserver/9789264174801-en.pdf?e xpires=1600641659&id=id&accname=guest&checksum=337609114C09DBA4A84487B 212880DF3.

OECD Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions (OECD Anti-Bribery Convention) (adopted 1997; entered into force 1999), Organisation for Economic Co-operation and Development, Paris. http://www.oecd.org/daf/anti-bribery/ConvCombatBribery_ENG.pdf.

Raeschke-Kessler, Hilmar, and Dorothee Gottwald. 2008. “Corruption.” In The Oxford Handbook of International Investment Law, edited by Peter Muchlinski, Federico Ortino, and Christoph Schreuer, 584–616. Oxford: Oxford University Press.

Spalding, Andrew B. 2014. “Corruption, Corporations, and the New Human Right.” Washington University Law Review 91 (6): 1365–1428. https://openscholarship.wustl .edu/cgi/viewcontent.cgi?article=6100&context=law_lawreview. UNCITRAL (United Nations Commission on International Trade Law). 2014.

UNCITRAL Model Law on Cross-Border Insolvency with Guide to Enactment and Interpretation. New York: United Nations. https://www.uncitral.org/pdf/english /texts/insolven/1997-Model-Law-Insol-2013-Guide-Enactment-e.pdf.

United Nations Convention against Corruption (UNCAC), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

Vega, Matt A. 2010. “Balancing Judicial Cognizance and Caution: Whether Transnational Corporations Are Liable for Foreign Bribery under the Alien Tort Statute.” Michigan Journal of International Law 31 (2): 385–447. https://repository.law.umich .edu/mjil/vol31/iss2/4/.

Young, Simon N. M. 2009. “Why Civil Actions against Corruption?” Journal of Financial Crime 16 (2): 144–59. https://www.researchgate.net/profile/Simon_Young7/publication /235310574_Why_civil_actions_against_corruption/links/57e3101e08aedde5f3659fe8 /Why-civil-actions-against-corruption.pdf.

11. Гадаад улсын шүүхийн шийдвэрийн дагуу дотооддоо хураан авах ажиллагаа явуулах процесс

11.1 Удиртгал

Зарим тодорхой тохиолдолд, эрүүгийн журмаар болон шийтгэх тогтоолгүйгээр (NCB) хөрөнгө хураах дотоодын захирамж гаргуулах, эсхүл гадаад улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ болон болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу ирүүлсэн хөрөнгө буцаах ажиллагааны хүсэлтийг гүйцэтгэх боломжгүй байдаг. Хууль эрх зүйн орчин, хуулийн тогтолцооны болон бусад бэрхшээл (жишээлбэл, халдашгүй байдал, хөөн хэлэлцэх хугацаа, эсхүл шилжүүлэн өгөхөөс татгалзах гэх мэт), эсхүл нөөц, бололцооны дутмаг байдал, улс төрийн сонирхол зэрэг нь үүний шалтгаан болж байдаг.[1] (Эдгээр саад бэрхшээлийн талаарх тайлбарыг 2-р бүлгийн 2.8 хэсгээс үзнэ үү.)

Бусад улсуудын харьяалалд багтаж байгаа (авлига, мөнгө угаах гэмт хэрэг гэх мэт) хэргийн хувьд тухайн хувь хүн, хөрөнгийг мөшгих, эсхүл шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах, иргэний хэрэг үүсгэх зэрэг арга замаар гадаад улсын эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно. Нөгөө талаар, гадаад улсын эрх бүхий байгууллагууд эрүүгийн, эсхүл иргэний хэрэг үүсгэх, эсхүл шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах эсэхийг тусдаа бие даан шийдвэрлэж болно.

Тодруулбал, авлигын замаар байгуулсан засгийн газрын гэрээний улмаас олсон ашгийг хураах буюу “буцаах” асуудлыг гэрээ байгуулсан газрын харьяалах улсаас илүүтэйгээр тухайн эцсийн өмчлөгчийн бүртгэлтэй, эсхүл үндсэн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг газрын харьяаллын дагуу шийдвэрлэдэг. Энэ утгаараа тус хөрөнгө нь засгийн газрын мэдэлд анхнаасаа байх ёсгүй байсан тул хүсэлт гаргагч улс (хууль бус гэрээ байгуулах боломжийг бий болгосон засгийн газар) нь тухайн хураасан хөрөнгийг буцаан өөрийн талд шилжүүлэн авахад ихээхэн бэрхшээлтэй учирдаг. Ийм тохиолдолд, хохирсон гэж тооцогдох засгийн газар нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа нөгөө улсын харьяалалд нэхэмжлэл гаргах, эсхүл хохирол барагдуулах хүсэлт гаргаж болох юм.[2]

Нэг улс өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг холбогдуулан хөрөнгө хураах, эсхүл иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа бөгөөд нөгөө улсад мөн итгэний хэргийн нэг тал болсон, эсхүл хувийн нэхэмжлэл гаргасан үед тус авлигын хэрэг үйлдэгдсэн улс нь аажмаар хэргийн талаарх “хяналтаа алдах”

[1] Тухайлбал, Экваторын Гвинейн дэд ерөнхийлөгч Теодоро Обианг-д холбогдох хэргийг дурдаж болно. (2-р бүлэг, Шигтгээ 2.10-аас үзнэ үү) Экваторын Гвиней Улсаас Обианд олгосон дипломат халдашгүй эрхийг зөрчсөн хэмээн Францын эсрэг Олон улсын шүүхэд гомдол гаргасан.

[2] Мэдээж, энэ тохиолдолд хүсэлт гаргагч тал хураан авах болон буцаан авах ажиллагааны талаарх өөрийн улсын процесс ажиллагааны журмыг баримтлан, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн туслалцааны хүсэлт илгээж болно.

юм. (Энэ талаар Шигтгээ 11.4 болон 11.5-д өгүүлсэн). Учир нь тухайн хэрэг нь нөгөө улсын дотоодын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа тул авлигын гэмт хэргийн улмаас хохирол амссан нөгөө улсад өөр улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөдлөнгөөс оролцох, удирдан шийдвэрлэх эрх байхгүй. Ийм хөрөнгийг буцаан авах ажиллагааг явуулах өөр арга зам бараг байхгүй гэж хэлж болно. Тиймээс, эрүүгийн журмаар, эсхүл шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах (эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн дагуу хэрэгжүүлэхг) зэрэг дотооддоо авч болох бүхий л арга хэмжээг авч үзсэний дараа л зөвхөн энэ аргыг салбарын мэргэжилтнүүд хэрэглэх нь бий.

Энэ арга замыг сонгох эсэх нь албан бус болон албан ёсны хамтын ажиллагааны механизмаар дамжуулан баталгаажих ба олон хүчин зүйлс нөлөөлнө. Анхаарвал зохих хүчин зүйлүүд нь:

- Мөрдөн шалгах, хөрөнгө хураах ажиллагаа явуулах талаар гадаад улсын чадавхи болон хүсэл зориг;
- Авлигын хэргийн улмаас хохирол амссан улсаас эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээр дамжуулан гадаад улсад явагдаж байгаа процесстой холбоотой гаргасан амлалт;
- Хөрөнгө буцаах талаарх гэрээ.

11.2 Харьяалал

Гадаад улсын эрх бүхий байгууллага нь тухайн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах эрх хэмжээтэй байх ёстой. Олон улсын гэрээгээр түүний гишүүн орнуудыг авлигын гэмт хэргийн хувьд харьяаллын талаар өргөн хүрээний арга хэмжээ авахыг шаарддаг буюу дэмждэг.[3] Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсон улсууд нь нутаг дэвсгэртээ, өөрийн улсын иргэн эсхүл түүний эсрэг үйлдсэн, эсхүл нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг харьяалалгүй хүн, эсхүл түүний эсрэг үйлдсэн авлигын гэмт хэргийг шүүх эрх мэдэлтэй байх ёстой болохыг шаарддаг.[4] "Хэрэгтэн шилжүүлэх, эсхүл яллах" зарчмыг баримтлах тохиолдолд (Шигтгээ 11.4-т тайлбарлав) процесс явагдаж байгаа талд харьяаллыг тогтооно.

Тухайн улсын иргэнд хамааралгүй бөгөөд харьяаллын нутаг дэвсгэрт нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсгүүдийн зөвхөн зарим нь үйлдэгдсэн байх, эсхүл гэмт хэргийн улмаас хохирол учирсан байх нь тэнд харьяалал тогтооход хангалттай үндэслэл болно. (2 дугаар бүлгийн Шигтгээ 2.10-т тайлбарлав) Аливаа гэмт

[3] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 42-р зүйл; Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 15-р зүйл; Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 4-р зүйл. Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Олон улсын бизнесийн гүйлгээний явцад гадаадын төрийн албан тушаалтнуудад хээл хахууль өгөхтэй тэмцэх тухай конвенцийг (“OECD-ийн Хээл хахуулийн эсрэг конвенц”)-ийн 4-р зүйлийг үзнэ үү. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-ын Зөвлөмж 3 (“Мөнгө угаах гэмт хэрэг”) (FATF 2019).

[4] АЭК-ийн 42-р зүйл. НҮБ-ын Конвенцид заасан гэмт хэргүүд болох Үндэсний болон гадаадын төрийн албан тушаалтнуудад хээл хахууль өгсөн (15-16-р зүйл); Төрийн албан тушаалтан бусдын эд хөрөнгийг шамшигдуулсан, завшиж үрсэн, өөр бусад хэлбэрээр урвуулсан (17 дугаар зүйл); Гэмт хэрэг үйлдэж, мөнгө угаахаас олсон орлогыг мэдсээр байж олж авсан, эзэмшиж, ашигласан (23-р зүйл). АЭК нь гишүүн орнуудыг худалдан авах ажиллагаанд нөлөөлөх, албан тушаалаа урвуулан ашиглах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хувийн хэвшлийн хээл хахууль, хөрөнгө шамшигдуулах зэрэг үйлдлүүдийг дотооддоо хуульчлахыг уриалдаг.

хэрэгтэй холбоотой үйлдлийн жижиг хэсэг нь л тэдний нутаг дэвсгэрийг "шүргэсэн" бол тэдний харьяалалд хамаарна гэж зарим эрх баригчид үздэг байна. (Шигтгээ 11.1-д харьяалал тогтоох шинэлэг байдлын талаар өгүүлэв.)

ШИГТГЭЭ 11.1 Тухайн нутаг дэвсгэрт үйлдэхийг хязгаарласан үйлдэл гарсан тохиолдолд харьяалал тогтоох

Тухайн улсын иргэнд хамааралгүй, харьяаллын нутаг дэвсгэрт нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсгүүдийн цөөн хэсгийг нь үйлдсэн тохиолдолд харьяалал тогтоох нь амаргүй зүйл юм. Гэсэн хэдий ч олон улс орнууд энэ асуудлыг шийдэх шинэлэг арга замыг олжээ. Тэдний авч үзсэн зарим хүчин зүйлүүдээс дурдвал:

- ***Харьяаллын нутаг дэвсгэр дээрх мөнгөн гүйлгээ.*** АНУ-ын дээд шүүх гадаадын засгийн газрын татварын орлогыг улс хоорондын мөнгөн шилжүүлэг ашигласан залилсан яллагдагчдад оноосон ялыг хүчин төгөлдөр хэвээр үлдээсэн.[a]
- ***Гэмт хэргийн үүсэл болсон газар.*** Авлигын хэргийг Бразилаас гадаад улс руу утасны дуудлага, факс, цахим шуудан ашиглан хийсэн бол Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын хууль тогтоомжид харьяалагдан шийдвэрлэхэд хангалттай гэж үзсэн.
- ***Нутаг дэвсгэрт нь болсон гэмт хэрэгтэй холбоотой байх.*** Францад хэрэв гэмт хэрэг гадаад улсад үйлдэгдсэн ба уг гэмт хэрэг нь Франц Улсад үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй гэж үзвэл өөрийн харьяалж болно.[b]
- ***Мөнгө угаах гэмт хэрэг.*** Улс орнууд мөнгө угаах гэмт хэргийн хүрээнд уг гэмт хэргийг үйлдсэн этгээд болон хөрөнгө нь тус улсад байвал хэргийн харьяаллыг өөрийн улсынхаар тогтоож болно. (Шигтгээ 11.3)
- ***Үндэсний мөнгөн тэмдэгтийн шилжүүлэг (нутаг дэвсгэрээс гадуур байсан ч).*** 2009 онд Бангладешийн Ерөнхий сайдын хүүд гадаадын компаниас авлига (Сингапурт, АНУ-ын мөнгөн тэмдэгтээр) өгсөн орлогыг хураан авах ажиллагааг АНУ-ын Хууль зүйн яам явуулсан.[c] АНУ-аас гадуурх санхүүгийн байгууллагуудын хооронд АНУ-ын мөнгөн тэмдэгтийг шилжүүлэх нь заавал АНУ-ын банкнуудаар дамждаг гэж Хууль зүйн яам нь амжилттай нотолсон. Харьяаллын өөр нэг үндэслэл нь авлига өгсөн гадаадын компани нь Нью-Йоркийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, АНУ-ын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байсан.
- ***Үндэсний эрх ашгийн эсрэг гэмт хэрэг.*** Гадаадын иргэд Украины иргэдийн эрх, эрх чөлөөний эсрэг эсхүл Украины ашиг сонирхлын эсрэг ноцтой гэмт хэрэг үйлдсэн бол Украины нутаг дэвсгэрээс гадуур үйлдсэн гэмт хэрэгт ч эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

a.Пасквантино болон АНУ-ын хэрэг, 544 АНУ 349 (2005). АНУ-ын Хууль зүйн яамнаас Японд төвтэй Бриджстоун компаний Япон, АНУ-ын хооронд илгээсэн цахим шууданг үндэслэн хэргийн харъяаллыг Гадаадын авлигын тухай хууль (FCPA), мөн Шерманы хуулийн хэсэл хахуулийн схемийн дагуу шийдвэрлэхээр болсон. АНУ болон Бриджстоун корпорацийн хэрэг., No. 11-651, Мэдээлэл (S.D. Tex. 2011), https://www.justice.gov/sites/default/files/criminal-fraud/legacy/2011/10/18/09- 15-11bridge-stone-information.pdf. —г үзнэ үү.
b. Давж заалдах шатны шүүх, 1981 оны 4-р сарын 23
c. 18 U.S.C. § 981(a)(1)(C): Хууль бус хэмээн тооцогдох орлогыг бүрдүүлсэн буюу түүнээс олсон үл хөдлөх болон хувийн аливаа эд хөрөнгө [...]

Ихэнх орнууд хуулиндаа зөвхөн харьяат иргэнээр хязгаарлалгүй мөн тухайн улсын харьяалал бүхий хуулийн этгээд өөр улсад авлига, мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн

тохиолдлуудыг харьяалан авч үзэхээр багтаасан байна. Шигтгээ 11.2-т ийм төрлийн харьяаллыг Их Британи болон АНУ-ын жишээн дээр үндэслэн харуулав.[5]

Шигтгээ 11.3-т хэд хэдэн улсад үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэргийг яллах харьяалал хэрхэн тогтоогдсон жишээнүүдийг харуулав.

ШИГТГЭЭ 11.2 Их Британи болон АНУ-ын иргэдийн хувьд харъяалал тогтоох

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Их Британийн 2010 оны Авлигын тухай хууль нь аливаа байгууллагын бизнесийн үйл ажиллагааны хүрээнд ажилтан, охин компани, төлөөлөгч, зөвлөхүүд нь хахууль өгдөг байгууллага эсхүл компанид дэлхийн хаана ч байсан эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Лондонд жижиг салбар ажиллуулдаг гадаадын банк аль ч улсад албан хаагч, төлөөлөгч, охин компани нь авлига өгсөн тохиолдолд Их Британи дахь салбараас зөвшөөрөл аваагүй, эсхүл дамжуулан аваагүй байсан ч эрүүгийн хариуцлага хүлээнэ. Зөвхөн салбар байгууллага байгаа нь Их Британийн прокурор, шүүхэд харьяалагдах эрхийг олгоно. Тус хуулийн 7-р зүйлд арилжааны байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй нөхцөлийг тусгасан байдаг. Тус заалтад "Хэрэв түүнтэй холбоотой этгээд өөр хүнд хахууль өгсөн, эсхүл үйл ажиллагаа явуулахад давуу тал олгосон бол гэмт хэргийг "холбогдох арилжааны байгууллага" үйлдсэнд тооцно" гэж заажээ.

Ноцтой Залилангийн Хэрэгтэй Тэмцэх Газар Sweett Group-ийг Авлигын тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу буруутгаж, ялласан. Тус компанийн Кипр дэх охин компани (Cyril Sweett International) нь Дубайд зочид буудал барих гэрээг баталгаажуулах зорилгоор авлигын төлбөр хийсэн юм. (Аль Айн Ахлиа даатгалын компанийн Үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалтын хорооны дарга, ТУЗ-ийн дэд дарга Халед Аль Бади).[a]

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-д Гадаадын авлигын гэмт хэргийн тухай хууль (FCPA) нь гурван нөхцөл байдалд харьяаллыг тогтоодог:

- Хөрөнгө барьцаалан зээл гаргах тохиолдолд АНУ-д бүртгэлтэй зээл гаргагч корпорацын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй аливаа албан тушаалтан, захирал, ажилтан, төлөөлөгч болон тэдгээрийн хувьцаа эзэмшигчид;
- Дотоодын асуудалтай холбоотой тохиолдолд АНУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан эсхүл АНУ-д төв оффис нь байрладаг аливаа хуулийн этгээд, мөн АНУ-ын иргэний авлигатай холбоотой үйлдлүүд, эдгээр үйлдлүүд нь АНУ-аас гадуур байх тохиолдол мөн хамаарна.
- Нутаг дэвсгэрийн харьяаллын тухайд, АНУ-ын нутаг дэвсгэрт байх хугацаандаа авлигын үйл ажиллагаа явуулж буй гадаадын иргэд эсхүл компаниуд.

Гадаадын авлигын гэмт хэргийн тухай хууль (FCPA)-ийн хүрээнд Парисын харилцаа холбооны компани Alcatel-Lucent болон түүний гурван охин компани АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (SEC) болон АНУ-ын Хууль зүйн яам (DOJ)-ын нэхэмжлэлийг барагдуулахын тулд 137 сая гаруй доллар төлөхийг зөвшөөрөв.[b]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[5] OECD-ийн гишүүн 38 орны 37 нь иргэншлийн болон компанийн хувьд харьяалан хамаарна.

ШИГТГЭЭ 11.2 Их Британи болон АНУ-ын иргэдийн хувьд харъяалал тогтоох

SEC-ийн гомдлын дагуу Alcatel нь Коста Рика, Гондураз, Малайз, Тайвань, Хятадад гэрээ байгуулахын тулд АНУ-ын муж хоорондын худалдааны шуудан болон бусад хэрэгсэл ашиглан гадаадын засгийн газрын албан тушаалтнуудад шууд болон шууд бусаар хахууль өгч, АНУ-ын банкнуудаар дамжуулан хууль бус төлбөр хийсэн.[c]

FCPA-д авлигын төлбөр авсан гадаадын албан тушаалтнуудыг хэргийн холбогдогчоор татах зүйл заалт байхгүй. Гэсэн хэдий ч мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн газар нь АНУ-д харьяалалтай бол төлбөртэй холбоотой мөнгө угаасан хэргээр яллах боломжтой.

Нэмж дурдахад, авлигын төлбөр авсан гадаадын албан тушаалтныг FCPA-ийн дагуу яллах боломжгүй байсан ч 1961 оны Аялал жуулчлалын тухай хууль, цахимаар болон шуудангаар залилан мэхэлсэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэж болно.

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг нь өөр улсад үйлдэгдсэн байж болохыг хуулиндаа тусгасан байх талаар Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF) -ын стандартын дагуу мөнгө угаах гэмт хэргийн харъяаллыг тогтоох талаар хуульд аль болох өргөн хүрээнд тодорхойлж болно. (Шигтгээ 11.3-т ийм харъялал тогтоох үндэслэлийг 5 улсын жишээгээр харуулав.) Зарим улсад эрх баригчид өөр нутаг дэвсгэрт үйлдэгдсэн авлигын хэргийн бэлтгэл ажлыг дотооддоо үйлдсэн тохиолдолд (жишээлбэл, хуйвалдаан, гэмт хэргийн шинжтэй эд хөрөнгө хүлээн авах, хамтран оролцох гэх мэт) хэрэг үүсгэдэг.[d] Эцэст нь, зарим улс орнууд гадаад дахь харилцагчийн дансанд хууль бусаар хийсэн орлогыг ял оноохгүйгээр хөрөнгө хураах ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.[e]

a. Онц ноцтой залилах гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэдээллийг үзнэ үү. 2016. "Sweett Group PLC-г хээл хахуулийн хэрэгт буруутгаж 2.25 сая фунт стерлингийн торгууль оногдуулав." Хэвлэлийн мэдээ, 2016 оны 2-р сарын 19-ны өдөр. https://www.sfo.gov.uk/2016/02/19/sweett-group-plc-sentenced-and-ordered-to-pay2-3-million-after-bribery-act-conviction/; болон Онц ноцтой залилах гэмт хэрэгтэй тэмцэх алба, "Sweett Group"-ын хэргийн талаар (2016 оны 5-р сарын 12-нд шинэчлэгдсэн мэдээлэл), https://www.sfo.gov.uk/cases/sweett-group/.

b. АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо. 2010. " Үнэт цаас, биржийн хороо нь Alcatel-Lucent-ийг FCPA зөрчсөн хэмээн буруутгаж байна." Хэвлэлийн мэдээ, 2010 оны 12-р сарын 27-ны өдөр https://www.sec.gov/news/press/2010/2010-258.htm

c. Үнэт цаас, биржийн хороо нь Alcatel-Lucent-ийн хэргийг үзнэ үү, SA, No. 10-cv-24620 (S.D. Флорида муж 2010), Гаргасан гомдол (мөр. 64), https://www.sec.gov/litigation/complaints/2010/comp21795.pdf.

d. Жишээлбэл, Франц Улсын хуулийн байгууллагаас Франц Улсад бодит гэмт хэрэг үйлдээгүй ч мөнгө угаах ажиллагааг бэлтгэх зорилготой хуйвалдаанд оролцсон гадаадын иргэнд хэрэг үүсгэж болно (Кассацийн шүүх, 1990 оны 2-р сарын 20-ны өдөр).

e.U.S.C.§ 981(k)-ийн 18 дугаар зүйлийн дагуу АНУ-ын шүүх гадаадын банкны болон АНУ-ын корреспондент дансанд байгаа, харилцагчийн гадаадын банкинд байршуулсан хууль бус орлогын дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг хураах шийдвэр гаргах эрхтэй. Энэ заалтыг гадаад улсын холбогдох байгууллага нь хөрөнгө хязгаарлах, хураах чиг үүргийг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хэрэгжүүлэх (MLA) боломжгүй эсхүл тийм сонирхол байхгүй байгаа тохиолдолд ашиглагддаг.

ШИГТГЭЭ 11.3 Бразил, Франц, Швейцарь, Их Британи, АНУ дахь мөнгө угаах гэмт хэргийг яллах ажиллагааны харьялал

Бразил

Бразилд 1998 оны 3-р сарын 3-ны өдрийн 9.613 тоот холбооны хуулийг 2012 оны 12.683 тоот холбооны хуулиар өөрчилсөн бөгөөд энэ хуулиар суурь гэмт хэрэгт багтах гэмт хэргийн жагсаалтыг байхгүй болгох замаар мөнгө угаах гэмт хэргийн тухай ойлголтыг өргөн хүрээнд авч үзсэн. Энэхүү хууль тогтоомжийн өөрчлөлт нь Бразил улсын хувьд гадаад улсын хохирогчдод өргөн хүрээнд тусламж үзүүлэх боломжийг олгосон байна.

Франц

Тухайн эд хөрөнгийг хууль бус гарал үүсэлтэй гэдгийг мэдэж байсан, эсхүл мэдэх ёстой байсан нөхцөл байдал тогтоогдсон тул хилийн чанадад үйлдсэн гэмт хэргээс олсон орлогыг хүлээн авсан хэрэгт Францын шүүхүүд шүүгдэгчийг гэм буруутайд тооцон шийтгэсэн байна.[a] Францын Эрүүгийн хуулийн 321 дүгээр зүйлийн 321.1-д "recel" буюу хууль бусаар олсон зүйлийг хүнд гэмт хэрэг үйлдэж олж авсан гэдгийг мэдсээр байж хүлээн авах, хадгалах, нуун дарагдуулах, шилжүүлэх, эсхүл түүнд зуучлах үйлдлийг гэмт хэрэгт тооцдог.

Үүнтэй адилаар Франц улс хилийн чанадад үйлдэгдсэн суурь гэмт хэргийн улмаас бий болсон орлогыг хувиргахыг гэмт хэрэгт тооцдог. Тухайлбал, Нигерээс цуглуулсан хахуулийн мөнгөөр Францад байр худалдаж авсан Нигерийн сайд асныг Францын шүүх шийтгэсэн. Авлигын гэмт хэргийн бүх элементүүд нь Нигерид үйлдэгдсэн бол мөнгө угаасан хэргийг нь Францын шүүх харьяалан шийдсэн байна.[b]

Швейцар

Швейцар Улсын хувьд, ихэвчлэн нөхцөл байдлын нотолгоо болон ял наймаалцах аргыг хэрэглэдэг бөгөөд мөн сэжиг бүхий орлогыг агуулж байгаа дансыг хянах эрхтэй субьект болох данс эзэмшигчид, эцсийн өмчлөгч болон bona fide бус сэжигтэй зуучлагч нарыг яллагдагчаар татдаг. Харгалзах эд хөрөнгийг ял оноохгүйгээр эд хөрөнгө хураах (NCB) журмаар хураан авдаг.

Их Британи

Их Британийн эрх баригчид гадаадад үйлдсэн гэмт хэргээс олсон гэмт хэргийн эд хөрөнгийг нуун дарагдуулсан, өнгөлөн далдалсан, хувиргасан, шилжүүлсэн гэмт хэрэг нь Их Британийн хуулийн дагуу гэмт хэрэг мөн гэж үзвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.[c] Прокурорууд уг хөрөнгийг "гэмт хэргийн шинжтэй үйлдэл"-ээр олж авсан болохыг нэмэлт нотлох баримт дээр тулгуурлан шийдэж болно; тухайн эд хөрөнгийг ямар эрүүгийн үйлдлээр олж авсан гэдгийг батлах албагүй.[d]

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-д мөнгө угаах гэмт хэрэг нь гадаадын албан тушаалтнуудад хээл хахууль өгөх, төсвийн хөрөнгийг шамшигдуулах, гадаадын банкнаас залилан мэхлэх, эсхүл олон улсын гэрээний дагуу АНУ-аас шилжүүлэн өгөх үүрэгтэй аливаа гэмт хэрэг зэрэг орно.[e] Ял оноохгүйгээр эд хөрөнгө хураан авах арга хэмжээг дээр дурдсан төрлийн гэмт хэргээс олсон орлого, мөн мөнгө угаах гүйлгээнд холбогдсон хөрөнгийг хураахад ашиглаж болно. Ийм тохиолдолд, хэрэв үндсэн гэмт хэрэг нь АНУ-д үйлдэгдсэн бол АНУ дотоодод хадгалагдаж буй авлигын орлого болон АНУ-аас гадуурх гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг буцаах ажиллагаа явуулж болно.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 11.3	Бразил, Франц, Швейцарь, Их Британи, АНУ дахь мөнгө угаах гэмт хэргийг яллах ажиллагааны харъялал

Украины Ерөнхий сайд асан Павло Лазаренког мөнгө угаасан хэргээр яллах үеэр Сан Францискогийн банкнуудаар дамжуулан хүлээн авсан мөнгө нь Украинд үйлдэгдсэн хээл хахуулийн үйлдлээр олсон орлого болохыг прокуроруд нотлон харьяаллыг тогтоожээ.[f]

a. "Анголагэйт"-ийн хэрэг. (Парисын Трибуналийн шүүх, 11 дүгээр хурлын танхим, 3d хэсэг, 2009 оны 10 дугаар сарын 29,), Хэдийгээр зарим суурь гэмт хэрэг нь Ангол Улсад үйлдэгдсэн боловч зэвсгийн наймаа, хээл хахууль, мөнгө угаасан хэргээр хэд хэдэн сэжигтнүүд болон өмнө албан тушаал хашиж байсан этгээдүүдийн хэргийг Франц Улсад шүүн тасалсан.
b. Парисын давж заалдах шатны шүүх, Эрүүгийн хэргийн танхим. А хэсэг. 2009 оны 03 дугаар сарын 08. Франц Улс. https://shellandenitrial.org/wp-content/uploads/2018/07/France-Court-Doc2ETETE-translation-20091215093409518-ETETE-Appeal_English.pdf .
c. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогын тухай хууль 2002 он (Их Британи), 327, 340 (2) хэсэг
d. Хааны прокурорын алба, Гэмт хэрэг үйлдэж олсон орлогын тухай хууль 2002, Мөнгө угаах гэмт хэрэг (Их Британи), https://www.legislation.gov.uk/ukpga/2002/29/part/7
e. АНУ-ын хууль 18 U.S.C. §§ 1956(c)(7)(B), 981.
f. Америкийн Нэгдсэн Улс v. Павел Иванович Лазаренкогийн хэрэг, 564 F.3d 1026 (9th Cir. 2009

11.3 Арга хэмжээ авч эхлэх журам

Гадаадын харьяалалд байгаа ч дотоодын эрх зүйн зохицуулалтаар хөрөнгө буцаах ажиллагаа явуулахад зөвхөн авлигын гэмт хэрэг үйлдэгдсэн улсын хүсэлтээс шалтгаалахгүй гэдгийг мэргэжилтнүүд ойлгох нь чухал юм. Гадаадын эрх бүхий байгууллагууд янз бүрийн арга замаар олж авсан мэдээлэлд үндэслэн бие даан хэрэг үүсгэж болно. (Шигтгээ 11.4-т эдгээр мэдээллийн хэд хэдэн эх сурвалжийг үзүүлэв.) Гадаадын эрх бүхий байгууллагууд нь хэрэг үүсгэх, мөрдөн шалгах ажиллагаа хэрхэн явуулахыг эцэслэн шийдвэрлэдэг.

11.4 Гадаад улсад мөрдөн шалгах, яллах ажиллагааг явуулахад авлигын гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн талын үүрэг

Нэгэнт гадаад улсад мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн бол тухайн харьяаллын дагуу ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд авлигын гэмт хэргийн талаар, эсхүл мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг нотлохын тулд авлигын гэмт хэргээс хохирсон улсын нутаг дэвсгэрт нотлох баримт цуглуулах шаардлага үүснэ. Бельги зэрэг зарим улсын хууль эрх зүйн хүрээнд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн нотолгоо байхгүй байсан ч дангаар үйлдэгдсэнээр нь яллахыг зөвшөөрдөг бөгөөд тухайн гүйлгээ нь хууль бусаар олсон орлоготой холбоотой гэдгийг шүүгдэгч үл тоомсорлох боломжгүй нөхцөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг олгодог.

ШИГТГЭЭ 11.4 Гадаад улсад эхлүүлсэн хөрөнгө буцаах ажиллагааны процессын талаарх мэдээллийн эх сурвалжийн жишээ

1. ***Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улс нь гомдол гаргах эсхүл нотлох баримт болон хэргийн материалыг гадаадын харьяаллын байгууллагуудтай хуваалцана.***

Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улс нь хэргийг гадаад улсад явуулахаар хөөцөлдөх үед ихэвчлэн энэ аргыг ашигладаг. Иргэний эрх зүйн хүрээнд авлигын замаар олж авсан хөрөнгийг буцаан авахыг хүссэн улс тухайн эд хөрөнгө угаахтай холбоотой хэрэг үүсгэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах зэрэг эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулж болно.

2. ***Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улс эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт гаргана.***

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх (MLA) хүсэлт нь гол төлөв зорилго, сэжиг бүхий гэмт үйлдэл, мөнгөний урсгалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулдаг. Энэхүү мэдээлэл нь хүсэлт хүлээн авсан улсыг өөрийн улсын нутаг дэвсгэрт буюу өөрийн улсын иргэдтэй холбоотой мөнгө угаах, гадаадын хээл хахууль болон бусад гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх үндэс болох боломжтой. Энэ нь Швейцар Улсад харьцангуй их давтамжтай тохиолддог бөгөөд үүнд тодорхой арга барил ашигладаг байна.

Швейцар улсад эрх баригчид ерөнхийдөө эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээс илүү өргөн хүрээтэй, гүнзгийрүүлсэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, тэр дундаа хүсэлтэд дурдаагүй банкны дансыг ч шалгахыг зөвшөөрдөг. Гадаад улсын харьяалалд хоёр өөр ажиллагаа явагдах нь олонтой: эхнийх нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтэд хариу өгөх, хоёр дахь нь дотоодын мөнгө угаасан хэргээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах.

3. ***Хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлига, мөнгө угаах гэмт хэргийн талаар мэдээлнэ.***

Авлигын хэргүүд, ялангуяа улс төрийн холбогдолтой хүмүүстэй холбоотой хэргүүд ихэвчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олны анхаарлыг татдаг. Энэ нь гадаадын харьяалалтай холбоотой үйл ажиллагааг ил болгох боломжтой бөгөөд гадаадын мэргэжилтнүүд тус мэдээлэл дээр үндэслэн хэрэг үүсгэх эсхүл банкны ажилтнууд сэжигтэй гүйлгээний тайлан (STR – suspicious transaction report) гаргаж, эцэст нь мөрдөн байцаах ажиллагаа эхлүүлэх нөхцөл үүснэ.

Сүүлийн жилүүдэд сэтгүүлчдийн холбоо "consortiums"[a]-ын судалгаа болон хэвлэл мэдээллээр ил болгосон мэдээлэлд үндэслэн Панамын баримтууд (Panama Papers), Луандагийн баримтууд (Luanda Leaks), Диваажингийн баримтууд (Paradise Papers), Оросын угаалга (Russian Laundromat) зэрэг янз бүрийн хэргийг эхлүүлсэн.

4. ***Санхүүгийн байгууллагууд сэжигтэй гүйлгээний тайлан (STR) гаргана.***

Санхүүгийн байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, гүйлгээг сэжиглэж байгаа тохиолдолд STR мэдүүлэх замаар санхүүгийн тагнуулын нэгжид (FIU-Financial intelligence unit) мэдээлэх ёстой. CTA-д STR-д дүн шинжилгээ хийж, тайланг хууль сахиулах байгууллага эсхүл Эгмонт группээр (The Egmont Group of Financial Intelligence Units) дамжуулан бусад CTA-д түгээх үүрэгтэй. Ингэснээр хууль сахиулах байгууллагууд CTA-аас өгсөн мэдээлэлд үндэслэн мөрдөн байцаалт явуулж болно.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 11.4	Гадаад улсад эхлүүлсэн хөрөнгө буцаах ажиллагааны процессын талаарх мэдээллийн эх сурвалжийн жишээ

5. "Шилжүүлэн өгөх эсхүл яллах" зарчмыг баримтална.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн (UNCAC) 44 дүгээр зүйлийн 44.11-т заасны дагуу иргэдийг шилжүүлэн өгөхөөс татгалзсан улс нь хүсэлт гаргагч талын хүсэлтийн дагуу тус хэргийг өөрийн дотоодын эрх бүхий байгууллагад яллахаар шилжүүлэн өгөх үүрэгтэй.[b]

Францад 5-аас доошгүй жилийн хорих ялтай гэмт хэргийг зохих журмын дагуу шилжүүлэн өгөхөөс татгалзсан эсхүл Францын нийтийн хэв журамтай (Эрүүгийн хуулийн [Франц], 113-р зүйл. 8-1) нийцэхгүй байгаа тохиолдолд дотооддоо ялыг эдлүүлнэ.

6. Талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 47 дугаар зүйлд нэгдэн орсон орнууд нь шударга ёсыг хэрэгжүүлэх зарчимд нийцүүлэн, конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг яллах зорилгоор шилжүүлэх эсэхийг шийдвэрлэж байх талаар заасан. Хэрэв хэд хэдэн улсад харьяалагдаж байвал хэргүүдийг нэгтгэх ажиллагааг конвенцийн дагуу хэрэгжүүлнэ.

a. Нэр хүндтэй сэтгүүлзүйн байгууллагууд нь үүнтэй холбоотойгоор Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн консорциумд нэгдэн ажилладаг байна. (https://www.icij.org/),Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигыг мэдээлэх төсөл (https://www.occrp.org/) зэрэг байгууллагууд багтдаг
b. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенцийн (UNTOC),-ын 16[12] дугаар зүйл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 6[9]2-ийг үзнэ үү.

Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улс нь хэргийн материалыг анхлан гаргаж өгсөн байсан ч гадаад улсын харьяалалд нэмэлт мэдээлэл, хууль зүйн туслалцаа (гэрчийн мэдүүлэг, санхүүгийн бүртгэл, банкны болон байгууллагын баримт бичиг) хэрэг болох магадлалтай. Энэ мэдээллийг албан бус туслалцааны аргаар эсхүл эрх зүйн туслалцааны хүсэлт тавих замаар авах боломжтой. Нэмэлт мэдээлэл, нотлох баримт хүссэн тохиолдолд буцаан хариу өгөх нь нэн чухал юм. Хэргийг үргэлжлүүлэн анхаарч, гадаадын хүсэлтэд хариу өгөхгүй бол гадаадад тус хэргийг амжилттай шийдвэрлэх нь хязгаарлагдмал эсхүл боломжгүй болно. (Шигтгээ 11.5-д ийм хамтын ажиллагааны ач холбогдлыг Хайти-ын жишээн дээр авч үзнэ.) Ямар ч тохиолдолд мэдээлэл солилцох боломжтой харилцааны сувгийг бий болгох нь зүйтэй.

Эх газрын эрх зүйн тогтолцоотой ихэнх улс орнуудын хувьд, авлигын гэмт хэргийн улмаас хохирсон гадаад улсыг гомдол гаргагч, эсхүл хохирогч (зарим улсад "нэхэмжлэгч" гэж нэрлэдэг)-ын хувиар мөрдөн шалгах ажиллагаа, шүүн хуралдаан, ял оногдуулах, хөрөнгө хураах ажиллагаанд тодорхой хэмжээгээр оролцохыг зөвшөөрсөн байдаг. Гомдол гаргагч болон хохирогч нь шүүх хуралдаанд оролцож, мөрдөн шалгах, яллах ажиллагааны явцад салбарын мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж болно. Шүүхээс шууд нөхөн сэргээх талаар шийдвэр гаргахад дөхөм байх үүднээс хохирогчдыг бүх үе шатанд татан оролцуулахыг олон улс оронд дэмждэг. Шүүхээс хүссэний дагуу хохирогчид зөвлөгөө өгөх, эсхүл шүүхэд мэдүүлэг өгөх боломжийг нь олгож болно. Гэсэн хэдий ч ажиллагаа хэрхэн өрнөх, мэдүүлэг авах хүмүүс,

нотлох баримт цуглуулах, шүүхэд нөхөн төлбөр, хохирол нэхэмжлэх талаар хүсэлт гаргах зэрэг асуудлыг эцсийн дүндээ мэргэжилтнүүд л хариуцан ажилладаг.

ШИГТГЭЭ 11.5 Гаити: Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улсын оролцооны ач холбогдол

Оршил: 2001 оны 5-р сараас 2003 оны 4-р сар хүртэл Гаитигийн төрийн өмчит харилцаа холбооны компанийн (Haiti Teleco) олон улсын асуудал эрхэлсэн захирал асан Роберт Антуан АНУ-ын харилцаа холбооны гурван компаниас хахууль авч, зуучлагчаар дамжуулан мөнгө хүлээн авчээ.

Гаити, АНУ–ын хамтын ажиллагаа: Гаити Антуан болон холбогдох аливаа зуучлагчдын эсрэг авлигын эсрэг шаардлагатай хууль тогтоомж, гэмт хэрэг үйлдэхэд шаардагдах мөрдөн байцаалтын хэрэгсэл зэрэг хуулийн хангалттай заалт байхгүй байсан тул түүнийг үргэлжлүүлж чадаагүй юм. Гаитигийн эрх баригчид АНУ-ын эрх баригчидтай энэ хэргийг хянаж үзээд эцсийн дүндээ АНУ-ын эхлүүлсэн хэргийг дэмжих нь хамгийн зөв арга хэмжээ болно гэж шийджээ.

АНУ Антуаныг гадаадын хээл хахуулийн схемтэй холбогдуулан мөнгө угаах хуйвалдаан хийсэн хэргээр, мөн Гадаадын авлигын эсрэг хууль (FCPA)-ыг зөрчсөн, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх зорилгоор хээл хахууль өгсөн болон зуучлагчдын эсрэг хэрэг үүсгэсэн. Гаитигийн эрх баригчид АНУ-ын прокуроруудад шаардлагатай бүх нотлох баримт, шинжээчдийг идэвхтэй хайж, гаргаж өгөх замаар хамтран ажилласан. Гаитигийн санхүүгийн тагнуулын алба (CTA), үндэсний цагдаа, Хууль зүй, олон нийтийн аюулгүй байдлын яам зэрэг олон эрх бүхий байгууллагаас тусламж хүссэн бөгөөд тусламж үзүүлсэн. Ийм тодорхой хамтын ажиллагаагүйгээр АНУ-д цааш явах боломжгүй байх байсан.

Шийтгэх тогтоол, ял оногдуулах, хөрөнгийг хураан авах: Антуан гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, 2010 оны 6-р сард анх 48 сарын хорих ял шийтгэгдсэн. Хожим нь түүний ялыг "хууль сахиулах байгууллагад их хэмжээний туслалцаа үзүүлсэн" учир 18 сар болгон бууруулсан. Тэрээр нөхөн төлбөрт 1,852,209 ам.доллар төлөхөөр шийдвэрлэгдсэн бөгөөд үүн дээр нэмж, 1.5 сая гаруй ам.долларыг хураан авсан байна.[a]

a. АНУ-ын Хууль зүйн яам, 2010 он. "Гаити Улсын төрийн албан тушаалтан асанд гадаадын хээл хахуулийн схемтэй холбоотой мөнгө угаах хуйвалдааны хэрэгт оролцсон хэргээр хорих ял оноолоо." Мэдээллийн дугаар. 10-639, 2010 оны 6-р сарын 2. https://www.justice.gov/opa/pr/ former-haitian-government-official-sentenced-prison-his-role-money-laundering-conspiracy АНУ ба Роберт Антуаны хэрэг (S.D. Fla. 2010), Эрүүгийн хэргийн нэмэлт өөрчлөлт оруулсан шийдвэр

Эх газрын, эсхүл холимог эрх зүйн тогтолцоонд хохирогчид (төр, засгийн газрыг оролцуулан) иргэний хувьд гадаад улсад эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулж, иргэний тал болж болно. Иргэний хэргийн оролцогчид нотлох баримт болон нэхэмжлэлийн шаардлагаа прокурор, эсхүл мөрдөх эрх бүхий магистратад гаргаж өгөх, гэрчийн, эсхүл сэжигтний мэдүүлэг авах ажиллагаанд оролцох, хавтаст хэрэгтэй танилцах боломжтой. Прокурор, эсхүл мөрдөх эрх бүхий магистрат нь хэргийг мэтгэлцүүлэн шүүх хуралдаанд оруулах хангалттай нотлох баримт бүрдсэн эсэхийг эцэслэн тодорхойлно. Хэргийг мэтгэлцүүлэн шүүх хуралдаан эхэлсэн бол иргэний талууд иргэний хэргийн шүүхэд ханддагтай адилаар хохирлыг барагдуулах шийдвэр гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болно. (Энэ талаар 10 дугаар бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү). Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа нь эрүүгийн хэргийн хамт, тухайн үндэслэл болон нотлох баримт дээр тулгуурлан явагддаг.

Зарим улсын хууль, эрх зүйд гомдол гаргагч болон иргэний талуудад хэргийн талаарх мэдээллийг авах, тэр дундаа хавтаст хэргийн материалыг хуулбарлан авах боломжийг олгодог. Тухайлбал, прокурор, мөрдөх эрх бүхий магистратыг томилсон тохиолдолд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийг төлөөлж буй өмгөөлөгчид хүсэлтийн дагуу хавтаст хэргийн хуулбарыг өгнө.[6]

11.5 Гадаад улсад байршуулсан хөрөнгийг буцаах талаар баталгааг гаргуулах нь.

Зарим улсад, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болох хураагдсан, эсхүл битүүмжлэгдсэн хөрөнгийг буцаан олгох захирамжийг шүүх, эсхүл бусад эрх бүхий байгууллагаас гаргадаг. Өмчлөлийн асуудал тодорхой биш, эсхүл гэмт хэргийн арга хэрэгсэл, олсон орлого, нотлох баримт болох тохиолдолд хөрөнгийг хураан авах ажиллагааг эцэслэхээс өмнө заримдаа буцаах ажиллагааг хийх тохиолдол байдаг.[7] Үүнээс гадна НҮБ-ын Авлигын Эсрэг Конвенц (UNCAC)-ын 53 дугаар зүйлд заахдаа, яллах ажиллагаа явагдаж байгаа улс нь хөрөнгө буцаах ажиллагаанаас өмнө нөгөө улсдаа нөхөн төлбөр, хохирлоо нэхэмжлэх, эсхүл хууль ёсны өмчлөлийн асуудлаа тодруулах боломж олгохыг үүрэг болгодог.

Ийм захирамжаар буцаан олгоогүй хөрөнгө нь гадаадын буюу бусад улсын өмч болох магадлалтай. Иймээс, хөрөнгөө эргүүлэн авахыг хүссэн улс нь тэдгээр хураагдсан орлогыг эргүүлэн авах, эсхүл хэсэглэн хуваах эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй. Шүүхийн харьяалал болон дагаж мөрдөх журмаас хамааран олон улсын конвенц, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнүүд, хөрөнгө хуваалцах гэрээ, эсхүл хууль тогтоомжоор дамжуулан хөрөнгийг буцаан авах боломжтой. Гадаад улсаас бие даан хэрэг үүсгэсэн ч гэсэн авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улс нь хөрөнгөө эргүүлэн авах боломжтой.

11.5.1 Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үед хулгайлагдсан хөрөнгийн өмчлөлийн талаар хүсэлт гаргах нь

Зарим улс оронд хулгайлагдсан эд хөрөнгийн өмчлөлийг мөрдөн шалгах ажиллагааны эхний шатанд шийдвэрлүүлэх боломжтой байдаг.[8] Хөрөнгийг илрүүлсэн бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тодорхойгүй байвал прокурор эсхүл мөрдөх эрхтэй магистрат уг хөрөнгийг сэжиглэгдсэн гэмт хэргээс олсон орлого, эсхүл хэрэгсэл мөн эсэхийг тогтоохыг оролдлого хийх нь зүйтэй. Хэрэв тухайн холбоо харилцаа нь тогтоогдвол битүүмжилсэн эд хөрөнгийг буцаан олгох талаар захирамжилж болно. Эдгээр захирамжийг давж заалдах боломжтой.

---

[6] Франц Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг жишээ болгон харна уу. 114 зүйл, R.155, R.165. дугаар бүлэг.

[7] Тунис Улс ийм эд хөрөнгө хүлээн авсан тохиолдол гарсан, үүнд өмнө нь шүүгдэгчдийн эзэмшлийн компанийн мэдэлд байсан Швейцарь Улсад хураагдсан онгоцыг багтсан байна. Мөн Итали, Испани улсууд өөрийн улсад явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байсан ч 2 ширхэг дарвуулт онгоцыг буцаасан, Парист хураагдсан онгоцыг Франц Улс буцаан олгосон байна.

[8] Франц болон Швейцарь улсууд энэхүү процессын журмыг зөвшөөрдөг.

11.5.2 Гадаадын шүүхээр дамжуулан хөрөнгөө шууд эргүүлэн авах

Олон шүүхүүд гэмт хэргийн хохирогч, эсхүл хөрөнгийн хууль ёсны эзэмшигчийн статусаа баталсан гадаадын этгээдэд шууд нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэдэг. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 53 дугаар зүйлд, "оролцогч улс (а) авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улсад хохирлыг нөхөн төлүүлэх, барагдуулахаар хөрөнгө буцаах ажиллагааг хянан шийдвэрлэж буй шүүхэд зөвшөөрөх, эсхүл (б) тус улсын шүүх, эсхүл эрх бүхий байгууллагад хөрөнгө буцаах ажиллагаа хийгдэж буй эд хөрөнгийн хууль ёсны эзэмшигч гэх нөгөө улсын нэхэмжлэлийг авч хэлэлцэхийг зөвшөөрнө" гэсэн байдаг. Практикт энэ нь ихэвчлэн улсуудын хооронд байгуулсан олон улсын гэрээнд тусгагдсан байдаг.

Авлигын гэмт хэргийн улмаас хохирсон улс нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчээр, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргагч, эсхүл хохирогчоор (нэхэмжлэгч), эрүүгийн хэрэгт иргэний оролцогч байх замаар тус тус оролцож, хөрөнгөө шууд буцаан авдаг. Эрүүгийн хэрэгт хохирогчийг иргэний төлөөлөгчөөр оролцуулахыг зөвшөөрдөг улсын хуульд авлигын улмаас хохирсон улс нь хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авахаар шүүхэд хандах боломжтой байхаар заасан. Нөгөөтэйгүүр, хохирсон улс нь гадаад улсын прокурортой боломжит нөхөн төлбөр, хохирлын талаар ярилцах замаар шүүхэд шийдвэрлүүлэхийг хүсэж болно. Шигтгээ 11.6-д шууд хөрөнгө буцаах ажиллагааг практик жишээгээр үзүүлэв.

Цагаатгагдсан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт нь улс бүрт харилцан адилгүй байна. Зарим улсад нэхэмжлэлийг авч хэлэлцэхгүй бөгөөд хохирогч тал хохирлыг нөхөн төлүүлэхээр иргэний журмаар нэхэмжлэл гаргадаг. Бусад тохиолдолд, нотлох баримт хангалттай бол шүүх цагаатгасан ч хохирлыг барагдуулах шийдвэр гаргаж болно.

ШИГТГЭЭ 11.6 Хөрөнгийг шууд буцаах талаар практик

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох иргэний тал

Францад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2 дугаар зүйлд, нэхэмжлэгч авлигын үйлдлээс үүдсэн хувийн болон шууд хохирлоо нотолж чадвал эрүүгийн шүүхээс иргэний нөхөн төлбөр авах боломжтой гэж заасан. Канн хотын захирагч асантай холбоотой авлигын хэрэгт Канн хотын захиргаа (эрүүгийн ажиллагаанд иргэний төлөөллөөр оролцсон) шүүхээс хохирлыг барагдуулах шийдвэр гаргаж чадсан ч эд материалын нөхөн төлбөр олгоогүй. Нэр хүнд унасан гэсэн үндэслэлээр хохирлыг барагдуулсан боловч энэ нь авлигын хэргийн улмаас бус, тусгай зөвшөөрлийг цуцлах, татгалзах тухай сайдын шийдвэрийн улмаас учирсан хохирол байсан тул барагдуулахаас татгалзсан.

Хэргээ хүлээсэн тохиолдлын нөхөн төлбөр

Их Британид гүүр барьдаг Mabey & Johnson компани нь Гана, Ямайкийн төрийн албан тушаалтнуудад хахууль өгсөн, НҮБ-ын Газрын тосоор хүнс солих хөтөлбөрийн хүрээнд хийсэн гэрээн дор Ирак дахь Саддам Хуссейн дэглэмд хууль бусаар төлбөр хийсэнтэй холбогдуулан "хөрөнгө босгосон" хэрэгт тус тус буруутай гэж үзжээ. Тус компани бага мөнгөн дүнтэй гэрээ байгуулах байсан бөгөөд Иракийн ард түмэн буцаан олголтыг төлөх хөрөнгөө алдсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн.[a]

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 11.6 Хөрөнгийг шууд буцаах талаар практик

Үүнд 4.6 сая фунт (ойролцоогоор 7.2 сая ам. доллар) торгууль бүхий ял ногдуулсан бөгөөд Гана, Ирак, Ямайкийн засгийн газарт төлөх нөхөн төлбөр, зардалд 2 сая фунт (ойролцоогоор 3.1 сая ам. доллар) багтсан. Иракийн хэргийн тухайд гэрээний үнэ болох 4,22 сая евро, хүү (ойролцоогоор 5,41 сая ам. доллар) -ийг хурааж, Иракийн ард түмэнд Иракийн хөгжлийн сан) 618,484 фунтын (ойролцоогоор 969,100 ам. доллар) нөхөн олговор олгосон.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нөхөн төлбөр олгох буюу нөхөн олговор олгох

Нигерийн авлигын хэрэг үйлдсэн албан тушаалтны (Плато мужийн амбан захирагч асан Жошуа Дарие) нэр дээрх Лондон дахь хөрөнгө мөнгө, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хэрэгт Лондон хотын цагдаагийн газраас явуулсан мөрдөн байцаалтын дүнд үл хөдлөх хөрөнгийн менежерийг мөнгө угаасан хэргээр эрүүгийн хэрэг үүсгэн шийтгэсэн байна. Энэ хэргийн дараа Лондонгийн дээд шүүхэд гаргасан иргэний нэхэмжлэлийн дагуу хулгайлагдсан хөрөнгийг Нигери улс эргүүлэн авчээ. (Дариегийн хэргийн талаар илүү дэлгэрэнгүйг 3-р бүлгийн Шигтгээ 3.4-ийг үзнэ үү.)

а. Роб Эванс, Дэвид Лэй нарын хэрэг. 2009 он. "Мэйби, Жонсон нар гэрээ байгуулахын тулд гадаадын албан тушаалтнуудад авлига өгсөн гэдгээ хүлээн зөвшөөрөв." Гардияан 2009 оны 07 дугаар сарын 10-ны өдөр https://www.theguardian.com/business/2009/jul/10/mabey-johnson-guilty-plea-compensation.

11.5.3 Гэрээ, хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу эд хөрөнгийг буцаан олгох

Олон улсын хэд хэдэн конвенцод хөрөнгө буцаах ажиллагааг үүрэг болгосон байдаг.[9] Эдгээр олон улсын конвенцуудыг хэрэгжүүлэхийн тулд олон талт болон хоёр талт гэрээнүүд (эрх зүйн харилцан туслалцааны гэрээ гэх мэт), гэрээ хэлцлүүд, харилцан ойлголцлын санамж бичиг болон хууль тогтоомжийн эрх бүхий байгууллагууд зэргийг ашиглан хөрөнгийг буцаан олгохыг зөвшөөрдөг.

Хураагдсан хөрөнгийг буцаан олгох үүргийн талаар тусгаагүй бол олон талт болон хоёр талт хөрөнгө хуваалцах гэрээ, эсхүл улсуудын хооронд байгуулсан санамж бичигт эдгээр механизмын тодорхой журмыг тогтоож болно.[10] Ийм гэрээг тухайн

[9] АЭК-ын 57 дугаар зүйл; ҮДЗБГХ-ийн эсрэг конвенцийн 14 дүгээр зүйл болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар зүйл. АЭК-д хөрөнгө буцаан авах ажиллагааны явцад зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагыг тусгасан бол ; ҮДЗБГХ-ийн эсрэг конвенц болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцид сонгон хэрэгжүүлэх боломжтой шаардлагуудыг тусгасан байна.

[10] Олон улсын конвенцийн хүрээнд хураагдсан хөрөнгийг захиран зарцуулах гэрээний талаар заасан байдаг. АЭК-ийн 57 дугаар зүйл; ҮДЗБГХ-ийн эсрэг конвенцийн 14 дүгээр зүйл; НҮБ-ын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар зүйл.

тохиолдол бүрээр, эсхүл илүү оновчтойгоор, бүх хөрөнгө хуваах тохиолдлыг хамрах зорилготой байнгын хөрөнгө хуваах гэрээгээр хэлэлцэж болно.[11]

Зарим улсууд хязгаарлалт тогтоох арга хэмжээг авахаас өмнө, эсхүл уг арга хэмжээг дагаж мөрдсөн боловч хураах эцсийн захирамж гарахаас өмнө хөрөнгийг хуваалцах тохиролцоог хийхийг илүүд үздэг. 2017 оны Хөрөнгийн нөхөн сэргээх дэлхийн форум (GFAR) нь хөрөнгө хуваах хэлэлцээр хийхэд баримтлах 10 зарчмыг гаргасан (GFAR 2017). Эдгээр зарчмуудыг 9-р бүлгийн Шигтгээ 9.8-д дэлгэрэнгүй тайлбарласан болно.

БОТА санг үүсгэн байгуулсан санамж бичиг (Шигтгээ 11.7), Сани Абачагийн хэргийн жишээнд хүсэлт гаргасан улстай байгуулсан түр гэрээ (Шигтгээ 11.8), мөн Абачагийн жишээнд өөр нэгэн хүсэлт хүлээн авсан улсаас хөрөнгө буцаах үйл ажиллагаа явуулах санамж бичиг (Шигтгээ 11.9) зэрэг амжилттай үйл ажиллагааны жишээг энэхүү бүлэгт авч хэлэлцлээ.

ШИГТГЭЭ 11.7 Казахстан: БОТА санг байгуулах эрх зүйн үндэс болох харилцан ойлголцлын санамж бичиг

Оршил: 1999 онд Швейцарийн шүүгчид Швейцарийн банкны дансанд байсан 84 сая ам.долларыг битүүмжлэх тушаал гаргасан бөгөөд Казахстаны засгийн газар тус хөрөнгийг өөрийн эзэмшлийнх гэж мэдэгджээ. 2003 онд АНУ-ын Хууль зүйн яамнаас эрүүгийн хэрэг үүсгэн шалгасны дараа прокуророууд АНУ-ын холбогдох иргэдийг утсаар залилан мэхэлсэн, мөнгө угаасан, гадаадын авлигын үйл ажиллагааны хууль (FCPA) зөрчиж газрын тос хайх эрх олж авахын тулд Казахстаны албан тушаалтнуудад хахууль өгсөн гэх үндэслэлээр буруутгагдсан.

Хөрөнгө буцаан олгох тухай санамж бичиг: Швейцарийн банкин дахь дансанд байгаа мөнгийг царцаах, дараа нь захиран зарцуулах талаар АНУ, Швейцарийн хоорондын 1999 онд хэлэлцээ хийж эхэлсэн. Дэлхийн банк 2005 онд зуучлагч бөгөөд техникийн зөвлөхөөр энэ хэрэгт оролцсон. 2007 онд Казахстан, Швейцар, АНУ-ын гурван засгийн газар эцэст нь тохиролцоонд хүрч, Швейцар улсаас БОТА санд хөрөнгө шилжүүлэх нөхцөл, болзлыг тодорхойлсон харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан (Борнштейн 2016, 2). Санхүүжилтийг нийт "БОТА хөтөлбөр"-ийн хүрээнд гурван хөтөлбөр (доор дурдсан) байгуулж, хэрэгжүүлэхээр тохиролцсон. Засгийн газрууд 2008 оны 4-р сард нэмэлт өөрчлөлт оруулж, дахин гарын үсэг зурсан санамж бичигт БОТА-г Казахстаны иргэдийн зөвлөлтэй, Казахстаны орон нутгийн байгууллага байхыг уриалсан (Борнштейн 2016, 14).

Тус сан ба түүний эрхэм зорилго: "БОТА хөтөлбөр" нь Казахстаны ядуу хүүхдүүдийн сайн сайхны төлөө төсөл хэрэгжүүлэх, тэдний төлөө захиран зарцуулахад чиглэгдсэн. Үүнийг Казахстан улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэх, Дэлхийн банкны хяналтад байх ашгийн бус, төрийн бус сан болох БОТА сангаар дамжуулан хэрэгжүүлэхээр тохиролцсон бөгөөд тус сан нь санхүүжилтийг хүлээн авч, зарцуулах эрхтэй байна (Борнштейн 2016).

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

[11] АНУ-д хөрөнгө хуваан эзэмших албан ёсны гэрээ нь хэргийг эцэслэж дуустал хэрэгжиж эхэлдэггүй бөгөөд хэргийн харьяалал хариуцсан бусад байгууллагаас хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны хэмжээгээр үнэлэгддэг: Гадаад улсын эрх бүхий байгууллага нь "зайлшгүй" тусламж үзүүлсэн тохиолдолд хураагдсан хөрөнгийн 50-80 хувь, "их хэмжээний" тусламж үзүүлсэн бол 40–50 хувь, гадаадын харьяалал "дэм болох" тусламж үзүүлсэн бол 40 хүртэл хувь байна.

ШИГТГЭЭ 11.7 Казахстан: БОТА санг байгуулах эрх зүйн үндэс болох харилцан ойлголцлын санамж бичиг

Авлигатай холбоотой 115 сая ам.долларыг буцаан авах зорилготой Казахстан, Швейцарь, АНУ-ын засгийн газар болон Казахстаны таван иргэн 2008 онд "БОТА" санг үүсгэн байгуулжээ (IREX болон Хүүхдийг Ивээх Сан 2015, 4). Эдгээр хөрөнгийг Казахстаны ядуу иргэдийн амьдралыг сайжруулах, ялангуяа ядуу хүүхэд, залуучууд, тэдний гэр бүлийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжид нь хөрөнгө оруулалт хийх замаар дэмжихэд зарцуулсан.[a] БОТА сан нь болзолт мөнгөн тэтгэмжийн хөтөлбөр, нийгмийн үйлчилгээний хөтөлбөр, сургалтын төлбөрийн тусламжийн хөтөлбөр гэсэн гурван хөтөлбөрийн хэлтэстэй байсан.

Хяналт: Дэлхийн банк Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, захиргааны дэмжлэг үзүүлэх, сангийн зорилгыг баталгаажуулах зорилгоор олон улсын төрийн бус байгууллагатай (Олон улсын судалгаа, солилцооны зөвлөл [IREX]) гэрээ байгуулсан (IREX ба Хүүхдийг Ивээх Сан 2015, 7, 9).

Түүнчлэн Дэлхийн Банкны орон нутгийн санхүүгийн удирдлагын ажилтан тус сангийн нягтлан бодох бүртгэлийг тогтмол хянаж байв.

Өв: Сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн 2009 оноос хойш 2014 оны 12-р сард үйл ажиллагаагаа дуусгах хүртэл тус сан 208,000 гаруй хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, ядуурлын байдлыг сайжруулж чадсан (IREX болон Хүүхдийг Ивээх Сан, 49). Тус сан нь авлигын улмаас олж авсан хөрөнгийг олон мянган хүний амьжиргааны нөхцөлийг сайжруулахад хэрхэн ашиглагдаж болохыг харуулсан, дэлхий даяарх хөрөнгө буцаах ажиллагаа, хөрөнгийн хэргийг удирдах үлгэр жишээ болохуйц чухал өв үлдээсэн юм. Тус сан нь санхүүгийн бололцоо доогуур хүмүүсийн амьдралд эерэг нөлөө үзүүлэхээс гадна 100 гаруй ажилтнуудыг ажилд авч, сургасан бөгөөд тэдгээр нь одоо олон улсын янз бүрийн агентлагуудад туршлагаа хуваалцаж байна (IREX болон Хүүхдийг Ивээх Сан 2015, 50). Бота Сангаар дамжуулан 115 сая гаруй ам.долларыг амжилттай эх оронд нь буцаан авчирсан нь иргэний нийгмээр дамжуулан хөрөнгө буцаах ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой бөгөөд хөрөнгө буцаан авах үйл явцын алхам бүрд тодорхой үүрэг гүйцэтгэж болохыг харуулсан (IREX болон Хүүхдийг Ивээх Сан 2015, 51).

a. БОТА сан. 2015 он. "БОТА сан зорилгоо биелүүлэв." БОТА сангийн зар мэдээ, 2015 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр, (July 31, 2020). https://star.worldbank.org/corruption-cases/sites/corruption-cases/files/Kazakh_Oil_BOTA%20 Fdn_End_Announcement_Dec_2014.pdf

ШИГТГЭЭ 11.8 Нигери: Нигерийн диктатор генерал асан Сани Абачагийн хулгайлсан хөрөнгийг буцаан авах тухай АНУ, Нигери, Жерсигийн хооронд байгуулсан хөрөнгө буцаах гэрээ.

Оршил: Генерал Сани Абача (1993 -1998 онд Нигерийн ерөнхийлөгч байсан) болон түүний хамтран зүтгэгчид Нигерийн Засгийн газар болон бусад хүмүүсээс олон тэрбум доллар шамшигдуулж, завшсан, улмаар АНУ-ын санхүүгийн байгууллагуудаар дамжуулан гэмт хэргээс олсон орлогоо ашигласан юм.

2014 онд АНУ-ын Хууль зүйн яамнаас гаргасан иргэний гомдлын дагуу АНУ-ын Колумб дүүргийн дүүргийн шүүхээс Абачагийн авлигаас олсон орлоготой холбогдох дэлхийн өнцөг булан бүрд байрлах дансанд байсан 500 сая орчим ам.долларыг хураах шийдвэр гаргажээ.

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 11.8 Нигери: Нигерийн диктатор генерал асан Сани Абачагийн хулгайлсан хөрөнгийг буцаан авах тухай АНУ, Нигери, Жерсигийн хооронд байгуулсан хөрөнгө буцаах гэрээ.

Гурван талт гэрээ: Жерси өөрийн харьяалалд байсан 308 сая гаруй ам.долларыг хураах АНУ-ын шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэв. 2020 оны 2-р сарын 3-нд АНУ-ын Хууль зүйн яам эдгээр хөрөнгийг Нигери руу буцаах зорилгоор Нигери, Жерси улстай гурван талт хэлэлцээр байгуулав.

Гурван талт хэлэлцээрийн дагуу АНУ, Жерси хоёр Нигери дахь дэд бүтцийн төслийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх зорилгоор хураасан цэвэр хөрөнгийг 100 хувь Нигерт шилжүүлэхээр тохиролцсон. Тэдгээр дэд бүтэц нь Нигерийн хоёр дахь гүүр, Лагос-Ибадан хурдны зам, Абужа-Кано Зам бөгөөд тэдгээр бүс нутгуудад суурьшиж буй иргэдэд ашиг тусаа өгөх хөрөнгө оруулалт байв.

Энэхүү гэрээнд Нигерийн Хөрөнгө оруулалтын газар нь санхүү болон төслүүдийг удирдах, бие даасан аудит нь санхүүгийн хяналт хийх, бие даасан иргэний нийгмийн байгууллага нь үйл ажиллагааны хяналт хийх зэрэг ил тод, хариуцлагатай байдлыг хангах үндсэн арга хэмжээг багтаасан болно.

Энэхүү гэрээ нь 2016 оны 12-р сард Вашингтон хотноо болсон Хөрөнгийг Буцаах асуудлаарх дэлхийн форумаас (GFAR) баталсан ил тод байдал, хариуцлагыг хангах зарчмуудыг тусгасан бөгөөд тус форум нь Хулгайлагдсан хөрөнгийг буцаах байгууллага (StAR), Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн газар (GFAR 2017)-ын тус тус дэмжлэгтэйгээр АНУ, Их Британи хамтран зохион байгуулсан.

ШИГТГЭЭ 11.9 Швейцар дахь хөрөнгө буцаах сонголтууд: Абачагийн хэрэгт харилцан ойлголцлын санамж бичгийг ашиглах нь

Оршил: Швейцар Улс дахь эд хөрөнгө нь гэмт хэрэгтэй холбоотой, өмчлөх эрх нь тодорхой тогтоогдсон гэдэгт шүүгч "дотоод итгэлтэй" байвал түүнийг хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгоно. Хэрэв өмчлөх эрх нь тодорхойгүй эсхүл тодорхойлох боломжгүй бол (шилжүүлсэн, эргүүлэн татсан, бусад мөнгөтэй холилдсон гэх мэт) шүүгч гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг хураах шийдвэр гаргаж, хураагдсан эд хөрөнгийг Швейцарийн засгийн газрын өмч болгоно. Хулгайлагдсан эд хөрөнгөө эргүүлэн авахыг хүссэн улс нь тодорхой гэрээ, шийдвэрийн үндсэн дээр Швейцарь Улсын төрийн эрх баригчидтай хэлэлцээ хийж, хураагдсан хөрөнгийг буцаан авах боломжтой. Эсхүл, эрүүгийн шүүх нөхөн төлбөр авахыг хүссэн улсад гэрээний, эсхүл гэм хорын хохиролтой тэнцэх хэмжээний төлбөрийг гаргаж болно.

Абачагийн хэргийн тухайд Нигери улс 2005, 2006 онд Швейцариас 752 сая ам. долларын хөрөнгийг амжилттай эргүүлэн авчээ.[a] 2017 онд Швейцарийн эрх баригчид Абачагийн хэргээр 300 сая орчим ам.долларыг Нигерт буцааж өгсөн. 2017 онд төлөгдсөн хөрөнгийн тухайд 2016 оны 12-р сард болсон Хөрөнгө Буцаах Дэлхийн Форум (GFAR)-ын хүрээнд Нигери, Швейцар, Дэлхийн банк харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд үүнд Швейцар Улс 300 сая орчим ам.долларыг Нигери рүү буцаах тухай тохиролцсон байна. Санамж бичгийн хүрээнд Дэлхийн банк нь Үндэсний

(үргэлжлэл дараагийн хуудсанд)

ШИГТГЭЭ 11.9 Швейцар дахь хөрөнгө буцаах сонголтууд: Абачагийн хэрэгт харилцан ойлголцлын санамж бичгийг ашиглах нь

нийгмийн аюулгүй байдлын нэгдсэн төсөл (NSSNP) дор шууд бэлэн мөнгө шилжүүлэх ажиллагаанд хяналт тавьж оролцжээ.[b]

Нийгмийн нийгмийн аюулгүй байдлын нэгдсэн төсөл (NSSNP): Энэ төсөл нь зорилтот бүлгийн ядуу, эмзэг өрхүүдэд мөнгөн тэтгэмж олгох зорилготой юм.[c] 2019 оны 5-р сарын байдлаар уг төслийн 37 сая ам.доллар зорилтот бүлгийн 300,000 ядуу өрхөд хүрч, үлдсэн 50 сая ам.долларыг үргэлжлүүлэн олгохоор ажиллаж байв.[d]

Хяналт: Нигерийн иргэний нийгмийн байгууллагууд санамж бичгийг байгуулахын өмнөх хэлэлцээ болон зарцуулсан хөрөнгийн хяналтад чухал үүрэг гүйцэтгэсэн. Африкийн Байгаль орчин, эдийн засгийн шударга ёсны нийгэмлэг (ANEEJ) нь Их Британийн Олон улсын хөгжлийн яамны (DFID) санхүүгийн дэмжлэгтэйгээр буцаасан хөрөнгийн зарцуулалт болон эцсийн ашиглалтад хяналт тавьжээ.[e] Эхний ээлжийн хяналт шалгалтын хүрээнд иргэний нийгмийн түншлэгч 35 байгууллагаас бүрдсэн 500 ажиглагчийг газар дээр нь илгээж, мэдээлсэн мэдээллийг баталгаажуулж, ашиг хүртэгчдийн судалгааг хийж, бэлэн мөнгөний зарцуулалтыг биечлэн гэрчлэв. Спот шалгалтаар нийт 11 мужид хамрагдагчдын бүртгэлийг баталгаажуулсан бөгөөд хяналтад хамрагдсан иргэдийн 90 гаруй хувь нь сард нэг өрхөд дор хаяж 5,000 найра (ойролцоогоор 16 ам. доллар)-ын тэтгэмж авсан гэж мэдээлсэн байна.

Энэхүү санамж бичгийн үйл ажиллагааны нь Хөрөнгө Буцаах Дэлхийн Форумын 4 ба 10-р зарчмуудад нийцэж, эргүүлэн авсан хөрөнгийг захиран зарцуулах үйл явцад ил тод, хариуцлагатай байх, иргэний нийгэм, төрийн бус болон олон нийтэд түшиглэсэн байгууллагуудыг оролцуулсан байна. (GFAR 2017).

Өв: Уг төсөл нь Нигери улсын үндэсний болон мужийн түвшинд ядуу өрхүүдэд дэмжлэг үзүүлэх үндэсний аюулгүй байдлын цогц системийн үндэс суурийг тавьсан юм.[f] Дараагийн том төсөл нь үндэсний аюулгүй байдлын цогц тогтолцоог бий болгох, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, тэр дундаа ядуу, эмзэг бүлгийн өрхүүдийн үндэсний бүртгэл, зорилтот механизмыг бий болгох зэрэг багтана.

a. https://star.worldbank.org/content/gfar-principles-action-mantra-projects-monitoring-disbursement-abacha-ii-funds-nigeria.
b. Дэлхийн банк ба UNODC (НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба). "GFAR-ын зарчмыг хэрэгжүүлэх нь: Нигери дахь MANTRA төслийн Абача II сангийн зарцуулалтын хяналт." StAR-ын 3 дугаар улирлын тайлан, 2019 оны 10 дугаар сар (2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр). https://star.worldbank.org/content/gfar-principles-action-mantra-projects-monitoring-disbursement-abacha-ii-funds-nigeria.
c. Дэлхийн банк. 2016 он. "Дэлхийн банк Нигерийн хамгийн ядуу иргэдэд нийгмийн тусламж үзүүлэхэд хагас тэрбум долларын тусламж үзүүлэв." Хэвлэлийн мэдээ, 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдөр https://www.worldbank.org/en/news/press-release/2016/06/07/world-bank-commits-half-a-billion-dollars-toprovide-social-assistance-to-nigerias-poorest.
d. Дэлхийн банк ба UNODC, "GFAR зарчмыг хэрэгжүүлэх нь," 2019 оны 10 дугаар сар.
e. Дэлхийн банк ба UNODC, "GFAR зарчмыг хэрэгжүүлэх нь," 2019 оны 10 дугаар сар.
f. Дэлхийн банк, "Хураангуй," Нийгмийн аюулгүй байдлын үндэсний сүлжээ төсөл (2020 07 дугаар сарын 11), https://projects.worldbank.org/en/ projects-operations/project-detail/P151488?lang=enP151488

Ном зүй

Bornstein, Aaron. 2016. “The BOTA Foundation: A Model for the Safe Return of Stolen Assets?” Case Study No. 1, Philanthropication thru Privatisation (PtP) project of the East-West Management Institute, New York. http://p-t-p.org/wp-content /uploads/ PtP_Bota-Foundation-Case-Study_Bornstein.pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. “International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation: The FATF Recommendations.” Recommendations adopted by the FATF Plenary in February 2012, updated June 2019, FATF, Paris. https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

GFAR (Global Forum on Asset Recovery). 2017. “GFAR Principles for Disposition and Transfer of Confiscated Stolen Assets in Corruption Cases.” Statement of principles adopted at inaugural GFAR meeting, December 4–6, Washington, DC. https://star .worldbank.org/sites/star/files/the-gfar-principles.pdf.

IREX (International Research & Exchanges Board) and Save the Children. 2015. “The BOTA Foundation: Final Summative Report.” Report, IREX, Washington, DC; Save the Children, London. https://www.irex.org/sites/default/files/node/resource/bota -foundation-final-report.pdf.

OECD (Organisation for Economic Co-operation and Development) Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions (OECD Anti-Bribery Convention) (adopted 1997; entered into force 1999), OECD, Paris. http://www.oecd.org/daf/anti-bribery/ConvCombatBribery_ENG.pdf.

UNCAC (United Nations Convention against Corruption, UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (December 20, 1988), United Nations, Vienna. https://www.unodc .org/ pdf/convention_1988_en.pdf.

UNTOC (United Nations Convention against Transnational Organized Crime, UN General Assembly Resolution 55/25 (November 15, 2000), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/55/25.

Нэр томьёоны тайлбар

Administrative confiscation. Захиргааны журмаар хөрөнгө хураан авах.

Гэмт хэргийн замаар бий болсон, эсхүл хууль бус үйлдэлд ашиглагдсан, эсхүл холбогдсон хөрөнгийг хураан авах шүүхийн бус арга хэмжээ.

Assets. Хөрөнгө.

Биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх зэрэг бүх төрлийн хөрөнгө, мөн эдгээр хөрөнгийн талаарх эрх, ашиг сонирхлыг нотлох эрх зүйн баримт бичиг, эсхүл хэрэгсэл.[1]

Энэ нэр томьёо нь **property** /өмч/-тэй адил хэрэглэгддэг.

Bona fide purchaser. "Шударга эзэмшигч"-/Innocent owner/-ийн тодорхойлолтыг харна уу.

Coercive investigation techniques. Мөрдөн шалгах тодорхой ажиллагааны арга техник. Хууль тогтоомж, шүүхийн, эсхүл бусад эрх бүхий байгууллагын зөвшөөрөл олгосноор хууль сахиулах байгууллагын зүгээс гэмт хэрэг үйлдсэн байж болох хүн, эсхүл гуравдагч этгээдийн зөвшөөрөлгүйгээр авах боломжтой аргуудыг ерөнхийд нь мөрдөн шалгах тодорхой ажиллагааны арга техник гэдэг. Үүнд ихэвчлэн үзлэг нэгжлэг, электрон /цахим/ ажиглалт, санхүүгийн баримт бичгийн шалгалт, эсхүл мэдээлэл лавлагаа авах, мөн гуравдагч этгээдийн мэдэлд байгаа баримт бичгийг гаргуулан авах зэрэг илүү нарийвчилсан техник ажиллагаанууд багтдаг. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт (MLA) нь нотлох баримтыг ихэвчлэн дээр дурдсан аргаар гаргуулан авахад чиглэдэг.

Civil action. Иргэний нэхэмжлэл гаргах. "Хувийн эрх зүйн нэхэмжлэл гаргах"- /Private law action/-ыг харна уу.

Claimant. Нэхэмжлэгч. Хөрөнгө, эсхүл маргааны талаар ашиг сонирхлоо илэрхийлж байгаа тал. Үүнд гуравдагч этгээд, шударга эзэмшигч, хариуцагч, нэхэмжлэлийн шаардлага, эсхүл зөрчил гаргагч орно.

Commingled assets. Холимог хөрөнгө. Гэмт хэргийн замаар олсон орлого, эсхүл хэрэгсэлтэй шударгаар олж авсан бусад хөрөнгө холилдсон байх.[2]

Confiscation. Хураан авах. Шүүх, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийг бүрмөсөн хураах.[3] Энэ нэр томьёо нь **forfeiture** /хураах/-тэй адил хэрэглэгддэг. Зарчмын хувьд, хураан авах шийдвэр гарснаар тодорхой сан, эсхүл хөрөнгийг эзэмшиж байсан хувь хүн, эсхүл хуулийн этгээд энэ талаарх бүх эрхээ алддаг. (FATF 2019).

Conviction-based confiscation. Шийтгэх тогтоолд үндэслэн хөрөнгө хураан авах. Хураан авах ажиллагааг явуулж эхлэхээс өмнө шүүгдэгч шийтгүүлсэн байхыг шаарддаг бөгөөд энэ нь хураан авах ажиллагааны бүх хэлбэрт хамааралтай.

Criminal confiscation. Эрүүгийн хэрэгт хөрөнгө хураан авах. "Шийтгэх тогтоолд үндэслэн хөрөнгө хураан авах"/Conviction-based confiscation/-ыг харна уу.

---

[1] Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (UNCAC), 2-р зүйл. 2(e).

[2] Холимог хөрөнгийн талаар 7-р бүлгийн 7.3.1-ээс үзнэ үү.

[3] UNCAC, 2-р зүйл (g). Мөн FATF (2010)-ыг үзнэ үү.

Defendant. Хариуцагч/Шүүгдэгч. Шүүхэд иргэний нэхэмжлэл гаргасан тохиолдолд нэхэмжлэгчийн гомдолд хариу өгч байгаа аливаа этгээд, эсхүл эрүүгийн хуулийг зөрчсөн гэж буруутгагдаж, албан ёсоор ял сонссон этгээд.

Ex parte proceedings. Экс парте процесс. Ямар нэг хүнийг эзгүйд нь буюу төлөөлөлгүйгээр, эсхүл мэдэгдэлгүйгээр явагддаг хууль зүйн процесс.

Financial intelligence unit (FIU). Санхүүгийн тагнуулын алба (FIU). "i) гэмт хэргээс олсон болон терроризмыг санхүүжүүлж байж болзошгүй сэжигтэй гүйлгээтэй холбоотой, эсхүл (ii) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор үндэсний хууль тогтоомж, эсхүл дүрэм журамд заасны дагуу шаардагдах санхүүгийн мэдээллийг хүлээн авах, (мөн зөвшөөрвөл хүсэлт гаргах), дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагад хүргүүлэх, мэдээлэх үүрэгтэй үндэсний төв байгууллага."

Forfeiture. Хураах. "Хураан авах"/Confiscation/-ыг үзнэ үү.

Freezing. Царцаах. "Түр зуурын арга хэмжээ"- /Provisional measure/-г үзнэ үү. Мөн 5-р бүлгийг үзнэ үү.

Gatekeeper. Гейткипер. Мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой гүйлгээг хийхэд дэмжлэг үзүүлэх боломжтой мэргэжлийн хүн. Ийм боломжтой хүмүүст ерөнхийдөө нягтлан бодогч, хуульч, санхүүгийн зөвлөх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч эсхүл санхүүгийн байгууллагад данс эзэмшиж, үйлчлүүлэгчдийнхээ нэрийн өмнөөс хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг санаатай болон санамсаргүй байдлаар шилжүүлэх, нуун дарагдуулдаг бусад мэргэжилтнүүд багтана. Гэмт этгээдүүд санхүүгийн системд нэвтрэхийн тулд хаалгачийг ашиглан, өөрсдөө нэрээ нууцалж, тодорхойгүй үлдэх боломжтой. (FATF 2001,2007). Хаалгачийн үүрэг гүйцэтгэгчийг ихэвчлэн "дэмжлэг үзүүлэгч" гэж нэрлэдэг.[4]

Hearsay. Дам яриа. Тухайн асуудлын талаарх үнэнийг батлах нотлох баримт гэж шүүхэд танилцуулж байгаа мэдэгдэл юм. Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий оронд дам яриаг үгүйсгэдэггүй бол нийтийн эрх зүйн тогтолцоонд нотлох баримтад тооцдоггүй. (зарим тохиолдолд). Нотлох баримтаар хүлээн авсан тохиолдолд ямар хэмжээнд түүнийг хүлээн авч байгаагаа шүүх харгалзан үзэх ёстой.

Informal assistance. Албан бус туслалцаа. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг (MLA) албан ёсоор бичих шаардлагагүйгээр олон улсын түвшинд хамтран ажиллах замаар туслалцаа үзүүлж буй бүх хэлбэр. Салбарын мэргэжилтнүүд энэ төрлийн туслалцааг хоорондоо үзүүлэх болон эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны талаар зохицуулсан хууль тогтоомж байж болно.

Innocent owner. Шударга эзэмшигч. Хураан авах эд хөрөнгийг хураахад хүргэсэн үйлдлийн талаар мэдээгүй бөгөөд хураагдах эд хөрөнгөд ашиг сонирхол бүхий, үнэнч шударгаар худалдан авсан гуравдагч этгээд. Энэ нэр томьёо нь **bona fide purchaser** /жинхэнэ худалдан авагч/-тай адил хэрэглэгддэг.

In personam. "Тодорхой хүнд чиглэсэн" гэсэн утгатай латин үг. Хөрөнгө хураах, эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргах агуулгатай холбож үзвэл, энэ нь тодорхой хүний эсрэг чиглэгдсэн хууль ёсны үйлдэл байдаг.

---

[4] 1996 оны 11-р сард Ромд болсон Эгмонт бүлгийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан тодорхойлолтод 2004 оны 6-р сард Гернсид болсон Эгмонт бүлгийн нэгдсэн хуралдааны үеэр өөрчлөлт оруулсан

In rem. “Тодорхой эд зүйлд чиглэсэн” гэсэн утгатай латин үг. Хөрөнгө хураах ажиллагааны агуулгатай холбон үзвэл, энэ нь тодорхой эд зүйл, эсхүл хөрөнгийн эсрэг чиглэгдсэн хууль ёсны үйлдэл байдаг. “Өмч-суурьтай хураан авах ажиллагаа”/ Property-based confiscation/-наас харна уу.

Instrument or instrumentality. Багаж хэрэгсэл эсхүл арга хэрэгсэл. Хар тамхи, эсхүл бэлэн мөнгө зөөвөрлөхөд ашиглах боломжтой машин, завь гэх мэт гэмт хэргийг хөнгөвчлөхөд ашигладаг хөрөнгө.

Know your customer (KYC). Харилцагчийг таньж мэдэх. Санхүүгийн болон бусад холбогдох байгууллагууд харилцагчаа таньж мэдэх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд хамаарах мэдээллийг тодруулах зорилгоор заавал мөрдөх ёстой банкны журам.

Letters rogatory. Шүүхийн захидал. Гадаад улсын шүүхээс нөгөө улсын шүүхэд хандан ямар нэгэн төрлийн хууль зүйн туслалцаа хүсэж буй албан ёсны хүсэлт. Энэхүү хүсэлтийн дагуу нөгөө улсын шүүх, прокурор, эсхүл хууль сахиулах байгууллагын ажилтнууд албан ёсоор харилцах боломжтой. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны тодорхой хэлбэр юм.

Mutual legal assistance (MLA). Эрх зүйн харилцан туслалцаа. Улс орнууд мэдээ, мэдээлэл цуглуулах, мөрдөн шалгах ажиллагааны явцад ашиглах нотлох баримтыг (албан ёсны сувгаар) цуглуулах туслалцаа хүсэх, үзүүлэх; шаардлагатай таслан сэргийлэх арга хэмжээ авах; болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой үйл явцыг хэлнэ. Энэхүү *Гарын авлага*-ын албан бус (**informal assistance** /албан бус туслалцаа/-г харна уу) болон албан ёсны (**mutual legal assistance request** /эрх зүйн харилцан туслалцаа/-г харна уу) туслалцааны хоорондох ялгааг гаргаж өгсөн. 8 болон 9 дүгээр бүлгийг үзнэ үү.

Mutual legal assistance request. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт. Энэ хүсэлт нь олон талт, эсхүл хоёр талт гэрээ, хэлэлцээр болон дотоодын хууль тогтоомжид заасан тусгай журам, протоколын дагуу бичигддэг. Нотлох баримтыг цуглуулах (мөрдөн байцаалтын албадлагын арга хэмжээг оролцуулан), түр арга хэмжээ авах, дотоодын эрх бүхий байгууллагын шийдвэрийг гадаад улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх зэрэг тохиолдолд энэхүү хүсэлтийг ашигладаг.

Non-conviction based confiscation (NCB confiscation). Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураах. Шүүхийн шийтгэх тогтоол гарсан эсэхээс үл хамааран хөрөнгө хураах. (FATF 2010)

Open-source intelligence (OSINT). Мэдээллийн нээлттэй эх сурвалж. Мэдээллийн нээлттэй эх сурвалжийг ерөнхийдөө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, эсхүл интернэт зэргээс үнэ төлбөргүй, төлбөртэй, эсхүл захиалах маягаар хууль зүйн аль ч арга замаар цуглуулах боломжтой, нийтэд ил мэдээлэл гэж тодорхойлдог.

Politically exposed persons (PEPs). Улс төрд нөлөө бүхий этгээд. “Улс төрд нөлөө бүхий этгээд. “Нийтийн албаны нэр хүнд бүхий албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, түүнтэй хамаарал бүхий этгээд" (Greenberg et al. 2010).

Practitioner. Салбарын мэргэжилтэн. Хууль сахиулах байгууллагуудад ажиллаж байгаа мөрдөгч, мөрдөх эрх бүхий магистратууд, хувийн хуульч, шүүх нягтлан бодогч, санхүүгийн шинжээч нар болон прокуроруд багтдаг. Эдгээр байгууллагууд нь дангаараа, эсхүл бүгд тус тусын харьяалах байгууллагын тухай хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагааны явцад тодорхой үүрэг гүйцэтгэж ажилладаг.

Private law action. Хувийн эрх зүйн нэхэмжлэл гаргах. Эрүүгийн бус журмаар хувийн зүгээс гаргаж байгаа нэхэмжлэл, эсхүл үйл ажиллагаа байдаг. Энэ төрлийн үйл ажиллагааны түгээмэл хэлбэр бол хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээ зөрчигдсөнтэй холбоотой нэхэмжлэлүүд байдаг. 10-р бүлгийг мөн үзнэ үү.

Proceeds of crime. Гэмт хэргийн замаар бий болсон орлого. Гэмт хэрэг үйлдэх замаар шууд эсхүл шууд бус замаар олж авсан, эсхүл бий болгосон аливаа эд хөрөнгө.[5] Ихэнх орнуудад холимог хөрөнгийг үүнд багтаадаг.

Property. Өмч. "Хөрөнгө"/Asset/-ийг үзнэ үү.

Property-based confiscation. Өмч-суурьтай хураан авах ажиллагаа. Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эсхүл хэрэгсэл болох нь тогтоогдсон тодорхой зүйл, эсхүл хөрөнгийг хураах ажиллагаа юм. Энэ ойлголт нь мөн ***in rem*** хураах ажиллагаа, эсхүл "tainted property" /бохирдсон хөрөнгө/ гэсэн ойлголттой ижил утгаар хэрэглэгддэг.

Provisional measures. Түр арга хэмжээ. Шүүх, эсхүл бусад эрх бүхий байгууллагын шийдвэрт үндэслэн хөрөнгийг шилжүүлэх, хувиргах, захиран зарцуулах, шилжүүлэхийг түр хугацаагаар хориглох, эсхүл эд хөрөнгийг хадгалах, хянах эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ.[6] Энэхүү ойлголт нь **царцаах, хязгаарлах, хураах,** хавсаргах, блоклох зэрэг ойлголтуудтай ижил утгаар хэрэглэгддэг.

Requested jurisdiction. Хүсэлт хүлээн авагч улс. Хөрөнгө буцаах, эсхүл мөрдөн шалгах, яллах болон шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг хүссэн хүсэлтийг нөгөө улсаас хүлээн авсан улс.

Requesting jurisdiction. Хүсэлт гаргагч улс. Хөрөнгө буцаах, эсхүл дотооддоо мөрдөн шалгах, яллах болон шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд дэмжлэг авах зорилгоор өөр улсад хүсэлтийг илгээсэн улс.

Restraint. Түр арга хэмжээ-г харна уу. Мөн 5 дугаар бүлгийг үзнэ үү.

Seizure. Түр арга хэмжээ-г харна уу. Мөн 5 дугаар бүлгийг үзнэ үү.

Seller for value. Үнэ цэнийг худалдагч. Хөрөнгийг хураан авах зүйл, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл болохыг нь мэдээгүй, эсхүл үндэслэл бүхий шалтгаанаар мэдээгүйгээр үнэ цэнэд тулгуурлан худалдах ажиллагаа хийж байгаа хүн. bona fide seller /жинхэнэ худалдагч/.

Special investigative techniques. Мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга техникүүд нь гэмт бүлэглэлд оролцох, удирдах, хүн худалдах, далайлган сүрдүүлэх, авлигын болон мөнгө угаах зэрэг онц ноцтой хэргүүдийг мөрдөн шалгахад тусгайлан хэрэглэгддэг. Мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга нь интрузив байдлын өндөр түвшинг илэрхийлдэг бөгөөд утас чагнах, цахим /электрон/ ажиглалт, халхавчилсан ажиллагаа явуулах, үзлэг нэгжлэг хийх, баривчлах болон ял тохиролцох зэрэг аргуудыг жишээ болгон дурдаж болно. Эдгээр аргуудыг ихэвчлэн шүүхийн зөвшөөрөлтэйгөөр ашигладаг ба гадаад улсын нутаг дэвсгэрт хэрэглэн нотлох баримтуудыг цуглуулах тохиолдолд голдуу эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх шаардлагатай байдаг.

---

[5] UNCAC, 2-р зүйл (e).

[6] НҮБ-ын АЭК, 2-р зүйл (f)-тэй нийцүүлсэн. Түр арга хэмжээний талаарх дэлгэрэнгүйг 5 дугаар бүлгийн 5.3 хэсгээс харна уу.

Substitute assets. Дагалдах хөрөнгө. Гэмт хэрэгтэй холбоогүй боловч хураагдах хөрөнгийн хамт хураагдах эд хөрөнгө. Үндсэн хөрөнгө нь гэмт хэрэгт шууд хамааралтай бөгөөд дагалдах хөрөнгөгүйгээр байршуулах, эсхүл олж авах боломжгүй байж болно.

Suspicious activity report (SAR). Сэжигтэй үйл ажиллагааны тайлан (SAR). Сэжигтэй гүйлгээний тайланг үзнэ үү.

Suspicious transaction report (STR). Сэжигтэй гүйлгээний тайлан (STR). Сэжигтэй, эсхүл сэжигтэй байж болзошгүй гүйлгээ, үйл ажиллагааны талаар санхүүгийн байгууллагаас гаргасан тайлан. Уг тайланг санхүүгийн тагнуулын алба харьяалан гаргадаг (FIU). Энэ нэр томьёог сэжигтэй үйл ажиллагааны тайлан (SAR) гэсэн ойлголттой адил хэрэглэгддэг.

State capture. Төр олзлогдох. Хувь хүмүүс болон төрийн албан тушаалтнууд өөрт олгогдсон давуу талаа ашиглан Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад үлэмж хэмжээгээр нөлөөлж, хариуцлагын механизмыг үр дүнгүй болгох боломжтой тогтолцооны улс төрийн авлигын нэг төрөл.

Tainted property. Бохирдсон хөрөнгө. "Өмч-суурьтай хураах ажиллагаа" /Property-based confiscation/-г харна уу.

Target эсхүл targets. Бай, эсхүл байнууд. Мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжиглэгдэж байгаа хүн, эсхүл сэжиг бүхий этгээдүүд.

Value-based confiscation. Үнэлгээнд суурилсан хураан авах ажиллагаа. Гэмт хэргийн улмаас үүссэн ашиг, эсхүл мөнгөн торгуультай дүйцэхүйц үнэ цэнэ бүхий зүйлийг хураан авах ажиллагаа.

Ном зүй.

FATF (Financial Action Task Force on Money Laundering). 2001. “Report on Money Laundering Typologies, 2000–2001.” Report of the FATF Secretariat, Organisation for Economic Co-operation and Development, Paris. http://www.apgml.org /includes/handlers/get-document.ashx?d=3d225555-d45d-44b8-8b32 -a0ceeb781978.

FATF (Financial Action Task Force). 2007. “Guidance on the Risk-Based Approach to Combating Money Laundering and Terrorist Financing: High Level Principles and Procedures.” Guidance document, FATF Secretariat, Organisation for Economic Co-operation and Development, Paris. http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/High%20Level%20Principles%20and%20Procedures.pdf.

FATF (Financial Action Task Force). 2010. “Best Practices: Confiscation (Recommendations 3 and 38).” Guidance document adopted by FATF plenary, February 19, 2010. FATF Secretariat, Organisation for Economic Co-operation and Development, Paris. http://www.fmu.gov.pk/docs/FATF%20Guidance%20Documents/BPP_Confiscation_R3_&_R38_(February_2010).pdf.

FATF (Financial Action Task Force). 2019. “Interpretive Note to Special Recommendation III: Freezing and Confiscating Terrorist Assets.” https://ms.hmb.gov.tr /uploads/2019/01/EK-13.pdf.

Greenberg, Theodore S., Larissa Gray, Delphine Schantz, Carolin Gardner, and Michael Latham. 2010. Politically Exposed Persons: Preventive Measures for the Banking Sector. Stolen Asset Recovery (StAR) Series. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/2441/542500PUB0Expo101Public.pdf?sequence=1&isAllowed=y.

United Nations Convention against Corruption (UNCAC), UN General Assembly Resolution 58/4 (October 31, 2003), United Nations Office on Drugs and Crime (UNODC), Vienna. https://undocs.org/en/A/RES/58/4.

Хавсралт А. Яллагдагчаар татвал зохих хэргүүдийн жагсаалт

Салбарын мэргэжилтнүүд нь эрүүгийн олон төрлийн гэмт хэргүүдээс аль зүйл хэсгээр яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэхдээ Зураг А.1-д заасан хэргүүдийг харгалзан үзэж болно.

ЗУРАГ А.1 Хөрөнгө буцаах ажиллагааг явуулахад харгалзан үзэх хэргүүд



Эх сурвалж: Дэлхийн банк

Хууль бусаар эзэмших буюу сан, өмчийг шамшигдуулах

Энэхүү ойлголтод доор дурдсан гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд хамаарна.

Хулгайлах, эсхүл дээрэмдэх. Энэ төрлийн гэмт хэргүүдийг ерөнхийдөө аливаа биет бөгөөд хувийн эд хөрөнгийг хууль ёсны эзэмшигч, өмчлөгчөөс нь салгах зорилгоор хууль бусаар авах, эзэмших үйлдэл гэж тодорхойлж болно. Энгийнээр тайлбарлавал, хууль ёсны эзэмшигч, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр (зарим бүс нутагт эзэмшигч, өмчлөгчийн зөвшөөрлийг авахдаа хуурч мэхлэсэн бол мөн тооцно) түүний эд хөрөнгийг авах тухай ойлголт юм. Нийтийн зориулалттай ойн бүс, тусгай хамгаалалт бүхий газар нутгаас зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэх, төв банкаас бэлэн мөнгө, чек болон санхүүгийн хэрэгсэл (хувьцаа, бонд г.м) хууль бусаар авах нь нийтийн албан тушаалтнаас үйлдэгддэг энэ төрлийн гэмт хэргийн жишээ билээ. Зарим бүс нутгийн хуульд үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой үйлчилгээ, биет бус эд хөрөнгийг Хулгайлах* (зөвхөн биет эд зүйлийг хууль бусаар авах гэсэн утгаар) төрлийн гэмт хэргийн халдлагын зүйлд тооцдоггүй байна.

Завших. Энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хувь хүн, хуулийн этгээдийн хууль ёсны эзэмшил, өмчлөлд байгаа эд хөрөнгийг зориулалтын бусаар буюу хууль бусаар, өөрийн хувийн ашиг сонирхлын төлөө бусдад шилжүүлэх, зарцуулах гэж тодолхойлж болно. Төрийн байгууллага, албан тушаалтнаас үйлдэгдэх хэлбэр нь Засгийн газрын эрхийг хэрэгжүүлэгч нэгжүүдэд (төв, орон нутгийн удирдлага, Засгийн газрын агентлаг,Төрийн өмчит компани г.м) төсөвлөгдөж, хуваарьлагдвал зохих байсан хөрөнгө, мөнгийг шамшигдуулах, зориулалтын бусаар зарцуулах хэлбэрээр илэрдэг. Тухайлбал, тухайн эд хөрөнгийн хууль ёсны эзэмшигч, өмчлөгчийн өмнөөс, тэдгээрийг төлөөлөн эд хөрөнгийг нь эзэмших, хуваарьлах, зарцуулах эрх гэрээ, хэлцлээр олгогдсон этгээд уг харилцан зөвшилцлийн нөхцлөө зөрчих үйлдэл юм. Зарим бүс нутагт үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой үйлчилгээг шамшигдуулах үйлдлийг Завших төрлийн гэмт хэрэг гэж үздэггүй.

Тодорхой жишээ гэвэл, хөлсөлж аван цалинжуулсан ажилтан нь гүйцэтгэвэл зохих ажлаа хийгээгүй байх (no-show jobs), зах зээлийн үнэлгээнээс хэт дээгүүр үнээр бараа, бүтээгдэхүүн худалдаж авах (overbilling), аливаа бараа, бүтээгдэхүүнийг тухайн мөчид шууд эзэмшилдээ оруулах боломжгүй нөхцлөөр худалдах, худалдан авах хэлцэл хийж, холбогдох төлбөрийг төлсөн ч эзэмшилдээ оруулах үед уг бараа, үйлчилгээ нь анх хэлцэл хийх үед тодорхойлсон шинж чанартай нийцэхгүй байх (fictitious billing) зэрэг болно.

Залилах, төөрөгдөлд оруулах, хууран мэхлэх. Үүнд хамаарах гэмт хэргийг субъектив шинжээс хамаарч 2 янзаар тодорхойлдог: бусдын эд хөрөнгө өмчлөх эрх болон эд хөрөнгийг авах зорилгоор (a) санаатайгаар хуурч мэхлэх, эсхүл (b) болж өнгөрсөн болон тухайн цаг үе дэх бодит нөхцөл байдлын талаар буруу мэдээлэл өгөх.

Зарим мужийн хууль тогтоомжид зааснаар, бусдын эд хөрөнгийг гагцхүү биет байдлаар эзэмшилдээ шилжүүлэн авсан (өмчлөх эрх нь хууль ёсны өмчлөгчид хадгалагдсан хэвээр) дээрх үйлдлүүдийг “ов мэх” ашиглан үйлдсэн “Хулгайлах” гэмт хэрэгт тооцдог байхад зарим нь халдлагын зүйлийг эзэмшилдээ оруулсан тохиолдолд хүндрүүлэн зүйлчлэх нь ч бий.

Залилах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг санаатайгаар хуурч, мэхлэх арга хэрэглэсэн эсэхэд дүгнэлт хийж зүйлчилж байгаа хэдий ч “хуурах” үйлдлийг хууль зүйн хувьд янз бүрээр тайлбарлаж болохыг анхаарах хэрэгтэй. Нийтлэг жишээнээс

дурдвал, Төрийн байгууллагад удирдах албан тушаал хашдаг Б, түүнд захирагддаг албан хаагч нартаа нэр бүхий компанийн данс руу төлбөр төлөх эсхүл тэдгээрт зээл олгох тухай чиглэл өгөв. Гэтэл бодит байдал дээр уг компани нь албан ташаалтан Б-тэй хамаарал бүхий этгээд эсхүл жинхэнэ эзнийг нуух зорилгоор ажиллаж байгаа хэн нэгнээр удирдуулсан, бодит байдал дээр ямар ч бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй компани байв.

Хахууль болон бусад холбогдох хэргүүд

"Хээл хахууль, эрх нөлөөг нь урвуулан ашиглуулах, чиг үүргээ урвуулан ашиглах болон бусад гэмт хэргүүд" гэсэн ойлголтод доор дурдсан гэмт хэргүүд хамаарна.

Үндэсний төрийн албан тушаалтныг (тухайн улсын) хахуульдах (Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 15 дугаар зүйл) хэрэг нь дараах үйлдлийг санаатайгаар үйлдсэн хэрэг байна:

- Албан тушаалтан нь эрхэлж буй ажил, эрх мэдлээ ашиглан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэрэгжүүлсний хариуд, түүнд эсхүл бусад хүн, хуулийн этгээдэд (зүй бус) давуу байдал бий болгох тухай аливаа этгээдээс тус албан тушаалтанд шууд буюу шууд бусаар амлах, санал болгох, ийм давуу байдлыг олгох хэлбэрээр;
- Албан тушаалтан нь эрхэлж буй ажил, эрх мэдлээ ашиглан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэрэгжүүлсний хариуд, өөртөө эсхүл бусад хүн, хуулийн этгээдэд (зүй бус) давуу байдал бий болгохыг аливаа этгээдээс шууд буюу шууд бусаар шаардах эсхүл дээр дурдсанчлан, санал болгосон давуу байдлыг хүлээж авах.

Гадаад улсын нийтийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтанд авлига, хээл хахууль өгөх (Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 16 дугаар зүйл) хэрэг нь дараах үйлдлийг санаатайгаар үйлдсэн хэрэг байна:

- Албан тушаалтан нь эрхэлж буй ажил, эрх мэдлээ ашиглан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэрэгжүүлсний хариуд, түүнд эсхүл бусад хүн, хуулийн этгээдэд (зүй бус) давуу байдал бий болгох тухай аливаа этгээдээс тус албан тушаалтанд шууд буюу шууд бусаар амлах, санал болгох, ийм давуу байдлыг олгох хэлбэрээр илэрнэ. Зорилго нь бизнес эрхлэх, эсхүл олон улсын бизнесийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой бусад давуу байдлыг олж авах, хадгалахад оршино.
- Албан тушаалтан нь эрхэлж буй ажил, эрх мэдлээ ашиглан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэрэгжүүлсний хариуд, өөртөө эсхүл бусад хүн, хуулийн этгээдэд (зүй бус) давуу байдал бий болгохыг аливаа этгээдээс шууд буюу шууд бусаар шаардах эсхүл дээр дурдсанчлан, санал болгосон давуу байдлыг хүлээж авах.

Эрх нөлөөг нь урвуулан ашиглуулах (Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 18 дугаар зүйл) хэрэг нь дараах үйлдлийг санаатайгаар үйлдсэн хэрэг байна:

Аливаа этгээд өөртөө болон бусдад тухайн улсын захиргааны буюу нийтийн байгууллагаас хууль бусаар аливаа хэлбэрийн дэмжлэг авахын тулд эрх мэдэл бүхий (эсхүл шаардлагатай эрх мэдэл бүхий гэж таамагласан) нийтийн албан тушаалтан ба бусад хүнийг эрх мэдлээ урвуулан ашиглахад нь (зүй бус) давуу тал олгох, олгохоо амлах, санал болгох зэргээр шууд болон шууд бусаар нөлөөлөх

- Албан тушаалтан ба аливаа этгээд нь бусдын нөлөөллөөр өөрийн эрх мэдлээ урвуулан ашиглаж тухайн улсын захиргааны болон нийтийн байгууллагаас дэмжлэг авсны хариуд, өөртөө эсхүл бусад хүнд (зүй бус) давуу байдал бий болгохыг будаас шууд буюу шууд бусаар шаардах эсхүл дээр дурдсанчлан, санал болгосон давуу байдлыг хүлээж авах.

Чиг үүргээ урвуулан ашиглах (Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 19 дүгээр зүйл) гэдэг нь албан тушаал, эрх мэдэл бүхий этгээд өөртөө болон бусад хүн, хуулийн этгээдэд давуу байдал олж авахын тулд хууль зөрчин гүйцэтгэж байгаа үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих (Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 20 дугаар зүйл) гэдгийг нийтийн албан тушаалтан хууль ёсны орлого нь мэдэгдэхүйц их хэмжээгээр өссөн шалтгааныг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байх явдал гэж тодорхойлсон байдаг. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа эрх бүхий албан тушаалтан нь холбогдох этгээдийг яллагдагчаар татах, уг хөрөнгийг нь хураан авч, улсын орлого болгоход тухайн хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг заавал нотлох шаардлагагүй. Гагцхүү нийтийн албан тушаалтны хууль ёсны орлого нь түүний шинээр үүссэн өмч, хөрөнгө ба зардлын эх сурвалж нь биш болохыг тайлбарлахад хангалттай. Харин үүний дараа, эд хөрөнгө нь хэрхэн нэмэгдсэн болохыг холбогдогч тайлбарлана. (Франц Улсын жишээг Шигтгээ-А.1-ээс харна уу.)

Ашиг сонирхлын зөрчил. Зарим улсад албан тушаалтан нь өөрийн байр суурь, эрх мэдэл, хяналт, эрхэлж байгаа ажлын нөлөөлөл орох аливаа зөвшөөрөл, гэрээ, хэлцэл, шийдвэр зэрэгт шууд болон шууд бусаар хувийн сонирхлоо илэрхийлэхийг гэмт хэрэгт авч үздэг. Тодруулбал, хувийн хэвшил дэх аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд албан үүргийн хувьд нөлөөлөх боломжтой эрх мэдэл бүхий төрийн албан хаагч нь тэдгээрт санхүүгийн хувьд хувийн ашиг сонирхолтой байх нь гэмт хэрэгт тооцогддог аж. Жишээ нь, нийтийн албан тушаалтны хамаарал бүхий буюу түүний эзэмшил, хяналтад шууд болон шууд бусаар харьяалагддаг компанид давуу байдал үзүүлж, төрийн байгууллагатай аливаа гэрээ хэлцэл хийж, түүний үр шимийг өөртөө хүртэх явдал нийтлэг хэлбэр юм.

Улс төрийн нам, эсхүл компанит ажлыг хууль бусаар санхүүжүүлэх. Улс төрийн болон авлига, хээл хахуультай холбоотой аливаа үйл ажиллагааг хууль бусаар санхүүжүүлэхийг хуулиар хориглосон байдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн төрийн байгууллагатай хийх гэрээ хэлцлийн үнийг өсгөж хөөрөгдөх хэлбэрээр илэрдэг. Улмаар тэдгээр гэрээлэгчид нь хуурамч нэхэмжлэх ирүүлсэн “Такси компани”(хууль бус үйлдлийн төлбөр болгон шилжүүлсэн мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгө авдаг тул ийнхүү нэрлэдэг) руу илүү төлөлтийн ашиг орлогоос мөнгө шилжүүлж, хариуд нь тэдгээр “такси компани” улс төрийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг байна. Энэхүү хуйвалдаанд оролцохоос татгалзсан гэрээлэгч төрийн байгууллагатай гэрээний үндсэн дээр авах байсан ажлаа алдсан нь тогтоогдсон тохиолдолд нийтийн албан тушаалтныг улс төрийн нам, эсхүл компанит ажлыг хууль бусаар санхүүжүүлэх гэмт хэргээс гадна рикетлэх, заналхийлэх-дарамтлах гэмт хэрэгт холбогдуулан шалгана.

ШИГТГЭЭ А.1	Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой Франц Улсын хуулийн заалтууд

Ял шийтгэл оногдуулах процесс

Хуулийн 321-6 дугаар зүйлд хэн нэгэн хүн "нэг буюу хэд хэдэн хүн өөрийн амьдралын хэв маягтай нийцүүлэн орлого, эсхүл хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарлаж чадаагүй бөгөөд энэ хэргийн улмаас, эсхүл хохирогчоос шууд болон шууд бусаар ашиг олсон тохиолдолд хүнд, эсхүл хүндэвтэр гэмт хэргийг байнга үйлдсэн гэж үзэж 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж заасан. Энэ гэмт хэрэгт гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх ба шийтгүүлсэн хүний хөрөнгийг бүхэлд нь хураах боломжтой.

Хөрөнгө хураах процесс

Хуулийн 131-21 дүгээр зүйлд шүүгдэгч хөрөнгөө хууль ёсны эх үүсвэрээс гаралтай гэдгийг баталж чадаагүй бол түүний хөрөнгийг бүхэлд нь хурааж болох талаар заасан. Энэ гэмт хэргийн улмаас шууд болон шууд бусаар ашиг олсон байх ба хамгийн багадаа таван жилийн хорих ял шийтгэгдэх ёстой.

Заналхийлэх, дарамтлах. Зарим улс оронд уг гэмт хэргийг тодорхойлохдоо, эрх мэдэл бүхий нийтийн албан тушаалтан бусдыг амаар болон бичгээр айлгах, заналхийлэх, албадах, сүрдүүлэх зэрэг хууль бус аргаар төлбөр, хураамж цуглуулах гэж тодорхойлдог.

Мөнгө угаах, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулах, олж авах, эзэмших, ашиглах гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэргийг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 23, 24 дүгээр зүйлүүдэд дараах байдлаар тодорхойлжээ:

- "Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний хууль бус гарал үүслийг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах эсхүл суурь гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд үйлдсэн хэргийнхээ хууль зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг эд хөрөнгийг хувиргах буюу шилжүүлэх;
- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулалт, хөдөлгөөн буюу өмчлөл эсхүл түүнтэй холбоотой эрхийг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах;
- Тухайн эд хөрөнгийг гэмт хэргээс олсон орлого гэдгийг түүнийг хүлээн авч байх үед мэдсээр байж түүнийг олж авах, эзэмших, ашиглах;
- Энэ зүйлд заасан аливаа гэмт хэрэгт хамтран оролцох, холбогдох, түүнийг үйлдэхэд хуйвалдах, үйлдэхийг завдах, мөн ийм гэмт хэрэг үйлдэхэд туслах, хатгах, дэмжих буюу зааж зөвлөх;
- Тухайн эд хөрөнгө нь энэхүү конвенцод заасан аливаа гэмт хэргийн үр дүн гэдгийг мэдсээр байж түүнийг санаатайгаар нуун дарагдуулсан буюу үргэлжлүүлэн эзэмшсэн."

Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн аливаа хөрөнгийн хууль бус эх сурвалжийг нуух зорилготой болохыг мэдсээр байж шилжүүлгийг хийсэн, оролцсон, дамжуулсан санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, бизнесийн байгууллага,

хувь хүн, санхүүгийн зуучлагч нарт хамааралтай. Мөнгө угаах гэмт хэрэгт яллагдагчаар татах ажиллагаа явуулахдаа хөрөнгө нөхөн сэргээх буюу эргэн төлүүлэх төлөвлөгөөг мөн орхигдуулахгүй байх нь чухал. Учир нь авлига авсан албан тушаалтан хууль бусаар олж авсан хөрөнгөө санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулах, тэдгээрээр дамжуулан зарцуулах шаардлага үүсдэг.

Ихэнх авлигын хэргүүд үйлдэгдэхэд мөнгө угаах схем багагүй дэмжлэг болж байдаг. Тухайлбал, дүр эсгэсэн нэхэмжлэхийн дагуу компанийн төлсөн мөнгө нь тэдгээртэй гэрээ байгуулсан эсхүл зөвлөх үйлчилгээ үзүүлдэг дундын санхүүгийн зуучийн оффшор дансанд шилжиж, дараа нь тухайн мөнгийг компанийн нэрийн өмнөөс уг зууч нар албан тушаалтнуудыг хахуульдахад ашигладаг байна. Ихэнх улс орнуудад, энэ мэт бохир мөнгөтэй холбоотой байгууллагыг мөнгө угаахын эсрэг хууль тогтоомжийн дагуу шалгадаг.

Бусад гэмт хэрэг

Энэ гэмт хэрэг нь дараах төрөл бүрийн гэмт хэрэг байж болно:

Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих. Нийтийн албан тушаалтан нь худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг зөрчихдөө ихэвчлэн тухайн төрийн байгууллагатай гэрээ байгуулагч этгээдэд шударга бус давуу байдлыг олгосон байдаг. Жишээлбэл, худалдан авах ажиллагааны үр дүнд гэрээ байгуулан хамтран ажиллах боломжтой оролцогчид тодорхой давуу байдлыг бий болгохын тулд худалдан авах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний захиалга өгсөн төрийн байгууллагын худалдан авалт хийх үнийн хязгаар зэрэг нийтэд ил бус мэдээллийг худалдан авах ажиллагааг зохион байгуулагч албан тушаалтнаас тухайн (тендерт) оролцогчид өгөх хэлбэрээр илэрч болно. Тийм маягаар, томоохон худалдан авах ажиллагааны гэрээг зохиомлоор жижиг (бага дүнтэй) гэрээнүүд болгож хуваан байгуулах замаар төслийн нийт өртгийг харгалзан үздэг, заавал явагддаг өрсөлдөөнт тендерээс зайлсхийдэг байна. Эсхүл, төрийн байгууллагын худалдан авах ажиллагаанд бараа, үйлчилгээ нийлүүлэхээр шалгарсан гэрээний оролцогч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад гэрээний нөгөө тал буюу захиалагч нь нийлүүлээгүй бараа бүтээгдэхүүн, үзүүлж амжаагүй үйлчилгээ, анх гэрээнд заасан чанар, тоо хэмжээнд үл нийцэх барааны үнийг урьдчилан төлөхийг зөвшөөрч зөвшилцдөг байна.

Хууль бусаар гэрээний үнийг их хэмжээгээр өсгөж байгуулсан гэрээнээс тендерт шалгарсан оролцогч ихээхэн ашиг хүртэнэ. Хариуд нь, тендерт шалгарсан оролцогчоос авсан буцаан олголт ба бусад давуу талууд нь худалдан авах ажиллагааг зохион байгуулсан төрийн албан хаагчид шан харамж болж өгдөг байна.

Үгсэн тохиролцох. Хуулиар хориглосон зорилгод хүрэх, эсхүл шударга бус давуу байдал олж авахын тулд бусдын хууль ёсны эрхийг хуурч мэхлэн авахаар хоёр ба түүнээс дээш этгээдийн хооронд байгуулсан гэрээ, хэлцлийг (ихэвчлэн нууцаар) үгсэн тохиролцох гэмт хэрэг гэж үзнэ. Тухайлбал, аж ахуйн нэгжүүдийн дунд, эсхүл аж ахуйн нэгж болон нийтийн албан тушаалтны хооронд байгуулсан өрсөлдөөнийг хязгаарлах, зохион байгуулах, төрийн худалдан авах ажиллагааны үнийг тогтоох зэрэг нууц хэлцэл нь авлигын хэрэгт түгээмэл тохиолддог. Тендерт оролцохоор бэлтгэж байгаа этгээдээс өгсөн мэдээлэл дээр үндэслэн нийтийн албан тушаалтан нь тендерт шалгарсан этгээдийн хийх ажлын тодорхойлолт, ажлын нөхцөл зэргийг боловсруулснаар хуйвалдаж байгаа нэг хэлбэр юм.

Бичиг баримт хуурамчаар үйлдэх. Энэ гэмт хэрэг нь эрх олгож, үүрэг хүлээлгэсэн, эрх, үүргийг бусдад шилжүүлсэн болон үүрэг хариуцлагаас чөлөөлсөн шинжтэй, хувь хүний болон нийтийн ямарч төрлийн бичиг баримтан дахь гол агуулга, огноо, талууд эсхүл гэрчийн гарын үсгийг хуурамчаар үйлдэх, мөн өөрчлөх явдлаар тодорхойлогдоно.

Нягтлан бодох бүртгэлийн гэмт хэрэг. Үүнд авлигын гэмт хэргүүд, хөрөнгө завших, нягтлан бодох бүртгэлийн гэмт хэргийг зохион байгуулах, үйлдэхэд дэмжлэг үзүүлэх нийтлэг арга, хэрэгсэл болох данс тооцоо, бүртгэлийн дэвтэр, баримт, санхүүгийн тайлан зэргийг хуурамчаар үйлдэхийг ойлгоно. Тухайлбал, компаниуд санхүүгийн зуучлагчдад төлсөн зохисгүй төлбөрийг нуун дарагдуулах, бохир мөнгийг шилжүүлэх, хахууль өгөхийн тулд тус тус зохиомол эсхүл буруу дүн бүхий нэхэмжлэх гаргаж харилцагчид илгээх буюу бусдаас илгээсэн ийм нэхэмжлэхийг хүлээн авч төлөхийг зөвшөөрдөг байна.

Гэмт хэргийг үйлдэх нийтлэг арга, хэлбэр нь санхүүгийн зуучлагчийн зүгээс хувийн компанид зөвлөх үйлчилгээ үзүүлэгч мэт дүр эсгэж, улмаар үйлчилгээний хөлсөө авахаар фирм рүү хуурамч нэхэмжлэх хүргүүлж, уг компани ч нэхэмжлэхэд дурдсан мөнгийг төлж, тийнхүү шилжүүлсэн мөнгийг зуучлагч нь албан тушаалтнуудыг хахуульдахад ашиглах хэлбэртэй байдаг. Энэ тохиолдолд, компанийн болон “зөвлөх үйлчилгээ үзүүлэгч” аль альных нь данс бүртгэл нь зохиомол гүйлгээг бүртгэдэг.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг. Энэ гэмт хэрэг үйлдэгдэхдээ, компанийн данс эсхүл санхүүгийн тайланд орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг гуйвуулж, буруу тусгаснаар компанийн хөрөнгө, орлого болон зардлыг хэтрүүлэн эсхүл дутуу үнэлэхэд хүргэж, улмаар татвар ногдох орлого, хасагдах зардлыг хууль бусаар өөрчлөхөд хүргэдэг. Энэ нь ихэвчлэн худалдан авалт хийсэн мэтээр холбогдох данс тооцоог (зардал) нэмэгдүүлэх зорилготой хуурамч, эсхүл худал дүн бүхий нэхэмжлэхийг ашигласан үед хэрэглэгдэх арга ба энэ мэтчилэн аж ахуйн нэгжийн татвар ногдох ашгийг бууруулдаг аж.

Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх. Авлигын хэргүүд, хөрөнгө завших, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэхэд ихэвчлэн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, бараа бүтээгдэхүүнийг хохирогч улсын хил, гаалиар хууль бусаар тээвэрлэж гаргах, шилжүүлэх эсхүл тээвэрлэж оруулах шаардлага үүсдэг. Түүнчлэн, татваргүй барааг импортолж аливаа улсад оруулж ирэхдээ зөвхөн тухайн орныг дамжин өнгөрүүлэх зорилгоор тээвэрлэлт хийнэ гэж гаальд мэдүүлдэг боловч үнэн хэрэгтээ тус улсад хууль бусаар худалдаалах байдлаар мөн хууран мэхэлдэг байна.

Шуудан, холбооны хэрэгсэл ашиглан бусдыг залилах. Зарим улс оронд шуудан, холбооны хэрэгсэл ашиглан бусдыг залилбал гэмт хэрэгт тооцдог. Жишээ нь, АНУ-д залилах аргаар бусдын мөнгө, эд хөрөнгийг авахын тулд төлөвлөгөө боловсруулж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд шуудан, харилцаа холбооны дэд бүтцийг (утас,факс, и-мэйл) ашиглах нь гэмт хэрэгт тооцогдоно. Энэхүү эрүүгийн гэмт хэрэг нь хууль бус гэж ерөнхийд нь тодорхойлоогүй байж болох арга замаар мөнгө олж авсан төрийн албан хаагчдад ч хамаарч болно.

Хуйвалдах. Хоёр ба түүнээс дээш этгээд ирээдүйд, тодорхой цаг хугацаанд хууль зөрчих үйлдэл хийхээр тохиролцсон тохиролцоог уг гэмт хэрэгт ойлгоно. Хуйвалдаанаар тохиролцсон үйлдлүүд нь ихэвчлэн залилах, авлигын хэргүүд, хөрөнгө завших, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэхэд чиглэгдсэн байдаг. Харин зарим улс оронд аливаа этгээдээс хуйвалдахаар тохиролцсон хэлцэлтэй холбоотой гэж

үзэхээр шууд санаатай үйлдлийг дор хаяж 1 удаа үйлдсэн бол энэ гэмт хэргээр зүйлчилдэг байна.

Гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэх, өдөөн хатгах. Хамтран оролцогч нь гэмт хэрэг үйлдэгдэхэд шууд оролцдоггүй ч гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлдэг. Хамтран оролцогчийг гүйцэтгэгчийн үйлдсэн үндсэн гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж, ижил төрлийн эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Шүүн таслах ажиллагаанд саад учруулах. Энэхүү гэмт хэргийг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 25 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ:

- энэхүү конвенцид дурдагдсан гэмт хэрэг үйлдсэнтэй холбоотой явагдаж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдыг худал мэдүүлэг өгөхийг ятгах, эсхүл мэдүүлэг өгч байх үед болон нотлох баримт гаргаж өгөх үед нөлөөлөх зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх буюу айлган сүрдүүлэх, эсхүл зүй бус давуу байдал амлах, санал болгох эсхүл олгох;
- энэхүү конвенцид дурдагдсан гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан албан үүргээ гүйцэтгэж байгаа шүүн таслах болон хууль сахиулах албан тушаалтанд хөндлөнгөөс нөлөөлөх зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх буюу айлган сүрдүүлэх.

Зарим улс орон болон эрх зүйн системийн хувьд, мөрдөн шалгах ажиллагаанд нотлох баримтыг нуун дарагдуулахыг мөн шүүн таслах ажиллагаанд саад учруулсан үйлдэл гэж үздэг.

Хавсралт В. Сонгон авсан хуулийн этгээд ба бизнесийн нөхцөлүүдийн талаарх тайлбар

“Корпорацийн бүтэц” нь олон төрлийн арилжааны үйл ажиллагаа явуулдаг ба хөрөнгө бүхий бүх хэлбэрийн хуулийн этгээд, хууль зүйн бүтцэд хамааралтай өргөн хүрээний ойлголт юм. Тэдгээр хуулийн этгээд болон үйл ажиллагааны хүрээ, хязгаарын тодорхойлолт, илэрхийлэл болон жишээнүүдийг доор харуулав.

Агентлаг/Agency: Агент буюу төлөөлөгч нь итгэмжлэгчтэй (ер нь бол үйлчлүүлэгч) байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг хүлээж ажиллах тохиолдолд агентлагийн харилцаа үүсдэг. Итгэмжлэгч-агент хоёрын харилцааны жишээ нь, үйлчлүүлэгч-өмгөөлөгч, үйлчлүүлэгч-нягтлан бодогч, ажил олгогч-ажилтан зэрэг болно. Агент нь өөрийн нэрийн өмнөөс бус харин үйлчлүүлэгчийг төлөөлж хуулийн этгээд байгуулах, банкинд данс нээх, менежментийн үйлчилгээ эрхэлж болно. Итгэмжлэл буюу трастаас ялгаатай нь,агентлагийн харилцаа үүссэнээр тухайн хөрөнгийг эзэмшиж буй дансыг, эсхүл эд хөрөнгийг захиран зарцуулах боломжгүй бөгөөд эд хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах хууль ёсны эрх нь төлөөлүүлж байгаа хүндээ үлддэг.

Холбоо/Association: Энэ нь гишүүнчлэлд суурилсан байгууллага бөгөөд гишүүд (хуулийн этгээд болон хувь хүн) нь, эсхүл тэдгээрийн сонгогдсон төлөөлөгчид нь байгууллагынхаа удирдах дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Холбоо нь нийгмийн ашиг тусын төлөө эсхүл гишүүдийн харилцан ашиг сонирхлын төлөө байгуулагдаж болно. Холбоо нь хуулийн этгээдийн статустай байх эсэх нь ихэвчлэн бүртгэгдсэн эсэхээс шалтгаална. Бүртгэлтэй холбоод нь бусад хуулийн этгээдтэй адил хөнгөлөлт эдэлж болно.

Бүртгэгдсэн хувьцаа/Bearer share: Энэ нь бүртгэгдсэн хувьцааны гэрчилгээг эзэмшдэг этгээд корпорацийн хувь эзэмшигч болохыг тодорхойлсон зөвшилцлийн хэрэгсэл юм. Хувьцаа эзэмшигчийн гэрчилгээг биечлэн эзэмшиж байгаа этгээд нь уг хувьцааг гаргасан корпорацийн хууль ёсны хувьцаа эзэмшигч гэж тооцогдох бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүх эрхийг эдлэнэ. Багагүй улс оронд эдгээр хэрэгслийг урвуулан ашиглахгүй байхын тулд, тухайлбал, хувьцааг хөдөлгөөнгүй болгох, материаллаг бус болгох гэх мэт хамгаалалтын арга хэмжээг нэвтрүүлсэн. Хөдөлгөөнгүй болгох гэдэг нь хувьцааг зохицуулалттай санхүүгийн байгууллага, эсхүл мэргэжлийн зуучлагчид хадгалуулахыг ойлгоно. Бүртгэгдсэн хувьцааг нэрлэсэн хувьцаа, эсхүл хувьцааны баталгаанд хөрвүүлэх шаардлагатай үед материаллаг бус болгоно. Түүнчлэн, улс орнууд бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийг хувьцаанд санал өгөх, ногдол ашиг цуглуулах, эсхүл хяналтын багцын тодорхой хувийг эзэмшихийг хүссэн тохиолдолд өөрийн хувийн мэдээллийг компанид тайлагнаж, компани нь мөн холбогдох мэдээллийг бүртгэхийг шаардаж болно.

Эцсийн өмчлөгч/Beneficial owner: Эцсийн өмчлөгч гэдэгт хуулийн этгээдийг, эсхүл түүний хөрөнгөнөөс хүртсэн ашгийг эзэмшиж, мөн өөрийнхөө өмнөөс гүйлгээ хийсэн этгээдийг хянадаг хувь хүнийг ойлгоно. Үүнд мөн хуулийн этгээд,

эсхүл тогтолцоонд эцсийн үр дүнтэй хяналт тавьдаг хүмүүсийг хамруулдаг. Ийм өмчлөл, хяналтын хэлбэрийг шууд болон шууд бусаар хэрэгжүүлэх боломжтой.

Корпорацийн бүтцийн сүлжээ/Chain of corporate vehicles: Үүнд ерөнхийдөө хууль зүйн эзэмшил, ашиг сонирхол, эсхүл хяналтаар холбогдсон 2 ба түүнээс дээш корпорацийн бүтцийн хэсгүүд багтдаг.

Хяналт/Control: Энэ нь бизнесийн байгууллагын удирдлага, бодлогыг чиглүүлэх шууд буюу шууд бус эрхтэй байх, эсхүл түүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадварыг хэлнэ.

Корпорацийн захирал/Corporate director: Энэ нь нэг корпорацийн хувьд захирлын үүргийг гүйцэтгэж буй нөгөө корпорацийн тухай ярьж байгаа бөгөөд хувь хүний тухай ойлголт биш юм.

Корпораци/Corporation: Корпорацууд нь хувьцаа эзэмшигчид буюу өмчлөгчдөөс тусдаа хуулийн этгээдэд үйлчилдэг. Корпорацын хяналт нь ихэвчлэн ТУЗ-д хадгалагдах бөгөөд хувьцаа эзэмшигчид корпорацыг удирдахад шууд оролцох оролцоо, эрх мэдэл нь хязгаарлагдмал байдаг. Хувьцаа эзэмшигчдэд олгогдсон эрх мэдэлд ихэвчлэн захирлуудыг сонгох, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх, компанийн борлуулалтад үр дүнтэй нөлөөлж чадах "онцгой шилжүүлэг"-ийг батлах эрх багтдаг. Корпорац нь ихэвчлэн хязгааргүй хугацаатай байдаг. Ихэнх тохиолдолд корпорацийн хувьцаа эзэмшигчдэд хязгаарлагдмал хариуцлагын хамгаалалт бий болгодог бөгөөд энэ нь компанийн болон компанийн зээлдүүлэгчдийн өмнө тэдний хүлээх хариуцлага нь хөрөнгө оруулалтаар хязгаарлагддаг гэсэн үг юм. Оффшор бүс бүхий олон улс орнууд гадаадын болон оффшор компани, олон улсын бизнесийн байгууллага эсвэл "чөлөөт компани"-уудад бүртгэл хийлгэхийг санал болгодог. Гадаадын болон оффшор компаниуд нь өөр өөр улс оронд үүсч байгуулагддаг боловч хүлээн авагч буюу бизнес хийх бүс нутагт бүтгэгдсэн байдаг. Олон улсын бизнесийн корпорацууд эсхүл чөлөөлөгдсөн компаниуд нь хүлээн авагчийн буюу оффшор бүсэд үүсгэн байгуулагдаж болох боловч харин тухайн бүс нутагт бизнес эрхлэхийг зөвшөөрдөггүй бөгөөд эдгээр компаниуд нь орон нутгийн татвараас чөлөөлөгддөг байна.

Санхүүгийн бус бизнес болон мэргэжлүүд/Designated nonfinancial businesses and professions: Энэхүү нэр томъёонд казино (интернэтэд суурилсан мөрийтэй тоглоомыг оролцуулна), үл хөдлөх хөрөнгийн агентууд, үнэт металлын дилерүүд, үнэт чулууны дилерүүд, хуульч, нотариатч, бусад бие даасан хуулийн мэргэжилтнүүд, нягтлан бодогч, траст буюу итгэлцлийн болон компанийн үйлчилгээ үзүүлэгч нар багтана.

Хэрэгжүүлэгч/Enforcer: Траст, эсхүл сангийн зорилгоор итгэмжлэлийг хэрэгжүүлэх, шаардлагатай бол шүүхэд хандах эрх бүхий этгээдийг гүйцэтгэгч гэнэ. Өршөөл үзүүлэх зэрэг хүмүүнлэгийн итгэлцлийн хувьд хэрэгжүүлэгч нь ихэвчлэн тухайн улсын хуулийн ахлах ажилтан-ерөнхий прокурор, эсхүл түүнтэй адилтгах эрх бүхий байгууллага байдаг. Харин хүмүүнлэгийн бус итгэлцлийн хувьд тухайн итгэмжлэлийн зорилгыг биелүүлэх үүрэгтэй, үүнтэй холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй, үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүхэд хариуцлага хүлээлгэх боломжтой хүнийг тусад нь томилдог байна.[1]

[1] Маркс Панет. 2017. "Use a Noncharitable Purpose Trust to Achieve a Variety of Goals." Маркс Панетийн цахим хуудас (блог) 2017 оны 8-р сарын 03. https://www.markspaneth.com/blog/2017/use-a-noncharitable-purpose-trust-to -achieve-a- variety- of-goals.

Гадаадын, эсхүл оффшор компани/Foreign or offshore company: Эдгээр компаниуд нь өөр улс оронд үүсгэн байгуулагдсан ч хүлээн авагч улсын газар нутагт бизнес явуулахын тулд бүртгэгдсэн байдаг.

Сан/Foundation: Сан гэдэг нь тодорхой зорилгод хүрэхийн тулд цуглуулж, хуримтлуулсан хөрөнгө бүхий хуулийн этгээд бөгөөд хувьцаа эзэмшигч, өмчлөгч эзэн гэж байдаггүй. Сангийн үйл ажиллагааг дүрэм болон бусад баримт бичигт заасан нөхцөл, журмын дагуу захирлуудын зөвлөл удирддаг. Зарим улс оронд нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий сан (олон нийтийн сан) байгуулахад хязгаарлалт тавьдаг бол зарим нь хувийн эрх, ашиг сонирхлынхоо төлөө үйл ажиллагаа явуулах сан (хувийн сан) байгуулахыг зөвшөөрдөг. Баталгаа гаргасан нөхцөлд хязгаарлагдмал баталгаат (Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орон дахь сантай ижил) компани байгуулахыг нийтийн эрх зүйн тогтолцоо бүхий улсууд ерөнхийдөө зөвшөөрдөг бөгөөд энэ харилцаа нь компанийн тухай хуулиар зохицуулагддаг. Түүнчлэн эдгээр улсуудын зарим нь компаниудыг хязгаарлагдмал баталгаат хэлбэртэй байхаас гадна хувьцаатай байхыг (холимог компани) зөвшөөрдөг. Холимог гэдэг нь сангийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж, компани шиг хувьцаа гаргахыг ойлгоно.

Олон улсын бизнесийн корпораци (ОУБК)/International business corporation (IBC): Заримдаа чөлөөт компани гэж нэрлэгддэг энэхүү байгууллага нь оффшор бүс дэх санхүүгийн төвүүддээ гол төлөв тус орон нутгийн оршин суугч бус хүмүүсийг ажиллуулдаг онцлогтой. ОУБК нь корпорацийн шинж чанартай боловч үүсгэн байгуулагдсан бүс нутагт бизнес эрхлэхийг зөвшөөрдөггүй бөгөөд ерөнхийдөө орон нутгийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг. Ихэнх улс орнуудад ОУБК-ийг банк, даатгал болон бусад санхүүгийн үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрдөггүй.

Эрх зүйн зохицуулалт/Legal arrangement: Эрх зүйн зохицуулалт гэдэг нь итгэмжлэл эсхүл *fiducie, treuhand, fideicomiso* гэх мэт бусад ижил төстэй зохицуулалтуудыг хэлнэ.

Хууль ёсны эзэмшигч/Legal owner: Хууль ёсны эзэмшигч гэж хуульд заасны дагуу тухайн компанийн өмчлөгчөөр хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүн, хуулийн этгээд, эсхүл эдгээрийн хослол юм.

Хуулийн этгээд/Legal person: Энэ нь санхүүгийн байгууллага, эсхүл өөрийн хөрөнгөтэй нь байнгын харилцагчийн холбоо үүсгэх боломжтой корпораци, сан, Аншталт, нөхөрлөл, холбоо болон эдгээртэй адилтгах аливаа байгууллагыг ойлгоно.

Итгэмжлүүлэгчийн хүсэл зоригийг илэрхийлсэн захидал/Letter of wishes: Энэхүү захидал нь ихэвчлэн траст буюу итгэмжлэлийг дагалдах ба итгэмжлэл хийсэн этгээд түүний төлөөлөгч нь үүргээ хэрхэн биелүүлэх тухай, өөрөөс нь гадна хэнээс зааварчилга авч болох тухай, хэнд (өөрийгөө оролцуулсан байж болно) тэтгэмж өгөх, ашиг хүртээх зэргийг дэлгэрэнгүй тусгасан байдгаараа онцлог юм. Хэдийгээр уг захидал нь итгэмжлэгдсэн төлөөлөгчид заавал биелүүлэх хууль ёсны үүрэг хүлээлгэдэггүй боловч төлөөлөгч нь ихэвчлэн тус захидалд тусгагдсан хүсэлтүүдийг биелүүлдэг байна.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)/Limited liability company (LLC): Энэ нь компанийн эзэмшигчдийнхээ өмнө (гишүүд гэж ойлгоно) хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг аж ахуйн нэгж юм. Корпорацид эзэмшигчдээсээ тусдаа хуулийн этгээд байдаг бол ХХК нь татвартай холбоотойгоор олсон орлогоо

эзэддээ шууд дамжуулдаг хуулийн этгээд юм. Тийм учраас энэ нь гишүүдэд ашиг, алдагдлыг хуваарилах, татвар ногдуулах боломжтой байдаг. ХХК-ийг гишүүд өөрсдөө, эсхүл нэг ба түүнээс дээш хэд хэдэн тусдаа менежер ХХК-ийн дүрэмд заасан нөхцлийн дагуу удирдаж болно.

Нэрлэсэн захирал/Nominee director: Энэ нь эцсийн өмчлөгч гэгдэх этгээдийн (гол төлөв нууц) нэрийн өмнөөс компанийн захирлаар бүртгэгдсэн хүн юм. Уг албан тушаалтай холбоотой тохиролцоогоор, захирлаас гаргасан аливаа нууцын зэрэглэлтэй эрх зүйн баримт бичиг (бүрэн эрхийн гэрээ, өмчлөгчийн өмнөөс захирлын үүрэг гүйцэтгэхтэй холбоотой гэрээ, бусад ижил төстэй гэрээ, хэлцэл г.м) нь эцсийн өмчлөгчид хадгалагдана. Нэрлэсэн захирал нь корпораци бол нэр дэвшигчийг корпорацийн захирал гэж нэрлэдэг. Зарим улс оронд ийнхүү томилогдсон захирлыг хүлээн зөвшөөрдөггүй. Нэрлэсэн захирал байхаас үл хамааран захирлын албан тушаалыг хашиж байгаа бол гэрээнд заасан уг албан тушаалын үүрэг, хариуцлага, тавигдах шаардлагыг бүгдийг (түүний дотор итгэлцлийн үүрэг) биелүүлэх үүрэг хүлээнэ. Зарим улс оронд, нэрлэсэн захирал нь эцсийн өмчлөгчөөс нөхөн төлбөр хүртэх боломжгүй байдаг байна.

Нэрлэсэн хувьцаа эзэмшигч/Nominee shareholder: Тухайн компанийн хувьцаа эзэмшигч байх боловч үнэн хэрэгтээ өөр хэн нэгний (ихэвчлэн нууц) буюу эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс тус хувьцааг эзэмшиж байгаа хуулийн этгээд, эсхүл хувь хүн байна. Зарим тохиолдолд, нэрлэсэн хувьцаа эзэмшигчтэй тохиролцсон тохиролцоогоор, уг хувьцаа эзэмшигчээс гаргасан аливаа нууцын зэрэглэлтэй эрх зүйн баримт бичиг (итгэмжлэл, шилжүүлэг хийсэн баримт, эцсийн өмчлөгчийн өмнөөс хувьцаа эзэмшихтэй холбоотой хийсэн гэрээ болон эдгээртэй адилтгах гэрээ, хэлцэл г.м) нь эцсийн өмчлөгчид хадгалагдана. Олон нийтэд арилжигдах хувьцаатай холбоотойгоор, нэрлэсэн хувьцаа эзэмшигч нь, жишээлбэл, хувьцааны арилжаа хийх урьдчилсан мэдүүлэг, арилжааны тохиролцоо зэргийг хийхдээ хувьцаагаа үнэт цаасны арилжааны брокерын газруудаар дамжуулан бүртгүүлэх нь түгээмэл бөгөөд хууль ёсны дагуу байдаг.

Нөхөрлөл/Partnership: Энэ нь бизнесийн үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулагдсан хоёр ба түүнээс дээш хувь хүн, аж ахуйн нэгжийн нэгдлийг хэлнэ. Корпорацаас ялгаатай нь, уламжлалт хэлбэртэй нөхөрлөл нь доод тал нь нэг гишүүн (хязгаарлагдмал харицлагатай нөхөрлөлийн хувьд)-тэй байдаг, мөн, бүх гишүүд нь (ердийн нөхөрлөлийн хувьд) бүх гишүүд нь хязгааргүй хариуцлага хүлээдгээрээ онцлог. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хувьд, гишүүд нь хязгаарлагдмал оролцоотой буюу удирдлагын шийдвэр гаргахад идэвхитэй оролцдоггүй, үүрэг хүлээдэггүй. Сүүлийн жилүүдэд, зарим улс оронд хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (LLPs) бий болсон бөгөөд гишүүд нь нөхөрлөлийн менежментийн үйл ажиллагаанд оролцох оролцооны цар хүрээнээс үл хамааран бүгд хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг байна. Татвар төлөхтэй холбоотойгоор, нөхөрлөлийг гишүүдийнхээ оролцооны түвшинд ашиг, алдагдлыг хуваариладаг байгууллага гэж үздэг.

Хуульчийн эрх хэмжээ/Power of attorney: Нийтийн эрх зүйн систем дэх хуульчийн эрх хэмжээ, эсхүл хуульчийн захидал, мөн эх газрын эрх зүйн тогтолцооны бүрэн эрх хэмээх ойлголт нь хууль, эрх зүйн болон бизнесийн асуудлуудаар хэн нэгний өмнөөс ажиллах эрх эдлэх, үүрэг хүлээх гэсэн үг юм. Бусдад өөрийнхөө өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх олгосон хүн нь эрх мэдлийн үндсэн хэрэгжүүлэгч, эрх олгогч, эрх мэдлээ шилжүүлэгч байдаг. Харин эрх хүлээн авсан этгээд нь агент

буюу төлөөлөгч, бодит байдалд хуульч, (нийтийн эрх зүйтэй улс оронд ихэвчлэн), эсхүл зүгээр өмгөөлөгч нь байна.

Хувийн итгэмжлэгдсэн компани (ХИК)/Private trust company (PTC): Энэхүү байгууллага нь гагцхүү нэг болон хэд хэдэн итгэмжлэлийг үндэслэж итгэмжлүүлэгч, итгэмжлүүлэгчдийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулагдсан компани бөгөөд тус компаниар дамжуулан итгэмжлэлийн үр дүнд ашиг хүртэх этгээд нь итгэмжлүүлэгчтэй холбогддог, мөн итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлүүлж байгаа этгээд нь энэхүү компаниас итгэмжлэлийн бизнесийн үйлчилгээ авч байгаа өөр бусад итгэмжлүүлэгч нар, тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй холбогдох боломжтой байдаг. “Хамаарал бүхий этгээд” гэж цусан төрлийн, гэрлэлтийн болон үрчлэлийн харилцааны үр дүнд холбогдсон бүх хүнийг ойлгоно. ХИК нь итгэмжлэлийн үйлчилгээ авахыг олон нийтээс хүсэх, шаардах, тус үйлчилгээг олон нийтэд үзүүлэхийг хориглоно. Үндсэндээ ХИК-ийг гэр бүлийн гишүүд, эсхүл траст буюу итгэмжлэлийн хууль, журмын мэдлэг туршлагатай төлөөлөгч, мэргэжилтнүүдээс бүрдсэн захирлуудын зөвлөл удирддаг.

Хамгаалагч/Protector: Компанийн, итгэмжлэлийн, сангийн хамгаалагч гэдэг нь тэдгээрт хяналт тавих эрх мэдэл бүхий хүнийг ойлгоно. Үүсгэн байгуулагч, итгэмжлэгдэгчийн тодорхойлсноор хамгаалагчид хяналтын эрх хэмжээ олгогдоно. Хамгаалагч нь хэдийгээр итгэмжлэгдсэн төлөөлөгч, захирал эсвэл сангийн удирдах зөвлөл биш боловч байгууллагын уулзалт, хуралд оролцох зэрэг бүхий л мэдээллийг авах эрхтэй хувь хүн юм. Хамгаалагч нь мөн зарим гол асуудлуудад (төлбөр төлөх, мөнгөн шилжүүлэг хүлээн авагч, шилжүүлэг хийх хугацаа болон ашиг хүртэгчийг томилох гэх мэт) хориг тавих эрхтэй бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч, захирал зэргийг ажилд авах, халах эрхтэй байж болно.

Зорилго бүхий итгэмжлэл/Purpose trust: Энэ тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эзэмшиж байгаа итгэлцлийн сан нь ашиг хүртэгчдэд зориулагдсан гэхээс илүү итгэмжлэлд дурдагдсан тодорхой зорилгод зориулагдсан байдаг. Зорилго бүхий итгэмжлэл нь хэрэгжих улсаасаа хамааран хүмүүнлэгийн болон хүмүүнлэгийн бус байж болно. Хөрөнгө хамгаалах итгэмжлэл нь нэгэн төрлийн зорилго бүхий итгэмжлэл юм

Бэлэн компани/Shelf company: Энэ нь ерөнхийдөө, компани нь үүсгэн байгуулагдсан ч (стандарт түвшний санамж бичиг, эсхүл компанийн дүрэмтэй бөгөөд идэвхгүй хувьцаа эзэмшигчидтэй, захирлуудтай, нарийн бичгийн даргатай) ирээдүйд зарах зорилгоор үйл ажиллагаа явуулдаггүй, идэвхгүй байгаа компанийг хэлнэ. Тус компани зарагдсан үед идэвхгүй хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зарж, захирлууд болон нарийн бичгийн дарга нар нь ажлаас гарах өргөдлөө гаргадаг. Түүнчлэн худалдан авсан тал нь компанийн зээлийн болон татварын түүхийг хүлээн авдаг.

Халхавч компани/Shell company: Энэ нь бие даасан үйл ажиллагаа явуулдаггүй, нэг их хөрөнгөгүй, байнгын бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй, ажилтангүй компани юм. Халхавч компани нь хууль бус биш бөгөөд хууль ёсны бизнесийн зорилготой байж болно.

Траст/Trust: Энэ нь эцсийн өмчлөгчөөс хууль ёсны өмчлөлийг салгах боломжийг олгодог хэрэгсэл юм. Энэ нь бусдын тусын тулд хөрөнгийг (бодит, биет, биет бус гэх мэт) нэг хүн удирддаг зохицуулалтын хэрэгсэл юм. Итгэмжлэлийг хөрөнгөө итгэмжлэн хариуцуулсан нэг ба түүнээс дээш тооны өмчлөгч нар байгуулж болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэгдсэн хөрөнгийг эзэмших хууль ёсны эрхтэй

байх боловч итгэмжлэлээр хүлээсэн үүргээ гүйцэтгэснээр (ихэвчлэн адил эрх бүхий итгэмжлэгдэгч нараас ашиг хүртэгчийг тодорхойлсон байдаг) ашиг хүртэх этгээдийн тусын тулд уг хөрөнгийг эзэмшиж, хамгаалах үүрэг хүлээдэг субъект юм. Тэрээр итгэмжлэгдсэн хөрөнгийн эцсийн өмчлөгч буюу ашиг хүртэгч нарын өмнө үүрэг хүлээнэ. Итгэмжлүүлэгч нь өөрөө хуулийн этгээдийн эрхтэй байгууллага биш. Итгэмжлүүлэгчийн хийсэн аливаа шилжүүлэг нь итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын нэр дээр хийгддэг. Хэдийгээр итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэгдсэн хөрөнгийг хууль ёсны дагуу эзэмшдэг боловч энэ нь түүний хувийн өмч хөрөнгөөс тусдаа хөрөнгө юм. Тиймээс, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувийн хөрөнгө, өр төлбөрийн аль аль нь итгэмжлүүлэгчтэй холбоогүй бөгөөд итгэмжлэгдсэн хөрөнгийг төлөөлөгчтэй холбоотой хувийн өр, зээлнээс тусад нь ялгаж авч үздэг.

Траст болон компанийн үйлчилгээ үзүүлэгч/Trust and company service provider: Энэхүү нэр томъёо нь гуравдагч этгээдэд дараах үйлчилгээг үзүүлдэг аливаа хүн эсхүл бизнесийг ойлгоно: хуулийн этгээд, байгууллагыг үүсгэн байгуулагч компанийг төлөөлөх; компанийн захирал, нарийн бичгийн дарга, нөхөрлөлийн гишүүн болон бусад хуулийн этгээдтэй холбоотой ижил төрлийн албан тушаалтан зэргийг төлөөлж үүрэг гүйцэтгэх (эсхүл өөр хүнээр үүрэг гүйцэтгүүлэх); компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд, бүртгэлтэй оффис, бизнесийн хаяг, оффис, шуудангийн хаяг, захиргааны хаягийг өгөх; шууд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх (эсхүл өөр хүн ажиллуулах асуудлыг зохион байгуулах); эсхүл нэрлэсэн хувьцаа эзэмшигчийн үүргийг өөр хүний оронд гүйцэтгэх (эсхүл өөр хүн ажиллуулах асуудлыг зохион байгуулах).

Хавсралт С. Санхүүгийн тагнуулын албаны тайлангийн загвар

Санхүүгийн тагнуулын алба

Хэнд:	Цагдаагийн дарга, Прокурорын байгууллага, эсхүл бусад холбогдох албан тушаалтан
Хэнээс:	Дарга, Санхүүгийн тагнуулын алба
Огноо:	2020 оны 03 дугаар сарын 01
Этгээд:	Жон Смит Буяны Сан

Нууцлалтай

Энэхүү баримт бичиг нь нууц бөгөөд хууль сахиулах байгууллагын хувьд нууц санхүүгийн мэдээлэл. Санхүүгийн тагнуулын алба (FIU)-аас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээс бусад тохиолдолд энэ баримт бичигт агуулагдах өгөгдлийг зөвхөн бүтнээр эсхүл хагасаар нийтэд дэлгэх, өөр байгууллага албан тушаалтанд шилжүүлэх, эрүүгийн, иргэний, захиргааны ямарч шүүхийн шатанд ашиглаж болохгүй.

Жон Смитийн буяны сантай холбоотой дансанд хэвийн бус үйл ажиллагаа болсонтой холбоотой сэжигтэй гүйлгээний тайлан СТА -д ирсний дараа энэ асуудлыг СТА -аас шалгаж эхэлсэн. Хэвийн бус үйл ажиллагаа гэдэгт **Жон Смитийн буяны сан** нь мөнгө угаах гэмт хэрэг болон Мөнгө угаах тухай хуулийн зарим заалтыг зөрчсөн байж болзошгүй.

2020 оны 01-р сарын 25-ны өдөр СТА нь **Жон Смитийн буяны сан**тай холбоотой сэжигтэй гүйлгээний талаар (STR) хүлээн авсан. СТА -гаас **17026557** дугаартай данснаас тус бүр нь **9,000.000** ам.долларын **48** сэжигтэй гүйлгээнд хийгдсэн болохыг тогтоосон. Энэ дансны дугаар нь **Жон Смит буяны сан** нэртэй төрийн бус байгууллагад (ТББ) харьяалагддаг. Энэ нь сан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэл болон үйл ажиллагааны 1985 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасныг үндэслэн 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдөр **5110282** бүртгэлийн дугаартайгаар **Жон Смит буяны сан** нэртэй төрийн бус байгууллага үүсгэн байгуулагдсан. Бүртгэлийн сертификат нь **99951** сериал дугаартай. УБЕГ-т бүртгүүлсэн хаяг нь **Смит Арал, Смитвилле, 100 Палм гудамж**, **дугаар 255-401-050**, факс **251-401-202**. Тус төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь “Смит арлын оршин суугч нарт төрийн бус байгууллага, хандивын байгууллага, концерт, спортын арга хэмжээ, театраас хандив цуглуулах” юм. Тус төрийн байгууллагыг дараах 3 иргэн байгуулсан:

1. **Роберт Франк,** 1980 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Смит арлын Жонэсвилле гэх газарт төрсөн, бүртгэлийн дугаар **1000718145,** хаяг Смитвилле, Палм гудамж 195, утасны дугаар 255-505-233, одоогоор спорт болон тоглоомын сайд, Смит Арлын Холбоо улс төрийн намын гишүүн, үеэл Томас Марк нь одоогийн ерөнхий сайд.

2. **Бэтти Франк,** 1985 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Смит арлын Марксвилле гэх газарт төрсөн, бүртгэлийн дугаар **1009875847,** хаяг Смитвилле, Палм гудамж 195, утасны дугаар 255-211-440, цахим шуудан betty.frank@gmail.com; Роберт Франкын эхнэр.
3. **Антони Смит,** 1975 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Смит арлын Марксвилле гэх газарт төрсөн, бүртгэлийн дугаар **1000719109,** хаяг Марксвилле, Яанкий Вэй 8097 гудамж, утасны дугаар 255-540-050; цахим шуудан tony.smith@gmail.com; **Жон Смит Буяны Сан**гийн Ардын банк /Peoples Bank/, Уулын банк /Mountain bank/, Голын банк /River Bank/-уудад данс нээлгэхэд зөвшөөрөл олгосон мөн тус банкнууд дээрх данснуудыг удирддаг, бизнесмэн, Смитвилле шар айрагны үйлдвэрийн хамтран эзэмшигч, Роберт Франкийн үеэл, ерөнхий сайд Маркийн зөвлөх, Смит Арлын Холбоо улс төрийн намын нярав.

Ардын банк /Peoples bank/-нд 17026557 тоот данс нээлгэсэн. 2018 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд тус дансаар 733,987.52 ам.долларын гүйлгээ хийгдсэн. Антони Смит дээрх дансны сэжигтэй орлогын гүйлгээнүүд дээр гарын үсэг зурсан. Сүүлийн дор хаяж 3 удаагийн гүйлгээ дээр Смит Ардын банканд очихдоо 100 ам.долларын шинэхэн дэвсгэртүүдийг 100-таар боосон боодолтой нь хамт авч очин хэдэн зуун мянган ам.долларын орлогын гүйлгээ хийсэн. Тэрээр банкны удирдлагад тайлбарлахдаа эдгээр мөнгөнүүд нь хэд хэдэн хүний Жон Смит Буяны Санд хандивлаж байгаа орлогын мөнгө гэж хэлсэн. Тэрээр гүйлгээ болгонд 9,000 ам.долларын (заримдаа бага зэрэг дутдаг) гүйлгээг хийж, орлогын гүйлгээ болгон дээр өөрийн нэрийг оруулдаг. Харин одоогоор, тус гүйлгээнүүд эх үүсвэрийн талаар ямар ч мэдээлэл байхгүй байна.

2018 оны 08 дугаар сарын 2018 оны 10 дугаар сарын хооронд нийт 492,000 ам.долларын орлого тус дансанд орсон. Эдгээр мөнгөний ихэнх нь 9,000 ам.долларaар хийсэн 48 удаагийн орлогын гүйлгээнээс төвлөрсөн. Мөнгө дараах байдлаар цугларсан:

Тухайн сангийн дансанд нийтдээ 59 гүйлгээ хийгдсэн. Эдгээрийн ихэнх нь 9,000 ам.долларaар хийсэн 48 удаагийн орлогын гүйлгээгээр төвлөрсөн ба тус гүйлгээг 1 л хүн хийсэн. Жон Смит Буяны сан нь Смит Арал дээр үйл ажиллагаа явуулдаг бүх банкан дээр данс нээсэн. Антони Смит нь эдгээр данснуудыг эзэмшдэг. 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нийт дансаар барагцаалбал 1,766,039.47 ам.долларын гүйлгээ хийгдсэн.

Огноо	Орлогын тоо	Орлого/Хэмжээ ($)
08/19/2018	5	9,000
09/05/2018	20	9,000
09/05/2018	1	10,000
09/05/2018	3	5,000
09/06/2018	20	9,000
09/06/2018	7	5,000
09/20/2018	2	9,000
10/03/2018	1	9,000

Хавсралт D. Үзлэг, нэгжлэг хийх, хураан авах талаар шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг төлөвлөх

- Банкны дансанд байгаа хөрөнгийг тодорхойлж, нэгжлэг хийхээс өмнө эсвэл нэгэн зэрэг (жишээ нь, царцаах шийдвэр гаргах замаар) тухайн хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах.
- Нэгжлэг хийх байршлын төрлийг тодорхойлох (жишээ нь, орон сууц эсвэл бизнес).
- Энгийн болон зорилтот бус хүмүүс байх магадлалыг тодорхойлж, үүний дагуу төлөвлө. Боломжтой бол бизнесийн оргил үеэс зайлсхийх.
- Тохиромжтой үед шийдвэрийг гүйцэлдүүлэх явцад бизнесийг хаах талаар авч үзэх.
- Аюулгүй, бүрэн гүйцэт нэгжлэг ажиллагааг явуулахад шаардлагатай албан хаагчдын тоог тогтооно.
- Үйл ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангахын тулд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
- Тухайн шийдвэрийн зөвшөөрлийн дагуу ердийн ажлын цагаар гүйцэтгэх.
- Хуулиар зөвшөөрөгдсөн болон мөрдөн байцаалтад ашигтай бол ажлын цагаас хойш нэгжлэг хийх шийдвэрийг гүйцэтгэх талаар бодож үзээрэй.
- Тухайн байршил нь дохиоллын системээр тоноглогдсон, зэвсэгт хамгаалалтын ажилтнууд, камер, эсвэл нохойн эргүүл зэрэг зүйлтэй эсэхийг тодорхойлох. Үүнийг харгалзан үйл ажиллагаагаа төлөвлөх.
- Тухайн үйл ажиллагаанд оролцох ажилтнуудыг дэлгэрэнгүй мэдээллээр хангах.
- Нэгжлэг хийх хүрээнд зорилтот этгээд болон байршлын талаарх холбогдох тагнуулын мэдээллээр хангах.
- Хэрэв байгаа бол орон сууц эсвэл бизнесийн талаарх газрын зураг, бүдүүвч зураг эсвэл бусад холбогдох мэдээллээр хангах.
- Тухайн шийдвэрийн дагуу үйл ажиллагаанд оролцох албан тушаалтан бүрт үүрэг хуваарилах. Тухайн ажиллагааг ахлах мөрдөгч ахлаж ажиллах ёстой. Эдгээр үүргүүдийн заримд дараах зүйлс багтана:
    - *Нэвтрэх үйл ажиллагааг хийх баг* эхлээд байгууламжинд нэвтэрч, хамгаалалтанд авч, бусад алба хаагчид аюулгүй, нарийн нэгжлэг хийх боломжтой болно. Энэ баг байранд орохдоо утасны шугамыг салгах ёстой.
    - *Нэгжлэг хийх ажилтнууд* нотлох баримт дэлгэх зэрэг эрсдэлээс зайлсхийх үүднээс боломжтой бол хоёр багт хувиарлагдаж ажилладаг.
    - *Үзлэг, нэгжлэг хийх ажилтнууд* нь нотлох баримтыг ил болгосон гэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд боломжтой бол хосоороо баг болон ажилладаг. Ахлах мөрдөгч нь баг бүрийн үзлэг, нэгжлэг хийх газруудыг тодорхойлж болно.
    - *Дүрс бичлэг болон зураг авах ажилтан* шийдвэрийн гүйцэтгэл болон нотлох баримт болох баримт бичгүүдийг бүртгэж авдаг. Тохиромжтой тохиолдолд зураг авахдаа масштабыг харуулах: зураг авч буй

объект(үүд)-ийн хажууд хэмжээсийг харуулсан шугам эсвэл бусад объектыг байрлуул.

- *Нотлох баримтыг хадгалах ажилтан* нь нэгжлэг хийх явцад илрүүлж, хураан авсан бүх нотлох баримтыг нэгжлэг хийсэн ажилтнаас хүлээн авч бүртгэдэг.
- *Ярилцлагын баг,* тэр дундаа ахлах мөрдөгчийг төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон байх ёстой. Зорилтот этгээд(үүд) байгаа бөгөөд ярилцлага өгөхийг зөвшөөрвөл ярилцлага явуулахад тохиромжтой, нэгжлэг хийхэд саад болохгүй газар асуулга явуулна.
- *Компьютерийн шүүх эмнэлгийн шинжээч* нотлох баримт цуглуулж, хамгаалах нь үр дүнтэй болно. Цахим болон компьютерийн мэдээллийг алдагдуулах, устгах, гэмтээхээс сэргийлж, улмаар хууль сахиулах байгууллагын ажилтнууд уг мэдээллийг өөрчилсөн гэх сэжигтний нэхэмжлэлээс зайлсхийх (жишээлбэл, мэдээллийн толин тусгал хуулбарыг бэлтгэх гэх мэт) байдлаар цуглуулсан байх ёстой. Хэрэв мөрдөгчийн хэсэг болон бусад холбогдох нэгжид компьютерын криминалистикийн мэргэшсэн шинжээч байхгүй бол мөрдөгч хувийн хэвшлийнхнээс уг үйлчилгээг авах эсвэл ийм чадвартай бусад улс орноос тусламж хүсэх талаар бодож үзэх хэрэгтэй.

Хавсралт Е. Санхүүгийн байгууллагаас баримт, мэдээлэл гаргуулан авах тухай шийдвэрийн загвар.

ABC банкны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх ABC банкнаас баримт мэдээлэл гаргуулан авах тухай шийдвэр

Re: Мөрдөн байцаалтын тухай

- ABC банкан дахь Жон Доугийн нэр дээр бүртгэлтэй 12345678 тоот данс
- АНУ-ын Делавэр мужид бүртгэлтэй XYZ компани; Мэн арлын Дуглас хотод бүртгэлтэй төлөөлөгчтэй бөгөөд Английн Лондон хотод оффистой
- Дээр дурдсан хувь хүн, аж ахуйн нэгжтэй холбоотой данс болон хөрөнгийн тодорхой болоогүй байгаа эцсийн өмчлөгчид.

Баримт мэдээлэл гаргуулан авах тухай шийдвэр

[*Холбогдох хуулийн*] дагуу ABC банкны эрх бүхий төлөөлөгч нь дор дурдсан баримт мэдээллийг прокурорын байгууллага [*шүүгч, мөрдөгч, эсвэл бусад зохих эрх бүхий байгууллага*]-д [*огноо]*-ны дотор гаргаж өгөхийг үүрэг болгосугай. Энэхүү баримт мэдээлэл гаргуулан авах тухай шийдвэрийг зориудаар биелүүлээгүй нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох бөгөөд торгуулах, хоригдох, эсвэл хоёулангаар нь шийтгүүлэх ялтай.

[*Хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд*] ABC банк нь энэхүү шийдвэрийн талаарх баримт, тухайн шийдвэрт дурдсан этгээдийн талаарх хувийн мэдээлэл болон гаргуулан авсан баримт мэдээллийг ABC банкнаас гадагш хэн нэгэнд мэдэгдэхгүй байхыг даалгасугай. Прокурорын байгууллага [*шүүгч, мөрдөгч эсвэл бусад зохих эрх бүхий байгууллага*]-д ямар баримт мэдээлэл гаргаж өгсөн талаар дараагийн шийдвэр гарах хүртэл задруулах ёсгүй.

Энэхүү шийдвэр нь [*огноо*]-оос [*огноо*] хүртэлх хугацааг хамрах эсвэл ABC банк шийдвэрийг хүлээн авсан өдрөөс эхэлж хугацааг тооцно.

Уг шийдвэрт дээр дурдсан хувь хүн, хуулийн этгээд, эцсийн өмчлөгчдийн дангаар эсвэл бусад хувь хүн, хуулийн этгээдтэй хамааралтай холбогдох бүх баримт мэдээллийг хамруулах бөгөөд эдгээр хувь хүний итгэмжлэгдсэн өмчлөгчөөр бүртгэлтэй, гарын үсгийн эрхтэй, итгэмжлэлээр төлөөлөх, бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхтэй дансдын талаарх баримт бичиг багтана. Үүнд, дараах мэдээлэл хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

Данс нээх, Харилцагчийг таньж мэдэх, Зааварчилгаа өгөх

1. ABC банкнаас үзүүлсэн аливаа үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагааны хүрээнд нээлгэсэн дансны талаарх баримт бичиг, үүнд охин компани болон корреспондент байгууллагыг оруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Хэрэв байгаа бол, дээр дурдсан хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой хаасан бүх дансны талаарх баримт бичиг. XYZ компанийн хувьд, баримт бичигт компанийн дүрэм, шийдвэр, тэмдэглэл, түншлэлийн гэрээ, итгэмжлэлийн

эрх болон дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчтэй холбоотой гарын үсгийн эрхтэй карт (урд болон ард тал) багтсан байх хэрэгтэй.

2. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийн банкны дансны хуулга, тодорхой хугацааны хуулга болон дансны хуулбар мэдээлэл.
3. Дээр дурдсан хувь хүнтэй холбоотой аливаа дансны эцсийн өмчлөгчийн хувийн мэдээлэл болон уг мэдээллийг агуулсан баримт бичиг. Үүнд, гэрээлэгч тал болон эцсийн өмчлөгчийн ирүүлсэн эсвэл гэрээлэгч тал, эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс аливаа санхүүгийн байгууллага, ажилтан, болон гуравдагч этгээдийн бэлтгэж өгсөн бүх дагалдах баримт бичгийг хамруулах боловч үүгээр хязгаарлагдахгүй.
4. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх, баталгаажуулахтай холбоотой ABC банкны олж авсан мэдээлэл.
5. Иргэний үнэмлэхний дугаар, татвар төлөгчийн дугаар, харилцагчийг таних дугаар, төрсөн огноо, төрсөн газар, болон дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх зорилгоор ABC банкны ашигласан (дансны дугаараас бусад) аливаа лавлах дугаар, аргачлал.
6. Дээр дурдсан аливаа хувь хүний хувьд, хадгаламжийн хайрцагны гэрээ, уг хайрцагт нэвтрэх эрхтэй бүх хүмүүсийн хувийн мэдээлэл, хадгаламжийн хайрцагт нэвтэрсэн огноог харуулсан баримт бичиг, мөн хадгаламжийн хайрцагтай хэсэгт нэвтэрсэн эрх бүхий этгээдүүдийг харуулсан аливаа видео бичлэг, бусад электрон хэрэгсэл.
7. ABC банкнаас дансны хуулгыг хэзээ, хэрхэн хүргүүлэх тухай харилцагчид өгсөн заавар болон шуудангаар, цахимаар эсвэл дуудлагаар холбоо барих тухай харилцагчид өгсөн заавар.
8. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийн дансдыг хариуцах, зохицуулах үүрэгтэй байсан эсвэл байгаа ABC банкны ажилтны хувийн мэдээлэл.
9. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийн төлсөн эсвэл тэдгээрийн нэрийн өмнөөс төлсөн орон нутгийн болон улс хоорондын утасны ярианы төлбөрийн бүх бүртгэл, үүнд утасны төлбөрийг оруулах бөгөөд бусад харилцаа холбооны үйлчилгээ, телекс, илгээмж, шуудангийн үйлчилгээний төлбөрийн бүх бүртгэл. Банкнаас холбоо барьсан тохиолдол бүрийн хувьд холбоо барьсан банкны албан тушаалтныг тогтоох, холбоо барих үеэр өгсөн эсвэл хүлээн авсан аливаа тэмдэглэл, баримт бичиг, мэдээлэл эсвэл илгээсэн, хүлээн авсан илгээмж, захидал, факс, цахим шуудангийн талаарх мэдээллийг бэлтгэнэ.

Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой баримт бичиг

10. ABC банкнаас дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийн талаар бэлтгэсэн “харилцагчийг таньж мэдэх”-тэй холбоотой баримт бичиг.
11. Энэхүү шийдвэрт заасан гүйлгээ, данс, мөнгөн гуйвуулга, Дэлхийн банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэг (СВИФТ)-ийн мессеж эсвэл бусад арга хэмжээтэй холбоотой хувь хүнийг (ABC банкны бодлого, журамд заасны дагуу) ABC банкнаас эцсийн өмчлөгч эсвэл улс төрд нөлөө бүхий этгээдээр тодорхойлсон тохиолдолд дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:
    а. Харилцагчийг таньж мэдэх ердийн болон нарийвчилсан үйл ажиллагааны явцад бүрдүүлсэн бүх баримт бичиг;
    б. Харилцагчид, дансд, улс төрд нөлөө бүхий гэж тодорхойлогдсон этгээд, бусад төрийн албан тушаалтнууд, төрийн албанаас ойрын хугацаанд

гарсан хүмүүс болон эцсийн өмчлөгчидтэй холбоотой гүйлгээг тодорхойлох, тэдгээрийг тусад нь авч үзэх зориулалттай ABC банкны үйл ажиллагааны болон комплаенсын системтэй холбоотой дүрэм журам, сэрэмжлүүлгийг тодорхойлсон баримт бичиг болон сэрэмжлүүлэг болохуйц аливаа гүйлгээ, асуулттай холбоотой баримт бичиг;

в. Энэхүү шийдвэртэй холбоотой харилцагчийг таньж мэдэх баримт файл болон сэрэмжлүүлэх системийг хариуцан ажиллуулж буй ABC банкны аливаа ажилтны хувийн мэдээлэл.

Орох, гарах мөнгөн гуйвуулга болон холбогдох баримт бичиг

12. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийн төлөө эсвэл тэдгээрийн нэрийн өмнөөс хийсэн орох, гарах, дотоодын эсвэл хил дамнасан хөрөнгийн шилжүүлэг (жишээ нь, Федвайр, ЧИПС, ЧАПС)-тэй холбоотой баримт бичиг. Үүнд, мөнгөн гуйвуулга хийх хүсэлтийн маягт, зөвлөмж мэдэгдэл, баталгаажуулах мэдэгдэл, дебит мемо, журналын бичилт эсвэл дотоодын лог бүртгэлийг оруулах боловч үүгээр хязгаарлагдахгүй.
13. ABC банк болон аливаа холбогдох зуучлагч эсвэл корреспондент байгууллагаар дамжуулан дээр дурдсан хувь хүн, эцсийн өмчлөгчийн төлөө эсвэл түүний нэрийн өмнөөс СВИФТ мессеж илгээх, цуцлах, дамжуулахтай холбоотой баримт бичиг. Үүнд, дараах мэдээллийг оруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:
    а. СВИФТ мессеж, үүнд, СВИФТ мессежийн төрөл болох (MT) 100, MT 103, MT 202, MT 202 COV, MT 199, MT 299 мессеж болон аливаа бусад СВИФТ мессеж (үнэт цаас болон арилжааны гүйлгээтэй холбоотой мессеж багтана) хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй;
    б. Факс, шуудан, цахим шуудан, эсвэл утасны заавар; мөнгөн гуйвуулга явуулах хүсэлтийн маягт; зөвлөмж мэдэгдэл; баталгаажуулах мэдэгдэл; дебит мемо; журналын бичилт; эсвэл дотоодын лог бүртгэл;
    в. Дээр дурдсан хувь хүн, хуулийн этгээд, эцсийн өмчлөгчтэй холбоотой аливаа “засварласан зүйлс”, татгалзсан мөнгөн гуйвуулга эсвэл СВИФТ мессеж; болон эдгээр засварласан болон дахин хийсэн мөнгөн гуйвуулга, СВИФТ мессежтэй холбоотой аливаа баримт бичиг.
14. ABC банкны СВИФТ-ын бизнесийг ялгах кодууд. Үүнд, үндсэн кодноос ялгаатай байдаг тухайн бизнесийн чиглэл (жишээ нь, хувийн банкны үйлчилгээ), охин компани, салбаруудын кодууд багтана.
15. ABC банк болон түүний охин компаниудыг тодорхойлсон бүх нэршил.

Дансны гүйлгээ

16. Дээр дурдсан хувь хүн, эцсийн өмчлөгчтэй холбоотой ABC банкны аливаа дансанд орсон эсвэл гарсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой баримт бичиг. Үүнд, дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчтэй холбоотой харилцагчийн хүсэлт, орлогын баримт, хадгаламжийн баримт (урд болон ард тал), зарлагын баримт, цуцлагдсан чек (урд ба ард тал), дебит болон кредит мемо, банкны данс хоорондын шилжүүлэг болон банк хоорондын шилжүүлгийн баримтыг оруулна.
17. Дээр дурдсан хувь хүн, эцсийн өмчлөгчтэй холбоотой аливаа зуучлагч эсвэл корреспондент санхүүгийн байгууллагад илгээсэн буюу хүлээн авсан баримт бичиг.

Бусад гүйлгээ

18. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчтэй холбоотой хадгаламжийн сертификатын хуулбар. Үүнд, хүүгийн төлбөр, эргэн төлөлтийн бүртгэл, орлогын захиран зарцуулалтыг оруулна.
19. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгчийн худалдаж авсан эсвэл худалдсан купонтой бонд, бусад үнэт цаас, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний талаарх бүртгэл.
20. Дээр дурдсан аливаа хувь хүн, эцсийн өмчлөгч эсвэл тэдгээрийн нэрийн өмнөөс худалдаж авсан чектэй хамт менежерийн чек, кассын чек, банкны мөнгөн гуйвуулгын баримтыг худалдаж авсан баримт бичиг.

ABC банкнаас Санхүүгийн тагнуулын албанд (зөвшөөрөгдсөн тохиолдолд) хүргүүлсэн баримт материалууд

21. Дээр дурдсан хувь хүн, эцсийн өмчлөгчидтэй ямар нэгэн байдлаар холбоотой гадаад валютын гүйлгээний тайлан.
22. Дээр дурдсан хувь хүн, эцсийн өмчлөгчидтэй ямар нэгэн байдлаар холбоотой гадаад валют болон мөнгөний гүйлгээний тайлан.
23. Дээр дурдсан хувь хүн, эцсийн өмчлөгчидтэй ямар нэгэн байдлаар холбоотой ирүүлсэн сэжигтэй үйл ажиллагаа эсвэл гүйлгээний тайлан.

Эдгээрт үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй бүх нэмэлт баримт бичгийг оруулна.

Тодорхойлолт ба заавар

А. “ABC” банк болон “XYZ” компани гэсэн нэр томъёог энэ шийдвэрт хамаарах бизнесийн аж ахуйн нэгж гэж ойлгоно. Үүнд, тухайн аж ахуйн нэгжийн хараат компани, хамтарсан үйлдвэр, охин компани, салбар нэгж, ашиг сонирхол бүхий өв залгамжлагчийг бүгдийг нь хамруулахаас гадна түүний одоогийн болон өмнөх захирлууд, албан тушаалтнууд, түншүүд, ажилтнууд, төлөөлөгчид болон эдгээр дурдсан хүмүүсийн аль нэгийг өмнөөс нь төлөөлөн ажиллаж буй бусад этгээдийг бүгдийг нь оруулна.

Б. “Баримт бичиг” гэсэн нэр томъёо нь албан болон албан бус бүх төрлийн бичмэл, хэвлэмэл материалыг хэлнэ. Үүнд, хаана байршиж байгаагаас нь үл хамааран компанийн эзэмшил, хадгалалт, хяналтанд байгаа эх хувь болон ижил бус бүх хуулбар (ийм хуулбар дээр тэмдэглэгээ хийсэн эсвэл өөр хүчин зүйлээс шалтгаалан эх хувиас ялгаатай болсон)-ыг хамруулна. Ингэхдээ, баримт бичиг; шуудан харилцаа; санамж бичиг; албан тэмдэглэл; хувийн тэмдэглэл; статистик материал; албан бичиг; телеграм мэдээ; хурлын тэмдэглэл; гэрээ; тайлан; судалгаа; чек; баримт тайлан; төлбөрийн баримт; буцаалт; товч дүгнэлт; товхимол; ном; оффисын дотоод болон гадаад харилцаа холбоо; санал; аливаа төрлийн харилцан яриа, утасны дуудлага, уулзалт болон бусад харилцаа холбооны тэмдэглэл; тойм мэдээ; зээлийн асуудал; компьютерээс хэвлэсэн материал; хатуу диск; зөөврийн драйв; зөөврийн хатуу драйв диск; уян диск; үндсэн болон хувийн компьютерийн мэдээллийн сан; теле шуудан; телекс материал; нэхэмжлэх; ажлын хуудас; мөн эдгээр дурдсан бүх төрлийн материалын төсөл, тэдгээрт оруулсан өөрчлөлт, сайжруулалт, тодруулга, засварыг бүгдийг нь оруулна. Түүнчлэн, видео бичлэг, дууны бичлэг, хөдөлгөөнт зураг зэрэг бүх төрлийн график болон дууны бичлэг; мөн аливаа электрон, механик, цахилгаан бичлэгийг бүгдийг нь оруулах бөгөөд ингэхдээ соронзон хальс, кассет, диск, бичлэг, кино гэж хязгаарлахгүйгээр хамтад нь оруулна.

В. “Баримт бичиг” гэсэн нэр томъёог бусад “баримт бичиг” хадгалагдаж буй ямар нэгэн тэмдэглэгээ, таних тэмдэг бүхий аливаа хайрцаг, бичиг баримтны хавтас эсвэл бусад дагалдах баримт бичиг гэж ойлгох боловч үүнд баримт бичигний шүүгээ орохгүй. Хэрэв аливаа эх хувь эсвэл түүний ялгаатай хуулбар нь энэхүү баримт мэдээлэл гаргуулан авах тухай шийдвэрийг хүргүүлсэн хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хяналтад байхгүй байх бүх тохиолдолд, “баримт бичиг” гэсэн нэр томъёонд аливаа эх хувийн хуулбар болон түүний ялгаатай хуулбарыг хамруулах хэрэгтэй.

Г. “Болон” гэдэг үгийг тайлбарлахдаа “эсвэл” гэсэн утгыг оруулж, эсвэл оруулахгүй байвал зохино.

Д. “Этгээд” гэсэн нэр томьёо нь аливаа хувь хүн, хуулийн этгээд, хувиараа эрхлэх аж ахуй, корпораци, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр, албан ёсоор бүртгүүлээгүй холбоо, төрийн байгууллага; эсвэл эдгээрийн аль нэг салбар нэгж, харъяа компани, албан тушаалтан, захирал, ажилтан, агент, эсвэл бусад төлөөлөгчийг хэлнэ.

Е. “Эцсийн өмчлөгч” гэсэн нэр томьёо нь эцсийн дүндээ харилцагчийг удирддаг, хянадаг хувь хүн болон эсвэл аливаа гүйлгээг өөрийнхөө өмнөөс хийлгэж байгаа этгээдийг ойлгоно. Түүнчлэн, үүнд хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалттай этгээдийн эцсийн үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлдэг хувь хүмүүс болон холбогдох гуравдагч этгээдийг багтаана.

Ж. “Хувийн мэдээлэл” гэсэн нэр томъёо нь дунд нэрийг оруулсан бүтэн овог нэр; төрсөн огноо; төрсөн газар; иргэний үнэмлэх эсвэл паспортын дугаар; ажиллах хугацаандаа эрхэлж байсан бүх албан тушаал; ажилласан огноо; албан тушаал тус бүрийн хувьд хүлээсэн үүрэг хариуцлага; хэрэв байгаа бол ажлаас гарсан огноо; болон ажлаас гарах болсон шалтгааныг хамруулж ойлгоно.

З. “Төрийн албан хаагч” гэж (1) хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны болон шүүх эрх мэдлийн албан тушаал хашиж байгаа томилогдсон эсвэл сонгогдсон, байнгын эсвэл түр зуурын, цалинтай эсвэл цалингүй, ахмад настай эсэхээс үл хамааран аливаа хувь хүнийг; (2) төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгж зэрэг төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг, эсвэл төрийн үйлчилгээг үзүүлдэг аливаа бусад хувь хүнийг хэлнэ.

И. “Цахим шилжүүлэг” болон “Мөнгөн гуйвуулга” гэсэн нэр томьёо нь санхүүгийн байгууллагаар дамжуулан аливаа этгээдийн нэрийн өмнөөс өөр санхүүгийн байгууллага дахь хүлээн авагч этгээдэд тодорхой хэмжээний мөнгөн дүнг цахим хэлбэрээр шилжүүлж буй аливаа гүйлгээг хэлнэ. Шилжүүлэгч болон хүлээн авагч нь нэг этгээд байж болно.

К. “Хил дамнасан шилжүүлэг” гэж шилжүүлэгч болон хүлээн авагч байгууллагууд нь өөр өөр улс оронд байрладаг аливаа шилжүүлгийг хэлнэ. Мөн энэ нэр томъёо нь дор хаяж нэг хил дамнасан элементийг хамарсан мөнгөн гуйвуулгын аливаа гүйлгээг хэлнэ.

Л. “Шилжүүлэгч” гэж данс эзэмшигчийг хэлэх бөгөөд данс байхгүй бол санхүүгийн байгууллагад гүйлгээний хүсэлт гаргасан этгээдийг шилжүүлэгч гэнэ.

М. “СВИФТ” гэж Дэлхийн банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэгийг хэлнэ.

Н. “ЧИПС” гэдэг нь Банк хоорондын төлбөр тооцооны клирингийн төв системийг хэлнэ.

О. “Федвайр” гэдэг нь АНУ-ын Холбооны нөөцийн системийн эзэмшиж ажиллуулдаг мөнгөн гуйвуулгын цахим систем буюу Федвайр шилжүүлгийн үйлчилгээг хэлнэ.
Ө. “ЧАПС” гэдэг нь стерлинг болон еврогийн нэг өдрийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээг санал болгодог Автоматжуулсан төлбөр тооцооны клирингийн төв системийг хэлнэ.

Давуу эрхийн нэхэмжлэл

Хэрэв хуульч, үйлчлүүлэгч хоорондын нууцлал зэрэг давуу эрхийн нэхэмжлэлд хамаарах аливаа баримт мэдээлэл ABC банканд хадгалагдаж байгаа бол ABC банк нь огноог заасан хуваарь; зохиогч этгээд, хаягласан этгээд болон хүлээн авагчийн нэр, албан тушаал; ийм төрлийн баримт бичиг бүрийн утга, давуу эрхийн нэхэмжлэлийн шинж чанар, тухайн баримт мэдээллийг нэхэмжилж буй үндэслэл, болон ийм төрлийн баримт бичиг тус бүрд хариу өгөх шаардлагатай шийдвэрийн заалтыг гаргаж өгнө.

Баримт мэдээллийг тодорхойлох

Энэхүү шийдвэрийн дагуу бүрдүүлсэн баримт бичигтэй танилцах ажлыг хөнгөвчлөх, тэдгээр мэдээллийн нууцлалыг хадгалах, үнэн зөв байдлыг хангах, шуурхай буцааж өгөх зорилгоор баримт бичиг бүрт дараалсан дугаарлалт өгч, таних дугаараар тэмдэглэхийг хүсдэг. Олон хуудастай, хавтасласан баримт бичгийн зөвхөн эхний хуудсыг дугаарлаж, баримт бичгийн нийт хуудасны тоог тэмдэглэнэ. Мөн бичиг баримтууд нь энэхүү шийдвэрийг хүргүүлэх үед байсан файлын хавтсандаа байх ёстой. Ийм файлын хавтаснуудыг өөр баримт бичиг мэтээр дугаарласан байх ёстой. Файлын хавтас бүрийн доторх бичиг баримтууд нь энэхүү шийдвэрийг хүргүүлэх үед байсан дараалаараа байх ёстой. Олон хуудастай бичиг баримтууд бүрэн бүтэн байх ёстой.

Баримт мэдээлэл гаргаж өгөх

Энэхүү шийдвэрийн дагуу шүүх, прокурор дээр ирж байгаа этгээд нь энэхүү шийдвэрт заасан баримт бичгийг ABC банкнаас хайж байгаа талаар бүрэн мэдлэгтэй байхаас гадна тухайн баримт бичгийн үнэн зөв эсэхийг бизнесийн үйл ажиллагааны хувьд баталгаажуулах чадвартай этгээд байх ёстой. Хэрэв нэг хүн энэ хоёр шаардлагыг биелүүлэх чадваргүй бол ABC банкнаас нэг ижил цаг, өдөр ирэх шаардлагатай нэмэлт хүмүүсийг томилох хэрэгтэй.

Цахим хэлбэрээр байгаа баримт бичгийг цахим хувилбараар гаргаж өгөхөөс гадна ABC банкны бүртгэл хөтлөгчөөс тухайн цахим эх хувийн үнэн зөв хуулбар болохыг баталгаажуулсан цаасан хуулбарыг хамт хүргүүлнэ. Бүх цахим баримт бичгийг ямар нэгэн тусгай программ хангамж ашиглахгүйгээр танилцаж, хайх боломжтой хэлбэрээр гаргаж өгөх ёстой.

Эх хувийг шаардах

Энэхүү шийдвэрийн дагуу дээр онцолж дурдсанаас бусад тохиолдолд энд заасан бүх баримт бичгийн эх хувийг гаргаж өгөхийг шаардана. Эх хувийн оронд хуулбарыг ирүүлсэн тохиолдолд энэхүү шийдвэрийг биелүүлээгүйд тооцно.

Хавсралт F. Цахим сангаар халхавчилсан бөгөөд цуврал байдлаар төлбөрийг шилжүүлэх аргууд.

Төлбөрийг шилжүүлэх арга зам

Society for Worldwide Bank Inter Financial Telecommunication (SWIFT) мессеж нь өөр хоорондоо шууд харилцах дансгүй санхүүгийн байгууллагуудын хоорондын корреспондент (хамтын ажиллагаа бүхий) банкны харилцааны салшгүй хэсэг юм. SWIFT нь эдгээр байгууллагуудын хооронд ашигладаг гүйлгээ хийх хоёр аргын мессеж форматыг боловсруулж хөгжүүлсэн нь: цуврал (эсхүл дараалсан) арга ба захиалгат гүйлгээний арга юм.

Цуврал/дараалсан төлбөрийн арга. Цуврал төлбөрийн аргын хувьд шилжүүлгийг илгээгч харилцагчийн санхүүгийн байгууллагаас дурын корреспондент банкуудаар дамжуулж, дараа нь хүлээн авагч харилцагчийн санхүүгийн байгууллага руу илгээдэг (Зураг F.1). Энэ үйл явцын эргэн тойрон дахь алхмууд нь клиринг (төлбөр тооцоо хийгдэх хүртэлх бүхий л процесс)-т хамаарах дараалсан шинжтэй үйлдлүүд байх ба улмаар эцсийн үр дүндээ төлбөр тооцоо шууд хийгддэг. Клиринг процессын явцад холбогдох төлбөр болон харилцагчийн мэдээллийг олж авах боломжтой.

Ийм шилжүүлэг хийхэд ашигладаг SWIFT мессежийн формат нь (MT) 103 буюу илгээгч, хүлээн авагч хоёрын аль алиных нь мэдээллийг агуулсан хүлээн авах талын банк руу шууд шилжүүлэх төлбөрийн даалгавар юм. MT 103 нь SWIFT сүлжээнд хамгийн өргөн хэрэглэгддэг мессежийн формат бөгөөд нийт SWIFT мессежийн 15 хувийг эзэлдэг байна.

Банкаар дамжуулан харилцагч хооронд шилжүүлэг хийх арга. Энэ арга нь харилцан хамааралгүй нэг банкнаас нөгөөд шилжүүлэг хийхэд корреспонд банкуудыг ашигладаг. Гэсэн хэдий ч Зураг F.1-ээс харахад шууд гүйлгээ хийх боломжтой хамтын ажиллагаа бүхий банк байхгүй бол төлбөр тооцоог хийгдэх процессыг хялбарчлахын тулд банк хоорондын корреспондент данстай байхыг шаарддаг. Энэ тохиолдолд илгээгч банк нь харилцагчийн гүйлгээг хийх тухай, мөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах мөнгөн шилжүүлэг нь банк хоорондын тусдаа харилцаагаар зохицуулагдаж хийгдэх талаар зааварчилгааг хүлээн авагч банкинд шууд өгч болно. Хэрэв шилжүүлэгч банкны корреспондент банк болон хүлээн авагч байгууллагын хооронд ямар ч харилцаа байхгүй бол төлбөр тооцоог өөр корреспондентээр дамжуулан хийж болно. Ийм үед, хүлээн авагч нь арилжааны харилцаа тогтсон банк хоорондын төлбөр тооцоо гүйцэтгэж дуусахаас өмнө, өөрийн банкин дахь дансыг эзэмшиж болно. Төлбөрийн үүргээ гүйцэтгэх нь нийт гүйлгээний зардал болон “клирингийн банк”-ны арилжааны гүйлгээг хийхэд зарцуулсан цаг хугацааг багасгахад тусладаг.

SWIFT мессеж гэдэгт, эцсийн хүлээн авагч банкинд төлбөр төлөх шилжүүлэгч нь банкны төлбөр төлөх үүргийг гүйцэтгэх зорилгоор корреспондент банк руу илгээсэн гүйлгээний захиалгыг MT 202 ашиглан гүйцэтгэх харилцаа мөн хамаарна. Эдгээр мессеж нь үндсэндээ санхүүгийн байгууллагуудын (жишээлбэл, гадаад

валютын арилжаа, хүүгийн төлбөр гэх мэт) хооронд хийгдэх төлбөр, тооцоонд ашиглагддаг. Харин MT 202 гүйлгээ хийх захиалга хүлээн авсан корреспондент банк MT 103 төрлийн гүйлгээг хүлээн авахгүй ба энэ нь тус банк MT103-т агуулагдах төлбөрийн мэдээллийг хянах, шүүх эсвэл шилжүүлгийн (төлбөрийн үүрэг гүйцэтгэх, эсхүл банк хоорондын төлбөр тооцоо) зорилгыг тодорхойлох боломжгүй гэсэн үг юм. Ийм учраас санхүүгийн шинжээч хийгдсэн төлбөр тооцоотой холбоотой бүх MT 103 төрлийн орлого, зарлагын гүйлгээг хянах нь чухал юм.

ЗУРАГ F.1 SWIFT цуврал/дараалсан болон харилцагч хоорондын гүйлгээ хийх процесс

a. Цуврал/дараалсан төлбөр гүйцэтгэх үе шат



b. Харилцагч хоорондын гүйлгээний үе шат



Эх сурвалж: Базелийн Банкны хяналтын хороо, *Due Diligence and Transparency Regarding Cover Payment Messages Related to Cross-Border Wire Transfers, 2009 оны 5 сар, хуудас 3.*
Тэмдэглэл: a. Нөгөө нэг хувилбар нь клирингийн систем байж болно.
b. Категор 9 ангиллын мессежийн төрлүүд нь MT 9xx төрлийн Бэлэн мөнгөний менежмент ба Хэрэглэгчийн статуст хамаарна.
MT = мессежний төрөл; SWIFT = Society for Worldwide Interbank Financial Telecommunication.

Харилцагч хооронд гүйлгээ хийх шинэ стандартууд (MT 202 COV)

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 16 нь санхүүгийн байгууллагууд хийж буй электрон гуйвуулгадаа илгээгч, хүлээн авагчийн мэдээлэл болон холбогдох зурвасын талаар оруулахыг шаарддаг бөгөөд эдгээр мэдээлэл нь төлбөрийн бүхий л үе шатуудын туршид хадгалагдаж байх ёстой байдаг. Түүнчлэн тус Зөвлөмжийн тайлбарт хил дамнасан мөнгөн гуйвуулга, дотоодын мөнгөн гуйвуулга, түүний дотор цуваа төлбөр болон төлбөрийн гүйцэтгэл (цөөн хэдэн нөхцөлд үл хамаарна) хийхэд, мөн төлбөрийн даалгавар гүйцэтгэх, дундын зуучлагч, хүлээн авагч зэрэг санхүүгийн байгууллагуудад илгээгч болон хүлээн авагчийн мэдээллийг нээлттэй болгох хэрэгтэй болохыг дурдсан байна.[1] Шигтгээ F.1 нь ил тод байдлын эргэлзээтэй болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд хүргэж болзошгүй мөнгөн шилжүүлгийн эсрэг Банкны хяналт шалгалтын Базелын хорооны хариу арга хэмжээг товч тайлбарласан болно.

ШИГТГЭЭ F.1	Илгээгчийн мэдээллийг нууцалсан мөнгөн шилжүүлгэд авах хариу арга хэмжээ

Шилжүүлэг илгээгчийн мэдээллийг нуухын тулд шилжүүлэг нь бүрэн бус мэдээлэл, буруу мэдээлэл эсвэл үйлчлүүлэгчийн хуурамч нэр (жишээ нь "Мики Маус") агуулж болно.

Банкны хяналт шалгалтын Базелын хорооны мэдээлснээр, "Хэрэв тухайн шилжүүлгийн талаар ерөнхий мэдээлэл оруулах талбар нь тодорхой утгагүй эсвэл бүрэн бус байвал дараах хариу арга хэмжээ авна. Жишээлбэл, (i) Бүрэн бус болон дутуу мэдээллийг тодруулахын тулд илгээгч банк эсвэл зуучлагч банктай холбоо барих (ii) корреспондент, эсвэл зуучлагч банктай харилцах харилцааг хязгаарлах эсвэл цуцлах эсэх талаар (тухайн корреспондент банк удаа дараа оролцсон тохиолдолд, эсхүл корреспондент банк нэмэлт мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд) авч үзэх; банкууд ийм нөхцөл байдлын талаар хянагчдаа мэдээлэх; түүнчлэн (iii) үүссэн нөхцөл байдал нь тухайн орон нутаг дахь эрх бүхий байгууллагад гомдол гаргах, мэдээлэл өгөх шаардлагад нийцэж байгаа тохиолдолд сэжигтэй үйл ажиллагааны талаар мэдээлэх" зэрэг болно.

Эдгээр үйлдлүүд нь угаасан мөнгийг мөрдөх, илрүүлэх зэргээр санхүүгийн шинжээчид туслаж чадах банкны дотоод бүртгэлийг бий болгодог.

[1] ФАТФ-ын Зөвлөмж 16 ("Цахим шилжүүлэг") болон уг Зөвлөмжийн тайлбарыг харна уу."Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх талаар олон улсын стандарт" 2020 оны 10-р сард шинэчлэгдсэн, хуудас 17–18, 78–83, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.

ШИГТГЭЭ F.2 Санхүүгийн байгууллагуудын бүртгэлийг хянах

Ерөнхийдөө санхүүгийн байгууллагууд мөнгөн гуйвуулгатай холбоотой олон хэлбэрийн хяналтыг ашигладаг:

- *Санхүүгийн хориг арга хэмжээ авагдсан эсэхийг шалгах.* Автоматаар, тухайн цаг хугацаанд систем нь илгээгч, хүлээн авагч, төлбөрийн мэдээллийг уншиж, НҮБ-ын болон бусад хориг арга хэмжээний жагсаалтад багтсан нэр байгаа эсэхийг шалгадаг. Хэрэв тохирч байвал гүйлгээтэй холбоотой мэдээллийг хянуулахаар тусгаарлаж, төлбөрийн гүйцэтгэлийг хийхээс татгалзах эсвэл санхүүгийн тагнуулын алба болон бусад холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ. Энэ бүх үйл явц нь санхүүгийн шинжээч банкнаас шаардаж, хянаж үзэх ёстой цахим болон цаасан бүртгэлийг бий болгоход хүргэдэг.
- *Гүйлгээ хийгдсэний дараа тавих хяналт.* Энэ нь гуйвуулгыг дамжуулсны дараа хийгддэг бөгөөд хэвийн бус эсвэл сэжигтэй байж болзошгүй үйл ажиллагааг хайж илрүүлэхэд эрсдлийг таамаглах аргыг ашигладаг арга юм. Энэ үйл явц нь мөн санхүүгийн шинжээч банкнаас шаардан авч, хянах ёстой бүртгэлийг бий болгоно.

Банкны шилжүүлгийн хяналт. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) Зөвлөмж 16-д санхүүгийн байгууллагууд мөнгөн шилжүүлэг илгээгч болон хүлээн авагчийн мэдээлэл дутуу тохиолдолд тус мэдээллийг илрүүлэхийн тулд мөнгөн гуйвуулгад хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авахыг заасан. Тус 16-р зөвлөмжийн тайлбар хэсэгт эдгээр шаардлагатай авч хэрэгжүүлэх арга хэмжээг илүү нарийвчлан тусгасан- жишээлбэл, холбогдох мэдээлэл болон гүйлгээ хийх лавлагааны дугаарыг шилжүүлгийн мэдээлэлд оруулахыг шаардаж болно. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн гэх сэжиг байгаа тохиолдолд санхүүгийн байгууллагууд харилцагчийн мэдээллийг шалгаж болно. Төлбөрийн даалгавар гүйцэтгэж буй санхүүгийн байгууллага нь шаардлага хангаагүй мөнгөн гуйвуулга хийх ёсгүй бөгөөд гүйлгээтэй холбоотой бүртгэлийг таван жилийн турш хөтлөх ёстой. Зуучлагч санхүүгийн байгууллага нь шаардлага хангаагүй мөнгөн шилжүүлгийг хэзээ гүйцэтгэх, татгалзах, түдгэлзүүлэхээ тодорхойлж, холбогдох арга хэмжээг авахын тулд эрсдэлд суурилсан бодлого, журамтай байх хэрэгтэй.

a. ФАТФ-ын Зөвлөмж 16, "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх талаар олон улсын стандарт" 2020 оны 10-р сард шинэчлэгдсэн, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations /pdfs/FATF%20Recommendations%202012.pdf.
b. ФАТФ-ын Зөвлөмж 16-ын тайлбар."Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх талаар олон улсын стандарт", хуудас 17–18, 78–83.

Дэлхийн банк хоорондын харилцаа холбооны тэргүүлэгчийн хувьд, мөн хил дамнасан мөнгөн шилжүүлгийн олон улсын төлбөрийн мэдээллийн практикийг стандартчилахын тулд SWIFT нь 2009 оны 11-р сараас эхлэн бүх төлбөрийн төлбөрийн шинэ стандартуудыг боловсруулсан. Шинэ MT 202 COV мэдээллийн формат нь MT 202-ын энгийн нэг хувилбар бөгөөд илгээгч байгууллагад байгаа бүх гүйлгээтэй холбоотой мэдээллийг төлбөр тооцооны үйл явцын туршид оролцох бусад байгууллагуудад ч нээлттэй болгох замаар илүү ил тод байдлыг хангах зорилготой юм.

Одоо бүх төлбөрийн гүйцэтгэлд ашиглагдах ёстой MT 202 COV нь MT 103-т агуулагдах мэдээллээс заримыг нь (тухайлбал, илгээгч болон хүлээн авагчийн мэдээллийн талбар) хуулбарладаг. MT 202 нь банк хоорондын төлбөр тооцоонд ашиглагдаж болох боловч харилцагчаас илгээх гүйлгээнд ашиглахгүй. Энэхүү шинэ

стандартыг бий болгосноор санхүүгийн байгууллагууд, ялангуяа корреспондент банкууд урьд өмнө нь мэддэггүй байсан харилцагчийн болон төлбөрийн мэдээлэлд эрсдэлд суурилсан хяналтын арга хэрэгслийг хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Хэдийгээр MT 202 COV стандарт нь харилцагч болон санхүүгийн байгууллагыг илтгэх бүх мэдээллийг оруулахыг шаарддаг ч SWIFT нь уг стандартыг баталгаажуулах, тодорхойлох үүрэг гүйцэтгэдэггүй гэдгийг анхаарах нь чухал юм. Энэ хариуцлагыг гишүүн байгууллагууд өөрсдөө үүрдэг. SWIFT систем нь илгээгч болон хүлээн авагчийн мэдээллийн талбарууд хоосон байвал шилжүүлэг хийхээс татгалздаг; гэхдээ тэдгээр талбарт оруулсан мэдээлэл нь худал эсвэл бүрэн бус өгөгдөл агуулсан эсэхийг тодорхойлж чадахгүй. Шигтгээ F.2-д санхүүгийн байгууллагууд мөнгөн шилжүүлгийн мэдээллийг хянах оролдлого хийдэг хоёр аргыг тайлбарлан харууллаа.

Хавсралт G. Санхүүгийн хувийн хэргийн маягтын загвар

Санхүүгийн хувийн хэрэг

Эцэг/Эх-ийн нэр	Лавлагааны дугаар (URN)

Өөрийн нэр	

Нууц нэр	Төрсөн огноо

Хаяг	

Арилжаатай холбоотой

Эрүүгийн хэрэг хариуцсан ажилтан _____

Хар тамхитай тэмцэх

Хэлтэс/Салбар _____

Утас _____

Санхүүгийн шинжээч _____

Хэлтэс/Салбар _____

Утас _____

Эрүүгийн хэргийн өмгөөлөгч _____

Утас _____ Факс _____

Эрүүгийн хэргийн зөвлөх _____

Утас _____ Факс _____

Санхүүгийн өмгөөлөгч _____

Утас _____ Факс _____

Санхүүгийн зөвлөх _____

Утас _____ Факс _____

Шүүхийн шинжилгээний нягтлан бодогч _____

Утас _____ Факс _____

Санхүүгийн хувийн хэрэг –Үзүүлэлт ба хяналтын хуудас

1 дүгээр хэсэг: Хувийн санхүүгийн намтар

ХӨРӨНГӨ	Хураан авсан бэлэн мөнгө/үнэт зүйл	
	Банкны данс	
	Бусад банк/нийгэмлэгийн данс	
	Үндэсний хадгаламж	
	Бонд	
	Хувьцаа	
	Хөрөнгө оруулалтын сан	
	Амьдралын даатгалын бодлого/мөнгөн сан	
	Авто тээврийн хэрэгсэл	
	Усан онгоц/автомашин/агаарын хөлөг г.м	
	Бусад	
	Гуравдагч этгээдэд өгөх бэлэглэлийн зүйлийн өртөг	
ӨР ТӨЛБӨР	Зээлийн карт	
	Худалдааны төвийн карт	
	Зээлийн гэрээ	
	Хүүхдийн тэтгэмж	
	Шүүхийн шийдвэр/торгууль/хураан авах шийдвэр	
	Бусад төлбөр/өр	
	Дансны зээлийн эрх	
	Төлбөрийн чадвар	
МЭДҮҮЛСЭН ОРЛОГО	Ажил эрхлэлт	
	Өмнөх ажил эрхлэлт	
	Орлогын албан татвар	
	Орлогын бусад эх сурвалж	
ЭД ХӨРӨНГӨ	Өмч хөрөнгө	
	Эзэмшигч	
	Түрээслэсэн эд хөрөнгө	
	Эзэмшиж буй эд хөрөнгө	
	Өртөг	
	Ипотекийн зээл	
	Эд хөрөнгийн зардал	
	Газрын түрээс (түрээслэж буй тохиолдолд)	
	Гуравдагч этгээдийн ашиг сонирхол	
	Байр/байшинд агуулагдах эд зүйлс	

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ	Иргэний төлбөр	
	Усны төлбөр	
	Цахилгааны төлбөр	
	Газ	
	Утас	
	Гар утас	
	Интернэт/кабел	
	Эд хөрөнгийн болон түрээслэгчийн даатгалын шимтгэл	

2 дугаар хэсэг: Бизнесийн санхүүгийн намтар

БИЗНЕСИЙН ХӨРӨНГӨ	Банкны данс	
	Автомашин	
	Үйлдвэр/машин тоног төхөөрөмж г.м	
	Оффис/худалдааны эд хогшил, тоноглол	
	Бусад үнэ цэнтэй эд хөрөнгө	
	Биржийн хувьцаа	
	Үйлдвэрлэлийн өртөг	
	Бүрэн баталгаат зээлдэгч	
	Хэсэгчилсэн баталгаат зээлдэгч	
	Бусад (оюуны өмчийн эрх г.м)	
БИЗНЕСИЙН ЗАРДАЛ, ӨР ТӨЛБӨР	Ажилтнууд	
	Бүрэн баталгаат зээлэгч	
	Хэсэгчилсэн баталгаат зээлэгч	
	Зээлийн карт	
	Дебит карт	
	Зээлийн гэрээ	
	Шууд дебит/байнгын захиалга	
	Шүүхийн шийдвэр	
	Татан буулгах шүүхийн шийдвэр/өөрсдийн санаачлагаар татан буугдах	
	Бусад гэрээгээр хүлээсэн хариуцлага	
	Корпорацийн татвар/орлогын татар	
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	

БИЗНЕСИЙН ЦАР ХҮРЭЭ	Урьдчилсан үнэлгээ	
	Худалдааны түнш/компани	
	Компанийн захирал/түнш	
	Компанийн бичиг баримт	
	Бизнесийн сонирхол	
	Бизнесийн бодит хөрөнгө	
БИЗНЕСИЙН ЭД ХӨРӨНГӨ	Биет бус хөрөнгө	
	Бусад эзэмшигч	
	Өр төлбөр	
	Барьцаа (бизнесийн)	
	Эд хөрөнгөтэй холбоотой бусад зардал	
	Тогтмол зардал/бизнесийн зардал	
	Усны зардал (бизнесийн)	
	Цахилгааны төлбөр (бизнесийн)	
	Газ (бизнесийн)	
	Утас (бизнесийн)	
	Эд хөрөнгийн даатгал (бизнесийн)	
	Байгууллагын эд зүйлсийн даатгал	
	Компанийн даатгалын нэхэмжлэл	

1 дүгээр хэсэг: _____-ийн дэлгэрэнгүй хувийн санхүүгийн намтар

МЭДҮҮЛСЭН ОРЛОГО

Ажил эрхлэлт

	Одоогийн ажил эрхлэлт	Өмнөх ажил эрхлэлт
Ажил олгогчийн нэр эсхүл хувиараа хөдөлмөр эрхэлдэг эсэх:		
Мэргэжил:		
Нийт орлого:		
7 хоног/сар эсхүл жилээр		
Эхлэх огноо:		
Дуусах огноо:		
Тэмдэглэл:		

Орлогын татварын дэлгэрэнгүй

Татвар ногдох хугацаа:	
Татвар төлөгчийн дугаар:	
Төлсөн татвар:	
Татварын байгууллага:	
Тэмдэглэл:	

Орлогын бусад эх сурвалж

Орлогын эх сурвалж:	
Тэмдэглэл:	

PROPERTY

Дэлгэрэнгүй мэдээлэл

	Одоогийн эд хөрөнгө	Өмнөх хаяг
Дэлгэрэнгүй хаяг, шуудангийн код:		
Худалдан авсан огноо:		
Худалдан авсан үнэ:		
Одоогийн (бодит) үнэ цэн:		
Өмнө тодорхойлсонүнэ цэн:		
Үнэлгээ тогтоогчийн нэр, хаяг:		
Эд хөрөнгийг эзэмшиж буй этгээдийн нэр:		
Ипотекийн зээл/төлбөр:		
Газрын бүртгэлийн гэрчилгээ, хавсаргасан эсэх(тийм/үгүй), огноо:		
Тэмдэглэл:		

Ипотекийн зээл

Барьцаат хөрөнгийн нэр:	
Барьцаат хөрөнгийн хаяг:	
Данс эзэмшигчийн нэр(с):	
Дансны дугаар:	
Зээлийн хэмжээ:	
Зээл авсан огноо:	
Дансны үлдэгдэл:	
Төлөлт 7 хоногоор/сараар:	
Эргэн төлөх арга, хэлбэр:	
Өр төлбөр:	
Тэмдэглэл:	

Эд хөрөнгөтэй холбоотой бусад зардал

Төлбөр тогтоогч:	
Хаяг:	
Төлбөрийн хэмжээ:	
Төлбөр төлөх хугацаа:	
Төлбөр тогтоосон үндэслэл:	
Тэмдэглэл:	

Газрын түрээс (түрээсэлж буй тохиолдолд)

Газрын эзний нэр:	
Газрын эзний хаяг:	
Түрээсийн хэмжээ сараар/жилээр:	
Түрээс төлөх хугацаа:	
Түрээс төлөх арга, хэлбэр:	
Тэмдэглэл:	

Эд хөрөнгийн талаар гуравдагч этгээдийн сонирхол

Статус/байр суурь:	
Нэр:	
Дүн:	
Ипотекийн зээлийн шимтгэл:	
Шимтгэлтэй холбоотой зардал:	
Тэмдэглэл:	

Эд зүйлс (зөвхөн ихээхэн үнэ цэн бүхий: эртний эдлэл, зураг, үнэт эдлэл болон бичлэг/гэрэл зураг г.м)

Тодорхойлолт	Үнэ цэн
Тэмдэглэл:	

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ (Өмчийн хариуцлага)

Нийтийн төлбөр

	Нийтийн төлбөр	Усны төлбөр	Цахилгааны төлбөр	Газ
Төлбөр/татвар авагч байгууллага:				
Төлбөрийн хэмжээ (жилээр):				
Төлбөр төлөх хугацаа, хэлбэр:				
Одоогийн/үлдэгдэл өр төлбөр:				
Тэмдэглэл:				

Утасны зардал

	Суурин утас	Гар утас
Утасны дугаар:		
Төлбөр авагч байгууллага:		
Төлбөрийн хэмжээ (жилээр):		
Төлбөр төлөх хугацаа, хэлбэр:		
Одоогийн/үлдэгдэл өр төлбөр:		
Дэлгэрэнгүй тооцоог хавсаргасан эсэх (Тийм/үгүй):		
Тэмдэглэл:		

Эд хөрөнгийн даатгал

Даатгалын компани:	
Даатгасан хөрөнгийн хэмжээ:	
Даатгалын эрсдэл:	
Хураамжийн хэмжээ 7 хоногоор/жилээр:	
Төлбөр төлөх хугацаа:	
Төлбөр төлөх хэлбэр:	
Онцгой эрсдэл:	
Тэмдэглэл:	

ХӨРӨНГӨ

Цагдаагийн газар/Гаалийн газраас хураан авсан Бэлэн мөнгө/Үнэт зүйл

Дүн/үнэ цэн:	
Хүлээлгэн өгсөн байршил:	
Хүлээлгэн өгсөн огноо:	
Хүлээлгэн өгөх болсон үндэслэл:	
Хураан авсан байршил:	
Эрх хязгаарласан эсэх (тийм/үгүй)	
Тэмдэглэл:	

Банкны /нийгэмлэгийн данс

Банкны нэр:	
Банкны хаяг:	
Банкны дугаар (сорт код):	
Дансны дугаар:	
Дансны төрөл:	
Данс эзэмшигчийн овог, нэр:	
Дансны үлдэгдэл:	
Жилд хийсэн нийт гүйлгээ:	
Жилд хийсэн нийт бууруулсан дүнтэй гүйлгээ:	
Тэмдэглэл:	

Үндэсний хадгаламж

Батламжийн дугаар:	
Үнэ цэн:	
Олгосон газар:	
Олгосон огноо, хадгаламжийн хэмжээ:	
Тэмдэглэл:	

Бонд

Гэрчилгээний дугаар:	
Үнэ цэн:	
Олгосон газар:	
Олгосон огноо, хадгаламжийн хэмжээ:	
Тэмдэглэл:	

Хувьцаа

	Арилжих хувьцаа	Арилжихгүй хувьцаа
Компанийн нэр:		
Эзэмшиж буй хэмжээ:		
Батламж олгосон газар:		
Эзэмшиж буй үнэ цэн:		
Хувьцаа шилжүүлэх бирж:		
Тэмдэглэл:		

Трастын нэгж

Трастын тодорхойлолт:		
Нэгжийн тоо хэмжээ:		
Үнэ цэн:		
Эзэмшигчийн нэр, хаяг:		
Тэмдэглэл:		

Амьдралын даатгалын бодлого/хөрөнгө оруулалтын сан

Даатгалын компани:	
Салбарын хаяг:	
Бодлого:	
Гэрээ цуцласнаар даатгуулагчид төлөх төлбөр:	
Даатгуулагч:	
Шимтгэлийн хэмжээ 7 хоногоор/сараар/ жилээр:	
Төлөх хугацаа, хэлбэр:	
Ипотекийн зээлийг холбосон эсэх (Тийм/Үгүй):	
Тэмдэглэл:	

Автомашин, Усан онгоц, Нисэх онгоц г.м.

	Автомашин	Усан онгоц, нисэх онгоц г.м
Үйлдвэр, загвар:		
Үйлдвэрлэсэн газар:		
Бүртгэлийн дугаар (байгаа тохиолдолд):		
Борлуулагчийн мэдээлэл:		
Худалдах үнэ:		
Одоогийн үнэ цэн (өртөг):		
(бүртгэгдсэн) хадгалагч:		
Лизингийн зээлээр худалдан авсан эсэх (Тийм/Үгүй):		

Компанийн нэр:		
Компанийн хаяг:		
Гэрээ байгуулсан огноо:		
Гэрээний үнийн үлдэгдэл:		
Тэмдэглэл:		

Бусад хувийн эд хөрөнгө

Тодорхойлолт	Эзэмшигч	Байршил	Худалдах үнэ	Үнэ цэн (өртөг)
Тэмдэглэл:				

Гуравдагч этгээдэд зориулсан бэлэг

Тодорхойлолт	Эзэмшигч	Байршил	Худалдах үнэ	Үнэ цэн (өртөг)

ӨР ТӨЛБӨР

Зээлийн карт

Картын нэр төрөл:	
Зээлийн дүн:	
Дундаж төлбөр:	
Карт эзэмшигчийн нэр:	
Тэмдэглэл:	

Дэлгүүрийн карт

Картын нэр төрөл:	
Зээлийн дүн:	
Дундаж төлбөр:	
Карт эзэмшигчийн нэр:	
Тэмдэглэл:	

Зээлийн гэрээ

Компанийн нэр:	
Салбар:	
Зээлийн зорилго:	
Зээлсэн дүн:	
Үлдэгдэл зээл:	
Сар бүрийн эргэн төлөлтийн хэмжээ:	
Өр төлбөр:	
Тэмдэглэл:	

Үйлчилгээний зардал

Шүүх/байгууллага:	
Захиалгын огноо:	
Төлбөр авагч:	
Төлбөрийн дүн:	
Төлбөр төлөх хугацаа:	
Төлбөрийн хэлбэр:	
Тэмдэглэл:	

Шүүхийн шийдвэр/Торгууль/Өмнөх хураан авах тухай шийдвэр

Шүүх:	
Захиалгын огноо:	
Төлбөр авагч:	
Төлбөрийн дүн:	
Төлбөр төлөх хугацаа:	
Төлбөрийн хэлбэр:	
Тэмдэглэл:	

Бусад хариуцлага/өр төлбөр

Зээлдүүлэгч:	
Зээлдүүлэгчийн хаяг:	
Өрийн дүн:	
Өрийн дэлгэрэнгүй мэдээлэл:	
Тэмдэглэл:	

Бодит овердрафт (зээл, өр төлбөр)

Банк:	
Хаяг, утасны дугаар:	
Банкны бүртгэлийн дугаар/дансны дугаар:	
Хэмжээ:	
Тэмдэглэл:	

Төлбөрийн чадвар:

Төлбөрийн чадваргүй болохыг тогтоосон шийдвэр, тушаал гарсан эсэх (Тийм, үгүй):	
Тушаал, шийдвэрийн дугаар:	
Итгэмжлэгдэгч/Эрх хүлээн авагч:	
Хаяг	
Холбоо барих утас:	
Тэмдэглэл:	

2 дугаар хэсэг: _____-ийн Бизнесийн санхүүгийн намтар

БИЗНЕСИЙН АШИГ СОНИРХОЛ

Урьдчилсан үнэлгээ

Хувиараа бизнес эрхлэгч болон бизнесийн байгууллагын үйл ажиллагаа явуулах суурь нөхцөл болсон үл хөдлөх хөрөнгө байгаа эсэх (Тийм/Үгүй)	
Бодит ашиг сонирхол нь эд хөрөнгөд нь суурьласан нөхөрлөл/хязгаарлагдмал компани эсэх (Тийм/Үгүй)	
Нөхөрлөл/Компани нь өмчтэй (хөдлөх болон үл хөдлөх) эсэх (Тийм/Үгүй)	
Тэмдэглэл:	

Худалдааны Түнш/Компани

Нэр:	
Үүсгэн байгуулагдсан огноо:	
Компанийн бүртгэлийн дугаар (байгаа тохиолдолд):	
НӨАТ бүртгэлийн дугаар:	
Худалдааны хаяг:	
Бүртгэлтэй хаяг:	
Тэмдэглэл:	

Компанийн захирал/түнш

Нэр:	
Хаяг:	
Албан тушаал:	
Тэмдэглэл:	

Компанийн баримт бичиг

Компанийн дэлгэрэнгүй мэдээлэл (Тийм/Үгүй)		Огноо:	
Санхүүгийн данстай эсэх (Тийм/Үгүй)		Огноо:	
Жилийн ашиг, өгөөж		Огноо:	
Тэмдэглэл:			

Бизнес эрхлэгчийн сонирхол

Дэлгэрэнгүй мэдээлэл	Үнэ цэнэ (өртөг)
Тэмдэглэл:	

Realizable Property Held by Business

Дэлгэрэнгүй мэдээлэл	Үнэ цэнэ (өртөг)
Тэмдэглэл:	

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Хөрөнгө

Худалдааны нэр:	
Бизнесийн хаяг:	
Үл хөдлөх хөрөнгө эзэмших эрх/санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө/түрээслэсэн хөрөнгө (түрээслэсэн тохиолдолд доорхыг харна уу)	
Бүртгэлтэй газар байгаа эсэх (Тийм/Үгүй)	
Өмчлөх эрхийн дугаар:	
Худалдан авсан үнэ:	
Худалдан авсан огноо:	
Төлөгдөөгүй дүн:	
Одоогийн өр:	
Одоогийн үнэ цэн (өртөг):	
Өмнөх үнэлгээний огноо:	
Үнэлгээ тогтоогчийн нэр:	
Үнэлгээ тогтоогчийн хаяг:	
Тэмдэглэл:	

Бусад эзэмшигчид

Давхар түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн хэсэг мөн эсэх (тийм/үгүй):	
Давхар түрээслэсэн хөрөнгийн мэдээлэл. Бүс 1:	
Түрээслэгчийн нэр:	
Түрээслэгчийн хаяг:	
Түрээсийн хэмжээ:	
Түрээс авагч:	
Давхар түрээслэсэн хөрөнгийн мэдээлэл. Бүс 2:	
Түрээслэгчийн нэр:	
Түрээслэгчийн хаяг:	
Түрээсийн хэмжээ:	
Түрээс авагч:	
Ашиг сонирхол бүхий гуравдагч этгээдийн мэдээлэл:	
Тэмдэглэл:	

Түрээслэсэн үл хөдлөх хөрөнгө

Газар өмчлөгчийн нэр:	
Газар өмчлөгчийн хаяг:	
Түрээсийн төлбөр 7 хоногоор/сараар:	
Төлбөрийн хэлбэр/түрээс төлөгч:	
Тэмдэглэл:	

Ипотек (Үл хөдлөх хөрөнгө)-ийн зээл

Зээлдүүлэгчийн нэр:	
Зээлдүүлэгчийн хаяг:	
Дансны дугаар:	
Данс эзэмшигчийн нэр(с):	
Зээлийн хэмжээ:	
Түрээсийн хэмжээ 7 хоногоор/сараар:	
Төлбөрийн хэлбэр/түрээс төлөгч:	
Тэмдэглэл:	

Эд хөрөнгөтэй холбоотой бусад төлбөр

Төлбөр хариуцагчийн нэр:	
Төлбөр хариуцагчийн хаяг:	
Төлбөрийн хэмжээ:	
Бүртгэлийн огноо:	
Тэмдэглэл:	

Бизнесийн зардал

	Тогтмол зардал/ төлбөр	Усны төлбөр	Цахилгааны төлбөр	Газын төлбөр	Утасны төлбөр
Төлсөн:					
Төлбөрийн хэмжээ 7 хоногоор/сараар					
Төлбөрийн арга хэрэгсэл					
Одоогийн өр төлбөр					
Тэмдэглэл:					

Бизнесийн Даатгал

	Үл хөдлөх хөрөнгө	Агуулга
Даатгалын газрын (даатгагч) нэр:		
Даатгагчийн хаяг:		
Даатгасан хөрөнгийн хэмжээ:		
Эрсдлийн хэмжээ:		
Хураамж 7 хоногоор/сараар		
Төлөх хэлбэр/хураамж төлөгч		
Тэмдэглэл:		

Компанийн даатгалын нэхэмжлэл

Даатгалын компани:	
Нэхэмжилсэн огноо:	
Нэхэмжлэлийн хэлбэр:	
Нэхэмжиллийн үнэ:	
Даатгалын нөхөн төлбөр олгосон дүн:	
Олгосон огноо:	
Олгосон хэлбэр:	
Нэхэмжлэлийн хуулбар хавсаргасан эсэх (Тийм/Үгүй)	
Тэмдэглэл:	

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭД ХӨРӨНГӨ

Бизнесийн банкны данс

Банкны нэр:	
Салбарын хаяг:	
Бүртгэлийн дугаар (Сорт код):	
Дансны дугаар:	
Данс эзэмшигчийн нэр(с):	

Дансны үлдэгдэл:	
Үлдэгдлийн огноо:	
Нийт шилжүүлэг:	
Нийт хязгаарлагдмал шилжүүлэг:	
Данстай харилцах итгэмжлэгдсэн төлөөлөгч:	
Нэр:	
Тэмдэглэл:	

Автомашин, Үйлдвэрийн тоног төхөөрөмж г.м.

	Автомашин	Үйлдвэрийн тоног төхөөрөмж
Үйлдвэр, загвар:		
Бүртгэлийн дугаар (байгаа тохиолдолд):		
Борлуулагчийн мэдээлэл (автомашин):		
Худалдах үнэ:		
Одоогийн үнэ цэн (өртөг):		
(бүртгэгдсэн) хадгалагч:		
Лизингийн зээлээр худалдан авсан эсэх (Тийм/Үгүй):		
Компанийн нэр:		
Компанийн хаяг:		
Гэрээ байгуулсан огноо:		
Гэрээний үнийн үлдэгдэл:		
Тэмдэглэл:		

Оффис/худалдааны эд хогшил, тоноглол

Үйлдвэр, загвар:	
Сериал дугаар:	
Худалдах үнэ:	
Одоогийн үнэ цэн (өртөг):	
Лизингээр худалдан авсан эсэх (Тийм/Үгүй):	
Лизингийн компанийн нэр:	
Компанийн хаяг:	
Гэрээ байгуулсан огноо:	
Тэмдэглэл:	

Бусад үнэ цэнтэй эд хөрөнгө

Дэлгэрэнгүй мэдээлэл:	
Бүртгэлийн мэдээлэл (байгаа тохиолдолд):	
Худалдах үнэ:	
Одоогийн үнэ цэн (өртөг):	
Хадгалагч этгээд/Байршил:	
Хуваарь төлсөн/түрээслэж буй эсэх (Тийм/Үгүй):	
Компанийн нэр:	
Компанийн хаяг:	
Гэрээ байгуулсан огноо:	
Гэрээний дүнгийн үйлдэгдэл:	
Тэмдэглэл:	

Биржийн хувьцаа

Мэдээлэл	Үнэ цэн (өртөг)	Үнэ цэнийг тодорхойлсон огноо
Тэмдэглэл:		

Үйлдвэрлэлийн өртөг

Мэдээлэл	Үнэ цэн (өртөг)	Үнэ цэнийг тодорхойлсон огноо
Тэмдэглэл:		

Бүрэн баталгаат зээлдэгч (Бизнесийн)

Нэр	Хаяг	Дүн	Барьцаа
Тэмдэглэл:			

Хэсэгчилсэн баталгаат зээлдэгч (Бизнесийн)

Нэр	Хаяг	Дүн	Барьцаа
Тэмдэглэл:			

БИЗНЕСИЙН ЗАРДАЛ, ӨР ТӨЛБӨР

Ажилтнууд

Бүтэн цагийн:	
Хагас цагийн:	
Төлөгдөөгүй цалин:	
Тэмдэглэл:	

Бүрэн баталгаат зээлдэгч (Бизнесийн)

Нэр	Хаяг	Дүн	Барьцаа
Тэмдэглэл:			

Хэсэгчилсэн баталгаат зээлдэгч (Бизнесийн)

Нэр	Хаяг	Дүн	Барьцаа
Тэмдэглэл:			

Зээлийн карт, дебит карт

	Зээлийн карт	Дебит карт
Картын нэр:		
Зээлсэн хэмжээ:		
Дундаж төлөлт:		
Карт эзэмшигчийн нэр:		
Тэмдэглэл:		

Зээлийн гэрээ (Бизнесийн)

Компанийн нэр:	
Салбар:	
Зээлийн зорилго:	
Зээлсэн дүн:	
Буцааж төлөх дүн:	
Сар бүрийн төлбөр:	
Өр:	
Тэмдэглэл:	

Шууд дебит/Байнгын захиалга

Банкны нэр:	
Салбарын мэдээлэл:	
Дансны дугаар:	
Данс эзэмшигчийн нэр(с):	
Төлөх дүн 7хоногоор/сараар:	
Төлөх хугацаа:	

Төлвөл зохих:	
Тэмдэглэл:	

Шүүхийн шийдвэр

Шүүх:	
Шийдвэрийн дугаар:	
Шийдвэрээр тогтоосон дүн:	
Төлбөр төлөх арга, хэлбэр:	
Тэмдэглэл:	

Шүүхийн шийдвэрээр татан буулгах/Өөрийн санаачлагаар татан буугдах

Шүүхийн шийдвэрээр татан буулгаж байгаа эсэх (Тийм/Үгүй):	
Өөрийн санаачлагаар татан буугдаж байгаа эсэх (Тийм/Үгүй):	
Шийдвэрийн дугаар:	
Тогтоол:	
Тэмдэглэл:	

Гэрээгээр хүлээсэн бусад үүрэг хариуцлага, өр төлбөр

Мэдээлэл	Дүн, хэмжээ	Төлвөл зохих огноо
Тэмдэглэл:		

Корпорацийн татвар/Орлогын татвар

Татварын байцаагчийн нэр:	
Татварын байцаагчийн хаяг:	
Дүүрэг:	
Лавлагааны дугаар:	
Татварын хэмжээ:	
Тэмдэглэл:	

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)

НӨАТ оногдуулж буй байгууллага:	
Хаяг:	
НӨАТ төлөгчийн бүртгэлийн дугаар:	
Татварын хэмжээ:	
Шалгагдаж байгаа эсэх (Тийм/Үгүй):	
Тэмдэглэл:	

Тодорхой этгээд эзэмшиж, ашиглаж байгаа боловч түүний өмчлөлийн бус үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой заалт (хөлсөөр авсан, зээлээр авсан, засвар хийх зорилгоор авсан, эсхүл өөр этгээдийн нэхэмжилсэн бараа гэх мэт). (Нэхэмжлэлийг дэмжсэн нотлох баримтууд авагдсан байх шаардлагатай.)

Зүйл	Үнэ цэнэ	Гуравдагч этгээдийн ашиг сонирхол
Тэмдэглэл:		

Эх сурвалж: Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах: Шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах талаарх сайн туршлагууд, (Вашингтон ДС: Дэлхийн банк, 2009), 213.Теодор С.Гринберг, Линда М.Самуэль, Вингате Грант болон Ларисса Грэй.

Хавсралт Н. Харилцах сувгаар дамжуулан хэлэлцэх боломжтой асуудлууд - Албан бус туслалцааны үе шат

Хэлэлцүүлэх асуудлууд

- Өөрийн олж авсан мэдээллийг тодорхойлох
- Санхүүгийн тагнуулын албаар дамжуулан санхүүгийн дүн шинжилгээ авах зэрэг мөрдөн шалгах ажиллагаа, хөрөнгө мөшгих зорилгоор дүн шинжилгээний болон мэдээллийг олж авах
- Хөрөнгийг мөшгих, барих эсхүл хязгаарлах эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг дэмжих суур мэдээллийг олж авах (тухайлбал, нэр, төрсөн огноо, гарчийн хаяг; банкны дансны байршил; банкны дансны дугаар; эд хөрөнгө болон гэмт хэрэг, гэмт этгээдүүдийн хоорондын холбоо)
- Хөрөнгийн эзэмшигч эсвэл зорилтот этгээдэд мэдэгдэл хүргүүлэх зэрэг албадлагын бус арга хэмжээ авах аливаа шаардлага, журмыг баталгаажуулах.
- Сарних эрсдэлээс зайлсхийх зорилгоор яаралтай түр зуурын арга хэмжээний (эрх зүйн харилцан туслалцаа бус) аливаа сонголтуудын талаар мэдэх. Хэрэв ийм сонголт байгаа бол ямар журам, шаардлага тавих вэ?
- Нэмэлт хэрэгцээг тодорхойлох: яаралтай, нууцлал, журмуудыг дагаж мөрдөнө.
- Олон улсын хамтын ажиллагаанд тулгарч болох саад бэрхшээлүүд, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад хамгийн тохиромжтой газар болон хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх боломж эсхүл хэргийн конференц ашиглах боломж зэрэг хэргийн стратегийг хянах
- Хэрэв хэд хэдэн мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага байгаа бол туслалцаа үзүүлэх боломжтой холбогдох байгууллагыг тодорхойлох
- Нөөцийн асуудлыг хянах
- Эрх зүйн харилцан туслалцааны шаардлага, үйл явц, холбоо барих зэрэг дараагийн алхмуудад чиглэл авах

Анхаарч байх хэрэгтэй асуудлууд (Асуудлыг хэлэлцэхээс өмнө түншийг тодорхойлох)

- Зарим улс орнуудтай мэдээлэл солилцоход Харилцан ойлголцлын санамж бичиг хэрэг болж магадгүй юм.
- Хууль тогтоомж болон хөрөнгө хураах тогтолцооны ялгаа нь юуг гаргаж өгөх, юу шаардлагатай, болон үйл ажиллагааны ялгаатай байдалд хүргэж болзошгүй.
- Хүргүүлж буй мэдээлэл нь гадаад улс оронд өөрийн хэргийг нээхэд ашиглагдаж болно.
- Хүсч буй мэдээлэл нь хүсэлт гаргасан болон хүсэлт хүлээн авсан аль аль улс орнуудын хувьд хууль ёсны дагуу цуглуулагдсан байх ёстой.
- Томоохон хэргийн хувьд хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа болон түншүүдтэй нүүр тулсан уулзалт хийх талаар авч үзээрэй.

Хавсралт I. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн загвар, төслийг боловсруулах талаар зөвлөмж

Энэхүү хэсэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт (ЭЗТХ) болон Шигтгээ I.1-д дурдсан эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг боловсруулах болон гүйцэтгэх зөвлөмжийн талаар авч үзлээ.

Хүсэлтийн захидал

ХЭНД: [*Хүсэлт хүлээн авагч улс орны эрх бүхий байгууллагын нэр, хаяг*]

ХААНААС: [*Хүсэлт илгээж буй улс орны дотоодын хууль тогтоомжид дурдсан шүүх, прокурор, эрх бүхий төв байгууллагын нэр, хаяг*]

[*Миний бие/Бид*] энэхүү хүсэлтийг (эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх эрх олгосон дотоодын хууль тогтоомжийг дурдах)-ын дагуу илгээж байна. [*Миний бие/Бид*] [*байгууллагын нэр*]-аас [*мөрдөн шалгах эсхүл яллах*] ажиллагаа явуулж буй эрүүгийн хэрэгт холбогдуулан та бүхнээс эрх зүйн туслалцаа хүсэх завшаан тохиов.

- *Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцан ажиллаж буй мөрдөгч, прокурорын нэр болон холбоо барих мэдээллийг тусгах*

Эрх зүйн үндэслэл

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг дараах (хууль тогтоомж, олон улсын гэрээ)-нд үндэслэн илгээж байна.

Эрүүгийн хэргийн товч утга

Энэхүү эрх зүйн туслалцаа нь [*яллах болон мөрдөн шалгах, эсхүл сэжигтний гэмт хэргийн улмаас олж авсан хөрөнгийг [эзэмшигчдийн жагсаалт] хураан авах ажиллагаа явагдаж байгаатай холбогдуулан шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах*]-тай холбоотой.

- *Хязгаарлах хөрөнгийг тодорхой дурдах. Ихэвчлэн, эдгээр хөрөнгийг хавсралт хэлбэрээр жагсаах нь тохиромжтой байдаг.*
- *Эзэмшигчдийн жагсаалт аль болох дэлгэрэнгүй мэдээллийн хамт – Пасппортын дугаар, төрсөн огноо, үндэстэн, хаяг, ажил албан тушаал.*

ШИГТГЭЭ I.1	Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт (ЭЗТ) төсөл боловсруулах болон гүйцэтгэх зөвлөмж

- Хамтран ажиллах талтай холбогдох (боломжтой тохиолдолд уулзалт зохион байгуулах). Ингэхдээ дараах зүйлсийг тодруулах шаардлагатай. Үүнд:
  - Ерөнхий болон нотлох баримтанд тавигдах шалгуурууд,
  - Нотлох баримт болон процессын наад захын шалгуурууд ыг хэрхэн хангах, шаардлагатай бүрдүүлэх жишиг баримтууд,
  - Нотлох баримтын төрлийг тодруулах (тухайлбал, аффидавит, гарын үсэг зурсан мэдүүлэг, баталгаажуулсан шүүхийн баримт бичгүүд гэх мэт),
  - Нэмэлт баталгаа, арга хэмжээний талаар,
  - Яаралтай эсэх, нууцлал, эсхүл тусгайлсан процесс,
  - Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулахад дэмжлэг авах, загвар хүсэлтийг авах,
  - Хүсэлтийг гүйцэтгэхэд оролцох боломжтой эсэх,
  - Хүсэлтийг гүйцэтгэхэд саад болж болзошгүй нөхцөл байдлыг дүгнэх, тухайлбал нууцлалыг ил болгох процесс болон нөөц бололцоотой холбоотой асуудлууд зэрэг.
- Ерөнхий болон нотлох баримтад тавигдах шалгуурууд хангагдсан эсэхийг нягтлах.
- Хэт бага ач холбогдолтой бол тухайн туслалцааг хүсэлтээс хасах.
- Хүсэлт илгээж буй улсын дотоодод тогтоогдсон нөхцөл байдал болон процессын талаар тодорхой мэдээлэл өгөх.
- Орчуулга шаардлагатай бол мэргэжлийн үйлчилгээ авах.
- Мөшгих болон царцаах тохиолдолд, тухайн хөрөнгийн байршил болон сэжигтэн этгээд, хүсэлт болгосон хөрөнгө хоорондын холбоог тодорхой дурдах.
- Бүхий л ажиллагааг (мөшгих, царцаах, хураан авах гэх мэт) нэг эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдахгүй байх. Аль болох эрт эхлүүлж шат шатаар урагшлах.
- Хүсэлтийг гүйцэтгэхэд хангалттай хугацаа олгох.
- Хөрөнгийг хураан авахад шүүхийн эцсийн шийдвэр шаардлагатай байдаг тул дотоодын мөрдөн шалгах ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрх зүйн туслалцааны хүсэлттэй зэрэгцээ үргэлжлүүлэх. Хэргийн хөөн хэлэлцэх хугацааны дотор ажиллагааг дуусгах (талуудад мэдэгдэх).

Эрх зүйн туслалцаа нь дараах гэмт хэрэгт холбогдуулан илгээж байна. Үүнд: (Гэмт хэргүүдийг эрүүгийн хариуцлагын дээд хэмжээтэй нь дурдах).

- *Гэмт хэргийг дурдахдаа, эрүүгийн хэргийг үүсгэх тогтоол, саналд дурдсан гэмт хэргийг хуулийн заалттай нь тусгах. Холбогдох дотоодын хууль тогтоомжийн заалтуудыг хүсэлтэд дурдаж хавсаргасан байх шаардлагатай.*

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн зорилго

Энэхүү асуудалтай холбоотойгоор, дараах зүйлсийг хүсэлт болгож байна: (шаардлагатай туслалцааг товчхон дурдах)

- *Эрх зүйн туслалцааны хүсэлт нь шат шатаар явагдах шаардлагатайг анхаарах. Нэг хүсэлтэд бүх туслалцааг (баримт бичиг гаргуулах, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хураан авах гэх мэт) тусгахаас зайлсхийх.*

Тогтоогдсон нөхцөл байдал

(Тухайн хэргийн тогтоогдсон нөхцөл байдлуудыг тодорхой дурдах.)

- *Гадаад улсын эрх бүхий байгууллагаас тухайн эрх зүйн туслалцааны хүсэлт нь шаардлага хангасан эсэхийг тодорхойлж гүйцэтгэх зөвшөөрөл олгоход хангалттай байх шаардлагатай (Тухайлбал, тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцдог байх шалгуур). Хүсэлт илгээж буй улсад дотооддоо мөрдөн шалгах ажиллагаа явуулж шаардлагатай нөхцөл байдлуудыг тогтоох шаардлагатай.*
- *Тухайн хөрөнгө болон гэмт хэрэг, эсхүл сэжигтэн хоорондын холбоог тайлбарлах.*
- *Албадлагын арга хэмжээ авахыг хүсэлт болговол (тухайлбал, нэгжлэгийн зөвшөөрөл болон баримт бичиг гаргуулах зөвшөөрөл гэх мэт), хангалттай тогтоогдсон нөхцөл байдлыг дурдаж хүсэлт хүлээн авч буй улсын шалгуурыг хангасан болохыг харуулах (Жишээг 4 дүгээр бүлгээс харах).*
- *Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай баримтуудыг хавсаргаад хүсэлтдээ дурдах. Тухайлбал, баталгаажуулсан шүүхийн шийдвэр, аффидавит, гэрчилгээнүүд гэх мэт.*

Хүсч буй туслалцаа

[*Хүсч буй туслалцаа*] Бид энэхүү хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай бүхий л шүүхийн шийдвэр болон бусад зөвшөөрлийг хавсаргасан талаар дурдах.

- *Хүсч буй туслалцааг бичихдээ хийлгэх ажиллагааг бус олж авах үр дүнг нь тусгаж өгөх нь зүйтэй. Учир нь тухайн үр дүнд хүрэхэд шаардлагатай арга хэмжээ нь улс орон бүрт адилгүй байдаг. Тухайлбал, нэг улсад нэгжлэг хийж хураан авах зөвшөөрөл гарч байж банкны баримтыг олж авах бол өөр улсад баримт бичиг гаргуулах зөвшөөрөл олгодог.*
- *Хүсэлтийг хүлээн авах хангалттай үндэслэлийг тусгаж өгөх, ялангуяа албадлагын арга хэмжээ авах тохиолдолд.*
- *Тухайн баримт нь нотлох баримтаар үнэлэгдэхэд шаардлагатай процессын талаар дэлгэрэнгүй тайлбарлах. Баталгаа, анхааруулга болон нотлох баримтын хэлбэр гэх мэт. Тухайлбал, гэрч мэдүүлэг өгөх үед бичлэг хийсэн байх, баримт бичгүүдийг баталгаажуулсан байх гэх мэт.*
- *Хөрөнгийг мөшгих тохиолдолд байршилтай холбоотой бүхий л мэдээллийг гаргаж өгөх нь зүйтэй. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах болон хураан авах тохиолдолд тодорхой байршлыг тусгасан байхыг шаарддаг. Тухайлбал, данс эзэмшигчийн нэр, дансны дугаар, салбар, хязгаарлах мөнгөн дүнгийн хэмжээ, хөрөнгийн байршил болон бусад мэдээлэл.*
- *Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хүсэлтэд тухайн хөрөнгө нь сарних эрсдэлтэй бөгөөд сэжигтэнд эрүүгийн хариуцлага оногдуулах өндөр*

магадлалтай талаар тусгаж өгөх. Тухайн хөрөнгийг хариуцах хуульд заасан эрх бүхий байгууллагын талаарх мэдээллийг хүсэлтдээ тусгах. Бусад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан арга хэмжээнүүдийг тусгах.

- *Мэдүүлэг авахад, асуух асуултуудын жагсаалтыг хавсаргах.*
- *Мэдүүлгийн маягтад нэмэлт мэдээлэл тусгах зай үлдээж болно (хэдийгээр шаардлага хангахгүй боловч). Тухайлбал, "Тодорхой асуудлын талаар нэмэлтээр мэдүүлэг авч мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай" тухай тусгах.*

Нууцлал

- *Нууцлал шаардлагатай тохиолдолд энэ талаар тусгаж өгөх бөгөөд чухалчилж авч үзэх шалтгааныг нь тайлбарлах.*

Хүсэлтийг гүйцэтгэх хугацаа

- *Тухайн мэдээлэл хэзээ хэрэгтэй байгаа талаар дэлгэрэнгүй тусгах (шүүх хурлын тов гэх мэт). Яаралтай гүйцэтгэх бодит хэрэгцээтэй байгаа тохиолдолд "яаралтай" гэж тодотгож өгөх.*

Баталгаа гаргах

Харилцан адил байх зарчим: [*хүсэлт илгээж буй улс*]–ын Засгийн газар нь [*хүсэлт хүлээн авч буй улс*]–аас адил төрлийн эрүүгийн хэрэгт холбогдуулан ирүүлсэн хүсэлтийг дүйцэхүйц хэмжээнд гүйцэтгэх талаар тусгах.

Ашиглах хязгаарлалт: [*Олж авсан мэдээллийг зөвхөн дурдсан мөрдөн шалгах ажиллагаанд холбогдуулан ашиглана.*[1] *Зарим ус орнуудад энэхүү баталгааг гаргуулахыг шаарддаггүй бөгөөд тухайн мэдээллийг өөр зориулалтаар ашиглахдаа тусад нь хүсэлт илгээдэг.*[2]]

Урьдчилан холбогдох болон бусад сувгийг ашиглах

Өмнө нь [*хүсэлт илгээж буй улс орны эрх бүхий байгууллага*] болон [*хүсэлт хүлээн авч буй улс орны эрх бүхий байгууллага*] хооронд харилцаж байсан тохиолдолд.

---

[1] Баримт ашиглалтын баталгааг бадаарх байдлаар тусгах болосчтой: "(Хүсэлт илгээж буй улсын засгийн газар) нь энэхүү хүсэлтийн дагуу олж авсан аливаа мэдээлэл, баримт, нотлох баримтыг хүсэлтэд дурдсан хэрэгт холбогдуулан ашиглана. (Хүсэлт хүлээн авч буй улсын) холбогдох байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр бусад зорилгоор ашиглахгүй болно."

[2] ИБУИНВУ нь олж авсан мэдээллийг эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсанаас бусад зорилгоор ашиглахын тулд холбогдох мэдээлэл бүхий албан ёсны хүсэлт илгээсэн байхыг шаарддаг. "Collateral Use: Requests Made to the UK" хуудас 6-7-г харах. "Requests for Mutual Legal Assistance in Criminal Matters: Guidelines for Authority Outside of the United Kingdom, 2015," https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/415038/MLA_Guidelines_2015.pdf.

Холбоо барих мэдээлэл

Энэхүү асуудлыг хариуцаж буй [*Шүүгч, прокурор, эсхүл эрх бүхий төв байгууллагын албан хаагч*] [*албан хаагчийн*]–тэй [*хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг*]-аар холбогдох боломжтой.

[*Хууль сахиулах болон прокурорын байгууллагын нэр*]–ийн [*албан хаагчийн нэр*]–ээс энэ асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл олж авах боломжтой бөгөөд холбоо барих дараах мэдээллийг өгч байна [*хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг*].

Хавсралт J. Цахим эх сурвалжууд

Stolen Asset Recovery (StAR) Initiative

- StAR website: https://star.worldbank.org/
- StAR, Asset Recovery Guides (country-wise): https://star.worldbank.org / ArabForum/asset-recovery-guides
- StAR, Beneficial Ownership Guides (country-wise): https://star.worldbank.org / content/beneficial-ownership-guides
- StAR publications: https://star.worldbank.org/?q=publications&keys =&sort_by=field_date_value&sort_order=DESC&items_per_page=20
- StAR Asset Recovery Watch Database: https://star.worldbank.org/corruption -cases/?db=All

World Bank Group

- World Bank: https://www.worldbank.org/
- Financial Integrity Unit: https://www.worldbank.org/en/topic / financialmarketintegrity
- United Nations
- United Nations: https://www.un.org/en/
- United Nations Office on Drugs and Crime (UNODC): https://www.unodc.org/
- United Nations Mutual Legal Assistance (MLA) Request Writer Tool (for criminal justice system practitioners only): https://www.unodc.org/mla/
- UNODC TRACK platform (Tools and Resources for Anti-Corruption Knowledge): https://www.unodc.org/unodc/en/corruption/track.html
- UNODC Documents, Publications, and Tools: https://www.unodc.org/unodc /en/ corruption/publications.html
- UNODC International Money Laundering Information Network (IMOLIN): https://www.imolin.org/
- UNODC SHERLOC (Sharing Electronic Resources and Laws on Crime): https:// sherloc.unodc.org/cld/v3/sherloc/
- Financial Action Task Force (FATF) on Money Laundering
- FATF: http://www.fatf-gafi.org
- FATF 40 Recommendations: https://www.fatf-gafi.org/publications /fatfrecom- mendations/documents/fatf-recommendations.html

Basel Institute on Governance

- Home page: https://www.baselgovernance.org/

International Conventions, Treaties, and Agreements

(year instrument adopted / year entered into force)

International Instruments

- United Nations Convention against Corruption (UNCAC): https://www.unodc .org/unodc/en/treaties/CAC/
- United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances, 1988: http://www.unodc.org/unodc/en/treaties/illicit -trafficking.html
- United Nations Convention against Transnational Organized Crime (UNTOC) https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html
- Organisation for Economic Co-operation and Development Convention on Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions (OECD Anti-Bribery Convention): http://www.oecd.org/daf/anti -bribery/ConvCombatBribery_ENG.pdf
- Multilateral Convention on Mutual Administrative Assistance in Tax Matters, OECD and Council of Europe: https://www.oecd.org/tax/the-multilateral -convention-on-mutual-administrative-assistance-in-tax-matters -9789264115606-en.htm
- Inter-American Convention against Corruption, Organization of American States (OAS): http://www.oas.org/en/sla/dil/inter_american_treaties_B-58 _against_ Corruption.asp
- Inter-American Convention on Mutual Assistance in Criminal Matters, OAS: https://www.oas.org/juridico/english/treaties/a-55.html

Regional Instruments

- Commonwealth of Independent States (CIS) Convention on Legal Assistance and Legal Relations in Civil, Family and Criminal Matters (Minsk Convention, 1993/1994): http://www.cisarbitration.com/2017/02/03/minsk-convention-on -legal-assistance-and-legal-relations-in-civil-family-and-criminal-matters/
- African Union Convention on Preventing and Combating Corruption (2003/2006): https://au.int/sites/default/files/treaties/36382-treaty-0028 _-_african_union_convention_on_preventing_and_combating_corruption_e.pdf
- Southern African Development Community (SADC) Protocol against Corruption (2001/2003): https://www.sadc.int/documents-publications/show/
- SADC Protocol on Mutual Legal Assistance in Criminal Matters (2002/2007): https://www.sadc.int/documents-publications/show/807
- Treaty on Mutual Legal Assistance in Criminal Matters (2004, Association of Southeast Asian Nations [ASEAN] Legal Instruments): https://asean.org/storage /2020/02/20160901074559.pdf; http://agreement.asean.org/home/index/2.html

European Union (EU) and Council of Europe (COE) Conventions

- Council of Europe Treaty Office: https://www.coe.int/en/web/conventions/
- COE Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime (1990), revised as the Convention on Laundering, Search, Seizure and Confiscation of the Proceeds from Crime and on the Financing of Terrorism (2005): https://www.coe.int/en/web/conventions/full -list/-/conventions/treaty/198
- Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms (European Convention on Human Rights, 1950/1953): https://www.echr.coe.int / pages/home.aspx?p=basictexts

- Convention on Jurisdiction and the Recognition and Enforcement of Judgments in Civil and Commercial Matters (Convention of Lugano, 2007): https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A22007A1221%2803%29
- 1968 Brussels Convention on Jurisdiction and the Enforcement of Judgments in Civil and Commercial Matters (Brussels Convention, 1968/1973): https://eur -lex.europa.eu/legal-content/GA/TXT/?uri=CELEX:41968A0927(01)
- European Convention on Mutual Assistance in Criminal Matters (1959/1962): https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/030; with two additional protocols:
- 1978/1982:https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/099
- 2001/2004:https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/182
- Convention drawn up on the basis of Article K.3 (2) (c) of the Treaty on European Union on the fight against corruption involving officials of the European Communities or officials of Member States of the European Union (1997):https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A41997A0625%2801%29
- COE Criminal Law Convention on Corruption (1999/2002): https://www.coe .int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/173#:~:text=The%20Criminal%20Law%20Convention%20on,the%20prosecution%20of%20 corruption%20offences
- COE Civil Law Convention on Corruption (1999/2003): https://www.coe.int /en/web/conventions/full-list/-/conventions/treaty/174

EU and COE Regulations, Directives, and Decisions

- EU legal documents: https://eur-lex.europa.eu/homepage.html
- Council of the European Union Framework Decision 2003/577/JHA on the Execution in the European Union of Orders Freezing Property or Evidence: https://www.ejn-crimjust.europa.eu/ejn/libcategories.aspx?Id=24; and Corrigendum to Council Framework Decision 2003/577/JHA: https://eur-lex .europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32003F0577; https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32003F05 77R%2801%29
- Council of the European Union Framework Decision 2005/212/JHA of 24 February 2005 on Confiscation of Crime-Related Proceeds, Instrumentalities and Property:https://eur-lex.europa.eu/legal-content/EN/NIM/?uri=CELEX:32005F0212
- Council of the European Union Framework Decision 2006/783/JHA of 6 October 2006 on the Application of the Principle of Mutual Recognition to Confiscation Orders:https://eur-lex.europa.eu/legal-content/EN/NIM/?uri=CELEX%3A32006F0783
- Council Decision 2007/845/JHA of 6 December 2007 Concerning Cooperation between Asset Recovery Offices of the Member States in the Field of Tracing and Identification of Proceeds from, or Other Property Related to, Crime: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32007D0845
- Council Regulation (EC) No. 44/2001 of 22 December 2000 on Jurisdiction and the Recognition and Enforcement of Judgments in Civil and Commercial Matters:https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32001R0044

- Council Regulation (EC) No. 1206/2001 of 28 May 2001 on Cooperation between the Courts of the Member States in the Taking of Evidence in Civil or Commercial Matters: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX%3A32001R1206
- Regulation (EU) No. 1215/2012 of the European Parliament and of the Council of 12 December 2012 on Jurisdiction and the Recognition and Enforcement of Judgments in Civil and Commercial Matters (recast Brussels I Regulation): https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX:32012R1215
- Directive 2014/42/EU of the European Parliament and of the Council of 3 April 2014 on the Freezing and Confiscation of Instrumentalities and Proceeds of Crime in the European Union: https://eur-lex.europa.eu/legal-content/EN / TXT/?uri=CELEX%3A32014L0042
- Regulation (EU) 2018/1805 of the European Parliament and of the Council of 14 November 2018 on the Mutual Recognition of Freezing Orders and Confiscation Orders: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:32018R1805

G-8 Best Practice Principles

- G-8 Best Practice Principles on Tracing, Freezing and Confiscation of Assets: https://www.justice.gov/sites/default/files/ag/legacy/2004/06/03/G8_Best _ Practices_on_Tracing.pdf
- G-8 Best Practices for the Administration of Seized Assets: https://docplayer .net/16960901-G8-best-practices-for-the-administration-of-seized-assets.htm

EU, Council of the European Union, and COE Websites

Main sites

- Official website of the European Union: http://europa.eu/index_en.htm and European Council/Council of the European Union: https://www.consilium .europa. eu/
- Mutual Legal Assistance (COE): https://www.coe.int/en/web/transnational -criminal-justice-pcoc/mutual-legal-assistance

Civil and commercial matters

- European Justice, European Judicial Network in civil and commercial matters: https://e-justice.europa.eu/content_european_judicial_network_in_civil_and _ commercial_matters-21-en.do
- European Commission, Civil Justice: https://ec.europa.eu/info/policies/justice -and-fundamental-rights/civil-justice_en
- European Justice, European Judicial Atlas in civil matters (practical information on judicial cooperation in civil matters): https://e-justice.europa.eu/content _ euro-pean_judicial_atlas_in_civil_matters-321-en.do
- European Justice, Taking Evidence, national information and online forms concerning Regulation No. 1206/2001: https://e-justice.europa.eu/content _taking_ evidence-374-en.do

Criminal matters

- European Justice, European Judicial Network in criminal matters: https://e-justice.europa.eu/content_ejn_in_criminal_matters-22-en.do
- EUR-Lex, Glossary of Summaries of EU Legislation on Police and Judicial Cooperation in Criminal Matters: https://eur-lex.europa.eu/summary/glossary / police_judicial_cooperation.html
- European Parliament, Judicial Cooperation in Criminal Matters: https://www.europarl.europa.eu/factsheets/en/sheet/155 / judicial-cooperation-in-criminal-matters
- EUR-Lex, Summaries of EU Legislation on Judicial Cooperation in Criminal Matters: https://eur-lex.europa.eu/summary/chapter/2303.html
- EUR-Lex, Green Paper on Obtaining Evidence in Criminal Matters From One Member State to Another and Securing Its Admissibility, November 2009: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT /?uri=CELEX%3A52009DC0624

Open-Source Intelligence (OSINT) Asset-Tracing Resources

Free Sites (general information, public records, business records, asset tracing, banking records)

- Open Corporates: https://opencorporates.com/ (company registries and company records)
- Open Ownership: https://www.openownership.org/ (beneficial ownership information)
- Opentender: https://opentender.eu/start (procurement data in the EU)
- EveryPolitician: https://everypolitician.org/ (politically exposed person [PEP] data)
- TinEye: https://tineye.com/ (reverse image search)
- FlightAware: https://flightaware.com/ (flight tracker)
- Internet Archive: http://www.archive.org/web/web.php
- SearchSystems.net: http://www.searchsystems.net ("invisible web" search of public records and company records—worldwide)
- Electronic Data Gathering, Analysis, and Retrieval (EDGAR) system: http://www.sec.gov/edgar.shtml (US company records)
- ZoomInfo: http://www.zoominfo.com (people and company finder)
- White Pages: https://people.yellowpages.com/whitepages/ (people finder)
- World Legal Information Institute (WorldLII): http://www.worldlii.org (legislation and court decisions)
- Companies House: http://www.companieshouse.gov.uk (UK company records, insolvency records, persons of significant control)
- Node XL, Social Media Research Foundation: https://www.smrfoundation.org / nodexl/ (social network and media analysis tool)
- SAM.gov, US General Services Administration: https://sam.gov/SAM/pages / public/searchRecords/search.jsf (search engine for records on entities doing business with the US government)
- Court Lookup, Public Access to Court Electronic Records (PACER) (free information on US court websites): https://pacer.uscourts.gov/file-case/court -cmecf-lookup

Subscription Sites

- Dun & Bradstreet: https://www.dnb.com/
- Arachnys: https://www.arachnys.com/
- Refinitiv: https://www.refinitiv.com/en
- TRACE International: https://www.traceinternational.org/
- LexisNexis: http://www.lexisnexis.com (public records, court decisions, media reports, business records, people searches, and so on)
- CompanyDocuments: http://www.companydocuments.com (business records—worldwide)
- CorporateInformation: http://www.corporateinformation.com (company records) Appendix J. Web Resources I 399
- FCPA Tracker: https://fcpatracker.com/ (public disclosures by companies and agencies related to Foreign Corrupt Practices Act [FCPA] investigations)
- Clear (Thompson Reuters): http://www.clear.thomsonreuters.com (public records, company records—worldwide)
- FreeERISA: http://www.freeerisa.com (US employee benefits data)
- Echosec: https://www.echosec.net/features (social media monitoring)
- IBM Security i2 Analyst's Notebook: https://www.ibm.com/products/analysts -notebook (tools for analyzing and uncovering connections and patterns in data)

Media, Civil Society, and Private Sector Resources

- Transparency International: https://www.transparency.org/en/
- Global Witness: https://www.globalwitness.org/en/
- Global Financial Integrity (GFI): https://gfintegrity.org/
- Global Integrity: https://www.globalintegrity.org/
- Public Eye: https://www.publiceye.ch/en/
- International Consortium of Investigative Journalists (ICIJ): https://www.icij.org/
- Organized Crime and Corruption Reporting Project (OCCRP): https://www.occrp.org/en
- Tax Justice Network (TJN): https://www.taxjustice.net/
- Partnering Against Corruption Initiative (PACI) of the World Economic Forum: https://www.weforum.org/communities/partnering-against-corruption -initiative

Specialized Asset Management Offices in Selected Countries

- Belgium: Belgian Central Office for Seizure and Confiscation (COSC), https://ec.europa.eu/avservices/photo/photoByReportage.cfm?sitelang=en&ref=020472
- Canada: Canadian Seized Property Management Directorate, https://www.btb .termiumplus.gc.ca/tpv2alpha/alpha-eng.html?lang=eng&i=&index=alt&srchtxt =SEIZED%20PROPERTY%20MANAGEMENT%20DIRECTORATE
- France: Agency for the Recovery and Management of Seized and Confiscated Assets (AGRASC), http://www.justice.gouv.fr/justice-penale-11330 / agrasc-12207/
- Honduras: Office for the Administration of Seized Property (OABI), https://oabi.gob.hn/
- Italy: National Agency for Seized and Confiscated Assets (ANSBC): https://www.benisequestraticonfiscati.it/

- Netherlands: Asset Management Office of the Dutch Criminal Assets Deprivation Bureau (BOOM), https://www.prosecutionservice.nl/
- Peru: National Seized Property Commission (CONABI), http://www.pcm.gob .pe/etiqueta/comision-nacional-de-bienes-incautados-conabi/
- Portugal: Asset Management Office (GAB), https://igfej.justica.gov.pt/Gabinete-de-Administracao-Bens
- Romania: National Agency for the Management of Seized Assets (ANABI), https://anabi.just.ro/en/The+mission+and+the+tasks+of+the+Agency
- Spain: Asset Recovery and Management Office (ORGA), https://www.mjusticia .gob.es/cs/Satellite/Portal/es/areas-tematicas/oficina-recuperacion-gestion
- Thailand: Anti-Money Laundering Office (AMLO), http://www.amlo.go.th /index.php/en/about-amlo/vision-and-mission
- Ukraine: National Agency for Finding, Tracing, and Managing Assets Derived from Corruption and Other Assets, https://arma.gov.ua/en/
- United States: US Marshals Service, https://www.usmarshals.gov/

Practitioner Networks and Resources

- StAR, International Partnerships on Asset Recovery: Overview and Global Directory of Networks: https://star.worldbank.org/sites/star/files/networks-16-reduced-maps.pdf
- Camden Asset Recovery Inter-Agency Network (CARIN): https://www.carin .network/
- ARIN-SA (Asset Recovery Inter-Agency Network Eastern and Southern Africa): https://new.arinsa.org/
- ARIN-EA (East Africa): https://eaaaca.com/about-arinea
- ARIN-AP (Asia Pacific): http://www.arin-ap.org/main.do
- ARIN-CARIB (Caribbean): https://arin-carib.org/
- ARIN-WCA (West and Central Asia): http://www.arin-wca.org/home
- RRAG (in South America, the GAFILAT Asset Recovery Network, "GAFILAT" being the Financial Action Task Force of Latin America): https://www.gafilat .org/index.php/es/espanol/18-inicio/gafilat/49-red-de-recuperacion-de-activos-del-gafilat-rrag
- Egmont Group: https://egmontgroup.org/en
- Interpol: https://www.interpol.int/en
- Interpol, Anti-Corruption and Asset Recovery: https://www.interpol.int/en / Crimes/Corruption/Asset-recovery
- Europol: https://www.europol.europa.eu/
- Secure Information Exchange Network Application (SIENA): https://www .europol.europa.eu/activities-services/services-support/information-exchange / secure-information-exchange-network-application-siena
- Aseanapol: http://www.aseanapol.org/
- Ameripol: http://www.ameripol.org/
- OECD Automatic Exchange Portal (for cooperation on tax matters): https://www.oecd.org/tax/automatic-exchange/
- World Customs Organization (WCO): http://www.wcoomd.org/
- Arab Anti-Corruption and Integrity Network (ACINET): http://www .arabacinet.org/index.php/en/home
- Iberoamerican Association of Public Ministers (AIAMP): http://www.aiamp .info/

- European Judicial Network (EJN): https://www.ejn-crimjust.europa.eu/ejn /ejn_home/EN
- Eurojust: http://www.eurojust.europa.eu/pages/home.aspx
- International Association of Prosecutors: https://www.iap-association.org/
- Bank for International Settlements (BIS): https://www.bis.org/
- International Organization of Securities Commissions (IOSCO): https://www.iosco.org/
- International Association of Insurance Supervisors (IAIS): https://www.iaisweb.org/home

Country-Specific International Cooperation Resources

Australia

- Information on mutual assistance, alternatives to mutual legal assistance, and contact details of central authority: https://www.ag.gov.au/international -relations/international-crime-cooperation-arrangements/mutual-assistance
- International relations, including information on serving legal documents, enforcement of foreign judgments, and bilateral treaties: https://www.ag.gov .au/international-relations
- Department of Foreign Affairs and Trade: https://www.dfat.gov.au/
- Australian Federal Police: https://www.afp.gov.au/
- Attorney-General's Department: https://www.ag.gov.au/
- Australian Transaction Reports and Analysis Centre (AUSTRAC) (financial intelligence unit): https://www.austrac.gov.au/
- Commonwealth Director of Public Prosecutions: http://www.cdpp.gov.au/

Brazil

- Ministry of Justice and Public Security: https://www.gov.br/mj/pt-br
- Ministry of Justice and Public Security, International Legal Cooperation: https://www.justica.gov.br/sua-protecao/cooperacao-internacional
- Ministry of Foreign Relations: http://www.itamaraty.gov.br/
- Financial Activities Control Council (COAF) (financial intelligence unit): http://www.coaf.fazenda.gov.br/
- Legislation Portal: http://www4.planalto.gov.br/legislacao/

France

- Ministry of Foreign Affairs: https://www.diplomatie.gouv.fr/en/
- Ministry of Justice: http://www.justice.gouv.fr/
- Tracfin (financial intelligence unit): https://www.economie.gouv.fr/tracfin
- National Police: https://www.police-nationale.interieur.gouv.fr/Accueil
- FICOBA (repository of bank accounts): https://www.service-public.fr /particuliers/vosdroits/F2233
- Légifrance (official publication of legislation, regulations, and legal information): https://www.legifrance.gouv.fr/
- Agence Française Anticorruption (AFA): https://www.agence-francaise -anticorruption.gouv.fr/fr

Germany

- Federal Foreign Office: https://www.auswaertiges-amt.de/en
- Federal Ministry of Justice and Consumer Protection: https://www.bmjv.de/DE / Startseite/Startseite_node.html
- Federal Ministry of Justice and Consumer Protection (International Cooperation): https://www.bmjv.de/DE/Themen/IntZusammenarbeit /IntZusammenarbeit_node. html
- Federal Ministry of Justice and Consumer Protection (Europe and International Cooperation): https://www.bmjv.de/DE/Themen/EuropaUndInternationale Zusammenarbeit/EuropaUndInternationaleZusammenarbeit_node.html
- Financial Intelligence Unit: https://www.zoll.de/DE/FIU/fiu_node.html
- Federal Criminal Police (BKA): https://www.bka.de/DE/UnsereAufgaben / Aufgabenbereiche/aufgabenbereiche_node.html
- German legal provisions: http://www.gesetze-im-internet.de/
- National Procedures for Mutual Legal Assistance: https://rm.coe.int /16806b6348

Hong Kong SAR, China

- Department of Justice: https://www.doj.gov.hk/eng/index.html
- List of Mutual Legal Assistance Agreements (Legislative References): https:// www.doj.gov.hk/eng/laws/table3ti.html
- Ministry of Foreign Affairs (Office of the Commissioner of the Ministry of Foreign Affairs of the People's Republic of China in the Hong Kong Special Administrative Region): http://www.fmcoprc.gov.hk/eng/
- Independent Commission Against Corruption: https://www.icac.org.hk/
- Joint Financial Intelligence Unit: https://www.jfiu.gov.hk/en/

India

- MLA information, Ministry of External Affairs: https://mea.gov.in/mutual -legal-assistance-in-criminal-matters.htm and https://www.mea.gov.in/emtsp .htm
- Indian Central Bureau of Investigation (investigation assistance, letters rogatory, MLA treaties): http://www.cbi.gov.in/interpol/interpol.php
- Ministry of Law and Justice: https://lawmin.gov.in/
- Directorate of Enforcement: https://enforcementdirectorate.gov.in
- Financial Intelligence Unit: https://dor.gov.in/preventionofmoneylaundering / financial-intelligence-unit-india-fiu-ind
- Ministry of Home Affairs (central authority): https://www.mha.gov.in/
- Ministry of Home Affairs, Internal Security-II Division (also issues policy guide-lines on mutual legal assistance): https://www.mha.gov.in/division_of _mha/ internal-security-ii-division

Luxembourg

- European Judicial Network (EJN) in Civil and Criminal Matters (information on civil processes, taking of evidence and mode of proof, and service of documents): https://e-justice.europa.eu/content_taking_of_evidence-76-lu-en .do?member=1
- Ministry of Foreign Affairs: https://maee.gouvernement.lu
- Ministry of Justice: https://mj.gouvernement.lu/

- Luxembourg–Financial Intelligence Unit (FIU-LUX): https://justice.public.lu/fr / organisation-justice/crf.html

Mexico

- Ministry of Foreign Affairs: https://www.gob.mx/sre
- Deputy Attorney General's and Prosecutor's Offices (request and receive MLA requests on criminal matters): https://www.gob.mx/fgr/acciones-y-programas / subprocuradurias-de-la-fgr
- Financial Intelligence Unit: https://www.uif.gob.mx/

Singapore

- Attorney-General's Chambers (central authority, receives MLA requests): https:// www.agc.gov.sg/
- Ministry of Foreign Affairs: https://www.mfa.gov.sg/
- Suspicious Transaction Reporting Office (STRO) (financial intelligence unit): https://www.police.gov.sg/Advisories/Crime/Commercial-Crimes/Suspicious -Transaction-Reporting-Office

South Africa

- National Prosecuting Authority (for informal requests): https://www.npa.gov.za/
- Department of International Relations and Cooperation: http://www.dirco.gov.za/
- Department of Justice and Constitutional Development (central authority for formal MLA requests): https://www.justice.gov.za/
- Department of Justice and Constitutional Development (International Legal Obligations, including service of process and treaties): https://www.justice.gov .za/ilr/about.html
- Financial Intelligence Centre (financial intelligence unit): https://www.fic.gov .za/ Pages/Home.aspx
- Public Service Commission (anticorruption authority): http://www.psc.gov.za/

Spain

- European Judicial Network (EJN) in Civil and Commercial Matters: https://e-justice.europa.eu/content_about_the_network-431-es-es.do?member=1
- Ministry of Foreign Affairs and Cooperation: http://www.exteriores.gob.es/Portal/ en/Paginas/inicio.aspx
- Ministry of Justice: https://www.mjusticia.gob.es/cs/Satellite/Portal/en/ministerio
- Ministry of Justice (International Affairs): https://www.mjusticia.gob.es/cs/ Satellite/Portal/en/area-internacional
- Financial intelligence unit: https://www.sepblac.es/en/

Switzerland

- Federal Office of Justice, International Legal Assistance (criminal, civil, administrative, legal aid): https://www.rhf.admin.ch/rhf/de/home.html
- Federal Office of Justice: https://www.bj.admin.ch/bj/en/home.html
- Database of Swiss Localities and Courts: https://www.elorge.admin.ch/elorge/

- Federal Department of Foreign Affairs (FDFA): https://www.eda.admin.ch/eda / en/home.html
- Office of the Attorney General of Switzerland (OAG): https://www .bundesanwaltschaft.ch/mpc/de/home.html
- Federal Office of Police (police cooperation): https://www.fedpol.admin.ch /fedpol/en/home.html
- Money Laundering Reporting Office (MROS) (financial intelligence unit): https://www.fedpol.admin.ch/fedpol/en/home/kriminalitaet/geldwaescherei.html

United Arab Emirates (UAE)

- Ministry of Justice: https://www.moj.gov.ae/
- Office of Public Prosecution: https://www.pp.gov.ae
- Central Bank of the UAE, Anti-Money Laundering and Suspicious Case Unit (AMLSCU) (financial intelligence unit): See https://www.centralbank.ae/ar and https://egmontgroup.org/en/content/united-arab-emirates-anti-money-laundering-and-suspicious-cases-unit

United Kingdom

- The UK Central Authority (UKCA), Home Office: https://www.gov.uk /government/organisations/home-office
- Guidance on Mutual Legal Assistance, Home Office: https://www.gov.uk /guidance/mutual-legal-assistance-mla-requests
- Crown Prosecution Service (represents requesting state in court proceedings): https://www.cps.gov.uk/about-cps and https://www.cps.gov.uk/legal-guidance / international-enquiries
- Serious Fraud Office (represents requesting state in court proceedings): https://www.sfo.gov.uk/
- National Crime Agency (NCA) (for investigation cases, asset tracing): https://www.nationalcrimeagency.gov.uk/
- UK Financial Intelligence Unit (within the NCA): https://www .nationalcrimeagency.gov.uk/what-we-do/how-we-work/intelligence-enhancing-the-picture-of-serious-organised-crime-affecting-the-uk

United States

- Department of Justice, Money Laundering and Asset Recovery Section (MLARS): https://www.justice.gov/criminal-mlars
- Office of International Affairs, Department of Justice (central authority): https://www.justice.gov/criminal-oia
- Department of State: https://www.state.gov/
- Department of State, Office of Anti-Crime Programs (INL/C): https://2009-2017.state.gov/j/inl/c/index.htm
- Financial Crimes Enforcement Network (FinCEN) (financial intelligence unit): http://www.fincen.gov/
- Federal Bureau of Investigation (FBI), specialized agency: https://www.fbi.gov/; https://www.fbi.gov/about/leadership-and-structure/international-operations; and https://www.fbi.gov/investigate/public-corruption
- Department of Homeland Security (DHS), Homeland Security Investigations (HSI), specialized agency: https://www.dhs.gov/

Хавсралт К. Лозаннагийн удирдамжийн тойм

Удирдамж 1: Урьдчилсан тойм

Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхээс өмнө улс орнууд санхүүгийн болон хууль сахиулах байгууллагын тагнуулын, нээлттэй эх сурвалж зэрэг боломжтой бүх эх сурвалжийг ашиглан аливаа шинж тэмдэг, мэдэгдлийг хангалттай түвшинд урьдчилан шалгаж, шаардлагатай бол санхүүгийн мэдээллийг холбогдох Санхүүгийн тагнуулын алба (СТА)-тай хуваалцах, дараагийн эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг дэмжих хэрэгтэй.

Удирдамж 2: Хөрөнгийг хязгаарлах

Улс орнууд хөрөнгийг хугацаагүй сарнихаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төрлийн хувилбаруудыг нэн даруй авч үзэх шаардлагатай бөгөөд тухайлбал засгийн газар царцаах, урьдчилан тогтоосон хугацаанд гүйлгээг хойшлуулах гэх мэт.

Удирдамж 3: Мөрдөн шалгах ажиллагаа

Улс орнууд холбогдох бүхий л төрийн байгууллагуудтай хэлэлцэж хэрэгт зориулсан цогц мөрдөн шалгах, хууль тогтоомжийг стратегийг боловсруулах шаардлагатай.

Уг стратеги нь дотоодын удирдах эрх бүхий байгууллагыг томилж, түүний үүрэг хариуцлагыг тогтоон бүх хуулийн арга замуудыг (захиргааны, иргэний болон эрүүгийн) авч үзсэн байх шаардлагатай. Мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх, мэдээлэл солилцох, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг гаргах зэрэг хэргийн лавлагааны дараалыг тохиролцсон байх шаардлагатай. Хөрөнгө буцаах үйл ажиллагааны турш стратегийг тогтмол хянаж байх ёстой.

Удирдамж 4: Цаг хугацаа

Эрх зүйн харилцан туслалцаатай холбоотой янз бүрийн төрлийн хүсэлт гаргах хугацааг харгалзан үзэж, хүсэлт гарагх эрх бүхий байгууллагатай хэлэлцэх хэрэгтэй.

Удирдамж 5: Хууль тогтоомжийн шаардлагууд

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авч буй улс орнууд нь бие биенийхээ хууль тогтоомжийн шаардлагыг ойлгох шаардлагатай бөгөөд энэ нь дотоодын хэрэг үүсгэлт болон олон улсын хамтын ажиллагаа аль алинд нь чухал ач холбогдолтой болно.

Удирдамж 6: Холбоо барих

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авч буй улс орнуудын мэргэжилтнүүд хоорондоо шууд холбоог үүсгэж, түүнийгээ ашиглах хэрэгтэй.

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авч буй эрх бүхий байгууллагууд олон улсын мэргэжилтнүүдээс туслалцаа хүсэх талаар авч үзвэл зохино.

Олон улсын болон бүс нутгийн сүлжээ зэрэг бүхий л боломжит сувгуудаар мэдээлэл солилцох хэрэгтэй.

Удирдамж 7: Харилцаа холбоо

Хүсэлт гаргаж буй улс орнууд хэрэв зохимжтой бол бүх хамаарал бүхий улс орнуудтай холбогдох мөрдөн шалгах ажиллагааны элементүүд, хууль тогтоомжийн стратеги болон хэргийн ерөнхий, хэргийн этгээдийн танилцуулгын талаар нэн даруй хэлэлцэх хэрэгтэй.

Хамаарал бүхий улс орнууд нь холбоо барих гол этгээдийг томилж, шаардлагатай бүх талуудад мэдэгдэх шаардлагатай.

Удирдамж 8: Зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагаа

Хүсэлт хүлээн авч буй улс орнууд өөрсдийн улс оронд аливаа хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хөрнөг болон хэргийн баримтууд дээр зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх талаар авч үзвэл зохино.

Хүсэлт хүлээн авагч, хүсэлт гаргагч улс орнууд нь боломжтой бол нэмэлт мэдээллийг сайн дураар хүргүүлж, эрх зүйн харилцан туслалцаатай холбоотой хүсэлтэд түргэн шуурхай хариулах замаар нэг нэгнийхээ хэрэг үүсгэлтийг бүх талаас нь дэмжиж ажиллах хэрэгтэй.

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авч буй улс орнууд нь нэг нэгнийхээ улс оронд шүүх ажиллагаанд оролцох чиглэлээр эдлэх боломжит эрхийг үнэлэх нь зүйтэй.

Хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч улс орнууд зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлж, хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх талаар авч үзвэл зохино.

Удирдамж 9: Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн төсөл

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авч буй улс орнууд хоорондоо эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн төслийг хуваалцаж бүх шаардлагууд хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулах шаардлагатай.

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авч буй улс орнууд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг түргэн шуурхай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх, дотоодын үйл ажиллагааны явцын талаарх ахицыг тогтмол хугацаанд хэлэлцэж байх ёстой.

Удирдамж 10: Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх

Хүсэлт хүлээн авсан эрх бүхий байгууллага хүсэлтийг гүйцэтгэх ажлыг шуурхай эхлүүлнэ.

Нөгөө улс оронд үүсээд буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлж болзошгүй дотоодод үүсгэсэн хэргийг шийдвэрлэж дуусах үед гадаадын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эсхүл гадаад хамтын ажиллагаанд тулгарч болзошгүй асуудлыг багасгах зорилгоор зохимжтой бол хоорондоо зөвлөлдөх нь зүйтэй.

Хавсралт L. Цогц мөрдөн шалгах ажиллагааны менежментийг сайжруулах зорилгоор хэргийн электрон менежментийн системийг ашиглах нь

Тойм

Нарийн төвөгтэй хэргүүдэд тулгарч буй бэрхшээлүүд

Хэргийн электрон менежментийн систем (ХМС)-ийн давуу талууд

Хэргийн электрон менежментийн системийг хэрэгжүүлэх нь

Хэргийн электрон менежментийн системийн суурь бүрэлдэхүүнүүд

Хэргийн мэдээллийн талбарууд

Нүүр хуудас

Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэл

Хэрэгт холбогдох этгээдийн мэдээлэл

Санхүүгийн мэдээлэл

Нотлох баримтын матриц

Эд мөрийн баримтын бүртгэл

Гол үйл явдлуудын он цагийн дараалал

Ашиг сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалт

Хэргийг хаахад шалгах хяналтын хуудас

Хайлт хийх

Графикууд

Баримт бичгийг бүрдүүлэх

Эх сурвалжууд

Тойм

Энэхүү удирдамжийг нөөц бололцоо сайтай, суурь мэдээллийн технологийн (МТ) дэд бүтэцтэй үйл ажиллагааны нэгжүүдэд бус, харин нөөц бололцоо хомс нөхцөлд ажиллаж буй мөрдөн шалгах нэгжүүдэд зориулан боловсруулсан болно.

Хулгайлагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх (СтАР) санаачлигад хамрагдсан улс орнуудаас харахад олон улс орнууд авлига, залилан, болон хүнд хүнд гэмт хэргүүдэд холбогдох санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд илүү анхаарал хандуулж байлаа. Эдгээр улс орнууд бүгд эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, шүүн таслах үйл ажиллагаанд оролцогчид буюу мөрдөгч, прокурор, шүүгчдийн чадавхыг нэмэгдүүлж, гэмт хэргээс олсон хөрөнгийг үр дүнтэй илрүүлэх, царцаах, нөхөн төлүүлэхийг эрмэлзэж байна. Оролцогчдын чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааг шударгаар хэрэгжүүлэх, улмаар ахлах менежерүүд мөрдөн шалгалтын явцад өргөн хүрээний хяналт, оролцоогоор хангах хатуу бодлого, тогтолцоог бий болгох шаардлагатай.

Дээрх хэргүүдийн нарийн төвөгтэй байдал, хэргийн стратегийг тодорхойлоход ахлах удирдлагын өргөтгөсөн хяналт, оролцоо шаардлагатай байгааг харгалзан хэргийн менежментийн арга барилыг өөрчлөх шаардлага үүсч байна. Эдгээр нарийн төвөгтэй хэргүүд урагшлах үед цаасан баримт бичгүүд нь хэргийн менежментэд бэрхшээл учруулж, хэд хэдэн мөрдөгчид нэг хэрэг дээр ажиллах, магадгүй мөрдөн шалгах ажиллагааны мөчлөгийн ондоо үе шатанд ажиллах үеийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь илт болдог. Энэхүү асуудлыг шийдвэрлэх гарц нь электрон хэргийн менежментийн систем (ХМС)-ийг танилцуулах явдал юм.

Электрон ХМС нь мөрдөн шалгах ажиллагааны шатанд байгаа бүх хэрэгт хамаарах эсэх нь удирдлагын шийдэх асуудал болно. Мөрдөн шалгах нэгжийн чадамж өсөхийн хэрээх уг системийг өргөжүүлж, мөрдөн шалгалтын үе шат, үндсэн мэдээллийг бүртгээд зогсохгүй баримт бичгийг цахимаар бүрдүүлж, улмаар заавар зөвлөгөө өгөх үйл явцыг оновчтой болгож, илрүүлэх, ил тод болгох ажиллагааг хөнгөвчлөх боломжтой. Дундын драйваас цахим баримт бичгүүдийг ХМС руу холбох нь тийм ч хэцүү биш бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагааг бүхэлд нь нэг аюулгүй газар байлгах боломжийг олгоно.

Нарийн төвөгтэй хэргүүдэд тулгарч буй бэрхшээлүүд

Эдгээр ээдрээтэй мөрдөн шалгах ажиллагаа эхлэх цагт тухайн хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусч, шүүхэд шилжин, эцсийн шүүхийн шийдвэр гарах хүртэл шаардагдах хугацаа ихэвчлэн тийм ч өндрөөр үнэлэгддэггүй. Үүн дээр байгууллагууд хулгайлагдсан хөрөнгөө нөхөн төлүүлэхийг хүсэх үед гарч ирэх хүндрэлүүдийг нэмээд олон жил өнгөрч болно. Ихэнхдээ хэрэг үүсгэх үед оролцож байсан мөрдөгчид цааш явж, өөр хэн нэгэн баримт бичгийн хариуцлагыг өвлөн авдаг. Хэрэв хэргийн мэдээллийг хэд хэдэн ялгаатай тэмдэглэлд хөтөлж, ондоо хавтсуудад хадгалсан эсхүл бүр муугаар бодоход буруу хавтаст хийсэн бол хэрэгт холбогдолтой ямар алхмууд хийгдсэн; яагаад тодорхой шийдвэрүүд гарах болсон; ямар нотлох баримт цуглуулсан; ямар нотлох баримтыг олж авах боломжгүй байсан; цуглуулсан өгөгдөлд яагаад болон хэрхэн дүн шинжилгээ хийсэн (хэнээр хийгдсэн) зэрэг асуудлуудыг ойлгоход хүндрэлтэй байх болно.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад ихэвчлэн олон байгууллагын, өргөн хүрээний ур чадварыг ашиглах шаардлага үүснэ. Мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч бүх талууд стратегит хувь нэмрээ оруулах нь чухал бөгөөд нэг хүн бүх хариултыг мэдэх боломжгүй. Энэхүү олон талт хандлагыг хэрэгжүүлэх удирдлагаар хангах шаардлагатай бөгөөд үүнд дараах зүйлс туслах болно:

- Төвлөрсөн мэдээлэх систем
- Мөрдөн шалгах ажиллагааны уялдаа холбоо (тохиромжтой этгээдэд тодорхой үүрэг хариуцлага бүхий ажлыг даалгах)
- Оноогдсон ажлыг гүйцэтгэсэн эсэхийг шалгаж, баталгаажуулах, хэрэв саатал гарсан тохиолдолд эцсийн дуусах хугацааг тодорхойлох ур чадвар
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад шаардагдах их хэмжээний баримт бичгийг (биет болон цахим хуулбар) цуглуулах ур чадвар, үр дүнтэй хамгаалалтын системийг хэрэгжүүлэх боломж.

Эдгээр менежментийн алхмуудаас гадна мөрдөн шалгалтын шатуудын цаг хугацаанд нөлөөлөх аливаа стратегийн шийдвэрүүдийг ойлгож, зохих ёсоор тооцож, төлөвлөх шаардлагатай бөгөөд тухайлбал хэзээ нэгжих тушаалыг хэрэгжүүлэх, гэрчийн мэдүүлгийн хугацаа, хуулийн мэргэжилтэн нь гэрч эсхүл сэжигтэн эсэх, хэзээ албан бус хэлбэрээс албан эрх зүйн харилцан туслалцаанд (ЭЗХТ) шилжих зэрэг багтана.

Хэргийг нээсний дараа олон удаа саатах тохиолдол маш их гардаг. Мөрдөн шалгах ажиллагааны явцад саатал гарахад хүргэж буй хамгийн гол алдаа, шалтгаан нь ЭЗХТ-г хэт эрт авахад оршиж байна. ЭЗХТ-ны хүсэлт, нэмэлт хүсэлт, болон албан бус хүсэлтийн төслийг боловсруулах нь цаг хугацаа ихээхэн шаарддаг бөгөөд хэргийн баримт бичгийг харах эрхтэй нэг хүний мэдлэгт тулгуурлан хүсэлтийг тухай бүрт дахин бичдэг. Хэрэв ЭЗХТ-ны хүсэлтэд татгалзаж, аливаа тайлбараар хангаагүй тохиолдолд түүний учир шалтгааныг олох гэж олон сарыг зарцуулдаг. Дахин хэлэхэд ЭЗХТ яагаад хүссэн тухай мэдээлэл нь зөвхөн баримт бичгийг харах эрх бүхий нэг л хүнд тулгуурладаг бол энэ хэрэг эмзэг болно.

Хэдийгээр эдгээр хүндрэлүүд байсаар байх боловч баримт бичгийг илүү сайн зохион байгуулснаар давхардлыг багасгаж, мөрдөн шалгах ажиллагааны болон баримт бичгийн явцын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ. Энгийн Экселд суурилсан системээс эхлэх замаар мэдээллийн технологийн системийг олж авах, ашиглах хязгаарлагдмал боломжтой хүмүүсийн суралцах боломжийг нэмэгдүүлэх юм. Энэхүү ажлын талбарт шинээр орж буй олон шинэ төгсөгчдийн хувьд Эксел систем нь өгөгдөлд (Банкны тодорхойлолт, дансны мэдээлэл) дүн шинжилгээ хийх, диаграм, график гаргах зэрэг программд суулгасан дүн шинжилгээний хэрэгслийг ашиглах өргөн хүрээний боломжийг олгодог бөгөөд энэ нь шүүхийн өмнө их хэмжээний нотлох баримтыг танилцуулах үйл явцыг хялбаршуулдаг.

Электрон системийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хэд хэдэн бодлого, үйл ажиллагааны шийдвэр, тогтоол гаргах шаардлагатай тулгардаг.

Хэргийн электрон менежментийн систем (ХМС)-ийн давуу талууд

Одоо хэрэглэгдэж байгаа цаасан суурьт системд нийцүүлэн электрон системийн бүтэц зохион байгуулалтыг тохируулж болох хэдий ч ажилтнууд электрон системд шилжсэнээр мөрдөн шалгах ажиллагааны ажилтнууд болон удирдлагад дараах давуу талууд үүснэ:

- Бүх мөрдөн шалгах ажиллагаанд стандартчилагдсан үндсэн үйл явцыг хэрэгжүүлэх
- Хариуцлага, ил тод байдал нэмэгдэх
- Зайнаас хяналт тавьж, хэргийн талаарх мэдээллээр хангах боломж
- Мөрдөн шалгах ажиллагааны хэрэгцээнд тулгуурлан нөөцийг нэмэгдүүлэх боломж
- Хүсэлт, тайланд гол нотлох баримтуудыг гаргаж авахад хялбар болсноор тайлагнах үйл явц сайжрах
- Мэдээллийг ил тод болгох систем сайжрах
- Тагнуулын өгөгдөл мэдээллийн төвлөрсөн сан.

ХМС нь тохируулсан систем эсхүл тохируулаагүй / бэлэн багц хэлбэрээр байж болох хэдий ч тохируулсан систем нь мэдээллийн технологийн суурь дэд бүтцэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг тул практикт байнга хэрэгжүүлэх боломжгүй байдаг.

Электрон системд шилжих үед тухайн систем нь ашиглахад хялбар, ээлтэй байх нь чухал. Илүү цогц ХМС-ийг хожим (нөөц боломж бүрдсэн үед) нэвтрүүлж болох ч юун түрүүнд шилжилтийг хэрэгжүүлэх нь чухал бөгөөд бүх шинэ мөрдөн шалган ажиллагаанд ХМС-ийг нэвтрүүлэх өдрийг тохирсноор эхлэх нь зүйтэй. Нөгөө талаас өнгөрсөн хугацаан дахь мөрдөн шалгах ажиллагааг электрон ХМС-д байршуулахдаа, ялангуяа хуучин цаасан баримт бичгүүдэд их хэмжээний мэдээлэл агуулагдаж байгаа тохиолдолд сайтар төлөвлөж, анхаарах шаардлагатай. Системийн үйл ажиллагаа явагдаж эхлэх үед ажилтнууд болон удирдлагууд системийн давуу болон сул талуудыг сайтар ойлгож, хожим тохируулсан системд шилжихийг хүсэх үед ямар шаардлагуудыг хангасан байх тухай илүү сайн мэдээлэлтэй болох болно.

Нөөцийн болон дэд бүтцийн зөвшөөрлийн дагуу өгөгдөл мэдээллийг анхны системээс илүү нарийвчилсан системд шилжүүлэх боломжийн талаар авч үзэх хэрэгтэй.

Хэргийн менежмент нь илүү өргөн хүрээний файл, баримт бичгийн удирдлага болон хэргийн материалд ижил төстэй байдлаар дахин боловсруулж болох мөрдөн шалгах ажиллагааны үндсэн ажиллагаанууд, хүрэх үр дүнг мөн харгалзан үзэх шаардлагатай.

Хэргийн электрон менежментийн системийг хэрэгжүүлэх нь

Ихэвчлэн байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтэц хязгаарлагдмал байж болно. Ажилтнууд дундаа компьютер ашиглах шаардлагатай гардаг эсхүл ажил дээрээ өөрийн зөөврийн компьютерийг ашигладаг байж болно. Байгууллага нь найдвартай сүлжээний системгүй, мэдээллийн технологийн аюулгүй байдлын протоколууд хуучирсан байж магадгүй. Эдгээр бүх хязгаарлалтууд нь мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг хадгалахад хүндрэл учруулж байдаг.

Байгууллага бүр өөрийн дотоод шийдлийг олох шаардлагатай. Гэсэн хэдий ч ХМС-ийн нөөц хувилбар байгаа эсэхийг баталгаажуулж, системийн нэвтрэлтийг хянах байдлаар ХМС-ийг хэрэгжүүлэх нь чухал хэвээр байна. Түүнчлэн системд хэн нэвтэрсэн, ямар нэмэлт, өөрчлөлтүүд хийгдсэн талаарх хяналт шалгалтыг хийдэг тодорхой процесс байх ёстой. Зарим засгийн газар, олон улсын байгууллагууд Google Workspace эсхүл албан хэрэгцээнд зориулсан Microsoft Office 365 (мөн Microsoft Teams)-ийн аль нэгийг ашигладаг бөгөөд учир нь эдгээр үүлэн тооцоолол,

бүтээмж, хамтын ажиллагааны хэрэгслүүд нь аюулгүй байдлын хамгийн энгийн шаардлагуудыг хангасан байдаг. Эдгээр хэрэгслүүдийн аль аль нь хязгаарлагдмал хандалттай дундын баримт бичгүүдийг үүсгэх боломжийг олгодог бөгөөд энгийн ХМС-г байрлуулах боломжтой байдаг. Энэ нь байгууллагын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдин оролцоо, дотоод хэлэлцүүлгийг шаардана.

Гадаад үүлэн хадгалалтын системд хэргийг хавтсийг нээх нь шийдлийн нэг хэсэг байж болно. Эдгээр системд хандах хандалт нь ихэвчлэн хавтсын эзэмшигчээс (бүрэн хандалт) хяналтын хандалт хүртэлх янз бүрийн түвшний хандалтыг дэмждэг. Мэдээллийн технологийн суурь дэд бүтэц хангалтгүй хөгжсөн байсан ч (өөрөөр хэлбэл дотоодын сүлжээний систем биш) удирдлагаас системийн хандалтыг хянаж, өгөгдлийг найдвартай нөөцлөх системтэй байх зайлшгүй шаардлагатай. Боломжтой бол гадаад биш үүлэн хадгалалтын системээр дэмжигдсэн системтэй байх нь илүү тохиромжтой.

Хэргийн электрон менежментийн системийн суурь бүрэлдэхүүнүүд

Энэхүү хэсэгт аливаа мөрдөн шалгах байгууллагын ХМС-ийн суурь бүрэлдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг өгнө. Эдгээр нь системийг нэвтрүүлэхдээ хэрэглэгчдэд танил болсон одоогийн загварыг ашиглах эсхүл тодорхой процесст нийцүүлэн тохируулах боломжтой. ХМС нь бизнесийн үйл явцыг оновчтой болгох, автоматжуулах хэрэгсэл биш, харин хэрэг бүрийн нарийвчилсан мэдээллийг бүртгэх төвлөрсөн систем гэдгийг давтан хэлэх нь зүйтэй.

Боломжтой бол тусдаа мэдээллийг ондоо талбарт байрлуулах хэрэгтэй ба энэ нь өгөгдөл мэдээллийг ангилах, шүүх ажиллагаанд дэмжлэг болно гэдгийг анхаарах нь зүйтэй. Энэ нь дараах хүснэгтийн бүтцэд нэмэлтээр мөр оруулахыг шаардаж болно.

Хэргийн мэдээллийн талбарууд

Дор харуулсан жишээнд (Зураг L.1) хүснэгт нэмж оруулах боломжтой байгаа хэдий ч өгөгдлийн баазад нэвтэрч, өөрчлөх эрхтэй этгээдэд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлж байгааг баталгаажуулах нь чухал. Үр дүнтэй мэдээллийн удирдлагад тусдаа ажлуудыг урсгалын оновчтой байдал нь зохих нэвтрэлтийн нэгэн адил чухал ач холбогдолтой байна.

Нэлээдгүй тохиолдлуудад санхүүгийн нарийвчилсан дүн шинжилгээг тусад нь дүн шинжилгээ хийх зорилгоор нээсэн файлд хийх нь тохиромжтой байна. Банкны дансны дебит, кредитийн зэрэг энгийн дансны дүн шинжилгээг Эксел талбарт хялбархан бүртгэж болох хэдий ч энэ талаар “Санхүүгийн профайл” хэсэгт дахин тайлбарлах юм. Эдгээр хүснэгтүүдэд бүртгэгдсэн өгөгдөл мэдээлэл нь хэргийн явцын талаарх мэдээллээр хангадаг. Энэхүү мэдээлэл нь бусад тайлан, хүсэлтийг бэлтгэхэд туслахаас гадна мэдээллийн дагуу шийдвэр гаргахад хангалттай мэдээллээр хангана.

Нүүр хуудас

“Нүүр хуудас” хүснэгт нь хэргийн баримт бичгийн ажилтнуудын энгийн мэдээлэл болон голлох огноог харуулсан хэргийн нүүрний хуудас юм (Зураг Л.2). Хэрэг бүрт дахин давтагдашгүй дугаар ашиглаж, дугаарын төгсгөлийг хэрэг нээсэн хугацаагаар оруулах нь нэгэн сайн туршлага юм.

Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэл

Энэхүү хүснэгтийн мөрдөгчийн тэмдэглэлийн дэвтэр эсхүл өдрийн тэмдэглэл гэж үзэх нь хамгийн оновчтой юм. Мэдэгдэлийн дагуу гаргасан хэргийн хураангуй; мөрдөн шалгалтын явцад илрэх боломжит гэмт хэргүүд (мөрдөн шалгах ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа тул одоо мөрдөн шалгаж эхэлж буй хэрэг болон цаашид яллах гэмт хэрэг нь ялгаатай байж болохыг санах нь зүйтэй), өөрт нь байгаа нотлох баримтууд болон нотолж чадах баримтуудаас энэ хэсгийг эхлэх хэрэгтэй. Хэргийн хураангуй бэлтгэх хүрээнд дараах асуудлуудыг бодох нь зүйтэй:

- Мөрдөн шалгах ажиллагаа нь ямар боломжит гэмт хэрэгт холбогдож байна вэ?
- Нарийвчлан тогтоогдсон тохиолдолд гэмт хэрэг тус бүрийн аль хэсгүүдийг нотлох хэрэгтэй вэ?
- Одоогоор ямар нотлох баримтууд байна вэ? Ямар зүйлсийг одоо нотолж чадах вэ?
- Ямар нотлох баримт, нотолгоог олж авах шаардлагатай вэ? Мөн хэрхэн олж авах вэ?

Хэргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээний нарийвчилсан бүртгэлээс мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны авах арга хэмжээ, стратеги бий болно. Хэрэв авах арга хэмжээний жагсаалт гарсан бол түүнийг хийх ажлын жагсаалт гэж харах хэрэгтэй. Ажлын онцлог шинж чанарыг ойлгох нь мөрдөгчид болон менежерүүдэд нэгэн адил чухал юм.

Товч, тодорхой, шинэчлэгдсэн мэдэгдлийн тойм чухал байдаг. Хэрэв мэдэгдлийн тойм нь зохимжтой хийгдсэн нөхцөлд хэргийн хураангуйг мөрдөн шалгах ажиллагааны хэд хэдэн ажилд ашиглаж, улмаар хэргийн хэт их баримтыг дахин дахин тохируулахад шаардагдах хугацааг багасгадаг.

ЗУРАГ L.1 Мөрдөн байцаалтын хэргийн материалын эксел дэх үндсэн талбарууд

Нүүр хуудас	Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэл	Субъектын профайл	Санхүүгийн профайл	Нотлох баримтын матрикс	Эд мөрийн баримтууд	Цаг хугацааны хүснэгт	Хэрэг хаахад шалгах хуудас	Ашиг сонирхол бүхий хүн	Ашиг сонирхол бүхий компани

Эх сурвалж: СтАР
Тэмдэглэл: COI=АСБК-Ашиг сонирхол бүхий компани; POI=АСБХ-Ашиг сонирхол бүхий хүн

ЗУРАГ L.2 Хэргийн материалын нүүр хуудасны жишээ

Хэргийн дугаар:
Баг / Мөрдөн шалгах нэгж:
Хэрэг нээсэн огноо:
Шүүхэд шилжсэн огноо:
Хэрэг хаагдсан огноо:

Эх сурвалж: СтАР

Мөрдөгчид ихэвчлэн мэдүүлгийг дэмжих тодорхой нотлох баримт гарган авахын өмнө мөрдөн шалгах ажиллагааны талаар товч танилцуулга хийх шаардлагатай болдог. Тухайлбал нэгжих зөвшөөрөл хүсэх эсхүл албан, албан бус туслалцааны хүсэлт гаргах үед энэхүү шаардлага бий болдог. Хэргийн хураангуй нь хэргийн тоймын үнэн зөв байдлыг баталгаажуулах, мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг оновчтой тусгах, танилцуулга хэлбэрээр ашиглах болон шаардлагатай үед бусад баримт бичигт хуулах, цаг хугацаа хэмнэх боломжийг олгодог.

Мөрдөн шалгах шатанд явж буй гэмт хэргүүдийг “Нотлох баримтын матриц” талбар (дор дэлгэрэнгүй тайлбарласан) хэсэгт оруулснаар мөрдөгч хэргийн мэдүүлгийг дэмжих нотлох баримтуудыг цуглуулах боломжийг олгодог. Мөрдөн шалгах ажиллагааны анхан шатанд нотлох баримтыг баталгаажуулах, хэргийн удирдагчдыг тодорхойлох, боломжит гэрчүүдээс ярилцлага авах зорилгоор авагдах урьдач арга хэмжээнүүд хамаарна.

Хэргийн хураангуйг гаргасны дараа бүртгэлд мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд тодорхойлсон алхмууд болон авсан арга хэмжээний талаар тэмдэглэнэ. Тэмдэглэл нь өдрийн тэмдэглэлийн эсхүл бичмэл тайлбар хэлбэрээр байж болох бөгөөд хийгдсэн, хийгдээгүй, хийгдэж байгаа арга хэмжээг тусгасан байна. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр мөрдөн шалгах ажиллагааны аль ч үед мөрдөгчийн бодол, үйл явцын талаарх хамгийн үнэн зөв бүртгэлийг гаргаж чадна. Өдрийн тэмдэглэл эсхүл бичмэл тайлбар хэлбэрээр бичих аргачлалыг хэрэглэх нь хэргийг хянах, учирч болох саад бэрхшээлийг ойлгох, мөрдөгч яагаад тодорхой арга хэмжээг авсныг тайлбарлахад хялбар болгодог. Түүнчлэн энэ нь сунжирсан мөрдөн шалгах ажиллагааны явцад, мөн мөрдөгч хавтаст хэргийг бусад хамтран ажиллагчдаа хүлээлгэн өгөх шаардлагатай үед онцгой ач холбогдолтой байж болох юм. Ямар арга хэмжээ авсан (магадгүй 1 жилийн өмнө) болон яагаад тухайн арга хэмжээг авсан талаар ойлгох нь мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд чухал ач холбогдолтой бөгөөд хэргийг шүүхэд шилжүүлэхэд хэрэгтэй лавлагаа болно.

Дор харуулсан хүснэгт (Хүснэгт L.1)-ийн А баганад огноо болон цагийг тэмдэглэж, С баганад тухайн арга хэмжээг эхлүүлсэн хүнийг тэмдэглэнэ. Д баганад тухайн мөрдөн шалгах ажиллагааны үе шатаас үүсэн гарсан аливаа бичиг баримтын холбоос эсхүл солбицсон эшлэлийг оруулна. Тухайлбал хэрэв хийгдэх үйл ажиллагаа нь банкны тодорхойлолтыг хадгалах байсан бол эд мөрийн баримтын бүртгэлээс авсан бичиг баримтын лавлагааг (энэхүү хавсралтын төгсгөлд тайлбарласан) оруулна. Хэрэв үйл ажиллагаа нь хувь хүнээс ярилцлага авах байсан бол мэдэгдлийн лавлагааг оруулна.

Хүснэгт L.1 Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэлийн загвар

Огноо цаг	Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэл	Бүртгэл хийсэн хүн	Баримт бичгийн дугаар
	Хэргийн тойм:		
	Мөрдөн шалгах ажиллагааны боломжит гэмт хэргүүд:		
	Мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны алхмууд:		
	Үйл ажиллагааны бүртгэл:		

Эх сурвалж: СтАР

Ажиллаж буй улс орны хууль тогтоомжоос шалтгаалан мөрдөн шалгах ажиллагааны бүртгэл нь илрүүлэх эсхүл задруулах үйл ажиллагаанд хамаарах боломжтой. Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад үүнийг авч үзэх нь нэн чухал юм. Зарим эмзэг мөрдөн шалгах тактикийг шүүх дээр тусгай хууль эрх зүйн хамгаалалтаар хангадаг бөгөөд ихэвчлэн үйл ажиллагааны тактикын нууцлалыг хангах, үнэ цэнийг хамгаалах боломжийг олгодог.

Хэрэв та эмзэг тактик ашиглаж байгаа бол зөвхөн эмзэг мэдрэмтгий үйл ажиллагааны зорилгоор тусдаа Эксел ХМС-д мөрдөн шалгах ажиллагааны параллел бүртгэл хөтлөхийг хүсч болно. Үүний нэгэн жишээ нь утасны бичлэг, нууц дүрс бичлэг болон дуу хоолойн бичлэг, тэр ч байтугай шүгэл үлээгчийг ашиглах явдал байж болох юм. Өөрийн үйл ажиллагааны бүртгэлийг нууц үгээр хамгаалсан, зөвхөн эрх бүхий этгээд харах эрхтэй байдлаар тусдаа газарт бүртгэснээр та нууц мэдээлэлд хандах эрхгүй этгээдэд эмзэг мэдээллийг санамсаргүй алдах эрсдэлийг эрс бууруулна.

Хэрэгт холбогдох этгээдийн мэдээлэл

Ямар ч мөрдөн шалгах ажиллагааны гол бүтээгдэхүүн нь мөрдөн шалгах ажиллагаанд хамаарах этгээд бүрт нээсэн “хэргийн этгээдийн танилцуулга” юм. Энэхүү багц дата мэдээлэл нь хэргийн этгээд хоорондын холбоо хамаарлыг тогтооход зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнд холбоо хамаарал бүхий этгээд, гэр бүл, гэмт хэргийн хамсаатан (зарим нь мэргэжлийн гэмт хэргийн туслах байж болно), түүнчлэн хэргийн этгээдийн амьдралын хэв маягууд хамаарах ба энэ нь хэргийн этгээдийг хөрөнгө, хууль бус мөнгөтэй холбоход туслана. Үүнийг санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааныхаа үндэс суурь гэж үзээрэй.

Гэмт этгээдүүд өөрсдийн хөрөнгийг нуун далдаж, мөрдөгчид гэмт хэргийн орлогыг өөртэй нь холбохоос сэргийлэхийн тулд чадах бүхнээ хийх болно гэдгийг бид мэднэ. Мөрдөгч гэмт хэргээс олсон орлогыг гэмт этгээдтэй нэгэнт холбосон тохиолдолд тэр даруй мөрдөн шалгах ажиллагааг бэхжүүлдэг. Хэргийн этгээдийн танилцуулга нь үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг баримт бичиг бөгөөд өөрөөр хэлбэл энэ нь хэзээ ч бүрэн гүйцэт болохгүй, хэргийн хугацаанд шинэ мэдээллүүд гарч ирсээр байх болно.

Хэргийн этгээдийн мэдээлэл дахь жижигхэн хэсэг ч нуун далдалсан гэмт хэргийн орлогын байршиж буй тодорхой улс орны ул мөрийг илэрхийлэх холбоос байж болох ба энэ бүхэн нь ЭЗХТ хайх, мөрдөн шалгах ажиллагааны удирдамжийг гаргахад зайлшгүй шаардлагатай. Эдгээр мөрдөн шалгах ажиллагааны удирдамжууд нь нэмэлт лавлагааны мөрүүдийг үүсгэж, хэргийн этгээдийн танилцуулгыг нэмэлт мэдээллээр ханган "хувьсан өөрчлөгдөх баримт бичиг"-ийн статусыг хадгалах болно. Тухайлбал хэргийн этгээд нь түрээсийн үл хөдлөх хөрөнгөд байгааг тодорхойлсон бол түрээсийн төлбөрийн эх үүсвэрээр лавлагаа үүсгэж болох ба хэргийн этгээдэд холбогдсон, өмнө нь мэдэгдээгүй байсан банкны дансуудыг илрүүлж болох юм. Хэрэв тухайн хүн нь үл хөдлөх хөрөнгө худалдан авсан байвал хэргийн этгээдийн ашигласан хуулийн төлөөлөгчөөр лавлагаа үүсгэж болно.

Экселийн бүтэц нь хэргийн шинэ этгээдийг багана бүрт нэмэх боломжийг олгодог. Тухайлбал Б, С, Д багануд гэх мэт цааш үргэлжилнэ. А баганад хэргийн этгээд тус бүрт хамаарах стандарт мэдээллийг тусгах ба танилцуулга үүсгэхэд зохимжтой гэж үзсэн тохиолдолд тухайн улсад байгаа бусад дата мэдээллийн эх сурвалжийг ашиглан шинээр мөрүүдийг нэмэлтээр оруулах боломжтой.

Хэд хэдэн утгыг оруулах бол утга бүр тусдаа шугамд байрших хэрэгтэй ба боломжтой бол стандарт форматыг хэрэгжүүлэх нь зүйтэй (Хүснэгт L.2). Стандарт форматыг бий болгох шалтгаан нь мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай мэдээллийн суурьтай танилцах явдал юм. Энэ нь эргээд стандартчилагдсан хяналтыг бий болгоно: Хэргийн этгээд нь өмнө нь гэмт хэрэг үйлдсэн бүртгэлтэй эсэх, ямар гэмт хэрэг үйлдсэн бэ? Хэргийн этгээд нь танай улсад банкны данс эзэмшдэг үү? Түүнчлэн хариулах шаардлагатай бусад асуултууд мөн байна: Ойрын хамаатан хэн бэ? Эхнэр нөхөр үү эсхүл хамтрагч уу? Ах дүүс үү? Хаяг болон бусад асуултуудын хариултад хэд хэдэн утгыг оруулах нь тодорхой хэдий ч асуулт бүрт тусдаа шугам ашиглах нь чухал. Асуултын жагсаалтыг бүрэн гүйцэт гэж үзэхгүй бөгөөд аль ч улсын мөрдөгчийг олж авах боломжтой мэдээлэлд уялдан өөрчлөгдөж болно.

Хэргийн этгээдийн танилцуулгын агуулга нь тайлбар шаардахааргүй, ойлгомжтой хэдий ч зарим асуудлууд дээр тэмдэглэл оруулбал зохимжтой.

Хүснэгт L.2 Хэрэгт холбогдох этгээдийн мэдээллийн стандарт форматын загвар

Холбогдох мэдээлэл	Холбогдох этгээд 1
Овог	
Нэр	
Дунд нэр	
Хоч нэр	
Хэргийн этгээдийн төрсөн огноо	
Ойрын хамаатан/хамтрагч/эхнэр, нөхөр	
Хүүхдүүд	
Төрсөн газар	
Пасспортын дугаар	
Пасспортын дуусах хугацаа	
Орлох бичиг баримт /жолооны үнэмлэх гэх мэт/	
Бусад үндэс, угсаа	
Мэдэгдэж буй хаягууд (одоогийн болон өмнөх)	
Ажил олгогчийн хаяг (эзэмшдэг компаниуд нь биш) ба эрхэлдэг ажил	
Мэргэжил эсхүл албан тушаал	
Эцэг, эх	
Эцэг эхийн хаяг	
Эцэг эхийн төрсөн огноо	
Байнга очдог/ аялдаг улс орнууд	

Эх сурвалж: СтАР

Хоч нэр. Танилцуулгын энэхүү хэсэгт хэргийн этгээдийн нэрийг үсэглэх аливаа сонголтот хувилбаруудыг багтаавал зохино. Ялангуяа энэ нь нэрийг галиглан бичсэн тохиолдолд чухал ач холбогдолтой бөгөөд хүний нэрийг ондоо этгээдүүд бүртгэхдээ янз бүрээр үсэглэсэн байх тохиолдол нийтлэг байна. Тухайлбал: Хэйли, Халэй, Хайлий, Хайлэйх, Хэйлийх, зэрэг нь нэг нэрийн хувилбарууд бөгөөд хэрэглээний үйлчилгээ үзүүлэгч эсхүл бичиг баримтад энэ ялгаа илэрч болно. Гэмт этгээдүүд нэрээ албан ёсны бүртгэлээс салгах зорилгоор хууль ёсны болон бусад албан ёсны баримт бичигт нэрээ зориудаар буруу бичих нь нийтлэг тохиолддог. Түүчлэн энэхүү хэсэг нь мөрдөгч хэргийн этгээдийн нэрийн бүх үсэглэсэн хувилбарыг мэдэхэд туслах ба учир нь хувилбаруудыг мэдсэнээр мэдээллийн сангаас хайлт хийх, ялангуяа гадаад улс орнуудаас асууж тэдгээрийн мэдээлийн сангаас хайлт хийж, чухал мэдээлэл олох боломжийг олгодог юм. “Хувилбарт зөв бичгийн алдаа хайгч” (тухайлбал https://datayze.com/alternate-spelling-finder) нь үсгийн боломжит орлуулалт дээр үндэслэн тухайн англи үгийн хэдэн хувилбар байж болох талаарх санааг өгөх болно.

Мөн хэргийн этгээдийн пасспортын зураг (иргэний үнэмлэх)-ний зургийг хэргийн этгээдийн танилцуулгад хуулах нь дараагийн хүсэлтэд хэрэг болж магадгүй гэдгийг

санах нь зүйтэй. Ихэвчлэн энэ нь тухайн хэргийн этгээдтэй холбоотой цор ганц зураг байх боломжтой.

Нээлттэй эх сурвалжийн дүн шинжилгээ /тагнуул/ (НЭСДШ). НЭСДШ бол мэдээллийн үнэлж боломгүй эх сурвалж бөгөөд хэргийн этгээдтэй холбоотой мэдээллийг тодорхойлоход өргөнөөр ашиглах хэрэгтэй (Хүснэгт L.3). Өнөө цагт ихэнх компани болон үл хөдлөх хөрөнгийн талаарх мэдээлэлд цахимаар нэвтэрч, хувь хүмүүсийн мэдээллийг сошиал медиа хаягаар дамжуулан олж авах боломжтой.

Хүснэгт L.3 Сошиал медиа болон бусад нээлттэй эх сурвалжийн дүн шинжилгээ (НЭСДШ)-ний мэдээллийн жишээ

Холбогдох мэдээлэл	Холбогдох этгээд 1
Цахим шуудангийн хаяг буюу имэйл	
Гар утас	
Твиттер	
ЛинкедИн	
Фэйсбүүк	
Бусад сошиал медиа	
Өмгөөлөгч / төлөөлөгч	
Өмчилж буй компани эсхүл эзэмшиж буй хувьцаа (эзэмшиж буй хувь): бүртгэлтэй нэр, үйл ажиллагаа явуулж буй нэр	
Хамаарал бүхий этгээд	
Тээврийн хэрэгсэл эсхүл мэдэгдэж буй тээврийн хэрэгсэл (тээврийн хэрэгслийн дугаар)	
Хобби/сонирхол	

Эх сурвалж: СтАР
Тэмдэглэл: НЭСДШ: Нээлттэй эх сурвалжийн дүн шинжилгээ

Нээлттэй эх сурвалжийн лавлагааг хэрэгжүүлэх үед хэргийн этгээдийн цахим шуудангийн хаяг болон гар утасны дугаар нь ихэвчлэн хэргийн этгээдийн нэрээс илүү хэрэгцээтэй байх ба энэ нь дахин давтагдашгүй таних тэмдэг болж өгдөг.

Хэргийн этгээдийн сошиал медиа хаягаас авсан мэдээлэл нь тухайн хүний хамаарал бүхий этгээд, хаашаа аялсан болон боломжтой хөрөнгийн холбоо хамаарлын талаар хэрэгцээт мэдээллээр хангаж чадна. Засгийн газрын бус цахим хуудсууд дахь мэдээллийг тогтоох үед дэлгэцийн зургийг (скрин шот) хадгалж авах нь чухал ба учир нь эдгээр холбоосууд богино хугацааны дотор устгагдах боломжтой.

Хэрэгт холбогдох этгээдийн хөрөнгийн тухай мэдээлэл. “Санхүүгийн танилцуулга” талбар нь нийт хөрөнгөд гарах өөрчлөлтийг тодорхойлоход хэрэгцээтэй хүний хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлын талаарх дүн шинжилгээний өргөн цар хүрээний мэдээллээр хангана. Гэсэн хэдий ч танилцуулгыг боловсруулах явцад “Хэргийн этгээдийн танилцуулга” талбарт хэргийн этгээдтэй холбоотой хөрөнгийн анхан шатны мэдээллийг давхар бүртгэх нь зүйтэй (Хүснэгт L.4).

Санхүүгийн мэдээлэл

Аливаа санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд тулгамддаг гол хүндрэл нь хууль бус орлогыг хууль ёсны орлогоос ялгаж салгах, заримдаа гэмт хэргийн орлого эсхүл

гэмт хэргээс олсон орлогыг тодорхойлох явдал юм. Санхүүгийн танилцуулгыг үүсгэх нь мөрдөгчид тухайн хэргийн этгээдийн санхүүгийн талаарх бүх асуудлыг тодорхойлох боломжийг олгодог бөгөөд улмаар хэргийн этгээдийн нийт хөрөнгө (нийт орлого болон хөрөнгийн дүн) нь хууль ёсны орлогоор тайлбарлагдах орлогоос хэтэрсэн эсэхийг тогтооход дэмжлэг үзүүлдэг. Энэ нь эргээд мөрдөн шалгах ажиллагааны явцад илэрсэн хөрөнгө, орлого нь гэмт хэргийн улмаас олсон орлого байж болохыг шүүхээр дүгнэхэд тусална.

Санхүүгийн танилцуулга нь мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийн этгээдийн мэдээлсэн орлогыг тухайн этгээдийн хөрөнгө, өр төлбөр (цэвэр хөрөнгө) болон хувийн зардалтай харьцуулан судалж, тайлбарлаж чадаж байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв этгээдийн нийт хөрөнгө, хувийн зардлын хэмжээ нь мэдээлсэн орлогоос давж, өмнө байсан хадгаламжид хамаарахгүй байвал гэмт хэргээс олсон орлогоос тухайн этгээд ашиг олсон гэх дүгнэлт гарч эхэлнэ. Орлого, зардал болон хөрөнгөд дүн шинжилгээ хийх нь тайлбарлагдаагүй орлого, хэргийн этгээдийн амьдралын хэв маяг дахь гэнэтийн эсхүл огцом өөрчлөлтийг харуулахад туслахаас гадна гэмт хэргийн улмаас олсон орлогоос хэргийн этгээд нь ашиг хүртсэн гэдгийг нотлоход дэмжлэг үзүүлнэ.

Хүснэгт L.4 Хэрэгт холбогдох этгээдийн мэдээлэлд багтаан оруулах санхүүгийн анхан шатны мэдээлэл

Холбогдох мэдээлэл	Холбогдох этгээд 1
Мэдэгдэж буй хөрөнгө (1)	
Мэдэгдэж буй хөрөнгө (1)	
Мэдэгдэж буй хөрөнгө (1)	
Мэдэгдэж буй хөрөнгө (1)	
Мэдэгдэж буй хөрөнгө (1)	
Мэдэгдэж буй хөрөнгө (1)	
Хамаарал бүхий этгээдүүд	
Тээврийн хэрэгсэл эсхүл мэдэгдэж буй тээврийн хэрэгсэл (Тээврийн хэрэгслийн дугаар)	
Мэдэгдэж буй өр төлбөр (Туршлагатай - хуулийн дагуу хайлт хийх эрхтэй бол)	

Эх сурвалж: СтАР

Хүний нийт хөрөнгө дахь өөрчлөлтийг тодорхойлохоор зорьж байгаа үед тодорхой огноо дахь эхлэлийн хөрөнгийг хэмжээг тогтоох шаардлагатай ба үүнийг сарын эхлэлээр тавиж болох юм (жишээ нь 2017 оны 1 дүгээр сар). Үүнтэй нэгэн адилаар хаалтын хөрөнгийн хэмжээг мөн тодорхойлох нь зүйтэй (жишээ нь 2020 оны 1 дүгээр сар). Заримдаа хэргийн этгээдийн орлогын суурь үзүүлэлтийг гаргаж болох цор ганц албан ёсны бүртгэл нь татварын бүртгэл байх ба энэ нь шүүх дээр маргаан үүсгэхэд хүндрэлтэй. Банкны дансны бүртгэлийг мөн адил ашиглаж, орлого зарлагыг харж болох хэдий ч хэргийн этгээдийн банкны дансыг анхнаасаа илрүүлж чадахгүй байж болно. Хэргийн этгээдийн танилцуулгын нэгэн адил санхүүгийн танилцуулгыг ч “байнга хувьсан өөрчлөгдөж байх” баримт бичигт тооцох хэрэгтэй.

Хөрөнгийн бүртгэлийг хөтөлж байх үедээ хэрэв боломжтой бол гүйлгээг дараалын дагуу (гүйлгээний огноо болон цагаар) байршуулах нь дараагийн дүн шинжилгээг

хийхэд тустай байна. Биет хөрөнгийн хувьд уг дараалал нь хэргийн этгээдэд тухайн эд хөрөнгийн нэр шилжиж очсон өдөр байх эсхүл биет хөрөнгийг (тухайлбал машин, завь, эсхүл үнэт эдлэл) худалдан авсан өдөр байх боломжтой.

Санхүүгийн танилцуулга нь бүх мэдэгдэж буй хөрөнгө, өр төлбөрийг хэргийн этгээд тус бүрээр бүртгэдэг учраас энэ талбарыг хэргийн этгээд тус бүрээр хуулбарлах шаардлагатай болдог. Хэргийн этгээдэд хамаарах хөрөнгийн хэмжээнээс хамаарч нээлтийн нийт хөрөнгө, хаалтын нийт хөрөнгийн тооцооллыг тусдаа талбар дээр үүсгэхийг хүсч болох юм.

Одоо байгаа бүтцийн хувьд бүх жинхэнэ эд хөрөнгүүдийг (амины сууц, завь, машин, үнэт эдлэл, урлагийн бүтээл, гулдмай гэх мэт) нэг хэсэгт байршуулсан (Хүснэгт L.5, а самбар). Хөрвөх хөрөнгө буюу бэлэн мөнгө, банкны данс (хадгаламж эсхүл чек) зэрэг хөрөнгө оруулалтууд, хувьцаа, бонд, эргүүлэн авах боломжтой амьдралын даатгал, үнэт цаас (хувьцаа, бонд эсхүл биржээр арилжаалсан хөрөнүүд) зэрэг нь өөр нэгэн хэсэгт байршсан (Хүснэгт L.5, б самбар). Хөрөнгүүдийг зах зээлийн үнэлгээгээр бус өртгөөр нь үнэлэх ёстой бөгөөд учир нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө орлогоос хэдий хэмжээний ашиг хүртэж байгааг тодорхойлоход мөрдөгчид туслана.

Хөрөнгийг бүртгэх үед нэмэлт мэдээллийг мөн адил бүртгэх бөгөөд тухайлбал банкны дансны дэлгэрэнгүй, хөрөнгийн хаяг, байршил гэх мэт. Эдгээр нэмэлт мэдээлэл нь хүсэлт гаргах, мөрдөн шалгах ажиллагааны баримт материалыг нэгтгэх үед хэрэг болно. Олон тооны хөрөнгө байгаа тохиолдолд хөрөнгө, өр төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг нээлтийн болон хаалтын жилээр зэргээр B, C, D гэх мэтээр багануудад бүртгэнэ.

Эдгээр дата мэдээлэл суурилан жил бүрээр нийт хөрөнгийн хэмжээ болон X жил болон Y жилийн хоорондын нийт хөрөнгийн ялгааг тооцоолон гаргана (Хүснэгт L.6).

Хүснэгт L.5 Санхүүгийн мэдээллийн стандарт форматын загвар

а. Бодит өмч							
		Жил Х	Жил Х	Жил Х	Жил У	Жил У	Жил У
Өмч	Төрөл (амины сууц/ завь/ машин)						
	Хаяг						
	Худалдан авсан огноо						
	Худалдан авсан үнэ						
	Өнөөгийн үнэ цэнэ						
	Сүүлийн үнэ цэнийг тооцсон огноо						
	Үнэ цэнэ тогтоогчийн нэр / хаяг						
	Эзэмшдэг өмчийн нэр						
	Мортгеж/ төлбөр						
	Газрын бүртгэлийн баримт бичиг (Y/N)						
	Нийт	0	0	0	0	0	0
б. Хөрвөх хөрөнгө							
		Жил Х	Жил Х	Жил Х	Жил У	Жил У	Жил У
Хөрөнгө	Төрөл (хадгаламж/ хувьцаа/ бонд)						
	Банк						
	Банкны хаяг						
	Ангиллын код						
	Дансны дугаар						
	Дансны төрөл						
	Данс эзэмшигчийн бүтэн нэр						
	Одоогийн үлдэгдэл						
	Жилийн нийт зардлын эргэц						
	Жилийн нийт орлогын эргэц						
	Тэмдэглэл						
	Нийт	0	0	0	0	0	0

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.6 Хэрэгт холбогдох этгээдийн санхүүгийн мэдээлэл дэх хөрөнгийн үнэ цэнийг тооцоолох форматын загвар

Хөрөнгийн төрөл	Х жил	У жил
Банкны дансууд		
Бусад банкууд		
Хувьцаа		
Бонд/ хөрөнгө оруулалтууд		
Завь/ тээврийн хэрэгсэл		
Үл хөдлөх хөрөнгө		
Үнэт эдлэл/ урлагийн бүтээл		
Гарт буй бэлэн мөнгө		
Нийт хөрөнгө		

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.7-д бүх өр төлбөрийг холбогдох огноон хамт бүртгэнэ. Цаашид нэмэлт өр төлбөрүүд гарч ирсэн тохиолдолд шугам нэмэх нь зүйтэй (тухайлбал оюутны зээл гэх мэт).

Хэргийн этгээдийн орлого хүлээн авсан бүхий л хугацаанд бүгдэнг нь бүртгэх шаардлагатай. У жилээс Х жилийн хоорондын бүх орлогыг мөн адил бүртгэнэ. Түүнчлэн орлогын мэдэгдэж буй эх үүсвэрүүдийг бүртгэх ба нийт дүнг зохих хүснэгтэд бөглөнө. Санал болгож буй бүтэц (Хүснэгт L.8) нь чиглэл өгөх хэдий ч нийт тооцооллыг гаргахдаа жил бүр, сар бүр, долоо хоног бүрээр хүлээн авсан хөрөнгө мөнгийг харгалзан үзэх нь чухал юм.

Энэ хугацаанд нэмэлт зардлууд мөн адил төлөгдөж болно. Энэ нь хоол хүнс, нийтийн үйлчилгээний зардал гэх мэт амьжиргааны зардлаас эхлээд өр барагдуулах хүүгийн төлбөр хүртэл байдаг (Хүснэгт L.9).

Оруулсан утгууд болон нийт дүнд суурилсан хэргийн этгээдийн нийт хөрөнгө дахь өөрчлөлт тооцоологдон гарна (Хүснэгт L.10). Мэдэгдэж буй эх үүсвэртэй орлогыг хасч, зардлыг нэмснээр эх үүсвэр тодорхойгүй орлогын дүнг тодорхойлох боломжтой болно.

Нийт хөрөнгө болон тайлбарлагдаж чадаагүй зардлыг тооцоолох үед дүн шинжилгээ хийгдэх хугацаа нь суурь мөрдөн шалгах ажиллагаа, хэргийн бодит баримтууд болон боломжит мэдээлэлд суурилж тодорхойлогдоно. Орлого, зардлыг харахад хэрэв тооцоолох шаардлагатай бол Эксел нүдэнд тайлбар оруулахыг зөвлөж байгаа ба учир нь ирээдүйд тодорхой тоог гаргаж, бодит өртгийг тусган тооцооллыг өөрчлөх боломжтой. Тооцоололд үндэслэл байх ёстой бөгөөд хэтрүүлэн тооцох нь илүү аюулгүй.

Хүснэгт L.7 Хэрэгт холбогдох этгээдийн санхүүгийн мэдээлэлд байгаа өр төлбөрийн тооцооллын форматын загвар

Өр төлбөрийн төрөл	Х жил	У жил
Үл хөдлөх хөрөнгийн мортгеж		
Тээврийн хэрэгслийн зээл		
Кредит картны өр төлбөр		
Бусад хэрэглээний зээл		
Бусдаас авсан өр		
Төлөгдөөгүй татвар		
Бусап өр төлбөр		
Нийт хөрөнгө		

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.8 Санхүүгийн мэдээлэл хэсэгт багтах орлогын талаарх мэдээллийн загвар

Орлогын дата мэдээлэл	Х жил	Х жилийн турш				
Ажилтан эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгч						
Мэргэжил						
Нийт орлого						
Долоо хоногоор/Сараар/Жилээр						
Ажилд орсон огноо						
Ажлаас гарсан орноо						
Тэмдэглэл						
Нийт орлого						

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.9 Санхүүгийн танилцуулга дахь зардлын дата мэдээллийн жишээ

Зардлын төрөл	Х жил	Х жилийн турш				
Ажилтан эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгч						
Хэрэглээ						
Мортгежийн хүүний төлбөр						
Даатгал						
Хоол хүнс						
Хувцас хэрэглэл						
Зугаа цэнгэл						
Нийт орлого						

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.10 Хэрэгт холбогдох этгээдийн нийт хөрөнгө дэх өөрчлөлтийг тооцоолох жишээ формат

Нийт хөрөнгө ба тайлбарлагдаагүй орлогын мэдээлэл	
У жил дахь нийт хөрөнгийн хэмжээ	
Хасах: У жил дахь өр төлбөр	
Хасах: Х жил дахь нийт хөрөнгө	
Нэмэх: Х жил дахь өр төлбөр	
Нийт хөрөнгийн өсөлт	
Нэмэх: Нийт зардал	
Хасах: Нийт орлого	
Мэдэгдэхгүй эх үүсвэрээс гарсан зардал	

Эх сурвалж: СтАР

"Мэдэгдэхгүй эх үүсвэрээс гарсан зардал" хэсэг тайлбар шаардана. Энэ зардал нь таны мөрдөн шалгаж буй гэмт хэргийн шууд нотлох баримт болж болох юм. Хэрэв залилангийн хэрэг гарсан бол хэргийн этгээдийн банкны дансны санхүүгийн гүйлгээг шууд мөшгих боломжтой бөгөөд хууль бус орлогын нотлох баримтыг олж авахаас гадна суурь гэмт хэргээс олсон орлогын ашиг хүртэгчийг хэрэгт шууд холбох боломжтой. Энгийн авлигын төлбөрийг ч үүний нэгэн адил мөшгиж болно.

Энэхүү мөрдөн шалгах ажиллагааны үе шат нь нийтлэг өмгөөллийг шийдвэрлэх, үр дүнтэйгээр худал өмгөөллийг няцаахыг эрэлхийлэх ёстой. Эдгээр өмгөөлөлд дараах багтана. Үүнд:

- *Хуримтуулах:* хэргийн этгээд нь эхлэлийн хугацаанд их хэмжээний бэлэн мөнгөтэй байсан ба хэргийн этгээд нь татварын эрх бүхий байгууллагад бэлэн мөнгийг мэдүүлээгүй тухай мэдэгдэл;
- *Бэлэг эсхүл зээл:* хэргийн этгээд нь заасан хугацаанд бэлэг хүлээн авсан эсхүл хувь зээл авсан тухай мэдэгдэл;
- *Алдаа гарсны улмаас мэдүүлээгүй:* Тодорхой данс эсхүл үндсэн бус анхүүгийн байгууллагад хадгалагдаж байсан мөнгөнөөс олсон орлогыг татварын эрх бүхий байгууллагад мэдүүлээгүй, дүн шинжилгээнд тусгагдаагүй тухай хэргийн этгээдийн мэдэгдэл.

Нотлох баримтын матриц

Нотлох баримтын матриц нь мөрдөн шалгах ажиллагаа нь төвлөрсөн хэвээр байх, сэжиглэгдсэн гэмт хэргүүдтэй холбоотой нотлох баримтыг цуглуулахад чиглэсэн мөрдөн шалгах ажиллагааны гол бүтээгдэхүүн юм.

Эхэн үе шатуудад нотлох баримтын матриц нь мөрдөгчийн олж авсан нотлох баримтууд болон тэдгээр нь гэмт хэргийн элементүүдтэй хэрхэн нийцэж байгааг тодорхойлохыг зорьдог. Нарийн төвөгтэй санхүүгийн хэргүүд, ялангуяа гэмт хэрэг нь гадаад улс оронд үйлдэгдсэн бол мөрдөгч нь нотлох баримт цуглуулах ажиллагаа нь бүрэн бус тул хэрэгт ямар нэгэн цоорхой байгаа гэдгийг ойлгох нь зүйтэй. Нотлох баримтын матрицын дасгал ажил нь тэдгээр цоорхойг илрүүлж, дараа дараагийн хийгдэх ажлуудад анхаарлаа хандуулахад тусалдаг. Нарийн төвөгтэй хэргийн хувьд энэ үе шатанд мөрдөн шалгах ажиллаагааг эсхүл нэг хэсгийг нь хэрэгжүүлэхээр томилогдсон хүнийг бүртгэх арга хэлбэр болох бөгөөд мөн мөрдөн шалгах ажиллагааны үе шат гүйцэтгэж дуусах бүрт түүнийг бүртгэх газар болдог.

Хэрэг хөгжихийн хэрээх батлагдаж буй хэргийн элемент бүрт холбогдох нотлох баримтуудыг нэгтгэн дүгнэх, тухайн нотлох баримтыг дэмжиж байгаа эсхүл хангаж байгаа эд мөрийн баримтад солбицсон эшлэл оруулахад ижил матрицыг дахин ашигладаг.

Нэмж дурдахад энэхүү матриц нь шинээр томилогдсон мөрдөгч, удирдлагад мөрдөн шалгах ажиллагааны явцын талаарх товч мэдээлэл өгөх, цуглуулсан нотлох баримтын цоорхойг тодорхойлох, мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх эсэх тухай стратегийн шийдвэрүүдийг гаргахад дэмжлэг үзүүлэх ач холбогдол бүхий хэрэгсэл юм.

Гадаад улсаас нотлох баримт олж авахаар эрэлхийлэх үед тулгардаг суурь асуудлуудын нэг нь сэжиглэгдэж буй гэмт хэргийн элементүүдийг зөвхөн мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй улс оронд бус эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүлээн авч буй улсын шаардлагатай стандартад нийцүүлэн нотлох явдал юм. Нотлох баримтын матриц нь хүсэлтийн бүтэц зохион байгуулалтыг гаргаж, нотлох баримтыг цэгцтэй, логиктой, ойлгомжтой тодорхойлсон байх боломжийг олгодог бөгөөд энэ нь эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн давхан шаардлагыг хангахад онцгой ач холбогдолтой. Давхар гэмт хэргийн шаардлага нь өргөдөлд заасны дагуу тухайн үйлдлийг өөрийн улсын дагуу гэмт хэрэг мөн гэдгийг хүлээн авагчийн улс оронд нийцүүлэх зорилготой байдаг. Хүсэлт хүлээн авагч улс оронд хүсэлт илгээж буй улс орны тодорхойлсонтой адил гэмт хэрэг байх магадлал бага боловч тогтоосон баримтуудын дагуу аль аль улсад нь гэмт хэрэг болох ёстой.

Мөрдөн шалгагдаж буй сэжиг бүхий эрүүгийн гэмт хэрэг тус бүрт нотлох баримтын матрицыг бэлдэх шаардлагатай. Ялангуяа санхүүгийн гэмт хэргийн хувьд сэжиглэгдэж буй эрүүгийн хэрэг нь эцэстээ шүүхэд ялласан / ял тулгаснаас ондоо зүйл болж хувирах боломжтой. Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлох баримтын матрицыг гэмт хэргийн шинжтэй шинэ хэргийн элементүүдэд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Үүний нийтлэг жишээ нь анх мөрдөн шалгах ажиллагааг “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн хүрээнд эхлүүлсэн хэдий ч мөрдөн шалгалтын явцад ял тулгахад “мөнгө угаах” гэмт хэрэг илүү тохиромжтой байгааг олж илрүүлсэн байна. Гэмт хэргийн элементүүдийг хожим тохируулсан нь зүйтэй.

Юун түрүүнд нотлох баримтын матрицыг мөрдөн шалгагдаж буй хэргийн мэдэгдлийн талаарх богино хэмжээний цогцолбор болгон гаргах хэрэгтэй (Хүснэгт L.11). Хураангуйг мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөний хураангуйлсан хэсгээс (“Мөрдөн шалгах ажиллагааны бүртгэл” талбар доторх) авах боломжтой хэдий ч энэ нь зөвхөн тухайн гэмт хэрэгт нарийвчлан гаргасан байх шаардлагатай. Тухайлбал дараах байдлаар гаргана: *“[Огноо]-ийн хооронд, Ноён Х нь У компаниас төлбөр хүлээн авч, хариуд нь тухайн компани дамжин өнгөрөх замын бүтээн байгуулалтын гэрээнд ялах нөхцлийг баталгаажуулсан. Тухайн үед Ноён Х нь Зам тээврийн яамнаас гаргасан гэрээнүүдийн үнэлгээний хорооны даргаар ажиллаж байсан. Төлбөрийг Ноён Х-ийн хүүхдийн нэр дээрх оффшор дансанд хийсэн байна.”*

Дараа нь уг матрицад авлига, төрийн албан хаагчийн авсан авлига зэргээр гэмт хэргийн талаарх товч тайлбарыг, зөрчиж буй хууль тогтоомж, холбогдох хэсэг болон зөрчлийн ял шийтгэлийн хамт тусгах ёстой.

Хүснэгт L.11 Урьдчилсан нотлох баримтын матрицын жишээ

A	Хэргийн мэдэгдэл				
	Гэмт хэрэг				
	Хэсэг				
	Хэргийн элементүүд	Лавлагааны эгнээ	Даалгавар	Хэн	Хэзээ
1					
2					
3					
4					
5					
6					

Эх сурвалж: СтАР

Энэ мэдээллийг эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд оруулах шаардлагатай. Энэ үйл явц нь дээр дурьдсанчлан гэмт хэрэгт яллах ажиллагааг баталгаажуулах ач холбогдол бүхий лавлах цэг болдог. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь жил биш юмаа гэхэд хэдэн сараар үргэлжилдэг тул хэрэв эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орж хууль өөрчлөгдсөн бол үүнийг мөн матрицад тусгах боломжтой.

Үүний дараагаар гэмт хэргийг бүрдүүлж буй хэргийн элементийг мөр бүрт зааж өгөх ёстой. Мөрдөгч нь хууль тогтоомжийг сайтар ойлгож, эрүүгийн гэмт хэрэг эсхүл мөрдөн шалгагдаж буй гэмт хэргийн дараах асуултуудад мөр бүрт тусгасан гэмт хэргийн элементүүдийн ашиглан нэн даруй эсхүл мөрдөн шалгах ажиллагааны явцад хариулах чадвартай байх шаардлагатай (тухайлбал, дээрх жишээний хувьд *төрийн албан хаагчийн авсан авлига*):

1. “Алба хаагч”: Одоо хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд “алба хаагч”-ийн тодорхойлолт юу вэ?
2. “Авлига хүлээн авах эсхүл эзэмших”: “авлига”, “хүлээн авах” болон “эзэмших” гэдэг үгнүүдийн хуулийн тодорхойлолт, тайлбар нь юу вэ?
3. “Өөртөө болон бусад хүнд өгөх аливаа хахууль”: “Хахууль” болон “бусад хүн” гэх үгийн тодорхойлолт нь юу вэ?
4. “Аливаа хийсэн эсхүл орхигдуулсан үйлдлийн өмнөөс”: “Аливаа хийсэн үйлдэл” эсхүл “орхигдуулсан” гэх үгийн тодорхойлолт юу вэ?
5. “Өөрийн албаны эрх мэдлээр”: “албаны” болон “эрх мэдлээр” гэдэг үгсийн тодорхойлолт юу вэ?

Эдгээр элемент тус бүрээс гадна мөрдөгч тухайн элементэд хамаарах нотлох баримтыг олж авахын тулд (мөн хуулийн асуултад хариулах зорилгоор) үүсгэсэн лавлагааг гаргах; лавлагааг үүсгэсэн этгээдийг тодорхойлох; гаргасан өдрийг оруулах; холбогдох эд мөрийн баримтууд болон тэмдэглэлийг гаргах ёстой. Тухайлбал, дээр оруулсан Элемент 1-ийн хувьд дараах байж болно. Үүнд:

- *Элемент:* Албаны
- *Лавлагааны эгнээ:* Албаны томилгоог харуулсан Засгийн газрын хэвлэл

- *Даалгавар:* Хэвлэлийн гэрчлэгдсэн хуулбарыг олж авах
- *Хэн болон Хэзээ:* (томилогдсон мөрдөгчийн нэр), (томилогдсон огноо)

Лавлагаа бүрдэж, нотлох баримт цугласан бол матрицыг гэмт хэргийн элемент бүрээр нотлох баримтын нэмэлт утгуудаар баяжуулж болно (Хүснэгт L.12). Үүнд:

- *Нотлох баримтын баганад:* цуглуулсан нотлох баримтын тайлбар. Нотлох баримтыг гэрчээс өгөх тохиолдолд тэдний мэдүүлэг эсхүл гэрчийн мэдүүлгээс тодорхой тайлбарыг гэрчийн лавлаж болох гол баримтат нотлох баримтын хамт гаргаж авах нь ач холбогдолтой. Нотлох баримт нь бичиг баримт тохиолдолд Нотлох баримтын баганд бичиг баримтын голлох хэсгүүдийг тайлбарлах нь зүйтэй.
- *Эд мөрийн баримтын лавлагаа (Эд мөрийн бүртгэл) баганад:* эд мөрийн баримтын лавлагааг Эд мөрийн баримтын талбар солбицсон эшлэл үүсгэж оруулах хэрэгтэй.
- *Тэмдэглэл баганд:* Нотлох баримтын хэсэгт холбогдох ямар нэгэн зүйлсийг оруулна. Тухайлбал, эд мөрийн баримтыг хэн боловсруулах шаардлагатай талаар лавлагаа оруулж болох юм.

Нотлох баримтын матрицыг бүрэн гүйцэт дуусгахын гол зорилго нь яллагдагчаар татах болон дараагийн яллах хэргийг дэмжих үндсэн нотлох баримтуудыг товч тоймлон гаргаж, хэргийн дутагдлыг аль болох эрт илрүүлж, арилгахад оршино.

Хүснэгт L.12 Нотлох баримтын матрицыг баяжуулсан жишээ, гол нотлох баримтуудыг элемент бүрээр жагсаасан загвар

A		Элемент бүрт хамаарах гол нотлох баримт		
	Гэмт хэрэг			
	Хэсэг			
	Элементүүд	Нотлох баримт	Эд мөрийн баримтын лавлагаа	Тэмдэглэл
1				
2				
3				
4				
5				
6				

Эх сурвалж: СтАР

Эд мөрийн баримтын бүртгэл

Дотооддоо эд мөрийн баримтуудыг бүртгэх, удирдах хэд хэдэн үй ажиллагаа явагдана. Хэдийгээр үйл ажиллагааг давхардуулахаас зайлсхийх нь чухал боловч цахим хавтаст хэргийн баримт бичигт холбогдох эд мөрийн баримтуудын бүртгэлийг хөтлөх нь эд мөрийн баримтын хялбархан шинэчлэх, хянах нөхцлийг бүрдүүлнэ. Энэхүү систем нь эд мөрийн баримтыг бусад талбаруудад солбицон эшлэхэд бэлэн болгож, хэрэв цахим архивлалт явагдаж буй үед баримт бичгийн цахим холбоосыг үүсгэх боломжийг олгодог.

Уг бүртгэл нь аливаа гэрч, сэжигтний өмнө нотлох баримтыг олж тогтоох, бүрдүүлэх, мөн шүүхийн баримт бичиг бэлтгэх үед эд мөрийн баримтын жагсаалтыг бүрдүүлэх, илрүүлэлтэд зориулаж эд мөрийн баримтын жагсаалтыг бэлтгэх сайн арга зам болдог.

“Эд мөрийн баримтууд” талбар дахь одоогийн багануудад цаашдын дүн шинжилгээ, ангилалтад туслах дата мэдээллийг хялбархан нэмж оруулах боломжтой. Жишээ нь “бичиг баримтын огноо”, “хэнд/хэнээс”, болон “дүн” гэх талбарууд нь эд мөрийн баримтын бүртгэлийг бүрдүүлэхэд нэмэлтээр орж болно.

Гол үйл явдлуудын он цагийн дараалал

Мөрдөн шалгах ажиллагааны явцад боловсруулагдан гарах гол бүтээгдэхүүн нь он цагийн дараалал юм (Хүснэгт L.14). Мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж, нэмэлт нотлох баримтууд цуглуулахын хэрээр үйл явдлууд хэрхэн хоорондоо холбогдож байгааг ойлгох, санах нь нэн чухал. Он цагийн дараалал нь мөрдөн шалгах ажиллагааны дутагдлыг илрүүлэх, голлох үйл явдлуудыг санах, хэргийн этгээд болон гэрчүүдээс мэдүүлэг авахад бэлтгэхэд ач холбогдол бүхий арга хэрэгсэл болно.

Хүснэгт L.13 Эд мөрийн баримтын бүртгэлийн стандарт форматын жишээ

Эд мөрийн баримтын дугаар	Эд мөрийн баримтын тайлбар	Илрүүлсэн байршил	Лавлагаа	Эд мөрийн баримтын авсан огноо / авсан этгээд

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.14 Үйл явдлуудын он цагийн дараалын жишээ формат

Огноо	Цаг	Үйл явдал	Эх сурвалж

Эх сурвалж: СтАР

Он цагийн дараалал нь үйл явдлуудын дараалын холбоо хамаарлыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлэх боломжийг олгож, юу болсон талаарх бүрэн зураглалыг гаргахад тусладаг. Ялангуяа хүнд эсхүл нарийн төвөгтэй хэргүүдийн хувьд он цагийн дараалал нь өдөр, сараар бус жил гаруй үргэлжилж болно. Үйл явдал бүр өөрийн гэсэн эх сурвалжтай байх ба энэ нь орон нутгын мэдээ эсхүл

аудитын хэлтсийн ажилтны санхүүгийн гүйлгээний талаарх санаа зовоосон асуудал гэх мэт байж болно. Бүх чухал үйл явдлуудыг он цагийн дараалаар бүртгэхийн тулд шинэ мөрүүдийг тухай бүр оруулах шаардлагатай.

Ач холбогдол бүхий гүйлгээг голлох үйл явдлуудад багтааж болох хэдий ч ялангуяа дансны дүн шинжилгээг сайн хийдэг нарийн төвөгтэй санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд бүх гүйлгээг он цагийн дараалаар бүртгэхэд уг он цагийн бүртгэлийг ашиглахыг зөвлөдөггүй.

Ашиг сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалт

Хэргийн этгээдийн танилцуулгыг боловсруулж, мөрдөн шалгах ажиллагаа үргэлжлэх явцад хийсэн судалгаа, баримт бичгүүдээс хэд хэдэн нэр болон компаниудыг тогтооно. Нэлээдгүй тохиолдолд эдгээр хүмүүсийг боломжит гэрчээр эрт тодорхойлж болно. Ихэвчлэн, тухайлбал агент болон компаниудын хувьд нотлох баримтууд цуглуулах хүртэл хэрэгт ямар оролцоотой байсныг илрүүлэх боломжгүй байдаг. Зарим тохиолдолд ашиг сонирхол бүхий хувь хүн, эсхүл хуулийн этгээд нь хэдэн сар эсхүл жилийн дараа цуглуулсан нотлох баримтаар гарч ирэх магадлалтай.

Мөрдөн шалгах ажиллагааны эхэнд ашиг сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг гаргах нь илэрсэн хувь хүн, эсхүл хуулийн этгээд бүрт бүртгэл үүсгэх, тайлбар хэсэгт (эсхүл “нэмэлт мэдээлэл”) зохих утгыг оруулж дата мэдээллийн эх сурвалжид холбох ажиллагааг баталгаажуулдаг (Хүснэгт L.15).

Хэргийг эцэслэх шатанд аливаа дүн шинжилээ /тагнуулын/ мэдээллийн санд ашиг сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг ашиглах талаар авч үзэх нь зүйтэй.

Хэргийг хаах хяналтын хуудас

Хэргийн материалыг эцэслэн боловсруулж дуусмагц хэрэг хаах хуудсыг бөглөж, тодорхой арга хэмжээг дуусах үед бүртгэх нь жишиг практик юм. Хяналтын хуудсын маягтыг одоо ашиглаж буй агентлагийн маягтаар хийж болно. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмж, 11 шууд хэрэгжилт зэрэг олон улсын стандартын дагуу улс орнууд өөрсдийн мөнгө угаахтай тэмцэх, хулгайлагдсан хөрөнгийг буцаах тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлүүлдэг. Хэрэг хаах хуудсыг шинэчлэхдээ хэд хэдэн шинэ хэмжигдэхүүнийг цуглуулж, хэрэв ямар нэгэн сургамжийг гаргаж авах, хуваалцах боломжтой бол кэйс судалгаа эсхүл типологийг бэлтгэх талаар анхаарч үзэх хэрэгтэй.

Хүснэгт L.16-д материалыг хаах үйл явцад оруулах нэмэлт хяналтуудыг харууллаа.

Хүснэгт L.15 Ашиг сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтын жишээ формат

А. Ашиг сонирхол бүхий хувь хүн						
Огноо	Овог, нэр	Бусад нэр	Хаяг	Төрсөн огноо	Утасны дугаар	Нэмэлт мэдээлэл

Б. Ашиг сонирхол бүхий хуулийн этгээд							
Огноо	Компанийн нэр	Компанийн дугаар	Хаяг	Захирлуудын мэдээлэл	Хувьцаа эзэмшигчид	Зуучлагч	Нэмэлт мэдээлэл (холбоотой компаниуд)

Эх сурвалж: СтАР

Хүснэгт L.16 Хэрэг хаахад шалгах хяналтын хуудсанд багтаах хэсгүүдийн жишээ

Хэсэг	Тайлбар
Шүүхэд шилжсэн огноо	Хянан шийдвэрлэх системд хэргийг шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн суурь дата мэдээлэл
Шүүх хуралдааны дугаар	
Давж заалдсан огноо	
Давж заалдах хүсэлтийг шийдвэрлэсэн огноо	
Хэргийн шийдвэрлэлт	Яллагдсан/хэрэгсэхгүй болгосон гэх мэт
Сэжигтний нэр	Уг хэргийн хүрээнд шийтгүүлсэн бүх хүмүүсийн жагсаалт, ял оногдуулсан гэмт хэргийн талаарх мэдээлэл, хуулийн заалтууд болон оногдуулсан ял шийтгэл. Бүх хүмүүст тусдаа утга оруулбал зохино.
Үйлдсэн гэмт хэрэг	
Ял шийтгэл	
Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт / улс орон	Энэхүү мэдээлэл нь тухайн улс орон олон улсын хамтын ажиллагааг хэр сайн хэрэгжүүлдэг тухай үнэлгээг дэмжих мэдээлэл болно.
Хөрөнгө хураан авах захирамж	Шүүхийн тогтоолын нарийвчилсан мэдээлэл
Хураасан хөрөнгө / үнийн дүн	Тогтоолын дагуу хураасан хөрөнгийн нарийвчилсан мэдээлэл
Гэмт хэргийг үйлдэхэд ашигласан салбарууд / мөнгө угаах	Мөнгө угаах гэмт хэргийг хамруулсан бол хэрхэн мөнгө угаасан талаарх нарийвчилсан мэдээлэл. Тухайлбал тухайн мөнгө нь хэрхэн санхүүгийн системд нэвтэрсэн тухай, мөн ямар хөрөнгүүдийг худалдан авсан зэрэг.
Анхан шатны тагнуулын эх сурвалж	Мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх болсон шалтгаан нь дотоодын эрх бүхий байгууллагын (жишээ нь Санхүүгийн тагнуулын алба) тагнуулын дүн шинжилгээнээс улбаалсан эсхүл олон нийт, шүгэл үлээгч зэрэг бусад эх сурвалжид үндэслэсэн эсэхийг тодорхойлно.

Эх сурвалж: СтАР

Дэлхийн банкнаас цогц Мөнгө угаах гэмт хэрэг цуглуулах хэрэгслийг Экселд суурилсан эсхүл JavaScript болон HTML шийдэл хэлбэрээр боловсруулан гаргасан. Аль аль хувилбарууд нь нэмэлт тохируулга, тохиргоо хийх уян хатан байдлаар

хангадаг. Мөрдөн шалгах ажиллагааны бүхий л үе шатуудад илүү нарийвчилсан мэдээлэл цуглуулах боломжийг олгодог эдгээр хэрэгслийг олж авахад ямар нэгэн зардал гарахгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг Санхүүгийн Цогц байдлын нэгжийн гаргасан хэрэгслийн товхимолын дараах холбоосоор авна уу. http://pubdocs.worldbank.org/en/422681580 318460585/POC-Update-04.pdf.

Хайлт

"Хайлт"-ын талбар (Зураг L.1-д харуулсан талбарууд дээр нэмж болно) нь мөрдөн шалгах ажиллагааны багуудын хандаж болох ач холбогдол бүхий холбоос, нөөцүүдийн нэгдсэн төв бүртгэл юм (Хүснэгт L.17). Үүнд төрийн цахим хуудсууд зэрэг эх сурвалж дата мэдээллийг цахим хуудсууд болон хэрэгтэй холбоотой аливаа мэдээлэл байгаа эсэхийг харах зорилгоор бусад байгууллагуудтай холбогдох зэрэг багтана.

Эдгээр мэдээллийн нэгдсэн сантай болсноор хэргийн нарийвчилсан хэсгүүд дээр ажиллаж буй мөрдөгчид авч үзэх шаардлагатай лавлагааны холбоо барих хаягийн жагсаалттай болно. Энэхүү талбарыг хэрхэн ашиглаж байгаагаас хамааран ажлын давхардлаас зайлсхийх зорилгоор хэзээ, хэн холбоо барьж, лавлагаа эхлүүслнийг харуулах нэмэлт багануудыг нэмж болно. Уг талбарыг зохистой удирдсанаар хүчингүй болсон холбоос болон холбоо барих мэдээллийг шинэчилж, мэдээллийн хэрэгцээт кэш болж чадах хамгийн дээд үр ашгийг гаргах боломжтой болно.

Энэхүү бүртгэлд байгаа мэдээллийг шинэ мөрдөн шалгах ажиллагааны материалд мөн шилжүүлэх боломжтой.

Графикууд

Тусдаа талбар биш хэдий ч экселд үүсгэсэн санхүүгийн урсгал болон холбоодын графикууд нь ХМС-д нэмж болох хэрэгцээтэй бүрэлдэхүүн юм. Бичвэр оруулах хэсэг эсхүл ондоо дүрсүүд дахь бичвэр оруулах хэсгийг ашиглах замаар хувь хүн, компаниуд, холбоосуудыг нүдээр хялбархан дүрслэн харах боломжтой нийтлэг практик юм.

I2 зэрэг ахицан түвшний дүн шинжилгээний хэрэгсэл байхгүй тохиолдолд энэ арга нь ялангуяа их хэрэгцээтэй байдаг.[1] Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь санхүүгийн урсгалыг цогцоор нь хамруулдаг тул тодорхой хугацааны мөчлөг, гүйлгээ, компани эсхүл шууд холбоос эсхүл сэжигтэнээр нь хуваах нь хялбар байж болно.

Баримт бичгийг бүрдүүлэх

Томоохон хэргийн материалууд нь санхүүгийн байгууллагаас авсан банкны хуулганы цахим хуулбараас эхлээд зөөврийн компьютерээс хураан авсан баримт бичиг, цахим шуудангууд зэрэг цахим файлуудаас их хэмжээний мэдээллийг олж авахад хүргэдэг. Түүнчлэн баримт бичгүүдийн цахим хуулбаруудыг үүсгэж болох ба мөрдөн шалгах ажиллагааны явцад баримт бичгийг боловсруулна.

[1] The IBM i2 Дүн шинжилгээний дэвтэр нь дата мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хамаарал, загварыг илрүүлэхэд ашиглагддаг. Дэлгэрэнгүй мэдээллийг бүтээгдэхүүний цахим хуудсаас авна уу. https://www.ibm.com/products/analysts-notebook.

Хүснэгт L.17 “Хайлт” талбарт оруулах мэдээлэл

Утас	Интернет	Тэмдэглэгээ	Санхүүгийн	Бусад хяналтууд
Дансны мэдээлэл	Имэйл бүртгэлийн мэдээлэл	Мэдээллийн хяналт	Гаалийн хяналт	Төрсөн, нас барсан болон гэрлэсэн
Тооцооны хүсэлт	IP хаягны хяналт	Тэмдэглэгээний маягт	Дотоодын орлого	Дотоодын татварын хяналт
Тусгай үйлчилгээ	Бусад	Анхааруулгын хяналт	CTA -ны хяналт	Компанийн бүртгэл
Үндэсний гар утасны өмчлөлийн бүртгэл		Интерпол	Хэрэгслийн хяналт	Equifax
Other			Үйлдвэрлэлийн захиалга	Experian
			Moneyweb хайлт	Цагаачлал
			Experian	Мэдээллийн хяналт
			Equifax	Дотоодын орлого
			Газрын бүртгэл	Газрын бүртгэл
			Бусад	Нээлттэй эх сурвалж
				Пасспортын хяналт
				Анхааруулгын хяналт
				Хэрэгслийн хяналт
				Сонгогчийн бүртгэл
				Бусад

Эх сурвалж: CtAP
Тэмдэглэл: FIU= CTA – Санхүүгийн тагнуулын алба; IP=ИП-Интернет протокол; NMPR=ҮГУӨБ-Үндэсний гар утасны өмчлөлийн бүртгэл.

Электрон ХМС системийг үүсгэх үед бүх цахим баримт бичгүүдийг хэрхэн системд оруулах талаар илүү өргөн хүрээний зохион байгуулалтыг авч үзэх шаардлагатай. Цахим ХМС үйл ажиллагаанд шилжих үед хуучин цаасан дээр суурилсан системтэй төстэй зохион байгуулалт тохиромжтой байж болно. Хэргийн хавтсын хувьд бүтцэд хэд хэдэн дэд хавтастай байх ба тухайлбал дараах дэд хавтсууд байж болно. Үүнд:

- Хэргийн хавтас (материалын дугаар)
  - ХМС (Хэргийн удирдлагын Эксел хавтас дахь байршил)
  - Админ (дотооддоо үүсгэсэн баримт бичгүүд)
    - Удирдамжууд (материалд олгосон эсхүл хүлээн авсан чиглэл)
    - Хүсэлтүүд (Нэгжих зөвшөөрлийн цахим хуулбар, эрх зүйн харилцан туслалцаа, Санхүүгийн тагнуулын алба (CTA)-ны хүсэлтүүд)
  - Эд мөрийн баримтууд (Эд мөрийн баримтын бүх цахим хуулбарууд)

- Баримт бичиг болон сэжигтнүүдийн эх сурвалжид суурилсан дэд хавтсууд
  - Ажлын бүтээгдэхүүнүүд
    - Банкны дүн шинжилгээ, график зэрэг ажлын бүтээгдэхүүн бүрээр үүсгэсэн дэд хавтсууд

Эх сурвалжууд

СтАР-аас оролцогчдыг хэргийн менежментийн системтэй танилцуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Тодорхой улс орны хууль тогтоомж, практикт тохируулсан хоёр курст хөтөлбөрт дараах зүйлс багтана. Үүнд:

1. Практик дасгал ажлуудаар дамжуулан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх, дотоодын нөөц бололцоог ашиглах болон санаатайгаар хамтран ажиллах суурь зарчмуудыг танилцуулна. Энэхүү курс нь хэргийн этгээд болон санхүүгийн танилцуулгагы бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх хэд хэдэн нээлттэй эх сурвалжийг ашиглах хэрэгцээт холбоосоор хангах, мөн оффшор бүс дахь компаниуд болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой нотлох баримтыг олж авах ажлыг хурдасгадаг.

2. Хэргийн менежментийн системийг ашиглан анхан шатны сургалтаас авсан мэдлэгийг хэргийн загварчлалын дасгал ажилд ашиглана. Энэхүү загварчлал нь оролцогчдоос санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хөрөнгийг мөшгих, хүсэлтийн төсөл гаргах болон мөрдөн шалгах ажиллагааны суурь ажлын бүтээгдэхүүнийг бэлтгэхийг шаардах ба эцэст нь хэргийн илтгэл танилцуулга болон санхүүгийн нотлох баримтын материалыг бэлтгэдэг.

Уг хөтөлбөр нь тухайн улсад байх бүхий л мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага болон прокурорын байгууллагаас оролцогчдыг хамруулбал илүү үр дүнтэй. Энэхүү олон талд багийн арга барил нь дотоод хамтын ажиллагааг дэмжиж, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд байгууллага тус бүр хэрхэн хувь нэмрээ оруулах талаар өргөн хүрээний ойлголттой болно. Хөтөлбөр бүрт оролцогчдын мэдлэг, сурсан зүйлсийг шалгах хэд хэдэн асуулгууд багтана.

Энэ хөтөлбөрөөс гадна СтАР нь тухайн улсын хөрөнгө буцаах хүчин чармайлтыг дэмжих өөр хэд хэдэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд мэргэжилтнүүдэд зориулан хэд хэдэн эх сурвалж материалуудыг боловсруулсан бөгөөд үүнд дараах хэвлэлүүд багтана:

- *Хөрөнгө буцаах гарын авлага: Мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага*
- *Хөрөнгө буцаахад тулгарах бэрхшээл: Голлох саад бэрхшээлд хийсэн дүн шинжилгээ ба Арга хэмжээний зөвлөмж*
- *Төрийн алдаа, хувийн хэвшлийн арга хэмжээ: Хулгайлагдсан хөрөнгийг буцаах иргэний шүүх ажиллагаа.* Иргэний шүүх ажиллагаа нь хулгайлагдсан хөрөнгийг буцаах чиглэлээр ихэвчлэн дутуу үнэлэгддэг. Энэхүү СтАР-ын тайлан нь илүү өргөн хэрэглэгддэг эрүүгийн аргачлалыг хэрхэн үр дүнтэйгээр орлуулж болохыг харуулна.
- *Хүүхэлдэйн мастерууд: Авлигачид хэрхэн хулгайлагдсан хөрөнгийг нуун далдлах зорилгоор хуулийн бүтцийг ашигладаг вэ, энэ талаар юу хийх вэ?*
- *Бүхий л зүйлээ эрсдэлд оруулах нь: Авлигын хэргүүдэд хил дамнасан хөрөнгийг буцаахад туслах төлбөрийн чадваргүй хэрэгслүүд.* Авлигын гэмт хэргээс олсон орлогыг нөхөн төлөхөд төлбөрийн чадваргүй байдлын ажиллагааг

хэрхэн ашиглах талаар хөрөнгө буцаах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдэд зориулсан алхам бүрээр заасан гарын авлага.

Бүх хэвлэгдсэн бүтээлүүдийг СтАР-ын цахим хуудас https://star.worldbank.org- аас татаж авах боломжтой.

ЭКО-АУДИТ

Хүрээлэн буй орчинд ээлтэй байх талаарх мэдэгдэл

Дэлхийн Банкны Групп нь хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулахыг зорьдог. Үүний тулд бид дэлхийн хэмжээнд бүс нутгийн түвшинд төвтэй цахим технологийг ашиглан электрон хэлбэрээр хэвлэх болон эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хэвлэх хувилбаруудыг сонгодог. Эдгээр арга замыг сонгон хэрэглэж хэвлэн нийтлэх тоо, тээвэрлэлтийн зайг багасгаснаар цаасны болон химийн хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдлыг бууруулах ач холбогдолтой. Бид Ногоон хэвлэлийн санаачлага байгууллагаас гаргасан цаасны хэрэглээний стандартыг дагаж мөрддөг. Манай номуудын дийлэнх нь Ой модны Удирдах Зөвлөлийн (FSC) гэрчилгээтэй цаасан дээр хэвлэгдсэн бөгөөд бараг бүгдээрээ 50-100 хувь дахин боловсруулагдсан байдаг. Манай номын цаасан дээрх дахин боловсруулсан эслэгийг цайруулсан болон цайруулаагүй болгохдоо бүрэн хлоргүй (TCF), боловсруулсан хлоргүй (PCF), эсхүл сайжруулсан элементийн хлоргүй (EECF) процессыг ашигладаг. Хүрээлэн орчны талаар баримталж байгаа Банкны бодлогын тухай дэлгэрэнгүй мэдээллийг http://www.worldbank.org/corporateresponsibilit цахим хуудаснаас авах боломжтой.

green press INITIATIVE

Хээл хахууль, хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан болон бусад авлигын үйлдлээс болж хөгжиж буй орнууд жил бүр тэрбум тэрбумаар нь алдаж байна. Энэхүү авлигын орлогын ихэнх хэсэг нь дэлхийн санхүүгийн тааламжтай хэсгүүдийг "диваажин" болгон сонгодог байна. Эдгээр гэмт хэргийн урсгалууд нь нийгмийн үйлчилгээ, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдийг цөлмөж, дэлхийн хамгийн ядуу орнуудыг улам ядуурахад нөлөөлж байна. Хөгжиж буй олон улс орнууд хулгайлагдсан хөрөнгөө буцаан авах арга замуудыг аль хэдийн эрэлхийлж эхлээд байна. Амжилттай шийдэгдсэн, олны анхаарлыг татсан хэд хэдэн хэргүүдэд олон улсын бүтээлч хамтын ажиллагааны үр дүнд хөрөнгийг буцаан авах ажиллагаа нь боломжтой зүйл болохыг харуулсан. Гэсэн хэдий ч олон улс орнуудын дотоодын агентлаг, яамдтай уялдаа холбоотой байж, хамтран ажиллахаас гадна хөрөнгийг мөшгих, хамгаалах чадавхитай байх, эрүүгийн хэрэгт хөрөнгө хураан авах, шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах, иргэний журмаар хөрөнгө хураан авах, эсхүл бусад хувилбаруудыг ашиглах талаар хууль зүйн янз бүрийн боломжуудыг хэрэгжүүлэх зэрэг нь маш нарийн төвөгтэй зүйл юм.

Энэхүү үйл явц нь хамгийн туршлагатай салбарын мэргэжилтнүүдийн хувьд ч хэцүү байж болно. Ялангуяа, улс нь дампуурсан, авлигад идэгдсэн, эсхүл хязгаарлагдмал нөөц бүхий нөхцөлд ажиллаж буй хүмүүст онцгой хэцүү байдаг. Энэ бүгдийг харгалзан, хууль бус хөрөнгийг буцаан авах ажиллагааны явцад стратегийн, зохион байгуулалтын, мөрдөн байцаалтын болон хууль эрх зүйн сорилтуудтай тулгарч буй хүмүүст туслах зорилгоор Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (StAR) хөтөлбөр нь "Олон улсад хөрөнгө буцаах ажиллагааны тухай гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж"-ийг боловсруулж, дахин шинэчилж гаргалаа. Тус төслийг салбарын мэргэжилтнүүд өөрсдөө хэрэгжүүлсэн тул гадаад улсад байршуулсан хөрөнгийг буцаан авах ажиллагааны талаарх ерөнхий чиг хандлага, практикт тулгарч болох асуудал, бэрхшээлүүдийг дурдаж, сайн туршлагуудыг Гарын авлагад танилцуулж өгсөн. Мөн тагнуулын тайлангийн загвар, шүүхийн шийдвэр гаргуулах тухай хүсэлт, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт зэрэг салбарын мэргэжилтнүүд ашиглаж болох арга хэрэгслийн жишээг багтаасан болно.

StAR буюу Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга хөтөлбөр нь Дэлхийн банк болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны (UNODC) хамтарсан хөтөлбөр бөгөөд авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хамгаалдаг диваажинг устгах талаар олон улсын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлж ажилладаг. StAR хөтөлбөр нь авлигын гэмт хэргийн улмаас бий болсон орлогоо хувиргаж, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, хулгайлагдсан хөрөнгийг илүү системтэй, цаг тухайд нь буцаан авах ажиллагааг явуулах талаар хөгжиж буй орнууд болон санхүүгийн төвүүдтэй хамтран ажилладаг юм.

Stolen Asset Recovery Initiative
The World Bank • UNODC

ДЭЛХИЙН БАНК

ISBN 978-1-4648-1616-1

90000
9 781464 816161

SKU 211616